МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ
ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ
2016

WHITE PAPER ON CRIME

УЛААНБААТАР ХОТ
2017 ОН

Үндсэн гүйцэтгэгч:

МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБОО

Хамтран гүйцэтгэгч:

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

ИЗОУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Дэмжигч:

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хамтран ажилласан байгууллага:

- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Улсын ерөнхий прокурорын газар
- Авлигатай тэмцэх газар
- Цагдаагийн ерөнхий газар
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
- Хил хамгаалах ерөнхий газар
- Гадаадын иргэн, харьяатын газар
- Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар

СУДАЛГААНЫ БАГ

Зөвлөх:

Н.Жанцан (Ph.D)
Г.Эрдэнэбат

Ахлагч:

Б.Мөнхдорж

Гишүүд:

Б.Батзориг (Ph.D)
Ж.Бумнанжид
Ц.Гантулгабат
С.Гантулга (Ph.D)
Э.Ганцэцэг
Г.Золбоо
Т.Золбоо
Ж.Мөнхболд (Ph.D)
Б.Мөнхсэргэлэн
О.Мөнхцэцэг
Ж.Нямдулам (Ph.D)
Ч.Нямсүрэн (Ph.D)
Г.Оюунболд
С.Пүрэврагчаа
Д.Сумъяацэрэн
Ж.Төгс-Очир
Г.Туяа
Л.Цогтбаяр
Ц.Цэлмэг (Ph.D)
Б.Энхболд (Ph.D)
С.Энхчимэг
М.Эрдэнэбаяр (Ph.D)
Ж.Эрдэнэбулган (Ph.D)
Ц.Эрдэнэчимэг

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ 7

БОСГО ҮГ 9

ӨМНӨХ ҮГ 10

ЗӨВЛӨХИЙН ҮГ 11

ОРШИЛ ҮГ 12

УДИРТГАЛ 13

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
Гэмт хэргийн цагаан ном эрхлэн гаргаж буй гадаад улсын туршлага **15**

ХОЁРДУГААР БҮЛЭГ.
Монгол Улс дахь гэмт явдлын төлөв байдал, чиг хандлага **20**

ГУРАВДУГААР БҮЛЭГ.
Криминологид суурилсан эрүүгийн эрх зүйн шинэтгэл **25**

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
Нуугдмал гэмт явдал **38**

ТАВДУГААР БҮЛЭГ.
Гэмт хэргийн хохирогч, хохирол судлалын төлөв байдал **46**

ЗУРГАДУГААР БҮЛЭГ.
Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, онцлог **64**

VI.1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, онцлог 65

VI.2. Авлигатай тэмцэх байгууллагын онцлог, үйл ажиллагаа 80

VI.3. Прокурорын байгууллагын онцлог, үйл ажиллагаа 89

VI.4 .Шүүх, шүүн таслах ажиллагаа 95

VI.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын онцлог, үйл ажиллагаа 123

VI.6. Шүүхийн шинжилгээний байгууллагын онцлог, үйл ажиллагаа 129

VI.7. Хууль сахиулах, бүртгэлийн чиг үүрэг бүхий зарим байгууллагын онцлог, үйл ажиллагаа 134

ДОЛДУГААР БҮЛЭГ.
Тодорхой төрлийн гэмт явдал **146**

VII.1. Хулгайлах гэмт хэрэг 147

VII.2. Зам тээврийн осол, хэрэг 159

VII.3. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 184
VII.4. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт явдал 194
VII.5. Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт явдал 206
VII.6. Хүүхэд холбогдсон, хохирсон гэмт явдал 212
VII.7. Эмэгтэйчүүдтэй холбоотой гэмт үзэгдэл ба жендер 219
VII.8. Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт явдал 226
VII.9. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт явдал 235
VII.10. Биеэ үнэлэлт ба хүн худалдаалах гэмт явдал 255
VII.11. Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт явдал 265
VII.12. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт явдал 272
VII.13. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт явдал 291
VII.14. Авлига, албан тушаалын гэмт явдал 302
VII.15. Согтуурал ба гэмт явдал 312
VII.16. Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт явдал 326
VII.17. Танхайрах гэмт явдал 347
VII.18. Бэлгийн мөлжлөг ба хүчиндэх гэмт явдал 355

НАЙМДУГААР БҮЛЭГ.
Төв, орон нутгийн гэмт явдлын төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ 361

VIII.1. Улаанбаатар хот 362
VIII.2. Архангай аймаг 374
VIII.3. Баян-Өлгий аймаг 385
VIII.4. Баянхонгор аймаг 399
VIII.5. Булган аймаг 410
VIII.6. Говь-Алтай аймаг 416
VIII.7. Говьсүмбэр аймаг 423
VIII.8. Дархан-Уул аймаг 443
VIII.9. Дорнод аймаг 459
VIII.10. Дорноговь аймаг 466
VIII.11. Дундговь аймаг 473
VIII.12. Завхан аймаг 479
VIII.13. Орхон аймаг 488
VIII.14. Өвөрхангай аймаг 499
VIII.15. Өмнөговь аймаг 510

VIII.16. Сүхбаатар аймаг 518
VIII.17. Сэлэнгэ аймаг 539
VIII.18. Төв аймаг 554
VIII.19. Увс аймаг 583
VIII.20. Ховд аймаг 594
VIII.21. Хөвсгөл аймаг 602
VIII.22. Хэнтий аймаг 609
VIII.23. Иргэний агаарын тээврийн салбар 623
VIII.24. Төмөр замын тээврийн салбар 642

НЭГДСЭН ДҮГНЭЛТ **659**

САНАЛ, ЗӨВЛӨМЖ **661**

ХАВСРАЛТ **662**

1. Гэмт хэргийн статистик мэдээлэл
(хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын статистикийн мэдээллийн үзүүлэлт)

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АНУ	Америкийн нэгдсэн улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БХЖЭ	Байгаль хамгаалах журмын эсрэг
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗЦГ	Замын цагдаагийн газар
ЗСБНХУ	Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улс
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
МАА	Мал аж ахуй
МБГ	Мөрдөн байцаах газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУТС	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НПГ	Нийслэлийн прокурорын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
ОХУ	Оросын холбооны улс
ӨМӨЗО	Өвөр Монголын өөртөө засах орон
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТПГ	Тээврийн прокурорын газар

ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХХАБАЖЭ	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УБХЦГ	Улаанбаатар хотын цагдаагийн газар
УДШ	Улсын Дээд шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
УЕП	Улсын Ерөнхий Прокурор
УИХ	Улсын Их хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮЭҮ	Үндэсний эрсдлийн үнэлгээ
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах бүлэг
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХСҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХСИС	Хууль сахиулах их сургууль
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХТХЗ	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХЭҮК	Хүний эрхий үндэсний комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШБҮ	Шударга байдлын үнэлгээ
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ЭМНДЕГ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭСЯ	Элчин сайдын яам
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль

БОСГО ҮГ

Дэлхийн олон улс оронд гэмт хэргийн цагаан номыг жил бүр хэвлэн гаргаж, түүндээ тулгуурлан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлаа зохион байгуулдаг туршлага бий болоод олон жилийн нүүрийг үзэж байна. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг судалгаанд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах шаардлага улс орон бүрт тулгарч байгааг харуулж байна.

Монгол Улс анхны Гэмт хэргийн цагаан номоо ийнхүү гаргаж байгаа нь олон талаар сайшаалтай зүйл. Энэхүү цагаан ном анхны хэдий ч Монгол Улсад үйлдэгдэн гарч буй гэмт хэргийн шинж төлвийг харуулсан судалгааны ажлыг криминологийн шинжлэх ухааны түвшинд чамбай сайн хийсэн төдийгүй судалгаанаас урган гарсан дүгнэлт, саналууд нь гэмт хэрэгтэй тэмцэх өөрийн орны онцлогт тохирсон бодлого арга замыг тодорхойлох боломж нөхцөлийг хангахуйц түвшинд хийгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд Монгол оронд үйлдэгдэж буй гэмт хэргийн бүтэц, хандлагад мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан байна. Энэ нь нэг талаар дэлхий даяар хүч түрэн явж буй даяаршлын нөлөөтэй холбоотой. Учир юу гэвэл дэлхийн улс оронд аюулын харанга дэлдэж буй хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, борлуулах гэмт хэрэг Монгол орныг тойрсонгүй, харин ч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх боломжтой орчин болж хувирсан байна.

Ийм орчин болоход энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал Монголын улс төрийн бодлогын анхаарлын төвд бүрэн ороогүй, дайврын шинжтэй явсаар ирсэн байдал нөлөөлсөн гэж үзэхээр байна. Үүнийг цагаан номд орсон судалгааны баримтууд давхар нотлон харуулж байна.

Өнөөдөр Монголын залуучуудын дотор боловсролтой залуучуудын тоо өсөн нэмэгдэж буй эерэг үзүүлэлт байгаа боловч тэдгээр боловсролтой залуучуудын дунд ажил хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын тоо өсөж, улмаар тэдний дунд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо нэмэгдсээр байна. Чухам яагаад эерэг үзүүлэлт нь нөгөө талдаа сөрөг үр дагавар дагуулаад байна гэдэгт төрийн бодлогын түвшинд дүгнэлт хийх шаардлага тулгараад байна.

Энэхүү "Гэмт хэргийн цагаан ном" анхны ном учраас криминологийн шинжлэх ухааны зарим ойлголтыг сурах бичгийн шинж чанартай дэлгэрэнгүй тайлбарласан явдал бий. Тухайлбал, нуугдмал гэмт хэргийн ойлголт, шинж чанар бүтцийн тухай, гэмт хэргийн хохирогч, хохирол судлалын төлөв байдлын тухай, түүнчлэн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны талаар тэдгээрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар хангалттай өргөн мэдээлэл өгсөн байна. Энэ бол нэг талаас бодлого хэрэгжүүлэгч албан тушаалтнуудад гарын авлага болох түвшинд ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

Энэхүү цагаан ном жил жилд гарахад цаашид юу анхаарах вэ? гэдэгт эрдэмтэн, судлаачид төдийгүй практикт уг ажлыг хэрэгжүүлэгч олон түмэн санал сэтгэгдлээ хуваалцах нь илүү үр дүн өгнө гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ,
ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР Н.ЖАНЦАН

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, хэтийн төлөв хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлон төр засаг, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад санал, зөвлөмж болгох зайлшгүй шаардлага бий болоод байна.

Дэлхийн улс орнуудын өмнө гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил нь хэзээд тулгамдсан асуудлын нэг байдаг тул улс бүр өөрийн орны нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэр, хүн ам, зан заншил, соёл иргэншлийг харгалзан харилцан адилгүй арга хэлбэрээр зохион байгуулж ирсэн.

Үүний тод жишээ нь тухайн улс жил бүр гэмт хэргийн байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийсэн гэмт хэргийн цагаан номыг (white paper on crime book) холбогдох эрдэмтэн, судлаачаас бүрдсэн судалгааны мэргэжлийн байгууллага эрхлэн гаргадаг билээ.

Тиймээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монголын Криминологичдын холбоо хамтран, Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016"-ыг эрхлэн гаргалаа.

Энэхүү номд гэмт явдалтай тэмцэх орчин үеийн чиг хандлага, гадаад орны туршлага, урьдчилан сэргийлэх бодлого, улсын хэмжээнд үйлдэгдэж гэмт хэргийн нөхцөл байдал, бүтэц, түүнд холбогдогчдын судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлохыг зорьсон нь цаашид Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, шалтгааныг зөв тодорхойлоход ач холбогдолтой байх болно.

Энэ бүтээл нь хурдтай хөгжиж буй өнөөгийн нийгэмд төрөөс гэмт хэргийн талаар баримтлах бодлогыг цаг үетэй нь уялдуулах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, холбогдох суурь судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх, түүнд тулгуурлан, иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх замаар нутаг дэвсгэрийн хэмжээд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулахад болон криминологийн чиглэлээр суралцаж буй оюутан, багш, эрдэмтэн судлаач нар өдөр тутам ашиглаж болохуйц болжээ.

Цаашид "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном"-ыг жил бүр эрхлэн гаргахаар төлөвлөж байгаа тул эрхэм уншигч Та бүхэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар өөрийн санаа бодол, туршлагаас хуваалцаж, холбогдох санал хүсэлтээ Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд ирүүлнэ гэдэгт итгэж байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД
МОНГОЛ УЛСАД ГЭРТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.НЯМДОРЖ

ЗӨВЛӨХИЙН ҮГ

Эрхэм уншигч Таны энэ өдрийн амгаланг айлтгая!

Гэмт хэргийн нөхцөл байдалд иж бүрэн анализ хийсэн "Гэмт хэргийн цагаан ном" (White paper on crime book)-ыг дэлхийн олон орон жил бүр өөрийн орны онцлог, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн гаргадаг уламжлал бий. Энэ номыг төрийн байгууллага өөрөө, зарим улс оронд энэ чиглэлийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны мэргэжлийн байгууллага эрхлэн гаргадаг туршлага байна.

Манай улсын хувьд Цагдаагийн ерөнхий газраас 2006 оноос эхлэн нь бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд үндэслэн жил бүр улсын хэмжээний гэмт хэргийн байдал, түүний шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох ажлыг хийж ирсэн. Гэвч энэ нь гэмт хэргийн цагаан ном гаргаж буй олон улсын жишиг шаардлагад нийцэхгүй, зөвхөн цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэлд үндэслэгдсэн гэж үзэж болно. Иймд Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан, нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, нуугдмал гэмт явдал, тэдгээрийн цаашдын чиг хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, тэмцэх арга замыг тодорхойлон төр засаг, хууль сахиулах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд санал, зөвлөмж болгох зайлшгүй шаардлага буйг олж харсан.

Энэхүү гэмт хэргийн цагаан номонд цагдаа, авлигатай тэмцэх, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн статистикийн мэдээлэл болон гэмт хэргийн гаралтад нөлөөлдөг нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн хүчин зүйлсийг илэрхийлдэг мэдээлэлд түшиглэн судалгаа хийж, Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж гаргахыг эрмэлзлээ.

Түүнчлэн, улсын хэмжээнд зонхилон үйлдэгддэг, эсхүл нийгэмд анхаарал татаж буй тодорхой төрлийн гэмт хэргийг тухайлан судалж, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлж оруулсан нь энэхүү номыг үнэ цэнэтэй болгоно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү "Гэмт хэргийн цагаан ном" нь цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээллээс илүү хууль сахиулах, шүүх эрх мэдлийн өргөн хүрээг хамарсан, улсын хэмжээний гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөлийг салбарын эрдэмтэн, судлаачдын багаас онол, арга зүйн талаас судалсан судалгааны бүтээл болсон.

Бидний анхлан хэрэгжүүлсэн энэхүү судалгааны ажлын үр дүн, тайлан алдаа, учир дутагдалтай байхыг үгүйсгэхгүй бөгөөд жилээс жилд улам чамбайруулан, баяжуулж гаргахыг эрмэлзэх болно.

Эрхэм уншигч Та бүхэн энэхүү номтой холбоотой санал хүсэлт, шүүмжлэл, зөвлөгөөгөө Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба болон Монголын Криминологичдын холбоонд ирүүлж, өөрийн туршлагаасаа хуваалцан хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Монгол Улсын хэмжээнд гэмт хэргийн статистикийн мэдээлэлд үндэслэн улсын хэмжээнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар суурь судалгаа хийх ажлыг дэмжсэн Нээлттэй нийгэм форумд криминологич эрдэмтэн, судлаачдын зүгээс талархал илэрхийлэхийн зэрэгцээ гэмт хэргийн цагаан номыг эрхлэн гаргах ажлыг бодлогын түвшинд дэмжиж, олон нийтийн хүртээл болгож буй Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд талархаж буйгаа илэрхийлж байна.

Таныг хүндэтгэсэн,

СУДАЛГААНЫ БАГИЙН ЗӨВЛӨХ Г.ЭРДЭНЭБАТ
2017 оны 10 дугаар сарын 07-ны өдөр

ОРШИЛ ҮГ

Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын цөм нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм. Тиймээс өнөөгийн цаг үе биднээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой зохион байгуулж, бодит үр дүнд хүрсэн байхыг шаардах боллоо. Даяарчлалын энэ эрин үед криминологийн шинжлэх ухааны орчин үеийн түвшингээс хоцрохгүй байх шаардлага ч та бидний өмнө тулгарч байна.

Орчин үед гэмт хэрэг үүдэн гарах болсон шалтгаан нөхцөл нийгмийн өөрчлөлт, техник технологийн хурдацтай хөгжлийг даган улам бүр хувьсаж байгаа бөгөөд гэмт явдал аяндаа, урсгалаараа гарахаа больсон төдийгүй нийгмийн хор аюул нь улам бүр нэмэгдэж, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ чиг хандлага, арга барилаар явуулах зайлшгүй байдал үүсч байгаатай та бүхэн санал нийлэх биз ээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх уламжлалт арга, хэрэгсэл үр дүнгээ өгөх нь багасаж, шинжлэх ухааны болон нийгмийн бусад салбарын мэдлэг, олон талын хамтын ажиллагаа илүү ихээр шаардагдах болсныг сүүлийн үед гарч байгаа шинэ төрлийн гэмт хэргээс харж болно. Үүнтэй холбогдуулан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг зөвхөн санхүү, эдийн засгийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, архины зохисгүй хэрэглээ, нийгмийн байдал гэх мэт явцуу хүрээгээр тодорхойлдог хуучин байдлаас татгалзаж, аль болох судалгаанд суурилсан тодорхой арга, арга зүйг практик үйл ажиллагаатай хослуулах бодит шаардлага байгааг үндэслэн Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба болон Монголын Криминологичдын Холбоо хамтран анх удаа “Гэмт хэргийн цагаан ном”-ыг бүтцийн хувьд цоо шинээр томьёолон гаргалаа.

Цаашид жил бүр гаргах уг товхимлыг эрдэмтэн, судлаач, практикийн ажилтан, гэмт хэргийн цагаан номыг хэрэглэгч, захиалагч хэн бүхний үнэтэй санал, шүүмжлэл, зөвлөгөөг авч, улам сайжруулан, баяжуулж гаргахыг эрхэмлэх болно. Гэмт хэргийн хар сүүдрийг үлдэн хөөхөд энэхүү "Цагаан ном"-ын гэгээ тусаа өгөх болтугай.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Л.НЯМГЭРЭЛ

УДИРТГАЛ

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар Монголын Криминологичдын холбооны гишүүн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны баг 2016 оны 12 дугаар сараас эхлэн 9 сарын хугацаанд Монгол Улс дахь гэмт явдлын байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, хэтийн төлөвийг тооцоолж, төр засаг, хууль сахиулах байгууллагуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмж зэргийг тусгасан "Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном-2016" сэдэвт судалгааны ажлын тайлан бэлтгэн гаргалаа.

Судалгааны ажлын хүрээнд бид дараах зорилтыг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

1. Гэмт хэргийн цагаан номыг эрхлэн гаргахад шаардлагатай тоон мэдээ, мэдээлэл, материал, тайлан, танилцуулга зэрэг холбогдох шаардлагатай мэдээллийг цуглуулж авах, түүнд дүн шинжилгээ хийх;
2. Тодорхой төрлийн гэмт явдал, нутаг дэвсгэр, салбарын гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, анализ хийх;
3. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, дүн шинжилгээ хийх;
4. Гэмт хэргийн цагаан ном эрхлэн гаргаж буй гадаад улсын туршлага, арга, зохион байгуулалтыг судлах;
5. Судалгааны үр дүнг нэгтгэн судалгааны тайлан бэлтгэж, захиалагчид хүлээлгэн өгөх, хэвлүүлэх.

Гэмт хэргийн цагаан номыг дэлхийн олон оронд гэмт хэргийн байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийж жил бүр тухайн улсынхаа онцлог, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн гаргадаг. Энэ номыг эрхлэн гаргаж буй туршлага нь төрийн байгууллага өөрөө, зарим улс оронд энэ чиглэлийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны мэргэжлийн байгууллага эрхлэн гаргадаг.

Улсын хэмжээний гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, хохирогч, хохиролтой холбогдох мэдээлэл, тодруулбал гэмт бүлэглэл, тэдгээрийн гишүүдийн нэрсийг нийтэд нээлттэй гаргаж тавих нь гэмт үзэгдэлтэй тэмцэх олон улсын нийтлэг эерэг арга, туршлага болж байна.

Иймд Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, гэмт явдлын нуугдмал байдал, цаашдын чиг хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлон төр, засаг, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд санал, зөвлөмж болгон өгөх зайлшгүй шаардлага байсан.

Гэмт хэргийн цагаан ном судалгааны бүтээлээр гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, практикт тулгарч буй асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон салбар зөвлөлийн гишүүд, хууль сахиулах байгууллагын удирдлагууд болон нийт иргэдэд танилцуулахыг зорьсон.

Энэхүү судалгааны ажлыг Монголын Криминологичдын холбооны 25 гишүүн криминологич эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэлээ.

Монголын Криминологичдын холбооны талаар товч дурьдахад анх 1999 онд байгуулагдсан бөгөөд 2012 онд шинэчлэгдэж, криминологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, сурталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг сургалт, эрдэм

шинжилгээ, судалгааны, ашгийн төлөө бус төрийн бус байгууллага. Тус холбооны Удирдах зөвлөлд гэмт үзэгдлийн шалтгаан, нөхцөлийг судалдаг, энэ чиглэлээр мэргэшсэн, эрдэм шинжилгээ, практикийн арвин туршлагатай криминологич эрдэмтэн, судлаачид байдгаас гадна холбооны гишүүнчлэлтэй, криминологийг сонирхон судалдаг олон тооны эрдэмтэн, судлаачид бий.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэн цагаан ном хэвлэгдэн гарч, олны хүртээл болсноор олон улсын хэмжээнд Монгол Улс дахь гэмт хэргийн гаралт харьцуулагдах, Монгол Улсын төр, засаг, хууль сахиулах байгууллагуудаас гэмт явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллага, эрдэмтэн, судлаачдын зүгээс бодитой дэмжиж, бодлогын хэмжээнд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой.

Түүнчлэн, Гэмт явдал судлалын чиглэлээр мэргэшсэн үе үеийн төлөөллөөс бүрдсэн, онол, арга зүй, практикийн өргөн мэдлэг, чадвартай эрдэмтэн, судлаачдын баг гүйцэтгэснээс гадна хууль сахиулах байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, их, дээд сургуулийн төлөөлөл оролцсон нь энэхүү судалгааны ажлын онцлог боллоо.

Үүний үр дүнд үндэсний хэмжээний томоохон суурь судалгаа явагдаж, гадаад улсын гэмт хэргийн цагаан ном эрхлэн гаргадаг туршлагыг нутагшуулж, төр засаг, хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд практикийн болон онолын талаас бодитой дэмжлэг болох бөгөөд цаашид жил бүр уламжлал болгон энэхүү номыг төгөлдөржүүлэн гаргана.

Мөн Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлон, судалгааны үр дүнг сургалтын болон практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл эрхлэн гаргах арга зүй, аргачлал, мэдээллийн систем, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шийдлийг боловсруулах зорилгоор ХЗДХЯ-ны захиалгаар ХСИС дээр 2016-2018 онд хэрэгжиж буй "Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал" шинжлэх ухаан, технологийн төслийн үйл ажиллагаа, үр дүнтэй улсын хэмжээний суурь судалгаа хийгдэх, гэмт хэргийн цагаан ном эрхлэн гаргах ажил зайлшгүй уялдаж байгаа явдал нь практикийн болон онол, арга зүйн түвшинд чухал ач холбогдолтой.

Энэхүү тайлан нь бүтцийн хувьд удиртгал, 8 бүлэг, нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмж, хавсралт хэсгээс бүрдэж байгаа бөгөөд гэмт хэргийн цагаан ном гаргадаг гадаад орны туршлага, Монгол Улсын гэмт явдлын төлөв байдал, чиг хандлага, эрх зүйн шинэчлэл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нөлөөлж буй байдал, нуугдмал гэмт явдлыг хэрхэн тооцоолох, гэмт хэргийн хохирогч, хохирлын байдал зэргийг тусгайлан бүлэг болгон авч үзсэн. Мөн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг голлон хэрэгжүүлж буй хууль сахиулах, шүүх эрх мэдлийн 9 байгууллагын үйл ажиллагаа, онцлогт дүн шинжилгээ хийсэн, тодорхой төрлийн 18 гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, төв, орон нутгийн гэмт явдлын төлөв байдал, онцлогийг тусгайлан судалсан.

Судалгааны төгсгөлд улсын хэмжээний гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэж буй эрх зүй, тогтолцоо, үйл ажиллагааны арга барилын талаар дүгнэн бичсэн. Улмаар "Гэмт хэргийн цагаан ном" хэмээх улсын хэмжээний гэмт хэргийн суурь судалгааны тайланд үндэслэн авч хэрэгжүүлж буй болохуйц санал, зөвлөмжийг дэвшүүлэв. Эцэст нь цагдаа, прокурор, шүүхийн байгууллагаас эрхлэн гаргасан гэмт хэргийн статистикийн 2016 оны үзүүлэлтүүдийг хавсарган оруулаа.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ ЭРХЛЭН ГАРГАЖ БУЙ ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА



Дэлхийн улс орнууд, тухайлбал Япон, АНУ, ХБНГУ, Канад, Австрали, БНСУ, ОХУ зэрэг улс оронд гэмт хэргийн цагаан ном буюу тайлант оны гэмт хэргийн нөхцөлд байдал, түүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийсэн тайлан, номыг эрхлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгодог. Тухайн судалгааны үр дүнг улс орон янз бүрийн байдлаар нэршиж байгаа бөгөөд нийтлэг байдлаар "White paper on crime book" хэмээн нэршдэг. Гадаад орны зарим туршлагыг судлан үзсэн үндсэн дээр Япон, ХБНГУ, АНУ-ын гэмт хэргийн цагаан ном эрхлэн гаргаж буй туршлагыг талаар тоймлуулж байна.

ЯПОН УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ

Япон Улсын Хууль зүйн яамны дэргэдэх Сургалт, судалгааны төв нь 1960-аад оны үеэс эрүүгийн эрх зүйн салбар дахь гэмт хэрэг, гэмт явдлын талаарх мэдээллийг "Гэмт хэргийн цагаан мэдээ" гэх нэртэйгээр эрхлэн гаргаж байв. Гэмт хэргийн цагаан мэдээний хураангуй нь англи хэл дээр хэвлэгддэг ба Япон улсад болон хилийн чанадад суугаа иргэд, төрийн албан хаагчид, хууль зүйн мэргэжлийн эрдэмтэн, судлаачид тухайн улсын гэмт хэргийн мэдээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй мэдээллийг судлах боломжтой юм.

Өнөөг хүртэл Гэмт хэргийн цагаан мэдээг Япон улсын Хууль зүйн яамны дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс жил бүр эрхлэн гаргаж байгаа ба http://hakusyo1.moj.go.jp/en/64/nfm/mokuji.html вэб сайтад нийтлэгдэж олны хүртээл болж байна.

2015 онд нийтлэгдсэн Гэмт хэргийн цагаан мэдээ нь гэмт хэргийн хандлага, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлага, насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг, түүнд оногдуулах хариуцлага, шинэ төрлийн гэмт хэргийн гаралт, чиг хандлага, гэмт хэргийн хохирогч гэсэн үндсэн таван бүлгээс бүрдсэн байна.

Бүлэг тус бүрийг дэлгэрүүлэн тухайн хэргийн талаарх тоон үзүүлэлт, судалгаа, гарсан хэргийг жишээ болгон дурьдаж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн хэрэгжилтийн талаар нарийвчлан судалжээ. Тухайлбал тухайн судалгааны 5 дахь бүлэгт тусгагдсан "Гэмт хэргийн хохирогч" сэдвийн талаар авч үзвэл:

5 дугаар бүлэг. Гэмт хэргийн хохирол


Хэсэг 1. Гэмт хэргийн хохирлыг тодорхойлох албан ёсны тоон үзүүлэлт

Хүснэгт 5.1.1.1-д Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс бусад бүртгэгдсэн эрүүгийн хэргийн хохирогчийн тоо

Зураг I.1

FIG. 5-1-1-1 NON-TRAFFIC PENAL CODE OFFENSES: CASES REPORTED, INVOLVING HUMAN VICTIMS AND VICTIMIZATION RATE (male/female)

(2005-2014)



Notes 1. Excluding cases in which victims are juridical persons or other organizations
2. "Victimization rate" refers to the number of reported cases per 100,000 population (male/female)
3. The count is based on the main victim if multiple victims were involved in a case.

Source: Criminal statistics of the National Police Agency
The Statistics Bureau, Ministry of Internal Affairs and Communications (population data)

I. Статистикийн материалуудын төрөл

Статистик, тоо, хүснэгт болон бусад тооцоолсон өгөгдлүүдийг Хууль зүйн яамны дараах товчоод/хэлтсээс гарган өгнө. Шүүхийн тогтолцооны сайдын ажлын алба, Эрүүгийн хэргийн товчоо, Засан хүмүүжүүлэх газар, Цагаатгах товчоо, Цагаачлалын алба. Холбогдох агентлагуудын явуулсан төрөл бүрийн судалгаа, мөн дараах албан ёсны статистик мэдээллийг авсан болно.

1. Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн статистик
   (Эрүүгийн мөрдөн байцаах товчоо, Үндэсний цагдаагийн газар)
2. Прокурорын статистикийн жилийн тайлан
   (Шүүхийн системийн газар, Сайдын нарийн бичгийн дарга нарын газар, Зөвшөөрлийн яам)
3. Шүүгчийн статистикийн жилийн тайлан
   (Дээд шүүхийн Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар)
4. Засвар хийх статистикийн жилийн тайлан
   (Шүүхийн системийн газар, Сайдын нарийн бичгийн дарга нарын газар, Зөвшөөрлийн яам)
5. Нөхөн сэргээлтийн статистикийн жилийн тайлан
   (Шүүхийн системийн газар, Сайдын нарийн бичгийн дарга нарын газар, Зөвшөөрлийн яам)

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ

Герман улсад гэмт хэргийн цагаан номыг Дотоод холбооны яам болон Холбооны хууль зүйн яам хамтран жил бүр "Герман улс дахь гэмт хэрэг ба гэмт хэргийн хяналтын тогтмол мэдээ" нэртэйгээр эрхлэн гаргадаг байна. Цагаан номыг Дотоод Хэргийн Яам, Хууль Зүйн яам, Их сургуулийн доктор профессор, Криминологийн судалгааны хүрээлэн, Криминалистикийн төв хүрээлэн, Холбооны статистикийн газрын судлаачид хамтран судалж нэгтгэн гаргадаг.

Холбооны Засгийн газрын зүгээс Холбооны Засгийн газрын чухал асуудлуудын нэг нь дотоодын аюулгүй байдлыг хангах явдал гэж үздэг бөгөөд үүний тулд "Гэмт хэрэг ба түүний шалтгаан нөхцөлийг судалж гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөлийг олж илрүүлэх үр дүнтэй арга хэрэгслийг хөгжүүлэхийг илүүд үздэг байна. Үүний тулд нэгдсэн өгөгдлүүдэд шинжлэх ухааны анализ хийж, шинжлэх ухааны ололтуудыг ашиглан харьцуулж, шинжлэх ухаанд суурилсан гэмт хэргийн талаарх иж бүрэн тайлан мэдээг гаргахаар Дотоод Холбооны Яам болон Хууль Зүйн Яам хамтран Криминологийн төв хүрээлэн, Холбооны статистикийн газар, Холбооны Эрүүгийн цагдаагийн газраас криминологи, социологийн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулан судлаачдын хороог байгуулж, энэхүү судлаачдын хороо нь гэмт хэргийн хяналт ба гэмт хэргийн тайлан мэдээг эрхлэн гаргаж байна.

Тайлан мэдээний гол зорилго нь Герман дахь гэмт хэргийн нөхцөл байдлын хамгийн дэлгэрэнгүй зураглалыг боломжит байдлаар гаргаж тавих хэмээн үзэж байсан бөгөөд хамгийн эхний тайланд албан ёсны одоогийн байгаа нэгдсэн тоон мэдээг цуглуулах, ялангуяа Эрүүгийн эрх зүйн захиргааны байгууллагын тоон мэдээ болон эрүүгийн цагдаагийн тоон мэдээг хамтад нь багтаасан байна.

Ингэснээр гэмт явдлын шалтгаан нөхцөл болон нөхцөл байдалд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан тоон мэдээг цаашид хөгжүүлэн үргэлжлүүлэн гаргаж, тогтмол хугацаагаар шинэчилж гаргах болжээ.

Судлаачдын хорооны хийсэн гэмт хэргийн судалгаа, мэдээ нь сонгогдсон газрын гэмт хэрэг ба бүтэц, аюулгүй байдлын шалтгаан нөхцөл байдлыг криминологийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж бичсэн. Мөн түүнчлэн уламжлалт гэмт хэргийн төрөл болох өмчийн эсрэг гэмт хэрэг, хар тамхи мансууруулах бодисын гэмт хэрэг, хүчирхийллийн гэмт хэрэг, шинэ төрлийн гэмт хэрэг, цахим гэмт хэргийн тухай тусгадаг байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн дагуу шалгагддаг гэмт хэргүүд энэ мэдээ тайланд мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэх үеэс дуусах хүртэл бичигдэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого дүгнэлт хэсэгт бичигдсэн байна.

Мөн гэмт хэргийн хяналт ба гэмт хэргийн мэдээ тайлангийн дугаар бүр нь тухайн цаг үеийн хамгийн чухал, сонирхол татахуйц, гол сэдвүүдийн нэгийг илүү дэлгэрэнгүй нарийвчлан авч үзсэн байх ба сүүлийн үеийн гэмт хэргийн цагаан номонд олон нийтийн сонирхлыг илүү их татаж байгаа насанд хүрээгүй хүн ба хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн талаар онцгой анхаарал хандуулж судалжээ.

Герман улс уг судалгааны бүтээлийн үндсэн дээр дотоодын аюулгүй байдлын хамгийн чухал асуудлуудыг ил гаргаж улс төр болон шинжлэх ухааны салбарын хооронд нээлттэй хэлэлцүүлгийг өрнүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаар ирээдүйд ашиглах гарын авлага, удирдамжийг боловсруулж дагаж мөрддөг байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН АРИЗОНА МУЖИЙН ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ

АНУ-ын муж тус бүр өөрийн орон нутаг дахь гэмт хэргийн тоон мэдээллийг Гэмт хэргийн цагаан ном нэртэйгээр эрхлэн гаргадаг байна. Аризонагийн гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөлийн дэргэдэх Судалгааны төв нь 1995 онд хэд хэдэн төрлөөр судалгааны асуулгыг боловсруулж хууль сахиулах байгууллага, прокурор, сангийн яамнаас судалгаа авч гэмт хэргийн мэдээллийг цуглуулан гэмт хэргийн цагаан номыг муж улсын гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоонд үнэлгээ өгөх байдлаар гаргажээ. Улмаар жил тутамд өсөн нэмэгдэж байгаа хүн амын тооноос шалтгаалан тэдний аюулгүй байдлыг хангах явдлыг илүүд үзэж байв. Асуулгад хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан эрүүгийн хэргийн тоо, бусад үйл ажиллагаанд холбогдох тоон үзүүлэлтүүдийг оруулсан бөгөөд хууль сахиулах бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, албан хаагчдын тоо зэргийг мөн багтаасан байна.

Аризона мужийн хууль сахиулах байгууллагуудаас авсан гэмт хэрэгтэй холбоотой тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн "Аризонагийн гэмт хэргийн чиг хандлага" хэмээх нийтлэлийг 2003 оны 1 сард мужийн захиргаа, гэмт хэрэгтэй тэмцэх нийгэмлэг болон олон нийтэд танилцуулсан. Энэ нийтлэл нь гэмт хэргийн мэдээллийг хэд хэдэн үзүүлэлтээр нэгтгэж эрүүгийн эрх зүйн тогтолцоонд тулгарч буй асуудлыг илрүүлж, цаашид хэрхэн хөгжүүлэх төлөв хандлагыг тодорхойлсон. Эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь тоон үзүүлэлтийг нэгтгэж гэмт хэргийн өнөөгийн байдал болон хэтийн төлөвийг гаргасан нь өмнөх судалгааг улам бүр дэлгэрүүлж, холбогдох зохион байгуулалтын асуудал болон санхүүжилтийг судалсан юм. Аризонагийн гэмт явдлын хандлага гэх ном нь гэмт явдлын түвшинг гаргасан бол гэмт хэргийн цагаан ном нь гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын хүч нөөцийг тусгаснаараа онцлог болсон гэж үзжээ.

Гэмт хэргийн цагаан номонд Аризонагийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог үр дүнтэй болгох, өнөөгийн түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоож өгөхөд оршиж гэмт хэргийн тоон үзүүлэлтийг агентлагийн түвшинд нарийвчлан авч үзэж Засгийн газар, хууль тогтоогч, гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөлийн гишүүд, хууль сахиулах байгууллагын удирдлагууд болон нийт иргэдэд гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал практикт тулгарч буй асуудлыг танилцуулахыг зорьсон байна.

Сүүлийн үед гэмт хэргийн талаарх тоог мэдээг 3 төрлийн эх сурвалжаас электрон байдлаар авчээ. Тухайлбал, бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, баривчлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн мэдээллийг сар тутам олон нийтийн аюулгүй байдлын яамнаас авах, Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн сангаас бүх шатны шүүхийн бүтэц, орон тоо, төсөв болон ял шийтгэлийн талаарх мэдээлэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн сангаас 1995 оноос хойш ял шийтгүүлсэн хүний мэдээллийг авдаг болсон нь илүү дэвшилттэй арга болсон гэж үзэж байна.

Хүн амын талаарх өгөгдөл нь 2003 оны цагаан номны гол үзүүлэлт байсан ба хүн амын тоог Статистикийн үндэсний газар болон Улсын бүртгэлтийн газраас авч тоон мэдээг хооронд нь харьцуулах замаар өгөгдлүүдийн үнэн бодит байдлыг шалгадаг байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ЯВДЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА


Монгол Улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн, тархалтыг тодорхойлж, гэмт хэргийн улмаас үүссэн хор хохирлыг илэрхийлэн гаргаж, гэмт хэргийн цаашдын чиг хандлагад дүн шинжилгээ хийлээ.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад 231,060 (жилд дунджаар 23,106) гэмт хэрэг бүртгэгдэж, нийт хэрэгт 207,843 хүн холбогдон шалгагдсан статистик мэдээлэл байна.

Хүснэгт II.1. Гэмт хэргийн хөдөлгөөн

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэгдсэн гэмт хэрэг	21268	20704	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167
Өсөлт, бууралт /хувиар/	16.5	-2.7	-1.6	-2.7	-3.2	15.1	14.8	7.7	1.6	- 2.1
Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүн	17810	18642	19612	19378	17982	19734	22286	23737	24857	23805
Өсөлт, бууралт /хувиар/	5.9	4.7	5.2	-1.2	-7.2	9.7	12.9	6.5	4.7	-4.2

График II.1. Гэмт хэргийн хөдөлгөөн



Гэмт хэргийн үзүүлэлт 2007 оноос 2011 он хүртэл 9.7%-аар буурч, харин 2011 оноос 2016 он хүртэл 41.5%-аар өссөн байна. Сүүлийн 10 жилийн дунджаас харахад гэмт хэргийн үзүүлэлт жилд 655 хэргээр нэмэгджээ.

Монгол Улсад Эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъектын насны доод хязгаар 16, зарим тодорхой гэмт хэрэг дээр 14 нас байдаг учраас 16 ба түүнээс нас гэж авч үзсэн, мөн олон

улсын түвшинд харьцуулах байдлаар 18-аас дээш насны хүмүүсийн тоонд харьцуулан тооцоолов. Албан ёсны статистикийн мэдээлэлд үндэслэн тооцоолоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 10 000 хүнд 115, 100 000 хүнд 1153 гэмт хэрэг, 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд 122, 100 000 хүнд 1219 гэмт хэрэг тус тус оногдож байгаа нь Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулах үзүүлэлт болно.

Үүнээс үзэхэд хүн ам цөөн манай улсын хувьд гэмт хэргийн түвшин өндөр, түүнээс үүссэн хор уршиг, хохирол харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна.

График II.2. 18 ба түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэрэг




График II.3. 16 ба түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэрэг




Гэмт хэргийн үзүүлэлтийн төлөв байдлаас үзэхэд дэлхий дахинд үйлдэгдэж буй гэмт үзэгдэл ерөнхийдөө өсч байна. Тодруулбал, сүүлийн 30-40 жилд гэмт үзэгдэл дунджаар 3-4 дахин өсчээ. ОХУ-д 6-8 дахин, АНУ-д 7-8 дахин, Англи, Швейцарт 6-7 дахин, Францад 5-6 дахин, Германд 3-4 дахин, Японд 1.5-2 дахин гэмт үзэгдэл өссөн байна.

Монгол Улсын 1968 оноос хойшхи 45 жилийн гэмт үзэгдлийн төлөв байдал, хандлагыг авч үзье. Монгол Улсад гэмт хэргийн гаралт 1968 оноос 2016 он хүртэл 7.9 дахин өсчээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас өрсөлдөөнт зах зээлийн эдийн засгийн шинэ нийгэмд

шилжсэн үе болох 1992 он 12,467 гарч байсан бол сүүлийн 25 жилийн хугацаанд 2016 он 27,167 болж, 2.2 дахин өссөн байна.

График II.4. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо.1968-2016 он



Монгол Улс дахь гэмт хэргийн төлөв байдал, чиг хандлагаас үзэхэд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн шалтгаан гэж шууд хэлэхээс илүүтэй төр засгийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар баримталж буй бодлого, Эрүүгийн хуультай шууд холбоотой гэсэн дүгнэлтийг ч хийж болохоор байна. Иймд тухайн нийгэм дэх сөрөг үзэгдэлтэй тэмцэхийн тулд сөрөг гэж үзэж буй нийгмийн харилцаатай тэмцэх, арилгахын тулд Эрүүгийн хуулийг оновчтой болгох нь гэмт үзэгдлийн чиг хандлагад шууд хамааралтай байдал ажиглагдав.

Харин Монгол Улсын шүүхээр жилд дунджаар 5,961 гэмт хэрэг шийдвэрлэгджээ. Цагдаа, авлигатай тэмцэх зэрэг хуулийн байгууллагад жилд дунджаар 23,106 гэмт хэрэг бүртгэгдсэн байдаг бол үүний 25.7% нь буюу 1/4 нь шүүхээр шийдвэрлэгджээ.

График II.5. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо



Гэмт хэргийн тархалт:

Сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн 41.3% нь орон нутагт, 58.7% нь нийслэлд үйлдэгдсэн байна.

График II.6. Монгол Улс, Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг





График II.7. Нийслэл дэх гэмт хэргийн эзлэх хувь




Харин гэмт хэргийн 2007 онд 49.4%, 2009 онд 55.7%, 2010 онд 54.8%, 2011 онд 56.1%, 2012 онд 58.4%, 2016 онд 65.9% нь Улаанбаатар хотод үйлдэгдэж, цаашид ч улам өсөх хандлагатай байгаа дүр зураг ажиглагдаж буй нь харамсалтай. Гэмт хэрэг төвлөрсөн суурин газруудад ихэвчлэн үйлдэгдэж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд "Улаанбаатар хот гэмт хэргийн үнэмлэхүй төв" болжээ. Хотжилт нь гэмт хэргийн үндсэн нөхцөл, орон зай, хамаарах хүчин зүйлс болж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Гэмт хэргийн төрөл

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 33.4%-ийг хулгайлах, 30.4% нь бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 7.9% нь залилан мэхэлж

авах, 6.6% нь ТХХАБАЖЭсрэг, 5.3% нь танхайрах, 1.7% нь дээрэмдэх, 1.2% нь завших, үрэгдүүлэх, 1.1% нь хүчиндэх бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

График II.8. 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл (Эрүүгийн хуулийн зүйлээр)



Улсын хэмжээнд 2016 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 27689 хүн эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа, 84 байгууллага, ААН эд хөрөнгөөрөө хохирчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн 41.0% нь эмэгтэй, 4.8% нь насанд хүрээгүй байгаа ба гэмт хэргийн улмаас 880 хүн нас барж, 11257 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн гэмт хэргийн үзүүлэлтээр чиг хандлагыг тодорхойлоход цаашид жилд дунджаар 655 хэргээр өсөн нэмэгдэх прогноз байна. Хүн амд оногдох гэмт хэргийн үзүүлэлт мөн нэмэгдсэн байна. Ялангуяа Улаанбаатар хотод үйлдэгдэж буй гэмт хэргийн үзүүлэлт улсын хэмжээнд эзлэх хувийн жин, ердийн хөдөлгөөн талаасаа өсөн нэмэгджээ.

Олон улс дахь гэмт хэргийн юүлүүр тогтолцоо (criminal funel system) талаас үзвэл цагдаагийн байгууллага болон авлигатай тэмцэх газар зэрэг хуулийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 25% нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг. Үлдсэн 75% нь цагдаа, авлигатай тэмцэх зэрэг хууль сахиулах байгууллагаас шалгах явцад болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэгддэг гэж болно.

Гэмт хэргийн юүлүүрийн амсар хэдий чинээ өргөн, үзүүр нь хэдий чинээ нарийн байх тусам хууль сахиулах тогтолцоо сул, авлига өндөр, хууль хэрэгжихгүй, ял завших нөхцөл бүрдсэнийг илэрхийлдэг. Товчхон дүгнэж хэлбэл, гэмт хэргийн юүлүүрийн тогтолцоо нь хууль эрх зүйн орчин сайтай газарт яагаад, ямар шалтгаанаар шат шатандаа багасч байгаа нь тодорхой харагддаг бол эсрэгээр нуугдмал хэрэг ихтэй, хууль сахиулах байгууллага, прокурорын байгууллагын шатанд гэмт хэрэг шийдэгдэхгүй байгаа сул талыг харуулдаг. Иймд орчин үеийн криминологийн шинжлэх ухаан гэмт хэргийн юүлүүрийн зарчмыг хууль эрх зүйн тогтолцоо, менежменттэй холбож судлахыг илүүд үзэж байна.

КРИМИНОЛОГИД СУУРИЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

Төрийн эрүүгийн бодлого /public criminal policy/ нь нийгэмд шууд нөлөө үзүүлдэг төдийгүй Эрүүгийн эрх зүйн чиглэлээр бодлого боловсруулах үйл явцад хувь хүн буюу бүлэг хүмүүс нь бодлогын шийдлийг шууд буюу шууд бусаар сонирхож байдаг. Тухайлбал, сонирхогч талууд нь төрийн алба, бодлогын зөвлөхүүд, төрийн бус байгууллага эсвэл нийгмийн өргөн хүрээний хувь хүн буюу хэсэг бүлэг хүмүүс, тэр ч байтугай гэм буруутай нь шүүхээр тогтоогдож ял эдэлж байгаа хүмүүс, гэмт хэргийн хохирогчид байнга сонирхож байдаг. Энэ тохиолдолд төрийн байгууллага нь бодлогын шинжээчид эсхүл криминологи судалгааны нэгж, байгууллагуудыг асуудлыг судалж хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах шийдвэрийг хүлээж байдаг.

Төрийн эрх мэдлийг авахаар сонгуулиар өрсөлдөж буй нам, улс төрийн хүчин нь дээр дурдсан гэмт хэрэг, ял шийтгэлийн талаар баримтлах бодлого боловсруулах нь зайлшгүй бөгөөд өөр, өөрийн онцлогтой. Ялсан нам, улстөрийн хүчин баримталж байгаа үзлээсээ хамаарч цаашид гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрийн бодлого, стратегийг тодорхойлдог. Улс төр, эдийн засгийн чиглэл, ялын бодлогыг авч үзвэл:[1]

Үзүүлэлт	Улстөр, нийгмийн хөгжлийн чиг баримжаа / Regime types/			
Нийгэм эдийн засаг, эрүүгийн индекс	**Неолиберализм /Neo-Liberalism/**	**Уламжлалт үзэл / Conservative corporatism/**	**Нийгмийн ардчилсан үзэл /Social democratic corporatism/**	**Дорны үзэл /Oriental corporatism/**
Нийгэм эдийн засгийн үзэл	Чөлөөт зах зээл, нийгмийн халамжийн үзэл	Нийгмийн халамжийн ерөнхий үзэл	Нийгмийн халамжийн нийтлэг үзэл	Хувийн хэвшилд суурилсан нийгмийн халамж, хүнд суртал, загварчлах үзэл
Иргэн-Төрийн харилцаа /Citizen-state relations/	Хүнчлэгдсэн, жижигрүүлсэн нийгмийн эрх хязгаарлагдсан	Нөхцөлт болон нийгмийн дунд зэргийн эрх	Харьцангуй нөхцөлт бус нийгмийн ерөнхий эрх	Феодалын шахуу үзэл, эрх, үүргийн хатуу мэдрэмж
Улс төрийн чиг хандлага /Political orientation/	**Барууны /Right-wing/**	**Төвийн /Centrist/**	**Зүүний /Left-wing/**	**Төв-барууны /Centre-right/**
Хорих ялын түвшин	High /Өндөр/	Medium /Дунд/	Low/Бага/	Low /Бага/
Жишээ:	АНУ, Англи, Австрали, Өмнөд Африк	Герман, Франц, Итали, Голланд	Швед, Финлянд	Япон

1 "Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага" судалгааны тайлан, ХСИС. 2014 он 73-74 дэх тал

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2008-2012, 2012-2016 онуудад хэрэгжсэнхөтөлбөрүүд, тэр дундаа Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэрэгжсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлж бичье.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт, 2008-2012 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2008-2012 онд хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, эрх зүй шинэтгэлийн мониторингийн тайлан, хүний эрхийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, ХЗЯ-ны үйл ажиллагааны тайлан, эрдэм шинжилгээний баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийлээ. Шинэ Үндсэн хуулийн дараах эрх зүйн шинэчлэлийн зурвас үе (1992-1996он), шинэчлэлийн эхний үе шат (1998-2002) эрх зүйн шинэчлэлийн хоёрдахь үе шат (2002-2008 он) эрх зүйн шинэчлэлийн гурав дахь үе шат (2012-2020 он) гэж үечилж болохоор байна.

3.1. Урьдач нөхцөл буюу 1998-2000 онд хэрэгжсэн "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн үр дүн

УИХ-ын 1998 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан. Тус хөтөлбөрт эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх 7 үндсэн чиглэлийн нийт 55 зорилтот арга хэмжээг төлөвлөжээ. Энэ хөтөлбөрт 2008 онд ХЗҮХ-ийн судалгааны багаар судалгаа хийлгэж үр дүнг үнэлсэн байна.

Хөтөлбөрийн үр дүнг судлан үзвэл хууль, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны талаар зарим зорилт хэрэгжээгүй, ялангуяа хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох байдал, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар дэвшүүлсэн зорилтуудыг хангалтгүй гэж дүгнэсэн боловч энэ нь 2008-2012 онд хийгдэх эрх зүйн шинэтгэлийн үндсэн суурь болж өгсөн байна. Тухайлбал, уг хөтөлбөрийн 28-т "Прокурорын үйл ажиллагааг шүүх эрх мэдлийг зөв хэрэгжүүлэхэд идэвхтэй нөлөөлөх чиглэлээр боловсронгуй болгох, прокурорын ажиллах нөхцөл, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиг үүргийг гүйцэтгэх байгууллага хариуцах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна." гэж тусгагдсантай холбоотойгоор хууль тогтоомж батлагдан гарсан боловч Прокурорын байгууллагын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх заалт өмнөх хуульд байснаас сайжраагүй байна. Прокурорын байгууллага нь төвлөрсөн удирдлагын тогтолцоог хэтэрхий шүтсэн, прокурор нь дээд шатны прокуророос шууд харааг, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаан дахь прокурорын хяналтын хүрэлцээ хангалтгүй, мөн бодитой өөрчлөлт гаргахаар төсвийн санхүүжилтийг шийдвэрлээгүй байна." гэсэн нь үндсэндээ 2015 он хүртэл хэвээр байв.

Энэ маягаар тус хөтөлбөрийн цагдаагийн байгууллагад холбогдох 29 дэх заалтыг дүгнэхдээ "Засгийн газар солигдох бүрт ЦЕГ, түүний газар, хэлтсийн дарга нар болон ЦЕГ-ын бүтэц өөрчлөгдөж байгааг хязгаарлах хууль зүйн орчин бүрдээгүй байна. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэд, олон нийтийн хяналт, дэмжлэгт түшиглэсэн бүтцийг бүрдүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна." гэж дүгнэсэн нь мөн л шийдвэрлэгдээгүй байна.

Түүнчлэн, 1998 оноос хойш Эрүүгийн эрх зүйн салбарт хамаарах :

1. Эрүүгийнхууль (2002.01.03)
2. Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002.01.03)
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. (2002.01.03) зэрэг гурван хууль нэг дор батлагдан гарч 13 жил хэрэгжсэн байна.

Эрх зүйн шинэтгэлийн 1998 оны хөтөлбөрт Албадан саатуулах, цагдан хорих арга хэмжээний тухай хууль, Дайны байдлын тухай хуулийг батлан гаргах, мөн Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн. Эндээс Албадан саатуулах, цагдан хорих арга хэмжээний тухай хууль батлагдан гараагүй бөгөөд Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байсан нь төлөвлөснөөс хожим буюу 2003 орсон байна.

УИХ-аас 2001 онд баталсан"Хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Эрүүгийн хууль, Торгуулийн хууль, Авлигын эсрэг хууль батлан гаргах, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн. Эндээс **Торгуулийн хууль** батлагдаагүй бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй.

Мөн 2005 онд батлагдсан "Хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Авилгын эсрэг хууль батлан гаргахаар төлөвлөсөн. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Дайны байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн. Эндээс Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Энэ бүхнийг дүгнэн үзвэл 1998 оны Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөө нь суурь шинжтэй томоохон өөрчлөлт байсныг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

3.2. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2008–2012 онд хийгдсэн хөтөлбөрийн үр дүн

УИХ-ын 2008 онд явагдсан сонгуулийн дүнгээр хамгийн олон санал авч УИХ-ыг өөрийн гишүүдээр бүрдүүлсэн улс төрийн хоёр хүчин Монгол Ардын Нам (одоогийн нэрээр нь бичив) Ардчилсан Нам улс эх орны хөгжлийг хурдасгах зорилтын үүднээс харилцан зөвшилцөн хамтарсан Засгийн газар байгуулж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн дөрөвдүгээрт "Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох" зорилтыг дэвшүүлсэн байна.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1 дүгээр бүлэгт "Эрх зүйн бодлого" гэсэн бүлгийг тусгайлан оруулж хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлж, хийдэл, давхардал, зөрчилдөөнийг арилгах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын үзэл баримтлалд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох зэрэг хэд хэдэн чухал асуудал тусгаж, төлөвлөсөн ихэнх ажлын боловсруулалтыг хийсэн боловч бодлого тодорхойлогчоор эцэслэн шийдвэрлүүлж чадаагүй байна. Үүнийг хөтөлбөрийн заалт бүрээр тоймлон авч үзвэл:

Хөтөлбөрийн 4.1.1-т заасан "Монгол Улсын хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлж, хийдэл, давхардал, зөрчилдөөнийг арилгаж хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох" ажлыг ХБНГУ-ын ГОУХАН-тэй хамтран "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах" төсөл хэрэгжүүлж 93 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг багц хэлбэрээр бэлтгэж, мөн "Хуулийн давхардал, хийдэл, зөрчилдөөнийг арилгах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 68 дугаар тогтоолыг батлуулж, нийт 234 хуулийн давхардал, хийдлийг арилгаж нэмэлт, өөрчлөлт оруулах санал бэлтгэсэн боловч УИХ-ын чуулганаар шийдвэрлүүлж чадаагүй, судалгаа төдий хэлбэрээр үлдсэн байна.

Мөн тус хөтөлбөрийн 4.1.5-т "Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох" ажлын хүрээнд Шүүхийн шинжилгээний тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн төслийг боловсруулан УИХ-аар батлуулсан бөгөөд Цагдаагийн байгууллагын тухай хууль, Харьяатын тухай хуулийн төслүүдийг эцэслэн шийдвэрлүүлж чадаагүй байна.

Хөтөлбөрийн 4.1.6-д "Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэргэжил, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, сургалтын материаллаг баазыг сайжруулах арга хэмжээ авах" ажлын хүрээнд ХСИС-ийг шинэчлэн байгуулж, хуульчийн үргэлжилсэн сургалтын 2011-2013 оны нэгдсэн төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж ажиллажээ. Гэтэл хөтөлбөрт дурдагдсаны дагуу хуульч биш хууль сахиулагчдыг чадавхжуулах ажил үндсэндээ орхигдсоны зэрэгцээ, байгууллага бүр харилцан адилгүй "албаны сургалт" нэр төдий хэвээр байв.

Энэ мэтчилэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн авлигын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шинэ хөтөлбөр боловсруулахтай холбоотой 4.1.9, 4.1.10, 4.2.14 дэх заалт, мөн шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын нэг албан хаагчийн үйлчлэх хүн амын тоог олон улсын жишигт ойртуулах арга хэмжээ авах тухай 4.2.2 дахь заалт, Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэхтэй холбоотой 4.2.11 дэх заалтууд хэрэгжээгүй, судалгааны байгууллага, институтын түвшинд боловсруулагдан, тайлан хэлбэрээр гарсан байна.

А. Эрүүгийн байцаан шийтгэх хууль-д 2008-2012 он хүртэл хийгдсэн шинэтгэл:

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2008-2011 онд нэг удаа нэмэлт, өөрчлөлт орсноос хойш Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг бүхлээр нь шинэчлэх нийгмийн хэрэгцээ, шаардлага байна гэж энэ салбарын эрдэмтэн судлаачид, практик алба хаагчид, хуулийн байгууллагын удирдлагаас дүгнэж байжээ.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын[2] "Эрх зүйн шинэтгэл 2007-2021" гэсэн 7.1 дэх хэсгийн 1 дэх стратегийн зорилтод *"Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны үнэт зүйл, эрх зүйн соёл, шинэ дэвшилтэт, түгээмэл ач холбогдол бүхий зохицуулалтын аргыг судалж нэвтрүүлэх"*-ээр заасан байна.

УИХ-ын 2008 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн[3] 4.1.5.-д *"Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох"*-оор тусгаж улмаар Монгол Улсын хууль тогтоомжийг 2008-2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн[4] 96-д *"Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулахын тулд байцаан шийтгэх ажиллагаа хэрэгжүүлэх байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн тоог нэмэгдүүлэх"*, тус хөтөлбөрийн 112-т *"Гэрч хохирогчийг хамгаалах эрх зүйн орчинг боловсонгуй болгох"* талаар заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр", "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийн тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж болон "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хуваарийг баталсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд 6 багц хуулийн төсөл боловсруулагдан, хэлэлцэгдэж энэ ажлын үр дүн 2012 хаврын чуулганаар батлагдсан.

Тухайн үед ЭБША-г олон улсын стандартад нийцсэн, шинэ түвшинд хүргэх зорилгоор хэрэгжүүлж буй зарим ажил хоорондоо уялдаа холбоогүйгээс хүлээгдэж, төсөөлөгдөж буй шинэчлэлүүд бүрэн тусах нь эргэлзээтэй, үйл явц удаашралтай байгаа нь тулгамдсан

2 УИХ-ын тогтоол №12, 2008 он
3 УИХ-ын тогтоол №35, 2008 он
4 УИХ-ын тогтоол №38, 2009 он

асуудал болсоныг судалгааны хэд хэдэн ажилд дүгнэн бичжээ.[5] Үүний өмнө **2007 оны 8 дугаар сард** Эрүүгийн байцаан шийтгэх хуульд орсон нэмэлт, өөрчлөлт нь тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэж чадахгүй гэж үзэж байв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2008 онд хэрэг бүртгэлт, хэргийг шүүхэд шилжүүлэх, шүүхийн шийдвэрийн талаарх гомдол, эсэргүүцлээ дээд шатны шүүхэд хэрхэн шилжүүлэх зэрэгтэй холбоотой найман нэмэлт, өөрчлөлт, **2009 онд** "Шүүхийн шинжилгээний тухай" хууль батлагдсантай холбоотойгоор хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон.

Түүнчлэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр"-ийг хэлэлцээд шүүх болон шүүх эрх мэдлийн бусад байгууллагын үйл ажиллагааны шударга байдал, ажлын чанар, үр нөлөөг сайжруулах зорилгоор хөтөлбөрт заасан тулгамдсан олон асуудлыг яаралтай шийдвэрлэхийн чухлыг тэмдэглэж "Зөвлөмж" гаргажээ.

Хөтөлбөрт тусгасан арга хэмжээг товчлон авч үзвэл: бүх шатны шүүхийн тогтолцоо, бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, эрх хэмжээний хуваарьт өөрчлөлт хийх, шүүгчийн статус, шүүхийн хараат бус байдлын тухай зохицуулалтыг улам нарийвчлан тогтоох чиглэлээр шүүхийн байгууламжийн болон процессын хуулиудад зарчмын нэмэлт, өөрчлөлт оруулахаар заажээ.

Прокурор, өмгөөлөх, мөрдөн байцаах зэрэг шүүх эрх мэдлийн хүрээний байгууллага (оролцогч)-ын зохион байгуулалт, үйл ажиллагааг оновчтой болгох чиглэлээр хуульд томоохон өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзжээ. Тухайлбал, эрүүгийн хэрэг мөрдөх албыг нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын харъяаллаас тусгаарлах, мөрдөх ажиллагаанд прокурор тасралтгүй хяналт тавьж, шүүхийн өмнөх шатанд хэрэг шалгах субъект болгон өөрчлөх, прокурорын үйл ажиллагааг шүүхийн хяналтад оруулах, шүүх эрх мэдлийг шударгаар хэрэгжүүлэхэд өмгөөлөгчдийн гүйцэтгэх мэргэшлийн үүргийг дээшлүүлэх, тэдний үйл ажиллагаа явуулах эрх зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх зэрэг үзэл баримтлалын шинжтэй гүнзгий өөрчлөлт хийхээр төлөвлөжээ.[6]

ХЗҮХ-ийн 2009 онд хийсэн судалгаанд оролцогчид (шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч)-ын 29.8% нь ЭБША-нд оролцогчдын, ялангуяа гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн, мөн гэрч, хохирогчийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн санал, 24.5% нь ЭБША-г хэрэгжүүлэгчээс уг ажиллагааг явуулахтай холбоотой, 12.2% нь нотлох баримт олж, цуглуулах, мэтгэлцэх боломж, эрхийг хангахад чиглэсэн, 10.5% нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх ажиллагаатай холбоотой, 7% нь таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байх баталгааг хангахад чиглэсэн, 5.2% нь ЭБША-ны явцад гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэхтэй холбоотой, 3.5% нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль үйлчлэх хэмжээ хязгаарыг өргөтгөхөд чиглэсэн санал гаргаж байв.[7]

Судалгааны явцад ЭБША дахь хэргийг зөвхөн байцаалтаар нотолж буй байдлыг үндсэнд нь өөрчилж, байцаалтаас бусад нотолгоогоор хэргийг нотлох эрх зүйн орчныг бий болгох, мэтгэлцэгч талууд (яллагч, өмгөөлөгч)-ын эрхийг ЭБША-ны бүх үе шатанд тэгш байлгах, шүүгчийн дангаар шийдвэрлэх хэргийн тоог нэмэгдүүлэх, эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тогтолцоо, журмыг боловсронгуй болгох талаар олон санал ирүүлсэн байна.

5 Хамтын бүтээл. "Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн хөгжилт. 1911-2011 он" ХЗҮХ, 2012 он

6 ХЗДХЯ-ны Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн байр суурь болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын боловсруулсан хөтөлбөр, үндсэн чиглэл, Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа өөрчлөлтүүд нь цаашид тогтвортой үйлчилж, хэрэгжих ёстой хууль боловсруулахад чиглэж байжээ.

7 "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны тайлан. Хууль Зүйн Үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор. 2009 он

Түүнчлэн, эрүүгийн хууль тогтоомжийн зохицуулалтад хамаарах асуудлаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлсэн байдлыг 31 гэрээний жишээн дээр судалж үзээд Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ Монгол Улс зохих ёсоор биелүүлэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Нэгэнт, ЭБША-г боловсронгуй болгох шаардлага байгааг судалгааны үр дүн нотлон харуулж, шүүхийн шинэчлэлийн хүрээнд суурь өөрчлөлтийг шийдвэрлэх чиглэлийг тодорхойлсон байх тул холбогдох хуулийн төсөл боловсруулахдаа дараах хэд хэдэн чухал нөхцөлийг анхаарч, нийгмийн амьдралд нийцсэн, "урт настай" хууль "төрүүлэх" шаардлагатай байгааг тэмдэглэхдээ дараах чиглэлийг санал болгов. Үүнд:

- Монголын нийгэм дэх гэмт үзэгдлийн өнөөгийн төлөв, цаашдын хандлагыг бодитой үнэлэн дүгнэж, түүнд төр, нийгмийн зүгээс хэрхэн хандаж буйг юуны өмнө тооцож үзсэн байх
- Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжид шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ хийж, нийгмийн харилцааг зохицуулахад үр нөлөөтэй болох нь мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны олон жилийн практикаар шалгагдсан хэм хэмжээг гээлгүй уламжлан авч үлдэх,
- ЭБША-нд хүний эрхийг хангах шаардлага гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох хууль зүйн арга, хэрэгсэл, арга ажиллагааны харилцан тэнцвэржсэн байдлыг алдагдуулахгүй байх,
- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бүх талын, бодитой дүн шинжилгээ хийсэн байх,
- Гадаад орны хууль тогтоомжийн үзэл санаа, зохицуулалтыг шууд хуулбарлан авахгүй байх зэрэг болно.

Дээр дурдсан нөхцөлүүдээс гадна хууль тогтоох байгууллагын албан хаагчдын сэтгэлгээний өөрчлөлт, хандлага, эрмэлзэл, хүсэл зориг тун чухал. Хүний халдашгүй эрхийг хязгаарлан, төр албадлага хэрэглэж байгаа тохиолдолд бид хүссэн хүсээгүй дэлхийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах хэрэгтэй. Хууль өргөн мэдүүлэх журмын дагуу боловсруулагдан хэлэлцэгдэж байгаа хуулийн төслийн зарим нь дэмжлэг авахгүй буцах эсвэл "жижиг засвар" хийх байдлаар хандвал төлөвлөж буй хуулийн шинэчлэл, үзэл баримтлалаас ухрахад хүргэж болно.[8] гэж дүгнэсэн байна.

Б. Эрүүгийн хуульд 2008–2012 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт

УИХ-ын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 95 дугаар заалтад "Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхой болгох, ойлгомжгүй буюу оновчгүй хэрэглэсэн зарим нэр томьёог залруулах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах"-аар заасан байна.

Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцөлийг тодорхой болгох, шинэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, түүнчлэн бусад хууль шинээр батлагдаж, зарим хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор хийгдэж байсан.

Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь нэгдэж орсон олон улсын гэрээ конвенци, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагаар нөхцөлдөн гарч байсан. Өөрөөр хэлбэл, нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, саналууд нь хуулийг агуулга зарчмын

8 ХЗҮХ-ийн "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилт" судалгааны тайлан. 2009 он

хувьд биш харин хуулийн тодорхой нэг зүйл, хэсгийг нэмэх, хасах эсхүл өөрчлөх байдлаар хязгаарлагдаж байжээ. Жишээлбэл, мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг 3 удаа өөрчилсөн, гэхдээ энэ төрлийн гэмт хэрэг шүүхийн практикт нэг ч удаа шийдвэрлэгдээгүй байх гэх мэт.

Хэдийгээр Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох талаар өнгөрсөн хугацаанд олон тооны санал, зөвлөмж гарч байсан боловч зөвхөн судлаач, эрдэмтдийн хүрээнд хэлэлцэгдээд УИХ-ын ХЗБХ, Засгийн газрын түвшинд хэлэлцэгдэхгүй эсхүл хэлэлцэгдсэн боловч ойлголтын зөрүүтэй байдлаас дэмжигдэлгүй буцах тохиолдол цөөнгүй байлаа.

3.3. Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үр дүн

УИХ-аас 2012 оны "Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны хөтөлбөр батлах тухай" 37 дугаар тогтоолын "Эрх чөлөөтэй монгол хүн" гэсэн тавдугаар бүлэгт "Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгохоор заасан нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн суурь болж өгөв.

Ардчилсан тогтолцоотой аль ч нийгэмд аливаа сонирхогч талууд сайн гэж үзсэн сонголтоо хамгаалахын тулд үр дүн өгөхүйц бүхий л аргыг хэрэглэдэг. УИХ-ын 2012 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт төрийн эрүүгийн бодлогын түвшинд (public criminal policy) хэд хэдэн томоохон асуудал дэвшүүлсэний үр дүнд хууль батлагдаж, удахгүй хэрэгжиж эхлэх нөхцөл бүрдсэн.

Урьд бидний мэдэхээр засгийн эрх барих дөрөв, дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлдэг эрх зүйн шинэчлэлийн нэг хэсгийг "хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл" гэж нэрлэн тухайн үед хууль тогтоох эрхийг эдэлж байгаа УИХ-аар батлуулан мөрдөж ирсэн. Гэтэл 2012-2016 оны хооронд улстөрийн нөхцөл байдлаас шалтгаалан уг хөтөлбөрийг батлах шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан юм. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хэрэгжилт, хүний эрхийг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилт, эрх зүйн шинэчлэлийн талаар гарсан хэлэлцүүлгийн товхимол зэргээс үзвэл дөрөв эсхүл найман жилийн давтамжтай хийгдэж байгаа эрх зүйн шинэчлэл, түүний хөтөлбөр бүр нь өөр хоорондоо залгамж шинж чанаргүй зөвхөн тухайн сонгуулийн хугацаанд эрх барьж байгаа нам, улс төрийн хүчин шийдвэрлэж ирсэн нь эрүүгийн эрх зүйн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2012-2016 онд хийгдсэн агуулгыг "том" дүр зургаар харвал:

Хүснэгт III.1.

Материаллаг хууль: Гэмт хэрэг, зөрчилд хариуцлага хүлээлгэх		**Процессын хууль:** Зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулах	
Эрүүгийн хууль	**Зөрчлийн тухай хууль**	**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль**	**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль**
Хууль зүйн хариуцлагын нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ		Хүний эрхэнд халдах, хязгаарлах үндэслэл, журмыг тодорхойлно.	

Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял, эрүүгийн бодлогын ялын төрөл, хэмжээг тогтооно.	Зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэлийн төрөл хэмжээг тогтооно.	Мөрдөн шалгах, яллах, нотлох, цагдан хорих, шүүх ажиллагаанд баримтлах зарчим, үндэслэл, журмыг тодорхойлно.	Хууль сахиулах нийтлэг ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх үндэслэл, журмыг тодорхойлно
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга		**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль**	

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эрүүгийн эрх зүйд хамаарах хэсгийн хэрэгжилтийг зүйл, заалт бүрээр авч үзвэл:

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 239-т заасан ажлын хүрээнд 2015 оны 12 дугаар сард Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийн тухай хуулиудыг батлан гаргасан байна. Эдгээр хуулийг 10 гаруй судалгаанд[9] үндэслэн боловсруулж, 3 жил гаруй хугацаанд хэлэлцүүлэгт санал авахаар 6 удаа батлан, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 оны 09 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөхөөр заасан.

Цаашид эдгээр хуулийг хэлбэрэлтгүй сахин хэрэгжүүлэх, гажуудах нөхцөл бий болгохоос сэргийлэх, ял, албадлагын арга хэмжээний шинэ институт бий болгож шинэлэг арга барилаар ажиллах шаардлагыг хуульч, хууль сахиулагчаас шаардана.

Үндсэн хуулиар баталгаажсан үнэт зүйлсийг хамгаалахдаа зөрчил, гэмт хэргийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж томьёолсноос гадна шинээр хамгаалах шаардлагатай үнэт зүйлсийг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд тусгаж, хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг бодитой хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд чиглэснээр зоримог алхам болсон байна. Тухайлбал, хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа "бага хэмжээ" гэсэн шалгуур үзүүлэлт бүхий, босго тогтоосон ойлголтыг байхгүй болгосноор гэмт хэрэг, зөрчлийг материаллаг шинжээр ялган төсөөтэй байдлаар хэрэглэдэг явдлыг халсан[10] зэрэг нь дэвшилтэт алхам болсон байна.

Түүнчлэн, Монгол Улсын хууль зүйн тогтолцоонд 1992 оноос эхлэн хэрэгжүүлсэн хамгийн том кодификаци бол бүх зөрчлийг төрөлжүүлэн нэгтгэж Зөрчлийн тухай хууль батлан гаргасан явдал гэж үзэж болно.


Эдгээр хууль хэрэгжиж эхлээгүй байхад 30 гаруй хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн баригдаж, мөн чанартаа нэг үйлдлийг зөрчил, гэмт хэрэг гэж хохирлын дүнгээр хуваасан нь цаашид давхар стандарт үүсгэж болох талтайг анхаарах нь зүйтэй.

Криминологид суурилсан эрүүгийн эрх зүйн хандлага

Эрүүгийн эрх зүйн онолд цаашдаа бидний уламжлан авч ирсэн эрүүгийн эрх зүй, криминологи салбар мөн огт дуулж байгаагүй дэд салбар болох пенологийн тухай бид зайлшгүй судлах, хуулийн хэрэгжилтийг хангахад урьд авсан мэдлэгийг шинэчлэх хэрэгцээ үүснэ.

9 Т.Мэндсайхан ахлагчтай судалгааны багаас хийсэн "Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал", ХЗҮХ-ээс 2004, 2009 онуудад хийсэн "Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" гэсэн суурь судалгаа, ХЗДХЯ-ны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгээс боловсруулсан зарим баримт, бичигт дурдсан схем, шүүмж, санал, дүгнэлт, зөвлөмжүүд, Академич С.Нарангэрэлийн боловсруулсан "Эрүүгийн төрөлжсөн хуулийн төсөл"

10 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрээгүй бол гэмт хэрэг биш гэж шийдвэрлэж байгаа нь хуулийн зарчмыг гажуудуулахад хүргэж байна. 2000 оноос хойш хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 13 удаа өөрчлөгджээ.



Гэмт явдлын тухай сургаалиас үүдэж ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох, түүнд ямар ял шийтгэж, гэмт хэрэг үйлдэгчтэй хэрхэн үр нөлөөтэй ажиллаж, урьдаас хэрхэн гэмт зан үйлээс нь татгалзуулах тухай бүхэл бүтэн мэдлэгийн тогтолцоо, арга зүйг криминологи гэдэг.[11] Харамсалтай нь манайд байдаг сурах бичгүүдэд эрүүгийн эрх зүй тусдаа, криминологи тусдаа хэмээн заасаар бүхэл бүтэн хагас зууныг элээсэн байх юм. Ийм ч учраас эрүүгийн эрх зүй судалдаг нь тусдаа, гэмт хэргийн учир шалтгааныг судалдаг нь тусдаа гэж үзэн криминологийн хичээл нь их сургуульд сонгон судлах багахан цагтай судлагдахуун болсон аж. Үүнээс улбаалан гэмт явдлын тухай онолын суурь мэдлэг олголгүй шууд эрүүгийн эрх зүйн онол сургааль руу орох нь түгээмэл байна.

Дүгнэлт.

1. Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн бодлого нь судалгаа, шинжилгээний үндэслэлээс гажих тохиолдол байна. 2013 онд Гэмт хэргийн тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл нэртэйгээр боловсруулагдан албан ёсны санал авахаар гаргаснаас хойш үзэл баримтлалын хувьд хэд хэдэн удаа өөрчлөгдөж батлагдсан нь бодлого боловсруулагчид эрүүгийн эрх зүйн бодлогын хувьд харилцан адилгүй байр суурьтай байна гэж дүгнэхэд хүргэж байна. Цаашид эрүүгийн эрх зүйн бодлогыг тогтвортой барих шаардлагатай төдийгүй, уламжлал шинэчлэлийг хослуулан хадгалах нь зүйтэй гэж үзэж байна.
2. Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хуулиуд болох Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг 2015 оны 12 дугаар сард, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 5 дугаар сард баталсан. Одоо түүнийг хэрэгжүүлэхэд цахим бүртгэл, тогтмол хийх криминологи судалгааны бааз суурийг хөгжүүлэх шаардлагатай. Өнөөгийн байдлаар хуулийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил уялдаа холбоо муутай, криминологийн шинжлэх ухааны үндэслэлээр хомсхон байна.
3. Монгол Улсад анх эрх зүйн шинэтгэлийн 1998 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн үед яригдаж байсан байцаалтаас бусад аргаар нотлох, хүний халдашгүй эрхийг хуульчлан баталгаажуулж, цагдан хорих явдлыг багасгах зэрэг асуудлууд ч энэ хуулийг шинэчлэн боловсруулахад яригдсаар байсан төдийгүй цаашид бодит үнэнийг тогтоох зарчимд суурилах эсхүл мэтгэлцэх зарчимд суурилах тал дээр онолын болон практикийн олон хэлэлцүүлэг маргаан явагдаж дундын хувилбарыг сонгосон байна. Өөрөөр хэлбэл, бодит үнэнийг тогтоох зарчим бүхий хавтаст хэрэг

11 F.Adler, G.Mueller, W.Laufer. "Criminology". sixth edition. 2007

дагадаг тогтолцоо хэвээр үлдсэн боловч шүүхийн өмнөх хэлэлцүүлэг, цагдан хорих хугацаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын талаар суурь шинжтэй өөрчлөлт, байцаахаас бусад аргаар гэмт хэргийг нотлох, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахад прокурор, шүүх зөвшөөрөл өгдөг байх зэрэг олон дэвшилтэт, зоримог өөрчлөлт хийгдсэн байна.

4. Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажил мөн л гурван жилийн турш хэлэлцэгдэж нэг удаа УИХ-аас буцаан татаж, хоёр удаа өргөн барьж үзэл баримтлалын хувьд өөрчлөгдсөний эцэст анхны үзэл баримтлалаар батлагдсан байна. Энэ хуульд улсын байцаагч, бусад эрх бүхий албан тушаалтны дураар авирлах, хүний эрхэнд зөвшөөрөлгүй халдах явдлыг хязгаарлаж, хууль сахиулах нийтлэг ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа зэргийг нарийвчлан тусгаснаараа онцгой ач холбогдолтой хууль болсон гэж үзэж байна. Хэдийгээр энэ хуулийг баталсан боловч эцсийн найруулга сонсоогүй шалтгаанаар 2016 онд шинээр эмхлэн байгуулагдсан УИХ-аас хууль санаачлагчид буцаажээ. Уг хуулийн төслийн үндсэн зарчмыг хадгалсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж 2017 онд баталсан байна.
5. Гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх нэгдсэн сан байгуулж, хууль сахиулах байгууллагын сүлжээнд холбогдох ажлыг үе шаттай зохион байгуулах ажил 2013 оноос эхлэн хэрэгжсэн байна. ЦЕГ-ийн Лицензийн төвийн хэрэгжүүлдэг тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох, жолоодох эрх сэргээх, үнэмлэх нөхөн олгох, жолоочийн үнэмлэх солих, гадаадын иргэнд жолооны үнэмлэх сольж олгох, жолоочийн лавлагаа гэсэн 6 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан байна.

   Хууль сахиулах байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбох ажлын хүрээнд 2015 онд ХЗДХ-н сайд, ШЕЗ-ийн дарга, УЕП-ын хамтарсан тушаалаар нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хамтран ашиглах зорилгоор харилцан өгөгдөл солилцох дундын нэгдсэн санд нэгтгэх болон ашиглах мэдээллийн жагсаалтыг гарган ажилласан. ХЗДХЯ-ны серверийн өрөөнд шүүхийн системийн кодчиллыг хөгжүүлэх тестийн серверийн орчин үүсгэн тохиргоо суурилуулалт хийсэн.

   Өнөөдрийн байдлаар ҮДТ-ХЗЯ-ШШГЕГ, ҮДТ-ХЗЯ-УДШ-ШЕЗ, ҮДТ-ХЗЯ-УПЕГ-ыг холбосон сүлжээний төгсгөлийн төхөөрөмжүүдийг байрлуулан хүлээлгэн өгч холболт үүсгэн тест хийсэн.
6. Мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх албаа болгон нэгтгэн зохион байгуулж, мөрдөх албаны дэргэд шүүхийн шинжилгээний бүтцийг бий болгох ажил 2013 онд Цагдаагийн албаны тухай хуулийг баталснаар эхэлсэн боловч Мөрдөх албаны тухай хуулийг хэлэлцээгүйгээс энэ ажил хэрэгжээгүй байна.
7. Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах ажил үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд ЦЕГ-т энэ асуудлыг хариуцсан хэлтэс, тусгайлсан мэргэжилтэн томилогдон ажиллаж байна. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2016 оны 12 дугаар сард хэлэлцэн баталж, 2017 оны 02 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан хэрэгжсэнээр хүн амын тоо, гэмт хэргийн гаралтыг харгалзан уг нэгжийг байгуулан ажиллаж эхэлжээ. Үр дүнгийн хувьд тодорхой хугацаа шаардагдана.
8. Хээл хахууль, шан харамж өгч авах зүйлийг ялгамжтай зохицуулж, хахууль өгсөн талыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хөнгөлөх асуудлыг хуульчлах гэсэн заалт

2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны 5 дугаар сард оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр авлигын гэмт хэргийн бие даасан бүлгийг тусгасан. Энэ хуульд албаны эрх нөлөөг урвуулан ашиглах, хахууль өгөх, хахууль авах зэргээр ялгамжтай зүйлчилсэн ба хэргээ илчлэн ирсэн тохиолдолд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх тухай зохицуулалтыг тусган батлуулсан байна.

ДҮГНЭЛТ

1. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2012-2016 онд Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг батлан хэрэгжүүлээгүй нь эрүүгийн эрх зүйн хувьд тогтворгүй байдал үүсгэж хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл явц хэт удааширсан байх талтай байна. Тухайлбал, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эрх зүй шинэтгэлийн хүрээнд төлөвлөсөн ХЗДХЯ-ны бодлогын баримт бичгийн хүрээнд энэхүү ажил хэрэгжсэн бөгөөд энэ хугацаанд Засгийн газар шинээр байгуулагдсанаас шалтгаалж хуулийн төслүүдийг буцаан татаж, ихээхэн хугацаа алдсан байна. 2014 оны 11 сараас 2015 оны 2 дугаар сарын хооронд, мөн 2017 онд ахин боловсруулсан хуулийн төслүүдийн хувьд өмнөхөөс ухралт хийсэн гэж зарим эрдэмтэн, судлаачид дүгнэж байв. Гэсэн хэдий ч хуулийн гол үзэл баримтлалыг алдалгүйгээр 2017 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зарим алдааг засаж шийдвэрлэсэн байна.
2. Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн бодлого нь судалгаа, шинжилгээний үндэслэлээс гажих тохиолдол байна. 2013 онд Гэмт хэргийн тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл нэртэйгээр боловсруулан албан ёсны 5 удаа санал асуулга явуулсан байна. Энэ хооронд уг төсөл үзэл баримтлалын хувьд нэг удаа өөрчлөгдөж өргөн баригдсан нь бодлого боловсруулагчид эрүүгийн эрх зүйн бодлогын хувьд харилцан адилгүй байр суурьтай байна гэж дүгнэхэд хүргэж байна. Цаашид эрүүгийн эрх зүйн бодлогыг тогтвортой барих шаардлагатай төдийгүй, уламжлал шинэчлэлийг хослуулан хадгалах нь зүйтэй.
3. Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хуулиуд болох Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуулиудыг эцэслэн баталж чадсан нь сүүлийн 15 жилд хийгдээгүй томоохон шинэчлэл болж чадсан.
4. Эрүүгийн эрх зүйн хувьд шинээр батлагдсан хуулиудын үзэл баримтлалаас ухрахгүй байх, зарчмын гол гол ололтууд болох хохирол барагдуулах тогтолцоо, ялын шинэлэг бодлого, хүний халдашгүй эрхийг хангах, баривчлах саатуулах, цагдан хорих, мөрдөн шалгах, хууль сахиулах, зөрчил шалган шийдвэрлэх, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр тогтоосон хэм хэмжээнүүдийг бататгахад анхаарч, хууль сахиулагчдын хандлагыг өөрчилж, шинэ мэдлэг олгох чиглэлээр сургалтыг байнга зохион байгуулах шаардлагатай.
5. Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр анх 1998 онд батлагдсанаас хойш хууль сахиулах байгууллагын удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хууль сахиулагчдыг чадавхжуулах талаар заалтууд үндсэндээ хэрэгжихгүй байна. Цаашид эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг шинээр боловсруулж, батлуулах шаардлагатай.

САНАЛ:

Нэг. Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн институт буюу ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэхэд алхмууд шаардагдана гэж үзэж байна. Үүнд:

1. **Тэнсэх институт (probation) ажиллуулах.** Урьд нь ял оноосны дараа тэнсдэг байсан зохицуулалтыг өөрчилж, ял оноохгүйгээр тэнсэж 6 төрлийн үүрэг хүлээлгэх, 5 төрлийн эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авахаар заасан учир шүүхээс авсан дээрх арга хэмжээнд хяналт тавих, зөрчсөн тохиолдолд дахин шүүхээр хэлэлцүүлж ял оногдуулахаар санал гаргах арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокуророос хэрэгжүүлэх шаардлага бий болно. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд цахим гав, техникийн хяналтын арга хэрэгслүүд болон зарим тохиолдолд биечилсэн хяналт тавих арга хэмжээг шийдвэрлэх шаардлагатай. Одоо байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, ял албадлагын арга хэмжээний нэгдсэн мэдээг үндэслэн урьдчилсан байдлаар тооцож үзвэл наад зах нь 2000-2500 орчим хүнд энэ төрлийн арга хэмжээг авах боломжтой байна. Одоо ашиглаж байгаа дэд бүтцээ цаашид хөгжүүлэх шаардлагатай.
2. **Өсвөр насны хүнд оногдуулах ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх институт, салбар хоорондын хамтын ажиллагаа шаардагдана.** Тухайлбал УИХ-ын 2016 оны хаврын чуулганаар батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуультай энэхүү арга хэмжээ зайлшгүй холбогдоно. НҮБ-ын санхүүжилтээр хэрэгжиж байсан Хүүхдэд ээлтэй эрх зүйн шинэтгэл хөтөлбөрийн хүрээнд заримт аймаг ажиллаж байсан Хүүхдийн хууль зүйн хороо цаашид Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын бүтцэд байхаар заасан. Энэ хууль мөн 2016 оны 9 дүгээс сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Шүүхээс өсвөр насны хүнд оногдуулсан ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд прокурор, хууль сахиулах байгууллагаас гадна хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны оролцоо, төрийн байгууллагын хамтын ажиллагаа хэрэгтэй болно.
3. Хуулийн этгээдэд ял оногдуулах гэсэн шинэлэг институтын хувьд торгуулийн ялаас гадна **эрх хасах ялыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хяналт, нэгдсэн бүртгэлийн тогтолцоо шаардагдана.** Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг хэрэгжүүлэхэд тухайн хуулийн этгээд өөр байгууллагын нэрээр үйл ажиллагаа явуулахаас эхлээд зориуд дампуурах гэх мэтээр ял завших нөхцөлийг таслан зогсоох шаардлага үүснэ.
4. **Ял оногдуулах зөвлөмж (sentencing guidline) шаардагдана.** Шинэ хуульд ялын дээд, доод хэмжээг харьцангуй сунгасан. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэгт 7 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар оногдуулж болохоор заасан учир наад захын ял онооход хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрхэн тооцож, үнэлэх талаар аргачилсан зөвлөмж хэрэгтэй болно. Шүүхийн тухай хуульд энэ талаар тусгайлсан зохицуулалт байхгүй учир маргаан үүсэж болох талтай ч хууль хэрэглээний асуудал учраас шийдвэрлэж болно гэж үзэж байна.
5. **Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэргийн шинжийг шаардлагатай гэж үзвэл тухай бүрд нь өөрчлөлт оруулах байдлаар шийдвэрлэж байх нь зүйтэй.** Харин тус хуулийн ерөнхий ангийн хувьд хуульчилсан зарчмын томоохон өөрчлөлтүүдийг хадгалж, цаашид тогтвортой барих бодлого баримтлах нь зүйтэй.

Хоёр. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал:

Эрүүгийн процессын хуулийн шинэчлэлийн хувьд анх өргөн баригдсан төслүүдээс хэд хэдэн ухралт байгаа төдийгүй уламжлалт "хавтаст хэрэг дагадаг" тогтолцоо, бодит үнэнийг тогтоох зарчимд суурилдаг байдал хэвээр үлдсэн байна. Магадгүй энэ хууль сахиулагч, мөрдөгчдийн хэвшмэл хандлагыг богино хугацаанд өөрчилж чадахгүй нөхцөлд зөв шийдэл байж болох талтай. Ялангуяа хавтаст хэрэг дагаж, шийдвэр гаргахдаа процесст бус хүнд эрх мэдэл олгож төвд тэмүүлэх хүч үйлчилдэг энэхүү тогтолцоог халах нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид уг хуулийг хэрэгжүүлж, гаргасан алдаа оноонд үндэслэн мэтгэлцэх зарчим руу шилжиж, оролцогчдын тэгш боломжийг хангах, шүүхийн урьдчилсан шатны хэлэлцүүлгийн төрлийг нэмж, зөвшөөрлийн системийн уян хатан болгох чиглэл рүү хөгжүүлэх төлвийг харгалзан үзэх нь зүйтэй.

Гурав. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан ХЗДХЯ, УЕПГ-ын шийдвэр, хамтарсан журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах, бусад улсын байцаагчийн эрхтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагаа, хамтарсан сургалтууд зохион байгуулахад урт болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулж ажиллах хэрэгтэй.

Дөрөв. Эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэх. Тухайлбал, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага буюу цагдаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хоорондоо ашиглах цахим сүлжээ, иргэдэд мэдээлэл өгөх, харилцах хувилбар зэрэг хүнд суртал, шат дамжлагыг багасгасан хувилбарыг боловсруулж, энэ арга хэмжээг хэрэгжүүлэх талаар УИХ-ын шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг нэг мөр хангах.

Тав. Хууль сахиулах ажиллагаанд хэрэглэх нэг бүрийн тусгай хэрэгсэл, техник, галт зэвсгийн асуудлыг цаашид боловсруулах хөтөлбөрт тусгах хэрэгцээ үүснэ. Мөн хууль сахиулах ажиллагаанд алба хаагчдыг бэлтгэх, чадавхжуулах, хууль сахиулах боловсон хүчин бэлтгэдэг их сургуулийн хөтөлбөрт агуулгын шинжтэй өөрчлөлт оруулах замаар чадварлаг хүний нөөцийг урт хугацаанд бэлтгэх, давтан сургах тухай заалтыг дараа дараачийн боловсруулж буй хөтөлбөрт тусгах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НУУГДМАЛ ГЭМТ ЯВДАЛ

1. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй цогцолбор байдлаар авч хэрэгжүүлэхэд юуны өмнө Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоох шаардлага зүй ёсоор тавигддаг. Цагдаагийн байгууллагаас гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг нэг бүрийг бүртгэх чиглэлээр 2002 оноос хойш жил дараалан тодорхой зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа ч дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны доголдол, цаашид гэмт хэрэг өсөх, гэмт хэрэг нуугдмал шинжтэй болох анхдагч нөхцөл гэж үзэх үндэстэй.

Тийм учир гэмт хэргийн тухай бодит мэдээлэлтэй байж, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг төлөвлөх, арга барилаа өөрчлөх, хүч арга хэрэгслийг зөв зохистой ашиглах, хэтийн төлөв боловсруулах, мэргэшсэн албадыг бий болгох нь чухал учир хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдээгүй, нуугдмал гэмт хэргийн талаар судлах нь сүүлийн үед эрдэмтэн судлаачдын туйлын зорилт болоод байна.

Нуугдмал гэмт хэргийн талаар XIX зууны эхээр анх удаа анхаарал хандуулж, А.Кетле, Э.Ферри, Ф.Захаревич[1] нарын эрдэмтдийн эрдэм шинжилгээний бүтээлд тусгалаа олсон байна. А.Кетле "үйлдэгдсэн гэмт хэргийн зөвхөн тодорхой хэсэг л мэдэгддэг ба нуугдмал гэмт хэргийн эзлэх хувь нь олон дахин их хувь эзэлдэг[2]". Түүнчлэн гэмт хэргийг гурван хэсэгт хуваах үзжээ.

Нэгдүгээрт: Илэрсэн гэмт этгээдтэй илэрсэн гэмт хэрэг,

Хоёрдугаарт: Илрээгүй гэмт этгээдтэй илэрсэн гэмт хэрэг,

Гуравдугаарт: Илрээгүй гэмт этгээдтэй илрээгүй гэмт хэрэг[3],

Энэхүү ангиллыг эрдэмтэн Ф.Захаревич 1853 онд өөрийн судалгааны үндсэн дээр баталсан. "...Голоос тороор барьсан загасны тоо голд байх загасны тоог илэрхийлдэггүйтэй адил баривчлагдсан этгээдийн тоо, үйлдэгдсэн гэмт хэргийн тоог бүрэн илэрхийлэх хэрэгсэл

1 Сорокин Н.О. "Измерение параметров скрытой преступности как криминологическая проблема" Дисс... канд юрид. Наук, Нижний Новгород, 1998.

2 Кетле.А. "Социальная физика, или опыт исследования о развитии человеческих способностей" Киев. 1911. /262 хуудас/ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест.2010. 15 хуудас.

3 Кетле.А."Социальная физика, или опыт исследования о развитии человеческих способностей" Киев. 1911. 263 хуудас/ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест. 2010. 16 хуудас.

биш юм.[4]" Италийн криминалистикч Э.Ферри XX зууны эхэн үед өөрийн социологийн судалгааны үндсэн дээр бодит гэмт хэрэг, илэрсэн гэмт хэрэг хоёрын хооронд харилцан хамаарал байдаг ба иргэдийн гэмт хэрэг гэж үзсэн үйлдлийн талаарх мэдээлэл өгөх хүсэл эрмэлзлийн их бага байхаас шууд хамаардаг гэж үзжээ. Түүнээс гадна "илэрсэн", "мэдээлсэн" гэмт хэргийн 65 хүртэл хувь нь ямар нэг хариуцлага хүлээдэггүй гэж үзсэн байна[5].

Дэлхий нийтэд нуугдмал гэмт хэргийн талаар судалгаа шинжилгээний ажлуудын үр дүнд маш их ахиц гарсан хэдий ч нуугдмал гэмт хэргийн нэгдсэн ойлголтод хүрээгүй, нарийвчилсан шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт боловсруулалтын шатанд байна. Манай улсад нуугдмал гэмт хэргийг тооцоолох аргачлал, арга зүй боловсруулагдаагүй байгаа нь криминологийн прогноз хийх боломжийг үгүйсгэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үр дүнгүй байгаагийн гол шалтгаан бол энэ талаар чиглэсэн судалгаа хийгдээгүй, анхаарал хандуулахгүй байгаад оршиж байна.

Латент гэдэг нь "latentis" гэсэн латин үгнээс эхтэй бөгөөд үзэгдэхгүй, нууц, далд, нуугдмал[6] гэсэн утга агуулдаг бөгөөд шинжлэх ухаан танин мэдэхүйн олон салбарт өргөнөөр хэрэглэгддэг байна. Гаднаас үл мэдэгдэх, үл харагдах үзэгдэл, үйл явцыг тодорхойлоход ашиглагддаг байна. Нуугдмал байдлыг зөвхөн судалж буй субьектэд үл үзэгдэх бодит болж буй үйл явцыг хамааруулан ойлгох ба нэг субьектэд үл үзэгдэн орших үйл явц маань нөгөө субьектэд ил байх харьцангуй байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Дээрх байдлыг харгалзан шинжлэх ухаан танин мэдэхүйн салбар бүрт өөрийн зөвхөн тэр салбарт тохирохуйц бодит шалгуур үзүүлэлт тогтоох нь нуугдмал үйл, үйл явцыг судлахад дөхөм юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгыг хангахад зохих ач холбогдолтой мэдээлэл хэрэгтэй байдаг.

Криминологийн ач холбогдол бүхий мэдээлэлд албан ёсны эх сурвалжаар гэмт хэргийн системчлэгдсэн статистик тоо бүртгэл ордог. Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг, нөөц хүчийг хуваарилах зөв зохистой зохицуулах, төлөвлөх, ашиглахад зөвхөн статистик тоо бүртгэлд агуулагдаж буй мэдээлэл ашиглагддаг. Криминологийн шинжлэх ухааны өмнө оршин буй зорилго зорилтод хүрэх, үр дүн гаргахад тоо бүртгэлд тусгалаа олсон бүрэн дүүрэн бодит мэдээлэл ач холбогдолтой. Тиймээс гэмт хэргийг бүртгэгдсэн, нуугдмал гэж хуваан ангилах нь статистик тоо бүртгэлд мэдээлэл байгаа эсхүл байхгүй гэсэн үндэслэлээр хуваан үзэж болно.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, нуугдмал гэмт хэрэг гэсэн ойлголтууд нь ерөнхий ба тусгай шинж чанарыг агуулна. Хэдийгээр нуугдмал гэмт хэрэг нь ерөнхий зүйлийн доторх тусгай хэсэг ч өөрийн гэсэн онцлогтой[7]. Бүртгэгдсэн гэмт хэргээс нуугдмал гэмт хэргийн ялгагдах онцлог нь түүний далд нууц шинж бөгөөд нуугдмал гэмт хэргийг бүрэлдэхүүн, шинж, өгөгдөхүүнүүд албан ёсны тоо бүртгэлийн системд байдаггүй.

Албан ёсны тоо бүртгэлд бүртгэгдээгүй хэдий ч нуугдмал гэмт хэрэг нь гэмт хэрэг болохын хувьд дараах шинжүүдийг агуулсаар байдаг:

- Нийгэмд аюултай үзэгдэл, эрүүгийн хариуцлага хүлээгээгүйн улмаас дахин давтагдах, их хэмжээний орон зайг хамарсан байдаг.
- Нийгмийн харилцааны гүнд оршин, түүний өөрчлөлтийг даган хувьсаж өөрчлөгдөх чадамжтай байдаг.
- Зарим шинжээчийн үзэж байгаагаар нуугдмал гэмт хэрэг нь бүртгэгдээгүй гэмт

4 Захаревич Ф. "Опыт юридической статистики" Дотоод Явдлын яамны сэтгүүл. 1853. Дугаар 41. 258 хуудас./ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест. 2010. 16 хуудас.

5 Ферри Э. "Уголовная социология" М.1908. 258 хуудас./ Храмов С.М. "патентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест. 2010. 16 хуудас.

6 http://ru.wikipedia.org/wiki

7 СазоноваН.В. "Понятие латентной преступности" Уголовное поаво и современность: Межвуз. Сб. Науч.тр. Вып. 6. Красноярск. СибЮИ МВД, 2002.-С.8-180-184.

хэргүүдийн нийлбэр бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргээс хэд дахин илүү байдаг учир нийгэмд тархсан гэж үздэг.

- Өөрийн гэсэн онцлог бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсгийн дийлэнх хэсгийг хөнгөн, хүндэвтэр хэргүүд эзэлдэг бол нуугдмал гэмт хэрэгт хөнгөн, хүндэвтэр, хүнд хэргүүд давамгайлдаг байна. Үүнд: Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд, иргэдийн эрх, эрх чөлөө, эрүүл мэндэд халдсан ямар байдлаар ар гэр, хамаатан садан, найз нөхдийн болон эрхэлж буй ажил үүргийн хувьд нуун дарагдуулсан хэргүүд эзэлдэг байна. Түүнчлэн, онц хүнд гэмт хэргүүд бага ч гэсэн тодорхой хувийг эзэлдэг. Энэ байдал нь нийгэмд олны анхааралд үргэлж байдаг сэдэв хэдий ч нуугдмал гэмт хэрэг дундаа эзлэх хувь бага байна гэж эрдэмтэд үзэж байгаа[8].
- Эрүүгийн болон байцаан шийтгэх (хууль сахиулах үйл ажиллагаа) цаг хугацааны хувьд нуугдмал гэмт хэргийн тооноос хоёр тохиолдолд хасагддаг. Үүнд:

  а/ тоо бүртгэлд бүртгэгдсэнээр

  б/ хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсноор
- Нуугдмал гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг нь орон зайн хувьд тухайн нутаг дэвсгэрийн онцлог шинжид нийцсэн бүтцийг агуулдаг.

Дээрх шинжүүдийг агуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж нуугдмал гэмт хэрэг гэх үзэгдлийн тодорхойлолтыг өгч болно. Нуугдмал гэмт хэрэг гэж "Цаг хугацаа, орон зайн хүрээнд нийгэмд аюултай үзэгдэл болох нийгмийн болон эрүүгийн эрх зүйн шинжийг агуулсан тодорхой нөхцөлд үүсч бий болсон албан ёсны бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн нэг хэсгийг нуугдмал гэмт хэрэг гэнэ[9]"

Нуугдмал гэмт хэрэг үүсэн бий болох шалтгаан нь объектив субъектив шинжээр тодорхойлогдсон эдийн засаг улс төр, үзэл суртал, ухамсрын, эрх зүйн болон бусад нийгмийн харилцаан дахь нөхцөлүүдээр нөхцөлдсөн нууц далд үйл явцуудын адил нийгмийн харилцааг удирдах, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын сул дорой байдал алдаанаас үүдэлтэй байна гэж хэлж болно.

Нуугдмал гэмт хэргийг объектив нуугдмал, субъектив нуугдмал гэмт хэрэг гэж ангилж болохоор байна.

Объектив нуугдмал гэмт хэрэг гэдэгт "нуун дарагдуулсан" өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагад ямар нэг хэлбэрээр мэдэгдсэн боловч нэгдсэн тоо бүртгэлд ороогүй гэмт хэрэг. Энэхүү ангиллыг орчин цагт үүсэн бий болж буй нуугдмал гэмт хэргийн механизмыг ажиглахад түүнийг тодотгох шаардлага байна гэж үзэж байна. Үйлдэгдсэн нөхцөл байдлын улмаас нуугдмал гэмт хэргийн бүрэлдэхүүнд орж байгаа, өөрөөр хэлбэл, хууль эрх зүйн хийдэл, боловсронгуй бус байдлаас хамаарч гэмт хэрэгт тооцогдохгүй, байгууллага албан тушаалтны мэргэжлийн алдаа дутагдал, гэмт хэргийн ертөнцийн сөрөг үйл ажиллагаа зэргээс болж тоо бүртгэлд бүртгэгдээгүй гэмт хэрэг нь ***объектив нөхцөл*** байдлын улмаас энэ байдалд байгаа гэж үзэж болно.

Субъектив нуугдмал гэмт хэрэг гэдэгт "нууц далд" гэмт хэрэг өөрөөр хэлбэл, бодит байдалд үйлдэгдэж хэн нэгэн этгээд хохирсон боловч хууль сахиулах байгууллагад огт мэдэгдээгүй гэмт хэрэг.

8 АкутаевР.М. "Криминологическая характеристика латентной преступности" Дисс... д-ра юрид. наук СПб, 2000.

9 Сазонова Н.В. "Латентная преступность: понятие, причины, измерение "Дисс.. канд юрид наук. Красноярск.. Автореферат С.9. 2004

2. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙГ ТООЦООЛОХ АРГА ЗҮЙ

2.1. Объектив нуугдмал гэмт хэргийг хэмжих арга зүй

ОХУ-д нуугдмал гэмт хэрэг, ялангуяа объектив нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор өнгөрсөн зууны 60-аад оны дунд үеэс дорвитой судалгааны ажлууд хийгдэж ирсэн байна. Үүнд Р.З.Акутаев, Х.Д.Аликперов, С.Босхолов, Г.Булатов, С.В.Вицин, Б.Гаврилов, К.К.Горяинов, А.И.Долгова, Г.И.Забрянский, А.А.Конев, В.В.Лунеев зэрэг криминологич эрдэмтэд өөрсдийн судалгааны ажлаа чиглүүлж байсан. Манай улсад энэ талаар хийсэн дорвитой судалгааны ажил хараахан байхгүй ч эрүүгийн эрх зүйн, байцаан шийтгэх эрх зүйн болон криминологич эрдэмтэд тодорхой түвшинд анхаарлаа хандуулж ирсэн.

А. Нуугдмал гэмт хэргийг тооцох аналогийн арга

Гэмт хэргийн нийгэм, эрх зүйн тодорхойлолтод үндэслэн хүн ам зүй, эдийн засаг зэрэг нийгмийн бүхий л салбарын нөхцөл байдлаар адил түвшинд байгаа тодорхой хоёр нутаг дэвсгэрийн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулан нэгтгэн дүгнэх үйл ажиллагааг ***аналогийн*** арга гэнэ.

Х1 - Г1 = Х2 – Г2 (Н1)

Х1 - Эхний нутаг дэвсгэрийн нэгжийн хүн амын тоо,

Г1 - Эхний нутаг дэвсгэрийн нэгжийн гэмт хэргийн тоо,

Х2 - Хоёр дахь нутаг дэвсгэрийн нэгжийн хүн амын тоо,

Г2 - Хоёр дахь нутаг дэвсгэрийн нэгжийн гэмт хэргийн тоо гэж үзвэл:

*Г2 (Н) = Г1 * Х2 / Х1 хоёр дахь нутаг дэвсгэрийн нэгжийн нуугдмал гэмт хэргийн тоог гаргаж болно.*

Дээрх томьёог ашиглахын өмнө нутаг дэвсгэрийн нэгжүүдийг адилтгаж харьцуулах хэрэгтэй ба тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэргийн бүтцийг сайтар судлан дүгнэж харьцуулах жишгийг тогтооно. Ингэхдээ гэмт хэргийг тодорхой төрлөөр болон нутаг дэвсгэрийн хүрээгээр төрөлжүүлэн ангилж болно. Үүний үр дүнд тухайн нутаг дэвсгэрийн объектив нуугдмал, субъектив нуугдмал гэмт хэргийг тус тусад нь гаргаж ирэх нь чухал. Тухайн нэгж нутаг дэвсгэрийн нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдлыг тодотгох зорилгоор явуулах асуулгын эрсдэлийг тогтоох зорилгоор тусгай коэффициент гаргаж ашиглах нь бодит байдлыг үнэлэхэд ач холбогдолтой. Бүртгэсэн өргөдөл, гомдол мэдээллийн нийт тоог бүртгэсэн гэмт хэргийн тоотой харьцуулж, гарсан тоог объектив нуугдмал гэмт хэргийн тоотой харьцуулж нуугдмал гэмт хэргийн боломжит тоог гаргаж авч судалгаа шинжилгээнд ашиглаж болно.

Б. Нуугдмал гэмт хэргийг тооцох тусгай коэффициентын арга

Гэмт хэргийн тоог эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоог татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон тогтоолын тоотой харьцуулж гарган авна. Нутаг дэвсгэрийн нэгжийн сүүлийн 2-5 жилийн тоон өгөгдэхүүнийг ашиглах нь нуугдмал гэмт хэргийн өсөлт бууралтад дүн шинжилгээ хийх дундаж байдлыг тогтоох боломжийг нээн гаргана. Тусгай коэффициентыг дараах томьёо ашиглан гаргана:

*Кд =((З-Д)/Д(П-Пт)Пт)*100%*

З - нийт бүртгэсэн гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол, мэдээлэл

Д - нийт бүртгэсэн гэмт хэрэг

П - нийт эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоо

Пт - татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон тоо

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээр дээрх томьёог ашиглан нийт гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл, нийт гэмт хэрэг, татгалзсан материал, татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон зэрэгт дүн шинжилгээ хийж гаргаж болно.

В. Хүн амын тоонд харьцуулах арга

Нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоох талаар 27 улсад[10] явуулсан судалгааны дүнд аль ч улсын нуугдмал гэмт хэргийн тоон үзүүлэлт нийт хүн амын 5.6%-аас илүү гараагүй байна[11]. Нийгэм эдийн засаг, хууль эрх зүйн онцлог бүхий улсуудад нийт хүн амд эзлэх нуугдмал гэмт хэргийн тоо 5.6% даваагүй байгаагаас үзвэл нуугдмал гэмт хэргийн тоон үзүүлэлт тодорхой хэмжээнд орших магадлал байна гэж үзэх нь сонирхол татах бөгөөд магадгүй үнэнд нийцэх асуудал нь маргаантай хэвээр байна.

Эрүүгийн хууль тогтоомжид заасан гэмт хэрэг бүр өөрийн онцлогоос хамааран нуугдмал байдлын эзлэх хувь нь тус тусдаа өөр байдаг. Гэмт хэргийн үйлдлийн арга, нөхцөл байдал, цаг хугацаа, орон зай, сэдэлт, хохирол зэргээс хамааран тухайн гэмт хэргийн нуугдмал байдал тодорхойлогддог.

Хээл хахууль авах, өгөх гэмт хэрэгт нуугдмал байдлын эзлэх хувь маш өндөр байдаг. Энэ гэмт хэргийн талаар мэдээлэх, гэрчлэх асуудал маш төвөгтэй эрсдэлтэй байдаг ба аль аль талын эрх ашиг хөндөгддөг учир нуугдмал байдалд оршдог. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хохирол, хохирогчоос хамааран нуугдмал байдал бага хувийг эзэлдэг. Нийт гэмт хэрэгт хулгайлах гэмт хэргийн эзлэх хувь 30-40% байгаа нь, хээл хахууль авах өгөх гэмт хэргийн эзлэх хувь 0,5-1% байгаа нь нуугдмал гэмт хэрэгт урвуу хамааралтайгаар илэрхийлэгдэнэ. Үүнээс үүдэн нуугдмал гэмт хэргийг нуугдмал шинж чанар бага, их, онц их гэж ангилж болно.

2.2. Субъектив нуугдмал гэмт хэргийг хэмжих арга зүй

Барууны хөгжингүй орнуудад нуугдмал гэмт хэргийн талаар XX зууны дунд үе буюу 1940-өөд оноос эхлэн эрчимтэй судалгаа хийж эхэлсэн. Энэхүү судалгаануудын үндсэн чиглэл нуугдмал гэмт хэргийн тоон хэмжээг хэмжих арга аргачлал боловсруулахад чиглэгдэж байсан. Энэ үйл ажиллагаанд барууны оронд түгээмэл хэрэглэгддэг "Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа" (*National crime victimization survey*), "Гэр бүлийн хүчирхийллийн судалгаа" *(National family Violence surveys)*, *"Үндэсний эмэгтэйчүүдийн судалгаа" (National women's study), "Өөрийгөө мэдээлэх судалгаа" (self reported survey) зэргийг дурдаж болно.*

Эдгээр судалгаа нь нийгмийн гишүүдэд чиглэгдэх бөгөөд тэдний гэмт хэрэгт хохирч байсан болон гэмт хэрэг үйлдэж байсан талаарх туршлагыг илрүүлэхэд

10 (АНУ, ХБНГУ, Финлянд, Польш гэх зэрэг)

11 Ли.Д.А. Уголовно-статистический учёт: структурно-функциональные закономерности: моногр. М.Русский мир, 1997. 21 хуудас.

чиглэгдсэн ярилцлага, санал асуулгын аргаар авагдсан судалгаа хамаардаг. Судалгааг явуулахад тусгайлан боловсруулсан асуултаар түүвэрлэлтэд багтаасан иргэдээс авдаг. Судалгаанд оролцогчдын тоо нь тухайн нийгмийн гишүүдийн санал бодлыг илрүүлэхэд хүрэлцэхүйц байх шаардлагатай.

А. Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа (National crime victimization survey)

Гэмт хэргийн албан ёсны статистик нь зөвхөн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоон үзүүлэлт байдаг бол гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа нь гэмт хэрэг, халдлагад өртсөн боловч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй нуугдмал гэмт хэргийн түвшинг хохирогчдоор дамжуулж тодорхойлохыг оролддог аргачлал. Тухайлбал, "Та өнгөрсөн жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болж байсан уу?", *"Хэрэв хохирогч болж байсан бол цагдаагийн байгууллагад мэдэгдэж байсан уу?", "Хэрэв цагдаагийн байгууллагад мэдэгдэж байгаагүй бол ямар шалтгаантай вэ?"* гэсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд чиглэгдсэн өргөн хүрээний асуултыг иргэдэд тавьдаг.

Б. Гэр бүлийн хүчирхийллийн судалгаа (National family Violence surveys)

Нуугдмал гэмт хэргийн тодорхойлох өөр нэг арга зүй нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор санал асуулга, ярилцлагын арга ашиглан түүврийн аргаар сонгосон гэр бүлийн гишүүдийн судалгаа явуулах арга зүй. Тухайлбал, *"Та гэр бүлийн хүрээнд ямар нэгэн хүчирхийлэлд өртдөг үү?", "Хүчирхийллийг хэн үйлддэг вэ"* гэх мэт асуултыг тавьдаг.

В. Өөрийгөө мэдээлэх судалгаа (self reported survey)

Сүүлийн нэг жилийн хугацаанд гэмт хэрэг үйлдэж байсан боловч цагдаагийн байгууллагад мэдэгдэж байгаагүй гэдгээ судалгаанд оролцогч хүлээн зөвшөөрөх байдлаар нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох аргачлал байдаг. Энэ аргачлалд ихэвчлэн жижиг гэгдэх хүний бие махбодид хөнгөн гэмттэл учруулах, эд зүйл хулгайлах, зарим тохиолдолд хүчиндэх, доромжлох зэрэг хэргийн чиг хандлагыг тогтооход ашигладаг. Тухайлбал, "Та өнгөрсөн жилийн хугацаанд ямар нэгэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж байсан уу?" гэх мэт асуулт тавигддаг.

3. МОНГОЛ УЛСЫН НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТААМАГЛАЛ

2012 онд цагдаагийн байгууллага гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 79 561 хүлээн авч, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл 27 566, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материал 49 564, татгалзсан материалыг прокурорын байгууллагаас хүчингүй болгосон тогтоолын тоо 51 гэсэн үзүүлэлттэй байна. Харин 2016 онд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 94 324, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл 27 167, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоо 65 709, Татгалзсан материалыг прокурорын байгууллагаас хүчингүй болгосон тогтоолын тоо 21 байжээ. Үүнийг тусгай коэффициентын аргачлалаар тооцоолж "график IV.1"-т үзүүлэв.


График IV.1. Нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдал таамаглал (2012-2016)

Он	Нуугдмал байх магадлал
2012	0.19
2013	0.15
2014	0.38
2015	0.26
2016	0.07
Дундаж	0.21

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд өнгөрсөн 5 жилийн дунджаар 1 гэмт хэргийн цаана 0.21 гэмт хэрэг нуугдмал байх магадлалтай байжээ.

"График IV.2"-т үзүүлснээр 2012-2016 оны хооронд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалыг харуулсан байна.


График IV.2. Нийт гэмт хэргийн гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэсэн тоо



Дээрх үзүүлэлтээс харахад цагдаагийн байгууллагад цугларч байгаа нийт гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл жил дараалан өсч байгаа бөгөөд нийт гомдол, мэдээллийн 30 орчим хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн нь гэмт хэргийн нуугдмал байх магадлалыг өсгөж байна.

"График IV.3."-т Монгол Улсад гэмт хэргийг шийдвэрлэж буй байдлыг 5 жилээр харуулсан байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн буюу эрүүгийн хэрэг үүссэн хэрэг маргаан, түүнд холбогдсон хүмүүсийн 21 орчим хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж байна. Энэ тоог цагдаагийн байгууллагад бүртгэсэн гомдол мэдээллийн тоотой харьцуулбал 7.4 хувийг эзэлж байна.

График IV.3. Монгол Улсад гэмт хэргийг шийдвэрлэж буй байдлын зураглал



Нуугдмал гэмт хэргийг судалснаар гэмт хэрэг үйлдэгчдийн зүгээс үзүүлж буй сөрөг үйл ажиллагаатай тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой. Дээрх зорилгыг биелүүлэхэд дараах хэд хэдэн ажлыг санал болгож байна. Нуугдмал гэмт хэргийг тооцоолох субъектив аргачлал манай улсад төдийлөн сайн хөгжөөгүй, одоогоор хийгдсэн судалгаа байхгүйг харгалзан иргэдийн дунд санал асуулгын болон ярилцлагын аргаар тогтмол хугацаанд асуулга явуулж хэвших, нийт улсын болон нутаг дэвсгэрийн хэмжээний нуугдмал гэмт хэргийн индекс тогтоон ашиглаж хэвших, гэмт хэргийн тоон мэдээнд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон тоог нэгтгэн гаргаж байх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албан ёсны төсөл хөтөлбөрийн хүрээнд нуугдмал гэмт хэргийн талаар судалгаа явуулах эрх зүйн болон эдийн засгийн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Дээрх арга хэмжээнүүд нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр ач тусаа өгөх боломжтой бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, хүний үндсэн эрх, эрх чөлөөг сэргээх, хангах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэн чадваржуулахад чиглэгдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРОЛ СУДЛААЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

1. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ СУДЛАЛЫН ОНОЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ХАНДЛАГА

Эрдэмтэд, судлаач нар гэмт хэргийн хохирогчийн асуудлыг эртнээс анхаарч, тэдний сэтгэл санаа, зовлонг хуваалцаж ирсэн түүхтэй.

Хохирогчийн эрх зүйн байдлын тухай үзэл санаа нь эхлээд утга зохиол, шүүхийн практик, дараа нь даатгалын нийгэмлэгүүдээс гэмт хэрэг, мөн золгүй үйлдлийн улмаас хохирсон этгээдийг илүү эрчимтэй судлах, танин мэдэх шаардлагын үүднээс судалж практик хэрэгцээ болон хөгжсөн байна.

Виктимологи гэсэн нэр томьёо нь "victima" (хохирогч) гэсэн латин үг, "logos" /сургаал/ гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд хохирогчийн тухай сургаал буюу "хохирогч судлал" гэсэн утгыг илэрхийлнэ.

Виктимологийн хөгжлийн эхэн үед энэ шинжлэх ухааны анхдагчдийн нэг Б.Мендельсон (1900-1990) виктимологийн шинжлэх ухааныг бие даасан шинжлэх ухаан болгон хөгжүүлэх тухай асуудал дэвшүүлж байсан бол, Х.Гентиг (1888-1974) түүнийг криминологийн нэг чиглэл хэмээн авч үзэж байжээ.

Виктимологийн шинжлэх ухаан нь XX зууны дунд үе 1970-аад оноос эхлэн АНУ, Герман, Финлянд, Япон, Канад, Швейцарт эрчимтэй хөгжиж эхэлсэн

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/34 дүгээр шийдвэрээр "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал" батлагдсан нь дэлхийн улс орнуудад виктимологийн шинжлэх ухаан хөгжих эрх зүйн гол үндэслэл болсон.

Дэлхийн улс орнууд хохирогчийг хамгаалах үзэл санааг амьдралд хэрэгжүүлээд хагас зуун жил болжээ. Харин манай улсын хувьд энэ асуудалд анхаарлаа хандуулан урьдчилан сэргийлэх тогтолцоогоо эргэн харах шаардлага тулгараад байна.

АНУ, Герман, Японд виктимологийн шинжлэх ухаан тодорхой хөгжлийг олж байгаа бөгөөд сэтгэл зүйн болон хүмүүжлийн ажлын тусгай лаборатори бүхий Хууль зүйн шинжилгээ судалгааны болон Цагдаагийн шинжлэх ухааны институтиудад виктимологийн судалгаа шинжилгээний ажлуудыг хийж, хохирогч бие хүн, тэдгээрийн зан үйл, тэдэнд үүссэн хохирол, эрх зүй зөрчигч ба хохирогчийн харилцаа холбооны хэлбэрүүдийг судалж байна. Тодорхой үе шаттайгаар олон улсын семинар, симпозиум, конгресс зохион байгуулагдаж, гэмт хэргийн хохирогчийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт, тэдэнд үзүүлэх тусламжийн талаар хууль тогтоомжийг улам боловсронгуй болгож байна.

Манай улсын эрдэмтэн судлаачид онолын болон практикийн зарим нэгэн туршлага хуримтлуулсан бөгөөд виктимологийн үзэл баримтлалын талаар зарим бүтээл бичиж, гэмт хэргийн хохирогч-бие хүн, тэдний зан үйлийн талаар судалгаа хийж байна. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд "Эрүүгийн хуулийн хамгаалах чиг үүрэг бүхий зорилт нь бүхэлдээ хохирогчийн эрх ашгийг хамгаалах, сэргээх, үүний тулд гэмт этгээдийн эрхийн эсрэг чиглэлтэй байдгийг хууль тогтоох болон хэрэглэх явцад онцгой анхаарах учиртай" гэжээ.

Гэмт хэргийн хохирогчийн тулгамдсан асуудлыг криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процесс, криминалистик, шүүхийн сэтгэл зүйн салбарын эрдэмтэд судалж байна. Аргагүй хамгаалалт, "хохирогчийн гэм буруу"-гийн асуудлаарх бүтээлүүдэд хувь хүн, тэдний зан үйлийн талаар ихээхэн анхаарал хандуулж байна. Хууль зүйн ухааны доктор, профессор Н.Жанцан "Криминологийн ухаанд виктимологи буюу хохирогч судлалын асуудал өөрийн тодорхой байр суурийг эзэлсээр ирсэн. Гэмт хэргийн хохирлын асуудлыг криминологийн төдийгүй эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинжлэх ухаан ч өөрийн чиглэлээр судалдаг" гэжээ. Түүнээс гадна гэмт хэргийн хохирогчдыг дэмжих холбоо, хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагууд байгуулагдаж байна.

Криминологийн виктимологийн чиглэлийн хүрээнд гадаад дотоодын эрдэмтдийн явуулж байгаа судалгаа, шинжилгээнээс үзэхэд эрх зүйн зөрчилд хохирогчийн гүйцэтгэх үүргийг нарийн тооцохгүйгээр гэмт хэрэгт нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг бүрэн дүүрэн ойлгох боломжгүй гэдгийг харуулж байна.

Зарим улс оронд виктимологийн асуудлуудыг судлах тусгай институт (Япон), эсхүл виктимологийн клиник, алба (АНУ) байгуулагдан ажиллаж байна.

Виктимологийн асуудлаар 1973 оноос эхлэн олон улсын бага хурал, зөвлөгөөн, ярилцлага зохиогдох болсон бөгөөд тухайлбал, 1973 онд (Иерусалим, Израйль), 1975 онд (Белладжо, Итали), 1976 онд (Бостон, АНУ), 1979 онд (Мюнстер, ХБНГУ), 1980 онд (Вашингтон, АНУ); 1982 онд (Токио, Япон), 1989 онд (Загреб, Югослав) 2000 онд тус тус зохиогджээ.

Мюнстер хотод 1979 онд болсон III симпозиумын үед НҮБ-ын ивээл дор Дэлхийн виктимологийн нийгэмлэг (World Society of Victimology) байгуулагдсан. Энэ нийгэмлэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх виктимологийн арга хэмжээг боловсруулах талаар олон улсын эрдэмтдийн үйл ажиллагааг зохицуулах зорилготой. Гэмт хэргийн хохирогч судлал *"виктимологи"* нь агуулгын хувьд эрүүгийн эрх зүйн онолын шинжлэх ухааны хүрээнд бодитойгоор оршоод зогсохгүй, идэвхтэй хөгжиж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Виктимологийн тухай үзэл санаа, түүний үзэл баримтлалын үндэс нь эхлээд гэмт үзэгдэл, гэмт хэргийн фактологи дээр суурилсан эх сурвалжтай.

Гэмт хэргийн виктимологи нь эрүүгийн ерөнхий онол, виктимологийн ерөнхий онол, социологийн ерөнхий онолын гүн ухааны үзэл, арга зүйд тулгуурлан суурилах боловч эрүүгийн эрх зүй, криминологи, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, эрүүгийн социологи, криминалистикийн зэрэг дунд түвшингийн тусгай шинжлэх ухааны хохирогчийн тухай мэдлэг, мэдээлэлд тулгуурлан хөгжиж байгаа салбар дундын шинжлэх ухаан юм.

Виктимологи нь гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэгт хохирох эрсдэл, түүний гэмт хэрэгт өртөмтгий чанар, гэмт хэрэгт хохирох учир шалтгаан, нөхцөл, тодорхой гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх тухай криминологийн шинжлэх ухааны нэг институц мөн.

2. СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРОЛ УЧИРСАН БАЙДАЛ

Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаанд гэмт хэрэгт хохирох үйл явц, түүний улмаас үүсэх үр дагаврыг нэгтгэсэн "хохирох үзэгдэл" буюу "victimization" гэсэн нэр томьёо ойлголтоор авч үзнэ.

Хохирох үзэгдлийг судлахын гол ач холбогдол нь статистик шинжилгээ судалгааны үндсэн дээр виктимологийн тоймыг бэлтгэх, гэмт халдлагын хохирогч болон хувирах үйл явц, үр дүнд шинжилгээ хийж, хохирох явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахад чиглэнэ.

Хохирох үзэгдэл (виктимизаци) нь аливаа этгээдээс хохирогч болон хувирах үйл явц, ганцаарчилсан буюу хамт олны түвшинд илэрч байгаа түүний үр дүн мөн. Ийм учраас хохирох явдлыг хоёр үндсэн хандлагаар авч үзнэ. Тухайлбал, тодорхой бодгаль этгээдийн хохирох үзэгдлийг судлахад тухайн гэмт хэрэгт хохироход нөлөөлсөн хувийн болон зан үйлийн эрсдэлийн түвшинд нь судална. Энэхүү судалгааг гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээг боловсруулахад хэрэглэнэ.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүн таслах ажиллагааны практикаас харахад зарим "төрлийн" хүмүүс гэмт хэрэгт илүүтэй өртөмтгий байдаг. Энэхүү "заяа төөрөг, хувь тавилан" гэмээр энэ байдалд:

- гэм буруутай ба гэм бурууг үй зан үйл;
- хувийн, нийгмийн болон мэргэжлийн эсхүл өөр бусад бүлгийн хамаарал зэрэг нөлөөлж болно.

Тийм ч учраас амь нас хохирох, гэмтэх, эсхүл дээрэмдэх халдлагын аюулд архичид, биеэ үнэлэгчид эсхүл биеэ барих чадваргүй, бүдүүлэг хэрцгий хүмүүс илүү өртөмтгий байдаг онцлогтой.


Гэмт хэрэгт хохирох явдлын судалгааг хамт олны түвшинд хийхдээ ялангуяа Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байдлаар улсын хэмжээнд 2007 оноос 2016 онуудад буюу сүүлийн 10 жилд гэмт хэргийн улмаас нийт 227 126 иргэн, 4 024 байгууллага хохирчээ.

Хүснэгт V.1.

д/д	Он	Нийт хохирогч иргэн	Эмэгтэй	Нас			
				18 хүртэлх	18-30 нас	31-35 нас	36-аас дээш
1	**2007**	19931	6115	1151	6721	2865	9194
2	**2008**	20256	6175	1080	7151	2953	9072
3	**2009**	19545	6312	1045	6528	2952	9020
4	**2010**	19381	7097	1066	6237	2868	9210
5	**2011**	18592	6856	1178	6484	2632	8298
6	**2012**	21294	7977	1270	7361	3179	9484
7	**2013**	25015	9838	1426	8389	3927	11273
8	**2014**	27475	10902	1576	9305	4115	12479
9	**2015**	27948	11207	1477	9079	4449	12943
10	**2016**	27689	11346	1340	8754	4552	13043
	Дүн	**227126**	**83825**	**12609**	**76009**	**34492**	**104016**

Сүүлийн 10 жилд гэмт хэрэг үйлдсэн нийт хүний 42% нь 18-35 насны залуучууд байсан бол гэмт хэрэгт хохирсон иргэдийн 48% нь тухайн насны хүн байна. Харин 45.8 хувь нь 36-аас дээш насны хүмүүс байна.

График V.1.



Гэмт хэрэгт хохирсон хүний насны бүтцийг 2007-2016 оны үзүүлэлтээс харахад 18-30 насны залуучууд гэмт хэрэг өртөх эрсэл өндөр байгааг харуулж байна. 2016 оны судалгаагаар улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.1%-ийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

График V.2.



Залуу болон дунд насны хүмүүсийн гэмт хэрэгт өртөгдөх эрсдэл, магадлал илүү байгаа нь тэдний өөр хоорондын харилцаанд байдаг шинжүүд болох эмзэг, түрэмгий, хэрцгий байдлуудаас гадна тэднийг гэмт хэрэгт их хэмжээгээр уруу татах зэргээс хамаарч байна.

2007-2016 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 83 825 буюу 36.9%-ийг эмэгтэйчүүд, 6%-ийг хүүхэд эзэлж байна.

Гэмт хэрэгт хохирсон хүүхэд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг ажиглахад эмэгтэйчүүд хохирох үзэгдэл 2007 оноос 2011 он хүртэлх хугацаанд харьцангуй тогтвортой байснаа 2012

оноос 2016 он хүртэл хугацаанд байнга өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь 2012 оноос эхэлсэн эдийн засгийн хямралтай холбоотой байх магадлал өндөр байна. Жирийн гэмт хэргүүдтэй харьцуулбал эмэгтэйчүүд илүү эмзэг, тэгш бус нөхцөлд байдаг учраас тэр болгон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар туйлбартай явж хэргээ эцэст хүртэл шийдүүлж чаддаггүй. Эдийн засгийн, цаг хугацааны, аж ахуйн хувьд боломж бололцоо муу байдаг.

График V.2.



Цагдаагийн байгууллагын гаргасан судалгаанаас харахад 2010 онд 284, 2011 онд 420, 2012 онд 534 эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж цагдаагийн байгууллагад хандсан байна. Үүний цаана мэдэгдээгүй хэдэн эмэгтэй хүчирхийлэл, дарамт дор амьдарч байгаа нь тодорхойгүй. Далд үйлдэгддэг энэ төрлийн гэмт хэрэг нийгмийн бүхий л давхаргын гэр бүлд гардаг ч хохирогчид тэр бүр цагдаагийн байгууллагад ханддаггүй. Харин хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг ТББ-д хандан тусламж, хамгаалалт хүсдэг байна. Жишээ нь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон эмэгтэйчүүд 2012 онд 434, 2013 онд 319 байсан бол 2014 онд 1106, 2015 онд 1307, 2016 онд 1356 болж өсчээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийг 2012 онтой харьцуулахад 2016 онд 3 дахин өсчээ. Энэ нь эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдэл, ядуурал, гэр бүл салж сарних, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тооны өсөлтөөс ихээхэн хамаарч байна.

Бүртгэлтэй нийт ажилгүй иргэд 2016 онд өмнөх оны мөн үеэс 1.6 (5.0%) мянган хүнээр, өмнөх сараас 1.0 (3.0%) мянган хүнээр өсч 34.4 мянга болсон бөгөөд эдгээрийн 17.8 (51.7%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Өрх толгойлсон эхчүүдийн 45.3 (58.3%) мянга нь 3 хүртэлх, 25.9 мянга (33.4%) нь 3-5 хүртэлх, 6.5 (8.3%) мянга нь 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байна.

2007-2016 онд буюу сүүлийн 10 жилийн хугацаанд шүүхээр Гэр бүлийн тухай хуулиар хянан шийдвэрлэсэн хэргийн 75,1% буюу 31 697 хэрэг гэрлэлт цуцлуулах, 12,2% буюу 5162 хэрэг хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 9,1% буюу 3824 хэрэг эцэг тогтоолгох, 0,3% буюу 129 хэрэг эцэг эх байх эрх хасуулах, 0,4% буюу 185 хэрэг гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцуулах, 2,8% буюу 1185 хэрэг гэр бүлийн бусад маргаан эзэлж байна.

2016 онд хянан шийдвэрлэсэн гэрлэлт цуцлуулах маргааныг 2007 онтой харьцуулахад 401 хэргээр буюу 15,5% өссөн байна.

Социологийн зарим судалгаанаас үзэхэд гэр бүл цуцлалтын шалтгааны 54.0% нь итгэл алдарсан, 47.3% санхүүгийн бэрхшээлтэй, 41.3% нь гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг гэсэн байгаа ба гэрлэлтээ цуцлуулсан өрхийн 70.0% нь 0-15 насны хүүхэдтэй байна.

Өнчин хүүхэд улсын хэмжээнд 2016 онд 37.2 мянга, үүнээс 3.5 мянга (9.5%) нь бүтэн өнчин хүүхэд, 33.7 мянга (90.5%) нь хагас өнчин хүүхэд байна. Өмнөх оноос бүтэн өнчин хүүхэд 2016 онд 304 (7.9%)-өөр, хагас өнчин хүүхэд 380 (1.1 %)-аар буурчээ. Нийт өнчин хүүхдийн 3.8 (10.3%) мянга нь 0-4 насны, 8.5 (22.8%) мянга нь 5-9 насны, 12.0 (32.3%) мянга нь 10-14 насны, 4.5 (12.0%) мянга нь 15 насны, 4.2 (11.4 %) мянга нь 16 насны, 4.2 (11.2%) мянга нь 17 насны хүүхэд байна.

Эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхэд 2016 онд 14, байгалийн гамшигт өртсөн хүүхэд 68, амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд 28, садар самуун, хүчирхийлэлд өртсөн хүүхэд 165, зам тээврийн осолд өртсөн хүүхэд 313, ахуйн осолд өртсөн хүүхэд 304 байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэрэгт: оюутан 9916, ЕБС-ийн сурагч 8790, сургууль завсардсан хүүхэд 166 хохирчээ. Судалгаанаас үзэхэд гэр бүлийн доторх хүчирхийллийн гуравны хоёр нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл эзэлж байна. Гэр бүлийн хүрээн дэх хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүүхэд эцэг эхээсээ айх, хэнээс тусламж эрэхээ мэдэхгүй байх зэргээс хамаарч ихэвчлэн нууцлагдмал, далд хэлбэртэй байна. Ийм учраас Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн эцэг эх, төрөл төрөгсөд, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хариуцлагыг нэмэгдүүлсэн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Орчин үеийн байцаан шийтгэх ажиллагааны тогтолцоо нь насанд хүрэгчдэд зориулагдсан гэж хэлж болно. Энэ нь үндсэндээ НҮБ-ын Бээжингийн дүрэмд заасан: "насанд хүрээгүй хүний байцаан шийтгэх ажиллагааны тогтолцоо нь тэдгээрийн эрх ашгийг хангахад чиглэх ёстой" гэсэн үндэслэлийг зөрчиж байна.

Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах хамгийн сайн арга бол насанд хүрээгүй хүүхэд оролцож байгаа иргэний, эрүүгийн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх *ювиналь* буюу насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн тогтолцоог бий болгох хэрэгтэй.

Хүснэгт V.1.

№	Он	Нийт хохирогч иргэн	Нийгмийн байдал							
			ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин	төрийн албан хаагч	оюутан	сурагч	сургууль завсардсан хүүхэд	тэнэмэл	хоригдол	ажилгүй
1	**2007**	19931	9422	1741	722	801	28	36	9	7172
2	**2008**	20256	11356	2242	626	660	24	30	15	5303
3	**2009**	19545	10757	1594	805	682	15	19	19	5654
4	**2010**	19381	8573	1416	970	854	17	32	27	7492
5	**2011**	18592	8556	1189	850	783	9	20	17	7168
6	**2012**	21294	10229	1795	974	865	13	27	50	7341
7	**2013**	25015	12681	2087	1210	974	13	29	58	7963
8	**2014**	27475	14239	2409	1357	1108	8	35	60	8259
9	**2015**	27948	14582	2452	1285	1067	20	36	62	8444
10	**2016**	27689	14114	2265	1117	996	19	31	66	9081
	Дүн	**227126**	**114509**	**19190**	**9916**	**8790**	**166**	**295**	**383**	**73877**

2007-2016 онд хохирогч иргэдийн 50 орчим хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, ажилтнууд, харин 33%-ийг ажилгүй иргэд эзэлж байна. Ажилгүйдэл, ядуурал ба тогтмол орлогогүй зэрэг нь хохирох явдлын байнгын дагавар болж байна. Мөн зарим хувийн хэвшлийн ажилтнуудын (бизнесмен, ажил хэрэгч хүмүүс, компанийн захирал гэх мэт) тоо нэмэгдэж, чинээлэг болохын хэрээр дээрэмдэх, далайлган сүрдүүлэх, авлигын гэмт хэргийн хохирогч болох эрсдэл нэмэгдэж байна.

Хүснэгт V.2.

№	Он	Нийт хохирогч байгууллага	Байгууллагын төрөл			Өмчийн төрөл				
			Төрийн	Төрийн бус	Хувийн	Төрийн	Гадаадын хөрөнгө оруулалттай	Хамтарсан	Орон нутгийн	Хувийн
1	**2007**	975	456	73	446	322	45	479		129
2	**2008**	1044	490	58	396	417	48	452		127
3	**2009**	824	468	49	307	418	50	268		88
4	**2010**	358	234	50	74	260		11		87
5	**2011**	184	128	14	42	129			7	48
6	**2012**	167	88	24	55	94			9	64
7	**2013**	157	99	10	48	103			7	46
8	**2014**	118	67	11	40	69			8	41
9	**2015**	113	49	10	54	45			7	61
10	**2016**	84	42	8	34	44			3	37
	Дүн	**4024**	**2121**	**407**	**1496**	**1901**	**143**	**1210**	**41**	**728**

Мөн гэмт хэргийн эдийн засгийн хүрээ улам өргөжиж, гэмт бүлэглэл, байгууллагын тоо нэмэгдэж, хээл хахууль авлигал өгөх, авах, гэмт хэрэгт мэргэших, зохион байгуулалтад орох хандлага нэмэгдэж байна.

График V.3.



Сүүлийн 10 жилд гадаадын 1567 иргэн гэмт халдлагад өртөж хохирсон ба жилд дунджаар 156 гадаадын иргэн гэмт хэрэгт өртөж хохирсон байна.

Хүснэгт V.3.

№	Он	Нийт хохирогч иргэн	Гэмт халдлагад өртсөн гадаадын иргэн						Нийт гадаадын иргэн
			БНХАУ	ОХУ	БНСУ	Япон	АНУ	Бусад	
1	**2007**	19931	83	38	32			46	199
2	**2008**	20256	94	26	41			50	211
3	**2009**	19545	55	14	26	11	8	35	149
4	**2010**	19381	60	25	10	5	4	29	133
5	**2011**	18592	44	13	17	7	4	26	111
6	**2012**	21294	51	15	17	3	9	26	121
7	**2013**	25015	49	12	21	4	6	34	126
8	**2014**	27475	81	15	37	2	6	35	176
9	**2015**	27948	90	19	29	3	11	41	193
10	**2016**	27689	64	13	24	4	6	37	148
	Дүн	**227126**	**671**	**190**	**254**	**39**	**54**	**359**	**1567**

График V.4.



Гэмт халдлагад өртсөн гадаадын иргэдийн 43%-ийг БНХАУ-ын, 16%-ийг БНСУ-ын, 12%-ийг ОХУ-ын, 3%-ийг АНУ-ын, 3%-ийг Япон улсын иргэд тус тус эзэлж байна.


Хүснэгт V.4.

№	Он	Нийт хохирогч иргэн	Гэмт халдлагад өртсөн шалтгаан нөхцөл		
			Хохирогчийн буруугаас	Архидан согтуурсаны улмаас	Гэр бүлийн хүчирхийлэлд автсан
1	**2007**	19931	2304	-	-
2	**2008**	20256	2281	-	238
3	**2009**	19545	2284	-	219
4	**2010**	19381	832	396	329
5	**2011**	18592	588	302	408

6	**2012**	21294	603	441	433
7	**2013**	25015	365	371	319
8	**2014**	27475	293	372	1106
9	**2015**	27948	317	315	1307
0	**2016**	27689	256	369	1356
	Дүн	**227126**	**10123**	**2566**	**5715**

Сүүлийн 10 жилд гэмт халдлагад өртсөн шалтгаан нөхцөлийн хувьд нийт хохирогчийн 1.1% буюу 2566 нь архидан согтуурсны улмаас, 4.5% буюу 10123 нь хохирогчийн буруугаас, 2.5% буюу 5715 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон байна.

График V.5.



Гэмт халдлагын шалтгаан нөхцөлийн 2016 оны тоон үзүүлэлтийг 2010 онтой харьцуулан үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчын тоо 1027 буюу 3.1 дахин өссөн бол архидан согтуурсаны улмаас хохирсон хохирогч нь 27 буюу 6.8%, хохирогчийн буруутай үйлдлийн улмаас хохирсон хохирогчид нь 576 буюу 69.2%-аар тус тус буурсан байна.

3. СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

a. Эд хөрөнгийн хохирол:

График V.6.



Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд гэмт хэргийн улмаас 870.542.700.000 (870 миллиард 542 сая 7 зуун мянга) төгрөгийн хохирол учирснаас 334.771.700.000 (334 миллиард 771 сая 7 зуун мянга) төгрөг буюу 38.5%-ийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн хохирол, нөхөн төлүүлсэн хохирлын хөдөлгөөнийг ажиглахад нийт хохирол 2007 оноос 2011 он хүртэлх хугацаанд харьцангуй тогтвортой байснаа 2012 оноос 2016 он хүртэл хугацаанд байнга өссөн бол нөхөн төлүүлсэн хохирол нь 2012 оноос 2013 онд 4.4 дахин өсч 2014 онд 2.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

b. Нас баралт

Улсын хэмжээнд 2007 оноос 2016 онд гэмт хэргийн улмаас 11 274 хүн нас барсан нь нийт хохирогчын 5.0%-ийг эзэлж байна.


Хүснэгт V.5.

№	Он	Нийт хохирогч ирсэн	Нас барсан хүн	Үүнээс					Хүйс, нас				
				91-93	94	95	215-225	Бусад	Эмэгтэй	18 хүртэлх	18-30	31-35	36-аас дээш
1	2007	19931	1597	283	13	889	344	68	318	86	417	172	922
2	2008	20256	1551	198	22	919	313	99	300	145	423	161	822
3	2009	19545	1358	205	17	739	317	80	337	117	281	170	790
4	2010	19381	1191	186	15	590	325	75	332	86	247	173	685
5	2011	18592	922	238	19	225	363	77	233	77	201	116	528
6	2012	21294	901	199	9	231	369	93	231	80	213	116	492
7	2013	25015	949	163	18	253	424	91	239	74	198	122	555

8	2014	27475	1078	207	26	245	503	97	270	101	249	112	616
9	2015	27948	847	185	32	123	429	78	228	100	179	97	471
10	2016	27689	880	177	22	203	399	79	246	112	184	106	478
	Дүн	227126	11274	2041	193	4417	3786	837	2734	978	2592	1345	6359

2007 онд гэмт хэргийн улмаас 1597 хүний амь нас хохирч байсан бол 2016 онд энэ тоо 880 болж 717 буюу 44.9% буурчээ.

График V.7.



Сүүлийн 10 жилийн байдлаар нас барсан хохирогчдын гэмт халдлагад өртсөн байдлыг хэргийн өнгөөр авч үзвэл хамгийн их буюу 39% нь бусдыг амиа хорлоход хүргэх, 34% нь ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, 18% нь хүнийг санаатай алах, эх нь нярай хүүхдээ алах, санаа сэтгэл нь хүчтэй цочирон давчидсан үед бусдыг санаатай алах, 2% нь бусдыг болгоомжгүй алах, 7% нь бусад гэмт хэргийн улмаас амь нас нь хохирсон байна.

График V.8.



Судалгаат хугацааны үед гэмт хэргийн улмаас амь нас хохирсон нийт иргэдийг насны ангиллаар авч үзвэл 8.7%-ийг 18 хүртэлх насны хүүхэд, 23.0%-ийг 18-30 насны иргэд, 11.9%-ийг 31-35 насныхан, 56.4%-ийг 36-аас дээш насны иргэд тус тус эзэлж байна. Түүнчлэн, нийт нас барсан хохирогчдын 24.3%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

График V.9.

НИЙТ ХОХИРОГЧ ИРГЭН БОЛОН НАС БАРСАН, ГЭМТСЭН ХОХИРОГЧДЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ (2007-2016 ОН)



Дээрх тоон үзүүлэлтээс харахад 18 хүртэлх насны хохирогчдын тоо 2007 онд 86 байсан бол 2016 онд 112 болж 30.2% өссөн, 18-30 насныхан 233 буюу 55.9%, 31-35 насныхан 66 буюу 38.4%, 36-аас дээш насныхан 444 буюу 48.1% тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон нийт иргэд болон нас барсан, гэмтсэн хохирогчдын хөдөлгөөнийг ажиглахад нийт хохирогч иргэд нь 2007 оноос 2011 он хүртэлх хугацаанд харьцангуй тогтвортой байснаа 2012 оноос 2016 он хүртэл хугацаанд байнга өссөн бол нас барсан хохирогчдын тоо 2007 оноос 2012 он хүртэл байнга буурч байгаад 2013, 2014 онд 5.3%-аас 13.6% өсч 2015 онд 21.4% буурсан үзүүлэлттэй байна.

Гэмтсэн иргэдийн хувьд 2008 онд 17.2% өсч 2009, 2010 онуудад буурч байгаад 2013 онд 16.1% өсч 2014-2016 онуудад тогтвортой үзүүлэлттэй байна.

с. Гэмтэл


Улсын хэмжээнд 2007 оноос 2016 онд гэмт хэргийн улмаас 963 092 хүн гэмтсэн нь нийт хохирогчдын 41.0%-ийг эзэлж байна.

Хүснэгт V.6.

Он	Гэмтсэн хүн	Үүнээс					Гэмтлийн зэрэг			Хүйс, нас				
		91-107	126	181	215-225	Бусад	Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Эмэгтэй	18 хүртэлх	18-30	31-35	36-аас дээш насны
2007	7759	4447	98	521	32	61	381	568	10	408	45	207	1125	782
2008	9096	5182	14	487	91	322	512	885	99	822	38	966	1361	131
2009	8593	5479	79	279	20	36	260	664	69	753	22	528	1277	166
2010	7486	4600	36	238	33	79	534	312	40	653	68	938	1126	854
2011	8100	4868	38	405	094	95	1079	375	46	894	101	423	1073	903
2012	8436	5371	8	291	078	98	529	278	29	041	08	460	1269	999
2013	9797	6288	05	459	282	63	574	446	77	583	21	812	1565	699
2014	11281	7561	10	413	460	37	728	643	10	272	17	345	1734	385
2015	11287	7712	92	1409	1382	692	8904	1555	828	4272	784	4230	1876	4397
2016	11257	7947	81	1267	1247	715	8870	1602	785	4289	715	4123	1945	4474
Дүн	**93092**	**59455**	**1351**	**13769**	**11219**	**7298**	**70371**	**15328**	**7393**	**32987**	**6919**	**37032**	**14351**	**34790**


2007 онд гэмт хэргийн улмаас 7759 иргэн эрүүл мэндээрээ хохирч байсан бол 2016 онд энэ тоо 11257 болж 3498 буюу 45.1%-аар өсчээ.

График V.10.



Сүүлийн 10 жилийн байдлаар гэмтсэн хохирогчдын гэмт халдлагад өртсөн байдлыг хэргийн өнгөөр авч үзвэл хамгийн их буюу 64 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 12% нь ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, 15% нь танхайрах гэмт хэрэг, 1% нь хүчиндэх гэмт хэрэг, 8% нь бусад гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон байна.

График V.11.



Гэмтлийн зэргийн хувьд нийт гэмтсэн хохирогчийн 76% буюу 70 371 иргэн хөнгөн, 16% буюу 15 328 иргэн хүндэвтэр, 8% буюу 7393 иргэн хүнд гэмтжээ.

График V.12.



Судалгаат хугацааны үед гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон нийт иргэдийг насны ангиллаар авч үзвэл 6919 буюу 7.4%-ийг 18 хүртэлх насны хүүхэд, 37 032 буюу 39.8%-ийг 18-30 насны иргэд, 14 351 буюу 15.4%-ийг 31-35 насныхан, 34 790 хүн буюу 37.4%-ийг 36-аас дээш насны иргэд тус тус эзэлж байна. Түүнчлэн, нийт эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн 35.4%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Монгол Улсын хүн ам 2016 оны эцэст урьдчилсан дүнгээр 3120.9 мянга болж, өмнөх оноос 63.2 (2.1%) мянган хүнээр өслөө. 2016 онд гэмт хэргийн улмаас 27 689 хүн хохирсон байдлаас үзэхэд хохирох эрсдлийн индекс нь 0,9% байна. Үүнээс үзэхэд 2017 онд 10 000 хүний 90 нь гэмт хэрэгт хохирох аюулын эрсдэлтэй байна.

2016 онд 104,478 ААН бүртгэгдсэнээс үйл ажиллагаа явуулж байгаа 46,153 байгууллага байна. ААН, бизнесийн 84 байгууллага гэмт хэргийн улмаас хохирсон нь хохирох эрсдэлийн индекс нь 1,8% байна. Иймд 2017 онд нийт ААН-ийн гэмт халдлагад хохирох аюулын эрсдэлийн коэффициент нь 1000 ААН-ийн 18 нь гэмт хэргийн халдлагад өртөх эрсдэлтэй байна.

4. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙГ ТООЦОЖ БУЙ ПРАКТИК

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохирлын үнэлгээг бодитой тогтоох, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх нь хууль зүйн болон нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн бөгөөд эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн хохирогчийн үндсэн эрхийн нэг бол учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх юм. Гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээ, түүнийг үнэлэх асуудал байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирлын төрөл, шинж чанар, хэмжээг тогтоож, түүнийг зөв үнэлснээр хохирогчийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдана.

Хохирол шаардсан хэргүүдээс гэмт хэргийн зүйлчлэл нь шууд нөлөөлдөг онцлогтой бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 80 гаруй зүйл, хэсэгт давхардсан тоогоор хохирлын хэмжээг шаардсан материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүд байна. Иймд хохирлын хэмжээг мөнгөн илэрхийллээр зөв тогтоох нь хэргийн зүйлчлэлд чухал байхаас гадна гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн хохирогчийн хохирлын хэмжээ үнэн зөв тогтоогдож, хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдах ач холбогдолтой юм.

Манай практикт гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоохдоо:

1. Шинжээчийн дүгнэлт (шүүх эмчийн, криминалистикийн, аудитын, нягтлан бодох бүртгэлийн гэх мэт),
2. Үнэлгээний комиссын тодорхойлолт;
3. Сум, багийн Засаг даргын тодорхойлолт;
4. Татвар, гааль, мэргэжлийн хяналтын байцаагч нарын акт;
5. Зардлын баримт;
6. Байгууллагын дансанд тусгагдсан үнэлгээ;
7. Даатгалын үнэлгээ зэргийг нотолгооны эх сурвалж болгож байна.

Гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын хэмжээг тогтоож буй байдлыг авч үзвэл:

Үнэлгээний комисс:

Эрүүгийн хэргийн материалаас судлан үзэхэд эд хөрөнгийн хохирлын хэмжээг ихэвчлэн аймаг, дүүргийн Засаг даргын дэргэдэх Үнэлгээний комисс тогтоодог бөгөөд комиссын бүрэлдэхүүн нь үндсэн ажил үүргийнхээ хажуугаар эд хөрөнгө үнэлэх ажлыг гүйцэтгэдэг, эд зүйл буюу хөрөнгө үнэлэх тусгай зөвшөөрөлгүй хүмүүсээс бүрдэж байна. Энэ нь эд хөрөнгийн хохирлын үнэлгээг бодитой, зөв хийж буй гэдэгт эргэлзээ төрүүлэхээс гадна хохирлын хэмжээг бодит бусаар тогтоох, хохирогчийн хохирол нөхөн төлүүлэх эрх зөрчигдөхөд хүргэж байна. Үүнээс гадна Үнэлгээний комисс гэх ойлголт, нэр томьёо ЭБШХ-д байхгүй, эрүүгийн хэрэгт эд хөрөнгийн хохирлын хэмжээг үнэлэх эрх хэмжээгүй этгээд байх бөгөөд эд хөрөнгийн хохирлын үнэлгээг ямар аргаар, юуг үндэслэж, хэрхэн үнэлж байгаа нь тодорхой бус байна. Эд хөрөнгийг үнэлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу бус, комиссын гишүүд өөрийн үзэмжээр үнэлгээ хийж, хохирогчийн үнийн саналыг ихэвчлэн бууруулж үнэлдэг, бууруулсан үндэслэлдээ тайлбар хийдэггүй байдал нь хохирогчийн хохирлоо үнэн зөв, бодитой нөхөн төлүүлэх эрх зөрчигдөхөд хүргэж байгаагаас гадна гэмт хэрэг үйлдэж буй хүмүүсийг эрүүгийн хариуцлагаас мултрах, ял завших нөхцөлийг бүрдүүлж байна.

Үнэлгээ хийх, эд хөрөнгөнд үнэ тогтоох ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл

авсан мэргэжлийн байгууллага, иргэд хийж байх нь бодит үнэ тогтоох нөхцөл бүрдэнэ. Иймд гэмт хэргийн халдлагад өртсөн эд хөрөнгөнд буюу гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн хохирлыг тогтоодог мэргэжлийн байгууллагыг байгуулан ажиллуулах шаардлагатай. Мөн татвар, гааль, мэргэжлийн хяналтын байцаагчийн акт, зардлын баримт, байгууллагын дансанд тусгагдсан үнэлгээ зэргийг эх сурвалж болгон эд хөрөнгийн хохирлын хэмжээг тооцож буй байдал нь хууль зүйн болон онолын хувьд оновчтой эсэхэд дүгнэлт хийж, хохирлыг тогтоох зүйлсийг хуульчлан тогтоох нь зүйтэй.

5. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

Хохирогч нь эрүүгийн хэрэг үүсгэхээс шүүхийн хэлэлцүүлэг эхлэх хүртэл хугацаанд гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлоо нөхөн төлүүлэх буюу сэргээлгэх, энэ талаар шаардлага тавих эрхтэй (ЭБШХ-ийн 42§,43§,115§). Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд хохирогч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ. Эрүүгийн хэрэгт холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхгүй. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

Хүснэгт V.7.

№	Он	Учирсан нийт хохирол (сая.төг)	Үүнээс:					Битүүмжилсэн хөрөнгө (сая.төг)	Нөхөн төлүүлсэн хохирол (сая.төг)
			Төрийн өмчид	Гадаадын хөрөнгө оруулалттай өмчид	Хамтарсан өмчид	Орон нуттийн	Хувийн өмчид		
1	2007	29464.3	10854.2	861.1	1994.3		15754.6	627.4	3978.0
2	2008	54802.3	10951.6	1234.6	19882.3		22733.7	1261.6	6974.7
3	2009	49186.2	13615.1	4661.3	5156.0		25753.8	4181.7	17964.9
4	2010	33383.0	8824.8			172.3	24385.8	27780.7	14347.2
5	2011	35904.1	10024.1			443.6	25436.4	3383.5	18490.4
6	2012	53263.2	9556.5			858.0	42848.7	3883.0	25135.6
7	2013	159024.2	78967.9			7149.4	72907.0	99801.9	111266.6
8	2014	148264.6	51520.1			2416.4	94328.1	11339.5	43652.5
9	2015	144341.4	8866.1			9124.0	126351.4	38855.9	48997.8
10	2016	162909.4	60512.7			2568.2	99828.6	17679.8	43964.0
	Дүн	870542.7	263693.1	6757.0	27032.6	22731.9	550328.1	208795.0	334771.7

Хохирогч нь гэмт хэргийн улмаас үүссэн эд хөрөнгийн хохирлыг нэхэмжлээд зогсохгүй, мөн бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх эрхтэй. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох явцад, эрх зүйн нэгэнт тогтсон уламжлалыг хадгалахын хэрээр нийгмийн эрх зүйн өндөр ухамсрын хүмүүжлийн нэг чухал баталгаа болсон хууль тогтоомжийн тогтвортой байдал хангагдана.

Иймд ЭБШХ тогтоомжийн маргаангүй сайн тал нь иргэний нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлж байсан явдал бөгөөд хохирогчийн эрхийн хамгаалалтын энэ чухал баталгаанаас Англи, Франц ба Германы ЭБША-нд зарим тодорхой хүрээний хэргүүдэд хохирогчоос хураамж төлөхөөс хамаарч эрүүгийн хэрэг үүсгэх эсэх нь хамаарна гэсэн үндэслэлээр татгалзах нь тийм ч зөв алхам биш.

Эрх зүй зөрчигч, түүний төлөө хариуцлага хүлээж байгаа этгээдээс хор уршиг арилгуулах эрхийн эд хөрөнгийн агуулга нь:

- Эд хөрөнгөө буцаан авах эрх;
- Үрэгдсэн эд хөрөнгөө нөхөн төлүүлэх эрх;
- Гэмт хэрэгт хохирох явдалд учирсан зардлыг нөхөн төлүүлэх эрх;
- Үйлчилгээ авах эрх (гэмт хэргийн улмаас гэмтсэн эрүүл мэнд, эд хөрөнгийн байдлаа нөхөн сэргээх);
- Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх;
- Сэтгэл санааны хохирлоо арилгуулах эрх зэргээс бүрдэнэ.

ЭБША дахь иргэний нэхэмжлэл нь иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө болон эд хөрөнгөтэй холбоотой үүссэн харилцаа буюу иргэний эрх зүйн зохицуулах зүйлд хамаарах учраас (иргэний болон хөдөлмөрийн маргаанаас үүссэн нэхэмжлэлийг хангах ажиллагааны журам адил учраас) энэ асуудлыг Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, зарим талаар Монгол Улсын олон улсын гэрээний журмыг баримтлах шаардлага гарна.

График V.13.



Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байдлаар улсын хэмжээнд сүүлийн 10 жилд гэмт хэргийн улмаас 870 тэрбум 542.7 сая төгрөгийн хохирол үүссэн бол нийт хохиролтой харьцуулахад 23.9% 208 тэрбум 795 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилжээ.

Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор битүүмжилсэн хохирлын хөдөлгөөнийг ажиглахад 2007 оноос 2010 он хүртэлх хугацаанд байнга өсөж 2013 онд хамгийн их буюу өмнөх оноос 25.7 дахин өссөн бол 2014 онд 8.8 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Шүүхээр тогтоосон хохирол

Сүүлийн 10 жилд **2007-2016** онд нийтдээ гэмт хэргийн улмаас 5559 хүн амь насаар хохирч, 24413 хүн хөнгөн, хүндэвтэр, хүндээр гэмтэж, **497** тэрбум **643.5** сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирчээ.

Хүснэгт V.8.


№	Он	Амь нас хохирсон	Гэмтсэн	Шүүхээр шийдвэрлэсэн эд хөрөнгийн хохирол (сая. төг)	Шүүхийн шатанд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн (сая. төг)
1	2007	539	2073	152033.3	1596.2
2	2008	534	2376	14927.6	9671.8
3	2009	483	2337	19440.5	1184.0
4	2010	535	1657	26312.8	1770.4
5	2011	589	1998	13854.6	1707.6
6	2012	654	2587	21982.1	2065.0
7	2013	555	2693	95896.9	850.9
8	2014	626	3016	78169.3	1483.1
9	2015	518	3028	59796.1	1348.7
10	2016	526	2648	15230.3	1150.9
	Дүн	5559	24413	497643.5	22828.5

Судалгаат хугацаанд шүүхийн шатанд тогтоогдсон **497** тэрбум **643.5** сая төгрөгийн эд хөрөнгийн хохирлын 4.6% буюу 22 тэрбум 828.5 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ



1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ

Монгол Улсын цагдаагийн байгууллага сүүлийн жилүүдэд бүтэц, зохион байгуулалтаа боловсронгуй болгоход анхаарч 2015, 2016 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог хоёр удаа шинэчлэн батлуулж:

ЦАГДААГИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА:

- Гэмт хэрэгтэй тэмцэх алба,
- Нийтийн хэв журам хамгаалах алба,
- Олон нийтийн аюулгүй байдлын хангах алба,

НУТАГ ДЭВСГЭР ХАРИУЦСАН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА:

- Хотын цагдаагийн газар,
- Аймгуудын цагдаагийн газар, хэлтэс,
- Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс,
- Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс гэсэн үндсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж иржээ.

Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд цагдаагийн байгууллагын үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах алба, Төв архивын газар, Сургалтын төв, Авто бааз, Сүүж-Уул сувилал, Хамгаалалтын хоёр, гуравдугаар газар, Улаанбаатар хотын цагдаагийн газар болон дүүрэг дэх цагдаагийн 16 хэлтэс, Багахангай дүүрэг дэх цагдаагийн тасаг, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хэнтий зэрэг 16 аймаг дахь цагдаагийн газрын орон тоонд тус тус өөрчлөлт оруулан зохион байгуулалтын бүтцийг баталж, Мэдээллийн технологи, холбооны газар, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрыг шинээр байгуулсан байна.

Цагдаагийн байгууллага 2016 онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн ардынхаа амар амгаланг хангах үүргээ зохих түвшинд хэрэгжүүлжээ.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА 2016 ОНД:

- Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах,
- Байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах,
- Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлэн ажилласан нь хүний нөөцийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага сахилга, зохион байгуулалт, манлайлан гүйцэтгэх түвшинг үндсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэхийн үндэс гэдэгт анхаарлаа төвлөрүүлсэн байна.

"Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах зорилгоор "Дотоод хяналт, аюулгүй байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө", "Цагдаагийн байгууллагын дотоод аудитын жилийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө", "Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын жилийн төлөвлөгөө", "Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө"-г тус тус гарган хэрэгжүүлсэн нь үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх, эрчимжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой болгох, гүйцэтгэлийг идэвхжүүлэхэд нөлөөлөхүйц бодлого болжээ.

Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль 109, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2, УИХ-ын тогтоол 2, Засгийн газрын тогтоол 36, Хууль зүйн сайдын дангаар болон хамтарсан тушаалаар батлсан эрх зүйн акт 48, ЦЕГ-ын тушаалаар батлсан гадагш чиглэсэн эрх зүйн акт 10 нийт 207 хууль, тогтоомжийг удирдлага болгон мөрдөж бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаад мониторинг, судалгаа хийж, хэрэгжилтийг бүрэн хангах талаар анхаарч хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн нь эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хүчин чармайлт гаргасны илрэл юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээ болох талаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд тодорхойлсон байдаг.

Дээрх байр сууриас цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнг авч үзвэл цагдаагийн байгууллагад тухайн тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд ашиглах боломжтой сүүлийн 9 жилийн хугацааны мэдээллийн цахим санг бүрдүүлсэн байна.

Тухайлбал:

- Дуудлага мэдээллийн сан;
- Гомдол, мэдээллийн сан;
- Өргөдөл гомдлын цахим зураглалын сан;
- Түүний шийдвэрлэлтийн мэдээллийн сан;
- Гэмт хэргийн мэдээллийн сан;
- Гэмт хэргийн цахим зураглалын сан;
- Яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн сан;
- Хэрэгсэхгүй болгох саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн сан;
- Түдгэлзүүлсэн хэргийн мэдээллийн сан;
- Сэргээсэн хэргийн мэдээллийн сан;
- Нөхөн илрүүлсэн хэргийн мэдээллийн сан;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунгасан хэргийн мэдээллийн сан;
- Шүүх, прокуророос нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан хэргийн мэдээллийн сан;
- Нэгтгэсэн хэргийн мэдээллийн сан;
- Зүйлчлэл өөрчлөгдсөн мэдээллийн сан;
- Харьяаллын дагуу шилжүүлсэн хэргийн мэдээллийн сан;
- Сэжигтний мэдээллийн сан;
- Яллагдагчийн мэдээллийн сан;
- Таслан сэргийлэх арга хэмжээ авсан мэдээллийн сан;
- Хохирогч иргэн, байгууллагын мэдээллийн сан;
- Хохирлын мэдээллийн сан;
- Хохирол нөхөн төлүүлэлтийн мэдээллийн сан;
- Хөрөнгө битүүмжилсэн мэдээллийн сан;

ТУСЛАХ ТОО БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД:

- Захиргааны зөрчлийн мэдээллийн сан;
- Саатуулагдсан хүний мэдээллийн сан;
- Захиргааны шийтгэл оногдуулсан мэдээллийн сан;

- Захиргааны хяналтад байгаа хүний мэдээллийн сан;
- Албадан саатуулсан мэдээллийн сан;
- Түр саатуулсан мэдээллийн сан;
- Албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан иргэний мэдээллийн сан;
- Захиргааны зөрчлийн улмаас хохирсон хүний мэдээллийн сан;

ЗӨВШӨӨРӨЛ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Эрэн сурвалжлалтын мэдээллийн сан /ASAP/;
- Ял шийтгэлийн мэдээллийн сан;
- Судалгаа хяналтын сан;
- Галт зэвсгийн мэдээллийн сан;
- ГХХ-ын байгууллагын бүртгэлийн зэрэг санг холбогдох мэдээлэлээр баяжуулж, түүнийг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шууд ба шууд бус хэлбэрээр ашиглах болсон нь томоохон дэвшил болжээ.

Цагдаагийн байгууллагаас сүүлийн үед анхаарал татаж байгаа шинэ төрлийн гэгдэх хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, хүний болон зэвсгийн наймаа зэрэг тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх асуудлаар мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, гадаад улсын туршлага судлах, үйл ажиллагааг сайжруулах, түүний үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг судлах, арилгах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж эхлээд байна.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 54 албан хаагчдыг гадаадын цагдаагийн байгууллагад зохион байгуулагдсан сургалт, хөтөлбөрт хамруулан сургажээ.

Үүнд:

- ХБНГУ-д "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр", "Терроризм ба аюулгүй байдлын судалгаа";
- АНУ-д "Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь хөтөлбөр", БНСУ-д "Хамгаалалтын төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт", "Хямралын үеийн менежмент", "Аюулгүй байдлын гүнзгийрүүлсэн шатны сургалт", "Хар тамхи, мансууруулах бодист донтогчдын эмчилгээ, судалгаа" олон улсын 5-р хурал;
- Тайвань Улсад "Цагдаагийн удирдлагын менежмент ба манлайлал" сургалт;
- АБНЕУ-д "Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх" сургалт, "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх нь" сэдэвт сургалт;
- БНСУ-д "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон хими биологийн хорт бодисыг илрүүлэх, аюулгүй болгох", "Цахим гэмт хэрэг" сургалт;
- БНХАУ-д "Ахлах болон дунд түвшний удирдах албан тушаалтнуудын сургалт", "Хар тамхитай тэмцэх" сургалт;
- Тайланд Улсад "Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх" олон улсын сургалт;
- Шинэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, түүний үйлдэгдэж болох нөхцөл байдал, газар орон, хамрагдаж болох хүрээ, татагдан орж болох субъектуудыг судлах, хараа хяналтдаа авах, гэмт санаа бодлоос нь татгалзуулах, сэрэмжлүүлэх талаар бэлтгэлтэй, чадваржсан байхад багагүй анхаарч ажилласан нь сайшаалтай байна.
- Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдийг илрүүлэх, бүртгэх, хяналтад авах зорилгоор "Бүртгэл-2016" нэгдсэн арга хэмжээг 6 сарын хугацаатайгаар улсын хэмжээнд зохион байгуулж, шинээр 546 этгээдийг бүртгэл судалгаанд авсан.

- ХЗДХЯам, ЭМСЯам, Гааль, татварын ерөнхий газар, Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, СЭМҮТ, "Цагаан соён" төрийн бус байгууллагатай хамтран Дорноговь аймгийн Замын-Үүд суманд "Мансууралгүй ирээдүй" сэдэвт өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, уг арга хэмжээний талаар МҮОНРТ-ээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн.
- ХЗДХЯ, "Цагаан соён" ТББ-тай хамтран "Мансууралгүй ирээдүй" аяныг 45 хоногийн хугацаатай зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус 12 байгууллагын 850 ажилтанд 36 цагийн, 6 их дээд сургуулийн 1680 оюутан, ерөнхий боловсролын 7 сургуулийн 910 сурагч, 270 эцэг эх, асран хүмүүжүүлэгчид нийт 39 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.
- Мөн Монгол Улс дахь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн гадаад, дотоод нөхцөл байдал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх түвшинд хүрсэн эсэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй арга барил, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаарх танилцуулгыг боловсруулж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.
- Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлт бүлэгт багтах хүмүүсийн судалгааг хийж, "Хүн худалдаалах цахим санд" хохирогч, холбогдогч нарын нийт 43 иргэнийг бүртгэж, гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдсон Монгол Улсын 10 иргэний ар гэрийг олж тогтоон мэдэгдэж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, тухайн улсдаа эрх ашиг нь зөрчигдсөн, тусламж хүссэн 3 иргэнийг БНСУ, БНХАУ-аас аюулгүй авчрах ажлыг ХЗДХЯам болон ГХЯамны Консулын газартай хамтран зохион байгууллаа.
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй алба хаагчдын нэгдсэн удирдлагаар хангах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах зорилгоор цагдаагийн фэйсбүүк (www.facebook.com/policemng) хуудсанд "CYBER DIVISION" нэртэй нууц группийг үүсгэж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс ирүүлсэн мэдээллийг солилцох, зөвлөгөө, зааварчилга өгөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.
- "Мааз" студитэй хамтран цахим (шуудангийн луйвар, интернет залилан, секс сүрдүүлгийн зэрэг) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 4 ширхэг дүрс бичлэгийг Монгол хэлнээ хөрвүүлэн "Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба" нэртэй фэйсбүүк хуудсанд байршуулан олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж, оюуны өмчийн зөрчилтэй 5 цахим хуудасны эрхийг хязгаарлах хүсэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд тавьж хандалтыг зогсоосон.
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газартай "Террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, улсын хил нэвтрэх зорчигчдод хяналт тавих" зорилгоор "Мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ"-г Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газартай байгуулж, дээрх ажлын хүрээнд хилийн боомтоор нэвтрэгчдийн бүртгэл, хяналтын мэдээллийн шинэ ISM системийг "Асап" сантай холбохоор зөвшилцөлд хүрсэн нь үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, болзошгүй халдлагаас өрсөж таслан зогсоох урьдчилан сэргийлэх боломжтой болох төдийгүй төрийн байгууллагуудын нэгдмэл ажиллагаа хангагдах эхлэл болсон байна.
- Монгол Улсад оршин суух байгаа терроризмын өндөр эрсдэл бүхий 19 улсын 3291 иргэний судалгааг шинэчлэн гаргаж, дээрх иргэдийн оршин суух байгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт хяналт тавьж ажиллах үүргийг хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан.
- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн статистик судалгаагаар зүй ёсоор

анхаарал татаж байгаа зарим тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гаралтыг саармагжуулах чиглэлээр багагүй анхаарал хандуулан ажилласан байна. Тухайлбал:

- "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр"-ыг боловсруулан ЦЕГ-ын даргын тушаалаар батлаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хүргүүлж, хяналт тавьж ажиллаж байгаа,
- Монгол Улсын Засгийн газраас Канад Улсын талд хууль зүй, шүүхийн салбарын хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавих явцад "Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх" (500.0 сая төгрөгийн өртөгтэй) дэд төсөл, АНУ-ын Төрийн Департамент, Олон улсын мансууруулах бодис, хууль сахиулах үйл ажиллагааны харилцааны товчоогоор (INL) дамжуулан Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах зохион байгуулалт, зохицуулалтыг сайжруулах, хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх зорилго бүхий "Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх" хөтөлбөрийн төсөл (200.000.000 төгрөгийн өртөгтэй) "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх-цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа" дэд төслийг боловсруулан тус тус хүргүүлсэн,
- Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 2016-2020 онд 1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй төсөл хөтөлбөр, Щвейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд судалгааны ажлыг хийж, нэгдсэн мэдээлэл, лавлагааны сантай болох хэрэгцээ шаардлагыг судлах болон дэд төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулан ажилласан,
- Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯамны дэмжлэгтэй "Монгол дахь жендерт суурилсан хүчирхийллийг зогсоох нь" төслийн хүрээнд АНУ-аас гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн чиглэлээр мэргэшсэн экспертүүд цагдаагийн алба хаагчдад туршлага судлах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх уулзалт, сургалтыг хамтран зохион байгуулсан зэрэг дорвитой арга хэмжээнүүдийг авчээ,
- Үүрэн телефоны оператор "Мобиком" корпорацтай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор 107 дугаарын утсанд хандаж зөвлөгөө авах талаар сурталчилгаа бүхий мессежийг нийт хэрэглэгчдэд үнэ төлбөргүй илгээн сурталчилсан,
- Энэхүү тусгай дугаарын утсыг сурталчилсан 2 төрлийн шторкийг "Үндэсний цуурай" ХХК-тай хамтран бэлтгэж, Өргөө-1, Өргөө-2, Тэнгис кино театрын дэлгэцээр иргэдэд хүргэсэн,
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор "Хулгай", "Сар шинэ", "Илрүүлэлт-Оргодол-2016", "Хаалт-Нээлт", "Зуслан" зэрэг ерөнхий болон тусгай арга хэмжээ зохион явуулж, үр дүнг тооцсон байна,
- Арга хэмжээний хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.1 дэх хэсэгт заасан яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 354 хэрэг, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 721 хэрэг, урьд нь цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байсан 409 хэргийг улсын хэмжээнд тус тус илрүүлж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.2 дахь хэсэгт заасан сэжигтэн, яллагдагч оргон

зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан 57 оргодол этгээдийг олж тогтоон, эрүүгийн хэрэгт холбогдон эрэн сурвалжлагдаж байсан 305 этгээдийг олж баривчлан эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах "ASAP" санд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргийн оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийн талаар зарлагдсан 640 этгээдийг олж тогтоожээ,

- "Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу "Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг батлуулж, Нийслэлийн Мэдээллийн технологийн газартай хамтран "Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор "Барьцааны бүртгэл, хяналтын систем", "Барьцааны бүртгэл, хяналтын систем ашиглах журам"-ын төслийг боловсруулж, нэгдсэн хяналтын системийг нэвтрүүлэхэд шаардагдах 82.0 сая төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн,
- Орон нутгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргийн гаралт их байгаад дүгнэлт хийж "Гарал үүслийн гэрчилгээ", "Хяналт-шалгалт", "Малчдын бүлгэм" зэрэг арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил аймгуудын дунджаар 10 хүртэл хувиар буурсан байна. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баруун бүсийн зөвлөгөөнийг Говь-Алтай аймагт "Улсын хэмжээнд бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал" сэдвээр зохион байгуулсан,
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Зочид буудал", "Биеэ үнэлэгч", "Саун массаж", "РС тоглоом", "Баар", "Архидалт", "Хүчирхийлэл ба хяналт" ерөнхий болон тусгай арга хэмжээ зохион явуулж, үр дүнг тооцжээ,
- Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллахаар "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв"-тэй гэрээ байгуулан хамтран ажилласан,
- Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 410 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам", "Интернэт кафе, цахим тоглоомын үйлчилгээний байранд тавих шаардлага MNS 6430:2014" стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор "Интернэт кафе-цахим тоглоом" хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд 59 удаа зохион явуулж зөрчил гаргасан 61 иргэн, байгууллагад Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, зөрчил дутагдлыг нь арилгуулахаар 342 албан мэдэгдэл өгч, 289 хариу авч, 8 төрлийн санамж сэрэмжлүүлэгийг 13992 ширхэг хэвлүүлэн тараан ажилласан,
- Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Зэвсэг-2016", "Мансуурал-Бодис" ерөнхий болон тусгай арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт 47.236 галт зэвсэг тоологдохоос 70 орчим хувь нь хамрагдсан,
- Мөн нийслэл, орон нутагт зохион байгуулагдсан нийт 121 удаагийн жагсаал, цуглааны хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн.
- "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн 11, 12, 15 дугаар зүйлд заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахаар хандсан

69 ААН-ийн материалыг хүлээн аван судалж, Уул уурхайн яаманд 40 ААН-ийг дэмжих санал хүргүүлж, шаардлага хангахгүй 29 ААН-д татгалзаж, хариуг өгсөн,

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг хэрэгжүүлж, Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасан чиг үүргийн дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 23 ААН-тэй байгуулсан гэрээг үндэслэн тээвэрлэлтийн хамгаалалтыг 18 аймаг нийслэлийн 3 дүүрэг, 42 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын уурхайн агуулахад тэсэлгээний хэрэгслийг хүргэх ажлыг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулсан,
- Зам тээврийн гэмт хэрэг, осол, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд "Хяналт", "Тусгай дуут болон гэрэл дохио", "Явган зорчигч", "Бүрэн бус тээврийн хэрэгсэл", "Зогсолт зогсоол", "Хүүхэд зам тээврийн осол", "Хурд", "Орон нутгийн зам", "Нийтийн тээвэр", "Согтуу", "Тээврийн хэрэгслийн зогсоол", "Хамгаалах бүс-Хамгаалах суудал", "Хүн тээвэр" зэрэг нийт 820 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион явуулж, үр дүнг тооцсон. 2016 онд ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 50 хүүхэд нас барсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7,4%-аар буурч, орон нутагт 7,1%-аар өссөн статистик үзүүлэлт гарсанд дүгнэлт хийж ажиллах шаардлага харагдаж байна.

Гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгааны нэг архидан согтуурах, согтууруулах ундаа үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд хууль тогтоомж, тогтоосон дэг журмыг сахиулах, согтуурлын хор холбогдлыг олон түмэнд таниулах, сэрэмжлүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажилласан нь харагдаж байна.

Тухайлбал:

- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, захиргааны зөрчлийн тоог бууруулах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай 601, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай 183, мэргэжлийн хяналтын газартай 331, татварын албатай 120, ТББ-тай 89 удаа тус тус хамтран согтууруулах ундаа үйлдвэрлэдэг 50, худалдан борлуулах зөвшөөрөлтэй 6420 цэг, үйлчлэх зөвшөөрөлтэй 3037 цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ерөнхий арга хэмжээ 553, тусгай арга хэмжээ 1022 зохион байгуулж, Захиргааны хариуцлагын тухай хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн нийт 28747 зөрчил илрүүлж, 2258 иргэн, 7 албан тушаалтан, 537 ААН, байгууллагыг 10 211 695 000 төгрөгөөр торгож, 202 литр спирт, 6448 литр архи, 3505 литр пиво, 74 литр дарс хураан авч шийдвэрлэсэн нь энэ чиглэлийн ажлыг өргөн цар хүрээ хамруулж, зохих давтамжтай, тасралтгүй хэрэгжүүлж ирсэн гэж үзэж болохоор байна.
- Цагдаагийн байгууллагаас архины зохисгүй хэрэглээ, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах чиглэлээр зохион явуулж байгаа ажлын үр дүнд цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн 2016 оны эхний 11 сарын мэдээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 5099 бүртгэгдсэн нь өмнөх оноос -310 нэгж буюу -5,7 хувиар, согтуугаар зөрчил гаргасан иргэдийн тоо 38375 бүртгэгдсэн нь -12972 нэгж буюу -25,3 хувиар, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан 79026 иргэнийг саатуулсан нь -9674 нэгж буюу -10,9%-аар тус тус буурчээ.
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, НИТХ-ын 91, 08 дугаар тогтоол,

Нийслэлийн Засаг даргын А/609 дүгээр захирамжийг зөрчсөн болон удаа дараа зөрчил гаргасан нийт 57 ААН, байгууллагын архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг 8 удаа албан бичгээр Нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлж, 47 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 5 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг хүргүүлж, шийдвэрлүүлжээ.

- Гудамж талбай, олон нийтийн газар болон гэмт хэрэг олноор үйлдэгдэж байгаа нутаг дэвсгэрийн байрлалыг "Гэмт хэргийн цахим зураглалд" оруулж, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах бодлого баримтлан ажиллаж байгаа нь цагдаагийн байгууллагын хүч хэрэгслийг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, албадын харилцан хамтын ажиллагааг тасралтгүй хангах арга хэмжээ авч байгаа тайлангаас харагдаж байна.
- Нийслэл болон төв суурин газрын нутаг дэвсгэрт автомашинтай болон явган эргүүлийг эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд уялдуулан, Шуурхай удирдлагын төвийн удирдлага хяналтын дор зохион байгуулж, шаардлагатай үед шуурхай маневарлах, газар дээр нь холбогдох ажиллагаа явуулах бэлтгэлийг хангахад багагүй анхаарал тавьж ажиллажээ.
- Аймаг, нийслэлийн гудамж, гэр хорооллын гудамж, талбай замын телекамер, гэрэлтүүлгийг сайжруулах арга хэмжээг нутгийн захиргааны байгууллагатай хамтран үе шаттай авч хэрэгжүүлсэн байна. Орон нутагт 1242, нийслэлд 1454 нийт улсын хэмжээнд 2696 камераар хяналт тавин ажиллаж байгаа нь орон нутагт 49.7%, нийслэлд 33.1%-тай хяналтад авагдан ажиллаж байгаа нь технологийн дэвшлийг ашиглах шаардлага хангагдахад түлхэц болжээ.
- "Хөршийн хяналт хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сурталчлах чиглэлээр Улаанбаатар хотын цагдаагийн газраас нийт 815 хөршийн хяналтын бүлгийг бүртгэлд авч, (Одоогоор нийслэлийн хэмжээнд 852 хөршийн хяналтын бүлэг ажиллаж байна) "Хөршийн хяналтын бүс", "Камерын хяналт ажиллаж байна" гэсэн бичиглэл бүхий самбар (1000 ширхэг)-ыг гудамж талбайд байрлуулан, 2000 ширхэг "Хөршийн хяналтын бүлгийн гарын авлага" бэлтгэн тараасан. Мөн хяналтыг сайжруулж орчны аюулгүй байдлыг хангах талаар сайн ажиллаж байгаа туршлагуудын талаар 22 хорооны 4500 гаруй иргэдэд зөвлөгөө өгч, цагдаагийн 760 алба хаагчдад мэдээлэл өгч ажиллажээ.
- Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гэр хорооллын гудамж, орон сууцны орц, нийтийн эзэмшлийн талбайг "Хөршийн хяналтын бүлэг"-тэй хамтран камержуулах ажлыг зохион байгуулсан.
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор нийт 11245 ААН, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж зааварчилга өгч ажилласнаас тэсэрч, дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг 145, ББСБ, барьцаалан зээлдүүлэх 1123, үйлчилгээний 5026, их, дээд сургууль 289, ЕБС 978, цахим тоглоомын төв 1213, асрамж, халамжийн төв 45, бусад 7871 ААН, байгууллагыг хамруулсан.
- Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулахаар байгууллага, ААН-д 31578 мэдэгдэл, шаардлага, зөвлөмж бичгээр хүргүүлж 30489 хариу авч, үр дүнг газар дээр нь шалгаж ажилласан.
- Нийслэлийн хэмжээнд 2016 онд 180 дунд сургууль дээр нийт 54720 эцэг, эх

эргүүлийн үүрэг гүйцэтгэж хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллуулж цагдаагийн байгууллагаас "Монголын Сурагчдын холбоо"-ны "School police" төвтэй хамтран хэсэгчилсэн шалгалтыг зохион байгуулж, сургуулиудын захиргаанд албан мэдэгдэл өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж үйл ажиллагааг хэвшүүлсэн нь сургууль, эцэг эх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа сайжрахад нөлөөлсөн арга хэмжээ болсон байна.

- Олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг хороодын хэсгийн байцаагч, цагдаа нартай хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн нь үр дүнд хүрсэн байна.
- "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газар, "Монголын Оюутны холбоо"-той хамтран "Оюутан цагдаа" арга хэмжээг 3 дахь жилдээ зохион байгуулж, 110 оюутантай хөдөлмөрийн гэрээ байгуулан, хантааз, малгай зэрэг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж, эргүүлийн 55 чиглэлд үүрэг гүйцэтгүүлэн, үр дүнг тооцон ажилласан нь аль аль талдаа үр дүнтэй ажил болжээ.
- НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан "Хэв журмын урамшилт эргүүл" ажиллах журмын дагуу 10 дугаар сараас эхлэн зохион байгуулж, үйл ажиллагаанд нь зориулж тодорхой хэмжээний хөрөнгө шийдвэрлэн өгч, урамшилт 1459 иргэн хамрагдан ажиллаж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулж байгаа хэлбэрүүдийн нэг болжээ.
- Цагдаагийн байгууллагаас давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэдний засрал хүмүүжилд эрх зүй, олон нийтийн нөлөөллийг хүртээмжтэй болгох замаар нийгэмшүүлэх, гэмт санаа бодол, муу зуршил, нөлөөллөөс ангижруулах талаар зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ.
- Цагдаагийн байгууллага 2016 онд 3557 иргэнийг захиргааны хяналтад авч ажилласны дотор шүүхээс тэнсэн суллагдсан 2200, хорих ялаас тэнсэн суллагдсан 8244, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 134, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэг хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 75, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 60, хорих ялын хугацаа дуусч суллагдсан 269 иргэн эзэлсэн байна.
- Захиргааны зөрчил гаргасан хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 15 этгээдийн ялыг биечлэн эдлүүлэх саналыг шүүхэд хүргүүлж 9 этгээдийн ялыг биеэр эдлүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.
- Хяналтад байх хугацаандаа хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 30, хорих ял эдлээд суллагдсан 7, бүгд 37 этгээд дахин гэмт хэрэг үйлджээ. Түүнээс гадна 2016 онд урьд ял шийтгэгдэж явсан 1608 этгээд дахин гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байгааг анхаарах шаардлагатай.
- Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй 2171, сэтгэцийн эмгэгтэй 2490, архаг архичин 1605, тэнэмэл иргэд 586, биеэ үнэлэгч 228 этгээдийн судалгаа, түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа 18,196 гадаадын иргэдийн судалгааг тус тус гаргаж, хяналт тавин ажилласан байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн идэвх оролцоог хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд цагдаагийн байгууллага онцгой анхаарч төрөл бүрийн идэвхжүүлэлт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, энэ чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу болон үндсэн үүргийнхээ хүрээнд өөрийн санаачилгаар төрийн болон ТББ-тай хамтран холбогдох хууль тогтоомжийг

иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажилласан нь зохих үр дүнгээ өгчээ. Үүнд:

- Засгийн газрын 2015 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, олон нийтэд сурталчлах ажлыг давтамжтайгаар хэрэгжүүлж ирсэн.
- Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, стратеги, бүсчилсэн хөгжлийн бодлого, ажил үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаа, олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтийн дэмжлэг хүлээсэн ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж, цагдаагийн байгууллагын талаар эерэг мэдээллийг түгээх ажлыг зохион байгуулсан.
- НҮБ-ын Хүн амын сантай хамтран "Жендэрт суурилсан хүчирхийлэл, хортой зуршлаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын үр дүнтэй үйлчилгээг хүргэх, чадавх нэмэгдүүлэх" төсөл зэрэг олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын далайц үр дүнг дээшлүүлэхэд чиглүүлэн зохион байгуулсан.
- "Монгол халамж", "Эрчүүд гэр бүл хөгжлийн нийгэмлэг", "Эрүүл Зөв Монгол", "Монгол соёл Ивээл" ТББ хамтран "Гэр бүлийн үнэ цэнэ", "Гэр бүлийн харилцаа" сэдэвт сургалт,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Цагдаагийн байгууллагын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрүүл Зөв Монгол", "Эрчүүд, гэр бүл хөгжлийн нийгэмлэг"-тэй хамтран Албадан саатуулах төвд баривчлагдсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт "Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт", "Гэр бүлийн харилцаа" сэдэвт сургалт,
- Орон нутгийн хэмжээнд ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын газар, ТББ-тай хамтран оюутан, сурагчдын дунд архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, эрүүл мэндийн зөв хүмүүжил, дадал хэвшил олгох, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилго бүхий сургалт, сурталчилгаа,
- УБХЦГ нь Хүүхэд, залуучуудыг хар тамхи, мансуурлаас сэргийлэх чиглэлээр Эрүүгийн цагдаагийн газар, Эрүүл мэндийн хүрээлэн, "Цагаан соён" ТББ, "Эм Би Си" ХХК-тай хамтран "Архидалт мансуурлаас урьдчилан сэргийлье" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, түүний хүрээнд Нийслэлийн Боловсролын газар, СЭМҮТ-тэй хамтран ЕБС-ийн нийгмийн ажилтнуудад "Хүүхдийг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт зэрэг олон төрлийн сургалт сурталчилгааг хууль тогтоомжийн заалт, нийгмийн хэрэгцээ шаардлагад уялдуулан зохион байгуулжээ.
- Нийслэлийн хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг гэмт хэрэг, хүчирхийлэл, мансуурал, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр "Нээлттэй зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, "Сургуулийн орчинд хүүхдийн эрх ашиг хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас цаашид хэрэгжүүлэх ажил, нөхцөл байдал"-ын мэдээлэл хэлэлцүүлэх,
- Аймаг, нийслэлийн хэмжээнд ИТХ-ын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, иргэний танхимын ажилтнууд болон иргэдийг хамруулан "Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци

нэвтрүүлэх нь" сэдэвт эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж, илтгэлийг хэлэлцэн, иргэдийн санал хүсэлтийг сонсож, гаргасан санал шүүмжлэл, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад анхаарч ажилласан байна.

- Улаанбаатар хотын хэмжээнд хөршийн хяналт, гэмт хэргийн газрын зураглал зэрэг олон нийт рүү чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэд гар утаснаасаа гэмт хэрэг гарч болзошгүй газар нутгийн талаарх мэдээллийг авч болзошгүй халдлагаас өөрийгөө болон бусдыг сэргийлэхэд айл хөрш, баг, хороогоороо хамтран ажиллах, харилцан сэрэмжлүүлсэн мэдээлэл солилцох боломж бүрдэж эхэлжээ.

Цагдаагийн байгууллагаас "Цагдаагийн мэдээлэл" www.police.gov.mn цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн нийтлэх, нэвтрүүлэх замаар олон нийтэд хүргэх ажлыг харьцангуй оновчтой зохион байгуулж ажилласан тайлангаас харагдаж байна.

Тухайлбал:

- МҮОНРТ-ийн 1 дүгээр сувгаар 7 хоног бүрийн баасан гаригт "Цагдаагийн мэдээлэл", 2-р суваг телевизээр 7 хоног бүрийн пүрэв гаригт "Амрыг эрье" нэвтрүүлгийн нийт 92 дугаарыг тус тус бэлтгэн олон нийтэд хүргэсэн.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зууны мэдээ, Өнөөдөр, Монголын үнэн, Өглөөний сонин зэрэг өдөр тутмын сонинд 260, Shuud.mn, Medee.mn, 24tsag.mn, Zaluu.com, Itoim.mn, Ikon.mn, Dorgio.mn зэрэг мэдээллийн сайтад 545, МҮОНРадиод 95, телевизэд 620, нийт 1520 ярилцлага мэдээллийг өгч түүгээр дамжуулан хууль тогтоомж, бодлого чиглэл бодит байдлыг олон нийтийн хүртээл болгосон.
- ЦЕГ-ын мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль"-ийн хэрэгжилт, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын заалтыг хангаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас www.police.gov.mn/, www.facebook.com, www.twitter.com, www.youtube.com/ цахим хуудас ажиллуулж "Нүүр", "Бидний тухай мэдээлэл", "Хууль эрх зүй", "Тусгай зөвшөөрөл", "Иргэний хяналт", "Олон нийтийн цагдаа", "Мэдээллийн ил тод байдал", "Эхлэл", "Байгууллага", "Мэдээлэл", "Зөвшөөрөл", "Иргэний зөвлөл", "Шилэн данс" гэсэн ерөнхий цэс, дэд цэсүүдэд нийт 285 мэдээ, мэдээлэл нийтлэн, өдөр бүр дэд цэсүүдийн агуулгын хүрээнд баяжуулж, холбогдох зураг, статистик тоо баримтыг хавсарган байршуулсан,
- Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 25 видео бичлэг, 75 зурагт хуудсыг өөрийн facebook, youtube, twitter хуудсанд байршуулсныг давхардсан тоогоор 4.0 сая гаруй хэрэглэгч үзсэн зэргээс үзвэл хэвлэл мэдээллийн хэрэгслийн боломжтой бүх сувгийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд олон нийт, хувь хүн, байгууллага ААН-ийн үүрэг, хариуцлагыг мэдрүүлэхийг зорьжээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Гэмт хэрэг илрүүлсэн, шалгасан, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлсэн, таслан зогсоосон ажлын "үнэлэмж"өнөөдөр харилцан адилгүй байгаа бөгөөд үүнийг өөрчлөх, боловсронгуй болгох асуудал онол, практикийн түвшинд яригдсаар ирсэн ч үр дүн багатай, гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах ажлын "хавсарга" байдалтай хэвээр байна. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бодлого,

хүн хүч, хөрөнгө, үйл ажиллагаагаа түлхүү чиглүүлэх, цаг хугацааг түүнд илүү зарцуулах нь нэн чухал байна.

Аливаа гэмт хэргийг үйлдэгдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх нь цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр, зардал хэмнэсэн төр, олон нийт, ард иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд нийцсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болох нь хууль сахиулах салбарынханд аль хэдийн тодорхой болсон асуудал гэдэг нь ойлгомжтой.

Иймд юуны түрүүнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ хуулийг бүх түвшинд хэрэгжүүлэх асуудалд онцгой анхаарч, нутгийн өөрөө удирдах болон төр захиргаа, хууль сахиулах байгууллага, ТББ, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гарган одоо ажиллаж байгаагаасаа илүү үр дүнтэй ажиллах шаардлагатай байна.

2. Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг, үйл ажиллагааг бодлогын түвшинд бие даасан хэмжээнд хэрэгжүүлж ирээгүй, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүргийн хавсарга байдлаар, алба хаагчдын нийтлэг үүргийн хэрэгжилтийн явц үр дүнгээр хязгаарлагдаж ирсэн нь бүтэц, орон тоо, зохион байгуулалтаас харагдаж байна. ЦЕГ-ын түвшинд бүтэц, орон тоогоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг идэвхжүүлэх, үр дүнг тооцож хэтийн төлөвөө тодорхойлох нэгдсэн тогтолцоо байхгүй явж иржээ гэж хэлж болохоор байна. 2016 оны байдлаар Нийслэлийн цагдаагийн газарт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтэс, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсүүдэд олон нийттэй харилцах мэргэжилтэн орон тоогоор нэг алба хаагч ажиллаж байгаа нь нэгдсэн бодлогод, тогтолцоо үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Иймд цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргийг бие даан хэрэгжүүлдэг, нэгдсэн бодлогоор нэгтгэн удирддаг удирдлага зохион байгуулалтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Үүний тулд цагдаагийн нэг алба хаагчид оногдож байгаа ажлын ачаалал, ажил үүргээ хэвийн, үр дүнтэй гүйцэтгэх бодит боломж, чадамжийг харгалзан орон тоог нэмэгдүүлэх, олон улсын жишиг, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөдөлмөр зохион байгуулалтыг хийж, төрийн тасралтгүй үйлчилгээг иргэн нь шаардлагатай үедээ шуурхай авч чаддаг байх зарчимд тулгуурлан шийдвэрлэх нь иргэдийн амар тайван амьдралын баталгааг хангах нэг үндсэн зорилт байхыг анхаарах нь зүйтэй.

3. Цагдаагийн байгууллагад улс орны эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийж гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах талаарх ойрын болон хэтийн бодлого, зорилтоо үндэслэлтэй тодорхойлж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн сүүлийн 9 жилийн хугацааны цахим мэдээллийн сантай болсон байна.

Цаашид мэдээллийн санг нийгмийн хөгжил дэвшлийн шаардлага, нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан баяжуулж, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, түүнд нөлөөлж байгаа нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан дүн шинжилгээ хийж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны бодлогыг улс орны болон тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд тодорхойлж, хэрэгжүүлэх ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийг өргөнөөр татан оролцуулах явдлыг тогтмолжуулахад анхаарах нь зүйтэй.

4. Дэлхийн даяарчлал, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, өөрчлөлтөөс хамааран терроризм, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, хүрээлэн буй орчин, эдийн засаг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд техник, технологийн хувьд хоцрогдсон, үйл ажиллагааны арга тактик бүрэн шинэчлэгдээгүй, алба хаагчийн ажлын ачаалал хэт өндөр, төсөв хөрөнгийн хүрэлцээ дутмаг, түүний хуваарилалт төрөл мэргэжлийн албадын үйл ажиллагааг хараат бус байлгах, зайлшгүй бодит хэрэгцээ шаардлагыг харгалзах боломжгүй байдлаар хийгддэг зэргээс шалтгаалан шаардлагын түвшинд хүрч ажиллаж чадахгүй байна.

Цагдаагийн байгууллагад хийгдсэн шинэчлэлийн үр нөлөөг гүнзгийрүүлж, ард иргэдийн аюулгүй, амар тайван амьдралын баталгааг хангахын тулд мэргэшсэн, чадварлаг, харилцааны өндөр соёлтой хүний нөөцөөр бэхжүүлэх, өндөр технологийг нэвтрүүлэх, орчин үеийн техник хэрэгслээр хангах, шуурхай, найдвартай ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, алба хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн хөгжлийн стратегийг судалгаанд суурилан, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогод уялдуулан тодорхойлж, урт хугацаанд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь нөхцөл байдлаас харагдаж байна.

5. Цагдаагийн байгууллагаас 2016 онд нэгдсэн болон хэсэгчилсэн (бүгд 52) арга хэмжээг тухайн нөхцөл байдлын өрнөлтэй уялдуулан үр дүнтэй зохион байгуулсан нь болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нөлөөлсөн байна.

Тухайлбал: бусдын эд хөрөнгийг булаах 18.5%, хүнийг санаатай алах 14.7%, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 11.7%, танхайрах 8.4%, ТХХАБАЖЭ 7.4%, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх 4.8%, бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх 3.3%, бусдын эд хөрөнгийг хулгайлах 1.1%-аар тус тус буурсан нь эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүн мөн.

Мөн Улаанбаатар хотын дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн тоог ажлын ачаалал, хүн амын нягтрал, нутаг дэвсгэрийн байршил зэргийг харгалзан нэмэгдүүлсэн нь цагдаагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдэд хүрч үйлчлэх боломж, шуурхай байдлыг нэмэгдүүлсэн бодитой арга хэмжээ болсон нь харагдаж байна.

Түүнчлэн, төрийн болон ТББ-тай хамтран гэмт хэргийн зураглал, хөршийн цагдаа, хяналт, устгал, оюутан-цагдаа, гудамж талбай, олон нийтийн газрыг камержуулах зэрэг арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлсэн нь улсын хэмжээнд гэмт хэрэг 2.1%-аар буурах шалтгаан болсон гэж үзэх үндэслэлтэй байна.

Цаашид цагдаагийн алба хаагчдын ажлын ачааллыг гаргаж болохуйц бүтээмж, үр дүнд нийцүүлэн, тэнцвэржүүлэхүйц хөдөлмөр зохион байгуулалтыг судалгаа тооцоотой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх, ард иргэдэд цагдаагийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний үйл ажиллагааг төрийн болон ТББ, ААН, ард иргэдтэй байнга тасралтгүй холбогдож, хүрсэн үр дүн, нөхцөл байдлын өрнөлт, өөрчлөлтөөр үнэлж, удирдлага зохион байгуулалтаар тасралтгүй хангах шаардлага байгааг анхаарч цахим мэдээллийн нэгдсэн санд урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр бие даасан санг бүрдүүлж ажиллах нь чухал байна.

6. Хууль, эрх зүйн орчинд бий болсон өөрчлөлттэй холбогдон гэмт хэргийн гаралт тархац өөрчлөгдөх төлөв хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хариуцлага чангарснаар ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 7.4%-аар буурах үндсэн нөхцөл болжээ.

Гэвч замын цагдаагийн биечлэн болон камерын байнгын хяналтгүй орон нутгийн замуудад гарсан ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг тогтвортой буурахгүй байгаад бид дүгнэлт хийж байнгын болон хөдөлгөөнт постуудын хяналт үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, зарим анхаарал татсан замыг камерын хяналтад авах нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зохих үр дүнгээ өгөх боломжтой.

7. Давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг бодитой, үр дүнг хэмжих тодорхой үнэлэмжтэй, аль болох хэлбэрдэхээс зайлсхийсэн, түүнд нөлөөлж болох орчинг бүрдүүлэхэд түлхүү анхаарсан, ойр дотно хүмүүсийг илүү татан оролцуулсан, ухааралд илүү тулгуурласан түвшинд зохион байгуулахад анхаарах зүйтэй.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. АТГ-ын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, түүний шинэчлэл

Даяаршлын үйл явц хурдацтай хөгжиж байгаа сүүлийн 20-оод жилд дэлхийн улс гүрнүүдийн харилцаанд урьд өмнө байгаагүй нэн таатай нөхцөл, хөгжил дэвшлийн сайхан бололцоо бүрдсэн боловч үүнийг дагасан сөрөг үзэгдлүүдийн нэг нь авлигал. Энэ сөрөг үзэгдэлтэй зөвхөн нэг улс дангаараа тэмцсэнээр үр дүнд хүрэхгүй, харин олон улсын түвшинд хамтран тэмцэхээс өөр аргагүйг харгалзан НҮБ-аас 2003 онд Авлигын эсрэг конвенцийг баталсан. Авлигын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсч буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн зүй ёсны үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгааг Авлигын эсрэг конвенцийн удиртгал хэсэгт дурдсан байдаг.

УИХ 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан.

УИХ 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталсан нь авлигын эсрэг тэмцлийн хүсэл зоригийн томоохон илэрхийлэл болсон билээ. Авлигатай тэмцэх ажлын явц удаан, үр дүн муутай байгааг нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн уур амьсгал нь Авлигын эсрэг хуулийг шинэчлэн батлах нөхцөл, шалтгаан болсон.

УИХ 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж эхэлжээ.

Авлигын эсрэг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа Авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР НЬ ДАРААХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Хуульд заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах ажлыг зохион байгуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР НЬ ДАРААХ БҮРЭН ЭРХТЭЙ:

- Авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;

- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;
- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;
- ААН, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- Авлигын холбогдолтой өргөдөл гомдлыг хүлээн авч шалгах;
- Хуулиар харъяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;
- Чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;
- Өөрийн байгууллага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;
- Гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулах авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;
- Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- Өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах;
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;
- Мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;
- АТГ-ын хуулиар хүлээсэн дээр дурьдсан чиг үүрэг, эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, захиргаа, санхүүгийн ажлыг хэрэгжүүлэх үүргийг Тамгын хэлтэс хэрэгжүүлнэ.

График VI.2.1. Авлигатай тэмцэх газрын бүтэц, зохион байгуулалт:



2. АТГ-т ирсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

		2011	2012	2013	2014	2015	2016
Нийт шалгасан гомдол, мэдээлэл		443	357	427	517	440	427
Үүнээс	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	214	146	176	323	265	274
	Харьяаллын дагуу шилжүүлсэн	164	124	152	90	70	49
	Эрүүгийн хэрэг үүсгэсэн	57	74	64	92	92	83
	Ажиллагаанд	8	13	35	12	13	21

3. Авлигын индексийн талаарх сүүлийн үеийн судалгааны дүн, тайлан, танилцуулга, мэдээлэл

АТГ нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг. Уг чиг үүргийн хүрээнд 2009-2013 оны хооронд Монгол Улсын Авлигын индексийг тооцож, үр дүнг нь олон нийтэд мэдээлж байсан бол 2015 оноос төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ (цаашид ШБҮ гэх)-г гаргаж, үр дүнг нь олон нийтэд мэдээлж байна.

ШБҮ нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээнд үндэслэсэн үнэлгээ юм. Үнэлгээг 0-100 хүртэл оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол шударгыг, 0-тэй тэнцүү бол шударга бусыг илэрхийлнэ. ШБҮ-2015-д 62 төрийн байгууллага (яам, засгийн газрын агентлаг, аймаг, Нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулсан.

ШБҮ-ний мэдээлэл цуглуулах судалгаанд нийтдээ 4340 нэгжийг хамруулсан бөгөөд үүнээс ГШБҮ-нд 2330 иргэн, ААН, байгууллагын төлөөлөл, ДШБҮ-нд 1390 төрийн албан хаагч, бодлогод оролцогчдын үнэлгээнд 620 шинжээчийг хамруулсан болно. Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 оноо авахаас дунджаар 73.8 оноо авсан байна. ШБҮ-ний дүнгээс харахад байгууллагын ДШБҮ-ний оноо 81.9 гарсан байгаа бол ГШБҮ болон БОҮ-ний оноо тус бүр 69.8 гэсэн дүнтэй гарчээ.

Хүснэгт VI.2.2. Шударга байдлын үнэлгээ (байгууллагаар)

Төрийн байгууллагын нэр	Шударга байдлын үнэлгээ	Төрийн байгууллагын нэр	Шударга байдлын үнэлгээ
Барилга, хот байгуулалтын яам	65.8	Газрын тосны газар	77.6
Эрүүл мэнд, спортын яам	66.1	Онцгой байдлын ерөнхий газар	77.8
Зам тээврийн яам	69.0	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	78.1
Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	69.3	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	79.0
Хүн амын хөгжил, нийгмийн хамгаллын яам	70.0	Стандартчилал, хэмжил зүйн газар	79.2
Уул уурхайн яам	71.3	Тахарын ерөнхий газар	79.3
Хүнс, хөдөө аж ахуйн яам	71.4	Оюуны өмчийн газар	79.4
Хууль зүйн яам	72.2	Нийгмийн даатгалын ерөнхий газар	79.7
Аж үйлдвэрийн яам	72.6	Цаг уур, орчны шинжилгээний газар	81.4
Хөдөлмөрийн яам	73.5	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	65.5
Эрчим хүчний яам	75.4	Завхан аймгийн ЗДТГ	66.2
Сангийн яам	75.6	Дундговь аймгийн ЗДТГ	66.6
Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	77.2	Өмнөговь аймгийн ЗДТГ	67.6
Гадаад хэргийн яам	77.2	Хэнтий аймгийн ЗДТГ	70.8
Батлан хамгаалах яам	78.9	Дархан-Уул аймгийн ЗДТГ	70.9
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	67.3	Төв аймгийн ЗДТГ	71.3
Ашигт малтмалын газар	68.2	Ховд аймгийн ЗДТГ	71.3
Гаалийн ерөнхий газар	68.9	Дорнод аймгийн ЗДТГ	71.3
Татварын ерөнхий газар	69.2	Орхон аймгийн ЗДТГ	72.2
Иргэний нисэхийн ерөнхий газар	72.3	Архангай аймгийн ЗДТГ	72.2
Газрын харилцаа, геодези, зурагзүйн газар	73.1	Өвөрхангай аймгийн ЗДТГ	72.6
Мал эмнэлэг, үржлийн газар	73.4	Нийслэлийн ЗДТГ	72.8
Улсын бүртгэлийн ерөнхий газар	73.7	Баянхонгор аймгийн ЗДТГ	73.0
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	73.9	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	73.6
Архивын ерөнхий газар	75.3	Булган аймгийн ЗДТГ	75.3
Хүүхдийн төлөө үндэсний газар	75.7	Говь-Алтай аймгийн ЗДТГ	76.3
Хөрөнгө оруулалтын газар	76.4	Сүхбаатар аймгийн ЗДТГ	77.1
Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	76.9	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	78.5
Цагдаагийн ерөнхий газар	77.1	Хөвсгөл аймгийн ЗДТГ	79.0

Худалдан авах ажиллагааны газар	77.3	Увс аймгийн ЗДТГ	79.4
Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний ерөнхий газар	77.5	Дорноговь аймгийн ЗДТГ	81.3

4. Харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэсэн гэмт хэрэг, сэжигтэн, яллагдагч, хохирлын талаарх статистик мэдээлэл

Хүснэгт VI.2.3.

		2011	2012	2013	2014	2015	2016
Нийт шалгасан эрүүгийн хэрэг		142	164	187	239	238	235
Үүнээс:	Яллах дүгнэлттээр	43	33	43	69	Г55	67
	Хэрэгсэхгүй болгох	35	33	41	48	50	43
	Харьяаллын дагуу шилжүүлсэн	27	25	30	47	30	26
	Эрүүгийн хэрэг нэгтгэсэн	7	24	21	19	28	40
	Түдгэлзүүлсэн	3	2	13	14	13	13
	Ажиллагаанд	27	47	39	42	62	46
Хэргийн холбогдогч		313	293	400	598	410	459
Хохирол	Нийт учирсан хохирол (тэрбум)	22.7	38.0	85.0	61.1	46.5	37.7
	Нөхөн төлүүлсэн	1.1	3.1	6.3	4.9	2.9	2.8
	Хөрөнгө битүүмжилсэн	3.0	3.9	17.1	17.4	11.3	10.6

5. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагаа, ажлын үр дүн тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын танилцуулга

АТГ-ын нэн тэргүүний зорилт нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах явдал юм.


Авлигыг үүсгэдэг шалтгаан, нөхцөлд төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал чирэгдэл, ил тод нээлттэй бус байдал, төрийн албан хаагчдын ёс зүйн доройтол зүй ёсоор хамаарах бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулахын тулд АТГ тодорхой бодлого, системтэй арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, АТГ-аас 2008 онд төрийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж буй 26 байгууллага буюу Монгол Улсын зарим яам, агентлагийг "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-тэй болгох ажлыг эхлүүлж байсан бол 2016 онд УИХ-ын байгууллага, бүх яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, нийт 128 байгууллага, тэдгээрийн салбар нэгжүүдийг төлөвлөгөөтэй болгон, хэрэгжилтэд нь хяналт тавин, биелэлтийг үнэлж дүгнэн ажиллаж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж хэрэгжүүлэх механизмыг бүрдүүллээ.

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг сүүлийн 4 жилийн хугацаанд АТГ-аас баталсан аргачлалын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгарсан хөндлөнгийн "Шинжээчдийн баг"-аар үнэлүүлж, Үнэлгээ нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноо, нийт 100 оноогоор үнэлдэг бөгөөд 2015 оны улсын дундаж үнэлгээ 68,2%-тай

байгаа нь 2014 онтой харьцуулвал 8.2%, 2013 оны дүнтэй харьцуулвал 20%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График VI.2.2. Үнэлгээний үр дүнг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулан үзүүлбэл:



УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын ХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" төслийн багийн дэмжлэгээр 2014-2016 онд Конвенцын 2 дугаар бүлэг (Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа) ба 5 дугаар (Хураагдсан хөрөнгийг буцаан олгох) бүлгийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх зөвлөх үйлчилгээний тайлан, дотоодын хууль тогтоомж хэрхэн нийцэж буй талаарх судалгаа, хөндлөнгийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийн тайлан эцэслэн боловсруулах, олон нийтээр хэлэлцүүлэх, тайланг баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн. Өөрийн үнэлгээг зохих ёсоор бэлтгэж хийх нь гишүүн орнуудын авлигын эсрэг хүсэл эрмэлзлийн чухал илэрхийлэл болохын зэрэгцээ төрийн байгууллагуудын зүгээс Конвенцыг хэрэгжүүлэх идэвх, оролцоог өрнүүлэх ач холбогдолтой. Конвенцын хэрэгжилтийг ийнхүү хянаснаар улс орнууд авлигатай тэмцэх талаар хуримтлуулсан туршлагаа хуваалцах, техник туслалцаа үзүүлэх зэрэгт хэрэглэж болохуйц арга хэрэгслийг төр, засгийн түвшинд бий болгож байдаг.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталсан 2174 гаруй тушаал шийдвэр, дүрэм журмыг хянан үзэж, авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзэхээр 127 шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмээг авч, 42 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, давхардсан тоогоор 47 зөвлөмж хүргүүлэн, 36 байгууллагын ёс зүйн дүрэмд санал өгч тусгуулан, 63 өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, авлигаас урьдчилан сэргийлжээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг нь дээшлүүлэх, энэ чиглэлээр

зөвлөх, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор авлигын эрсдэлийн судалгаагаар өндөр үзүүлэлттэй байгаа барилга, уул уурхай, эрүүл мэнд, боловсрол, гаалийн салбаруудад ажилласан.

Мөн АТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ГХЯам, БОНХЯам, АМГТГ, ЭМНДЕГ, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, нийслэлийн 7 дүүрэг, ШШГЕГазар, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Хорих 409, 411 дүгээр ангиуд дээр тус тус ажилласан байна.

Түүнчлэн, тус байгууллага нь төсвийн эрх мэдэл орон нутагт шилжсэнтэй холбогдуулан гарч болох авлигын эрсдэлээс сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2014 онд 8 аймгийн 123 суманд, 2015 онд 5 аймгийн 52 суманд, 2016 онд давхардсан тоогоор 24 аймгийн 20 суманд очиж ажиллажээ.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан, түүнийг сурталчлах, орон нутаг дахь ГХУСАЗЗ-ийн дэргэд ажиллах Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэх, судалгаа авах, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, эрх бүхий албан тушаалтанд сургалт зохион байгуулах, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор 21 аймагт АТГ-ын ажлын хэсэг тус тус томилолтоор ажилласан байна. Тус ажлын хэсгүүд томилолтоор ажиллах хугацаанд давхардсан тоогоор 5400 орчим иргэдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл өгч ажилласан байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр ААН, байгууллагын хүлээх үүрэг, авлигын нийгмийн хор аюул, төрийн байгууллагын албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар лекц, ярианы сэдэв боловсруулан иргэн болон төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшжээ. Сүүлийн 3 жилийн хугацаанд давхардсан тоогоор 53400 орчим иргэнийг сургалтад хамруулж, арга зүйн удирдлагаар хангасан үзүүлэлттэй байна.

Авлигын хор хөнөөлийг хүүхэд залууст ухуулан таниулж, шударга зан суртахууныг төлөвшүүлэх зорилгоор цэцэрлэгийн ахлах, дунд ангиас, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, багш сурган хүмүүжүүлэгч нарт танилцуулж, гарын авлага материалаар хангаж ажилласан нь олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын үр дүнтэй арга хэмжээ болсон байна. Тухайлбал, Цэцэрлэгийн болон ЕБС-ийн сурагчдад зориулсан "Туулайхүүгийн адал явдал", "Шударга ёс-бидний тэмүүлэл", их, дээд сургуулийн оюутнуудад зориулан "Глоб интернешнл" ТББ-тай хамтран боловсруулсан "Хангай ба түүний нөхөд юу хэлэв?" кино сургалтын хөтөлбөр боловсруулах гэх мэт ажлыг дурдаж болно.

Нийтийн албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах, арга зүйн удирдлагаар хангах, мөн иргэд олон нийтэд авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах зорилгоор АТГ-аас гарын авлага, хэвлэмэл хуудас, түүнчлэн видео болон аудио материалыг төрийн албан хаагч, иргэд олон нийт, хүүхэд залуус, сургагч багш нарт зориулан эрхлэн гаргаж сургалт, сурталчилгааны ажилд ашиглаж ирсэн байна.

Мөн видео болон аудио хэлбэрээр богино хэмжээний кино, цуврал кино, анимейшн, тавилттай уншилт, нэвтрүүлэг зэргийг бүтээж улсын хэмжээнд таниулах ажлыг хийж гүйцэтгэжээ. Сүүлийн 3 жилийн хугацаанд "Төр түмэн нүдтэй" цуврал баримтат нэвтрүүлэг, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан цуврал анимэйшн видео, АТГ-ын ажилтны нэг өдөр цуврал нэвтрүүлэг, авлигаас ангид, сайн засаглалын сайн санаачилга зэрэг нэвтрүүлгийг хийж олон нийтийн хүртээл болгожээ.

Улсын хэмжээнд 2015 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ гаргах 39853 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 39850 мэдүүлэг гаргагч буюу 99.99% нь бүртгүүлсэн. Үүнээс хуульд заасан хугацаанд 39848 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн бол 2 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулсан, 3 мэдүүлэг гаргагч тус тус мэдүүлгээ гаргаагүй байна. Дээрх зөрчил гаргасан албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ажиллав. Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг гаргуулж байгаа нь төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хууль бусаар хөрөнгөжих зэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих алхам болж байна.

Цаашид хийх тулгамдаж буй асуудлууд:

- "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг яаралтай боловсруулан байгууллагуудын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг, манлайллыг нэмэгдүүлэх болон эрх бүхий албан тушаалтны эрх үүрэг, хариуцлагын асуудлыг тодорхой тусгаж өгөх;
- ГХУСАЗЗ-ийн дэргэд ажиллах авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, тодорхой байгууллага, салбарт чиглэсэн үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулан ололт амжилт, алдаа дутагдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллах;
- Олон нийтийн мэдээллийн төвийг түшиглэн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, ажилтнуудыг чадавхжуулах асуудлыг цогцоор шийдвэрлэх;
- Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулах, арга хэлбэрийг нэмэгдүүлэх зорилгоор сургагч багшийг бэлтгэн ажиллуулах, сургалтын цахим болон онлайн шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлэх;
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах "1800-1969" дугаарыг сурталчилж, олон нийтэд хүргэх, 24 цагаар ажиллуулах хангах;
- Авлигатай тэмцэх байгууллагын алба хаагч нарын сэтгэлзүйн түвшний судалгааг жилд 2 удаа авч, чадваржуулах нь зүйтэй.

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



3. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага бөгөөд УЕПГ, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газраас бүрдэнэ.

Зураг VI.3.1.

Улсын ерөнхий прокурорын 2015 оны 04 сарын 01 өдрийн А22 тоот тушаалын 1 хавсралт



Түүнчлэн дагнасан прокурорын газар болох Тээврийн прокурорын газар нь ТХХАБАЖЭсрэг гэмт хэргүүдэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн дагуу бүх аймаг, Нийслэлийн 8 дүүрэгт болон Дорноговь аймгийн Замын-Үүд, Завхан аймгийн Тосонцэнгэл, Өвөрхангай аймгийн Хархорин, Өмнөговь аймгийн Ханбогд, Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан, Ховд аймгийн Булган, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд тус тус прокурорын газар ажиллаж байна. Прокурорын байгууллагад нийт 482 прокурор, 192 туслах ажилтан, 385 захиргаа, үйлчилгээний ажилтан ажиллаж байна.

Прокурорын байгууллага нь 2011 онд 63036, 2012 онд 67215, 2013 онд 81025, 2014 онд 93961, 2015 онд 97656, 2016 онд 94751, нийт 497,644 гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд хяналт тавьж ажилласан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо сүүлийн жилүүдэд өсч байсан бол 2016 онд урьд оноосоо 2.9%-аар буурсан байна. Энэ нь харьяаллын бус, иргэн, захиргааны шинжтэй гомдол, мэдээллийг гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд бүртгэж авахгүй байх талаар нэгжүүдэд чиглэл өгч ажилласны үр дүн.

2011-2016 онуудад хяналт тавьсан нийт 497,644 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 169,966 буюу 34.1%-д нь эрүүгийн хэрэг үүсгэж, 316,105 буюу 63.5%-ийг нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж тус тус шийдвэрлэсэн байна. Дээрх тоо баримтаас

дүгнэлт хийхэд нийт гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн ихэнх хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэж байна.

ГОУХАН-ийн Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл, Монгол Улсын прокурорын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Прокурорын байгууллагын үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, мониторингийн програм хангамжийг боловсруулан нийт нэгжүүдэд 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүрэн нэвтрүүлж, УЕПГ-ын Дүн шинжилгээ, судалгаа, хяналт шалгалтын хэлтэс цахим мэдээлэл, мэдээллийн систем, мэдээлэл дамжуулах сүлжээний тасралтгүй ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Прокурорын байгууллага нь 2011 онд 31 349, 2012 онд 34 697, 2013 онд 42 850, 2014 онд 46 575, 2015 онд 48 677, 2016 онд 41 525, нийт 245 673 эрүүгийн хэрэгт хяналт тавьж ажилласан байна.

Хяналт тавьсан нийт хэргийн 81 085 буюу 33%-ийг хөнгөн, 133 587 буюу 54.3%-ийг хүндэвтэр, 23 441 буюу 9.5%-ийг хүнд, 7 560 буюу 3%-ийг онц хүнд хэргүүд тус тус эзэлж байна. Нийт хэргийн 87.3%-ийг хөнгөн, хүндэвтэр хэргүүд эзэлж байна.

2016 онд гарсан нийт гэмт хэргээс 21 509 буюу 66.9% нь Нийслэлийн нутаг дэвсгэр үйлдэгдсэн байна. Сүхбаатар дүүрэгт 3294, Баянгол дүүрэгт 3374, Баянзүрх дүүрэгт 4796 гэмт хэрэг гарсан нь хамгийн их байгаа бол Налайх дүүрэгт 614, Багануур дүүрэгт 342 гэмт хэрэг гарсан нь хамгийн бага байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагаа, хийсэн ажлын үр дүн:

Улсын хэмжээний болон тухайн бүс нутгийн хэмжээнд үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд прокурорын байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт гарч байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг зөв үнэлж, тогтоох шаардлагатай. Үүнд:

Хүснэгт VI.3.1.

Хууль сахиулах байгууллага, прокурор, шүүхийн мэдээ, тайлан, статистик үзүүлэлтийг нэгтгэн дүгнэх	Нэмэлт судалгаа явуулах: • криминологийн • социологийн • шүүх сэтгэц гэм судлалын • хавтаст хэргийн гэх мэт

УЕПГ-ын бүтцэд 2015 онд шинээр байгуулагдсан Дүн шинжилгээ, судалгаа, хяналт шалгалтын хэлтэст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах чиг үүргийг хариуцуулсан.

Тус хэлтэс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, Улсын Ерөнхий прокурорын 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар "Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар"-ыг батлан гаргуулж, хэрэгжилтийг нь хангуулж ажилласан.

Аргачилсан зааварт прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэдэгдэл бичих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шалгалтыг дангаараа болон бусад байгууллагатай хамтран хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа хийх, яриа таниулга хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл гаргах гэсэн хэлбэрүүдээр хэрэгжүүлэхийг тодорхойлсон. Мөн прокурорын газрууд нь тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар нийт хяналт тавьж ажилласан хэргийнхээ 5%-д мэдэгдэл бичих,

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шалгалтанд хагас жилд 1-ээс доошгүй удаа оролцох, орон нутгийн эрүүгийн нөхцөл байдал болон тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар хагас жил тутам судалгаа хийх, жилд нэгээс доошгүй удаа тухайн нутаг дэвсгэрийн сум, хороонд очиж ажиллаж байхыг тус тус журамласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр 2015 онд 1704 мэдэгдэл бичсэн нь 2014 оны мөн үеэс 319 буюу 23%-аар, зөвлөгөөн, ярилцлага, мэдээлэл 1212 удаа зохион байгуулсан нь 403 буюу 49.8%-аар, түүнд 111,122 хүнийг хамруулсан нь 4898 хүнээр буюу 4.6%-аар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалтанд 453 удаа оролцсон нь 99 буюу 27.9%-аар тус тус өссөн.

Прокурорын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр УЕПГ-ын цахим хуудсаар 371 удаагийн мэдээг нийтийн хүртээл болгосон байна. Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/07 дугаар тушаалаар "Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ажилд дүн шинжилгээ хийх аргачилсан заавар, дүн шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт"-ийг батлан гаргасан ба энэхүү аргачилсан зааварт зааснаар прокурорын газруудын гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлыг 4 үзүүлэлтээр дүгнэж хэвшээд байна.

2016 онд аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд нь нийт 41,408 эрүүгийн хэрэгт хяналт тавьснаас 7,2%-д нь буюу 3020 мэдэгдэл бичсэн нь 2015 оноос 3.5% буюу 1316 мэдэгдлээр өссөн, эрүүгийн нөхцөл байдал болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг 272 удаа судалсан нь 73 буюу 36.6%-аар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шалгалтанд 511 удаа оролцсон нь 58 буюу 12.8%-аар тус тус өссөн байна. Прокурорын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр УЕПГ-ын цахим хуудсаар 297 удаагийн мэдээг нийтийн хүртээл болгожээ.

Прокурорын газрууд нь хагас, бүтэн жилийн байдлаар эрүүгийн нөхцөл байдлын судалгааг гаргаж, аймаг, нийслэл, сум, дүүргийн ГХУСАЗСЗ-ийн дарга болон Засаг дарга нарт танилцуулга хүргүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах санал, зөвлөмж гаргах, сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалган тусалж, иргэдэд яриа таниулга хийх, баг, хороо, аж ахуйн нэгж, байгууллагуудыг прокуроруудад хуваарилан өгч ажиллуулан, хуулийн байгууллагуудтай хамтран тодорхой сэдвээр зөвлөгөөн, уулзалт, ярилцлага зохион байгуулж, иргэдийн дунд нээлттэй хаалганы өдөр, өдөрлөг, сургуулийн сурагчдын дунд "АХА", "Дэвжээ" тэмцээн зохион байгуулсан, их, дээд сургууль болон ЕБС-ийн сурагчдад сургалт явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллаж, ярилцлага, нэвтрүүлэг явуулсан, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санамж, зураг хуудас гаргаж, иргэдэд тараах, зам тээврийн осол их гарч байгаа замуудад анхааруулга, самбар байрлуулах, тодорхой төрлийн эрүүгийн хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл бичих зэрэг ажлыг хийж хэвшсэн байна.

Тухайлбал, 2016 онд Тээврийн прокурорын газраас нийтийн тээврийн үйл ажиллагаа явуулдаг компанийн жолооч нараас гаргаж байгаа зам тээврийн ослыг Замын хөдөлгөөний дүрмийн заалт бүрээр төрөлжүүлэн судалж, холбогдох газруудад мэдэгдэл хүргүүлж, Баян-Өлгий аймгийн прокурорын газраас АТГ-аас шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам болон төрийн албан тушаалтнууд гэмт хэрэгт холбогдож буй шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл тавьж хэлэлцүүлсэн, Нийслэлийн прокурорын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Нийслэлийн ИТХ-ын ажлын хэсэг, Нийслэлийн прокурорын газрын хооронд "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ"-г байгуулан уг гэрээний дагуу "Орон байр агуулах саванд нэвтэрч бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, гэмт хэрэг гарч буй шалтгаан нөхцөл"-ийг 2014 оны байдлаар Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрийн

хэмжээнд, "Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэгсдэд оногдуулж байгаа ял шийтгэлийн байдал"-ыг 2014 оны байдлаар Дүүргийн 2 дугаар прокурорын газраас шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд тус тус судалж, судалгааны дүнд үндэслэн хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, албан байгууллагуудад яриа таниулга хийсэн ажлууд нь улсын хэмжээнд шинэлэг, ач холбогдолтой болсон байна.

Нийслэлийн ЗДТГ-аас 2016 онд санаачлан, Нийслэлийн прокурорын газартай хамтран "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь Нийслэл хотын ажил" сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, Нийслэлийн прокурор "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд прокурорын оролцоо", Баянзүрх дүүргийн прокурор "Хулгайлах гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал" сэдвээр тус тус илтгэл тавьсан, Тээврийн прокурорын газар нь Нийслэлийн ГХУСАЗЗөвлөл, "Намуун зэт" студитэй хамтран зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, түүнээс гарах үр дагавар", "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай", "Явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох нь" сэдвээр 4 удаагийн цуврал нэвтрүүлэг бэлтгэн явуулсан, Хан-Уул дүүргийн прокурорын газар дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн тасаг, ШШГЕГ-ын харьяа баривчлах 431 дүгээр анги, дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхтэй хамтран "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгийг зохион байгуулж, 1500 орчим иргэдэд хууль хяналтын байгууллагыг сурталчлан, хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгч, гарын авлага, материалыг тараах, өдөрлөгийн талаар TV-9, NTV, MHCTV, TV-5 зэрэг телевизээр мэдээлсэн, Чингэлтэй дүүргийн прокурорын газар FM 96.3 радиогоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон төр, иргэн, ААН, байгууллага, албан тушаалтны хүлээх үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан, TV8 телевизид дүүргийн прокурор нь биечлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар мэдээлэл хийсэн, мөн MYOHPТелевизийн "Эрх зүйн хөтөч" нэвтрүүлэгт оролцож прокурорын байгууллагад өргөдөл, гомдол гаргах журмын талаар мэдээлэл хийсэн, Баянхонгор аймгийн прокурорын газар аймгийн хууль сахиулах байгууллагуудтай хамтран нээлттэй хаалганы өдөрлөгийг Жаргалант суманд хийж, энэ үеэр 2 эрүүгийн хэргийн нээлттэй шүүх хуралдаан зохион байгуулсан зэрэг ач холбогдол бүхий ажлуудыг зохион байгуулсан байна.

Прокурорын байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, шинэ түвшинд хүргэх зорилт тавин ажилласнаар энэ чиглэлээр хийсэн ажлын тоон үзүүлэлт жил бүр өссөн, прокурорын газрууд харъяа ГХУСАЗСЗ болон хууль хяналтын байгууллагуудын хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагаа сайжирсан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрсдөө санаачлан ач холбогдол бүхий олон ажил зохион байгуулсан байна.

Тулгамдсан асуудал

- Тус байгууллагын төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажилд зарцуулах зардал бага төсөвлөгддөг учраас харъяа сум бүртээ хүрч ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага, материал хэвлэж тараах, зураг хуудас, самбар байршуулах зэрэгт зарцуулах зардал хүрэлцээ муутай байна.
- Шинэ арга хэрэгслээр үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь хэргийн онцлог байдлаас шалтгаалан өөр өөр байдаг тул прокурор нь криминологийн судалгааны наад захын аргачлалыг хэрэглэх чадвартай байх төдийгүй арга барилаа шинэчлэхийг шаардаж байна.
- УЕПГ-ын Сургалт, судалгааны төв гадаадын зарим орны гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалдаг хүрээлэн, төвтэй холбоотой ажиллаж, туршлага солилцох,

тэдэнд мэргэжилтэн илгээж бэлтгэх, криминологийн судалгааны шинэ арга, арга зүйг практикт нэвтрүүлж үр дүнг хүртэх хэрэгтэй байна.

Шийдвэрлэх арга зам:

Иймд төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.


- "Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэн" прокурорын байгууллагын дэргэд байгуулагдан 10-аад жил ажиллаж байсан түүхтэй. Энэ туршлагыг харгалзан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, зөвлөмж боловсруулах ажлыг УЕПГ-ын Сургалт, судалгааны төвд хариуцуулж, хүний нөөцийг чадавхжуулах;
- Хууль сахиулах байгууллага тэр дундаа цагдаа, авлига, тагнуулын байгууллагууд, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах,
- ХЗДХЯ-аас хэрэгжүүлж буй цахим бүртгэл, мэдээллийн төсөлтэй нягт уялдуулах, гэмт хэрэг, зөрчлийн талаарх статистик мэдээ, тайлангаа гаргадаг тайлангийн хугацааг ижил болгож, ажлын уялдаа холбоог сайжруулах;
- Прокурорын байгууллага нь хууль сахиулах байгууллагуудтай хамтран түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг болон тодорхой төрлийн гэмт хэргийн талаарх криминологи судалгааг хийж, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Прокурорын газар нь өөрсдийн эрх, үүргийн талаарх мэдээллийг захиргааны байгууллагуудад хүргүүлж, мэдээллээр ханган, хамтарч ажилладаг байх шаардлагатай байна.

Хүснэгт VI.3.2.

Police science	Criminology	Penology
Цагдаагийн шинжлэх ухаан (криминалистикийн тактик, техник судлал)	Гэмт үзэгдэл судлал	Ялын бодлого судлал
Хууль сахулах байгууллага нь гэмт хэрэг үйлдэж байгаа арга, цаашдын чиг хандлага, түүнтэй тэмцэх, илрүүлэх аргыг боловсронгуй болгох асуудлыг судална.	Прокурорын байгууллага нь гэмт хэргийг яллаж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавьдагийн хувьд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлана.	Шүүх нь ялын хэрэгжилт, түүний үр нөлөөг судалж, цаашид баримтлах ялын бодлого, албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэглэх талаар бодлго боловсруулна.
Гэмт явдалтай тэмцэх тогтолцоо, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажиллагаа бүрдүүлнэ.		Ялын тогтолцоо, үр нөлөөтэй ялын бодлогыг хэрэгжүүлнэ.

Цаашид цагдаагийн шинжлэх ухаан, гэмт үзэгдэл судлал, ялын бодлогын хувьд гурвалсан дэд салбараас бүрдэх төрийн эрүүгийн бодлого байх учиртай гэж үзэж байна. Манай улстай ижил түвшний хөгжилтэй гадаад орны туханд энэ асуудлыг эрт шийдсэн бөгөөд цагдаа, прокурор, шүүх гэсэн нийгэмд шударга ёсыг тогтооход тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг гурван институтын тус бүрийн хувьд судлан хөгжүүлэх чиглэлүүд ойлгомжтой байдаг. Үүнийг криминологид суурилсан төрийн эрүүгийн бодлого гэх бөгөөд үр нөлөөтэй ял, шийтгэлийн системийг хэрэгжүүлж чадвал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд эерэг нөлөө үзүүлнэ.

ШҮҮХ, ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГАА



4. ШҮҮХ, ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГАА

1. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ

Шүүх шинэчлэл хийж, шүүн таслах ажиллагаа хараат бусаар явуулсны үр дүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн ахиц гарсан шийдвэрийн тогтвортой байдал хир байгаа талаар шүүн таслах ажиллагааны статистикийн тайлан мэдээнд үндэслэн дүн шинжилгээг хийв.

Хүснэгт VI.4.1.

№	Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он
1	Нийт шийдвэрлэсэн хэрэг	50222	56588	62216
2	Шүүгчийн тоо	475	516	520
3	Шүүхийн захиргааны ажилтны тоо	**1222**	**1327**	**1262**
4	Шүүхийн төсөв	59.6 тэрбум	52.1 тэрбум	48.9 тэрбум
5	Шүүхээс төрийн санд оруулсан орлого	10.0 тэрбум	12.6 тэрбум	15.1 тэрбум

Сүүлийн 3 жилийн байдлаар Монгол Улсын шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн тоо жил тутам тогтмол 9.9-12.7%-аар өссөн байна.

2.1. Анхан шатны шүүх[1]

Анхан шатны шүүхүүд 2016 онд нийт 10 120 хүнд холбогдох 7025 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 1368 хүнд холбогдох 730 хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, 42 хүнд холбогдох 22 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1148 хүнд холбогдох 782 хэргийг хэрэгсэхгүй болгож, нийт 5762 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 6566 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 14.75%-аар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 14.7%-аар тус тус буурсан дүнтэй байна.

График VI.4.1. Хянан шийдвэрлэсэн нийт хэрэг



Өршөөл үзүүлэх тухай хууль 2015 оны 08 дугаар сарын 11-ний өдөр батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нийт хүлээн авсан хэрэг, хүний тоо, шийдвэрлэсэн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо буурсан үзүүлэлттэй гарсан байх магадлалтай.

1 Анхан шат, давж заалдах шат, хяналтын шатны шүүхийн эрүүгийн хэргийн статистик тайлан мэдээг judinstitute.mn "Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан"-аас авав.

Хүснэгт 2. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо[2]

Хүснэгт VI.4.2.


№	Шүүх	Хэргийн тоо		Өсөлт бууралт		Ял шийт-гүүлэгч-дийн тоо		Өсөлт бууралт	
		2015 он	2016 он	Тоо	Хувь	2015 он	2016 он	Тоо	Хувь
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	138	117	-21	-15.2	202	152	-50	-24.8
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	80	73	-7	-8.8	95	88	-7	-7.4
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	169	167	-2	-1.2	180	182	2	1.1
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	136	109	-27	-19.9	144	126	-18	-12.5
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	76	47	-29	-38.2	96	60	-36	-37.5
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	76	75	-1	-1.3	73	67	-6	-8.2
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	285	216	-69	-24.2	351	290	-61	-17.4
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	134	101	-33	-24.6	153	106	-47	-30.7
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	209	138	-71	-34.0	257	180	-77	-30.0
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	95	50	-45	-47.4	116	50	-66	-56.9
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	78	59	-19	-24.4	83	72	-11	-13.3
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	239	197	-42	-17.6	291	241	-50	-17.2
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	152	117	-35	-23.0	161	112	-49	-30.4
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	150	112	-38	-25.3	161	142	-19	-11.8
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	120	86	-34	-28.3	134	102	-32	-23.9
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	147	134	-13	-8.8	170	140	-30	-17.6
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	271	400	129	47.6	250	291	41	16.4
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	136	94	-42	-30.9	170	155	-15	-8.8
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	123	87	-36	-29.3	152	103	-49	-32.2

2 "Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан" 11-12-р тал

20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	266	256	-10	-3.8	265	219	-46	-17.4
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	178	131	-47	-26.4	217	136	-81	-37.3
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	93	143	50	53.8	104	109	5	4.8
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	33	33	0	0.0	32	39	7	21.9
24	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	66	54	-12	-18.2	71	61	-10	-14.1
25	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	78	59	-19	-24.4	89	77	-12	-13.5
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	139	103	-36	-25.9	159	150	-9	-5.7
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	71	56	-15	-21.1	96	65	-31	-32.3
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	28	34	6	21.4	31	26	-5	-16.1
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	48	23	-25	-52.1	59	20	-39	-66.1
30	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх (Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг)[25]	1494	1240	-254	-17	1606	1561	-45	-2.8
31	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх (Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг)[26]	1191	1094	-97	-8.1	1466	1280	-186	-12.7
32	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	125	91	-34	-27.2	112	89	-23	-20.5
33	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	132	66	-25	-52.1	59	20	-39	-66.1
34	**Нийт**	**6756**	**5762**	**-994**	**-14.7**	**7696**	**6566**	**-1130**	**-14.7**

3 Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хууль 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж, 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хуулиар мөн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болж тус тусдаа харьцалах нутаг дэвсгэрийн хэргийг хянан шийдвэрлэдэг болсон ч нийлбэр дүнгээр тооцон гаргасан.


График VI.4.2. Сум, сум дундын, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо



Ял шийтгүүлэгчид: Ял шийтгүүлсэн нийт 6566 хүнийг зарим бүлгээр авч үзвэл 7.6% нь эмэгтэй, 5.5% нь насанд хүрээгүй этгээд, 27% урьд нь ял шийтгүүлж байсан, 26.3% согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 6.9% нь гэмт хэрэг давтан үйлдэж ял шийтгүүлжээ.

Нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс гэмт хэрэг согтуугаар үйлдсэн хүний тоо 1.7%-аар өссөн дүнтэй байна.


График VI.4.3. Ял шийтгүүлэгчид зарим бүлгээр



Шийдвэрлэсэн гэмт хэргийн төрөл: Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс тодорхой төрлийн 13 гэмт хэргийн шийдвэрлэлтийг өмнөх онтой харьцуулан харахад бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг 31.6%-аар буурсан бол мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг 1.8 дахин өссөн байна.


Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй цогц бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Энэ төрлийн гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад нийт хэрэгт эзлэх хувиараа бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 1.1%-аар, хүчиндэх гэмт хэрэг 0.6%-аар, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, борлуулах гэмт хэрэг 0.7%-аар мөн өссөн дүнтэй гарсан байна.

График VI.4.4. Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг



Хянан шийдвэрлэсэн зарим хэргийг ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл ял шийтгүүлэгчдийн тоо хүнийг санаатай алах гэмт хэрэгт 2%-аар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт 21.6%-аар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэгт 12.9%-аар, танхайрах гэмт хэрэгт 13%-аар, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэгт 14.2%-аар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт 13.7%-аар, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэгт 32.2%-аар, Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэгт 30.5%-аар, хүн худалдаалах гэмт хэрэгт 4 дахин буурсан бол, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгт 3.5%-аар, хүчиндэх гэмт хэрэгт 7.7%-аар, **мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэгт 81.5%-аар тус тус өссөн байна. Ө**мнөх онтой харьцуулахад нийт ял шийтгүүлэгчдэд эзлэх хувиараа бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгт 0.9%-аар, хүчиндэх гэмт хэрэгт 0.7%-аар, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, борлуулах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн 1.1%-аар мөн өссөн дүнтэй гарсан байна.

График VI.4.5. Зарим хянан шийдвэрлэсэн хэрэгт ял шийтгүүлсэн хүний тоо



Оногдуулсан ялын төрөл: Анхан шатны шүүхээр 2016 онд торгох ялаар нийт 216, албадан ажил хийлгэх ялаар 376, баривчлах ялаар 733, хорих ялаар 5114 хүн шийтгүүлсэн байна. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс биечлэн эдлүүлсэн 1823, тэнссэн 2866 хүн, насанд хүрээгүй этгээд 217, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 86 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна.

Зураг VI.4.1.



Өнгөрсөн оноос албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний тоо 18.8%-аар, баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 23.4%-аар, хорих ял оногдуулсан хүний тоо 11.2%-аар тус тус буурчээ. Үүнээс торгох ял шийтгүүлсэн хүний тоо 41.6%-аар буурсан ч нийт хэрэгт эзлэх хувиараа хорих ял оногдуулсан хүний тоо 3.1%-аар өссөн байна.

Хүснэгт VI.4.3. Оногдуулсан ялын төрөл

№	Ялын төрөл			Өсөлт, бууралт		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү
		2015 он	2016 он	Тоо	Хувь	2015	2016	/+/, /-/
1.	Торгох	370	216	-154	-41.6	4.8	3.3	-1.5
2.	Албадан ажил хийлгэх	463	376	-87	18.8	6	5.7	-0.3
3.	Баривчлах	957	733	-224	-23.4	12.4	11.2	-1.2
4.	Хорих	5757	5114	-643	-11.2	74.8	77.9	+3.1

Шүүхээс 2016 онд 216 хүнийг нийт 983.923.582 төгрөгийн торгох ялаар, 256 хүнийг нийт 104.037.910 төгрөгийн эд хөрөнгө хураах ялаар шийтгэж, тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах ялыг 86 хүнд, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 484 хүнд оногдуулжээ.


Хүснэгт VI.4.4. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах ял оногдуулсан хүн

№	Нэмэгдэл ялын төрөл			Өсөлт, бууралт	
		2015 он	2016 он	Тоо	Хувь
1.	Эд хөрөнгө хураах	450	256	-194	-43.1
2.	Тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах	87	86	-1	-1.1
3.	Тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах	594	484	-110	-18.5

Хорих ялын хугацаа: Улсын хэмжээнд 2016 онд шүүхээс нийт 5114 хүнийг хорих ял шийтгэснээс 512 хүнд 1 жил, 2299 хүнд 1-3 жил, 1418 хүнийг 3-5 жил, 497 хүнд 5-8 жил, 23 хүнийг 8-10 жил, 240 хүнийг 10-15 жил, 94 хүнийг 15-20 жил, 31 хүнийг 20-25 жилийн хорих ялаар тус тус шийтгэсэн байна.


Өнгөрсөн онтой харьцуулахад 1 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 7.9 хувиар, 1-3 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 14.8%-аар, 3-5 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 11.8%-аар, 5-8 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 5.5%-аар, 8-10 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 23%-аар, 20-25 жил 26.2%-аар тус тус буурсан бол 10-15 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 8.1%-аар, 15-20 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо 27%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь хүнд, онц хүнд гэмт хэргийн гаралт өндөр байгааг харуулж байна.

График.VI.4.6. Хорих ялын хугацаа




Хорих ялын дэглэм: Анхан шатны шүүхээс хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүмүүсээс 1230 буюу 67.6%-д жирийн дэглэмтэй хорих ангид, 559 буюу 30.7%-д чанга дэглэмтэй хорих ангид, 30 буюу 1.6%-д онцгой дэглэмтэй хорих ангид, 4 буюу 0.3%-д ялыг гянданд эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

График VI.4.7. Хорих ялын дэглэм



Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг: Ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр өмнөх онтой харьцуулахад 14-15 насны хүн 84 буюу 23.6%-аар, 16-17 насны хүн 73 буюу 20.9%-аар, 18-29 насны хүн 579 буюу 16%-аар, 30-34 насны хүн 116 буюу 8.9%-аар, 35-аас дээш насны хүн 336 буюу 14.5%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Ял шийтгүүлэгчдийн дотор 18-29 насны хүн 3037 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 46.3%-ийг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад дийлэнх хэсгийг эзэлсэн хэвээр байгаа нь энэ насны онцлогт тохирсон гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг нэгдсэн бодлогоор цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.


График VI.4.8. Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг



Ял шийтгүүлэгчдийн боловсрол: Нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс 902 буюу 13.7% нь дээд, 2 буюу 0.1% нь техникийн болон мэргэжлийн анхан шатны, 276 буюу 4.2% нь тусгай мэргэжлийн дунд, 2895 буюу 44.1% нь бүрэн дунд, 1269 буюу 19.3% нь суурь, 739 буюу 11.2% нь бага боловсролтой байх бөгөөд 483 буюу 7.4% нь боловсролгүй хүмүүс байна. (График 2.4) Ял шийтгүүлэгчдийг боловсролын түвшингээр нь өмнөх онтой харьцуулж үзвэл, дээд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 10.3%-аар, суурь боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 18.8%-аар, бага боловсролтой ял шийтгүүлэгчид 16.2%-аар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчид 11.8%-аар, боловсролгүй ял шийтгүүлэгчдийн тоо 16-%-аар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 26%-аар, техникийн

болон мэргэжлийн анхан шатны боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 3 хүнээр буюу 2.5 дахин буурсан үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онтой харьцуулахад дээд боловсролтой ял шийтгүүлсэн хүний тоо 0.7%-аар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлсэн хүний тоо 1.4%-аар тус тус өссөн нь анхаарал татаж байна.

График VI.4.9. Ял шийтгүүлэгчдийн боловсролын түвшин



Ял шийтгүүлэгчдийн эрхэлж байсан ажил, сурч байсан сургууль: Нийт ял шийтгүүлсэн иргэдийн 0.1% нь улс төрийн албан хаагч, 0.2% нь цэрэг, 0.6% нь төрийн захиргааны албан хаагч, 0.8% нь ТББ, ААН-ийн албан тушаалтан, 1.3% нь төрийн тусгай албан хаагч, 2.2% нь төрийн үйлчилгээний албан хаагч, 3.3% нь сурагч, 3.6% нь оюутан, 3.9% нь малчин, 21.4% нь бусад, 62.6% нь эрхэлсэн тодорхой ажил сургуульгүй хүн байна.

График VI.4.10. Ял шийтгүүлэгчдийн нийгмийн байдал



Нийт ял шийтгүүлсэн 6566 хүнээс Монгол Улсын иргэн 6546 хүн буюу 99.7%-ийг, гадаадын иргэн 19 буюу 0.3%-ийг эзэлж байгаа бол 1 харьяалалгүй хүн байна. Ял шийтгүүлсэн гадаад улсын иргэдийн тоо өнгөрсөн оноос 15 хүнээр буюу 44.1%-аар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд учирсан хохирлыг авч үзвэл амь хохирсон хүний тоо өмнөх оноос 8 хүнээр буюу 1.5%-аар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 611 хүн хүнд, 819 хүн хүндэвтэр, 1218 хүн хөнгөн гэмтсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулвал хүнд гэмтэл авсан хүний тоо 11%-аар, хөнгөн гэмтэл авсан хүний тоо 20.5%-аар тус тус буурсан бол хүндэвтэр гэмтэл авсан хүний тоо 1.6%-аар өсчээ.

Хүснэгт VI.4.5. Гэмт хэргийн улмаас амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол

Үзүүлэлт				Өсөлт, бууралт	
		2015 он	2016 он	Тоо	Хувь
Амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол	Амь хохирсон	518	526	8	1.5
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь хохирсон эмэгтэй	15	12	-3	-20
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь хохирсон насанд хүрээгүй этгээд	4	4	-	-
Гэмтэл	Хүнд	690	611	-79	-11
	Хүндэвтэр	806	819	13	1.6
	Хөнгөн	1532	1218	-314	-20.5

Улсын хэмжээнд 2016 онд шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээ 15 тэрбум 230 сая 342 мянга 818 төгрөг байна. Үүнээс улсад үүссэн хохирол 1 тэрбум 183 сая 929 мянга 75 төгрөг, ААН-д учирсан хохирол 1 тэрбум 577 сая 708 мянга 382 төгрөг, иргэдэд учирсан хохирол 12 тэрбум 468 сая 705 мянга 361 төгрөг байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээг өнгөрсөн онтой харьцуулвал 44 тэрбум 565 сая 806 мянга 994 төгрөгөөр буюу 74.5%-аар буурсан байна.

Хэргийн үлдэгдэл: Анхан шатны шүүхэд хугацаа хэтэрсэн хэргийн үлдэгдэл байхгүй хэдий ч хэргийн үлдэгдэл өмнөх оноос 5.8%-аар өссөн үзүүлэлттэй байгаа нь гэмт хэргийн ангилал, ээдрээ төвөгтэй байдал, шүүгчийн хэргийн ачааллыг судлан тогтоох шаардлагатайг харуулж байна.

2.1.1. Сэжигтнийг баривчлах арга хэмжээ

Улсын хэмжээнд 2016 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 769 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 713 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 56 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Баривчлах зөвшөөрөл олгосон нийт хүмүүсийн 3.6%-ийг насанд хүрээгүй хүмүүс, 5.6%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

ЭБША-ны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулвал 152 хүн буюу 16.5%-аар буурсан байна. Баривчлах зөвшөөрөл олгосон насанд хүрээгүй этгээдийн тоо өнгөрсөн оноос 16 хүн буюу 38.1%-аар, эмэгтэйчүүдийн тоо 45 хүн буюу 52.9%-аар тус тус буурсан байна.

Хүснэгт VI.4.6. Сэжигтнийг баривчлах арга хэмжээ


№	Утга	2015 он	2016 он
1.	Баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоо	921	769
	Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо	869	713
2.	Үүнээс Насанд хүрээгүй хүн	42	26
	Үүнээс Эмэгтэй	85	40
3.	Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо	52	56

Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо өнгөрсөн оноос 156 хүн буюу 18%-аар буурсан бол татгалзсан хүний тоо 4 хүн буюу 7.7%-аар өсчээ.

График VI.4.11. Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо



График VI.4.12. Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо



2.1.2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2016 онд шүүхээс 1747 хүнийг сэжигтнээр, 1895 хүнийг яллагдагчаар цагдан хорих шийдвэр гаргажээ. Нийт 3642 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгосноос 123 буюу 3.4% нь насанд хүрээгүй, 238 буюу 6.5% нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт VI.4.7. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан тухай мэдээ


№	Утга	2015 он	2016 он
	Цагдан хорих зөвшөөрөл олгосон нийт хүний тоо	**3227**	**3642**
1.	Сэжигтэн	1898	1747
2.	Яллагдагч	1329	1895
3.	Насанд хүрээгүй хүн	78	123
4.	Эмэгтэй	130	238

Шүүхээс цагдан хорих зөвшөөрөл олгосон хүний тоо 2015 оноос 415 хүн буюу 12.9%-аар өссөн үзүүлэлттэй байх бөгөөд цагдан хорих арга хэмжээ авсан сэжигтний тоо 151 хүнээр буюу 8%-аар буурсан бол, яллагдагчийн тоо 566 хүнээр буюу 42.6%-аар өсчээ. Түүнчлэн, цагдан хорих арга хэмжээ авсан насанд хүрээгүй хүний тоо 45 хүн буюу 1.5 дахин, эмэгтэйчүүдийн тоо 108 хүн буюу 1.8 дахин тус тус өссөн байна.

Цагдан хорих зөвшөөрлийн 1503 буюу 41.3%-ийг "оргон зайлж болзошгүй", 819 буюу 22.5%-ийг "хүнд гэмт хэрэг үйлдсэн", 712 буюу 19.5%-ийг "онц хүнд гэмт хэрэг үйлдсэн", 256 буюу "удаа дараа гэмт хэрэг үйлдэж байсан", 196 буюу 5.4%-ийг "өмнө авсан таслан

сэргийлэх арга хэмжээг зөрчсөн", 155 буюу 4.3%-ийг "оргон зайлсан үндэслэлээр" 1 буюу 0.1%-ийг "онц аюултай гэмт хэрэгтэн хэрэг үйлдсэн" үндэслэлээр тус тус олгожээ.

График VI.4.13. Цагдан хорих зөвшөөрөл олгосон үндэслэл



Баривчлах, цагдан хорих талаар гаргасан шүүгчийн захирамж: 2016 онд баривчлах, цагдан хорих талаар нийт 9746 шүүгчийн захирамж гарсан байна. Үүнээс сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай 3616, цагдан хорих хугацааг сунгах тухай 3453, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай 1352 болон сэжигтнийг баривчлах тухай 377 захирамж гарсан нь нийт захирамжийн 90.3%-ийг эзэлж байна. **Эдгээр сэжигтэн, яллагдагчаар баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүст холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж байгаа талаарх мэдээллийг шүүн таслах ажиллагааны тайлан мэдээнээс гаргах боломжгүй байгаа нь учир дутагдалтайг дурдах нь зүйтэй байна.**

2.1.3. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн байдал

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 74, 75 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333, 334 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн нийт 1510 хүний материалыг хянан хэлэлцсэнээс 19 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлж, 945 ялтныг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллаж, 486 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан бол 39 ялтны хорих ялын дэглэмийг хүндрүүлж шийдвэрлэсэн байна.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн тухай мэдээллийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт:

Хүснэгт VI.4.8. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн

№	Утга	2015 он	2016 он
1.	Эрүүгийн хуулийн 74, 75, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333, 334-р зүйлд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо	1813	1510
2.	Өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн	30	19
3.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан	1228	945
4.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө үлдсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай санал, дүгнэлтийг хэрэгсэхгүй болгосон хүний тоо	14	10
5.	Хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан бүгд	395	486
6.	Хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлсэн бүгд	67	39

Эрүүгийн хуулийн 74, 75 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333, 334 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоог 2015 онтой харьцуулан үзвэл 303 хүнээр буюу 16.7%-аар, өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн хүний тоо өнгөрсөн оноос 4 хүнээр буюу 28.6%-аар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд 2016 онд нийт 486 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан нь өнгөрсөн онтой харьцуулвал 91 хүн буюу 23%-аар өссөн, хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлсэн хүний тоо 28 хүнээр буюу 41.8%-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

График VI.4.14. Хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан





График VI.4.15. Хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлсэн



2.1.4. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн байдал

Улсын хэмжээнд 2016 онд 8318 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс 7003 зөрчилд захиргааны хариуцлага оногдуулж, 1307 тохиолдолд татгалзаж буцаасан байна. Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл оногдуулсан 179 шийдвэрийг давж заалдах журмаар хянаснаас 112 буюу 62.5%-д нь хэвээр үлдээж, 18 буюу 10.5%-д нь өөрчлөлт оруулж, 48 буюу 27%-ийг хүчингүй болгожээ.

График VI.4.16. Захиргааны зөрчил авагдсан




График VI.4.17. Захиргааны арга хэмжээ авахаас татгалзсан



Хүснэгт VI.4.9. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн мэдээлэл

№	Утга	2015 он	2016 он
1.	Бүгд	15159	8318
2.	Захиргааны арга хэмжээ авагдсан бүгд	14913	7003
3.	Арга хэмжээ авахаас татгалзаж буцаасан	245	1307
4.	Торгуулсан бүх хүн	945	1251
5.	Торгуулсан эмэгтэй	166	246
6.	Нийт торгуулийн хэмжээ (мян.төг)	15389205	191562940
7.	Баривчилсан бүгд	13966	5752
8.	Баривчлагдсан эмэгтэй	502	219
9.	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан	2	0
10.	Үлдэгдэл	1	8
Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн			
1.	Бүгд	222	179
2.	Үүнээс: Хэвээр үлдээсэн	164	112
3.	Өөрчлөгдсөн	40	18
4.	Хүчингүй болсон	18	49

Улсын хэмжээнд 2016 онд торгох арга хэмжээ авсан хүмүүсийн 19.7%-ийг, нийт баривчлагдсан хүмүүсийн 3.8%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал шүүхэд хүлээн авсан захиргааны зөрчлийн тоо 45.1%-аар буурсан байна. 2015 онд захиргааны арга хэмжээ авагдсан хүний тоо 14913 байсан нь 2016 онд 7003 болж 53%-аар буурсан байна. Харин торгуулсан эмэгтэйчүүдийн тоо 80 хүн буюу 49.3%-аар, баривчлагдсан эмэгтэйчүүдийн тоо 283 хүн буюу 56%-аар буурсан байна.

Захиргааны арга хэмжээ авахаас татгалзаж, буцаасан тохиолдол өнгөрсөн онд 245 байсан нь 2016 онд 1307 болж 5.3 дахин, торгуулсан бүх хүний тоо өнгөрсөн онд 945 байсан нь 2016 онд 1251 болж 7.5%-аар, нийт торгуулийн хэмжээ өнгөрсөн онд 15.389.205 төгрөг байсан нь 2016 онд 191.562.940 төгрөг болж 12.4 дахин тус тус өссөн дүнтэй гарсан байна. Анхан шатны шүүхэд буртгэгдсэн захиргааны зөрчлийн тоо 45%-аар буурсан нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зарим захиргааны зөрчил гаргасан этгээдэд ЗЦГ арга хэмжээ авах болсонтой холбоотой буурсан боловч 2016 онд УИХ-ын болон Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчийг сонгох сонгууль болсонтой холбоотойгоор захиргааны арга хэмжээ авахаас татгалзаж буцаасан, нийт торгуулийн хэмжээ өсөхөд голлон нөлөөлсөн байна.

График VI.4.18. Захиргааны арга хэмжээ авахуулсан хүний тоо



График VI.4.19. Захиргааны арга хэмжээ авахуулсан эмэгтэйчүүдийн тоо



Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн тоо өнгөрсөн онд 222 байсан бол 2016 онд 179 болж 19.3%-аар буурсан байна. Өнгөрсөн онд давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны 222 шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 164 буюу 73.8%-ийг хэвээр үлдээж, 40 буюу 18%-д өөрчлөлт оруулж, 18 буюу 8.1%-ийг хүчингүй болгож байсан бол 2016 онд 179 шийтгэврийн 112 буюу 62.5%-ийг хэвээр үлдээж, 18 буюу 10%д өөрчлөлт оруулж, 49 буюу 27.5%-ийг хүчингүй болгосон байна.

Баривчлах захиргааны шийтгэл оногдуулсан нийт хүний тоо өнгөрсөн онд 13966 байсан бол 2016 онд 5752 болж 8214 хүн буюу 41.2%-аар буурсан байна.

ДҮГНЭЛТ

Статитистик мэдээнээс харахад хэргийн эздрээ төвөгтэй байдал болон хүнд, онц хүнд гэмт хэргийн гаралт өмнөх жилээс нэмэгдсэн байгаа нь нийгмийн сэтгэл зүйтэй холбон тайлбарлаж болохоор байна. Өршөөлийн тухай хуультай холбоотойгоор шүүхэд хүлээн авч хянан шийдвэрлэсэн хэрэг багассан мэт үзүүлэлт гарсан ч онц хүнд гэмт хэрэг нэмэгдсэн нь маш том аюул гэдгийг хэлэх нь зүйтэй. Дан ганц шүүхэд ирсэн хэргээс үндэслэн төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлох боломжгүй. Эрүүгийн хэрэг үүссэнээс хэрэг архивт шилжүүлэх хүртэл бүх үе шатанд тухайн хэрэг хэрхэн яаж шийдвэрлэж байгаа талаар бодит судалгааг хийн цогц бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай. Сүүлийн жилүүдэд шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй мэдээлдэг болсон нь судлаачдад том судлагдахуун бий болсон.

2.2. Давж заалдах шатны шүүх

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 2016 онд нийт 1961 хэрэг хүлээн авч, 1822 хэргийг хянан шийдвэрлэж, 66 хэргийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 73 хэрэгт давж заалдах гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан байна. Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо өмнөх оноос 190 хэргээр буюу 8.8%-аар, үлдэгдэл хэргийн тоо 3 хэргээр буюу 6%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

График VI.4.20. Хянан шийдвэрлэсэн хэрэг



Хүснэгт VI.4.10. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг

№	Утга	2015 он	2016 он	Өсөлт, бууралт: Тоо	Өсөлт, бууралт: Хувь
1.	Хянан шийдвэрлэсэн бүх хэрэг	1971	1822	-149	-7.6
2.	Тогтоолыг хэвээр үлдээсэн	828	837	9	1.1
3.	Тогтоолд өөрчлөлт оруулсан бүгд	450	367	-83	-18.4
4.	Тогтоолыг хүчингүй болгосон бүгд	693	618	-75	-10.8
5.	Давж заалдсан гомдол эсэргүүцлээсээ татгалзсан	60	73	13	21.7
6.	Үлдэгдэл хэрэг	47	66	19	40.4
Тогтоолд өөрчлөлт оруулсан					
7.	Ял гэмт хэргийн хүнд хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй	251	143	-108	-43
8.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	199	224	25	12.6
Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн					
9.	Шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй	40	24	-16	-40
10.	Хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн	15	18	3	20
11.	Хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн	29	43	14	48.3
12.	Бусад	115	139	24	20.9
Тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн					
13.	Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан	292	242	-50	-17.1
14.	Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан	359	348	-11	-3.1
15.	Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгосон	42	28	-14	-33.3
Тогтоолыг хүчингүй болгосон үндэслэл					
16.	Тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй	478	421	-57	-11.9
17.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн	210	197	-13	-6.2
Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн					
18.	Шүүх хууль бус бүрэлдэхүүнээр тогтоол гаргасан	18	10	-8	-44.4
19.	Хуульд зааснаар шүүгдэгчийг заавал байлцуулбал зохих байтал түүнийг байлцуулаагүй	-	1	1	-
20.	Сэжигтэн, яллагдагч шүүгдэгчийг өмгөөлүүлэх эрхээр хангаагүй	7	5	-2	-28.6
21.	Зөвлөлдөх тасалгаанд болсон шүүгчдийн зөвөлгөөний нууцыг задруулсан	-	-	-	-
22.	Тогтоолд шүүгчийн хэн нэг нь гарын үсэг зураагүй	-	-	-	-
23.	Хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл байгаагүй	-	-	-	-
24.	Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч заавал оролцуулах хуулийн заалт зөрчсөн	1	0	-1	-100
25.	Бусад	184	181	-3	-1.6

Шийдвэрийн тогтвортой байдал: Давж заалдах шатны шүүх нийт 1822 хэрэг хянан шийдвэрлэснээс 837 хэрэгт буюу 45.9%-д анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, 367 хэрэгт буюу 20.2%-д нь тогтоолд өөрчлөлт оруулсан бол 618 хэрэгт буюу 33.9%-д нь тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Өөрчлөлт оруулсан: Анхан шатны шүүхийн тогтоолд "ял шийтгэл хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй" гэсэн үндэслэл 39%-ийг, шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй гэсэн үндэслэл 6.5%-ийг, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн гэсэн үндэслэл 4.9%-ийг, хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэсэн үндэслэл 11.7%-ийг эзэлж байгаа бол бусад үндэслэл 37.9%-ийг эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулвал, "ял гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй" гэсэн үндэслэл 108 буюу 43%-аар, шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй гэсэн үндэслэл 16 буюу 40%-аар тус тус буурсан бол хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн гэсэн үндэслэл 3 буюу 20%-аар хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэсэн үндэслэл 14 хэргээр буюу 48.3%-аар, бусад үндэслэл 24 хэрэг буюу 20.9%-аар тус тус буурсан байна. Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр тогтоолыг өөрчилсөн хэрэг өмнөх оноос өсөлттэй гарсан нь цаашид анхан шатны шүүгчид хууль хэрэглээний чадварыг дэмжихэд чиглэсэн сургалтыг үр дүнтэй зохоион байгуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

График VI.4.21. Анхан шатны шүүхийн тогтоолд өөрчлөлт оруулсан үндэслэл



Хүчингүй болгосон: Анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн нийт 618 магадлалаас 242 буюу 39.2%-д нь шүүхийн тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж, 348 буюу 56.3%-д нь тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол 28 буюу 4.5%-д нь тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулвал, шүүхийн тогтоолыг хүчингүй болгож хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хэргийг буцаасан хэргийн тоо 50 хэргээр буюу 17.1%-аар, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан хэргийн тоо 11 хэргээр буюу 3.1%-аар, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 14 хэргээр буюу 33.3%-аар тус тус буурсан байна.

Давж заалдах шатны шүүхийн нийт хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиар анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон үндэслэлийг өмнөх онтой харьцуулвал тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 0.9%-аар буурсан бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон хэрэг 1.5%-аар өссөн байна.

График VI.4.22. Шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байдал



Тогтоолыг хүчингүй болгосон үндэслэлээс "Тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй" гэсэн үндэслэл 57 хэрэг буюу 11.9%-аар, "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн" гэсэн үндэслэл 13 хэргээр буюу 6.2%-аар тус тус буурсан байна.

2.3. Хяналтын шатны шүүх

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхим 2016 онд нийт 454 хэрэг хүлээн авч, 337 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 22 хэрэгт Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж, албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд 88 хэргийг хянан буцааж, 6 хэргийн үлдэгдэлтэй байна. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 337 хэргээс 320 хэргийг гомдлын дагуу, 5 хэргийг прокурорын эсэргүүцлээр, 12 хэргийг прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэжээ.

Хүснэгт VI.4.11. Хяналтын шатны шүүн таслах ажиллагааны дүн


№	Утга			Өсөлт, бууралт (хувиар)
		2015 он	2016 он	
1.	Хүлээн авсан бүгд	520	454	-12.7
2.	Хуралдаанаар хянаж шийдвэрлэсэн бүгд	383	337	-12.0
3.	Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн	192	167	-13.0
4.	Тогтоол магадлалд өөрчлөлт оруулсан бүгд	113	81	-28.3
5.	Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бүгд	78	89	14.1
Өөрчлөлт оруулсан үндэслэл				
1.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	31	16	-48.3
2.	Шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй	5	5	-
3.	Хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн	3	4	33.3
4.	Эрүүгийн хуулийн 55[1].1, 62[1].1 дугаар зүйл	3	12	3 дахин
5.	Хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн	2	6	2 дахин
6.	Бусад	69	38	-44.9

Хүчингүй болгосон				
1.	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан	40	51	27.5
2.	Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаасан	20	20	-
3.	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	7	7	-
4.	Шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, магадлалыг хэвээр үлдээсэн	2	0	-
5.	Шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон	9	11	22.2
6.	Шийтгэх тогтоол магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон	-	-	-
	Хүчингүй болгосон үндэслэл			
7.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн	4	7	75
8.	Тогтоол, магадлалд дурьдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй	74	82	10.8
	Тайлангийн үлдэгдэл			
9.	Тайлангийн үеийн эцсийн үлдэгдэл	8	6	-25

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт 337 хэргээс 167 хэрэгт буюу 49.5%-д нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 81 хэрэгт буюу 24%-д нь өөрчлөлт оруулж, 89 хэрэгт буюу 26.5%-д нь тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн онтой харьцуулвал, анхан болон давж заалдах шатны шүүхээс гаргасан тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн хэргийн тоо 25 хэргээр буюу 13%-аар, тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан хэргийн тоо 32 хэргээр буюу 28.3%-аар тус тус буурсан бол тогтоол, магадлалыг хүчингүй болгосон хэргийн тоо 11 хэргээр буюу 14.1%-аар өссөн байна. Мөн хяналтын шатны шүүхийн нийт хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй орхисон хэрэг 0.6%-аар, тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан хэрэг 5.5%-аар тус тус буурсан бол тогтоол, магадлалыг хүчингүй болгосон хэрэг 6%-аар өссөн нь анхаарал татаж байна.

График VI.4.23. Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн байдал



Шүүхийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан үндэслэлийг авч үзвэл 16 хэрэгт буюу 19.7%-д нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, 5 хэрэгт буюу 6.2%-д нь шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй, 4 хэрэгт буюу 4.9%-д нь шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн,


6 хэрэгт буюу 7.4%-д хуулийг жинхэнэ агуулгаас нь зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэж үзжээ.

Хяналтын шатны шүүх нийт 89 тогтоол, магадлалыг хүчингүй болгосноос 51 хэрэг буюу 57.3%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан, 20 хэрэг буюу 22.5%-ийг шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаасан, 7 хэрэг буюу 7.9%-ийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх 89 хэргийг хүчингүй болгож шийдвэрлэхдээ 11 хэрэгт буюу 12.3%-д шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, шийтгэх тогтоол магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон тус тус шийдвэрлэсэн байна.

Үүнээс үзэхэд шийдвэрийн тогтвортой байдал жил ирэх тусам багасч байгаа тул анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт хууль хэрэглээний талаарх сургалтыг тогтмол хийж хэвшүүлэхээс гадна үр дүнтэй зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.

График VI.4.24. Шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байдал



Хяналтын шатны шүүх нийт 89 тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэснээс анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэсэн үндэслэл 7 хэрэг буюу 7.9%-ийг, тогтоол, магадлалд дурдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 82 хэрэг буюу 92.1%-ийг тус тус эзэлж байна.

График VI.4.25. Тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн үндэслэл



Өнгөрсөн онтой харьцуулвал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэсэн үндэслэл 3 хэрэг буюу 75%-аар, тогтоол, магадлалд дурдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 8 хэрэг буюу 10.8%-аар тус тус өссөн байна. Мөн тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн хэргийн эзлэх хэмжээний хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэсэн үндэслэл 19%-аар буурсан бол, тогтоол, магадлалд дурдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 19%-аар өссөн байна.

Анхан шатны шүүхийн тогтоолыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийвэл нийт эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шийтгэх тогтоолын 54% нь давж заалдах шатанд өөрчлөгдөж, хүчингүй болсон байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийвэл эрүүгийн хэргийн тогтоол магадлалын 50.4%-ийг өөрчилсөн болон хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Иймд цаашид анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлал хүчингүй болсон үндэслэл, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, анхаарах нэн шаардлагатай байна.

2.2. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал

Анхан шатны шүүхээс 2016 онд шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийн 31.6%-ийг нь давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 18.4%-ийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэжээ.

Эрүүгийн хэрэг: Давж заалдах шатны шүүхээс 2016 онд анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээсэн магадлал нь нийт магадлалын 45.9%, тогтоолд өөрчлөлт оруулсан нь 20.2%, тогтоолыг хүчингүй болгосон нь 33.9%-ийг тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулвал хэвээр үлдээсэн магадлалын эзлэх хэмжээ 3.8%-аар өссөн бол, өөрчлөлт оруулсан магадлалын эзлэх хэмжээ 2.6%-аар, тогтоолыг хүчингүй болгосон магадлалын эзлэх хэмжээ 1.3%-аар тус тус буурсан эерэг үзүүлэлт.

Шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн үндэслэлийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 11.9%-аар, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн үндэслэл 6.2%-аар буурсан нь эрүүгийн хэргийг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх талаар гарсан эерэг өөрчлөлт.

Хяналтын шатны шүүхийн 2016 онд нийт шийдвэрт шүүхийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж 50%, тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж 24%, тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн шийдвэр 26%-ийг тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн шийдвэрийн эзлэх хэмжээ өөрчлөгдөөгүй, тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан шийдвэрийн эзлэх хэмжээ 6 хувиар буурсан бол, тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн шийдвэрийн эзлэх хэмжээ 6 хувиар өсжээ.

Хяналтын шатны шүүх нийт 89 тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэснээс анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэсэн үндэслэл 7 хэрэг буюу 7.9%-ийг, тогтоол, магадлалд дурдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 82 хэрэг буюу 92.1%-ийг тус тус эзэлж байна. Иймд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн хууль хэрэглээний чадварыг нэмэгдүүлэх, шүүгчийг процессын алдаа гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

2.3. Шүүгчийн хэргийн ачаалал

2.3.1. Анхан шатны шүүх

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Шүүгчийн хэргийн ачааллыг тооцохдоо тухайн шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийг тайлант хугацаанд ажилласан[4] шүүгчийн тоонд харьцуулж гаргав. 2016 онд эдгээр шүүхэд нийт 55.8 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 43.7 хэрэг ногдож байна. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын хэргийн ачаалал дунджаас харьцангуй өндөр байгаа бол Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал харьцангуй бага байгааг харуулж байна.

Хүснэгт VI.4.12. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№		Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх / Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг/[3]	1240	22.2	55.8
2	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх / Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг/[4]	1094	25	43.7
3	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	91	4	22.7
4	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	66	4	16.5
5	**Нийт**	**2491**	**55.2**	**45.1**

Сум дундын эрүүгийн, иргэний хэргийн анхан шатны шүүх: Тайлант хугацаанд сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 67.3 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгч дунджаар 41.0 хэрэг шийдвэрлэсэн байна. Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 90.9 хэрэг, Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 65.6 хэрэг, Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 60.9 хэрэг ногдож байгаа дунджаас харьцангуй их ачаалалтай ажилласан байна.

Харин Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид дунджаар 18.8 хэрэг, Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан

4 Тайлбар: Тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн тоог тооцохдоо Шүүхийн хуний нөөцийн газраас гаргасан 1-12 саруудын тоон судалгаан дээр үндэслэн гаргасан болно. Тухайлбал Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 1 дүгээр сард 36 шүүгчтэй, 2-5 дугаар саруудад 39 шүүгчтэй ажилласан байна. Харин Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 6-12 дугаар саруудад 16 шүүгчтэй, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 6 сард 12 шүүгчтэй, 7-9 дүгээр саруудад 11 шүүгчтэй, 10-11 дүгээр сард 12 шүүгчтэй, 12 дугаар сард 11 шүүгчтэй, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 6-8 дугаар саруудад 11 шүүгчтэй, 9-11 дүгээр сард 10 шүүгчтэй, 12 дугаар сард 11 шүүгчтэй тус тус ажилласан байна. Эндээс 36 шүүгч нь тайлант хугацаанд бүтэн 12 сар, шинээр томилогдсон 1 шүүгч нь 11 сар, 1 шүүгч нь 10 сар, 1 шүүгч нь 5 сар ажилласан гэж тооцвол тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн дундаж тоо 38.2 байна. Өөрөөр хэлбэл, 1 шүүгч тайлант хугацааны 12 сар бүтэн ажилласан бол "1 бүхэл" гэж тооцогдох бөгөөд шинэ шүүгч томилогдсон тохиолдолд 1/12*ажилласан сар гэсэн аргачлалаар тооцсон болно.

27 "Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хууль 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж, 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хуулиар мөн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болж тус тусдаа харьяалах нутаг дэвсгэрийн хэргийг хянан шийдвэрлэдэг болсон хэдий ч шүүгчийн хэргийн ачааллыг гаргахдаа нийлбэр дүнгээс тооцож гаргасан болно.

6 Мөн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болж тус тусдаа харьяалах нутаг дэвсгэрийн хэргийг хянан шийдвэрлэдэг болсон хэдий ч шүүгчийн хэргийн ачааллыг нийлбэр дүнгээр тооцон гаргасан болно.

шатны шүүхэд нэг шүүгчид дунджаар 16.6 хэрэг ногдож байгаа нь дунджаас харьцангуй бага байгааг харуулж байна.

Хүснэгт VI.4.13. Сум дундын эрүүгийн шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	117	3.5	33.4
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	73	2.7	27
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	167	3	55.6
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	109	3	36.3
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	47	2.5	18.8
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	75	3.4	22
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	216	5	43.2
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	101	3	33.6
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	138	4	34.5
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	50	3	16.6
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	59	3	19.6
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	197	3	65.6
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	117	3	39
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	112	3	37.3
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	86	2.4	35.8
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	134	3	44.6
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	400	4.4	90.9
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	94	2.2	42.7
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	87	3	29
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	256	4.2	60.9
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	131	3	43.6
22	**НИЙТ**	**2766**	**67.3**	**41**

2.3.2. Давж заалдах шатны шүүх

Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ачаалал[7]:

Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2016 оны байдлаар нийт 94.4 шүүгч ажилласан бол нэг шүүгчид дунджаар 52.2 хэрэг ногдож байна. Нийслэлийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 100.4 хэрэг шийдвэрлэсэн байгаа нь дунджаас харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. хэрэг шийдвэрлэсэн нь харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 39.3 хэрэг, Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудын Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 39.2 хэрэг шийдвэрлэсэн нь орон нутгийн давж заалдах шатны шүүхүүдээс хамгийн өндөр байна. Харин Говь-Алтай, Завхан аймгуудын Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 19.3 хэрэг шийдвэрлэсэн нь дунджаас харьцангуй бага байна.

Хүснэгт VI.4.14. Эрүүгийн болон Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх		Шүүгчийн тоо	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Нийт хэрэг	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Дорнод, Хэнтий, Сухбаатар	Дорнод аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Хэнтий аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Сүхбаатар аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	8.7	139	**63**	202	23.3
Говьсүмбэр, Дорноговь	Говьсүмбэр аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Дорноговь аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6.1	90	64	154	25.3
Өмнөговь, Дундговь, Төв	Өмнөговь аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Дундговь аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Төв аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	8.8	114	105	219	25
Архангай, Баянхонгор, Өвөрхангай	Архангай аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Баянхонгор аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Өвөрхангай аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6.8	165	55	220	32.2
Говь-Алтай, Завхан	Говь-Алтай аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Завхан аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	5.5	61	45	106	19.3

7 Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж 2016 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөж байгаатай холбогдуулан Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ачааллыг тооцохдоо өмнөх хуулийн дагуу тооцсон болно.

Баян-Өлгий, Увс, Ховд	Баян-Өлгий аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Увс аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Ховд аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	7.1	76	202	278	39.2
Булган, Орхон, Хөвсгөл	Булган аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Орхон аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Хөвсгөл аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	12.6	203	237	440	35
Дархан-Уул, Сэлэнгэ	Дархан-Уул аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Сэлэнгэ аймгийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	9.8	141	242	383	39.3
Нийслэлийн Эрүүгийн, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх		29.2	833	2095	2928	100.4
Нийт		**94.4**	**1822**	**3108**	**4930**	**52.2**

Шүүгчийн хэргийн ачаалалд тухайн орон нутгийн гэмт хэргийн, гаралт хүн амын нягтаршил, дэд бүтцийн хөгжил, иргэдийн эрх зүйн мэдлэгийн байдал нөлөөлж байгаа нь харагдаж байна.

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын шүүхийн 2016 оны статистикийн нэгдсэн дүн мэдээ, түүнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Шүүгчийн хэргийн ачааллын хүрээнд:

- Шүүгчийн хэргийн ачаалалд тухайн орон нутгийн гэмт хэргийн гаралт, хүн амын нягтаршил, дэд бүтцийн хөгжил, иргэдийн эрх зүйн мэдлэгийн байдал нөлөөлж байгааг цаашид анхаарч, цогц арга хэмжээгээр хэргийн ачааллыг тэнцвэржүүлэх;
- Шүүгчийн хэргийн ачаалал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилтэй холбогдож буй эсэхийг судлан шинжлэх, түүнчлэн шүүгчийн орон тоо, шүүхийн хүний нөөцийн хуваарилалт зохистой байгаа эсэхийг шинжлэн судлах;
- Шүүгчийн хэргийн ачааллыг бодитойгоор, нарийвчлан гаргах арга зүйг нэвтрүүлж, тогтмол судлах, түүний үр дүнд шүүхийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх;

2. Шүүхийн захиргааны хүрээнд:

- Хэргийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж буй тохиолдлуудыг шинжлэн судалж, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн хэрэг нэмэгдэхээс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг уе шаттайгаар авч хэрэгжүүлэх. Энэ хүрээнд хэргийн хөдөлгөөний удирдлагыг бэхжүүлэн сайжруулах;
- Анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлал хүчингүй болсон үндэслэл, шалтгаан нөхцөлд нарийвчилсан дүн шинжилгээ хийх. Энэ хүрээнд шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах асуудлаарх сургалтыг зохион

байгуулах. Энэ тайланд дурдсан зарим төрлийн тогтмол, ихээр өсөх болсон гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг нарийвчлан судлах;

- Шүүхийн захиргааны байгууллагын зүгээс шүүн таслах үйл ажиллагааны тайлан мэдээг гаргах үүрэг бүхий ажилтныг мэргэшүүлэх, чадавхжуулах замаар холбогдох тайлан, мэдээний үр ашгийг бэхжүүлэх;
- Шүүн таслах үйл ажиллагааны статистикийн батлагдсан маягтыг бодит дүн шинжилгээг хийх зорилгод нийцүүлэн уян хатан, дэлгэрэнгүй болгон шинэчлэхэд анхаарах;

3. Шүүгчийн ур чадварыг сайжруулах хүрээнд:

- Шүүгчийн хууль хэрэглээний болон процессын алдаа гаргахгүйгээр хэргийг хянан шийдвэрлэхэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах;
- Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангалттай, зөв тайлбарлах, шүүхийн шийдвэрийг боловсруулах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг үе шаттай тогтмол зохион байгуулах;
- Шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулахтай холбоотой сургалтыг шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээтэй уялдуулан зохион байгуулах;

4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд:

- Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн боловсрол олгох цогц арга хэмжээг авах;
- Батлагдсан хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах, хуулийн үр дагаврыг ухуулан ойлгуулах системтэй мэдлэгийг олгох;
- Хууль тогтоогчийн зүгээс хэрэг, маргааны шийдвэрлэлтийн мэдээнд үндэслэн хууль, тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарах, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Гэмт хэрэгт холбогдож буй этгээдийн онцлогийг судлах, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилсан сэргийлэх арга хэмжээг нэгдсэн бодлогоор цогц байдлаар хэрэгжүүлэх;

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА




5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэлхийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагын хувьд Монгол Улс шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны хөгжлийн хувьд харьцангуй богино хугацааны түүхтэй бөгөөд Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гарах үед үйлчилж байсан Хууль зүйлийн бичиг, Жинхэнэ дагаж явах дүрмийн дараагаар 1926 онд батлагдсан Эрүүгийн хуульд хорих ялын эрх зүйн үндсийг анх удаа тусгаж өгснөөс хойш 90 гаруй жил өнгөрч байна. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор эрх зүйн шинэтгэлийн хүрээнд УИХ 2016 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлтэй уялдуулан боловсруулж, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, тэнсэх институт, зорчих эрхийг хязгаарлах ял зэрэг шинэлэчлэлийн үр дүнд харьцангуй дэвшилтэт хандлага ажиглагдаж байна.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд зохицуулж байсан нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарснаар хөгжлийн шаардлагад нийцүүлэн дээрх хуулиудад зарим өөрчлөлт оруулах шаардлагатай болсон бөгөөд 2012-2016 онд эрх зүйн шинэтгэлд холбогдох Эрүүгийн хууль тогтоомжууд бүхэлдээ батлагдаагүй хэд хэдэн удаа буцсан нь энэ байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байв.

Зураг VI.5.1.

ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН 2016 ОНЫ 10 САРЫН 10-НЫ ӨДРИЙН А/65 ТУШААЛААР БАТЛАГДСАН ШШГЕГ-ЫН БҮТЭЦ



Хорих ялын онцлог

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм бурууtай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга хэмжээ юм.[8]

Хорих ялыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд гэхчлэн нас, хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь эдлүүлэхээс гадна ялтанд үзүүлэх эрхийн хязгаарлалтын хэр хэмжээгээр өөр хоорондоо ялгарах дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлдэг. Энэ нь хүнд, онц хүнд гэмт хэрэгтнээс хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг, онц аюултай болон рецедив гэмт хэрэгтнүүдээс анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг тусгаарлан ялыг эдлүүлэх зорилготой байдаг.

Эрх зүйн орчин

Монгол Улсад гэмт хэрэг үйлдэж, гэм бурууtай нь шүүхээр тогтоогдсон хүнд хорих ял эдлүүлэхдээ Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.4-т "Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ.", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйл "Баривчлах байр, жирийн дэлгэмтэй хорих анги", 108 дугаар зүйл "Чанга, онцгой дэглэмтэй хорих анги", 109 дүгээр зүйл "Гяндан" гэсэн зүйл, хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу хорих ялыг эдлүүлж байна. Цаашид Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд нээлттэй, хаалттай хорих анги болон өсвөр насны хүний сургалт хүмүүжлийн байгууллага, хорихооос өөр төрлийн ял эдлүүлэх албa байгуулан шинэ соёл бүрдүүлэн ажиллах шаардлага үүснэ.

Монгол Улсад хорих ял эдлүүлж байгаа байдал

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7272 хүн хорих ял эдэлдэг. Урьд хийгдсэн судалгааны дүнгээс[9] үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 8000 байна.[10]

(Prison Brief for Mongolia")

Шоронд байгаа хүний тоо (цагдан хоригдож байгааг орсон)	**7690**2015 оны байдлаар
Ял эдэлж байгаа хоригдлын дундаж тоо (100.000 хүн тутамд)	**262** (2.7 сая хүн амтай) дэлхийд 216 улсаас 44-т жагсаж байна.
Эмэгтэй хоригдол (нийт хоригдлын дунд эзлэх хувийн жин/	**5.1%**
Хүүхэд (нийт хоригдлын дунд эзлэх хувийн жин/	**0.9%** (18 наснаас доош)
Хорих газар	**52** (24 хорих ял эдлүүлэх газар, 28 цагдан хорих төв)
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албa хаагч, ажилчдын тоо	**6182**

8 УДШ, Ханс Зайделийн Сан. "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар", 2010 он, Зохиогчдын хамтлаг. 162-163 дах тал


9 Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавх хэлтсийн хяналтын прокурор., "Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал", эрдэм шинжилгээний өгүүлэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл 2006 оны №2., 73 дах тал

10 Д.Дамдинцэрэн. "Шүүхийн шийдвэр, түүний хэрэгжилт" илтгэл. "Эрх зүйт төр-хууль ёсны хэрэгжилт" /Үндэсний зөвлөгөөний илтгэлүүд/. 2008 он. 162 дахь тал.

11 http://prisonstudies.org/country/mongolia last visited 2017.07.14/

Хүснэгт VI.5.1. Хорих ял эдлүүлсэн байдал (оноор)

2001	6,656	275
2002	7,256	297
2004	6,400	256
2006	6,593	258
2008	7,570	288
2010	7,044	260
2012	8,417	300



2002 оны Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд баривчлах ялыг "гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгах замаар сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх" хэлбэрээр эдлүүлэхээр заажээ. Гэвч баривчлах ял шийтгүүлсэн этгээдийг жирийн дэглэмтэй хорих ангид олноор нь хорих эсхүл бусад хоригдлын нэгэн адил ажил хөдөлмөр эрхлүүлэх зэргээр хуульд заасан ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчиж, хүний эрхийг хохироох явдал түгээмэл байна. Иймхүү хорих, баривчлах ялыг ялгамжгүй эдлүүлснээр Эрүүгийн хуульд заасан ялын зорилго биелэгдэхгүйд хүрч байв.

Иймээс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар баривчлах ялыг хассан бөгөөд хорих ял 6 сараас дээд тал нь 20 жил хүртэл хугацаатай байхаар зааж өгчээ.

Гадны зарим орны туршлагыг судлан[12] үзвэл зарим орны хорих ангийн төрөл, дэглэм нь пенологийн[13] хөгжлийн үе шатуудад тухай бүр зохицсон байдлаар хөгжиж, төлөвшиж ирсэн байна. Хуучин ЗСБНХУ задран бутрах үед "ГУЛАГ"[14]-ийн тогтолцоог хуулбарлан хэрэглэж байсан "посткоммунист" гэсэн тодотголтой Эстони, Латви, Польш, Чех, Унгар гэх мэт орон Европын холбоонд нэгдэн орохын тулд эрүүгийн болон шүүхийн шийдвэр

12 Dirk Van Zyl Smit, Frieder Dьnkel, / 2011/ "Imprisonment today and tomorrow: international perspectives on prisoners' rights and prison conditions

13 Penology: deterrence, prison, prison reform, prisoner abuse, prisoners' rights, rehabilitation, recidivism, retribution

14 "GULAG" нь хорих ангийн төрөл, дэглэмийн социалист системийн үеийн нэн түгээмэл хэлбэр бөгөөд хүний эрхийг ихэд дордуулсан, бусад байдлаар нэр төрийг нь гутаан доромжилж эрүүдэн шүүж харьцдаг байсан систем. Одоогийн зарим постсоциалсит орнууд ЗСБНХУ-ын хорих ангийн төрөл дэглэмийг хуулбарлан хэрэглэж байв.

биелүүлэх эрх зүйн системд шинэ өөрчлөлт хийж, хүний эрхийг баталгаажуулсан стандартыг хүлээн зөвшөөрч, тодорхой үр дүнд хүрч байна.

ШШГЕГ-аас 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээнээс дурдвал:

Тухайн онд нийт 5 гэмт хэрэг хорих ангийн хэмжээнд үйлдэгдэж (оргох 2, бусдын биед санаатай гэмтэл учруулах 3) урьд оныхоос 61%-аар буурсан байна. Ялтныг нийгэмшүүлэх, суллахад бэлтгэх хөтөлбөрийг хорих ангиудад хэрэгжүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулж чадсан байна. Хэдий ийм ч хорих ангид гарах гэмт хэргээс илүү хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажлыг хэрэгжүүлснээр гарсан үр дүнгийн талаар мэдээлэл хангалтгүй байна. Ялын зорилго нь цээрлүүлэхээс илүү нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл рүү хөгжиж байгаа учир цаашид тэнсэх, хорихоос өөр төрлийн ялыг шинэ түвшинд хөгжүүлэх, одоо байгаа дэд бүтцээ сайжруулах зэрэг ажил нь криминологийн ач холбогдолтой.

Зураг VI.5.2.



Тухайлбал, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр 2016 онд хийж гүйцэтгэсэн зарим ажлыг дурдвал:

Албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн 331 ялтны 91914 цагийн эдлүүлэхээс 278 ялтны 54894 цагийн ялыг дуусгавар болгож 53 ялтны 28789 цагийн ялыг хэсэгчлэн эдлүүлж, 53 ялтны 8241 цагийн үлдэгдэлтэй байна.

Торгох ялын хувьд гүйцэтгэх хуудасны биелэлт 94%, мөнгөн дүн 67.4%-тай, эд хөрөнгө хураах ялын гүйцэтгэх хуудасны биелэлт 89.5%, мөнгөн дүн 72.4%-тай байна.

Тухайн онд хорихоос өөр төрлийн ялыг хэрхэн биелүүлэх, хэрэгжүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ зэрэг эрх зүйн орчин тодорхойгүй, шүүхээс торгох ялыг биелүүлэх боломжгүй хүнд энэ ялыг оноодог, тодорхой эрхийг хасах ялыг мэргэжлийн эрхийг хассан тохиолдолд ямар байгууллагад хандах талаар зохицуулалт байхгүй зэрэг олон шалтгааныг 2016 оны үйл ажиллагааны тайланд дурджээ.

Эрүүгийн хууль хэдийгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ яв цав гүйцэтгэдэг ч ял шийтгэлийн эрүүл бодлого, үр нөлөөтэй тогтолцоо байхгүй бол зөвхөн цээрлүүлэх хэрэгсэл болон хувирдаг эрсдэлтэй. Гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт хорих ял оноогоод байвал рецедив гэмт хэрэгтэн өсч гэмт хэргийн карьер ахих боломжийг олгоно. Цаашид дэлхийн орнуудын эрүүгийн болон ялын бодлого нь гэмт хэрэг үйлдсэн хүнтэй тулж ажиллан, тухайн хүнд нөлөөлж чаддаг байхад чиглэж байна. Гэтэл бидний хувьд эрүүгийн эрх зүйн ялын бодлогын алдаа засах хэрэгсэл нь Өршөөл үзүүлэх тухай хууль болж хувирсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эрх зүйн салбарт хийж буй шинэчлэл, өөрчлөлтөд хурдтай дасан зохицож, бусад улсын сайн туршлагыг зээлдэн авах, өөрийн хөрсөнд буулгах зэргээр бодитой ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Тэнсэх институт (probation) ажиллуулах. Урьд нь ял оноосны дараа тэнсдэг байсан зохицуулалтыг өөрчилж, ял оноохгүйгээр тэнсэж 6 төрлийн үүрэг хүлээлгэх, 5 төрлийн эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авахаар заасан учир шүүхээс авсан дээрх арга хэмжээнд хяналт тавих, зөрчсөн тохиолдолд ахин шүүхээр хэлэлцүүлж ял оногдуулахаар санал гаргах арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокуророос хэрэгжүүлэх шаардлага бий болно. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд цахим гав, техникийн хяналтын арга хэрэгслүүд болон зарим тохиолдолд биечилсэн хяналт тавих арга хэмжээг шийдвэрлэх шаардлагатай. Одоо байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, ял шийтгэлийн нэгдсэн мэдээг үндэслэн урьдчилсан байдлаар тооцож үзвэл наад зах нь 2000-2500 орчим хүнд энэ төрлийн арга хэмжээг авах боломжтой байна. Үүний цаана танхайрах зөрчил нэрийн дор шийдвэрлэж байсан гэр бүлийн хүчирхийлэл, гэмтэл учруулахгүй боловч бусдын биед халдах гэсэн гэмт хэргүүдийг нэмбэл энэ тоо хоёр дахин нэмэгдэнэ.
2. Өсвөр насны хүнд оногдуулах ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх институт, салбар хоорондын хамтын ажиллагаа шаардагдана. Тухайлбал 2016 оны хаврын чуулганаар батлагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаллын тухай хуультай энэхүү арга хэмжээ зайлшгүй холбогдоно. НҮБ-ын санхүүжилтээр хэрэгжиж байсан хүүхдэд ээлтэй эрх зүйн шинэтгэл хөтөлбөрийн хүрээнд зарим аймагт ажиллаж байсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо цаашид Хүүхэд хамгаллын тухай хуулиар хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын бүтцэд байхаар заасан. Энэ хууль мөн 2016 оны 9 дүгээс сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Шүүхээс өсвөр насны хүнд оногдуулсан ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд прокурор, хууль сахиулах байгууллагаас гадна хүүхдийн хууль зүйн хорооны оролцоо, төрийн байгууллагын хамтын ажиллагаа хэрэгтэй болно.
3. Хуулийн этгээдэд ял оногдуулах гэсэн шинэлэг институтын хувьд торгуулийн ялаас гадна эрх хасах ялыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хяналт, нэгдсэн бүртгэлийн тогтолцоо шаардагдана. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг хэрэгжүүлэхэд тухайн хуулийн этгээд өөр байгууллагын нэрээр үйл ажиллагаа явуулахаас эхлээд зориуд дампуурах гэх мэтээр ял завших нөхцөлийг таслан зогсоох шаардлага үүснэ.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



6. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хууль сахиулах байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, шинжээчийн эрх зүйн байдлыг "хараат бус" байдлаар хуульчлах шаардлага зүй ёсоор тавигдаж, 2009 онд Шүүхийн шинжилгээний тухай хууль баталсан. Энэ хуулиар шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, зарим төрлийн шинжилгээний онцлог болон шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоож өгсөн юм.

ШШҮХ нь мөр судлалын, галт зэвсгийн, бичиг, гарын үсгийн, баримт бичгийн, хүний гадна дүр төрхийн, техникийн, галын, физикийн, химийн, биологийн шинжилгээнүүдийг хийдэг.

Шүүхийн шинжилгээний байгууллагын чиг үүрэг

Шүүхийн шинжилгээний байгууллага нь цагдаагийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурор, тагнуул, гааль, татварын газар зэрэг хууль хамгаалах байгууллагад үйлчилж, гэмт хэргийн холбогдолтой ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлж авах, түүнд шинжилгээ хийж гэмт этгээдийн үйлдлийг ул мөр, эд мөрийн баримтаар нь шинжлэх ухааны үндэслэлтэй нотлон тогтоох үүрэгтэй улсын хэмжээнд үйлчилж байгаа мэргэжлийн байгууллага.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь гэмт хэргийн газрын үзлэгт оролцож ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагын тогтоол шийдвэрээр криминалистик, шүүх эмнэлэг, шүүх нягтлан бодох бүртгэлийн шинжилгээ хийж магадлагаа, дүгнэлт гаргах, мэдээлийн сан бүрдүүлж ашиглах үндсэн чиг үүрэгтэй.

Бүтэц, удирдлага зохион байгуулалт

УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 44 дүгээр зүйлд "хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх эмнэлэг, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтанд оруулан материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна" гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2005 оны 63 дугаар тогтоолоор ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ШШҮХ-г байгуулан 12 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээ алба, сум дундын болон дүүргийн шүүхийн шинжилгээний хэсгээс бүрдэнэ. ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар "ШШҮХ-ийн бүтэц, орон тооны дээд хязгаар"-ыг шинэчлэн баталсан. Үүнд:


4. Захиргаа, удирдлагын газар;
5. Санхүү төлөвлөлт, хангамжийн газар;
6. Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс;
7. Криминалистикийн шинжилгээний газар;
8. Шүүх эмнэлгийн шинжилгээний газар;
9. Тусгай шинжилгээний газар;

10. Эдийн засгийн шинжилгээний хэлтэс;
11. Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс;

Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, алба, тасаг, хэсэг гэсэн бүтэцтэй буюу 6 газар, 3 хэлтэс, 7 тасаг, 22 алба, 8 хэсэгтэй, 514 албан хаагчийн орон тоотой байхаар заасан.

Зураг VI.6.1.

БҮТЦИЙН СХЕМ



Нийслэл, аймгийн шүүхийн шинжилгээний алба

Нийслэл, аймгийн шүүхийн шинжилгээний алба нь гэмт хэргийн холбогдолтой гарын хээний, хуурамч бичиг баримт, гарын үсгийн, гутлын мөр, малын болон тээврийн хэрэгслийн мөр, шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох үзлэг, шүүх задлан шинжилгээ, эд эрхтэний гистологи шинжилгээ, цусны бүлэг тогтоох, цусан дахь согтолтын зэрэг тогтоох, шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлагаа хийх зэрэг анхан шатны шинжилгээг богино хугацаанд хийж, шинжээчийн дүгнэлт гаргах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагад шилжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж хэргийг хурдан шуурхай шийдвэрлэхэд чухал ач холбогдол өгч байна.

Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба нь цагдаагийн байгууллагын жижүүрийн шуурхай албаны бүрэлдэхүүний хамт хэргийн газрын үзлэгт оролцон ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэн авах, тэдгээрт анхан шатны шинжилгээ хийж дүгнэлт гаргах бөгөөд шинжээчдийн дүгнэлттэй холбоотой үүссэн маргаан, давтан шинжилгээг ШШҮХ-д хийж байх, шинжилгээний төрөлжсөн нарийн мэргэжлийн лабораториудыг төвлөрүүлэн онц хүнд, ээдрээ төвөгтэй гэмт хэргийн үед шинжилгээг хүрээлэнгийн лабораториудад хийж нотлох дүгнэлт гаргаж байх, төвийн криминалистикийн болон шүүх эмнэлгийн бүрэлдэхүүнтэй шинжээчдийн гаргасан дүгнэлт нь эцсийн шатны дүгнэлт байхаар бүтэц, зохион байгууллалтыг хийсэн.

Аймгийн шүүхийн шинжилгээний албаны бүтэц, орон тоо нь тухайн аймгийн гэмт хэргийн тоо, эрүүгийн нөхцөл байдал, хүн амын суурьшлаас шалтгаалан харилцан адилгүй байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь бүртгэл мэдээллийн санг ашиглаж байгаа тухай: Шүүхийн шинжилгээний байгууллага нь дараах санг бүрдүүлж гэмт хэргийг илрүүлэх, нотлон тогтоох үйл ажиллагаанд ашиглаж байна.

Үүнд:

1. ***Генетик мэдээллийн нэгдсэн сан***
2. ***Гарын хээний сан:*** Гарын хээний санг цагдаагийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн албатай хамтран гэмт хэрэг илрүүлэх ажилд ашигладаг.
3. ***Галт зэвсгийн хонгио, хошууны сан:*** Галт зэвсгийн тухай хуулийн заалтын дагуу 21 аймаг болон нийслэл, дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд сумны хошуу авах зориулалт бүхий тоног төхөөрөмжийг суурилуулан иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа галт зэвсгийн загвар хонгио, хошуугаар сан бүрдүүлэн байна.
4. ***Хариуцах эзэнгүй хэн болох нь тогтоогдоогүй цогцосны сан:*** Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэст байгуулан эзэнгүй цогцос ирсэн тухай бүр цогцосны таних зураг, содон шинж тэмдэг, өмсөж байсан хувцасны зургийг дижитал аппаратаар авч, цогцос олдсон газар нутаг, хүргэж ирсэн цагдаагийн байгууллагын ажилтан, нэр албан тушаал зэрэг мэдээллийг компьютерт оруулан сан бүрдүүлжээ.

Цаашдын чиг хандлага, анхаарах асуудал

Нэгэнтээ "forensic science" гэх шинжлэх ухааныг манайд криминалистик-шүүх эмнэлэг гэж орчуулж, хуучин ЗСБНХУ-ын нөлөөгөөр хөгжүүлж ирснийг бид мэдэх билээ. Гэтэл энэ нь гэмт хэрэг илрүүлэх цогц шинжлэх ухаан юм. Зарим оронд (police science) хэмээн нэрлэж, хөгжүүлж ирсэн нь ч байна. Дэлхий дахинд шүүхийн шинжилгээ гэмт хэргийг илрүүлэх чиг үүргээ гүйцэтгэх замаар, мөн урьдчилан сэргийлэх чиг үүргийг гүйцэтгэх хэлбэрээр хөгжиж байна.

Тухайлбал, "forensic criminology" буюу сэтгэц гэм судлалын криминологи хурдацтай хөгжиж байна. Хуучин соцкриминологийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

уламжлалт аргыг хэрэглэж байх зуур шинэ криминологийн нэгэн ийм салбар үүсээд даруй тавин жил болжээ. Шүүх эмнэлэг тусдаа, криминологи тусдаа зүйл гэж онол, хичээл зааж байхад аль хэдийн эдгээрийн хосолсон салбар бий болоод хүний биеийн онцлог, сэтгэц гэм судлалыг ашигласнаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь үр дүнд хүрсэн байна.

Нийгэм хөгжихийн хэрээр 1940-өөд оноос эрчимжиж 1970-аад оноос хүн төрөлхтөний нэн хүнд асуудал болсон цуврал алуурчин, сэтгэл зүйн гаж зуршил, хэв маягийг зөвхөн нэг шинжлэх ухаан дангаар шийдэж чадахгүй болсон. Хүний тархи, сэтгэхүй гэдэг маш эмзэг эрхтэн бөгөөд гэмтвэл ямар нөхцөл байдалд хүргэхийг тааварлашгүй. Гэтэл үүнийг судалдаг шинжлэх ухаан, гэмт хэргийг судалдаг шинжлэх ухаан хамтдаа тулгамдсан асуудлаа шийдэх хэрэгцээ зайлшгүй гарч ирэв. Гэмт үзэгдэл судлаачид асуудлын мөн чанарыг хайж Ханс Гросс, Ч.Ломброз нарын дэвшүүлсэн "гэмт хэрэгтэн бие хүн гэдэг нийгмийн үзэгдэл, нийгмийн бүтээл тул түүний асуудлыг нийгмээс эрж хайх ёстой" гэдэг философид тулгуурласан онол чухалд тооцогдоно.

Мөн чанартаа хүн сэтгэцийн янз бүрийн бэрхшээлтэй нөхцөл байдалд хүч хэрэглэсэн гэмт хэргийг үйлддэг гэдгийг сэтгэц эмгэг судлалийн шинжлэх ухаан хөгжиж буй бүх шатандаа тодорхойлсон байдаг. Гэтэл энэ шинжлэх ухаан ихэнхдээ гэмт хэрэг үйлдэгдэж дууссан хойно буюу тухайн хүнийг шүүхийн өмнө яллахад л нотолгоо, хэрэг хариуцах чадваргүй байдал, шалтгаан нөхцөлийг судлахад л хэрэглэгдэж, эрдэмтэд нь шинжээч, мэргэжилтний үүрэг гүйцэтгэж ирсэн. Манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар ч энэ нь гагцхүү хэрэг үйлдэгдсэний дараа л яригддаг асуудал юм. Өөрөөр хэлбэл, хэрэг үйлдэгдсэний дараа шинжээчийн дүгнэлт гаргаж, мэргэжилтний хувиар оролцдог.

Тэгвэл "forensic criminology" нь гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө хүний сэтгэл зүйн хүчин зүйл, сэтгэцийн эмгэг, сэтгэцийн хөгжлийн хоцрогдол, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг урьдаас судалсны үндсэн дээр гэмт үзэгдлийн шалгааныг илүү бодитой гаргаж, урьдчилсан арга хэмжээг боловсруулах боломжтой болтлоо хөгжжээ. Цаашид энэ чиглэлд шүүхийн шинжилгээний салбарыг хөгжүүлэх шаардлагатай.

7. ХУУЛЬ САХИУЛАХ, БҮРТГЭЛИЙН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, чиг үүрэг, онцлог

Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлыг хангах зорилгоор Монгол Улсын хууль, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа тээш шалган нэвтрүүлэх, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагааг чиг үүргийн дагуу хил хамгаалах байгууллага хариуцдаг.

Үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичигт тогтоосон үндэслэл, тодорхойлсон журмыг баримтлан улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоо, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон цогц үйл ажиллагаагаар хууль ёсыг тогтоодог.

Хил хамгаалах үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна", 2 дахь хэсэгт "Монгол Улсын хилийг хуулиар бататгана" гэж заасны дагуу баталгааждаг бөгөөд УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", 2002 оны 20 дугаар тогтоолоор батлсан "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-оор тодорхойлогддог.

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээгээр тодорхойлогдсон улсын хилийн дэглэмийн зорилгод хамаардаг улсын хил хамгаалалтын төрөл болох улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа тээш шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журмыг сахиулах чиг үүргийг улсын хил хамгаалах байгууллага нэгдмэл тогтолцоог хангаж ажиллаж байна.

Улсын хил хамгаалах байгууллагын үндсэн чиг үүргийн нэг хэсэг нь хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Хил хамгаалах байгууллагын үндсэн чиг үүрэг:

- Улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах;
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;
- Улсын хилийн шугам, тэмдэг, холбоосны байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байж, хилийн асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх;
- Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа тээш зохих журмын дагуу нэвтрүүлэх;

Гэмт хэрэг, зөчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Улсын хил хамгаалах байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ улсын хил дамнасан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хил орчмын нутаг дэвсгэрт ард, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, үйл ажиллагаандаа тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэхдээ үндэсний болон олон улсын эрх зүйн тогтоосон хэм хэмжээг баримтлан ажиллаж ирсэн.

1. Хилийн нөхцөл байдалд хийж байгаа дүгнэлт:

Монгол-Оросын хилд: Мал хулгайлах, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд шилмэл үүлдрийн адуу, галт зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, хориглосон болон хязгаарласан эд зүйлийг хил нэвтрүүлэх, хоёр улсын иргэд үгсэн тохирч хил дамнан мал хулгайлах, дээрэм хийх, мал хил давах;

Монгол-Хятадын хилд: Манай улсаар дамжин БНАСАУ-ын иргэд гуравдагч орон руу дүрвэх, салан тусгаарлах, хэт даврах үзэлтнүүд, бичиг баримтаа үрэгдүүлсэн иргэд хил зөрчих, хоёр улсын иргэд үгсэн тохирч мал хулгайлах, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд зэвсэг, галт хэрэглэл, хар тамхи, мансууруулах бодис, хориглосон болон хязгаарласан эд зүйлийг хилээр нэвтрүүлэх, мал хил давах;

Хилийн боомтоор: Хуурамч баримт бичиг ашиглан хил зөрчих, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, зорчигч тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага гарах, зохион байгуулалттайгаар хориглосон болон хязгаарласан эд зүйлийг хилээр нэвтрүүлэх, зорчигч, тээврийн хэрэгслийн бөөгнөрөл үүсэх зэргээр хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил цаашид гарч болзошгүй.

Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийн талаар (2012-2016 он)

а) Хилийн дэглэмийн зөрчлийн талаар:

Монгол Улсын Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын хилийн хэсгээр мал хулгайлах, хориглосон болон хязгаарласан эд зүйл нэвтрүүлэх, хууль бус наймаа хийх, хил давсан малаа буцааж авах, ан амьтан агнах, байгалийн баялаг ашиглах, тэнүүчлэх, төөрөх, манай улсаар дамжин гуравдагч оронд гарах, цагаачлах хэлбэрээр 420 удаагийн 762 хүн хил зөрчсөнийг илрүүлэн, хууль зүйн дагуу шийдвэрлэсэн.

Монгол-Хятадын хилийг гадаадаас 95 удаагийн 169 хүн, дотоодоос 32 удаагийн 44 хүн, Монгол-Оросын хилийг гадаадаас 163 удаагийн 294 хүн, дотоодоос 130 удаагийн 255 хүн зөрчсөн.

Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын хилийн хэсгээр нийт 600 удаагийн 18243 толгой мал бэлчээрээр болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас хил давсныг хөрш орнуудтай байгуулсан хилийн дэглэмийн гэрээний дагуу шийдвэрлэсэн.

Монгол-Хятадын хилийг гадаадаас 54 удаагийн 2322 мал, дотоодоос 9 удаагийн 865 мал, Монгол-Оросын хилийг гадаадаас 332 удаагийн 9469 мал, дотоодоос 205 удаагийн 5587 мал давсан.

Монгол-Оросын хилд гадаадаас 11 удаагийн 69, дотоодоос 80 удаагийн 1419, Монгол-Хятадын хилд дотоодоос 4 удаагийн 49 нийт 95 удаагийн 1537 тооны мал Дорнод, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Хэнтий аймгуудын хилийн хэсгээр хил дамнан хулгайлагдсанаас нэг талын болон хамтарсан эрлийн үр дүнд 360 тооны малыг олж, эздэд нь хүлээлгэн өгч, ОХУ-ын талаас 953 тооны малыг нэхэмжилж байна.

Хилийн дэглэмийн зөрчлийн 18.7% нь Монгол-Хятадын, 81.3% нь Монгол-Оросын хилд үйлдэгдсэн байна.

б) Хил орчмын дэглэмийн зөрчлийн талаар:

Хилийн бүс, зурваст зөвшөөрөлгүй нэвтрэх, ашигт малтмал олборлох, хайгуул

хийх, байгалийн баялаг ашиглах, агнуурын амьтан агнах, барих хэлбэрээр Монгол-Хятадын хилд 338 удаагийн 1527, Монгол-Оросын хилд 339 удаагийн 2082 нийт 677 удаагийн 3609 хүн хил орчмын дэглэм зөрчсөнийг илрүүлж, 1287 хүнд Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу 35.4 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулсан.

Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын хилийн хэсгээр 934 удаагийн 60486 тооны мал бэлчээрээр болон байгалийн давагдашгүй нөхцөлийн улмаас хилд тулсныг тоггоон, ард иргэдийг 13.4 тэрбум төгрөгийн эрсдлээс урьдчилан сэргийлсэн.

Хил орчмын дэглэмийн зөрчлийн 41.9% нь Монгол-Хятадын хилд, 58.1% нь Монгол-Оросын хилд үйлдэгдсэн байна.

Сүүлийн 5 жилд үйлдэгдсэн зөрчлүүдийг өмнөх 5 жилтэй нь харьцуулахад хилийн зөрчил 64.5%, хил зөрчигчдийн тоо 71.9%, хил дамнан хулгайлагдсан малын зөрчил 39.2%, хил давсан малын тоо 12.0%, хилд тулсан малын тоо 22.6%-аар тус тус буурч, хил орчмын дэглэмийн зөрчил 47.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

в) Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журмын хэрэгжилтийн талаар:

Тус байгууллага нь 2012 оноос 2014 оны 04 дүгээр сарын 01-ний хооронд хилийн шалган нэвтрүүлэх албаны, 2014 оноос 2017 оны 02 дугаар сар хүртэл хугацаанд хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журам сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын ГХЯамнаас жил бүр БНХАУ-ын талтай дипломат шугамаар тохиролцож, түр ажиллагаатай хилийн боомтуудыг нэмэлт хуваариар нээн ажиллуулсан.

Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн, ГХЯ-аас ОХУ-тай харилцан нот солилцож, Алтанбулаг боомтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 24 цагийн ажиллагаанд, Ханги боомтыг 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс байнгын ажиллагаанд шилжүүлсэн.

Жилд дунджаар Монгол-Хятадын хилийн автозам, төмөр замын боомтуудаар 3 сая зорчигч, 1.8 сая тээврийн хэрэгсэл, Монгол-Оросын хилийн автозам, төмөр замын боомтуудаар 840000 зорчигч, 40000 тээврийн хэрэгсэл, агаарын замын Буянт-Ухаа, Чойбалсан, Өлгий, Ховд боомтуудаар 82000 зорчигч, 7000 тээврийн хэрэгсэл нэвтэрч байна.

Хилийн боомтуудад үйлдэгдсэн зөрчлийн илрүүлэлтийн талаар:

1. Хилийн боомтод мөрдөх журам зөрчсөн 1481 удаагийн зөрчлийг илрүүлж, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу 339 хүнд 16.4 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулсан.
2. Алтанбулаг, Цагааннуур, Боршоо, Замын-Үүд авто замын боомтуудаар улсын хил нэвтрэх эрхийн баримт бичигт штамп дараагүй 268, тээврийн хэрэгсэлд үзлэг хийгээгүй 1601, гаалийн байгууллагын шалгалтгүй 1083, хорио цээрийн хяналтын байгууллагын шалгалтаар ороогүй 323, нийт 3275 зөрчлийг хилийн боомтын журамд хяналт тавих манаанаы хяналтаар илрүүлж, гарч болзошгүй хилийн зөрчил, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлсэн.
3. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан алт, зэс, төмрийн хүдэр, хар тамхи, сэргээшийн төрлийн бэлдмэл, эм, сум, эртний үнэт эдлэл,

байгалийн чулуу, мах, амьтаны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд нууж, улсын хил нэвтрүүлэхийг завдсан 367 удаагийн 7 тэрбум 780 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, холбогдох байгууллагад шилжүүлсэн.

4. Хилийн боомтуудаар 2012-2014 онд хил нэвтрэх эрхийн баримт бичиггүй, бусдын баримт бичиг ашигласан, хуурамч баримт бичгээр гадаадаас улсын хил зөрчсөн 412, дотоодоос хил зөрчихийг завдсан 63, тээврийн хэрэгсэлд нуугдан хил зөрчсөн 3, нийт 478 зөрчлийг илрүүлж, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлж, шийдвэрлэсэн.

Хилийн боомтуудад 2014-2016 онд Гадаадын иргэн, харьяатын байгууллага (хуучин нэршлээр Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллага)-ын илрүүлсэн хил нэвтрэх эрхийн баримт бичиггүй, бусдын баримт бичиг ашигласан, хуурамч баримт бичгээр гадаадаас улсын хил зөрчсөн 170, дотоодоос хил зөрчихийг завдсан 10, нийт 180 хүнийг хүлээн авч холбогдох хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Хил нэвтрэх эрхийн баримт бичгийн зөрчилтэй 16 зорчигчийг хилийн төлөөлөгчийн шугамаар хүлээлгэн өгч, хөрш орнуудын шалган нэвтрүүлэх боомтуудад саатуулагдсан 77, буцаагдсан 51 иргэнийг хүлээн авч, хууль зүйн дагуу шийдвэрлэсэн.

3. Хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа (сүүлийн 3 жил), үр дүнгийн талаар

Засгийн газрын 2012 оны 110 дугаар тогтоолоор батлагдсан "Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн, улсын хил хамгаалалт, хангалт, үйлчилгээг зохион байгуулж байна.

Хөвсгөл, Булган, Сэлэнгийн хилийн хэсэгт ОХУ-ын талтай хамтарсан хил хамгаалалтыг зохион байгуулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажилласан.

ХХЕГ, ОХУ-ын ХАБА-ны Сибирийн холбооны тойргийн хилийг удирдах газар, БНХАУ-ын Цэргийн төв зөвлөлийн Батлан хамгаалах дайчилгааны ерөнхий газар, НАХЯ-ны Хилийн цэргийг удирдах газар, ӨМӨЗО-ны Дотоодыг хамгаалахын ХХЕА, ХАЧА-ийн ӨМӨЗО-ны Цэргийн тойргийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн уулзалтыг байгууллагын гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан,

Улсын хилийн зарим хэсгийг теле хяналтын камерын хамгаалалтад шилжүүлэн, хил хамгаалалтыг зохион байгуулж эхэлсэн.

Хилийн цагийн байдлын өрнөлт ихтэй, хил дамнан мал хулгайлдаг, хориглосон болон хязгаарласан эд зүйл нэвтрүүлдэг хилийн хэсэгт тусгай ажиллагааг бие дааж болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Хил дамнасан малын хулгай, хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор ОХУ-ын хил хамгаалах байгууллагатай хамтран тусгай арга хэмжээг 2016 онд зохион байгуулахад хилийн дэглэмийн зөрчил 42.2%, хулгайлагдсан малын зөрчил 35.2%, хилээр мал давсан зөрчил 28.4%-аар тус тус буурсан.

Хөрш улсуудын хил хамгаалах байгууллагатай хамтран Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баян-Өлгий, Увс, Сэлэнгийн хилийн хэсэгт "Хил зөрчигчийг эрэх саатуулах үеийн хамтарсан ажиллагаа", "Хил дамнасан малын хулгайн зөрчлийг таслан зогсоох нь", "Хилийн боомтод эмх замбараагүй байдал үүссэн үеийн ажиллагаа" сэдэвт дадлага, сургуулийг хамтран зохион байгуулсан.

ХЗДХСайдын 2016 оны Б/1625 дугаар тушаалын дагуу ХСИС-тай хамтран Сэлэнгэ аймаг дахь тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд "Терроризмтэй тэмцэхэд

байгууллагуудын хамтын ажиллагаа, чадавхийг нэмэгдүүлэх нь" сэдэвт "Сэлэнгэ-2016" команд штабын сургуулийг зохион байгуулсан.

Увс аймгийн Улаангом хотод "Хил дамнасан хууль бус үйлдэл малын хулгайтай тэмцэх нь" сэдэвт нэгдсэн зөвлөгөөнийг 2016 онд зохион байгуулж, ХЗДХЯам, орон нутгийн хууль хяналтын байгууллагууд, ОХУ-ын Тува улсын хууль хяналтын байгууллагууд оролцсон.

ХЗДХСайдын 2015 оны А/35 дугаар тушаалын дагуу "Тал хээр", Говь цөл", "Уул", "Ой тайга"-ын бүсүүдийн Хил хамгаалалтад туслах хүчний нэгдсэн зөвлөгөөнийг Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий, Булган аймагт Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл (ХХТХЗ), гишүүд, харилцан ажиллагаатай байгууппагуудын төлөөллийн оролцоотойгоор зохион байгуулж, хилийн 14 аймаг, 70 сумдын удирдлага 95 хүн, ХХТХ-ний 625 төлөөлөгч оролцсон.

Хилийн отрядууд орон нутгийн хууль хяналтын байгууллага, аймгуудын ХХТХЗ-тэй хамтран давхардсан тоогоор 3600 гаруй ард иргэдэд Монгол Улсын "Хилийн тухай хууль", "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам", "ХХТХЗ-өөс гарсан зөвлөмж" зэрэг эрх зүйн баримт бичиг, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар сар бүр яриа, таниулгын ажлыг зохион байгуулсан.

Дээрх зөвлөгөөн, орон нутгийн хууль хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн хууль сурталчилах арга хэмжээ нь хил хамгаалах байгууллага, аймаг, сумын ХХТХЗ, гишүүдийн хамтын ажиллагааг тодорхойлсон, хилийн зөрчлөөс уръдчилан сэргийлэх, таслан зогсоох, орон нутгийн иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн чухал арга хэмжээ болсон.

Мөн хилийн аймгуудын ИТХ-ын дарга, Засаг дарга, сумдын Засаг дарга нартай "Хил хамгаалалтад орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" сэдэвт зөвлөгөөнийг ХХЕГ-т зохион байгуулсан.

Өнөөгийн байдлаар улсын хил хамгаалалтад хилийн 14 аймгийн ХХТХ-ний 1410 гишүүдийг хил хамгаалалтад биечлэн болон оршин суугаа байршлаар нь оролцуулж байна.

Улсын хил хамгаалалтад орон нутгийн удирдлага, ХХТХ-ний гишүүд, хил орчмын иргэдийн идэвх, оролцоо дээшилж, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил буурсан.

Улсын хилийн шугамын явалтыг тодорхой болгох, хилийн дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Буйр нуурын усан хилийг тэмдэгжүүлэх асуудлыг Монгол, Хятадын хилийн хамтарсан комиссын II хуралдаанаар тавьж, хоёр улсын Усны хамтарсан комисс усан хилийн шугамын дагуу гүний хэмжилт хийсэн.

БОАЖЯ-тай хамтран Сэлэнгэ, Хэнтий, Дорнодын хилийн хэсэгт хилийн дэглэмийн зөрчил, ойн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 62.7 км ойн зурвас, 612 км шороон зурвасыг байгуулсан.

4. Тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам

а) Тулгамдаж буй асуудлууд

- Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, зөрчлийн тархалт;
- Улсын хил хамгаалалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Хилийн нөхцөл байдалтай уялдуулан зэвсэглэл, тусгай техник, тоног төхөөрөмж, технологийг өөрчлөх шаардлага үүссэн;
- Улсын хилийн нөхцөл байдал, техник, технологийн дэвшилд нийцүүлэн хил хамгаалалтын арга, хэрэгслийг сайжруулах;
- Бие бүрэлдэхүүний алба хаах, үүрэг гүйцэтгэх ахуй нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгааг бэхжүүлэх.

б) Шийдвэрлэх арга зам

- Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Хилийн тухай хууль, Хил хамгаалалтын дүрмүүдийн хэрэгжилтийг сайжруулах;
- Улсын хил хамгаалалтын эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Хилийн боомт, усан хил хамгаалалт (Бүйр нуур)-ыг зохион байгуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хилийн албаны сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, гэрээт албыг бэхжүүлэх;
- Гадаадын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Улсын хил хамгаалах орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх;
- Улсын хил хамгаалалтад орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, иргэдийг хилийн бүс, зурваст тогтвортой суурьшуулан хязгаар нутгийн эзэмшлийг сайжруулах;
- Хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлж, хилчдийн алба хаах, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

Дүгнэлт

Хилийн тухай хууль УИХ-ын 2016 оны намрын чуулганаар батлагдан улмаар шинэ эрх зүйн орчинд бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, тодорхой үр дүнтэй ажилласан амжилтаар дүгнэж болох бөгөөд цаашид орчин үеийн нийгмийн хөгжил, амьдралын хандлага, сэтгэл зүйн шинэ орчин, мэдээллийн хүртээмж зэрэг нөхцөл байдалтай уялдуулан улам хөгжүүлэхэд дараах дутагдлыг арилгах шаардлагатай байна. Үүнд:

Байгууллагын эрх зүйн орчин, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэн мэргэжлийн албаны зохион байгуулалттайгаар, мэргэшсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгох (материаллаг болон процессын хууль) тухайлбал, байгууллагын тухай хуульд тодорхойлсон үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хуулийг баримтлан бүтэц, тогтолцоог бий болгох, үйл ажиллагааны хуулийг баримтлан ажиллах, мэдээ тайланг чиг үүргийн дагуу тодорхой гаргах шаардлагатай.

Хилийн болон хил орчмын дэглэмийн аюулгүй байдлыг бүрэн хангах, далд эдийн засгийн үр дагавар болсон үндэстэн дамнасан, зохион байгуулалттай үйлдэгддэг нуугдмал гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд хяналт, шалгалт, бүртгэлийн үйл ажиллагааны суурь мэдээллийн нөөцийг (сан) бүрдүүлэхэд анхаарах.

Шинэ нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдыг ажлын байрны дараах сургалт, диплом, боловсролын анхисан шатны зэргийн сургалтад хамруулах, сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай.

Үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг өргөн ашиглахаас гадна, шинэ санаачилга гаргах, шинжлэх ухаанд суурилсан захиалгат судалгааны ажлын үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Хилийн бүс дэх хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хяналт-хэмжилтийн ухаалаг технологи, радио долгионоор мэдээлэл цуглуулах технологи нэвтрүүлэх ажлыг шинжлэх ухаанд суурилсан захиалгат судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Хилийн болон хил орчмын дэглэмийн гэмт хэрэг, зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээ бага учир хуулийн хариуцлагын үр нөлөөгүй нөхцөл байдлыг судлах, чангатгах.

Хилийн болон хил орчмын дэглэмийн аюулгүй байдал, хууль сахиулах үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайн туршлага, шилдэг арга-техникийг өөрийн орны онцлогт уялдуулах, үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зэрэг дутагдалтай байна.

Гадаадийн иргэн, харъяатын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, чиг үүрэг, онцлог

Гадаадын иргэн, харьяатын байгууллага нь гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон үйл ажиллагааг үндэсний болон олон улсын эрх зүйн тогтоосон хэм хэмжээг баримтлан эрхлэн гүйцэтгэж байна.

Хүний эрхийг дээдлэх, гадаадын улсын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой аливаа асуудлыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн.

Үндсэн чиг үүрэг:

- Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх;
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Иргэний харьяалал, цагаачлал, гадаадын гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- Гадаадын иргэдийн хяналт, виз, визийн зөвшөөрлийн болон улсын хил нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах, хөтлөх;
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүргийг хэрэгжүүлж байна.

Гадаадын иргэн, харъяатын асуудал хариуцсан байгууллага хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишиг хүрсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэн чиг үүргийн дагуу ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

ГИХГ нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль, Хилийн боомтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаас гадна Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, ХЗДХСайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласнаар дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

1. Албан хаагчийн эрх ашгийг хамгаалах, сэргийлэх чиглэлээр албан хаагчдад сургалт зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөөг тогтмол өгч, санал хүсэлтийг нь сонсож, үйл ажиллагаандаа тусган ажилласнаар албан хаагчийн ажиллах нөхцөл сайжирсан;

2. Хууль хяналтын болон төрийн байгууллагаас албан хаагч урьж төв, орон нутаг дахь газруудын албан хаагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хичээл сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсанаар албан хаагчдыг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж чадсан;
3. Төв, орон нутаг дахь газруудад Ёс зүйн хороог байгуулсан ба албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, сэтгэл зүйг төлөвшүүлэх талаар 15 удаагийн сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлж ажилласан;
4. Бүгд Найрамдах Солонгос Улсын "Койка" олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран гадаадын иргэдийн болон хилийн шалган нэвтрүүлэх бүртгэлийн үйл ажиллагаанд шинээр "ISM" системийг бий болгон ашиглаж, хилийн шалган нэвтрүүлэх болон гадаадын иргэний бүртгэлийн системийг нэгтгэсэн. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа болон гадаадын иргэдийн бүртгэлийн үйл ажиллагаанд хувь хүний "биометрик дата" ашиглах болсноор бичиг баримт хуурамчаар ашиглах байдлыг таслан зогсоож хяналт шалгалтын үйл ажиллагаа сайжирсан;
5. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд цахим гарц (auto gate)-ын шинэ технологи ашиглаж эхэлснээр зорчигчийг бүртгэх цаг хугацаа хэмнэх, таних чадавхи нэмэгдэж, хилийн шалган нэвтрүүлэх чадавхийг нэмэгдүүлсэн;
6. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын /хуучин нэрээр/ даргын 2016 оны А/80 дугаар тушаалаар батлагдсан "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын компьютер техник хэрэгсэлд ашиглах нууц үгийн журам"-ын дагуу ямар нэгэн утга илэрхийлэхгүй, том болон жижиг үсэг тоо, тусгай тэмдэгт агуулсан 15-аас доошгүй тэмдэгтийн урттай, аль нэг хэл дээр орчуулагдахааргүй, хэрэглэгчийн хувийн мэдээллийг илэрхийлээгүй нэвтрэх болон системийн нууц үгүүдийг боловсруулж байгууллагын нийт компьютерт нэвтрэх болон системийн нууц үгүүдийг сольж, компьютер дахь нууцлал, аюулгүй байдлыг ханган ажилласан;
7. Байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөөнд заасан хугацаанд болон шинээр ажилд орсон албан хаагчдад тухай бүр сургалтыг зохион байгуулж ажилласан;
8. Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор төв, орон нутаг дахь газруудын албан хаагчдад "Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх", "Мэдүүлэг гаргах тухай" сэдвүүдээр сургалт зохион байгуулсан;
9. АТГ-аас бэлтгэсэн сурталчилгааны материалыг орон нутаг дахь газарт хүргүүлж, хилийн боомтуудад "Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах гарын авлага", "Ашиг сонирхолын зөрчлийн тухай мэдлэг ойлголтыг олон нийтэд түгээн таниулах гарын авлага"-ыг шуудангаар, авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх, мэдүүлэг гаргагчдад зориулсан хичээлийн иж бүрдэлийг боомтуудад дотоод сүлжээгээр хүргүүлэн албан хаагчдад бие даан судлах боломжийг хангаж ажилласан. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах зорилгоор судалгаанд хамрагдсан албан хаагчдын үйл ажиллагааг хянах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, Авлигын эсрэг хуулийн 3, 5, 7, 33 дугаар зүйлийн заалтуудыг танилцуулж тусгай маягтын дагуу авлигаас ангид байх баталгаа авах ажлыг зохион байгуулж хэвшүүлсэн;
10. Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу иргэд, байгууллагын зүгээс мэдээллийг чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс төв болон бүсийн газруудад цахим хуудас, хилийн боомтод олгож буй визийн хураамж, үнэ тариф, үзүүлж буй

үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг мэдээллийн самбарт байршуулж ажилласан. Ингэснээр албан хаагчид авлигаас урьдчилан сэргийлэгдэж чадсан;

11. Байгууллагад ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, жолооч нарт дүрэм, журмыг судлуулж ажилласнаар зам тээврийн осол гараагүй;
12. Түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын хор, гал унтраах усны хоолойн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаатай эсэхэд үзлэг шалгалт хийсэн;
13. Байгууллагын аюулгүй байдлыг хангах, гадны үзэгдэх орчныг сайжруулах зорилгоор ажлын байрны гаднах гэрэлтүүлгийг болон аюулгүй байдлыг хангахын тулд хяналтын камерыг сайжруулан тус тус нэмж тоноглон ажилласан;

Дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын байгууллага нь шинэ эрх зүйн орчинд бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, тодорхой үр дүнтэй бүтээлч ажилласныг дүгнэж болох бөгөөд цаашид хөгжлийн түгээмэл хандлага, орчин үеийн нийгмийн хөгжил, даяаршил, хүний амьдралын хэв маяг, сэтгэл зүйн өөрчлөлтийн шинэ орчин, мэдээллийн хүртээмж зэрэг нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэхэд дараах асуудалд анхааран ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Байгууллагын эрх зүйн орчин, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэн мэргэжлийн албаны зохион байгуулалттайгаар, мэргэшсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгох (материаллаг болон процессын хуулийг төрөлжүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх), Тухайлбал, байгууллагын тухай хуульд тодорхойлсон үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хуулийг баримтлан бүтэц, тогтолцоог бий болгох, үйл ажиллагааны хуулийг баримтлан ажиллах, мэдээ тайланг чиг үүргийн дагуу тодорхой гаргах;

Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, далд эдийн засгийн үр дагавар болсон үндэстэн дамнасан, зохион байгуулалттай үйлдэгддэг нуугдмал гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд хяналт, шалгалт, бүртгэлийн үйл ажиллагааны суурь мэдээллийн нөөцийг (сан) бүрдүүлэхэд анхаарах;

Шинэ нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдыг ажлын дараах сургалт, диплом, боловсролын ахисан шатны зэрэг сургалтад хамруулах, сэтгэлгээг өөрчлөх;

Албаны тангараг, ёс суртахууны талаарх хэм хэмжээг гадаадын хөгжилтэй улс орнуудын зохицуулалттай харьцуулан судалж, сайн жишгийг өөрийн онцлогт уялдуулах;

Үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг өргөн ашиглах, шинэ санаачилга гаргах, шинжлэх ухаанд суурилсан захиалгат судалгааны ажлын үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

Хилийн бүс төдийгүй улсын хэмжээнд хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хүний эрхийг баталгаатай хангах, хяналт-хэмжилтийн ухаалаг технологи нэвтрүүлэх, шинжлэх ухаанд суурилсан захиалгат судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгоход үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээний үр нөлөө, ач холбогдлыг судлах, шинэчлэх;

Хууль сахиулах үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайн туршлага, шилдэг аргыг өөрийн орны онцлогт уялдуулах, үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;.

Оюуны өмч, улсын бүртгэлийн байгууллага

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай", "УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол", "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоол, "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоол, ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/16 тоот тушаалаар ОӨУБЕГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтэц, орон тооны дээд хязгаарыг 1259 байхаар батлаж, зохион байгуулалтын өөрчлөлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иргэний эрх, язгуур ашиг сонирхолд суурилсан бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний эрхийг хангах, засаглалын ой санамжийг бүрдүүлэх, бэхжүүлэх, Монгол Улсад мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх, оюуны өмчийн тогтолцоог улам бүр хөгжүүлж, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг хангах, мөн шинийг санаачлах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон улс орны хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.

Бүртгэлийн байгууллагын тогтолцоо нь улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар, нэгж, ажилтнаас бүрдэх бөгөөд хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Үндсэн чиг үүрэг:

- Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;
- Бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;
- Улсын бүртгэлийн эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;
- УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх
- Салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавхи, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах;

- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, үйл ажиллагааны мэдээ, тайланд дүн шинжилгээ, судалгаа хийх
- Улсын бүртгэгчийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох заавар, журмыг хуульд заасан журмын дагуу баталж мөрдүүлэх;
- Улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэг.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, захиргааны хяналтын албад эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах үүрэгтэй" тул тус газар нь дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Байгууллагын төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж, биелэлтэнд хяналт тавин ажиллаж тайланг ХЗДХЯ-нд жил бүр хүргүүлсэн;
- Байгууллагын нийт ажилтан албан хаагчдад хууль, хяналтын байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулсан. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, хүний дүр төрх таних, мэдээллийн сангийн аюулгүй байдал, халдлагаас урьдчилан сэргийлэх болон бичиг баримтын үнэн зөв байдлыг хангах чиглэлээр холбогдох сургалтыг ЦЕГ, ТЕГ, АТГ, ШШҮХ, ХСИС-аас тус тус авч, албан хаагчдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг чадавхийг дээшлүүлсэн;
- Ажлын байрны аюулгүй байдлын хүрээнд тус газрын үйлчилгээний 1, 2, 3 дугаар байр болон Тамгын газрын байр, Иргэний цахим үнэмлэхийн үйлдвэрийн байрыг камержуулан, 24 цагийн турш цагдаагийн хамгаалалттай болсон;

Мөн улсын бүртгэлийн байгууллагын цаасан болон цахим суурьт мэдээллийн сангийн аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалтыг төрийн байгууллагын хяналтад авах, гадны халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, халдлагын үед шаардагдах зардлыг улсын бүртгэлийн байгууллагын төсөвт суулгах нь чухал ач холбогдолтой.

Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар жил бүр зохион байгуулагддаг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ажилтан албан хаагч, мөн үйлчлүүлж буй иргэдийг энэ талын мэдээллээр хангаж ажиллахын тулд ажлын байранд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, гарын авлага байршуулах, ажлын байр үйлчилгээний заал, гаднах орчинг бүрэн камержуулах шаардлагатай байна.

Дүгнэлт

ОӨУБЕГ нь шинэ бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгтэйгээр хуулийн дагуу үйл ажиллагаагаа хангалттай хэрэгжүүлж ирсэн амжилтыг дүгнэж болох бөгөөд цаашид орчин үеийн нийгмийн хөгжил, иргэдийн амьдралын хандлага, сэтгэл зүйн шинэ орчин, мэдээллийн хүртээмж зэрэг нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэхэд дараах байдлаар ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Байгууллагын эрх зүйн орчин, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэн мэргэжлийн албаны зохион байгуулалттайгаар, мэргэшсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгох. Тухайлбал, байгууллагын тухай хуульд тодорхойлсон үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэх, мэдээ тайланг чиг үүргийн дагуу тодорхой гаргах шаардлагатай.

Далд эдийн засгийн үр дагавар болсон эдийн засгийн салбар, оюуны өмчийн салбар, бүх төрлийн бүртгэлтэй холбоотой үйлдэгддэг нуугдмал гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд бүртгэлийн үйл ажиллагааны суурь мэдээллийн нөөцийг бүрдүүлэхэд анхаарах.

Шинэ нөхцөл байдалд үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдыг ажлын байрны дараах сургалт, диплом, боловсролын анхисан шатны зэргийн сургалтуудад хамруулах шаардлагатай.

Үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг өргөн ашиглахаас гадна, шинэ санаачилга гаргах, шинжлэх ухаанд суурилсан захиалгат судалгааны ажлын үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Аюулгүй байдал, хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод хамтын ажиллагаа өргөжүүлэх, сайн туршлага судлах, өөрийн орны онцлогтой уялдуулах, үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ЯВДАЛ



ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ







1. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ


Сүүлийн 20 гаруй жилийн судалгаанаас үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нь Монгол Улс дахь гэмт үйлдлийн бүтцэд дангаараа 47.4%-ийг эзэлж, нийт хулгайлах гэмт хэргийн 53% нь Улаанбаатар хотод, 47 орчим хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна. Хулгайлах гэмт хэргийн улмаас иргэд, ААН, байгууллагад бий болсон хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж, энэ нь шунахайн сэдэлтэй, нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэг болоод байна.

Улсын хэмжээнд 1990-1994 оны хооронд улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 36,833 бүртгэгдсэнээс 15,465 буюу 41% нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, жилийн дундаж нь 3093 гэмт хэрэг болж өссөн байна. Харин 1995-1999 оны хооронд хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд 61633 бүртгэгдсэнээс 26484 буюу 42,9% нь Улаанбаатар хотод бүртгэгдэж жилийн дундаж 5296,8 гэсэн үзүүлэлттэй байна. Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийг 2001-2005 онд улсын хэмжээнд 42 141 бүртгэж авснаас нийслэлд 21316 буюу 50.5% нь ноогдож байсан бол 2006-2010 онд улсын хэмжээнд 33346 бүртгэгдэж үүнээс 16283 буюу 48% нь нийслэлд тус тус ноогдож байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитоор гаргаж дүгнэлт хийхэд гэмт хэргийн түвшинг бодитойгоор тодорхойлох шаардлагатай. Монгол Улс дахь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшинг тодорхойлохын тулд эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн 100.000 хүн тутамд ноогдох тухайн гэмт хэргийн түвшинг он дараалаар авч үзье.

"График 1"-т 1990-2015 оны хооронд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн чиг хандлагыг 100.000 хүн амд ноогдох түвшингээр харуулсан байна. Судалгаанаас үзэхэд нийт гэмт хэрэг болон бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн чиг хандлага, хөдөлгөөн ерөнхийдөө ижилхэн байна. 1990-1997 оны хооронд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд тогтвортой өсч 100.000 хүн амд ноогдох дундаж түвшин 578 байсан бол 1998 оноос буурах хандлагатай болж 2003 онд дундаж түвшин 351 болжээ, харин 2004 оноос энэ үзүүлэлт өсөх хандлагатай хэлбэлзэж дундаж түвшин 274 болсон байна. Харин 2011-2015 оны хооронд бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт 30719 бүртгэгдсэн нь жилийн дундаж 7403, 100,000 хүн амд ноогдох түвшин 251 гэсэн үзүүлэлттэй байна. 2015 оны хувьд 100,000 хүн амд ноогдох хулгайлах гэмт хэргийн түвшин 299 байгаа нь сүүлийн 8 жилийн үзүүлэлтээс хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож, цаашид өсөх хандлагатай байна.

График VII.1. 100.000 хүн амд ноогдох бусдын эд хөрөнгийн хулгайлах гэмт хэрэг (1990-2015)



Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны алба

Дээрх судалгааны дүнгээс харахад Монгол Улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрийн түвшингээс хамааралтай байгааг харуулж байна. 1998 оноос бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг буурсан шалтгаан Монгол Улсын эдийн засгийн өсөлт, иргэдийн амжиргааны болон боловсрол, соёлын түвшин дээшилсэн нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн гэж үзэж болно. Харин бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн хандлага 2007 онд өссөн үзүүлэлттэй байсан бол 2011 он хүртэл буурч одоогийн хандлага өсөх төлөвтэй байна. Дээрх нөхцөл байдлаас харахад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн хандлага Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч байгаа нь тогтоогдож байна. Тухайлбал, 2007 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт буурч байхад энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай болж эдийн засаг сэргэсэн үед гэмт хэргийн түвшин буурч байжээ.

1. ХАЛААСНААС ЭД ЗҮЙЛ ХУЛГАЙЛАХ

Халааснаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд 2012-2016 онд 1519 бүртгэгдсэн нь нийт хулгайлах гэмт хэргийн 4.5%-ийг эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн 96.4% нь нийслэлд бүртгэгджээ. Гэмт хэрэг 2014 онд өмнөх оны мөн үеэс 4.5%-аар буурсан бол 2015 онд 80 хэргээр буюу 47.3%, 2016 онд 177 хэргээр буюу 71.1%, 160 хэргээр буюу 37.5%-аар тус тус өссөн байна.

Сүүлийн 5 жилд бүртгэгдсэн халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлт дунджаар 37.6%-тай байгаа нь хулгайлах нийт хэргийн илрүүлэлтийн түвшингээс 14.4%-аар бага байна.

Нийт гэмт хэргийн 70.0% нь хөнгөн ангиллын гэмт хэрэг байгаагаас үзэхэд халаасны хулгайн гэмт үйлдлийг бүртгэх, хүлээн авах, хэргийг илрүүлэх, шийдвэрлэх асуудал учир дутагдалтай байна.

Халааснаас эд зүйл хулгайлах гэмт хэргийн улмаас 1447 иргэнд 971.1 сая төгрөгийн хохирол учирснаас 283.6 сая төгрөгийн буюу нийт хохирлын 29.2%-ийг нөхөн төлүүлжээ. 2012-2016 онд бүртгэгдсэн энэ төрлийн хулгайлах гэмт хэрэг Нийслэлийн төвийн бүсийн

дүүрэг болох Сүхбаатар, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд бусад дүүрэгтэй харьцуулахад илүү бүртгэгдсэн байна.

2.МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 14 жилийн хугацаанд мал хулгайлах гэмт хэрэг нийт 22863, жилд дунджаар 1633 бүртгэгдсэний 93.6% нь орон нутагт, 6.4% нь нийслэлд үйлдэгджээ. 2003-2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 33,7%-ийг хулгайлах, 7,9%-ийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаа ба хулгайлах гэмт хэргийн 23.5%-ийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Мал хулгайлах гэмт хэрэг 2004 онд 3305 бүртгэгдсэн нь сүүлийн 14 жилийн хугацааны хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол 2016 онд энэ төрлийн гэт хэрэг 805 бүртгэгдсэн хамгийн бага үзүүлэлт байжээ. 2003-2009 оны хооронд мал хулгайлах гэмт хэргийн түвшин сүүлийн 7 жилтэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй байжээ.

2012 онд энэ төрлийн гэмт хэрэг 1376 бүртгэгдэж байсан бол 2013 онд энэ үзүүлэлт 1435 болж 59 буюу 4.1%-аар өссөн үзүүлэлттэй байжээ. Харин 2016 онд тус гэмт хэрэг 805 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 375 буюу 46%-аар буурсан нь сүүлийн 14 жилийн хугацааны хамгийн бага үзүүлэлт байна. (Хүснэгт №1)

График VII.2. Мал хулгайлах гэмт хэргийн төлөв байдал (2003-2016 он)



Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

Дээрх судалгааны дүнгээс үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа бол мал хулгайлах гэмт хэрэг буурах төлөв ажиглагдаж байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг сайжруулах, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутагт малчдын оролцоотойгоор оновчтой зохион байгуулж байгаа зэрэгтэй холбон тайлбарлаж болно.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд *"Мал сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна"* гэсэн заалтыг удирдлага болгон 2015 онд батлагдаж, 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 12-т мал хулгайлах үйлдлийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс ялгаж, бие даасан байдлаар төрөлжүүлэн хуульчилж, оногдуулах ялын бодлогыг тодорхойлсон нь энэ төрлийн гэмт

хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын илэрхийлэл юм. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр төр засгийн байгууллагууд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн ч гэмт хэргийн үйлдэгдэж буй арга, хэлбэр нь улам нарийсч, хохирлын хэмжээ өссөн, гэмт этгээдүүд тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэл өргөнөөр ашиглаж, урьдчилан үгсэн тохиролцож, бүлэг, зохион байгуулалттайгаар үйлдэх хандлагатай байна.

Судалгааны үр дүнгээс үзвэл мал хулгайлах гэмт хэрэг дараах өвөрмөц аргаар үйлдэгдэж байгааг анхаарч урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ харгалзан үзэх нь зүйтэй. Үүнд:

- Хээр задгай бэлчээрт хариулгагүй байгаа үед хулгайлах;
- Машин, техник хэрэгсэл ашиглан хөдөө орон нутагт очиж хээрийн бэлчээрт байгаа мал сүргээс шилж махалж авах;
- Хашсан, хотлуулсан малаас нь шөнийн цагаар ганц нэгээр нь хулгайлан авч, зайтай газар нядлах;
- Хулгайлсан малаа эзгүй, нууцлаг, зөвхөн өөрсдийн мэддэг газраа аваачин нуугаад, тохиромжтой цаг хугацааг хүлээн аажмаар махлах, зарах;
- Малыг нутаг дамжуулан солилцох (зохион байгуулалттай бүлэг;
- Бэлчээрт байгаа малыг хоцроох, бусдаас нь салгах;
- Өндөр үр шимтэй, ашигтай, үнэ хүрэх мал хулгайлах;
- Мал хулгайлан хил давуулан дамжуулж борлуулах, солилцох гэх мэтийн аргуудыг нэрлэж болох юм.

Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж буй аргыг бүхий л талаар судалж тогтоох нь хулгайлах гэмт хэргийн энэ төрлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

3. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ

3.1. Хулгайлах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Эрүүгийн хуульд заасан ялуудаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ, түүний хувийн байдалд нь тохирсон ялыг сонгон хэрэглэсэн тохиолдолд ялын үр нөлөө сайн байдаг. Иймд шүүхээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг сүлийн 5 жилийн байдлаар авч үзлээ.

"Хүснэгт 1"-т үзүүлснээр Монгол Улсын хэмжээнд 2011-2015 оны хооронд анхан шатны шүүхээр хулгайлах гэмт хэрэг 6600 шийдвэрлэгдсэн нь нийт хэргийн 21.5(%)-ийг эзэлж байна. Шүүхээр шийдвэрлэгдэж буй хулгайлах хэргийн тоо 2012 оноос жил дараалан өсч, 2015 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан нь өмнөх онтой харьцуулахад 82 хэрэг буюу 5.7%-аар өссөн байна.

Шийдвэрлэгдсэн хулгайлах гэмт хэргийг түүний бүрэлдэхүүний төрлөөр нь авч үзвэл нийт хулгайлах гэмт хэргийн 9.6% ердийн бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), 87.3% хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн тугай ангийн 145 дугаар зүйлийн 2, 3 дэх хэсэг), онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 4 дэх хэсэг) 2.9%-ийг эзэлж байна.

Хүснэгт VII.2.1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэгдсэн байдлын судалгаа (2011-2015)

Жил	Хэрэг (145)	(%)	145.1	(%)	145.2	(%)	145.3	(%)	145.4	(%)
2011	1282	(100)	146	(10.5)	1064	(83.0)	55	(4.3)	27	(2.1)
2012	1281	(100)	147	(11.5)	1070	(83.5)	20	(1.6)	50	(3.9)
2013	1283	(100)	98	(7.6)	1111	(86.6)	33	(2.6)	41	(3.2)
2014	1336	(100)	129	(9.7)	1114	(83.4)	53	(4.0)	38	(2.9)
2015	1418	(100)	117	(8.3)	1234	(87.8)	16	(1.1)	37	(2.6)
Нийт	6600	(100)	637	(9.6)	5593	(84.7)	177	(2.6)	193	(2.9)

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим мэдээллийн сан

Дээрх судалгаанаас үзвэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 2 дах хэсгээр шийдвэрлэгдсэн хэрэг жил дараалан өсч байна.

Энэ хэсэгт хулгайлах гэмт хэргийг түгээмэл үйлддэг арга, халдлагын зүйл, газар болох орон байр агуулах сав зэргийг тусгайлан заасан байдагтай холбоотой. (орон байр, агуулах саванд нэвтрэх, мал хулгайлах, бүлэглэн болон давтан үйлдэх гэх мэт). Түүнчлэн, хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ нь энэ хэсэгт заасан хохиролтой ихэнх тохиолдолд тохирч байна.

3.2 Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж бу ялын төрөл, хэмжээ

Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын төрлийг "Хүснэгт-2"-т харууллаа. Сүүлийн 5 жилийн судалгаанаас үзвэл 10821 хүн хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлснээс 7010 буюу 64.7% нь хорих, 2073 буюу 19,4% нь баривчлах, 397 буюу 3.6% нь албадан ажил хийлгэх, 685 буюу 6.26% нь торгох ялаар тус тус шийтгүүлсэн байна.

Хүснэгт VII.2. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын төрөл (2011-2015)

Ялын төрөл	Ял шийтгүүлэгчид									
	2011		2012		2013		2014		2015	
	2227 (100%)		2191 (100%)		2077 (100%)		2296 (100%)		2030 (100%)	
Торгох	142	(6.3)	151	(6.8)	122	(5.8)	149	(6.4)	121	(6.0)
Албадан ажил хийлгэх	71	(3.1)	94	(4.2)	88	(4.2)	73	(3.1)	71	(3.4)
Баривчлах	429	(19.2)	399	(18.2)	392	(18.8)	450	(19.5)	403	(19.5)
Хорих	1436	(64.4)	1393	(63.5)	1381	(66.4)	1501	(65.3)	1299	(64.0)
Хэрэгсэхгүй болгосон	45	(2.2)	153	(6.9)	94	(4.5)	123	(5.3)	121	(6.0)
Нэмэгдэл ял										
Эд хөрөнгө хураах ял	183	(8.2)	201	(9.1)	196	(9.4)	179	(7.7)	186	(9.1)

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим мэдээллийн сан

Шүүхээс 2015 онд 121 хүнийг нийт 645 сая төгрөгийн торгох ялаар, 71 хүнийг 8400 цагийн албадан ажил хийлгэх ялаар, 103 хүнд нийт 12 сая төгрөгийн эд хөрөнгийг нэмэгдэл ялаар оногдуулжээ. Харин баривчлах ялаар 403 хүнийг шийтгэсэн нь дунд жаар 2.6 сарын хугацаатай байна. 2011-2015 оны дунджаар хорих ял шийтгүүлсэн хугацааг авч үзвэл нийт

хорих ял шийтгүүлэгчдийн 63(%) 2-3 жил, 20,1(%) нь 3-5 жил, 6.2(%) нь 5-8 жил, 4.1% нь 8-10 жил, 6.6(%) нь 10-15 жил хүртэл хугацаагаар шийтгүүлсэн байна.

3.3. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялын байдал

"Хүснэгт 3"-т хорих ял оногдуулсан шүүхийн тогтоолыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх судалгааг харуулсан байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хорих ялаар 7010 хүн шийтгүүлсэнээс 2853 буюу 40,7% хорих ялыг биечлэн эдлүүлсэн, үүнээс 93 хүн буюу 3.2% Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял оноосон байна. Харин нийт хорих ял шийтгүүлэгчдийн 3740 буюу 49.3%-д оноосон ялыг 2.1 жил хүртэл хугацаагаар тэнссэн байна. Мөн нийт хорих ялаар шийтгүүлэгчдийн 440 буюу 6.2% насанд хүрээгүй этгээдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулсан (Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 62), 144 буюу 1,5% жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт оногдуулсан хорих (Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 63) тус тус хойшлуулсан байна. Түүнчлэн, нийт 133 хүнд оногдуулсан хорих ялыг өршөөсөн байна.

Хүснэгт VII.3. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялыг гүйцэтгэсэн байдал (2011-2015)

№	Хорих ялаар бүгд: үүнээс	2011		2012		2013		2014		2015	
		1436	(100%)	1393	(100%)	1381	(100%)	1501	(100%)	1299	(100%)
	Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	598	(41.6)	564	(40.8)	555	(40.1)	617	(41.1)	519	(40.0)
1	Тусгай ангид зааснаас доогуур ял оноосон (Эрүүгийн хуулийн 55-1-р зүйл)	24	(1.6)	13	(0.9)	16	(1.1)	21	(1.3)	19	(1.4)
2	Тэнсэн (Эрүүгийн хуулийн 61-р зүйл)	681	(47.4)	706	(50.6)	710	(51.1)	765	(51.0)	608	(46.8)
3	Ял хойшлуулсан (Эрүүгийн хуулийн 62-р зүйл)	98	(6.8)	84	(6.0)	85	(6.1)	83	(5.5)	90	(6.9)
4	Ял хойшлуулсан (Эрүүгийн хуулийн 63-р зүйл)	33	(2.2)	22	(1.5)	19	(1.3)	20	(1.3)	20	(1.5)
5	Өршөөсөн (Эрүүгийн хуулийн 77-р зүйл)	26	(1.8)	17	(1.2)	12	(0.8)	16	(1.0)	62	(4.7)

Дээрх судалгаанаас үзвэл хорих ялыг өндөр хувьтай оногдуулж байна. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 1,2,3 дахь хэсэгт хорих ял оноохоор заасан бөгөөд ялангуяа 145 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт сонгох санкцгүйгээр хорих ялыг хуульчилсан байна.

Мөн Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хорих ялын хугацааг 1-15 жил байхаар хуульчилсан байхад 145 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жил байхаар заасан нь хорих ялыг нэг жилийн хугацаагаар оногдуулах боломжийг хаасан зохицуулалт болжээ. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 55.1 дүгээр зүйлд заасан "Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оноох" зохицуулалт бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад харьцангуй бага хэрэглэгдэж байна.

Энэ нөхцөл байдал нь хуулийн зохицуулалттай холбоотой байх магадлалтай юм. Учир нь хууль тогтоогч 55-1 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял

оногдуулахдаа дараах 3 үндсэн шаардлагыг хуульчилсан байна. Үүнд:

1) хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн байх;

2) гэмт хэргийн хохирлыг барагдуулсан байх;

3) гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзах;

Дээрх 3 шаардлагаас гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн байх гэсэн шаардлага ихэнх тохиолдолд хангагддагүй байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдын 52,5% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 8,9% нь согтуугаар, 49,2% нь бүлэглэн үйлдсэн, 17,2% нь урьд шийтгэгдэж байсан хүмүүс байна.

4. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж үзвэл дараах онцлог шинж ажиглагдаж байна.

1. Монгол улсын нийгэм, эдийн засгийн суурь нөхцөл байдал нь хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болж байна. Тухайлбал, ажилгүйдэл, ядуурал, хүн амын боловсролын түвшин, хотжих үйл явцтай холбоотой байна.
2. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй олон талт ажиллагааны үр дүн муу байгаа байдал. Хулгайн хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа нь судалгаа шинжилгээны ажлын үндсэн дээр хийгддэггүй нөгөө талаас энэ төрлийн гэмт хэрэг нийгмийн нийтлэг үзэгдэл болж төрөөс авах арга хэмжээ хулгайн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд нөлөөлөхгүй хэлбэрийн төдий явагдсаар байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг өсөх нөхцөл болж байна.
3. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, ялын бодлого оновчгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг өсөх бас нэг шалтгаан юм. 2002 онд батлагдаж 2008 онд нэмэлт өөрчлөлт орсон эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг материаллаг шинжтэйгээр хуульчилсан бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхүйц эд зүйлийг хулгайлсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь алдаатай зохицуулалт юм. Бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэйгээр хулгайлсан хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүйгээс ганцаараа болон бүлэглэн 150,000 төгрөгнөөс доош үнэ бүхий эд зүйлийг хулгайлах үйлдлийг байнгын үйлдэж байна.
4. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн хувьд орон байрнаас эд зүйл хулгайлах, халааснаас эд зүйл хулгайлах, тээврийн хэрэгсэл, түүний эд зүйлийн хулгайлах гэмт хэрэг зонхилон үйлдэгддэг бөгөөд эдгээрийн дотор орон байр, халаасны хулгайн хэргүүд тэргүүлж, Улаанбаатар хот нь мал, мод хулгайлах болон хууль бус бусад бизнесийн нийлүүлэлтийн томоохон зах зээл болж байна. Энэ төрлийн гэмт хэргийг дагнасан бүлэг зохион байгуулалттай этгээдүүд үйлдэх болж нэг талаас тэдний хулгайлсан эд зүйлийг худалдаж авдаг хүмүүс өөгшүүлж нөгөө талаас, иргэд харуул хамгаалалтгүй газарт эд зүйлээ удаан хугацаагаар орхисноос ийм гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдэж байна.
5. Халааснаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг нь хот дагасан нийгмийн үзэгдэл болохын хувьд Улаанбаатар хотод бусад орон нутагтай харьцуулахад автобус, худалдааны төвүүд, үзвэр, үйлчилгээний газруудад түгээмэл гарч байна.
6. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг гол төлөв эрхэлсэн тодорхой ажилгүй, сургуульгүй амар хялбар аргаар амьдрахыг хичээгч, шилжин ирэгсдээс үйлдэж байна.

Сүүлийн 5 жилд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын 75% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 16% нь оюутан сурагч, үүнээс 55.3%-ийг 18-30 насны хүүхэд залуучууд эзэлж байна. Түүнчлэн хулгайлах гэмт хэргийг бүлэглэж буюу зохион байгуулалттай бүлэг болон давтан үйлдэх явдал нийслэл хотод тархмал шинжтэй, дагнасан хэлбэртэй байна. ЦЕГ-ын мэдээлэл судалгааны албанаас гаргасан судалгаанаас үзэхэд тус хотод хулгайлах гэмт хэрэгт холбогдогчдын 5 хүний 1 нь бүлэглэж, 4 хүний 1 нь давтан гэмт хэрэг үйлджээ. Бүлгээр гэмт хэрэг үйлдэгчид ихэвчлэн 14-20 насны хүмүүс байгаа ба эдгээрийн олонх нь урьд 1-2 удаа хулгайлах хэрэгт холбогдож байсан хүмүүс байна. 2014-2016 оны хооронд хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэргийг бүлгээр болон урьдчилан үгсэн тохиролцсон бүлгээс үйлдсэн тохиолдол 3807 бүртгэгдсэн байна.

5. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Сүүт сэтгэгчид Аристотель, хожуу XYIII зууны үеийн соён гэгээрүүлэгчдийн гол төлөөлөгч Ш.Монтескье "Мэргэн хууль тогтоогч гэмт хэрэг гарсан хойно нь ял шийтгэхийн төлөө санаа тавихаасаа түүнийг урьдчилан сэргийлэхэд голлон анхаарах ёстой" гэж сургаж байсан нь одоо ч ач холбогдолтой хэвээр байна.

Монгол Улсын эдийн засагт бий болсон хямралт байдал, төрийн байгууллаганы үйл ажиллагааны тогтворгүй байдлыг гэтлэн давах шүүх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, боловсронгуй болгох талаар төр засгаас авч явуулж буй иж бүрэн арга хэмжээнүүд нь тойруу замаар хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны чиглэл

Хулгайлах гэмт хэрэгтэй хийх тэмцэлд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага шийдвэрлэх үүрэгтэй. Хууль сахиулах байгууллагууд дотроо цагдаагийн байгууллага, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4.1-т "Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн" гэж заасан бөгөөд цагдаагийн байгууллага хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
2. Хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;
3. Хулгайлах гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;
4. Хулгайлах гэмт хэргийг үйлдэгдсэн тохиолдолд хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;
5. Хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, зохион байгуулалттай сүлжээг таслан зогсоох, хор уршгийг арилгах зорилгоор хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;
6. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн, шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх,

лавлагаа гаргах;

7. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах, татан оролцуулах;
8. Хариуцсан нутаг дэвсгэрийн хулгайлах гэмт хэргийн халдлагад өртөгдөж болзошгүй байгууллага ААН, иргэдийн орон байр, тэдгээрийн байрлал, хамгаалалтыг харгалзан иргэдийн оролцоотойгоор цагдаагийн эргүүл, пост, жижиг пост ажиллуулах;
9. Хот суурин газруудад нийтийн тээврийн хэрэгслийн оргил ачааллын үеэр халаасны хулгайч нарыг илрүүлэх зорилгоор тусгай бэлтгэгдсэн шуурхай эрэн сурвалжлах хэсгийг ажиллуулах;
10. Папилон систем, туслах тоо бүртгэлд тулгуурлан хулгайн гэмт хэрэг үйлдэгчдийн талаарх мэдээллийн сан байгуулж, орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдээлэл солилцож байх, аймаг, дүүргийг төвтэй холбосон мэдээллийн сүлжээ байгуулах асуудлыг шийдвэрлэх;
11. Хулгайлах гэмт хэргийн газрын үзлэгийг мэргэжлийн өндөр түвшинд хийх нь гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой тул жижүүрийн шинжээч, мөрдөн байцаагч, төлөөлөгч нарын ур чадварыг дээшлүүлэх сургалтыг гадаад, дотоодод зохион байгуулж байх;
12. Олон үйлдэлтэй. хэд хэдэн холбогдогчтой, бүлэг зохион байгуулалттай хулгайлах гэмт хэргүүдийн талаар цагдаа, шүүх, прокурорын байгууллага хамтран хэлэлцэж, шуурхай шийдвэрлэх талаар хамтран ажиллах;
13. Шүүх нь хулгайлах гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь хуулийн дагуу тогтоогдсон, шүүгдэгч нэг бүрт хэргийг нийгмийн хор аюул, түүний хувийн байдал бусад нөхцөл байдлыг харгалзан шударга ял оногдуулах замаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэм зэмгүй өнгөрөх, ял завших боломжгүй, хариуцлага хүлээх нь зайлшгүй тухай ойлголтыг гэмт хэрэг үйлдсэн хүмүүс, үйлдэхээр бэлтгэж санаархаж хүмүүс, жирийн иргэдэд төрүүлж шүүх засаглалыг жинхэнэ утгаар хэрэгжүүлэх ёстой. Шүүх нь бусдын эд хөрөнгө хулгайлсан нэг ч хүн ял зэмлэлгүй өнгөрөхгүй байх чиглэлийг үйл ажиллагаандаа удирдлага болгож нэг ч хулгайчийн ялыг үндэслэлгүйгээр хөнгөрүүлэхгүй байх, түүнчлэн засарч хүмүүжээгүй нэг ч ялтанд тэнсэн суллагдах тухай хуулийн энэрэнгүй заалтыг хэрэглэхгүй байх;
14. Прокурорын байгууллага хулгайлах гэмт хэргийг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж хулгайлах гэмт хэргийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгох хууль зөрчигдөх, ял завших боломж олгож байгаа нөхцөл байдлуудыг тухай бүрд нь таслан зогсоох үйл ажиллагаа ур нөлөөтэй хэрэгжүүлэх;

Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нутгийн захиргааны байгууллага, ААН-үүд чухал үүрэгтэй бөгөөд дараах чиглэлээр ажиллах ёстой. Үүнд:

1. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах арга хэлбэрийг боловсронгуй болгохын зэрэгцээ тэдний үүсгэл санаачилгыг дэмжин ажиллах талаар бүх шатны Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг чиглүүлэх;
2. Иргэд, ААН, байгууллага өөрсдөө өмч хөрөнгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх сэтгэлгээг хөгжүүлэх, хулгайн гэмт хэрэг үйлдэгсдийг олон нийтэд жигшүүлэх чиглэлээр радио, телевиз, сонин хэвлэлээр сурталчилгааны ажлыг дэс дараатай хийх.
3. Орц, байрны жижүүр, гэр хороололд гудамжны эргүүл ажиллах журмыг сууц өмчлөгчдийн холбоо, орон сууцны байгууллага, дүүрэг, хороо, сум, баг хамтран

боловсруулж, иргэдийг нийтийн эргүүлд татан оролцуулах арга хэлбэрийг боловсронгуй болгох;

4. Төвлөрсөн зах, шаардлагатай зарим гудамж талбайг телекамерын хяналтад авах ажлыг хот, дүүргийн холбогдох байгууллагуудтай хамтран судалж хэрэгжүүлэх;
5. Үнэт зүйл хадгалдаг үйлчилгээ, дохиолол, хамгаалалт, найдвартай хаалга, цонхны бэхэлгээний ач холбогдлыг нийтэд сурталчлах;
6. Төв, суурин газарт хөршийн холбоо, хөдөөд мал сүрэг хамгаалах нөхөрлөл зэрэг олон нийтийн үүсгэл санаачилгыг үр ашигтай зохион байгуулах ажлыг бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага хамтран зохион байгуулж байх;
7. Орон нутгаас мал, мах, түүхий эдийг тухайн мал эмнэлгээс олгосон ариун цэврийн сертификат, баг, сумын Засаг даргын тодорхойлолт зэргийг үндэслэн төв, суурин газарт оруулж байх журмыг холбогдох яам, агентлаг, байгууллагатай хамтран боловсруулан хэрэгжүүлэх;
8. Аймаг сумын төв, бусад суурин газарт амьдардаг мал бүхий иргэдийн малыг байнгын хариулга маллагаатай болгох ажлыг баг, хорооны Засаг дарга нар зохион байгуулах;
9. Аймаг, сум бүр индекс бүхий эзмэг, тамгатай болж, адууг тамгалан бусад бод малыг ээмэгтэй болгох, баг, сум бүр өөрсдийн өрхийн им, тамга, ээмэгний судалгаа гаргаж, орон нутгийн цагдаагийн байгууллага, мал сургийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэгт хүргүүлэх ажлыг бүх шатны ЗДТГ хариуцан зохион байгуулах явдал чухал.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээний хүрээнд:

1. Нутаг дэвсгэрийн иргэд, албан газар, ААН, байгууллагын бод малыг индексжүүлсэн им тамгын сүлжээнд хамруулах, им тамга, зүсмийн бүртгэлтэй болгох бүртгэлийг 3% хийж, баг, сум, хэсгийн төлөөлөгчид хадгалах, өндөр ашиг шимтэй сайн үүлдрийн мал, хурдан жороо удмын адуу нэг бүрийг зурагжуулах зэрэг ажлыг баг, хороо, сум, дүүрэг бүрт тусгайлан зохион байгуулж дүгнэх;
2. Малын өдрийн хариулга, шөнийн манаатай болгох, малчдын бүлэг, нөхөрлөлийн ажлыг тогтмолжуулах, энэ ажлын явцад үзлэг аттестатчилал явуулж дүгнэж, урамшуулах;
3. Төв суурин бүрт мал мах бэлтгэх цэгийг албан ёсоор тогтоон өгч, тендерээр ААН, байгууллагыг шалгаруулан ажилд оруулах;
4. Мал, махны гарал үүслийн гэрчилгээг журмын дагуу олгох, зах, дэлгүүр бусад газарт уг гэрчилгээтэй мал, мах борлогдож буй эсэхэд тавих хяналтыг тогтмолжуулах, энэ ажлын явцад үзлэг шалгалт хийх;
5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн телевиз, радио, хэвлэлд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сэрэмжлүүлэг, нийтлэл тогтмол явуулах;
6. Мал хулгайлах гэмт хэргээс сэрэмжлүүлэх сэдэвтэй зураг хуудас, санамж, сэрэмжлүүлэг хэвлүүлж олшруулан айл өрх, ААН, байгууллага бүрт хүргэх;
7. Алдуул мал бүртгэх, мэдээлэх ажлыг орон нутгийн онцлогт тохируулан сум, дүүрэг, баг, хороонд төвлөрүүлэн журамлаж зохион байгуулах;
8. Баг, хороо, хэсгийн иргэдийн нийтийн хурлаар мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын өдрийн хариулга, шөнийн манааг сайжруулах, им тамга, зүсмийн бүртгэлтэй болгох зэрэг тулгамдсан асуудлыг хэлэлцүүлэх;
9. Байнгын болон түр пост, эргүүл, жижүүрийн мал хулгайлах гэмт хэрэг гарч болох шаардлагатай цэгүүдэд оновчтой ажиллуулах.

Мал хулгайлах явдалтай тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд: Үүнд:

1. Малаа алдсан тохиолдолд мал хулгайлах гэмт хэрэг нэг бүрийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг цагдаагийн газар, хэлтэс, алба, нэгж бүрт авч хэрэгжүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, хэсгийн ажлыг идэвхжүүлэх;
2. Мал хулгайлах гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэхэд хэрэг бүртгэх, мөрдөх байцаах, прокурорын хяналт, шүүн таслах, шийдвэр гүйцэтгэлийн ажлыг чиглүүлж, явцыг үе үе нэгтгэх дүгнэх, тэргүүний хүмүүсийг урамшуулах;
3. Мал хулгайлах гэмт хэргийг бүртгэх шалгах явцад болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд нуугдмал хөрөнгө илрүүлэх явцад ч хөрөнгө хамгаалах арга хэмжээ авч байх;
4. Зэргэлдээ аймаг, сум, дүүргийн цагдаагийн байгууллагатай хулгайлагдсан малын тухай, хулгайч нарыг илрүүлэх асуудлаар шуурхай мэдээлэл солилцох нөхцөл, журам, хугацаа зэргээ албан ёсоор тохиролцож ажиллах;
5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлах ажилд цагдаагийн бүх алба, ажилтны хүчийг чиглүүлэн, энэ ажилд идэвх зүтгэл, үр дүнтэй оролцсон алба хаагчийг урамшуулан шагнаж байх;
6. Мал хулгайлах гэмт хэргийн талаар хүчинтэй байгаа шүүхийн тогтоол, шийдвэрийн өр төлбөрийг нөхөн барагдуулах, энэ талаарх шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа шуурхай болгох;
7. Мал хулгайлах хэргийг хууль сахиулах байгууллагаас шалган шийдвэрлэх, ял оноох, хохирол төлүүлэх ажлын явцыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд хууль сахиулах байгууллагын удирдлагын түвшинд дүгнэж байх;

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, энэ гэмт хэрэг үйлдэгдэх, нийгмийн хор аюулыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаарх санал, дүгнэлт:

1. Хулгайлах гэмт хэрэг нь манай улсын хувьд төрөөс тодорхой бодлого боловсруулж тэмцэл хийхийг шаардаж байгаа нийгмийн сөрөг үзэгдэл тул шалтгаан нөхцөлийг нь шинжлэх ухааны аргаар судалж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны онол, практикийн үндэслэлийг иж бүрэн боловсруулах,
2. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт заасан арга хэмжээг тодорхой үе шаттай, хөрөнгийн шаардагдах эх үүсвэртэйгээр хэрэгжүүлэх, хуогайлах гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 35 хувиас дээш байгааг хэдий ч энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхгүй байна.
3. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дагнасан үүрэг бүхий цагдаагийн байгууллагын бүтцэд багтдаг мэргэшсэн алба ААН-ийг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол, албаны тусгай бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, ажил үүргээ гүйцэтгэх боломжоор хангах,
4. Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэстэй судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний арга зүйг онолын өндөр түвшинд боловсруулах үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага бий болгох, хулгайн гэмт хэргийг судалж, эрдэм шинжилгээний ажил хийж байгаа ажилтнуудад дэмжлэг үзүүлэх,
5. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар гадаад орнуудын, тухайлбал, Японы Кобан, түүний нэг хувилбар болох Сингапурын хөршийн холбооны цагдаагийн постын туршлагыг судалж нэвтрүүлэх зэрэг болно.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРЭГ



2. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРЭГ

НЭГ. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Замын хөдөлгөөний аюулгүй байдал гэдэг нь: **"Хүн-тээврийн хэрэгсэл-зам-орчин** гэсэн өөр хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий элементүүдийн аюулгүй байдлын цогц" гэж дэлхийн эрдэмтэн, судлаачид тодорхойлжээ.

"Зам тээврийн осол" - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг хэлнэ" гэж Замын хөдөлгөөний дүрэмд заасан байдаг.

График VII.2.1.



Улсын хэмжээнд 2016 онд цагдаагийн байгууллага зам тээврийн ослын шинжтэй дуудлага 94733-г хүлээн авч 46712 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна.

Цагдаагийн байгууллагад зам тээврийн ослыг:

- Эд материалын хохиролтой зам тээврийн осол;
- Хүн гэмтсэн зам тээврийн осол гэж ангилан авч судалгаа шинжилгээнд ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэн шалгасан 46712 зам тээврийн ослоос 1782-т ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн зүйл заалтаар эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан.

График VII.2.2.



Улсын хэмжээнд 2016 онд нийт 27167 гэмт хэрэг бүртгэгдсэнээс *ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 1782 бүртгэгдэж нийт гэмт хэргийн 6,6%-ийг эзэлсэн.*

График VII.2.3.



ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 2016 онд 1782 бүртгэгдсэнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 11.3%-аар, орон нутагт 12.8%-аар, нийслэлд 14.6%-аар тус тус буурсан үзүүлэлт гарсан.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн 870 буюу 48,8% нь орон нутагт, 912 буюу 51,2% нь нийслэлд бүртгэгдсэн байна.


График VII.2.4. Сүүлийн 10 жилийн үзүүлэлт:



Сүүлийн 10 жилд бүртгэгдсэн ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн 875 буюу 49,1% нь хөнгөн, 872 буюу 48,9% нь хүндэвтэр, 35 буюу 2,0% нь хүнд хэрэг байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин дөрөвдүгээр бүлгийн зүйл бүртгэгдсэн гэмт хэргийн 587 буюу 32,9% нь Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчлэгдсэн байна.

График VII.2.5.




ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИЙН НАС ХҮЙС, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БАЙДАЛ

Улсын хэмжээний гэмт хэргийн мэдээнд тусгагдсанаар 2016 онд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэгт 954 хүн холбогджээ.


Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн хүйсийн ерөнхий харьцаанаас эрэгтэй жолооч 87,8%-ийг, эмэгтэй жолооч харьцангуй бага 12,2%-ийг эзэлж байна.

График VII.2.6.



Гэмт хэрэгт холбогдсон 18-34 насны залуу хүмүүс 60.1%-ийг эзэлж байна.

График VII.2.7.



Хүснэгт VII.2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нийгмийн байдал:

Нийгмийн байдал	Холбогдогч	Эзлэх хувь
Ажилгүй	914	46.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	415	21.2
Хувийн хэвшлийн ажилтан	250	12.8
Ажилчин	4	0.2
Малчин	111	5.7
Төрийн албан хаагч	128	6.6
Төрийн бус байгууллагын ажилтан	60	3.1
Сурагч	8	0.4
Оюутан	61	3.1
Цэргийн алба хаагч	1	0.1
Цагдаагийн алба хаагч	2	0.1

Боловсролын хувьд гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 58,6% нь бүрэн дунд боловсролтой байна.

Хүснэгт VII.2.2.


Боловсрол	Холбогдогчийн тоо	Эзлэх хувь
Бүрэн дунд	1146	58.6
Дээд	568	29.1
Бага	112	5.7
Тусгай дунд боловсрол	100	5.1
Боловсролгүй	28	1.4

ХОЁР. ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, АМЬ НАС ХОХИРСОН БАЙДАЛ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг илэрхийлэх хүн амд ногдох амь нас алдалт, гэмтлийн харьцангуй үзүүлэлтүүдээр манай улс бусад оронтой харьцуулахад өндөр бөгөөд хүнд нөхцөлтэй орнуудын тоонд орж байна.

Гэмт хэргийн улмаас нас баралтыг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:


График VII.2.8.



Зам тээврийн ослын улмаас 2016 онд нийт 5835 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсны дотор ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас 399 хүн амь насаа алдаж, 1247 хүнд хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ.

Монгол Улсын хэмжээнд нийт гэмт хэргийн улмаас 880 хүний амь нас хохирсны 45,3% нь ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас амь насаараа хохирчээ.

График VII.2.9.



Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон ослын тохиолдол 424 бүртгэгдэж, 479 хүний амь нас хохирсон байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн шалгасан 80 ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24.1.1-р хэрэгсэхгүй болгожээ.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 399 хүн нас барж, 1247 хүн гэмтсэн үзүүлэлтийг урьд оны үзүүлэлттэй харьцуулахад амь нас алдалт 7.0%-аар, гэмтсэн хүн 9.8%-аар тус тус буурсан. ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүний 310 буюу 77.7% нь орон нутагт, 89 буюу 22.0% нь нийслэлд байна.

Гэмтсэн хүн

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1646 хүн амь насаа алдаж, гэмтсэн.

Амь насаа алдсан, гэмтсэн хүний нас, хүйсийн байдал

Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон 1646 хүний насны байдлыг авч үзвэл:

- 0-17 насны хүүхэд 274 буюу 16.6%;
- 18-34 насны 587 буюу 35.7% нь;
- 35-54 насны 559 буюу 34.0%;
- 55 ба түүнээс дээш насны 226 буюу 13.7%-ийг тус тус эзэлсэн.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүмүүсийн 35.7% нь 18-34 насны хүн байна.

Хүйсийн харьцааны хувьд:

- эрэгтэй - 932 буюу 56,6%,
- эмэгтэй - 714 буюу 43,4% нь байна.

Нас, хүйсийн үзүүлэлтээс дүгнэхэд 18-35 насны эрэгтэй хүмүүс нь зам тээврийн осолд өртөж амь насаа алдаж, гэмтсэн нь тухайн насны хүмүүс замын хөдөлгөөнд идэвхтэй оролцдогтой холбон үзэж болно. Түүнчлэн, хөдөлмөрийн насны хүмүүс замын хөдөлгөөнд зөв оролцоогүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн хэн нэгэн буруутай этгээдээс болж амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна.

Гэмтсэн хүний гэмтлийн зэрэг

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн хамгийн хүнд үр дагавар бол хүний эрүүл мэнд, амь нас хохирох явдал байдаг. Гэмтлийн зэрэг:

- Хөнгөн гэмтэл 229 буюу 18.4%;
- Хүндэвтэр гэмтэл 726 буюу 58.2%;
- Хүнд гэмтэл 292 буюу 23.4% нь байна.

Тус гэмт хэргийн улмаас гэмтсэн хүмүүсийн гэмтлийн зэргээс харахад нийт гэмтэл авсан хүний 55,8% нь хүндэвтэр, 22,3% нь хүнд, 21,9% нь хөнгөн гэмтэл авчээ.


Амь нас, эрүүл мэндээрээ хохирогсдын биедээ гэмтэл авсан байдал:

Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүмүүсийн биедээ гэмтэл авсан байдлаас үзвэл: толгойн, цээж, хөлийн гэмтэл хамгийн их хувийг эзэлж байна. Орон нутгийн замд гарсан ослын улмаас гэмтэгсэд биеийн бүх хэсэг, толгойн гэмтэл их авч байгаа нь осол илүү ноцтой, учирч буй гэмтэл хүнд байгааг харуулж байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн үзүүлэлтээс амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүмүүсийн биеийн гэмтэл авсан хэсгийн мэдээллээс авч үзвэл:

- Толгой 26,8%,
- цээж 8,6%
- хөл 25,0%
- гар 10,5%
- Нүүр 6,0%
- хүзүү 3,9 %
- хэвлий хэсэгтээ 5,7%
- биеийн бүх хэсэгт 1,8%,
- аарцаг, нуруу 7,0%
- бөгсөн биед 4,7% тус тус гэмтэл авчээ.

Зураг VII.2.1.



Амь насаа алдсан хүмүүсийн 53,0% нь толгой, 19,0% нь цээж, 10,4% нь аарцаг, нуруундаа хүнд гэмтэл авч, 17,8% нь толгой болон нуруундаа хавсарсан гэмтэл авч амь насаа алдсан байна.

Амь насаа алдсан хүний 27,3%, гэмтсэн хүний 46,5% нь эмнэлгийн анхны тусламж авсан байна. Эмнэлгийн анхны тусламж авсан хүний тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 12,4-21,6%-аар өсчээ.

Амь насаа алдсан хүний 90,7% нь 24 цагийн дотор нас барсан бол 8,8% нь 30 хоногт, 0,5% нь 30-с дээш хоногт нас барсан байна.

Нийслэлд замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчдын замын хөдөлгөөний мэдлэг дутмаг, мэдсэн ч дүрмээ баримталдаггүй, хэнэггүй байдлаас үүдсэн ослууд, жолоочийн хариуцлагагүй байдал зонхилж байхад, орон нутагт жолоочийн буруугаас болж жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч осолд их өртөж байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан 399, гэмтсэн 1247 нийт 1646 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг судалж үзвэл:

Улаанбаатар хотод:

- Явган зорчигч - 57 нас барж 412 гэмтсэн;
- Жолооч – 16 нас барж 29 гэмтсэн;
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 14 нас барж, 220 гэмтсэн ;
- Унадаг дугуйгаар зорчигч – 2 нас барж, 20 гэмтсэн;

Орон нутагт:

- Явган зорчигч - 66 нас барж, 242 гэмтсэн;
- Жолооч - 116 нас барж, 57 гэмтсэн;
- Тээврийн хэрэгслээр зорчигч - 127 нас барж, 258 гэмтсэн;
- Унадаг дугуйгаар зорчигч - 1 нас барж, 9 гэмтсэн;

Амь нас нь хохирсон, гэмтэж бэртсэн хүний үзүүлэлтээс үзэхэд нийслэлд явган зорчигч замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, мэдсэн ч дүрмээ биелүүлдэггүй, хэнэггүй байдлаас болж зам тээврийн осолд өртөж байна. Орон нутгийн замд жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж тээврийн хэрэгслээр зорчигч, жолооч амь нас эрүүл мэндээрээ хохирч байна.

Нийслэл хотод явган зорчигч, орон нутагт тээврийн хэрэгслээр зорчигч, жолооч зам тээврийн ослын улмаас их хохирч байна.

Гэмт хэрэгт өртсөн жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчийн 53,7% нь автомашины урд суудалд сууж явсан бол 28,1% нь урд, 15,2% нь бусад суудалд сууж явахдаа зам тээврийн ослын улмаас гэмтэж бэртсэн бол 3,0% нь автомашины аль суудалд сууж явсан нь тогтоох боломжгүй гэсэн үзүүлэлт гарч байна. Нас барсан жолооч, зорчигчийн 53,0% нь автомашины урд суудалд сууж яваад ослын улмаас амь насаа алджээ.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД ҮҮССЭН ЭД ХӨРӨНГИЙН ХОХИРОЛ

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд учрах хохирлоос гадна хохирол ихээхэн учирдаг, зам тээврийн осол бүр хохирол дагуулдаг.

Гэмт хэргийн улмаас 2016 онд иргэн, ААн, байгууллагад 6 тэрбум 435.1 сая төгрөгийн хохирол үүссэний 5 тэрбум 551.1 сая төгрөгийн буюу 86,3%-ийг нөхөн төлүүлсэн байна.

График VII.2.10.



ГУРАВ. ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ГАРЧ БУЙ ШАЛТГААН

Монгол Улсад автомашины тоо жил ирэх тусам нэмэгдсэн нь 2016 онд 766019 хүрч насанд хүрсэн 3 хүнд 1 автомашин ногдож байна.

График VII.2.11.




Гэмт хэрэг гарсан шалтгааныг:

- Жолоочийн буруутай үйлдэл;
- Явган зорчигчийн буруутай үйлдэл;
- Замын нөхцөл;
- Техникийн гэмтэл гэж ангилан авч үздэг.

Улсын хэмжээнд бүртгэн шалгасан 1782 гэмт хэргийн 1658 буюу 93,0% нь жолоочийн буруутай үйлдлээс, 100 буюу 5,7% нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 24 буюу 1,3% нь замын нөхцөлөөс гарсан гэж бүртгэгджээ.

График VII.2.12.



Зам тээврийн осол, гэмтлийн шалтгаан түүнээс урьдчилан сэргийлэх арга зам нь улс орон бүрт өөрмөц байх боловч ерөнхий зарчим нь адил байна. Зам тээврийн осол гэмтлийн гол эрсдэлтэй (шалтгаан) хүчин зүйлүүд нь:

- Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодох;
- Хамгаалалтын бүс, малгай хэрэглэхгүй байх;

- Хурд хэтрүүлэх;
- Замын аюулгүй байдал хангалттай биш байх зэрэг хүчин зүйл байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаанууд хэрэгжүүлж үр нөлөөг тооцох нь чухал байдаг.

Энэ үйл ажиллагаанд хурд хэтрүүлэх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг бууруулах, мотоциклын хамгаалалтын малгай, хамгаалах бүс, хүүхдийн хамгаалалтын суудлын хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд багтдаг.

Жолоочийн буруутай ослын шалтгаанаас:

- хажуу хоорондын зай тохируулаагүйгээс 50,9%;
- уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн 15,0%;
- эгнээ байр буруу эзэлсэн 11,2%;
- ухрах үйлдэл буруу хийсэн 5,9%-ийг эзэлсэн байна.

Хурд хэтрүүлэх нь улс орны зам тээврийн осол гарах үндсэн хүчин зүйл болдог ба энэ нь шинэ, залуу жолооч нартай холбоотой. Хурдыг 1 км/цаг-аар бууруулахад зам тээврийн осол 4-5% буурдаг гэж олон улсад үздэг.

Осол гарах үед автомашины хурд 30 км/цаг түүнээс бага хурдтай байхад осолд өртсөн явган зорчигч (бусад оролцогчид)-ын авсан гэмтэл нь үхэлд хүргэх эрсдэлд хүргэдэггүй. Өөрөөр хэлбэл, автоашинаар хурд багатай явах тусам хохирол бага учирдаг байна.

Орон нутаг гарч буй зам тээврийн ослын шалтгаанд жолооч анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсоноос гарсан зам тээврийн осол дийлэнх хувийг эзэлдэг.

Жолоочийн хөдөлмөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бөгөөд жолооны ард удаан хугацаагаар ажиллах нь биеийн хүчний хөдөлмөр хийсэнтэй адил тооцогддог.

Хөдөлмөрийн чадвар тогтмол байдаггүй, цаг, өдөр, хоног, гарагийн хугацаанд өөрчлөгдөж байдаг. Ядаргаа нь жолоочийн бие болон сэтгэл зүйн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал: харах мэдрэмж буурна, бусад эрхтэний мэдрэх чадвар муудаж, ой тогтоолт, анхаарал суларч, мэдээллийг хүлээн авах болон боловсруулах чадвар энэ үед мууддаг онцлогтой. Амрахгүйгээр удаан явах, 12 цаг буюу түүнээс дээш хугацаагаар өдөр бүр ажиллах нь хэт ядаргааны шалтгаан болдог.

Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд "Долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл, ердийн ажлын үргэлжлэл 8 цаг хүртэл, ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй 12 цаг ба түүнээс дээш байхаар тогтоосон" нь жолооч, ААН, байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтан мөрдөж биелүүлэх ёстой хэм хэмжээ юм.

Гэмт хэргийн шалтгаан нь төв, орон нутгийн замд ялгаатай байна.

Хүснэгт VII.2.3.

Улаанбаатар хотод:	Орон нутагт:
Хажуу хоорондын зай тохируулаагүй	Хажуу хоорондын зай тохируулаагүй
Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн	Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон
Эгнээ байр буруу эзэлсэн	Зогсоох арга хэмжээ аваагүй
Ухрах үйлдэл буруу хийсэн	Хурд хэтрүүлсэн
Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон
Бусад	Бусад

Улсын хэмжээнд хурд хэтрүүлсэнээс бүртгэгдсэн ослын 67,7% нь орон нутгийн замд гарсан осол байхад согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс шалтгаалсан ослын 60,3% нь нийслэлийн замд гарсан осол байна.

Энэ төрлийн гэмт хэрэг жолоочийн буруутай үйлдлээс дийлэнх хувь нь гарч нийслэлд явган зорчигч, орон нутагт тээврийн хэрэгслээр зорчигчийн амь нас, эрүүл мэнд хохирсон байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол

- явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах;
- гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах;
- ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх;
- зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох;
- замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах;
- согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсэг дээгүүр явах, хэвтэх;
- замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах;
- замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох (зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, чихэвчээр хөгжим сонсох, мессеж бичих);
- сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах (эцэг ах асран хамгаалагчийн буруугаас) зэргээс автомашинд дайрагдах, мөргөгдөх хэлбэрээр хохирох тохиолдол бүртгэгдсээр байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2016 онд улсын хэмжээнд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэгт 100 буюу 5,6%-ийг эзэлсэн байна. Явган зорчигч амь насаа алдсан явган зорчигчийн өөрсдийн буруутай үйлдлээс шалтгаалсан 32 хэргийг хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад явган зорчигчдын Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсэхгүй, тэдэнд оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэл бэртэл авч хохирч байна.

Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол

Замын нөхцөл:

- Замын гадаргуу, нөхцөл;
- Замын гэрэлтүүлэг, чимэглэл;
- Замын тэмдэг тэмдэглэгээ ойлгомжгүй байснаас;
- Бусад гэж ангилан авч үзэж байна.

Техникийн гэмтэл саатал:

Жолоочоос хамааралгүй техникийн гэмтэл (жолооны хүрд гацах, тоормос гэнэт барихгүй болох, гэрэл дохионы саатал, хөдөлгүүрийн гэмтэл гэх мэт) үзүүлэлтийг тооцож байна.

Замын нөхцөл - Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр (замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт) нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг. Зам-орчин нь өөрөө замын хөдөлгөөний нэг бүрдэл болдог.

Замын нөхцөлөөс шалтгаалан гарсан осол улсын хэмжээнд 24 бүртгэгдсэн байна. Дээрх хүчин зүйлд техникийн гэмтэл, гадны гэрэл (замын гэрэл), зам орчны нөхцөлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон бүртгэл хангалтгүй байгаагаас замын нөхцөлөөс гарсан ослын үзүүлэлт бага бүртгэгдсэн хэвээр байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцөлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол хэрэг гарах шалтгаан нөхцөлүүдийн нэг болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бууруг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Манай орны замын нөхцөл тийм сайн биш байхад замын нөхцөл гэсэн үзүүлэлт маш бага байгаа нь үүнтэй холбоотой.

Замын нөхцөлөөс шалтгаалсан зам тээврийн ослын хохирлыг тухайн зам, байгууламжийг хариуцсан байгууллага, ААН бүрэн хариуцдаг учраас энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, ААН-ийн хариуцлага маш өндөр байдаг гэж Европын Хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн тээврийн хорооны тайланд дурджээ.

Замын хөдөлгөөнд оролцогчдод сайхан зам дотроо аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцөлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж үзэж байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн хэлбэр

Улсын хэмжээнд тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, шүргэлцэх хэлбэрээр дийлэнх буюу 1386 гарсан нь нийт тохиолдлын 77,8%-ийг эзэлж байна.

- Тээврийн хэрэгсэлтэй тээврийн хэрэгсэл мөргөлдөх - 965 буюу 54,2%;
- Явган зорчигч мөргөх - 632 буюу 35,4%;
- Тээврийн хэрэгслээр онхолдох - 127 буюу 7,1%;
- Зорчигч унагах - 28 буюу 1,6% ;
- Унадаг дугуйтай хүн мөргөх - 3 буюу 0,2%;
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх - 27 буюу 1,5% бүртгэгдсэн байна.

Нийслэл хотод автомашин мөргөлдөх, явган зорчигч мөргөх хэлбэрээр дийлэнх гэмт хэрэг гарч байхад орон нутагт автомашин мөргөлдөх, онхолдох хэлбэрээр их бүртгэгдсэн.

Улсын хэмжээнд тээврийн хэрэгсэл онхолдсоноос 193 хүний амь нас хохирчээ, үүний 93,1%-ийг орон нутгийн замд гарсан осол эзэлсэн. Орон нутагт онхолдох хэлбэрээр гарч буй зам тээврийн осол нь бүрэн бус мотоцикл согтуугаар жолоодох, хурд хэтрүүлэх, замын нөхцөлд хурд тохируулан яваагүйгээс гарсан байна.

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН УЛИРАЛ, САР, ГАРАГ, ЦАГ, ЗАМ, ОРЧИН

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 25,2% нь өвөл, 23,1% нь хавар, 21,3% нь зун, 30,4% нь намар тус тус бүртгэгджээ. Өнгөрсөн онд бүртгэгдсэн осолтой харьцуулахад намрын улиралд гарсан осол 5,8%-аар өсч, хавар гарсан осол 5,3%-аар буурсан байна.

Зам тээврийн ослын шинжтэй дуудлага нь замын гадаргуунд өөрчлөлт гарах, хальтиргаа гулгаанаас хамааралтай өвлийн улирал болон хичээлийн шинэ жил эхэлж

хотод шилжин суурьшигсад өсөх, оюутан залуус сургуульдаа ирэх гэх мэт хөдөлгөөнд оролцогчид харьцангуй ихэсдэгтэй холбоотойгоор намрын улиралд ослын дуудлага тодорхой хэмжээгээр өсдөг байна. Зам тээврийн ослын улмаас зун, намрын улиралд хөдөлгөөнд оролцогчид амь насаа алдсан, гэмтэж бэртсэн үзүүлэлт илүү бүртгэгджээ.

УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДУУДЛАГА, БҮРТГЭГДСЭН ОСОЛ

Хүснэгт VII.2.4.

Сар	Бүртгэгдсэн бүх зам тээврийн осол	Гэмт хэргийн улмаас	
		нас барсан хүн	гэмтсэн хүн
1 сар	4602	12	73
2 сар	3046	21	83
3 сар	3347	25	111
4 сар	3572	24	107
5 сар	3849	31	121
6 сар	3471	47	129
7 сар	2896	54	112
8 сар	3564	55	127
9 сар	4665	42	128
10 сар	4723	37	109
11 сар	4831	30	68
12 сар	4146	21	79
өвөл	11794	54	235
хавар	10768	80	339
зун	9931	156	368
намар	14219	109	305

Зам тээврийн осол бүртгэгдсэн гаригаар авч үзвэл: ослын гаралт долоо хоногийн бүх өдрүүдэд жигд бүртгэгдсэн байна. 2014 оноос өмнөх жилүүдэд амралтын Бямба, Ням гаригуудад осол бага, Даваа гариг их гардаг байсан бол улсын дугаарын хязгаарлалтаар хөдөлгөөнд оролцуулснаас ажил, амралтын өдрүүдэд гарсан ослын ялгаа байхгүй болсон. Түүнчлэн, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, баяр ёслолын үеэр, амралтын өдрүүдэд ачаалал ихтэй байх тохиолдол их бүртгэгдсэн байна.

2016 онд бүртгэгдсэн 1782 гэмт хэрэг гарсан цагийг бүлэглэн авч үзвэл:

- 07,00-12,00 цагийн хооронд 339 буюу 19,0%;
- 13.00-18.00 цагийн хооронд 613 буюу 34,4%;
- 19.00-00.00 цагийн хооронд 627 буюу 35,2%;
- 01.00-06.00 цагийн хооронд 203 буюу 11,4% нь тус тус бүртгэгджээ.

Осол их бүртгэгдэж байгаа цагийн байдлаас харахад ажил тарах, тарсаны дараа гарсан осол дийлэнх хувийг эзэлсэн тоон үзүүлэлт гарсан байна.

Хүний амь нас хохирсон гэмт хэргийн гаралт зун, намрын улиралд харанхуй бүрэнхий, гэрэлтүүлэг муутай замд 21.00 цагаас 06.00 цагийн хооронд их бүртгэгдсэн хэвээр байна.


ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ГАРСАН ЗАМ ОРЧИН, ЦАГ АГААРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг нь:

График VII.2.13.



График VII.2.14.



Зам орчны нөхцөл байдлаас дүгнэхэд:

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 81,1% нь асфальтан 7,0-9,0 м өргөнтэй авто зам дээр гарсан нь нийслэлд буюу хүн ам ихээхэн төвлөрсөн хот суурин газарт бүртгэгдсэн осол ихэнх хувийг эзэлж байгаатай холбоотой. Цаг агаарын таатай үед нийт ослын 81,6% нь гарсан байхад ослын 61,0% нь тэгш замд, авто замын зорчих хэсэгт 92,3% нь бүртгэгдсэн үзүүлэлт гарч байна.

Гэмт хэрэгт холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл

Гэмт хэрэгт холбогдсон тээврийн хэрэгслийн төрлөөр авч үзвэл: суудлын автомашин 92,3%-ийг эзэлсэн тоо баримт нь манай улсад бүртгэлтэй автомашины 69,3%-ийг суудлын автомашин эзэлдэг ба энэ төрлийн автомашин замын хөдөлгөөнд их оролцдогтой холбон үзэж байна.

2016 онд зам тээврийн осолд орсон автомашины төрлийг урьд оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл мотоциклоор үйлдэгдсэн осол 2.8%-аар, автобус 19,2%-аар, механизм 38,7%-аар буурсан байхад ачааны автомашинаар үйлдэгдсэн осол 17,5%-аар өсчээ.

Хүснэгт VII.2.4.

№	он		Суудлын	Ачааны	Автобус	Механизм	Мотоцикл	Унадаг дугуй	Микро автобус
		Улсын хэмжээнд							
1	**2016**	улсын хэмжээнд	1642	73	32	1	17	6	11
		эзлэх хувь	92.1	4.1	1.8	0.1	1.0	0.3	0.6

ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХҮҮХЭД ӨРТСӨН БАЙДАЛ

Улсын хэмжээнд энэ төрлийн 274 гэмт хэрэг бүртгэгдэж, 50 хүүхэд амь насаа алдаж, 255 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ.

Улсын хэмжээний үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад нас барсан хүүхэд 7,0%-аар, гэмтсэн хүүхдийн тоо 0,4%-аар буурчээ. Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн 90% буюу 45 хүүхэд орон нутгийн замд амь насаа алдсан байна.

Хүснэгт VII.2.5.

Төв, орон нутаг	Нас барсан хүүхэд	Өссөн, буурсан хувь	2016 онд нийт нас барсан хүнд хүүхдийн эзлэх хувь	Гэмтсэн хүүхэд	Өссөн, буурсан хувь	2016 онд нийт гэмтсэн хүнд хүүхдийн эзлэх хувь
Архангай	4		*30.8*	4	*-20.0*	*14.3*
Баянхонгор	4	*4*	*40.0*	5	*-28.6*	*31.3*
Булган	1	*-50.0*	*6.7*	1	*-75.0*	*4.8*
Говь-Алтай				5	*2.5д*	*23.8*
Говьсүмбэр						
Дархан-Уул	2		*20.0*	5	*-37.5*	*11.6*
Дорноговь	1		*4.0*	6	*50.0*	*17.1*
Дорнод	1		*16.7*	5	*-16.7*	*16.7*
Дундговь				2	*2д*	*15.4*
Завхан				2	*-50.0*	*18.2*
Орхон	1		*33.3*	3	*-62.5*	*12.0*

Өвөрхангай	3	-25.0	13.6	5	-16.7	12.8
Өмнөговь	2	2	10.5	4	-20.0	15.4
Сүхбаатар	1		11.1	2	-50.0	12.5
Сэлэнгэ	4	-20.0	12.1	12	2д	15.2
Төв	5	25.0	10.6	5		6.9
Увс	2	-33.3	50.0	4	2д	36.4
Ховд	2	-50.0	10.5	6	2д	26.1
Хөвсгөл	2	-33.3	11.8	4	-42.9	21.1
Хэнтий	4	33.3	17.4	1	-66.7	5.0
Баянгол				22	4.8	22.4
Баянзүрх	2	-60.0	9.5	33	-2.9	22.3
Сүхбаатар				25	25.0	23.4
Сонгинохайрхан	1	-50.0	6.3	27		18.5
Хан-Уул				15	15.4	25.0
Чингэлтэй				17	-10.5	21.3
Багануур	1		16.7	1		5.0
Багахангай						
Налайх	1		20.0	2		9.5
Улаанбаатар	5	-58.3	5.6	142	6.0	20.9
Орон нутаг	45	7.1	14.5	82	-9.9	14.5
Улс	50	-7.4	12.5	224	-0.4	18.0

Гэмт хэргийн улмаас нийт нас барсан хүний 12,5%-ийг, нийт гэмтсэн хүний 18,0%-ийг хүүхэд эзэлж байна.

ДӨРӨВ. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ТЭМЦЭЖ БУЙ ТОГТОЛЦОО, ХҮН, ХҮЧ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Замын цагдаагийн алба нь 1 газар, 6 хэлтэс, 4 тасагтай, Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар нь хамгаалалтын 1, дүүрэг дэх замын цагдаагийн 6 хэлтэстэй, албаны хэмжээнд нийт офицер 261, ахлагч 262 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй, улсын хэмжээнд 21 аймгийн цагдаагийн газар, хэлтсийн Замын цагдаагийн тасаг, Төмөр зам, Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг, Зэвсэгт хүчин, ХХЕГ-ын Авто техникийн шалгах албаны бүтэц, зохион байгуулалттайгаар зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэн хяналт тавьж байна.

Зураг VII.2.2.

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2016 оны 10 дугаар сарын 11-ий өдрийн
б/544 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



ТАВ. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1.2 сая гаруй хүн амь насаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна. Зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжиж байгаа улс оронд ногдож, жилд нийт 65 тэрбум ам. долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд Ерөнхий Ассемблейн хуралдаанаас 2011-2020 оныг "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд" болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50%-аар бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

2010 онд Тайланд Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссын Бүс нутгийн замын хөдөлгөөний шинжээч нарын уулзалтаар улс орон бүрт зам тээврийн ослын нас баралтыг бууруулах "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж"-ийг гаргасан.

Манай улсын хувьд зам тээврийн осол, зөрчлийн тоо жилээс жилд нэмэгдэж, түүнээс шалтгаалах нас баралт өсөх хандлагатай байна. Зам тээврийн осол, гэмтэл үүсэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь хурд хэтрүүлэх (22.7%), согтууруулах ундаа хэрэглэх (9.1%) зөрчил болж байгаагаас гадна хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангахгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын

биелэлт хангалтгүй, тээврийн хэрэгслийн ашиглалт хуучирсан, хөдөлгөөнд оролцогчдын соёл, боловсрол дутмаг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг дутагдал байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал нь замын хөдөлгөөнийг зохицуулагч, жолоочийн үүрэг мэт алдаатай ойлголт байсан бөгөөд орчин үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь "Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин" гэсэн харилцан уялдаа бүхий цогц асуудал гэдгийг эрдэмтэд тогтоогоод байна.

Монгол Улсын хэмжээнд 2012-2020 онд зам тээврийн ослын улмаас нас барсан болон хүнд гэмтсэн хүний тоог тус бүр 50%-аар бууруулах зорилттойгоор Засгийн газрын 2015 оны 05 сарын 02-ны өдрийн 146 дугаар тогтоолоор "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах (2011-2020 он) үндэсний стратеги" батлан хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн дагуу "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, түүнийг хэрэгжилт"-ийг хангах Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хороог Зам тээврийн сайдын 2017 оны 1 сарын 02-ны өдрийн 01 дүгээр тушаалаар байгуулсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хороонд ЗТХЯам, ХЗДХЯам, СЯам, ЭМЯам, БСШУСЯам, БХБЯам, НХХЯам, БОАЖЯам, Хөдөлмөр хамгааллын үйлчилгээний ерөнхий газар, МХЕГ, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, их, дээд сургуулийн төлөөлөл ХСИС, ЦЕГ-ын төлөөлөл замын цагдаагийн алба, Монголын авто тээврийн нэгдсэн холбоо, МҮОНРТ, ТББ-ын төлөөллүүд багтсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 оны 09 сарын 01-ны өдрөөс шинэчлэн батлагдаж хуульд захиргааны зөрчилд оногдуулах торгуулийн хэмжээ өссөнтэй холбоотойгоор улсын хэмжээнд зөрчлийн тоон үзүүлэлт буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт VII.2.6.

№	Үзүүлэлтүүд	2015.01.01-2015.12.14	2016.01.01-2016.12.14	Харьцуулалт
1	Зам тээврийн ослын дуудлага	89154	80574	*-9.6*
2	Нийт бүртгэгдсэн осол	39033	32247	*-17.4*
3	Хүн гэмтсэн осол	3811	3415	*-10.4*
4	Эдийн хохиролтой осол	35222	35832	*1.7*
5	Гэмтсэн хүн	4683	4632	*-1.1*
6	Нас барсан хүн	109	90	*-17.4*
7	Хүүхэд өртсөн осол	935	921	*-1.5*
8	Согтуу жолооч илрүүлэлт	26215	19516	*-25.6*
9	Журамлагдсан автомашин	10534	3484	*-66.9*
10	Илрүүлсэн зөрчил	1404614	962706	*-31.5*
11	Торгуулийн дүн	15926469400	20808025500	*30.7*

"Хүн-Тээврийн Хэрэгсэл-Зам-Орчин" гэсэн системийн аюулгүй байдлыг цогцоор нь бүрдүүлснээр зам тээврийн ослын сөрөг үр дагаврыг мэдэгдэхүйц хэмжээгээр багасгана.

ЗУРГАА. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Жолоочийн буруутай үйлдэл - Монгол Улсад бүртгэгдсэн ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлөөс харахад жолоочийн буруутай үйлдлээс 93,0% нь бүртгэгдсэн байна. Жолоочийн буруутай үйлдэл дотроо хажуу хоорондын зай тохируулаагүй, эгнээ байр, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэснээс гарсан осол давамгайлж байна. Хурд хэтрүүлсэн болон согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс шалтгаалсан зам тээврийн осол буурсан үзүүлэлттэй ч орон нутагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, хурд хэтрүүлсэнээс гарсан осол нилээд хувийг эзэлж байна.

Хамгаалах бүс - Гэмт хэрэгт өртсөн, холбогдсон жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчдын 64,4% нь хамгаалах бүсээ хэрэглээгүй, 16,5% нь хэрэглэсэн эсэх нь тогтоогдоогүй үзүүлэлт гарч байна. Нас барсан хүмүүсийн хамгаалах бүсний хэрэглээнээс харахад 4,2% нь хамгаалах бүс хэрэглэсэн, 82,5% нь хамгаалах бүсээ хэрэглээгүй, 13,3%-ийг нь хамгаалах бүс хэрэглэсэн эсэхийг тогтоох боломжгүй тогтоогдоогүй гэсэн судалгаа байна. Хамгаалах бүсийг хэрэглэснээр жолооч болон тээврийн хэрэгслээр зорчигчид осолд өртөх тохиолдолд автомашины урд сууж явсан зорчигчийг 40-50%-аар, ард суусан зорчигчийг 25-75%-аар осол гэмтэл, эрсдлээс бүрэн хамгаалдаг.

Хүүхдийн зориулалтын суудал–.Орон нутагт хүүхдүүд тээврийн хэрэгслээр зорчиж байх үедээ амь насаа алдаж байгааг амь насаа алдсан хүүхдийн 88,9% нь орон нутгийн замд гарсан ослоос шалтгаалжээ. Хүүхдийн зориулалтын суудал хэрэглэж хэвшсэнээр зам тээврийн осол гэмтлийг нярай хүүхдийг 70 хүртэл хувиар, бага болон өсвөр насны хүүхдийг 54-80 хүртэл хувиар бууруулах магадлалтай байдаг.

Явган зорчигч - Явган зорчигчийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцдоггүй, согтуугаар хөдөлгөөнд оролцож байгаа нь зам тээврийн ослын хохирогч болоход нөлөөлж байна. Явган зорчигч замын хөдөлгөөнд зөв оролцох хандлага, дадал эзэмшихгүй байна.

Унадаг дугуйгаар - зорчигчийн хөдөлгөөнд оролцох эрх, үүргийг тодорхой зааж өгөх, сургалт явуулах, мэдээлэл ихээр өгөх, унадаг дугуйгаар зорчих замыг тодорхой болгох гэх мэтчилэн асуудлуудыг хөндөх нь зүйтэй.

Мотоцикл - улсын хэмжээнд мотоциклоор зорчиж үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас сүүлийн 3 жилд 282 хүн амь насаа алдсаны 265 буюу 93,9% нь орон нутгийн замд гарсан ослын улмаас амь насаа алдсан байна. Амь насаа алдсан хүмүүсийн дийлэнх нь толгойдоо гэмтэл авсан нь үхэлд хүргэх шалтгаан болж энэ нь жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч хамгаалалтын малгай өмсөж хэвшээгүйтэй холбоотой. Мотоциклыг зориулалтаар нь зөв зохистой хэрэглэж (хамгаалалтын малгай өмсөж) заншвал үхэлд хүргэх эрсдэл 40 хүртэл хувиар буурна гэж олон улсад үздэг.

Тулгамдсан асуудал:

Жил ирэх тусам тээврийн хэрэгслийн тоо өсч, хөдөлгөөнд оролцогчдын тоо өсөхийн хирээр нутаг дэвсгэрийг бүрэн хяналтандаа авч чадахгүй байна. Хүн хүч дутмаг ялангуяа орон нутгийн замд гарч буй зөрчил бүрт, жолооч бүрт хүрч ажиллах боломжгүй, техник

хэрэгсэл, орчин техник, технологи, зөрчил оногдуулах багаж хэрэгсэл, хурд хэмжигч, согтуурал шалгах багаж, гэрлийн тохиргоо, лампны стандарт шалгах гэх мэт багаж хэрэгсэл хангалтгүй байна. Тухайлбал, орон нутагт замын цагдаагийн алба хаагчдын орон тоо сүүлийн 10 жилд нэмэгдээгүй байхад хариуцсан нутаг дэвсгэрийн автомашины тоо 7-10 дахин өсч хяналт тавихад хүндрэл гарч байна.

Замын хөдөлгөөнд оролцогчдын замын хөдөлгөөний мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд зөв оролцох дадал эзэмшээгүй, эрх зүйн мэдлэг хангалтгүй, замын хөдөлгөөнд оролцох соёл, ухамсар учир дутагдалтай, хэнэггүй зан, хайхрамжгүй байдал нь зам тээврийн осол, хэрэгт холбогдох, өөрт болон бусдад хохирол учруулах шалтгаан болж байна.

Зам, замын байгууламж, зам орчны нөхцөл байдал, тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй, зам арчлалт хариуцсан ААН-үүдэд хариуцсан замын засвар арчлалтыг нэр төдий хийдэг, мэдэгдэл, шаардлага хүргүүлж байгаа боловч төсөв мөнгөгүй гэх шалтаг шалтгаанаар чанар муутай хийгдэж, замын арчилгаа хийгддэггүй байна. Замын бүтэц, зорчих хэсгийн гадаргууны байдал, замын өргөн, тэмдэг тэмдэглэл, замын эвдрэл, гэмтэл тухайн замын нөхцөл байдал хангалтгүйгээс зам тээврийн осол, хэрэг бүртгэгдэх явдал их байна. Өнөөдрийн байдлаар замын нөхцөлтэй холбоотой ослын тохиолдлыг жолоочийн буруутай үйлдлээр шийдвэрлэж байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн замын цагдаагийн албаны хийх ажил мэтээр хандаж байгаа бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил учир дутагдалтай, энэ төрлийн ажилд бусад төрийн болон ТББ, ААН, иргэд анхаарал хандуулддаггүй. Олон талт хамтын ажиллагаа нь санхүүжилт байхгүйгээс тодорхой үр дүнд хүрдэггүй (зөвлөмж шийдвэр гаргаад хэрэгжүүлэх шатанд хөрөнгө, мөнгөний асуудал тулгарч шийдэлд хүрч чаддаггүй, төсөв, санхүүжилт муутай батлагдан гарч байна).

Орон нутагт аймаг, сумдын ИТХ, Засаг дарга нар энэ чиглэлийн ажилд ямар нэгэн шийдвэр гаргах, хяналт тавихдаа шуурхай биш байдгаас цаг үеийн болон яаралтай асуудалд шийдвэр хожимдож гарч цаг, хугацаа алдах асуудал их байна.

Явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөл тэр бүр бүрдээгүй, тухайлбал явган зорчигчийн зам дээр худалдаа үйлчилгээ эрхэлсэн, явган зорчигчийн зөвшөөрөгдсөн гэрэл нь автомашины хөдөлгөөнтэй огтлолцол олон байдаг.

Орон нутгийн замд том оврын болон хот хоорондын зорчигч тээвэрлэж байгаа жолооч нарын жолоочийн бүхээг өндөр байрласан байдгаас гэрлийн гялбаанд орох эрсдэл бага байдаг бол суудлын автомашинууд илүү гэрлийн гялбалтанд орж баримжаа алдан онхолдох бусад байдлаар зам тээврийн осол гардаг ба зам дээр хяналт тавьж байгаа цагдаагийн алба хаагч гэрэл шилжүүлээгүй тээврийн хэрэгсэлд хариуцлага тооцох үед нотлогдох боломжгүй байдаг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажил зохион байгуулахад орон нутгийн хувьд төсөв мөнгөний асуудлаас үүдэн хяналтын камер гэх мэт сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи ашиглах боломж бүрдэхгүй байна.

Алдаа дутагдал:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заагдсан зарим зөрчилд тухайлбал: харгалзах хүнгүйгээр 10 хүртэлх насны хүүхдийг хөдөлгөөнд оролцуулсан тохиолдолд арга хэмжээ авах нөхцөл бүрдээгүй бэлэн бус торгуулийн төхөөрөмжөөр иргэнийг торгох нөхцөл бүрдээгүй, бусад оролцогчдыг торгох нөхцөл хангалтгүй;
- Энэ төрлийн гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах, үнэлж дүгнэхэд шинжээч болон холбогдох албан тушаалтны мэдэл ур чадвар хангалтгүй;

- Хүн хүч, техник хэрэгсэл дутмаг учраас орон нутгийн олон зуун км замд зөрчил бүрт, жолооч бүрт хүрч хяналтаа тогтмол тавьж ажиллаж чаддаггүй;
- Орон нутгийн замд жолооч хэт ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож байгаад тавих хяналт дутмаг.

Давуу тал:

- Зөрчлийн торгуулийн дүн нэмэгдсэнээр жолооч нарт анхааруулга болж, зөрчил, ослын нас баралт тодорхой хэмжээгээр буурахад нөлөөлсөн.
- "Жолоочийн зөрчлийн оноо тооцох журам" хэрэгжсэнээр жолооч нарын хариуцлагыг өндөржүүлэх хүчин зүйл болж байна.
- Холбогдох хууль, дүрэм, журам шинэчлэгдэн хэрэгжиж эхэлсэнээр хариуцлагын тогтолцоо сайжирсан.
- Цагдаагийн шалгах төхөөрөмж ашиглаж эхэлсэнээр мэдээллийн сүлжээ ашиглаж жолоочийн, тээврийн хэрэгслийн мэдээллийг нэг дороос авч, хяналт тавих нөхцөл бүрдсэн.

ДОЛОО. ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

- Бүх нийтэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн боловсролыг олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, журмуудыг сурталчлан ойлгуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран албан ба албан бус сургалт улс орон даяар зохион байгуулах, шат шатны сургалтыг давтамжтайгаар оруулах, мэдээллийг хүртээмжтэй болгох (ЕБС, их, дээд сургууль, коллеж, техник мэргэжлийн сургууль гэх мэт);
- Алба хаагчийн мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг нэмэгдүүлэх чиглэлээр жилд 2 удаа тодорхой чиглэлийн сургалтанд хамруулж ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх;
- Замын хөдөлгөөний аюулгүй бәйдлыг хангахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах (хууль сахиулах байгууллагын уялдаа холбоо хамтын ажиллагаа тааруухан байгаагаас хамтран ажиллах талаар тэр бүр санал санаачилга гарахгүй байна);
- Хууль сахиулах байгууллагад жил бүрийн зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөвтэй болгох;
- Орон нутгийн замд замын ачаалал, анхаарал татах зам орчинтой цэгүүдэд хяналтын камерыг олноор байршуулах, автомат хурд хэмжигч байршуулах, хяналтын системийг автоматжуулах;
- Замын хөдөлгөөнийг хяналтанд авах зорилгоор дэд бүтэц бүхий хяналтын цэгийг байгуулах ажлыг эрчимжүүлж, цаашид хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух улсын чанартай замуудад хяналтын цэгүүдийг байгуулах ажлыг хэрэгжүүлэх;
- ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал болон өсвөр үе, залуучуудын дунд Замын хөдөлгөөний дүрмийн ойлголтын талаар тандалт судалгаа хийх, цаашдын хандлага, шалтгааныг тодорхойлох зорилгоор криминологи судалгааг мэргэжлийн болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран хийх;
- Зам, тээвэр болон цагдаагийн байгууллагын чиг үүрэг хариуцсан ажилтан, албан

хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгөөр тасралтгүй зохион байгуулах.

Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

- Аймаг, хотын Засаг даргын мөрийн хөтөлбөрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажлуудыг нарийн тусгаж хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- Замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, хурд сааруулагч, эсрэг урсгалыг тусгаарлагч хашлага, гарам зэрэг хөдөлгөөн зохицуулах техник, тоног төхөөрөмжийн шаардагдах тоо хэмжээг судалж, шийдвэрлэх;
- Согтууруулах, мансууруулах зүйл, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэхийг шалгаж тогтоох арга зүйг боловсронгуй болгож, холбогдох байгууллагыг шаардлагатай техник хэрэгслээр хангах;
- Зам арчлалт хариуцсан ТӨХК-ийн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг нэмэгдүүлэх, орон нутгийн төрийн өмчит компаниуд хариуцсан замын арчлалтыг маш хангалтгүй хийж байгаа тул хяналтын тогтолцоог чангатгах,
- Орон нутагт замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж, түүний хэрэгжилтэд хяналт тавихад бэлэн бус торгуулийн системд ажиллах цагдаагийн шалгах төхөөрөмжөөр бүрэн хангах, техник хэрэгсэл шинээр ашиглах нөхцөл бололцоо, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх.

Төр засгийн түвшинд анхаарч шийдвэрлүүлэх асуудал:

- Хүн ам, тээврийн хэрэгслийн тооны эрчимтэй өсөлтийг харгалзан замын цагдаагийн албыг орон тоо, хүн хүч, техник хэрэгслийн хувьд бэхжүүлэх;
- Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд заасан жишиг норматив зааснаар олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу байнгын хяналтын пост, үйлчилгээний төв, зогсоол барих ажлыг зохион байгуулж, авто зам, авто тээврийн болон мэргэжлийн хяналтын, цагдаагийн байгууллагын хяналтыг уялдуулах; Орон нутгийн 150 км тутам замд хяналтын пост барьж байгуулахаас гадна явуулын хөдөлгөөнт пост ажиллуулах, орон нутгийн замд зорчиж буй жолооч бүрт хүрч ажиллах нөхцөл бололцоо, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгөх;
- Зам тээврийн осол, хэргийн шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, авч хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий улсын хэмжээний институцийг шинээр байгуулах;
- Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдгийг таних шаардлага хангасан камер, программыг үйл ажиллагаандаа ашиглах, хяналтын камерын байршлын тоо, харах орчныг нэмэгдүүлэх, бичлэгийг чанаржуулах, тодруулах тоног төхөөрөмжтэй теле камерын цогц шийдлийг бий болгох;
- Орон нутгийн болон төв суурин газруудад хяналтын камерын систем нэвтрүүлж, зам дээр автомашины улсын дугаар таних болон хурд хэмжигч хяналтын камерыг олноор байрлуулах, зөрчил илрүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан шийдвэрлэх;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон барилга байгууламж, авто зам, гүүр, тэдгээрийн хиймэл байгууламжийг төлөвлөх, шинээр барих, өргөтгөх, засварлах зэрэг улсын стандартыг боловсронгуй болгох;

- Хөдөлгөөний ачаалал нэмэгдэж байгаад анхаарч шинээр зам, гүүр барьж байгуулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, орон нутгийн зам, замын тэмдэглэл олон улсын стандартад нийцүүлэх, чанарт анхаарах, улсын чанартай асфальтан замд замын голын тэнхлэгийн цагаан зураасыг цацруулагчтай болгох (огцом эргэлт, уулын уруу дэржигнүүртэй, өгсүүр гэх мэт замын онцлогт тааруулан тэмдэг тэмдэглэгээг хийлгэх, арчилгаанд мөн анхаарах);
- Зам, замын зохион байгуулалтыг сайжруулах, шинээр барих, өргөтгөх, техник хэрэгслийг шинээр байрлуулах зэрэг хөрөнгө мөнгө ихээр шаардаж хийгддэг ажлыг мэргэжлийн, туршлагатай ААН-үүдээр хийж гүйцэтгүүлэх, тендерийн шалгаруулалтыг явуулж буй төр, захиргааны байгууллага, ажилтан, албан тушаалтнуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэх, хариуцлагын тогтолцоог чангатгах;
- Зам засвар арчлалтын компанид олгох санхүүжилтийг нэмэгдүүлж шаардлагыг өндөрсгөх, үр дүнг тооцох механизм бий болгох;
- Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх олон талт ажил, арга хэмжээ зохион байгуулахад зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэр хангалтгүй учир санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын 2012 оны 05 сарын 02-ны өдрийн 146 дугаар тогтоол "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020)"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын асуудлыг шийдвэрлэх.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс:

- Замын хөдөлгөөнд оролцогчдын замын хөдөлгөөний мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд зөв оролцох дадал эзэмшээгүй, замын хөдөлгөөнд оролцох соёл, ухамсар учир дутагдалтай, хэнэггүй зан, хайхрамжгүй байдал зэрэг нөлөөлж байна. Эрх зүйн мэдлэг маш хангалтгүй;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад олон нийтийн мэдлэг, соёл ухамсрыг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээг явуулах,
- Бага насны хүүхдийг харгалзагч хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцох нөхцөл хангалтгүй;
- Явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөл тэр бүр бүрдээгүй, тухайлбал явган зорчигчийн зам дээр худалдаа үйлчилгээ эрхэлсэн, явган зорчигчийн зөвшөөрөгдсөн гэрэл нь автомашины баруун зүүн эргэх хөдөлгөөнтэй давхцдаг гэх мэт;
- Жолооч нарын замын хөдөлгөөний мэдлэг дутмаг, мэдсээр байж зөрчил гаргаж байгаа нь зам тээврийн осол хэрэг гарах шалтгаан нөхцөл болж байна
- Хайлшин обудтай хурд ихтэй, хөнгөн, тогтвор муу Хятад улсад үйлдвэрлэсэн мотоциклийн хөдөлгөөнд хяналт тавих;
- Хамгаалах бүс, хамгаалалтын малгай, хүүхдийн суудлын хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Орон нутгийн замд том оврын болон хот хоорондын зорчигч тээвэрлэж байгаа жолооч нарын жолоочийн бүхээг өндөр байрласан байдгаас гэрлийн гялбаанд орох эрсдэл бага байдаг бол суудлын автомашинууд илүү гэрлийн гялбалтанд орж баримжаа алдан онхолдох бусад байдлаар зам тээврийн осол гардаг ба зам дээр хяналт тавьж байгаа цагдаагийн албан хаагчнь гэрэл шилжүүлээгүй тээврийн хэрэгсэлд хариуцлага тооцож болох үед нотлогдох боломжгүй байдаг;

Хүндрэл бэрхшээл

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажил зохион байгуулахад орон нутгийн хувьд төсөв хөрөнгийн асуудлаас үүдэн хяналтын камер гэх мэт сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи ашиглах боломж бүрдэхгүй байна,
- Орон нутагт бэлэн бусаар торгууль оногдулах багаж, техник хэрэгсэл бүрэн хангагдаагүй;
- Зөрчил бүрт хүрч ажиллаж чадахгүй байна;
- Замын арчлалт хангалтгүй;
- Алба хаагчдын хувцасны хангалт чанар муу;
- Хөдөлгөөнд оролцогчдийн эрх зүйн мэдлэг дутмаг, ухамсар төлөвшөөгүй.

Алдаа дутагдал

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заагдсан зарим зөрчилд тухайлбал: харгалзах хүнгүйгээр 10-с доош насны хүүхдийг хөдөлгөөнд оролцуулсан тохиолдолд арга хэмжээ авах нөхцөл бүрдээгүй бэлэн бус торгуулийн багажаар иргэн, бусад оролцогчийг торгох нөхцөл хангалтгүй;
- Энэ төрлийн гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах, үнэлж дүгнэхэд шинжээч болон холбогдох албан тушаалтны мэдэл ур чадвар хангалтгүй;
- Олон зуун км замд хүрч ажиллах, хяналт тавих бололцоо муу;
- Хүн хүч, техник хэрэгсэл дутмаг учраас хяналт тогтмол тавьж чадахгүй байна.

БУСДЫН БИЕ МАХБОДИД ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГ



3. БУСДЫН БИЕ МАХБОДИД ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГ

1. БУСДЫН БИЕ МАХБОДИД ГЭМТЭЛ УЧИРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, КРИМИНОЛОГИЙН АСУУДАЛ

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг гэх ойлголтонд хүний бие махбодь, эрүүл мэндийн эсрэг чиглэсэн нийгмийн хор аюул ихтэй гэмт хэргүүд багтана. Үүнд:

- Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах -ЭХ-н 96-р зүйл
- Бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах - ЭХ-н 97-р зүйл
- Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах -ЭХ-н 98-р зүйл
- Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах -ЭХ-н 99-р зүйл
- Тарчлаах -ЭХ-н 100-р зүйл

Тус гэмт хэргийн нэг онцлог бусдад бие махбодид хохирол учруулаад зогсохгүй хохирогч төдийгүй, түүний ойр дотны хүмүүсийг санаа сэтгэлийн хүнд дарамтанд оруулдаг гэмт хэрэг юм.

Гэмтлийн зэргийг дөрвөн шалгуур шинжээр тогтооно. Үүнд:

- Амь биед аюултай эсэх;
- Эрүүл мэндийг сарниулсан хугацаа;
- Энгийн хөдөлмөрийн чадварыг тогтонги алдсан хэмжээ (%);
- Гэмтлээс үүссэн уршигт үлдэц.

Амь биед аюултай гэмтэл гэдэгт гэмтэх үедээ амь насанд аюултай байдалд хүргэсэн болон ердийн явцаараа ихэвчлэн үхэлд хүргэх гэмтлүүд хамаарна. Эмнэлгийн тусламжийн үр дүнд амь нас аврагдсан нь амь биед аюултай гэсэн шалгуур шинжийг өөрчлөхгүй;

Эрүүл мэндийг сарниулсан хугацаа: гэмтлээс үүссэн бүтэц, үйл ажиллагааны хямрал арилах хүртэл үргэлжилсэн хугацаагаар тогтооно. Эрүүл мэндийг түр хугацаагаар сарниулах гэдэгт гэмтэл, өвчин, эмгэг байдал, үйл ажиллагааны хямрал нь дөрвөн долоо хоногоос хэтрээгүйг, удаан хугацаагаар сарниулах гэдэгт дөрвөн долоо хоногоос дээш хугацаанд гэмтэл, өвчин, эмгэг байдал үргэлжлэхийг хамааруулна;

Энгийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалт мэргэжлийн болон тусгай нарийн мэргэшлийн хөдөлмөрийн чадварын алдагдалтаар бус энгийн ажлыг хийх чадвар алдсан хэмжээгээр нь үнэлнэ. Үүнийг "Энгийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалтын хэмжээ" хүснэгт 1-ээр тогтооно;


Гэмтлээс үлдсэн уршигт үлдэц гэдэгт: хараагүй, сонсголгүй болсон, эрхтэнгүй болсон буюу түүнийг ажиллагаагүй болгосон, нүүр засаршгүй гэмтэж, дүрс алдагдсан, жирэмслэлт таслагдсан (Эрүүгийн хуулийн 96.1 дүгээр зүйлд хүүхэд дутуу гаргуулсан гэж заасан), сэтгэцийн өвчтэй болсон нь хамаарна;[1]

Дээрх шинжүүд нь бусдын бие махбодид гэмт учруулах гэмт хэргүүд нийгмийн хор аюулаар хэр гэмт хэрэг болохыг илтгэн харуулж байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийг 2016 оны байдлаар аймгуудын хэмжээнд харьцуулсан судалгаа

График.VII.3.1.

1 Гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний заавар.



Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг нь хот суурин газар ихэвчлэн үйлддэгдэг, нийт гэмт үзэгдлийн дунд эзлэх хувийн жин 30-40 орчим хувийг эзэлдэг, зарим тодорхой бүс нутагт 60 хүртэл хувийг эзэлдэг гэмт хэрэг юм.

Тус гэмт хэргийн гаралтыг 2015-2016 оны байдлаар авч үзвэл: [2]

Хүснэгт VII.3.1.


	Хэргийн тоо		Өсөлт бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	
	2015 он	2016 он		2015он	2016 он
Орон нутаг	3277	3282	0,2%	40.6%	39.8%
Нийслэлд	4784	4958	3.6%	59.3%	60.1%
Бусад газар	3	8	2.7 дахин	0.04%	0.1%

Дээрх үзүүлэлтэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөлттэй байхаас гадна хүн ам ихээр төвлөрсөн газар их үйлддэгдэг нь батлагдаж байна. Тухайлбал 2015 онд орон нутагт 3277 хэрэг бүртгэгдсэн бол нийслэлд 4784 байгаа нь 1507 гэмт хэргээр, 2016 онд нийслэлд үйлдэгдсэн бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг орон нутагд үйлдэгдсэн гэмт хэргээс даруй 1676-аар тус тус их байна.

2 ЦЕГ. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийг хэргийн ангиллаар авч үзвэл:

График VII.3.2.



Хэргийн ангиллын хувьд 2015 онд хүнд гэмт хэрэг 424 буюу 5.2%, хүндэвтэр гэмт хэрэг 1128 буюу 14%, хөнгөн гэмт хэрэг 6512 буюу 80.8%, 2016 онд хүнд гэмт хэрэг 407 буюу 4.9%, хүндэвтэр гэмт хэрэг 1143 буюу 13,9%, хөнгөн гэмт хэрэг 6698 буюу 81.2% эзэлж байгаа хэргийн хүнд хөнгөний хувьд харьцангуй тогтвортой байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн дотор эзлэх хөнгөн гэмт хэргийн эзлэх хувь хэмжээ их байгаа нь хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх нэг шалтгаан болж байна (...яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн бөгөөд учирсан хохирлоо бүрэн төлсөн гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгон...)[3] тухайлбал, 2016 онд Сэлэнгэ аймагт энэ төрлийн хэрэгт 150 хүнд холбогдох хэргийн 158 хэрэг буюу 78.2%-ийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон байх бөгөөд энэ нь хохирогч, яллагдагчтай эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна.

Прокурор 44 хэрэг буюу 21.8%-ийг сэжигтнийг яллагдагчаар татах тогтоол болон яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна. Гэмт хэрэгт холбогдсон 150 хүнээс 7 буюу 4.6% нь боловсролгүй, 118 буюу 78.6% нь бүрэн болон бүрэн бус дунд, бага боловсролтой, 25 буюу 16.6% нь дээд боловсролтой байх бөгөөд 92 буюу 61.3% нь ажилгүй, 15 буюу 10% нь төрийн албан хаагч тус тус холбогдсон байна.

Хэрэгт холбогдсон хүмүүсийн насны байдлыг авч үзвэл 18-25 насны 23 хүн буюу 15.3%, 25-50 насны 111 хүн буюу 74.0%, 50-аас дээш насны 35 хүн буюу 23.3%-ийг тус тус эзэлж байна.

Сэлэнгэ аймаг дахь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд 61.3%-ийг (эр эмийн хардалт, өр авлага, хэрүүл маргаан, хохирогчийн бурууталй үйл ажиллагаа) буюу хувийн таарамжгүй харилцааны улмаас үйлдэгдсэн байх бөгөөд үүнээс 38.6%-ийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь согтуугаар үйлдсэн болох нь судалгаагаар тогтоогдсон байна.

Сэлэнгэ аймгийн прокурорын газрын "Бусдын бие махбодид гэмтэл учруулах" гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар явуулсан судалгаанд архидан согтуурах нь энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл болж байна гэж үзсэн бол 2011 онд ЦЕГ-аас явуулсан судалгаагаар мөн архидан согтуурах нь бусдын бие махбодь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг төдийгүй нийтлэг үйлдэгддэг гэмт хэргийн гол нөхцөл болох нь тогтоогдсон байна.

3 Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25 дугаар зүйл. 25.1 дэх хэсэг. 2002 он

График VII.3.3.



ЦЕГ-аас 2011 онд явуулсан судалгаанд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 22.5% нь архидан согтуурсаны улмаас үйлдэгдэж байгаа ба зарим төрлийн гэмт хэргийн хувьд харьцангуй өндөр хувьтай байгаа юм. Статистикийн мэдээллээс үзэхэд хүнийг санаатай алах гэмт хэргийн 64.1%, танхайрах гэмт хэргийн 52.1%, хүчиндэх гэмт хэргийн 51.5%, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 35.6%, дээрэмдэх гэмт хэргийн 20.9%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн 19.3% нь архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн байна.[4]

Дээрх судалгаанаас үзэхэд бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 3/1 архидан согтуурсны улмаас үйлдэгдэж байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн гаралт ба эрүүгийн хариуцлага

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн гаралтыг сүүлийн 12 жилийн байдлаар:

График VII.3.4.



4 ЦЕГ-ын 2011 оны статистик мэдээнээс

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 2005 онд 2991 бүртгэгдэж байсан бол 2016 онд 8248 бүртгэгдэж 5257 гэмт хэргээр нэмэгдсэн бол тус гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг сүүлийн гурван жилийн байдлаар авч үзвэл:

2014 он: 8666 хүн, 2 байгууллага, ААН хохирсон.

2015 он: 8824 иргэн хохирч, үүнээс 7683 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос 152 буюу 2,0%-аар өссөн.

2016 он: 8664 иргэн хохирч, үүнээс 7931 хүн гэмтсэн нь өмнөх оноос 248 буюу 3,2%-аар, 2014 оныхоос 400-аар өссөн байна.

График VII.3.5. Хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр авч үзвэл (сая төгрөгөөр)



Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн улмаас хохирсон иргэд болон гэмт хэргийн хохирлын хэмжээ жил дараалан өссөн байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хүлээлгэх эрүүгийн хариуцлага

2002 оны Эрүүгийн хууль

Хүснэгт VII.3.2.

	Ялын төрөл	96	97	98	99	100
1	Торгох	-	-	-	5-100 дахин	-
2	Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах	-	-	-	-	-
3	Эд хөрөнгө хураах	-	-	-	-	-
4	Албадан ажил хийлгэх	-	-	251-450 цаг	251-350	-
5	Баривчлах	-	-	3-6 сар	1-6 сар	3-6 сар
5	Хорих	5 жилээс 10 жил	2 жил хүртэл хугацаагаар	5 жил хүртэл хугацаагаар хорих	-	2 жил хүртэл

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэгт торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулж байна. Хорих ял дээд хугацаа 10 жил, баривчлах ял 6

сар, торгох ял дээд хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлэх, албадан ажил хийлгэх ял дээд хугацаа 450 цаг байгаа нь энэ төрлийн гэмт хэргүүдэд оногдуулах ялын төрөл сонгох санкцын хэмжээнд нэлээд боломжтой мэт харагдаж байгаа боловч бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн гаралт сүүлийн 12 жил дараалан өссөнийг анхаарах шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу, үгүй юу гэдгийг судлах шаардлагатай.

Энэ байдалд дараах хоёр дүгнэлт хийж болно:

- Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргүүдэд ногдуулах эрүүгийн хариуцлага тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэмжээнд тохироогүй өөрөөр хэлбэл, хэт зөөлөн байна.
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргүүдэд ногдуулах ялын төрөл оновчтой бус байна.
- Эхний тохиолдолд тус гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлагын хэмжээг нэмэгдүүлж болох боловч хариуцлагыг чангатгаснаар ялын болон ялтай байдлын хугацаа, гэмт хэрэгтний тоо нэмэгдэх, хэт шоронжих зэрэг олон сөрөг нөлөөтэй.
- Харин ялын оновчтой хэлбэрийг сонгоно гэдэг хамгийн зөв асуудал боловч одоо үйлчилж буй Эрүүгийн хуульд тусгагдсан ялын төрлүүдийн хэмжээнд авч үзвэл боломжгүй юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан ялын төрлийг авч үзвэл

- Торгох ял;
- Нийтэд тустай ажил хийлгэх ял;
- Зорчих эрхийг хязгаарлах ял;
- Хорих ял;
- Эрх хасах ялуудыг тусган өгч "Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг"(Хүний эрүүл мэндэд хохирол учруулах 11.1-11.7)5-т дээрх төрлийн ялаас дараах байдлаар оногдуулахаар хуульчилсан байна.
- Торгох ял: 11 000-27 000
- Зорчих эрхийг хязгаарлах ял: 1 сараас-5 жил хүртэл
- Хорих ял: 2 жилээс-12 жил
- Эрх хасах ял: 3 жил хүртэл хугацаагаар эрх хасах гэсэн ялын төрлийг"Бусдын бие махбодид гэмтэл учруулах" гэмт хэргүүдэд хөнгөнөөс хүнд рүү ялгамжтай оногдуулахаар хуульчилж албадан ажил хийлгэх буюу нийтэд тустай ажил хийлгэх ялыг ногдуулахгүй харин тус гэмт хэрэгт оногдуулах бусад ялын хэмжээг нэмэгдүүлсэн байна. Энэ байдал нь эрүүгийн хариуцлагын оновчтой хэлбэр сонгох гэсэн хувилбарыг бус ялын хэмжээг нэмэх гэсэн зарчимыг сонгосон болох нь харагдаж байна.

Эрүүгийн хариуцлагын оновчтой хэлбэр гэдэг нь хариуцлага чанд хатуудаа бус ялын олон төрлийг нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран уян хатан шинж чанартай тусгасан байхыг ойлгох ёстой.


Гэхдээ гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх гэдэг дан ганц ялын төрөл, түүний оновчтой хэлбэрээс хамаарахгүй гэдгийг ойлгох нь зүйтэй.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдэгдэх газар орон, цаг хугацаа:

5 Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. Арван нэгдүгээр бүлэг, 11.1-11.7 зүйл


Гарагийн байдлаар:

График VII.3.6.



24 цагийн байдлаар:


График VII.3.7.



Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг цаг хугацааны хувьд даваа гараг, 22-06 цагийн хооронд ихээр үйлдэгдэж байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:


График VII.3.8.



Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд гэр, орон сууц, гудамж талбай, олон нийтийн газар ихэвчлэн үйлдэгдэж байна. Сүүлийн гурван жилийн байдлаар бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг нийт 24444 үйлдэгдэж үүнээс гэр орон сууцанд 10211, гудамж талбай 6402, олон нийтийн газар 3666 үйлдэгдсэн нь нийт 20279 гэмт хэрэг буюу 82,9%-ийг дээр дурдсан газруудад үйлдэгдсэн байна.

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЭТГЭЭДИЙН НИЙГМИЙН БАЙДАЛ:

График VII.3.9.



Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэгт холбогдсон этгээдийн насны байдлыг авч үзвэл 18-34 насныхан 2015 онд 4314, 2016 онд 25-39 насныхан 4529 иргэн холбогдсон байна. Энэ байдалд дүгнэлт хийхэд 18-39 насны иргэд, тэр дундаа ажилгүй иргэд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Тус гэмт хэрэгт холбогдсон иргэдийн дунд эмэгтэйчүүд нэлээдгүй хувийг эзэлж байна. 2015 онд 14,3% буюу 1215 эмэгтэй шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.3%-аар өссөн, 2016 онд 13.1% буюу 1111 эмэгтэй шалгагдсан нь өмнөх оноос 8.6%-аар буурсан үзүүлэлт байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ 10-аас дээш хувь байгаа болон сургуулийн сурагчид, оюутнууд ихээр холбогдож байгааг анхаарах ёстой.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дараах байдал бодитой нөлөөлөл үзүүлж байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг сүүлийн 12 жил дараалан өссөн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт нийгэм эдийн засгийн уналт, өсөлт төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгаа нь шалтгаан нөхцөлийг илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагатайг харуулж байна. Иймд шалтгаан нөхцөлийг тодорхой хүрээнүүдэд авч үзвэл зохино.

Гэр бүлийн хүрээнд: Тухайлбал, Сэлэнгэ аймаг дахь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд 61.3%-ийг (эр эмийн хардалт, өр авлага, хэрүүл маргаан, хохирогчийн буруутай үйл ажиллагаа) буюу хувийн таарамжгүй харилцааны улмаас үйлдэгдсэн байх бөгөөд үүнээс 38.6%-ийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь согтуугаар үйлдсэн болох нь судалгаагаар тогтоогдсон байна.

Архидалт: ЦЕГ-аас 2011 онд явуулсан судалгаанд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 22.5% нь архидан согтуурсаны улмаас үйлдэгдэж байгаа ба зарим төрлийн гэмт хэргийн хувьд харьцангуй өндөр хувьтай байгаа юм. Статистикийн мэдээллээс үзэхэд хүнийг санаатай алах хэргийн 64.1%, танхайрах хэргийн 52.1%, хүчиндэх хэргийн 51.5%, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэргийн 35.6%, дээрэмдэх хэргийн 20.9%, ТХХАБАЖЭсрэг хэргийн 19.3% нь архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн байна.

ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АЖЛЫН БАЙР, СУРГУУЛИЙН ОРЧНЫ ДЭГ ЖУРАМ БОЛОН ХУВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ЁС ЗҮЙН АСУУДАЛ:

Тухайлбал, 20147-2016 онуудад энэ төрлийн гэмт хэрэг холбогдсон иргэдийн дунд төрийн албан хаагч 1439, оюутан 973, сурагч 427 холбогдсон байна.

Эдгээр шалтгаан нөхцөлөөс гадна эрүүгийн ялын бодлого, эрүүгийн хариуцлага урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байх зэрэг шалтгаан, нөхцөл нөлөөлж байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн нэг онцлог нийт бүртгэгдсэн гэмт хэргийн ихэнх хувь нь хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн, хохирлоо барагдуулсан, хохирогчтой эвлэрсэн гэдэг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байгаа энэ тохиолдолд иргэд, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Жишээ нь, 2015 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд энэ төрлийн хэргийг шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл, 150 хүнд холбогдох хэргийн 158 хэрэг буюу 78.2%-ийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон байх бөгөөд энэ нь хохирогч, яллагдагчтай эвлэрсэн тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох хуулийн заалтыг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДАЛ



4. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДАЛ

Монгол Улсад сүүлийн 3 жилд бүртгэгдсэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоон мэдээг авч үзвэл хар тамхи, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хэрэглэгчид бий болж, хууль бус эрэлт, нийлүүлэлтийн хэрэгцээ өсөн нэмэгдэж, төрөл зүйл нь олширсон, ашиг орлого олох зорилгоор тухайн гэмт хэргийг үйлдэж байгаа нь мансууруулах бодистой холбоотой нөхцөл байдал хүндэрч байгааг харуулж байна.

Тухайлбал:

- 2002-2006 оны хооронд дунджаар **1 жилд 8 гэмт хэрэгт 21 хүн;**
- 2007-2011 оны хооронд дунджаар 1 жилд 14 гэмт хэрэгт 50 хүн;
- 2012-2016 оны 6 сарын 24-ны өдрийн байдлаар дунджаар **1 жилд 46 гэмт хэрэгт 135 хүн шалгагдсан байгаа** нь сүүлийн жилүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг 2002-2006, 2007-2011 оны хооронд бүртгэгдсэн гэмт хэргийн дундажтай харьцуулахад:
- 2002-2006 оны дундажтай харьцуулахад гэмт хэрэг 5.8, холбогдогч 6.5 дахин,
- 2007-2011 оны дундажтай харьцуулахад гэмт хэрэг 3.3, холбогдогч 2.7 дахин тус тус өссөн үзүүлэлт харагдаж байна.
- 2016 оны 06 дугаар 24-ны өдрийн байдлаар 97 хүнд холбогдох 40 гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 19 гэмт хэргээр буюу 75 хувиар, холбогдогч 37 хүнээр буюу 61.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын 40.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 76.3 хувь нь 18-35 насны залуучууд байна. Үүнд:

- Ажилгүй гэдэгт ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэггүй, амьжиргааны түвшнөөс доогуур орлоготой иргэд бус харин амьдрал, мөнгөний эх үүсвэр нь хувийн бизнес эсвэл эцэг, эхийн мөнгө, хөрөнгөөр хар тамхи мансууруулах бодисын хэрэглээг авдаг этгээдүүд дийлэнх нь байна.
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч 18-35 насны залуучууд нь ихэвчлэн гэр бүлтэй, тогтсон амьдралтай байдаг ба хар тамхи, мансууруулах бодис нийлүүлж, борлуулж байгаа этгээдүүд нь тэднээс цөөн тооны байдаг учир хэрэглэгч, худалдан авагч нарын дунд найз нөхдийн харилцаа холбоо үүсдэг байна.

2013-2015 оны хооронд дээрх төрлийн гэмт хэрэгт шалгагдсан этгээдүүдийг харилцаа холбоогоор нь авч үзвэл эхнэр нөхрийн харилцаатай 4, зүс мэдэх 44, найз нөхөд 235, урьд гэмт хэрэг хамтран үйлдэж байсан 2, огт танихгүй 20 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан төрийн алба хаагч нараас эрүүл мэндийн байгууллагын ажилтан 2, хуулийн байгууллагын ажилтан 2 хүн байна.

Гэмт хэргийн холбогдогч нарыг нас, хүйс, ажил эрхлэлтийн байдлаар ангилахад сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хүүхэд, оюутан залуучууд хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох тохиолдол ихэссэн тул дунд сургуулийн сурагчид, их дээд сургуулийн оюутан залуучууд дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү явуулах шаардлагатай байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийг хүйсийн байдлаар авч үзвэл 2013, 2014, 2015, 2016 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдэж шалгагдсан насанд хүрээгүй хүмүүс дунд эмэгтэй хүн бүртгэгдээгүй байна.

Дээрх төрлийн гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүс нь хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдээллийг интернет, цахим хуудас, кино болон найз нөхдөөсөө олж авсан байна. Түүнчлэн хүүхдүүдийн ар гэр тогтворгүй, анхаарал халамж сул, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар хомс, хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, суурь хүмүүжил, ухамсар зэрэг нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байна. Судалгаанаас үзэхэд, 2013, 2014 онд хар тамхи, мансууруулах бодисыг ихэвчлэн сургалтын төлбөр өндөр, улсын тэргүүний гэх тодотголтой сургуулийн сурагчид хэрэглэдэг байсан бол 2015 оны судалгаанаас харахад нийгмийн давхарга харгалзахгүйгээр уг гэмт хэрэгт холбогддог болсон байна. Иймд насанд хүрээгүй хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

- Өрхийн орлого бага, өрх толгойлсон эцэг, эхтэйгээ амьдардаг, зан төрхийн өөрчлөлттэй мэтийн гэмт хэрэгт холбогдож болзошгүй эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн судалгаануудыг бүхий л шатанд гаргаж байх.
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүүхдүүдийг хүүхдийн байгууллага болон харъяалагдах засаг захиргааны нийгмийн ажилтан анхааралдаа авч, бусад байгууллагуудтай хамтран хүүхдүүдэд зориулан хувь хүний хөгжил, төлөвшил, амьдрах ухааны сургалтууд, олон нийтийн янз бүрийн арга хэмжээнүүдийг байнга авч явуулж хэвших. Үүнд, хүүхдүүдэд сэтгэл зүй, харилцаа, зөрчлийг шийдвэрлэх чадварыг сайжруулах практик сургалтууд явуулж байх.
- Хүүхдүүд хууль эрх зүйн мэдлэггүйгээс болж гэмт хэрэгт холбогдож байгаа учраас тэдэнд хууль эрх зүйн мэдлэг олгохын тулд бүх шатны сургуулиуд болон хүүхдүүд олноор цугладаг газруудад (РС тоглоомын газруудад гэх мэт) янз бүрийн таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг сонирхолтой хэлбэрүүдээр авч явуулах шаардлагатай. Хүүхдүүд чөлөөт цагаа сонирхолтой, үр бүтээлтэй өнгөрөөхөд зориулсан газруудын тоо болон тэнд хамрагдах хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд стресс, сэтгэл түгшилттэй байгаа учраас сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл засал эмчилгээнд хамруулах
- Бүх шатны сургуулиудын сурагчдад, ялангуяа гэмт хэрэг үйлдэж болзошгүй, эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд зориулан сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл засал эмчилгээ хийдэг мэргэшсэн сэтгэл зүйчдийг бэлтгэж ажиллуулах.
- Сургуулийн нийгмийн ажилтнууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах, хүүхдүүдэд хар тамхины хор хөнөөл, учрах үр дагаврыг таниулж ойлгуулах, хүүхэд тус бүртэй тулж ажилладаг байхад анхаарах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөнөөс үүдэлтэй сүүлийн үед интернет цахим хуудсууд болон сонин, сэтгүүл, телевиз, радиогоор хар тамхи мансууруулах бодисын талаар хэт дэлгэрэнгүй, сурталчлах өнгө аястай мэдээ мэдээлэл гарч байгаа нь өсвөр насны хүүхдүүд эсрэгээр ойлгох, сонирхох сэтгэгдэл төрүүлж тэднийг гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байгаа учир хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт, хэмжүүр тогтоох.

Гэмт хэргийн өсөлт болон амьдрал, гэр бүлийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалан уг төрлийн гэмт хэрэгт холбогдсон эмэгтэй хүний тоо өсөж байна. Гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүд нь хар тамхи, мансууруулах бодис зарж, борлуулдаг этгээдүүдтэй байнгын харилцаа холбоотой байдаг ба ихэвчлэн гэмт хэрэгт хар тамхи, мансууруулах бодисын хэрэглэгч, зуучлагч хэлбэрээр холбогдож байна.

Улсын хэмжээнд

- 2013 онд: 4979,9 грамм каннабис, 198,8 грамм гашиш, 61,7 грамм мөс,
- 2014 онд: 13841 грамм каннабис, 15,5 грамм гашиш, 140,74 грамм мөс,

- 2015 онд 9808,21 грамм каннабис, 24,51 грамм гашиш, 344,164 грамм мөс,
- 2016 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар 658,72 грамм каннабис, 86,9 грамм гашиш, 0,4 грамм Кокаин, 285,44 грамм мөс тус тус хураагдсан байна.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад мансууруулах бодисын хэмжээ, төрөл өссөн байна. Мөс гэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бусдад давтан үйлдлээр зарж борлуулах гэмт хэргийн гаралт өссөөр байна. Мөн сүүлийн жилүүдэд 2013 онд Монгол Улс эмчилгээнд хэрэглэх эмийн жагсаалтаас хассан, 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Эрүүл мэнд, спортын яамны сайдын 68 дугаартай тушаалаар хяналтад авсан сэтгэцэд нөлөөт Залеплон гэх бодис агуулсан "Анданте" гэх эмийг дунд сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутан залуучууд хэрэглэж донтох өвчнөөр өвчлөх болсон. Анданте гэх эм нь Оросын Холбооны улсад худалдаалагддаг тул хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг 2015 онд 1, 2016 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар 2 хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон манай улсын иргэдийг энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн зүгээс ихэвчлэн интернет сайтуудаар / wechat, yahoo, facebook, tagged.com/ танилцан судлах, тэдний Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих боломжтой байдал, гэнэн итгэмтгий зан, амар хялбар аргаар мөнгө олох зэрэг сул талуудыг нь ашиглан хууль бус эргэлтэд татан оруулж тээвэрлэлт хийлгэн БНХАУ-аас мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис олж авч, хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлж тээвэрлэсэн гэмт хэргийн тоо өссөн байна. Үүнд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг бол тухайн улсын их, дээд сургуульд суралцаж төгссөн, олон жил ажил хөдөлмөр эрхэлсэн эсвэл тухайн улсад биеэ үнэлж байсан этгээдүүд хар тамхи борлуулагч этгээдүүдтэй харилцаатай болж мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргийн захиалагч, гүйцэтгэгч болж байгаа явдал юм.

Хэдийгээр хар тамхины хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нуугдмал байдал өндөр байгаа ч түүний тоо хэмжээ, бусад төрлийн гэмт хэрэгтэй хэрхэн харилцан хамааралтай байгаа ба тулгамдсан асуудлууд, бусад хүчин зүйлийн нөлөөлөл зэргийг бүрэн нээж чадахгүй байгаа. Мансууралтай холбоотой гэмт хэрэг үйлдэгчдийн криминологи шинжийг бүлгийн шинж чанараар нь дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Нийгэм-хүн ам зүйн;
- Нийгэмд гүйцэтгэх үүрэг;
- Эрүүгийн эрх зүйн;
- Ёс суртахуун-сэтгэл зүйн;
- Бие бялдар зэрэг болно.

Нийгэм-хүн амын зүйн шинжид (нас, хүйс зэрэг) - Гэмт хэрэгтний нийгмийн хэв шинжийн тухай үзүүлэлт, тэдгээрийн хүн амын нийгмийн бүлэглэлтэй хамааралтай байдлыг тодорхойлсон үзүүлэлт орно.

Нийгэмд гүйцэтгэх үүргийн шинжид – Нийгэмд бий болж буй олон янзын амьдралын хэв маяг, тухайн бие хүнийг тодорхойлж буй зан төлөвийн үзүүлэлт[6].

Эрүүгийн эрх зүйн шинж нь – Мансууралтай холбоотой гэмт хэргийн тодорхойлолт, тэдгээрээс хэсэгчлэн үйлдсэн этгээдийн ангилалтын тухай үзүүлэлт[7] зэргийг тус тус хамааруулан ойлгоно.

6 Криминология. /Под ред. С.Я. Лебедева, М.А. Кочубея. М. 2007. -518 дахь тал.
7 Жалыбин В.В. Криминологическая характеристика и профилактика преступлений, связанных с незаконным оборотом наркотических средств. Дисс. ...канд. юрид. наук. Красноярск. 2004. 45. -147 дахь тал.

Ёс суртахууны шинж байдлыг судалснаар гэмт хэрэгтний хүрээн дэх хэрэгцээ-сэдэлтийг илрүүлж, тэдний ухамсрын шинж төлөв, түүнд үнэлэмж өгдөг[8].

Бие бялдрын шинж нь гэмт зан үйлийн механизмд нөлөөлж буй биологийн хүчин зүйлийг тооцох явц юм. Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэгчдийн олонх нь мансуурах донд автсан, өвчилсөн этгээдүүд байдаг оршино[9].

Бие бялдрын (биологийн) шинжийг судалснаар гэмт зан үйлд нийгэм ба бие бялдрын харилцан хамаарал хэрхэн нөхцөлдөж байгааг тодруулж өгдөг.

Монгол Улсын шүүхээр шийдвэрлэгдсэн мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой эрүүгийн хэрэгт хийсэн судалгаагаар тухайн гэмт хэрэг үйлдэгчдийн дараах шинжийг тодруулж өгсөн.

Нийгэм-хүн ам зүйн үзүүлэлт. Монгол Улсад тухайн гэмт хэрэг үйлдэгчдийн хүйсийн байдал тэгш бус харьцаатай, 89% ба 11% үзүүлэлттэй байна. Түүнчлэн, Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг 3 хэсэгт авч үзэж байна. Үүнд:

Манай улсад ургаж байгаа мансууруулах үйлчилгээтэй ургамлын тархац их байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй энэ төрлийн гэмт хэргийн 50-60 хувийг мансууруулах үйлчилгээтэй ургамалтай холбоотой гэмт хэрэг эзэлж байна.

Зүүн өмнөд Азийн улс орнууд болон хил залгаа БНХАУ-аас Монгол Улсын хилээр хууль бусаар синтетик /нийлэгжүүлсэн/ төрлийн мансууруулах бодис болох амфетамин, метамфетаминыг нэвтрүүлэх, зарж борлуулах, хэрэглэх үйлдэл нэмэгдэхийн хирээр олон улсын шуудан илгээмжийн үйлчилгээг ашиглан хар тамхи, мансууруулах бодисыг Монгол Улсад нэвтрүүлэн худалдах, хэрэглэх нь нэмэгдэх хандлагатай байна. Үүний зэрэгцээ Монгол Улсад хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, тогтолцоо, эрх зүйн орчин муу байгаа зэрэг нь нөлөөлж байна.

Тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдийн үндсэн хэсгийг залуучууд бүрдүүж байгаа бөгөөд ял эдлэж буй этгээдүүдийн 86% нь 16-29 насныхан, тэдгээрийн 9%-ийг 17-19 насныхан, 77%-ийг 20-29 насны залуучууд эзэлж байна. Бидний үзэж байгаагаар мансууруулах бодистой холбоотой гэмт явдлын эрчимжилт, Монгол Улс дахь нийгэм-эдийн засгийн тогтворгүй жилүүдтэй давхцаж, тухайн насны ангиллын хүмүүсийн зан төлвийн хэлбэршилд "шилжилтийн үе" нөлөөлж байх магадлалтай.

Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтнүүдийн олонх нь байнга оршин суух газартай байгааг энэ төрлийн гэмт хэрэгтнүүдийн зонхилох хэсэг нь амьдралын боломж сайтай гэр бүлд хамаарагдаж буйгаар тайлбарлаж болно. Тухайн хүрээний гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн этгээдүүдийн боловсролын дундаж түвшинг бусад гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдүүдийн боловсролын түвшинтэй харьцуулбал нэлээд дээгүүр үзүүлэлттэй байна. Ял шийтгэгдсэн этгээдүүдийн 17% нь бүрэн дунд боловсролтой, 21% нь тусгай дунд, 36% нь дээд боловсрол бүрэн эзэмшээгүй, 26% нь дээд боловсролтой хүмүүс байгаа бөгөөд 74% нь дээд боловсрол бүрэн эзэмшээгүй хүмүүс эзэлж байна. Энэ байдал нь сүүлийн жилүүдэд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж ял эдлэгчдийн нэлээд хэсэг нь их, дээд сургуульд суралцагчид байсантай холбоотой.

Гэмт хэрэг үйлдэгсдийн нийгмийн үүргийн шинжийг тодруулахын тулд тэдний ажил сургууль, амьдрах орчны талаарх судалгааг хийх ёстой. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг үйлдэгсдийн бараг 1\3 буюу 31,3% нь ажилгүйчүүд, зөвхөн тэдний 93,4% нь хотын, 6,6% нь хөдөө орон нутгийн оршин суугчид байна. Энэ төрлийн хэргээр шийтгэгсдийн 69,3% нь тогтмол орлогогүй иргэд байгаа бөгөөд тэдний 46,5% нь ажилгүйчүүд байна.

8 Криминология. /Под ред. Г.А. Аванесова. М. 2006. 255-291-р тал.
9 Криминология. /Под ред. С.Я. Лебедева, М.А. Кочубея. М. 2007. 518 дахь тал.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэгсэд нь ихэвчлэн гэр бүл, сургууль, хөдөлмөрийн хамт олонтойгоо таагүй харьцаатай, сахилга хариуцлага сул хүмүүс байдаг. Мөн ажил сургуульгүй эсвэл ажлаас халагдаж, уруудаж доройтсон, архинд дуртай хүмүүс ч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх нь элбэг байдаг.

Мансууруулах бодис хэрэглэгчид, түүнтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгсдийн аль аль нь өөрсдийн үйлдэлдээ бусдыг уруу татах сонирхолтой байгаагаараа ижил төстэй хэмээн судлаачид үзсэн байдаг.[10] Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн 68,4%-ийг жижгэвтэр бүлэг хамт олон рок, поп хамтлаг сонирхлын бүлэг, анги, гэр бүл гэх мэт, түүний гишүүд үйлдсэн болохыг эрүүгийн цагдаагийн байгууллага тогтоожээ. Мөн мансуурал нь рок поп урлаг, архи тамхинд хорхойсох явдал, биеэ үнэлэх зэрэгтэй нилээд холбоотой болохыг судалгаагаар харуулсан байна.

МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТЭН БИЕ ХҮНИЙ ШИНЖ

Монголын шат шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн талаарх судалгаанд үндэслэн үзэхэд, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж буй хүний ерөнхий шинж нь дараах байдлаар тодорхойлогддог. Үүнд:

- Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэгсдийн дийлэнх буюу 59,4% нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан байгаа бол;
- 27,7% нь мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан ;
- 7.2% нь дээрх хэргийг бүлэг, их хэмжээгээр, насанд хүрээгүй хүмүүсийг оролцуулан, урьдчилан тохиролцож давтан үйлдсэн байгаа бөгөөд үлдэх 5.7% нь Эрүүгийн хуулийн бусад зүйл ангиар шийтгэгдэж байсан этгээдүүд эзлэж байна.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэгсэд нь өөрсдийн санхүүгийн болон биологийн хэрэгцээгээ хангах зорилгоор дээрх бодис, эм бэлдмэлийг хэрэглэдэг ч тэд ихэнхдээ хувиа бодсон, бусдын хүчинд дулдуйдсан, хөнгөн дэвүүн зантай байдаг нь тэдний ёс суртахуун сэтгэл зүйн талын тодорхойлолт мөн.

Мансуурагчид ихэвчлэн ёс суртахууны асуудалтай, ажил сургуульдаа сонирхолгүй, танхайрах, бага наснаасаа архи тамхи хэрэглэж эхэлсэн, гэр орноосоо дайжсан байх нь элбэг ажиглагдаж байна. Тэд гэр бүлийн хүрээндээ мансуурах, тэр ч байтугай шүүхийн танхимд ч танхай байдал үзүүлэх нь бий. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэгчид нь сэтгэл зүйн болон зан суртахууны тогтсон хэм хэмжээг байнга зөрчигчид буюу "Этгээд араншинтай" хүмүүс байх тохиолдол цөөнгүй байна. Мансууруулах бодис хэрэглэх явдал нь тэдний хувьд ердийн хэм хэмжээний зөрчил байдаг11. Залуучуудын чөлөөт цагийн арга хэмжээ (Нийтийн шоу концерт, дискотек, хамтлаг дуучдын тоглолт)-г зохистой бус арга хэлбэрээр зохион байгуулснаас, тэнд мансуурагчид цугларах боломж бүрдүүлэх, залуу хүний бие даасан байдлыг үл дэмжих, тэдний хэт загвар хөөсөн үг хэллэг, зан үйл, дур сонирхлыг дэвэргэснээс залуучууд мансууралд уруу татагдах шалтаг шалтгаан ч үүсэх явдал байна.

Этгээд араншинтай хүмүүсийн сэтгэл зүйд хийсэн шинжилгээ судалгаагаар тэд, юуны өмнө сэтгэх чадвар сул байдгаас гадна оюуны хөдөлмөрт сонирхолгүй, идэвхгүй, тэвчээргүй, зугаа цэнгэлд дуртай байдаг. Тэд бусдыг хэт дуурайдаг, учир шалтгааны сэтгэмж муу, өөрийгөө хянах жолоодох чадвар сул, нэн итгэмтгий, тоглоом наадамд дурламтгай байдлаараа инфатилизм буюу "хэт нялхамсаг" сэтгэхүйтнүүд байдаг.

10 Прохорава Л.М. Наркотизм: Уголовно-правовое и криминологическое исследование. СПб. 2002. 13-18 дахь тал.

11 Противодействие незаконному обороту наркотических средств и психотропных веществ. Учебное пособие. \под общ.ред. А.Н.Сергеева. М.2005. 251 дэх тал.

МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГСДИЙН ХУВИЙН ШИНЖ

Мансууруулах бодис худалдах, зарж борлуулах үйл ажиллагааны дийлэнх хэсгийг буюу /72.3%/-ийг мансууруулах бодис хэрэглэгч нар гүйцэтгэдэг байна. Ер нь мансуурах донд автсан этгээдүүд ихсэж байгаа нь мансууруулах бодисын хэрэгцээ, түүнийг бэлтгэх систем, тархах сүлжээ бий болж улам идэвхжин газар авсаар байгааг харуулж байна.

Мансуурагчдын 35.6% нь өөрсдийгөө мансуурах донд автсан, өвчтэй хэмээн үздэггүй бөгөөд мансууруулах бодисыг эмийн чанартайгаар хэрэглэсээр байдаг. Мансууруулах бодисын хууль бус арилжаа болон түүнийг хэрэглэгчдийн тоон харьцааг шинжлэх ухааны үндэстэй тогтоох шаардлагатай. Хэрэв ингэж чадвал тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэрэгсэл, бүс нутгийг зөв тогтоох, эмнэлгийн болон бусад арга хэмжээг оновчтой төлөвлөж, зохион байгуулах боломжтой болно.12

Судлаачид, гэмт хэрэг үйлдэгсдийг дараах гурван бүлэгт хуваан авч үзсэн байна.

Үүнд:

1. **Гэмт хэргийг зориудаар үйлдэгсэд**: Энэ бүлэгт хамаарагдах гэмт хэрэгтнүүдийн хувьд, гэмт хэргийн үйлдэл нь тухайн хүний зан араншин, ёс зүйгээс үүсмэл, үүнд гадны нөлөөлөл, шалтгаан төдийлөн нөлөөтэй биш байдаг.
2. **Тодорхой шалтгааны улмаас гэмт хэрэг үйлдэгсэд**: Эдний хувьд өмнө нь үйлддэг байсан ёс зүйн болоод бусад зөрчлүүд нь даамжирсаар, тэр нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл нь болсон байдаг.
3. **Шалтгаант үйлдэлтнүүд**: Үүнд амьдралын тодорхой нөхцөлийн улмаас санамсар, болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдэгчид хамаарна.[13]

Олон улсын шинэ харилцаа, нээлттэй хаалганы бодлого зэргээс шалтгаалан Монгол Улсад янз бүрийн орны иргэд чөлөөтэй нэвтэрч байгаад тавих хяналт ч сул байна. Ялангуяа мансуурах явдал ихэд дэлгэрсэн орнуудаас ирж буй гадаад иргэдийн нөлөөлөл нь Монгол Улсад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх, тархах нэг шалтгаан болж байна. Өнөөдөр Монгол Улсад мансууралтай холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн 20,3%-ийг гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс үйлджээ.

Сүүлийн жилүүдэд монголчууд гадаад улсад амьдрах явдал ердийн үзэгдэл болсон. Монголын залуучууд гадаад орнууд, түүний дотор АНУ, Их Британи, Япон, БНСУ, ОХУ зэрэг, мансуурал тархсан, шийдвэрлэхэд бэрх болсон улсууд болон хар тамхи ихэд дэлгэрсэн бусад оронд ажиллаж амьдарч байна.

Монголд илэрч, хураагдсан мансууруулах бодисын 90 шахам хувийг гадаадын иргэд, гадаадад сурч ажиллаж байсан Монгол залуучууд оруулж ирснийг бидний судалгаа харуулсан.

12 Противодействие незаконному обороту наркотических средств и психотропных веществ. Учебное пособие. \под общ.ред. А.Н.Сергеева. М.2005.

13 Жалыбин В.В. Криминологическая характеристика и профилактика преступлений связанных с незаконным оборотом наркотических средств. Дисс... канд. юрид. наук. Красноярск. 2004.53 дахь тал.

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН УЧИР ШАЛТГААН

Нийгмийн үйл явцыг судалдаг "Интеракци"-ийн онолоор нийгэмд этгээд араншинтай хүний шинэ үе бий болж байгаа бөгөөд, энэ нь залуучуудын дунд болон сургууль, гэр бүлийн орчин хүрээнд мансуурагчид бий болох үндсэн учир шалтгаан болж байна14.

Мансууралтай холбоотой гэмт хэрэг үйлдэгчдийн 48,9%-ийг эцэг эх нь гэмт хэрэг үйлдэж хорих болон хорихоос бусад төрлийн ял эдэлж байсан, гэр бүл салсан, буруу зуршилтай болсон зэрэг *"бүтэлгүй"* гэр бүлд хүмүүжсэн хүмүүс эзэлсэн байна. Боломжтой амьдралтай гэгдэх гэр бүлээс ч мансууралтай холбоотой гэмт хэрэгтэн төрөх нь элбэг тохиолдож байна. Ийм гэр бүлийн дотоод зөрчил, бие биенээ үл хайрлах байдал, сэтгэл хөөрөлт зэрэг нь нийгэмд үл анзаарагддаг. Иймд гаднаас нь харахад боломжийн ажиглагдах гэр бүлээс ч *этгээд араншинтай хүн* төрөх нь гайхах зүйл биш болоод байна.

Ийнхүү бие хүн хамт олноосоо хөндийрч, мансууруулах бодис дамжуулах, хэрэглэхэд оролцогч болсноор гэмт хэрэгтнүүдийн нөлөөнд автаж нийгэм сэтгэл зүйн өвөрмөц сөрөг учир шалтгаан буй болдог байна.

Монгол Улс дахь гэмт хэргийн сэтгэл зүйн учир шалтгаан. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтнүүдийн зан байдлыг судалж үзэхэд, гэмт хэрэг үйлдэгчдийн *хувийн хэрэгцээ* - шалтаг шалтгааны хүчин зүйлд голлох байрыг эзэлдэг байна. Гэмт хэргийн шалтагт юуны өмнө хуулиар хориглосон арга хэлбэрээр өөрийнхөө хэрэгцээг хангах үйлдэл ордог. Мансуурах хэрэгцээ гэдэгт, нийгмийн болоод хүний хөгжил сонирхолд сөргөөр нөлөөлөх, мансууруулах бодистой холбоотой хууль бус үйлдэл, гаж сонирхол багтдаг.

Мансууралтай холбоотой гэмт хэрэг нь шунахай сэдэлттэй эсвэл хэрэглээний зорилгоосоо хамаарч уг хэргийн ***шалтаг шалтгааны түвшин*** тодорхойлогддог. Монгол дахь мансуурагчдын хэрэгцээ шалтаг шалтгааныг тодруулах зорилгоор бид наркологийн төвд явуулсан санал асуулга:

Эмчлүүлэгчдийн дунд асуулгад оролцогсдын:

- 58,4% нь сонирхлоороо уг бодисыг хэрэглэсэн гэсэн бол;
- 24,7% нь найз нөхөд танилуудаа дуурайж;
- 11,6% нь онцгой мэдрэмж олж мэдрэхийн тулд;
- 5,3% нь өвчнөөсөө шалтгаалж хэмээн хариулсан байна.

Харин асуулгад оролцогсдын 79,4% нь мансууруулах бодисыг "Танил нөхдөөсөө" олж авсан гэсэн бол;

- 13,5% нь танихгүй хүмүүсээс;
- 7,1% нь өөрсдөө уг бодисыг бэлтгэж хэрэглэсэн гэжээ.

Мөн мансууруулах бодис хэрэглэгчдийн 25,4% нь өөрийн гэртээ;

- 13,5% нь танил найз нөхдийнхөө гэрт;
- 37,6% нь дискотек, шөнийн клубт;
- 5,5% нь бусад газарт хэрэглэдэг гэжээ.

14 Противодействие незаконному обороту наркотических средств и психотропных веществ. Учебное пособие. \под общ.ред. А.Н.Сергеева. М.2005.256 дахь тал.

Мансууруулах бодис хэрэглэсэн аргын хувьд:

- 31,7% нь шприцээр;
- 33,6% нь татах хэлбэрээр;
- 31,2% нь үнэртэх байдлаар;
- 3,5% нь аман хэлбэрээр хэрэглэдэг гэжээ.

Асуулгад оролцогсдын 35,6% нь өөрийгөө мансуурах дон өвчтэй хэмээн үздэггүй гэсэн бол;

- 48,7% өөрийгөө туршилтын журмаар хэрэглэгч;
- 28,5% нь тохиолдлоор хэрэглэгч;
- 18,8% нь тогтмол хэрэглэгч хэмээн үзсэн байна.

Хэрэглэж буй мансууруулах бодисын хувьд:

- 26% нь мансууруулах морфин, эм бэлдмэл седуксин бусад;
- 28,3% нь мансууруулах үйлчилгээтэй янз бүрийн ургамал;
- 7,1% нь марихуан;
- 3,2% нь кокайн;
- 25,8% нь бусад;
- 9,4% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Эдгээр болон бусад судалгаанд анализ хийж үзэхэд:

Монгол Улсад мансуурах явдал, түүнтэй холбоотой гэмт хэрэг хурдацтай өсч, үйл явц таагүй хандлагатай болж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зарим арга зам

Аливаа улс орон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөр өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлдэг.

Мансууралтай холбоотой гэмт явдлаас урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээний нэг хэлбэр нь төрийн эдийн засгийн бодлогод суурилах бөгөөд, улс орны эдийн засаг, тэдгээрийн цаашдын хөгжил, чиг хандлагад тулгуурлан явагддаг.

Төрийн оновчтой бодлого эдийн засгийн хэвийн үйл ажиллагааны нөхцөл нь мансууруулах бодисын хууль бус худалдааны үр ашгийг багасгах таслан зогсооход чиглэгддэг. Эдгээр нь хар тамхитай тэмцэх эдийн засгийн дүн шинжилгээнд тулгуурлана.

Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх нэг арга хэмжээ нь нийгэм дэх тухайн бодисын эрэлт хэрэгцээг хязгаарлах явдал юм.

Өөрөөр хэлбэл, мансууруулах бодис хэрэглэгчидтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, мансууруулах бодис хэрэглэгч нарыг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд хамруулах зэрэг ажил зохиох нь чухал байна.

Үүний үр дүнд мансууруулах бодис хэрэглэгчийн болон, мансууруулах бодис худалдан авагчдын тоо, тэдгээрээс олох орлого, хар тамхины үнэ ханшийн уналт бий болох боломжтой. Түүнчлэн, уламжлалт альтернатив тэмцлийн нэг хэлбэр нь мансууруулах үйлчилгээтэй эмийг эмийн сангуудаар худалдан борлуулах, өөрөөр хэлбэл, гэмт бүлэглэлүүдийн нууц далдуур

явуулдаг худалдааг төрийн мэдэлд авч эмийн сан болон бусад хэлбэрээр хэрэглэгч, донтогч нарт түгээдэг байдалд тавих хяналтыг хүчтэй болгох шаардлагатай.

Энэ жишиг нь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хараат болсон хүн ам ихтэй улс оронд буюу, одоогоор Их Британи, АНУ, Австрали зэрэг оронд хэрэгжиж байна. 1990 оноос улс орнууд мансууруулах бодисын хэрэглээний эсрэг тэмцэх төрийн бодлого, чиг хандлагыг тодорхойлон, хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж байна. Монгол Улс дахь мансууруулах бодистой холбоотой нөхцөл байдлаас харахад тухайн төрлийн эм бэлдмэлийг хязгаарлах, гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангаруулах нь эргэд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гэмт бүлэглэлийн сүлжээ нууц далд байдлаар өргөжих, мансууруулах донд автсан хүмүүс ихсэх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй.

Харин урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний хүрээнд эрүүл амьдралын хэв маягийг бий болгоход чиглэсэн үзэл суртал, ухуулгын ажлыг хүн амын дунд зохиох хэлбэр чиглэлийг нэмэгдүүлэх нь үр дүнтэй арга хэмжээ болно.

ИХ ДЭЭД, ДУНД СУРГУУЛИЙН ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН ДУНД ЯВУУЛАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Шүүхийн практикаас харахад энэ гэмт хэрэгт холбогдогч болон хэрэглэгч нар дийлэнхдээ өсвөр насныхан байгаа нь ажиглагдаж байна. Үүнтэй холбоотойгоор мансууруулах бодис хэрэглэснээс үүсэх сөрөг үр дагавар хүний бие организмд ямар их хор аюул учруулдаг, мансууруулах бодисын хууль бус ажиллагаанд оролцсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх эрх зүйн үр дагаврыг сурталчлах тал дээр анхаарлаа хандуулах шаардлага улам нэмэгдсээр байна.

Энэ арга хэмжээний хүрээнд:

- Сургалтын үйл ажиллагаа, хичээлийн хөтөлбөрүүдэд хар тамхины хор аюулаас өөрсдийгөө хэрхэн урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн үр дагавар, ял шийтгэлийн талаар сургалт зохион байгуулахаар албан ёсоор оруулах;
- Багш нарт мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын талаар хууль эрх зүйн мэдлэг эзэмшүүлэх;
- Сургууль, боловсролын байгууллагуудад мансууруулах бодисын хор уршиг, сөрөг үр дагаврын талаар болон хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт мэдээлэл хийх сургагч багш нарыг бэлтгэх, тэдгээр сургагч багш нараар дамжуулан сургалт явуулах;
- Энэ гэмт үйл ажиллагааны эсрэг сурталчилгаа явуулах багш, суралцагч, эцэг эхчүүдийн баг, бүлэг байгуулах. Энэхүү бүлгийн зорилго нь аливаа хэлбэрийн уулзалт, зөвлөгөөн, хурал, семинар зохион байгуулахад чиглэгдсэн байж болно. Түүнчлэн энэхүү арга хэмжээний зардлыг, сургалтын байгууллага бүрийн жилийн тусгайлан төсөвт суулгаж өгөхийн зэрэгцээ хандив, тусламж, сангуудаас санхүүжүүлэх боломжтой.
- Номын сан, хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан борлуулах газарт мансуурлын хор уршигтай холбоотой танилцуулга, хэрэглэгдэхүүнээр хангах, тараах үйл ажиллагаа явуулах урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХАМААРАЛД ОРОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГЭР БҮЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

Мансууруулах донд автахаас урьдчилан сэргийлэх гэр бүлийн арга хэмжээ нь мансуурлын эсрэг хүмүүжлийн арга, хэрэгслийн нэг юм. Гэр бүлийн зөв хүмүүжил нь мансууруулах бодис хэрэглэх дур сонирхол үүсэх аюулыг зайлуулах сэтгэл зүйн чиг хандлагыг бие хүнд бүрэлдүүлж өгдөг15. Энэхүү арга хэмжээг залуу хосууд гэр бүл болж, гэрлэлтээ батлуулах үеэс эхлэн хэрэгжүүлж, залуу эцэг эхчүүдэд эрүүл мэндийн байгууллага, харин хүүхдүүдэд нь сургуулиар дамжуулан гэр бүлийн зөвлөгөө өгөх замаар явуулж болно. Түүнчлэн, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээ, мансуурлаас урьдчилан сэргийлэхэд шашны байгууллагуудын үүрэг оролцоо нилээд байдаг. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа буддын, христын, исламын гэх мэт шашны байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, архи, тамхи хэрэглэх явдлыг зөвшөөрдөггүй, хор уршиг, үр дагаврын талаар сургасан байдаг.

Гадаадын зарим оронд мансууралтай тэмцэж байгаа практикийг судалж үзэхэд сүм хийдүүд мансуурагч болон мансууруулах бодист донтсон хүмүүстэй харьцаж, тухайн бодисын хамаарлаас гарахад тусалдаг үйл ажиллагааг ихээр явуулдаг. Энэ мэтчилэн мансуурал болон мансууруулах бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр улс орон бүр боломжит бүх арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүлж байна.

МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭ

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг хууль сахиулах байгууллагууд явуулах нь үр дүнтэй. Энэ арга хэмжээг тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллага хариуцан явуулдаг нь гадаадын улс орнуудад нийтлэг байдаг. Монгол Улсад мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг болон мансууруулах бодис хэрэглэгч нартай тэмцэх чиг үүрэг бүхий тусгайлсан байгууллага байгуулагдаагүй байна. Дийлэнх судлаач, эрдэмтэд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, урьдчилан сэргийлэх тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага байгуулахыг дэмжиж байдаг. Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлаар дээрх үүргийг цагдаа, хил, гааль, тагнуулын байгууллага тус тусын чиглэлээр гүйцэтгэж байна.

Засгийн газраас *"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"* батлан гаргасан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эсрэг ажиллагааны чухал баримт бичиг болж байна.

Тухайн үндэсний хөтөлбөрийн хүрээнд мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ, мансуурах донд автсан хүмүүс бий болох шалтгаан, нөхцөл, мансууруулах бодистой тэмцэх эрх зүйн орчин бий болгох чиглэлээр олон арга хэмжээ багтана. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлж болно. Үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага байгуулах;
- Мансууруулах бодистой тэмцэх чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, замаар эрх зүйн орчныг сайжруулах;

15 Борьба с наркоманией. Проблемы и перспективы. Отв. ред. Е.Г. Мартынчик. Кишинев 1990., 219 дахь тал.

- Мансууруулах бодисоос хараат болсон хүмүүсийг эмчлэх шинэ арга хэрэгслийг анагаах ухааны салбарт хэрэгжүүлж эхлэх;
- Мансууралтай амжилттай тэмцэж буй гадаадын зарим улс орны туршлагыг судалж Монгол Улсад нэвтрүүлэх;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт мансууруулах бодис нэвтрэх боломжтой хил, гаалийн боомт бүсүүдийг шинэ техник технологиор тоноглох;
- Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах, хангах хөтөлбөр, үйл ажиллагааг хуульчлан тогтоож өгөх;
- Тухайн гэмт хэрэгтэй тэмцэж буй практик үйл ажиллагаанд мөрдөх шинэ арга зүйг нэвтрүүлж, алба хаагч нарыг давтан сургах;
- Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлийн эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлж, гүнзгийрүүлэн судлах зэрэг ажлыг нэн яаралтай эхлүүлэх, хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна. Үүний зэрэгцээ мансуурах гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээний хүрээнд мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбогдсон этгээдүүдийн сэтгэл зүйг тухайн үйл ажиллагааны эсрэг чиглүүлэх үйл ажиллагаа хамаарна. Жишээлбэл, ял эдлүүлэх үйл ажиллагааны хүрээнд олон арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Энэ мэтчилэн төрөөс мансууралтай тэмцэх бодлогын хүрээнд криминологийн урьдчилан сэргийлэх ерөнхий ба тусгай арга хэмжээнүүдийг нэгдмэл цогц байдлаар хэрэгжүүлснээр мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, мансууруулах бодисоос хамаарал бүхий этгээдүүд бий болохоос болон тархахаас урьдчилан сэргийлэх боломжтой.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ГЭМТ ЯВДАЛ



5. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ГЭМТ ЯВДАЛ

НЭГ. СУУРЬ НӨХЦӨЛ

Криминологийн судалгаанаас үзвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг урьд нь гэмт хэрэг, зөрчил гэсэн ойлголтод тооцдоггүй байснаас шалтгаалж онц хүнд гэмт хэрэг буюу хүнийг санаатай алах, хүнд гэмтэл санаатай учруулах зэрэг хэргийн үзүүлэлтэд шууд нөлөөлж байгааг нотолсон байна.[16] Цагдаагийн байгууллагад бүртгэгддэг 100 мянга орчим зөрчлийн 20-30%-ийг "танхайрах" захиргааны зөрчил эзэлж байгаа боловч бодит байдал дээр уг зөрчлийн дийлэнх нь гэр бүлдээ агсам тавьсан, сэтгэл зүйн дарамт учруулсан, байнга зодсон шинжтэй үйлдлүүд байна. Нэг жилд бүртгэгддэг 30 орчим мянган танхайрах зөрчлийн 60 гаруй хувьд нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу торгох эсхүл 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулдаг байна. Хэсгийн байцаагчтай хийсэн ярилцлагын судалгаанаас үзвэл сардаа 3-4 "танхайрах" захиргааны зөрчилд баривчлах шийтгэл оногдуулахаар шүүхэд шилжүүлдэг гэх ба эдгээр нь мөн чанартаа бүгд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд байдаг аж.[17]

Нэгэн судалгаанд хамрагдсан респонтентуудын 15,2% нь гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их гарч байна гэсэн төдийгүй нийгмийн тогтвортой байдлын хамгийн чухал нэгж болох гэр бүлийн хүрээнд гэмт хэрэг их үйлдэгдэж байгааг таван хүн тутмын нэг нь хүлээн зөвшөөрсөн нь анхаарал татаж байна.[18] Цаашид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх шаардлага байгаа нь ажиглагдана.

График VII.5.1.



Гэмт хэрэг үйлдэх болон түүнд холбогдоход тухайн хүний эргэн тойрны хүмүүс, нийгмийн орчин, тухайн тодорхой тохиолдол нөлөөтэй ч хувь хүний өөрийн ухамсар, хүмүүжил гол хүчин зүйл болдог. Нэг жилд 300 орчим бүртгэгддэг "хүнийг санаатай алах" гэмт хэргийн 80 орчим хувь гэр бүлийн орчинд үйлдэгдсэнээс харагддаг.[19] Дээр дурдсан криминологийн судалгаанаас дүгнэн үзвэл энэ нь нийгмийн феномен буюу үзэгдэл болсон байна. Цаашид гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг зөрчилд тооцож хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөх шаардлага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг бусад хуультай уялдуулан гаргах үндсэн нөхцөл болсон байна.

16 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад ашигласан судалгааны тайлангаас. 2014 он

17 Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн харьцуулсан судалгаа. ХЗҮХ. 2007 он (Судалгааны хавсралт. Фокус бүлгийн ярилцлагаас)

18 "Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл" Судалгааны тайлан. ХЗДХЯ, ФСЭХ. 2005 он

19 "Homicide" З.Төрмандах, Г.Цоодол нар. Хамтын бүтээл. 2008 он.

АНУ-ын 2 судлаачийн 10-аад жил хийсэн судалгааны дүн тун өвөрмөц: Бага ангийн хэсэг сурагчдын дунд сургуультай нь ямар ч холбоогүйгээр зөвхөн хүүхдүүдтэй өөрсдөд нь нөлөөлж тэдэнд мэдэгдэхгүйгээр ажиглалт, тандалт хийжээ. Судалгааг бага ангийн хүүхдүүдэд багш нараас харьцах хандлага, ангийн хүүхдүүдээс харьцах хандлага гэсэн 2 чиглэлээр ажиглалт хийж үр дүнг тэмдэглэн авч байв. Урт удаан хугацааны (зөвхөн энэ судалгааг арван жил хийсэн) судалгааны дүнд бага ангийн багш нь доромжилж харьцдаг байсан ангийн хүүхэд тэр дундаа доожоо муутай хэмээн ангийнхандаа нүд үзүүрлэгдэж байсан эрэгтэй хүүхдүүдийн 68 хувь нь өсч том болоод хүч хэрэглэсэн гэмт хэрэг тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл, дээрэмдэх, танхайрах гэмт хэргийг нэгээс доошгүй удаа үйлдэж түүндээ арга хэмжээ авахуулсан нь тогтоогджээ.[20]

ХОЁР. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр **зүйл болох "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчих"** гэсэн зөрчлийг шинээр нэмж тусгажээ. Зөрчлийн диспозицийг "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, мөрдөн мөшгисөн, заналхийлсэн, бусадтай харилцахыг хязгаарласан, гутаан доромжилсон, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол" гэж заасан байна.

Энэ зөрчлийн шийтгэлийг шүүгч оногдуулах бөгөөд 7-30 хоногийн хугацаатай баривчилж, албадан сургалтанд хамруулахаар тусгасан. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хууль гэмт хэрэг, зөарчлийн зааг ялгааг байнга байх шинжээр ялган заагласан.

Зөрчлийн шийтгэлийн төрөл, хэмжээнд баривчлах шийтгэл, "албадан сургалт" гэсэн албадлагын арга хэмжээ нэмэгдсэн. Ийнхүү нэмэгдэл шийтгэлийг оруулсан нь зөрчил гаргагчдад нөлөөлөх зорилготой болно.

Эрүүгийн хуулийн **11.7 дугаар зүйлд "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэсэн гэмт хэргийг тусгаж Үүнд үйлдлийн хэв шинжийг заахдаа:**

1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

1.1. зодож;

1.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадаж;

1.3. мөрдөн мөшгиж;

1.4. заналхийлж;

1.5. бусадтай харилцахыг хязгаарлаж;

1.6. гутаан доромжилж;

1.7.хуваарьт, дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдаж бие махбодын, сэтгэл санааны зовиур, шаналал байнга учруулсан бол долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.хохирогчийг байнга зодож харгис хэрцгий харьцаж;

2.2.тохуурхан даажигнаж;

2.3.тарчлаах шинжтэй бусад үйлдэл хийж;

20 criminalman.blogspot.com

2.4.доғшин авирлаж;

2.5.хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг;

2.6.энэ гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж;

2.7.асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн бол нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. гэжээ.

Гэсэн хэдий ч хууль хэрэгжих явцад энэ төрлийн хэргийг шалгах арга барил шинэчлэгдээгүй, хохирогч хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх, аюулгүй зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ зэргийг эрүүгийн хавтаст хэрэгт хийж хүний аюулгүй байдалд эрдсэл учруулдаг зэрэг таагүй нөхцөл арилаагүй байна.

ГУРАВ. ШАЛТГААН НӨХЦӨЛ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд баталснаас хойш Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр[21], УДШ-ээс тус хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх тухай тайлбар[22], ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ-наас хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмыг[23] батлан хэрэгжүүлж байв.

Мөн төрөөс хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалан байрлуулах, гэр бүлд утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг гэрээгээр мэргэшсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан[24] үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг бодлого, үйл ажиллагааны хүрээнд нааштай алхмууд хийгдэж иржээ. Гэвч хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болжээ. Тухайлбал, зөвхөн сүүлийн 3 жил 8 сарын хугацаанд гэр бүлийн хүчирхийлэл 1505 бүртгэгдсэн бөгөөд 49 хүн амь насаа алдаж, 1180 хүн гэмтсэн.[25]

Цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй болон захиргааны зөрчилд тооцогдон арга хэмжээ авагдсан хүчирхийллийн тоо үүнээс даруй 5 дахин их байгааг энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг ТББ-уудын судалгаа харуулж байна.[26]

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2004 оны хойш 8 жил гаруй хугацаанд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах 41 шийдвэрийг шүүх гаргасан ч тэдгээр шийдвэрийн нэг нь ч хэрэгжээгүй байна.[27]Хэрэгжилтийн үр дүнгүй байдал нь хуулийн зохицуулалт оновчтой бус, ялангуяа байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий, салангид байдлаар тусгаж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах процедурыг орхигдуулсантай холбоотой байна.

21 Засгийн газрын 2007 оны 255 дугаар тогтоол.

22 Улсын Дээд шүүхийн 2006 оны 47 дугаар тогтоол.

23 "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр" ХЗДХ-н сайд, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он.

"Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох" заавар 2009 он.

"Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлөн эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах заавар. ХЗДХ-н сайд, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он


24 "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам". ЭМ-н сайд, ХЗДХ-н сайд, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он.

25 Цагдаагийн Ерөнхий газрын статистик мэдээ. 2010-2013 оны 8 сарын байдлаар.

26 ХЭҮТ-ийн судалгаа. 2010 он.

27 Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн мониторингийн тайлан. ННФ, ХЭҮТ. 2010 он.

График VII.5.2.



Сүүлийн арван жилд эмэгтэй хүн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг судалж үзэхэд тогтмол өсч байгаа тодийгүй гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй нөхцөл байдлын улмаас хамтран амьдрагч, нөхөр бусад гишүүний амь насыг санаатайгаар хөнөөх, хүнд, хүндэвтэр гэмтэл учруулах гэмт хэрэг түгээмэл үйлдэж байна. Эмэгтэйчүүдийн хорих ангид хорих ял биечлэн эдэлж байгаа ялтнуудын дунд хийсэн судалгаанаас үзвэл 30 гаруй хувь нь хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн байгаа тодийгүй цаад шалтгааныг судлан үзвэл дийлэнх нь гэр бүлийн хүчирхийлэлд удаан хугацаанд байсны улмаас паталоги шинж, сэтгэл зүйн хүнд дарамтанд орж, тухайн аюул ахин бий болохоос эмээж хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хохироожээ.[28]

- Хүнийг санаатай алах - 30.5%;
- Гэмтэл учруулах - 5,7%;
- Хүн худалдаалах - 2,7%;
- Хээл хахууль өгөх, авах - 0,3%;
- Залилан мэхлэх - 41,9%;
- Хулгайлах - 8,9%;
- Дээрэмдэх - 3,3%;
- Танхайрах - 2,7% (хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн гэмт хэргийн төрөл)

Нөгөөтэйгүүр гэр бүлийн орчинд, сургуулийн өмнөх боловсрол, дунд сургууль, их сургуульд хүчирхийлэл, гэмт хэрэг, харилцааны талаар үндсэн болон нэмэлт мэдлэг, хандлага өөрчлөх чиглэлээр хичээл орохгүй явж ирсэнээс шалтгаалж нийгэм тэр чигтээ хүчирхийлэлд дасан зохицох хандлагатай болсныг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Ийм нөхцөлд өсч торнисон хүүхдүүд одоо 25-аас дээш насныхан буюу идэр насныханд хамаарч, гэр бүлийн харилцаа үүсгэж, эцэг, эх болжээ. Гэтэл гэр бүлийн хүчирхийллийг архидалт, ядуурлаас хамааралтай гэж үзэж зөвхөн гэр хороолол, зах хэсгээр үйлдэгддэг үзэгдэл хэмээн ташаа ойлголттой байгаа нь харамсалтай.

Бодит байдалд дундаас дээд түвшний, тогтсон амьдралтай гэр бүлд ч хүчирхийлэл гарсаар байгааг тодорхой кейсээс харж болно. Өөрөөр хэлбэл, хүчирхийлллийн зан үйлд дасан зохицсон хүн эрх мэдлийн ялгаатай байдлыг ашиглан гэр бүлийн бусад гишүүндээ үзүүлж буй дарамт, бие махбодын хүчирхийлэл үйлдэх хэлбэр түгээмэл байна.

28 ХЗҮХ, судлаач ГОюунболд, Р.Оюунбадам нар "Хорих ялыг үр нөлөө" судалгааны тайлан. 2009 он

Тухайлбал, Багануур дүүргийн прокурорын газар нь 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 50 гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласнаас 16 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 34 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэж шийдвэрлэсэн ба дээрх 34 эрүүгийн хэргийг прокуророос шийдвэрлэсэн байдлыг судлахад 10 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлж, 24 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын 18 буюу 35.2% нь хүчирхийлэл үйлдэгчтэй хамтран амьдрагч байгаа бол 25 буюу 49% нь эхнэр, 4 буюу 7.8% нь хүчирхийлэл үйлдэгчийн охин болон дагавар охин, 3 буюу 5.8% нь хүчирийлэл үйлдэгчийн төрсөн болон дагавар хүү, 1 буюу 1.9% нь нөхрийн харилцаатай хүмүүс байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэх 51 хохирогчийн хувьд бие махбодын хүчирхийлэлд ихэвчлэн өртсөн байх боловч эдгээр хохирогчдын ард сэтгэл санааны хүчирхийлэлд дам өртсөн өөрөөр хэлбэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх хугацаанд тухайн газар байсан 47 хүүхдийн эрх нь давхар зөрчигдсөн байна.

Дээрх иргэд нь боловсролын хувьд 9 нь дээд, 22 нь бүрэн дунд, 9 нь бүрэн бус дунд, 2 иргэн тусгай боловсролтой бол 6 иргэн бага боловсролтой байна. Ажил эрхлэлтийн хувьд 22 нь эрхэлсэн ажилтай байгаа бол үлдсэн 26 иргэн эрхэлсэн тодорхой ажилгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй шалтгааныг судлахад цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээллийн 70 гаруй хувьд хамаарах тохиолдол нь архидан согтуурсан үедээ үйлдсэн бол эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй гол шалтгаан нь хардалтаас үүдэлтэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлд прокурорын байгууллагын чиг үүргийг заахдаа "Прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, үр дүнтэй тэмцэхийн тулд дараах ажлыг хийх шаардлагатай. Үүнд:

Цаашид мөрдөн байцаагч, прокуророос эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх явцдаа гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, энэ тухай танилцуулга, дүгнэлт бичиж хэвших шаардлагатай;

Хүчирхийллийг үл тэвчих хандлагыг нийгмийн бүхий л хүрээнд бий болгох, ялангуяа боловсролын системээр дамжуулан мэдлэг түгээх, харилцааг сайжруулах талаар тодорхой ажлыг зохион байгуулах;

Хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөх албадан сургалтыг чанаржуулах, үр дүнг нь тооцох, шаардлагатай гэж үзвэл хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, төрийн бус байгууллагын туслалцааг авах;

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг эрт илрүүлэх, нөхөн сэргээх талаар хамтарсан багийн үйл ажиллагааг чадваржуулах;

Хөршийн холбоо, хэсгийн байцаагч, төлөөлөгчийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, анхны дуудлага бүрийг шууд гэр бүлийн хүчирхийлэл гэж урьдчилан дүгнэхгүй байх, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хууль сахиулагчийн хандлагыг өөрчлөх, ур чадвар олгох, хохирогч төвтэй арга барил нэвтрүүлэх зэрэг болно.

ХҮҮХЭД ХОЛБОГДСОН, ХОХИРСОН ГЭМТ ЯВДАЛ





6. ХҮҮХЭД ХОЛБОГДСОН, ХОХИРСОН ГЭМТ ЯВДАЛ

Монголын нийгэм дэх 1990-ээд оны нийгэм соёлын өөрчлөлт ажил эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, гэрлэлт, хүүхэд өсгөх, хүүхэд хүмүүжүүлэх, гэр бүл төлөвлөх талаар шинэ үнэлэмж, итгэл үнэмшил нийгэмд бий болгосон байна. Үүний зэрэгцээ гэр бүл хүүхдэд анхаарал халамж тавих чадвар муудаж, боловсролын тогтолцоо суларсанаас хараа хяналтгүй хүүхэд нэмэгдэж, траншейны гэгдэх хүүхдүүд бий болсоноос хүүхдээс үйлдэх гэмт хэрэг огцом өссөн байна.

Тухайлбал, 1990 онд 87% байсан суурь боловсрол эзэмшигчдийн хувь 1999 онд 64%, 2000 онд бага боловсролд элсэлтийн хувь 75.6% болтлоо буурчээ. Сургуулиудын ачаалал хэтэрч, иргэний бүртгэлийн бичиг баримт байхгүйн улмаас, сургуульдаа хэрэглэх ойр зуурын хэрэглээний зүйл худалдан авах санхүүгийн боломжгүйгээс сургуулиас завсардаж байгаа буюу сургуульд суралцах боломжоо бүрмөсөн алдаж байв. Тухайн үед архидалт, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл ихэссэнээс хүүхдүүд гэмт хэргийн зам руу шилжиж, гэмт хэрэг үйлдэхэд татагдан орж байжээ.

Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага чанга, насанд хүрсэн хүнтэй ижил нөхцөлд ял авдагаас хүүхэд хорих ял биечлэн эдлэх явдал өсч, мэргэшсэн гэмт хэрэгтэн бэлтгэх суурь нөхцөлийг бүрдүүлж байсан тухай судалгаанд дурдаж байв.[29] Тухайлбал, хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг 1995-2002 оны хооронд тасралтгүй өсөж байсан нь дээр дурдсан олон нөхцөлөөс шууд хамаарч байв.

4. 1990 онд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн нийт 3062 хүнээс 18 хүртэл насны 321 хүн буюу 7.5%-ийг эзэлж байсан. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 18 хүртэл насны хүмүүс 1990 онд 231 байсан бол 2004 онд 1059 болж 4.5 дахин өссөн.
5. Хүний эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хувьд 1990 онд 18 хүртэл насны гэмт хэрэг үйлдэгч нь 64 байсан бол 2004 онд 118 буюу 1.8 дахин өссөн.
6. Танхайрах гэмт хэргийн хувьд. Танхайрах гэмт хэрэгт 18 хүртэлх насны гэмт хэрэгт холбогдогч нь 1990 онд 80 байсан бол 2004 онд 104 буюу 1,3 дахин өссөн.
7. Дээрэмдэх гэмт хэргийн хувьд 18 хүртэл насны гэмт хэрэгт холбогдогч нь 1990 онд 42 байсан бол 2004 онд 88 буюу 2,1 дахин өссөн.

Үүнээс цааш он дараалаар авч үзвэл, 2000-2004 онд Улаанбаатар хотод гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн тоо, насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн тоо аль аль нь өсчээ.[30] Тухайн үеийн гэмт хэргийн мэдээнээс харахад хүүхдийн гэмт явдлын төлөв байдал ерөнхийдөө ижил төстэй байлаа.[31] Хөдөө орон нутагт хүнийг санаатай алах, хүчиндэх, дээрэмдэх гэмт хэрэг давамгайлж байсан бол Улаанбаатарт бүлэглэн дээрэм хийх, танхай, хүний эрх чөлөөнд халдах гэмт хэргүүд давамгайлж, гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 33% арван жилийн сургуулийн сурагчид, 11% гудамжны хүүхдүүд байжээ.[32]

Энэ үед 16-аас доош насны ял эдлэж буй хүүхдийн тоо 10.8%-аар нэмэгдсэн ба шоронд ял эдлэхээс өөр шийтгэл эдлэж буй хүүхдийн тоо мөн өссөн байна. Шүүхээр ял сонссон хүүхдийн 10% шоронд ял эдлэх шийтгэл авсан нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо жилд 150-200-аар нэмэгдэж байгааг харуулж, ял эдэлж буй хүүхдийн 30% бичиг үсэг

29 Насанд хүрээгүй хүний хууль зүйн хорооны үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ . ХЗҮХ. 2007 он.

30 Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн байдал, НҮБХС, Монгол, 2007, х. 71

31 Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн зонхилох хувь нь хүч хэрэглэсэн гэмт хэргээс илүүтэйгээр өмчийн эсрэг гэмт хэрэг байдаг. Залуусын үйлдэг гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэр бол хулгай ба танхайн гэмт хэргүүд бөгөөд үүнээс хот, төвлөрсөн газарт ихэвчлэн халаасны хулгай, зах, галт тэрэгний буудалд хулгай их гардаг бол хөдөө орон нутагт малын хулгай их байв. Түүнчлэн арай ахмад насны хүүхдүүд өөрсдөөсөө насаар бага, сургуулийн хүүхдүүдийг айлгах, дээрэмдэх, хулгай хийх нь их тохиолддог. Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд, НҮБХС Монгол, 2002. х 12

32 Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн байдал, НҮБХС, Монгол, 2007, х. 72

тайлагдаагүй, 10-15% өнчин болон орон гэрээсээ дайжсан хүүхдүүд байсан байна.[33]


2006 оны байдлаар насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн 1049 гэмт хэрэг бүртгэгдсэн ба төрлөөр авч үзвэл:

1. Хүнийг санаатай алах гэмт хэргийн 2.2%;
2. Бусдын биед санаатай гэмтэл учруулах гэмт хэргийн 3.0%;
3. Хүчиндэх гэмт хэргийн 11.7%;
4. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 10.1%;
5. Танхайрах гэмт хэргийн 4.5%;
6. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн 11.2% ;
7. Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 14.3%;
8. Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 0.8%-ийг насанд хүрээгүй хүн оролцож үйлдсэн байна.

Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхтэй холбоотой асуудал, тоо баримт нь нийслэлийн хэв журмын хэлтэс, түүний харьяа нэгжийн төлөвлөгөө, тайлангийн ажилд тэр бүр тусгагдахгүй насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал бүр орхигдож, аймаг, дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд хүүхдийн хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нарын орон тоог цөөлсөн нь гэмт хэргийн гаралтад нөлөөлөх нэг хүчин зүйл болжээ.

Сүүлийн жилүүдэд хотжих үйл явц нэмэгдэж, нийт хүн амын 60 орчим хувь нь хот, суурин газар, үүнээс 50 орчим хувь нь нийслэлд амьдарч байна. Ийнхүү хотын хүн ам огцом нэмэгдэж байгаа нь нийслэл, төв, суурин газар дахь сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн бусад үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж байна.

График VII.6.1.



Улсын хэмжээнд 2006, 2007, 2008 онуудад насанд хүрээгүй этгээдүүдээс 2804 гэмт хэрэг үйлдэгдсэн ба үүнд 4072 хүүхэд холбогджээ. Харин дээрх хэргүүдээс хүүхдүүд чухам ямар төрлийн гэмт хэргийг ихэвчлэн үйлдэж гэмт хэргийн холбогдогч болж байгааг тодруулбал, нийт 2804 гэмт хэргийн 57.6% мөн нийт гэмт хэрэгт холбогдогчийн 55% нь дан ганц хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаа нь хүүхдүүд хулгайлах гэмт хэргийг илүүтэй үйлддэг нь харагдаж байна. Үүний дараагаар бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах, дээрэмдэх гэмт хэргүүдийг голлон үйлдэж байсан.

2008-2011 онд Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн зарим онцлогийг авч үзвэл 21.8% нь согтуугаар, 11.0% нь бүлэглэн үйлдэгдэж, 3.0% нь хүүхэд, 8.1% нь эмэгтэй хүн оролцож үйлдэгджээ.


33 Мөн эх үүсвэр х 72-73.

График VII.6.2.



Хүүхэд үйлдсэн гэмт хэргийн төрлийг авч үзвэл, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 64.6%-ийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, 9.0%-ийг бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 7.5%-ийг танхайрах, 5.5%-ийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 3.9%-ийг хүчиндэх, 3.8%-ийг бусдын эд хөрөнгийг булаах, 1.2%-ийг бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах, 1.0 хувийг хүнийг санаатай алах, 0.6%-ийг ТХХАБАЖЭсрэг, 2.8%-ийг бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

График VII.6.3.



2016 онд гэмт хэрэгт холбогдсон болон шүүхэд шилжүүлсэн хүүхдийн харьцааг үзвэл 1/3 байна. Нийт 838 гэмт хэрэгт 1194 хүүхэд холбогдсоноос 470 хүүхдэд холбогдох хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд хүүхдээс үйлдэх гэмт хэргийн төрөл нь 2008 оноос хойшхи нөхцөл байдлаас тэдийлэн өөрчлөгдөөгүй боловч цахим орчинд бусдад уруу татагдах гэмт хэргийн яллагдагч, хохирогч болох өсвөр насны хүмүүсийн дундах үе тэнгийнхний хүчирхийлэл, дарамт ихсэх хандлагатай байгаа ажигдлагдлаа.

Хүснэгт VII.6.1.

ХБМБ явуулсан ЭХтоо	Насанд хүрээгүй хүнтэй		Прокурорын хяналтанд ХБ-сон хасагдаад холбогдсон			ЭХ-н шийдвэрлэлтээр					Шүүхэд шилжүүлсэн яллагдагч
	ЭХ тоо	Хүний тоо	Нийт	ЭР	ЭМ	Ажил-лагаанд	Нэгтгэгдсэн	ХБ-сон	Түдгэлзүүлсэн	Шүүхэд шилжүүлсэн	
41843	838	1194	1004	927	77	40	106	323	45	324	470

Түүнчлэн шүүн таслах ажиллагааны мэдээллээс авч үзвэл, 2016 онд нийт 360 хүүхдэд ял оногдуулснаас 233 хүүхдэд хорих ял оногдуулж, 13 хорих ял биечлэн, 217 шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулж, 117 хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулсан байна.

Хүснэгт VII.6.2.

Огноо		Ял шийтгүүлсэн нийт	Хүйс		Сураг	Хорих ял		Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	Насанд хүрээгүй этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулсан хүн /ЭХ-ийн 62 /	Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан бүгд	Үүнээс			Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн
			эр	эм		Бүгд	Үүнээс: Эмэгтэй				торгох ял	Албадан ажил хийлгэх ял	Баривчлах ял		
2016	Орон нутаг	227	226	1	144	120	0	9	12	9	2	5	2	107	98
	Нийслэл	133	127	6	71	113	6	4	8	1	0	0	1	110	19
	Нийт	360	353	7	215	233	6	13	20	10	2	5	3	217	117
Нийт	Орон нутаг	1391	1363	28	786	891	17	86	78	48	6	14	18	802	462
	Нийслэл	993	947	46	391	822	33	88	99	26	4	15	17	707	135
	Нийт	**2384**	**2310**	**74**	**1177**	**1713**	**50**	**174**	**177**	**74**	**10**	**29**	**35**	**1509**	**597**

ХҮҮХЭД ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ:

- Орон нутаг болон нийслэлд РС тоглоомын газар олноор ажилладаг болсонтой холбоотойгоор тэнд тоглодог, энэ тоглоомыг сонирхдог хүүхдүүдийн тоо эрс нэмэгдсэн нь гэмт хэрэг гарах нэг нөхцөл болж байна. Учир нь энэ тоглоомонд донтсон хүүхдүүд гар утас, бэлэн мөнгө зэрэг эд зүйлсээ ил задгай тавьдаг, эсвэл хувцасныхаа халаасанд хийгээд орхидгоос хулгайлах гэмт хэрэгт ихээр өртдөг. Ийм нөхцөл байдлыг далимдуулж хулгайлах, дээрэмдэх, булаах гэмт хэрэг үйлддэг хүүхдүүд багагүй байна;
- Хүүхдэд тавих эцэг эх, ар гэрийн хараа хяналт сул, насанд хүрээгүй хүүхдээ шөнийн цагаар хаана юу хийж байгааг болон ямар хүүхэдтэй найзалж нөхөрлөж байгааг нь анхаардаггүйгээс болоод зарим хүүхдүүд бусдад уруу татагдаж гэмт хэрэг үйлдсэн байна;
- Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн тодорхой хувь нь сургууль завсардаж, суралцдаггүй, хамт олонгүй, тодорхой ажил эрхэлдэггүй хүүхдүүд байгаа нь тэдний гэмт хэрэг үйлдэх нэг шалтгаан болж, бусад хүүхдүүдийг гэмт хэрэгт татан оролцуулах нэг үндэслэл болж байна. Бүлэглэж гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүд дотор заавал 1-2 нь сургууль завсардсан хүүхдүүд байгаа нь ийм дүгнэлт хийхэд хүргэж байна;
- Насанд хүрээгүй хүнд, шөнийн цагаар согтууруулах ундааны зүйл худалддаг, эцэг эх нь эзгүй байгаа хэн нэгнийдээ очиж архи уудаг, улмаар согтож, хүчиндэх болон танхайрах гэмт хэрэг үйлдсэн гэх мэт олон шалтгаан нөхцөлийг дурдаж болохоор байна;
- Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын тогтолцоонд харилцааны наад захын ур чадвар, хууль сахигч иргэн бий болгох, зүй бус зан үйлд дасан зохицуулахгүй байх зэрэг олон арга хэмжээ тусгагдаагүйгээс суурь хүмүүжлийн хувьд бүрэн төлөвшөөгүй хүчирхийлэл, авлига, бусдын өмчид халдаж хулгайлах, булаах зэрэг үйлдэлд дасан зохицох хандлагатай болон хүмүүжиж байна;

- Телевизүүд гадаад, дотоодын телевизийн бүтээлийг тэр бүр худалдаж авах санхүүгийн чадавх султай. Тиймээс программ солилцоо, худалдааны аргаар авдаг ганц нэг бүтээлийг эс тооцвол ихэнхдээ чанар муутай видео кино, эсвэл хулгайлах замаар хуулж бичсэн зарим бүтээлийг орчуулан гаргах байдалтай (нийслэлд байгаа телевизүүдийн хөтөлбөрийн 25-57% нь гадаадын телевизийн бүтээлийг орчуулан үзүүлдэг) байна. Судалгаагаар нийт гарч байгаа кино нь хүчирхийллийг шууд харуулсан, сурталчилсан, өөгшүүлэн дэмжсэн, хэдийд насны ангиллаар, онцлогоор яаж үзүүлэх талаар ямар нэг хязгаарлалтгүй байна.[34] Энэ нь бага болон өсвөр насны хүүхдийн сэтгэхүйд гэмт зан төлөвийг бүрдүүлэх нэг нөхцөл болж байгааг ч үгүйсгэх аргагүй[35] юм;
- Фэйсбүүк, твиттер гэх мэт нийгмийн сүлжээний хэрэгсэл, аппликэйшнүүд нэмэгдэхийн хэрээр үүнийг дагаад интернетийн хэрэглээ ч нэмэгдэж байна. Улмаар хүмүүсийн мэдээлэл авах хурд, холбоо харилцаа урьд бидний төсөөлж байснаас ихэссэн бөгөөд цаашид энэ нь орчин үеийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн зөвхөн нэг хэсэг болж байна.
  - Хууль бус зар сурталчилгааг хянах, гаргуулахгүй байх;
  - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх постер, контент гаргуулах;
  - Гэмт хэргийг сурталчлахгүй байх;
  - Олон нийтийн сүлжээ буюу фэйсбүүк, твиттер зэргийг 16-аас доош насны хүүхдэд хэрэглүүлэхгүй байхаар төрийн байгууллага зохицуулалт хийж, эцэг эх, интернет үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах;
  - Садар самуун, биеэ үнэлэлт шинэ хэлбэрт буюу цахим орчинд шилжиж байгаатай холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудад сургалт явуулах;
  - Урамшуулан дэмжиж, хамтран ажиллах;
  - Шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах;
- Нийгмийн хамгааллын салбарын бодлого болон эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2012-2016 онд хүүхэд хамгаалын бодлогыг шинээр тодорхойлж, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг УИХ-аас батлан гаргаж, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхээр заасан. Хүүхэд эрх, хүүхэд хамгаалал нь зөвхөн дээрх хоёр хуулиас гадна эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан эрүүгийн багц хууль тогтоомжтой уялдан боловсруулагдсан билээ.

Өсвөр насны хүнд ял оногдуулах бодлогыг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгайлан зохицуулснаар Монгол Улсын олон улсад хүлээсэн үүргээ бодитойгоор биелүүлэх нөхцөл бүрдэх ба өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд түүнд оногдуулах ял нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, цаашид гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх нөхцөл журам, хэрэгжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэх процесс зэргийг Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуульд нарийвчлан зааж өгсөнөөр шүүхээс уг албадлагын арга хэмжээг хэрэглэх боломж бүрдэхээс гадна гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг хуульд заасан гол зорилгууд биелэх бодит нөхцөл үүснэ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан шинээр батлагдсан

34 "Монголын телевизийн өчигдөр өнөөдөр", дэд доктор Ю.Эрдэнэтуяа, http://zorigtsoc.wordpress.com/
35 Өдрийн сонин, 2009 оны 5 сарын 9 №112, "Телевиз аливаа даган дууриах сэдэл, сэтгэхүйг төрүүлдэг" гэсэн ХИС-ын хэсэг оюутнуудын нэг өдрийн ажиглалтын аргаар хийсэн судалгаагаар үүнийг нотолсон байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо"-г байгуулахаар заасан ба уг хороо нь дараах үйл ажиллагааг явуулахаар заасан байна:

15.1.1.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.2.сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.3.гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

15.1.4.хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

15.1.5.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

15.1.6.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

15.1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах.

Иймд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг практикт хэрэглэх, хэрэгжүүлэх зэрэг олон асуудал хүлээгдэж байна. 2016 оны тухайд шинээр Хүүхэд хамгааллын тухай хууль болон Эрүүгийн хууль тогтоомж батлагдах, хэрэгжиж эхлэх зэрэг шатанд байсан учраас шинэ хуулийн зохицуулалтыг дүгнэх боломжгүй байв. Цаашид Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг зэргийг орон нутагт үр дүнтэй ажиллуулж, шинэ соёл бүрдүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог хуульд заасан үзэл баримтлалаар бүрдүүлэх ажил бидний өмнө байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДАЛ БА ЖЕНДЕР



7. ЭМЭГТЭЙЧҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДАЛ БА ЖЕНДЕР

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ГЭМТ ҮЗЭГДЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Монгол Улсад төдийгүй олон улсад сүүлийн жилүүдэд жендэр болон хүйсийн тэгш бус байдлыг хангах чиглэлээр нийгмийн олон салбарт анхаарал хандуулахыг зөвлөх болсон. Нийгэмд хүйсийн болон жендэрийн тэгш бус байдал алдагдах нь олон сөрөг үр дагаварт хүргэх болсныг сануулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна. Жендэр гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаа (зан үйл, ажил үүрэг, нийгэмд эзлэх байр суурь гэх мэт.).

Манай Улсад сүүлийн 4 жилд гэмт хэргийн үзүүлэлтийг авч үзвэл улс орны нийгэм, эдийн засгийн байдал харьцангуй сайжирч, улмаар гэмт хэрэг харьцангуй тогтвортой байна. Харин нийгэм дэх эмэгтэйчүүдийн оролцоо өсөн нэмэгдэж, гэр бүл, байгууллага, хувийн хэвшил, улс төрд ч эмэгтэйчүүд манлайлах хандлагатай холбоотойгоор нийгмийн сөрөг үзэгдэлд өртөх, гэмт хэрэгт холбогдох, хохирогч болж буй байдал дараах судалгаагаар илэрхийлэглэж байна.

Улсын хэмжээнд 2013-2016 онд нийт 94685 гэмт хэрэг бүртгэгдсэний 14129 буюу 15.0%-ийг эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна.

График VII.7.1.



Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 15 хувь байгаа нь хүн амын хүйсийн харьцаатай харьцуулахад дунджаас доогуур үзүүлэлт. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад 1996 оноос хүн амын өсөлт, төрөлтийн 60-70 орчим хувийг эмэгтэй хүүхэд төрөх болсон, нийгмийн бүхий л салбарт эмэгтэй хүний оролцоо өсөн нэмэгдсэн, боловсрол, ажил эрхлэлтээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дээгүүр үзүүлэлттэй байгааг анхаарах шаардлагатай.

Монгол Улсад 2016 онд нийт 23805 хүн гэмт хэрэг үйлдсэний 3592 нь эмэгтэй хүн байна. Энэ нь өмнөх оныхоос 5.0%-аар буурсан үзүүлэлт байгаа нь хангалттай тоо биш.

Хүснэгт VII.7.1.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Эмэгтэй		Өсөлт, бууралтын хувь
	2015	2016		2015	2016	
Орон нутагт	10346	9323		1206	1045	
Нийслэлд	14511	14482		2576	2547	
Улсын хэмжээнд	24857	23805	-4.2	3782	3592	-5.0

Улсын хэмжээнд 2016 онд эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг 3516 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 266 хэргээр буюу 7.0%-аар, Улаанбаатар хотын хэмжээнд 100 хэргээр буюу 2.7%-аар тус тус буурсан байна. Нийт гэмт хэрэгт эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэргийн эзлэх хувь 30.2% байна. Энэ нь өмнөх оныхоос 1.6%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг сүүлийн 4 жилийн байдлаар харьцуулсаныг харуулбал:


Хүснэгт VII.7.2.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	1136	977	-14.0	11.6	10.5
Нийслэлд	2636	2536	-3.7	20.2	19.7
Бусад газарт	10	3	-70.0	0.03	0.01

Мөн онд бүртгэгсэн эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэргийг ангиллаар нь авч үзэхэд 2218 хэрэг буюу 63.1%-ийг хөнгөн, 1054 хэрэг буюу 30.0%-ийг хүндэвтэр, 167 хэрэг буюу 4.7%-ийг хүнд, 77 хэрэг буюу 2.2%-ийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Диаграмм VII.7.1.

2016 онд эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэргийг гэмт хэргийн ангиллаар авч үзвэл



Эмэгтэйчүүдээс үйлдэж буй нийт гэмт хэргийг бүтэц, төрлөөр нь авч үзвэл, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 45.0% нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 34.2% нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 12.5% нь, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн 11.9% нь, аж ахуйн эсрэг гэмт хэргийн 9.2% нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 8.0% нь, танхайрах гэмт хэргийн 7.2% нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 6.3% нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 3.4% нь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн 2.1% ийг тус тус эмэгтэй хүн үйлдсэн гэж бүртгэгджээ.

Диаграмм VII.7.2.



Манай улсад бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх болон залилан мэхлэх гэмт хэргийн 40-50%-ийг эмэгтэй хүн үйлдэж байгаа нь эмэгтэйчүүдээс энэ төрлийн гэмт хэргийг ямар шалтгааны улмаас үйлдэж байгааг нарийн тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс эрүүгийн хэрэгт ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн судалгааг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 6819 эмэгтэй ял шийтгүүлсэн байна.

График VII.7.1.



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2016 онд нийт 10120 хүнд холбогдох 7025 эрүүгийн хэрэг хүлээн авч, нийт 5762 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 6566 хүнд ял шийтгэл оногдуулснаас 518 нь эмэгтэй хүн байна. Үүнээс торгох - 67, албадан ажил хийлгэх - 41, баривчлах - 24, хорих - 386, үүнээс биечлэн эдэлсэн - 81, ял хойшилсон - 86 байна. Энэ нь өмнөх оныхоос 146 эмэгтэй буюу 22 хувиар буурсан үзүүлэлт гарч байна.

Хүснэгт VII.7.3.

№	Утга	2015 он	2016 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Урьд ял шийтгүүлсэн	1900	1773	-127	-6.7
2	Гэмт хэрэг давтан үйлдсэн	600	451	-149	-24.5
3	Бүлэглэж үйлдсэн	1616	1382	-234	-14.5
4	Согтуугаар үйлдсэн	1700	1729	29	1.7

5	Эмэгтэй	664	518	-146	-22
6	Насанд хүрээгүй этгээд	422	360	-62	-14.7

ХЭҮК болон иргэний нийгмийн байгууллагууд 1996 оноос гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар дагнан судалсан боловч харин гэмт хэрэгтэн бие хүн талаас судлах асуудал манай энэ салбарын эрдэмтдийн анхаарлаас гадуур орхигдож ирсэн нь нууц биш.

Эмэгтэйчүүдээс гэмт хэрэг, зөрчил үйлдсэн судалгааг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, тэдний эрх зүйн болон аюулгүй байдлын асуудлыг чухалд тавьж судалж ирсэн. Улсын хэмжээнд 2016 онд нийт 27167 гэмт хэрэг бүртгэгдэж, үүний улмаас 27689 хүн хохирсноос гэр бүлийн хүчирхийлэлд 1357 иргэн өртөж хохирсон байна. Үүний 90,7% нь эмэгтэйчүүд байна. Үүний дотор эхнэр 830, хамтран амьдрагч 229 эмэгтэй өртсөн байна.

Бид гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалж гэмт хэрэгтэн болсон эмэгтэй гэмт бие хүн судлалын асуудлыг тэдний сэтгэл зүйн болон гэмт зан төлвийн талаас дагнан судлах шаардлага нэгэнт бий болсон. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 595 буюу 41,1% нь согтуугаар, 91 буюу 6,3% нь эмэгтэй хүн оролцож үйлдсэн (2016 онд) судалгааг ЦЕГ-аас гаргасан байна.

ХЭҮК 2012 онд хүнийг санаатай алах гэмт хэргээр хорих ялаар шийтгүүлж, хорих 407 дугаар ангид ял эдэлж байгаа 103 хоригдлын дунд хийсэн судалгаагаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 93 дугаар зүйл санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг алах, 94 дүгээр зүйл бусдын болгоомжгүй алах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн байхгүй зөвхөн Эрүүгийн хуулийн 91.1 болон 91.2-д заасан зүйлээр ял шийтгүүлсэн байна. Гэтэл эдгээр хоригдол эмэгтэйчүүдийн дунд явуулсан судалгаагаар 31,28% нь хохирогч байнга агсан согтуу тавьж, хүчрхийлэл үйлддэг байсан, 20,3% нь хэрүүл маргааны улмаас хэрэг үйлдсэн гэх шалтгааныг тодорхойлох судалгааны дүнд тусгажээ[36]

Эндээс бид хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн гэмт хэрэг үйлдэх гол нөхцөл болжээ гэж харахад хүргэхээр судалгааны үр дүн биш ч энэ төрлийн бүртгэл судалгаанд зайлшгүй анхаарч тайлан, статистик мэдээг нарийвчилж гаргах шаардлага бий болсныг харуулж байна. Цаашид эмэгтэйчүүд зөвхөн хүчирхийлэлд өртөж гэмт хэрэг үйлдэхээс гадна тэдний улс төрд шийдвэр гаргах түвшний оролцоо, эрх мэдэл, эдийн засаг, бизнесийн салбар, гэр бүл дэх үүрэг, хариуцлага, байр суурь нь гэмт хэрэгт татан оруулах нөхцөл бүрдэх чиг хандлага ажиглагдаж байна.

Эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйл нь өөр хоорондоо харилцан уялдаа бүхий нийгмийн тойрог харилцаа бөгөөд түүнийг зөв тогтоосноор түүнтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Дээрх судалгаа, тайлангаас харахад манай улсад эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Нийгмийн зүгээс нөлөөлж буй уламжлалт сөрөг хандлага. Гэр бүл, нийгмийн олон талт харилцаанд эмэгтэйчүүдийг дорд үзэх, хүлээн зөвшөөрөхгүй байх, эрэгтэй хүйсийн дараа тэдний эрх, ашиг, боломж тавигдах гэх мэт хандлага;
2. Эдийн засгийн хувьд орлогогүй, орлого багатай, эдийн засгийн эрх мэдэлгүй, хараат байдал. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гол шалтгаан нь амар хялбар аргаар мөнгө, ашиг олох явдал. Эмэгтэйчүүдээс энэ төрлийн гэмт хэргийг зонхилон үйлдэж байгаа нь гэр бүлд тэдний үүрэг, хариуцлага өндөр байгааг илтгэж байна. Бага орлоготой, өрх толгойлсон эмэгтэйчүүд, мөн архинд донтсон, гэр бүлийн хүчирхийлэлд амьдардаг гэсэн голлох нөхцөлөөр тэд гэмт хэрэг үйлдэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Харин бусдын бие махбодид гэмтэл учруулах,

36 http://www.mn-nhrc.org/. Татсан 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдөр

хүнийг санаатай алах гэмт хэрэг хэдийгээр эмэгтэйчүүдээс үйлдэх гэмт хэргийн хувийн жинд эзлэх хувь бага байгаа ч нийгмийн хор аюул их энэ гэмт хэргийг анхаарлаас гадуур орхих ёсгүй;

3. Төр засгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн эрх, нийгмийн баталгаа, гэр бүл, хүүхдэдээ анхаарах, сурч боловсрох, хөдөлмөрлөх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн бодлого, шийдвэр гаргаж байгаа ч төдийлөн үр дүнтэй биш байна. Өөрөөр хэлбэл, хэрэгжүүлэх төрийн механизм боловсронгуй бус байгаа явдал;
4. Эмэгтэйчүүдийн нийгмийн олон талын харилцаанд оролцох оролцоо өсөн нэмэгдсэн байдал. Тухайлбал, Эрэгтэйчүүдийн гэр бүл дэх хариуцлага суларч, өрх толгойлсон ганц бие эхийн тоо нэмэгдэж, улмаар гэр бүлээ тэжээн тэтгэх үүрэг хариуцлага эмэгтэйчүүдийн амьдралын зорилго болсон явдал;
5. Бие, физиологийн хувьд сул дорой, аймхай, ичимхий, сэтгэл гутралд амархан өртөх, сэтгэл зүйн хувьд тогтворгүй байдал;
6. Хөдөлмөрийн харилцаанд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн үнэлэмж, ажиллах орчин нөхцөл тааруу буюу эрэгтэйчүүдтэй харьцуулахад доогуур үнэлгээтэй байгаа явдал;
7. Архидалт, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн 40 орчим хувийг согтуугаар үйлдсэн байна;
8. Гэр бүлийн хүчирхийлэл;
9. Хохирогчийн гэм буруутай зан үйл;

1. Эмэгтэйчүүдийн гэмт явдалтай тэмцэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрдэх арга зам

Олон улсын чиг хандлагаар эмэгтэйчүүдийн гэмт үзэгдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд хувь хүний хөгжил, түүний сэтгэхүйн онцлог, амьдралын хэв маягт нийцүүлэн авч хэрэгжүүлэх арга хэмжээг сонгох явдал түгээмэл байна. Манай улсад эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тал хувийг эзэлж, харин гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдсэн үзүүлэлт бага байна. Энэ нь нуугдмал гэмт үзэгдэл байгааг илтгэхийн зэрэгцээ мөн хууль сахиулах байгууллагын бүртгэл судалгаа нарийвчлал багатай байгааг илтгэж байна. Нөгөөтэйгүүр криминологи судлал гэмт бие хүн судлалд анхаарлаа хандуулах, тэр дундаа эмэгтэй гэмт хэрэгтэн, бие хүнийг судлах шаардлага байна.

Бүртгэгдсэн, шүүхээс шийдвэрлэгдсэн хэрэгт эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэрэгт шунахайн сэдэлттэй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг давамгайлж байгаа бөгөөд харин зохион байгуулалтад орсон, рецедив гэмт хэрэгтэн байхгүй. Өөрөөр хэлбэл, зан төлвийн хувьд гэмт зан багаас суусан, нийгэмд харш засрашгүй үзэл тогтсон гэмт хэрэгтэн байхгүй. Энэ нь эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт явдалтай тэмцэх, ялын зорилго болох хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зорилго хангагдахад эерэгээр нөлөөлнө.

Эмэгтэй хүн байгалиас заяасан уян зөөлөн, сэтгэл эмзэг, сэтгэл гутралд орж, гарах процесс хурдан, асуудлыг шийдвэрлэх гарц хайх чадвар сайн, мөн хүмүүсийн зан төлөв нь эмэгтэй хүнд итгэх явдал эрэгтэй хүнтэй харьцуулахад илүү байдаг зэрэг байгалийн өгөгдлөөр гэмт хэрэг үйлдсэн эсвэл өртсөн байна.

Эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт үзэгдэлтэй тэмцэх нь нийгмийн олон сөрөг үзэгдлээс давхар урьдчилан сэргийлэх олон талын ач холбогдолтой. Гэмт хэргийн болон шүүхийн одоогийн статистик мэдээнээс харахад эмэгэйчүүдээс үйлдэж буй гэмт хэрэг, ял эдэлсэн тоо нь бусад гэмт хэрэг болон эрэгтэй хүйсийнхтэй харьцуулахад бага, тулгамдсан асуудлын нэг болоогүй хэдий ч эмэгтэй хүн гэмт хэрэг үйлдэх нь гэр бүлийн хүрээнд маш олон сөрөг үр дагаварыг бий болгодог. Тухайлбал, гэр бүл, хүүхдийн хүмүүжил, хувь заяа, хүн амын

өсөлт, нийгмийн сэтгэл зүйд хор нөлөөтэй. Тиймээс криминологи судалгааны гол зорилго бол нуугдмал гэмт явдлыг илрүүлэх, бүртгэлжүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал тул энэ асуудалд анхаарлаа хандуулж, тэмцэх нь зайлшгүй.

Эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт явдлын шалтгаан, нөхцөл, хүчин зүйл нь өөр хоорондоо харилцан уялдаа бүхий нийгмийн тойрог харилцаа бөгөөд түүнийг зөв тогтоосноор түүнтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.


2. Эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт явдалтай тэмцэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

1. Цагдаагийн байгууллага 2008 оноос гэмт хэргийн статистик мэдээллийг боловсронгуй болгох, хэргийг субъект бүрээр нарийвчлан гаргаж эхэлсэн нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд төдийгүй судлаач нарт чухал мэдээлэл болж байгаа. Харин эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэргээр нарийвчилсан судалгаа гаргаж, нас, боловсрол, эрүүл мэндийн байдал, сэтгэцийн төлөв, уг гэмт хэргийг үйлдэх болсон шалтгаан, нөхцөл зэрэг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар тогтоогдох мэдээллийн хүрээнд гаргаж байх;
2. Цагдаагийн байгууллага Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу шинэчлэн найруулсан эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг зөв зүйлчлэх, нэг мөр ойлголт, аргачлалтай болж, үүргээ зохих түвшинд гүйцэтгэх;
3. Хууль сахиулах байгууллага болон прокурор, шүүхийн практикт эмэгтэй хүн үйлдсэн хэрэгт (гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой болон бусдын амь нас хохирсон хэрэгт) зүйлчлэлийн асуудлыг онцгой анхаарч, аргагүй хамгаалалт, сэтгэл санааны хүчтэй цочрол, гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийг сайтар нягтлах;
4. Нийгмийн зүгээс нөлөөлж буй уламжлалт сөрөг хандлага, түүнчлэн цагдаагийн алба хаагчдын дунд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах сургалтыг сайтар зохион явуулах;

3. Эмэгтэйчүүдээс үйлдэж буй гэмт явдалтай тэмцэхэд төр засгийн түвшинд анхаарч шийдвэрлэх асуудал

1. Эдийн засгийн хувьд орлогогүй, орлого багатай, эдийн засгийн эрх мэдэлгүй, хараат байдалтай эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тиймээс эмэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлтийн байдалд онцгой анхаарч, төрөөс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2. Эмэгтэйчүүдийн нийгмийн олон талын харилцаанд оролцох оролцоо өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан тэдний гэр бүл дэх хариуцлага өсч, өрх толгойлсон ганц бие ээжүүдийн тоо нэмэгдэж байгаа нийгмийн буруу дүр зураг өсөх хандлагатай байгаад үндэсний хэмжээний цогц судалгааг хийх, эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг тэдэнд хамгийн ойр нэгжид үзүүлж байх, цаашилбал эрэгтэй, эмэгтэй хүмүүст гэр бүлийн үнэ цэнэ, хоёр биедээ үнэнч байх, харилцан итгэлцэл, үр хүүхдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг ухамсарлуулах явдлыг улс орон даяар цогц бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх;
3. Дээрх саналтай холбоотойгоор хүнийг багаас нь зөв төлөвшүүлэх хүмүүжил олгох, хүнийн мөн чанар, үнэт зүйлсийг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шат дараатайгаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд олгох тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх;

ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ЯВДАЛ



8. ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ЯВДАЛ

1. ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Эрүүгийн хуулийн "Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" 25-р бүлэг, 226-229-р зүйлд кибер гэмт хэргийн зарим бүрэлдэхүүнийг хуульчилж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байна. Эрүүгийн хуульд тусгагдсан цахим гэмт хэрэг нь материаллаг болон хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, гэм буруугийн санаатай хэлбэртэй, хүндэвтэр болон хүнд гэмт хэрэг байгаа бөгөөд халдлагын зүйлс нь:

1. Компьютер, компьютерын программ, түүний төхөөрөмж;
2. Компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа болон дамжуулж байгаа мэдээлэл;
3. Компьютер, мэдээллийн хамгаалалттай сүлжээ;
4. Компьютерын мэдээлэл;

Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн "Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" бүлэгт заасан 26.1 "Цахим мэдээлэлд хууль бусаар халдах", 26.2 "Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах", 26.3 "Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах" гэмт хэргийг үйлдсэн бол 14-16 настай хүүхдэд ял оногдуулна37 гэж заажээ. Мөн уламжлалт гэмт хэргүүдийг цахим төхөөрөмж, цахим сүлжээ ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалтай ял оногдуулахаар заасан байдаг. Тухайлбал, 13.10 дугаар зүйл. "Хувь хүний нууцад халдах", 16.9 дүгээр зүйл. "Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах", 17.3 дугаар зүйл. "Залилах гэмт хэрэг" гэх мэт.

1. Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл

Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсад 2016 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 2,512,100 интернет хэрэглэгч байгаагаас нийт хэрэглэгчдийн хамрах хүрээ 86,7% нь Улаанбаатар хотод, 10,3% нь аймагт, 2,9% нь сумдад, интернет үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 ААН, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.38 Интернетийн хэрэглээ эрс нэмэгдэж, зөвхөн компьютер төдийгүй төрөл бүрийн ухаалаг төхөөрөмж ашиглан сүлжээнд холбогддог болсон, өдөр тутмын амьдралын олон хэрэглээг ухаалаг төхөөрөмж, сүлжээ ашиглан эрхлэн явуулдаг болсонтой зэрэгцэн технологийн ололт амжилтыг гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашиглах төрөл, арга хэлбэр хөгжиж байна.

Дэлхийн улс орнууд үндэсний бодлого, стратеги гаргах, хүний нөөцөө бэлтгэх, хамгаалалтын дэд бүтэц бий болгох, байгууллага бүр бодлого, журам батлан мөрдөж, эрсдэлийн үнэлгээ, аудит дээр суурилсан хамгаалалтын шийдлүүд хэрэгжүүлэх, цахим гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоогоо бий болгох, эрх зүйн орчин, хамгаалалт бий болгох, бүх нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлж энэ төрлийн гэмт үзэгдэлтэй тэмцэж байна.

Манай Улсын хувьд "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ыг шинэчлэн баталж "Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр" гаргасан ч хэрэгжилт нь хангалтгүй, ялангуяа хуулийн салбарын ажилтнууд кибер гэмт хэрэгтэй тэмцэх туршлага, мэдлэггүй, техникийн хангалт, шинжлэн судлах чадвар бүрэлдээгүй, эрх зүйн зохицуулалт, орчин


37 Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6.2 дугаар зүйл. Ял оногдуулах насны хязгаар.
38 ЦЕГ-ын ЭЦГ-ын "Цахим орчинд хуурамч шуудангийн хаяг ашиглан үйлдэж буй гэмт хэрэг, тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал"-д дурдсанаар.

хоцрогдсон, хууль, хяналтын байгууллагууд өөрсдөө кибер халдлага, гэмт хэргийн хохирогч болсоор байгаа нь нууц биш.

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тооцоолох төхөөрөмжөөс нотлох баримтуудыг гарган авах, баталгаажуулах техник хэрэгсэл, мэргэжилтэн дутмаг байна. Цахим файл, өгөгдлийг нотлох баримт гэж тооцохгүй учир ихэнх цахим гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа мухардалд орох магадлалтай. Тооцоолох хэрэгслийн бүртгэл, аудитын файлуудыг гаргаж авах, шинжлэх, түүнээс нотлох баримтууд олох, бэхжүүлэх тогтолцоо, дэд бүтэц, хүний нөөц хомс учир кибер гэмт хэргийг илрүүлэх чадвар маш доогуур түвшинд байна гэж үзэж байна. Олон улсын хамтын ажиллагаа хөгжөөгүй учир хил дамнан үйлдэгддэг цахим гэмт хэргийг илрүүлэх боломжийг үгүй болгож байна.

Сүүлийн жилүүдэд цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн төрөл нэмэгдэж түүнийг дагаад гэмт хэргийн үзүүлэлт мөн адил өсч байна. Иргэд цахим орчинд бусдыг доромжлох, гүтгэх, бусдын захидал харилцааны нууцад халдах, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, залилан мэхлэх, далайлган сүрдүүлэх, компьютер, мэдээллийн сүлжээ ашиглан үйлдэж буй гэмт хэргүүд ихээр бүртгэгдэх болжээ.

График VII.8.1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25 дугаар бүлэг. Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг бүртгэгдсэн гэмт хэрэг (2006-2016)[39]



Сүүлийн 10 жилийн байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 226-229 дүгээр зүйлд хамаарах бүртгэгдсэн гэмт хэргийн тоо баримтаас харахад, 2006-2013 онуудад компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт жилд дунджаар нэг бүртгэгдэж байсан нь тухайн гэмт хэрэг тогтвортой байгааг харуулж байна. Гэвч сүүлийн гурван жилийн хугацаанд 4-5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Техник, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед манай улсын иргэд, албан байгууллага болгон интернетэд холбогдож тэр хэрээр байгууллага, иргэд кибер гэмт хэрэгт ихээр өртөж хохирч байна. Ялангуяа байгууллагын сүлжээнд байгаа мэдээллийг устгах, худалдаа үйлчилгээ хэлбэрээр эсвэл аялал жуулчлалын салбар, банк санхүүгийн салбарт хуурамч гүйлгээ хийх, гадаад улс орнуудын хуурамч байгууллага, гэмт хэрэгтнүүдэд захиалга өгч хохирох, хууран мэхэлж эд зүйл, бэлэн бус мөнгийг шилжүүлэн авах гэмт хэргүүд гарсаар байна. Хэдий тийм боловч гадаад орнуудын хакерууд, кибер гэмт хэрэгтнүүдтэй хийж байгаа тэмцэл манай улсад байхгүй, хохирогч байгууллага, ААН, иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгаж үзээд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэж байгаа тохиолдол ихээр гарсан нь анхаарал татаж байна


Компьютерын гэмт хэргүүд дотроос нууц үг хулгайлах (phishing), вирус тараах (virus),

39 "Гэмт хэргийн мэдээ" /2006-2011 он/, ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв, Эрүүгийн цагдаагийн газрын тоо мэдээ /2017/-ээс.

бусдын и-мэйл хаяг руу хэрэггүй захиа олноор явуулах (spaming), банкны цахим картын дугаар хулгайлах хийгээд өөрчлөх /carting/, хуурамч код тааруулан хууль бус гүйлгээ хийх зэрэг гэмт хэрэг түгээмэл байдаг байна. Түүнчлэн нууц үг хулгайлах гэмт хэргүүд дийлэнхийг эзэлж байна. Үүнийг үйлдэхдээ интернетээр төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулдаг интернет банк, интернет худалдаа зэрэг веб хуудсыг дуурайлган хийдэг байна. Нууц үг, картны дугаар хулгайлах цахим хуудасны 86%-аас 30% нь л хаяг нь мэдэгдэх (IP) байрших газар байрладаг нь тэдгээрийг олж илрүүлэхэд хүндрэлтэй байдаг.

Манай улсын хэмжээнд 2014 оноос 2017 оны эхний сарын байдлаар цахим орчинд гэмт хэргийн хохирогч болсон тухай нийт 476 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110 дугаар зүйл, 111, 123, 135, 140, 148, 149, 226-229 дүгээр зүйл ангид хамаарах 202 гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.[40]


График VII.8.2.



Дээрх 202 эрүүгийн хэргийн 16 нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд, 39 эрүүгийн хэрэг буюу 19,3% нь яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт санал хүргүүлж, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр 29 эрүүгийн хэрэг буюу 14,3%-ийг түдгэлзүүлж, 20 эрүүгийн хэрэг буюу 9,9%-ийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 98 эрүүгийн хэрэг буюу нийт үүссэн эрүүгийн хэргийн 46,5% нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Үүнийг графикт үзүүлбэл,

40 ЦЕГ-ын Эрүүгийн Цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн мэдээллээс.


График VII.8.3.



Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд одоогоор байхгүй бөгөөд дээрх 202 эрүүгийн хэрэгт эрэгтэй 103, эмэгтэй 35, насанд хүрээгүй хүн 1, нийт 138 хүн холбогдон шалгагдсан ба яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр 29 эрүүгийн хэргийг түдгэлзүүлжээ.

Түүнчлэн, гадаад улс орнуудаас манай улсыг чиглэсэн олон зуун халдлага өдөр бүр бүртгэгдэж байдаг. ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газраас манай улсад интернетийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн 0.02% интернетийн урсгал дээр бодит, тухайн цаг мөчид (Real time) интернетээр хийгдэж буй хандалтын 2016 оны 4 дүгээр сарын халдлагын шинж бүхий хандалтын үзүүлэлт[41]-ийг авч үзвэл,

График VII.8.4.



2015 оны 4 дүгээр сард л гэхэд урд хөрш улсаас 22613 халдлагын шинж бүхий хандалт манай улс руу чиглэжээ. АНУ-аас 4034 хандалт бүртгэгдсэн бол Орос, Солонгос, Франц улсаас хандалтууд удаалж байна. Дээрх графикаас манай улс ямар эрсдэлд байгаа нь харагдаж байна.

Цахим орчинд бусдыг залилан мэхлэх, цахим шуудангийн залилан, бусдыг гүтгэх, доромжлох, мөн манай улсын хувьд уг гэмт хэргийн шинэ төрөлд тооцогдох скимминг зэрэг хэрэг түгээмэл үйлдэгдэх болсон. Эдгээр гэмт хэргийн үйлдэх арга хэлбэрийн тухайд товч байдлаар авч үзвэл,

Манай улсын томоохон худалдааны компаниуд цахим шуудангийн залилан мэхлэх гэмт хэрэгт өртөж их хэмжээний мөнгийг гэмт этгээдүүдийн гадаад улсын банкинд байрлах

41 http://ncsc.gov.mn/?id=134

хуурамч дансанд шилжүүлэх байдлаар залилуулах явдал сүүлийн 3 жилд эрс нэмэгдсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд харилцагч байгууллагуудын (импортын худалдааны байгууллага) цахим шууданд хууль бусаар нэвтэрч 2 байгууллагын хоорондын нууц мэдээллийг олж аван өөрт ашигтай нөхцөл байдал бүхий цахим шууданг нөгөө талд илгээх байдлаар төлбөрийг өөрсдийн дансанд шилжүүлэн авах гэмт хэрэг юм. Энэ гэмт хэрэг нь ихэвчлэн харилцагч байгууллагын цахим хаягтай тун төстэй (нэг үсэг, тэмдэгт илүү, дутуу, өөрчилж бичсэн) өөр цахим хаягаас тус байгууллагын дансны мэдээлэл өөрчлөгдсөн тухай үнэмшилтэй шалтгаан бүхий захидал илгээж уг захидалд дурдагдсан дансанд мөнгөө шилжүүлснээр дээрх гэмт үйлдэл төгсдөг байна. Сүүлийн 3 жилд Монгол Улсад цахим шуудангийн залилан мэхлэх 51 тохиолдол бүртгэгдсэнээс 21-д нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байдаг бол дээрх 51 тохиолдлоор 23 иргэнд 860,572,311 төгрөгийн, 28 ААН, байгууллагад 1,733,475,014 төгрөгийн буюу нийт **2,597,047,325** төгрөгийн хохирол учирсан байна.[42]

Цахим орчинд үйлдэгдэж буй залилан мэхлэх гэмт хэрэг нь онлайн худалдан авалт хийх, мессеж, цахим шуудан хэлбэрээр их хэмжээний мөнгө хожсон, өв залгамжлагч болсон, хэн нэгэнд туслах шаардлагатай байгаа зэрэг захидал ирэх, цахим болзоо тогтоох, гадаад төслийн зээлийн санал ирэх зэрэг төрлөөр үйлдэгдэж байна. Цахим шуудангийн залилан мэхлэх гэмт хэрэгт өртөхгүй байх үүднээс албаны цахим шууданг олон хүн дундаа ашиглахгүй байх, нэг компьютероор тухайн хаягт нэвтэрдэг байх, цахим хаягаа гар утастай холбосон байх, харилцагч байгууллагын цахим шуудангийн хаягийг нягталж байх, дансны мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд заавал утсаар тодруулж байх, интернет орчинд худалдан авалт хийх, татвар шимтгэл төлөх, тусламж үзүүлэх зэрэг үйлдэл хийхдээ эх сурвалжийг нягтлан шалгаж мөнгөн шилжүүлэг хийснээр энэ гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой. Фэйсбүүк компанийн Ази номхон далайн хариуцсан төлөөлөгчийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсад зохион байгуулсан уулзалт семинарын үеэр тавьсан илтгэлд дурдсанаар Монгол Улсад сард нэгээс доошгүй удаа тус сайтад ханддаг 1,600,00 хэрэглэгч, өдөр бүр тогтмол ханддаг 950 хэрэглэгч идэвхтэй фэйсбүүк ашиглаж байна. Тус компаниас гаргасан судалгаагаар фэйсбүүк хэрэглэгчдийн 5-10% буюу ойролцоогоор 140 сая хуурамч хаяг, твиттер хэрэглэгчдийн 4% буюу ойролцоогоор 20 сая нь хуурамч хаяг байгааг тогтоосон байна.

Сүүлийн жилүүдэд Филиппин, Сингапур, Малайз зэрэг Азийн улс оронд харьяалалттай гэмт этгээдүүд хуурамч фэйсбүүк хаяг ашиглан манай улсын иргэдтэй харилцаа холбоо тогтоох, харилцан мэдээлэл солилцох, видео чат хийх зэргээр иргэдийн хувийн мэдээллийг цуглуулах, мэдээллийг хууль бус үйл ажиллагаанд ашиглах гэмт хэрэг ихээр гарах болсон. Гэмт этгээдүүд нь ямар нэг байдлаар иргэдтэй харилцаа тогтоож улмаар видео чат хийх хүсэлтийг илгээдэг, үүний дараа чат хийж байгаа бичлэгийг хуулбарлан цахим хуудсанд байршуулж танил найз нөхөд, гэр бүлийнхэнд нь мэдээллийг тараана гэх зэргээр дарамталж бэлэн мөнгө өгөхийг шаарддаг.

Шинэ төрлийн кибер гэмт хэрэгт тооцогдох скимминг (skimming)-ийн тухайд АТМ буюу бэлэн мөнгөний автомат машинд суурилуулсан иргэдэд үл мэдэгдэх тусгайлан бэлтгэсэн төхөөрөмжийн туслалцаатай хэрэглэгчийн банкны гүйлгээний картын мэдээллийг хуулбарлан авах, гүйлгээний пин код оруулах хэсэгт бичил камер байрлуулах замаар бусдын дансанд хууль бусаар нэвтрэх гэмт үйлдэл гэж тодорхойлж болно.[43] Энэхүү гэмт үйлдэл нь дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад ихээр үйлдэгдэж байгаа бөгөөд манай улсад хоёр ч тохиолдол бүртгэгдсэн байдаг. Иймд хууль сахиулах салбарын болон,



42 ЦЕГ-ын Эрүүгийн Цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн мэдээллээс.

43 Л.Цогтбаяр нар. "Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс". УБ., 2015, 294 дэх тал.

банк санхүүгийн байгууллагуудын ажилтан, алба хаагчдыг мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна. Жишээ дурдвал, 2015 оны 8 сард БНХАУ-ын 4 иргэн гэрээт ажилчнаар манай улсад ирсэн бөгөөд манай улсын арилжааны банкнуудын АТМ буюу бэлэн мөнгөний машинд скимминг төхөөрөмжийг 3 хоногийн хугацаатай байрлуулж харилцагчдын мэдээллийг хууль бусаар хуулан авч өөрийн улсдаа гүйлгээ хийж 126,0 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэг үйлдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг буюу хуурамч карт ашиглаж арилжааны банкнуудаас бэлэн мөнгө хүүлэх гэмт хэрэгт гаршсан нилээд гэмт бүлэглэл байдаг талаар дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг. 2012 оноос манай улсад Украйн, Малайз улсын иргэд хуурамч виза карт ашиглан арилжааны банкнуудын АТМ буюу бэлэн мөнгөний машинаас их хэмжээний мөнгө авсан, авахыг завдсан хэргүүд удаа дараалан гарсан. Тухайлбал, Малайз улсын иргэд хуурамч төлбөрийн карт ашиглаж томоохон худалдааны төвүүдээс бараа бүтээгдэхүүн худалдаж авсан нь илэрсэн. Гэмт этгээдүүд ойролцоогоор 45 сая орчим төгрөгийн гүйлгээ хийсэн болохыг тогтоосон байдаг. Тэд Монгол төдийгүй бусад орны банкны картыг дуурайн хийдэг болох нь тодорхой болсон. Жишээлбэл, АНУ-ын "Чейз", "Ай Ти Эс" гэх мэт банкны харилцагчийн картын хар туузан дахь мэдээллийг хулгайлж Малайзад бэлтгэсэн картын бэлдэц дээр суулгадаг аж. Ингэснээр тухайн карт эзэмшигчийн мэдээлэл гэмт этгээдүүдийн гарт ордог байна.

Жишээлбэл, зарим иргэд интернет худалдаа, зарлалын цахим хуудсуудад тавигдсан автомашин, эд зүйлийг худалдан авахаар таньж мэдэхгүй, гадаад дотоодын хүнтэй интернетээр харилцаж залилагч этгээдийн санал болгосон "Вестерн Юнион" гэх хуурамч сайт руу нэвтэрч гүйлгээний мэдээллээ өгч, мөнгөө шилжүүлснээр залилан мэхлэх гэмт хэргийн хохирогч болжээ. Ийм байдлаар манай улсын 2 иргэн Дани улс руу 7500 ам.долларын гүйлгээ хийж залилагч нарт алдсан хэрэг гарсан байдаг. Мөн сүлжээний бизнес, гоо сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж бусдыг их хэмжээгээр хохироосон хэрэг сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь бусдын дансыг ашиглах, албан тушаалын (сүүлийн үед банк санхүүгийн салбарт) давуу байдлаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэж байна.

1. Цахим аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, үйл ажиллагааны чиглэл

Хүснэгт VII.8.1.

№	Байгуулагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	**Үндэсний аюулгүй байдлын зөвлөл**	- Мэдээллийн аюулгүй байдлын цогц бодлого боловсруулах
2	**Кибер аюулгүй байдлын газар**	- Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээн дэх кибер халдлага, аюул заналыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх; - Кибер аюулгүй байдлын талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах төрийн байгууллагуудад кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх; - Кибер аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах; - Төрийн байгууллагуудын нэгдсэн, төрийн тусгай холбооны болон ТЕГ-ын нууцлалтай холбооны сүлжээг зохион байгуулах, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, шинэчлэлтийг хариуцах; - Төрийн болон төрийн захиргааны байгууллагуудын хооронд төрийн нууц мэдээ, мэдээлэл дамжуулах, солилцох үеийн нууцлал аюулгүй байдлыг хангах;

3	**ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс**	- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25 дугаар бүлэгт заасан компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг шалгах; - Цахим орчинд үйлдэгдсэн бусад хэрэг;
4	**Харилцаа холбооны зохицуулах хороо**	- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хяналт шалгалт, мөрдөлт, гомдол маргаан шийдвэрлэх, байгууллагын веб сайтын менежмент; - Тусгай зөвшөөрөл, стандарт болон баталгаажуулалт, харилцан холболтын техникийн асуудлууд, дугаарлалт, техникийн нөхцөл шаардлага, технологийн шинэчлэл, нэгдэл болон интернет; - Радио давтамж төлөвлөлт, техникийн дүн шинжилгээ, радио давтамж хуваарилалт болон менежмент;
5	**Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар**	- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбоо, сансрын технологийн салбарт орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, - Монгол Улсад цахим засаг хөгжих орчинг бий болгох, энэ талаарх бодлого, стратеги, арга хэмжээг хэрэгжүүлэх, мэдээллийн найдвартай, аюулгүй байдлыг хангах;
6	**Үндэсний дата төв**	- Төрийн цахим дата, мэдээллийн технологийг зориулалтын нөхцөлд хадгалах, хамгаалах, хүртээмжтэй байлгах; - Төрийн цахим дата, мэдээлэл, өгөгдлийн сангуудын хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах;
7	**Монголын кибер довтолгоотой тэмцэх үндэсний төв (MonCIRT)**	- Кибер халдлагад хяналт тавьж, илрүүлэх
8	**Бусад**	

Дээрх байгууллагуудаас энэ төрлийн гэмт хэрэгтэй дагнан тэмцэх чиг үүрэг бүхий нэгж нь ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс бөгөөд түс хэлтэс нь цахим орчинд үйлдэгдсэн "Садар самууныг сурталчлах" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 123 дугаар зүйлийн 123.2), цахим орчинд үйлдэгдсэн "Иргэний захидал харилцааны нууц, халдашгүй байдлыг зөрчих" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 135 дугаар зүйлийн 135.2), цахим орчинд үйлдэгдсэн "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 140 дүгээр зүйл), "Компьютер, мэдээлэл, өөрчлөх, эвдэх, сүйтгэх" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 226 дугаар зүйлийн 226.2), "Компьютерын мэдээллийг хууль бусаар олж авах" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 227 дугаар зүйлийн 227.2), "Компьютерын мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, борлуулах" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 228 дугаар зүйл), "Нянтай програм зохион бүтээх, ашиглах" (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 229 дүгээр зүйл) гэмт хэргийг харьяалан шалгадаг байна.

ДҮГНЭЛТ

Цахим гэмт хэрэг нь тооцоолох төхөөрөмж болон сүлжээний арга хэрэгслийг ашигласан гэмт хэрэг үйлдсэн үйл ажиллагааг хэлж болох ч нарийн тодорхойлох шаардлагатай болон маргаантай асуудлуудыг ихээхэн дагуулдаг. Гэмт хэргийг үйлдэхдээ техник хангамж, програм хангамжийг ашиглах болсон нь уламжлалт гэмт хэргийг цахим гэмт хэрэг болгон өөрчлөхөд хүргэж байна. Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг, 226-229 дүгээр зүйлд компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 4 төрлийн гэмт хэргийг хамааруулж хуульчилсан нь цахим гэмт хэрэг гэсэн тодорхойлолтыг бүрэн илэрхийлж чадахгүй байна.

Монгол Улсын өнөөгийн байдлыг хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн цөөн, иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг муу, төрийн мэдээллийн нэгдсэн дотоод сүлжээ байхгүй, интернетэд олон

гарцаар замбараагүй холбогддог, албан ёсны эрхтэй үйлдлийн систем, хэрэглээний програм хангамж хэрэглэдэггүй зэргээр тодорхойлж болно. Манай улс үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бие даасан нэг төрөл гэж тусгайлан тодорхойлолт өгсөн хэдий ч өнөөг хүртэл мэдээллийн аюулгүй байдлын суурь хууль батлагдаагүй байна.

Өсвөр үеийг мэдээллийн технологийн хэрэглээнд сургадаг ч аюулгүй, зүй зохистой хэрэглээнд сургах, цахим орчинд учирч болох төрөл бүрийн аюул, заналхийллээс сэргийлэх мэдлэг, ойлголт хангалттай хэмжээнд өгдөггүйн улмаас тухайн гэмт хэргийн хохирогч болох магадлалыг нэмэгдүүлсээр байна. Тиймээс нийгэм даяараа аюулгүй, зохистой хэрэглээний туршлага, ойлголт сул, цахим гэмт хэргийн хохирогч болсон ч тийм зүйл байх л мэтээр хүлээн авдаг байдал төлөвшиж байна. Их, дээд сургуулиудад энэ талын мэргэжилтэн бэлтгэх тал дээр сул анхаардаг, бэлтгэж буй мэргэжилтнүүд нь ерөнхий чиглэлийн, орчин үеийн шаардлагаас хоцорсон байдалтай байна. Мэргэжилтнүүдийг цаашид мэргэшүүлэн бэлтгэх үндэсний бололцоо нөөцөө огт ашигладаггүй, хөрөнгө мөнгө хуваарилдаггүй, удирдлага дэмждэггүй зэрэг сул талыг нэрлэж болохоор байна.

Цагдаагийн алба хаагчдын цахим гэмт хэргийн талаарх, уг гэмт хэргийн шинжүүдийн талаарх мэдлэг ойлголт, цахим гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, мөрдөн шалгах, зүйлчлэх, хянан шалгах, хариуцлага оногдуулах талаар мэдлэг, чадвар маш хангалтгүй түвшинд байна. Цахим гэмт хэргийг илрүүлэхэд онцгой чухал ач холбогдолтой ажиллагаа болох хэргийн газрын үзлэг хийх, ул мөрийг илрүүлэх, бэхжүүлэх, тэдгээрийг задлан шинжлэх, нотлох баримт гаргаж авах чадварыг бий болгох нь онцгой чухал асуудал болоод байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ЯВДАЛ



9. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ЯВДАЛ

БХЖЭсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлд түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тооцохдоо:

1. Монгол орны байгаль орчны өнөөгийн төлөв байдал,
2. БХЖЭсрэг гэмт хэрэг түүний гаралт, хөдөлгөөн, бүтэц, өөрчлөлт,
3. Хууль эрх зүй
4. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага
5. БХЖЭсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар олон нийтийн сэтгэл зүй, хэвлэл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж тодорхойлов.

МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТОЙМ

Монгол Улс Ази тивийн төв хэсэгт өргөргийн дагуу сунаж тогтсон, уур амьсгалын хувьд сэрүүн бүсэд хамаарч, нутаг дэвсгэрийн газрын гадарга янз бүрийн хэлбэр дүрстэй өндөр уулс, ухаа гүвээ, цав толгод өргөн уудам тал, хөндий хосолсон ой тайга, хээр, говь цөл бүхий далайн түвшнээс дунджаар 1580м өргөгдөн тогтжээ.

Нийт газар нутгийн 11.2%-ийг ой, 77.4%-ийг хөдөө аж ахуй газар эзэлдэг, харьцангуй цөөн хүн амтай. Улс орны эдийн засгийн хөгжил нь байгалийн нөөцийн ашиглалтаас өргөн хамаарах онцлогтой. Байгалийн нөөц баялаг болон түүнийг түшиглэсэн салбарууд болох нүүдлийн мал аж ахуй, эрдэс түүхий эд, ой, ангийн олборлох анхан шатны боловсруулах үйлдвэрүүд эдийн засгийн хөгжлийн түшиг тулгуур бөгөөд цаашид энэ хэвээр байх төлөвтэй.

Улсын хэмжээнд байгаль орчны төлөв байдлыг товч авч үзэхэд ухагдаж эвдэрсэн нийт 10487.8 га талбай байна. Тэдгээр талбайн 11.0 сая га-д ашигт малтмалын 2736 зөвшөөрөл олгогдсон нь нийт нутгийн 7.0 хувийг эзэлж байна. Үүнээс 1079.9 га нь ашиглалтын 1391 зөвшөөрөлтэй, 9.9 сая га нь хайгуулын 1345 зөвшөөрөлтэй байна.

Уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагааны улмаас 24636.8 га талбай эвдрэлд орж, 10263.1 га талбайд техникийн, 6781.5 га талбайд биологийн нийт 19895.1 га талбайд нөхөн сэргээлт хийжээ. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжсэн үеэс эхлэн жил тухайн газарт ашигт малтмал хайх, ашиглах явдал буурч байгаа сайн талтай.

Усны тухай хуулиар 4 жил тутамд нэг удаа гадаргын усны тооллого явуулах заалтын дагуу 2014 онд 10809 булаг, шанд тоологдсоноос 9718 устай, 5800 гол, горхи үүнээс 5413 устай, 4545 нуураас 4023 нуур устай бөгөөд нуурын усны түвшин жил бүр зохих хэмжээгээр багасаж байна. Усны хэрэглээний 85%-ийг газрын доорх усаар хангаж байгаа нь гадаргын уснаас 21 дахин илүү байна.

БХЖЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СТАТИСТИК СУДАЛГАА (2016 ОН)

БХЖЭсрэг гэмт хэргийн нөхцөл байдлыг статистик мэдээнд тулгуурлан гэмт хэргийн бүтэц, хөдөлгөөн, тархалт, хор аюулын шинж чанар, дахин давтан ба бүлэг гэмт хэрэг, гэмт хэргийн илрүүлэлтийн (нуугдмал гэмт хэргийн) түвшин зэргээр задлан шинжлэв.[44]

БХЖЭсрэг гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль хамгаалах түүнийг зүй зохистой ашиглах, элдэв халдлагаас хамгаалах зорилгоор төрөөс газар, түүний хөрс, газрын хэвлий түүний баялаг, ус ургамал, амьтан агаарт халдаж хор уршиг учруулдаг,

44 Аливаа үзэгдэлд задлан шинжилгээ хийхдээ заавал түүний тухай бүх мэдээллийг авах явдалгүй, хамгийн чухал нь тэдний мөн чанарыг танин мэдэх илүү ур нөлөө бүхий арга замыг олох нь чухал гэж үздэг. А.Г.Аванесов. Криминология и социальная профилактика М., 1980. 166 дахь тал

учруулах боломжтой, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн цогц бүрдэл юм.

Эрүүгийн хуульд (2002, 2008 оны) заасан байгаль орчинд халдсан 17 зүйлийн гэмт үйлдлийг зөрчигдөж буй объектоор нь:

а/ Байгаль орчны үндсэн объект болох газар, ус, агаар хамгаалах журамд халдсан гэмт хэрэг[45],

б/ Амьтан, ургамлын аймгийг хамгаалах журамд халдсан гэмт хэрэг[46] гэж хуваан үзнэ.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 14 жилийн хугацаанд БХЖЭсрэг гэмт хэрэг нийт **2632**, жилд дунджаар **188** бүртгэгджээ.

ГЭМТ ХЭРГИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА (2016 ОН)

График VII.9.2. БХЖЭсрэг гэмт хэргийн эзлэх хувь





График VII.9.3. БХЖЭсрэг гэмт хэргийн гаралт (Ангиллаар)



45 Эрүүгийн хуулийн 202-р зүйл. Агаар бохирдуулах
Эрүүгийн хуулийн -ийн 204-р зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих
Эрүүгийн хуулийн 205-р зүйл. Байгаль орчныг бохирдуулах
Эрүүгийн хуулийн 207-р зүйл. Газрын хөрс, усыг бохирдуулах
Эрүүгийн хуулийн 208-р зүйл. Усны хууль тогтоомж зөрчих
Эрүүгийн хуулийн 210-р зүйл. Байгалийн объектыг санаатай эвдэх гэмтээх,устгах
Эрүүгийн хуулийн 214-р зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох
Эрүүгийн хуулийн 2141-р зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих
Эрүүгийн хуулийн 304-р зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах
46 Эрүүгийн хуулийн 84-р зүйл. Хорлон сүйтгэх
Эрүүгийн хуулийн 175-р зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх
Эрүүгийн хуулийн 203-р зүйл. Ан агнуурын хууль тогтоомж зөрчих
Эрүүгийн хуулийн 206-р зүйл. Химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, бүрдүүлэх журам зөрчих
Эрүүгийн хуулийн 209-р зүйл. Ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчих
Эрүүгийн хуулийн 211-р зүйл. Ойн тухай хууль тогтоомж зөрчих
Эрүүгийн хуулийн 212-р зүйл. Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих
Эрүүгийн хуулийн 213-р зүйл. Ой, хээрийн түймэр тавих

Улсын хэмжээнд 2016 онд Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн гэмт хэрэг 165 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэрэг 0.6%-ийг эзэлж байна.

БХЖЭсрэг 165 гэмт хэргийн зүйл тус бүрийн гаралт, эзлэх хувийг авч үзвэл: 203-р зүйлийн гэмт хэрэг 30 буюу 18.2%, 204, 207-р зүйлийн гэмт хэрэг тус бүр 1 буюу 0.6%, 211-р дугаар зүйлийн гэмт хэрэг 72 буюу 43.6%, 213-р зүйлийн гэмт хэрэг 9 буюу 5.5%, 214-р зүйлийн гэмт хэрэг 35 буюу 21.2%, 214[1]-р зүйлийн гэмт хэрэг 7 буюу 4.2%-ийг эзэлж байна.

БХЖЭсрэг гэмт хэргийн 86.7% нь орон нутагт, үүнээс 13.3% нь баруун, 21.8% нь хангайн, 45.5% нь төвийн, 10.3% нь зүүн бүс нутагт үйлдэгдсэн байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ (2016 он, бүс нутгаар)

Зураг VII.9.1. БХЖЭсрэг гэмт хэргийн гаралт (Бүс нутгаар)



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ЭРСДЭЛИЙН ЭРЭМБЭ (аймаг, орон нутгаар)


ЗурагVII.9.2. БХЖЭсрэг гэмт хэргийн гаралт (Аймгаар)



Зураг VII.9.3. БХЖЭсрэг гэмт хэргийн гаралт (Дүүргээр)



График VII.9.4. БХЖЭсрэг гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын хэмжээ (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)



Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2016 онд 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.7 тэрбум буюу 55.1%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ҮҮССЭН ХОХИРОЛ, ҮҮНЭЭС НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙДАЛ (САЯ ТӨГРӨГӨӨР)

График VII.9.5. БХЖЭсрэг гэмт хэргээс үүссэн хохирлын хэмжээ (Эрүүгийн хуулийн зүйл ангиар, сая төгрөгөөр)



Улсын хэмжээнд 2016 онд 14 аймгийн 61 суманд 138 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч 31.3 мянган га ой, 3.2 сая га хээр, нийт 3.2 сая га талбай түймэрт өртсөн байна. Гарсан түймрийг аймгуудаар нь авч үзвэл:

График VII.9.1. 2016 онд гал түймрийн мэдээлэл (аймгаар).



Түймрийн улмаас (урьдчилсан байдлаар) байгаль, экологид 10.7 тэрбум төгрөг, эд материалд 1.3 тэрбум төгрөг, унтраахад 100.1 сая төгрөгийн зардал гарсан.

Ой, хээрийн гал түймрийн тоо, хохирлыг 2015 онтой харьцуулахад гал түймрийн тоо 2.5 дахин, нийт хохирол 5.8 дахин буурсан боловч нас барсан хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

ГЭМТ ХЭРГИЙН ХАЛДЛАГЫН ЗҮЙЛ

Хууль бусаар агнуурт өртөгдсөн амьтны тоо

Хүснэгт VII.9.1. Гэмт хэргийн халдлагын зүйл

Амьтан:		Ургамал:
Алтайн хойлог	3	Мод
Янгир	5	Цагаан гоёо
Аргаль	2	Дэрэвгэр жиргэрүү
Хулан	9	Самар
Бор гөрөөс	1	Ашигт малтмал
Ирвэс	1	Алт
Хар сүүлт	3	Нүүрс
Хүдэр	1	Хайрга
Баавгай	3	Боржин чулуу
Халиун буга	6	Бохирдуулагч
Бөхөн	7	Борын хүчил
Хандгай	1	Мөнгөн ус
Тул	1	Химийн бодис

Гэмт хэрэгт **210** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 11.9% нь 45-49 насны, 10.0% нь 50-54 насны, 1.9% нь 55-59 насны, 1.9% нь 60-64 насны, 1.4% нь 65 ба түүнээс дээш насны,
- 26.6% нь ажилчин, 24.3% нь малчин, 48.6% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 37.1% нь бүлэглэн гүйцэтгэсэн, 1.9% нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛДЭГСДИЙН НАСНЫ АНГИЛАЛ

График VII.9.6. БХЖЭГХэргийн сэжигтэн, яллагдагчийн насны ангилал (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)




График VII.9.7. БХЖЭГХэргийн сэжигтэн, яллагдагчийн хүйсийн ангилал (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)





График VII.9. 8. БХЖЭГХэргийн сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн байдлаар



ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛДЭГСДИЙН НИЙГМИЙН БАЙДАЛ

График VII.9.9. БХЖЭГХэргийн сэжигтэн, яллагдагчийн ажил эрхлэлт (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)





График VII.9.10. БХЖЭГХэргийн сэжигтэн, яллагдагчийн боловсрол (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)



ГЭМТ ХЭРГИЙН НУУГДМАЛ ШИНЖИЙН ТАЛААР

Бодитойгоор үйлдэгдсэн гэмт үзэгдэл, гэмт хэргийн гаралтыг үнэлэхдээ нуугдмал гэмт үзэгдлийн түвшинг зайлшгүй харгалзах шаардлагатай болдог.

Манай улсад нуугдмал гэмт хэргийн гаралтыг хэмжих бодитой, шалгарсан аргачлал одоо хүртэл байхгүй байгаа ч гэсэн нуугдмал гэмт хэргийн гаралтын түвшинг судалгааны хэд хэдэн аргуудыг ашиглаж тогтоох нь онол-практикийн чухал ач холбогдолтой. Тодорхой төрлийн гэмт хэргийг задлан шинжилж, судлахад заавал түүний тухай бүх мэдээллийг авах бус хамгийн чухал нь тэдний мөн чанарыг танин мэдэх үр нөлөө бүхий арга замыг олох нь чухал.

БХЖЭсрэг гэмт хэрэг нь хөдөө хээрт, зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин худалдаалах, тээвэрлэх, хадгалах, ашиглах үйлдэл нь зөвхөн худалдагч, худалдан авагч нарын дунд далд хэлбэртэй явагддаг зэргээрээ нуугдмал шинжтэй, нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг юм.

Уг гэмт хэргийн гаралтыг үнэлэхдээ нуугдмал түвшинг тогтоох47 нь чухал бөгөөд тухай

47 Гэмт хэргийн нуугдмал байдлын түвшинг тогтоох нь хялбархан хийгдэх ажил биш юм. Түүнийг тодорхойлохын тулд судалгааны янз бүрийн аргыг хэрэглэх ёстой. Оросын эрдэмтэн В.В Панкратов нуугдмал гэмт явдлын асуудлыг шийдвэрлэхэд хамгийн тохиромжтой арга бол тойруу судалгааны арга юм. Асуулга явуулах, нийгэм-эдийн засгийн байдлыг задлан шинжлэх, хууль хяналтын байгууллагын бусад мэдээ баримтад дүн шинжилгээ хийх нь тойруу судалгааны аргын бүрэлдэхүүн элемент болохыг тодорхойлжээ. Орчин үед статистикийн математик аргын тусламжтайгаар нуугдмал гэмт хэрэгт судалгаа хийж байна.

гэмт хэргийн нуугдмал шинж нь гэмт хэргийн статистикаас гадна хүрээлэн буй орчны доройтлоос тодорхой харагдана.

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 23 ДУГААР БҮЛГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ, ҮЙЛДЛИЙН АРГА, ҮЙЛДЭГДСЭН ЦАГ ХУГАЦААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

БХЖЭсрэг гэмт хэргийн илрүүлэлтийн тухайд улсын хэмжээнд бүртгэгдсэн хэргээс бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг 48 бүртгэгдсэнээс 41 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдсон ба гэмт хэргийн илрүүлэлт 85.4%-тай байна.

Ихэнх гэмт хэргийн суурь нөхцөл болсон архидан согтуурах явдал нь уг гэмт хэргийн гаралтад нөлөөтэй биш байгаа нь эрүүл саруул ухаанаар уг гэмт хэргийг үйлдэж байгааг илтгэнэ.

График VII.9.11. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



- 20.2% нь 06-14 цагт, 36.1% нь 14-19 цагт, 15.8% нь 19-22 цагт, 27.9% нь 22-06 цагт,

График VII.9.12. Гэмт хэрэг үйлдсэн цаг



Доктор Ц.Цэлмэг Байгаль орчны эсрэг эвэрчил 1 жилд 15000 орчим бүртгэгдэж байгаагийн 20 орчим хувь нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байхад эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр захиргааны хариуцлага тооцсон, гааль дээр хураагдсан их хэмжээний амьтны эд эрхтний тоо зэргээс байгаль хамгаалах журмын эсрэг нэг гэмт хэргийн цаана 50 орчим гэмт хэрэг нуугдмал байна гэж дүгнэсэн нь эвэхэн хоёрхон шалгууруар тооцож гаргасан тул учир дутагдалтай юм.

АНУ-ын болон Барууны орны хуульч эрдэмтэд нэг илэрсэн гэмт хэргийн ард 3-10 нуугдмал хэрэг байдаг гэж үздэг. М.Эрдэнэбаяр. Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн байцаах, урьдчилан сэргийлэх онол, арга зүйн асуудал. Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан диссертаци. УБ., 2015.

- Даваа гараг 28, мягмар гараг 25, лхагва гараг 26, пүрэв гараг 24, баасан гараг 25, бямба гараг 27, ням гараг 28 хэрэг тус тус үйлдэгджээ.

График VII.9.13. Гэмт хэрэг үйлдсэн гараг



Дээрх байдлаас ан агнахад тодорхой өдрийг сонгодоггүй, харин орой, шөнийн цагт уг гэмт хэрэг үйлдэгддэг гэсэн ерөнхий дүгнэлт хийж болно.

Гэмт хэргийг илрүүлэлтийг цагдаагийн байгууллагын алба хаагчдаар нь авч үзвэл:

- 76.1%-ийг мөрдөн байцаагч,
- 47.5%-ийг эрүүгийн цагдаагийн алба хаагчид үүнээс 3.8%-ийг хэсгийн төлөөлөгч илрүүлжээ.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хэмжээнд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамгийн их хууль тогтоомж, эрх зүйн акт, гэрээ конвенц хэрэгжиж байна. Тухайлбал, байгаль орчны салбарт 30 гаруй хууль, 200 гаруй эрх зүйн акт, 14 олон улсын конвенц, олон улстай 60 гаруй гэрээ хэлэлцээр хийжээ.

Засгийн газар 2012 оноос эхлэн байгаль орчны багц хуулиудыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, 30 гаруй хуулийн 500 гаруй давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, ижил төстэй 18 хуулийг 8 болгон нэгтгэж, 2 хуулийг шинээр боловсруулан батлуулжээ.

Багц хуульд байгалийн нөөцийг хомстуулсан орон нутаг хариуцсан Засаг даргад хариуцлага тооцох, бохирдуулагч нь төлбөр төлөгч байх, ашиглагч нь хамгаалагч байхаар зохицуулсан нь зарчмын цоо шинэ, томоохон өөрчлөлт юм.

Байгаль орчныг хамгаалах багц хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ хязгаараар авч үзвэл эрх зүйн орчин хангалттай сайн бүрдсэн хэдий ч зарим хуульд нэмэлт өөрчлөлт, шинэчлэн боловсруулах зэрэг ажил тасралтгүй хийгдэж байна.

Гэвч тэдгээр хуульд давхардал, хийдэл, зарим зохицуулах ёстой харилцааг орхигдуулсан зэрэг дутагдал оршсон хэвээр байна.

Тухайлбал:

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 19.1.8 зүйл.

Химийн хорт болон аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулж, зөрчил гаргасан иргэнийг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

Эрүүгийн хуулийн 214[1] дүгээр зүйл.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн 214[1].1. Химийн хорт болон аюултай бодисыг зөвшөөрөлгүйгээр экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, ашиглах болон бусдад дамжуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Химийн хорт болон аюултай бодистой холбогдсон үйл ажиллагаанд экспортлох, импортлох, үйлдвэрлэх, хадгалах, ашиглах гээд олон үйлдэл байдаг тул зөрчил гаргасан хүнд хуулийн аль заалтыг хэрэглэх нь тодорхойгүй байгаа нь гэмт хэргийг зөрчил болгон шийдвэрлэх боломжтой олон зүйл заалт байна.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа зарим хөтөлбөр, тогтоол шийдвэр нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн нэг болж байдаг. Засгийн газраас 1992, 2000 онуудад "Алт хөтөлбөр"-ийг баталж хэрэгжүүлсний сөрөг зүйл нь байгаль орчин руу "нинжа" хэмээх дүрэм журамгүй, бүлэг хүмүүс зохион байгуулалтад орж олон мянган га газар эвдэж сүйтгэсэн. Одоо Хөгжлийн бодлогын тухай хуулийн нэрээр Засгийн газар "Алт-2" хөтөлбөрийн төслийг батлуулах бэлтгэл ажил явагдаж байгаа нь бас л сөрөг нөлөөллийг бий болгох магадлалтай

БХЖЭсрэг гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг тогтоох нь тун төвөгтэй нарийн ажиллагаа бөгөөд хохирлын хэмжээг гүйцэд тогтоох аргачлал одоо хир бүрэн гараагүй байна.

Тухайлбал, газрын экологи эдийн засгийн үнэлгээ, хөрс, усны бохирдлын экологи эдийн засгийн үнэлгээг тодорхойлох, ургамлын нөмрөгийн экологи эдийн засгийн үнэлгээ, ашигт малтмалыг олборлох, боловсруулах явцад үүсэх экологийн хохирлыг тогтоох асуудал анхаарал татсан хэвээр байна. УДШ-ийн 2008 оны 30-р тогтоолд *"Эрүүгийн хуулийн 23-р бүлэгт заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирол болон бусдын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцэл, байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлын нийлбэрээр тооцож тогтооно"* гэж заасан нь байгаль орчны хохирлыг зөвхөн шууд хохирол бус олон хохирлын нийлбэрээр[48] тогтооно гэж тодорхой заасан бөгөөд ийм нийлбэрээр хохирлыг огт тооцохгүй зэрэг олон хийдэл, цоорхой байгаа нь үр нөлөөтэй хариуцлагын тогтолцоо, хамгаалалт болж чадахгүй байна.

Хууль тогтоомжийн нөөц шавхагдах эсвэл хомс байх нь гэмт хэргийн гаралтад нөлөөлөх хүчин зүйлийн нэг мөн. Олон улсад байгаль орчны гэмт хэргийг өргөн утгаар нь авч үзэж хууль тогтоомждоо тусгаж байна.

Тухайлбал, Интерполын Ерөнхий Ассамблей[49] 2014 онд байгаль орчны гэмт хэрэг гэдэг ойлголтыг тодорхойлохын оронд **"байгаль орчны аюулгүй байдал"** гэдэг зүйлд анхаарал хандуулан байгаль орчны гэмт хэрэг хэрхэн улс үндэстний үйлдвэрийн тогтвортой байдал, байгаль орчны чанар, байгалийн нөөц, биологийн төрөл зүйл, эдийн засаг болон хүний амьдралд нөлөөлдөг болохыг чухалчилж хууль тогтоомждоо цогц байдлаар өөрчлөлт оруулж эхэлсэн. Энэ нь байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин аюулгүй байдлыг хангахад шууд чиглэгдэж эхэлснээр нэг мод устсанаар аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх вэ? гэсэн өргөн асуудлаар хандаж эхлээд байна.

48 Европын холбооны улсуудад "хохирол" гэдгийг байгалийн нөөцөд гарсан хэмжиж болохуйц сөрөг өөрчлөлт, эсвэл шууд ба шууд бус байдлаар үүсэж болох байгалийн нөөцийн үйлчилгээний хэмжиж болохуйц доройтол гэсэн утгаар нь авч үздэг. Ашигт малтмал олборлох, боловсруулахад үүсэх хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, экологийн хохирлыг тооцох аргачлал. УБ., 2008

49 Байгаль орчны аюулгүй байдалд халтай аюултай тэмцэх Интерполын хариу арга хэмжээ (AG-2014-RES-03) (2014 оны 8 дугаар сард батлсан 3 дахь тогтоол)

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Байгаль орчныг хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах эрх зүйн орчноос гадна байгаль орчныг хамгаалах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих 700 шахам ТББ-ыг нэгтгэсэн хүчирхэг "Монголын байгаль орчны иргэний зөвлөл" 2008 оноос хойш ажиллаж байна.

Түүнээс гадна улсын хэмжээнд нийт 162950 нутгийн иргэдийн нөхөрлөлд 16994 айлын 41295 гишүүн хамрагдаж, 8.2 сая га талбайг хариуцан хамгаалж байна. Дээрх нөхөрлөлд нийт 1148 нь идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байгаа нь байгаль орчны олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гэвч зарим нөхөрлөлөөс тухайн орон нутагт байнга нутагладаггүй төв, суурин газрын иргэд, нийслэл хотод амьдардаг хүмүүс орон нутагт нөхөрлөл байгуулж ашиг хонжоо хайх, өөрсдөө хууль бус зарим ажиллагаа явуулах зэрэг сөрөг үйлдэл цөөнгүй гарч байна.

Жишээ:

Төв аймгийн Заамар сумын 3-р багт үйл ажиллагаа явуулдаг "нутгийн буян" нөхөрлөлийн ахлагч Г нь засаг дарга Б-тэй хамтран бичил уурхай ашиглах журам зөрчсөн, тус суманд иргэн Э нь тусгай хэрэгцээний газруудад нөхөрлөл байгуулан ажиллахдаа хууль бусаар алт олборлосон[51]

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн52 байгууллагын үр дүн бодитой нүдэнд харагдахгүй байгаа нь жил ирэх тусам доройтож байгаа байгаль орчны төлөв байдлаас шууд харж болно.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА

Цагдаагийн байгууллага:

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор төрийн болон ТББ-тай хамтран эргүүл шалгалт, хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээ зохион явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа, нэвтрүүлэг бэлтгэн зохион явуулж ирсэн.

Жишээ:

УБХЦГ-аас БХЖЭсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний хүрээнд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд 06 дугаар сарын 07-ний өдрийг хүртэлх хугацаанд давхардсан тоогоор эргүүл, хяналт шалгалтаар 181 байнгын постод 720 цагдаагийн алба хаагч, онцгой байдлын 190 алба хаагчтай хамтран 190 автомашинтайгаа үүрэг гүйцэтгэж 696 ААН, байгууллага, 6050 иргэн, 85 нөхөрлөл, 2350 тээврийн хэрэгслийг тус тус шалган, 63 зөрчил илрүүлж, 157 иргэнийг 1,255,000 мянган төгрөгөөр торгож, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар 137 албан мэдэгдэл өгч, 71 хариуг авч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 9 удаа санамж, сэрэмжлүүлэг өгч ажилласан.

Жишээ:

Архангай аймгийн ЗДТГ, МХГ, БОАЖГ, ОБГ, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэстэй хамтарсан хяналт шалгалтыг 2016 оны 05 дугаар сараас нийт 6 удаа алт олборлож байгаа ААН-д зохион байгуулж хууль бус үйлдлийг таслан зогсоон удаа дараалан тавьсан боловч

50 Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн судалгаанаас үзэхэд усыг хамгаалах чиглэлээр 51, ан амьтныг хамгаалах чиглэлээр-100 орчим, байгалийн ургамал хамгаалах чиглэлээр-32, бэлчээр хамгаалах чиглэлээр-126, аялал жуулчлалын чиглэлээр-2, нийт 411 байгалийн чиглэлээр ажиллаж байна.

51 Эрүүгийн 201619000533 дугаар хэрэг. ЦЕГ-ын гэмт хэргийн дэлгэрэнгүй судалгаа.

52 Засгийн газар болон цэрэг, цагдаагийн байгууллагуудад хамааралгүй бусад бүх оролцогсдыг иргэний нийгэмлэг гэдэг бөгөөд тэдгээр нь шийдвэр гаргах процессод нөлөөлдөг. Зарим улсад гэмт бүлгэмүүд хүртэл хот суурин газар, үндэсний хэмжээний бодлого гаргахад хүчтэй нөлөөлж чаддаг байна.

лацыг дур мэдэн хөдөлгөж үйл ажиллагаа явуулсан гэх үйлдэлд мэргэжлийн хяналтын байцаагч акт тогтоон 4 ААН, 1 иргэнд нийт 22 сая 850 мянган төгрөгийн торгууль тавьж,сумдын ЗДТГ, Ойн нөхөрлөл, сумдын ойн мэргэжлийн байгууллагуудтай хамтран энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 удаа 1550 иргэнд мэдээлэл сурталчилгаа хийж санамж сэрэмжлүүлэг тараасан.

Сэлэнгэ аймаг "Бодис-2016", "Хяналт-Шалгалт-2016","Хүдэр-2016" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг мөн оны 05 дугаар сарын 25-аас 28-ны өдрийг хүртэлх хугацаанд цагдаагийн 24 алба хаагчын бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, Хүдэр сумын нутаг "Монгол алт", "Нуурын тагт", "Амж" гэх газарт хууль бусаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан 20 тээврийн хэрэгсэл, 24 Монгол гэр, 6 отог оромжтой 90-100 орчим иргэнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга яриа хийж, хууль бусаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан талбайг бүрэн чөлөөлжээ.

Гэвч дээрх ажил, арга хэмжээ нь түр зуурын цаг үеийн шинжтэй зохиогддог учраас цагдаагийн байгууллага нь энэ төрлийн гэмт хэрэгтэй зөвхөн "гал унтраах" буюу асуудлыг намжаах хэлбэрээр л үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна гэж үзэх үндэстэй. Асуудалд өнгөц хандах, намжаах хэлбэрээр хандах нь "өвчнийг" архагшуулах аюултай байдаг.

Мэргэжлийн хяналтын байгууллага:

МХЕГ-ын Байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын газар түүний удирдлагад нийслэл, 21 аймаг, 332 сум, тосгонд нийт 336 байцаагч, орон тооны бус байгаль орчны байцаагч 224 ажиллажээ. Тус байгууллага 2016 онд байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр 1828 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөж түүнээс 1648 объектод хяналт шалгалт хийж, төлөвлөгөөт бус 12 хяналт шалгалт хийгдсэн байна.

Улсын хэмжээнд байгаль орчин, геологи уул уурхайн хяналтаар илэрсэн зөрчилд 260 акт тавьж, **82681** заалт бүхий 10517 албан шаардлага хүргүүлснээс 26660 заалт бүхий 6218 албан шаардлага биелэгдсэн, 46021 заалт бүхий 3782 албан шаардлага хугацаа болоогүй байна. Үүнээс үйл ажиллагааг бүр зогсоосон 8, түр зогсоосон 204, сэргээсэн 24, устгасан 7, хураасан 17, нөхөн төлбөр тогтоосон 21 акт үйлдэж, 257 ААН, байгууллагад 198,941,840 төгрөгийн торгууль, 68,814,255 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулан 70,8% нь төлөгдсөн байна. Хяналт шалгалтад 2374 иргэн, 1841 ААН, байгууллага, 22 салбар нэгж хамрагджээ. Судалгааг явуулах үед байгаль орчны зөрчлийн нэгдсэн мэдээ мэргэжлийн хяналтын газраас гардаггүй нь зөрчлийн бүтэц, гаралтад дүн шинжилгээ хийж боломжгүй байна. Судалгаанд зориулж мэдээлэл авахад хүндрэл бэрхшээл ихтэй байгаа нь ажиглагдлаа.

Илэрсэн зөрчилд 260 акт тавьж, **82681** заалт бүхий **10517** шаардлага нь байгаль орчны эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн **165** гэмт хэрэгтэй харьцуулахад энэ төрлийн гэмт хэргийн нуугдмал түвшин их байгааг харуулах баримт гэж үзлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын 30 захиргаанд нийт 613 алба хаагч 6,4 тэрбум төгрөгийн төсөвтэй хамгаалалтын үйл ажиллагаа явуулж байна. Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтэрсэн аялагчид өмнөх оныхоос 33,5 хувь өсжээ. Тусгай хамгаалалттай газар нутагт 2015 оны байдлаар 834 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Нийслэл орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамгаалалтын дэглэмийг сахих талаар авч хэрэгжүүлж байгаа ажилд үр дүн гарахгүй байна.

БХЖЭсрэг гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ

ЦЕГ-ын гэмт хэргийн дэлгэрэнгүй судалгаа, Монгол Улсын шүүхийн цахим сан (www.shuukh.mn)-аас эрүүгийн хэрэгт судалгаа явуулахад хууль бусаар буюу зохих

зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнасан, ойд мод бэлтгэсэн, ашигт малтмал олборлосон, химийн хорт бодис ашигласан, болгоомжгүй байдлаас гал алдаж, хээрийн түймэр тавьсан зэрэг үйлдлүүд ихэнх хувийг эзэлж байна. Ялангуяа ашигт малтмал олборлох хэрэгт төрийн алба хаагч нар ААН, компанийн эзэдтэй хуйвалдах, тусгай хамгаалалттай газарт хууль бус үйлдэл хийсэн хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Жишээ:

Төв аймгийн Заамар суманд "Сүлд Майнинг Ресурс" ХХК-ийн захирал, сумын засаг даргатай хамтран хууль бусаар ашигт малтмал олборлосон, "Мон дулаан трейд" ХХК нь MY000211 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн хууль бус 4.5 га газарт олборлолт явуулж, 614.936.028 төгрөгийн хохирол учруулсан.

Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт "Дун Юань" ХХК химийн бодис зохих зөвшөөрөлгүй ашигласан.

Баянхонгор аймгийн Өлзийт суманд иргэн Г, Б нар нь нөхөн сэргээлт явуулах нэрийдлээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан.

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Наран багийн нутагт иргэн Г нь 9,8 кг цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёог түүж бэлтгэсэн.

Дорнод, Сүхбаатар аймагт автомашины доод эд ангиудад хуримтлагдсан өвс шатсан, гагнуурын оч үсэрч түймэр тавьсан зэрэг хэрэг үйлдэгдсэн байна.

БХЖЭсрэг гэмт хэргийн шалгаан нь иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, амьтан ургамлын эд эрхтнийг хэрэглэвэл бие эрүүл болно гэсэн сэтгэлгээ, ой хээрийн түймрийг санамсар болгоомжгүй хэлбэрээр үйлдэж байгаа ч гэсэн хувь хүний хариуцлага, хэт салан задгай хэнэггүй байдал түүнээс үүсэх хор уршгийг төдийлөн ухамсарладаггүй зэрэг нь гэмт хэргийн нөхцөл болж байна. Байгалийн баялгийг ашиглахад заавал зөвшөөрөл авдаг учраас түүнийг олгодог, хянадаг төрийн байгууллагын үйл ажиллагаа зохих ёсоор явагддаггүй, төрийн алба хаагчдын албандаа хандах хандлага нь хувийн эрх ашгийг нэгдүгээрт тавьж, авлига хээл хахуульд өртөмтгий, өөрөөр хэлбэл засаглал муу байгаатай холбоотой.

БХЖЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ ТОГТООХЫН ТУЛД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН БУСАД СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ[53]

Энэ төрлийн гэмт хэргийн 15% орчим хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд ашигт малтмалын хайгуул, олборлолт, ашиглалт хийж байгаа 2000 гаруй ААН, байгууллага, хувараа алт олборлож байгаа 90.000 орчим иргэнтэй харьцуулахад энэ гэмт хэргийн нуугдмал хэв шинж байх магадлал өндөр байна.

Дээрх нуугдмал байдал нь субъектээс хамааралтай буюу нэг хэсэг нь хөрөнгө мөнгөтэй алтны компаниуд *(хайгуулын лицензээр ашигт малтмал ашигладаг, мөн нөхөн сэргээлтийг зөвхөн хэлбэрийн төдий буюу цаасан дээр хийдэг, үүнийг нь хянадаг шалгадаг байгууллагууд нь хараагүй мэт нуудаг, авилгал хээл хахуультай холбоотой)* нөгөө хэсэг нь хэт эмзэг давхаргынхан *(судалгаанаас харахад хувараа алт олборлогчдын 70 хувь нь ажилгүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд)* үйлдэж байгаа явдал бөгөөд хуулийн хэрэгжилт, хариуцлага сул, тэдгээр иргэд рүү хандсан урьдчилан

53 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн шинжилгээг зөвхөн төрийн байгууллагад цугларсан тоо мэдээ төдийгөөр бус судалгааны бусад арга болох олон нийтийн санаа бодлыг сонсох фокус ярилцлага, социологийн судалгаа, хэвлэл мэдээлэл, баримтад дүн шинжилгээ хийх зэрэг өргөн хүрээтэй явуулах нь үр дүнтэй. Дээрх олон талын шинжилгээ нь зарим талаараа бэрхшээлтэй боловч практикийн хувьд зайлшгүй хэрэгцээтэй юм.

сэргийлэлт муу олон хүн цугласан тохиолдолд бөөгнөрсөн хүчийг тараах, захиргааны шинжтэй арга хэмжээнээс өөрөөр ажил зохиогдохгүй байна.

Жишээ:

Өмнөговь аймгийн Сэврэй сумын "Нурууны ар" гэдэг газарт хууль бусаар алт олборлосон 201616000188 хэрэгт хохирогч мэдүүлэхдээ "07.18 байгаль хамгаалагч болон сумын цагдаагийн хүмүүс 7 хоног үүрэг гүйцэтгэсэн. Харамсалтай нь санхүүгийн байдлаас болж байнгын харуул хамгаалалт гаргах боломжгүй болсон.

Шүүгдэгчийн мэдүүлэгт "7.15-нд "Нурууны ар" гэдэг газарт очиход хөндий дүүрэн хүн, машин байсан."

Дээрх жишээнээс үзэхэд төрийн байгууллагын ажилтан алба хаагчийн хариуцсан талбайн хэмжээ их, төсөв хөрөнгө дутагдалтайн улмаас хяналт зохих ёсоор тавьж чадахгүй байгаа нь энэ гэмт хэрэг үйлдэгдэх нэг нөхцөл болж байна.

Жишээ:

БХЖЭсрэг гэмт хэрэгтэй газар дээр нь тэмцэгч бол байгаль хамгаалагч. Тэд ажиллагаа муутай ганц цахилгаан бороохой, бас хуурамч дуу хураагуур, гандсан, томдсон дүрэмт хувцас өмсөж, номхон морь унаад, хурдан буу, хөрөөгөөр бүрэн зэвсэглэж, машин, усан завь хөлөглөсөн хууль зөрчигчидтэй тэмцэж байгаа нь үнэхээр хүч тэнцвэргүй тулаан мэт санагдаж байсан.

Сумын цагдаагийн байгууллагатайгаа хамтарч ажилладаг, байгаль хамгаалагчдын хамгийн сайн "туслагч" тэд байдаг. Гэхдээ тэднийг дээрээс дарамталж зарим зөрчлийг даруулах тохиолдол байдаг".[54]

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллага нь цагдаагийн байгууллагын ажилтантай хамтран ажиллах нь тэдэнд амар хялбар байж, тэдний нэр сүрээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь хяналт шалгалтын байгууллага хүчгүйн байгааг илтгэхийн зэрэгцээ, тэднийг "дээрээс" буюу элдэв нөлөөлөлд автах эрсдэлтэй байдал нь гэмт хэрэгтэй тэмцэхэд зохих хэмжээгээр нөлөөлж байна.

ДҮГНЭЛТ

Дээрх судалгаа, баримтад дүн шинжилгээ хийхэд Монгол орны байгаль экологийн төлөв байдал нь цаг уурын өөрчлөлт, дулаарал хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалан өмнөх байдлаасаа хурдацтайгаар өөрчлөгдөж ширүүхэн хэлбэл "нутаг дэвсгэрийн тал хувь нь сүйдсэн"[55] байна.

Байгалийн нөөц баялгийн хууль бус ашиглалт тасрахгүй байгаа нь байгаль экологи доройтох нэг гол шалтгаан болж байгаа ба байгаль орчныг бохирдуулах нь хүний үйл ажиллагаатай салшгүй холбоотой байна. Тухайлбал:

Нийслэл хотын төвийн хэсэг гэр хорооллын агаарын бохирдол хүйтний улиралд хэвийн хэмжээнээс давсан, түүнчлэн хөрсөн дэх хүнд металлын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин илүү үзүүлэлттэй байгаа, хатуу хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 500 тонноор нэмэгдэж, химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ өндөр байгаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд шууд хохирол учруулж байгаа ч шууд эрүүгийн хариуцлага тооцох субъектгүй байна. Байгаль орчны бохирдол нь олон жижиг зөрчлөөс үүдэн үүсч байна.

54 "Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд бүс нутгийн хамтын ажиллагаа" хангайн бүсийн зөвлөгөөний оролцогчдын яриа.

55 Байгаль орчны яамнаас 1,7 тэрбум төгрөгийн зардал 2012 онд гарган байгаль орчинд учруулсан хохирлын талаар дүгнэлт, шинжилгээ хийлгэхэд *"нутаг дэвсгэрийн тал хувь нь сүйдсэн байна гэсэн дүгнэлт гарсан бөгөөд үүнийг нөхөн сэргээхэд 4 их наяд төгрөг шаардлагатай"* гэж дүгнэжээ.
http://criminology.mn/print.php?id=142&lang=1 сайтаас. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам.

БХЖЭсрэг гэмт хэрэг нь олон хүчин зүйлээс үүдэн гарч байна. Олон шалтгаан, нөхцөл нийлж гэмт хэргийн үндсэн шалтгаан, нөхцөл болж байгаа төдийгүй тэдгээр нь өөр хоорондоо уялдаа холбоотой, ганцхан шалтгаан, нөхцөлийг арилгаснаар үндсэн шалтгаан, нөхцөл арилахгүй. Голлох том шалтгаан гэж үгүй байна. Тэдгээр шалтгаан, нөхцөлийг тоочин дурдвал:

1. Засаглал муу;
2. Авилга хээл хахууль их;
3. Улс төрийн эрх мэдэлтнүүдийн хөндлөнгийн оролцоо их;
4. Цагдаа, мэргэжлийн хяналтын газарт гаргаж өгөх төсөв бага;
5. Алба хаагчдын идэвх санаачилга, ур чадвар, мэдлэг дутмаг;
6. Гэмт хэргийн явцад бий болсон эд зүйлийн эрэлт хэрэгцээ хар зах дээр улам нэмэгдэж байгаа;[56]
7. Иргэдийн эрх зүйн мэдлэг, соёл, ёс суртахууны төлөвшилт дорой сул;
8. Мэдээллийн хурдтай сүлжээ нь гэмт хэргийн гаралтад нөлөөлсөн;
9. Ядуурал нэмэгдэж байгаа нь доод түвшний гэмт хэрэг үйлдэгчийг их хэмжээгээр бий болгоход гол хүчин болдог зэргээс хамааралтай байна.

А) Засаглал муу[57].

Муу засаглалын гол шинж болох авилгал, ашиг сонирхлын зөрчил, улс төрийн хуваагдмал байдал зэрэг олон бэрхшээл манай засаглалд нүүрлэсэн хэвээр байна. Хуулийн хэрэгжилт муу, гүйцэтгэлд тавих хяналт сул, хариуцлагын тогтолцоо алдагдаж буруу алдаатай шийдвэр гаргагсдад хариуцлага тооцохгүй байгаагаас дараа дараагийн улс төрчид, албан тушаалтнууд дээрх алдааг давтсаар байна.

Б) Улс төрийн эрх мэдэлтнүүдийн хөндлөнгөөс оролцох нь их.

Эрх мэдэл бүхий улс төрчид, бизнесийн бүлэглэлүүд хувийн компаниараа дамжуулан ялангуяа лиценз нэрээр олгож байгаа зөвшөөрлийг хүчээр авах, хяналт шалгалтын ажиллагааг аливаа хэлбэрээр саатуулах, шалгуулахгүй байх зэрэг хууль бус үйлдлийг "өндөр" хэмжээнд үйлдэж хэвшээд байна.

В) Цагдаа, прокурор болон мэргэжлийн хяналтын газарт гаргаж өгөх төсөв бага.

Хууль хяналтын байгууллага ялангуяа цагдаагийн байгууллагын ажлын ачаалал их, төсөв хөрөнгийн хүрэлцээ дутмаг зэргээс хүний эрх эрх чөлөөг хамгаалах, хуулиар хүлээсэн үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч байна.[58] Монгол Улс нь өргөн уудам нутагтай, байгалийн нөөц баялагт шууд хяналт тавих бололцоогүй, эрх зүйн хамгаалалтаас гадна хүний хүчээр хийдэг хамгаалалтаас орчин үеийн дэвшилтэд техник технологи болох сансрын хиймэл дагуул, хяналт тавих хөнгөн онгоц зэрэг технологийг ашиглаж гэмт хэргийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх хэрэгцээ нэгэнт бий болжээ.

56 Зах дээр байгаа эд зүйл ховор байх тусам үнэ ханш нь илүү үнэтэй болдог. Иймээс худалдан авагчид ховор зүйлд илүү мөнгө хэрдаг. Хэрэв нэг талаас хулгайн модыг хоригловол, нөгөө талаас түүний үнэ ханшийг өсгөхөд хүргэнэ.

57 Сайн засаглалын шинж нь хариуцлагатай, ил тод, идэвхтэй, ур дүнтэй, бусдад ижил тэгш үйлчилдэг болон хууль дээдэлдэг зэрэг болно. Сайн засаглал нь аль болох авилга хээл хахуулийг арилгаж, хариуцлагыг өндөржүүлдэг.

58 Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги, түүнийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага. Цагдаагийн байгууллагын онол практикийн хурлын үндсэн илтгэлээс.

Г) Алба хаагчдын идэвх санаачилга, ур чадвар, мэдлэг дутмаг.

Гэмт явдал аяндаа урсгалаараа гарахаа больсон төдийгүй нийгмийн хор аюул нь улам бүр өсөн нэмэгдэж, тэдгээртэй тэмцэх арга, хэрэгсэл, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ тутам арга барилд шилжүүлэх цаг үе бидний өмнө тулгарч, аль 1990, 2000, 2005 онд хэрэглэж байсан бидний мэдэх *"уламжлалт"* гэх тэр арга, хэрэгсэл одоо үр дүнд хүрэх нь багасч, шинжлэх ухааны болон нийгмийн бусад салбарын мэдлэг, хамтын ажиллагаа илүү ихээр шаардагдах болжээ.

БХЖЭсрэг гэмт хэргийн тоо өсч байгаа хэдий ч хэргийн шийдвэрлэлт буурах хандлагатай байгаа аж. Энэ нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй, прокурорын хяналтын үед гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, хохирол тодорхойгүй гэх мэт шалтгаанаас хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол олон гарч байгаа нь алба хаагчдын санаачилга, сэтгэл дутсан, мэргэжлийн ур чадваргүй байгаатай шууд холбоотой.

БХЖЭсрэг гэмт хэргийг мөрдөхөд байгаль орчны олон хууль дүрэм, журмыг мэдэхээс гадна экологийн зохих мэдлэг зайлшгүй шаардлагатай байдгаараа бусад хэргээс онцлог[59].

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид[60] "Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн бүтэц, тархалт, шинж байдал нь улам бүр өөрчлөгдөж, амьтны эд, эрхтэн худалдаалах үйлдэл илүү давамгайлж, тэдгээр нь хил дамнасан, нарийн зохион байгуулалттай сүлжээтэй болж байгааг дурдаж, гэмт хэргийн илрүүлэлт сул, хууль хяналтын байгууллагад байгаль орчны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, удирдлага зохион байгуулалт хангалтгүй байгаа нь уг гэмт хэрэгтэй тэмцэх явдал тулгамдсан асуудлын нэг болсныг харуулж байгааг тэмдэглэжээ.

Д) Гэмт хэргийн явцад бий болсон эд зүйлийн эрэлт хэрэгцээ хар зах дээр улам нэмэгдэж байна.

Зах зээлд эд зүйл ховор байх тусам үнэ ханш нь илүү үнэтэй болдог. Энэ нь БХЖЭсрэг гэмт хэргийн гаралтын нэг нөхцөл мөн. Хулгайн ан, хууль бус мод бэлтгэлийг хүчтэй хоригловол түүний үнэ ханшийг өсгөхөд хүргэдэг. Тийм учраас байгалийн нөөцийн зах зээлийн худалдаанд тавих хяналтыг сайжруулах, бусад орлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг дэс дараатай авах шаардлагатай.

Е) Иргэдийн эрх зүйн мэдлэг, соёл, ёс суртахууны төлөвшилт дорой сул байгаа нь гэмт хэргийн бас нэгэн шалтгаан мөн.

Иргэдийн ёс зүй, хүмүүжил дорой байгааг хууль бус ан агнуурын жишээн дээр авч үзвэл, эрх мэдэл, мөнгө хөрөнгөөр далайлгасан, хүмүүжил, ухамсраар дулимаг хүмүүс ан авыг эр хүний гайхуулах нэг хэрэгсэл мэтээр ойлгож агнасан олзоороо уралдах, нэр хүндтэй хүмүүсийн гайхуулах дуртай сэдвийн нэг ан ав болов. Нөгөө талаар амьтны эд эрхтэн идэж, уснаар эрүүл болдог сэтгэлгээ иргэдийн дунд асар хүчтэй байгаа нь хүмүүсийн аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах хандлага сул байгаагийн илрэл төдийгүй энэ нь дам байдлаар хэргийн гаралтад нөлөөлж байна.

59 Үүнийг ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн жишээн дээр үзвэл, ан амьтны морфологи шинж, эд эрхтний бусад ойролцоо төрлийн амьтны эд эрхтнээс ялгагдах байдал, амьтныг хэдийд агнадаг вэмар хэрэгсэл, аргыг ашигладаг. Хөдөө хээр эзгүй газар, хүний нүднээс далд үйлдэгддэг хэргийг хэдийд илрүүлж болох зэрэг ур чадвар, мэдлэг шаарддаг.
60 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж. 2013.01.08 №02/02

Ё) Мэдээллийн хурд, багтаамж нь гэмт хэргийн гаралтад нөлөөлж байна.

Ялангуяа ашигт малтмал хууль бусаар олборлогчид буюу нинжа нар алт, өнгөт чулуу илэрлээ гэх мэдээллийг асар хурдтай тархаж хэдэн зуугаар төд удалгүй ирж байгаль орчныг сүйтгэдэг.

Жишээ дурдвал, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Гацуурт ордод алтны сургаар "Нинжа" нар өдрөөс өдөрт хэдэн зуугаараа нэмэгдэн ирж, тэнд ажиллаж байсан цагдаа нарын хүч мөхөсдөж богино хугацаанд 600 хүн цуглажээ. 2014 онд Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Сэрх Богд уулын Улаантолгой гэх газарт "Нинжа" алт ухаж хоёрхон өдрийн дотор 500 хүн ирсэн байна. Тус сумын малчин хонио хариулж яваад алтны судал олж тэндээсээ хумсын чинээ алт олсон гэнэ гэсэн мэдээлэл маш хурдан тархаж хүмүүс иржээ. Үүнээс 3 жилийн өмнө Бигэр сумын Алтан гэдэг ууланд 20 гаруй мянган нинжа цугларч Говь-Алтай аймагт их хэмжээний үймээн болох шахсан, таван цагдаагийн алба хаагч "Нинжа" нартай хэдэн өдөр тэмцэлдэж байж арай гэж тараасан байдаг.[61] "Нинжа" нар төрөл зүйлийн хувьд баяжиж, алт, гянтболд, өнгөт чулуу, нүүрс, самар зэргээр хүрээгээ тэлжээ.

Ж) Зөвхөн хувираа алт олборлож байгаа 90.000 орчим иргэн байгаа судалгаа байна. Хувираа алт олборлогчдын 70% нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байна.

Хотын хүн амын 85% нь өвлийн улиралд гэрээ дулаацуулж хоол ундаа хийхэд агаарын бохирдол маш ихээр үүсгэдэг мод эсхүл нүүрсээр галладаг зуух хэрэглэж байгаа бөгөөд агаар бохирдуулдаггүй цахилгаан болон бусад хэрэглээг "орлого муу, амьдрал тааруу" гэдэг шалтгаанаар хэрэглэхгүй байна.

САНАЛ

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь юуны өмнө хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлыг бууруулснаар үр дүнд хүрэх учиртай. Үүний тулд төрөөс шударга өрсөлдөөнийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ажлын байрыг бий болгох орчин нөхцөлийг бүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагаан дахь оролцоог багасгах, татвараар дарамтлахгүй байх ёстой бөгөөд үүний дүнд эдийн засаг зөв голдиролд орно.
2. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд шашны зан үйлийг ашиглах. Манай өвөг дээдэс байгаль дэлхий, уул усанд элдэв идээ ундаагаар тахил өргөн гол усыг бохирдуулахыг цээрлэж амьтны амь таслахыг нүгэлд тооцож байсан тэр уламжлал, шашны зан үйлийг сэргээж өргөнөөр ашиглах нь иргэдийн экологийн ухамсарт нөлөөлөх нэгэн гол арга зам болно.
3. Байгаль орчныг хамгаалах цагдааг бий болгох түүний үйл ажиллагааг бие даалгах, эрх хэмжээг нэмэгдүүлэх нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал түлхэц өгнө. Одоогийн цагдаагийн байгууллагад байгаа БХЖЭсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс нь зөвхөн хэрэг илрүүлэх, мөрдөхөд л үйл ажиллагаа нь чиглэгдэж байгаа учраас гэмт үзэгдэлтэй тэмцэх цогц бодлого хэрэгжүүлэх субъект болж чадахгүй байна. Байгаль орчны гэмт явдалтай тэмцэх ерөнхий стратеги байхгүй байна.

   Интерполын Ерөнхий ассамблейн 1993 онд баталсан тогтоолд дурдагдсан байгын гишүүн орнууддаа экологийн цагдаагийн тусгай салбар байгуулж, гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, бусад хуулийн байгууллагатай хамтран ажиллахыг зөвлөмжийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх.

61 Өдрийн сонин. 2014.01.24. Дэлгэр суманд алт гарч аймаг аймгийн "Нинжа" нар цуглажээ. Мэдээлэл. Э.Хүрэлбаатар.

4. Иргэдийн эрх зүйн мэдлэг, экологийн ухамсрыг дээшлүүлэх үйл ажиллагааг байнга эрчимтэй зохион байгуулах. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр экологийн боловсролыг олгох, дээшлүүлэх, танин мэдэхүйн шинжтэй нэвтрүүлгийг бэлтгэн нийтийн хүртээл болгох ажлыг өргөн цар хүрээтэйгээр явуулах.
5. Байгаль орчныг хамгаалахад иргэдийн нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллагыг зөв чиглүүлж, үйл ажиллагааны үр дүнг нийтэд сурталчлах, гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн туслалцааг цаг алдалгүй авч байх тогтолцоог бий болгох. Гэмт хэрэгтэй тэмцэх явцад иргэдийг ухамсарлуулах ба албадлагын аргыг хосолсон эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүжил, эрх зүйн чанартай арга хэмжээ хэрэгжүүлэх нь зохих үр дүнгээ өгнө.
6. Байгалийн нөөц баялгийг ашиглах зөвшөөрлийн тогтолцоог олон нийтэд ил тод болгох, авилгал, хээл хахуулиас ангид байх бүхий л ажлыг зохион байгуулах шаардлагатай.

БИЕЭ ҮНЭЛЭЛТ БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ЯВДАЛ







10. БИЕЭ ҮНЭЛЭЛТ БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ЯВДАЛ


1. ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН БИЕЭ ҮНЭЛЭХИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ЯВДЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүн худалдаалах болон бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдлыг тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзэн, гэмт хэргийн хөдөлгөөн, гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жин, гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий бүлгийг улсын чанартай статистик мэдээ болон өөрсдийн явуулсан хэсэгчилсэн судалгаа, олон улсын хандлага зэрэгт үндэслэн дүн шинжилгээ хийв.

Гэмт хэргийн статистик мэдээнээс үзэхэд, Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх, нийгмийн хор аюул нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагад 2000-2016 онд бүртгэгдсэн хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн байдлыг[62] графикаар үзүүлбэл:

График VII.10.1.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭГДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ, БИЕЭ ҮНЭЛЭХЭД БУСДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ, БИЕЭ ҮНЭЛЭХИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨН (2000-2016 ОН)



Үүнээс үзэхэд, 2003-2009 онд хүн худалдаалах гэмт хэргийн гаралт огцом өссөн бол сүүлийн 3 жил тогтворжих хандлагатай байгаа боловч энэ нь эрх зүйн орчин боловсронгуй бус, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчид энэ төрлийн

62 Монгол Улсад 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт. ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. УБ., 2013. 7 дахь тал, Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. УБ., 2014. 5 дахь тал, Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. ЦЕГ-ын Мэдээлэл, технологийн төв. УБ., 2015. 203 дахь тал, Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. ЦЕГ-ын Мэдээлэл, технологийн төв. УБ., 2016. 236 дахь тал, Монгол Улсад 2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. ЦЕГ-ын мэдээлэл нэгтгэн боловсруулах газар. УБ., 2017. 211 дэх тал

гэмт хэргийн талаар нэг мөр ойлголтгүй, гэмт хэргийг мөрдөх арга зүй дутмаг, хохирогч, гэрчийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй зэргээс шалтгаалан хүн худалдаалах гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй, бүртгэгдсэн ч шүүхээр хянан шийдвэрлэгдэхгүй, улмаар хэрэгсэхгүй болох, шүүхээс хэргийн зүйлчлэлийг өөрчилж, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр хянан шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байна. Учир нь хүн худалдаалах хэргүүдээс үзэхэд, эмэгтэйчүүдийг биеийг нь үнэлүүлэх болон бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт ашигласан байдаг учраас практикт энэ төрлийн гэмт хэргийг биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл гардаг.

Хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:[63]

Хүснэгт VII.10.1.

№	Он	Хүн худалдаалах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл)		Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл)	
		Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн
1	2006	1	1	1	1
2	2007	2	6	6	6
3	2008	2	2	19	38
4	2009	4	8	7	16
5	2010	3	6	5	12
6	2011	2	5	6	9
7	2012	3	7	5	11
8	2013	4	9	5	12
9	2014	1	1	7	8
10	2015	2	5	6	9
11	2016	6	8	6	9
Нийт		**30**	**58**	**73**	**131**

Шүүхийн байгууллагын дээрх мэдээнээс үзэхэд, цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хүн худалдаалах гэмт хэргийн цөөн хувийг шүүхээр таслан шийдвэрлэж, шүүхээс зарим эрүүгийн хэргийн зүйлчлэлийг өөрчилж, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр ял оногдуулах байдал түгээмэл байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагад 2008 онд бүртгэгдэн, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан 11 хэргээс зөвхөн 2 хэрэгт 2 хүн ял шийтгүүлж, харин Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан 19 хэрэгт 38 хүн шийтгүүлжээ. Үүнээс үзэхэд, хүн худалдаалах гэмт хэрэг өмнөх оныхоос өсөөгүй боловч Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг өмнөх оныхоос (өмнөх онд 6 хэрэгт 6 хүн шийтгүүлсэн) хэрэг 68%-аар, хүн 83.7%-аар тус тус өсчээ.

Энэ байдал нэг талаас, практикт хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргүүдийн бүрэлдэхүүний шинж, зүйлчлэлийн талаар нэг мөр ойлголтгүй, нөгөө талаас, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн

63 Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал судалгааны тайлан (15 жилээр). Нийслэлийн Шүүх, Хүний ажуулгүй байдлын судалгааны төв. УБ., 2010. 12 дахь тал, Монгол Улсын шүүхийн 2010-2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

13.2-т зааснаар "...Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ"[64] гэсэн гэм буруугүйд тооцох зарчмын дагуу хүн худалдаалах гэмт хэргийг хөнгөн ялтай Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр зүйлчлэн, ял шийтгэж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Улсын хэмжээнд 2003-2016 онд 149, жилд дунджаар 10.6 хүн худалдаалах гэмт хэрэг бүртгэгдсэн нь хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргийн 36.2%-ийг эзэлж байна.

Энэ гэмт хэрэгт 197 хүн холбогдон шалгагдсаны 10.5% нь 18-30 насны, 33.7% нь 30-35 насны, 55.8% нь 35-аас дээш насны хүмүүс байсан ба 30.8% нь бүлэглэн үйлдсэн байна.

Улсын хэмжээнд 2006-2016 онд 189, жилд дунджаар 17.1 биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

"Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг, эрсдэл, эмзэг байдал, хор уршиг" сэдэвт судалгааны тайланд "Монгол Улсын иргэнийг дотоодод худалдаалах гэмт хэрэг 30%, гадаад улсууд руу худалдаалах гэмт хэрэг 70%-ийг тус тус эзэлж байна"[65] гэсэн дүгнэлт хийснээс үзэхэд дотоодод хүн худалдаалах гэмт хэрэг бодитоор бий болсон гэж дүгнэхэд хүргэж байна.

2. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН БИЕИЙГ ҮНЭЛЭХИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улс дахь хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэхэд нэг талаас дэлхийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт, нөгөө талаас Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёлын амьдрал, хүн амын амьжиргааны түвшин, хүний хөгжил, төр засгийн хүлээх үүргийн хэрэгжилт зэрэг олон хүчин зүйлийн нөлөө оршин байгааг бид нэгтгэн үзэж, энэ төрлийн гэмт хэргийн өнөөгийн байдал, чиг хандлагыг тодорхойлохыг зорилоо.

1. Хүн худалдаалах гэмт хэрэг нь дараах чиг хандлагатай байна. Үүнд:

Нэгдүгээрт: Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг нь охид, эмэгтэйчүүдийн биеийг хүчээр үнэлүүлэх, бусад хэлбэрийн бэлгийн мөлжлөгт ашиглах хэлбэрээр ихэвчлэн үйлдэгдэж ирсэн бол цаашид мөлжлөгийн бусад хэлбэрээр үйлдэгдэх хандлагатай байна. Тухайлбал, Анагаахын шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил, техник, технологийн дэвшилттэй уялдан эд, эрхтэн[66] шилжүүлэн суулгах мэс засал сүүлийн үед ихээр хийгдэх болж, улмаар дэлхийн болон дотоодын зах зээлд хүний эд, эрхтний донорын эрэлт, үнэ ханш огцом нэмэгдсэн нь хүнийг эд, эрхтний донор болгон худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл бүхий нөхцөл байдлыг бий болгож байна.

Хоёрдугаарт: Сүүлийн жилүүдэд гэмт этгээдүүд биеэ үнэлэгчдийг гадаадад биеэ үнэлэхийг ятгаж, улмаар зөвшөөрүүлэн улсын хил давуулан худалдаалах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2013 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах 10 гэмт хэргийн 21 хохирогчийн 12 нь Монголд биеэ үнэлдэг байсан бөгөөд гэмт этгээдүүд гадаад улсад биеэ үнэлэхийг санал болгож, их хэмжээний мөнгө амлан хууран мэхэлж улсын хил давуулан худалдаалжээ.

64 Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. 2002. №5

65 Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг, эрсдэл, эмзэг байдал, хор уршиг судалгааны тайлан. Хүйсийн тэгш эрхийн төв. УБ., 2006. 29 дэх тал

66 Донорын тухай хуулийн 3.1.1. **"хүний эд, эрхтэн"** гэж хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, өндгөн эс, ураг)-ээс бусад эд, эрхтэнг. //Төрийн мэдээлэл. 2000. №6

Сүүлийн жилүүдэд Монгол эмэгтэйчүүд гадаадад болон дотоодод биеэ үнэлэх явдал эрс нэмэгдсэн болох нь төрийн болон ТББ-уудын хийсэн судалгаа, цагдаагийн байгууллагын статистик мэдээнээс харагдаж байна. Тухайлбал, 2012 онд ОУХБ, Үндэсний статистикийн хорооны хийсэн судалгааны тайлангаас үзэхэд, 4683 хүн биеэ үнэлж байгаагаас 13.6% нь гудамж талбай, 86.4% нь ямар нэгэн үйлчилгээний газар, дуудлагаар биеэ үнэлж байна гэжээ. Энэ бол цөөн хүн амтай манай улсын хувьд өндөр үзүүлэлт.

Биеэ үнэлэх, түүнийг зохион байгуулах гэмт явдалтай төрийн бодлогын түвшинд тэмцэх шаардлагатай байна. Юуны өмнө энэхүү гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг зөв тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагууд үүргээ нарийн хуваарилан, удирдамж, төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу шат дараатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Гуравдугаарт: Хүн худалдаалах гэмт хэрэг хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан үйлдэгдэх чиг хандлагатай байна.

Монгол эмэгтэйчүүдийн дийлэнх нь БНСУ, Япон, БНХАУ, ХБНГУ, АНУ зэрэг хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хүлээн авагч улсын иргэдтэй гэрлэсэн байгаагаас үзэхэд, эмэгтэйчүүд "Гадаадын иргэдтэй гэр бүл болоход зуучилна" гэсэн зарын дагуу гэмт этгээдүүдэд хууран мэхлэгдэн худалдаалагдсан байхыг үгүйсгэх аргагүй. Тухайлбал, гэр бүл зуучлалын нэгэн байгууллагаар зуучлуулж, БНСУ-ын иргэнтэй гэрлэсэн С нь ХЭҮК-т гаргасан өргөдөлдөө *"...Зуучлалын компани намайг И гэгч Солонгос хүнтэй танилцуулахдаа баян чинээлэг, хувьдаа хаустай, олон га газар эзэмшдэг, урьд нь гэрлэж байгаагүй гэж хэлсэн, харин энэ бүхэн эсрэгээрээ ядуу амьдралтай, хөдөө амьдардаг, жижигхэн байшинтай, ногоо тарьдаг талбайтай, урьд нь гэрлээд салсан, маш хэрцгий, архи их уудаг хүн байсан. Очсон өдрөөсөө л намайг загнаж харааж, өглөө 6 цагт босгон хоол, цайгаа хийлгэж, ногооны талбай дээрээ өглөөнөөс орой болтол ажиллуулж байсан. Ингээд гадаадын иргэдийг хамгаалах төвд бүх учраа хэлээд 4 хоносон. Гэтэл тус төв нөхөр руу маань утастаад таны эхнэр энд байна, их сэтгэл санааны дарамтад орсон, 3 сартай жирэмсэн байна гэж хэлсэн. Тэр намайг ирж аваад шууд эмнэлэгт аваачсан. Эмч хүүхэд нь эрүүл өсөж байна авахгүй гэж хэлж байхыг сонссон. Харин И эмчид мөнгө өгснөөр намайг наркозонд оруулж, 3 сартай хүүхдийг маань авсан. Ингээд би ажил хийж, Монгол руу ирэх зардлаа олж байж ирсэн. Намайг зуучилсан компани одоо болтол олдохгүй байна..."*[67] гэжээ.

Судалгаанаас үзэхэд, Монгол Улсын нэг гэрлэлтэд ногдох хүн амын тоо дэлхийн зарим оронтой харьцуулахад бага байна. Иймд Монгол эмэгтэйчүүд гадаадын иргэдтэй гэрлэж буй шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дөрөвдүгээрт: Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэгт гадаадын иргэд өртөх хандлага ажиглагдаж эхэлсэн. Тухайлбал, Монгол Улсын чинээлэг гэр бүлүүд Филиппин зэрэг Зүүн Өмнөд Азийн орнуудаас гэрийн үйлчлэгчээр ажиллуулахаар эмэгтэйчүүдийг олноор авчрах болсон. Монголд Филиппин улсаас нэг гэрийн үйлчлэгч эмэгтэйг авчрахад 1200 орчим ам.долларын зардал гарах тооцоог "Хүйсийн тэгш эрхийн төв" ТББ-аас хийсэн бөгөөд Монгол гэр бүлүүд гэрийн үйлчлэгч эмэгтэйг 4000 ам.доллар төлөхийг шаардаж, бичиг баримтыг нь барьцаалан, амралтгүй олон цагаар ажиллуулдаг, сүмдээ мөргөхийг хүртэл хориглодог талаар тус төвд хандсан Филиппин улсын 5 иргэн өгүүлжээ.

67 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. ХЭҮК. УБ., 2008. 36 дахь тал

Мөн 2011 онд УИХ-ын гишүүн асан Э-ийн гэрт гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаад нас барсан Филиппин улсын иргэн 34 настай Террил Атиенза гэх эмэгтэйн үхэлд түүний гэр бүлийнхэн Э-ийн эхнэр С-г буруутгаж, Филиппин улсын Манила хотод олон нийтийг хамарсан жагсаал болж байсан билээ.[68] Манай улсад уул уурхай, барилгын салбар эрчимтэй хөгжихийн зэрэгцээ гадаадаас ажиллах хүч авах явдал жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа барилгын салбарт БНХАУ, БНАСАУ, авто засварын чиглэлээр Вьетнам улсын иргэд манай улсад ихээр хөдөлмөр эрхэлж байна. Манай улсын зарим барилгын компани, иргэд дээрх орнуудын иргэдийг ажиллуулж, улмаар цалин өгөхгүй байх явдал гарах болсон. Тухайлбал, "Бэрэн" ХХК-д гэрээгээр барилга угсралтын ажил гүйцэтгэж байсан БНХАУ-ын иргэдийн цалинг олон сараар нь тус компани олгоогүйн улмаас тэдгээр иргэд Чингисийн талбайд эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахаар завдсан тул цалинг нь олгожээ.

Тавдугаарт: Орчин үед хүн худалдаалах гэмт хэргийг цөөн оролцогчидтой, түргэн хугацаанд зохион байгуулагддаг, хэлцэлд суурилсан жижиг гэмт бүлэглэлүүд үйлдэх болсон. Эдгээр бүлэглэлийг криминологчид бичил мафи (квартирная мафия) гэж нэрлэх болжээ.[69] Манай улсад сүүлийн жилүүдэд үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргүүдээс үзэхэд, холбогдогчдын тоо эрс өсөж, тодорхой бөөгнөрөл бүлгүүд бий болж, энэ гэмт хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, гадаадын иргэдтэй хамтран үйлдэх байдал ажиглагдаж байна. Тухайлбал, Их Британи улсын иргэн Ж, Монгол Улсын иргэн С нар бүлэглэн эмэгтэйчүүдийн санхүүгийн хүндрэлтэй байдлыг нь далимдуулан 2000-3000 ам.долларын цалинтай массажист, үйлчлэгчийн ажилд оруулна гэж хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар нийтлүүлэн хууран мэхэлж, 2 эмэгтэйг улсын хил давуулан Макаод аваачиж худалдсан байна (2007 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 430 дугаартай УДШ-ийн тогтоол)

Охид, эмэгтэйчүүдийн биеийг хүчээр үнэлүүлдэг бүлэглэлийг Эрүүгийн цагдаагийн газрынхан илрүүлж тус хэрэгт сэжиглэн 21-35 насны 8 залуу шалгаж байна. Тэд амьдралын боломж тааруу айлын 14-18 насны охидыг нэг газар хорьж, Бөхийн өргөө, Саппоро орчмоор зогсоож, биеийг нь хүчээр үнэлүүлдэг байсан байна. Энэ бүлэглэлийг М гэх залуу зохион байгуулж, хямд үнэтэй зочид буудлуудтай гэрээ хийсэн байжээ.

Зургаадугаарт: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис тээвэрлүүлэх, гэмт хэрэг үйлдүүлэх, порнографт ашиглах, бага насны хүүхдүүдээр хулгай хийлгүүлэх, аялал жуулчлал өндөр хөгжсөн улсуудад гуйлга гуйлгах зорилгоор хүүхдийг улсын хил давуулан худалдаалах, Монгол Улсад секс жуулчлал хөгжих үндэс суурь нэгэнт бүрэлдсэн тул охид, эмэгтэйчүүдийг энэ төрлийн бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор худалдаалах чиг хандлагатай байна.

Долоодугаарт: Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь эргээд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид болох хандлагатай байна. Тухайлбал, Макаод худалдагдаж, бэлгийн мөлжлөгт өртөж байсан эмэгтэй, Монголд ирээд 2 эмэгтэйг дагуулан явж, Макаод аваачиж худалдсан гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн.

2. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг зөв тогтоосноор энэ төрлийн гэмт хэргийн мөн чанарыг нээн илрүүлэх, түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлох зэрэг ач холбогдолтой. Энэ төрлийн гэмт хэрэг нь зөвхөн нэг улс оронд үйлдэгдэх бус хил дамжин үйлдэгддэг учраас түүнтэй тэмцэх асуудал олон улс, улс хоорондын харилцан туслалцаан дээр явагдах ба шалтгаан, нөхцөлийг мөн нэг

68 24tsag.mn/content/9653.shtml

69 П.Оюунчимэг. Хүн худалдаалах гэмт хэрэг (шүүгч, прокурор нар зориулсан сургалтын гарын авлага). УБ., 2011. 25 дахь тал

улсын хүрээгээр бус дэлхийн улс орны байдалтай холбон үзэх зайлшгүй шаардлагатай.[70]

Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн нийгэм, эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй шалтгааныг дараах байдлаар авч үзлээ. Нийгэм, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, инфляц, ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр, тогтвортой буурахгүй байгаа, иргэд гадаад улсад ажиллах, суралцах сонирхол нэмэгдэж, гадагшаа чиглэсэн ажиллах хүчний урсгал бий болсон, иргэдийн хялбар аргаар мөнгө олох хүсэл нэмэгдсэн зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн суурь шалтгаан болж байна.

Нийгэм, эдийн засгийн хөгжил сул улсуудад хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүч хэрэглэсэн гэмт хэргийн гаралт их байдаг. Буурай хөгжилтэй, шилжилтийн үедээ буюу хуучин төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэн улсуудын иргэд энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж, хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн "үүр уурхай" болжээ хэмээн олон улсын шинжээчид үзэж байна.

Охид, эмэгтэйчүүдийн (оюутан) биеэ үнэлэхэд нөлөөлж буй хүчин зүйл нь:

1. Хүн амын төвлөрөл (нийслэл хотод нийт хүн амын талаас илүү хувь нь амьдардаг);
2. Их, дээд сургуулиудын дийлэнх нь нийслэлд үйл ажиллагаагаа явуулдаг учраас хөдөө, орон нутгийн оюутнуудад дотуур байрны хүрэлцээ хангалтгүй[71];
3. Иргэдийн амьжиргааны түвшин доогуур;
4. Их, дээд сургуулиудын төлбөрийн хэмжээ иргэдийн амьжиргааны түвшинтэй харьцуулахад харьцангуй өндөр;
5. Оюутан, сурагчдын хичээлийн бус цагаар хийх цагийн ажлын боломж, хүрэлцээгүй;
6. Анги, хамт олны нөлөө;
7. Оюутан, суралцагсдын амар хялбар аргаар мөнгө олох гэсэн хүсэл, эрмэлзэл;
8. Сургалтын тогтолцооны гажуудал;
9. Сургууль, анги хамт олон, ангийн багш мөнгө, бусад зүйлсийг суралцагсдаас татах үзэгдэл газар авсан;
10. Сургууль, эцэг, эхээс оюутанд тавих хяналт сул зэрэг болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналтгүй байдал нь хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад сонин, сэтгүүл, богино долгионы FM радио, арилжааны телевизүүд олноор байгуулагдаж,[72] иргэд мэдээ, мэдээллийг цаг тухай бүр нь түргэн шуурхай авах боломжийг олгож байгаа боловч гэмт хэргийн шинжтэй зар мэдээ ихээр цацагдах болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа зар мэдээнд хууль хяналтын байгууллагаас тавьж буй хяналт шалгалт дутмаг байна.

70 Хүн худалдаалах гэмт хэрэг сурапцагчдын гарын авлага. НХХЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, Цагдаагийн Академи, Хүйсийн тэгш эрхийн төв. ТББ.УБ.,2009. 17 дахь тал

71 Нийслэлд 2014 оны 9 сарын байдлаар 121 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 152.000 оюутан суралцдаг. Нийслэлийн хэмжээнд 16.500 дотуур байр байдаг.

72 1999 онд Хууль зүй, дотоод хэргийн яаманд 1130 мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй, түүний 190 орчим нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан бол энэ тоо 2008 онд 398-д хүрч даруй 2 дахин өссөн байна. Тухайлбал, 1999 онд өдөр тутмын таван сонин гарч байсан бол 2008 онд өдөр тутмын 12 сонинтой болж, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг таван телевиз 18 болсон. Түүнчлэн, орон даяар нэвтрүүлгээ цацдаг телевизийн тоо нэг байсан бол зургаа болж, нийслэлийн FM радио долоогоос 20 болтлоо өсжээ.

3. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХЭД ХУУЛЬ БУС ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ:

Хүчин зүйл (factor) ямар нэгэн үзэгдэл, үйл явцын учир шалтгаан хөдөлгөгч хүч, нөхцөл байдал мөн.

2004-2007 онд Нийслэлийн дүүргүүдийн шүүхээр шийдвэрлэгдсэн нийт 17 хүн худалдаалах гэмт хэргүүд үйлдэгдэхэд нөлөөлсөн зар сурталчилгааг түгээсэн байгууллагуудыг ямар нэгэн байдлаар хэрэгт хамааруулан шалгаагүй хариуцлага хүлээлгээгүй байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80.1.6-д заасан гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг нотлох хүрээнд хууль бус зар сурталчилгааг түгээсэн байгууллагад хариуцлага тооцдог болох нь чухал ач холбогдолтой.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд зар сурталчилгаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын болон ААН-ийн тусгай зөвшөөрөл олгодог байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах зэрэг ажиллагаа огт хийгддэггүй нь нөлөөлдөг байна. ХЗҮХ-ээс 2009 оны 8 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан "Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт уулзалтад оролцогчид хууль бус зар сурталчилгааны эсрэг тодорхой арга хэмжээ авдаг боловч үр дүн муутай талаар дурдаж байсан.

Хууль бус зар сурталчилгааг түгээх үйл ажиллагаа далд байдалд зохион байгуулалттай шинжийг агуулж, залилан мэхлэх, хүн худалдаалах, банк санхүүгийн үйл ажиллагааг зөрчих, бусдыг доромжлох, гүтгэх зэрэг гэмт хэргээс гадна сауна, массажны газар нэрийн дор үйлчилгээ үзүүлж буй газар олноор нээгдэж хүрээгээ тэлэх, гэмт этгээдүүд биеэ үнэлэгчдийг ашиг орлого олох хэрэгсэл болгох, үүндээ олон охид, эмэгтэйчүүдийг татан оруулах зэрэг сөрөг үзэгдэл гарсаар байгаа нь хуулийн хэрэгжилт, үр нөлөө муу байгааг илтгэн харуулж байна. Иймд дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай:

- Хэвлэл мэдээллийн байгууллага ялангуяа тусгай хэрэгцээт сонинууд иргэдээс ирж буй зарыг хүлээн авах ажилд хууль зүйн зохих мэдлэгтэй хууль бус зарын наад захын хэлбэрийг таних чадвартай хүнийг ажиллуулдаг тогтолцоонд шилжих,
- Гэмт явдлын шалтгаан болсон согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис түүнчлэн, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг сурталчилсан үйлдлийг Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцож тусгах,
- Зар сурталчилгааны тухай хуулийн 21.2-т "Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч, тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардах эрхтэй" гэсэн заалтын "эрхтэй" гэснийг "үүрэгтэй" гэж өөрчлөх нь хууль бус зар сурталчилгааг захиалагч, бүтээгч, түгээгч нарт хариуцлага хүлээлгэхэд ач холбогдолтой.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, радио, телевизийн нэвтрүүлгийн сүлжээг ашиглан, худалдан авагч, хэрэглэгчдийг хууран мэхлэх, мөн өндөр цалинтай ажлын байр амлах, гадаадад ажиллуулна, сургана, загвар өмсөгч болгоно гэх зэргээр хуурч хүн худалдаалах гэмт хэрэгт татан оролцуулж болохыг хүн амд байнга сэрэмжлүүлж, тэдний сурталчилгаанаас давсан сөрөг сурталчилгааг тогтмол хийх зэрэг болно.

4. ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН БИЕЭ ҮНЭЛЭХИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ, ҮР ДҮН, АНХААРАХ АСУУДАЛ

Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолоор "Хүн худалдах, алангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг баталсан. Энэхүү үндэсний хөтөлбөр 2014 он хүртэл 3 үе шаттай хэрэгжсэн боловч дээр дурдсан төрийн болон ТББ-аас хийсэн судалгааны үр дүнд үндэслэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулаагүй, төсөв хөрөнгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тодорхой үр дүн гараагүй гэж хэлж болно.

Монгол Улс НҮБ-ын конвенцын нэмэлт болох "Хүн, алангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-д 2008 онд нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжуудаа олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн өөрчлөн найруулах, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүд, хүүхдэд тусгайлан анхаарал тавих, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих зэрэг үүргийг хүлээн, тухайн үзэгдлийн эсрэг тууштай тэмцэх олон улсын тэмцэлд нэгдсэн. Энэ ч үүднээс 2008, 2012 онуудад УИХ-аас Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг өөрчлөн найруулж, 2011 онд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг баталсан.

Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн бөгөөд одоо зөвхөн судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, төрийн зүгээс энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах шаардлагатай байна.

5. ДҮГНЭЛТ

1. Социологийн эмпирик судалгааны үр дүнгээс үзэхэд, Монгол Улсад хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий нөхцөл байдал нэгэнт үүсэж, нийтийн сүлжээний хяналтгүй байдал, хууль бус зар сурталчилгааны[73] улмаас иргэд уг гэмт хэргийн хохирогч болох эрсдэл үлэмж нэмэгдэж байна.
2. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн нотлох баримт цуглуулах ажиллагааны алдаа дутагдлаас шалтгаалан энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэх явцад төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчилж чадахгүй, хөнгөн ялтай зүйлээр шийдвэрлэж, гэмт этгээдэд ял завшуулж буй байдал ажиглагдав.
3. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, Монгол Улс дахь энэ төрлийн гэмт хэрэг нь тодорхой объектив болон субъектив хүчин зүйлийн улмаас "нуугдмал шинжтэй"[74], эмэгтэйчүүдийн биеийг хүчээр үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт ашиглах хэлбэрээр ихэвчлэн үйлдэгдэж байсан бол мөлжлөгийн бусад хэлбэрээр (эд, эрхтний донор болгох, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох г.м) үйлдэгдэх чиг хандлагатай болжээ.
4. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт явдалтай тэмцэх

73 Одоогийн зарын агуулга нь гадаадад тэтгэлэгтэй суралцуулна, гадаад хэл суралцангаа ажиллах боломжтой ажилд зуучилна, уралдаан тэмцээнд оролцуулна, ардын урлаг сурталчилна, уран нугаруулна зэргээр цаг үе, нийгмийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалан далд хэлбэр, агуулгатай болжээ.

74 Нийгмийн зүгээс хохирогчдод хандах хандлага (алангуяа бэлгийн мөлжлөгийн хохирогчдыг иргэд, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хэрэгжүүлэгчид сайн дураараа биеэ үнэлсэн гэж харьцдаг, буруутгадаг) нь энэ төрлийн гэмт хэрэг илрэхгүй, нуугдмал байхад нөлөөлдөг болох нь судалгаагаар тогтоогдсон.

төрийн бодлого, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа үгүйлэгдэж байна.

5. Монгол Улсын хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзэхэд, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй. Гэхдээ эрх зүйн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох чиглэлээр тулгамдсан олон асуудал байна.
6. Монгол Улс НҮБ-аас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баталсан цөөнгүй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд тэдгээрийн хэм хэмжээ, үзэл баримтлал, зарчмыг үндэслэн хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.
7. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, албан хаагчдын хүрэлцээ хангалтгүй байна.
8. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай байна.
9. Тодорхой төрлийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг тэргүүлэх үзүүлэлтэд тооцдоггүй байдал нь хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд саад тотгор болж байна.

6. САНАЛ

Монгол Улсын иргэд ихээр зорчдог болон оршин суудаг АНУ, Канад, Их Британи, ХБНГУ, Япон, Энэтхэг, Малайз, Тайланд зэрэг улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг шинээр байгуулж, хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх;

Хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх; Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор дэлхий нийтэд түгээмэл ашиглаж буй объект дотор байгаа хүний биеийн дулаан, хөдөлгөөн мэдрэгч төхөөрөмж, профайлинг, гар утасны хяналтын систем, цахим хяналтын төхөөрөмж гэх мэт. Монгол Улсын цагдаагийн байгууллагаас тодорхой бүс нутагт ялангуяа, Зүүн Өмнөд Азийн улсуудад Интерполын төлөөлөгч, гадаад улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамдад атташе ажиллуулах;

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ЗАЛИЛАН МЭХЭЛЖ АВАХ ГЭМТ ЯВДАЛ




11. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ЗАЛИЛАН МЭХЭЛЖ АВАХ ГЭМТ ЯВДАЛ

1. ЗАЛИЛАН МЭХЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсад үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн дийлэнх хэсгийг эдийн засгийн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар 87.1 тэрбум төгрөгийн хохирол иргэдэд үүсч байна. Эдийн засгийн гэмт хэрэг дотроос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн нэг нь бусдын эд хөрөнгийн залилан мэхлэх гэмт хэрэг юм.

Сүүлийн 10 гаруй жилд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт жилд дунджаар 22215 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд залилан мэхлэх 1084 гаруй хэрэг бүртгэгдсэн. Энэ үед бүртгэгдсэн залилан мэхлэх гэмт хэрэг нийт гэмт хэргийн 4.88 хувийг эзэлж байна. (График VII.11.1, Хүснэгт VII.11.1.)

График VII.11.1. 2006 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн нийт гэмт хэргээс залилан мэхлэх гэмт хэргийн эзлэх хувь



Хүснэгт VII.11.1. 2006 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн нийт гэмт хэрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн тоо

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	Дундаж тоо
Нийт гэмт хэрэг	18,253	21,268	20,704	20,373	19,825	19,197	22,089	25,362	27,318	27,757	**22215**
Залилан мэхлэх	669	816	866	801	764	688	1,098	1,231	1,843	2,067	**1084**
Хувь хэмжээ	3.67%	3.84%	4.18%	3.93%	3.85%	3.58%	4.97%	4.85%	6.75%	7.45%	**4.88%**

График VII.11.2. 2010 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн өсөлт



Улсын хэмжээнд сүүлийн 5 жил нийт гэмт хэргийн тоо жил болгон 6% өсч, дунджаар 23591 хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг жилийн 9%-ийн өсөлттэй 10219 хэрэг бүртгэгдэж нийт гэмт хэргийн 43.31%-ийг эзэлж байна. (Хүснэгт VII.11.2.)

Хүснэгт VII.11.2. 2010 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн тоо, хувь хэмжээ

Он	Нийт гэмт хэрэг	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	Залилан мэхлэх гэмт хэрэг	Хувь хэмжээ: Нийт гэмт хэрэг – Залилан мэхлэх гэмт хэрэг	Хувь хэмжээ: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг – Залилан мэхлэх гэмт хэрэг	Хувь хэмжээ: Нийт гэмт хэрэг – Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
2010	19,825	7,944	764	3.85%	9.62%	40.07%
2011	19,197	7,232	688	3.58%	9.51%	37.67%
2012	22,089	9,023	1,098	4.97%	12.17%	40.85%
2013	25,362	11,118	1,231	4.85%	11.07%	43.84%
2014	27,318	12,551	1,843	6.75%	14.68%	45.94%
2015	27,757	13,445	2,067	7.45%	15.37%	48.44%
Дундаж	**23,591**	**10,219**	**1,282**	**5.43%**	**12.54%**	**43.31%**
Жилийн дундаж өсөлт	**6%**	**9%**	**18%**	**12%**	**8%**	

2010, 2011 онуудад нийт гэмт хэргийн тоонд өөрчлөлт бараг ороогүй боловч 2012 оноос 2014 оны хооронд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо жил болгон дунджаар 2707-оор огцом өссөн байна.

Гэвч 2014 оноос 2015 оны хооронд гэмт хэргийн тоо харьцангуй тогтвортой байв. Энэ үзэгдэл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн хувьд ч

75 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо "Монгол Улсын статистикийн эмхтгэл" 2003-2016 он.

ялгаагүй илэрч 2010, 2011 оны үед гэмт хэргийн тоо харьцангуй тогтвортой байсан боловч 2012 оноос огцом өссөн байна. (График VII.11.2)

Ялангуяа 2010 онд залилан мэхлэх гэмт хэрэг улсын хэмжээнд 764 хэрэг бүртгэгдсэн боловч 2015 он гэхэд 2067 хэрэг болж, жилд дунджаар 18 хувь өссөн. 2010-2015 оны туршид залилан мэхлэх гэмт хэрэг дунджаар нийт гэмт хэргийн 5.43%, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 12.54%-ийг эзэлж, жилд дундажаар тус тус 12%, 8% өссөн байна. (Хүснэгт VII.11.2)

ГЭМТ ХЭРГИЙН ТОО

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдээс хулгайлах гэмт хэргийн дараа залилан мэхлэх гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн. Өөрөөр хэлбэл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 69.8 гаруй хувь нь хулгайн гэмт хэрэг бөгөөд 12.5 хувийг залилан мэхлэх гэмт хэрэг эзэлж байгаа нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэргээс харьцангуй өндөр хувь хэмжээтэй байна. (Хүснэгт VII.11.3)

Тодруулбал сүүлийн 5 жилийн туршид өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг дунджаар 10219 хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс хулгайлах гэмт хэрэг 7133 (68.8%), залилан мэхлэх гэмт хэрэг 1282 (12.5%), дээрэмдэх гэмт хэрэг 575 (5.6%), завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 294 (2.9%), булаах гэмт хэрэг 191 (1.9%) тус тус бүртгэгдсэн. (График VII.11.3)

График VII.11.3. 2010 оноос 2015 он хүртэл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн дундаж тоо



Хүснэгт VII.11.2.3. 2010 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн тоо, хувь хэмжээ

Гэмт хэрэг	2010	2011	2012	2013	2014	2015	Дундаж тоо	Хувь хэмжээ
Бүртгэгдсэн гэмт хэрэг-Бүгд	19,825	19,197	22,089	25,362	27,318	27,757	23591	
Өмчлөх							10219	100.0%
Хулгайлах	5,777	5,276	6,266	7,884	8,424	9,169	7133	69.8%
Залилан мэхлэх	764	688	1,098	1,231	1,843	2,067	1282	12.5%
Дээрэмдэх	520	536	552	620	686	537	575	5.6%

Завших, үрэгдүүлэх	337	202	269	326	297	333	294	2.9%
Булаалт	143	137	179	227	245	216	191	1.9%

Дээрх статистик мэдээллээс[76] харахад залилан мэхлэх гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн багагүй хувь хэмжээг эзэлж, бүртгэгдсэн тоогоор хулгайлах гэмт хэргийн дараа жагсаж байна. Мөн залилан мэхлэх гэмт хэрэг 2012 оноос хойш жил болгон их хэмжээгээр өссөн байна. Ирээдүйд ч энэхүү гэмт хэргийн гаралт буурахгүй өсөх чиг хандлагатай. Энэхүү гэмт хэргийн өсөлтөд хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр нөлөөлөх магадлалтай. Учир нь:

2002 оны Эрүүгийн хуульд залилан мэхлэх гэмт хэргийг "Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол" хэмээн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зааж өгсөн байдаг. Энэхүү хохирлын хэмжээний байдал нь 192,000[77] төгрөг хүртэлх хохирол учруулсан залилан мэхлэх үйлдлийг залилан мэхлэх гэмт хэрэгт тооцож байгаагүй. Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар залилан мэхлэх гэмт хэргийг "Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж; нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлэн авсан бол" хэмээн зөвхөн үйлдлээр нь зүйлчилж, учруулж болох хохирлын хэмжээг харгалзахгүй болгосон нь хууль зүйн орчны хувьд онцлогтой болсон.

1. ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

1.1 Санхүүгийн хүнд нөхцөл байдал

Залилан мэхлэх гэмт хэрэг гол төлөв санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас үйлдэгдэж байна. Тухайлбал, амьдралын хэрэгцээний зүйл болсон гар утас, машин, орон сууц зэргийг олж авахын тулд худал ярьж[78] эсхүл түр хэрэглэхээр авч буцаан өгөхгүй байх[79], худалдах худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, зээлийн гэрээ зэрэг иргэний эрх зүйн гэрээ байгуулж итгэл эвдэх замаар[80] залилан мэхэлж бусдад хохирол учруулсан тохиолдол их үүссэн байна. Ялангуяа зээлийн гэрээ байгуулж зээлээ эргэн төлөхгүйгээр сураггүй болох замаар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа бөгөөд зээлтэй холбоотой гэмт хэрэг цөөнгүй үүсэж байгаа гол шалтгаан нь банкны зээлээ эргэн төлж чадахгүй болсон, зээлийн өрөөс чөлөөлөгдөхийн тулд түр зуур хувь хүнээс зээл авсан, банкны зээл авах шаардлага хангаагүйн улмаас зээл авах боломжгүй болсон, гэнэт мөнгө шаардлагатай болсон зэрэг санхүүгийн хүнд нөхцөлөөс шалтгаалсан байна.

Ингэхдээ танил талын болон хамаатан, төрөл садан зэргийн дотно хүмүүсийн илтгэлийг эвдэх замаар гэмт хэрэг үйлдсэн байгаа нь шүүхийн шийтгэх тогтоол дээрээс харагдаж байна. Үүнээс гадна зээлийн өрөөс чөлөөлүүлэхийн тулд бага хувийн хүүгээр хувь хүнээс эсвэл ломбард, ББСБ зэргээс зээлж авсан тохиолдол ч бий.

76 Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар, Бүртгэгдсэн гэмт хэргийн сарын мэдээ, ГХТБ-2401. Үндэсний статистикийн хороо
77 Хуучин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр авч үзсэн болно.
78 Баянгол дүүргийн шүүх, 2013-06-25, 248-р тогтоол, Баян-Өлгий аймаг дахь Сум дундын шүүх, 2012-10-25, 084-р тогтоол,
79 Увс аймаг дахь Сум дундын шүүх, 2013-06-18, 49-р тогтоол
80 Чингэлтэй дүүргийн шүүх, 2012-11-27, 371-р тогтоол, Сонгинохайрхан дүүргийн шүүх, 2013-07-31, 379-р тогтоол, Сум дундын 8 дугаар шүүх, 2015-06-25, 55-р тогтоол, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх, 2015-04-01, 419-р тогтоол, Сонгинохайрхан дүүргийн шүүх, 2013-05-23, 264-р тогтоол, Орхон аймаг дахь Сум дундын шүүх, 2013-01-17, 010-р тогтоол

1.2 Иргэдийн сонор сэрэмжийн байдал

Өөрийнхөө тухай бусдад худал ярьж эд хөрөнгө залилан мэхэлж авсан хэрэг цөөнгүй байна. Жишээлбэл өөрийгөө захиргааны байгууллагын албан тушаалтан хэмээн итгүүлж, хураамж хэлбэрээр (тухайлбал, тусгай зөвшөөрөл гаргаж өгнө, газрын эрх олгоно хэмээн худал ярьж) залилан мэхлэх хэрэг үйлдэж байна.81 Мөн шашин шүтлэгийг ашиглан өөрийгөө зурхайч, лам гэж худал ярьж мөнгө төгрөг авсан гэх мэтийн хэрэг үүссэн байна.82 Үүнээс үзэхэд гэмт этгээдийн албан тушаал, эрхэлж буй ажил мэргэжлийг тухайн үе болгонд үнэн зөв мэдэх, шалгах боломжгүй байгаа нь албан тушаал, ажил мэргэжлийн талаар хуурч мэхлэхэд ашиглах нэгэн нөхцөл болж байна. Ялангуяа гэмт этгээд өөрийгөө төрийн албан хаагч гэж итгүүлж, хохирогчид тодорхой шийдвэр гарган тусалж өгнө хэмээн хураамж авч залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж байна. Гадаад улс орнуудад төрийн захиргааны байгууллагын бүтэц зохион байгуулалтын хамт тухайн хэлтэс, газарт ажилладаг төрийн албан хаагчийн нэрсийг нэг бүрчлэн зааж нийтэд ил болгодог бөгөөд байгууллагын албан ёсны цахим хуудсанд нэрээр, албан тушаалаар шүүж хайх боломжтой байдаг. Монгол Улсын хувьд ч захиргааны байгууллага, түүний албан тушаалтны талаарх мэдээллийг нийтэд ил болгосноор гэмт этгээд өөрийгөө захиргааны албан хаагч гэж хуурч мэхлэх явдлыг бууруулах боломжтой.

2. НИЙГМИЙН ЧИГ ХАНДЛАГА, НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын нийгэм-эдийн засаг хурдацтайгаар өөрчлөгдөж нийгмийн үзэгдэл, хандлага үүнийг даган өөрчлөгдсөн. Тухайлбал, ард иргэд гадаад руу цагаачлах, хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдсэн бөгөөд энэ нөхцөлийг ашиглан гадаадад зорчих виз гаргаж өгнө гэж хуурч мэхэлснээр их хэмжээний хохирол учирч байна[83]. Ийнхүү улс орны эдийн засгийн нөхцөлөөс үүдэн ард иргэд гадагшаа явах сонирхол, чиг хандлага нэмэгдэж байгаа нь залилан мэхлэх гэмт хэрэг бий болох нэг нөхцөл болж байна.

Үүнээс гадна Монгол залуучууд гадаадын их дээд сургуульд явах нь нэмэгдэж дээд боловсрол гадаад улсад эзэмших сонирхол нэмэгдсэн. Тэр хэмжээгээр элсэлтийн шалгуур өндөр эсвэл гадаадын сургуульд сурах хүсэл эрмэлзлийг ашиглан сургуульд зуучилна хэмээн хууран мэхэлж бусдын эд хөрөнгийг авах гэмт хэрэг бий болж байна84.

3. ЗАЛИЛАН МЭХЛЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Дээрх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлд тулгуурлан залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргээс үүсэх хохирлыг бууруулах арга хэмжээг зөв оновчтой авах хэрэгтэй.

Нийгэм, эдийн засаг хөгжих хэрээр гэмт хэрэг үйлдэх арга байдал, гэмт хэргийн тоо хэмжээ, хохирол өсөн нэмэгдэх хандлагатай байна. Энэ дундаа Монгол Улсад үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн дийлэнх хэсгийг эдийн засгийн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар 87.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийн хохирол иргэдэд бий болдог. Эдийн засгийн гэмт хэрэг дотроос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн

81 Багануур дүүргийн шүүх, 2013-05-07, 42-р тогтоол, Чингэлтэй дүүргийн шүүх, 2013-09-24, 306-р тогтоол

82 Төв аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүх, 2013-01-03, 08-р тогтоол,

83 Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх, 2014-04-22, 509-р тогтоол, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх, 2015-05-14, 632-р тогтоол, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх, 2014-01-16, 116-р тогтоол, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, 2016-07-22, 50-р тогтоол

84 Сонгинохайрхан дүүргийн шүүх, 2013-09-10, 441-р тогтоол, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, 2016-05-30, 43-р тогтоол

нэг нь бусдын эд хөрөнгийн залилан мэхлэх гэмт хэрэг юм. Энэхүү гэмт хэрэгтэй бодитой тэмцэхийн тулд онолын ойлголт болоод гэмт хэрэг үйлдэгдэх болсон учир шалтгааныг бодитой тогтоох нь нэн чухал. Практикт залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрх зүйн зөрчлөөс ялгаж зүйлчлэхэд хүндрэлтэй байна. Зарим тохиолдолд цэвэр гэрээний үдсэн дээр бий болсон иргэний хэрэг, залилан мэхлэх гэмт хэрэг хэмээн эрүүгийн шүүхээр шийдэгдэж байна. Энэхүү байдал нь залилан мэхлэх гэмт хэргийн тоон үзүүлэлтийн бодит байдлыг алдагдуулах нэг хүчин зүйл болж байна.

Иймд залилан мэхлэх гэмт хэргийн онолын ойлголтыг шинжлэх ухааны үндэслэлтэй гарган түүнийг практикт нэг мөр болгон хэрэглэх асуудал нэн шаардлагатай байна.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ЯВДАЛ



12. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ЯВДАЛ

1. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГ

Мөнгө угаах гэмт үзэгдэл нь олон салбар, нарийн мэргэжлийн мэдлэг хамардаг гэж судлаачид үздэг[85] бөгөөд эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, улс төр, засаглалын тогтолцоонд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэл дагуулдаг үргэлжилсэн үйл явц бүхий гэмт хэргийн хувьд хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжсан байдаг. Мөнгөний хууль бус эх сурвалжийг нуун далдлахад чиглэсэн энэхүү гэмт явдлыг олон улсын түвшинд өнгөрсөн хорин таван жилийн өмнөөс гэмт хэрэгт тооцох болсон хэдий ч энэ төрлийн үйл ажиллагаа эртнээс үүсэлтэй гэдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг. Мөнгө угаахтай тэмцэх бодлогыг санаачлах болсон гол шалтгаан нь АНУ-ын хар тамхины хууль бус эргэлтийн эсрэг зарласан тэмцэл амжилтад хүрээгүйтэй холбон тайлбарладаг. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис үйлдвэрлэгч, нийлүүлэгч гэмт бүлэглэлийн гэмт хэргээс олсон ашиг орлогыг илрүүлж, хураан авах замаар гэмт үйл явдлыг цаашид үргэлжлүүлэн үйлдэх чадамжгүй болгох, дархлааг нь үгүй хийх зорилготой байсан мөнгө угаахтай тэмцэх тус улсын бодлого эцсийн дүндээ бүхий л төрлийн гэмт хэргийн ашиг орлогыг илрүүлэх, хураах, улмаар уг гэмт явдлыг таслан зогсооход чиглэсэн бодлого болж хувирчээ[86]."Их-7"-ийн бүлэгт багтах улс орнууд 1989 онд нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий засгийн газар хоорондын "Санхүүгийн хориг арга хэмжээ авах бүлэг" (ФАТФ) -ийг үүсгэн байгуулагдаж "ФАТФ-ын стандарт" хэмээх 49 зөвлөмж батлагдсан[87].

Мөнгө угаах гэдэг нь энгийн ухагдахуунаар гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогын эх үүсвэрийг нуун далдлах, хууль ёсны мэт харагдуулж чөлөөтэй захиран зарцуулах зорилгоор бодит төрхийг өөрчилж, хувиргаж буй үйл явц юм. Мөнгө угаахыг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд олон янзаар тодорхойлж ирсэн бөгөөд ихэнх улс орнууд НҮБ-ын "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг" 2000 оны Палермогийн Конвенцид тодорхойлсон эрх зүйн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрдөг. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцид тусгалаа олсон байдаг[88]. Тус Конвенцийн 6 дугаар зүйлд (Гэмт хэргийн улмаас олсон орлогыг гэмт хэрэгт тооцох) мөнгө угаахыг:

1) *тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;*
2) *тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эд хөрөнгийг эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;*
3) *тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;*
4) *Энэхүү зүйлд тусгагдсан аливаа гэмт үйлдлийг үйлдэхэд оролцсон, хуйвалдсан, завдсан, хамжсан, хатгасан, хөнгөвчилсөн, зөвлөсөн..."*

85 Unger, B and Van der Linde, D. eds., 2013. *Research handbook on money laundering*. Edward Elgar Publishing.

86 Unger, B. 2013. Money Laundering Regulation: From Al Capone to Al Qaeda. B. Unger & D. van der Linde (red.), Research handbook on money laundering, 16 дахь тал.

3 Өмнө нь Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага гэж Монгол хэлнээ нэрлэдэг байсаныг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны Монгол хэлнээ хөрвүүлсэн "ФАТФ-ын Аргачлалын орчуулга"-д ийнхүү өөрчилсөн. Financial Action Task Force, http://www.fatf-gafi.org/

4 НҮБ-ын Хар мансууруулах бодистой тэмцэх алба (2000). Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенц. [онлайн] Дараах холбоосоор нэвтэрч үзэх: http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html [Нэвтэрсэн 2017.09.15]

үйлдлийг гэмт хэрэгт тооцох хууль тогтоох болон бусад шаардлагатай арга хэмжээг авбал зохино..." гэж тодорхойлдог.

2017 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эрүүгийн Хуулийн 18.6 дугаар зүйл[89] мөнгө угаах гэмт хэргийг:

> *"...Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан; энэ хэргийг ЭХ-ийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж үйлдсэн; байнга тогтвортой үйлдсэн; албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн; хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн..."*

гэж тус тус тодорхойлжээ.

Сүүлийн жилүүдэд террорист үйл ажиллагаанд энгийн гэмгүй иргэд улам их өртөх нь эрс нэмэгдэж байгаа нь харамсалтай . Терроризмтой тэмцэх асуудал нь дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч буй хамгийн том эрсдэлд тооцогдож байна. АНУ-д 2001 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр болсон террорист хадлага нь терроризмыг санхүүжүүлэхийг гэмт хэргийн улмаас олсон ашиг орлого, арга хэрэгслийг нуун далдлахад чиглэсэн мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаатай тэмцэх бодлого үйл ажиллагаатай нэгтгэн хөгжүүлэхэд хүргэжээ.[90]

Энэхүү халдлагын дараа АНУ-ын терроризмтой тэмцэх бодлого чангарч террорист халдлага үйлдэхэд ашигласан, гадаад улс оронд үйлдэгдсэн хар тамхины гэмт хэрэг болон бусад гэмт хэргээс олсон орлогыг иргэний болон эрүүгийн журмаар хураах, хууль сахиулах байгууллагуудын эрх хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль[91]- ийг 2001 онд баталсан байдаг[92]. Энэхүү хуулийг терроризмыг санхүүжүүлэхтэй өргөн далайцтай тэмцэх түлцэх болсон гэж дүгнэдэг93. Терроризмыг санхүүжүүлэхийн илрэх хэлбэрийг улс орнууд, эрдэмтэн судлаачид янз бүрээр тодорхойлдог ч НҮБ нь улс орнуудыг терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн тодорхойлолтыг олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенцийн дагуу нийцүүлэхийг шаарддаг. 1999 онд НҮБ-ын Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай Конвенци батлагдаж тус гэмт үйлдлийн тодорхойлолсон байдаг. Конвенцийн 2 дугаар зүйлийн 1, 2 дугаар хэсэг нь терроризмыг санхүүжүүлэх гэдэгт:

> *"...Аливаа этгээд "Терроризмын санхүүжүүлэхийг хориглох тухай Конвенцийн" хавсралтад дурдсан гэрээнүүдийн аль нэгний үйлчлэлд хамаарах гэмт хэрэг хэмээн тодорхойлогдсон үйлдлийг хийсэн, эсхүл өөрийн шинж чанар, агуулгын хувьд аль нэг засгийн газар, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахыг тулган шаардах, олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн, эсхүл зэвсэгт мөргөлдөөний үед байлдааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцоогүй энгийн иргэд болон аливаа бусад хүний амь насыг нь хөнөөх буюу*

89 *Монгол Улсын Эрүүгийн хууль* (Шинэлсэн найруулга) 2017. Дараах холбоосоор нэвтэрч үзэх: http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634 [Нэвтэрсэн 2017.09.15]

90 Unger, B., 2013. *Money Laundering Regulation: From Al Capone to Al Qaeda. B. Unger & D. van der Linde (red.), Research handbook on money laundering*, 17 дугаар тал.

91 US PATRIOT ACT (*Uniting and Strengthening America by Providing Appropriate Tools Required to Intercept and Obstruct Terrorism Act*, 2011 - "Терроризмын Үйлдлийг Илрүүлэх, Таслан Зогсооход Шаардлагатай Зохих Хэрэгслээр Хангах Замаар Америкийг Нэгтгэх, Бэхжүүлэх Тухай Хууль" хэмээн хөрвүүлэгддэг. Дараах холбоосоор нэвтэрч үзэх: https://www.justice.gov/archive/ll/highlights.htm [Нэвтэрсэн 2017.09.15]

92 Baldwin F. N. "The regulation of the financing of terrorism". edds.Rider, B. ed., 2015. *Research Handbook on International Financial Crime*. Edward Elgar Publishing. 544 дахь тал.

93 Мөн тэнд. 544-545 дахь тал.

бие махбодид нь ноцтой гэмтэл учруулах зорилготой аливаа бусад үйлдэлд бүрэн буюу хэсэгчлэн ашиглуулах зорилготойгоор, эсхүл тийнхүү ашиглагдахыг мэдсээр байж, мөнгөн хуримтлалыг аливаа байдлаар, шууд буюу шууд бус, хууль бусаар болон санаатайгаар олгосон буюу хуримтлуулсныг...",

гэж тодорхойлжээ

2017 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүчин төгөлдөр болсон МУ-ын ЭХ-ийн 29.10 дугаар зүйлд терроризмыг санхүүжүүлэх гэдэгт: *"Террористы террорист байгууллага, террор ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд, шууд бусаар эд хөрөнгө хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан; энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэнийг..."*[94] хэмээн тодорхойлдог. байна


Ингээд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх нь мөнгөний гарал үүсэл, зорилго, сэдлээрээ ялгаатай ч мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах, будлиантуулах аргаараа ижил төстэй гэмт үйлдлүүд юм. Мөнгө угааж буй хүн, хуулийн этгээд нь хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгө, мөнгө, орлогыг хууль бус болон хууль ёсны салбараар дамжуулан угаах эсхүл хөрөнгө оруулалт хийж, гарал үүслийг нь нууж эцсийн үр шимийг хүртэх шунахайн сэдэл тээдэг бол терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны, эсхүл хууль бусаар олсон мөнгө, хөрөнгөөр терроризмыг дэмжих - улс төр, шашны болон хэт даврах үзэл түгээн дэлгэрүүлэх, "мөнгөн хуримтлал бүрдүүлэх" зорилгоор ухуулга сурталчилгаа явуулах, гишүүдийг элсүүлэх, сургах, цалинжуулах, террорист ажиллагаанд ашиглах зорилго агуулж байдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргүүд нь гурван үе шат, дэс дараалалттай үйлдэгддэг үргэлжилсэн гэмт үйлдлүүд гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Барууны судлаачид эдгээр үе шатуудыг байршуулах(placement), үечлэх/давхрага үүсгэх (layering), нэгтгэх (integration) хэмээн нэрлэдэг. Эхний үе шатанд гэмт этгээдүүд, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгө, мөнгийг (***терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хувьд орлого, хөрөнгө, мөнгөний гарал үүсэл нь хууль ёсны ч байж болно, гэмт хэрэг үйлдэж олсон орлого ч байдаг болдог***) санхүүгийн тогтолцоо, эдийн засгийн ямар нэгэн салбарт байршуулдаг. Дараагийн үе шатанд мөнгө угаах хэргийн хувьд мөнгөний гэмт хэргийн шинжтэй гарал үүслийг будлиантуулах, нуун дарагдуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Харин терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн давхарга үүсгэх гэж нэрлэгддэг үе шатанд терроризмыг санхүүжүүлэх зориулалттай хөрөнгө, мөнгийг хууль хяналтын байгууллагын анхааралд өртөлгүй мөн будлиантуулах ажиллагаа явуулж эцсийн хүлээн авагч буюу террорист байгууллагад хүргэх явдал байдаг.

Эцсийн үе шатанд мөнгө угаах гэмт хэргийн хувьд гарал үүсэл нь хууль ёсны мэт болж өөрчлөгдсөн хөрөнгө, мөнгө, орлогыг аль болох ашигтай эдийн засгийн салбарт хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх, хөдлөх хөрөнгө худалдаж авах, хууль ёсны үйл ажиллагааны орлого мэтээр хувийн хадгаламжийн дансандаа байршуулах хүртэл үйлдлүүд багтана. Харин терроризмыг санхүүжүүлэхийн тухайд эцсийн үе шатанд терроризмын зориулалттай хөрөнгө, мөнгө орлогыг алан хядах тактикийн шинжтэй ажиллага явуулах эсхүл террорист байгууллагын алс хэтийн бодлогыг дэмжих ухуулга сурталчилгаа явуулах ажиллагаануудад хуваарилах явдал байдаг. Зарчмын ялгааг дараахь бүдүүвчийн дагуу харуулбал[95]:

94 2 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн a, b. *Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай Конвенци (1999).*, [онлайн].. Дараахь вэбхаягаар орж үзэх: http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634. [Нэвтэрсэн 2017.09.15]. *International Convention for the Suppression of the Financing of Terrorism 1999.* Дараах холбоосоор англи хэл дээр үзэх: http://www.un.org/law/cod/finterr.htm

95 Schott, P.A., 2006. Reference guide to anti-money laundering and combating the financing of terrorism. World Bank Publications [Онлайн],I бүлгийн-8 дахь тал., Дараахь холбоосоор орж үзэх: http://siteresources.worldbank.org/EXTAML/Resources/396511114658142787 1/Reference_Guide_AMLCFT_2ndSupplement.pdf




2015 онд залилангийн гэмт хэрэг үйлдэж 30 гаруй сая ам.долларын хохирол учруулсан улс дамнасан кибер гэмт хэрэгтнийг илрүүлж, хариуцлага тооцсон хэрэг мөнгө угаах гэмт хэргийн арга, үе шатуудыг ойлгомжтой дүрсэлдэг.[96] Тэрбээр өөрийн мэдэлд байдаг хоолны үйлчилгээ эрхэлдэг байгууллагын данс, хуурамч данс, гуравдагч этгээдтэй хамтран эзэмшдэг данс, казино, мөрийтэй тоглоомын газар, интернет банк ашиглан Австрали, Канад, ХБНГУ, Хонг Конг, Индонез, Люксембург, Нигер, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улс орнуудаар дамжуулан мөнгө угаасан байдаг.[97] Уг гэмт хэргийн үйл явцыг дор дурдсан бүдүүвч зураглалаар харуулав.

96 "AUSTRAC Data Helped Capture International Cyber-Criminal", Australian Transaction Reports and Analysis Center[Онлайн], Дараахь холбоосоор орж үзэх: http://www.austrac.gov.au/case-studies/austrac-data-helped-capture-international-cybercriminal. [Нэвтэрсэн 2017.09.15

97 Typologies and case studies report (2014).Australian Transactions Reports and Analysis Centre (AUSTRAC) [Онлайн], Дараахь холбоосоор орж үзэх.http://www.austrac.gov.au/typologies-and-case-studies-report-2014. [Нэвтэрсэн 2017.09.15]

Хэргийн жишээ № 1. Мөнгө угаах гэмт хэргийн бодит хэргийн жишээ



2. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫН ШИНЖ

Ихэнх гэмт хэргийн улмаас тодорхой ул мөр үлдэж ямар нэгэн илт үр дагавар гарсан байдаг. Тухайлбал, бусдын эд хөрөнгийг завших гэмт хэрэгт хохирогч гомдол мэдүүлэх, хулгайн гэмт хэрэгт эд зүйл алдагдах гэх мэт. Харин мөнгө угаах гэмт хэргийн хувьд хэн нь жинхэнэ хохирогч болох нь тодорхойгүй байдаг. Энэхүү онцлог нь мөнгө угаах гэмт хэргийг хохирогчгүй буюу "үл үзэгдэх" гэмт хэргийн ангилалд хамааруулдаг байна.[98] Энэ утгаараа мөнгө угаах гэмт хэрэг нь аюул заналхийлэл, хохирлыг шууд утгаараа гэмт хэрэг

98 Ferwerda, J., 2013. The effects of money laundering. B. Unger & D. van der Linde (red.), Research handbook on money laundering, 35-46 дугаар тал.

үйлдмэгц үүсгэдэггүй боловч далд хэлбэрийн үр дагавартай, тодорхой хугацаанд үргэлжилж дам байдлаар хохирол учруулж байдаг онцлогтой.

Мөнгө угаах гэмт хэргээс учирч болох хохирол, үр нөлөөний талаарх Нидерландын судлаачийн судалгаанаас үзэхэд мөнгө угаах нь эдийн засгийн аюулгүй байдалд богино болон урт хугацааны нөлөө үзүүлэхээс гадна гэмт хэргийн өсөлт, тэлэлт, өнгөлөн далдлалт, тогтвортой сайн засаглалд хүртэл нөлөөлдөг гэж үздэг[99]. Богино хугацаанд зах зээлийн жам ёсны эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх, үнийн зохиомол хөөрөгдөл, шударга бус өрсөлдөөн бий болгох, импорт, экспортын урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбарт хөөсрөлт бий болгох, зээлийн тогтворгүй эх үүсвэрийг нэмэгдүүлдэг урт хугацаанд гадаад шууд хөрөнгө оруулалт болон хадгаламжийн тэнцвэрт байдлыг алдагдуулдаг гэсэн байна[100]. Олон Улсын Валютын сан мөнгө угаах нь санхүүгийн салбарт богино хугацаанд хөрөнгө дотогшлох, гадагшлах урсгалыг нэмэгдүүлдэг бол урт хугацаанд санхүүгийн салбар, хөрвөх чадамж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт эрсдэл үүсгэдэгийн зэрэгцээ санхүүгийн салбарт хуурамч өсөлт бий болгож харагдуулдаг гэж үзсэн байна[101].Гэмт этгээдүүд нь их хэмжээний бэлэн мөнгөний эх үүсвэр эзэмшиж буй давуу талаа ашиглан үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажиллагааг өндөр үнээр худалдан авдаг нь нийтлэг байдаг(Walker, 1995)[102]. Тухайлбал, Колумбын "Меделин картел" нь 1980 онд зах зээлийн ханш нь 500$ ам.доллар болох 1 га газрыг 2000$ ам.доллар болгож үнэ өртгийг нь хөөсрүүлж байсан бодит жишээ байдаг[103].

Мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт хэргийн өсөлт, тэлэлт, өнгөлөн далдлалт, тогтвортой засаглалд сөргөөр нөлөөлдөг үзүүлдэг болохыг олон нийт өргөнөөр хүлээн зөвшөөрдөг. Үүний нэг жишээ нь ихэнх хөгжиж буй улс оронд мөнгө угаах, зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, улс төр, олон нийтийн салбар нь хоорондоо гүнзгий харилцан хамааралтай, харилцан ашигтай (symbiotic relation) нөхцөлд орших хандлагатай болсоор байна[104]. Албан тушаалтанд шууд хахууль өгөх замаар эрх баригчдад шууд нөлөөлж болох нийтлэг арга байдаг ч сонгуулийн компанит ажлын үеэр ялах магадлалтай нэр дэвшигчийг санхүүжүүлж, улмаар сонгогдсон тохиолдолд нөлөөллөө тогтоох нь гэмт бүлэглэлүүдийн ашигладаг овжин арга барилуудын нэг юм . 1996 оны Колумб Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Эрнесто Сампер (Ernesto Samper) нь кокаины хууль бус эргэлтээр гаршсан "Кали Картел" (Cali Cartel) хэмээх гэмт байгууллагаас 6 сая ам.долларын улс төрийн санхүүжилт авсан үндэслэлээр байсан нь үүний тод жишээ юм[105].

Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хор хөнөөл нь террорист хүнийг санхүүжүүлэх, террорист байгууллагыг санхүүжүүлээс шалтгалан нийгэмд учруулах хор уршгийн хэмжээ, далайцаар хэмжигдэж байдаг. Террорист байгууллагын төрөл, хэлбэр нь дотроо тусгаар улс, нутаг дэвсгэрт хяналтаа тогтоосон томоохон байгууллагаас эхлээд цомхон бүлэглэл ч байж болдог. Террорист байгууллагын үзэл санааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр шууд ба шууд бусаар түгээн дэлгэрүүлэхэд олгогдсон мөнгөн хуримтлал нь тухайн террорист байгууллагын эгнээнд нэгдэх хүмүүсийн тоог нэмэгдүүлж

99 Ferwerda, J. (2013). The Effects of Money Laundering. In B. Unger & D. van der Linde (Eds.), Journal on Money laundering control. Cheltenham: Edward Elgar Publishing. 35-46 дахь дугаар тал.

100 Мөн тэнд. 35-46 дугаар тал.

101 International Monetary Fund (2014). The IMF and the Fight Against Money Laundering and the Financing of Terrorism. Дараахь холбоосоор орж үзэх http://www.imf.org/about/factsheets/sheets/2016/08/01/16/31/fight-against-money-laundering-the-financing-of-terrorism?pdf=1. [Нэвтэрсэн 2017.09.15]

102 Walker, J.R. and Walker, J., 1995. Estimates of the Extent of Money Laundering in and through Australia. John Walker Consulting Services. 33 дахь тал.

103 Keh, D.I., 1996. Drug money in a changing world: economic reform and criminal finance. In UNDCP Technical series (No. 4, p. 22). UNDCP. Дараахь холбоосоор орж үзэх: http://www.unodc.org/pdf/technical_series_1996-01-01_2.pdf, 5 дугаар тал. [Нэвтэрсэн 2017.09.15]

104 Aluko, A. and Bagheri, M., 2012. The impact of money laundering on economic and financial stability and on political development in developing countries: The case of Nigeria. Journal of Money Laundering Control, 15(4), pp.442-457.

105 Milliard, G.H. (1997), "Drugs and organized crime in Latin America", Journal of Money Laundering, Vol.1, November. 73-78 дахь тал

үйл ажиллагааг тэлэх, улам хүчирхэг болгох хор уршигтай. Ийм хүчирхэг болсон террорист байгууллагын үйл ажиллагаа чадавхи, боломжоо дагаад олон улсын улс төр, аюулгүй, тогтвортой, байдал, эдийн засаг, нийгэм, хүмүүсийн амьд явах эрхэнд үзүүлэх нөлөөлөл нь хүртэл улам бүр өргөн далайцтай болдог. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Ойрхи-Дорнодын бүс нутагт нөлөөллөө тогтоосон, дэлхийн олон улс орнуудын сайн дурын алан хядагч хөлсний цэргүүдийг эгнээндээ нэгтгэсэн "Исламын Улс" террорист байгууллагын явуулж буй гэмт үйл ажиллагаа нь Европын Холбооны аюулгүй, тогтвортой байдалд хүртэл нөлөөлж байна.[106] АНУ-ын цагаачлалын бодлогод хүртэл өөрчлөлт орж байна[107]. 2016 онд Их Британи Европын Холбооноос гарах шийдвэр гаргалаа[108]. Ойрхи-Дорнодоос Европ руу чиглэн Дундад тэнгисийг гатлан зугтаж буй дүрвэгсэд замдаа олноороо живж амь насаа алдаж байна[109]. Өргөн цар хүрээг хамраагүй ч хүн ам олноор төвлөрсөн суурин газарт террорист ажиллагаа явуулах газар орныг судлах, зэвсэг хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тээврийн хэрэгсэл худалдаж авах, түрээслэх, холбооны хэрэгсэл ашиглах, түр орогнох байрны төлбөр, хөлсийг төлөх зардлыг санхүүжүүлэх нь террорист ажиллагааг бодитой явуулах, гэмт үйлдлийг төгсгөх аюултай нөхцөлийг бүрдүүлж өгч байдаг. Тухайлбал, ийм террорист ажиллагаа болсон тохиолдолд тухайн улс дахь банк санхүү, хөрөнгийн зах зээлд уналт үүсэх, жуулчдын урсгал татрах зэрэг үр нөлөө үзүүлдэг талтай байдаг[110].

3. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

Мөнгө угаах гэмт хэрэг нь ашиг, орлого хуримтлуулдаг бүх гэмт хэргийн өсөлтөд нөлөөлж гэмт этгээдүүдийн дархлааг нэмэгдүүлдэг болохыг хүлээн зөвшөөрөөс болсноос хойш мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судлалд ач холбогдол өгч эхэлдэг болжээ. Гэсэн хэдий ч энэ сэдвээр хийгдсэн дорвитой судалгаа хомс байдаг байна. Мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг авч үзэхийн өмнө мөнгө угаах нь гэмт бүлэглэл, гэмт этгээдүүдэд ямар ач холбогдолтой байдгийг судалж үзэх нь зөв гэж Массиандро (2007) үздэг. Тэрээр мөнгө угаах нь ашиг орлого хуримтлуулдаг гэмт үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэл, гэмт этгээдийн дараах хэрэгцээ, шаардлагаас улбаатай байдагийн тодорхойлжээ[111].

Үүнд:

- "Мөнгө угаах нь хууль сахиулах байгууллагуудад илчлэгдэх эрсдэлийг бууруулж шууд утгаараа эдийн засгийн үр шимийг нэмэгдүүлж гэмт хэрэг үйлдэж олсон бохир орлогыг хувиргаж эд хөрөнгө худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, гэмт үйл ажиллагааг тэлэх боломжтой болгодог.
- Гэмт хэргийн орлогыг хууль ёсны эдийн засгийн салбарт оруулах магадлалыг нэмэгдүүлдэг.
- Гэмт этгээд, гэмт бүлэглэлийн үйл ажиллагааны өнгөлөн далдлалт, нуугдмал байдлыг нэмэгдүүлдэг".

106 Byman, D., 2016. Understanding the Islamic State-A review essay. *International Security*. 127-165 дахь тал.
107 Slack, J., Martinez, D.E., Lee, A.E. and Whiteford, S., 2016. The geography of border militarization: Violence, death and health in Mexico and the United States. *Journal of Latin American Geography*, *15*(1), 8 дахь тал.
108 Whitman, R.G., 2016. Brexit or Bremain: what future for the UK's European diplomatic strategy?. *International Affairs*, *92*(3), pp.509-529.
109 Hansen, R., 2016. Immigrants, ISIS, the Refugee Crisis, and Integration in Europe: A Response to Klaus von Beyme. *European Policy Analysis*, *2*(1), pp.14-19.
110 Barry Johnston, R. and Nedelescu, O.M., 2006. The impact of terrorism on financial markets. *Journal of Financial Crime*, *13*(1), pp.7-25.
111 Masciandaro, D., Takats, E. and Unger, B., 2007. *Black finance: the economics of money laundering*. Edward Elgar Publishing. 6 дахь тал.

Олон улсын түвшинд мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн судлагдсан байдлыг судалж үзвэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх асуудлыг олон улсын түвшинд авч үзэхдээ мөнгө угаахад боломжтой таатай орчин хаана бүрэлдсэн байна тэнд мөнгө угаагддаг гэсэн дүгнэлт хийдэг[112]. Мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг (determinants) эдийн засгийн дүн шинжилгээний арга барилаар анх удаа тодорхойлж үзэхэд хөрөнгийн чөлөөт хөдөлгөөн (либералчлал), улс орнуудын нээлттэй хил хязгаар мөнгө угаах таатай боломжийг олгодог гэжээ[113]. ".. Гэмт хэрэгтнүүд гэмт хэргийн улмаас олсон орлогоо нуухын тулд дотоодын зах зээлийг ашигласнаас олон улсын зэх зээлийг ашиглах нь илүү хялбар.."ыг эрмэлздэг[114].

Дэлхийн мөнгө угаах гэмт хэргийн эргэлт хэмжээ, цар хүрээг тодорхойлох "таталцах хүчний загвар" (gravity model)-ыг хэрэглээнд нэвтрүүлсэн Австралийн эрдэмтэн Валкер мөнгө угаахад тухайн улсын бусдыг улс орондоо ирүүлэхэд нөлөөлөх аятай таатай нөхцөл нөлөөлдөг гэжээ. Тэрээр энэхүү үндэслэлээ тайлбарлахдаа:

- Мөнгө угаахыг тэвчдэг гадаадын улс орнууд мөнгө угаахыг тэвчдэггүй улс орнуудтай харьцуулвал, илүү их хэмжээний мөнгө татах боломжтой байдаг. Мөнгө угаахыг тэвчдэг гэдэгт банкны нууцлалын тухай хууль тогтоомж хатуу, чанга хууль тогтоомжтой, мөнгө угаахтай тэмцэх бодлогыг зөвшөөрдөггүй, хамтран ажилладаггүй улс орныг ойлгоно;
- Авлигын түвшин өндөр, дотоод зөрчилдөөн, тогтворгүй байдал газар авсан улс орнуудад хөрөнгө оруулсан, байршуулсан хөрөнгөө алдах эрсдэлтэй байдаг тул мөнгө угаагчдыг үргээдэг;
- Мөнгө угаагчид ДНБ-ийн хэмжээ өндөр үзүүлэлттэй улс орнуудад мөнгийг нуух, будлиантуулахад хялбар гэж үздэг тул ийм улс орнуудыг илүүд үздэг[115];
- Бусдыг татах дур булаам чанар (attrativeness), аятай таатай нөхцөлөөс гадна улс хоорондын зай мөнгө угаахад нөлөөлдөг байна. Гадаад худалдааны урсгалд хол ойрын зай саад, тотгорт тооцогддог бол мөнгө угаахад мөн нөлөөлдөг байна. Улс орнууд орон зайн хувьд ойр байх тусам мөнгө угаалтын хэмжээ өндөр байдаг гэжээ.[116]

Унгер нь олон улсын түвшинд мөнгө угаагдах шалтгаан, нөхцөлд газар зүйн хол ойрын орон зай, хил хязгаар, хэл, соёлын ялгаа түүнчлэн худалдааны нэгдүгээр зэрэглэлийн түнш байх зэрэг хүчин зүйл нөлөөлдөг гэсэн бол эдгээр хүчин зүйлээс гадна хэлэлцээр хийх зарчим, хэв загвар, хэлний саад бэрхшээл нөлөөлдөг гэж тэмдэглэжээ[117]. Хэрвээ улс орнуудын хоорондын зай хол, өөр өөр хэлээр харилцдаг байдал, түүх, соёлын хувьд нийтлэг зүйлгүй байх, худалдаа, наймааны харилцаагүй байдал нь мөнгө угаагдах магадлал бага байхад нөлөөлдөг гэж тайлбарлажээ.

Түүнчлэн Массиандрогийн мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийхдээ гэмт бүлэглэл, гэмт этгээдийн зан төлөв, чиг хандлагыг микро эдийн засгийн аргаар загварчлах оролдлого хийсэн нь сонирхол татахуйц байдаг. Түүний үзэж буйгаар дараах хүчин зүйлс мөнгө угаахад нөлөөлдөг байна. Үүнд:

- Гэмт хэргийн улмаас олсон бохир мөнгө нь хууль ёсны гарал үүсэлтэй мөнгөтэй харьцуулахад өрсөлдөх чадвар, хөрвөх чадваргүй байдаг. Гэмт бүлэглэл, гэмт этгээдүүд гэмт хэргийн улмаас олсон орлогоо зарим тохиолдолд өдөр тутмын

112 Мөн тэнд. 11 дэх тал.
113 Мөн тэнд 1 дэх тал.
114 Мөн тэнд.
115 Том эдийн засагтай улс орнуудад мөнгө нуухад амархан байдаг бол жижиг эдийн засагтай улс орнуудад гэнэт байршуулсан мөнгө нь бусдын анхааралд өртөж сэжиг төрүүлдэгтэй холбоотой. Түүнчлэн нилээн хүн ам багатай улс орнуудад мөнгө угаах нь сэжиг төрүүлдэг аж.
116 Мөн тэнд 82-р тал.
117 Unger, B.(Унгэр, Брижжит) and Van der Linde, D. eds., 2013. Research handbook on money laundering. Edward Elgar Publishing.

хэрэглээндээ бусдын анхааралд өртөлгүй зарцуулж болоод байдаг бол банк санхүүгийн байгууллагад байршуулах, эдийн засгийн салбарт хөрөнгө оруулалт хийх, тансаг зэрэглэлийн хөдлөх, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө худалдаж авах зэрэг томоохон зарцуулалт хийхэд бусдын анхааралд өртөх эрсдэл бий болдог.

- Мөнгө угаах гэмт хэрэг илрэх илүү магадлалтай газар гэмт үзэгдлийн түвшин бага байдаг. Гэмт бүлэглэлүүд мөнгө угаах тохиолдолд санхүүгийн тодорхой зардал гаргадаг бөгөөд хэрвээ мөнгө угаах гэмт үйлдэл, үйл ажиллагааг хууль сахиулах байгууллагууд илрүүлэх өндөр магадлалтай бол гэмт бүлэглэл, гэмт этгээдүүдийн хувьд мөнгө угаах нь илүү эрсдэлтэй байдаг.
- Мөнгө угаах гэмт хэрэгт хүлээлгэх ялын бодлого хатуу, чанга хууль тогтоомжтой газар гэмт бүлэглэл, гэмт этгээдүүд мөнгө угаах оролдлого хийх нь ашиггүй байдаг.
- Угаагдсан мөнгийг нэгтгэх үе шатанд ямар эдийн засгийн ашигтай салбарт байршуулахаас мөнгө угаах үйл ажиллагаа шалтгаалдаг. Аливаа гэмт бүлэглэл нь гэмт хэргийн улмаас олсон орлогоо угаахдаа ямар эдийн засгийн салбарт хөрөнгө оруулалт хийвэл ашигтай вэ? гэдгийг ямагт бодолцож байдаг. Эдийн засгийн аль нэг салбарт гэмт хэргийн улмаас олсон угаагдсан хөрөнгийг байршуулахад илүү ашигтай байвал тухайн салбарт илүү мөнгө угаагдах чиг хандлага нэмэгддэг.

Террорист байгууллагууд бүтэц, хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, алсын хараа, зорилго, бүрэлдэхүүн, чадамжаас шалтгаалан олон янзын илрэл, хэлбэртэй байдаг. Тиймээс терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь террорист хүн, террорист байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагаас шууд хамаардаг. Террорист байгууллагын үйл ажиллагаа, дэд бүтцийг авч явахад ихэнхдээ асар өндөр зардал гардаг. Мэдээж тодорхой газар нутагт хяналтаа тогтоох зорилготой террорист байгууллагын хувьд санхүүгийн хэрэгцээ харьцангуй өндөр байх нь ойлгомжтой. Учир нь террорист байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө нь санхүүгийн чадамжаас нь шууд шалтгаалдаг тул террорист байгууллагаа нь тогтвортой мөнгөн хөрөнгө хуримтлуулах нөхцөлийг бүрдүүлэхээр тогтмол эрэлхийлж байдаг.

Террорист байгууллага нь өдөр тутмын үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, ухуулга сурталчилгаа хийх, гишүүдийг элсүүлэх, сургалт явуулах, цалин хөлс, нөхөн төлбөр олгох, нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх зэрэг өргөн хүрээний санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангах шаардлагатай болдог гэдгийг ФАФТ-ын "Терроризмын санхүүжилтийн шинээр бий буй болж эрсдэлүүд" гэдэг тайланд онцлон тэмдэглэгджээ[118].

Нөгөөтэйгүүр, цомхон террорист сүлжээ, бие даасан террорист хүний санхүүгийн хэрэгцээ шаардлага бага байдаг нь террорист халдлага үйлдэхэд үлэмж их хэмжээний зардал гардаггүйтэй холбоотой. Учир нь тодорхой газар орон, нутаг дэвсгэрт хяналт тогтоох, ухуулга сурталчилгаа явуулах, гишүүдийг элсүүлэх зэрэг далайцтай, бодлогын түвшний, логистикийн шинжтэй үйл ажиллагаа явуулдаггүйтэй холбоотой. Тухайлбал, Норвегийн Батлан Хамгаалах Судалгааны Байгууллагын жижиг, цомхон террорист сүлжээний терроризмыг санхүүжилтийн талаар хийсэн тайланд 1994-2013 оны Европын Холбооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 40 террорист халдлагын 75% орчим хувь нь 10,000 ам.доллараас бага хэмжээний зардал гарсан гэж дурдагджээ[119].

118 "Терроризмын санхүүжилтийн шинээр бий буй болж эрсдэлүүд" (Emergina Terrorist Financing Risks). Дараахь холбоосоор орж үзэх: http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Emerging-Terrorist-Financing-Risks.pdf [онлайн]. [Нэвтэрсэн:2017. 09.13]

119 Oftedal, E., 2015. *The financing of jihadi terrorist cells in Europe*. Forsvarets Forskningsinstitutt. 7-р тал

5 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Гадаад нөхцөл байдал, чиг хандлага

Мөнгө угаах болон терроризыг санхүүжүүлэх гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлагыг аль нэг улс орон өөрийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо баримт, мэдээлэлд, судалгаанд суурилан гаргах нь дутуу дулимаг гэж тооцогдохгүй ч олон улс, бүс нутгийн нөхцөл байдал, чиг хандлагыг давхар тооцдог байх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлого боловсруулахад, хариу үйлдэл үзүүлэхэд ач холбогдолтой байх талтай. ж нэYндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Палермогийн 2000 оны Конвенци нь мөнгө угаах гэмт хэргийг үндэстэн дамнасан хэрэгт тооцдог болсныг тус гэмт хэргийн гаралт зөвхөн нэг улс орноор хязгаарлагддаггүй гэмт үйлдэл гэдгийг хүлээн зөвшөөрдөг болсон нь тохиолдлын асуудал биш юм[120]. 2012 онд батлагдсан ФАТФ-ын 1-р Нэгдүгээр зЗөвлөмж нь улс орнуудыг МУТС гэмт хэргийн эрсдэлээйг тодорхойлдог байхыг ж байхыг шаарддаг болсон[121]. Сүүлийн жилүүдэд ФАТФ-ын гишүүн улс орнууд МУТС гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулдаг болж байна[122]. Эрсдэлийн үнэлгээ боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх шалтгаан нь хязгаарлагдмал нөөц бололцоог илүү оновчтой ашиглах, хуваарилахад оршдог. Монгол Улс 2016 оны 10 дугаар сард МУТС эрсдэлийн үнэлгээний анхны тайлангаа боловсруулсан байна[123].



Зураг VII.12.1. Үндэстэн дамнасан гэмт явдал, түүний урсгал[124]

Эх сурвалж: *The Globalization of Crime: Transnational Organized Crime Threat Assessment Report, UN Office on Drugs and Crime, 2010. 2 дахь тал.*

120НҮБ-ын Үндэстэн дамнасан Зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенци. Дараах холбоор орж үзэх: https://www.unodc.org/unodc/treaties/CTOC/[онлайн]. [Нэвтэрсэн: 2017.09.15]

121 ФАТФ-ын 1-р Зөвлөмж. Дараах холбоосоор орж үзэх: http://www.fatf-gafi.org/publications/fatfrecommendations/documents/fatf-recommendations.html [Нэвтэрсэн: 2017.09.15]

122**Улсын орнуудын МУТС гэмт хэргийн эрсдэлийн болон эмзэг байдлын үнэлгээний тайлангууд: Австрали:** http://austrac.gov.au/publications/mltf-risk-assessments; **Их Британ**: https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/468210/UK_NRA_October_2015_final_web.pdf; **Сингапур:** http://www.mas.gov.sg/-/media/resource/news_room/press_releases/2014/Singapore%20NRA%20Report;
АНУ: https://www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Documents/National%20Money%20Laundering%20Risk%20Assessment%20%E2%80%93%2006-12-2015.pdf; [Нэвтэрсэн: 2017.09.15]

123 Монгол Улсын МУТС гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээний тайлан 2016 он. https://www.mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf^_

124 Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал эрхэлсэн НҮБ-ын алба "Үндэстэн дамнасан гэмт хэргийн аюул, заналын үнэлгээ", Дараахь холбоосоор орж үзэх: https://www.unodc.org/documents/data-and-analysis/tocta/TOCTA_Report_2010_low_res.pdf [Нэвтэрсэн: 2017.09.15]

Мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлоход олон улс, бүс нутгийн үндэстэн дамнасан гэмт хэргийн төрөл, чиг хандлагыг тооцож байх шаардлагатай.[125]Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын албаны боловсруулсан "Үндэстэн дамнасан гэмт хэргийн аюул, заналын үнэлгээ (Transnational organized crime assessment)-нд олон улсын хэмжээнд хамгийн их аюул, занал учруулж буй үндэстэн дамнасан гэмт хэрэгт героин, кокайны хууль бус эргэлт, хүн худалдаалах гэмт хэрэг, цагаачдыг хууль бусаар хил нэвтрүүлэх, зэвсгийн наймаа, ховордсон, зэрлэг ан амьтдын эд, эрхтний наймаа, хуурамч, дууриамал бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, далайн дээрэм, кибер гэмт хэрэг зонхилж байгааг тэмдэглэсэн байна.[126]

Үндэстэн дамнасан гэмт явдал нь гэмт этгээд, гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэхээсээ илүү зах зээлийн эрэлт, хэрэгцээнээс шууд хамааралтай байдаг. Иймд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хямд төсөр ажиллах хүч, галт зэвсэг, зэрлэг ан амьтны эд эрхтэн, алт үнэт металл зэрэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт хэрэгцээ дэлхий даяар байсаар байхад түүнийг хангах, ашиг олохыг эрэлхийлсэн нийлүүлэлт байсаар байх болно гэдгийг онцлон тэмдэглэжээ.[127] Бусад оронтой харьцуулахад Монгол Улс цөөн хүн амтай, банк санхүү, хөрөнгө зах зээл хөгжлийн үе шатандаа явж байгаа улс орны хувьд гадаад орчноос хамааралтай мөнгө угаах эрсдэлд өртөмтгий байдлаар доогуур түвшинд тооцогдоно гэж үзэж болох ч Монгол Улс нь олон улсын тээвэр логистик, харилцаа холбоо, интернет технологи, цахим худалдаа, төлбөр тооцооны хэрэгслийн өргөн сүлжээнд улам их нэвтэрч, улам их харилцан хамааралтай болж байна. Эдгээр хүчин зүйлээс хамааран манай улс гадаад эх үүсвэртэй мөнгө угаах үйл ажиллагаанд өртөхгүй байх баталгаа байхгүй.

Гадаад орчноос хамааралтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн өртөмтгий байдлын үзүүлэлтэд Монгол Улс руу чиглэсэн гадны аялал жуулчлал, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч авах харилцаа, гадаад хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, төлбөр тооцооны шилжүүлэг, гадаадын зээл хөрөнгө оруулалт зэрэг багтдаг[128] гэж 2016 оны Монгол Улсын МҮТС үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланд тодорхойлжээ.

Монгол Улсын хилээр 2015 онд давхардсан тоогоор 4,859.3 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оныхоос 504.2 мянган хүн буюу 11.6%-аар өсчээ. Улсын хилээр 2015 онд орсон зорчигчдын 37.4% нь Дорноговь аймгийн Замын-Үүд, 16.6% нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, 16.5% нь Улаанбаатар, 6.7% нь Өмнөговь аймгийн Гашуун сухайт, 17.4% нь бусад боомтод оногдож байна. Газар зүйн хувьд дээрх хилийн боомтууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гадаад орчноос үүдэлтэй гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй бүс нутагт тооцогдоно.[129]Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 46.1%-ийг БНХАУ-ын иргэд, 15.7%-ийг ОХУ-ын иргэд, 10.5%-ийг БНСУ-ын иргэд, 4.2%-ийг Япон улсын иргэд, 3.3%-ийг АНУ-ын иргэд, 3.2%-ийг Казахстан улсын иргэд, 17.0%-ийг бусад орны иргэд эзэлж байна. Харин манай улсад 2015 оны байдлаар 78 орны 6.8 мянган иргэн хөдөлмөр эрхэлж байгаагаас 35.4% нь БНХАУ-ын, 23.0% нь БНАСАУ-ын, 8.3% нь ОХУ-ын, 6.7% нь БНСУ-ын, 4.2% нь АНУ-ын, 3.4% нь БНСВУ-ын, 19.0% нь бусад улсын харьяат иргэд байна.[130]

Манай улстай гадаад худалдаа, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын өргөн харилцаатай, хөрш зэргэлдээ, Монгол Улсын иргэд түгээмэл зорчдог, мөнгө угаах өндөр эрсдэлтэй 6 улс

125 "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхины хууль бус эргэлтийн аюул, заналын бүс нутгийн сэдэвчилсэн нөхцөл байдлын тайлан", "Дэлхийн Хар тамхины хууль бус эргэлтийн тайлан"- (World drug report)-г тус тус боловсруулж, олон нийтийн хүртээл болгодог. https://www.unodc.org/wdr2016/

126 https://www.unodc.org/documents/data-and-analysis/tocta/TOCTA_Report_2010_low_res.pdf

127 Мөн тэнд 18 дахь тал.

128 Монгол Улсын МҮТС үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан. 2006 он. 15 дахь тал. Дараах холбоосыг үзэх: https://www.mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf, [Нэвтэрсэн: 2017.09.15]

129 Мөн тэнд.

130 Мөн тэнд. 15 дахь тал.

орон, тусгай бүс (БНХАУ, ОХУ, Япон, Макао, Хонг Конг, Сингапур)[131]-ийг сонгон 2016 оны байдлаарх мөнгө угаах гэмт хэргийн бүс нутгийн ерөнхий нөхцөл байдал, чиг хандлагыг товч түүвэрлэн авч үзвэл[132]. Үүнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улс-ын санхүүгийн салбарын хөгжлийг дагаад гэмт бүлэглэлийн сүлжээ улам боловсронгуй болж байгаа нь Хятадын эрх баригчдын зүгээс тэдгээрийн хурд, хэмнэлийг гүйцэхэд ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай болж байна.[133] Гэмт хэргийн орлогын үндсэн эх үүсвэр нь авлига, хээл хахууль, мансууруулах бодис, хүний худалдах, хориглосон, хязгаарлсан бараа, бүтээгдэхүүн хууль бусаар хил нэвтрүүлэх, эдийн засгийн гэмт хэрэг, оюуны өмчийн зөрчил, хуурамч бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өмчийн эсрэг гэмт хэрэг, татвараас зайлхсийх гэмт хэрэг тооцогдож байна. Гэмт хэргийн орлогыг ерөнхийд нь их хэмжээний бэлэн мөнгө хил давуулах, гадаад худалдааны механизм ашиглах; тээвэрлэх, ачуулах, бараа, үйлчилгээний төлбөрийн даалгаврыг будлиантуулах; үл хөдлөх хөрөнгө, алт, урлагийн бүтээл, зааны ясан сийлбэр зэрэг өндөр үнэ өртөгтэй хууль бус хөрөнгө худалдаж авах; хууль ёсны салбарт хөрөнгө оруулалт хийх; мөрийтэй тоглоомын салбарыг ашиглах, албан болон албан бус санхүүгийн тогтоолцоог урвуулан ашиглах замаар угааж байна. БНХАУ-д гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдэхдээ санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээ (онлайн банк, гуравдагч этгээдийг төлбөрийн систем)-ний давуу талыг ашиглах болсоныг хятадын эрх баригчид онцлон тэмдэглэж байна[134] .

БНХАУ-ын өндөр албан тушаалтнууд, төрийн өмчит аж ахуйн нэгж холбогдсон авлигын гэмт хэрэг өндөр үзүүлттэй байгааг тэмдэглэж байна. 2013 оны байдлаар 182,000 улс төрийн намд хамааралтай албан тушаалтнуудад авлигын хэргээр ял шийтгэл оногдуулжээ[135].Дэлхийн Санхүүгийн шударга байдлын үнэлгээ (Global Financial Integrity/GFI)-ээс үзэхэд БНХАУ нь гадаад худалдааны төлбөр тооцооны үнэ өртөг (trade-mis-invoicing)-ийг будлиантуулах үйл ажиллагаанд Дэлхийн хууль бус мөнгөний урсгалаар тэргүүлж байна. Тус байгууллагын тооцоолсноор 260 тэрбум хууль бус ам.доллар БНХАУ-аас гадагшилсан байна[136]. Авлигын гэмт хэргээс олсон хөрөнгө ихэнхидээ хөгжингүй улс орнуудад (АНУ, Канад, Их Британи гэх мэт) байршиж угаагддаг бөгөөд Хятадын авлигын хөрөнгө сүүлийн жилүүдэд Их Британий үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөөсрүүлсээр байна гэж үзжээ.[137] Тус улсад итгэмжлэгч, гуравдагч этгээд, гэр бүлийн гишүүн, садан төрлийн хүмүүсийг мөнгө угаахдаа ашигладаг нь нийтлэг байдаг аж.

131 ФАТФ-ын бүс нутгийн байгууллагууд бүс нутгийн МУТС гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлохын тулд жил бүр санал асуулгын аргаар гишүүн улс орнуудаас мэдээлэл цуглуулж МУТС гэмт хэргийн арга, чиг хандлагын тайлан боловсруулдаг. Дараах холбоосыг үзэх: http://apgml.org/methods-and-trends/page.aspx?p=8d052c1c-b9b8-45e5-9380-29d5aa129f45 [Нэвтэрсэн: 2017.09.15]

АНУ-ын Төрийн Департаментын бүтцэд харьяалагддаг "Олон Улсын Мансууруулах бодис болон хууль сахиулах хэргийг хамаарах товчоо" (Bureau of International Narcotics and Law Enforcements Affairs) нь Дэлхийн 200 улсын мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдалд үндэслэн Олон Улсын Хар Тамхины Хяналт Стратегийн тайланг жил бүр эрхлэн боловсруулдаг. Энэ тайланд дурдагдсан мэдээлэл ФАТФ-ын бүс нутгийн байгууллагуудын судалгаанд суурилдаг тул энэхүү судалгааг хамгийн үл сууртай, найдвартай эх сурвалж гэж үзэж байна. Уг товчоо нь гол анхаарлын төвд орших улс орнууд (Jurisdictions of Primary Concern), анхаарал татах улс орнууд (Jurisdictions of Concern), хяналтанд байлгах бусад улс орнууд (Other Jurisdictions Monitored) гэсэн ангилалд тус тус оруулж эрсдэл, аюул занал, эмзэг байдлын түвшинг тодорхойлдог. Холбоос: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/253367.htm

132 АНУ-ын Төрийн Департамент жил бүр Конгресст танилцуулдаг Олон улсын мансууруулах бодисын эргэлтэнд хяналт тавих стратегийн тайлан (The International Narcotics Control Strategy Report (INCSR)-г ашиглав. Холбоос: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/index.htm

133 БНХАУ нь мөнгө угаах өндөр эрсдэлтэй улс орнуудын ангилалд багтдаг. Countries/Jurisdictions of Primary Concern – PRC. Link: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/253391.htm

134 Онлайн банкны харилцагч өөрийн дансаа тогтмол хянах боломжтой байдлийн зэрэгцээ гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэх болон цоог бүрдүүлдэг бөгөөд гуравдагч этгээдийг ашигласан төлбөрийн системд харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах таарууган хийгддэг тул мөнгөний урсгалын гинжин холбоог салгадаг байна. Иймээс төрлийн үйлчилгээ нь харилцагчийн хувьд амар хялбар боловч мөнгө угаахын эсрэг хяналт тавихад хүндрэлтэй байдаг.

135 Xing. L, Corruption in China. Eds.. Rider, B. ed., 2015. Research Handbook on International Financial Crime. Edward Elgar Publishing. 417 дахь тал.

136 Countries/Jurisdictions of Primary Concern – China. Дараахь холбоосоор орж үзэх: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/253391.htm [Нэвтэрсэн 2017.09.16.]

137 Chen I., Chiu J., Beijing goes hunting for overseas real estate bought with dirty money^ https://qz.com/143017/beijing-goes-hunting-for-overseas-real-estate-by-corrupt-officials/[Нэвтэрсэн 2017.09.16.]

Япон Улс нь бүс нутгийн санхүүгийн төв юм. Тус улс нь зохион байгуулалттай гэмт бүлэглэл (Якуза), Мексикийн хар тамхины бүлэглэл, бусад дотоодын болон гадаадын гэмт этгээдүүдийн өргөн хүрээний мөнгө угаах үйл ажиллагааны эрсдэлтэй нүүр тулсаар байна. Сүүлийн жилүүдэд Япон Улсад оршин суудаг Баруун Африкийн улс орнууд (Нигер, Гана г.м.)-ын иргэдийн үйлддэг олон төрлийн залилан, санхүүгийн гэмт хэргийн үзүүлэлт нэмэгдэж байна. Тус улсад ашиг орлого хуримтлуулдаг залилан, мөнгө хүүлэх (loan sharking), хулгай, хар тамхины наймаа, интернет орчин дахь хэрэглэгчийн банкны, зээлийн картны мэдээллийг вирус тараах эсхүл хууран мэхлэх замаар хулгайлах (phishing) гэмт хэргүүд зонхилж байна.[138] Тус улсад биеэ үнэлэлтийг зохион байгуулах, казино хориотой (саяхнаас нээлттэй болох шийдвэр гарсан) байдгаас их хэмжээний гэмт хэргийн орлого хуримтлагддаг ажээ. Япон улсад санхүүгийн шинэ үйлчилгээ, төлбөрийн шинэлэг хэрэгсэл, интернет технологийг мөнгө угаахад ашиглах нь түгээмэл байна.[139]

БНХАУ-ын Засаг Захиргааны Тусгай Бүс Макао нь бүс нутгийн санхүүгийн томоохон төвд тооцогддоггүй хэдий ч зарим нэг оффшор санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг бизнесийн салбартай (зээлийн байгууллага, даатгалын компани, итгэлцлийн удирдлагын компани гэх мэт)-д тооцогддог байна. Тус бүс нь жилдээ 30 тэрбум ам.долларын ашигтай ажилладаг дэлхийн мөрийтэй тоглоомын төв юм. Макаогийн өнөөгийн мөнгө угаах эрсдэл нь эх газрын Хятадаас хууль бус хөрөнгө шилжих үйл явцыг дэмжиж, нууц далд санхүүгийн тогтолцоог идэвхитэй хөхүүлэн дэмждэг.[140] Санхүүгийн Тагнуулын Албанд ирүүлдэг сэжигтэй гүйлгээний 75 хувь нь мөрийтэй тоглоомын салбараас, 24 хувь хувь нь санхүүгийн салбар (банк, даатгал, санхүүгийн зуучлал), 1 хувь хувь нь бусад салбараас бүртгэгдсэн бол мөнгө угаах арга барилын хувьд бэлэн мөнгийг казиногийн чип болгох, бэлэн бус шилжүүлэг хийх, их хэмжээний мөнгө бэлнээр гаргуулах, эх сурвалж нь тодорхойгүй бэлэн мөнгө байршуулах, улс төрд нөлөө бүхий этгээдүүдтэй холбоотой сэжигтэй гүйлгээ илэрчээ.[141] Монгол Улсын хувьд тус бүсэд чөлөөтэй зорчих боломж нь дотоодод үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтай орлого, хөрөнгө угаагдах эрсдэлийг дагуулж болох юм.

Оросын Холбооны Улс нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн тогтолцоогоо боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байгаа ч тус улс дахь мөнгө угаах гэмт хэргийн гаралт өндөр байгаагаас санхүүгийн салбарын хөгжилд томоохон хүндрэл бэрхшээл учруулж байна. Мөнгө угаах нь ОХУ-ын эдийн засагт олон тэрбум ам.долларын хохирол учруулж байна. 2014 онд 8.6 тэрбум ам.доллар, 2015 оны эхний хагас жилд 936 ам.долларын "зохиомол", "дүр эсгэсэн" гүйлгээ (fictitious transactions)-ээр тус улсаас шилжжээ. ОХУ-д угаагддаг мөнгөний дотоод эх үүсвэр нь зохион байгуулалттай гэмт хэрэг, татвар, гаалийн хураамжаас зайлсхийх, залилан, хориглосон, хязгаарласан барааг хил нэвтрүүлэх, хар тамхи, авлигын гэмт хэргүүд тооцогдож байна. Засгийн газрын бүх түвшинд авлига, хээл хахуулийн гэмт хэргийн нөхцөл байдал ноцтой түвшинд байсаар байна. Гэмт хэргийн гаралтай орлогын ихэнхи хэсгийг гол төлөв оффшор санхүүгийн төв рүү шилжүүлдэг явдал нийтлэг байна.[142]

Түүнчлэн ОХУ-д кибер гэмт хэргийн аюул, заналхийлэл тулгамдсан асуудалд тооцогдсоор байна. Оросын хакерууд болон уламжлалт гэмт бүлэглэлийн сүлжээ нь хамтын хүчин чармайлтаа нэгтгэх дэлхийн нийтийн чиг хандлагыг улам ихээр дагаж санхүүгийн тогтолцоонд аюул заналхийлэл учруулах нь нэмэгдэж байна. Тус улс нь олон

138 Asia Pacific Group on Money Laundering. Typologies Report.(2016). 18-р тал. Дараахь холбоосоор орж үзэх: http://amlcft.bnm.gov.my/publication/M16_APG%20Yearly%20Typologies%20Report%202016.pdf; [Нэвтэрсэн 2017.09.16.]

139 Мөн тэнд.

140 Countries/Jurisdictions of Primary Concern – China. Дараахь холбоосоор орж үзэх: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/253419.htm; [Нэвтэрсэн 2017.09.16.]

141 Asia Pacific Group on Money Laundering. Typologies Report.(2016). 18-р тал. Дараахь холбоосоор орж үзэх: http://amlcft.bnm.gov.my/publication/M16_APG%20Yearly%20Typologies%20Report%202016.pdf; [Нэвтэрсэн 2017.09.16.]

142 Ledyaeva, S., Karhunen, P. and Whalley, J., 2013. Offshore jurisdictions (including Cyprus), corruption money laundering and Russian round-trip investment (No. w19019). National Bureau of Economic Research.

улсын мансууруулах бодис тээвэрлэгчдийн хамгийн өргөн цар хүрээтэй дамжин өнгөрөх болон эцсийн хэрэглэгч улс гэдэг ангилалд багтсаар байна. ОХУ болон хөрш зэргэлдээ улс орнуудын эрүүгийн гэмт хэрэгтнүүд ОХУ-ын санхүүгийн систем, гадаадын хуулийн этгээдийг мөнгө угаахдаа ашигласаар байна. Гэмт этгээд гэмт хэргийн орлогоо хөрөнгийн зах зээл, дотоодын болон хилийн чанад дахь үл хөдлөх хөрөнгийн зах зээлд байршуулж хууль ёсны болгон хувиргах аргуудыг хэрэглэж байна. Тус улсад казиногийн үйл ажиллагаа тусгайлсан бүс нутагт явагддаг. Интернетийн орчинд мөрийтэй тоглох нь хориотой байдаг. Албан бус мөнгө шилжүүлгийн механизм мөнгө угаах эмзэг байдлыг бий болгосоор байна. 2014 оны байдлаар мөнгө угаасан үндэслэлээр 164 хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ. Сергей Магины 14 халхавч компани байгуулан 2.7 тэрбум долларыг гадаад улс руу гаргасан хэрэг хамгийн зартайд тооцогдож байна.[143] Харин хамгийн сүүлийн байдлаар тус улсаас 2000-2014 оны хооронд Молдав Улсаар дамжуулан нийт 22 тэрбум ам.долларыг гаргасан мөнгө угаах гэмт хэргийн олон улсын мөрдөн шалгах ажиллагаа мухардалд орсоныг 2017 оны 3 дугаарын 20-ны өдөр BBC агентлаг мэдээлж байна [144]. Оросын Qiwi гэх цахим төлбөр тооцооны томоохон систем нь 2016 онд Bitruble хэмээх цахим валютыг зах зээлд нэвтрүүлэхээ мэдэгдсэн. Хэдийгээр Биткойн ОХУ-д хууль бус боловч хэрвээ Bitruble зах зээлд нэвтэрвэл тус улсын хууль сахиулах байгууллагууд мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нилээн саад бэрхшээлтэй тулгарна гэж үзэж байна.[145]

БНХАУ-ын Тусгай Засаг Захиргааны Бүс Хонг Конг нь олон улсын санхүүгийн болон худалдааны гол төв юм. Хонг Конгийн хөрөнгийн зах зээл нь зэрэглэлээрээ дэлхийд эхний зургаад, Азид эхний гуравт жагсдаг. Гадаад гүйлгээний цар хүрээгээр дэлхийн найм дахь банк санхүүгийн төв бөгөөд тав дахь гадаад валютын солилцооны томоохон төвд тооцогддог. Хонг Конг нь юаний үндсэн оффшор санхүүгийн төв болохын хувьд 2015 оны 9 сарын байдлаар 158 тэрбум ам.доллартай тэнцэх хөрөнгийг албан ёсны санхүүгийн байгууллагуудад байршуулжээ. Хонг Конг нь хуулийн этгээдийг бүртгэх, хяналт тавих зорилгоор оффшор бүсэд харьяалагддаг компани, оффшор бүсэд харьяалагддаггүй компани гэж ялгадаггүй. Хонг Конгийн татвар, хураамжийн хялбаршуулсан тогтолцоо, боловсронгуй банкны систем, халхавч компани байгуулах зуучлалын үйлчилгээ, боомтын чөлөөт статус, валютын эргэлт, солилцоонд хяналт тавьдаггүй хүчин зүйлс нь мөнгө угаах таатай нөхцөлийг бүрдүүлж, эрсдэл дагуулдаг. Хонг Конгийн эрх баригчид угаагдсан хөрөнгийн гол үүсвэр нь дотоодод болон гадаадад үйлдэгдсэн залилан, санхүүгийн гэмт хэрэг, хууль бус мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа, мөнгө хүүлэх, эд зүйл хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргүүд гэж тодойрхойлсон. 2015 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар мөнгө угаах 194 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 99 хэргийг шүүхээр шийдвэрлэжээ. Хонг Конгоор дамжин Колумбын хар тамхины гэмт бүлэглийн 5 тэрбум ам.доллар угаагдсан хэрэг илэрсэн байна.[146]

МОНГОЛ УЛСЫН ДОТООД НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

ФАТФ нь мөнгө угаахын суурь гэмт хэрэгт тооцогдох 21 төрлийн томоохон гэмт хэргийг тодорхойлсон[147] бөгөөд эдгээрийг Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх

143 Интерфакс. "Суд приговорил двух финансистов к 8,5 годам тюрьмы за вывоз 122 млрд рублей за границу". Дараах холбоосоор үзэх: http://www.interfax.ru/russia/543531, [Нэвтэрсэн 2017.09.16.]

144 BBC Русская служба. "Что мешает расследовать дело о выводе из России 22 млрд долларов". Дараах холбоосоор үзэх: http://www.bbc.com/russian/features-39329634, [Нэвтэрсэн 2017.09.16.]

145 Countries/Jurisdictions of Primary Concern – China. Дараахь холбоосоор орж үзэх: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/253427.htm [Нэвтэрсэн 2017.09.16.]

146 Countries/Jurisdictions of Primary Concern – China. Дараах холбоосоор орж үзэх: https://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2016/vol2/253428.htm [Нэвтэрсэн 2017.09.16.]

147 FATFMethodology 2012, Дараах холбоосоор орж үзэх: http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/methodology/FATF%20Methodology%2022%20Feb%202013.pdf, [Нэвтэрсэн 2017.09.16.]128 дахь тал.

Үндэсний эрсдэлийн үнэлгээнд манай улсын Эрүүгийн хуулийн 86 зүйлийг хамарч байна хэмээн үзжээ. Эрүүгийн хуулийн эдгээр зүйл нь шунахайн сэдэлтэй, ихээхэн ашиг орлого бүрдүүлдэг дийлэнх нь зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргүүд юм.

Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах гол тактик нь мөнгөний урсгалыг хөөх (*follow the money trail*) арга байдгийн хувьд эдгээр гэмт хэргийн зүйл ангиас мөрдөн шалгасан хэргийн тоо, эзэн холбогдогчийн тоо, битүүмжилсэн хөрөнгө, хураасан хөрөнгө зэрэгт дүн шинжилгээ хийж хамгийн их эрсдэлтэй гэмт хэргийг тодорхойлжээ.

ЦЕГ, УЕПГ, ШЕЗөвлөлөөс өмнө дурдсан 86 гэмт хэргээр битүүмжилсэн хөрөнгийн үнийн дүнгээр жагсаахад Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл (Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх)-д заасан гэмт хэрэг нь 271,517,450,979 төгрөг битүүмжилсэнээр нэгдүгээрт жагсаж, хамгийн их хөрөнгө битүүмжилсэн 30 гэмт хэргийн 75%-ийг ганцаараа бүрдүүлж байна. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх болон хулгайлах гэмт хэрэг (148, 145 дугаар зүйл) нь прокурорын байгууллагад шалгагдсан эрүүгийн хэргийн эхний байруудыг эзэлж байна (Хүснэгт №5.2 Хамгийн их хөрөнгө битүүмжилсэн 10 гэмт хэрэг).

Хүснэгт VII.12.1. Хамгийн их эд хөрөнгө битүүмжилсэн 10 гэмт хэрэг (2012-2015, УЕПГ)

№	Эрүүгийн хуулийн зүйл анги	Прокурорын байгууллагад шалгагдсан гэмт хэргийн тоо	Шүүхэд шилжүүлсэн нийт гэмт хэргийн тоо	Гэмт хэргийн төрлөөр битүүмжилсэн хөрөнгө	Хамгийн их хөрөнгө битүүмжилсэн эхний 30 гэмт хэрэгт эзлэх хувь
1	148 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах	5,809	598	203,083,769,948	75 хувь
2	273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	35	4	10,211,000,000	3.8 хувь
3	150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	1,176	236	8,807,921,070	3.2 хувь
4	166 дугаар зүйл. Татвар төлөхөөс зайлсхийх	236	23	8,731,527,884	3.2 хувь
5	145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах	30,384	4,448	8,363,580,341	3.1 хувь
6	166[1]дүгээр зүйл. Мөнгө угаах	1	1	7,855,610,000	2.9 хувь
7	175 дугаар зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	285	159	4,910,079,217	1.8 хувь
8	263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	157	31	4,712,900,000	1.7 хувь
9	214 дүгээр зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	111	12	2,722,246,103	1.0 хувь
10	211 дүгээр зүйл. Ойн тухай хууль тогтоомж зөрчих	583	395	2,459,954,444	0.9 хувь

Эх сурвалж: *УЕПГ, 2016 оны 6 сар, Улаанбаатар хот.*

Прокурорын байгууллагад шалгаж, шүүхэд шилжүүлсэн гэмт хэргийн тоо, битүүмжилсэн хөрөнгийн хэмжээг харьцуулахад 211 дүгээр зүйл (Ойн тухай хууль тогтоомж зөрчих)-

ээр 583 хэрэг шалгагдаж битүүмжилсэн хөрөнгийн хэмжээгээр 10 дугаарт (2,459,954,444 төгрөг) эхний 10 битүүмжилсэн хөрөнгийн 0.9%-ийг эзэлж байхад 166[1] дүгээр зүйл (Мөнгө угаах)-ээр 6 хэргийг шүүхэд шилжүүлсэн ч битүүмжилсэн хөрөнгийн хэмжээгээр 6 дугаарт (7,855,610,000 төгрөг) эхний 10 битүүмжилсэн хөрөнгийн 2.9%-ийг дангаараа эзэлж байна. Хамгийн их эд хөрөнгө битүүмжилсэн гэмт хэргийн төрлийг "График № 5.4"-т тусгав.

График VII.12.1. Монгол Улсад хамгийн их эд хөрөнгө битүүмжилсэн гэмт хэргийн төрөл (2012-2015, УЕПГ)[148]



Эхсурвалж: *Улсын ерөнхий прокурорын газар, 2016 оны 6 сар, Улаанбаатар хот.*

Гэтэл шүүхийн шийдвэрээр хураасан хөрөнгийн хэмжээгээр эхний 20 гэмт хэргийг жагсаахад 211 дүгээр зүйл (Ойн тухай хууль тогтоомж зөрчих)-ээр 703 холбогдогчтой 424 гэмт хэрэг анхан шатны шүүхээр шийтгэх тогтоол үйлдэж 1,440,729,037 төгрөгөөр 11 дүгээрт бичигдэж байхад 166[1] дүгээр зүйл (Мөнгө угаах)-ээр 7 холбогдогчтой 1 хэрэг 19,009,915,334 төгрөгөөр гуравдугаарт жагсаж байна.[149]

2012-2015 онд хамгийн их хөрөнгө хураасан гэмт хэргийн зүйл ангиас харахад[150] 156 зүйл (Банкны тухай хууль тогтоомж зөрчих) нь 72,658,000,135 төгрөг нэгдүгээрт (43 холбогдогчтой 21 хэрэг), 148 зүйл (Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах) 52,934,785,236 төгрөгөөр хоёрдугаарт (772 хүнтэй, 681 хэрэг) жагсаж байна. 2012-2015 оны хооронд Монгол Улсын хэд хэдэн банк дампуурч, банкны салбарын хувьд онцгой мөчлөгтэй жилүүд байсан тул 156 дугаар зүйл хэт өндөр өсөлттэй гарсан гэж үзэж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй зайлшгүй холбогддог ч уг гэмт хэргийг зөвхөн авлигын гэмт хэрэгтэй холбох нь өрөөсгөл ойлголт. Учир нь нийгмийн аюулгүй байдалд хор хөнөөл учруулдаг, зохион байгуулалттай бусад гэмт хэргийн хөрөнгө,

148 Монгол Улсын МУТС-ийн Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан 2016, 42 дахь тал,
Дараах холбоосоор орж үзэх: https://mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf, [Нэвтэрсэн 2017.09.16.]
149 Прокурорын байгууллагаас шүүхэд шилжүүлсэн хэрэг нь нэмэлт хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтад буцаж дараа ондоо шүүхээр шийдвэрлүүлэх, мөн шүүх хэргийг цагаатгасан, хэрэгсэхгүй болгосон зэрэг шийдвэрээс хамаарч энэ 2 байгууллагаас ирүүлсэн тоон үзүүлэлт хоорондоо таарахгүй байна (ШЕЗ-ийн тайлбар, 2016.04 сар).
150 Шүүхийн Ерөнхий Зөвлөл.

орлого ашиг, арга хэрэгслийг илрүүлж, хураан авч, бохир мөнгийг угаахаас урьдчилан сэргийлж, гэмт хэргийг таслан зогсоох нь зөвхөн авлигын гаралтай хөрөнгө бус бусад хэд хэдэн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж, таслан зогсооход маш чухал ач холбогдолтой. Тухайлбал, 2012-2015 онуудад битүүмжилсэн, хураасан хөрөнгийн статистикаас харахад Эрүүгийн хуулийн 263-273 дугаар зүйлд хамаарах авлига, албан тушаалын гэмт хэрэг тэргүүлэх байр эзэлж байгаа ч БХЖЭсрэг гэмт хэргийн бүлэгт багтах хууль бусаар ашигт малтмал олборлох, мод бэлтгэх, ховордсон ан амьтан, ургамал, соёлын болон түүхэн үнэт зүйлс хил давуулан худалдах, татвараас зайлсхийх, төлбөр тооцооны шинэ хэрэгсэл ашиглаж залилан мэхлэх, банкны хууль тогтоомж зөрчих, ББСБ-ын хууль тогтоомж зөрчих, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис нэвтрүүлэн худалдаж мөнгө угаах зэрэг гэмт хэргийг орхигдуулж болохгүй.

Үндэсний эрсдлийн үнэлгээ (цаашид ҮЭҮ гэх)-ний тайланд Монгол Улсад эдийн засаг, нийгэмд учруулах үр дагавар (хохирлын хэмжээ, битүүмжлэгдсэн, хураагдсан дүн, төсөөлөл), үйлдэгдэх магадлал (хэргийн тоо, төсөөлөл)-ыг тооцож мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбогдох хамгийн их эрсдэлтэй 17 гэмт хэргийг эрсдэлийн түвшнээр нь эрэмбэлэн тодорхойлсон байна.[151] Мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг дор дурдав. Үүнд:

Нэгдүгээрт, бусдыг залилан мэхлэх гэмт хэргийг нийгэмд учруулж буй хор хохирлын хэмжээ, хамрах хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхойлжээ. Залиланд "...төр, олон нийт, хувийн өмчийг завших, үрэгдүүлэх, залилан мэхлэж авах, ялангуяа, нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгалтай холбоотой залилан мэхлэх үйл ажиллагаа тасрахгүй байна. Зээл, кредит карт, бусад төлбөрийн хэрэгсэл ашиглах замаар залилах, ашиг амлах, итгэл алдуулах замаар хууран мэхлэх, хуурамч баримт, нэхэмжлэл үйлдэх замаар залилах, цахим орчин дахь залилан, сүлжээ, пирамидын бизнесийн залилангууд"[152] Монгол Улсад тогтмол өсөлттэйгөөр үйлдэгдэж байна.

Хоёрдугаарт, БХЖЭсрэг гэмт хэрэг орж байгаа бөгөөд манай улсад ашигт малтмал хууль бусаар олборлохдоо зохион байгуулалтын хэлбэрт орж, хүнд машин механикм ашиглаж, ашигт малтал хууль бусаар хил дамнуулан худалдах, хууль бусаар мод бэлтгэх, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулж буйг харгалзан үзэж өндөр эрсдэлтэй гэмт хэрэгт багтаасан байна.

Гуравдугаарт, татвараас зайлсхийх гэмт хэрэг орж байгаа бөгөөд татвараас зайлсхийхийг нийгэмд хүлээн зөвшөөрч болохуйц үзэгдэл мэтээр хандах хандлага үүсээд байгаа нь улсын төсвийн бүрдүүлэлт, татварын бааз суурьт сөргөөр нөлөөлж байна. Энэ нь Татварын өршөөлийн тухай хуулийг ойр ойрхон баталдагтай мөн холбоотой байж болзошгүй.

Дөрөвт, авлига, албан тушаалын гэмт хэргийг оруулсан учир нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгасан хэргийн тоо, эзэн холбогдогчийн тооноос харахад бага ч далд хэлбэрээр, урт хугацааны туршид бусад гэмт хэрэгтэй нийлж эсхүл огтлолцсон байдлаар үйлдэгддэг онцлогтой, илрүүлэхэд төвөгтэй, нийгэмд учруулж буй хохирлын хэмжээ маш өндөр байдгаас үүдэн мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэрэгт багтаажээ.

Мөнгө угаах дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хүн худалдах гэмт хэрэг, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хадгалах, бэлтгэх, борлуулах, зохион байгуулалтай гэмт бүлэглэл зэрэг гэмт хэргийг тусгасан байна. Мөн банкны тухай хууль тогтоомж зөрчих, бусдын эд хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, гадаадад үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтай

151 Мөнгө угаах, терроризмыгсанхүүжүүлэхүндэснийэрсдэлийнүнэлгээнийтайлан, 2016 оны 10 сар. https://mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf, 55-57 дахь тал.

152 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан, 2016 оны 10 сар. https://mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf , 55 дахь тал.

хөрөнгө Монгол Улсад илэрсэн, дамжуулан ашигласан зэрэг гэмт хэрэг үйлдэгдэж байгаатай холбоотой энэ төрлийн гэмт хэргийг мөнгө угаах дундаж эрсдэлтэй гэж үзжээ.

Харин мөнгө угаах бага эрсдэлтэй гэмт хэрэгт мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх, гэмт хэргийг нуун далдлах, мөрийтэй тоглох гэмт хэргийг оруулсан бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн эрсдэл нь бусад шунахайн сэдэлттэй гэмт хэрэгтэй харьцуулахад харьцангуй бага боловч тэдгээрийг тодорхой хяналтад байлгах шаардлагатай гэж ҮЭҮ-ний тайланд дурджээ.

Гэмт этгээдүүд, мэргэжлийн мөнгө угаагчид эдийн засгийн ямар салбар, санхүүгийн ямар бүтээгдэхүүн, үйлчилгээг, хуулийн этгээдийн ямар хэлбэрийг урвуулан ашиглаж болох талаар ямагт судалж, тухайн салбарын сул талыг тодорхойлохыг эрэлхийлж байдаг. Гэмт этгээдүүд гэмт хэргийн улмаас олсон орлогоо угаах эдийн засаг, санхүүгийн салбарыг сонгохдоо тухайн салбарын ашигтай байдал, эрх баригчдын зүгээс тухайн салбарт тавьдаг хяналт, шалгалтын түвшинг зайлшгүй харгалздаг. Иймд МУТС-тэй тэмцэх нөхцөл байдлын судалгаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бүхий гэмт хэргийн нөхцөл байдлыг судлах нь зайлшгүй байдгийн зэрэгцээ эдийн засгийн аль салбарыг, санхүүгийн ямар бүтээгдэхүүн, үйлчилгээг, хуулийн этгээдийн ямар хэлбэрийг урвуулан ашиглах боломжтой эсэхийг судалж тогтоох ажлыг орхигдуулж болохгүй.

Түүнчлэн, тухайн улсын далд эдийн засгийн түвшин мөнгө угаах үйл ажиллагаанд таатай орчин нөхцөл бүрдүүлж болно. Албан бус эдийн засаг нь манай улсын ДНБ-ийн 35 гаруй хувийг эзэлж байна гэж дурджээ.[153] Албан бус эдийн засаг гэж ДНБ-нд тусгагдаагүй буюу эцэг эх нь хүүхдээ гэртээ асран халамжлах, өрхийн жижиг бизнес эрхлэх зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж байгаа ч ДНБ-д тусгагдаагүй үйл ажиллагааг бүхэлд нь хамруулан ойлгодог бол сүүдрийн эдийн засаг нь хууль бус гаралтай хөрөнгө, мөнгө эргэлддэгээрээ ялгагддаг. Одоогоор Монгол Улсын сүүдрийн эдийн засгийн хэмжээг тодорхойлсон дорвитой судалгаа байхгүй ч сүүдрийн эдийн засаг нь манай улсад төдийгүй хөгжингүй орнуудад 17.2%, хөгжиж буй орнуудад 36.3%, шилжилтийн эдийн засагтай орнуудад 35.4%-тай тэнцдэг байна.[154]

153 "Албан бус эдийн засаг", МБСГ-ын эдийн засагч Д.Энхзаяа, Монголбанкны судалгааны товхимол 8 (2013).
154 Friedrich Schneider, Andreas Buehn, Claudio E.Montenegro, (2010), "Shadow economies all over the World: New estimates for 162 Countries from 1999 to 2007", Policy research working paper 5356, Poverty and Inequality Team, Development Research Group, and the Human Development Economics Unit, Europe and Central Asia Region, The World bank.

ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ЯВДАЛ



13. ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ЯВДАЛ

НЭГ. ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн чиг хандлага бол эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгэхээс илүүтэй гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг нь нөхөн төлүүлэхийг чухалчилж байгаа учир төлөхөөс зайлсхийсэн татварын орлогыг нөхөн төлүүлэх нь эдийн засгийн хувьд хавьгүй өгөөжтэй болох нь хэнд ч тодорхой билээ.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн гол шинж нь түүний нуугдмал байдалтай холбоотой бөгөөд олон улсын криминологийн судалгаагаар бүртгэгдсэн 1 гэмт хэргийн ард 3-10 гэмт хэрэг нуугдаж байдаг бол авилга, татвараас зайлсхийх зэрэг онцлог гэмт хэргүүдийн цаана 1:100 гэмт хэрэг нуугдаж байх бүрэн магадлалтай ажээ.

Бид зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн хүрээнд судалгаа хийж харьцангуй цөөн бүртгэгддэг гэмт хэргүүдийг анхаарлын төвөөс холдуулдаг нь гэмт хэрэгтэй тэмцэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд хүндрэл учирдаг.

Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд нуугдмал гэмт явдлын талаар тодийлөн ойлголтгүй байдаг учир жилд 10 гаруйхан гэмт хэрэг бүртгэгддэг, бүртгэгдсэн гэмт хэргийн 50% нь шүүхээр шийдвэрлэгддэг, ийм цөөхөн хэрэг гарч байхад энэ татвараас зайлсхийх гэмт хэрэгт анхаарал хандуулах зүйл юу байна гэж төсөөлдөг нь түгээмэл.

Манай улсад 1 жилд татвараас зайлсхийсэн 60-90 татварын маргаанд эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг гэж үзвэл 600-900 татвараас зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэгдсэн байх бүрэн магадлалтай билээ. Нуугдмал гэмт хэргийн улмаас улсын төсөвт орох ёстой хэчнээн хэмжээний орлого орох боломжтой байсныг 2015 онд баталсан Эдийн засгийн өршөөл үзүүлэх тухай хуулиар ил болсон 36 их наяд төгрөгийн орлого бэлхнээ харуулж байна.

Аливаа улсад далд эдийн засаг байдаг ч Монгол Улсын хувьд 1 жилийн улсын төсвөөс 6 дахин их, дотоодын нийт бүтээгдхүүнээс 2 дахин их хэмжээний далд эдийн засаг бодитой оршин байгааг дээрх хуулийн үр дүн харуулсан билээ.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь манай улсад дараах байдлаар түгээмэл үйлдэгдэж байна. Үүнд:

- Татвар ногдох эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар зэргийг зах зээлийн үеийнхээс бага үнээр борлуулсан эсвэл өндөр үнээр худалдан авснаар гэрээ хэлцэл хийх;
- Нягтлан бодогч, нярав зэрэг ажилтнууд, бусад татвар төлөгчидтэй үгсэн хуйвалдаж санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт материалыг хуурамчаар үйлдэн татвар ногдох зүйлийг нуух, санаатайгаар багасгах, өртөг зардлаа зохиомлоор өсгөж санхүүгийн тайлан тэнцэл, татварын ногдуулалт, төлөлтийн тайланг үндэслэлгүй буруу гаргах;
- Улсын бүртгэлд бүртгүүлэлгүй үйл ажиллагаа эрхлэх, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр зориуд бүртгүүлэхгүй байх;
- Импортолсон барааны үнийг гаалийн байгууллагад багаар, нэмэгдсэн өртгийн албан татварын бууаан авалтын үед өндрөөр мэдүүлэх;
- Хамаатан садан, танил, найз нөхөд болон нас барсан хүний нэрээр бараа материал импортлон борлуулж татварын ногдуулалт, төлөлтийн тайлан гаргахгүй байх, улсын бүртгэлд бүртгүүлсэн хаяг байршилдаа байхгүй, олдохгүй байх, татварын албанаас

дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байх, үнэ шилжүүлэх, нимгэн капиталжуулалт зэрэг аргыг ашиглаж олон улсын хэмжээнд татвараас зайлсхийх зэрэг болно.

Татварын улсын байцаагчид хяналт шалгалтын ажлын явцад татвар төлөхөөс зайлсхийж буй үйлдэл, эс үйлдлийг дараах арга замуудаар илрүүлж байна. Үүнд: Хаяг байршилдаа байхгүй, олдохгүй, татварын албанаас дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гарган, цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулж олуулах, бараа материал импортлох, бусад ажил үйлчилгээ үзүүлэх, иргэн, хуулийн этгээд, бусад татвар төлөгчидтэй гэрээ хэлцэл байгуулсан, тэдгээрийг дүгнэсэн байдал, тооцоо нийлсэн акт, төлбөр тооцооны баримтыг нягтлан үзэх, хамаарал бүхий этгээдэд бараа материал борлуулсан, ажил, үйлчилгээ үзүүлсэн байдал, үнэ ханш нь зах зээлийн үеийнхээс өндөр эсвэл бага, санхүүгийн баримт материалаа хуурамчаар үйлдсэн эсэх зэргийг ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчдийн үйл ажиллагаатай харьцуулж үзэх, зарим татвар төлөгч 1-2 жил үйл ажиллагаа эрхэлсний дараа татан буугдаж өөр аж ахуйн нэгж байгуулдаг тул татан буугдах, шинээр үүсгэн байгуулах үед нь эхлэлтийн болон дуусгалтын тайлан тэнцэл, хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл, эх үүсвэр, үл хөдлөх хөрөнгө, татварын өр төлбөртэй эсэхийг шалгах, гааль, нэмэгдсэн өртөг, онцгой албан татварыг ногдуулан төлсөн, үнэ, тарифыг үнэн зөв хэрэглэсэн эсэхийг хууль, дүрэмд нийцүүлэн хянан шалгах зэрэг болно.

Түүнчлэн, ТУЗ, захирлуудын зөвлөл, холбогдох бусад газарт гаргаж өгсөн тайлангуудыг татварын албанд гаргаж өгсөн тайлантай тулган, зөрүүтэй эсэхийг хянан шалгах байдлаар, зөрүүтэй тохиолдолд холбогдох хүмүүстэй асуулга, ярилцлага хийж шалтгааныг тодруулан, ярилцлагын тэмдэглэл хөтлөх, татвар төлөгчид хяналт шалгалтын явцад татварын албанд гарган өгсөн тайлбар, тодорхойлолтоо дараа нь үгүйсгэдэг тул тухайн хяналт шалгалтын материал хууль хяналтын байгууллагаар хянагдахаар бол гэрчээр оролцохыг санал болгох;

- Татвар төлөгч иргэд бусдын иргэний үнэмлэх зэрэг баримт бичиг ашиглан бараа материал, автомашин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, эд анги зэргийг импортлох, оршин суух хаяг байршил нь тодорхойгүй байх, иргэний бүртгэл мэдээллийн төвд байхгүй хаяг, нас барсан хүний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн эсэхийг тогтоох;
- Автомашин, шатахуун, мод зэрэг зүйлийг реэкспортлосон, хилийн гадна борлуулсан гэж тайлбарладаг тул ГЕГ-аас лавлагаа авах, гаалийн бүрдүүлэлтийн горимтой танилцах, экспортолсон автомашины арлын дугаарыг ЗЦГ-ын мэдээллийн сан дахь бүртгэл, хилээр нэвтрүүлсэн барааны мэдүүлэгтэй тулган шалгах;
- Гадаад орнуудад салбар компанитай эсэх, татвар ногдох зүйлийг гадаадын аль нэг улс оронд шилжүүлсэн эсэхийг татварын мэдээлэл солилцох тухай давхар татварын гэрээний заалтын хэрэгжилтийг шалгах;
- Татварын таатай нөхцөлтэй орнуудад эцэг эсвэл охин компани байгуулж худалдаа арилжаагаа эдгээр компаниудаар дамжуулж татвараас зайлсхийх, өөрөөр хэлбэл татваргүй буюу бага татвартай оронд эцэг эсвэл охин компаниа байгуулж татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлээ шилжүүлэх эсвэл өөрөө суурьшин амьдрах зэргээр татварын ачааллаа бууруулах буюу татвар төлөхөөс зайлсхийх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд Монгол Улсад байнга байрладаг болон байрладаггүй ААН, оршин суугч болон оршин суугч бус этгээдийн аль нь болохыг шалгаж тогтоосны дараа Монгол Улсын Татварын хууль болон Монгол Улсаас гадаад орнуудтай байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр"-үүдэд заасны алинаар нь татварын ногдлыг хийхийг тодорхойлох;

- Монгол Улсын хуулиар өөрийн хөрөнгөөр санхүүждэг компаниудын ногдол ашиг татвар ногдох орлогоос хасагдахгүй харин зээлийн хөрөнгөөр санхүүждэг компаниудын зээлийн хүүгийн зардал татвар ногдох орлогоос хасагддаг тул ийм хэлбэрээр буюу нимгэн капиталжуулалтын хэлбэрээр татвараас зайлсхийсэн тохиолдолд энэ талаар татварын хуулийн нарийвчилсан зохицуулалтыг хэрэгжүүлэх байдлаар илрүүлнэ.
- Татвар төлөгч бэлэглэл, арилжаа, бараа солилцоо хийх эсвэл бараа үйлчилгээг бусад этгээдээс болон харилцан хамаарал бүхий этгээдэд худалдах, худалдан авах, шилжүүлэхдээ зах зээлийн үнээс хэт өндөр эсвэл хэт бага үнээр худалдан авах буюу худалдаж үнэ шилжүүлэх хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд гуравдагч этгээдээс мэдээлэл авах, харилцан хамааралгүй этгээдүүдэд борлуулсан үнээр тооцож татвар ногдуулах зэргээр татвараас зайлсхийсэн үйлдлүүдийг илрүүлдэг байна.

ХОЁР. ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Манай улс нь татварын нэг шатлалтай, дунджаар 10 хувийн татварын босго тогтоосон нь дэлхийн бусад улстай харьцуулахад харьцангуй бага татвар авдаг орны тоонд ордог гэж зарим судлаачид үздэг байхад бизнес эрхлэгчдийн хувьд манай улс татварын хэмжээ өндөр, татварын давхардлыг тооцоход нэг ААН дунджаар 35-45%-ийн татвар төлөх болдог нь бага татвартай орны тоонд орохгүй" гэдэг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 83,450 ААН, байгууллагын 80 орчим хувь нь үйл ажиллагаа явуулж орлого олоогүй гэсэн утгатай "Х" (икс) тайлан гаргадаг, зарим компани орлогоо янз бүрээр тусгасан 2-3 янзын тайлан, баланс гаргах зэргээр татвараас зайлсхийдэг бол жирийн иргэд ч орлогоо үнэн зөвөөр тайлагнахаас аль болох татгалзаж татвараас зайлсхийхийг оролддог.

Нэмүү өртгийн албан татварын шинэ хууль 2015 батлагдаж 2016 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжсэнээр олон ААН-ийн орлого ил болж улсын төсөвт орох орлогын хэмжээ 1 жилд гэхэд л 34-38 тэрбум төгрөгөөр нэмэгдэж далд байсан орлогыг ил гаргах чухал механизм болохыг харуулав.

Шинэ хууль хэрэгжиж эхэлснээр олон компани урьдын адил "х" тайлан гаргах аргагүй болж нэмүү өртгийн албан татвар төлөгч болж байгаа нь дэвшил юм.

Тухайлбал, орон сууц худалдан авах, худалдах гэрээ хийж байгаа иргэд гэрээгээр халхавчилж бэлэглэлийн гэрээ хийх эсвэл худалдан авсан үнийн дүнг илтэд бууруулах зэргээр үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны 2 хувийн татвараас зайлсхийх үзэгдэл буурахгүй байгаа жишээг дурьдаж болно.

Түүнчлэн жилдээ 100 сая төгрөгнөөс дээш хэмжээтэй борлуулалтын орлого олсон, байнгын үйл ажиллагаа явуулж орон сууцны барилга ашиглалтанд оруулсан 10 орчим компани "Х" тайлан өгч байсныг татварын алба илрүүлсэн боловч эрүүгийн хариуцлага тооцож чадаагүй.

Жижиг, дунд компаниудын олонх нь 2-3 янзын тайлан баланс гаргадаг, өөрөөр хэлбэл, татварын байгууллагад орлогоо нуун дарагдуулсан буюу "Х" тайлангаа өгдөг бол харин түншүүддээ болон банкнаас зээл хүсэх үедээ жинхэнэ тайлангаа гаргаж өгдөг буруу жишиг нэгэнт тогтсон байна.

Манай төрийн бодлогын нэг алдаа нь татварын хэмжээг өсгөснөөр улсын төсвийн орлогыг нэмэгдүүлнэ гэж үздэг ингээд шинээр байгуулагдсан засгийн газар татвар нэмэх

төсөл санаачилж эхэлдэг нь хууль эрх зүйн орчинг тогтворгүй болгож хөрөнгө оруулагч нарт эрсдэл үүсгэдэг. Тухайлбал, 2009 онд алт, зэсийн борлуулалтын орлогоос 68%-ийн татвар авах хуулийг тухайн үеийн УИХ-аас батлан гаргасан нь эцэстээ улсын төсөвт орох орлогыг 3 дахин бууруулж жилдээ 10-15 тонн алтыг хууль бусаар улсын хил давахад хүргэсэн бөгөөд 5 жилийн хугацаанд улсын төсөвт орох валютын орлогоо алдсаны эцэст 2015 онд 68 хувийн татварыг 2.5% болгон бууруулснаар Монгол Банканд 1 жилд тушаах алтны хэмжээ 2 тонноос 16 тонн болтлоо 8 дахин өссөн жишээг бид харж байна.

Манай улсад ААН-үүд татвараас зайлсхийх бас нэг шалтгаан нь хэт ойрхон буюу 3-5 жилийн давтамжтайгаар эдийн засгийн буюу Татварын өршөөлийн хуулийг парламентаас батлан гаргаж байгаа явдал бөгөөд татвараас зайлсхийх санаатай ААН, байгууллагын эзэд ээлжит Татварын өршөөлийн тухай хуулийг хүлээж хөрөнгө, орлогоо зохих ёсоор тайлагнахгүй байгаа үзэгдэл анхаарал татах боллоо.

Авилга, хээл хахуулийн асуудал ч татварын байгууллагыг тойроогүй бөгөөд "Транспаренси интернейшнл" олон улсын байгууллагын судалгаагаар манай улс 2016 онд 85 дугаар байранд буюу авилгад автагдсан орны тоонд орж өмнөх жилээс 10 гаруй байраар ухарсан үзүүлэлт гарлаа. Энэ төрлийн гэмт хэргийн шалтгааныг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нэг. Эдийн засгийн шалтгаан

Манай улс нэг хүнд оногдох үндэсний орлогоор дэлхийд сүүл мушгиж, амьдралын түвшин дорой, ажилгүйдэл, ядуурал газар авсан явдал бүхий л гэмт хэргийн үндсэн шалтгаан болж байна. Татвар төлөгч нар төрийн бодлогыг байнга шүүмжилж байгаа нь ортой бөгөөд цугларсан татварын орлого буюу төсвийг зориулалтын бусаар зарцуулах, нийгмийн халамжийг хавтгайруулах атлаа нөгөө талдаа талдаа татвар төлөгч нараа улам шахаж байгаа нь татвараас зайлсхийх үндсэн шалтгаан болж байна.

Хоёр. Сул засаглал, сул бодлого

Сул засаглал гэдэгт тухайн улсын татварын алдаатай бодлого, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогын алдаа, бодлого боловсруулах, үйл ажиллагааны хяналт хариуцсан байгууллагуудын үүрэг ба хариуцлагын давхардал, гэмт хэрэгтэй тэмцэх хангалттай хөрөнгө хүч, боловсон хүчин муутай, урт хугацааны стратеги, төлөвлөлт байхгүй, урсгалараа ажилладаг, зөвшөөрлийн тогтолцооны гажуудал зэргийг хамааруулж болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон хууль тогтоомж батлагдсан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй, хуулийг хэрэгжүүлэх механизм сул байна.

Гурав. Хууль эрх зүйн орчин зөрчилтэй, хуулийн хэрэгжилт муу, хэрэгжих механизм сул

Манай улсын татварын хууль эрх зүйн орчин болон гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин аль аль нь асуудалтай, хийдэлтэй байгааг өмнөх бүлэгт хангалттай өгүүлсэн. Нэгэнт хуулийн хийдлийг олж харсан татвар төлөгч нар хууль зөрчилгүйгээр татвараас бултах, эсвэл цагдаагаар шалгуулах нэрээр хэргээ мөрдөн байцаалтын явцад хэрэгсэхгүй болгуулах зэргээр хариуцлагаас мултарч байна.

Дөрөв. Ил тод байдал, хариуцлага, бие даах чадварын дутагдал

Монгол Улсын хувьд татварын болон хууль сахиулах байгууллагуудын хоорондын ажлын харилцан уялдаагүй, бие даасан шинжтэй шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулдаг,

удирдлагын босоо тогтолцоотой, салбарын асуудал хариуцсан байгууллагууд нь бусад байгууллагуудыг өөрийн үйл ажиллагаанд оролцуулах дургүй байдаг. Шийдвэр гаргах шатанд ил тод байдал алдагдсанаас авилга дэлгэрсэн, салбарын хэмжээнд хууль бус ажиллагаа зонхилж байгаа учир бүх үйл ажиллагаа нууц, далдуур тохиролцсон шинжтэй байдаг.

Төр, хууль хяналт, иргэний нийгмийн байгууллагуудаас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гарсан зөрчлийг шуурхай шударга шийдвэрлэх, улмаар шийдвэрээ нийтэд мэдээлж сэрэмжлүүлэх сүлжээ муу ажиллаж байна. Энэ нь төрийн хуулийг уландаа гишгэсэн этгээдүүдэд боломж олгож, нийгмийг бүхэлд нь бухимдуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Шат бүрд хариуцлага тооцох механизм алдагдсан нь байдлыг улам муутгаж байна.

Тав. Олон нийтийн хяналтын тогтолцоо бүрдээгүй, иргэдийн эрх зүйн ухамсар, соёл дорой байгаа явдал

Иргэдийг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд татан оролцуулах ажлыг зохион байгуулдаггүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоо сул, олон нийтийн хяналтын тогтолцоо улсын хэмжээнд хэмжээнд бүрдээгүй байна.

Дээр өгүүлснээр Эрүүгийн хуулийн боловсронгуй бус байдал, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо сул, хуульч, шүүгч нарын эдийн засгийн тусгай мэдлэг хангалтгүй, татварын байгууллагын хүнд суртал, авилгад өртөмтгий байдал, иргэдийн эрх зүйн ухамсар сул зэрэг олон шалтгаан, нөхцөлийн улмаас татвараас зайлсхийх гэмт хэрэг манай улсад буурахгүй байна.

Энэ гэмт хэргийн шалтгаан нь татвар төлөгчдийн ухамсар, татварын байгууллагын үйл ажиллагааны доголдол, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа алдагдсан, хариуцлагын тогтолцоо сул, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтын хийдэл, олон нийтийн хяналтын тогтолцоо бүрдээгүй, иргэдийн ухамсар сул дорой, хуулийн хэрэгжилт муу, хэрэгжүүлэх механизм хангалтгүй зэрэг олон шалтгаантай байна.

ГУРАВ. ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ДАВУУ ТАЛ

Эрүүгийн хуулийн боловсронгуй бус байдал, тэр дундаа тусгай ангийн 166 дугаар зүйлийн объектив талыг 2002 онд хууль тогтоогч салаа утгатай, оновчгүй тодорхойлсоноор энэ төрлийн гэмт хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэхэд бэрхшээл үүсгэдэг байв. Хууль сахиулах байгууллагууд болон мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, шүүгч нарын дунд 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн объектив талд заагдсан "татвар ногдох их хэмжээ" гэдгийг хэрхэн ойлгох талаар нэг мөр ойлголтгүй, өөр өөрсдийн өнцгөөс тайлбарласаар ирлээ.

Тухайлбал, зарим мөрдөн байцаагч, прокурор нь "татвар ногдох орлого" гэдгийг тухайн хувь хүн болон байгууллага, ААН-ийн орлогоос нь шууд тооцож эрүүгийн хэрэг үүсгэдэг буруу практик байсныг нуух аргагүй.

Харин тухайн аж ахуйн нэгж нь 1 жилд 300.0 сая төгрөгийн орлогоо нуун дарагдуулж "Х" тайлан гаргасан байсан бол уг компанийн төлбөл зохих татварын хэмжээ нь 30.0 сая төгрөг болж зайлсхийсэн татварын хэмжээ нь Эрүүгийн хуульд заасан "..их хэмжээний татварын орлого" гэдэгт хүрч байгаа тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх бүрэн боломжтой.

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас татвараас зайлсхийсэн эрүүгийн хэргүүдийг шийдвэрлэхдээ татвар төлөгч субъектийн орлогоос нь хуульд заасан татварыг тооцоод зайлсхийсэн буюу нуун дарагдуулсан татварын хэмжээ нь тухайн үеийн хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг 125 дахин буюу түүнээс дээш нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байгаа тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа практик тогтсон байсныг дээр өгүүлсэн.

Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээг нуусан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн заалт амьдрал дээр төдийлөн хэрэгжиж чадахгүй, хууль зөрчигчид элдэв тайлбараар ам таглан татвараас зайлсхийж эдийн засгийн аюулгүй байдалд хохирол учруулж байгаа учир шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд энэ гэмт хэргийн шинжийг өөрчлөх шаардлага тулгарсан.

Дээрх хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын үйл ажилллагааг сайжруулах, банк, санхүүгийн байгууллага болон холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулж ажиллах, татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс татварын хяналт шалгалтын болон татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээлэл цуглуулах, түүнийг татварын хяналт шалгалтад ашиглах, татварын алба дотооддоо мөрдөх журам, заавар батлан ажиллах зэрэг болно.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд эдийн засгийн тусгай мэдлэг эзэмшсэн хууль сахиулагч, хуульч, шүүгчдэд шаардлагатай байна. Бусад улсын жишгийг харж байхад татварын асуудлаар мэргэшсэн мөрдөгч, прокурор, шүүгчтэй болох нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийг эрчимжүүлдэг байна.

ДӨРӨВ. ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Дэлхийн олон улсын хэмжээнд татвар төлөхөөс зайлсхийх нь татварын эрх зүйн зөрчлийн хамгийн дэлгэрсэн төрөл учир нуун дарагдуулсан их бага хэмжээндээ бус, харин үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж, зайлсхийсэн, нуун дарагдуулсан орлогын тодорхой хувиар торгох ял түлхүү хэрэглэж байна.

Ихэнх улс орны хууль хэрэглэх практикаас үзэхэд "татвар төлөхөөс зайлсхийх" болон татвараас "булталх" гэсэн хоёр ойлголтыг ангилан авч үздэг байна.

Татвар төлөхөөс зайлсхийх явцад татвар төлөгч нь хуульд заасан арга хэрэгслээр өөрийн татварын үүргийг багасгахыг эрмэлзэнэ. Орлого болон татвар ногдох бусад зүйл зэрэг объектын үнийг бууруулах, борлуулагдсан бүтээгдэхүүний өөрийн өртгийг зориуд өсөн нэмэгдүүлэх, баримт бичгийг устгах, өөр өөр банканд тооцооны хэд хэдэн данс нээж "давхар данс" хөтлөх замаар татвараас зайлсхийх, эд хөрөнгийг түрээслэх замаар нуун далдлах зэрэг нь татвараас зайлсхийж, орлогоо нуун дарагдуулах үндсэн арга болж байна.

Татвараас булталх гэдэг нь хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн, хууль ёсны оролдлого хийх, "татварын төлөвлөгөө" гэгчийг ашиглан татварын дарамтыг багасгах (хөнгөрүүлэх) зэрэг илрэх байдлаараа татвар төлөхөөс зайлсхийхээс ялгаатай.

Татвараас булталх гэдэг нь (англи хэлээр: tax evasion, tax avoidance; орос хэлээр-уклонение от уплаты налогов) татварын эрх зүйн зөрчлөөс нэлээд тархмал ба аюултай хэлбэр бөгөөд ААН-ийн татварын хөнгөлөлтийг хууль бусаар ашиглах, хугацаанд нь татвараа төлөхгүй орлогоо нуух, татвар тооцох, төлөхөд зайлшгүй шаардлагатай баримт бичгийг эс өгөх буюу тухайн үед нь өгөхгүй байх зэргээр илэрнэ.

Америкийн судлаач Ж.Ю.Стиглиц "Төрийн секторын эдийн засаг" бүтээлдээ "татвараас булталх"-ыг татварын бүтэц дэх хууль ёсны бүх нүх сүвийг боломж болгон ашиглах гэж тодорхойлжээ. Татварын төлөвлөлтийн үндэс нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан татварын хөнгөлөлтийг иж бүрэн хэрэглэх, хууль тогтоомжийн хийдэл, тодорхой бус бүх байдлыг ухаалаг ашиглахад оршино.

Тухайлбал, манай улсын жишээн дээр ярихад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд татварын шатлалыг тогтоохдоо жилийн орлого нь 3 тэрбум төгрөг хүрэхгүй ААН-ийн татварыг орлогын 10%-аар, нэг жилд 3 тэрбум төгрөг болон түүнээс дээш орлогод 25%-аар татвар төлөхөөс заасан бөгөөд энэ хуулийн заалтыг ашиглаж компаниа томруулахгүйгээр нэг жилийн орлогоо 3 тэрбум төгрөгнөөс хэтрүүлэхгүй барих явдал цөөнгүй байгаа нь дээрх ААН-үүд хуулийн дагуу татвараас бултаж байгаа хэрэг юм.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр шилжүүлсэн татварын хэргээс шүүхээр шийдэгдсэн нь цөөн, ихэнхдээ мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болох буюу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэгдсэн байна.

Тухайлбал, 2015 онд татварын албанаас нийт 62 татвар төлөгчид холбогдох 98,8 тэрбум төгрөгийн зөрчил бүхий татвар төлөхөөс их хэмжээгээр зайлсхийсэн үйлдэлд дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлснээс 8 татвар төлөгчид холбогдох 4.8 тэрбум төгрөгийн зөрчил бүхий хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 7 татвар төлөгчид холбогдох 11.2 тэрбум төгрөгийн зөрчил бүхий хэргийг хэрэгсэхгүй болгож, 45 татвар төлөгчид холбогдох 82.3 тэрбум төгрөгийн зөрчил бүхий 41 хэрэг эцэслэн шийдэгдээгүй, шийдвэрлэлтийн шатанд хүлээгдэж байгаа бол 2 татвар төлөгчид холбогдох ердөө 169.0 сая төгрөгийн зөрчил бүхий хэргийг төлүүлэхээр шийдвэрлэсэн гэсэн мэдээ, судалгаа ирүүлсэн байна.

2010-2014 онд нийт 274 татвар төлөгчид холбогдох 279.5 тэрбум төгрөг, 43.1 сая доллар, 1.6 сая еврогийн хэргийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн боловч шүүхээр эцэслэн шийдэгдсэн хэрэг хуруу дарам цөөн буюу 1 жилд 2-5 хэргийг шийдвэрлэсэн нь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг илрүүлэх, гэм бурууtай этгээдийг шийтгэх, улмаар хохирлыг барагдуулж улсын төсвийг хохиролгүй болгох асуудал хийгдсэнгүй гэж дүгнэхээр байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) баримтад хоосон бичилт хийж, хууль бусаар бусдад тарааж татвар төлөхөөс зайлсхийсэн 4211 ААН-ийн 3000 гаруйд нь холбогдох үйлдлийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй гэж үзэн захиргааны арга хэмжээ авч, нөхөн татвар, торгууль, алданги төлүүлэхээр нэрсийг нь Татварын ерөнхий газарт хүргүүлжээ.

Татварын байгууллага, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу байгааг дээрх тоо баримт харуулж байна. Ялангуяа прокурорын байгууллагын үүрэг голлох үүрэгтэй бөгөөд татварын байгууллага, цагдаагийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар ханган ямар тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэх, эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд мөрдөн байцаах ажиллагаанд хэрхэн хяналт тавих, нотлох ажиллагаанд анхаарч гэмт этгээдүүдийг ял завшуулахгүй байхад онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

Түүнчлэн захиргааны арга хэмжээ авах нэрийн дор татварын гэмт хэргийг нуун дарагдуулах явдал цөөнгүй гарч байгаа тул прокурорын хяналтыг эрчимжүүлэх замаар илрүүлэх боломжтой. Татвараас зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх гол арга зам нь хууль эрх зүйн орчин бүрхэг, хууль тогтоомжууд зөрчилтэй, хариуцлагын тогтолцоо сул байгаа нөхцөлд энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжгүй.

Хуулийн хэрэгжилтийг хангах улс төрийн хүсэл зоригийг нэмэгдүүлэх, Олон нийтийн татварын соёл, боловсрол ба мэдээллийг сайжруулах, татварын болон шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг дэмжих, ажлын уялдаа холбоог сайжруулах, авилга, хээл хахуультай тэмцэх, татварын цагдаагийн газрыг байгуулах зэрэг олон талт үйл ажиллагааны үр дүнд урьдчилан сэргийлэх боломжтой болно.

ТАВ. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Татвараас зайлсхийх гэмт хэргүүдийн дийлэнх нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байх бөгөөд орон нутгийн ААН-үүдийн хувьд борлуулалтын орлого багатай, татвараас зайлсхийсэн хэмжээ нь 30 сая төгрөгт хүрэх байгууллагын тоо хуруу дарам цөөн байдаг. Сум, аймгуудад байрлах томоохон ААН-ийн орлогыг шууд улсын төсөвт төвлөрүүлдэг нь хэт төвлөрлийг бий болгож сум, орон нутгийн жижиг хотуудын хөгжил сул байхад хүргэж байна.

Энэ байдлыг төрийн зүгээс анхаарч Улаанбаатар хотоос алслагдсан аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн татварыг алслагдсан зайнаас хамаарч 80-90 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлэх, мөн арьс шир, түүхий эд барилга зэрэг үйлдвэрлэл явуулж байгаа ААН, байгууллагуудын татварыг 90% чөлөөлж 1%-ийн татвар төлөх болсон нь бизнесийг дэмжсэн цагаа олсон шийдвэр болсон.

Орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь зарим төрлийн татварыг орон нутагтаа захиран зарцуулах эрхтэй байгаагийн хувьд татвар, хураамжийг зөв үйл ажиллагаанд зарцуулах, зарцуулалтыг ил тод тайлагнах, орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа явуулах нь чухал.

Татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад төрлийн гэмт хэрэгтэй нийлмэл байдлаар үйлдэгдэж байна.

Тухайлбал, 233 дугаар зүйл буюу "Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах" 265 дугаар зүйл буюу Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, 266 дугаар зүйл буюу Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэсэн зүйл ангиудтай нийлмэл байдлаар үйлдэгдэж байна.

ЗУРГАА. ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААР ТӨР ЗАСГИЙН ТҮВШИНД АНХААРЧ ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

Хамгийн түрүүнд анхаарвал зохих ёстой асуудал нь хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал билээ. Татварын хуулиуд болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн шинэчлэл яах аргагүй анхаарал татсан асуудал болж байна.

Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлд заасан "...татвар ногдох их хэмжээний орлого" гэх бүрхэг заалтыг "...Татварын эрх бүхий байгууллагын шийдвэрээр эцэслэн тогтоосон нэг зуун сая төгрөгөөс дээш хэмжээний татвар" гэж 2015 оны Эрүүгийн хуульд тусгасан боловч 2017 оны Эрүүгийн хуулийн өөрчлөлтөөр дахин их хэмжээний татвараас зайлсхийсэн бол гэж оруулсан нь өмнөх маргааныг дахин сэдрээх болж байна.

Мөн татвараас зайлсхийх гэмт хэргийн субъект нь хуулийн этгээд байхаар төсөлд тусгагдаж байсан боловч эцэстээ зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тогтсон. Энэ нь байгууллагын нягтлан бодогч, гүйцэтгэх захирал зэрэг хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хөлсний менежерүүд эрүүгийн хариуцлага хүлээж тухайн компаний үүсгэн байгуулагч болон гол хувьцаа эзэмшигч нарт хариуцлага нөлөөлдөггүй практик хэвээр үргэлжилнэ гэсэн үг билээ.

Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулж дагнасан шүүх буюу татварын асуудлаар дагнасан шүүхийг байгуулах явдал чухал байна. Энэ шүүх улсын хэмжээнд нийслэлд нэг л байхад хангалттай бөгөөд татварын холбогдолтой эрүүгийн, иргэний, захиргааны аль ч

төрлийн хэргийг шийдвэрлэхээр харьяаллыг нь зааж өгөх боломжтой. Түүнчлэн татварын гэмт хэргийг мөрддөг тусгай хэлтсийг ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын нэг хэлтэс болгон байгуулах, Нийслэлийн прокурорын газар нь энэ төрлийн хэргийг дагнан хянадаг болох нь ойлголцлын зөрүүг арилгаж энэ төрлийн гэмт хэргийг шуурхай илрүүлж, хянан шийдвэрлэх бодит боломжийг олгоно.

Татвараас зайлсхийх гэмт хэргийн шалтгаан нь татвар төлөгчдийн ухамсар, татварын байгууллагын үйл ажиллагааны доголдол, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа алдагдсан, хариуцлагын тогтолцоо сул, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтын хийдэл, олон нийтийн хяналтын тогтолцоо бүрдээгүй, иргэдийн ухамсар сул дорой, хуулийн хэрэгжилт муу, хэрэгжүүлэх механизм хангалтгүй зэрэг олон шалтгаантай байна. Хууль эрх зүйн орчин бүрхэг, хууль тогтоомжууд зөрчилтэй, хариуцлагын тогтолцоо сул байгаа нөхцөлд энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа төдийлөн амжилт олохгүй далд эдийн засаг улам цэцэглэсээр эцэстээ Монгол Улс дефолт зарлах дээрээ тулаад байгааг нийт иргэд харж түгшиж сууна.

Татвараас зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхийн тулд хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх улс төрийн хүсэл зоригийг нэмэгдүүлэх, олон нийтийн татварын соёл, ухамсар, боловсрол ба мэдээллийг сайжруулах, татварын болон шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын хамтын үйл ажиллагааг дэмжих, ажлын уялдаа холбоог сайжруулах, авилга, хээл хахуультай тэмцэх, цагдаагийн газрын харьяанд татварын гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байгуулах зэрэг олон талт үйл ажиллагааны үр дүнд урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр, давхар татварын хэлэлцээрүүдийг улс орнууд өөр хоорондоо байгуулдаг.

Гэвч эдгээр гэрээ хэлцлийг урвуулан ашиглах зорилгоор гэрээ хэлцэлтэй оронд "оффшор компани" (татварын таатай орчинтой улс оронд бага татвар төлөх зорилгоор байгуулагдсан компани) байгуулах, хөрөнгө оруулалтаа шилжүүлэх зэрэг үйлдлүүд гардаг.

Хэдэн жилийн өмнө олон улсын татварын хуульч нар "Голланд сэндвич" гэсэн нэр томьёог гаргаж ирсэн ба гол утга санаа нь А улсын хөрөнгө оруулагчийн В улсад оруулсан хөрөнгө оруулалтын дунд Нидерландад байгуулсан компани бага татвар төлөх зуучлагч болж өгч буй явдал юм.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Дэлхий нийтийн хэмжээнд эдийн засгийн гэмт хэрэг тэр дундаа татвараас зайлсхийх гэмт хэрэгт буруутай этгээдийг ял шийтгэхэд бүс хохирлыг нь нөхөн төлүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна. Энэ хандлагын үүднээс татвараас зайлсхийсэн этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрч татварын байгууллагаас эцэслэн тогтоосон татварыг шүүх хурлын өмнө бүрэн төлж барагдуулсан тохиолдолд ял оногдуулахгүйгээр тэнсэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх явдал түгээмэл байна.

Хөгжиж байгаа зарим улс татварын Өршөөлийн хуулийг батлан гаргаж хэрэв нуусан хөрөнгө, орлогоо ил болгож оффшор (эргийн гадна, далайн чанад гэж орчуулна) бүсээс нуусан хөрөнгө, мөнгөө оруулж ирвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, нуусан хөрөнгийг нь хураахгүй байх амлалт өгч эдийн засгаа тэлэх арга хэмжээ авч байгааг ч буруутгах аргагүй.

Манай улсын татварын болон хууль хяналтын байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чадвар сул, далд эдийн засаг газар авсан болох нь 2015 онд Эдийн засгийн өршөөл

үзүүлэх тухай хууль батлагдснаар ганцхан жилийн хугацаанд 34 их наяд төгрөгийн татварт бүртгүүлээгүй хөрөнгө, орлого ил болж байсан нь манай улсын 6 жилийн төсөвтэй тэнцэх хэмжээний орлого байсан.

Цаашдаа ийнхүү ойр ойрхон татварын өршөөлийн хууль гаргах замаар далд эдийн засгийг илрүүлэх бус харин татварын бааз суурийг өргөтгөж жижиг дунд бизнесийг дэмжих замаар татварын орлогыг нэмэгдүүлэх бодлогыг баримтлах нь чухал.

Татвар төлөлтийн байдал, түүний хэрэгжилтэд хийж буй татварын хяналт шалгалтын үр дүнгээс харахад шалгалтад хамрагдаж буй ААН, иргэдийн 65-75% нь татварын хууль тогтоомжоо судалж, мэдээгүй, нягтлан бодох бүртгэлийг зөв хөтөлдөггүйгээс болж санамсаргүй гаргасан алдаанаас татварын зөрчилд орж, хүү торгууль төлөн үргүй зардал гаргаж байна. Энэ нь зах зээлийн нийгэмд татварын суурь мэдлэг зайлшгүй болох, түүнчлэн татварын боловсролыг системтэй олгох асуудлыг зүй ёсоор шаардаж байна.

Татварын албаны гол зорилго нь "Татвар төлөгчид хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ тэгш, шударга, зөв зохистой, бүрэн биелүүлдэг тогтолцоог бий болгох" юм. Төр татвараар цуглуулсан орлогоор санхүүжиж, мөнгөн хуримтлалыг бүрдүүлэн, түүнийгээ дахин хуваарилах замаар иргэддээ төрийн үйлчилгээг үзүүлдэг.

Татвар төлөгч буюу хувийн хэвшил болон татвар хураагч төрийн байгууллагын хооронд ойлгомжтой, ил тод, харилцан хүндэтгэсэн харилцаа тогтсон байж татварын орлого хангалттай гүйцэтгэгддэг.

Татварын бодлого нь юуны өмнө шударга татварын тогтолцоо буюу орлоготой нь уялдсан байх буюу их орлоготой нь их татвар төлөх зарчимд тулгуурлах ёстой.

Энэ төрлийн гэмт хэргийг эцсийн шатанд шүүхээр шийдвэрлүүлэх хүртэл татварын алба нь хохирогч, иргэний нэхэмжлэгчээр ажиллаж байгаагийн хувьд гэмт хэргийг үнэн зөв шийдвэрлүүлэхийн тулд дээрх хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын хэмжээнд татварын гэмт хэргийг илрүүлэх улмаар далд эдийн засгийг ил болгох талаар хурал, зөвлөгөөн зохион байгуулж, бодлогын бичиг баримт боловсруулан ажиллаж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татварын албанаас оруулж буй томоохон хувь нэмэр гэж дүгнэж байна.

Манай улсад хууль дүрмийг эс тоомсорлох үзэгдэл газар авч хүн амын цөөхөн хувь буюу 8 орчим хувь нь үндэсний нийт баялгийн 90%-ийг эзэмшиж байгаа бол үлдсэн 92% нь 10%-ийн баялгийг хуваан эзэмшиж байгаа нь шударга ёс биш юм. Ганцхан жишээ дурдахад нийт хадгаламж эзэмшигчдийн 4%-д нийт хадгаламжийн 95% нь төвлөрсөн байх бөгөөд 100 сая төгрөгөөс дээш хадгаламжийн хүүгээс 10%-ийн татвар авах тухай заалт 5 жилийн өмнө батлагдсан боловч өнөөдрийг хүртэл хэрэгжилтийг нь хойшлуулсаар байна.

Шинэ хууль хэрэгжиж эхэлснээр олон компаниуд урьдын адил "Х" тайлан гаргах аргагүй болж нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болж байгаа нь яахын аргагүй дэвшил болж байна.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ЯВДАЛ



14. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ЯВДАЛ

1. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Авлига нь зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхины хууль бус наймаа, хүний наймаа, галт зэвсгийн хууль бус наймаа, алан хядах ажиллагаа зэрэг тив дэлхий дамнасан гэмт хэргийн гол тулгуур. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 181 орон нэгдээд байгаа нь дэлхий нийтээр авлигатай хийх тэмцэлд хэр их ач холбогдол өгч байгаагийн илрэл юм.[155] Түүнчлэн, бүс нутгийн хэмжээнд авлигын эсрэг конвенци батлан хэрэгжүүлж байна.

Авлига нь хээл хахууль, шан харамжийн шинжтэй үйлдлүүдийг хамарсан өргөн утга агуулга бүхий ойлголт. Энэ үзэгдлийг олон янзаар тодорхойлдог, тиймээс ч олон улсын хууль зүйн нэгдсэн нэг шалгуур үзүүлэлтээр үнэлэгдээгүй байна. Манай улсын хувьд Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар толь бичигт: "Эдэд шунах, ёсон бус аргаар юмыг олзолж авах" гэж тодорхойлжээ. Харин Авлигын эсрэг хуульд "Авлига гэж албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил" гэж заасан байна. Түүнчлэн Монгол Улсад авлигын эсрэг судалгааны үйл ажиллагаа явуулдаг Транспэрэнси Интернэшнл байгууллага нь "авлигыг итгэж олгосон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах" гэдгийг онцолсон.

Авлигын олон төрөл байх бөгөөд тэдгээрийг янз бүрээр ангилсан байдаг авч төрөл бүрийн судалгаа, бүтээлийг харьцуулан үзээд дараахи 3 бүлэгт хувааж үзлээ. Үүнд:

"Жижиг" ба "том" хэмжээний авлига

Жижиг авлига. Энэ нь бага түшаалын албан хаагчтай хамаатай, мөнгөн дүнгийн хувьд их биш, голдуу төрийн албан хаагчид хясан боогдуулах замаар шан харамж авах байдлаар илэрнэ. Жижиг авлигын хохирогчид нь нийтлэг шинжтэй олны хамарсан жирийн иргэд байдаг бөгөөд жижиг авлигыг бюрократ авлига буюу хүнд суртлын хэмээн нэрлэнэ. Жижиг авлигын түгээмэл тохиолддог салбарууд нь боловсрол, эрүүл мэнд, татварын алба, хөдөлмөр зохицуулалтын алба, газрын алба, нийгмийн халамжийн алба, цагдаа, байгаль хамгаалагч, зам харилцаа холбооны ажилтан болох нь авлигын талаарх судалгаануудаар ажиглагдсан.

Том авлига. Улс төр, санхүү, засаг захиргааны томоохон албан тушаалтнууд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад албан тушаалаа хувийн ашиг хонжоо олоход ашигласан их хэмжээний мөнгөн дүнтэй үйлдлийг том авлига гэнэ. Энэ нь маш ноцтой шинжтэй, ихээхэн хор уршиг бүхий үр дагавартай. Жишээ нь, зөвшөөрлийг хүчингүй болгох, хэн нэгэнд ямар нэг салбарт давуу эрх эдлэх зөвшөөрөл олгох, төр засгийн шийдвэр гаргагчийн зүгээс уралдаант шалгаруулалтийн нөхцөл болон жишиг стандартыг өөрчлөх, гадаадын иргэн хуулийн этгээдээс хахууль авч гадны банкинд данс нээлгэх, татвараас чөлөөлөх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэх мэт хэлбэртэй байдаг.

Улс төр, захиргааны болон бизнесийн хүрээн дэх авлига

Улс төрийн авлига нь хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй оронд голчлон сонгуулийн үйл явцтай уялдаа холбоотойгоор илэрлээ олдог. Цөөнхийн засаглал, улс төрчид, сонгуулийн хорооны гишүүдийг хахуульдах, улс төрийн хуурамч амлалт өгөх, сэтгүүлчдийг худалдаж авах, сонгогчдод мөнгө ба бусад зүйл тараах зэргээр илэрдэг. Бодлогын хэрэгжилтийг гардан хариуцах явцыг гажуудуулж буй авлигыг захиргааны авлига гэнэ. Зохих шаардлага хангахгүй хүнд лиценз олгох явдал манайд хавтгайрсан нэг жишээ

155 Цахим эх сурвалж https://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/signatories.html

юм. Бизнесийн авлига бол гэмт хэрэг биш харин ажил төрлөө хурдан бүтээх, хүнд суртлыг гэтлэн давах арга гэх мэтээр авлигыг зөвтгөх хандлагатай янз бүрийн тайлбар байдаг ч энэ нь шударга ёсонд яавч нийцэхгүй. Тухайн төрлийн авлига нь хээл хахууль, дотоод мэдээллийн нууцыг задруулан ашиг олох, мөнгө угаах, хөрөнгө мөнгө завших, татвараас зугатах, дансны аргаар хожих зэрэг янз бүрийн хэлбэртэй.

Авлигын хэлбэрүүд

- Bribery (Хээл хахууль) - Албан хаагч, эсхүл бусад хүний албаны буюу хууль ёсны үүргийг биелүүлэхгүй болгоход нөлөөлөхийн тулд аливаа үнэт зүйлийг санал болгох, өгөх, авах, зуучлах;
- Kickbacks - Төр олон нийтийн эд хөрөнгө, мөн хамтын өмчийг хувь хүн, ААН-д хууль бусаар олгох хэлбэрийг хэлнэ;
- Embezzlement, theft and fraud - Залилан мэхлэх, өмч хөрөнгө шамшигдуулах хэлбэрийг хэлнэ;
- Extortion - Айлган сүрдүүлэх: Хэн нэгэн этгээдийг хууль бус үйлдэлдээ хамтран ажиллуулахын тулд хүч хэрэглэхээр айлган сүрдүүлэх, нэр хүндийг нь унагаж болзошгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацна гэж айлгах гэх мэт;
- Abuse of discretion - Нээлттэй бус байдлыг урвуулан ашиглахыг хэлнэ;
- Favoritism - Давуу тал олгох гэсэн үг;
- Patronage, improper political contributions - Улс төрийн намд зүй бусаар хандив олгох: одоо эрх барьж буй эсвэл ирээдүйд эрх барих нам болон төрийн өндөр албан тушаалтан аливаа сонгуулийн үеэр болон дараа мөнгө болон бусад зүйлийг хандивын хэлбэрээр өөрийг нь дэмжигч этгээдийг нөхөн төлбөр болгон төрийн аливаа албан тушаалд томилох буюу томилуулах хэлбэр;
- Шан харамж - Авлигын шинжтэй эрх зүйн зөрчлийн нийгмийн хор аюулын зэрэглэлээр харьцангуй бага хэлбэр. Албаны үүргээ зохих ёсоор биелүүлсний төлөө тухайн этгээдийг хувиараа урамшуулан шагнахыг шан харамжид хамаарууллж ойлгоно. Өнгөц харахад үүнд буруу зүйл байхгүй мэт боловч үзүүлэх хор нөлөө нь их юм. Шан харамж өгч байгаа хүний хувьд баярласнаа илэрхийлэхээс өөр гэм буруутай санаа байдаггүй мэт боловч авч байгаа албан хаагчийн хувьд мэргэжлийн ёс зүйг ноцтой зөрчсөн үйлдэл учраас гаж үзэгдэл рүү түлхэж буй хэлбэр;
- Graft (Бэлэг) - Тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн бэлэг авах, түүнчлэн өөрийн эрх мэдлээ урвуулан ашиг олох, аль нэг явцуу бүлэгт үйлчлэх зорилгоор нийтэд мэдээлэхээс өмнө олж авсан мэдээллийг ашиглан өөртөө болон бусдад давуу эрх бий болгох хэлбэрийг хэлнэ. Бэлэг өгсөн тохиолдол бүрт "Намайг ийм албан тушаалгүй бол энэ хүн тухайн бэлгийг өгөх байсан уу" гэсэн асуултыг тавьж олсон хариултаараа авлигын шинжтэй эсэхийн заагийг ялгаж байх шаардлагатай. Бэлэг авлигын шинжтэй эсэхийг чухамхүү энэ шинжээр л тодорхойлж болно;
- Ах дүүсэрхэх, найзархах - Албан тушаалтан аливаа асуудлаар найз нөхдөдөө, эсхүл төрөл садан, ах дүү нартаа илүү ашигтай шийдвэр гаргах, тэдний ажил хэргийн мэдлэг, чадварыг үл харгалзан зөвхөн хувийн харьцааны шалгуурыг баримтлан албан тушаалд томилох зэрэг байдлаар авлигын энэ хэлбэр илэрнэ;
- Тал тохой татах - Энэ нь ихэвчлэн албан тушаалын томилгоотой холбоотой илэрдэг авлигын хэлбэр. Албан тушаалд танилаа, эсхүл танилынхаа санал болгосон хүнийг, бүр тодруулбал "дотно танилын шалгуур"-ыг ажил хэргийнхээс ямар ч үндэслэлгүйгээр илүүд үзэж томилох явдал авлигын энэ хэлбэрийн агуулга мөн чанарыг тодорхойлно;

- Зүй бусаар тал өгөх буюу хөнгөлөлт үзүүлэх - Төрийн байгууллага, албан тушаалтан зарим ААн-д ялгаварлан тал өгч хэт ойр харилцаа үүсгэн түүнд тусгайлсан дэмжлэг үзүүлэх явдлаар авлигын энэ хэлбэр илэрнэ;

Авлигын гэмт хэрэг

Хүснэгт VII.14.1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэгт:

Эрүүгийн хуулийн зүйл	Авлигын гэмт хэрэг
22.1 дүгээр зүйл.	Эрх мэдлээ урвуулан ашиглах
22.2 дугаар зүйл.	Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах
22.3 дугаар зүйл.	Хахууль авах
22.4 дүгээр зүйл.	Хахууль өгөх
22.5 дугаар зүйл.	Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах
22.6 дугаар зүйл.	Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах
22.7 дугаар зүйл	Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх
22.8 дугаар зүйл.	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
22.9 дүгээр зүйл.	Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
22.10 дугаар зүйл.	Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
22.11 дүгээр зүйл.	Дураараа аашлах
22.12 дугаар зүйл.	Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

Монгол Улсад үйлдэгдэж болох авлигын гэмт хэргийн үйлдэх арга, хэлбэр:

- Улсын хилээр хориглосон эд зүйл нэвтрүүлэх, гадаадад их хэмжээний мөнгө, хөрөнгийг байршуулах;
- Төрийн өмч хөрөнгийг албан тушаалтан, хувийн хэвшлийнхэн хамтран бараа бүтээгдэхүүн, эд зүйл өндөр үнээр шахах, мөнгийг хувьдаа завших;
- Хуурамч бүтээгдэхүүн хууль бусаар үйлдвэрлэх, хууль бусаар хөрөнгө эзэмших, дансны аргаар мөнгө ашиглах, өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулах;
- Албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, бусдад давуу эрх хөнгөлөлт хууль бусаар олгох;
- Шүүхийн шийдвэрийг мушгин гуйвуулах, үл биелүүлэх, шийдвэр биелүүлэхээс зайлсхийх;
- Албан тушаалдаа хайнга хандах, шударга бус замаар орлого олох;
- Хээл хахууль, шан харамж авах, хууль бус ашиг хонжоо олон, хууль бус орлогоо хуваах;
- Татвар төлөхөөс зайлсхийх, орлогоо нуун дарагдуулах;

- Төрийн болон ААН-ийн нууц мэдээллийг зүй бусаар ашиглах, бичиг баримтыг хуурамчаар үйлдэх;
- Нөлөөлөх оролдлого гаргах, тал засч зуучлах, ашиг сонирхлын зөрчилд автах;
- Төрийн албан тушаал, өмч хөрөнгө, зөвшөөрлийг дур мэдэн худалдах, дүрэм журам, худалдан авсан зүйлсийг нэр төрөл, үнийн жагсаалт, гэрээ болон зээлийн ов мэх гарган будлиантуулах;
- Зүй зохисгүй бэлэг, мөнгөн төлбөр, үзвэр үйлчилгээ, дайллага цайллагад өртөх;
- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоо тогтоох, хар захын үйл ажиллагаа эрхлэх;
- Тал тохой татах, бусдыг хууль бусаар хаацайлах;
- Хууль бус хяналт шалгалт хийх, харилцаа холбоо болон шууданг зүй бусаар ашиглах;
- Албаны тамга тэмдэг, баримт бичгийг урвуулан ашиглах гэх мэт.

2. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Олон улсын байгууллагууд өөрсдийн хэрэгжүүлж буй бодлогод авлига хэрхэн нөлөөлж байгаа, түүнчлэн дэлхий нийтээр авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэлгээ өгдөг.

Авлигын төсөөллийн индексийн[156] 2016 оны судалгаагаар манай улс 38 оноо авч судалгаанд хамрагдсан 176 орноос 87 дугаар байрт орсон. Энэ нь өмнө он буюу 2015 оныхтой харьцуулахад авлигын төсөөллийн индексийн утга 1 оногоор буурч, эзлэх байр 15-аар ухарчээ.


Хүснэгт VII.14.2. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр

	2012[1]	2013	2014	2015	2016
Авлигын төсөөллийн индексийн утга	36	38	39	39	38
Монгол Улсын эзэлж буй байр	94	83	80	72	87
Үнэлгээнд хамрагдсан улс орны тоо	176	177	175	168	176

"Трансперенси интернэшнл" олон улсын байгууллагын судалгааны тайланд *"энэ оны судалгааны үр дүн авлига, тэгш бус байдлын хамаарлыг онцлон илэрхийлж байгаа бөгөөд авлига, тэгш бус байдал хоёр нь харилцан бие биедээ нөлөөлж нийгэм дэх авлига, эрх мэдэл болон баялгийн тэгш бус хуваарилалтыг бий болгож байна. Мөн түүнчлэн авлига, тэгш бус байдлын харилцан нөлөөлөл нь популизмыг үүсгэж байна. Авлига, эрх мэдлийн холбоосыг таслах амлалт өгч байгаа популист улс төрчдийг хүмүүс ихээр дэмжиж байна"* гэжээ.

156 Дэлхийн улс орнуудын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан үнэлгээ гаргадаг "Транспэрэнси интернэшнл" байгууллагын Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийг 2012 оноос эхлэн 0 (авлигад автсан), 100 (авлигагүй) хүртэл оногоор үнэлдэг болсон.

Зураг VII.14.1. Авлигын төсөөллийн индекс-2016, улсаар[157]



"Транспэрэнси интернэшнл" байгууллагаас дээрх судалгааны үр дүнд үндэслэн Ази, номхон далайн бүс нутгийн орнуудад дөрвөн үндсэн зөвлөмжийг өгсөн байдаг. Үүнд:

- Засгийн газрууд өлсгөлөн, ядуурал, боловсрол, эрүүл мэнд, жендер, уур амьсгалын өөрчлөлт зэрэг тогтвортой хөгжлийн зорилтуудын бүхий л зорилгод авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа нэгтгэх, авлигын эсрдлийг бууруулах механизмыг хөгжүүлэх;
- "Транспэрэнси интернэшнл" зэрэг байгууллагын боловсруулсан олон улсын одоогийн стандартад тулгуурлан шүгэл үлээгчийг хамгаалах хууль эрх зүйн цогц орчинг бий болгож, мөрдөх;
- Хээл хахуультай холбоотой ял завших асуудлыг эцэс болгох зорилгоор хээл хахууль өгөгч/авагчид хариуцлага хүлээлгэх, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх;
- Авлигатай тэмцэх байгууллагууд хээл хахууль өгөхөөс татгалзсан, мөн авлигыг мэдэгдсэн иргэдтэй хамтран ажиллах, тэднийг дэмжих.

Дэлхий нийтийн авлигын хэмжүүр

Дэлхий нийтийн авлигын хэмжүүр[158] судалгааны дүнгээс[159] харахад төрийн үйлчилгээг авахын тулд судалгаанд оролцсон дөрвөн хүн тутмын нэг нь хээл хахууль өгсөн байна. Хээл хахууль авч буй төрийн үйлчилгээний жагсаалтын хамгийн эхэнд цагдаагийн байгууллага орж байна. Судалгаанд хамрагдсан бараг гурван хүн тутмын нэг нь сүүлийн 12 сарын хугацаанд цагдаагийн ажилтанд хээл хахууль өгсөн гэжээ.

Монгол Улсын хувьд авлигатай тэмцэх чиглэлээр Засгийн газар/төр ямар түвшинд ажиллаж байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 61% нь муу гэж хариулсан, бол сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээг авахдаа хээл хахууль өгсөн гэж 20% нь хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 16% нь эмнэлэгт, мөн 16% нь цагдаад хээл хахууль өгсөн байна[160].

157 улаан өнгөөр авлигын эрсдэл өндөр, шар өнгөөр авлигын эрсдэл багатай улсыг тэмдэглэсэн
158 Global Corruption Barometer
159 Транспэрэнси интернэшнл байгууллагаас Ази, номхон далайн бүс нутгийн 16 улс орон дахь авлигын нөхцөл байдлыг судалж тогтоох зорилгоор 22000 орчим хүнээс авсан судалгаа
160 http://www.transparency.org/whatwedo/publication/people_and_corruption_asia_pacific_global_corruption_barometer

Хууль дээдлэх ёсны индекс[161]

Хууль дээдлэх ёсны 2016 оны судалгаанд[162] дэлхийн 113 орныг хамруулснаас Монгол Улс 0.54 оноотойгоор 55 дугаар байранд орсон бөгөөд өмнөх оныхоос 1 байраар ахисан эерэг үзүүлэлттэй байна.

Хүснэгт VII.14.3. Хууль дээдлэх ёсны индексийн дэд үзүүлэлтээр, Монгол Улс

Үзүүлэлт	2014	2015	2016
Хууль дээдлэх ёсны индекс	0.51	0.53	0.54
-авлигаас ангид байдал	0.39	0.42	0.41
-дэг журам, аюулгүй байдал	0.78	0.79	0.79
-суурь эрх, эрх чөлөө	0.61	0.61	0.60
-засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт	0.53	0.54	0.53
-иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй байдал	0.52	0.55	0.54
-эрүүгийн хэрэг шийдвэрлэж буй байдал	0.48	0.42	0.48
-хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	0.43	0.48	0.47
-нээлттэй засаг	0.33	0.46	0.48

Монгол Улс дахь авлигаас ангид байдлын үзүүлэлтийн дэд индексийг авч үзвэл хууль тогтоох үйл ажиллагаа (0.14), гүйцэтгэх засаглал (0.42)-ын үзүүлэлтүүд үнэлгээ харьцангуй бага байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига

Улс төрийн авлигын түвшин 2016[163] онд 3.65[164] пункт гарсан нь өнгөрсөн онтой адил үзүүлэлттэй байгаа нь Монгол Улсад улс төрийн авлига түгээмэл тархалттай байгааг илэрхийлж байна.


Түүнчлэн, Азийн сангаас явуулсан Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаагаар 2012 оны 11 дүгээр сараас хойш "Монгол улсад дээд түвшний авлига их байдаг" гэж хариулсан оролцогчдын тоо өндөр хэвээр байна. 2012 оны 11 дүгээр сард 43.1% байсан нь 2014 оны 3 дугаар сард 37.6 хувь буурсан ч 2016 оны 3 дугаар сард 43.1% болж буцаж өсчээ. "Дээд түвшний авлигын зарим нэг тохиолдлууд байгаа" гэж үзэх оролцогчдын тоо тогтмол нэмэгдэж байна. 2012 оны 11 дүгээр сард 24% байсан нь 2016 онд 35.4% болж өссөн байна.

Дээд түвшний авлига Монголд оршиж байгаа шалтгаан нь "Бизнес, улс төрийн сонирхол нийлсэн учраас" гэсэн хариулт 2016 онд 12% болж нэмэгдсэн байна. Энэ нь 2012 оны УИХ-ын сонгуулийн жилийн 11.2%-тай ойр байна. Бизнес болон улс төрийн сонирхол, зөрчилдөөн зэрэг нь сонгуулийн үеэр ил гардагтай холбоотой байж болох юм.[165]

161 Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл, http://worldjusticeproject.org/sites/default/files/media/wjp_rule_of_law_index_2016.pdf
162 "Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл" нь ашгийн бус, бие даасан байгууллага бөгөөд дэлхийн улс орнуудад хууль ёсыг дээдлэн сахиж буй байдлыг судалгаанд үндэслэн үнэлдэг.
163 Авлигатай тэмцэх газраас "Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа"-г 9 дэх удаагаа зохион байгуулав.
164 Үзүүлэлтийн утгыг 1-5-ын хооронд хэмжих бөгөөд 1-д дөхөх тусам авлигагүй, 5-д дөхөх тусам авлигад автсан байгааг илэрхийлнэ.
165 Азийн сангийн судалгаа

Түүнчлэн, намын санхүүжилтийн механизм, сонгуулийн санхүүжилтийн механизм, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил зэрэг нь улс төрийн авлигад нөлөөлсөн гол шалтгаан, нөхцөл болсон байна. Түүнчлэн, хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, олон шат дамжлага, давхардал, хийдэл, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул зэрэг нөхцөл байдал нь улс төрийн авлигыг нөхцөлдүүлэгч шалтгаан болж байна.[166]

Зураг. Улс төрийн авлигын түвшин, 2008-2016 онд



Улс төрийн хүрээний авлигын хор уршиг нь улс орныг бүхэлд нь хамарсан нийгэм, эдийн засгийн олон сөрөг үзэгдлийг үүсгэж байна. Тухайлбал улс орны эдийн засгийн хүч чадал сулрах, гадаадын хөрөнгө оруулалт буурах, өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдэх, нийгэмд шударга ёс алдагдахад нөлөөлсөн байна.

Азийн сангийн судалгаанаас харахад Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын томоохон компаниуд авлигын арга замыг ихээхэн ашигладаг гэж үзэх оролцогчдын тоо тогтвортой өссөөр 2012 оны 11 дүгээр сард 16.2% байснаас 2016 оны 3 дугаар сард 20.4% болжээ. Харин дотоодын томоохон компаниуд "Асуудлаа авлигаар шийдэх нь түгээмэл" гэж үзэх оролцогчдын тоо харьцангуй тогтвортой байгаа ба 2016 оны 3 дугаар сард 7.8% байна.


Асуудал шийдэгдэхгүй байгаагийн үндсэн шалтгааныг төр засгийн дээд түвшинд ил тод байдал хангалтгүй (17.9%) мөн хууль эрх зүйн тогтолцоо ийм түвшний асуудлыг авч шийдэх чадваргүй байдаг (16.7%) гэж судалгаанд оролцогчид үзжээ. Монгол Улсын эдийн засагт хяналт муутай их хэмжээний мөнгө байгаа гэж үзсэн оролцогчдын тоо бага зэрэг буурсан нь нийгэм эдийн засгийн ерөнхий хямралтай холбоотой байж болох юм гэж дүгнэжээ.

Авлигын гэмт хэргийн мөрдөн байцаалт явуулсан хэрэг

2016 онд АТГ хуульд заасан харьяаллын 471 үйлдэл, 459 холбогдогчтой 235 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулав.


166 Авлигатай тэмцэх газраас "Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа

Зураг VII.14.2. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн тоо, оноор




Эрүүгийн хэрэгт холбогдуулан 459 хүн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.9%-аар өссөн байна. Албан тушаалын байдлаар нь авч үзвэл төрийн улс төрийн 28 буюу 6.1%, төрийн захиргааны 74 буюу 16.1%, төрийн тусгай 65 буюу 14.2%, төрийн үйлчилгээний 61 буюу 13.3%, ТББ, төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААН-ийн албан тушаалтан 112 буюу 24.4%, энгийн иргэд 119 буюу 25.9%-ийг эзэлж байна.

Зураг VII.14.3. Эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нийт хүний тоо, албан тушаалын байдлаар




Зураг VII.14.4. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо, оноор



Гэмт хэргийн улмаас 37.7 тэрбум төгрөгийн хохирол учирсныг мөрдөн байцаалтын явцад тогтоожээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийг аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хотод 146 хэрэг буюу нийт хэргийн 62.1% нь, аймгуудад 89 хэрэг буюу 37.9% нь хамаарч байна.

Зураг VII.14.5. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн хувийн жин, аймаг, нийслэлээр



СОГТУУРАЛ БА ГЭМТ ЯВДАЛ



15. СОГТУУРАЛ БА ГЭМТ ЯВДАЛ

ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2016 оны статистик тоо баримтаас үзэхэд хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэгчдийн 66.1%, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдэгчдийн 35.6%, хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчдийн 50.6%, танхайрах гэмт хэргийн 53.1%, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгчдийн 28.9%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн 17.3%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэгчдийн 7.3%, бүлэглэн гэмт хэрэг үйлдэгчдийн 24.7%, гэр бүлийн хүчирхийлэгч үйлдэгчийн 39.5% нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.

Нийт согтуугаар гэмт хэрэгт хохирсон хохирогчдийн 6.7% архидан согтуурсаны улмаас гэмт хэргийн хохирогч болсон байна.

Монгол Улсад сүүлийн арван жилийн хугацаанд 231060[167], жилд дунджаар 23 орчим мянган гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 2007-2011 онуудад гэмт хэргийн тоон үзүүлэлт буурах хандлагатай байснаа 2012 оноос жил ирэх тусам өсөх хандлагатай байна.

Жилд дунджаар 23106 гэмт хэрэг бүртгэгдсэний 58.5% нь Улаанбаатар хотод, 41.5% нь орон нутаг үйлдэгдсэн байна.

2016 онд нийт 27167[168] гэмт хэрэг үүнээс: нийслэлд 17909, орон нутагт 9222, бусад газарт 36, сард дунджаар 2615 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 590 хэргээр буюу 2.1%, орон нутагт 557 хэргээр буюу 5.7%, нийслэлийн хэмжээнд 30 хэргээр буюу 0.2%-аар тус тус буурсан байна.

Улсын хэмжээний 2016 оны эрүүгийн нөхцөл байдлыг товчоор, тоон хэлээр дүгнэвэл нэг гэмт хэрэгт 6.0 сая төгрөгийн хохирол ногдож, 30 гэмт хэрэг тутамд нэг хүн нас барж, 2.4 гэмт хэрэг тутамд нэг хүн гэмтжээ. Өөрөөр хэлбэл, хоногт 74 гэмт хэрэг бүртгэгдэж, 2 хүн нас барж, 76 хүн гэмтжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 33.1% бусдын эд хөрөнгийг хулгайлах, 30.4% нь бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 64.0%, Улаанбаатар хотод 61.5% байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 1.9, Улаанбаатар хотод 2.6 нэгжээр тус тус өссөн.


СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг сүүлийн 10 жилийн байдлаар: 2007-2016 онд улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн нийт 51820 гэмт хэрэг бүртгэгдсэний 37.6% нь нийслэлд бүртгэгджээ. (Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 22.4%-ийг эзэлж байна)

Жилд дунджаар 4218 гэмт хэрэг бүртгэгдэж, сард 351, хоногт 11, хоёр цаг тутамд 1 гэмт хэрэг гарсан байна.

167 Цагдаагийн Ерөнхий газрын 2014-2016 оны гэмт хэрэг зөрчлийн статистик цагаан мэдээ
168 Цагдаагийн Ерөнхий газрын 2016 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын танилцуулга

График VII.15.1.



Хүснэгт VII.15.1.

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Импортолсон тоо хэмжээ (сая.л)[2]										
Согтууруулах ундаа[3]	36.8	43.5	22.5	40.0	57.3	61.0	66.6	46.1	23.0	35.8
Импортын үнийн дүн (сая.доллар)[4]										
Согтууруулах ундаа	29.1	36.3	18.6	31.2	38.9	51.4	50.9	38.5	25.1	24.1
Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ (сая.литр)										
Спирт	39.3	35.1	3.5	3.6	3.4	3.3	10.0	9.1	8.7	8.6
Архи, дарс	74.3	82.3	17.4	20.4	25.6	26.9	24.9	24.3	21.2	23.9
Шар айраг	83.8	101.5	32.4	44.9	57.1	65.1	63.8	67.7	74.9	75.7
Нэг хүнд ногдох (мян.литр)										
Согтууруулах ундаа	13.3	24.6	24.3	32.8	41.6	46.6	29.7	29.1	28.5	27.6

Улсын хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэдэг ААН[169]

Хүснэгт VII.15.2.

Үзүүлэлт	Спиртийн үйлдвэр	Архины үйлдвэр	Пивоны үйлдвэр	Дарсны үйлдвэр
2007 он	15	74	14	10
2008 он	14	75	15	6
2009 он	12	78	13	8
2010 он	12	79	15	8
2011 он	12	71	7	7
2012 он	9	58	14	6
2013 он	11	56	15	6
2014 он	9	56	19	10
2015 он	7	21	10	15
2016 он	8	22	11	9

169 Нийгмийн хэв журам хамгаалах албаны тайлан /2007-2016/

Улсын хэмжээнд согтууруулах ундааны зүйл худалддаг түүгээр үйлчилдэг байгууллага ААН[170]

Хүснэгт VII.15.3.

Үзүүлэлт	Үйлчилдэг				Худалддаг			
					Хүнсний дэлгүүр			
	Зоогийн газар	Диско	Караоке	Кафе	Орон сууцны хороолол	Гэр хороолол	Нийт	Бөөний төв
2007	614	596	331	427	2085	3457	5542	172
2008	550	569	255	344	2041	3359	5400	178
2009	569	630	274	453	1993	3811	5804	214
2010	874	879	538	585	3227	4682	7909	248
2011	1045	787	461	567	2370	4457	6827	217
2012	982	536	615	589	2304	4047	6351	185
2013	919	536	686	544	2368	4688	7056	266
2014	1473	630	1175	995	2012	4752	9364	266
2015	1114	419	788	718	2077	5003	7080	284
2016	1357	440	831	690	2171	4928	7099	194

2007-2016 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 1182166 хүн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ цагдаагийн байгууллагад саатуулагдсанаас (44.4% нь Улаанбаатар хотод, 45.7% нь аймагт, 9.8% нь бусад газарт) жилд дунджаар 125796, сард 10483, хоногт 349, цагт 14 хүн саатуулагдаж байна.

График VII.15.2.



170 Нийгмийн хэв журам хамгаалах албаны тайлан /2007-2016/

2016 ОНД СОГТУУГААР ҮЙЛДЭГДЭН БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ:

ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн болосвруулах газрын статистик мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн нийт 5520 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 387 хэргээр буюу 6.6%-аар, Улаанбаатар хотын хэмжээнд 353 хэргээр буюу 12.0%-аар, Орон нутагт 21 хэргээр буюу 1.0%-аар тус тус буурсан статистик үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг (нутаг дэвсгэрээр)

Хүснэгт VII.15.4.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	2962	2933	-1.0	1.7	0.11
Нийслэлд	2937	2584	-12.0	1.6	0.10
Бусад газарт	8	3	-62.5	0.003	0.0001

Зураг VII.15.1.



Хүснэгт VII.15.4.

Дархан-Уул аймаг	↓ 258	Орхон аймаг	↓ 206	Говьсүмбэр аймаг	↓ 77
Баянгол	↓ 416	Баянзүрх	↓ 638	Сонгинохайрхан	↓ 472
Сүхбаатар	↓ 312	Хан-Уул	↑ 210	Чингэлтэй	↓ 292
Багануур	↓ 92	Багахангай	↑ 13	Налайх	↑ 139

Бүртгэгдсэн гэмт хэрэг (хэргийн ангиллаар)

График VII.15.3.



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Хөнгөн гэмт хэрэг 2.7%-аар өссөн
- Хүндэвтэр гэмт хэрэг 12.7%-аар
- Хүнд гэмт хэрэг 8.3%-аар
- Онц хүнд гэмт хэрэг 14.1%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

График VII.15.4.



График VII.15.5.



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2016 онд буурсан боловч Архангай, Төв, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Дорнод, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Увс аймгууд, Улаанбаатар хотын Баганхангай, Хан-Уул дүүргүүдэд 1.0-85.7%-иар өссөн байна.

Согтуугаар үйлдэгдсэн хэргийн бүтэц, гэмт хэргийн төрлөөр:

- Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн **56.7%**;
- Танхайрах гэмт хэргийн **13.8%**;
- Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн **11.0%**;
- ТХХАББАЖЗөрчих гэмт хэргийн **6.4%**;
- Хүнийг санаатай алах гэмт хэргийн **2.2%**;
- Хүчиндэх гэмт хэргийн **2.7%**;
- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн **2.0%**;
- Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн **0.2%**;
- Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн **0.3%**;
- Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн **0.07%** нь архидан согтуурсны улмаас үйлдэгджээ.

Бүтцийн хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бусдын бие махбодид гэмтэл учруулах, ТХХАБАЖурам зөрчих, хүчиндэх гэмт хэрэг 0.2-4.7 пунктээр буурч, хүнийг санаатай алах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, булаах, хулгайлах, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх, танхайрах гэмт хэрэг 0.03-2.1 пунктээр өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүн: Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 5507 хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42 буюу 0.8 хувиар буурсан байна. Үүнээс 372 буюу 6.8 хувь нь эмэгтэй, 5135 буюу 93.2 хувь нь эрэгтэй, тэдний 59 буюу 1.1 хувь хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 12.8 хувиар, эрэгтэй 6.1 хувиар, хүүхэд 24.4 хувиар тус тус буурчээ.

Нас, нийгмийн байдал:

График VII.15.6.




График VII.15.7.



График VII.15.8.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирогч, хохирлын хэмжээ: Гэмт хэргийн улмаас 1 ААН, байгууллага, 4855 иргэн хохирч, үүнээс 242 хүн нас барж, 3722 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, барсан хүн 24 буюу 9.7%-аар, гэмтсэн хүний тоо 171 буюу 4.4%-аар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 5.5 тэрбум төгрөгийн хохирлын 76.4%-ийг нөхөн төлүүлж, 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Бүртгэгдсэн захиргааны зөрчил, согтуугаар саатуулагдсан хүн: 2016 оны байдлаар нийт 1,034,598 захиргааны зөрчил бүртгэгдсэний 8.1% нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ захиргааны зөрчил үйлдсэн байна.

Архи согтууруулах ундааны зүйл удаа дараа хэрэглэн зөрчил үйлдсэн 817 иргэнд баривчлах, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 30017 иргэнд торгох, эрх хасах арга хэмжээ авсан байна.


График VII.15.9.



Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас 2016 онд архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, захиргааны зөрчлийн тоог бууруулах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай 601, Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай 183, мэргэжлийн хяналтын газартай 331, татварын албатай 120, ТББ-тай 89 удаа тус тус хамтран согтууруулах ундаа үйлдвэрлэдэг 50, худалдан борлуулах зөвшөөрөлтэй 7293 цэг, үйлчлэх зөвшөөрөлтэй 3318 цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ерөнхий арга хэмжээ 553, тусгай арга хэмжээ 1022 зохион байгуулж, Захиргааны хариуцлагын тухай хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн нийт 30816 зөрчил илрүүлж, 30445 иргэн, 7 албан тушаалтан, 364 ААН, байгууллагыг 11 202 630 400 төгрөгөөр торгож, 352 литр спирт, 7371 литр архи, 3924 литр пиво, 76 литр дарс хураан авч, 709 000 төгрөгийг улсын орлого болгосон байна171.

171 ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах албаны 2016 оны тайлан.

График VII.15.10.



Нийт 87356 хүн эрүүлжүүлэгдсэний (60.0% нь Улаанбаатар хотод, 40.0% нь орон нутагт) 76.3% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 5.6% нь эмэгтэй, 0.3% нь насанд хүрээгүй хүмүүс, 0.1% гадаадын иргэд бүртгэгджээ.

График VII.15.11.



Нийт согтуугаар саатуулагдсан иргэдийн 63.6% гэр, орон сууц, 25.3% гудамж, талбай олон нийтийн газраас 87.8% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан шалтгаанаар саатуулагдсан байна.

СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Согтуурал бол өнгөрсөн нийгмээс өвлөгдөж ирсэн нийгмийн үзэгдэл. Согтуурал нь өөрийн нийгэм, түүхийн агуулгаараа олон талаар гэмт явдалтай адил төсөөтэй.

Согтуурлыг төрүүлдэг үндсэн шалтгаан болох сэтгэл зүйн гэмтэл, ядуу хоосон байдал, ажилгүйдэл, өөртөө итгэлгүй байдал, амьдралын тэсвэрлэх аргагүй хүнд нөхцөл болон нийгмийн шударга бус хэлбэрүүд устаагүй байна.

Ууж согтуурах явдал зарим талаар хүний хувийн амьдралын зохисгүй байдал, тухайлбал хувь хүнд тохиолдсон хүндрэлтэй байдал, ажил, сургууль дээр гарсан бэрхшээл, ойр дотны хүнээ алдах, гэр бүл салах зэрэг сэтгэл санааны хямралд оруулсан зүйлс нөгөө талаар ямар нэгэн тэмдэглэлт үйл явдлыг заавал согтууруулах ундаа хэрэглэж, найр наадмыг өргөн их бэлтгэж тэмдэглэн өнгөрүүлдэг явдал нь үндсэн шалтгааны нэг болж байна.

Мөн жижгээр танхайрах, нийтийн хэв журам зөрчих зөрчил нь бүхэлдээ согтуурлаас үүдэлтэй гэж хэлж болохоор байна.

ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АВЧ ҮЗВЭЛ:

- Ажилгүйдлээс үүссэн ядуу сэтгэлгээ (согтуугаар гэмт хэрэг үйлдэгчдийн 55.3%, захиргааны зөрчил үйлдэгчдийн 2.8%, саатуулагдсан иргэдийн 76.3% нь тус тус эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байна.)
- Гэр бүл цуцлалт, сэтгэл санааны хямрал (Гэр бүл цуцлалтын тоо жилээс жилд дунджаар Монгол Улсын хэмжээнд тухайн тоо баримтаар өдөрт 10 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 40 хос гэрлэлтээ бүртгүүлдэг гэсэн статистик гарсан байна)
- Хот суурин дагасан хүн амын хэт төвлөрөл (Үндэсний статистикийн хорооны 2015 оны салбарын статистик мэдээгээр шилжин ирж буй хүмүүсийн тоо өмнөх оноос Улаанбаатар хотод 31014, Дархан хотод 349, Эрдэнэт хотод 6045 иргэн шилжин ирсэн байна)
- Аливаа амралт, баяр ёслолын өдрүүдийг согтууруулах ундаа хэрэглэн хавтгайруулан тэмдэглэх болсон (Засгийн газрын шийдвэрээр амралтын өдрийг уртасгаж байгаа зэрэг асуудлаас шалтгаалж)
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй (хэвлэл мэдээллийн хэрэгслээр согтууруулах ундааны сурталчилгаа ихэссэн)
- Зах зээлд нийлүүлэх архи, согтууруулах ундааны хэмжээ ихэссэнээр иргэдийн хэрэглээ нэмэгдэж, архидан согтуурах явдал нийгмийн түгээмэл үзэгдэл болсон (хүснэгт 2)
- Согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоо хэт олширсноос хүн ам, ялангуяа хүүхэд, залуучууд оршин суугаа газар болон сургууль, ажлын газраасаа 50-700 метр яваад л хүссэн цагтаа (24 цаг) согтууруулах ундаа авч хэрэглэх боломжтой байгаа нь хүн амын согтууруулах ундааны хэрэглээ ихсэхэд нөлөөлж байна.

Согтуугаар саатуулагдсан иргэний тоо 2013 оноос хойш буурсан нь (график-3) 2003 онд батлагдсан "Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай" хуулийн нэмэлт өөрчлөлт нь 2013 оны 07-р сарын 05-ны өдөр УИХ-аар батлагдаж, тус хуулийн 6.2-т "Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байр нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяалалд ажиллана" гэж заасантай холбоотой буурчээ.

НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Иргэд архидан согтуурсан хүнтэй зохих ёсны тэмцэл явуулахгүй эвлэрэнгүй хандаж өөгшүүлж, аливаа тэмдэглэлт өдрийг архи, согтууруулах ундааны зүйлтэй тэмдэглэх хэв маяг бий болсон.

Архидан согтуурч үр хүүхдээ буруу хандлага төрүүлдэг эцэг эх цөөнгүй байна. Согтууруулах ундаа хэрэглэдэг зарим эцэг, эх үр хүүхдээ архины хорт муу зуршлын талаар тайлбарлан хэлдэг боловч өөрсдийн биеэр дэргэд нь ууж согтуурч байна.

Согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг цэг, ААН-үүдийн тоо олширсон, тэд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр гарсан хууль тогтоомжийг мөрдөн ажиллах явдал хангалтгүй зарим зүйл заалтыг зөрчих явдлыг нийтээрээ хэвийн зүйл мэт бодох болсон.

Тухайлбал, Телевизээр энэ төрлийн сурталчилгаа маш их цацагдах болсон.

Зураг VII.15.2. Телевизээр гарч байгаа согтууруулах ундааны рекламын зураг





Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 (согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах) гэснийг зөрчиж байгаа үйлдэл.

Хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, хоёр хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, пиво, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи согтууруулах ундаанд хамаарна[172] гэж хуульд заасан байдаг.

Монгол Улсад үйлдвэрлэж байгаа согтууруулах ундааны үйлдвэрлэл жил ирэх тусам өсч байгаа нь нэг хүчин зүйл болж байна. Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик мэдээллээс үзэхэд сүүлийн таван жилд нийтдээ 508.1 сая литр согтууруулах ундаа үйлдвэрлэсэн нь жилд дунджаар 3.4 сая литрээр өссөн төдийгүй 2017 онд 111.6 сая литрийг үйлдвэрлэгдэх прогноз гарч байна.

ДҮГНЭЛТ:

Монгол Улсын хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 24.8% нь архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн байгаа нь согтууруулах ундааны зохистой хэрэглээний соёл, төлөвшил, ёс суртахуун, гэр бүлийн орчин, байгууллага, хамт олон, найз нөхдийн харилцаа, нөлөөлөл, тэмдэглэлт баяр ёслол, амралтын өдрүүд зэргээс шалтгаалахаас гадна согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх явдал буурахгүй байгаа тул үүнээс улбаалан гарах сөрөг үр дагавар, хор уршиг нь жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байна.

Сүүлийн таван жилд 508.1 сая литр согтууруулах ундаа үйлдвэрлэж, 232.5 сая литрийг импортолсон 3.1 сая хүн амтай, үүний дотор 18 ба түүнээс дээш насны 1.9 сая хүн амтай[173] улсын хувьд хэтэрхий өндөр үзүүлэлт.

Статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын хэмжээ нь хүн амын хэрэглээний зохих түвшингээс хэт давж, улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд хүрч, ард иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах нөхцөл хангагдах баталгаа байхгүй болж байгааг харуулж байна.

172 Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 3.1 дэх хэсэг
173 Үндэсний статистикийн хорооны 2015 оны хүн амын судалгаа

ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын статистик мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн нийт 5520 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 387 хэргээр буюу 6.6%-аар, Улаанбаатар хотын хэмжээнд 353 хэргээр буюу 12.0%-аар, Орон нутагт 21 хэргээр буюу 1.0%-аар тус тус буурсан статистик үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа гараг, цаг хугацааны хувьд амралтын өдрүүд болон 19-06 цагт гэмт хэргийн 59.9% нь үйлдэгдэж байгаа нь энэ цагуудад үйлдэгдсэн гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Согтуугаар үйлдсэн нийт иргэдийн 87.4%-ийг 18-44 хүртэлх насныхан эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа 18-24 хүртэлх насныхан 20.7%, 25-29 насныхан 24.5% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Согтуугаар үйлдэгдсэн нийт гэмт хэргийн дотор гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийн тоо өсөх хандлагатай байна. Жишээ нь: 2010 онд аймгийн хувьд 82, Улаанбаатар хотод 56 бүртгэгдсэн бол 2014 онд 280 ба 232 болтол өссөн байна. 2010-2014 оны байдлаас харахад, аймгуудад 2.9 дахин, дүүргүүдэд 2.3 дахин нэмэгджээ. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өсөхийн хэрээр гэр бүлийн хүчирхийллийн тоо өсч байна.[174]

Мөн статистик тоо баримтаас согтуугаар үйлдэгсэн гэмт хэргийн бүтцийг үзэхэд бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 56.7% нь, танхайрах гэмт хэргийн 13.8% нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 11.0% нь, ТХХАБАЖурам зөрчих гэмт хэргийн 6.4% нь тус тус архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн байна. Согтууруулах ундааг зүй зохистой, тохируулж хэрэглэх ёс зүй төлөвшөөгүй, хувь хүний ухамсар, зан үйл, согтуу хүмүүсийн хоорондын таарамжгүй харьцаа, маргаанаас үүдэн энэ төрлийн гэмт хэрэг зонхилон үйлдэгдэж байна.

Статистик мэдээнээс үзэхэд 2016 онд хоногт дунджаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 80 жолоочийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авсан байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол, хэрэг гаргахгүй, дүрэм, журмыг зөрчихгүй гэж хөнгөмсөгөөр найдаж, заримдаа өөрийгөө удирдан жолоодох чадваргүй болтлоо согтсон үедээ тээврийн хэрэгсэл жолоодож осол, хэрэг гаргаж байна.

Согтуугаар гэмт хэрэг үйлдэж байгаа иргэдийн **48.5%** нь 18-29 насны хүмүүс эзэлж байгаа бөгөөд гэмт хэргийн **59.9%** нь оройн 19.00 цагаас өглөөний 06 цагийн хооронд бүртгэгдэж байгаа ба согтууруулах ундаа худалдах, үйлчлэхийг хориглосон шийдвэрийн хэрэгжилт хангалтгүйгээс гадна хүнийг санаатай алах, иргэдийн эрх чөлөөний эсрэг, танхайрах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх гэмт хэргүүд болон согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгслэл жолоодох, согтуурсан үедээ амиа хорлох зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл өсч байна.

Ажилгүй иргэдийн дунд архины хэрэглээ өндөр байна. Тухайлбал, Улсын хэмжээнд 2016 онд согтууруулах ундааны зүйл хэрэглэж, цагдаагийн байгууллагад саатуулагдсан иргэдийн 76.3%-ийг (жилд дунджаар 67.614), согтуугаар гэмт хэрэг үйлдсэн тохиолдлын 50-иас дээш хувийг ажилгүй иргэд эзэлж байна. Үүнээс харахад ахуйн хүрээний архидалт нэмэгдэж байна гэж үзэж болох талтай.

Сүүлийн 5 жилийн байдлаар дүүргүүдэд нэмэгдэх, харин аймгуудад буурах төлөвтэй байна. Шалтгааны хувьд эхний байранд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан нь аймаг, дүүргийн хувьд 70 орчим хувийг эзэлж байна.

СЭМҮТ-өөс хийгдсэн судалгаагаар 29 оролцогчдын 14 орчим хувь нь архинд донтох эмгэгтэй, 6.1% нь ноцтой хэрэглээтэй, 13 орчим хувь нь хортой үр дагавар учруулах хэрэглээтэй гэж тодорхойлогджээ. Архинд донтох эмгэгтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь

174 Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах судалгааны ажлын тайлан 2016 он

эмэгтэйчүүдээс 4 дахин их байна. 1990-2000 онуудад уг эмгэгийн тохиолдол хоёр дахин өссөн бөгөөд улсын хэмжээнд эмчилгээ хийлгэх шаардлагатай 12,000 орчим хүн байгааг уг судалгаанд дурджээ.[175]

Аймаг, дүүргийн төвшинд архидан согтуурахтай тэмцэх нэгдсэн төлөвлөгөөгүй. ЗДТГ-ын харьяа байгууллага, хэлтсүүд өөрсдийн үйл ажиллагааны хүрээний үйл ажиллагаагаар бусадтайгаа хамтран ажиллах тохиолдол гардаг аж. Харин Хэнтий, Дорноговь зэрэг аймаг "Архигүй Хэнтийчүүд" 2012 оноос, "Архигүй Дорноговьчууд" хөтөлбөрийг 2014 оноос хэрэгжүүлж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ЦААШИД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ, САНАЛ. Үүнд:

Нэг. Засгийн газар

- Согтууруулах ундаа худалдан авах чадварыг бууруулах, согтууруулах ундааны хүртээмжтэй байдлыг хязгаарлах бодлого баримтлах
- Хүн амын шилжилт хөдөлгөөн, ажилгүйдлийг зохицуулах хуулийн төслийг УИХ-д өргөн барих. Энэ хуулийн төсөлд хүн амын оршин суух нутаг дэвсгэрийн ложистик төлөвлөлт, иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээ, тухайн оршин суугчдад дунджаар ногдох ажлын байрны доод хязгаарыг зааж, түүнийг хэрхэн хангах талаар зохицуулсан байх;
- Нийгмийн эмзэг бүлэг, тэнэмэл амьдралтай, орон гэргүй, архаг архичин, мансуурах донтой, хорихоос суллагдсан хүмүүсийг эмчлэх, нийгэмшүүлэх, бусад хэлбэрээр туслалцаа үзүүлэх Үндэсний төв болон төвлөрсөн асрамжийн газруудыг байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;
- Хүч хэрэглэсэн гэмт хэргийн 60 хувийг согтуугаар үйлдэж, иргэдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа тул нийт нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчлэх ААН (цэг)-ийн дээд хязгаарыг тогтоож, журамлах, үүний тулд тухайн нутаг дэвсгэрт оршин суугчийн тоон үзүүлэлтийг харгалздаг байх;
- Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийг сэтгэл зүйн болон бусад эмнэлгийн үйлчилгээнд хамруулж, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
- Төрийн болон ТББ-ууд дээр хийгдсэн судалгаа, тоо баримтад үндэслэн дараа дараачийн урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг чадавхжуулах, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх чиглэлээр жил бүр Засгийн газрын тусгай сангаас хөрөнгө гаргах.

Хоёр. Хууль зүй, дотоод хэргийн салбарын түвшинд

- Архидан согтуурах гэмт явдалтай тэмцэх чиглэлээр хууль сахиулах үйл ажиллагаа явуулахад учирч буй бэрхшээлийг шийдвэрлэж, хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг УИХ, Засгийн газарт өргөн барих;
- Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаа, хууль сахиулах байгууллагаас явуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцох, бусад хэлбэрээр хамтран ажиллах;

175 Эрүүл мэнд, эдийн засаг учруулах архины дарамтыг судлах судалгааны ажлын тайлан 2016 он

- Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага болон ямар хэлбэрээр зохион байгуулбал үр дүнтэй болохыг урьдчилан судалж байх;
- ГХУСАЗЗөвлөл, дэд зөвлөлийн үүрэгт ажилд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч ажиллах бодлогыг тодорхойлох;
- Согтуугаар үйлдэгдсэн зарим төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд салбарын яамдуудтай гэрээ, санамж бичгийг байгуулж, хамтарсан арга хэмжээ, судалгаа, төлөвлөлтийг уялдуулан зохион байгуулах;
- Зам, гудамж талбай, нийтийн үйлчилгээний газруудад нэгдсэн стандарт бүхий CCTV системийг нэвтрүүлэх, цагдаа, хууль сахиулах байгууллагын техник, технологийн бодлогыг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх.
- Архидан согтуурахтай тэмцэх, түүнийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ын явуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцох, бусад хэлбэрээр хамтран ажиллах;
- Цагдаагийн үйлчилгээний чанар, хүртээмж, жишиг нормативийг хангуулж ажиллуулах, учирч буй бэрхшээлийг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.
- Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны хүрээнд иргэдийн төрөл бүрийн идэвхжүүлэлт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах зэрэг болно.

Гурав. Нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга, түүний харъяа байгууллагуудыг нийтлэг үүргийн дагуу согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж хүлээх үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сум, баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын оролцоог хангах, улирал тутам сургалт, зааварчилгаа өгдөг байх;
- Ял шийтгэгдсэн, хорихоос суллагдсан иргэдийг нийгэмшүүлэх, нийгмийн үйлчилгээ авахад нь туслах, ажлын байраар хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулах, ажилгүй иргэдийг ААН, байгууллагад ажилд зуучлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, судалгааны үр дүнг ашиглан ажил, арга хэмжээ зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлж үлгэрлэн ажиллах;
- Иргэдэд архидан согтуурах, архины хор хөнөөлийн талаар сурталчлах, соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын график төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх;
- Аймаг, сум, дүүргийн хэмжээнд долоо хоногт 1 өдрийг согтууруулах ундаа худалдах, үйлчлэхгүй болгох;
- Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй ажил, үр дүнгийн талаарх нэгдсэн санг бүрдүүлэх

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ, ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ЯВДАЛ



16. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ, ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ЯВДАЛ

НЭГ. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Булаах гэмт хэргийн нөхцөл байдал

Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг нь "Бусдын эд хөрөнгийг өмчилж, эзэмшиж, итгэмжлэн хариуцаж байгаа этгээдийг харсаар мэдсээр байхад нь хүч хэрэглэхгүйгээр, илээр, шунахай зорилгоор хууль бусаар өөрийн эзэмшилд шилжүүлэн авч байгаа идэвхитэй үйлдэл юм" хэмээн эрдэмтэд тодорхойлсон байна.

Бүртгэгдсэн байдал:

График VII.16.1.



2010-2016 оны байдлаар нийт 1423 булаах гэмт хэрэг бүртгэгдсэний 76,7% нь нийслэлд, 15,1% нь орон нутагт үйлдэгдсэн байна.

Түүнчлэн, бүртгэгдсэн гэмт хэргийн хувьд аваад үзвэл 2010-2011 он хүртэл буурч 2012 онд өмнөх оноос 30.7%, 2013 онд 26.8%, 2014 онд 7.9% тус тус өсч, улмаар 2016 онд 176 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 18.5%-иар буурсан үзүүлэлттэй байна.


Цагдаагийн байгууллага 2010-2014 оны байдлаар булаах, дээрэмдэх гэмт хэргийн талаар 13074 гомдол, мэдээлэл хүлээн авсан ба үүний 931 нь буюу 7.1% нь булаах гэмт хэрэг гэж тогтоогдсон байна.

График VII.16.2.



Дээрх 5 жилд бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэгтэй холбоотой гомдол, мэдээлэл 5380 бүртгэгдсэний 82,5% нь нийслэлд, 13,6% нь орон нутагт үйлдэгдсэн байна.


График VII.16.3.



2015 оны байдлаар улсын хэмжээнд нийт 27757 гэмт хэрэг бүртгэгдсэний 0.1% буюу 216, 2016 оны байдлаар нийт 27167 гэмт хэрэг бүртгэгдсэний 0.6% буюу 176 нь бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Булаах гэмт хэргийн илрүүлэлтийг 2010-2014 оны байдлаар харьцуулахад 2011 онд 6%, 2012 онд 10.1%, 2014 онд 4.9%-иар тус тус буурсанаас харвал гэмт хэргийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн хангалтгүй байгаагын илрэл.

График VII.16.4.



Харин 2016 оны байдлаар 157 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8%-аар буурч, түүнээс яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн илрүүлэлт 56.1%-тай байгаа нь өмнөх оныхоос 7.8 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэсэн гэмт хэргийн ангилал: /2016 оны байдлаар/


График VII.16.5.



Үүнээс: хөнгөн 116, хүндэвтэр 57 болон хүнд 3 булаалтын гэмт хэрэг бүртгэгджээ.


Булаалтын гэмт хэрэгт холбогдогчдын насны байдал: (2016 оны байдлаар)

График VII.16.6.



Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нийгмийн байдал: (2016 оны байдлаар)

График VII.16.7.



Холбогдогсдын хүйсийн байдлаар (2016 оны байдлаар): Нийт 120 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 буюу 13.7%-аар буурсан байна. Үүнээс 6 буюу 5.0% нь эмэгтэй, 114 буюу 95.0% нь эрэгтэй, тэдний 22 буюу 18.3% нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 14.9%-аар, хүүхэд 29.0%-аар тус тус буурч, эмэгтэй 20.0%-аар өссөн байна.

График VII.16.8. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар (2016 оны байдлаар)



2010–2014 оны байдлаар: Нийт булаах гэмт хэргийн 72.6% буюу 529 нь гудамж талбайд, 152 нь гэр, орон сууцанд, 65 нь олон нийтийн газарт, 31 нь зочид буудалд, 31 нь ААН-д, 17 нь нийтийн тээвэрт үйлдэгдсэн байна.

2016 оны байдлыг 2015 оны мөн үетэй харьцуулахад: Бусад газарт 2 буюу 16.7%-аар өсч, гудамж талбайд 35 буюу 24.8%-аар, нийтийн тээвэрт 4 буюу 50.0%-аар, олон нийтийн газарт 1 буюу 7.7%-аар, ТББ, авто замд 1 буюу 1%-аар тус тус буурч гэр орон сууц, ААН, байгууллагад мөн үеийн түвшинд байна.

Хүснэгт VII.16.1. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг:

Даваа	26	14.8%
Мягмар	19	10.8%
Лхагва	31	17.6%
Пүрэв	34	19.3%
Баасан	25	14.2%
Бямба	24	13.6%
Ням	17	9.7%

График VII.16.9. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг:



Хүснэгт VII.16.2. Аймгуудын хэмжээнд үйлдэгдсэн байдал:

№		Аймгийн нэр	2015	2016
1	Баруун бүс	Баян-Өлгий		
2		Говь-Алтай		1
3		Завхан		
4		Үүнээс: Тосонцэнгэл		
5		Увс		
6		Ховд	1	
7	Хангайн бүс	Архангай	1	
8		Баянхонгор	1	1
9		Булган		
10		Орхон	5	2
11		Өвөрхангай	1	2
12		Үүнээс: Хархорин	1	
13		Хөвсгөл	5	
14	Төвийн бүс	Говьсүмбэр		1
15		Дархан-Уул	11	4
16		Дорноговь	2	
17		Үүнээс: Замын Үүд		
18		Дундговь	1	1
19		Өмнөговь		
20		Сэлэнгэ	1	1
21		Төв	1	1

22	Зүүн бүс	Дорнод	1	1
23		Сүхбаатар		1
24		Хэнтий	2	2
25	**Нийт**		34	18

Хүснэгт VII.16.3. Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн байдал:


№	Нийслэл	2015	2016
1	Баянгол	38	55
2	I хэлтэс	15	30
3	II хэлтэс	23	25
4	Баянзүрх	49	23
5	I хэлтэс	14	7
6	II хэлтэс	30	14
7	III хэлтэс	5	2
8	Сүхбаатар	37	20
9	I хэлтэс	25	12
10	II хэлтэс	12	8
11	Сонгинохайрхан	35	29
12	I хэлтэс	18	13
13	II хэлтэс	6	4
14	III хэлтэс	11	12
15	Хан-Уул	9	6
16	I хэлтэс	6	6
17	II хэлтэс	3	
18	Чингэлтэй	14	24
19	I хэлтэс	9	15
20	II хэлтэс	5	9
21	Багануур		
22	Багахангай		
23	Налайх	1	1
24	Нийт (илрүүлсэн)	216	176

Дээрхээс харахад, 2015 оны мөн үеэс харьцуулахад 2016 онд булаах гэмт хэргийн гаралт нь 15.9%-аар буурсан байна.

ХОЁР. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРОЛ

2016 оны байдлаар гэмт хэргийн улмаас: 176 иргэн хохирч, гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан 103.9 сая төгрөгийн хохирлын 33.7%-ийг нөхөн төлүүлж, 3.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

График VII.16.10.



ГУРАВ. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ, ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГ ГАРЧ БУЙ ШАЛТГААН

Манай улсад тогтмол гардаг бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт хэрэг нь 2014 он хүртэл өсөх хандлагатай байсан бол 2016 оны байдлаар буурах хандлага харагдаж байна. Жил ирэх тусам энэхүү гэмт хэргийн улмаас иргэдийн эд хөрөнгөнд их хэмжээний хохирол учирсаар байна.

Шалтгаан нөхцөлийг аваад үзвэл 2013 оны мэдээ, баримтаар авч үзвэл, 87.4% нь ашиг олох, шунахай зорилго, 8.4% нь эрхэлсэн тодорхой ажилгүйн улмаас, 0.7% нь тус бүр итгэл эвдсэн, амжиргааны эх үүсвэргүй, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ, хувь хүний ёс суртахууны доголдол, 3.5% нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн болох нь дурдагдсан байна. Энэхүү гэмт хэрэгт холбогдогчид нь ихэвчлэн 18-30 насны, эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн дундаас доогуур боловсролтой хүмүүс архидан согтуурсан үедээ, бүлэглэж буюу давтан, үйлдэхдээ ихэвчлэн харуй бүрийгээр хүний хөдөлгөөн татарсан гудамж, орон сууцны байрны булан, орцонд гол төлөв биеэ хамгаалах чадваргүй хүн, хүүхэд, эмэгтэйчүүдийг зориуд сонгон үйлддэг бэ өвлийн улиралд ихэвчлэн үйлдэгддэг нь статистик судалгаанаас дүгнэгдэж байна.

Эдгээр гэмт хэргийн гаралт буурч байгаа нь урьдчилан сэргийлэх ажлын үр дүн юм. Тухайлбал, камержуулалт, гудамж талбайн гэрэлтүүлэг, эргүүлийн чиглэлийг оновчтой зохион байгуулах гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

ДӨРӨВ. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ТОГТОЛЦОО, ХҮН, ХҮЧ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Улсын хэмжээнд ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх газар, аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтэс, Төмөр зам, Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс зэрэг албаны бүтэц, зохион байгуулалттайгаар өмчийн эсрэг гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь бие, эрүүл мэнд болон иргэд, ААН-ийн эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэдийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийг булаах гэмт хэргээс хамгаалах, хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Эрүүгийн хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомж, журмуудаар зохицуулж, хяналт тавьж байна.

ТАВ. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн улмаас жилд дунджаар 100-200 сая гарүй төгрөгөөр үнэлэгдэх хохирол учирч, үүнээс өнгөрсөн жилд л гэхэд 33%-ийг нь л нөхөн төлүүлсэн байна.

Манай улсын хувьд энэхүү гэмт хэрэг гарч буй гол хүчин зүйл нь ядуурал, ажилгүйдэл, согтууруулах ундаа, боловсролгүй байдал зэргээс гадна хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангаагүй, камержуулалт зарим хэсгээр байхгүй, гэрэлтүүлэг муу гудамж талбай, цагдаагийн байгууллагын хурдан шуурхай байдал, ажлын уялдаа хангалтгүй зэрэг хүчин зүйлийг дурдаж болохоор байгаа юм.

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг дэмжих зорилгоор 1997 он баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:

- Нутаг дэвсгэрийн нэгж бүрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, сүүлийн үеийн байдлаар УЕПГ-аас аймаг, сумдуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт зохион байгуулав176.
- Засгийн газраас 2012 оны 252 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр"-ийг батлан 2016 он хүртэл хэрэгжүүлсэн.
- Мөн сумдуудад ГХУСАЗСЗөвлөл байгуулж, үйл ажиллагааг нь прокурорын байгууллагаас хянаж ажиллаж байна.
- Тухайлбал, Нийслэлийн Цагдаагийн газраас цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн иргэд, олон нийтийн хүчин туслалцаанд түшиглэн нийслэлийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үүргээ нэр төртэй биелүүлэн, 2017 онд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:
  - Цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулж, хамтран ажиллах "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
  - Улаанбаатар хотын гудамж зам, талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камерын хяналтын нэгдсэн төв бүхий "Аюулгүй хот" төслийг хэрэгжүүлнэ.
  - Гэмт хэргийн цахим зураглалын системийг нийслэлийн хэмжээнд нэвтрүүлж, гэмт

176 http://prokuror.mn/index.php?newsid=1190

хэрэг, зөрчлийн байдлыг үнэлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр шуурхай, оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх дүн шинжилгээ, хяналтын нэгдсэн удирдлагын төв байгуулна.

- Иргэдийн идэвх, санаачлагад тулгуурлан аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор орон сууц, гэр хорооллын гудамж талбайд ажиллуулах "Хэв журмын урамшилт эргүүл"-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, гудамж, талбайд тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд "Эргүүл" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- Нийслэлийн Засаг даргын санаачлагаар "Аюулгүй хот" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ төслийн хүрээнд хотын камержуулалтын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Монгол Улсад ГХУСАЗӨвлөл 2016 оны 12 дугаар сарын 23-нд хуралдаж, 2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг хэлэлцэж, ерөнхий төлөвлөгөөг баталсан ба уг төлөвлөгөөгаар цагдаагийн байгууллагад шинээр нэвтрүүлж буй дэвшилтэт техник, технологи, орчин үеийн програм хангамж, цаашид иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлэх "Телекамер" хөтөлбөр, "Эргүүл" дэд хөтөлбөр, "Ухаалаг цагдаа" зэрэг төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон байна.

ҮР ДҮН:

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн ажлууд, УЕПГ-аас салбар хэлтсүүдээрээ дамжуулан хийсэн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд зэрэгтэй холбоотойгоор булаах гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байна.

2014 оноос өмнөх онуудад бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн гаралт өсөлттэй байсан ч 2014-2016 он хүртэлх тоон үзүүлэлтийг харвал буурах хандлагатай байна.

2010 онд булаах гэмт хэргийн 60.5 байсан бол 2014 онд 43.5 болон буурсан байна. Үүнээс харахад гэмт хэргийн илрүүлэлт буурсан байна. 2015 онд орон нутагт 36 булаах гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2016 онд 18 болж 52.9%-аар буурсан үзүүлэлттэй, нийслэлд 2015 онд 216 илрүүлсэн бол 2016 онд 176 болж 18.5%-аар буурсан.

Хохирлын хэмжээ нь 2015 онд 223.8 сая төгрөгийн хохирол учирсанаас 122.8 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн бол 2016 оны байдлаар 103.9 сая төгрөгийг хохирол учирсанаас 35 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. 2016 оны байдлаар гэмт хэргийн гаралтыг дагаад хохирлыг хэмжээ буурсан үзүүлэлтийг харуулж байна.

ЗУРГАА. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Улсын хэмжээнд гарч буй бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг ажилгүйдэл, эдийн засгийн уналт, боловсролын түвшин, ашиг олох, шунахайн зорилго, амьжиргааны эх үүсвэргүй байдал, архи согтууруулах ундаа, хувь хүний ёс суртахууны доголдол зэрэг шалтгаанаас үүдэн ихэвчлэн харанхуй, хүний хөл татарсан гудамж, талбай, орон сууц, ААН гэх мэт газарт үйлдэгдэж иргэдийн эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсаар байна.

Ажилгүйдэл: Иргэдийн ажилгүйдлийн түвшин 2015 оны IV улирлын байдлаар 8,3% байсан бол 2016 оны III улирлын байдлаар 9.4% болж 1.1%-аар өссөн үзүүлэлттэй байна. Ажиллагсдын тоо 27.6 мянгаар буурсан байхад нийт ажилгүй иргэдийн тоо 143.5 мянгад хүрч, 55 орчим мянгаар нэмэгдсэн дүн гарчээ. 143.5 мянган ажилгүй иргэдээс хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй, ажил хайж буй 33.4 мянган иргэн байгаа аж. Эдгээр иргэдийн 52% нь эмэгтэйчүүд, 49% нь дунд боловсролтой иргэд байна. Булаах гэмт хэргийг

үйлдсэн этгээдүүдийн 79 буюу 43.1%-ийг ажилгүй иргэд үйлдсэнээс харахад ажилгүйдэл нь булаах гэмт хэрэг гарах хамгийн гол шалтгаануудын нэг байгаа юм.

Гудамж талбайн гэрэлтүүлэг муу: Энэ төрлийн гэмт хэрэг 2016 оны байдлаар 176 бүртгэгдсэний 106 буюу 60.2% нь гудамж, талбайд үйлдэгдсэн байна. Ихэвчлэн 22-00 цагийн хооронд гаралт ихтэй байгаа үзүүлэлтээс харахад гудамжны гэрэлтүүлэг булаалтын гэмт хэргийн гаралтад нөлөөлөх хүчин зүйл болсон байна. Тухайлбал, Нийслэлийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 223 дугаар тогтоолын хавсралтаар "Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулах хөтөлбөр"-ийг авч хэрэгжүүлсэн ба уг хавсралтаар Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн 24492 шон байгаа бөгөөд тэдгээрийн 80 хувь нь ажиллаж байгаа цаашид 14450 ширхэг гэрэлтүүлэгч шинээр суурилуулахаар төлөвлөсөн байна. Үлдсэн 14450 ширхэг гэрэлтүүлэгчийг суурилуулах ажил 2016 онд хэрэгжиж эхлээд одоог хүртэл үргэлжилсээр байна. Эдгээрийг суурилуулж, ажиллагаагүй хэсгийн гэрэлтүүлэгийг ажиллагаатай болгосноор гэмт хэргийн гаралт буурах бас нэг нөхцөл болно.

Камержуулалт: Булаах, дээрэмдэх гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйлийн нэг нь гудамж талбай, барилгын камергүй, хараа хяналт сул байдал юм. Дээрхи гэмт хэргүүд ихэвчлэн камергүй гудамж талбай, орон байранд үйлдэгдэж байна. 2016 оны байдлаар Улаанбаатар хотод 1483 ширхэг телекамер байгаагын 376 нь одоогийн байдлаар эвдрэл гэмтлийн улмаас ажиллагаагүй байна. 2016 оны эхний арван сарын байдлаар камерын бичлэгээр 42 гэмт хэргийг үйлдэл дээр нь барьж, 163 захиргааны зөрчил илрүүлсэн. Камеруудын тоог нэмж, ажиллахгүй байгаа камеруудыг ажиллагаанд оруулсанаар гэмт хэрэг илрүүлэлт, гаралтын тоог багасгах боломжтой.

Иргэд, байгууллага, орон сууцны харуул хамгаалалтын сонор сэрэмжгүй байдал: Булаах гэмт хэргийн улмаас 176 иргэн хохирсон. Гол төлөв биеэ хамгаалах чадваргүй хүн, хүүхэд, эмэгтэйчүүдийг зориуд сонгон үйлддэг. Мөн байгууллага, орон сууцны харуул хамгаалалт муу байршилыг сонгон авах нь их байдаг байна. Тиймээс иргэд гэрэлтүүлэг муу, хүний хөл хөдөлгөөн бага гудамж, талбайгаар оройн цагаар явахаас аль болох зайлсхийх, байгууллага, орон сууцанд харуул хамгаалалтыг сайжруулж, хяналтын камерыг суурьлуулах шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа: 2014 оны байдлаар 3645 дээрэмдэх, булаах гэмт хэргийн дуудлага, мэдээлэл ирсэнээс 245 булаалтын гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэхүү гэмт хэргийн хувьд маш хурдан хугацаанд, ихэвчлэн үзэгдэх орчин муутай оройн эсвэл өглөө эрт, түүнчлэн камергүй, хүний хөл хөдөлгөөн бага газар үйлдэгддэгээс иргэд цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн ч илрүүлэлт муугаас ихэнх гэмт хэрэгтэнг барих боломжгүй байдаг. Тиймээс цагдаагийн байгууллагын уялдаа холбоо, түргэн шуурхай байдал, камержуулалтыг сайжруулах шаардлага тавигдаж байна.

ДОЛОО. ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд, иргэн байгууллага, ААН-үүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг дэлгэрэнгүй оновчтой болгох, биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг чангатгах талаар нэмэлт оруулах саналыг хууль санаачлагчид хүргүүлэх;
2. Цагдаагийн байгууллагын үүрэг бүхий албa, дүүрэг хороодын тухайн ажил хариуцсан ажилтны орон тоо, төсөв, цалин, хүч хэрэгслийг нэмэгдүүлэх
3. Тухайн дүүргийн нутаг дахь байгууллага, ААН, иргэдийг өргөнөөр байнга оролцуулах,

ажлын байр, орон сууц бусад обьектод гэрэлтүүлэг, дохиолол, камержуулалт хийсэн байгууллага, ААН, иргэдийг хөхиүлэн дэмжих;


4. Архи, согтууруулах ундааг худалддаг, үйлчилдэг дэлгүүр, цэнгээний газруудыг цөөрүүлэх, зөвшөөрөл олгохдоо тэдгээрийн байршил, өөр хооронд зайг зохистой байхаар зохицуулах, дурдсан төрлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх, худалдах хугацааг богиносгож өдрийг цөөрүүлэх асуудлыг судлан ИТХТ-ээс урьд гаргасан шийдвэрээ дахин хянаж зохих шийдвэр гаргах, түүний хэрэгжилтэнд тавих хяналтанд иргэд, төрийн бус болон олон нийтийн байгууллагыг татан оролцуулах;
5. Дүүргийн нутагт оршин суугчид, шилжилт хөдөлгөөний бүртгэл хаягжуулалтыг тухай бүр байнга хийх;
6. Иргэний эрхийг зөрчихгүйгээр, гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон ял шийтгүүлэгсдийн суурьшил хөдөлгөөнийг хяналтанд бүрэн оруулах, хорих газраас суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд ТББ болон гадаадын хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хүчийг ашиглах боломжийг судалж зохих арга хэмжээ авах;
7. Насанд хүрээгүй хүнийг тэнүүчлэл, гуйланчлал, гэмт хэрэгт татан оруулагч эцэг эхэд хариуцлага хүлээлгэх тухай эрүүгийн хуулийн заалтыг хэрэгжүүлдэг болох;
8. Гэмт явдал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон бусад шаардлагатай хууль тогтоомжоор иргэн, байгууллага, ААН, тэнд ажиллаж байгаа ажилтан ямар эрх үүрэгтэй болохыг хүн бүрт хүргэх тэр нь байнгын шинжтэй байхаар сургалт сурталчилгааг зохион байгуулах, үүнд боловсрол, сургалт эрхэлдэг болон шүүх прокурор, мөрдөн байцаах, өмгөөлөх байгууллагын ажилтан, хуульчдын хүчийг нэгтгэн ашиглах;
9. Прокурор, мөрдөн байцаагч хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож түүнийг арилгуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулах мэдэгдлийг зохих газарт тухай бүр хүргүүлэх, мэдэгдэл авсан байгууллага, ААН-ийн удирдлага түүний мөрөөр тодорхой, үр нөлөөтэй ажил хийж энэ тухай хариуг заавал өгдөг байх, арга хэмжээ аваагүй, хариу өгөөгүй албан тушаалтанд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэдэг болох зэрэг болно;
10. Цагдаагийн байгууллагын камерын хяналтын системийг сайжруулах, боловсронгуй болгох;

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

НЭГ. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дээрэмдэх гэмт хэрэг гэдэг нь "бусдын эд хөрөнгийг хууль бусаар, үнэ төлбөргүйгээр, шунахай зорилгоор, хуульд заасан арга хэлбэрээр өөрийн эзэмшилд шилжүүлэх явдал" гэж ашиглан шамшигдуулах ойлголтыг нэлээд ерөнхий байдлаар тодорхойлсон байдаг. Энэ ойлголтын үндсэн шинж болох авсан, хэрэглэсэн бусдын эд хөрөнгө нь материаллаг ертөнцийн тодорхой зүйл, биежсэн бодит үзүүлэлтээр хэмжигдэх (тоо, ширхэг, жин, хэмжээ) эд юмс байдаг.

График VII.16.11.



2010 оноос 2016 оны байдлаар дээрэмдэх гэмт хэрэг 3867 бүртгэгдсэний 81% нь нийслэлд, 19% хувь нь орон нутагт үйлдэгджээ. Жилд дунджаар 638 орчим, сард 53, хоногт бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 2 гэмт хэрэг бүртгэгдэж байна гэсэн статистик тоон үзүүлэлттэй байна.

Энэ төрлийн гэмт хэрэг 2016 оны байдлаар улсын хэмжээнд 474 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 63 хэргээр буюу 11.7%-аар буурсан байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн нийт хэрэгт эзлэх хувийн жин нь 2014 оны байдлаар 4.3%-тай байна. 2015 онд улсын хэмжээнд нийт 27757 гэмт хэрэг бүртгэгдсэний 5537 хэрэг буюу 1.9% нь, 2016 онд улсын хэмжээнд нийт 27167 гэмт хэрэг бүртгэгдсэний 474 хэрэг буюу 1.7% нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг байна.

Цагдаагийн байгууллага 2010-2014 оны 5 жилийн байдлаар булаах, дээрэмдэх гэмт хэргийн талаарх 13074 гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэсэн ба эдгээр гомдол мэдээллийн 1125 буюу 85.1% нь нийслэлд, 1534 буюу 11.7% орон нутагт, 415 буюу 3.2% нь бусад газарт бүртгэгдсэн байна. 2010 оноос 2014 оны хооронд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 7694 бүртгэгдсэний 86.9% нь нийслэлд, 10.4% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

График VII.16.12.



График VII.16.13.



Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн илрүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2011 онд 0.4%-аар өсч, 2012 онд 9.0%, 2013 онд 0.4%, 2014 онд 0.9%-аар тус тус буурч, 2015 онд 2.4%, 2016 онд 5.6%-аар өссөн байна. 2012 оноос хойш гэмт хэргийн илрүүлэлтийн хувь байнга буурсан үзүүлэлттэй байсан боловч 2015 болон 2016 онд тодорхой хэмжээгээр өссөн байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, таслан сэргийлэх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн ахицтай байгааг харуулж байна.


Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн өсөлт бууралтыг өмнөх оныхтой харьцуулахад:

- Хүндэвтэр гэмт хэрэг 5.7%-аар
- Хүнд гэмт хэрэг 15.3%-аар тус тус буурч
- Онц хүнд гэмт хэрэг мөн үеийн түвшинд байна.

График VII.16.14.




График.16.15.



БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИЙН НАС, ХҮЙС, НИЙГМИЙН БАЙДАЛ

2016 оны байдлаар нийт 512 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 буюу 1.7%-аар буурсан байна. Үүнээс 11 буюу 2.1% нь эмэгтэй, 501 буюу 97.9% нь эрэгтэй, тэдний 130 буюу 25.4% нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хүүхэд 2.7%-аар өсч, эмэгтэй 38.9%, эрэгтэй 0.4%-аар тус тус буурсан байна.

График VII.16.16.



Дээрэмдэх гэмт хэрэгт зөвхөн залуучууд холбогддог байсан бол сүүлийн үед ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд ихээр үйлдэх болсон нь гэмт хэрэг үйлдэгсэд насны хувьд залуужиж байгааг харуулж байна.

График VII.16.17.




График VII.16.18.




2016 оны дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оныхтой харьцуулахад: Нийтийн тээвэрт 2 буюу 66.7%-аар, ТББ-д 2 буюу 1.0 дахин өссөн байна. Харин гудамж талбайд 60 буюу 17.3%-аар, гэр орон сууцанд 3 буюу 3.1%-аар, олон нийтийн газарт 1 буюу 3.8%-аар, төрийн байгууллагад 1 буюу 50.0%-аар тус тус буурч, бусад газар, ААН, байгууллагад үйлдэгдсэн хэрэг мөн үеийн түвшинд байна.

Дээрэмдэх гэмт хэрэг гудамж талбай, олон нийтийн газарт ихээр үйлдэгдэж байгаад анхаарч зөвхөн шөнийн цагаар гэлтгүй өдрийн цагаар гудамж талбайд хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, хяналтын камерийн тоог нэмэх, чанарт нь анхаарах шаардлагатай болсон байна.

График VII.16.19. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг

Даваа	63	13.3%
Мягмар	78	16.5%
Лхагва	72	15.2%
Пүрэв	72	15.2%
Баасан	73	15.4%
Бямба	50	10.5%
Ням	66	13.9%



Гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн хувьд өмнөх жилийнхтэй харьцуулахад: Лхагвад 4 буюу 5.9%-аар, нямд 12 буюу 22.2%-аар тус тус өсч, даваа гарагт 31 буюу 33.0%-аар, мягмар гарагт 11 буюу 12.4%-аар, пүрэвт 19 буюу 20.9%-аар, баасанд 8 буюу 9.9%-аар, бямбад 10 буюу 16.7%-аар буурсан байна.

Хэргийн цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 10 буюу 14.9%-аар, 14-19 цагийн хооронд 10 буюу 10.0%-аар, 19-22 цагийн хооронд 5 буюу 5.3%-аар, 22-06 цагийн хооронд 38 буюу 13.8%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

График VII.16.20.



Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгийн 41.7%-ийг бүлэглэн, 20.4%-ийг архидан согтуурсан үедээ, 13.0%-ийг насанд хүрээгүй хүүхэд оролцож үйлдсэн байна.

ХОЁР. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРОЛ

2010-2014 оны хооронд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн халдлагад 2374 иргэн өртөж, 844 хүн гэмтэж, 1560.5 сая төгрөгийн хохирол учирсны 733 сая төгрөг буюу 47%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлсэн байна.

Сүүлийн үеийн хүүхдүүд, залуус амар хялбар аргаар бэлэн мөнгө, үнэтэй гар утастай болохын тулд хэсэг бүлгээрээ нийлж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд их бага хэмжээний хохирол учруулах явдал буурахгүй байна.

2016 оны байдлаар 489 иргэн хохирч, үүнээс 173 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 5 буюу 3.0%-аар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, ААН, байгууллагад учирсан хохирлын 44.4%-ийг нөхөн төлүүлж, 55.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

ГУРАВ. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГ ГАРЧ БУЙ ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Гэмт хэргийн мэдээллийн санд бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 82.1% нь ашиг олох, шунахай зорилго, 5.6 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 5.4% нь айлган сүрдүүлсэн, 4.0% нь тус бүр архи согтууруулах ундаа хэрэглэсэн, танхай байдал, 1.2% нь амжиргааны эх үүсвэргүй, 1.0% нь хувь хүний ёс суртахууны доголдолтой, 0.4% нь бэлгийн гаж сонирхол, 0.2% нь тус бүр ёс суртахууны доголдол, итгэл эвдсэн, 4.6% нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдсэн тухай дурдсан байна.

Хүүхэд, залуучууд олноороо цуглах, дарвих, бие биенээ уруу татах, бусдын нөлөөнд автах, оройн цагаар сэлгүүцэх, архидан согтуурах, амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор эрхэлсэн тодорхой ажилгүй, ихэвчлэн 25 нас хүртэлх насны залуучууд дээрмийн гэмт хэрэг үйлдэж байна.

График VII.16.21.



Дээрэмдэх гэмт хэрэгт холбогдогсод 18-30 насны, эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн дундаас доогуур боловсролтой хүмүүс архидан согтуурсан үедээ, бүлэглэж буюу давтан үйлдэхдээ цаг хугацааны хувьд харуй бүрийгээр ихэвчлэн хүний хөл хөдөлгөөн татарсан үеэр гудамж, орон сууцны байрны булан, орцонд гол төлөв биеэ хамгаалах чадваргүй хүн, хүүхэд, эмэгтэйчүүдийг зориуд сонгон үйлддэг ба өвлийн улиралд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсдөг нь статистик судалгаанаас дүгнэгдэж байна.

Хулгайлах болон дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгааны нэг хэсэг нь ажилгүйдэл, ядуурал гэдэг. Үүнийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ ажил хийхийг үл хүсэгчид, бусдын бүтээсэн баялгийг завшигчид олширсон нь түлхүү шалтгаан болно. Зөвхөн архи эсхүл мансууруулах бодис худалдаж авахын тулд эсвэл компьютероор тоглоом тоглохын тулд хулгайлах, дээрэмдэх гэмт хэрэг үйлдэж байгаа нь олон удаа бүртгэгджээ. Эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч нар насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхих, тэднээр хулгайлах, дээрэмдэм гэмт хэрэг үйлдүүлэх асуудал ч цөөнгүй гарчээ.

ДӨРӨВ. БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ТОГТОЛЦОО, ХҮН, ХҮЧ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Манай улсын хувьд энэхүү гэмт хэрэг гарч буй гол хүчин зүйл нь ядуурал, ажилгүйдэл, согтууруулах ундаа, боловсролгүй байдал зэргээс гадна хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангаагүй, камержуулалт зарим хэсгээр байхгүй, гэрэлтүүлэг муу гудамж талбай, цагдаагийн байгууллагын хурдан шуурхай байдал, ажлын уялдаа хангалтгүй зэрэг хүчин зүйлийг дурдаж болохоор байна.

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг дэмжих зорилгоор 1997 он батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:

- Нутаг дэвсгэрийн нэгж бүрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, сүүлийн үеийн байдлаар УЕПГ-аас аймаг, сумдуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт зохион байгуулав[177].
- Засгийн газраас 2012 оны 252 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр"-ийг батлан 2016 он хүртэл хэрэгжүүлсэн.

177 http://prokuror.mn/index.php?newsid=1190 ,

- Мөн сумдуудад ГХУСАЗСЗөвлөл байгуулж, үйл ажиллагааг нь прокурорын байгууллагаас хянан ажиллаж байна.

ҮР ДҮН:

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн ажил, УЕПГ-аас салбар хэлтсүүдээрээ дамжуулан хийсэн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд зэрэгтэй холбоотойгоор булаах гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байна.

2014 оноос өмнөх онуудад бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн гаралт өсөлттэй байсан ч 2014-2016 он хүртэлх тоон үзүүлэлтийг харвал буурах хандлагатай байна.

2010 онд булаах гэмт хэрэг 60.5 байсан бол 2014 онд 43.5 болон буурсан байна. Үүнээс харахад гэмт хэргийн илрүүлэлт буурсан байна. Нийслэлд 2015 онд 216 илрүүлсэн бол 2016 онд 176 болж 18.5%-аар буурсан.

Хохирлын хэмжээ нь 2015 онд 223.8 сая төгрөгийн хохирол учирсанаас 122.8 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн бол 2016 оны байдлаар 103.9 сая төгрөгийг хохирол учирсанаас 35 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Мөн л 2016 оны байдлаар гэмт хэргийн гаралтыг дагаад хохирлыг хэмжээ буурсан боловч нөхөн төлүүлэх ажил хангалтгүй байна.

ТАВ. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Улсын хэмжээнд үйлдэгдэж буй бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг ажилгүйдэл, эдийн засгийн уналт, боловсролын түвшин, ашиг олох, шунахайн зорилго, амжиргааны эх үүсвэргүй байдал, архи согтууруулах ундаа, хувь хүний ёс суртахууны доголдол зэрэг шалтгаануудаас үүдэн ихэвчлэн харанхуй, хүний хөл татарсан гудамж, талбай, орон сууц, ААН гэх мэт газарт үйлдэгдэж иргэдийн эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсаар байна.

Ажилгүйдэл: Ажиллагсдын тоо 27.6 мянгаар буурсан байхад нийт ажилгүй иргэдийн тоо 143.5 мянгад хүрч, 55 орчим мянгаар нэмэгдсэн дүн гарчээ. 143.5 мянган ажилгүй иргэдээс хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй, ажил хайж буй 33.4 мянган иргэн байгаа аж. Эдгээр иргэний 52% нь эмэгтэйчүүд, 49% нь дунд боловсролтой иргэд байна. Дээрэмдэх гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдийн 339 буюу 71.5%-ийг ажилгүй иргэд үйлдсэнээс харахад ажилгүйдэл нь дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдэх хамгийн гол шалтгааны нэг юм.

Гудамж талбайн гэрэлтүүлэг муу: Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 2016 оны байдлаар 474 бүртгэгдсэний 287 буюу 60.5% нь гудамж, талбайд үйлдэгдсэн байна. Ихэвчлэн 22-00 цагийн хооронд үйлдэгдэж байгаа бөгөөд гудамжны гэрэлтүүлэг булаалтын гэмт хэргийн гаралтад нөлөөлөх хүчин зүйл болсон байна. Тухайлбал, Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 223 дугаар тогтоолын хавсралтаар "Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулах хөтөлбөр"-ийг авч хэрэгжүүлсэн ба уг хавсралтаар Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн 24492 шон байгаа бөгөөд тэдгээрийн 80% нь ажиллаж байгаа цаашид 14450 ширхэг гэрэлтүүлэгч шинээр суурилуулахаар төлөвлөсөн байна. Эдгээрийг суурилуулж, ажиллагаагүй хэсгийн гэрэлтүүлэгийг ажиллагаатай болгосноор гэмт хэргийн гаралт буурах бас нэг нөхцөл болох юм.

Камержуулалт: Булаах, дээрэмдэх гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйлийн нэг нь гудамж талбай, хараа хяналт сул байдал юм. Дээрхи гэмт хэргүүд ихэвчлэн камергүй гудамж талбай, орон байранд үйлдэгдэж байна. 2016

оны байдлаар Улаанбаатар хотод 1483 ширхэг телекамер байгаагын 376 нь одоогийн байдлаар эвдрэл гэмтлийн улмаас ажиллагаагүй байна. 2016 оны эхний арван сарын байдлаар камерын бичлэгээр 42 гэмт хэргийг үйлдэл дээр нь барьж, 163 захиргааны зөрчил илрүүлсэн. Камеруудын тоог нэмж, ажиллахгүй байгаа камеруудыг ажиллагаанд оруулснаар гэмт хэрэг илрүүлэлт сайжирч, гаралтын тоог багасгах боломжтой.


Иргэд, байгууллага, орон сууцны харуул хамгаалалтын сонор сэрэмжгүй байдал: Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн улмаас 2016 онд 474 иргэн хохирсон, үүнээс 173 хүн гэмтсэн, өмнөх жилийнхтэй харьцуулахад 3%-аар өссөн. Гол төлөв биеэ хамгаалах чадваргүй хүн, хүүхэд, эмэгтэйчүүдийг зориуд сонгон үйлддэг. Мөн байгууллага, орон сууцны харуул хамгаалалт муу байршилыг сонгон авах нь их байдаг байна. Тиймээс гэрэлтүүлэг муу, хүний хөл хөдөлгөөн бага гудамж, талбайгаар оройн цагаар явахаасаа аль болох зайлсхийх, байгууллага, орон сууцанд харуул хамгаалалтыг сайжруулж, хяналтын камерыг суурьлуулах шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа: Энэхүү гэмт хэргийн хувьд маш хурдан хугацаанд, үзэгдэх орчин муутай, камергүй, хүний хөл хөдөлгөөн бага газар үйлдэгддэгээс иргэд цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн ч илрүүлэлт муугаас ихэнх гэмт хэрэгтнийг барих боломжгүй байдаг. Тиймээс цагдаагийн байгууллагын уялдаа холбоо, түргэн шуурхай байдал, камержуулалтыг сайжруулах шаардлага тавигдаж байна.

ДОЛОО. ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд, иргэн байгууллага, ААН-үүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг дэлгэрэнгүй оновчтой болгох, биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг чангатгах талаар нэмэлт оруулах саналыг хууль санаачлагчид хүргүүлэх;
2. Цагдаагийн байгууллагын үүрэг бүхий алба, дүүрэг хороодын тухайн ажил хариуцсан ажилтны орон тоо, төсөв, цалин, хүч хэрэгслийг нэмэгдүүлэх;
3. Тухайн дүүргийн нутаг дахь орон сууц бусад обьектод гэрэлтүүлэг, дохиолол, камержуулалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хөхүүлэн дэмжих;
4. Иргэний эрхийг зөрчихгүйгээр, гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон ял шийтгүүлэгсдийн суурьшил хөдөлгөөнийг хяналтанд бүрэн оруулах, хорих газраас суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд ТБББ-ын хүчийг ашиглах боломжийг судалж зохих арга хэмжээ авах;
5. Насанд хүрээгүй хүнийг тэнүүчлэл, гуйланчлал, гэмт хэрэгт татан оруулагч эцэг эхэд хариуцлага хүлээлгэх тухай Эрүүгийн хуулийн заалтыг хэрэгжүүлдэг болох;
6. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон бусад шаардлагатай хууль тогтоомжоор иргэн, байгууллага, ААН-д сургалт суталчилгааг зохион байгуулах, үүнд боловсрол, сургалт эрхэлдэг болон шүүх прокурор, мөрдөн байцаах, өмгөөлөх байгууллагын ажилтан, хуульчдын хүчийг нэгтгэн ашиглах;

ТАНХАЙРАХ
ГЭМТ ЯВДАЛ



17. ТАНХАЙРАХ ГЭМТ ЯВДАЛ

ТАНХАЙРАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ТҮҮНТЭЙ ХИЙХ ТЭМЦЭЛ

Танхайрах гэмт хэрэг нь бүртгэгдсэн гэмт хэргийн дунд эзлэх хувь хэмжээ харьцангуй бага боловч нийгэмд түгээмэл үйлдэгддэг, нуугдмал шинжтэй гэмт хэрэг юм. Улсын хэмжээнд 2011-2016 оны байдлаар цагдаагийн газар бүртгэгдсэн нийт гэмт хэрэг болон түүний бүтцэд эзлэх танхайрах гэмт хэргийн эзлэх хувь хэмжээг харьцуулан авч үзвэл

Хүснэгт VII.17.1.

	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэгдсэн гэмт хэрэг	19197	22089	25362	27318	27757	27167
Танхайрах гэмт хэрэг	1824	1687	1839	1681	1582	1449
Бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь	9.5	7.63	7.25	6.15	5.7	5.33
Танхайрах гэмт хэргийн өсөлт, бууралт тоогоор	-137		-158		-133	
Танхайрах гэмт хэргийн өсөлт бууралт хувиар	-7.3		-8.6		-8.4	

Дээрх статистик үзүүлэлтэд нийт гэмт хэрэгт эзлэх "Танхайрах" гэмт хэрэг харьцангуй бага 5.33-9.5 хүртэл хувийг эзэлж, 2014 он хүртэл өссөн боловч жил дараалан буурсан эерэг үзүүлэлт ажиглагдаж байна.

Судалгаанд хамрагдсан онуудын эдийн засгийн нөхцөл байдалд тойм дүгнэлт хийхэд 2013 оноос улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн, инфляц идэвхжсэн зэрэг сөрөг үзүүлэлт 2016 оныг хүртэл үргэлжилж байгаа боловч жил дараалан өмнөх оныхоос 133-158 буурсан, нийт буурсан хэмжээг авч үзвэл 2013 оноос 2016 он хүртэл хугацаанд 428[178] нэгжээр танхайрах гэмт хэргээр буурсан нь уламжлалт эдийн засгийн уналт гэмт хэргийн гаралтыг ихэсгэж байдаг гэх ойлголтыг үгүйсгэсэн статистик харагдаж байгаа нь Монголын криминологийн шинжлэх ухаанд гэмт үзэгдлийг нийгэм эдийн засгийн үзэгдэл гэж тайлбарлах ойлголтыг эргэн харах зайлшгүй шаардлага гарч байна. Өөрөөр хэлбэл, гэмт үзэгдэл бол нийгэм эдийн засгийн болон нийгмийн сэтгэл зүйн төдийгүй бие хүний сэтгэл зүйн шинж чанарыг агуулсан цогц ойлголт гэсэн илүү өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй шаардлагатай.

Криминологийн шинжлэх ухаан нь хавсарга шинжлэх ухаан бус:

- Нийгэм судлал
- Нийгмийн сэтгэл зүй
- Эдийн засаг
- Шүүх сэтгэц гэм судлал
- Удамшил зүй
- Хүн судлал зэргийг цогц байдлаар агуулсан объектив, субъектив нөхцөл байдлуудын нэгдэл бие даасан шинжлэх ухаан юм.

Танхайрах гэмт хэргийн нуугдмал шинжтэй байхад олон нөхцөл байдал нөлөөлөх бөгөөд эдгээрийн зарим нэгийг тодруулан авч үзвэл:

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажлыг дүгнэх үнэлгээний тогтолцоо

178ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал 2016 он.

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны практикт тогтсон жишиг
- Социалист эрх зүйн тогтолцоон дахь сэтгэлгээний хоцрогдсон хэв маяг зэрэг нөхцөл байдал нөлөөлж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх процесс дахь хугацаа урт байгаа нь (Жишээлбэл: Мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 2 сар) эрүүгийн хэргийг түргэн шуурхай илрүүлэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилттой зөрчилдөж байгаа төдийгүй, тус ажиллагаанд оролцогч ялангуяа гэрч, хохирогч, хөндлөнгийн гэрчид чирэгдэлтэй байдлыг үүсгэдэг.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажлын үр дүнг үнэлэх үнэлгээний тогтолцоо нь гэм хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд идэвхгүй оролцох нөхцөл байдлыг бий болгож байна.

Жишээлбэл: 2017 оны хоёр сард Иргэн С байрныхаа гадаа цагаан сарын бэлтгэлийн эд зүйлээ гэртээ оруулах гээд ганцаараа зогсож байтал үл таних согтуу байрын нэг залуу ирээд гал байгаа эсэхийг асуугаад муусайн баячууд цагаан сараар тарган ууц тавиад байгаарай гээд машин түшүүлэн тавьсан ууцыг газар түлхэн унагаж, машины хаалгыг хонхойтол өшиглөн, гэрээс гарч ирсэн эхнэрийг түлхэн унагаж та нарыг ална гэх зэргээр заналхийлэн айлгасан байна.

Иргэн С нь энэ тухай цагдаад гомдол гаргасан байх бөгөөд цагдаагийн газраас шаардлагатай асууж тодруулах зүйл байна гэсэн нэрийн дор 3 удаа дуудаж байцаалт авсан нь үл ялих зүйлээс цагдаагийн байгууллагад удаа дараа дуудагдан байцаагдах нь цаг хугацааны хувьд ч, нэр хүндийн хувьд ч муугаар нөлөөлж байна гэж үзсэний улмаас хохирогч С гомдлоо татан авсан байна.

Дээрх тохиолдол гэмт хэргийн хохирогчийг залхаан гэмт хэрэгтний нэг адил хандаж байгаа мэт сэтгэгдлийг хохирогчид төрүүлснээр гомдлыг буцаалгаж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөгшүүлсэн, нуугдмал гэмт хэргийн тоог нэгээр нэмсэн олон сөрөг үзэгдлийг өөртөө агуулсан үйлдэл төдийгүй байцаан шийтгэх ажиллагаанд оршин буй дутагдлыг харуулсан хэдийгээр нийтлэг биш ч гэсэн бодитой жишээ юм.

Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд эзлэх танхайрах гэмт хэргийн гомдол мэдээлэл болон танхайрах гэмт хэргийн чанартай гомдол мэдээллийн талаар хэсэгчилсэн судалгааг Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн 2-р хэлтсийн хариуцсан 9 хороонд ирсэн гомдол мэдээллийн байдлаар авч үзэхэд :

График VII.17.1. 2015 оны эхний 7 сарын байдлаар



Судалгаанд хамрагдсан хугацаанд нийт 1283 гомдол мэдээлэл ирсэн үүнээс 183 буюу 14.26% танхайрахтай холбоотой гомдол, 30 буюу 2.33% нь танхайрах гэмт хэрэгтэй холбоотой гомдол мэдээлэл эзэлж байна. Танхайрах болон танхайрах гэмт хэрэгтэй холбоотой нийт 148 гомдол мэдээлэл байгаагийн 30 буюу дөнгөж 20.2%-ийг танхайрах гэмт хэрэгтэй холбоотой гомдол мэдээлэл эзэлж байгааг зайлшгүй анхаарах шаардлагатай.

Дээрх байдал нь танхайрах захиргааны зөрчил, танхайрах гэмт хэргийн зүйлчлэлийн талаар УДШ тайлбар гаргахдаа "...танхайрах зөрчил нь үйлдэгдсэн арга, орон зай болон бусад шинжээрээ танхайрах гэмт хэрэгтэй төстэй боловч бусдыг хүч хэрэглэн зодсон, бие махбодид нь гэмтэл учруулсан, ААН, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, олон нийтийн чанартай арга хэмжээг тасалдуулсан, эд хөрөнгийг санаатайгаар устгаж, гэмтээсэн зэрэг үр дагавар бий болгодоггүй, нийгмийн хор аюулаараа бага байдгаараа танхайрах гэмт хэргээс ялгагдана. Танхайрах гэмт хэргийг танхайрах зөрчлөөс ялгахын тулд зөрчил гаргасан газар, орон зай, арга, түүний өрнөлт, үр дагавар зэрэг нөхцөл байдлуудыг харгалзан үзвэл зохино..." гэж объектив шинжтэй шалгуурыг үндэслэн ялган зүйлчлэх асуудлыг боловсруулсан нь зарим үйлдлийг хэрхэн авч үзэх талаар нарийвчлан тусгаагүй нь зөрчлөөс ялган зүйлчлэхэд бэрхшээлтэй байдлыг үүсгэж байдаг. Тухайлбал, "Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж..." гэж Эрүүгийн хуульд заасныг хэрхэн ойлгох талаар тайлбарлаагүй орхигдуулсан байгаад гол асуудал оршиж байна. Жишээ нь, ахмад настай хүнийг илтэд үл хүндэтгэн ална тална хэмээн ёс бус, хэл амаар дайрч хүч хэрэглэнэ гэж заналхийлсэн нь илтэд танхайрах үйлдэл мөн боловч зодсон зүйлгүй, биед гэмтэл учруулаагүй, эд хөрөнгийг устгаж гэмтээгээгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх вэ? Захиргааны зөрчил үү? Эсвэл гэмт хэрэг үү? гэсэн асуулт бодит байдалд тулгарч байна. Энэ байдал нь танхайрах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн дунд эзлэх танхайрах гэмт хэрэг бага байгаад шууд нөлөөлж байгаа юм.


ТАНХАЙРАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ЧИГ ХАНДЛАГА

Танхайрах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн онцлог.

Танхайрах гэмт хэрэгт 2016 оны байдлаар 1464 холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 270 буюу 15.6%-аар буурсан. Үүнээс 122 буюу 8.3% нь эмэгтэй, 1342 буюу 91.7% нь эрэгтэй хүн эзэлж байна.


Танхайрах гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийг хүйсээр нь 2014-2016 оны байдлаар авч үзвэл.

График VII.17.2.



Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг хүйсийн байдлаар авч үзэхэд 91-98 орчим хувийг эрэгтэй, 2-9 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Эрэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ өндөр байгаа ч эмэгтэйчүүд танхайрах гэмт хэрэг үйлдэх явдал нэмэгдэж байгааг онцгой анхаарах шаардлагатай. Танхайрах гэмт хэрэг хэргийн ангиллын хувьд ихэвчлэн хүндэвтэр, хүнд гэмт хэргүүд эзэлж байгаа нь түүний нийгмийн хор аюулын буурахгүй байгаатай холбоотой юм. Танхайрах гэмт хэрэгт эзлэх хүндэвтэр, хүнд хэргийн хувийн жинг сүүлийн гурван жилээр (хувиар) авч үзвэл:


График VII.17.3.



Танхайрах гэмт хэргийг хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн болох "...догшин авирлаж, нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэнийг эсэргүүцэх, урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд, давтан гэмт хэрэг үйлдсэн, бүлэглэж үйлдсэн, онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж үйлдсэн" зэрэг объектив талын хүндрүүлэх бүрэлдэхүүнээр үйлдэгдэж байгааг онцгой анхааран Эрүүгийн хууль дахь танхайрах гэмт хэргийн нийгмийн хор аюул болон эрүүгийн хариуцлагын уялдаа холбоог сайжруулах, тухайлбал тодорхой үйлдэл бүр дээр ялыг нарийвчлан ялгамжтай тусгах, ялын олон төрлийг хуульчлах гэх мэт зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байна. Танхайрах гэмт хэргийн нэг онцлог хот суурин газар ихэвчлэн үйлдэгддэг 2016 онд улсын хэмжээнд 1449 танхайрах гэмт хэрэг бүртгэгдсэн, үүний 1204 буюу 83%-ийг Улаанбаатар хотод үйлдэгдсэн бол үлдсэн 17%-ийг аймгуудад үйлдэгдсэн хэрэг эзэлж байна.

Танхайрах гэмт хэргийн гаралтыг 2016 оны байдлаар аймаг тус бүрээр авч үзвэл:


График VII.17.4. (Багаас их руу дараалсан байдлаар)



Танхайрах гэмт хэргийн гаралтыг аймаг тус бүрээр авч үзвэл, тухайн аймгийн хүн амын тоо төдийлөн нөлөөл үзүүлэхгүй байна. Тухайлбал, 2016 оны байдлаар хамгийн цөөн хүн амтай Говьсүмбэр аймагт танхайрах гэмт хэрэг 8 бүртгэгдсэн байхад Архангай аймагт 1 бүртгэгдсэн байна. Танхайрах гэмт хэргийг газар нутгийн байршлаар авч үзэхэд төвийн бүсэд ойр байх тусам танхайрах гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Нөгөө талаар зам харилцаа, дэд бүтэц сайжирсантай холбоотой байж болно. Мөн энд нэг зүйлийг дурдахад Баян-Өлгий аймаг танхайрах гэмт хэрэг төдийгүй нийт гэмт хэргийн гаралт бага байгааг анхааран гэмт үзэгдлийн шалтгаан нөхцөлийг бүсчилсэн байдлаар судлах шаардлагатай.

Танхайрах гэмт хэргийн гаралтыг сүүлийн гурван жилийн гарагийн байдлаар авч үзвэл:

График VII.17.5.



Дээрх зураглал нь тухайн жилээс хамааран гарагийн өдрүүдэд харилцан адилгүй байгаа нь нийтлэг байдлаар даваа, лхагва, пүрэв гарагуудад танхайрах гэмт хэрэг үйлдэх давтамж өндөр байна.[179] Эдгээр нь ажлын өдрүүд байгаагаас үзэхэд ажил эрхэлж байгаа хүмүүс энэ гэмт хэрэгт холбогдож байна гэх таамаг дэвшүүлэх үндэслэлтэй байна.

Мөн нөгөө талаар танхайрах гэмт хэрэг хот суурин газар буюу хүн олноор цугларсан газар үйлдэгддэг гэсэнтэй холбон тайлбарлаж болно.

Энэ утгаараа 2002 оны Эрүүгийн хуульд 2008 онд өөрчлөлт орохоос өмнө танхайрах гэмт хэргийн диспозицд "Олон нийтийг..." гэсэн агуулгыг тусгаж байсан.

Тэгвэл энэ гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийг нийгмийн байдлаар нь авч үзье.

Танхайрах гэмт хэрэгт холбогдогчид 2014-2016 он (нийгмийн байдал)

График VII.17.6.

	Хоригдол	Хугацаат цэргийн албан хаагч	Малчин	Тэтгэвэл	Сургууль завсардсан	Сурагч	ТТБ ажилтан	Төрийн албан хаагч	Оюутан	Хувийн хэвшил	Х/хөдөлмөр эрхлэгч	Ажилгүй
2014	7	1	92	3	2	28	40	52	171	138	364	790
2015	4		58	9	2	45	32	59	157	162	412	794
2016	1		36	4		13	41	35	103	125	382	727
Нийт	12	1	186	16	4	86	113	146	431	425	1158	2311

Хүснэгтээс харахад хэдийгээр ажилгүй хүмүүсийн танхайрах гэмт хэрэгт ихээр


179 ЦЕГ, Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал 2014 он, 2015 он 2016 он.

холбогдож байгаа ч эрхэлсэн ажилтай болон сурагч, оюутан, хувираа хөдөлмөр эрхлэгч, малчин зэрэг хүмүүсийн тус гэмт хэрэгт холбогдсон байдлыг нийлбэр байдлаар авч үзвэл, нийт 2545 хүн ба энэ тоо ажилгүй иргэдээс даруй 234 хүнээр илүү байгаа нь анхаарал татаж байгаа бөгөөд ажил алба бүхий этгээдүүд ажлын өдрүүдэд, тэр дундаа даваа, лхагва, пүрэв гарагуудад танхайрах гэмт хэрэг ихээр үйлддэг болох нь харагдаж байна. Энэ нь нийгмийн дэг журам хяналт хангалтгүй байхаас гадна тухайн байгууллагын хөдөлмөр зохион байгуулалт, дотоод хяналт сул байгаатай холбоотой.

Дээрх нөхцөл байдлыг танхайрах гэмт хэрэг үйлдэх цаг хугацааны хувьд авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Сүүлийн гурван жилийн байдлаар танхайрах гэмт хэрэг үйлдэгдэх цаг хугацааны давтамжийг авч үзвэл:

График VII.17.7.



Танхайрах гэмт хэрэгт оногдуулах ялын шинэчлэлийн асуудлыг авч үзвэл:

Хүснэгт VII.17.2.

Эрүүгийн хууль 2002 оны				Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2015 он		
Ялын төрөл	Торгох	Баривчлах	Хорих	Ялын төрөл	Зорчих эрх хязгаарлах	Хорих
181.1	ХХДХ 51-100	3-6 сар	3 жил хүртэл	26.1	1-5 жил	1-5 жил
181.2			3-5 жил	26.2		2-8 жил
181.3			5-8 жил			

Танхайрах гэмт хэрэг оногдуулах хорих ялын дээд хэмжээ нэмэгдээгүй харин доод хэмжээ нь буурсан, зорчих эрх хязгаарлах гэсэн хорихоос өөр төрлийн ял нэмэгдсэн байгаа нь сайн талтай боловч хөдөлмөрөөр хүмүүжүүлэх (албадан ажил хийлгэх, нийгэмд тустай ажил хийлгэх ял) хэлбэрийг тусгах нь илүү үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, хорих, баривчлах ялын төрөл голчлох бус хүмүүсийн эерэг харилцаа бүхий газар нийгэмшүүлэх (хүмүүжүүлэх) танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь хамгийн үр дүнтэй арга болно.

Танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухайд:

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацааг багасгах шаардлагатай, хэдийгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд байцаан шийтгэх ажиллагааны үндсэн хугацааг 1 сар болгон багасгасан нь сайшаалтай боловч гэмт хэргийн шинж төрөл байдлаас хамааран ялгамжтайгаар харилцан адилгүй байдлаар бага тогтоох;
- Танхайрах гэмт хэргийн хохирогч, гэрч зэрэг оролцогчдын эрхийг хамгаалах, тэдгээрт ямар нэг байдлаар эрх зүйн байдлыг дордуулахгүй түргэн шуурхай хэрэг хянан шийдвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, тухайлбал шүүхийн өмнөх шатанд шүүхээс үл хамааран хэргээ шийдвэрлүүлэх боломжийг гэмт этгээд болон хохирогчид олгох;
- Нийгэмд тустай ажил хийлгэх байдлаар танхайрах гэмт хэрэгт холбогдогчийг нийгэмшүүлэх ялын төрлийг ногдуулах;
- Танхайрах гэмт хэрэг үйлдэгчийн шалтгаан нөхцөлийг судлахдаа нийгэм, эдийн засгийн шинжтэй шалтгааныг судлахын зэрэгцээ хувь хүний сэтгэл зүйн байдал, танхайрах гэмт хэрэг үйлдэгчдэд байх нийтлэг шинжтэй объектив, субъектив шалтгаан нөхцөлийг ижил түвшинд судлах зайлшгүй шаардлагатай байна. Учир нь гэмт үзэгдлийн шалтгаан, нөхцөлд нийгэм, эдийн засгийн шинжтэй шалтгаан нөхцөл голлон нөлөөлөх бус сэтгэл судлал, нийгмийн төлөвшилт зэргээс гадна, газар нутгийн байршил, зам харилцаа гэх мэт хүчин зүйл хүчтэй нөлөөлдөг болохыг цаг хугацаа бодитойгоор харуулж байна.

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ БА ХҮЧИНДЭХ ГЭМТ ЯВДАЛ



18. БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ БА ХҮЧИНДЭХ ГЭМТ ЯВДАЛ

"Монгол Улсын хэмжээнд 1990-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг иж бүрэн судалж, нэгдсэн прогноз гаргах" судалгааны хүрээнд "хүчиндэх" гэмт хэргийн хувийн жинг авч үзэхэд хамгийн өндөр нь 1990 онд 5.3%, 1991 онд 4.1% байснаа 1992-1997 онуудад жил дараалан буурч 1.5% болжээ. 1998-2004 онд 1.5-2.0% орчимд хэлбэлзсэн үзүүлэлттэй байжээ.

Гэмт хэргийн тооны хувьд жигд 400 орчимд хэлбэлзсэн байдалтай, мэдэгдэхүйц өсөлт, бууралт ажиглагдахгүй боловч 2000-2004 оны турш тогтмол өсөлттэй байсан. Хуулийн байгууллагын ажилтнууд хүчиндэх гэмт хэрэг ихээр үйлдэгддэг гэдэгтэй санал нийлж байгаа ба бүртгэгдсэн гэмт хэргээс даруй 3.5 дахин их байж болохоор төсөөлөлтэй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг ялангуяа захын хороолол, хөдөө орон нутагт нуугдмал байх магадлал харьцангуй өндөр байх прогнозтой байсан. Тухайн үед хүчиндэх гэмт хэрэг гардаг орчин нөхцөл, энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг хүмүүсийн насны бүтэц, тэдний ёс суртахууны байдал, өсөлт хөгжилт, сэтгэцийн эмгэг зэрэг тухайн төрлийн гэмт хэрэгт нөлөөлдөг гол хүчин зүйлүүдэд ойрын жилүүдэд мэдэгдэхүйц нааштай өөрчлөлт гарахгүй гэж үзэж байв.[180]

Нийслэлийн цагдаагийн газрын Олон нийтийн харилцааны хэлтсээс гаргасан мэдээгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд буюу нэгдсэн арга хэмжээгээр биеэ үнэлдэг нь тогтоогдсон, хүүхдийн байцаагчийн хяналтанд байдаг насанд хүрээгүй охидын тоо 2005 онд 93, 2006 онд 156, 2007 онд 127 гэж гарсан байна. Эрүүгийн цагдаагийн газраас гаргасан мэдээгээр улсын хэмжээнд "биеэ үнэлсэн" гэсэн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүүхдүүд 2005 онд 380, 2006 онд 412, 2007 онд 426 (давхардсан тоогоор) болж өссөн байна.

Бэлгийн мөлжлөг, хүчиндэх гэмт хэрэг нуугдмал байдгаас шалтгаалж хууль сахиулах байгууллагаас илрүүлэлт тааруу, ихэвчлэн ирүүлсэн өргөдөл гомдлын хүрээнд шийдвэрлэж иржээ. Урьд хийгдсэн судалгааны дүнгээс үзэхэд Улаанбаатар хот болон хилийн боомт орчмын хот, суурингуудад насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг нэмэгдэх төлөвтэй байна. Бэлгийн мөлжлөгт өртөгсдийн нилээд нь гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн гишүүдийн зөрчилдөөний улмаас орон гэрээсээ дайжсан охид байдаг. ХЭҮК-ийн тайлангаас үзэхэд олон жил тэнэмэл амьдралаар айл, халамжийн төв дамжин амьдардаг, хөдөө орон нутгаас нийслэлд нүүж суурьшсан, ядуу айлын сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй гэр бүлийн охид бэлгийн мөлжлөгт ихээр өртдөг аж.[181]

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглагчдын ихэнх нь зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гудамжинд амьдрагчид, үе тэнгийн хөвгүүд, архинд донтогчид байгаа нь сэтгэл түгшээж байна. Өсвөр насны охидын дунд бусдыгаа бэлгийн мөлжлөгт зуучлах, уруу татах явдал цөөнгүй байгаа төдийгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар явуулж буй үйл ажиллагаа хангалтгүй байгааг зарим судалгаанд дурдаж байжээ.[182] Энэ төрлийн гэмт хэргийн үйлдэгдэж буй нөхцөл байдлыг үзвэл:

- Насанд хүрээгүй хүмүүсийг биеэ үнэлэхэд татан оролцуулах, зуучлах;
- Садар самуунд уруу татах;
- Насанд хүрээгүй хүнийг тэнүүчлэл, мансуурал, гуйланчлал, бие үнэлэхэд татан оролцуулах;
- Бусдын биеэ үнэлэхийг зохион байгуулах зэрэг хэлбэртэй байна.

180 "Монгол Улсын хэмжээнд 1990-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл" суурь судалгааны тайлан. 2005 он. ХЗҮХ.
181 ХЭҮК-ийн 2008 оны тайлангаас., 46 дугаар хуудас
182 Хүн амын сургалт, судалгааны төв, 2005он. ОУХБ/АПЕК

ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний төвөөс гаргасан статистик үзүүлэлтийг үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 2015 онд 383, 2016 онд 384 буюу бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2.1%-ийг тус тус эзэлж байна.

Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг тогтмол гарч бүртгэгддэг боловч Эрүүгийн хуулийн энэ хэсгийн хэрэгжилт муу байна. Мөрдөн байцаагч нартай хийсэн бүлгийн ярилцлагын судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг цөөн тоотой гарч бүртгэгддэг, ихэвчлэн нууц далд байдалд байдаг байна.[183]

Хуулийн хэрэгжилт дутмаг шалтгааныг судлан үзэхэд хуулийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл ирдэггүй, ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүсийн өмнөөс өргөдөл гомдол гаргах субьект байдаггүй аж.[184] Иймээс гагцхүү гэмт хэргийн тоон үзүүлэлт бус бусад эх сурвалжид дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулж хохирогчид ээлтэй орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсад 2002-2009 онд шүүхээр шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл, 124 зүйлд заасан эрүүгийн хавтаст хэргийн судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 124 зүйлийг нэг мөр ойлгон хэрэглэх талаар онол-арга зүйн зөвлөмж гаргах, урьд шийдэгдсэн эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуульч, хууль сахиулагч нарт сургалт явуулах хэрэгтэй гэж дүгнэж байв. Хуульч, хууль сахиулагчид бэлгийн мөлжлөг, хүчиндэх гэмт хэрэг үйлдэх хэлбэрүүдийн талаар нэг мөр ойлголтгүй байгаатай шууд холбоотой төдийгүй цаашид шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн зүйл хэсгийн үзэл санаа, агуулгыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Судалгаанаас харахад Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан ял шийтгүүлэгчдийн 65% нь эмэгтэйчүүд байна.

Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2015 онд 28, 2016 онд 20, хүчиндэх гэмт хэрэг 2015 онд 279, 2016 онд 290 бүртгэгджээ.

Хохирогчийг хамгаалах эрх зүйн боломжийг ашиглахгүй байгаа нь дахин хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна. Монгол Улсад хохирогчтой харилцах олон улсын эрх зүйн стандартыг мөрдөх өнөөгийн эрэлт хэрэгцээ, гэмт хэргийн гаралт ба хохирлоос үүдэж гэмт хэргийн хохирогчийн сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг шийдвэрлэх нь цаг хугацааны асуудал гэж үзэж байна.

Хохирогч болох өндөр эрсдэлтэй хүмүүсийн тоонд яах аргагүй хүүхдүүд хамаарна. Хүүхдүүд нь гэмт этгээдээс бие бялдрын, сэтгэхүйн хувьд сул дорой байдаг учир хүч хэрэглэсэн гэмт хэргийн золиос болдог. Гэмт хэрэгт хохирсон хүмүүсийн 73% нь ямар нэгэн шалтгаанаар хуулийн байгууллагад хандаагүй байдаг. Эдгээр хохирогчдын 31% нь хэрэг сунжрахаас төвөгшөөсөн, 37% нь хуулийн байгууллагын хүнд суртлаас залхсан, 10% нь нэр төрөө бодсон, 29% нь ямар нэгэн үр дүн гарахгүй, 14% нь гэмт этгээдийн өшөө хонзон, дарамтаас айсны улмаас зохих газар хандаагүй хэмээн хариулжээ.

183 Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны тайлангаас ., ХЗҮХ, ЭЭЗКС, 2009 он
184 ОУХБ-ын төслийн хүрээнд УМБГ-тай хамтран зохион байгуулсан 15 мөрдөн байцаагчтай хийсэн ярилцлагын судалгаанаас, ХЗҮХ., 2009 оны 11 сарын 12



Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэг арга зам нь хохирогчтой ажиллах, түүнийг эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагаа байдаг. Гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнх нь өөрөө урьд нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч байдаг онцлогийг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн, биеэ үнэлэлт, садар самуунд бусдыг уруу татах, бэлгийн мөлжлөг үйлдэхэд интернет орчны нийгмийн сүлжээний сайт руу шилжиж байгааг цаашид анхаарах хэрэгтэй байна.

Ялангуяа 16-22 насны хүүхэд, эмэгтэйчүүдийн хувьд болзооны хүчин буюу нийтийн сүлжээ, гар утсаар танилцаж, уулзах явцдаа бэлгийн хүчирхийлэлд өртөх явдал нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох хууль тогтоомжийн ухуулга, сурталчилгаа, яриа, таниулга хийх ажил үр дүнтэй биш, иргэдийн мэдлэг дутмаг, сургуулиудад эмэгтэй хүүхдийг үзлэгт хамруулдаггүй, өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн хүмүүжлийн талаар хичээл оруулах, хохирогчийн зүгээс харж хандах хүнгүй байх, эцэг эхийн хараа хяналт халамж сул, зөнд нь хаяснаас, бусадтай нийлж согтууруулах ундаа хэрэглэсэн, амьдралын боломж тааруу зэрэг нөхцөл байдал нөлөөлдөг. Мөн дээрээс нь Хүүхэд хамгаллын тухай хуульд заасан "эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд"-ийг олж илрүүлэх, хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол бүрийг илрүүлж, арга хэмжээ авч чадахгүй байгаатай холбоотой.

Нийгэм, улс төрийн төлөвшил дутмаг, эдийн засгийн хөгжлийн түвшин буурай, ажилгүйдэл, ядуурал буурахгүй байгаа, эмэгтэйчүүд биеэ үнэлэх явдал газар авсан[185] нь биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэгдэх суурь шалтгаан болж байна.

Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг тогтвортой буурах хандлага харагдахгүй, энэ нь нуугдмал, зохион байгуулалттайгаар үйлдэгддэг, хохирогчийн зүгээс тэр бүр хуулийн байгууллагад гомдол гаргадаггүйтэй холбоотой.

Энэ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэлд дүн шинжилгээ хийж үзэхэд саун массаж, баар, цэнгээний газар, зочид буудлын үйл ажиллагаанд тавих хяналт сул, тэдгээр нь хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилладаггүй байна.

Өсвөр насны охидын дунд бусдыгаа уруу татах, биеэ үнэлэхэд зуучлах явдал цөөнгүй байгаа төдийгүй гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг илрүүлэх, үйлдлийг таслан зогсоох, үйлдэгдэхээс өмнө нь урьдчилан сэргийлэх талаар явуулж буй төрийн бодлого үйл ажиллагаа хангалтгүй байна.[186]

"Насанд хүрээгүй биеэ үнэлэгч" гэсэн ойлголт байх ёсгүй бөгөөд насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулсан тохиолдол бүрийн цаана хүүхэд хэн нэгэн этгээдийн эрхшээлд байдаг шинжийг хууль тогтоогч орхигдуулснаас гэмт этгээдэд ял завших боломж бүрдүүлж байгааг анхаарах хэрэгтэй.

Судалгаанаас үзэхэд хүчиндэх 2 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар, 3 гэмт хэрэг тутмын нэг нь бүлэглэн, 10 гэмт хэрэг тутмын нэг нь урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс үйлдэж байна[187]. Хүчиндэх гэмт хэрэг нь нуугдмал байх тохиолдол цөөнгүй байх бөгөөд насанд хүрээгүй хүмүүс хохирсон ихэнх тохиолдолд хойд эцэг, эсвэл таньж мэддэг хүмүүс үйлддэг онцлогтой.

185 Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Үндэсний статистикийн хорооноос 2010 онд хийсэн судалгааны тайланд дурдсанаас үзэхэд нийт 4683 хүн бүртгэгдсэнээс 13.6 хувь нь гудамж талбай, 86.4 хувь нь ямар нэгэн үйлчилгээний газар, дуудлагаар биеэ үнэлдэг тооцоо гарчээ.

186 Хүн амын сургалт судалгааны төв, 2005 он. ОУХБ/АЙПЕК-ийн санхүүжилтээр хийгдсэн/.

187 Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл судалгааны төв, Хууль зүйн үндэсний төв хамтарсан "Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл" судалгааны ажлын тайлан, 2010 он.

Насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэх бэлэгсийн гэмт үзэгдлийн гаралтад гэр бүлийн таагүй уур амьсгал (эцэг эхийн архидалт, хүүхэдтэйгээ харгис хэрцгий хандах, хүмүүжлийн буруу арга), сургуулийн хүмүүжлийн орчин дахь эрх зүй, зан суртахууны ба хүйсийн харилцааны алдаа, хувь хүний сэтгэц физиологийн онцлог, хохирогчийн буруутай үйлдэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг сурталчилгаа нөлөөлж байна.

Садар самууныг сурталчлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл): *"Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлэхдээ арван зургаан насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ."*

Гэтэл *"садар самууныг сурталчлах"* гэсэн гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талын шинжид заасан үйлдлүүдийг бусад хууль тогтоомжид давхардуулан зааж өгснөөс шалтгаалан сүүлийн 7 жилд ердөө 9 хэрэг эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч шүүхээр нэг нь ч шийдвэрлэгдээгүй байна.

Тухайлбал, Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйл. Садар самууныг сурталчлахыг хориглох" гэсэн хэсэгт заахдаа:

5.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.

5.2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

5.3. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

Зар сурталчилгааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.7-д "айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; гаргах, бэлтгэх, түгээхийг хориглоно " гэжээ.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйл. "Садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх"

"Садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

Зарим тохиолдолд эрүүгийн хэргийн шинжтэй үйлдлүүд энэ хуулийн дагуу захиргааны шийтгэл хүлээгээд өнгөрдөг. Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 13.2.2 дах хэсэг нь Эрүүгийн хуулийн 124.2 дах заалттай агуулга ижил буюу чухам ямар үйлдэл нь гэмт хэрэг ямар үйлдэл нь захиргааны зөрчил болох талаар нэгдсэн ойлголт үгүй байна.

Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 12.2-т заасны дагуу бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг цагдаагийн зүгээс хохирогч гэж хандахаасаа илүү захиргааны зөрчил гаргагч гэж хандан, хүүхдийн эрхийг зөрчиж байгаа нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хувьд түүний хувийн нууцыг хамгаалах тухай Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 50 FM радио үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 18 FM радио нэвтрүүлгээ цацаж байна. Үүнээс буюу "life 104" болон "Инээмсэглэл 99.3" FM радиог сонгон авч мэдээллийн агуулагад дүн шинжилгээ хийхэд гол төлөв садар самууныг сурталчилсан шинжтэй сурталчилгаа явуулж байлаа.

Тухайлбал: ***Шигтгээ FM радиогийн хөтлөгч эрэгтэй оролцогчоос асууж байгаа асуулт: "Чи нэг эрэгтэй, 2 эмэгтэй гурвуулаа секс хийж үзсэн үү? Мөнгө, хайр, секс гурвын алийг нь илүүд үздэг вэ?, чи хамгийн сүүлд хэзээ секс хийсэн бэ? Найз***

залуутайгаа юу? Эсвэл зуурдын хүнтэй юу?" гэсэн хөтлөгчийн энэхүү садар самуун, ёс суртахуунгүй үг хэллэг хэрэглэж байгаа нь өсвөр үе залуучуудын хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна. Учир нь FM радиогийн нэвтрүүлэгт холбогдсон оролцогчдын 91% нь өсвөр үе буюу 14-18 насныхан байдаг нь судалгааны явцад ажиглагдлаа. FM радиод холбогдож буй сонсогчдын хүйсийг аваад үзвэл 60.5% эмэгтэй, 39.5% нь эрэгтэй байна.

Ийнхүү дээр дурдагдсан хэлбэрээр хууль бус зар сурталчилгаа газар авах нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг эсэх асуудлыг тодруулах үүднээс "Хууль бус зар сурталчилгаа нь эрүүгийн хуульд заасан ямар төрлийн гэмт хэрэг үйлдэхэд голчлон нөлөөлдөг болох?" гэсэн асуултанд дараах байдлаар хариулсан байна.

- Биеэ үнэлэхэд татан оруулах, зохион байгуулах 240 буюу 80%
- Бага насны хүүхдийг гэмт хэрэгт уруу татах 200 буюу 66.8%
- Гуйланчлал, тэнүүчлэлд татан оруулах 40 буюу 13.3%
- Хүч хэрэглэх, хүчиндэх 80 буюу 26.7%
- Бусад 80 буюу 26.7% гэж хариулсан байна.[188]

Гадаадын улс орнуудын эрүүгийн эрх зүй болон, криминологийн салбарын чиг хандлагыг судлан үзэхэд дээрх ойлголтыг төрөлжүүлэн авч үзсэн байна. Үүнийг тодорхой дурьдвал **"marital rape"** буюу **"гэрлэлтэн дэх хүчин"** хэмээх ойлголтод гэр бүл, хамаатан садны хүрээнд гардаг хүчиндэх гэмт хэргийг ялган нэрлэдэг бөгөөд түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага хүртэл ялгамжтай байдаг.

Харин **"date rape"** хэмээх ойлголтыг мөн тусгайлан ялган төрөлжүүлсэн байх бөгөөд үүнийг **"болзооны хүчин"** хэмээн дүйцүүлэн ойлгож болох юм.

Дээр дурдсан **"хүчиндэх"** гэмт хэргийг ерөнхийд нь **"statutory rape"** гэж нэршиж заншжээ.

Сүүлийн үед нийгэмд гарч байгаа мэдээллүүд нь бага насны болон өсвөр насны охидыг хүчирхийлсэн тухай айдас цочроо өгөхөөр шинжтэй байна. Гэмт хэрэг үйлдэгчдийн нийтлэг байдлыг үзэхэд хохирогчийн танил, 18-35 насны, ажилгүй, бүрэн дундаас доош боловсролтой, эрэгтэй хүмүүс байгаа дүр төрхийг олж харж болохоор байна.


188 Б.Энхболд "Хууль бус зар сурталчилгаа" эрдэм шинжилгээний өгүүллээс

НАЙМДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ГЭМТ ЯВДЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



УЛААНБААТАР ХОТ



1. УЛААНБААТАР ХОТ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь дараах үндсэн шинжүүдийг өөртөө агуулж байна. Үүнд

1. Тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн нөхцөл байдлыг судлах;
2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах;
3. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг цогцолбор байдлаар явуулах зэрэг болно. Тиймээс дээрх 3 үндсэн шинжийг тус бүрд нь авч үзэх замаар нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг тодорхойлох боломжтой.

1. НИЙСЛЭЛ ДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

"График №1"-д үзүүлснээр улсын хэмжээнд 2012-2016 онд нийт 131.649 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэл хотод 81.382 буюу 61.8%, хөдөө орон нутагт 52.206 буюу 38.2% нь тус тус оногдож байна. 2014 онд нийслэл хотын хэмжээнд 17939 гэмт хэрэг бүртгэгдсэн нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлт байсан бөгөөд 2013 онтой харьцуулахад гэмт хэрэг 5029 буюу 28%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2016 онд гэмт хэрэг 30 буюу 0.16%-аар буурсан байна.

Улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэгт Улаанбаатар хотод үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувийн жин нэмэгдсээр байна. Тухайлбал 2012 онд нийт гэмт хэргийн 58.4 хувь нь нийслэл Улаанбаатар хот бүртгэгдэж байсан бол энэ тоо 2016 онд 65.9 хувь болж 9.5 хувиар өссөн байна.


График VIII.1.1.



Дээрх судалгаанаас үзэхэд гэмт хэргийн чиг хандлага тогтворжсон боловч өсөх хандлагатай байна. Улсын хэмжээнд гарч байгаа нийт гэмт хэргийн дийлэнх хувийг нийслэл хотод үйлдэгдэж байгаа нь урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Цаашид Улаанбаатар хот дахь гэмт явдлын гаралтыг тууштай бууруулж чадсанаар улсын хэмжээний гэмт явдлыг багасгах нөхцөл бүрдэнэ. Бүртгэгдсэн гэмт хэргийг дүүргүүдээр авч үзвэл нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргүүдээс 13750 буюу 16.9% нь Баянгол дүүрэгт, 19234 буюу 23.6% нь Баянзүрх дүүрэгт, 13158 буюу 16.1% нь Сүхбаатар дүүрэгт, 13988 буюу 17.16% нь Сонгинохайрхан дүүрэгт, 6924 буюу 8.50% Хан-Уул дүүрэгт,

10905 буюу 13.39% нь Чингэлтэй дүүрэгт, Багануур дүүрэгт 1397 буюу 1.71% нь, 1843 буюу 2.26% нь Налайх дүүрэгт, Багахангай дүүрэгт 118 буюу 0.14% нь тус тус үйлдэгдсэн байна. "График №2"-т сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийг дүүрэг тус бүрээр нь харуулав.


График VIII.1.2. Гэмт хэргийн гаралт (2012-2016)



Дээрх статистик үзүүлэлтээс харахад Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэг гэмт хэргийн нөхцөл байдал хамгийн хүнд нөхцөл байдалтай байна. Харин нийслэлийн төвийн 6 дүүргийн дотроос гэмт хэргийн нөхцөл байдал харьцангуй доогуур үзүүлэлттэй дүүрэгт Хан-Уул дүүрэг багтаж байна. Гэмт хэргийн нөхцөл байдал хамгийн доогуур үзүүлэлттэй дүүрэгт Багахангай, Багануур дүүрэг тус тус хамаарч байна. Харин хүн амын төвлөрөл нэмэгдэх, хотын төв рүү ойртох тусам гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч байгаа нь харагдаж байгаа боловч нуугдмал гэмт хэрэг их байх магадлалтай.

"График №3"-т бүртгэгдсэн гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл нийт гэмт хэргийн 46.9%-ийг хөнгөн хэрэг, 44%-ийг нь хүндэвтэр 7.0%-ийг хүнд, 1.9%-ийг онц хүнд гэмт хэрэг тус тус эзэлж байна.

График VIII.1.3. Гэмт хэргийн ангилал (2012-2016)



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /төрлөөр/:

"Хүснэгт №1"-т бүртгэгдсэн гэмт хэргийн харьцуулан хүснэгтээр үзүүлэв. 2016 онд нийт бүртгэгдсэн 17909 гэмт хэргийн: 6098 буюу 34.0%-ийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, 4958 буюу 27.7%-ийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 1405 буюу 7.8%-ийг бусад төрлийн гэмт хэрэг, 1908 буюу 10.7%-ийг бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх, 1204 буюу 6.7%-ийг танхайрах, 912 буюу 5.1%-ийг ТХХАБАЖурам зөрчих, 404 буюу 2.3%-ийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 158 буюу 0.9%-ийг бусдын эд хөрөнгийг булаах, 132 буюу 0.9%-ийг хүчиндэх гэмт хэрэг, 91 буюу 0.5%-ийг хүнийг санаатай алах гэмт хэрэг, 107 буюу 0.6%-ийг бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт VIII.1.1. 2015, 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийг харьцуулан хүснэгтээр үзүүлвэл:

№	Хэргийн өнгө	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг				Илрүүлэлт		
		2015 он	2016 он	Нэгжээр	Өсөлт бууралт	2015 он	2016 он	Өсөлт бууралт
1	Хүнийг санаатай алах	113	91	-22	-19.5	100	98.1	-1.9
2	Бусдыг амиа хорлоход хүргэх	94	107	13	13.8			0
3	Хүчиндэх	133	132	-1	-0.8	91.2	84.7	-6.5
4	Хулгайлах	5899	6098	199	3.4	47.6	48.3	0.7
5	Халаасны хулгай	604	532	-72	-11.9	51.2	54	2.8
6	Булаах	183	158	-25	-13.7	45.1	55.6	10.5
5	Дээрэмдэх	446	404	-42	-9.4	52.2	60	7.8
7	Залилан мэхлэх	1788	1908	120	6.7	70.6	68.1	-2.5
8	Танхайрах	1253	1204	-49	-3.9	78.6	74.5	-4.1
9	ББМБГУ	4784	4958	174	3.6	86.5	87.7	1.2
10	ТХХАБАЖ-ын эсрэг	1068	912	-156	-14.6	88.9	85.7	-3.2
11	Бусад	1574	1405	-169	-10.7			0
Нийт		17939	17909	-30	-0.2	58.9	61.5	2.6

Эх сурвалж: Нийслэлийн цагдаагийн газрын мэдээ, 2016

Урд оны мөн үетэй харьцуулахад: Хүнийг санаатай алах гэмт хэрэг -19.5%, бусдын эд хөрөнгийг булаах -13.7%, халааснаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг -11.9%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг -14.6%, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг -9.4%, танхайрах гэмт хэрэг -3.9%, хүчиндэх гэмт хэрэг -0.8%, бусад төрлийн гэмт хэрэг -10.7%-аар тус тус буурсан. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 13.8%, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 6.7%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 3.4%, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 3.6%-аар тус тус өссөн.

2. НИЙСЛЭЛ ХОТОД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Нийслэл хот дахь гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь гэмт үзэгдлийн ерөнхий шалтгаан болсон архидалт, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн суурь харилцаатай шууд холбоотой ерөнхий хүчин зүйлсээс гадна тусгай хүчин зүйлс нөлөөлж байна.

2.1. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлд нөлөөлж буй ерөнхий хүчин зүйлс

Нийгэм дэх ажилгүйдлийн түвшин нэмэгдснээр гэмт хэргийн тоо өсдөг үүний цаад шалтгаан нь ажилгүй болсон хүмүүс богино хугацаагаар шинэ ажил хайдаг боловч энэ байдал удах тусам гэмт хэрэг үйлдэхэд хүрдэг нь судалгаанаас харагдаж байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл гэмт хэрэг үйлдсэн нийт иргэдийн 1250 буюу 14.0%

нь ажилчин, малчин, 427 буюу 4.8% нь албан хаагч, 363 буюу 4.0% нь оюутан, 182 буюу 2.0% нь сурагч, 32.6 буюу 0.3% нь сургууль завсардсан хүүхэд, 48 буюу 0.5% нь тэнэмэл, 22 буюу 0.2% нь хоригдол, 5975 буюу 67.3% нь эрхэлсэн ажил сургуульгүй хүмүүсээс үйлджээ. Тэдгээрийн 19.4% нь дээд боловсролтой, 3% нь мэргэжлийн анхан дунд, 47.5% нь бүрэн дунд, 19.9% нь бүрэн бус дунд, 6.7% нь бага, 2.8% нь боловсролгүй хүмүүс байна. Согтуурал бол гэмт хэрэг үйлдэхэд түлхдэг нэг нөхцөл болж байна. Ялангуяа хүнийг санаатай алах, эрүүл мэндийн эсрэг, танхайрах гэмт хэргүүдийн 60-70%-ийг согтуу хүмүүс үйлджээ. Сүүлийн үед согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх явдал эрс нэмэгдсэнийг эрүүгийн тоо бүртгэл харуулж байна. Сүүлийн 5 жилийн дунджаас үзвэл 14738 хүн гэмт хэрэг үйлдсэнээс 8827 нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гурван хэрэг тутмын нэг нь гэр, орон сууцанд үйлдэгджээ. Гэр бүл, ахуйн хүрээнд архидан согтуурч, эцэг, эхчүүд хүүхэд, багачуудад буруу үлгэр дуурайлал үзүүлж байна. Эрүүл Мэндийн Яамнаас 2009 онд явуулсан судалгаанд оролцсон нийт хүүхдийн 6,1% нь архийг согготлоо, 54,5% нь амсах төдий хэрэглэж үзсэн гэсэн бол тэдний эцэг (81,9%,) эх (66,1%) нь согтууруулах ундааг хэрэглэдэг гэсэн дүн гарсан нь гэр бүлийн орчинд онцгойлон анхаарч ажиллах, урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

2.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлд нөлөөлж буй тусгай хүчин зүйлс

Хүн амын төвлөрөл: энэ нь хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх сэдэл, гэмт хэрэг үйлдэгсэдийн биеэ авч явах байдалд шууд нөлөөлөхгүй ч, гэмт хэрэг үйлдэх таатай орчин бүрэлдэх, сөрөг соёл төлөвших, гэмт үйл ажиллагаа зохион байгуулалтад орох нөхцөл болж, улмаар түүнд механик нөлөө үзүүлдэг гэж үздэг. Манай улсын хувьд хотжилт түүнтэй уялдан нийслэл Улаанбаатар хотод хяналтгүй шилжин ирэгсэд сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн нь энэ бүс нутагт гэмт хэрэг өсөхөд хүргэсэн.

Нийслэлийн хүн амын нягтаршлыг гэмт хэргийн нөхцөл байдалтай нь харьцуулан үзвэл 1989 онд 548,4 мянган хүн амтай байсан Улаанбаатар хотод 2211 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 1998 онд 814 мянган хүн амтай болж 10150 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх 10 жилээс хүн ам 230 мянгаар нэмэгдэж, гэмт хэрэг 7939 буюу 78.2%-аар өссөн байна. Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж үзвэл 2002-2006 оны хооронд тогтвортой буурч байсан бол 2007 оноос өсөх хандлага ажиглагдаж байна.

Сүүлийн 5 жилийн статистик мэдээнээс үзэхэд 2013 оноос хойш гэмт хэргийн тоо өсөх хандлагатай тогтворжиж байна. 2006 оны эцэст манай улсын хүн ам 2.5 сая, 2007 оны 5 дугаар сард Улаанбаатар хот нэг сая хүнтэй хотоор бүртгэгдэж тус хотод 100.000 мянган хүнд ноогдох гэмт хэрэг 122 байсан нь харьцангуй өндөр үзүүлэлтэд тооцогдож, бүх гэмт хэргийн 49.4% нь нийслэлд бүртгэгдэж байсан бол 2016 онд нийт гэмт хэргийн 64.5% нь нийслэлд бүртгэгдэжээ. Монгол Улсын хүн амын тоо 2010 онд 3,01 сая, 2011 онд 3,68 сая болсон бөгөөд 2020 онд 4,28 сая болж өсөх урьдчилсан тооцоо бий. Хэрэв өнөөгийнх шиг хурдацтайгаар өссөн үед 2020 оны үед Улаанбаатар хотын хүн амын тоо бараг 2 сая болж гэмт хэргийн нөхцөл байдал 3 дахин хүндэрнэ гэсэн прогноз хийж болно.

Хот төлөвлөлтийн асуудал: Хот байгуулалтыг төлөвлөхдөө байгалийн гамшиг, түймрийн аюул, үйлдвэрлэлийн гэнэтийн ослын үед болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад тохиромжтой байдлаар төлөвлөснөөр эрсдэлийн үед шуурхай арга хэмжээ авч ажиллах боломжийг бүрдүүлж чаддаг. Мөн гудамж талбай олон нийтийн газрыг стандартын дагуу урт, өргөн, өнцөг, муруйлт зэргийг нь тогтоож бодлогоор зохицуулаагүйгээс техник технологи өндөр хөгжсөн улс орнуудад өргөнөөр хэрэглэгддэг камерын хяналтын системийг манайд нэвтрүүлэхэд хүндрэл учруулж урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээг орхигдуулахад хүрч байгаа нь гэмт хэрэгт нөлөөлөх бас нэг нөхцөл

юм. Улаанбаатар хот нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын хувьд тэргүүлэх байр суурьтай байгаагаас хүн амын үлэмж хэсэгт төвлөрч, харин хот төлөвлөлт, зохион байгуулалт, тохижилт нь эргээд оршин суугчдынхаа түгээмэл эрх, ашиг сонирхлыг хангах чадваргүй байна. Цаашид ч энэ байдал даамжрах төлөвтэй бөгөөд юуны өмнө оршин суугчдын аюулгүйн орчин, амгалан тайван байдал, гэмт халдлагаас хамгаалагдах эрхэд хамаатай зүйл мөн билээ. Судалгаанд оролцсон иргэдээс "Хот төлөвлөлт, тохижилт гэмт хэрэгт нөлөөлж байна уу?" гэсэн асуулт тавихад дараах байдлаар хариулжээ.


Хүснэгт VIII.1.1.2

	Ихээхэн нөлөөтэй	Дунд зэрэг	Бага	Мэдэхгүй	Нийт
Хот төлөвлөлт, тохижилт	32.4%	37.4%	20.6%	9.6%	**100.0%**

Судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь ямар нэг хэмжээгээр нөлөөтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн бол гурван хүн тутмын нэг нь илүү онцлон үзсэн байна. Чанарын судалгааны явцад хотын зах хэсгээр гудамж талбайн зохион байгуулалт муу, хаяггүй, ил задгай хэсэг ихтэй, замбараагүй суурьшилт сүүлийн үед эрс өссөнийг онцолж байсан бол хотын төв орчим хэсгээр ч мөн адил газар ашиглалт замбараагүй, уялдаа бүтэц муутай ашиглалт, олон барилга хуучирч хотын тохижилт, эмх цэгцийг үл хүндэтгэсэн байдал нь эргээд хүмүүс гэр орныхоо орчинд ч гэмт халдлагад өртөх магадлалыг нэмэгдүүлж байна. Түүнээс гадна нутгийн захиргааны байгууллагууд, төвлөрсөн суурин газрын орон сууц, гудамжны хороонд болон гудамж талбайг гэрэлтүүлэгтэй болгох нь иргэдийн амгалан тайван аж төрөх, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нэн тэргүүний асуудал болж байна.

Төвлөрсөн суурин газрын алслагдсан хороодын иргэд, гэрэлтүүлэггүйгээс айдас, түгшүүрийн дунд аж төрж, нийтийн тээврээс буугаад харих замд гэмт халдлагад өртөх магадлал өндөр, үүнийг нь гэмт этгээдүүд далимдуулан хүчирхийлэх, эрх чөлөөнд нь халдах, эд зүйлийг нь булаах, дээрэмдэх явдал байнга гарч байгааг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мэдээллээс харж болно. Гэрэлтүүлэгтэй орчинд шөнө оройн цагаар танхайн сэдэлттэй, хүч хэрэглэсэн гэмт хэргүүд төдийлөн гараад байдаггүйг иргэдийн дунд явуулсан санал асуулгын дүн, гэмт хэргийн статистик баримтууд давхар нотолж байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх 5 жилтэй харьцуулахад өссөн байна. Хүнийг санаатай алах гэмт хэргийн 22.7%, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргийн 26.8%, хүчиндэх гэмт хэргийн 13.7%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 6.1%, авто машин хулгайлах гэмт хэргийн 47.6%, булаах гэмт хэргийн 73.5%, дээрэмдэх гэмт хэргийн 69.8%, танхайрах гэмт хэргийн 36.2%, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 27.1% нь гудамж талбайд үйлдэгдсэн байна.

График VIII.1.4.



Хүнийг санаатай алах гэмт хэргийн 66.3%, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргийн 54.6%, хүчиндэх гэмт хэргийн 71.6%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 60.2%, авто машин хулгайлах гэмт хэргийн 67.3%, булаах гэмт хэргийн 62.2%, дээрэмдэх гэмт хэргийн 79.1%, танхайрах гэмт хэргийн 65.5% нь орой 19-06 цагийн хооронд тус тус үйлдэгдэжээ[1]. Эдгээр баримтаас үзэхэд төвлөрсөн суурин газрын гэр хорооллуудад орой шөнийн цагаар танхайрах сэдэлттэй гэмт хэргүүд зонхилон үйлдэгдэж байна. Судалгаанд оролцсон хэсгийн байцаагч нараас хорооны тохижилт, иргэдийн амьдрах орчин бүрдсэн эсэхийг тодруулах зорилгоор *"Таны хариуцан ажиллаж буй хороонд хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх спортын ил цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн бий юу?"* гэсэн асуултанд 6 буюу 6.6% байгаа, 35 буюу 40% нь бага насны хүүхдийн ганц нэг тоглоомын талбайг эс тооцвол бараг байхгүй, 55 буюу 53.3% нь огт байхгүй гэж хариулжээ. Улаанбаатар хотод хүүхэд, залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар хомс болж цөөн хэдэн цэцэрлэгт хүрээлэн, спортын цогцолборыг нурааж зай завсаргүй барилга байшин барьж хот төлөвлөлт алдагдсанаас залуучууд чөлөөт цагаа баар ресторан, шөнийн цэнгээний газарт өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж улмаар гэмт хэрэг үүдэн гарч байна.

Хууль сахиулах байгууллагын оролцоо: Цагдаа болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны үр дүн, зохион байгуулалт, хүн, хүч, техник хэрэгслийн хангамж, гэмт хэрэгтэй тэмцэх арга тактик зэрэг нь гэмт хэргийн өсөлтөнд нөлөөлдөг нөхцөл юм. Цагдаагийн байгууллагын үйлчилгээ хүрэлцэхгүй байх нь хүмүүс гэмт халдлагаас хамгаалагдах боломж тэр хэмжээгээр багасаж, өдөр тутмын амьдрал нь эрсдэлийн дунд өнгөрөх болдог. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, бүтэц оновчтой эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Сүүлийн үед нийслэл хотруу эрчимжсэн их нүүдлээр хотын захын хороололд шилжин ирэгсдийн улмаас хүн амын хэт төвлөрөл нь нийгмийн үйлчилгээний төдийгүй хууль сахиулах байгууллагын хүчин чадлаас хэд дахин давсан.

Цагдаагийн байгууллагын зүгээс алба хаагч, техник хэрэгслийн тооцоо судалгааг гэмт хэргийн бодит нөхцөл байдалд тохируулан үндэслэлтэй гаргаж холбогдох байгууллагуудад танилцуулж асуудлыг шийдвэрлэх талаар дорвитой арга хэмжээ авахгүй байгаатай холбон үзэж болно. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй цогцолбор байдлаар авч хэрэгжүүлэхэд юуны өмнө цагдаагийн байгууллагаас Монгол Улс, Нийслэл хотын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг нэг бүрийг бүртгэх, улмаар тодорхой нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоож чадсанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болох учиртай[2].

Цагдаагийн байгууллагаас гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг нэг бүрийг бүртгэх чиглэлээр 2002 оноос хойш жил дараалан тодорхой зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа ч дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны доголдол, цаашид гэмт хэрэг өсөх, гэмт хэрэг нуугдмал шинжтэй болох анхдагч нөхцөл гэж үзэх үндэстэй. Бидний явуулсан судалгааны дүнгээр нийслэл Улаанбаатар хотод үйлдэгдэж байгаа гэмт халдлагын одоогийн түвшинг олон талаар тооцоолбол бүртгэгдсэн гэмт хэргээс даруй 6 дахин их байна. Судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь юмуу тэдний ойр дотны хүмүүс сүүлийн нэг жилд гэмт халдлагад өртжээ. Харин гэмт халдлагад өртсөн үедээ цагдаад бүртгүүлсэн гэж дөнгөж 17.5% нь хариулжээ.

Гэмт халдлагад өртсөнөө бүртгүүлэхгүй байх шалтгаан нь цагдаад хандаад хэрэг шийдэгдэнэ гэж итгэдэггүй гэж 37.8% нь түүнчлэн хэрэг төвөг хэт сунжрахаас төвөгшөөдөг гэж 28.6% нь тус тус хариулсан бол 16.6% нь цагдаад утсаар хандсан боловч гомдлыг

1 ЦЕГ-ын мэдээлэл судалгааны алба "Монгол улс дахь гэмт хэргийн нөхцөл байдал-2016". судалгааны тайлан.
2Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйл "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ" төрийн мэдээлэл. 1997 он №4

хүлээж аваагүй гэж хариулсан байна. Цаашид дүүргүүдэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр ажиллаж буй эргүүлийн тоо, хүч, техник хэрэгслийг судалж дүгнэлт хийх үлмаар эрх бүхий байгууллагад танилцуулж алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх;

Нийслэлийн нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын нэгдсэн байршил, маршрут нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай хэрхэн зохицож байгаад судалгаа хийж судалгааны үр дүнд үндэслэн нийслэлийн хэмжээнд эргүүлийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах загвар буюу Нийслэл хот дахь гэмт хэргийн атлас (crime of map) боловсруулж дүн шинжилгээ хийж ажиллах;

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөө: Судалгаанаас үзэхэд дотоод мэдээлэл авдаг хамгийн чухал эх сурвалж нь телевиз хэвээрээ байгаа боловч урьд нь судалгаанд хамрагдагчдын 91% нь телевизийн мэдээлэл авдаг байсан бол өдгөө 59% болж буурчээ. Мэдээлэл авдаг дараагийн гол эх сурвалж нь "facebook" болж байна. Хууль бус зар сурталчилгаатай тэмцэх талаар олон хууль батлагдсан хэдий ч нийгэмд энэ үзэгдэл буурахгүй байгаагийн нэг том шалтгаан нь хууль бус зар сурталчилгааг захиалах, бүтээх, түгээх үзэгдэл түгээмэл байгаатай холбоотой. Хууль бус зар сурталчилгаа гэмт хэргийн харилцан хамаарлыг тогтоох үүднээс "Хууль бус зар сурталчилгаа нь гэмт хэрэг гарахад нөлөөлдөг эсэх талаарх таны бодол?" гэсэн асуултанд 260 буюу 86.6% нь нөлөөлнө, 10 буюу 3.4% нь нөлөөлөхгүй гэж үзсэн бол маш их нөлөөлдөг гэж 30 буюу 10% нь үзсэн байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж байгаа хууль бус зар сурталчилгааг агуулгаар нь авч үзвэл дараах хэлбэртэй байгаа нь дүгнэгдэж байна.

- Архи, согтууруулах ундаа;
- Садар самуун болон нийгмийн ёс суртахуунд харшлах мэдээлэл;
- Иргэдийг төөрөгдүүлэхэд чиглэгдсэн (залилан мэхлэх, хүн худалдах, орон сууцны худалдаа);
- Бусад асуудлыг хөндсөн, зар сурталчилгааны мэдээ (Эм бэлдмэл, сүлжээний бизнес);

Хууль бус зар сурталчилгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж, түгээгдэж байх үед та бид өөрсдөд нь хамаагүй мэт санадаг боловч үүний уршгаар хохироод ирэхээрээ харамсах явдал гардаг. Өнөөдөр телевизээр явагдаж байгаа зар сурталчилгаа хууль ёсны мэт харагдаж байгаа ч хэдэн жилийн дараа иргэд олон мянгаараа хохирч болзошгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, садар самуун, аллага, хядлагын сэдэвтэй элдэв кино, дүрс бичлэг сурталчлах нь нэг ёсондоо хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэх арга замын талаарх иргэдэд, ялангуяа хүүхэд залуучуудад хүртээмжтэй сөрөг сурталчилгаа түгээх болсон нь гэмт явдалд хүргэх шалтгаан, гишгүүр шат болж залуучууд, архидан согтуурах, чөлөөт цаг, эд мөнгө, оюун ухаанаа зөвхөн хөнгөн хялбар, зугаатай амьдралд зориулах, мөрийтэй тоглоом, мансуурал садар самуун, хүчирхийллийг сурталчилсан зүйлээр оюуны ядмаг хэрэгцээгээ хангах явдал илт давамгайлах болжээ.

Хотын амьдралын хэв маяг: Хотжилт амьдралын хэв маяг гэж үзсэн социологич Л.Уэрт энэ талаар судалгаа хийсэн байдаг. Тэрээр хотын иргэд хоорондын харилцааны түвшин ихээхэн сул, хотынхон хүн чанаргүй байдаг нь гэмт хэрэг гарах нэг хүчин зүйл болдог гэж дүгнэсэн нь олон баримтаар батлагддаг. Бид дээрх дүгнэлтийг бататгах зорилгоор Улаанбаатар хотын 500 иргэнийг хамруулсан судалгаа явуулж "Та бусдын эрх чөлөө, эд хөрөнгөнд халдаж буй хууль бус үйлдэлтэй таарч байсан уу?" гэж асуухад 426 буюу 85,3% нь тийм, 60 буюу 12% нь, үгүй гэж хариулсан бол 13 буюу 2,6% нь санахгүй байна гэжээ.

"Хэрэв та тийм гэж хариулсан бол өөрийн биеэр туслах болон энэ талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж байсан уу?" гэж асуухад нийт 426 хүнээс тийм гэж 59 буюу 23% нь, үгүй гэж 327 буюу 76,9% нь хариулсан байна.

Энэ судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотод бусдын эрх, эрх чөлөөнд халдсан хууль бус үйлдэл түгээмэл шинжтэй болсныг, нөгөө талаас гэмт хэрэг эрх зүйн зөрчлийг таслан зогсоох, цагдаа, хууль хяналтын байгууллагад мэдээллэх явдал хангалтгүй байгааг илэрхийлж хотын иргэд хоорондын харилцааны түвшин ихээхэн сул, хотынхон хүн чанаргүй байдаг гэсэн Л.Уэртын дүгнэлтийг баталж байна.

3. ГЭМТ ЯВДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХОТЖИХ ҮЙЛ ЯВЦЫН СӨРӨГ ҮР ДАГАВРУУДЫГ АРИЛГАХАД ЧИГЛЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд гэмт хэрэг үйлдэгдэх, түүний өсөлтөд ажилгүйдэл, ядуурал, согтуурал, гуйланчлал зэрэг нийгмийн олон сөрөг үзэгдэл, хүчин зүйл нөлөөлж байна. Тиймээс ч тэдгээр сөрөг үзэгдэлтэй тэмцэх талаар төр засгийн зүгээс багагүй арга хэмжээ авч, бие даасан хууль батлан хөрөнгө мөнгө зарцуулан, ажиллаж байгаа нь сайшаалтай боловч энэ нь гэмт хэрэг үүдэн гарахад нөлөөлж буй хүчин зүйлсийг бүрэн тогтоосны эцэст хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ гэхэд учир дутагдалтай.

Учир нь ажилгүйдэл, ядуурал, архидалт, садар самуун явдал зэрэг нь улс орны нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой ч нөгөө талаараа хүн амын нүүдэл сууршилтыг зөв зохистой зохион байгуулж чадаагүйгээс үүдэлтэй үр дагавар юм. Өөрөөр хэлбэл хүмүүс нэг газарт хэт олноороо төвлөрч, хотжилт явагдаж буй газарт ийм үр дагавар бий болох нь нийтлэг үзэгдэл болох нь батлагджээ.

Судалгааны дүнгээс үзвэл Улаанбаатар хотод шилжин ирэгсэд, дамжин өнгөрөгсдийн тоо нэмэгдэж хүн амын механик өсөлт бий болсон нь гэмт хэргийн үндсэн шалтгаан болох ажилгүйдэл, ядуурал, согтуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдэд нөлөөлж улмаар эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрч байга. Иймээс гэмт үзэгдлийн шалтгаан болж буй нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэхийн хамт түүнийг идэвхжихэд бодитой нөлөө үзүүлж буй хотжих үйл явц, түүнийг саармагжуулахад чиглэгдсэн эдийн засаг, нийгэм, улс төр, зохион байгуулалт, техник, эрх зүйн шинжтэй арга хэмжээг цогц байдлаар авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй, бодит ажил болно. Энэ арга хэмжээнүүд нь гэмт үзэгдэлтэй тэмцэхэд шууд чиглэгдээгүй боловч, нийгмийн үзэгдлийн хувиар оршин тогтнож буй гэмт үзэгдлийг арилгах, даван туулах нөхцөл боломжийг бүрэлдүүлэн бий болгодог.

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэрийлэх зохион байгуулалтын арга хэмжээ

Улаанбаатарт үйлдвэр, аж ахуй, соёл, шинжлэх ухаан, тээвэр худалдаа, засаг захиргааны бүхий л байгууллага хэт төвлөрснөөс үүдэн хүн амын механик өсөлт ихэсч эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Иймээс Улаанбаатар хотод хүн ам төвлөрөх болсон хүчин зүйлүүдийг харгалзан зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг төр засгийн зүгээс бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр нөлөөтэй болно. Үүний тулд нийслэл хотоос томоохон ААН, үйлдвэрүүд, их, дээд сургуулиудыг нүүлгэн шилжүүлэх, цаашид баригдах үйлдвэр, соёл, үйлчилгээний байгууллагуудыг бүсийн төвүүдэд түшиглэн хөгжүүлэх, бүсийн төвүүд болон дагавар хотуудыг жигд хөгжүүлэх, дотоодын болон олон улсын шинжтэй спорт, урлаг, хурал чуулганы ажлыг хөдөө орон нутаг, бүсүүдийн төвд зохион байгуулах нь хүн амын төвлөрлийг саармагжуулахад ач холбогдолтой бөгөөд ингэснээр түүнийг дагасан нийгмийн сөрөг үзэгдлүүдээс сэргийлэх боломж бүрдэнэ. "Нийслэл Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд хотоос үйлдвэр, аж ахуйн газар 13, улсын чанартай

хангамжийн 6 бааз, эрдэм шинжилгээний институт зэрэг 31 байгууллагыг дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөсөн боловч биелүүлж чадаагүйн зэрэгцээ харин ч ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй 20 гаруй үйлдвэр, аж ахуйн газрыг шинээр байгуулсан байна.

Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "нутаг дэвсгэрийн харьцангуй жигд хөгжлийг хангах", Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын 5 дугаар зүйлийн 28-д "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын зохистой тогтолцоо, нийгэм, соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд ойртуулах явдал бол хүн ам хот хөдөөд жигд тархан суурьших гол нөхцөл гэж үзнэ" мөн 29-д "Байгаль орчны даац, хүн амын өсөлт, нийгмийн үйлчилгээний тэнцвэртэй харьцааг хослуулах үндсэн дээр хот суурин Монгол хүний сэтгэл зүйд нийцсэн үндэсний өвөрмөц хэв шинжтэй хөгжүүлэх чиглэл баримтална. Нийслэл хот болон томоохон хотын хүн амын хэт төвлөрлийг багасгах, бүс нутгийн төвүүдийг хөгжүүлэхийг түлхүү анхаарна"[3] гэсэн төрийн бодлого байгаа ч эхнээсээ хот хөгжүүлэх тодорхой төлөвлөлт, зохицуулалтгүй урсгалаараа өнөөгийн байдалд хүрээд байна.

Судалгааны дүнгээс үзэхэд нийслэл хотод шилжин ирж буй хүмүүсийн гол шалтгаануудад чанартай боловсрол эзэмших, эмнэлэгийн үйлчилгээ авах, амжиргааныхаа түвшинг дээшлүүлэх гэх мэт нийгэм, эдийн засгийн асуудлууд зонхилж байгаа юм[4]. Иймээс нэн тэргүүнд нийслэлд төвлөрөөд байгаа төрийн болон ТББ, эмнэлэг, сургууль, үйлдвэрийн газруудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх бодлого баримталж түүнийгээ тууштай хэрэгжүүлэх нь хүн амын төвлөрөлтөөс үүдэлтэй гэмт хэргийн өсөлтийг бууруулах алс хэтийн зорилгод бүрэн нийцнэ. Нэн тэргүүнд их, дээд, сургууль коллежуудыг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсийн төвүүдэд шилжүүлэх асуудал нь хүн амын төвлөрлийг бууруулахад бодитой ажил болох учиртай.

3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эдийн засгийн арга хэмжээ

Орон нутгаас төв суурин руу шилжин ирэгсдийн хувьд ажлын байраар тэр бүр хангагдаж чаддаггүйгээс шалтгаалан хотын ядуучуудын эгнээнд шилждэг. Ер нь шилжин ирэгсэд хотын нийгэм, эдийн засгийн амьдралын хүрээнд олон хүндрэлтэй асуудлыг бий болгож байгаа билээ.

Тиймээс иргэдийг хөдөө ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлсэн эдийн засгийн бүх талын хөшүүрэг бий болгох хэрэгтэй. Үүний тулд:

- Хөдөө ажиллаж буй төрийн болон ТББ-ын алба хаагчдын цалин, нөхөн олговор, хөдөө ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан өндөр настны тэтгэврийн хувь хэмжээ зэрэг нь хотын иргэдээс өндөр байх;
- Хөдөө орон нутагт ажилласан жил бүрийг нь удаан жилд оруулан тооцож нөхөн олговрыг мөнгөн хэлбэрээр олгодог болох;
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэл, коллеж, их, дээд сургууль төгсөөд хөдөөд ажиллах сонирхолтой иргэдтэй гэрээ байгуулж сургалтын төлбөрөөс нь зохих хэмжээгээр хөнгөлөх, чөлөөлдөг байх;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжлийн дагуу бүсүүдийн төврүү чиглүүлэх, хөдөөд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт хамрагдах хүмүүс, байгуулагдаж буй үйлдвэр, ААН-д ажиллах хөдөлмөрийн хүч, нөөц бололцоог нутгийн иргэдээс бүрдүүлж цалинжуулдаг байх;
- Хөдөө орон нутгаас нийслэл Улаанбаатар хотод шилжин ирэхэд иргэн тус бүрээс хотын татвар авах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

3 Төрийн мэдээлэл, УБ., 2002 №3
4 Шилжих хөдөлгөөн ба Улаанбаатар хот дахь ядуурал. УБ., 2005

3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох

Гэмт үзэгдлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээ ихэвчлэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хэрэгжин биелэх үйл ажиллагаа мөн. Тиймээс Улаанбаатар хот дахь хүн амын механик өсөлт, түүнээс үүдэлтэй гэмт хэрэг зөрчлийг бууруулахад төр засгийн зүгээс эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн ам жигд тархан суурших нөхцөл боломжийг бүрдүүлэх нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэх юм.

Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй..." гэж заагаад энэ харилцааг зөнд нь орхисон нь хот суурин газар дахь хүн амын механик өсөлтөнд хамгийн гол нөлөө үзүүлж улмаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 55 дугаар зүйлийн 7-д заасан "Хот, суурин газрыг төлөвлөх, байгуулахдаа хүн амыг хэт бөөгнөрүүлэхээс зайлсхийнэ"[5] гэсэн төрийн бодлоготой зөрчилдөх хэмжээнд хүрээд байна.

Иймээс Улаанбаатар хот дахь хүн амын төвлөрлийг бууруулахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг хийх, одоо үйлчилж буй буй хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох асуудал зүй ёсоор тавигдсаар байна. Өөрөөр хэлбэл бүсчилсэн хөгжлийг дэмжсэн, түүний үзэл санаанд нийцсэн хууль, эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, шинээр батлан гаргах явдал юм.

Өнөөдрийн байдлаар хөдөө орон нутагт ажиллаж буй багш, эмч, хил хамгаалах, цагдаа зэрэг цөөн тооны төрийн алба хаагчдад хөдөө ажилласны нөхөн олговор олгох, мөнгөн тэтгэмж үзүүлэх зэрэг тушаал шийдвэрүүд гарч үйлчилж байгаа нь хүн амын төвлөрлийг бууруулахад чиглэгдсэн төрийн бодлогын нэг хэсэг гэж үзэж болно. Энэ мэт эрх зүйн зохицуулалтыг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжинд тусгах шаардлагатай байна.

Түүнээс гадна гэмт хэрэгтэй тэмцэхэд тэргүүлэх үүрэгтэй хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох нь нийслэл хотын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд нэн шаардлагатай байна. Тухайлбал, гэмт хэрэгтэй хийх тэмцлийн үр дүн иргэдийн өргөн оролцооноос шууд шалтгаалах учир оролцооны үр дүнтэй хэлбэр үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгон өргөжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй тууштай оролцдог иргэд, байгууллагыг урамшуулдаг төрийн сан бий болгох, эрх зүйн орчинг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд тусгаж хэрэгжүүлэх.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээ

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд орчин үеийн техник хэрэгсэл, компьютерийн тусламжтайгаар гүйцэтгэгдэх арга хэмжээнүүд хамаарна. Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, компьютерийг өргөнөөр ашиглах, нийт иргэдийн гар, хурууны хээг авч компьютерт хадгалах, татварын тооцоо, бэлэн мөнгөний эргэлтийг аль болох хумиж банк, зээлийн картын системд орох нь чухал юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээний хүрээнд урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэх ба дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талын ач холбогдолтой. Үүнд:

- Орчин үеийн техник, технологийн ололт дэвшлийг нэвтрүүлсэн судалгаа шинжилгээний төв, эмчилгээ, техник оншилгооны хүрээлэнгүүдийг хөдөө орон нутагт байгуулах;

5 Төрийн мэдээлэл. УБ., 2000. №1

- Гэмт хэрэгтэй тэмцэх, тухайлбал гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох, үйл явдлыг хяналттай болгох зэрэг шат дамжсан үйл ажиллагааг, аюул багатай, түргэн шуурхай, үр өгөөжтэй болохуйц орчин үеийн техник хэрэгсэл, үйл ажиллагааны өвөрмөц технологи (арга барил) өргөн нэвтрүүлэх, тухайлбал, бүх нийтийн хуруувы хээний болон бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн санг улсын хэмжээнд бүрдүүлэх;
- Нийслэл хотын хэмжээнд бичил хороолол болон гудамж талбайд гэрэлтүүлэг, дуут дохиолол, хийх, хүн ам ихээр төвлөрдөг худалдаа үйлчилгээний газрууд болон нийслэл хотын гудамж талбайд телекамерын систем өргөн нэвтрүүлэх;
- Орон сууц, авто машин болон бусад эд хөрөнгийг хамгаалахын тулд дохиоллын хамгаалалт, түгшүүрийн товчлуур, машины дохиот төхөөрөмж, бусад техникийн хэрэгсэл болон гэмт халдлагаас хамгаалах нэг бүрийн хамгаалалтын (цахилгаан цохигч, хийн гар буу, нулимас асгаруулагч) зэрэг үр нөлөөтэй иж бүрэн техникийн хэрэгслүүдийг өргөнөөр нэвтрүүлэх арга хэмжээг багтааж болно;
- Хамгийн энгийн жишээ нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ болсон гар утас ашиглан үйлдэгддэг болон гэмт хэргийн замаар алдагдсан гар утас зарж борлуулдаг зах зээлийг хаах зорилгоор дахин ашиглагдах боломжгүй болгох, байршлыг нь тогтоох техник, технилоги байхгүй, үүрэн холбооны оператор компаниудын үзэмжээр шийдэгдэж байна.


3.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн арга хэмжээ

- Хөдөө орон нутагт дотоодын болон олон улсын чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах орчин үеийн спортын цогцолбор, театр, музей зэргийг байгуулах;
- Нийслэл хотод "цэцэрлэгт хүрээлэн", "ногоон бүс", спортын цогцолбор байгуулах бодлого хэрэгжүүлэх. Учир нь хүүхэд, зууучууд чөлөөт цагаараа тоглох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх тоглоом, бусад газар цөөн буюу очих газрын "сонголт" байхгүй тул чөлөөт цагаа шөнийн цэнгээний газруудад өнгөрүүлэх нь түгээмэл байна.

Ийнхүү дээр дурдсан урьдчилан сэрийлэх ерөнхий арга хэмжээнүүд бүхэлдээ хот суурин газар дахь дараах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ёстой.

- Гудамж, талбай, олон нийтийн газарт үйлдэгдэж байгаа иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Ахуйн хүрээнд үйлдэгдэж буй хувийн сэдэлттэй иргэдийн амь нас эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Гудамж талбай олон нийтийн болон бусад газар үйлдэгдэж буй дээрэмдэх, булаах, танхайрах, хүчиндэх гэмт хэрэг;
- Бэлгийн халдашгүй байдал ба гудамж, олон нийтийн газар үйлдэгдэж байгаа зарим хүч хэрэглэсэн гэмт хэрэг;
- ААН, байгууллага иргэдийн эд хөрөнгийг хулгайлах болон халааснаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг;
- ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг зэрэг болно.

АРХАНГАЙ АЙМАГ



2. АРХАНГАЙ АЙМАГ

НЭГ. АРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ:

Архангай аймаг нь 55.300 км газар нутагтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай, олон жилийн дундаж температур дулааны улиралд +15, хүйтний улиралд -15, хамгийн ихдээ -47, +40.6 хэм хүрч байсан, жилд дунджаар 350-450 мл/м хур тунадас ордог, жилийн ихэнх хур тунадас нь 4-8 дугаар сард ордог байна.

Тус аймаг 91.600 хүн амтай (2012 оны байдлаар), хүн амын нягтрал 1 км талбайд 1.6 хүн ноогддог, Булган уул, Тайхар чулуу, Өгийнуур, Тэрхийн цагаан нуур, Хоргын тогоо уул, Суварга хайрхан уул зэрэг байгалийн үзэсгэлэнт газар олонтой.

2012 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн 141 тэрбум 325.8 сая төгрөг, 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний индекс 536 ам.доллар байна.

Хөдөлмөрийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1971 иргэн байна. Хөдөлмөрийн насны 10.000 хүн тутамд 345 ажилгүйчүүд ногдож байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 97.% нь боловсролтой иргэд байгаагийн 329 нь дээд, 106 нь тусгай дунд, 1281 нь бүрэн болон бүрэн бус дунд, 203 нь бага боловсролтой хүн байна.

Архангай аймаг газар нутгийн хэмжээгээр Өмнөговь аймгаас хоёр дахин бага боловч алтны нөөц, ашиглалтын лицензийн тоогоороо зөвхөн Цэнхэр сум бусад 20 аймгийг тэргүүлж байна. Ашигт малтмалын газрын албан ёсны мэдээллээр тус аймагт өнөөдрийн байдлаар уул уурхайн 89 лиценз олгожээ. Үүнээс Цэнхэр суманд 22 лиценз бүртгэлтэйгээс 17 нь алтны ашиглалтын лиценз байна.

ХОЁР. АРХАНГАЙ АЙМГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

2.1. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:

Архангай аймаг дахь Цагдаагийн газар 2016 онд иргэд, ААН, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2685 гомдол, мэдээллийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шалгаж шийдвэрлэсэн байна. Үүнээс:

Гэмт хэргийн шинжтэй 1132 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 540 буюу 47.7%-ийг эрүүгийн хэрэг үүсгэж, 571 гомдол, мэдээлэл буюу 50.4%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 21 гомдол, мэдээлэл буюу 1.8%-ийг эрүүгийн хэрэг болон гомдол, мэдээлэлд нэгтгэж, нийт 1090 буюу 96.2%-ийг шийдвэрлэж, 42 гомдол, мэдээлэл буюу 3.7%-ийг шалгаж байна.

Шалгасан гомдол, мэдээллийн 505 буюу 44.6%-ийг 0-5 хоногт, 627 буюу 55.3%-ийг 5-19 хоногт шийдвэрлэжээ.

Захиргааны зөрчлийн шинжтэй 1185 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 799 буюу 67.4%-д торгох, 314 буюу 26.5%-д эрх хасах, 33 буюу 2.7%-д баривчлах шийтгэл оногдуулж, 1166 буюу 98.4%-ийг шийдвэрлэжээ.

Шалгасан гомдол, мэдээллийн 1053 буюу 88.9%-ийг 0-14 хоногт, 132 буюу 11.1%-ийг 14-28 хоногт шийдвэрлэсэн байна.

2.2.Гэмт хэргийн байдал

Аймгийн хэмжээнд 2016 онд 536 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 24 хэрэг буюу 4.48%-аар өссөн байна.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 268 буюу 50%-ийг хөнгөн, 246 буюу 45.9%-ийг хүндэвтэр, 15 буюу 2.8%-ийг хүнд, 7 буюу 1.3%-ийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байгаа ба өмнөх оныхоос хөнгөн гэмт хэрэг 18.6%-аар өссөн, хүндэвтэр гэмт хэрэг 9.2%-аар, онц хүнд хэрэг өмнөх оныхоос 12.5%-аар буурсан, хүнд гэмт хэрэг өмнөх онтой ижил түвшинд байна. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 69.8%-тай, өмнөх оны мөн үеийнхээс 6.4 пунктээр өссөн.

Гэмт хэргийн илрүүлэлтийг ангиллаар нь тооцож үзвэл: Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 60.7%, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 75.7%, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 50.0%, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 100% байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хөнгөн хэргийн илрүүлэлт 1.4 пунктээр, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 50 пунктээр буурч, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 12.7 пунктээр өссөн, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт өнгөрсөн оныхтой ижил түвшинд байна.

Аймгийн хэмжээнд 68 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй байгаагаас: Хашаат сум 4, Өгийнуур сум 5, Өлзийт сум 5, Хотонт сум 4, Хайрхан сум 3 , Төвшрүүлэх сум 2 , Цэнхэр сум 2, Батцэнгэл сум 2 , Булган сум 3 , Эрдэнэбулган сум 27 , Эрдэнэмандал сум 2 , Ихтамир сум 3 , Цэцэрлэг сум 1 , Өндөр-Улаан сум 2, Жаргалант сум 1, Чулуут сум 1, Хангай сум 1 тус тус байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр авч үзвэл: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг 173 бүртгэгдсэн нь 36 буюу 20.8 хувиар, өмчлөх эрхийн эсрэг 290 хэрэг бүртгэгдсэн нь 12 буюу 4.1 хувиар, хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг 4 бүртгэгдсэн нь 2 буюу 50 хувиар тус тус өссөн байна.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 8 бүртгэгдсэн нь 1 буюу 12.5 хувиар, аж ахуйн эсрэг хэрэг 1 бүртгэгдсэн нь 2 буюу 2 дахин, нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг 3 хэрэг бүртгэгдсэн нь 9 буюу 3 дахин, байгаль хамгаалах журмын эсрэг хэрэг 5 бүртгэгдсэн нь 5 буюу 100 хувиар, захиргааны журмын эсрэг хэрэг 1 бүртгэгдсэн нь 4 буюу 4 дахин, шүүн таслах ажиллагааны эсрэг хэрэг 3 бүртгэгдсэн нь 4 буюу 57.1 хувиар буурсан байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 47, албан тушаалын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд байна.

Зарим төрлийн гэмт хэргийн хувьд: Бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг 167 бүртгэгдсэн 38 буюу 22.7%-аар, авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 59 бүртгэгдсэн нь 36 буюу 61%-аар, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг 19 бүртгэгдсэн нь 11 буюу 57.8%-аар тус тус өсчээ.

Гэмт хэргийн төрөл: Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 101 бүртгэгдсэн нь 23 буюу 18.5%-аар, үүнээс мал хулгайлах хэрэг 84 бүртгэгдсэн нь 13 буюу 13.4%-аар, БХЖЭсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь 5 буюу 50.0%-аар, хүчиндэх гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь 1 буюу 14.2%-аар, танхайрах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь 10 буюу 90.9%-аар тус тус буурчээ.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн 536 гэмт хэргийн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг 173 буюу 32.2%, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 246 буюу 45.9%, хүчиндэх хэрэг 6 буюу 1.1%, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх хэрэг 19 буюу 3.5%, танхайрах хэрэг 1 буюу 0.19%, ТХХАБАЖЭсрэг хэрэг 47 буюу 8.7%, бусад хэрэг 44 буюу 8.2%-ийг тус тус эзэлж байна.

Мал хулгайлах гэмт хэрэг 84 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 13 буюу 13.4%-аар буурч, нийт хэргийн 15.6%, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 34.1%-ийг эзэлж байна.

Согтуугаар үйлдэгдсэн хэрэг 149 бүртгэгдсэн нь 45 буюу 30.2%-аар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 29 бүртгэгдсэн нь 3 буюу 10.3%-аар, эмэгтэй хүн оролцсон хэрэг 45 бүртгэгдсэн нь 11 буюу 24.4%-аар өссөн. Галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг бүртгэгдээгүй, бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг 56 бүртгэгдсэн нь 21 буюу 27.2%-аар тус тус буурчээ.

Гэмт хэрэгт 549 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 14 буюу 2.5%-аар өссөн, нийт шалгагдсан хүний 45 эмэгтэй бүртгэгдсэн нь 8.29%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.1 пунктээр өссөн, 18 буюу 3.2%-ийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.3 пунктээр тус тус өссөн байна.

Насны ангиллаар авч үзвэл: 15 хүртэлх насны 8, 16-17 насны 18, 18-24 насны 154, 25-29 насны 101, 30-34 насны 82, 35-39 насны 80, 40-44 насны 42, 45-49 насны 32, 50-54 насны 17, 55-59 насны 8, 60-64 насны 4, 65-69 насны 1, 70 ба түүнээс дээш насны 2 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.

Хэрэгт холбогдогсодын нийгмийн байдал, боловсролоор нь авч үзвэл: төрийн албан хаагч 21, хувийн хэвшлийн байгууллагын ажилтан 11, ТББ-ын ажилтан 10, хувиараа хөдөлмөр эрхлэгч 55, малчин 210, оюутан 8, сурагч 21, хоригдол 2, тэнэмэл 6, ажилгүй 205 хүн байгаа ба тэдгээрийн 5.4% нь боловсролгүй, 23.6% нь бага, 32.9% нь суурь, 26.4% нь бүрэн дунд, 1.2% нь техникийн, тусгай мэргэжлийн дунд, 10.2% дээд боловсролтой хүмүүс байна.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 89 нь Даваа, 94 нь Мягмар, 77 нь Лхагва, 85 нь Пүрэв, 65 нь Баасан, 62 нь Бямба, 64 нь Ням гараг, 14.1 хувь нь 06-14 цагт, 22.7 хувь нь 14-19 цагт, 15.8 хувь нь 19-22 цагт, 47.2 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 176 бүртгэгдсэн нь 10 буюу 5.6%-аар, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 100 бүртгэгдсэн нь 36 буюу 36.0%-аар, төрийн байгууллагад үйлдэгдсэн 7 хэрэг бүртгэгдсэн нь 1 буюу 14.2%-аар, ТББ-д үйлдэгдсэн хэрэг 2 бүртгэгдсэн нь 1 буюу 50%-аар өсөж, олон нийтийн газар үйлдэгдсэн хэрэг 31 бүртгэгдсэн нь 1 буюу 3.2%-аар, ААН-д үйлдэгдсэн хэрэг 19 бүртгэгдсэн нь 4 буюу 21.5%-аар, бусад газарт үйлдэгдсэн хэрэг 174 бүртгэгдсэн нь 19 буюу 12.2%-аар буурчээ. Авто замд үйлдэгдсэн хэрэг 46 бүртгэгдсэн нь өмнөх үеийнхтэй ижил үзүүлэлттэй байна.

Гэр, орон сууцанд 176 хэрэг үйлдэгдсэний дотор гэрт 91, орон сууц 9, хувийн байшинд 60, зуслангийн байшин 1, хаус 2, гараж 3, амбаар 4, бусад газарт 6; харин гудамж талбайд 100 хэрэг үйлдэгдсэний дотор гэр хорооллын гудамжинд 68, орон сууцны хорооллын гудамж 3, ил зогсоол 8, бусад газарт 21; олон нийтийн газарт 31 хэрэг үйлдэгдсэний дотор нийтийн зах-5, бөөний худалдааны төв 5, дэлгүүрт 6, зочид буудал 1, баар 4, ресторан зоогийн газар-4, жуулчны бааз 1, бусад 5: төрийн байгууллагад 7 хэрэг, ТББ-д 2 хэрэг, ААН-д 19 хэрэг, бусад газарт 174 хэрэг тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 571 иргэн хохирсны 26.4% нь эмэгтэй, 1.7% нь 7 хүртэлх, 0.5% нь 8-13, 1.9% нь 14-17, 9.2% нь 18-24, 15.9% нь 25-29, 15.5% нь 30-34, 14.5% нь 35-39, 12.2% нь 40-44, 11.5% нь 45-49, 7.3% нь 50-54, 3.6% нь 55-59, 3.8% нь 60-64, 0.7% нь 65-69, 1.05% нь 70 ба түүнээс дээш насны хүн байна.

Хохирогч иргэдийн дотор төрийн албан хаагч 70, хувийн хэвшлийн байгууллагын ажилтан 15, ТББ-ын ажилтан 13, хувиараа хөдөлмөр эрхлэгч 84, малчин 254, оюутан 8, сурагч 16, сургууль завсардсан хүүхэд 1, эрхэлсэн тодорхой ажилгүй 111 гэмт хэргийн халдлагад өртжээ.

Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, ААН, иргэдэд 2.389.3 сая төгрөгийн хохирол бий болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 43.7%-аар өссөн ба хохирлын 892.2 сая төгрөг буюу 37.3%-ийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Хөнгөн ангиллын гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын 238.4 сая төгрөг буюу 75.3%-ийг хэрэг бүртгэх шатанд, хүндэвтэр, хүнд, онц хүнд ангиллын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 653.8 сая төгрөг буюу 31.5%-ийг мөрдөн байцаах шатанд нөхөн төлүүлж, хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагааны явцад 101.2 сая төгрөгийн хөрөнгийг тус тус битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас 19 хүн нас барж, 209 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс нас барсан хүний тоо 8 буюу 29.6%-аар буурч, гэмтсэн хүний тоо 35 буюу 16.7%-аар өсжээ.

Нас барсан хүмүүсийн 4 буюу 21.05%, гэмтсэн хүмүүсийн 69 буюу 33.01%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеийнхээс нас барсан эмэгтэй хүмүүс 1 буюу 25%-аар, гэмтсэн эмэгтэй хүмүүс 17 буюу 26.4%-аар өсжээ.

Тэдгээрийн 159 буюу 76.08 хувь нь хөнгөн, 27 буюу 12.9 хувь нь хүндэвтэр, 23 буюу 11 хувь нь хүнд хэлбэрээр гэмтжээ.

2.3. 2016 онд Архангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хэрэг таслан шийдвэрлэсэн байдал:

Тус шүүх 276 холбогдогчтой 156 эрүүгийн хэрэг хүлээн авч, 64 холбогдогчтой 20 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 152 холбогдогчтой 117 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Тус шүүхийн 2014, 2015, 2016 онд хянан шийдвэрлэсэн Эрүүгийн хэргийг тодорхой бүлэг болон анхаарал татаж байгаа төрлөөр нь авч үзвэл:

Хүснэгт VIII.2.1.

№	Хэргийн төрөл	Хэрэг			Ял шийтгүүлэгсэд		
		Он			Он		
		2014	2015	2016	2014	2015	2016
1.	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	29	11	8	31	56	8
2.	Хүчиндэх гэмт хэрэг	2	5	4	7	8	4
3.	Хулгайлах гэмт хэрэг	60	53	27	113	106	42
4.	Мал хулгайлах гэмт хэрэг	39	36	10	64	78	19
5.	Танхайрах гэмт хэрэг	2	12	5	2	18	10
6.	ТХХАБЭсрэг гэмт хэрэг	8	15	22	18	14	21
7.	Ойн тухай хууль тогтоомж зөрчих	20	8	2	21	7	2

2016 онд хянан шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийн 6.1%, ял шийтгүүлэгчдийн 12.8%-ийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэргийн; 3.6%, ял шийтгүүлэгчдийн 3.9%-ийг хүчиндэх; хэргийн 38.4%, ял шийтгүүлэгчдийн 52.4%-ийг хулгайлах; үүнээс: хэргийн 26%, ял шийтгүүлэгчдийн 38.6%-ийг мал хулгайлах, хэргийн 3.6%, ял шийтгүүлэгчдийн 4.4%-ийг дээрэмдэх, хэргийн 5.9%, ял шийтгүүлэгчдийн 8.9%-ийг танхайрах, хэргийн 10.8%, ял шийтгүүлэгчдийн 6.9%-ийг ТХХАБАЖЭсрэг, хэргийн 5.7%, ял шийтгүүлэгчдийн 3.4%-ийг ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас 15 хүний амь нас хохирч, 10 хүний биед хүнд, 5 хүний биед хүндэвтэр, 16 хүний биед хөнгөн гэмтэл тус тус учирсан байна. Мөн гэмт хэргийн улмаас нийтдээ 374985890 төгрөгийн хохирол учирснаас улсад 99387380, ААН-д 53627580, иргэдэд 221970930 төгрөгийн хохирол тус тус учирсан байна.

Ял шийтгүүлэгчдийн 21 буюу 10.3% нь насанд хүрээгүй хүн, 9 буюу 4.4%-ийг эмэгтэй, 16 буюу 7.9% нь 16-17 насны, 107 буюу 52.9% нь 18-29 насны, 38 буюу 18.8% нь 30-34 насны, 38 буюу 18.8% нь 35-аас дээш насны, 15 буюу 7.4% нь дээд боловсролтой буюу бакалавр зэрэгтэй хүмүүс, 2 буюу 0.9% нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 102 буюу 55.4% нь бүрэн дунд боловсролтой, 52 буюу 25.7% нь бага боловсролтой, 21 буюу 10.3% нь боловсролгүй, 40 буюу 19.8%-ийг урьд ял шийтгүүлсэн, 34 буюу 16.8%-ийг 2 дахь удаа ял шийтгүүлсэн, 6 буюу 2.9%-ийг 3 ба түүнээс дээш ял шийтгүүлсэн, 4 буюу 1.9%-ийг давтан үйлдсэн, 40 буюу 19.8%-ийг бүлэглэж, 8 буюу 3.9%-ийг согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүмүүс тус тус эзэлж байна.

Нийт ял шийтгүүлэгчдийн 166 буюу 82.1%-ийг эрхэлсэн ажил, сургуульгүй хүн эзэлж байна.

Шүүхээс ял оногдуулж буй байдлыг авч үзвэл:

Хүснэгт VIII.2.2.

№	Ялын төрөл	Он		
		2014 он	2015 он	2016 он
1	Хорих ялаар, үүнээс;	162	156	102
	А. Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	45	55	12
	Б. Тэнссэн	102	87	88
	В. Тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	15	14	1
2	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн	21	11	14
	А. Торгох	7	7	1
	Б. Албадан ажил хийлгэх	14	3	7
	В. Баривчлах	30	30	8
3	Г. Цаазаар авах	-	-	-

Архангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 онд хянан шийдвэрлэсэн нийт ял шийтгүүлэгчдийн 156 буюу 77.2%-д хорих, 1 буюу 0.4%-д торгох, 3 буюу 1.4%-д албадан ажил хийлгэх, 30 буюу 14.8%-д баривчлах ял тус тус оногдуулжээ.

Хорих ялаар шийтгүүлсэн 156 хүний 55-ыг буюу 35.2%-д, нийт ял шийтгүүлэгчдийн 27.2%-д нь хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Хорих ял биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн 55 хүний 51 буюу 92.7%-ийг жирийн, 4 буюу 7.2%-ийг чанга дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймгийн цагдаагийн байгууллагад 2016 онд 536 гэмт хэрэг бүртгэгдсэнээс аймгийн шүүхэд 276 холбогдогчтой 156 эрүүгийн хэргийг шилжүүлж, шүүхээс 64 холбогдогчтой 20 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 152 холбогдогчтой 117 хэргийг хянан шийдвэрлэжээ. Эндээс үзэхэд, цагдаагийн байгууллагад нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 1/5 нь шүүхээс таслан шийдвэрлэгдэж, үлдсэн хувь нь хэрэг бүртгэлт, прокурорын хяналтын явцад хэрэгсэхгүй болгож, түдгэлзүүлжээ.

Архангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 онд захиргааны зөрчлийн материалыг хянан шийдвэрлэсэн байдал:

Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2016 онд 80 захиргааны зөрчлийн материал хүлээн авснаас 30 материалд арга хэмжээ авахаас татгалзаж, 50 зөрчлийн материал хянан шийдвэрлэсэн байна.

Тус шүүхийн 2016 онд нийт хүлээн авсан 80 зөрчлийн материалын 39 буюу 48.7% нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн, 2 буюу 2.5% нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн, 35 буюу 43.8% нь Сонгуулийн тухай хуулийн, 4 буюу 5% нь Захиргааны хариуцлагын 30 дугаар зүйлийн зөрчлүүд байна.

Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 50 зөрчлийн материалыг хянан шийдвэрлэхдээ 35 хүнд баривчлах шийтгэл ногдуулж, 15 хүнд нийт 2808000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ. Нийт 50 хүн шийтгүүлснээс 49 эрэгтэй, 1 эмэгтэй байна.

Тус шүүх 2015 онд захиргааны зөрчлийн 267 материал хянан шийдвэрлэж байсан ба 2016 онд Захиргааны хариуцлагын тухай хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулан шийдвэрлэсэн материалын тоон үзүүлэлт буурсан үзүүлэлттэй байна.

Тус шүүхийн 2016 онд хянан шийдвэрлэсэн 80 хэргийн 35 буюу 43.8%-ийг Сонгуулийн тухай хуулийн зөрчил хянан шийдвэрлэгдсэн нь уг онд УИХ-ын болон аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийн сонгууль болсонтой холбоотой.

ГУРАВ. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2016 онд ТХХАБАЖЭсрэг бүлэгт заасан гэмт хэргийн 27 хүнд холбогдох 26 хэрэг хүлээн авснаас 2 хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, 22 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Тус шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг зүйл ангиар нь авч үзвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлд зааснаар 20 хэрэг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлд зааснаар 2 хэрэг хянан шийдвэрлэгджээ. Дээрх хэрэгт 21 хүн ял шийтгүүлснээс баривчлах ялаар 1, хорих ялаар 20 тус тус шийтгүүлсэн байна.

Ял шийтгүүлэгчдийн 12 буюу 57.2% нь 18-29 насны, 7 буюу 33.3% нь 30-34 насны, 2 буюу 9.5% нь 35-аас дээш настай, 4 буюу 19.4% нь дээд боловсролтой буюу бакалавр зэрэгтэй хүмүүс, 6 буюу 28.6% нь бүрэн дунд боловсролтой, 5 буюу 23.8% нь бага боловсролтой, 6 буюу 28.6% нь боловсролгүй, 8 буюу 38.1%-ийг согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүмүүс тус тус эзэлж байна. Нийт ял шийтгүүлэгчид нь бүгд эрхэлсэн тодорхой ажил, сургуульгүй хүн байжээ.

Гэмт хэргийн улмаас 9 хүний амь нас хохирч, 10 хүний биед хүнд, 8 хүний биед хүндэвтэр, 2 хүний биед хөнгөн гэмтэл тус тус учирсан байна.

Уг зүйл ангиар хянан шийдвэрлэгдсэн хэрэг нь тус шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн 18.8%-ийг эзэлж байгаа, уг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 38.1% нь согтуугаар уг хэргийг үйлдсэн, мөн дээрх хэрэгт холбогдсон этгээдүүд нь бүгд эрхэлсэн ажил сургуульгүй, энэ гэмт хэргийн улмаас 9 хүний амь нас хохирсон үзүүлэлтүүд гарч байгаа нь энэ төрлийн хэрэг тус орон нутагт нэлээдгүй гарч байгаа байдалд анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй байна.

ДӨРӨВ. АРХАНГАЙ АЙМГИЙН ГХУСАЗСЗӨВЛӨЛИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН:

Архангай аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 60 дугаар тогтоолоор аймгийн ГХУСАЗСЗөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталж, зөвлөлийн ажиллах журмыг шинээр баталсан.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн даргаар аймгийн ИТХ-ын дарга, орлогч даргаар аймгийн Засаг дарга, нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Хууль, эрх зүй, ГХУСАЗСЗөвлөл хариуцсан ажилтан, гишүүдээр Цагдаагийн газрын дарга, Аймгийн прокурор, Шүүхийн тамгын газрын дарга, Онцгой байдлын газрын дарга, Тагнуулын газрын дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Шүүх шинжилгээний албаны дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Боловсрол, соёлын газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга тус тус ажиллаж байна.

Архангай аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь зөвлөлийн ажиллах журамд заасны дагуу 2017 онд аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

ТАВ. АРХАНГАЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР 2016 ОНД ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор "Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг баталж, Эрдэнэбулган сумын 7 багт хөршийн холбоог байгуулан өнөөдөр үйл ажиллагаа нь жигдрэн ажиллаж байна. Эрдэнэбулган сумын ГХУСАЗСЗөвлөл, ЗДТГ хамтран иргэдийн аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор өөрсдийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан хөршийн хяналтын бүлгийн идэвхтэн 350 гаруй хүнийг мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлжээ. Дээрх ажлын үр дүнд Эрдэнэбулган сумын хэмжээнд 2016 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар өдөр, оройн цагаар үйлдэгдсэн хулгайлах гэмт хэрэг 90 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 20 гэмт хэрэг буюу 18.18%-аар буурчээ.

Монгол Улсын Засгийн газрын 257 дугаар тогтоолоор баталсан "Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийн хүрээнд "Амар тайван амьдралын төлөө хамтдаа" уриан дор 2016 оны 05, 10 дугаар сарын 13-ны өдөр "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгууллаа.

Өдөрлөгт Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Архангай 1, 2 салбар, ерөнхий боловсролын сургуулиуд идэвхтэй оролцож, байгууллагын ажил үйлчилгээг сурталчилж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийг иргэдэд таниулах ажил зохион байгуулав. Тухайлбал, Засгийн газрын 257 дугаар тогтоолоор баталсан "Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөр", "Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм", аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан "Хөршийн хяналтын хөтөлбөр", "Хөршийн хяналтын бүлгийн ажиллах журам", ерөнхий боловсролын сургуулийн орчинд "School police" эцэг, эхийн эргүүл ажиллуулах журмыг тус тус танилцуулав.

Арга хэмжээний үеэр Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн орчинд "School police" эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй эцэг эх, багийн "Хөршийн хяналтын бүлгийн идэвхтэн 40 гаруй иргэдийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилснаас гадна

"School police" эргүүлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, тодорхой үр дүн гарган ажилласан 2 сургууль, 4 нийгмийн ажилтныг шалгаруулж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр урамшуулав.

Аймгийн Цагдаагийн газраас мал хулгайлах болон орон байрны хулгайлах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, цахим гэмт хэрэг, замын хөдөлгөөний осол, хэргээс урьдчилан сэргийлэх санамж, хоногийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, шийдвэрлэлтийн талаар сэрэмжлүүлэг мэдээллийг "АВ", "Архангай", "Тамир" телевиз, www.facebook.com/Архангай цахим хаягаар болон нийтийн худалдааны төвийн мэдээллийн самбар, Цагдаагийн газрын гадна байрлах LED дэлгэцээр олон нийтэд тогтмол хүргэж ирсэн.

Гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах, шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр криминологи судалгааны баг ажиллуулж, Архангай аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг 7 хоног тутам судалж, мэдээлэл, санал дүгнэлт гаргах, гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд өгөх, түүний мөрөөр 7 хоногийн тогтсон цагуудад нэгдсэн эргүүлийг ажиллуулахын зэрэгцээ хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "SCHOOL POLICE" эргүүл ажиллуулах журмын төсөл, холбогдох санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, аймгийн ИТХ-д танилцуулан батлуулан, Эрдэнэбулган сумын ЕБС-ийн орчинд эцэг, эхийн эргүүлийг 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үр дүнтэй зохион байгуулж байна.

Цагдаагийн газраас бусад байгууллагатай хамтран жендер, гэр бүл, хүүхдийн хүмүүжлийн асуудлаар бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 сумын 2000 гаруй иргэн, 4800 оюутан, сурагчид 18 удаагийн сургалт, мэдээлэл хийсэн.

Цагдаагийн газраас байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагуудыг камержуулах "Теле хяналт" аяныг зохион байгуулан ажиллалаа. Тус аяны хүрээнд хэсгийн байцаагч нар "Судалгаа", "Хяналт", "Камер" хэсэгчилсэн арга хэмжээг Эрдэнэбулган сумын 7 багийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, худалдаа үйлчилгээ эрхлэн явуулдаг 113 хүнсний дэлгүүр, 85 ААН-д эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өөрсдийн хөрөнгөөр дотор, гадна талдаа хяналтын камерын систем суурилуулах албан мэдэгдэл хүргүүлснээр 78 хүнсний дэлгүүр, 55 байгууллага, ААН камерын хяналтын системээр бүрэн тоноглогдсон.

"Теле хяналт" аяныг зохион байгуулснаар ААН, байгууллага, иргэд гэмт халдлагад өртөх эрсдэл буурч, хулгайлах гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх ажилд эерэг үр дүн гарч байна. Мөн Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-тай хамтран "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 9.168.900 төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэбулган сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 38 дугаар байр, 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 39 дүгээр байр, Майнт уулын станц, "Зая гэгээний хийд", Цогт-Уулын станц зэрэг газрыг камерын хяналттай болгосон.

Мал хулгайлах болон хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх зорилгоор Халзангийн даваа, Сангийн толгойн гүүр зэрэг газарт тус бүр 1 ширхэг хяналтын камерыг байрлуулан сумын байгаль хамгаалагч нартай хамтран ажиллаж байна.

УЕП, ЦЕГ-ын даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05, А/09 дүгээр тушаалаар баталсан "Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам", "Цагдаагийн байгууллагын үйл

ажиллагааны журмын "Тэнсэгдсэн ялтан, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдэд хяналт тавих" журмын хэрэгжилтийг хангах зорилгоор хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн 76 хүний материалыг хүлээн авч, хувийн хэргийг шинээр нээж хяналт тавьж ажиллаж байна.

Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүмүүсийг хүлээн авч бүртгэл судалгаанд хамруулахдаа гарын хээний дардас, фото зураг, анкетыг бүртгэн авч папилон болон генетик мэдээллийн санд оруулан хяналтын хувийн хэрэг нээн, хууль тогтоомжийн заалт болон дахин гэмт хэрэгт холбогдохгүй байх талаар урьдчилан сэргийлэх сургалтыг аймгийн Прокурорын газартай хамтран 2 удаа зохион байгууллаа.

Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран захиргааны хяналтад байгаа хүмүүст хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, ажил олгогч байгууллагын захиалгын дагуу ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамруулах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа 26 иргэд зохион байгуулж, 3 хүнийг ажилтай болгож, 2 хүнийг төсөл хөтөлбөрт хамруулан ажиллалаа.

Аймгийн прокурорын газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 удаагийн шалгалт, 4 судалгаа хийж, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар прокурорын мэдэгдэл 59-г бичиж, байгууллага, ААН, албан тушаалтнуудад хүргүүлж, мэдэгдлийн хариуг хугацаанд нь авч, биелэлтийг тооцож ажилласан.

Хууль тогтоомж сурталчлах чиглэлээр 2016 онд яриа таниулгыг 29 удаа, хууль тогтоомжийн сургалтыг 24 удаа зохион байгуулсан. Тухайлбал, Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиуд, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сурагч, оюутнуудад прокурорын байгууллагын үйл ажиллагаа, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт сургалт зохион байгуулав.


ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил криминологи, шинжлэх ухааны үндэслэлгүй, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын "үзэмж"-ээр явагдаж байгаа байдал ажиглагдав.
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан явуулах байдал хангалтгүйн зэрэгцээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагаар байгуулагдсан холбоо, нэгдлийг цагдаа, прокурорын байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах, аймгийн удирдлагаас дэмжих байдал төдийлөн сайнгүй байна.
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил иргэдэд зөвлөгөө өгөх, ААН, байгууллагад шаардлага хүргүүлэх байдлаар хязгаарлагдаж, гадаад улс болон Монгол Улсын хэмжээнд үр дүнтэй болох нь тогтоогдсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ төдийлөн зохион байгуулахгүй байна.
4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутгийн захиргааны болон шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа үгүйлэгдэж байна.
5. Монгол Улсын хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзэхэд, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн боловч урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийг бүрдүүлэх, зарцуулах чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй шаардлага байна.
6. Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.

ДОЛОО. САНАЛ

1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж зохион байгуулахдаа криминологийн судалгаанд үндэслэх;
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулах, иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлах явуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, нэгдлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллах;
4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн шашны байгууллагатай хамтран ажиллах;
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутгийн захиргааны болон шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах;
6. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн оронд нэгэнт үйлдэгдсэн гэмт хэрэг илрүүлэхэд анхаарал хандуулдаг, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын бүрэлдэхүүн хэсэг болох урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцдоггүй, тооны хойноос хөөцөлддөг байдлыг өөрчлөх;
7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд шуурхай тогтмол хүргэх, энэ ажилд нийтийн сүлжээ, мэдээллийг хэрэгслийг өргөнөөр ашиглах, гар утасны апликейшн бүтээж, ашиглах;
8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тэргүүн туршлагыг судалж, өөрийн аймгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэх, тухайлбал, гэмт хэргийн зураглал үйлдэх аргыг ашиглах г.м;
9. Гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэл бүхий бүлэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл хүргэх, сургалтад хамруулах зэргээр "дархлаа" тогтоох;
10. Уул уурхайн салбарын хөгжлөөс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, энэ чиглэлээр криминологи судалгаа хийж, судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
11. Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх;
12. Хүч хэрэглэсэн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй обьект, олон нийтийн газрын гэрэлтүүлгийг сайжруулж, теле хяналтад бүрэн авах;
13. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, тухайлбал, цагдаагийн эргүүл, харуулын үйл ажиллагаанд дрон ашиглах, теле камерын хяналт, профайлинг, гар утасны хяналтын систем, цахим хяналтын төхөөрөмж гэх мэт,
14. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг ихэвчлэн үйлдэгдэж буй орон нутгийн чанартай болон хот хоорондын авто зам тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, сэрэмжлүүлэг бүхий самбар байршуулах, хяналтын постыг тогтмол ажиллуулах, хурд хэмжигч байршуулах;

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ



3. БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

1. ТУХАЙН НУТАГ ДЭВСГЭР, БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙН ТАЛААР:

Баян-Өлгий аймаг нь 1940 оны 8 дугаар сард БНМАУ-ын Бага Хурлын шийдвэрээр байгуулагдсан. Монгол Улсын хамгийн баруун хязгаар Монгол Алтайн нурууны далайн түвшинээс 1350-4374 метр өргөгдсөн, өндөр уулсаар хүрээлэгдсэн учир эх газрын эрс тэс уур амьсгалтай (нийт нутгийн 95,3% далайн түвшингээс 1600 м-ээс дээш) өргөгдсөн, мөнх цааст өндөр уулсаар хүрээлэгдсэн, 45,8 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай.

Зураг VIII.3.1.



ОХУ-ын Алтайн БНУлс (225 км), БНХАУ-ын ШУӨЗО (450 км), Монгол Улсын Ховд (450 км), Увс (165 км) аймгуудтай хиллэдэг. 101,1 мянган хүн амтай, (хүн амын тоогоор улсад 5-р байр, бүсэд 1-р байр) үүнээс 93% казах үндэстэн, үлдсэн хувийг дөрвөд, урианхай, тува, халх ястангууд эзэлдэг. Засаг захиргааны 14 нэгжтэй (13 сум, 1 тосгон), нийслэл Улаанбаатар хотоос 1760 км зайд оршдог, аймгийн төв Өлгий хотод 33 мянган хүн оршин суудаг, 2 сая 167 мянган малтай.

Байгалийн унаган төрхөө хадгалсан нутаг дэвсгэр нь мөнх цааст сүрлэг өндөр уулс, уудам хөндий хотос, тунгалаг уст гол мөрөн, нуур цөөрөм, рашаан булаг, жимс жимсгэнэ, дэлхийд ховордсон эмийн ургамал, ан амьтан, жигүүртэн шувууд, алт, мөнгө, гянтболд, төмрийн хүдэр, зэс, хар тугалга зэрэг эрдэс баялагийн арвин их нөөцтэй, уул уурхайн үйлдвэрлэл, эрчимжсэн МАА, улс дамнасан худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс хөгжүүлэх боломжтой аймаг юм.

2. НУТАГ ДЭВСГЭРИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛСОН ТАНИЛЦУУЛГА: (2003-2016 ОН)

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо:

График VIII.3.1.




График VIII.3.2.



График VIII.3.3.



График VIII.3.4.



График VIII.3.5.



График VIII.3.6.



Тус аймгийн хэмжээнд сүүлийн 14 жилийн хугацаанд /2003-2016 он/ нийт 4116 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд бусдын бие махбодид санаатай гэмтэл учруулах гэмт хэрэг 1724 бүртгэгдэж нийт гэмт хэргийн 42%-ийг, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 1205 бүртгэгдэж нийт гэмт хэргийн 29.3%-ийг, ТХХАБАЖЭсрэг 211 гэмт хэрэг бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 5.1%-ийг тус тус эзэлж байна.

Мөн нийт гэмт хэргийн 1115 буюу 27.1% нь согтуугаар үйлдэгдсэн ба гэр, орон сууц, ахуйн хүрээнд 1075 гэмт хэрэг бүртэгдсэн нь нийт гэмт хэргийн 26.1%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг судлан дүн шижилгээ хийж үзэхэдтус аймгийн нутаг дэвсгэрт уламжлалт гэмт хэргүүд болох бусдын эд хөрөнгийг хулгайлах,бусдын бие махбодид гэмтэл учруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргүүд зонхилон үйлдэгдэж байгаа бөгөөд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 76.3%-ийг эзэлж байна.

Иймд цаашид дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг орон нутгийн онцлогт тохируулан төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотой зохион байгуулж ажилласнаар гэмт хэргийн гаралтыг жилд 50%-аар бууруулах нөхцөл боломж харагдаж байна. Тус аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйлсийг судалж үзэхэд: (2003-2016 он)

1. Ерөнхий шалтгаан нөхцөл:

1.1. Ажилгүйдэл, ядуурал (орлогын эх үүсвэргүй)

1.2. Хүн амын хэт төвлөрөл

1.3. Иргэдийн боловсролын түвшин доогуур

1.4. Ёс суртахууны төлөвшил хангалтгүй

1.5. Архидалт

1.6. Бусдын эрхийг үл хүндэтгэх явдал нийтлэг болсон

1.7. Хүмүүсийн стресс, бухимдал нэмэгдсэн

1.8. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй

2. Тодорхой шалтгаан нөхцөл:


2.1. Хувь хүмүүсийн ухамсар, ёс зүйн төлөвшил
2.2. Хүмүүс бие биеэ үл хүндэтгэх явдал
2.3. Эрх, үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй
2.4. Иргэдийн сонор, сэрэмж, анхаарал болгоомжгүй, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал
2.5. Жолооч нарын ур чадвар, хууль, дүрмийн мэдлэг муу
2.6. Замын орчин, нөхцөл стандартын шаардлага хангаагүй
2.7. Хувь хүний стресс, бухимдал
2.8. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэггүй байдал
2.9. Ахуйн хүрээний архидалт

3. Хүчин зүйл:

3.1. Нийгмийн ёс суртахууны төлөвшил
3.2. Хувь хүний хүмүүжил, хүнлэг харилцаа
3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага, сэтгэлгээ иргэдийн дунд төлөвшөөгүй байдал
3.4. Иргэдийн орлого буурснаас иргэд амар хялбар аргаар мөнгө олох сонирхолтой болсон
3.5. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ахуйн хүрээнд архидан согтуурах явдал их байгаа

3. НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

График VIII.3.7.



Тус аймгийн хэмжээнд 2016 онд 7115 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад 476 зөрчил буюу 7.2%-аар нэмэгдсэн байна.

1. Зөрчлийн шалтгаан нөхцөл, хүчин зүйл:

1.1. Хүн амын төвлөрөл
1.2. Ахуйн хүрээний архидалт
1.3. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй
1.4. Хувь хүний стресс, бухимдал
1.5. Замын хөдөлгөөнд оролцогчдын хууль, дүрмээ баримтлах, хэрэгжүүлэх явдал


хангалтгүй

1.6. Нийгмийн ёс суртахууны төлөвшил

1.7. Хувь хүний хүмүүжил, хүнлэг харилцаа

4. НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ:

График VIII.3.8.



Тус аймгийн хэмжээнд 2016 онд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журам зөрчих 21 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад 7 хэрэг буюу 50%-аар нэмэгдсэн байна.

1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйл нь:

- Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсээр байгаа /өнөөдрийн байдлаар 19121 гаруй тээврийн хэрэгсэл бүртгэлтэй/
- ОХУ, БНКазУ-аас жилд дунджаар 50,000 орчим тээврийн хэрэгсэл орж гарч байгаа
- Замын хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байгаа хүн, хүчний (3 зохицуулагч, 8 цагдаа-зохицуулагч) хүрэлцээ хангалтгүй
- Замын орчин нөхцөл, стандартын шаардлага хангаагүй, замын багтаамж, нэвтрүүлэх чадвар муу
- Жолооч нарын хариуцлага, ур чадвар муу, жолооны сургалтын төвийн сургалтын чанар хангалтгүй
- Бүрэн бус тээврийн хэрэгсэл
- Замын хөдөлгөөнд оролцогчдын хууль, дүрмээ баримтлах, хэрэгжүүлэх явдал хангалтгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж байна.

Үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тогтсон хандлага байгааг өөрчлөн боловсронгуй болгож, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйл, суурь шалтгаан нөхцөлийг арилгах, сааруулах, таслан зогсоох арга хэмжээ авах нь нэн чухал юм.

Урьдчилан сэргийлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгон төр, иргэд, олон нийтийн

санаа сэтгэл, хүчин чармайлтыг нэгтгэсэн үйл ажиллагааг түүнд чиглүүлэх нь хөрөнгө, хүч, цаг хугацаа хэмнэхэд чухал ач холбогдолтой.

Үүний тулд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх механизмыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх цаг үеийн шаардлага бий болж байна.

Дээрх гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан нөхцөлүүдийг нэгтгэн дүгнэж үзэхэд хамгийн гол шалтгаант холбоо нь иргэн бүрийн хуулиа дээдлэх сэтгэлгээ, хандлага, хууль эрх зүйн мэдлэгийн түвшингээс шууд хамааралтай болоод байна.

Одоогийн нийгэмд иргэдийн аюулгүй байдал улс, үндэстний нэн тэргүүний асуудал болж байгаа нь дэлхий дахинд өрнөж буй зарим үйл явдлууд нотлон харуулаад байна.

Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, урьдчилан сэргийлэх мөн иргэн бүрийн хуулиа дээдлэн, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн шинж чанартай нийтлэг арга хэмжээг зохион байгуулах замаар аюулгүй амар тайван нийгмийг бүрдүүлэх боломжтой.

5. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ТАЙЛАН:

Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн хурлыг 4 удаа хийж, 2 удаа баруун бүсийн зөвлөгөөн зохион байгуулж орон нутгийн хэмжээний тулгамдсан асуудал бүрийг авч хэлэлцэв. Хурал, зөвлөгөөнөөс тухай бүр шийдвэр гарган, цаашид авах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх зохион байгуултын арга хэмжээ авч ажилласны үр дүнд тодорхой ахиц гарлаа.

2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, ажиллах журмын хамт хэлэлцэн баталлаа.

2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн аймгийн ГХУСАЗ3-ийн хуралдаанаар 2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 бүлэг, 25 зүйлээр баталж, Иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд зохион байгуулалтын ажлаа чиглүүлэн сургалт, сурталчилгааны ажиллаа түлхүү хэрэгжүүлж байна.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Улаанхус, Алтанцөгц, Сагсай, Ноогоннуур, Баяннуур, Цэнгэл сумдын ГХУСАЗСЗөвлөлийн ажлыг шалгаад, илэрсэн зөрчил, дутагдлын талаар шалган зааварлаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг илүү үр дүнтэй бодитой болгох, иргэдийн оролцог нэмэгдүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллав.
- Аймгийн төвийн ЕБС-ын хэмжээнд 2015 оны байдлаар багш, сурагчдын дунд гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлуудыг нь шалган, тус сургуулийн нийт багш, ажилчдад гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийн талаар ойлголт өгч ажиллав.
- 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр аймгийн төвийн Мобикомын 12121 хэрэглэгчийг хамруулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мессеж илгээв.
- Аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар хамтран Монгол Улсын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль", болон "Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа" хөтөлбөрийн хэрэгжилтийг

хангах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахад нь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон цагдаагийн байгууллагаас мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэхэд байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн төвийн бүх ААН, байгууллагуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулав.

- ХЗДХЯамны 2016 оны б/1366 дугаар албан тоотоор ирүүлсэн Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллага, тэдгээрийн урсгалын талаар шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын А/199 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллагуудад шалгалт хийв.

  Уг шалгалтанд Баян-Өлгий аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ислам шашны 7 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн зүгээс өөрийн байгууллагуудын харъяа нийт 55 сүм, хийд, шашны сургалт явуулдаг сурагчдын дотуур байр, 126 лам, санваартан, багш, ажилтнуудын судалгааг гаргаж өгсөн. Үүнээс гадна буддын шашны 1 сүм, христийн шашны 1 төв үйл ажиллагаа явуулж байна.

  Нийт шашны чиглэлийн байгууллагууд, тэдгээрийн харъяа сүм, хийдүүдийн албан ёсны зөвшөөрөл, лам, санваартны тоо, шашны чиглэл урсгалтай биечлэн шалгалт танилцсан ба тухайн байгууллагуудын болон тэргүүний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, санхүүгийн холбогдолтой бичиг баримт, гадаад харилцаа, холбогдох бичиг баримтуудыг гаргуулан авч, орлогын эх үүсвэр, зохион байгуулдаг арга хэмжээ, хурал цуглааны талаар харилцан ярилцах хэлбэрээр судалгааг явууллаа.
- Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 30 дугаар тогтоолоор баталсан "АСЕМ"-ын дээд хэмжээний уулзалтыг угтаж баталсан тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд 2016 оны 04 дүгээр сараас эхлэн аймгийн МХГазар, ЦГазар, ОБГазар болон ТГазрын дарга нарын хамтран баталсан удирдамжын дагуу дээрх байгууллагуудын ажилтнуудын хамт тэсрэх бодис ашигладаг 4 ААН-д үзлэг шалгалт хийсэн ба үзлэгээр доорх зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:
- 2 байгууллагын агуулахад чанарын шаардлага хангаагүй, ашиглах хугацаа хэтэрсэн 32477м ОШП буюу гал дамжуулах шижим, 6750ш энгийн капсюль, 2204 ширхэг цахилгаан капсюль, 10м ДША зэрэг бодисууд хадгалагдсан байна. Дээрх байгууллагуудад хяналт хийсэн байгууллагуудын зүгээс хугацаа хэтэрсэн бодисуудыг холбогдох байгууллагуудын хяналтын доор устгуулахаар хамтарсан албан шаардлага хүргүүлсэн ба биелэлтийг хянан ажиллаж байна. Дээрх байгууллагуудыг 2.22 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 2 байгууллага "Дунд" 2 байгууллага "Бага" эрсдэлтэй үнэлэгдлээ.
- Цагааннуур боомтод хийх хяналт шалгалтыг сайжруулах, хүнсний аюулгүй байдал, хуулийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний дагуу Тирлик захын гадна орчинд ил задгай хүнсний худалдаа хийж байгаа иргэдэд ЭМБСХХААХ-ийн холбогдох байцаагч нартай хамт хяналт шалгалт хийж, холбогдох хуулиудаар зөвлөмж, мэдээлэл хүргүүлэн ажилласан. ОХУ-аас Цагааннуур боомтоор хууль бус хүнс импортлон худалдаалж байгаа иргэдийн судалгааг гаргаж хилийн боомтод ажиллаж байгаа МХГ-ын байцаагч нарт хүргүүлж, хууль бусаар хүнс импортлох зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллахыг байцаагч нарт үүрэг болгож ажиллаж байна.

2016 оны 1-р улиралд болон 4-р улиралд Цагааннуур боомтоор импортлогдсон бодис бараа бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийхэд Засгийн Газрын 173-р тогтоол, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 23-р зүйлийн 23.1.4, 23.2, 29-р зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5-р зүйлийн 5.8 дахь заалт, Эм эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн 15.9-дэх заалтууд зөрчигдсөн 90 гаруй зөрчил дутагдал илэрсэн. Хяналт шалгалтаар нийтдээ импортын мэдэгдэлгүй хориглосон бараа болох хууль бус эм тариа, архи импортолсон, хязгаарласан бараа болох өндөг импортлосон зэрэг зөрчил илэрсэн.

Авсан арга хэмжээ:

Дээрх гарсан зөрчлийг арилгуулах үүднээс МХГ нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудын холбогдох зүйл заалтыг үндэслэн 1280.0 мянган төгрөгийн торгууль, шийтгэвэр ногдуулан 100%-ийн барагдуулалттай ажилласан. Мөн МХГ-ын улсын байцаагчийн зөрчил арилгуулах 19 заалт бүхий 9 албан шаардлага, 54 бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг саатуулах, хураах, буцаах, устгах актуудыг үйлдэн улсын хилээр нэвтэрсэн бараа бүтээгдэхүүндхяналт шалгалт хийж ажиллаж байна.

4-р сард экспортлогч улсын бичиг баримтгүй 1800 ширхэг өндгийг саатуулан, экспортлогч орон руу буцааж, 1 ААН импортын мэдэгдэлгүй 20 тн сонгино оруулж ирсэн тул 50000 төгрөгийн шийтгэвэр, 1 иргэний гар тээшин дэх 24 ширхэг даралт бууруулах цай - био бэлдмэлийг илрүүлж хураж авч 150000 төгрөгийн шийтгэвэр тус тус оногдуулан ажилласан байна.

Хууль бусаар эм согтууруулах ундаа түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн оруулахгүй зөрчлийг газар дээр нь таслан зогсоож ажиллаж байна.

- Жилээр, улирлаар эрүүгийн нөхцөл байдлын судалгаа гарган, дүн шинжилгээ хийж жилээс жилд өсөх хандлагатай, харьцангуй буурахгүй байгаа гэмт хэргүүдэд судалгаа хийж цаашид авах арга хэмжээ, зорилтыг тодорхойлж байна. Энэ жил бусдын эд хөрөнгийг хулгайлсан хэргийг үйлдсэн Х, А, С нарт холбогдох эрүүгийн хэргийг Дэлүүн сумын ард иргэдийн дунд "Нээлттэй" шүүх хуралдааныг зохион байгуулж ажиллав.
- 9 дүгээр сарын 01-ний өдрийг угтаж сургуулийн бага ангийн сурагчдад "Бид зам, тээврийн осол зөрчил, түүний улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох явдлыг хэрхэн бууруулж, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?" сэдэвт уриалга гаргаж аймгийн хэмжээний бүх сургуулийн сурагчдад хүргүүлэн ажиллав.
- Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг, гудамж талбай, олон нийтийн газрыг болон сэжигтэй этгээд, байр байгууламжийг хяналтанд авах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хууль хяналтын (Аймгийн ГХУСАЗЗ-ийн гишүүн байгууллага) болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 6 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцож ажиллав.

  Сумдад архидан согтуурах явдлыг багасгах зорилгоор аймгийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар захирамжаар батлагдсан "Архины хамааралтай иргэдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх" клубийн гишүүдтэй хамтран нийт 104 хүнд зөвлөгөө өгч ажиллав.
- "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 17

дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн төвд мал, махны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Малын зах", мах зардаг "Тирлик", "Көк базар" зэрэг захуудад тогтмол хяналт шалгалт хийж ажиллаж байгаагаас өдөр, оройн эргүүлд томилогдсон алба хаагч нар мал, мах ачиж ирж буй тээврийн хэрэгслүүдийг тогтмол шалгалт явуулан ажиллаж байна.

Сургалт, сурталчилгааны чиглэлээр

Аймгийн ИТХ-ын www.bayan-olgii.khural.mn сайтад болон фейсбүүкийн "Баян-Өлгий аймгийн ГХУСАЗСЗөвлөл" хуудсанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион явуулсан ажил, арга хэмжээний талаар мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна.

Орон нутгийн радио, телевизээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 35 удаагийн сэрэмжлүүлэг, нийтлэл, 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтэд хүргэх ажлыг оновчтой зохион байгуулан ажиллав.

- ЕБС-ийн сурагч бүр өөрийн эрх, үүргээ мэдэх, илтгэх, мэтгэлцэх ур чадвараа сайжруулах, аливаа эрх нь зөрчигдөхөөс өөрийгөө болон үе тэнгийнхнийгээ хамгаалж чадахуйц чадвар эзэмшүүлэх зорилгоор аймгийн хувийн хэвшлийн сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд "ХҮҮХДИЙН ЭРХ ҮҮРЭГ" сэдэвт мэтгэлцээний тэмцээнийг зохион явуулав.

  Уг тэмцээнд нийтдээ 8 баг уран ухаанаа сорин мэтгэлцэж Эмпати төвийн "Язгууртан" баг Тэргүүн байр, Заид БДС-ийн "Гэрэлт цох" баг хоёрдугаар байр, Эмпати төвийн "Шилтэнгүүд" баг гуравдугаар байр, Дарын сургуулийн "Тэмүүлэл" баг тусгай байр тус тус эзлэв.
- Аймгийн ГХУСАЗСЗөвлөл, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс хамтран аймгийн төвийн ЕБС-ын 9-12-р ангийн 960 хүүхдэд "ХОРТ ЗУРШИЛГҮЙ ОРЧИНД АМЬДАРЦГААЯ" сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулав. Сургалтанд сургуулийн ГХУСАЗСЗөвлөлийн гишүүд, нийгмийн ажилтануд болон бусад багш нар идэвхтэй оролцож сургалтыг мэргэжлийн эмч нар болон хүүхдийн байцаагчид амжилттай заав. Хүүхдүүд өөрсдийн сонирхсон асуултуудад хариулт аван ихэвчлэн хөвгүүд тамхи татаж байгааг нь хэлж түүний хор уршгийн талаар мэдээлэл авч, санал бодлоо солилцов.
- Мөн аймгийн төвийн ЕБС-ийн сурагчдын дунд "ХҮҮХДИЙН ДУУ ХООЛОЙ" сэдэвт өдөрлөгийг зохион байгуулав. Уг өдөрлөгийн зорилго нь эцэг, эх сурган хүмүүжүүлэгч, сурагч нарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ сахин биелүүлэх, насанд хүрээгүй хүмүүсээс согтууруулах ундаа болон утаат тамхи хэрэглэх, хорт зуршлын улмаас хүүхдийн боловсрол, хүмүүжил, ёс суртахуун, нийгэмшихэд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг иргэд, олон нийтэд энгийн бөгөөд хялбар арга, хэлбэрээр сурталчлан таниулах явдал юм.





Өдөрлөгийн үеэр сургууль бүр удирдамжийн дагуу хариуцсан сурталчилгааны ажлын чиглэлээр соггуууруулах ундаа болон утаат тамхи, цахим тоглоом, хорт зуршил бусад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгаа зохион байгуулж "Архи бидний сонголт биш" уриан доор аймгийн төв замаар жагсаав.

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, шинэчлэн найруулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах зорилгоор Баян-Өлгий аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газар, Дэлхий зөн ОУБ, жолооны авто сургуулиудтай хамтран хүүхдийн цэцэрлэгүүдийн ахлах бүлгийн хүүхэд, багачуудын дунд "БЯЦХАН ЦАГДАА-2016" тэмцээнийг 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион явуулав.





Уг тэмцээнд аймгийн төвийн хүүхдийн цэцэрлэгүүдийн ахлах бүлгийн хүүхэд, багчууд амжилттай оролцож,

Нэгдүгээр байрыг - Өлгий сумын 11 дүгээр цэцэрлэгийн хүүхэд багачууд

Хоёрдугаар байрыг - Өлгий сумын 10 дугаар цэцэрлэгийн хүүхэд багачууд

Гуравдугаар байрыг - Өлгий сумын 5 дугаар цэцэрлэгийн хүүхэд багачууд

Тусгай байрыг - Өлгий сумын 1 дүгээр цэцэрлэгийн хүүхэд багачууд тус тус эзлэв.

- Жил бүр мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг хангах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, алба хаагч нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт уулзалт, зөвлөгөөн бүсчилсэн байдлаар улсын хэмжээнд зохион байгуулагддаг билээ.

  Зөвлөгөөнийг ЦЕГ, Говь-Алтай аймгийн ГХУСАЗЗөвлөл, аймаг дахь Цагдаагийн газар хамтран зохион байгуулсан бөгөөд Завхан, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгуудын цагдаагийн газрын удирдлагууд тус чиглэлээр ажилладаг цагдаагийн алба хаагчид болон аймгуудын

  Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажилтнууд оролцов.

- "Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь" сэдэвт баруун бүсийн ГХУСАЗСЗөвлөлийн болон цагдаагийн газруудын алба хаагчдын нэгдсэн эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохион байгуулагдлаа

  Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Баян-Өлгий аймгийн ГХУСАЗСЗөвлөл, аймаг дахь Цагдаагийн газар

хамтран зохион байгуулсан бөгөөд Завхан, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгуудын Цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, тус чиглэлээр ажилладаг цагдаагийн алба хаагчид болон аймгуудын ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗөвлөлийн ажилтнууд оролцлоо.

- Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийг хориглоход хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл аймгийн ГБХЗХГ-тай хамтарч "Нэг санаачилга - Нэг ажил" үндэсний аянг тус аймгийн ЕБС-ын дунд амжилттай зохион байгууллаа.

  Тус аянд 14 сургууль оролцож, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт тайлангаа ирүүлж, үйл ажиллагаагаа танилцуулсны үр дүнд

  - Өлгий сумын 1-р бүрэн дунд сургууль - 1 дүгээр байр
  - Өлгий сумын 2-р бага сургууль - 2 дугаар байр
  - Өлгий сумын 4-р бүрэн дунд сургууль - 3 байр
  - Бастама бүрэн дунд сургууль, Зайд бүрэн дунд сургууль, Толбо сумын бүрэн дунд сургууль тусгай байр тус тус эзэллээ.
- АТГ-ын ажлын хэсэг манай аймагт ажиллах үеэр аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн гишүүдийн оролцоотойгоор Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, төрийн албанд олон нийтийн тавих хяналтыг сайжруулах чиглэлээр анхаарах ёстой асуудал, энэ чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлын талаар сургалт зохион байгуулагдлаа.
- Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 34 дүгээр тогтоолоор батлсан "Иргэдийн нийтийн эргүүл ажиллуулах журам"-ын хэрэгжилтийг хангах, аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн амар тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Иргэдийн нийтийн эргүүлийг аймгийн ГХУСАЗСЗ, аймаг дахь Цагдаагийн газар хамтран хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Баян-өлгий аймгийн 2016 оны 12 дугаар сарын эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээ

Гэмт хэргийг ангилалаар авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэтэй харьцуулахад хөнгөн, хүнд гэмт хэргийн гаралт 17.4-2.7 дахин өсч, хүндэвтэр гэмт хэргийн гаралт 33.6%-аар буурч, онц хүнд гэмт хэрэг энэ сард бүртгэгдээгүй.

Үүнд: бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 44.4%-аар, үүнээс: иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 38.5%-аар, мал хулгайлах гэмт хэрэг 61.5%-аар, залилан мэхлэх гэмт хэрэг 50%-аар, танхайрах гэмт хэрэг 33.3%-аар, бусад гэмт хэрэг 18.6%, хүүхэд оролцсон гэмт хэрэг 45.4%-аар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 45.4%-аар тус тус буурч, бусдын бие махбодид санаатай гэмтэл учруулах гэмт хэрэг 27.0%-аар, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 50%-аар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 33.3%-аар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.1%-аар, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг 40%-аар, бусдын өмчийн ашиглалын гэмт хэрэг 3.5 дахин, хүчиндэх гэмт хэрэг 3 дахин, тээврийн хэрэгслийг хулгайлах гэмт хэрэг 2 дахин өсч, албан тушаалын гэмт хэрэг мөн үеийн түвшинд байна.

Нийт гэмт хэрэг 281 бүртгэгдсэн, илрүүлэлт 88.7%-тай байна.


Суманд бүртгэгдсэн гэмт хэрэг:

2016 оны 12 дугаар сард Алтай суманд 12, Алтанцөгц суманд 13, Баяннуур суманд 23, Бугат суманд 16, Буянт суманд 12, Булган суманд 4, Дэлүүн суманд 7, Улаанхус суманд 25, Ногооннуур сум 15, Цагааннуур тосгон 12, Сагсай суманд 11, Цэнгэл суманд 19, Толбо суманд 5, Өлгий сумын төвд 107 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

6. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ:

1. Гэмт хэрэг, зөрчилд хамгийн ихээр ажилгүй хүмүүс өртөж байна. Иймд ажилгүйдлийг бууруулах нь урьдчилан сэргийлэх хамгийн том алхам гэж үзэж байна.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сумдын удирдлагууд, иргэд, ААН, байгууллагын оролцоо, идэвх, уялдаа холбоо сул байна.
3. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсөв, хөрөнгө бага, сумдын урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд батлагдсан төсөв, хөрөнгө мөнгө огт байхгүй байна.
4. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажилтнуудад чиглэгдсэн мэргэшүүлсэн сургалт сүүлийн жилүүдэд зохион байгуулагдахгүй байна.
5. Аймгийн ГХУСАЗСЗ-ийг сургалт, сурталчилгааны гарын авлага, брошур, шторк, богино хэмжээний нэвтрүүлэг, кино зэрэг материаллаг баазаар хангах асуудал бүр зогсонги байдалд байна.

БАЯНХОНГОР АЙМАГ



4. БАЯНХОНГОР АЙМАГ

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, НУТАГ ОРОН, САЛБАРЫН ОНЦЛОГ

Баянхонгор аймаг нь 1941 онд байгуулагдсан, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 7,8 хувийг эзэлдэг газар нутгийн хэмжээгээрээ Өмнөговь, Говь-Алтай, Дорнод аймгийн дараа улсад дөрөвт ордог том газар нутагтай аймгийн нэг.

Аймаг байгуулагдсан үеэсээ Бөмбөгөр, Баян-Овоо, Галуут сумдын нутагт шилжиж, одоогийн оршин байгаа Түйн голын хөвөөнд 1961 оноос суурьшсан.

Баянхонгор аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 20 сум, 104 багтай, 2016 оны байдлаар 83,603 хүн амтай.

Тус аймгийн нутаг дэвсгэр Монгол орны хангай, тал хээр, говь, цөл бүхий газар зүйн 4 муж, байгалийн 3 бүс, цаг агаарын 2 бүсийг хамардгаараа онцлогтой.

Тус аймаг Монгол орны баруун урд хэсэг байрлаж Өвөрхангай, Өмнөговь, Говь-алтай, Завхан, Архангай аймгуудтай нутаг залган, БНХАУ-тай 140 км нутгаар хиллэдэг, 115 978 км² газар нутагтай.

Аймгийн төв Баянхонгор хот нь нийслэл Улаанбаатар хотоос 630 км орчим алслагдсан ба аймгийн ихэнх нутаг нь далайн түвшинээс дээш 1000-1400 метрт оршдог ба хамгийн нам цэг нь Эхийн гол 720 м, хамгийн өндөр цэг нь Говь-Алтайн нурууны оргил "Их Богд" уул 3957 мөндөрт өргөгдсөн байдаг.

Баянхонгор аймгийн газар нутгийн 10%-ийг ой мод, 30%-ийг тал хээр, 50%-ийг говь, цөл эзэлдэг.

Баянхонгор хот нь 1961 онд байгуулагдсан, засаг захиргааны 9 багтай, 6.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй 40 гаруй мянган хүн амтай Монгол Улсын хангайн баруун бүсийн эрчимтэй хөгжиж байгаа аймгийн төвүүдийн нэг бөгөөд аймгийн гол засаг захиргаа, үйлдвэр, үйлчилгээ, соёл боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын төвүүд байрладаг.

Баянхонгор аймгийн гэмт хэрэгт холбогдогчдын тоон мэдээг судалж үзэхэд гэмт хэрэгт холбогдогчдын 90% нь эрэгтэйчүүд, 10 орчим хувь нь эмэгтэйчүүд байгаа нь улсын дундажтай адил байна.

Түүнчлэн, гэмт хэрэгт холбогдогчдын 15% нь 18 хүртэлх настай, 57% нь 18-35 хүртэлх насны залуучууд, 35-45 насны хүмүүс 16%, 50-с дээш насны хүмүүс 12% байгаа ба судалгааны дүнгээс харахад залуучууд голчлон холбогдсон нь тэдний эрх зүйн ухамсар соёл дорой, хууль эрх зүйн мэдлэг муу, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ бага, бие махбодын хувьд гэмт хэрэг үйлдэх илүү боломжтой байдаг зэрэгтэй холбоотой.

Гэмт хэрэгт холбогдогчид нь ихэвчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй, орлого багатай, нийгэмд ашигтай хэлхээ холбоо сул, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ бага байдаг бөгөөд гэмт хэрэгт холбогдсон 250 хүний 67% нь ажилгүй, нийгмийн эмзэг давхаргын иргэд байсан бол 23% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, тодорхой орлоготой хүмүүс байгаа бол үлдсэн 10 орчим хувь нь төсвийн болон ААН, байгууллагад ажилладаг хүмүүс байв.

Зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлодог хүмүүсийн тоо зуны дулаан цагт эрс нэмэгдэж харин өвлийн цагт багасдаг, аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийг нөхөрлөл хэлбэрт оруулж хяналтад оруулах, тэднээр нөхөн сэргээлт хийлгэх ажлыг зохион байгуулах цаг нь болжээ.

Гэмт хэрэг, зөрчил нь цаг хугацааны хувьд байнгын болон улирлын шинжтэй гардаг гэж хуваагддаг. Тус аймагт үйлдэгддэг байгаль орчны эсрэг гэмт хэрэг гэхэд л өвлийн цагт багасаж, хуурайшилтын үед буюу хавар 5-6 сард, намар 9-10 сард болон барилгын ажил эхлэх үед гэмт хэргийн гаралт ихээхэн нэмэгддэг. Ялангуяа түлшний хэрэгцээ нэмэгддэг 10 сараас 12 сарын хооронд үйлдвэрлэлийн болон түлшний зориулалтаар мод бэлтгэх нь нэмэгддэг.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүмүүс нь ихэвчлэн хууль, дүрмийг эс тоомсорлодог, хууль эрх зүйн мэдлэг дорой, архи дарсанд автагдсан, шунахай болон танхайрах сэдэлтээр зан төлөвийн онцлог нь илэрч байна. Тэдний олонх нь хууль зөрчиж байгаагаа мэддэг, ухамсарладаг бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн шалтгаанаа амьдрал ядуу байна, хулгай дээрэм хийсэн биш яадаг юм гэсэн сэтгэхүйгээр үйлдэл, хор уршигтаа хандаж байлаа.

Түүх сөхвөл тус аймагт 1990 онд 205 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2004 онд энэхүү үзүүлэлт 343 болж 138 хэрэг буюу 1.5 дахин нэмэгджээ.

1990-1994 онд Баянхонгор аймагт 1381 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол дунд 5 жилд буюу 1995-1999 онд 2101 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх 5 жилээс 720 хэргээр буюу 1.5 дахин өсчээ. 2000-2004 онд нэлээд нааштай өөрчлөлт гарч өмнөх 5 жилээс, ялангуяа 2001 оноос гэмт хэргийн гаралт буурч 2066 болсон байна.

Баянхонгор аймаг дахь гэмт хэргийн үзүүлэлт 1990-1994 онд он дараалан прогресс хандлагаар өсөн нэмэгдэж, 1997, 2001 онд оргил цэгтээ хүрсэн байна.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Тус аймагт 2010-2016 онд нийт 2696 гэмт хэрэг бүртгэгдсэн ба жилд дунджаар 347-436 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 2011, 2012 онуудад гэмт хэргийн гаралт 2010 оноос 89-100 нэгжээр буурсан бол 2013, 2014 онд гэмт хэргийн гаралт өсөж, харин 2015, 2016 онуудад гэмт хэргийн гаралт 2010, 2013, 2014 онуудтай харьцуулахад 76-82 нэгжээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, өмчийн эсрэг гэмт хэрэг, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг голлон үйлдэгддэг гэж тоо баримт харуулж байна.

Тухайлбал, 2005 онд хүний амь нас эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 129 бүртгэгдэж байсан бол 2006 онд 164, 2007 онд 154, 2008 онд 123, 2009 онд 152, 2010 онд 128, 2011 онд 69, 2012 онд 78, 2013 онд 117, 2014 онд 106, 2015 онд 113, 2016 онд 106 хэрэг бүртгэгдсэн байна.

Эдгээр гэмт хэргээс хүний амь насыг хохироосон гэмт хэрэг 1 жилд 4-9 бүртгэгдэж байгаа бол бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг 2006 онд 116, 2007 онд 138, 2008 онд 112, 2009 онд 142, 2010 онд 114, 2011 онд 63, 2012 онд 67, 2013 онд 105, 2014 онд 93, 2015 онд 103, 2016 онд 92 удаа тус тус бүртгэгдсэн байна. Тус аймгийн хувьд 2015 онд 360 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2016 онд 356 гэмт хэрэг бүртгэгдэж 0.4%-аар буурчээ.

2015 онд 430 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаснаас 247 хэрэгт мөрдөн байцаалт, 183 хэрэгт хэрэг бүртгэлт явуулсан байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь хэмжээ 71.3%, 2016 онд 74.4%-тай байж илрүүлэлт 3.1%-аар өссөн дүн мэдээ гаргасан.

Илрээгүй гэмт хэргийн тоо 2015 онд 25 байсан бол 2016 онд 30 болж нэмэгдсэн, гэмт хэрэг бүртгэгдэж үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэргийн тоо 2015 онд 87 байсан бол 2016 онд 117 болж 34.5%-аар өсчээ.

Гэмт хэргийн ангиллын хувьд хөнгөн гэмт хэргийн тоо 2015 онд 169 байсан бол 2016 онд 180 бүртгэгдсэн ба үүнээс 2015 онд 22 хөнгөн гэмт хэрэгт, 2016 онд 17 хөнгөн гэмт хэрэгт ял сонсгосон ба гэмт хэргийн илрүүлэлт нь 2015 онд 68.8% байсан бол 2016 онд 54.8% болж 14.4%-аар буурчээ.

Баянхонгор аймагт 2015 онд хүндэвтэр гэмт хэрэг 158 гэмт хэрэг бүртгэгдсэний 38 хэрэгт, 2016 онд 159 хэрэг бүртгэгдсэнээс 69 хэрэгт ял сонсгож хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлжээ.

Тус аймагт 2015 онд хүнд гэмт хэрэг 29 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 2 хэргийг, 2016 онд 1 хэргийг прокурорын хяналтын шатанд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, илрүүлэлт 66.7%-тай байсан бол онц хүнд гэмт хэрэг 2015 онд 4, 2016 онд 5 бүртгэгдэж тус тус шийдвэрлэгдсэн байна.

Тус аймагт 2015 онд 401 хүн, 2016 онд 377 хүн гэмт хэрэгт холбогдож байсан бол хохирогчийн тоо 2015 онд 383, 2016 онд 369 байсан ба үүнээс нас барсан хохирогчийн тоо 2015 онд 12, 2016 онд 27, гэмтсэн хохирогч 2015 онд 180, 2016 онд 171 байжээ.

Баянхонгор аймагт 2005 онд хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт 4, 2006 онд 11, 2007 онд 6, 2008 онд 10, 2009 онд 7, 2010 онд 16, 2011 онд 3, 2012 онд 5, 2013 онд 6, 2014 онд 8, 2015 онд 5, 2016 онд 11 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлд заасан хүчиндэх гэмт хэрэг энэ төрлийн гэмт хэргийн 90%-ийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Хохирлын тухайд 2016 онд 469.2 сая төгрөгийн хохирлоос 344.5 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн бол 2016 онд 700.6 сая төгрөгийн хохирлоос 536.6 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Баянхонгор аймагт 2015 онд 180 хүнд холбогдох 169 эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байсан бол 2016 онд 182 хүнд холбогдох 167 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх оныхоос 1,2%-аар буурсан үзүүлэлт.

Шүүхээс хэргийг мөрдөн байцаалтад буцаасан 36 хэрэг, хэрэг бүртгэлтэд буцаасан 4 хэрэг байна.

Өмчийн эсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгддэг гэмт хэргийн 30 орчим хувийг эзэлдэг бөгөөд 2005 онд 157, 2006 онд 111, 2007 онд 137, 2008 онд 134, 2009 онд 121, 2010 онд 157, 2011 онд 123, 2012 онд 147, 2013 онд 197, 2014 онд 167, 2015 онд 113, 2016 онд 108 гэмт хэрэг бүртгэгдсэний 80 орчим хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, үлдсэн хувийг дээрэмдэх, залилан мэхлэх гэмт хэргүүд байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд улс орны хэмжээнд тулгамдсан асуудал болоод байгаа ажилгүйдэл, ядуурал, архидан согтууралт голлох шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж байна.

Орон нутгийн удирдлагууд байгалийн нөөц баялгийг ашиглах, төлбөр хураамж авах сонирхолтой атлаа төвлөрсөн хөрөнгийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулахаас аль болох татгалзаж шаардлагагүй зардалд их хэмжээгээр зарцуулдаг. Үүнд хөшөө дурсгал босгох, ойн баяр, наадам тэмдэглэх, шагнал урамшуулал зэрэгт их хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

Санхүүжилт хангалтгүй байгаагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх далайцтай арга хэмжээ явуулж чадахгүй, алив төсөл, үйл ажиллагаа нь санхүүжилтгүйгээр урагш ахихгүй нь тодорхой учир төсвийн 10 хүртэлх хувийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулж байж тодорхой үр дүнд хүрнэ.


Тус аймагт гэхэд дунджаар 1 жилд 400 орчим гэмт хэрэг бүртгэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулсан байхад 30 гаруй хувийг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэж бусдыг нь шүүхийн өмнөх шатанд түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох зэргээр шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Тус аймгийн гол асуудал болоод байгаа хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь гэмт хэрэгтэй тэмцэх ажил улсын хэмжээний нэгдсэн бодлого, чиглэлгүй явж ирсэн, иргэдийн цалгар назгай байдал болон ААН, байгууллагуудын удирдлагын зохион байгуулалт сул, харуул манааны сонор сэрэмжгүй, дэг журамгүй явдал газар авсан, гэмт хэрэгтнүүд зохион байгуулалтад орж ул мөрөө нуун далдлах, гэмт хэрэг үйлдэж орлого олох нь зарим этгээдийн амьжиргааны эх сурвалж болсон, эрүүгийн хариуцлага гарцаагүй бус, гэмт хэргийн илрүүлэлтийн түвшин доогуур, хариуцлага сул буюу ял шийтгэл хөнгөн зэрэг нь нөлөөлж байна.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Баянхонгор аймгийн хэмжээнд 3405 гомдол, мэдээлэл Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэнээс 1050 нь гэмт хэргийн шинжтэй гомдол, 1991 нь захиргааны зөрчлийн шинжтэй байжээ. 2010-2016 оны хугацаанд тус аймагт нийт 66218 захиргааны зөрчил илрүүлэн захиргааны арга хэмжээ авч ажилласан байна.

График VIII.4.1. Он тус бүрээр нь үзүүлбэл:



Энэ хугацаанд нийт 12973 хүн саатуулагдаж, 2485 хүн баривчлагдсан байна.

График VIII.4.2



График VIII.4.3



2010-2015 оны хугацаанд нийт 3293 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жилийн хугацаатай хасаж захиргааны арга хэмжээ авсан бол "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль" 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээс хойш нийт 769 жолоочийг торгож, эрхийг нь 6 сараас 2 жилийн хугацаатай хассан байна. Эдгээрийг жил бүрээр нь дэлгэрэнгүй үзвэл:

График VIII.4.4.



График VIII.4.5.




ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

2010-2016 онд нийт 2696 гэмт хэрэг бүртгэгдсэний 273 буюу 10,1%-ийг ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байна.

2011-2016 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт нийт 231 гэмт хэргийг үйлдэгдсэн сум, багаар нь авч үзвэл Баянхонгор сумын "Номгон" 1 дүгээр багт 36 буюу 15,5%, Өлзийт суманд 23 буюу 9,9%, Баян-Овоо суманд 21 буюу 9% нь тус тус үйлдэгдсэн байна.

График VIII.4.7.



Хүснэгт VIII.3.1.

№	Сумдын нэр	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Бүгд
1	Баацагаан	1	1		3	1		6
2	Баян-Овоо	3	5	5	2	3	3	21
3	Баянговь		1		1	1	1	4
4	Баянлиг	1	1					2
5	Баян-Өндөр	1			1			2
6	Баянцагаан	1		2				3
7	Богд		1		1	1	1	4
8	Баянбулаг				1			1
9	Бөмбөгөр	1	1	1	3	1	1	8
10	Бууцагаан		1		3			4
11	Галуут		2	2	3	1		8
12	Гурванбулаг	1	1					2
13	Жаргалант	1	2			2		5
14	Жинст	1				1		2
15	Заг	1	1		1	1		4
16	Өлзийт	1	4	9	3	2	4	23
17	Хүрээмарал					1		1
18	Шинэжинст	1		1				2
19	Эрдэнэцогт			2	2			4
20	1 дүгээр баг	7	11	3	10	1	4	36
21	2 дугаар баг	1	3	4	1			9
22	3 дугаар баг		10	1	4	2	1	18
23	4 дүгээр баг	1	3	2		2		8
24	5 дугаар баг	5	3	2	2	1	2	15
25	6 дугаар баг		1		3		1	5
26	7 дугаар баг	2	3	2	3	1		11
27	8 дугаар баг	1	2					3
28	9 дүгээр баг	БХР-13	2	2	1		2	7
	Бүгд	44	59	38	48	22	20	231

Гэсэн хэдий ч Баян-Овоо, Өлзийт сум, "Номгон" 1 дүгээр багт ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн гаралт сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг үйлдэгсдийн 94% нь эрэгтэйчүүд, 6% нь эмэгтэйчүүд байгаа бол насны хувьд 18-30 хүртэлх насны залуус энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн 60 орчим хувийг, 25% нь 30-40 насныхан байна.

Цаг хугацааны хувьд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг нь байнгын шинжтэй учир улирал харгалзахгүй үйлдэгддэг, ихэвчлэн 22-06 цагийн хооронд үйлдэгдэх нь илүү байдаг.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг үйлдэж байгаа хүмүүс нь ихэвчлэн хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрмийг эс тоомсорлодог, хурд хэтрүүлдэг, хууль эрх зүйн мэдлэг дорой,

бусдыг хүндэтгэх ёс суртахуун төлөвшөөгүй, хувиа хичээсэн аминчхан сэтгэлээр үйлдэл, эс үйлдэхүй болон хор уршигтаа хандсан онцлогтой.

Боловсролын хувьд судалж үзэхэд 45% нь бүрэн бус дунд боловсролтой, 35% нь бүрэн дунд боловсролтой, 10% нь тусгай дунд болон дээд боловсролтой, 5% нь боловсролгүй, бичиг үсэг мэддэггүй хүмүүс байв.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас тус аймагт 2016 онд зам тээврийн осол хэрэг 19 бүртгэгдэж, 16 хүн хүнд, хөнгөн гэмтэж, 2 хүний амь нас хохирсон, осол хэргийн улмаас 5 хүүхэд хохирч, 4 хүүхэд хүнд, хөнгөн гэмтэж, 1 хүүхэд нас барсан байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар нь аймгийн төв болон улсын чанартай авто зам дээр голчлон үйлдэгддэг. ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нэг. Жолооч болон замын хөдөлгөөнд явганаар оролцож байгаа иргэдийн хөдөлгөөний соёл, ухамсар доогуур, хохирогчийн хэт хайхрамжгүй, хууль дүрэм зөрчсөн зан үйл голлох шалтгаан болж байна.

Нүүдэлчин ахуйн уламжлалтай ард түмний зан төлөвтэй холбоотойгоор бусдыг хүндэтгэдэггүй, хот хоорондын зам дээр байнга хурд хэтрүүлэн давхидаг жолооч нараас болж зам тээврийн осол буурахгүй байна.

Хоёр. Хохирогчийн хэт хайхрамжгүй байдал, зан үйл, замын хөдөлгөөний оролцогч гэдгээ ухамсарладаггүй. Автомашинтай ч, явган ч замын хөдөлгөөний оролцож байгаа хүн бүр хуулийн өмнө эрх тэгш. Гэтэл хохирогч иргэдийн хувьд гарцгүй газраар үл тоон гарах, хориглосон улаан гэрэл ассаар байхад дүрэм зөрчин гүйх, согтуугаар гуйвж дайван зам хөндлөн гарах зэргээр байнга хууль дүрэм зөрчиж байгаа бөгөөд тэдэнд замын цагдаа нар хариуцлага тооцдоггүй байдал нь бүр ингэж байх ёстой гэсэн хэвшлийг бий болгожээ.

Харин зам тээврийн осолд гэмтсэний дараа гэнэт эрхээ ухамсарлаж хохирогчийн дүрд тоглож зөвхөн жолоочийг буруутгаж мөнгө салгахыг оролддог үзэгдэл цөөнгүй байна.

Гурав. Жолооч нар бүрэн бус техниктэй замын хөдөлгөөнд оролцож байгаа явдал нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан болж байна.

Замын хөдөлгөөнд оролцож байгаа хөдлөх бүрэлдэхүүний 80 гаруй хувь нь хөгширсөн буюу 10-с дээш жил ашигласан, ашиглалтын хугацаа нь дууссан тээврийн хэрэгслүүдийг иргэд улсын хилээр оруулж ирэн худалдаж авч ашигласаар байна.

Дээр нь автомашины дугуйны хээ нь хэт элэгдсэн, өвлийн улиралд зуны дугуйтай явах, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчих, аюул тохиолдох үед зогсоох арга хэмжээ авч чадахгүй, гэрэл тохиргоо нь алдагдсан буюу зарим тохиолдолд гэрэл нь шатсан байхад хөдөлгөөнд оролцох, тоормосны шингэн багассан, тоормос сайн барихгүй байхад хөдөлгөөнд оролцох зэргээр хөдөлгөөний аюулгүй байдал зөрчигдөж осол гарсаар байна.

Дөрөв. Орон нутгийн замууд хэт нарийн, хагархай догол ихтэй, гэрэлтүүлэг байдаггүй, гэрлэн дохио байхгүй, зарим нэг нь эвдэрхий, явган хүний зам автомашины замтай заавал давхацдаг зэрэг нь осол гарах нэг шалтгаан болж байна. Хот төлөвлөлтийн бодлогоор дээрх асуудлыг шийдвэрлэх боломжтой бөгөөд тухайлбал нүхэн гарц, гүүр хийх замаар явган хүнийг машин замтай давхцуулахгүй байх, хөрөнгө мөнгө шийдвэрлэх замаар зам засварын ажлыг чанаржуулах зэргээр асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Тав. Судалгаанаас үзэхэд манай улс шиг зүүн гарын дүрэмтэй (жолооны хүрд нь зүүн талдаа байрлах ёстой) улсад эмх замбараагүй байдал газар авсны нэгэн жишээ нь буруу талдаа жолоодлоготой тээврийн хэрэгсэл улсын хэмжээнд нийт тээврийн хэрэгслийн 50 хувь, Улаанбаатар хотын хувьд 60 гаруй хувьд хүрчээ. Буруу талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл нь зам тээврийн осолд өртөх магадлал илүүтэй. Ялангуяа хот хоорондын зам дээр зүүн хүрдтэй автомашин жолоодож яваа жолооч нь өмнөх машиныг гүйцэж түрүүлэхийн тулд жолооч нь бүтнээрээ эсрэг урсгалд орж байж өмнөх замаа тодорхойлдог, өөдөөс нь автомашин хурдтай гарч ирсэн тохиолдолд буцаж эгнээндээ орж амжихгүй осолд орох нь цөөнгүй. Түүнчлэн зүүн хүрдтэй машины гэрлийн тусгал нь эсрэг зүгээс ирж байгаа автомашины жолоочийг гялбуулдаг нь ослын магадлалыг нэмэгдүүлж байгаа учир цаашид төрийн бодлогоор зүүн хүрдтэй автомашины импортыг хориглох, нэгэнт орж ирсэн зүүн хүрдтэй автомашинуудын жолоодлогыг зүүн талд нь байрлуулахыг шаардаж болно.

Зургаа. Замын цагдаагийн алба, авто тээврийн газар, бусад хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоо сул, төрийн бус байгууллагууд болон иргэдийн хамтын үйл ажиллагаа тасарсан явдал энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил буурахгүй байх нэг нөхцөл болж байна.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажил нь зөвхөн нэг байгууллагын үүрэг биш бөгөөд төрийн бус байгууллага, иргэдийн дэмжлэг, оролцоог хангаж байж гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж чаддаг. Манай зарим замын цагдаагийн албан хаагч нар онц шаардлагагүй байхад жолоочийг зогсоож өө сэв эрэх, торгохыг оролдох зэрэг ухамсаргүй байдал гаргадаг ч бэлэн мөнгөөр торгохыг зогсоосноос хойш энэ байдал харьцангуй намжсан.

Долоо. Жолооч нар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох нь энэ төрлийн гэмт хэргийн бие даасан шалтгаан болж байна. Жолооч нар хот хооронд зорчихдоо хяналт шалгалт, цагдаа байхгүй гэж найдан уулын овоо бүр дээр шахам зогсож архидан согтуурч улмаар хурд хэтрүүлэх, эсрэг урсгалд явах, гүйцэж түрүүлэх журам зөрчих нь осол гарах нэг үндсэн шалтгаан болж байна.

Түүнчлэн жолооч нар нь замын хөдөлгөөний соёл эзэмшээгүй, ухамсар муутай, бие биенээ огт хүндэлдэггүй бөгөөд шөнийн цагаар гэрлээ шилжүүлдэг жолооч маш цөөн буюу зөрж өнгөрсөн автомашины 20-30% нь гэрлээ шилжүүлж бусад нь огт шилжүүлэхгүй байгаа нь бидний удаа дараагийн ажиглалтаар тодорхой байсан бөгөөд энэ нь шөнийн цагаар осол гарах нөхцөлийг бүрдүүлдэг.

Монгол Улсад жил дараалан орж ирж байгаа тээврийн хэрэгслийн тооны өсөлт, хотын доторх замын нөхцөл, багтаамж муу байгаа, замын хөдөлгөөний соёлд ахиц гараагүй зэрэг нөлөөлөх хүчин зүйлийг харгалзан үзвэл энэ төрлийн гэмт хэргийн тоо буурахгүй, харин ойрын 5 жилд өсөх магадлалтай. Иймд эхний 10 жилийн өсөлт нь нөхцөл байдал, нөлөөлөх хүчин зүйлүүдээсээ шалтгаалсан хэвийн өсөлт гэж үзэж байна. Харин сүүлийн жилүүдийн бууралт нь далд гэмт хэргийн өсөлттэй ч хамааралтай байх боломжтой. Учир нь замын хөдөлгөөнтэй холбоотой гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйлүүд, нөхцөл байдалд нь мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гараагүй байна.

ТАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ГХУСАЗСАЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Баянхонгор аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах болон

зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохион байгуулж, энэ ажилд иргэд, байгууллага, ААН, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлыг шуурхай, ил тод, хариуцлагатай, хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах зорилт дэвшүүлэн ажиллаж зарим үр дүнд хүрчээ.

ГХУСАЗСЗөвлөлөөс 2016 онд 4 бүлэг бүхий 27 ажил төлөвлөсөн бөгөөд зөвлөлийн гишүүдэд ажил үүргийн дагуу хариуцуулж, 80.0 сая төгрөгийг төлөвлөсөн 27 ажилдаа хуваарилан зохицуулах зөвлөлийн хурлаар батлаж зарцуулжээ. Тухайлбал,

- "Хуулиа дээдэлье" аяны хүрээнд хуулийн байгууллагуудтай хамтран "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь иргэн бүрийн үүрэг мөн" уриан дор нээлттэй өдөрлөгийг сумдад зохион байгуулсан;
- Баянхонгор аймгийн хэмжээнд залуу гэр бүлийн чуулган анх удаагаа "ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ" сэдвийн хүрээнд 2016 оны 03 дугаар сарын 02-10-ны өдрүүдэд зохион байгуулсан;
- Гэр бүл, хүүхдийн сайн сайхны төлөө, тэдний бүх талын хэрэгцээнд зориулан аюулгүй, хайрын орчныг бий болгоход гэр бүлүүдийг хөхүүлэн дэмжих зорилгоор "ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ" сургалтад төрийн болон ТББ-аас 50 хүн оролцуулж орон нутгийн сургагч багшаар бэлтгэж гэрчилгээ олгосон;
- Нийгмийн түншлэлийн багийн зөвлөгөөн "гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нийгмийн түншлэлийн багийн ажлын үр дүн, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" сэдвийн хүрээнд зохион байгуулагдлаа.
- Япон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай танилцаж, туршлага судаллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар ГХУСАЗСЗөвлөлийг 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсан зэрэг ажлуудыг хийсэн нь аймгийн хэмжээнд хийвэл зохих ажлууд хийж гүйцэтгэжээ.

ЗУРГАА. БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Хуулийн байгууллагын албан хаагч нарт зориулсан "Гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт нэгдсэн сургалтыг зохион байгуулсан.

ГХУСАЗСЗөвлөлөөс хийж буй урьдчилан сэргийлэх ажлын талаар "Өнөөгийн Баянхонгор" сонин, "Малчин" сэтгүүл, Хөгжлийн ертөнц "TV-10", "Баянхонгор", "Хонгор" телевизүүд болон www.bayankhongor.khural.mn цахим хуудсаар нийтэд мэдээлэл хүргэж байна.

- Аймгийн хэмжээнд Олон нийтийн цагдаагийн 28 ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж, хувцас формтой болгон ажиллуулж байна.
- Гарын хээний дардас, гэрэл зургийг "Папилон" санд оруулан бүртгэлжүүллээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ЕБС-ийн ахлах анги болон мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн нийт 832 сурагчийн гарын хээний дардас, гэрэл зургийг "Папилон" санд оруулан бүртгэлжүүллээ.

ДОЛОО. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Бүртгэгдсэн нийт 2696 гэмт хэргийн 1637 буюу 60,7% нь Баянхонгор суманд, 1059 буюу 39,3% нь бусад сумдад үйлдэгдсэн байна.

Баянхонгор суманд бүртгэгдсэн нийт 1637 гэмт хэргийн 623 буюу 23,1% нь "Номгон" 1 дүгээр багт, 246 буюу 9,1% нь "Дуурсах" 3 дугаар багт тус тус үйлдэгдсэн нь бусад багтай харьцуулахад гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татахуйц байна.

Баянхонгор аймгийн бусад сумдад үйлдэгдсэн 1059 гэмт хэргээс 153 буюу 14,4% нь Баян-Овоо суманд, 107 буюу 10,1% нь Галуут суманд, 103 буюу 9,7% нь Өлзийт суманд, 102 буюу 9,7% нь Бөмбөгөр суманд бүртгэгдсэн байгаа нь хамгийн их гэмт хэргийн гаралттай сум байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилд Өлзийт, Баян-Овоо сумдын гэмт хэргийн гаралт буурах хандлагатай байна.

Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж цагдаагийн байгууллагыг чадварлаг боловсон хүчин, орчин үеийн техник хэрэгслээр хангах зүй ёсны шаардлага тулгарч байна.


Түүнчлэн техникийн шинжтэй арга хэмжээ нь аймгийн төвийг бүхэлд нь камержуулах, улсын чанартай болон аймгийн төвийн гол замууд дээр пост байгуулж камержуулах, бод мал бүрийн чихэнд чип суулгах, айл бүр, автомашинтай иргэн бүр дохиолол тавиулах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх техникийн шинжтэй арга хэмжээг ашиглан гэмт хэргийн гаралтыг бууруулж чаддаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь зарим хууль зөрчих магадлалтай иргэдийн хууль бус үйл ажиллагаа буюу гэмт хэрэг үйлдэх сонирхлыг бууруулах, боломж, нөхцөлийг нь хаах зорилгоор тэмцлийн ажлын бодлого, тогтолцооны бүтцэд өөрчлөлт хийхэд чиглэнэ.

Илрүүлэх арга хэмжээний хүрээнд зөрчлүүдийг бүртгэх болон мэдээллийн менежментийг сайжруулах, статистикийн болон экологийн мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, хууль бусаар мод огтолж байгаа үйл ажиллагааг илрүүлэхэд сансрын хяналтын системийг ашиглах, ойн үйл ажиллагааны болон тээвэрлэлтийн хяналтыг бие даасан болгох, ой хариуцсан засаг захиргааны байгууллагуудын болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд санхүүгийн аудит явуулах зэрэг болно.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажил нь зөвхөн нэг байгууллагын үүрэг биш бөгөөд ТББ, иргэдийн дэмжлэг, оролцоог хангаж байж гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж чаддаг.

БУЛГАН АЙМАГ



5. БУЛГАН АЙМАГ

Булган аймаг нь газар тариалан, дэд бүтэц өндөр хөгжсөн төвийн бүсийн хойд хэсэгт орших бөгөөд 16 сум, 1 тосгон, 75 багтай 48531 км² газар нутагтай. Аймгийн төв Булган сум нь далайн түвшингээс дээш 1210 метр өндөрт, Улаанбаатар хотоос 318 км, агаараар 265 км, Сэлэнгэ, Төв, Орхон, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймаг болон ОХУ-ын Буриад улстай хиллэдэг.

Хангайн нурууны салбар бэсрэг уулс Хантай, Булган хан, Хан жаргалант, Дулаан хан, Намнан, Хутаг-Өндөр, Онгон сарьдаг, Сардиг бүтээл, Бөхөн шарын нуруу, Бүрэн хан, Могодын нуруу, Авзага хайрхан, Бүрэгхангай, Хөгнө хан, Лах баян, Өрхтэй, Баянзүрх, Баян-Агт зэрэг 2000 метрээс дээш өндөртэй 20 гаруй уул нуруутай. Сэлэнгэ, Орхон, Туул, Эг, Хануй, Харбух, Тарвагтайн тарни, Хангал зэрэг 388 гол горхи, 396 булаг, Хунт, Хульж, Хануй, Цагаан гол, Чин толгой зэрэг 30 орчим рашаантай. Байгалийн баялагт ашигт малтмалаас алт, мөнгө, зэс, молибден, хар тугалга, чулуун нүүрс, оюу, номин, болор, гантиг, боржин чулуу, барилгын төрөл бүрийн материал, элс хайрга, хүрмэн бай шохойн чулуу, зос, будаг элбэг.

Уур амьсгал нь эх газрын эрс тэс сэрүүвтэр чийглэг, 1-р сарын дундаж температур нь Булган хотын орчимд -22.8 хэм, 7-р сард 16.5 хэм, үнэмлэхүй дулаан нь 34.8 хэм, үнэмлэхүй хүйтэн нь -44.10, жилийн дундаж тунадас 324 мл боловч зарим жил 500 мл-с дээш байдаг. 2017 оны 1 дүгээр сарын байдлаар Хангал 23 см, Тэшиг 20 см, Бугат 18 см, Булган 15 см, Орхон 13 см, Баян-Агт, Сэлэнгэ, Хутаг-Өндөр 12 см, Баяннуур 9 см, Рашаант 8 см, Гурванбулаг 7 см, Сайхан 5 см, Дашинчилэн 4 см, Могод, Бүрэгхангай 3 см, Хишиг-Өндөр 2 см цас тус тус орсон байна.

Байгалийн аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын хувьд өнгөрсөн онд (2016 он) байгалийн аюулт үзэгдэл, осол 68 удаа гарч 7 хүн амь насаа алдаж, 40.1 мянган толгой мал амьтан хорогдож, объектын түймэр 24 удаа гарсан нь өнгөрсөн онтой харьцуулан үзвэл 33.3 хувиар, гал түймрийн улмаас учирсан хохирол 21.8% буюу 674.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ХҮН АМ ЗҮЙ

Хүн ам 2016 жилийн эцсийн байдлаар 61149 болсон өмнөх оноос 1135 хүн буюу 1.9%-аар өссөн. Үүнээс эрэгтэйчүүд 31077 болж өмнөх оноос 565 буюу 1.9%, эмэгтэйчүүд 570 буюу 1.9%-аар тус тус өссөн бол тус аймагт 1321 хүн шилжин ирж, 1662 хүн шилжин явсан нь ирсэн 249 буюу 23.2%-аар өссөн, шилжин явсан хүн 138 буюу 7.6%-аар буурсан байгаа нь тухайн аймгийн хүн амын өсөлтөд эерэг дүн гарч байна, хүн амын төвлөрөл явагдах эхлэх тавигдаж байна гэж үзэх сайн талтай боловч хүн амын төвлөрлийг даган гэмт хэргийн үзүүлэлт нэмэгдэж байдаг учир гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг анхааруулсан дохио гэж үзэх нь зүйтэй.

ЭДИЙН ЗАСАГ

Мал аж ахуй, газар тариалангийн гол бүс нутаг бөгөөд 2016 оны эцсийн мал тооллогын дүнгээр мал сүргийн нийт тоо толгой 3485.6 мянган толгойд хүрч өмнө оны тоо толгойноос 55.5 мянга буюу 1.7%-аар өссөнөөс адуун сүргийн тоо 268.7 мянга, үхэр 284.9 мянга, тэмээ 1.3 мянга, хонь 1827 мянга, ямаа 1034.7 мянга хүрч, 2015 оныхоос адуу 4.5 мянга буюу 1.6%-аар, үхэр 3.4 мянга буюу 1.2%-аар, 129.9 мянга хонь буюу 7.6%-аар, ямаа 55.8 мянган толгой буюу 5.7%-аар, тэмээ 85 толгой буюу 1.2%-аар тус тус өссөн байна. Улсын хэмжээнд нийт толгой мал тоологдсоны 5.6%-ийг тус аймгийн мал эзэлж байна. 2016 онд

нийт мал сүргийн тоогоороо улсын хэмжээнд 8-р байрт байна. Нийт мал сүргийг 5 төрлөөр нь аймагтай харьцуулбал адуун сүргийн тоогоороо 6-р байр, үхэр сүргийн тоогоороо 4-р байр, хонин сүргийн тоогоороо 6-р байр, ямаан сүргийн тоогоороо 13-р байр, тэмээн сүргийн тоогоороо 16-р байранд, нийт мал сүргийн тоогоор Бүрэгхангай сумын 3-р баг 4-р байранд, адуун сүргийн тоогоор Сайхан сум 3-р байр, хонин сүргийн тоогоор Бүрэгхангай сумын 3-р баг 4-р байрыг тус тус эзэлж байна.

Малчин өрхийг авч үзвэл Аймгийн хэмжээнд 2016 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 10595 өрх тоологдсон байна. Үүний 78.3% буюу 8301 малчин өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг ба 21.6% буюу 2294 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна. 2016 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 15579 малчид ажиллаж байна. Малчдын 45.5% нь буюу 7103 нь эмэгтэй малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 27.4% нь 15-34 насны, 61.7% нь 35-59 насны, 10.9% нь 60-с дээш насны хүмүүс байна. Нэг өрхөд оногдох малын тоо толгойг нь дундчилж үзвэл 329.9 толгой мал оногдож байна.

График VIII.5.1.



ГАЗАР ТАРИАЛАН

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 42125.8 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 37651.8 га, төмс 518.5 га, хүнсний ногоо 262.9 га, техникийн ургамал 2731 га, тэжээлийн ургамал 405.6 га, эмийн ургамал 556 га талбайд тус тус тариалсан байна. Өнгөрсөн мөн үетэй харьцуулахад нийт тариалсан талбай 2.4%-аар буюу 1005.5 га-гаар өссөн. Үүнээс: үр тариа 61.6 га буюу 16%-аар, хүнсний ногоо 6 га буюу 2.2%-аар буурсан ба техникийн ургамал 449 га буюу 19.7%-аар, төмс 21.5 га буюу 4.3%-аар, тэжээлийн ургамал 46.6 га буюу 13%-аар өсч, эмийн ургамал 550 га-д нэмж тариалсан байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 798 өрх, 106 ААН, байгууллага тариалалт хийснээс 2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 42106.8 га талбайгаас 62512.9 тонн ургац хураасан байна. Үүнээс: үр тариа 53.7 мянга тонн, төмс 4.9 мянга тонн, хүнсний ногоо 1.7 мянга тонн, тэжээлийн ургамал 0.5 мянга тонн, 1.5 мянга тонн техникийн ургамал тус тус хураан авсан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үр тариа 85.4%-аар, техникийн ургамал 2 дахин, тэжээлийн ургамал 57.7%-аар өсч, төмс 2.6%-аар, хүнсний ногоо 18.9%-аар буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд байгалийн хадлан 101.7 мянга тонн, гар тэжээл 2.3 мянган тонн, хужир шүү 4.9 мянган тонн бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хадлан 17.5%-аар, гар тэжээл 12.6%-аар, хужир 47.9%-аар тус тус хураан авсан нь төмс хүнсний ногооноос бусад ургац өссөн тус аймгийн эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлэх ахиц харагдаж байна гэж дүгнэж болох боловч орон нутгийн төсвийн орлогын хувьд 2016 оны

байдлаар 17844.9 сая төгрөг буюу 35.4%-ийг татварын орлого, 31847.5 сая төгрөг буюу 63.2%-ийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2016 оны жилийн эцсийн байдлаар 50425.9 сая төгрөг болж байгаа төсвийн алдагдал (төсвийн ашиг хасах үзүүлэлттэй) ажиглагдаж байгааг дараах байдлаар дүгнэж болохоор байна.

- Орон нутгийн татварын орлого төсвийн орлого бүрдүүлэлтэд голлох хувь нэмрийг оруулахгүй байна.
- Төсвийн бүрдүүлэлт улсын төсвөөс хараат байгаа аймгийн татварын үндсэн голч зүйл болсон татвар төлөх бааз суурь бэхжээгүй өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, үйлчилгээний салбар бодитой хөгжөөгүй.
- Дээрх хоёр үзүүлэлт нь гэмт хэргийн гаралтад нөлөөлөх эдийн засгийн шалтгаан нөхцөл болж байна гэж үзэх үндэслэлтэй.

Дээрх бүлэгт тусгагдсан тоо баримтыг Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсээс 2016 онд гаргасан үндэслэн бичсэн болно.

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ

Гэмт хэргийн нөхцөл байдал

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 265 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 32 хэргээр буюу 10.7%-аар буурсан байна. БҮСТЗЭТХэрэг 117 бүртгэгдэн 74 хэргийг илрүүлэлт 63.2%-тай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.3%-аар өссөн байна.

Хэргийг бүтцээр нь авч үзвэл нь авч үзвэл:

ИЭЧЭМЭГХ 92 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 11 хэргээр буюу 10.6%-аар ХАБАЖЭГХ 26 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 10 хэргээр буюу 26.3%-аар Танхайрах гэмт хэрэг 2 бүртгэгдэж 5 хэргээр буюу 2.5%-аар Бусдын амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнө оны мөн үетэй харьцуулахад 50%-аар, дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 2 дахин, БХЖЭГХ 5 бүртгэгдэн урьд оны мөн үеэс 6 хэргээр буурсан, хүнийг санаатай алах гэмт хэрэг 7 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 42.8%-аар, хулгайлах гэмт хэрэг 101 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 2.9%-аар өсч, үүнээс мал хулгайлах хэрэг 39 бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 9 хэргээр буюу 23%-аар буурчээ. Хүчиндэх гэмт хэрэг 10 бүртгэгдэн урьд оны мөн үеийнхээс 50 хувиар, албан тушаалын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн урьд оны мөн үеэс 50%-аар, золгүй байдлаар амь насаа алдсан хэрэг 6 бүртгэгдэж 33.3%-аар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас үүссэн хохирол нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 759.8 сая төгрөгийн хохирлоос иргэдэд 679.0 сая төгрөгийн хохирол үүссэн байна. Үүнээс хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын шатанд 555.0 сая төгрөгийн хохирол барагдуулсан байдлаас харахад гэмт хэргийн гаралт багассан, хохирол барагдуулах үйл явц сайн байгаа зэрэг нь ажиглагдаж байна.


Ялангуяа аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн үзүүлэлт нь сүүлийн таван жилийн байдлаар харьцангуй тогтвортой, мөн бууралт ажиглагдаж байгаа боловч 2005-2016 оны байдлыг авч үзвэл гэмт хэргийн гаралт өссөн байна гэж үзэж болно.

График VIII.5.2. Дээрх нөхцөл байдлыг графикаар авч үзвэл:



Графикаас харахад шугамын төгсгөл рүү бууралт байгаа боловч шугамыг ерөнхий байдал өсөлт байгааг харуулж байна. Өсөлтийн энэ хэв маяг нь аймгийн өнөөгийн нөхцөл байдал болоод гэмт хэргийн өсөлтийн шатлалын байдлаар 2020 хүртэл прогнозлон авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна.

График VIII.5.3.



Гэмт хэргийн гаралт ирээдүйд өсөх магадлалтай таамаглал байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс зөв зохистой авах шаардлагатай байгааг Булган аймгийн нийгэм эдийн засаг болон гэмт хэргийн гаралтын байдал харуулж байна.


Булган аймгийн гэмт хэргийн гаралтын байдал улсын дундажтай ойролцоо хүн амтай аймгуудын хүн амтай харьцуулбал дараах байдал харагдаж байна.

Булган аймаг - 61145 хүн амтай;

Завхан аймаг - 69700 хүн амтай;

Говь-Алтай аймаг - 56700 хүн амтай;

График VIII.5.4.



Булган аймгийн гэмт хэргийн хазайлт 61.9, Завхан аймгийн гэмт хэргийн хазайлт 35.7, Говь-Алтай аймгийн гэмт хэргийн хазайлт 29.8 нэгж байгаа нь Булган аймгийн гэмт хэргийн өсөлт ойролцоо хүн амтай аймгаас огцом өссөн болох нь харагдаж байна.


БУЛГАН АЙМГИЙН ГЭМТ ҮЗЭГДЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

Эдийн засгийн нөхцөл байдлын хувьд газар тариалан, мал аж ахуй хөгжсөн аймгуудын нэг боловч аймаг орон нутгийн төсөв улсын төсвөөс авах татааснаас ихээхэн хамааралтай төдийгүй алдагдалтай, Нийгмийн халамжийн сангаас 2016 оны жилийн эцсийн байдлаар 12899 хүн 4808.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 1124.2 сая.төг буюу 30.5%-аар өсчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1394 хүн хамрагдаж 1776.3 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 78.9 сая төгрөг буюу 4.6%-аар өссөн зэрэг нөхцөл байдал гэмт хэргийн гаралтад нөлөөлсөн шалтгаан нөхцөл болох бүрэн үндэслэлтэй. Тухайлбал гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дорвитой хөрөнгө төсөвлөөгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь сургалт, сурталчилгааны ажлаар хязгаарлагдсан байгаагаас тодорхой харагдана.

АЖИЛГҮЙДЭЛ

Булган аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оныхоос 2.9 дахин хувь нэмэгдсэн байгаа нь дэд бүтцийн таатай нөхцөлд байгаа тус аймгийн хувьд тун хангалтгүй статистик юм.

График VIII.5.5. Булган аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүд 2015-2016



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ



6. ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

НЭГ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, НУТАГ ОРОН, САЛБАРЫН ОНЦЛОГ

Говь-Алтай аймаг нь Улаанбаатар хотоос 1037 км зайд алслагдсан, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум, 2 тосгонтой бөгөөд газар нутгийн хувьд улсын хэмжээнд 2 дугаарт ордог, 141.4 мянган км² нутаг дэвсгэртэй, говь, цөл, уулархаг нутагтай, эрс тэс уур амьсгалтай.

2016 оны жилийн эцэст 16.3 мянган өрхөд 56700 хүн оршин сууж байгаагийн 49.7% буюу 28200 нь эрэгтэйчүүд, 50.3% буюу 28500 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд аймгийн хүн амын 30.2% буюу 17100 нь аймгийн төв Алтай хотод, 25.2% буюу 14300 хүн сумын төвд, 1.6% буюу 900 хүн тосгонд, 43.0% буюу 24400 хүн хөдөө амьдарч байна.

Насны хувьд 0-39 насны хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байхад 40-с дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна.

Аймгийн дүнгээр бүтэн өнчин 49, хагас өнчин 900 хүүхэд, 18 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн 900, ганц бие өндөр настан өрх 1200, өрх толгойлсон 3000, хөгжлийн бэрхшээлтэй 2100 хүн байна. Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 786 байгаагийн 55.3% буюу 435 нь эмэгтэйчүүд байна. 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 3497.5 мянган толгой мал тоолуулж төрөл тус бүрээр өссөн дүнтэй гарсан байна.

Говь-Алтай аймгийн гэмт хэрэгт холбогдогчдын тоон мэдээг судалж үзэхэд гэмт хэрэгт холбогдогчдын 93% нь эрэгтэйчүүд, 7 орчим хувь нь эмэгтэйчүүд байна. Түүнчлэн гэмт хэрэгт холбогдогчдын 20% нь 18 хүртэлх настай, 50% нь 18-35 хүртэлх насны залуучууд, 35-50 насны хүмүүс 18%, 50-с дээш насны хүмүүс 12% байгаа ба судалгааны дүнгээс харахад залуучууд голчлон холбогдсон нь тэдний эрх зүйн ухамсар соёл дорой, хууль эрх зүйн мэдлэг муу, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ бага, бие махбодын хувьд гэмт хэрэг үйлдэх илүү боломжтой байдагтай холбоотой.

Гэмт хэрэгт холбогдогчид нь ихэвчлэн ажилгүй, орлого багатай, нийгэмд ашигтай хэлхээ холбоо сул, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ бага байдаг бөгөөд гэмт хэрэгт шалгагдсан 200 хүнээс 60 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, нийгмийн эмзэг давхаргын иргэд байсан бол 26 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, тодорхой орлоготой хүмүүс байгаа бол үлдсэн 7 хувь нь төсвийн болон ААН, байгууллагын ажилтнууд байсан.

Гэмт хэрэг, зөрчил нь цаг хугацааны хувьд байнгын болон улирлын шинжтэй гардаг гэж хуваагддаг. Тухайн аймагт үйлдэгддэг байгаль орчны эсрэг гэмт хэрэг гэхэд л өвлийн цагаар багасаж зуны дэлгэр цагт ашигт малтмал хууль бусаар хайх олборлох, хүчиндэх зэрэг гэмт хэргийн гаралт ихээхэн нэмэгддэг.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүмүүс нь ихэвчлэн хууль, дүрмийг эс тоомсорлодог, хууль эрх зүйн мэдлэг дорой, архи дарсанд автагдсан, шунахай болон танхайрах сэдэлтээр зан төлөвийн онцлог нь илэрч байна. Тэдний олонх нь хууль зөрчиж байгаагаа мэддэг, ухамсарладаг бөгөөд өөрсдийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн шалтгаанаа "амьдрал ядуу байна, хүн алж хүрээ талсан биш яадаг юм" гэсэн сэтгэхүйгээр үйлдэл, хор уршигтаа хандаж байлаа. Түүх сөхвөл тус аймагт 1990-1994 онд 750 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол дундах 5 жилд буюу 1995-1999 онд 1258 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх 5 жилийнхээс 508 хэргээр буюу 1.6 дахин өсчээ. 2000-2004 онд нэлээд нааштай өөрчлөлт гарч өмнөх 5 жилээс гэмт хэргийн гаралт бага зэрэг буурч 1144 болсон байна.

Говь-Алтай аймаг дахь гэмт хэргийн үзүүлэлт 1990-1994 онд он дараалан прогресс хандлагаар өсөн нэмэгдэж, 1997 онд 301 гэмт хэрэг бүртгэгдэж оргил цэгтээ хүрсэн байна.

Говь-Алтай аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тооны дунджаар 1 хувийг эзэлдэг.

Тус аймагт бүртгэгдсэн болон хүнд ноцтой гэмт хэргийн гаралт тогтвортой буурч, 1000 хүнд ногдох гэмт хэргийн үзүүлэлт буурч байгаа нь хүн амын гадагшаа шилжих хөдөлгөөн ихтэй, алслагдмал аймгийн хувьд эрүүгийн нөхцөл байдал сайжрах хандлагатай байна.

ХОЁР. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Говь-Алтай аймагт 2015 онд 96 хүнд холбогдох 76 эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байсан бол 2016 онд 60 хүнд холбогдох 47 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх оныхоос 38.2%-аар буурсан үзүүлэлт гарчээ.

Говь-Алтай аймгийн цагдаагийн хэлтэс нь 2016 онд 238 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаснаас 141 хэрэгт мөрдөн байцаалт, 97 хэрэгт хэрэг бүртгэлт явуулсан нь ихэнх гэмт хэрэг шүүхийн өмнөх шатанд түдгэлзүүлэх буюу хэрэгсэхгүй болж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна. Тус аймгийн хэмжээнд хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг болон танхайрах гэмт хэргүүд голлон үйлдэгддэгийг тоо баримт харуулж байна. Тухайлбал, 2005 онд хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 32 гарч байсан бол 2006 онд 28, 2007 онд 35, 2008 онд 46, 2009 онд 25, 2010 онд 32, 2011 онд 24, 2012 онд 46, 2013 онд 59, 2014 онд 78, 2015 онд 77, 2016 онд 72 хэрэг бүртгэгдсэн байна.

Эдгээр гэмт хэргээс хүний амь насыг хохироосон гэмт хэрэг 1 жилд 1-6 бүртгэгдэж байгаа бол бусдын бие махбодид хүнд болон хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг 2006 онд 21, 2007 онд 28, 2008 онд 37, 2009 онд 20, 2010 онд 26, 2011 онд 19, 2012 онд 42, 2013 онд 54, 2014 онд 75, 2015 онд 74, 2016 онд 71 гэмт хэрэг бүртгэгджээ.

Говь-Алтай аймагт хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт 2005 онд 4, 2006 онд 5, 2007 онд 6, 2008 онд 5, 2009 онд 2, 2010 онд 4, 2011 онд 5, 2012 онд 10, 2013 онд 5, 2014 онд 3, 2015 онд 7, 2016 онд 3 гэмт хэрэг бүртгэгджээ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгддэг гэмт хэргийн 30 орчим хувийг эзэлдэг бөгөөд 2005 онд 96, 2006 онд 105, 2007 онд 142, 2008 онд 84, 2009 онд 67, 2010 онд 99, 2011 онд 74, 2012 онд 74, 2013 онд 60, 2014 онд 71, 2015 онд 84, 2016 онд 69 гэмт хэрэг бүртгэгдсэний 60 орчим хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах болон мал хулгайлах гэмт хэрэг зонхилсон бол үлдсэн хувийг дээрэмдэх, залилан мэхлэх гэмт хэргийн төрлүүд байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд төрийн болон ААН, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөнд 248.8 сая төгрөгийн хохирол учирсан 176 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 15 хэргээр буюу 7.8%-аар буурч, учирсан хохирол 45 сая төгрөгөөр буюу 15.3%-аар буурчээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгээр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзвэл танхайрах гэмт хэрэг 4 хэргээр буюу 33.3%-аар, хүчиндэх гэмт хэрэг 2 хэргээр буюу 40%-аар, БХЖЭсрэг гэмт хэрэг 3 хэргээр тус тус буурсан бол дээрэмдэх, булаах гэмт хэрэг 50%-аар, залилан мэхлэх гэмт хэрэг 33%-аар, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 7 хэргээр буюу 50%-аар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 3.7%-аар, үүнээс орон байрнаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг 11.9%-аар, мал хулгайлах гэмт хэрэг 50%-аар тус тус өссөн байна.

Нийт хэргийн 4.5%-ийг танхайрах гэмт хэрэг, 39.7%-ийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 30.1%-ийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, үүнээс 79.2%-ийг орон байрнаас эд хөрөнгө хулгайлах, 16.9%-ийг мал хулгайлах гэмт хэргүүд эзэлж байна. Үйлдэгдсэн гэмт

хэргийн 6.2%-ийг бүлэглэн, 39.7%-ийг согтуугаар үйлдсэн байна. Гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын 171.2 сая төгрөг буюу 68.8%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт 66.7%-тай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.7%-аар өсчээ.

Говь-Алтай аймагт үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 111 хэрэг буюу 63% нь Есөнбулаг сумд, 7 хэрэг буюу 3.95% нь Бигэр, Дэлгэр сумдад, 6 хэрэг буюу 3.4% нь Шарга сумд, 5 хэрэг буюу 2.8% нь Тайшир, Халиун, Эрдэнэ сумдад, 4 хэрэг буюу 2.3% нь Жаргалан, Төгрөг, Хөхморьт, Цогт сумдад, 3 хэрэг буюу 1.7% нь Баян-Уул, Чандмань сумдад, 2 хэрэг буюу 1.1% нь Бугат, Тонхил, Цээл сумдад, 1 хэрэг буюу 0.5% нь Алтай сумаңд үйлдэгдсэн байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд улс орны хэмжээнд тулгамдсан асуудал болоод байгаа ажилгүйдэл, ядуурал, архидан согтууралт голлох шалтгаан нөхцөлийг бүрдүүлж байна.

Орон нутгийн удирдлагууд байгалийн нөөц баялгийг ашиглах, төлбөр хураамж авах сонирхолтой атлаа төвлөрсөн хөрөнгийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулахаас аль болох татгалзаж шаардлагагүй ажилд их хэмжээгээр зарцуулдаг. Үүнд хөшөө дурсгал босгох, ойн баяр, наадам тэмдэглэх, шагнал урамшуулал зэрэгт их хэмжээний хөрөнгө зарцуулсан нь сөрөг талтай болно.

Санхүүжилт хангалтгүй байгаагаас гэмт хэрэг, тэр дундаа байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх далайцтай арга хэмжээ явуулж чадахгүй, алив төсөл, үйл ажиллагаа нь санхүүжилтгүйгээр урагш ахихгүй нь тодорхой учир төсвийн 10 хүртэлх хувийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулж байж тодорхой үр дүнд хүрнэ. Тус аймагт дунджаар 1 жилд 230 гэмт хэрэг бүртгэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулсан байхад 47-60 эрүүгийн хэрэг буюу 30 орчим хувийг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэж бусад хэрэг нь шүүхийн өмнөх шатанд түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох зэргээр шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

ГУРАВ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Тайлант хугацааны эхний 11 сард иргэд, ААН, байгууллагаас гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн шинжтэй 1723 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 617 өргөдөл гомдлын 472 буюу 76.4%-ийг 5 хоногт, 145 буюу 23.5%-ийг 19 хоногт шийдвэрлэсэн бөгөөд нийгмийн хэв журам 4298 зөрчил илрүүлэн шалгаж, 586 хүн саатуулж, бусдын амгалан тайван байдал алдагдуулан жижгээр танхайрсан 13 хүнийг баривчлуулан, 4123 иргэнд 133.1 сая төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулсан байна.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа, үйлдэгдэж болзошгүй зөрчлийг илрүүлэх, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, архи согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэдэг, худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг цэгүүдээс гаргаж байгаа зөрчил дутагдлыг илрүүлэн шалгах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Зөрчил" нэгдсэн арга хэмжээг 2016 оны 08 дугаар сард зохион байгуулжээ.

2015 онд гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдсэн сумдад удирдамжийн дагуу ажлын хэсэг 4 чиглэлд 8 сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг шалган зааварчлан, зөрчлийг арилгуулах үүргийг өгч биелэлт үр дүнг тооцож үүрэг даалгавар биелүүлээгүй 12 алба хаагчид, гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээнд хангалтгүй ажилласан 6 алба хаагчид тус тус арга хэмжээ тооцуулан ажилласан.

Захиргааны хяналтад 35 хүнийг хүлээн авч бүртгэл судалгаанд хамруулан хяналт тавьж, захиргааны зөрчилд холбогдсон 2 ялтны ялыг өөрчлөх саналыг харьяа Прокурорын газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, 38 хүнд захиргааны хяналт тогтоон хяналт тавин ажиллаж байна.

Есөнбулаг сумын ЕБС-уудын эцэг эхийн төлөөлөл, багш, нийгмийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулгын ажлыг зохион байгуулж багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга нарын сургалт семинарын үеэр аймгийн Цагдаагийн хэлтсээс 2015 он, 2016 оны гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл хийлээ. Мөн мал хулгайлах гэмт хэргээс малчид, орон нутгийн удирдлага хэрхэн урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг харилцан солилцож ажиллах талаар сургалт семинарыг зохион байгууллаа. Энэ үеэр мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг 250 ширхэг түгээсэн.

ААН, байгууллагуудын камержуулалт, гэрэлтүүлэг тэр дундаа орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "ХААН", "Хадгаламж" банкны аймаг, сумын бүх салбаруудын камержуулалт, дохиололжуулалтын судалгааг гаргуулан авч сумдад ажиллах ажлын хэсгээр судалгааны бодит байдалд хяналт шалгалт хийлгэхээр ажиллаж байна.

ДӨРӨВ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг үйлдэгсдийн 94% нь эрэгтэйчүүд, 6% нь эмэгтэйчүүд байгаа бол насны хувьд 18-30 хүртэлх насны залуус энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн 60 орчим хувийг, 25% нь 30-40 насныхан байна. Цаг хугацааны хувьд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг нь байнгын шинжтэй учир улирал харгалзахгүй үйлдэгддэг, ихэвчлэн 22-06 цагийн хооронд үйлдэгдэх нь илүү байдаг.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг үйлдэж байгаа хүмүүс нь ихэвчлэн хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрмийг эс тоомсорлодог, хурд хэтрүүлдэг, хууль эрх зүйн мэдлэг дорой, бусдыг хүндэтгэх ёс суртахуун төлөвшөөгүй, хар амиа бодсон би л болж байвал бусад нь хамаагүй гэсэн аминчхан сэтгэлээр үйлдэл, эс үйлдэхүй болон хор уршигтаа хандсан онцлогтой.

Боловсролын хувьд судалж үзэхэд 45 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 35 хувь нь бүрэн дунд боловсролтой, 10 хувь нь тусгай дунд болон дээд боловсролтой, 5 хувь нь боловсролгүй, бичиг үсэг мэддэггүй хүмүүс байв.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас тус аймагт 2016 онд зам тээврийн осол хэрэг 19 бүртгэгдэж, 16 хүн хүнд, хөнгөн гэмтэж, 2 хүний амь нас хохирсон, осол хэргийн улмаас 5 хүүхэд хохирч, 4 хүүхэд хүнд, хөнгөн гэмтэж, 1 хүүхэд нас барсан байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар нь аймгийн төв болон улсын чанартай авто зам дээр голчлон үйлдэгддэг.

ТАВ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ГХУСАЗСЗӨВЛӨЛИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл 30 гаруй ажил төлөвлөснөөс 4 дүгээр улирлын байдлаар давхардсан тоогоор 30 ажлыг зохион байгуулахаас 16 асуудал 90-100%-ийн биелэлттэй, 5 асуудал 70-80%-ийн биелэлттэй, 1 асуудал 50-60%-ийн биелэлттэй, 7 асуудал тасарсан байна. ГХУСАЗСЗөвлөлөөс жилд төлөвлөсөн 30 ажил арга хэмжээ төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 76.6%-ийн биелэлттэй байна. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс хүүхдийг

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, интернет кафе болон компьютер тоглоомын газар ажиллуулах журмын талаар, Цагдаагийн хэлтсээс гэмт хэргийн шалтгаан нөхцөл түүнээс урьдчилан сэргийлэх талаар ярилцлага хийсэн байна.

Эдгээрт "Гэмт хэрэгт зөрчилгүй хамт олон" аяныг зохион байгуулах, хууль хяналтын байгууллагуудтай хамтарч сумдад шалган туслах, эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын хэсэг томилон ажиллуулах, олон нийтийн цагдаагийн ажилтан, иргэний зөвлөлийн гишүүдийн урамшууллыг нэмэгдүүлэх асуудал, "Хууль сурталчлах сарын аян" арга хэмжээг зохион байгуулах, хууль бус ан агнуур болон мод бэлтгэл, нэн ховор амьтад, заган ойн бүхий сумдад хамтарсан хяналт шалгалт хийх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, ан агнуур хийдэг үеэр хамтарсан эргүүл шалгалтыг зохион байгуулах зэрэг хөрөнгө санхүү шаардсан ажил тасарсан байна.

Ял хойшлогдсон, тэнссэн, хорих ял эдлээд хугацааны өмнө тэнсэн суллагдаад захиргааны хяналтад байгаа хүмүүсийг ажлын байранд зуучлах, Олон нийтийн эргүүлийг сар тутам ажиллуулж 7 хоног бүр албан байгууллагуудыг ээлжээр нийтийн эргүүлд гаргах, эд хөрөнгө хулгайлах болон мал хулгайлах гэмт хэргийн талаар иргэдийн мэдээллийг худалдаж авдаг журам боловсруулж хэрэгжүүлэх, мал хамгаалах бүлэг нөхөрлөлийн туршлагыг судлуулах, ААН, байгууллагуудыг камержуулах, гэрэлтүүлгийг сайжруулах уралдааны болзол зарлах зэрэг ажлууд тасарсан байдалтай байна.

Дарви сумын ГХУСАЗСЗөвлөл "Хууль бидний амьдралд" сэдэвт хууль эрх зүйн тэмцээнийг албан байгууллагуудын дунд зохион байгуулж, иргэдийг хамруулан үзэгчдийн дунд асуулт асууж зөв хариулсан иргэдийг урамшуулсан байна.

Эрдэнэ сумын ГХУСАЗСЗөвлөл Өрхийн тэргүүн нарын зөвлөгөөнийг зохион байгуулж баг тус бүрээс "Нийгмийн хариуцлагатай гэр бүл"-ийг шалгаруулж батламж гардуулан, шагнаж урамшуулсан зэрэг ажил нь сумдын ГХУСАЗСЗөвлөлүүдээс зохион байгуулсан онцлог, бусдаас шинэлэг, хууль сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтийг хамарсан ажил болсон байна.

ЗУРГАА. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сумдын ГХУСАЗЗөвлөлүүд зөвлөлийн хурлаа хийж, жилийн ажлын төлөвлөгөө батлан ажлаа улирлаар төлөвлөн хийж байна. Цагдаагийн байгууллагаас зохион байгуулдаг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг чанартай зохион байгуулж байна. Архи согтууруулах ундаанд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулсан, Тамхины хяналтын тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулж бүх сумд хууль сурталчилгааны ажлыг зохион байгуулсан зэрэг үр дүнтэй тогтмол ажлыг хийж байна. Сумдын ГХУСАЗСЗөвлөлүүд хууль эрх зүйн болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтийг хамруулсан, ажлаа тайлагнаж мэдээлэх, баримтжуулж хадгалах асуудал учир дутагдалтай байна.

Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 3235 байгууллага, ААН-д хяналт шалгалт хийж, 91 зөрчил илрүүлэн 52.75 литр архи, 14.25 литр дарс, 87.5 литр пиво, 2503 хайрцаг тамхи, 3 ширхэг процессор хураан авч Есөнбулаг сумын Засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөлд, металл хайгч 4 ширхэгийг Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэн ажилласан. Зөрчил гаргасан 91 иргэн, ААН-д 5.380.600 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчил гаргасан согтууруулах ундаа худалддаг болон түүгээр үйлчилдэг, тамхи худалддаг 13 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг холбогдох

газарт хүргүүлэн 5 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулан ажилласан байна.

Орон нутгийн "Миний нутаг" телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 7 хоног бүрийн даваа гарагт эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг мэдээлж, баасан гарагт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 60 удаа "Алтай радио"-оор 7 удаа, "Алтай телевиз"-ээр 2 удаа, "Алтайн мэдээ" сонинд 5 удаа мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг хийж ажилласан.

Тамхины хяналтын тухай хуулийг нийтэд сурталчлах, "Тамхигүй хамт олон" болох хөдөлгөөнийг өрнүүлж аяны нээлтийг зохион байгуулан байгууллага, аж ахуйн нэгж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, ЭМШУҮИС-ийн Говь-Алтай салбар сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн сурагчид, ажилчид алба хаагчдыг хамруулсан ажлыг зохион байгуулан орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилж ажилласан байна.

Цаашид ГХУСАЗСЗөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон нийтийн цахим хаягт болон "хурал.мн"-д салбар зөвлөлийн мэдээ мэдээллийг байршуулах тогтмол ажиллуулах, мөн хууль эрх зүйн сурталчилгааны ажлыг олон нийтийг хамарсан, сонирхолтой хэлбэрээр зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзэж байна.

Сумдын удирдлагууд болон цагдаагийн ажилтнуудтай хамтран мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ярилцлага зохион байгуулж, жишиг бүлэг нөхөрлөлийг ажиллуулах, тэдгээрийг удирдлагаар ханган ажиллах чиглэлээр анхаарч малын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зайлшгүй шаардлагатай байна.


Цагдаагийн газартай хамтран аймгийн хэмжээнд гарч байгаа гол усны аюулын тоо, хохирлыг бууруулах, ард иргэдийг усны ослоос урьдчилан сэргийлэх, аврах хамгаалах, тусламж үзүүлэх, сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, орон нутгийн "Миний нутаг", "Алтай" телевизүүд, "Их Алтай мэдээ" сонины газартай хамтран Завхан гол, түүний ай сав газрууд, Тайшир сумын "Улаан боом"-ын усан цахилгаан станцын Гэгээн нуурын байгууламж, эрэг дагуу, Гуулин тосгоны оршин суугч иргэд, оюутан сурагчдын "Нөхөрлөл" зуны амралтын газар, Жаргалан сумын "Эрээн нуур"-ын амралтын газруудад эргүүл, шалгалтуудыг 24 удаа хийж ажилласан.

Тайшир сумын Хуримт баг, Жаргалан сумын Завхан голын ай сав газраар нутаглаж байсан 24 айлыг нүүлгэн шилжүүлж, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт үүрэг чиглэл өгч, Завхан голын ай сав, түүний эрэг дагуух амралт зугаалгын газруудын усанд ордог хэсгээс бусад газраар орох, хязгаарын шугам давах, осолдож болзошгүй хэсгүүдэд сэрэмжлүүлэх 20 ширхэг самбар байршуулж орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн газар дээрээс нь иргэдэд сурталчлан ажилласан.

Эргүүл шалгалтын үеэр иргэдэд үер, усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 580 иргэнд яриа таниулга хийж, зөвлөмж, сэрэмжлүүлэг материалыг 3444-ыг тараан "Хамгаалах бүс-Хамгаалалтын суудал" арга хэмжээний хүрээнд 2015 зөрчил илрүүлж, 186 хүнийг 5232000 төгрөгөөр торгох арга хэмжээ авсан. "Тусгай дуут болон гэрэл дохио" нэгдсэн арга хэмжээнд 5 байгууллагын 24 автомашинд Замын цагдаагийн тасгийн 2 зохицуулагч 5 цагдаа зохицуулагч нар хяналт шалгалт хийж судалгааг гарган зөвшөөрөлгүй 22, хугацаа дууссан 1 тээврийн хэрэгслийн зөрчлөө арилгуулах талаар албан мэдэгдэл хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо сүүлийн 15 жилийн байдлаар 10000 хүн тутамд харьцуулан үзэхэд улсын дундаж 2107 байгаа бөгөөд дунджаас дээш үзүүлэлттэй нь Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Сэлэнгэ, Хэнтий аймгууд, Улаанбаатар хот орж байгаа ба Говьсүмбэр, Хэнтий аймгууд хамгийн өндөр хувьтай байна. Улсын дунджаас доош хамгийн бага үзүүлэлттэй аймгуудын тоонд Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгууд орж байна. Улсын дунджаас үл шалтгаалан сүүлийн 2 жилд гэмт хэргийн тоо буурсан байна.

ГОВЬСУМБЭР АЙМАГ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ

1. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, ЭДИЙН ЗАСАГ, ХҮН АМ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Говьсүмбэр аймаг нь хүн амын байршил, эдийн засгийн чадавх, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг харгалзан бие даасан аймаг болон хөгжих нөхцөл бүрдэж Улсын Бага Хурлын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сумбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулж улмаар УИХ-ын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тогтоолыг үндэслэн Чойр хотын хилийн цэсээр Говьсүмбэр аймаг 1994 оны 8 сард байгуулагдсан.

Нутаг дэвсгэр, байгаль цаг уурын нөхцөл байдал

Говьсүмбэр аймаг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт хойд өргөргийн 46057'-47002', зүүн уртрагийн 1070 57'-1090 04' солбилцол, нийслэл Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км зайд 5.5 мянган километр хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэрийг хамааран, 376819 га буюу 68.0%-ийг Сүмбэр сум, 91606 га буюу 16.5%-ийг Баянтал сум, 85755 га буюу 15.5%-ийг Шивээговь сум эзэлж оршдог.

Хойд талаараа Төв аймгийн Баянцагаан, Баян, Баянжаргалан сумдтай зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Дархан сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумд зэрэг **4** аймгийн **8** сумтай хиллэж авто болон төмөр замын сүлжээнд холбогдсон төвийн бүсийн нөлөө бүхий аймгийн нэг болж хөгжиж байна.

Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1620 метр. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр. Өвлийн улиралд хамгийн хүйтэн нь -33 хэм, зуны улиралд хамгийн халуун нь +32 хэм хүртэл дулаарах хандлага тохиолддог. Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг нь говийн бүсийн дунджаас илүү. Тал хээрийн хүрэн, хүрэн цайвар хөрстэй.

Мал аж ахуйн хувьд хонь, тэмээ, үхэр, ямаа, адууны аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой. Усан хангамжийн хувьд өрөмдмөл, богино яндант болон энгийн, бетонон хашлагат худагт уснаас ундны хэрэгцээг хангадаг ба түс аймгийн нутагт байнгын ундрагатай Хулгар, Уулзвар, Цоорхой, Хүхээ, Цагаан Ус, Уст ханан, Шивээ зэрэг 43 ил задгай горхи, булаг шанд бий. Нутгийн баруун хойд талаар хялгана, харгана, баруун өмнөд талаар бударгана дэрс зэрэг тойрмын ургамал голлох бөгөөд бэлчээрийн өвөл хаврын даац нь дунджаар 08-1,0 центнер га, зун намрын даац нь 2,5-3,0 центнер га-гийн нөөцтэй тул 80,0 мянгаас илүү малыг бэлчээрээр хангах боломжгүй гэсэн тооцоо байдаг.

Аймгийн нутагт хүйтэвтэр хоногийг авч үзвэл хамгийн олон нь 122, хамгийн цөөн нь 95, хүйтэрдэггүй хоног 80-100 байдаг нь байгаль цаг уурын хувьд гадаадын иргэд ажиллаж амьдрахад тохиромжт нөхцөлтэй.

Аймийн төвөөс 100 километрийн радиус дотор 30 гаруй төрлийн ашигт малтмалын орд, илэрц байдаг бөгөөд гидрогеологийн судалгааны ажлын дүнд тоосгоны шавар, хүрэн нүүрс, газрын тос, холимог металл болон эрдэс будгийн нөөц, хайлуур жонш (38 сая тонн), холимог металл (1.1 сая тонн), төмрийн хүдэр (13 сая тонн), бал чулуу (200 мянган тонн), хүрэн нүүрс (13 биллион тонн).

Шивээ-Овоогийн нүүрсний уурхай жилдээ 2 сая тонн нүүрс олборловол 300 жилийн нөөцтэй гэж тогтоогдсон нь улсын хэмжээнд эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой. Сүүлийн жилүүдэд явуулсан судалгаагаар Чойрын Богд, Огторгуй уулсын орчимд 150 гаруй

аргаль, Халзангийн говь, Хүрэн дух, Баянхошууны говь, Нүхэн сондуул, Тогоогийн булаг орчимд хар сүүлт, цагаан зээр нутагшиж, 2015 оны судалгаагаар 10000 гаруй, хээрийн тарвага 1 га-д 42 коэффициент байгаа нь улсын дундаж хэмжээнд, жигүүртэн шувуудаас талын бүргэд, элээ, харцага, сар, ууль, ховордсон шувуудаас цармын бүргэд, идлэг шонхор зэрэг шувуу уул, хад асга бүхий газруудад амьдардаг.

Хүн ам зүйн өнөөгийн байдал

Хүснэгт VIII.7.1. Хүн амын тоо, улс, төвийн бүс, төвийн бүсийн аймгуудын дүн харьцуулалт

Нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Улсын дүн	2,760,968	2,811,666	2,867,744	2,930,277	2,995,949	3,057,778	3,119,935
Төвийн бүс	450,710	456,193	467,034	469,909	480,177	485,525	492,494
Дорноговь	58,859	60,450	60,935	62,484	63,808	65,267	66,450
Дундговь	38,728	37,726	37,773	37,364	44,351	44,429	44,762
Өмнөговь	61,591	63,426	65,373	67,149	59,694	61,655	63,307
Сэлэнгэ	97,876	99,240	103,543	103,191	106,212	106,292	107,513
Төв	85,411	85,705	86,818	85,898	90,107	90,421	91,660
Дархан-Уул	94,922	96,031	97,917	98,969	99,947	100,939	101,876
Говьсүмбэр	13,323	13,859	14,308	14,801	16,058	16,522	16,926

Төвийн бүсэд Төв, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь, Дундговь аймгууд багтдаг. Төвийн бүсийн хүн амын дүнг улсын дүнд харьцуулж үзвэл 2010 онд 16.6%-ийг, 2011 онд 16.4%-ийг, 2012, 2013 онуудад 13.3%-ийг, 2014 онд 13.2%-ийг эзэлж 2010 оноос хойш төвийн бүсийн хүн амын тоо улсын дүнд эзлэх хувь хэмжээгээр буурч байна.

Говьсүмбэр аймгийн хүн амыг төвийн бүсийн хүн амд харьцуулж үзвэл 2010 онд 3.2%-ийг, 2011, 2012, 2014 онуудад 3.3%-ийг, 2013 онд 3.4%-ийг тус тус эзэлж өсөх хандлагатай байна. Говьсүмбэр аймгийн хүн амын тоо сүүлийн жилүүдэд өссөөр байна.

Хүн амын тоо 2014 онд 15891 болж 2013 оноос 1.3%-аар, 2005 оноос 25.6%-аар тус тус өссөн байна. Аймгийн хамгийн олон хүн амтай Сүмбэр сум (11609 хүнтэй), хамгийн цөөн хүн амтай Баянтал сум (1084 хүнтэй) байна.

Говьсүмбэр аймаг нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 16934 хүн, үүнээс эрэгтэй 8476, эмэгтэй 8458 хүнтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүн ам 626 буюу 3.8%-аар, үүнээс эрэгтэй 230 буюу 2.8%-аар, эмэгтэй 396 буюу 4.9%-аар өссөн.

Нийт хүн амын 50.1%-ийг эрэгтэйчүүд, 49.9%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаагаас нийт хүн амын 33.8%-ийг 0-15 насны хүүхэд, 60.7%-ийг 16-59 насны хүмүүс, 5.5%-ийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 366, 80 ба түүнээс дээш настан 99, 90 ба түүнээс дээш настан 16, энэ үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 70 ба түүнээс дээш настан 2.7%-аар, 80 ба түүнээс дээш настан 1.0%-аар, 90 ба түүнээс дээш настан 11.1%-аар тус тус буурсан байна.

Говьсүмбэр аймгийн өрхийн тоо 2014 онд 4749 болж 2013 оноос 1.5%-аар, 2010 оноос 10.7%-аар, 2005 оноос 46.5%-аар тус тус өссөн байна. Графикаас харахад Сүмбэр сумын өрхийн тоо нилээд өсөлттэй, Шивээговь сумын өрхийн тоо аажим өсөлттэй, Баянтал сумын өрхийн тоо багахан хэмжээний өсөлттэй байгаа нь харагдаж байна. 2014 онд Баянтал сумын өрх 331 болж 2013 оноос 4.1%-аар, Сүмбэр сумын өрх 3424 болж 2013 оноос 0.9%-

аар, Шивээговь сумын өрх 995 болж 2013 оноос 2.4%-аар тус тус өссөн, хүн амын нягтрал 2014 онд 1 мян.га нутаг дэвсгэрт ойролцоогоор 29 хүн ногдож байна. Энэ үзүүлэлт 2013 оноос 1.4%-аар, 2010 оноос 9.5%-аар, 2005 оноос 25.9%-аар тус тус өссөн байна.

2016 онд 5189 өрх тоологдсон нь өмнөх оноос 202 өрхөөр буюу 4.1%-аар өссөн үзүүлэлттэй байна. Нийт өрхөөс 3048 буюу 58.7% нь аймгийн төвд, 921 буюу 17.7% нь сумын төвд, 1220 өрх буюу 23.5% нь хөдөөд байршиж байгаа бөгөөд нийт өрхөөс 10 буюу түүнээс дээш ам бүлтэй өрх 12 тоологдлоо. Хөдөлмөрийн насны хүн ам 2016 онд 10272, үүнээс 5869 нь ажилчид байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 57.1%-ийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 5988 хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас 2% нь тэтгэврийн насны хүмүүс байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөдөлмөрийн насны хүн ам 2.8%-аар, хөдөлмөрийн насны ажил эрхлэгч 0.7%-аар өссөн үзүүлэлт гарчээ.

Тус нутаг дэвсгэрт дараах эерэг, сөрөг хандлагууд тогтоогдож байна. Үүнд:

Эерэг хандлага:

1. Хүн амын тоонд өсөх хандлага бий болж хүн амын тоо жилээс жилд нэмэгдсэн;
2. Шилжилт хөдөлгөөний урсгал саарч, шилжин ирэгсэд нэмэгдсэн;
3. Хүн амд хөдөлмөрийн насныхан зонхилж, цаашид өсөх хандлагатай байгаа;
4. Сүүлийн жилүүдэд төрөлтийн тоо тасралтгүй нэмэгдэж өсөх хандлага бий болсон;
5. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь эерэг үзүүлэлттэй гарч байгаа;
6. Хүйсийн харьцаа тэнцвэржсэн;
7. Өрхийн тоо нэмэгдсэн;
8. Дундаж наслалт уртассан.

Сөрөг хандлага:

1. Хүн амд өсвөр ба залуу насны (0-29) иргэд зонхилох хувийг эзлэж байгаа боловч сүүлийн 3 жил дараалан цөөрөх хандлагатай;
2. Хүн ам зүйн ачаалал өсөх хандлагатай;
3. Шилжилт хөдөлгөөн бүрэн зогсоогүй;
4. Нас баралт тогтвортой буурахгүй байгаа;
5. Гэр бүл салалт тогтвортой буурахгүй байгаа зэрэг хандлага ажиглагдаж байгаа нь төрийн захиргааны ажилтнууд болон шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй хүмүүс, оюутнууд нийгэм, эдийн засгийн олон үр дүн, үйл явцтай холбон судлахад ашиглах боломжтой.

Хөдөө аж ахуйн өнөөгийн байдал

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1055 малтай өрх тоологдсоноос 721 малчин өрх, 334 малтай өрх (тавиул малтай өрх 1) тоологдсоноос, малчин өрхөд 2449 хүний 1231 малчин, үүнээс 558 нь эмэгтэй малчин байна.

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл: 15-34 насны 338 малчин буюу 27.5% 35-59 насны 740 малчин буюу 60.1% 60-аас дээш насны 153 малчин буюу 12.4%-ийг тус тус эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал малтай өрх 60 буюу 6.0%-аар, малчин өрх 48 буюу 7.1%-аар, мал бүхий өрх 12 буюу 3.7%-аар тус тус нэмэгдсэн байна. Малчдын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал 71 буюу 6.1%-аар, үүнээс эмэгтэй малчин 23 буюу 4.3%-аар өссөн.

Аж үйлдвэр, үйлчилгээний өнөөгийн байдал

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хувьд "Шивээ-Овоо" ХК, "Ус-Ду" ОНӨААТҮГ, "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ, "Талын илч" ОНӨААТҮГ, "Илчлэг Шивээ" ОНӨААТҮГ, "Илчит сансар" ХХК зэрэг ААН, байгууллага 2016 онд 47.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 44.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Энэ нь өмнөх оны үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 25.3 хувиар өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлж бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оны мөн үеэс 14.5%-аар өссөн.

"Шивээ-Овоо" ХК нь 2016 онд 45.1 тэрбум төгрөгийн нүүрс олборлож 42.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 26.4%-аар, бүтээгдэхүүн борлуулалт 15.0%-аар өссөн үзүүлэлттэй. Тус компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 95.9%-ийг, нийт борлуулалтын 95.6%-ийг гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир ус татан зайлуулах чиглэлээр Ус-Ду, Талын Илч, Илчлэг Шивээ, Илчит сансар зэрэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2016 онд нийт 1952.5 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулснаас 1689.1 сая төгрөгийн дулаан, 186.0 сая төгрөгийн ус, 77.3 сая төгрөгийн татан зайлуулсан бохир ус хийсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал нийт үйлдвэрлэл 5.0%-аар үүнээс дулаан үйлдвэрлэл 4.0%-аар, ус 10.2%-аар, сувагжуулалт 15.3%-аар тус тус нэмэгдлээ.

Тээвэр, холбоо харилцаа, дэд бүтцийн өнөөгийн байдал

Говьсүмбэр аймаг нь орон нутгийн болон олон улсын чанартай төмөр зам, авто замын тээврийн салбарын дэд бүтцээс гадна олон улсын шилэн кабелийн дэд бүтэц бүхий бүс болон хөгжиж байна.

Говьсүмбэр аймаг дахь авто тээврийн үндэсний төвийн мэдээгээр 2016 онд 23.7 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 5355.2 мян.хүн км болж, 14.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3047 тээврийн хэрэгсэл бүртгэгдэж, зорчигч тээвэрлэлт 8.0%-аар, зорчигч эргэлт 1.0%-аар, тээврийн орлого 17.2%-аар тус тус өссөн үзүүлэлт гарсан байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал суудлын авто машин 2.3%-аар, ачааны автомашин 11.3%-аар, 2 дугуйт 2.5%-аар өссөн хэдий ч бусад төрлийн тээврийн хэрэгсэл 3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 онд нийт орлого 202.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.7 сая төг буюу 8.0%-аар, нийт суурин телефон цэгийн тоо 334 болж өмнөх оны мөн үеэс 64 буюу 16.1%-аар, КТВ суваг 1233 болж өмнөх оны мөн үеэс 39 буюу 3.1%-аар буурсан үзүүлэлттэй байна. 2016 онд интернет үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 270 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 77 байна.

Боловсрол

Аймгийн хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 9 цэцэрлэгийн 49 бүлэгт 1652 хүүхэд байгаагаас эмэгтэй 797 хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 151 буюу 9.1% нь малчдын хүүхэд байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл бага бүлэг 12, дунд бүлэг 10, ахлах бүлэг 8, бэлтгэл бүлэг 10, холимог бүлэг 3, ээлжийн бүлэг 1, нүүдлийн бүлэг 5 байна.

Ерөнхий боловсролын 5 сургуулийн 122 бүлэгт 3340 сурагч суралцаж байгаагаас I-V ангид 1740 сурагч, VI-IX ангид 1026, X-XII ангид 574 сурагч байна. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй 28 сурагч суралцаж, дотуур байранд 165 сурагч амьдарч байна.

Хөгжлийн чиг хандлага, аюулгүй байдал

Аймгийн хөгжлийн хандлага нь "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр, "Төрөөс уул уурхай, эрдэс баялагын талаар баримтлах бодлого", "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого" "Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр" зэрэг бодлогын баримт бичиг, хөтөлбөр батлагдсантай уялдан эрчимтэй хөгжих эрх зүйн орчин бүрдсэн.

Тухайлбал, нүүрсний орд, барилгын түүхий эдийн орд, авто зам болон төмөр замыг түшиглэн байгуулагдах Говьсүмбэр, Сайншандын аж үйлдвэрлэлийн парк, аялал жуулчлалын цогцолбор зэрэг мега төслийг хэрэгжүүлсний үр дүнд зүүн өмнөд бүсийн эрчимтэй хөгжлийн тогтолцоо бодит биелэл болсоноор дотоод болон гадаад ачаа эргэлт 20 орчим сая тонн болж өсөх, өөрийн аймгийн 20 орчим мянган иргэд, хил залгаа сумдын 40 орчим мянган иргэд, авто зам болон төмөр замаар дамжин өнгөрөх зорчигч эргэлт 2 сая 300 мянга орчим нийт 3 сая орчим мянган хүн ам[6]-д, төрөл бүрийн үйлчилгээгээр бүрэн хангах шаардлага бий болж улмаар тухайн нөхцөлд тохирсон төрийн болон хувийн хэвшлийн ухаалаг тогтолцоо бүрдэх болно.

2. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн шалтгаан нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай орчин нөхцөл бүрдээгүй, амьдралын зөв хэв маяг, сэтгэл зүйн эерэг хандлага дутагдалтай, түүнчлэн, уул уурхай болон авто зам, төмөр замын дотоод, гадаад сүлжээ бүхий нутаг дэвсгэртэй, байнгын оршин суугч иргэдээс гадна зорчигч эргэлтийн эрчим их, нөхцөл байдалд тохирсон эрх зүйн болон бодитой аюулгүй байдал, эрсдэлийн хяналт, хамгаалалтын удирдлагын тогтолцоо хангалттай бүрдээгүйтэй холбоотой.

Иймд иргэдийн сэтгэл зүйд эерэг нөлөөлөх, нийтээр амьдрах соёл, зөв хандлагатай, өөрийгөө ухамсартайгаар хариуцах ёс зүйтэй иргэн болгон гэгээрүүлэх, төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1 Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал

Хууль сахиулах байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдлыг сүүлийн 6 жилийн хугацаагаар судлан авч үзэхдээ хууль сахиулах байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэсэн гэмт хэрэг, ангилал, төрөл, илрүүлэлтийн тоо, хувийн жин зэрэг үзүүлэлтийг харьцуулан тоймлон дүгнэв. Үүнд:

6 ҮСХ-ны 2011-2016 оны хүн ам зүйн болон төмөр зам, авто замын тээврийн салбарын тоон мэдээлэлд үндэслэв.

1. Улсын хэмжээнд 2011-2016 онд бүртгэгдсэн гомдол, мэдээллийн дүн;
2. Улсын хэмжээнд 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;
3. Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдэж 2011-2016 онд бүртгэгдсэн гомдол, мэдээллийн дүн;
4. Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдэж 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;
5. Говьсүмбэр аймгийн хувьд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн дүнтэй харьцуулсан хувийн жинг харьцуулан шинжлэн дүгнэсэн болно.

Говьсүмбэр аймгийн цагдаагийн байгууллага 2011-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт **9396** гомдол мэдээллийг хүлээн авч үүнээс гэмт хэргийн шинжтэй **3629** гомдол, мэдээллийг шалган **1234** тохиолдол буюу 34,0%-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр **2296** тохиолдолд буюу 63,2%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт **2614** буюу 27,8%, 6-19 хоногт **1029** буюу 10,95%-ийг шалгасан.

Гэмт хэрэг

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний болон сүүлийн жилийн байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийг сонгон авч тоймлон дүгнэсэн болно.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2011 онд нийт гэмт хэргийн шинжтэй 1060 гомдол, мэдээллийг шалгаад 149 (14,0%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 266 (25,0%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, 2016 онд нийт гэмт хэргийн шинжтэй 1580 гомдол мэдээллийг шалгаад 185 (11,7%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 370 (23,4%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь судалгаанд хамрагдсан эцсийн жил 2016 онд хүлээн авсан гомдол, мэдээлэл нь судалгааны эхний жил 2011 оны дүнгээс +520 нэгжээр өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл +110 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэсэн +36 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан +104 нэгжээр өссөн бөгөөд нийт дүнгээр нь шинжлэн үзвэл бүх үзүүлэлт жил бүр тогтмол өссөн цаашид өсөх хандлагатай байна. (Хүснэгт VIII.7.2.), (Хүснэгт VIII.7.3.)

Гэмт хэргийн илрүүлэлтийн нөхцөл байдал

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2011-2016 онд нийт 1087 (өсөлт 11,84%) гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 654 (илрүүлэлт 73,4%), хүндэвтэр 373 (илрүүлэлт 52,9%), хүнд 47 (илрүүлэлт 83,3%), онц хүнд 13 (илрүүлэлт 100%), илрээгүй хэрэг 128 үүнээс хулгайлах гэмт хэрэг 18 нэгж, танхайрах гэмт хэрэг 3 нэгж, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 7 нэгжээр тус тус өссөн байдал нь ихэнх хувийг эзэлж байгаа дүн мэдээлэл (*ирүүлсэн зарим тоон мэдээлэл зөрүүтэй байгаа нь өмнөх оны илрээгүй хэргийн дүн нэмэгдсэн байх магадлалтайг анхаарах хэрэгтэй*) гарсан байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд судалгаанд хамрагдсан эхний 2011 онд нийт 119 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 65, илрүүлэлт 54,6 хувь, хүндэвтэр гэмт хэрэг 49, илрүүлэлт 41,1 хувь, хүнд гэмт хэрэг 2, онц хүнд гэмт хэрэг 3, харин гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 16 байгаагаас хулгайлах гэмт хэрэг 30, танхайрах гэмт хэрэг 6, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 байсан бол 2016 оны байдлаар нийт 207 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 116, илрүүлэлт 84,9%, хүндэвтэр гэмт хэрэг 80, илрүүлэлт 66,7%, хүнд гэмт хэрэг 9, илрүүлэлт 66,7%, онц хүнд гэмт хэрэг 2, гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 23, нийт гэмт хэргээс хулгайлах

гэмт хэрэг 48, танхайрах гэмт хэрэг 9, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 13 (*ирүүлсэн зарим тоон мэдээлэл зөрүүтэй байгаа нь өмнөх оны илрээгүй хэргийн дүн нэмэгдсэн байх магадлалтайг анхаарах хэрэгтэй)* бүртгэгдсэн байна. (Хүснэгт VIII.7.3)

Дүгнэлт: Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллийг Улсын хэмжээний дүнтэй харьцуулвал нийт гомдол, мэдээллийн 0,5%, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 0,74%, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн 0,53%, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 0,72%, шалгасан нийт хэргийн хувьд хөнгөн 0,94%, хүндэвтэр 0,56%, хүнд 0,45%, онц хүнд 0,43%, илрээгүй хэрэг 0,48%, хулгайлах гэмт хэрэг 1,14%, танхайрах гэмт хэрэг 2,74%, ТХХАБАЖЭГХ 93 нэгж тус тус эзэлж байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд хууль сахиулах, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд мөрдөн шалгасан нийт гэмт хэргийн 94,4% нь ил цагаан үйлдэлтэй хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг шалгасан төдийгөөр ихээхэн цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө зарцуулсан нь зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг бараг шалгаагүй[7], урьдчилан сэргийлсэн тоон мэдээлэл тодорхойгүй учир хангалтгүй ажилласан гэж дүгнэхэд хүрч байна.

Аймгийн байгаль, цаг уур, тээвэр, харилцаа холбоо, үйлдвэр, үйлчилгээний нөхцөл байдлын хувьд улсын нийт эдийн засаг, авто болон төмөр замын тээврийн ачаа, зорчигч тээврийн эргэлтийн хэмжээ эрс өссөнтэй холбоотой нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй, урьдчилан сэргийлсэн ажлын мэдээлэл байхгүй байна.

Мөн улсын хэмжээнд хүлээн авч шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, шалгасан гэмт хэрэгтэй харьцуулахад хүнд, онц хүнд ангиллын гэмт хэргийн илрүүлэлтийн хувь харьцангуй бага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх зохион байгуулалт, арга зүй, болон мэргэжлийн чадвар, сэтгэлгээ, хандлагыг эрс сайжруулах шаардлагатай байгааг илэрхийлнэ. (Хүснэгт VIII.7.4, VIII.7.5)

Хүснэгт VIII.7.2. Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

№	ХСБ	Хүлээн авсан нийт гомдол, мэдээлэл	Гэмт хэргийн шинжтэй	ЭХҮ	ЭХҮТ	ГХБ-гүй	Шийдвэрлэсэн хоног	
							0-5	6-19
2011 оны дүн								
1	Улс	128664	59376	23405	33356	32974	28763	30612
2	Говьсүмбэр	1060	445	149	266	231	281	164
2012 оны дүн								
1	Улс	141276	62371	24273	36615	36167	31743	30628
2	Говьсүмбэр	1022	420	179	218	180	318	102
2013 оны дүн								
1	Улс	171438	79983	93984	51139	50403	39533	40380
2	Говьсүмбэр	1474	549	196	329	288	431	118
2014 оны дүн								
1	Улс	450967	93984	29940	63245	62439	45337	48647
2	Говьсүмбэр	2167	883	299	574	570	659	238
2015 оны дүн								
1	Улс	471556	96661	30439	65885	64293	45568	51093

7 Эдийн засгийн салбар дахь гааль, татвар, төмөр замын тээвэр, банк санхүү, төсвийн хууль тогтоомж зөрчсөн хүнд, онц хүнд ангиллын зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж үзэх үндэслэлгүй тул Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэхэд хүргэж байна.

2	Говьсүмбэр	2093	777	226	539	531	509	268
2016 оны дүн								
1	Улс	488076	94324	28320	65709	64316	35730	58694
2	Говьсүмбэр	1580	555	185	370	388	416	139
2011–2016 оны нийт дүн								
1	Улсын дүн	1851977	486699	230361	315949	310592	226674	260054
2	Говьсүмбэр	9396	3629	1234	2296	2188	2614	1029

Хүснэгт VIII.7.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг (ангилал, өндөр үзүүлэлттэй гэмт хэрэг)

№	ХСБ	Бүртгэсэн нийт гэмт хэрэг	Өсөлт, бууралт хувь	хөнгөн	Илрүүлэлт хувь	хүндэвтэр	Илрүүлэлт хувь	хүнд	Илрүүлэлт хувь	Онц хүнд	Илрүүлэлт хувь	Илрээгүй гэмт хэрэг	Хулгайлах гэмт хэрэг	Танхайрах гэмт хэрэг	ХАБ
2011 оны дүн															
1	Улс	19197	-3,2	**7977**	58,0	**8889**	60,1	**1823**	72,2	**508**	89,3	2505	2059	113	1870
2	ГС	**119**		65	70,6	**49**	54,2	**2**		**3**	100	16	30	6	7
2012 оны дүн															
1	Улс	22089	15,1	**9637**	53,8	**10041**	55,9	**1914**	64,3	**497**	77,1	3555	2444	189(13)	1999
2	ГС	**160**	34,5	**87**	68,8	**62**	60,7	**7**		4	100	18	28	10	15
2013 оны дүн															
1	Улс	25362	14,8	**11648**	62,0	**11514**	54,7	**1766**	68,1	**434**	85,5	4528	3471	169	2148
2	ГС	**179**	11,9	**115**	53,3	**52**	38,5	**9**	...	**3**	100	16	30	7	22
2014 оны дүн															
1	Улс	27318	7,7	**13057**	60,9	**11951**	54,9	**1781**	67,2	**529**	88,0	5215	3674	(460)	2143
2	ГС	**211**	17,9	**138**	80,8	**63**	26,9	**9**		**1**	100	30	38	4	17
2015 оны дүн															
1	Улс	27757	1,6	**13487**	64,1	**12127**	58,9	**1628**	72,9	**515**	88	5278	3857	(498)	2010
2	ГС	**211**		**133**	82,2	**67**	70,7	**11**	100			25	48	13	19
2016 оны дүн															
1	Улс	27167	-2,1	**13519**	68,5	**11767**	58,8	**1393**	76,4	**488**	91,9	5331	3917	(357)	1783
2	ГС	**207**	-1,9	**116**	84,9	**80**	66,7	**9**	66,7	**2**		23	48	9	13
2011–2016 оны нийт дүн															
Дүн	**Улс**	148890	33,9	69325	61,2	66289	57,2	10305	70,1	2971	86,6	26412	19422	1786	11953
	ГС	**1087**	**11,84**	654	73,4	373	52,9	47	83,3	13	100	128	222	49	93

Хүснэгт VIII.7.4 Гэмт хэргийн төрөл

№	ХСБ	79-90	Илрүүлэлт хувь	91-107	Илрүүлэлт хувь	145-155	Илрүүлэлт хувь	175	Илрүүлэлт хувь	177-191	Илрүүлэлт хувь	215-225	Илрүүлэлт хувь	263-273	Илрүүлэлт хувь
2011 оны дүн															
1	Улс	96		6462		7232		54		1873		1870		101	
2	ГС	-	-	**57**		39				8		7		2	
2012 оны дүн															
1	Улс	138	93,9	7155	74,6	9023	51,6	66	57,1	1749	65,4	1999	72,4	110	5,0
2	ГС	-	-	**78**		40				11		15		00	
2013 оны дүн															
1	Улс	54	12,5	8156	85,0	11118	51,8	98	20,0	1894	77,4	2148	78,5	106	
2	ГС	-	-	**98**		40				8		22		1	
2014 оны дүн															
1	Улс	45	21,4	8697	85,1	8424	49,4	69	22	1750	74,3	2143	84,8	135	
2	ГС	-	-	**106**		67				6		17		4	
2015 оны дүн															
1	Улс	10		8468	89,0	13445	56,1	42		1630	79,8	2010	85,9	128	66
2	ГС	-	-	**92**		74				13		19			
2016 оны дүн															
1	Улс	36	50	8691	88,7	13336	56,8	40	100	1479	75,6	1783	87,8	111	
2	ГС	-	-	**91**		73				9		13		2	
2011–2016 оны нийт дүн															
Дүн	Улс	389		47629	84,4	62578	53,1	369	25,0	10375	74,5	11953	81,0	681	
	ГС	-	-	**152**		301		37		19		22		1	

Хүснэгт VIII.7.5. Прокурорын байгууллагаас гомдол, мэдээллийг хянан, шийдвэрлэсэн байдал

№	Хянасан нийт гомдол мэдээлэл	ЭХУ	ЭХУТ	Эрүүгийн хэрэг үүссэн				Шүүхэд шилжүүлсэн	Хэрэгсэхгүй болгосон	Хэрэгсэхгүй болсон үндэс		
				Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Онц хүнд			Бүр/гүй	Эвлэрсэн	Бусад
Аймгийн Прокурорын газрын хүлээн авсан, хянан, шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
1	2769	936	1821	515	373	51	16	237	606	84	392	130
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		33,8	65,7	55,0	39,8	5,4	1,7	25,3	64,7	13,8	64,6	21,4
Улсын хэмжээнд хүлээн авсан, хянан, шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
2	367393	121128	244453	53667	68321	10395	3459	24379	85412	19640	38359	27413
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		32,9	66,5	44,3	56,4	8,5	2,8	20,1	70,5	23	44,9	32,1
ГС аймгийн прокурорын хувьд улсын хэмжээний дүнтэй харьцуулалтын хувь (2013-2016 он)												
3	**0,75**	**0,77**	**0,74**	**0,95**	**0,54**	**0,49**	**0,46**	**0,97**	**0,7**	**0,42**	**1,02**	0,47

1.2 Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн криминологи шинж

Тайлбар: Гэмт хэрэгт холбогдогсдын криминологи шинжийг үндэсний аюулгүй байдлын эсрэг, эрх, эрх чөлөөний эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, гаалийн хууль тогтоомж зөрчсөн, танхайрах, ТХХАБАЖЭсрэг, албан тушаалын гэсэн гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувийн жинтэй 6 төрлийн гэмт хэргийг сонгон авч шинжлэсэн болно. Судалгааг сүүлийн **6** жилээр авч үзлээ. **(Хүснэгт VIII.7.6.)**

Гэмт хэрэгт холбогдогсдын хүйс, нас, боловсрол

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2011-2016 онуудад нийт 1111 хүн холбогдсоноос 180 эмэгтэй, бүлэглэсэн 204, согтуугаар 511, насанд хүрээгүй хүн 42, насны хувьд 18-34 насны 635, 35-дээш насны 434, ажил эрхлэлтийн хувьд төрийн албаны 97, хувийн салбарын 440, оюутан сурагч 66, ажилгүй 509, боловсролын хувьд бага 464, дунд 394, тусгай боловсролтой 70, дээд 186 байна.

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний 2011 он, сүүлийн 2016 оны байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдлыг 2011 оныхтой харьцуулахад 2016 онд нийт 218 буюу 95 хүнээр өссөн нь харьцангуй өсөх хандлагатай, хүйсийн хувьд: 41 эмэгтэй буюу 24-р өссөн, насны хувьд: 9 хүүхэд буюу 2-р өссөн, 18-34 насны 141 буюу 61-р өссөн, 35-70 насны 68 буюу 32-р өссөн, ажил байдлын хувьд: Төрийн албан хаагч 19 буюу 9-р өссөн тогтвортой, хувийн секторын ажилтан 90 буюу 50-р өссөн, оюутан, сургачид 11 буюу 1-р өссөн тогтвортой, ажилгүй 98 буюу 35-р өссөн, оролцооны хувьд бүлэглэж 36 буюу 5-р өссөн, боловсролын хувьд: бага 70-80 буюу харьцангуй тогтвортой, дунд 84 буюу 46-р өссөн, тусгай 25 буюу 23-р өссөн, дээд 44 буюу

31-р өссөн үүнээс согтуу 85 буюу 19-р өссөн байгаа нь харьцангуй тогтвортой мэт боловч тээврийн салбарын онцлогтой холбоотой үзүүлэлт тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. (Хүснэгт VIII.7.6.)

Дүгнэлт: Улсын хэмжээний дүнтэй харьцуулж үзэхэд төрийн болон хувийн салбарын дунд, дээд боловсролтой оролцогч нар, бүлэглэж үйлдэх гэмт хэрэг зэрэг онцлог үзүүлэлтээр 25-50 хувь өсөх хандлагатай байгаа нь уул уурхай, авто зам, төмөр замын тээврийн салбарын эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, үйлчилгээ, ачаа, зорчигч тээврийн эрчимтэй эргэлттэй холбоотойгоор дундаж настай, мэдлэг боловсролтой хүмүүс бүлэглэж гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байгааг илэрхийлнэ.

Хүснэгт VIII.7.6. Гэмт хэрэг үйлдэгсэд

№	ХСБ-га	Бүх хүн	эм	бүлэг	ЗБ-тай бүлэг	согтуу	Нас			Ажлын байдал				Боловсрол			
							НХХ	18-34	35-70	Төрийн	Хувийн	Оюутан сурагч	ажилгүй	бага	дунд	тусгай	дээд
2011 оны дүн																	
1	Улс	17982	2303	2117	3	4312	1136	11357	5462	664	2742	1209	10238	2899	8663	548	2493
2	ГС	**123**	**17**	**31**	**00**	**66**	**7**	**80**	**36**	**10**	**41**	**10**	**63**	**70**	38	2	13
2012 оны дүн																	
1	Улс	19734	2667	4030	23	4791	1248	12320	6166		1764	1316	10639	2808	8403	616	3305
2	ГС	162	23	39	00	72	3	96	63	13	67	8	74	76	60	5	21
2013 оны дүн																	
1	Улс	22286	3137	4205	10	5695	1222	13766	7271	988	541	1575	11558	3084	14674	723	3816
2	ГС	184	33	33	00	90	7	108	69	18	58	15	93	82	64	11	27
2014 оны дүн																	
1	Улс	23737	3618	2732	2	6686	1250	14481	8006		6900	1581	11966	3073	15250	876	4395
2	ГС	201	25	30	00	95	7	101	93	18	79	13	91	85	66	13	37
2015 оны дүн																	
1	Улс	24857	3782	4624		5465	1402	15088	8363	1018	7178	644	12820	3251	1600	836	4755
2	ГС	223	41	35	00	103	9	109	105	19	105	9	90	83	82	14	44
2016 оны дүн																	
1	Улс	23805	3592	3722	4	5507	1265	14422	8218	835	4927	1310	13143	2897	15494	834	4580
2	ГС	**218**	**41**	**36**	**00**	**85**	**9**	**141**	**68**	**19**	**90**	**11**	**98**	**68**	**84**	**25**	**44**
Нийт	Улс	132401	19099	21430	42	32456	7523	81434	43486	946	24052	7635		18012	64084	4433	23344
	ГС	1111	180	204	00	511	42	635	434	97	440	66	509	464	394	70	186

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, орон зай

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний жил 2011 он, сүүлийн жил 2016 оны байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн

болно. Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2011 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагын 1, 2 дахь өдрүүдэд, цагийн хувьд 19-22, 22-06 цагийн хооронд харин 2016 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагын 1, 4 дэх өдөр, цагийн хувьд 06-14, 22-06 цагийн хооронд гэмт хэргийн түвшин өндөр хувьтай байгаа нь авто замын болон галт тэрэгний цагийн хуваарь, ачаалал, галт тэрэгний буудлын үйлчилгээний хүрээ, төрөл, хуваарьтай шууд холбоотой байсан боловч жилийн аль сарын хэд дэх 10 хоногт гэмт хэрэг үйлдэгдэж байгаа байдлаар гэмт хэргийн түвшинг тодорхойлох мэдээлэл байхгүй байсан болно. (Хүснэгт VIII.7.7.)

Говьсүмбэр аймгийн хэмжээнд гэмт хэрэг үйлдэгдэж байгаа орон зайн хувьд аймгийн онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээ, зам тээврийн салбарын онцлогтой холбоотой авто замын тээвэр, суудлын галт тэрэгний буудлын орчин, үйлчилгээний байгууллагуудын ажилчид, албан хаагчид албан үүрэгт хамааралтай гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Хүснэгт VIII.7.7. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг

№	ХСБ-га	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2011 оны дүн												
1	Улс	3407	2815	2843	2819	2850	2217	2246	3251	5115	3554	7277
2	ГС	20	26	13	17	15	16	12	16	25	19	59
2012 оны дүн												
1	Улс	3593	3342	3243	3212	3202	2714	2783	3814	5664	3956	8658
2	ГС	25	25	23	19	25	17	26	28	31	27	74
2013 оны дүн												
1	Улс	4067	3875	3765	3778	3707	3140	3030	4532	6405	4541	9884
2	ГС	24	23	21	24	26	35	26	33	33	44	69
2014 оны дүн												
1	Улс	4655	4178	4115	3937	4093	3192	3148	5758	7326	4434	9800
2	ГС	38	22	29	30	22	29	41	33	52	40	86
2015 оны дүн												
1	Улс	4655	4266	4159	4127	4028	3328	3194	6056	7948	4326	9427
2	ГС	25	29	26	34	25	39	33	44	49	25	93
2016 оны дүн												
1	Улс	4280	4157	4018	4019	3979	3424	3280	5884	7782	4109	9392
2	ГС	36	31	28	33	28	23	28	45	43	25	94
Дүн	Улс	24657	22633	22143	21892	21859	18015	17681	29295	40240	24920	54438
	ГС	168	156	140	157	151	159	166	199	233	180	475

Гэмт хэргийн хохирогч болон хохирлын байдал

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний жил **2011 он,** сүүлийн жил **2016 оны** байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт хохирсон болон хохирлын байдлыг 2011 оныхтой харьцуулахад 2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 221 хүн хохирсон буюу 101-р өссөн, эмэгтэй 92 буюу 50-р өссөн, хүүхэд 13 буюу 9-р өссөн, 18-34 насны 107 буюу 55-р өссөн, 35-70 насны 101 буюу 37-р өссөн, гэмт хэргийн улмаас нийт 792,6 орчим сая төгрөгийн хохирол буюу 553,0 сая төгрөгөөр өссөн үүнээс хөнгөн гэмт хэргийн улмаас 471,6 сая төгрөг буюу 321,9 сая төгрөгөөр өссөн, хөнгөн гэмт хэрэг 111,6 сая төгрөг буюу 78,7 сая төгрөгөөр өссөн, хүндэвтэр 227,6 орчим сая төгрөг буюу 159,5 сая төгрөгөөр өссөн, хүнд 128,2 сая төгрөг буюу 111,2 сая төгрөгөөр өссөн, үүнээс хэрэг бүртгэлтийн явцад 87,6 сая буюу 58,7 сая төгрөгөөр өссөн, мөрдөн байцаалтын явцад 218,0 сая буюу 145,7 сая төгрөгөөр өссөн дүнтэй хохирол нөхөн төлүүлсэн нь бүх үзүүлэлт эрс өссөн.

Харин нийт хохирлоос нөхөн төлүүлэлт 64,8%-тай байсан нь нэг талаас сайн үзүүлэлт боловч нөгөө талаас хөнгөн, хүндэвтэр "ил цагаан" үйлдэлтэй гэмт хэргийн нөхөн төлүүлэлт гэдгийг анхаарах ёстой.

Дүгнэлт: Эндээс харвал хохирогчийн тоо, хохирлын хэмжээ тогтвортой өссөн нь үйлчилгээний салбарын болон зам тээврийн хөгжилтэй холбоотой авто зам, төмөр замын тээврийн ачаа, зорчигчийн эргэлт, үйлчилгээний эрчимтэй өсөлт, мөнгөний ханш, үнийн инфляцтай холбоотой байх магадлалтай, учир нь нөхөн төлүүлэлт харьцангуй сайн төдийгүй хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт ногдох хувь өндөр учир төлүүлэлт хялбар байх магадлалтай.

Энэ нь нэг талаас сайн үзүүлэлт мэт боловч нөгөө талаас зохион байгуулалттай, хүнд, онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудал байгааг илтгэнэ. Цаашид хохирлын хэмжээ эрс өсөх хандлагатай. (Хүснэгт VIII.7.8.)

Хүснэгт VIII.7.8. Хохирогч, хохирлын байдал

№	ХСБ-га	Нийт хохирогч	Эм	НХХ	Хохирогчийн нас		Хохирол Сая ₮	Хөнгөн гэмт хэрэгт сая ₮.	Хүндэвтэр гэмт хэрэг Сая ₮	Хүнд гх	Онц хүнд гэмт хэрэг Сая₮	Төлөлт, Сая₮	ХБ Сая₮	МБ Сая₮
					18-34	35-70								
2011 оны дүн														
1	Улс	18592	6856	1178	9116	8298	35904,1	4226,4	19986,0	4713,0	6978,8	18490,4	2603,8	15886,6
2	ГС	120	42	4	52	64	149,7	32,9	67,2	17,0	32,6	101,2	28,9	72,3
2012 оны дүн														
1	Улс	21294	7977	1200	10540	9567	53263,2	6613,2	22223,1	14564,8	9862,2	25135,6	4409,6	20726,0
2	ГС	140	48	8	64	68	138,7	44,1	58,8	0,1	35,8	47,4	40,3	7,1
2013 оны дүн														
1	Улс	25015	9838	1426	12316	11273	159024,2	9433,2	87481,9	37049,2	25059,9		6582,2	
2	ГС	199	74	9	89	101	224,5	71,8	132,8	12,0	8,0	148,3	39,4	108,9
2014 оны дүн														
1	Улс	27475	10902	1576	13420	12479	148204,6	13800,7	34202,4	61890,7	38370,9	43652,5	9195,9	34456,6
2	ГС	229	68	17	101	111	1146,1	91,7	94,8	5,5	954,1	78,7	50,0	28,7
2015 оны дүн														
1	Улс	27948	11207	1477	13528	12943	144341,4	15388,4	45783,3	38075,5	45094,2	48997,8	10224,2	38773,5
2	ГС	241	92	11	115	115	1164,0	760,3	336,4	67,4	0,00	468,6	240,3	228,3

2016 оны дүн														
1	Улс	27689	11346	1340	13306	13043	162909,4	16585,8	40518,4	67975,0	37830,2	43964,0	11320,4	32643,5
2	ГС	221	92	13	107	101	471,6	111,6	226,7	128,2	5,0	305,6	87,6	218,0
Нийт	Улс	148013	58126	8197	72212	67603	150845,3	66047,7	250195,1	224268,2	163196,2	131242,5	44336,1	142486,2
	ГС	1150	416	62	528	560	3294,6	1112,4	916,7	227,2	1036,0	1149,8	486,5	662,1

1.1 Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа зөрчлийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний жил 2011 он, сүүлийн жил 2016 оны байдлаар зөрчлийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа "танхайрах", "тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг"[8], "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" зэрэг төрлийг сонгон авч тоймлон дүгнэсэн болно.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2012-2016 онд нийт 45681 зөрчилд 40424 хүн холбогдуулан бүртгэж 631,7 сая төгрөгөөр торгосон, үүнээс торгуулийн тасалбараар 37217 зөрчилд 435,3 сая төгрөгний торгуул ногдуулсан. Тус салбарт бүртгэгддэг зонхилох зөрчлөөс "танхайрах" зөрчил 1777-г бүртгэн 9,1 сая төгрөгний торгуул, "ТХХАБАЖурам" зөрчсөн 33437 зөрчил бүртгэж 393,8 сая төгрөгөөр торгож, "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" 58 зөрчилд 0,3 сая төгрөгний торгуул ногдуулсан байна. Энэ нь нийт зөрчлийн 77,2%, торгуулийн 64 орчим хувь эзэлж байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2016 онд зөрчлийн байдал, төрөл болон торгуулийн дүнг 2012-2015 оныхтой харьцуулахад 2016 онд нийт зөрчил 14178 буюу 3213-10697-р өссөн, холбогдсон хүн 13873 буюу 3308-10722-р өссөн, торгуулийн хэмжээ 435,992 сая төгрөг буюу 417,115-337,239 сая төгрөгөөр өссөн, торгуулийн тасалбараар 13081 хүн буюу 3534-10163 хүнээр өссөн, тогруулийн хэмжээ 269,178 сая төгрөг буюу 197,735-256,989 сая төгрөгөөр өссөн үүнээс танхайрах зөрчил 708 буюу 285-460-р өссөн, торгуулийн хэмжээ 3,5 сая буюу 1,41-2,28 сая төгрөгөөр өссөн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил 12223 буюу 9064-9659-р өссөн, торгуулийн хэмжээ 291,55 сая буюу 252,5-280,71 сая төгрөгөөр өссөн, цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй зөрчил 46 буюу 39-44-р өссөн, торгуулийн хэмжээ 0,275 сая төгрөг буюу 0,24-0,26 сая төгрөгөөр өссөн байна.

Дүгнэлт: Говьсүмбэр аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, зам харилцааны хөгжлийн онцлогтой холбоотойгоор нутаг дэвсгэрийн нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг хэдий ч авто болон төмөр замын тээврийн салбарын дамжин өнгөрдөг замын сүлжээний төвд байдаг учир жилд 2,5 сая орчим зорчигч, 50 мянга орчим үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг баталгаатай хангаж ажиллах учиртай.

Гэтэл зөрчлийн бүртгэл жил бүр харилцан адилгүй хэдий ч цаашид улам бүр өсөх хандлага ажиглагдаж байгаа нь хууль сахиулах үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, арга зүйг мэргэжлийн үүднээс зохион байгуулж хэрэгжүүлэх, үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бүрэн хянаж чадахгүй байгаагаас урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй гэж дүгнэх үндэслэлтэй.

8 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэл, 2015 он, №28 дугаарт нийтлэгдсэн.

ГУРАВ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГХУСАЗСЗӨВЛӨЛИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Өмнөх 2014 онд батлагдсан ГХУСАЗСЗөвлөлийн бүрэлдэхүүнд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллагуудын удирдах ажилтнууд гишүүнээр ажиллаж байсан бол 2016 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан ГХУСАЗСЗөвлөлийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, иргэн, хүүхдийн байгууллагын төлөөлөл орсноор өсвөр насны хүүхдийн нийгмийн харилцаа, эрх зүйн харилцаанд оролцоход анхан шатны мэдлэг мэдээлэл олгох, иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог өргөтгөх, төрөөс баримталж буй бодлого шийдвэр, хуулийн хэрэгжилтийг хангах зэрэг олон давуу тал гарна гэж үзэж байна.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь 4 бүлэг 27 зүйлтэй төлөвлөгөө боловсруулан хурал, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зэрэг нийт 19 төрлийн ажил зохион байгуулж давхардсан тоогоор 9600 орчим иргэнийг хамруулсан байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аймгийн ИТХ-ын шийдвэрээр 30 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 26,5 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан.

Улсын хэмжээнд мөрдөн ажиллаж буй ЕБС, түүний орчинд сурагчид бага насны хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хэв журам зөрчих, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг, эх асран хамгаалагчдыг эргүүлд гаргах "School police" арга хэмжээг зохион байгуулж, нутаг дэвсгэрийн онцлогт зохицуулан Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргын 2016 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/05 дугаар захирамжаар "School police"-ийн ажиллах журам, удирдамж, төсвийг батлан гаргаж ЕБС-иудад хүргүүлсэнээр мөрдөн ажиллаж байна.

"Албадан эмчилгээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус аймагт наркологийн эмч байхгүйн улмаас Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн захиргаанд хүсэлт гаргаж, сэтгэц, наркологийн эмчийг урьж байнга архидан согтуурдаг 6 иргэнийг шүүхэд шилжүүлэн албадан эмчилгээнд эмчлүүлэх шийдвэрээр 5 иргэнийг согтуурах мансуурах донтой этгээдийн албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх төвд эмчлүүлэхээр хүргүүлсэн.

Мал хулгайлах, ой хээрийн түймэр, хууль бус ан агнуурын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар хамтран аймгийн салбар зөвлөлөөс санхүүжилт гаргуулж Баянтал сумын 2 дугаар баг, Сүмбэр сумын 5, 6 дугаар багийн 6 нөхөрлөлийн 48 иргэнд "Гал унтраагч үлээгч аппараттай ажиллах, хээрийн түймрийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдвээр дадлага сургуулилтыг 4 удаа зохион байгуулж, эргүүл, хяналт шалгалтын ажлыг тогтмол хийсэн.

Гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хяналтыг сайжруулах зорилгоор хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтын пост дээр орчин үеийн шаардлага хангасан авто машины дугаар таних, хадгалах, сигнал өгдөг "IVMS-5200 professional" праграм, хяналтын камерыг суурилуулсан байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, мэдээлэл цуглуулах, малчдад анхааруулга, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгөх зорилгоор эрсдэлтэй үе буюу 11 сарын 14-өөс 12 сарын 14-ны хооронд Цагдаагийн хэлтсийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх алба аймгийн хэмжээнд хөдөлгөөнт эргүүл явуулсан.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн авто зам дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ суурьлуулж, Хонхор хотхоны 3, 8 дугаар байрны урд, 4 дүгээр байрны хойно, Ханангийн эгнээнд, I сургуулийн зам дагуу 2 ширхэг, II сургуулийн ард хүүхэд зам гардаг хэсэгт, НИК шатахуун түгээх станцаас Дугуй дэлгүүр

орох замд нийт 8 ширхэг хурд сааруулагч, анхааруулга тэмдэг 8 ширхэг, замын тусгаарлагч анхааруулах товруу (анивчдаг) 60 ширхэгийг байрлуулсан.

Бага ангийн хүүхдүүдэд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБС-иудын 3-5 дугаар ангийн хүүхдүүдийн дунд "Ногоон гэрэл цагаан шугам" тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, ААН, байгууллагуудыг 12 дугаар сараас эхлэн эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэхээр аймгийн ИТХ-ын даргын захирамжаар хуваарийг батлан эргүүлийн ажлыг зохион байгуулж байна. Тус арга хэмжээг Цагдаагийн хэлтэс хариуцан зохион байгуулж байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Сар шинэ", "Архи, тамхигүй ирээдүй", "Хяналт-1", "Хяналт-2", "Судалгаа хяналт", "Хулгай", "Хичээлийн шинэ жил-2016", "Сургуулийн орчны хяналт шалгалт", "Зөрчил", "Шинэ жил", "Хяналт шалгалт", "Сэрэмжлүүлэг", "Захиргааны хяналт", "Архи-шалгалт" нэгдсэн арга хэмжээ, "Согтуу", "Сэрэмж", "Албадан эмчилгээ", "Судалгаа-хяналтын сан", "Оюутан-цагдаа", "Хяналт" зэрэг арга хэмжээг 28 удаа зохион байгуулсаны үр дүнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 5.5 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4.2%-аар тус тус буурсан ба захиргааны зөрчлийн илрүүлэлт 37,3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сүмбэр сумын нутаг дэвсгэрт "Согтуу", "Хяналт Шалгалт", "Хороолол такси", "Хулгайн тээвэр", "Зорчигч хамгаалах бүс" арга хэмжээг 5 удаа, Шивээговь, Баянтал сумдын нутаг дэвсгэрт "Хурд ба хяналт" арга хэмжээг Замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн Босоо тэнхлэгийн хатуу хучилттай зам дагуу үзлэг шалгалтыг 2 удаа зохион байгуулсан.

Аймгийн Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасагт "Police reader" буюу бэлэн бус торгуулийн пос машин 6 ширхэгийг ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн торгуулийн хуудас, пос машины цаас зэрэг шаардлагтай техник хэрэгслийг ГХУСАЗСЗөвлөлөөс санхүүжүүлсэн байна.

ААН, байгууллагад гадна, дотны гэрэлтүүлэг болон хяналтын камерыг өөрийн хөрөнгөөр хийх талаар зөвлөмж хүргүүлсэний мөрөөр 2016 онд нийт 31 ААН, байгууллага хяналтын камер болон гэрүүлтүүлэг хийсэн нь өөрсдийн болон нийтийн эзэмшлийн газарт гарсан гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд үр дүнгээ өгч байна.

Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг, донтох өвчтэй болсон иргэдийг нийгэмшүүлэх, архинаас түдгэлзүүлэх зорилгоор АА бүлгэмтэй хамтран 4 удаа уулзалт сургалтыг зохион байгуулсан. Уулзалт сургалт хийснээр 3 иргэн архинаас татгалзан АА бүлгэмд нэгдэн орж нийгэмшиж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хуулийн байгууллагуудын дунд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2016 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалт, хэлэлцүүлэгт аймгийн Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, ИТХ-ын ажлын алба, Цагдаагийн хэлтэс, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэл, статистикийн хэлтсийн нийт 53 албан хаагч хамрагдлаа. Сургалтыг аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн гишүүн, Шүүхийн тамгын газрын дарга Д.Сувд удирдан зохион байгуулж Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт хийсэн судалгаа, шүүхийн бүтэц зохион байгуулалт, шүүхийн шинэтгэлийн

10 үр дүн, Эрүүгийн хуулийн танилцуулга зэрэг сэдвээр сургалт явуулсан. Сургалт хэлэлцүүлгээр өнөөдрийн байдлаар Говьсүмбэр аймагт ямар төрлийн гэмт хэрэг ихээр гарч байна, үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаж зохион байгуулах вэ? гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүсийн нас, мэргэжил, боловсрол зэргийг судалж гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалддаг болон түүгээр үйлчилгээ үзүүлдэг ААН, байгууллагыг хэрхэн зохицуулах, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах ажлыг ямар байдлаар зохион байгуулвал үр дүнд хүрэх талаар хэлэлцэж цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөж зохион байгууллаа.

Аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэлтэстэй хамтран "Хувь хүний харилцаа" сэдэвт сургалтыг аймаг, сумдын ИТХ-ын ажилтнууд, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдыг хамруулан 2016 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр Цагдаагийн хэлтсийн хурлын танхимд "Хувь хүний хөгжлийн институт"-ын лектор багш нар 3 цагийн хөтөлбөртэй явуулж, нийт 72 ажилтан, албан хаагч хамруулсан. Сургалтаар ажилтан, алба хаагчийн харилцааны ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх, нэр төр, хүнлэг чанар, нинжин сэтгэлийн мөн чанарыг таниулах, алба хаагчдын хоорондын харилцааны соёлыг төлөвшүүлэхэд үр дүнгээ өгсөн байна.

Хорих газраас суллагдсан болон тэнсэн харгалзахаар шийдвэрлэсэн захиргааны хяналтад байгаа 29 хүнд хяналт тавьж тэдгээрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дахин гэмт хэрэг зөрчилд холбогдуулахгүй байх талаар сум багийн Засаг дарга, Хөдөлмөрийн хэлтэс, Аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг 4 удаа зохион байгуулан 2 иргэнийг ажлын байраар ханган ажилласан байна. 2016 онд 13 этгээдийн хувийн хэргийг шинээр нээж хяналт тавин биечлэн уулзаж, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх баталгаа гаргуулан, хилийн хориг тавих саналыг хүргүүлсэн.

Архи, тамхины хор нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх санамж 896, сэрэмжлүүлэг 3061 ширхэгийг тарааж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан арга хэмжээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалт, мэдээ, мэдээлэл, шторк, зэргийг орон нутгийн Холбооны газрын кабелийн телевиз, 3-р багийн нутаг дэвсгэрт байрлах LED дэлгэц, аймгийн ЗДТГ, "Нэг цэгийн үйлчилгээ"-ний хүлээлгийн танхимын LCD дэлгэцээр 24, "Чойрын толь" сонинд хэвлүүлэн олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн зохицуулалтаар 21 байгууллага, ААН-ийн 1456 ажилчид, 5 сургуулийн 1050 сурагч, Политехник коллежийн 3 ангийн нийт 1256 оюутныг оролцуулан сургалт зохион байгуулсан.

Орон байрны болон мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэн холбооны Жи-Мобайл, Юнитейл, Скайтел, Мобиком утасны хэрэглэгчдэд сэрэмжлүүлэгийг 2 удаа 4550 иргэнд хүргэн ажилласан. Архи, тамхины хор нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх санамж 250, сэрэмжлүүлэг 350 ширхэгийг тарааж, орон нутгийн Холбооны газрын кабелийн телевиз, 3-р багийн нутаг дэвсгэрт байрлах LED дэлгэц, аймгийн Засаг даргын тамгын газар, "Нэг цэгийн үйлчилгээ"-ний хүлээлгийн танхимын LCD дэлгэцээр 6, "Чойрын толь" сонинд 2 удаа олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан.

Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж байгаа "Дэлхийн зөн" олон улсын байгууллагын төлөөлөгч нартай хамтран 2016 оны 1 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн 40 оролцооны бүлгийн сурагчдын дунд өсвөр насны хүүхдийн өнөөгийн тулгамдаж байгаа асуудал сэдвээр ярилцлага зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдүүдийн судалгааг гаргаж, хүчирхийлэл үйлддэг 48 хүнийг цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Хууль сахиулахын их сургуулийн багш, цагдаагийн ахлах дэслэгч О.Отгонтуяатай хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сэдвээр Аймгийн Политехник

коллеж, ЕБС-уудын багш, нийгмийн ажилтнуудыг оролцуулан сургалт зохион байгуулсан.

2016 оны 1 сарын 22-23-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Дархан, Баянмөнх, Бор-Өндөр, Сүмбэр, Шивээ, Баянтал сумын хамтарсан багийн нийт 65 гишүүнийг хамруулан "Хамтарсан багийн үйл ажиллагааг чадавхжуулах нь" сэдэвт сургалтыг "Дэлхийн зөн" олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд анхааруулга сэрэмжлүүлэг зөвлөмжийг хөдөөгийн айл өрхүүдэд мессеж болон багийн өдөрлөгөөр цаасан хэлбэрээр тухай бүр хүргүүлэн ажилласан байна.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН БАЙДАЛ

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулж аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн зүгээс багагүй хэмжээний хүн хүч, хөрөнгө мөнгө, техник хэрэгслийн дэмжлэгтэй ажиллаж байгаа боловч[9] үйл ажиллагаагаа шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой тодорхойлж чадахгүй байгаа тул өнөөгийн бодит байдалд тохирсон ажилд зарцуулж чадахгүй байна. Тухайлбал, зөвхөн цөөн тооны хүнд яриа хийсэн, цөөн тооны камер суурилуулсан зэрэг 16-18 төрлийн ажил төлөвлөж гүйцэтгэсэн гэсэн тайлан гаргасан нь хангалтгүй байна.

Шалтгаан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бодитой, оновчтой тодорхойлж, үйл ажиллагаагаа төлөвлөх (прогноз), хэрэгжүүлэхдээ цагдаагийн албан хаагчид урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдлэг хомс, ур чадвар, дадлага хангалтгүй, үйл ажиллагаандаа криминологийн ур дүнг ашиглахгүй байгаа нь судалгаанаас илэрхий байна. Мөн алба хаагчийн харилцааны соёл хангалтгүй байгаатай холбоотой "танхайрах", "замын хөдөлгөөний аюулгүй байдал"-тай холбоотой болон "цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" зөрчил зонхилон бүртгэгдсэн байх тул цагдаагийн байгууллагын нийтлэг чиг үүрэг гүйцэтгэх шинэ мэдлэг, арга зүй, техник технологи нэвтрүүлэх, сайн туршлагыг "нийгмийн гэрээний онол"-д тулгуурлаж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт VIII.7.9. Зөрчил, шийдвэрлэлтийн байдал

№	ХСБ-га	Нийт зөрчил	Хувь (+, -)	Иргэн	Торгууль Сая ₮	Торгуулийн тасалбар торгосон		Танхайрах нийт зөрчил		ХАБ журам нийт зөрчсөн		ХЁШаардлага эсэргүүцсэн	
						Тоо	Сая₮	Тоо	Сая₮	Тоо	Сая₮	Тоо	Сая₮
2011 оны дүн													
1	Улс	653619											
2	ГС	3301											
2012 оны дүн													
1	Улс	795923	21,8	751571	4654,413	627853	3043,012	126018	462,230	502438	238,823	10503	42,23
2	ГС	3481	5,5	3151	18,877	2918	12,189	335	1,265	2564	10,845	3	0,012
2013 оны дүн													
1	Улс	777793	-2,3	726716	4853,349	655728	3029,8	137259	563,539	469677	2242,6	9565	42,684
2	ГС	4313	23,9	3861	23,454	3413	15,150	248	0,93	3159	14,189	00	00
2014 оны дүн													
1	Улс	681222	-12,4	-	5253,6	538473	2973,76	131600	6032,7	369295	2192,42	12761	62,113
2	ГС	9443	118	8974	54,607	8258	40,378	263	1,233	7963	39,001	2	0,01

9 Говьсүмбэр аймгийн ГХУСАЗСЗ-н 2016 оны үйл ажиллаганы тайлан

2015 оны дүн													
1	Улс	1423088	2дах	1372058	17016,3	1279774	14300,4	117008	559,861	786338	5126,278	21720	107,24
2	ГС	10965	16,1	10565	98,753	9547	71,437	423	2,130	7528	38,168	7	0,035
2016 оны дүн													
1	Улс	1034585	-27,3	1001379	30617,3	927639	16749,2	107531	534,062	597524		30412	153,332
2	ГС	14178	29,3	13873	435,992	13081	296,178	708	3,540	12223	291,552	46	0,275
Нийт дүн	Улс	4712611		3850345	62394,9	4029467	117472,1	619416	8152,4	2725272	9800,1	84961	407,59
	ГС	45681	38,2	40424	631,683	37217	435,332	1777	9,098	33437	393,755	58	0,332

ТАВ. САНАЛ

Говьсүмбэр аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, зам харилцааны хөгжлийн онцлогтой холбоотойгоор нутаг дэвсгэрийн үйлчилгээ цогц байдлаар өргөжиж байгаатай уялдуулан аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагааг бодит байдалд тохирсон, үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс цагдаа, хуул сахиулах байгууллагуудыг мэргэжлийн албаны зохион байгуулалт, мэргэшсэн алба хаагчдаар бэхжүүлэх, нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон тодорхой чиглэлээр үйл ажиллагааг мэргэшүүлэн гүйцэтгэх шаардлагтай (зам тээврийн, ачаа тээврийн, уул уурхай зэрэг эдийн засгийн салбарын гэмт хэрэгтэй тэмцэх) болсон байна.

Тайлбар: Хүнд, онц хүнд **ангиллын** гэмт хэрэг тээврийн салбарт үйлдэх магадлал өндөр бөгөөд үндэстэн дамнасан зохион байгуулалттай буюу НҮБ-ын тодорхойлсон 15 төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх магадлал их байна.

Гэтэл Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн онцлогтой холбоотой үйлдэгддэж байгаа гэмт хэрэг шалгаж шийдвэрлэхгүй байгаа нь шинэ нөхцөл байдалд тохирсон сэтгэлгээ, сэтгэл зүй, арга барил, чадвар, туршлагыг шаардаж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хүний нөөцийн удирдлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах, сэтгэлгээтэй, мэдлэгтэй, чадварлаг бүтэц бүхий хамт олныг бүрдүүлэх, хүний хүчин зүйлийг багасгах, ухаалаг технологид суурилсан урьдчилан сэргийлэх ажиллагааг (дүрс, дуу бичлэг, гэрэл зураг, зурагт, радио, хэвлэлийн төрөл зүйлийг өргөн ашиглах) зохион байгуулах шаардлагатай болсон.

ДАРХАН-УУЛ АЙМАГ



8. ДАРХАН-УУЛ АЙМАГ

НЭГ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, НУТАГ ОРОН, САЛБАРЫН ОНЦЛОГ

Дархан хотын анхны суурийн чулууг "Бурхантын хөндий"-д 1961 оны 10 дугаар сарын 17-нд тавьсан. УИХ-ын 1994 оны 32 дугаар тогтоолоор Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон өөрчилсөн. Тус хот нь хуучнаар эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнууд болох ЗХУ, Болгар, Польш, Унгар, Чехословак, Герман зэрэг улсын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар байгуулагдсан. Энэ ч утгаараа Дархан хотыг "Найрамдлын хот" хэмээн нэрлэсээр ирсэн.

Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327,5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70,7% буюу 231,7 мянган га талбайг ХАА-н эдэлбэр газар эзэлдэг. Нийт 91093 хүн амтай, үүнээс 74526 хүн Дархан хотод амьдардаг. Нийт хүн амын 64.5%-ийг 35 хүртэлх насны залуус эзэлнэ. Аймгийн хэмжээнд 24989 өрх байгаагийн 67.5% нь нийтийн орон сууцанд амьдардаг. Засаг захиргааны нэгжийн хувьд Дархан, Орхон, Хонгор, Шарын гол гэсэн 4 сум, 24 багтай.

Тус аймгийн газар нутгийн хэмжээ бага боловч алт, шохойн чулуу, нүүрс, барилгын материалын төрөл бүрийн түүхий эд зэрэг байгалийн баялгийн нөөц ихтэй. Далайн түвшнээс 707 м өндөрт өргөгдсөн харьцангуй нам дор газарт байрлана. Тус аймгийн нутгаар Хэнтийн нуруунаас эх авч Орхон голд цутгадаг Хараа, Зулзага, Шарын гол, Ерөө, Орхон, Хүйтний, Хавчуун зэрэг гол урсдаг.

Агаарын үнэмлэхүй их температур 7-р сард 42.6 C^0, үнэмлэхүй бага температур нь 1-р сард -43.7 C^0 хүрдэг. Жилд дунджаар 310-320 мм хур тунадас ордог бөгөөд 85-90% буюу 284-290 мм тунадас дулааны улиралд унадаг.

Дархан-Уул аймаг нь анх Монгол Улсын барилгын салбарыг түүхий эд, материалаар хангах зорилгоор аж үйлдвэрийн бааз хотын статустай байгуулагдсан. Тус аймаг нь хар төмөрлөгийн үйлдвэр, тоосго, бетон, цементийн болон хүнсний төрөл бүрийн үйлдвэрлэл, мах боловсруулах, ургамлын тос боловсруулах үйлдвэр зэрэг голлох үйлдвэртэй. Үүнд: "Дарханы Дулааны Цахилгаан Станц", "Дархан Төмөрлөгийн Үйлдвэр", "Дархан Нэхий" компани, "Эрэл цемент" зэрэг томоохон үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Дэд бүтэц сайн хөгжсөн, Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлийн олон улсын авто зам, Улаанбаатар-Сүхбаатарын олон улсын төмөр замын зангилаан дээр оршдог, төвийн эрчим хүчний системд холбогдсон, өндөр хурдны шилэн кабел, тоон системийн радио релений шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй, бусад аймагтай харьцуулвал нийтийн найдвартай, тогтмол хямд тээврийн хэрэгсэлтэй, хүмүүсийн амьдралын өртөг багатай зэрэг давуу талтай.

2016 оны 12-р сарын байдлаар аймгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн мэдээгээр бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1879 болж өмнөх сараас 94 хүнээр буурсан байна. Энэ оны 12 сард хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст 190 хүн шинээр бүртгүүлжээ. Тайлант хугацаанд нэмж бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 11 нь өөр газраас шилжиж ирсэн, 80 нь сургууль төгссөнөөс, 61 нь бусад шалтгаанаас, сарын эцэст байгаа бүртгэлтэй ажилгүйчүүдийн 1036 нь буюу 55.1% нь эмэгтэйчүүд, 1505 нь буюу 80.1% нь урьд нь ажил хийж байсан хүмүүс байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 961 нь буюу 51.1% нь 16-34 насны залуучууд эзэлж байна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр ашигт малтмалаар баялаг бөгөөд Шарын голын нүүрсний ил уурхай ашиглалтын 40 жилийн хугацаанд 218 сая метр хөрс хуулж, 50.9 сая тонн нүүрс олборлож улс орныхоо төвийн районыг нүүрсээр хангах хэрэгцээнд нийлүүлсэн бөгөөд цаашид 28 сая тонн нүүрсийг ил далд хосолсон аргаар ашиглаж Төв, Дархан-Уул, Орхон, Дархан-Уул аймгийг нүүрсээр хангах зорилготой ажиллаж байгаагаас гадна алт олборлох 10 гаруй үйлдвэр, барилгын материалын чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүд ажиллаж улс, аймаг, сумын төсвийг бүрдүүлж өөрийгөө санхүүжүүлж давсан орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлдэг сум юм.

Зуны улиралд зөвшөөрөлгүй хууль бусаар гар аргаар алт олборлогч иргэд Шарын гол, Хонгор зэрэг сумдад эрс нэмэгдэж харин өвлийн цагт багасдаг, аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийг нөхөрлөл хэлбэрээр хяналтанд оруулах шаардлага байгаа хэдий ч өөр аймаг, сумдаас ирж ашигт малтмал олборлодог тул гэмт хэрэг гарах нэг шалтгаан болохоор байна.


Мөн нэг онцлог нь гэмт хэрэг, зөрчил нь цаг хугацааны хувьд байнгын болон улирлын шинжтэй байдаг. Тухайлбал, Тус аймагт үйлдэгддэг БХЖЭсрэг гэмт хэрэг гэхэд л өвлийн цагт багасч 6-10 сард гэмт хэргийн гаралт гаралт ихсэх жишээтэй. Ялангуяа хууль бусаар ашигт малтмал олборлох асуудал 8-10 сард ихэсдэг байна.

ХОЁР. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Бүртгэгдсэн гэмт хэрэг:

Тус аймагт 2011-2016 онд нийт 4306 гэмт хэрэг бүртгэгдсэн ба жилд дунджаар 718 гэмт хэрэг бүртгэгддэг байна. 2011-2014 онуудад гэмт хэргийн гаралт урьд оноос 59-132 хэргээр өсч байсан бол 2015, 2016 онуудад гэмт хэргийн гаралт 100-117 хэргээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

График VIII.8.1.



Тус аймгийн хэмжээнд бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгө хулгайлах, залилан мэхлэх, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргүүд голчлон үйлдэгддэг байна.

Тухайлбал: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгдсэн хэргийн 40 гаруй хувийг эзэлдэг бөгөөд үүнээс бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 95 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 193, 2012 онд 252, 2013 онд 291, 2014 онд 297, 2015 онд 261, 2016 онд 249 хэрэг бүртгэгдсэн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 40 гаруй хувийг эзэлдэг бөгөөд үүнээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 65 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 130, 2012 онд 162, 2013 онд 197, 2014 онд 235, 2015 онд 217, 2016 онд 185 гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 11 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 15, 2012 онд 9, 2013 онд 21, 2014 онд 42, 2015 онд 45, 2016 онд 66 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгдсэн хэргийн 8 гаруй хувийг эзэлдэг бөгөөд үүнээс Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг 70 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 26, 2012 онд 43, 2013 онд 33, 2014 онд 48, 2015 онд 48, 2016 онд 43 хэрэг бүртгэгдсэн байна.

Прокурорын статистик тоо үзүүлэлтээс үзэхэд Дархан-Уул аймагт сүүлийн 3 жилд 754 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлж, 1697 хэргийг хэрэгсэхгүй болгож, 227 хэргийг нэгтгэж, 293 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна.

Шүүхийн статистикаас үзэхэд Дархан-Уул аймагт 2011-2013 онд 100б хүнд холбогдох 697 эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байсан бол 2014-2016 онд 972 хүнд холбогдох 755 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх 3 жилтэй харьцуулахад 0.8%-аар өссөн үзүүлэлт гарчээ.

2011-2016 онд нийт 1978 хүн ял шийтгүүлснээс 112 буюу 5.7% нь албадан ажил хийлгэх ял, 193 буюу 1.0% нь баривчлах ял, 1585 буюу 80.1% нь хорих ял (үүнээс 459 буюу 29.0% нь биечлэн эдлэх, 1094 буюу 57.8% нь тэнсэн харгалзах ял)-аар шийтгүүлж, 31 буюу 1.6% нь Өршөөлийн тухай хуулиар өршөөгдсөн байна.


Хүснэгт VIII.8.1.

	2015 он	2016 он	Өсөлт, бууралт	
			Тоогоор	Хувиар
Бүртгэгдсэн нийт хэрэг	27757	27167	-590	-2.1
Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэг	9928	9222	- 706	-7.1
Дархан-Уул аймаг гэмт хэрэг	792	675	-117	-14.8

Дархан-Уул аймгийн цагдаагийн газар нь 2016 онд орон нутагт 9222 гэмт хэрэг бүртгэгдсэний 675 буюу 7.3%-ийг Дархан-Уул аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс Дархан-Уул аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг 117 буюу 14.8%-аар буурсан байна.

Гэмт хэргийн гаралт, өсөлт бууралт /сум/:

График VIII.8.2.




Бүртгэгдсэн хэргийн илрүүлэлт /хувиар/:

Хүснэгт VIII.8.2

	2015	2016	Өсөлт, бууралт /нэгжээр/
Улсын хэмжээнд	62.1	64.0	1.9
Орон нутагт	70.8	71.6	0.8
Дархан-Уул аймагт	63.0	71.7	8.8

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (хэргийн төрлөөр):

График VIII.8.3.



Өмнөх онтой харьцуулахад: бусдын эд хөрөнгийг булаах 63.6%, танхайрах гэмт хэрэг 52.2%, бусад төрлийн гэмт хэрэг 41.2%, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 40.0%, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 33.3%, хүнийг санаатай алах гэмт хэрэг 28.6%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 14.7%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 11.6%, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 4.6%-аар тус тус **буурсан.** Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 46.7%-аар **өссөн**.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

Хүснэгт VIII.8.3.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	2015	2016	Нэгжээр	Өсөлт бууралт /хувиар/
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	50	58	8	16.0
Эмэгтэй хүн оролцсон	136	118	-18	-13.2
Хүүхэд оролцсон	47	25	-22	-46.8
Бүлэглэн гүйцэтгэсэн	100	53	-47	-47.0
Согтуугаар	275	258	-17	-6.2

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар:


Дархан-Уул аймагт бүртгэгдсэн 675 гэмт хэргийн 255 буюу 37.8% нь гэр орон сууцанд, 145 буюу 21.5% нь гудамж талбайд, 79 буюу 11.7% нь олон нийтийн газар, 62 буюу 9.2% нь авто замд, 55 буюу 8.1% нь бусад газар, 42 буюу 6.2% нь ААН, 19 буюу 2.8% нь ТББ-д, 10 буюу 1.5% нь төрийн байгууллагад, 8 буюу 1.2% нь нийтийн тээвэрт үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гараг, цаг:

Хүснэгт VIII.8.4.

(Бүртгэгдсэн хэргийн гариг, нийт хэрэгт эзлэх хувь)		
Даваа	110	16.3%
Мягмар	96	14.2%
Лхагва	108	16.0%
Пүрэв	88	13.0%
Баасан	110	16.3%
Бямба	90	13.3%
Ням	73	10.8%

График VIII.8.4.




Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 668 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.0%-аар буурсан. 127 буюу 19.0% нь эмэгтэй, 541 буюу 81.0% нь эрэгтэй хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан. 34 буюу 5.1% нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.3%-аар буурсан байна.

График VIII.8.5.




График VIII.8.6.



Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

График VIII.8.7.



Гэмт хэргийн улмаас 4 ААН, байгууллага, 699 иргэн хохирч, үүнээс, 20 хүн нас барж, 339 хүн гэмтсэн, 318 буюу 45.5% нь эмэгтэй хүн гэмт хэрэгт өртөж хохирсон байна.

Иргэн, ААН, байгууллагад учирсан 1866.1 сая төгрөгийн хохирлын 1088.2 сая төгрөг буюу 58.3%-ийг нөхөн төлүүлж, 195.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

БНХАУ-ын 1 иргэн гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон байна.

Дархан-уул аймгийн хэмжээнд 2016 онд урьд оны үлдэгдэл болон шинээр эрүүгийн хэрэг үүсгэн нийт 873 хэрэг шалгаснаас 43.2%-д хэрэг бүртгэлт, 56.8%-д мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт VIII.8.5.

	2015он	2016 он	Өсөлт, бууралт	
			тоогоор	хувиар
Шалгасан хэрэг	1136	873	-263	-23.2
Яллах дүгнэлт үйлдүүлэхээр	354	289	-65	-18.4
Хэрэгсэхгүй болгуулахаар	542	416	-126	-23.2
Нэгтгэсэн	64	69	5	7.8
Шийдсэн хэргийн хувь	84.5	88.7	4.2	

Аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил буурсан хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, гэр орон сууц, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, согтуугаар болон гэр орон сууц, ахуйн хүрээнд бусдын бие махбодод гэмтэл учруулах хэрэг, хулгайлах гэмт хэргийн эзлэх хувь нь төдийлөн буураагүй залилан мэхэлж авах гэмт хэрэг өссөн байна.

Бусдын эд хөрөнгө залилан мэхэлж авах гэмт хэрэг 46.7%-аар **өссөн** байгаад дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

Бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 36.9%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 27.4%-ийг эзэлж байгаа ба гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нь архидан согтуурсан, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн дорд ухамсраас болсон байна. Тус аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 40.7%-ийг тус гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйл нь тус аймаг нь ашигт малтмалын томоохон орд болон нөөцтэй улмаас зуны улиралд хил залгаа болон бусад аймгуудаас


зөвшөөрөлгүй хууль бусаар гар аргаар алт олборлогч иргэд эрс нэмэгддэг мөн үйлдвэрийн бүс учир тоног төхөөрөмж нийлүүлэх, хөрөнгө оруулах зэргээр иргэдийг залилан мэхэлж үйлддэг байна.

ГУРАВ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 12536 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 99.0%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.

2011-2016 онд нийт 114995 захиргааны арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

График VIII.8.8.



Дархан-Уул аймагт 2016 онд 22008 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49 буюу 0.2%-аар өсч, зөрчил гаргасан 20789 иргэн, 33 ААН, байгууллагад 903.3 сая төгрөгөөр торгох, үүнээс 1024 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 162 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

График VIII.8.9.




Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 6183 хүн саатуулагдсанаас 503 буюу 8.1% нь эмэгтэй, 30 буюу 0.5% нь 18 хүртэлх насны хүмүүс байна. 75 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

График VIII.8.10.



График VIII.8.11.



2011-2015 оны хугацаанд нийт 4047 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жилийн хугацаатай хасч захиргааны арга хэмжээ авсан бол Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээс хойш нийт 1374 жолоочийг торгож, эрхийг нь 6 сараас 2 жилийн хугацаатай хассан байна.

График VIII.8.12.




График VIII.8.13.



ДӨРӨВ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ


Дархан-Уул аймагт ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 2011-2016 онд нийт 327 хэрэг бүртгэгдэж, 107 буюу 32.7% согтуугаар үйлдэгдсэн байна.

График VIII.8.14.



Гэмт хэргийн ангилал (2011-2016 он):

График VIII.8.15




Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа (2011-2016 он):

Хүснэгт VIII.8.6.

(Бүртгэгдсэн хэргийн гариг, нийт хэрэгт эзлэх хувь)		
Даваа	40	12.2%
Мягмар	54	16.5%
Лхагва	43	13.1%
Пүрэв	52	15.9%
Баасан	35	10.7%
Бямба	55	16.8%
Ням	48	14.7%


График VIII.8.16.



Цаг хугацааны хувьд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг нь байнгын шинжтэй учир улирал харгалзахгүй үйлдэгддэг, ихэвчлэн 14-19, 22-06 цагийн хооронд үйлдэгддэг байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар (2011-2016):

График VIII.8.17.




2011-2016 онд нийт 348 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 34 буюу 9.8% нь эмэгтэй, 408 буюу 90.3% нь эрэгтэй, тэдний 7 буюу 2.0% нь 16-17 насны хүүхэд, 202 буюу 58.0% нь 18-34 насны, 139 буюу 40.0% нь 35-аас дээш насны иргэд байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын 17 буюу 4.9% нь төрийн алба хаагч, 44 буюу 12.6% нь хувийн хэвшилд ажиллагч, 71 буюу 20.4% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 165 буюу 47.4% нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд гэмт хэрэг үйлдсэнээс 112 буюу 32.1% нь согтуугаар, 8 буюу 2.3% нь урьд ял шийтгэгдсэн этгээд гэмт хэрэг үйлдсэн байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол (2011-2016 он):

График VIII.8.18.



Гэмт хэргийн улмаас 377 иргэн хохирч, үүнээс 57 хүн нас барж, 201 хүн гэмтсэн (үүнээс: хөнгөн 47, хүндэвтэр 118, хүнд 36) байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, ААН, байгууллагад учирсан 946.6 сая төгрөгийн хохирлын 82.8%-ийг нөхөн төлүүлж, 409.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2016 онд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 61 бүртгэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 буюу 11.6%-аар буурсан байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэгт 2016 онд 62 иргэн холбогдон шалгагдсанаас 30 буюу 48.4% нь 18-34 насны иргэд эзэлж, 32 буюу 51.6% нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Мөн энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2016 онд 65 иргэн хохирч, 10 иргэн нас барж, 11 хүн хөнгөн, 27 хүн хүндэвтэр, 5 хүн хүнд гэмтэж, хэргийн улмаас 7 хүүхэд хохирч, 5 хүүхэд хүнд, хөнгөн гэмтэж, 2 хүүхэд нас барсан байна.

2016 онд бүртгэгдсэн нийт 61 буюу 93.8% нь аймаг, сумын төв болон улсын чанартай авто зам дээр голчлон үйлдэгдсэн байна.

Шалтгаан нөхцөл, хүчин зүйл

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, осол, хохирлын байдалд тээврийн хэрэгслийн өсөлт, замын хөдөлгөөний нягтрал, замын байгууламж болон түүний орчны байдал зохих хэмжээгээр нөлөөлж байна.

Тээврийн хэрэгслийн тоо жил бүр тогтмол өсөж, замын хөдөлгөөний нягтрал, ачаалал нэмэгдэхийн зэрэгцээ хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос хүний амь нас, эрүүл мэнд, төрийн болон ТББ, ААН, иргэдийн өмч хөрөнгөнд хохирол учруулах явдал багасахгүй байна.

Замын хөдөлгөөнд оролцогчдоос Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх хөдөлгөөний соёл ихээхэн дутагдалтай замын хөдөлгөөнд оролцохдоо холбогдох журам, замын хөдөлгөөний дүрмийн заалтыг баримталдаггүй, энэ талаарх мэдлэг, сахилга хариуцлага сул, хурд хэтрүүлэх, урсгал сөрөх, явган хүний гарам руу ойртон ирэхдээ хурдаа хасдаггүй, гарцаар гарч яваа явган зорчигч нарт зам тавьж өгдөггүй, согтуугаар машин жолоодох зэрэг нөхцөл байдал нөлөөлсний гадна стандартын шаардлага хангаагүй эвдрэл гэмтэлтэй зам харгуй, замын тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй, жолооны курсын чанаргүй сургалтууд зэрэг нь гэмт хэргийн тоо өсөх үндсэн шалтгаан болж байна.

Дархан-Уул аймгийн хувьд орон нутгийн замууд нь нарийн, энхэл догол ихтэй, гэрэлтүүлэг байдаггүй, гэрлэн дохио байхгүй, байгаа зарим нь алдаг оног асдаг, явган хүний зам автомашины замтай заавал давхацдаг зэрэг нь осол гарах нэг шалтгаан болж байна.

Гэмт хэрэг үйлдэгсдийн 20 гаруй хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох нь энэ төрлийн гэмт хэргийн бие даасан шалтгаан болж байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2011-2014 он хүртэл энэ төрлийн гэмт хэрэг өсөлттэй байж байгаад 2014 оноос буурсан байна.

ТАВ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГХУСАЗСЗӨВЛӨЛИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Дархан-Уул аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь 2016 онд 9 бүлэг 26 багц ажил хийхээр төлөвлөгөө гарган ажиллаж төлөвлөгөөний биелэлт 94.3%-тай ажилласан байна.

ГХУСАЗСЗ-ийн хурал 2016 оны байдлаар нийт 7 удаа хуралдаж хурлаар салбар зөвлөлийн 2016 оны төлөвлөгөө батлан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн боловсрол олгох хөтөлбөр, аймаг, сумдын эрүү хэв журмын нөхцөл байдал, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн багц 36 асуудлыг хуралдаж шийдвэрлэсэн байна.

Хийсэн ажлуудаас онцлогийг дурдвал: Мансууруулах бодисын хор нөлөөг сурталчлах, Мансууруулах бодистой тэмцэх хууль эрх зүйн орчныг таниулан сурталчлах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлж ажилласан юм. Мөн төслийн хүрээнд сэтгэцэд нөлөөлөх бодисын хамааралтай болон хамааралгүй өсвөр үеийн хүүхэд залуучуудын талаарх судалгааг гарган, сургалт явуулж "Хүүхэд, эцэг, эх сургууль" хоорондын тогтмол уялдааг бий болгох, хяналтыг сайжруулах зорилгоор аймаг, сумдын ГХУСАЗСЗөвлөл, хууль хяналтын бүх байгууллагууд, сумдын ЗДТГ, багууд, Сууц өмчлөгчдийн холбоод, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг их, дээд, ерөнхий боловсролын сургууль, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд хамрагдаж, үр дүнтэй ажил болсон байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 60 ААН, байгууллагын 300 ажилтан алба хаагчдыг "Бүх нийтийн

эргүүл"-д, 18 багийн Засаг дарга нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч нар хамтран хариуцсан багийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Сайн дурын", "Урамшуулалт", "Хөршийн холбоо" зэрэг эргүүлүүдийг өдрийн цагаар ажиллуулан тус багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг эргүүлд татан оролцуулах ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газраас "Өсвөр үе залууст ээлтэй орчин бүрдүүлж эрүүл амьдрахад нь тусалъя" зөвлөгөөн, "Өсвөр үе залуучуудыг архинд донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах" зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

Дархан-Уул аймгийн "Архигүй Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд аймгийн удирдах шатны шийдвэр гаргагч нарт "Архины хор хөнөөлийг бууруулах нотлогдсон үр дүн туршлага" сэдэвт сургалтыг ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Эрүүл идэвхтэй амьдрал клуб, "Аз жаргалын эрэлд" ТББ-уудтай хамтран 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад нийт 84 төрийн болон ТББ-уудын шийдвэр гаргагч нар, төлөөллүүдийн хамт 262 хүн оролцсон.

"Эмх цэгц" арга хэмжээг зохион байгуулж, хориглосон газар худалдаа үйлчилгээ явуулахгүй байх талаар 37 иргэнд "Мэдэгдэх хуудас" өгч биелэлтийг нь хангуулан ажилласан. Дархан сумын ЗДТГ-аас эдгээр иргэдийг сар шинийн баярыг дууталх хугацаанд худалдаа үйлчилгээ явуулах газрыг гаргаж өгсөн.

Засгийн газрын 410 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран Интернет РС цахим тоглоомын 15 газрын үйл ажиллагаанд 4 удаагийн шалгалтыг хийж холбогдох заавар зөвлөмжийг өгсөн. "Интернет, цахим тоглоомын газрын үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарах асуудал" сэдэвт "Зөвлөгөөн"-ийг зохион байгуулж 54 иргэнийг хамруулж, компьютерийн дэлгэцэд өсвөр насны хүүхдүүдийг тоглоомын донтолтоос сэргийлэх талаар сэрэмжлүүлгийг байршуулан хамтран ажилласан.

"Хяналт-Шалгалт", "Баар", "Архидалт, Архи" нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 950 ААН, байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийж Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж зөрчсөн 8 ААН, байгууллагуудыг 1.845.000 төгрөгөөр торгож, гар дээрээс согтууруулах ундаа зарсан 15 иргэнийг 525,000 төгрөгөөр торгож, цагдаагийн албан хаагчдын хууль ёсны шаардлагыг удаа дараа биелүүлээгүй 5 иргэнийг Сум дундын шүүхээр 7-14 хоногоор баривчлуулан дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа гаргуулсан. Холбогдох байгууллагуудтай хамтран Согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААН, байгууллагын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох шалгалтыг явуулж, нийт 280 ААН, байгууллагын гадна талын гэрэлтүүлэг, дотор талын хяналтын камерыг орчин үеийн шаардлагад нийцүүлсэн байдлаар камертай болгох ажлыг зохион байгуулж, нэгдсэн судалгаанд хамруулах ажлыг зохион байгуулсан энэ ажил нь 90%-ийн гүйцэтгэлтэй байна.

Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт малчдын холбоо, бүлгэмүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Малчдын зөвлөгөөн"-ийг 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан.

БХЖЭсрэг гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт хийж ажиллахад тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан "Мон Зол" ХХК, "JI and CO" ХХК-ны үйл ажиллагааг зогсоож нүүлгэсэн. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа "Уулс ноён" ХХК, "Желбор" ХХК, "Очир ундраа" ХХК, "Газар хэвлий" ХХК зэрэг ААН-ийн бичиг баримтын бүрдлийг шалгаж зарим дутуу баримт

бичгүүдийг бүрдүүлэх, химийн хорт бодис ашиглахгүй байх талаар заавар, зөвлөгөө өгсөн. Хүйтний гол, Цэхэрт суурин гэх газруудад хууль бусаар алт олборлож болзошгүй этгээдүүд хяналт тавьж мэдээ мэдээлэл цуглуулан ажиллаж байна. Шарын гол сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Баян талын өв" ХХК нь сумын ИТХ-ын тогтоолоор хориглосон газарт алт олборлох үйл ажиллагаа явуулж 700 грамм алт олборлосон, "Бага таян" ХХК нь өөрийн зөвшөөрөлгүй талбайд хөрс хуулалт хийж 100 орчим грамм алт олборлосон үйлдлүүдийг илрүүлж шалгалтын ажиллагаа явуулсан.

"Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлийг бүртгэх, шалгах арга зам цаашид анхаарах асуудал", "Мэдээллийн сөрөг нөлөөллөөс хүүхдийг хамгаалах нь", "Нэг л алдвал", "Өсвөр насны хүүхдүүдийг мэдээлэл, зан үйлийн сөрөг нөлөөллөөс хамгаалъя" зэрэг сэдэвт 4 удаагийн Зөвлөгөөн, ярилцлагыг зохион байгуулж 240 оюутан сурагч, эцэг эх, нийгмийн ажилтан багш сурагчдыг хамруулан ажилласан. "Хүчирхийллийн эсрэг хамтдаа", "Хүүхэд хамгаалал", "Сургууль аюулгүй орчин", "Өсвөрийн цагдаа", "Цахим тоглоом", "Сар шинэ" зэрэг тусгай арга хэмжээг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулсан.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл, Цагдаагийн газар, Боловсрол соёлын газар, Улаан загалмай хороотой хамтран сургуулийн өмнөх насны хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадал, хэвшил эзэмшүүлэх зорилгоор цэцэрлэгүүдийн дунд **"Замын хөдөлгөөний цагаан толгой 2016"** тэмцээнийг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр 4 удаа 110 багш ажилтан нарт сургалт зааварчилга өгсөн.

Сургуулийн насны хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор "Ногоон гэрэл Цагаан шүгам 2016" тэмцээнийг сургуулийн өмнөх боловсролын 13 байгууллагын 156 хүүхдийн дунд зохион байгуулж явуулсан тус ажилд шаардлагатай 1.582.000 төгрөгийг зөвлөлөөс санхүүжүүлсэн. "School Police" эргүүлийн үйл ажиллагааг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран амжилттай ажиллуулж эхэлснээр ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг нь 2015 онтой харьцуулахад 4,6%-аар буурсан байна.

Криминологи судалгааны багийн дүгнэлтэд үндэслэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулан ажилласнаар **сар бүр 12-18.5 хувиар** буурсан ажлын үр дүн гарсан.

Дархан-Уул аймгийн ГХУСАЗСЗөвлөл зөвлөл нь төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөний дагуу дээрх тодорхой арга хэмжээг зохион байгуулснаар 2016 онд гэмт хэргийн гаралт 117 буюу 14.8%-аар буурсан байна.

Мөн тодорхой төрлийн гэмт хэрэг ялангуяа тус аймагт ихээр үйлдэгдэж байгаа хулгайлах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргүүдтэй тэмцэх, гэмт хэрэг түүнийг үйлдэгдэхээс өмнө урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэснээр 2016 онд бүртгэгдсэн тодорхой төрлийн гэмт хэргийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бусдын эд хөрөнгийг булаах 63.6%, танхайрах гэмт хэрэг 52.2%, бусад төрлийн гэмт хэрэг 41.2%, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 40.0%, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 33.3%, хүнийг санаатай алах гэмт хэрэг 28.6%, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 14.7%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 11.6%, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 4.6%-аар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

ЗУРГАА. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголын уламжлалт "Сар шинэ"-ийн баярыг угтаж иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангах, гудамж талбай олон нийтийн газар согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, өртөж хохирох, осгож амь насаа алдах мөн хулгайлах болон тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох илрүүлэх зорилгоор ААН, байгууллагуудаас нийтийн эргүүлийг 2016 оны 01 сарын 27-ний өдрөөс 2016 оны 02 дугаар сарын 05-ний өдрийн хооронд гаргасан.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 60 ААН, байгууллагын 300 ажилтан алба хаагчдыг "Бүх нийтийн эргүүл"-д, 18 багийн Засаг дарга нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч нар хамтран хариуцсан багийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Сайн дурын", "Урамшуулалт", "Хөршийн холбоо" зэрэг эргүүлүүдийг өдрийн цагаар ажиллуулан, тус багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ААН, байгууллагуудыг эргүүлд татан оролцуулах ажлыг зохион байгуулсан.

Мал хулгайлах гэмт хэргийн гаралт, шалтгаан өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээ, мал эмнэлэг ариун цэвэр гарал үүслийн гэрчилгээ олгох түүнийг хэрэглэх тухай, малын бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал зэрэг сэдвүүдээр илтгэл тавин, санал асуулга өрнүүлсний дараа төр захиргааны байгууллагуудын түвшинд, Мал эмнэлэг үржлийн газрын малын эмч нарын түвшинд, цагдаагийн байгууллагын түвшинд, малчин өрх, иргэдийн түвшинд "Зөвлөмж" гаргасан.

Иргэдийн үүсэл санаачлагаар байгуулагдсан 10, 100, 1000-ын холбоодын үйл ажиллагааг дэмжиж төрийн байгууллагууд хамтран "Эргүүл болон нэгдсэн шалгалтыг хамтран зохион байгуулах ажлыг тогтмолжуулахаар хэлэлцэж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр төрийн болон ТББ, иргэд, малчдын бүлгэмүүдийн хийж гүйцэтгэх ажлын талаар "Зааварчилга" гарган 150 ширхгийг тараан өгч, зөвлөгөөний үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан.

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Монгол мал" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлэг үржлийн албаны ажилтнуудтай хамтарч "Малын бүртгэл мэдээллийн сан"-г хэрхэн ашиглаж байгаа талаар зөвлөлдөж, цаашид малчдыг уг бүртгэлийн санд малаа хамруулахын ашиг тусыг сурталчлах чиглэлээр аймгийн Мал эмнэлэг, үржлийн албаны ажилтнуудаар мал бүхий иргэдэд сургалт сурталчилгааны ажлыг 4 удаа зохион явуулсан.

Цагдаагийн газраас УЕП, ЦЕГ-ын даргын А/05, А/09 дүгээр журмаар тэнсэгдсэн ялтанд тавих захиргааны хяналтыг сайжруулах зорилгоор "Захиргааны хяналт", "Хяналт зөвлөмж", "Захиргааны хяналтыг сайжруулъя" 45 хоногийн аян, "Захиргааны хяналт", "Хяналт" зэрэг нэг бүрчлэн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж шүүхээс тэнсэн суллагдсан 116, хорих ангиас хугацааны өмнө тэнсэн суллагдсан 52, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 9, жирэмсэн 3 нас хүртэлх хүүхэдтэй эх, ганц бие эцэг хорих ял хойшлуулсан 3, нийт **180%-**ийн хэрэг материалтай танилцан зааварчилга өгч зөрчил дутагдлыг засуулан хяналт тавьж ажилласан байна.

ДОЛОО. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэд, олон нийт, ТББ-уудын дэмжлэг туслалцаанд түшиглэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх инноваци нэвтрүүлэх зүй ёсны шаардлага тулгарч байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил буурсан хэдий ч согтуугаар болон гэр орон сууц, ахуйн хүрээнд танхайрах, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, залилан мэхлэх гэмт хэрэг, зөрчлийн гаралт нийт хэрэг, зөрчилд эзлэх хувь нь төдийлөн буурахгүй байгаа тул үүнд чиглэгдсэн зөв оновчтой, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлага байгаа нь харагдаж байна.

Гэмт хэргийг түргэн, шуурхай илрүүлснээр гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж таслан сэргийлэх арга хэмжээ авснаар дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг нь таслан зогсоохоос гадна гэмт хэрэг үйлдвэл заавал хариуцлага хүлээдэг гэсэн эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг нийт иргэдэд ойлгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны талаар сурталчлах, соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын график төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй хөршийн хяналт, оюутан цагдаа, "school police" зэрэг хөтөлбөр арга хэмжээнд идэвхтэй оролцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгч буй санамж, зөвлөгөөг ахуй амьдралдаа мөрдлөг болгох.

Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг багасгах замаар ядуурлын түвшин, ажилгүйдлээс үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх уриалгыг гаргаж, ААН, байгууллагад дэмжлэг үзүүлснээр гэмт хэргийн гаралт буурна.

Нийгмийн эмзэг бүлэг, тэнэмэл амьдралтай, орон гэргүй, архаг архичин, мансуурах донтой, хорихоос суллагдсан хүмүүсийг эмчлэх, нийгэмшүүлэх, бусад хэлбэрээр туслалцаа үзүүлэх, хүч хэрэглэсэн гэмт хэргийн 60 хувийг согтуугаар үйлдэж, иргэдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа тул тухайн нутаг дэвсгэрт оршин суугчийн тоон үзүүлэлтийг харгалзан нийт нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчлэх ААН (цэг)-ийн дээд хязгаарыг зааж өгөх шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн болон хууль сахиулах байгууллагаас явуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцох, бусад хэлбэрээр хамтран ажиллаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, судалгааны үр дүнг ашиглан ажил, арга хэмжээ зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзэж байна.

ДОРНОД АЙМАГ



9. ДОРНОД АЙМАГ

Дорнод аймаг нь нутаг засаг захиргааны хувьд 14 сум, 2016 оны жилийн эцсийн байдлаар түс аймагт 22.9 мянган өрхөд 76.5 мянган хүн амьдарч байгаагийн 56.8% нь аймгийн төвд, 11.5% нь сумын төвд, 31.7% нь хөдөө амьдарч байна. Халх, буриад, барга, үзэмчин зэрэг ястнаас бүрдсэн 74,7 мянган хүн амтай, үүний 70%-ийг 35 хүртэлх насны хүүхэд залуучууд эзэлдэг. Дорнод аймаг тал хээр болон ой хээр хосолсон 123.5 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай, хойд талаараа ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаар, зүүн талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган аймгуудтай улсын хилээр, баруун урд, баруун талаараа Сүхбаатар, Хэнтий аймгуудтай аймгийн хилээр хиллэдэг. Түс аймагт ерөнхий боловсролын 27 сургуульд 13285 сурагч, 26 цэцэрлэгт 4488 хүүхэд хүмүүжиж, 900 гаруй багш ажиллаж байна. Дорнод Их сургууль, ШСТТС, МСҮТ зэрэг их дээд, түсгай дунд сургуулиудад 1000 гаруй оюутан, сурагч суралцаж байна.

Дорнод аймгийн төв Чойбалсан хот нь зүүн бүсийн тулгуур төв бөгөөд "Адуунчулуун" ХК, "Дорнод Гурил" ХК, Махны үйлдвэрлэл худалдааны "Дорнод" ХК, "НИК", Гаалийн газар, НААҮГ, Зүүн бүсийн оношлогоо, эмчилгээний төв, зэрэг бүсийн хэмжээний томоохон үйлдвэр, ААН-тэйгээс гадна газрын тос олборлох компаниуд үйл ажиллагааг явуулж байна.


Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2016 оны жилийн эцэст 1722745 толгой мал, үүнээс тэмээ-5183, адуу-224903, үхэр-175474, хонь-831357, ямаа-485828 толгой мал түс түс тоологдож малын тоо өмнөх оноос 167.3 мянган толгой буюу 10.7%-аар өсөж, үүнээс тэмээ 275 толгой буюу 5.6%, адуу 28366 толгой буюу 14.4%, үхэр 11824 толгой буюу 7.2%, хонь 86035 толгой буюу 11.5%, ямаа 40820 толгой буюу 9.2%-аар өсчээ.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Дорнод аймаг засаг захиргааны хувьд 14 сумын 64 багт хуваагддаг. Дорнод аймгийн хүн амын тоо 2000 онд 75,373 байсан бол 2015 онд 76476 болон өссөн байна. 2016 онд онд 2076 хүүхэд шинээр мэндэлж, 517 хүн нас баржээ. Хүн амын нас баралт 517 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 хүн ам тутамд 6.83 ногдож байна.

Дорнод аймгийн хүн ам, өрхийг тоог 2015 оны байдлаар зүүн бүсийн хүн ам, өрхийн тоонд авч үзвэл өрхийн 36%, нийт хүн амын 36.7%-ийг эзэлж байна.

График VIII.9.1.



Дорнод аймгийн хүн амыг сумдаар авч үзвэл:

Хэрлэн сум 43506 хүн ам тоолуулсан нь аймгийн нийт хүн амын 56.8%-ийг эзэлж байна. 2015 оны хүн амын тоогоор Хэрлэн, Баянтүмэн, Баян-Уул, Матад, Чулуунхороот сумдын хүн амын тоо өссөн бол бусад сумдын хүн ам буурсан байна. Дорнод аймгийн нийт 64 багаас хамгийн их хүн амтай баг нь Хэрлэн сумын 10-р

баг бөгөөд 7.3 мянган хүн тоолуулсан. Бусад сумдын хүн амын тоог авч үзвэл Халхгол, Дашбалбар, Баян-Уул сумууд 3000-аас дээш хүн амтай байна.

Дорнод аймгийн уул уурхайн нөхцөл байдал


Дорнод аймаг ашигт малтмалын багагүй нөөцтэй бөгөөд 85 орд, ирээдүй бүхий 149 илрэлийг тогтоосон байдаг. Тамсагийн сав газарт газрын тос, Адуунчулуун, Үхэрт, Хөөвөр нуур, Хөөт, Баянбулаг зэрэгт хүрэн нүүрсний, Цав, Улаан, Мухарт холимог металлын Цагаанчулуут, Үрлийн овоо, Тогоотын хөндий, Дөч голын алтны, Мардай, Дорнод, Гурванбулагт ураны зэрэг ашигт малтмалын томоохон ордтой. Одоогийн байдлаар тус аймагт 216 аж ахуйн нэгж, иргэн 2629.5 мянган га талбайд хайгуулын, 44 аж ахуйн нэгж 10952.2 га талбайд ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр "Адуунчулуун", "Петро Чайна Датчин Тамсаг", "Улз гол", "Жамп", "Төв Азийн уран", "Эмээлт майнз", "Дамбат", "Тунамал шижир", "Дун-Эрдэнэ", "Шанлун", "Шинь Шинь" зэрэг томоохон компани аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

ДОРНОД АЙМГИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Гэмт хэргийн гаралтыг бүртгэгдсэн гэмт хэргээр авч сүүлийн 12 жилээр дундчилан үзвэл жилийн дундаж нь 529.25 гэмт хэрэг болох бөгөөд нь 2007 онд хамгийн их буюу 803 гэмт хэрэг бүртгэгдсэн. Аймгийн хэмжээнд 2016 онд 3039,9 сая төгрөгийн хохиролтой, 476 холбогдогчтой, эрүүгийн 482 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулбал 47 хэргээр буюу 8,9%-аар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 77,4%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,6 нэгжээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 2016 онд 3039,9 сая төгрөгийн хохиролтой, 476 холбогдогчтой, эрүүгийн 482 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулбал 47 хэргээр буюу 8,9%-аар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 77,4%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,6%-аар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр авч үзвэл

График VIII.9.2.




Гэмт хэргийн үзүүлэлтээс дүгнэхэд бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн гаралт их байгаа боловч өнгөрсөн оныхоос 9.0%-аар буурсан, харин бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 30.7%-аар, ашиглалтын гэмт хэрэг 75%-аар тус тус өссөн нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, хулгайлах гэмт хэрэг, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн гаралт их байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд эдгээр гэмт хэргийн гаралтад архидан согтуурах, ажилгүйдэл, ядуурал, нөлөөлөхөөс гадна 16-36 насны залуучууд энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн үйлддэгийг зайлшгүй анхааран үзэх шаардлагатай.

Дорнод аймгийн хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтэд үндэслэн тус аймгийн хэмжээнд архидан согтуурах явдал болон ажилгүйдэл, ядуурал үзүүлэлт өндөр байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Мөн гэмт хэргийн бусад нөхцөл байдлыг өмнөх оны нөхцөл байдалтай харьцуулан авч үзвэл гэр орон сууц, бэлчээрт үйлдэгдсэн хэрэг 2-13 нэгжээр буюу 4,5-13,5%-аар, онц хүнд гэмт хэргийн гаралт 2 нэгжээр буюу 22,2%-аар, хүүхэд оролцож үйлдэгдсэн хэрэг 4 нэгжээр буюу 22,2%-аар өсч, гудамж талбай олон нийтийн газар, байгууллага, ААН, бусад газарт үйлдэгдсэн хэрэг 1-43 нэгжээр буюу 2,4-34,9%-аар, хөнгөн, хүндэвтэр, хүнд хэргийн гаралт 5-29 нэгжээр буюу 6-13,5%-аар, согтуугаар, бүлэглэн, эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн хэрэг 1-18 нэгжээр буюу 2,1-9,8%-аар тус тус буурсан байна.

Дорнод аймгийн гэмт хэргийн нөхцөл байдлыг хилийн бүсэд хамаарах аймгуудын гэмт хэргийн гаралттай харьцуулахад. (2016 оны байдлаар)


График VIII.9.3.



Дээрх харьцуулсан судалгаагаар Дорнод аймаг нь хилийн бүсийн аймгууд дундаа гэмт хэргийн үзүүлэлтээр тэргүүлж байна.

Зүүн бүсийн аймгуудын гэмт хэргийн үзүүлэлт:

График VIII.9.4.



Харьцуулалтад зүүн бүсийн гэмт хэргийн үзүүлэлт нь Дорнод аймгийн гэмт хэргийн дундаж түвшин байна гэж үзэж болох боловч 2013-2016 онуудад гэмт хэргийн үзүүлэлт өндөр байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн үзүүлэлтийг бууруулах талаар үр дүнтэй тодорхой арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэж болохоор байна.

2010 хойш гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн жил нь 2013 он бөгөөд тухайн оны гэмт хэргийн гаралтын тоон үзүүлэлтийг авч үзвэл 10000 хүнд 100,25 гэмт хэрэг оногдож байна.


Гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал: Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2016 оны 11 сарын байдлаар 1720 байгаагийн 792 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 223 хүнээр буюу 11.5%-аар, 2015 оны 11 сарын үеэс 222 хүнээр буюу 11.4%-аар тус тус буурсан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 792 хүн буюу 46.0%-ийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 165 хүн буюу 25.2%-аар буурлаа. Эхний 11 сард хөдөлмөрийн хэлтсээр дамжуулан 995 иргэн ажилд оржээ.

Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 60.4% нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 21.7% нь дээд, 6.5% нь тусгай дунд, 9.7% нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 51.8% нь бүрэн дунд, 6.6% нь суурь, 2.4% нь бага боловсролтой, 1.3% нь боловсролгүй хүмүүс байна. Ажилгүйдэл ядуурлын түвшин улсын дунджаас дээгүүр байгаа нь гэмт хэрэг үйлдэгдэх нэг шалтгаан нь болж байна.

График VIII.9.5.



Хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд ажилгүй иргэдийн 60.4%-ийг 15-34 насны залуучууд эзэлж байгааг гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн насны байдалтай харьцуулахад сүүлийн зургаан жилийн байдлаар үйлдэгдсэн нийт гэмт хэрэгт 3472 этгээд холбогдсоныг дундчилж тооцвол жилд 578.6 этгээд гэмт хэрэг үйлдэгдсэн байх бөгөөд үүний 354.6 этгээд нь 18-36 насны хүмүүс буюу 61.3%-ийг эзэлж байна.

График VIII.9.6.




Архидан согтуурах нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна. 2016 онд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг төрөл бүрээр нь судлан дүн шинжилгээ хийхэд хүнийг санаатай алсан 9 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 8 хэргийг согтуугаар үйлдэгдсэн байна.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨД БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 2016 онд 37 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 38.3% буюу 23 нэгжээр буурсан үзүүлэлт байгаа ч нийт захиргааны зөрчил гарган торгуулсан 1432 хүн байгаагийн 553 нь зөвхөн Замын хөдөлгөөний аюулгүй тухай хуулиар торгууль ногдуулсан этгээд буюу 38.7%-ийг эзэлж, нийт торгууль болох 38.5 сая төгрөгийн 82.5% нь зам хөдөлгөөний зөрчил гаргасан этгээдэд оногдуулсан байна.

2005-2016 оны хооронд үйлдэгдсэн "ТХХАБАЖЗөрчих" гэмт хэргийн судалгаа


График VIII.9.7.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нөхцөл байдал


Дорнод аймагт үйлдэгдсэн гэмт хэргийн судалгаа 2005-2016 байдлаар

График VIII.9.8.



Дээрх тоон үзүүлэлт тус аймгийн гэмт хэргийн гаралт бууралттай байгааг харуулсан байна. Энд жишээ авч үзвэл хамгийн олон хүн амтай Хөвсгөл аймаг нэг жилд бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их тоо нь 756 байхад Дорнод аймгийн хувьд 803 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаад дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

ДОРНОГОВЬ АЙМАГ



10. ДОРНОГОВЬ АЙМАГ

1. НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, НУТАГ ОРОН, САЛБАРЫН ОНЦЛОГ.

Нутаг дэвсгэр, засаг захиргаа

Дорноговь аймаг нь анх 1931 онд байгуулагдсан. Засаг захиргааны хувьд 14 сум, 64 багтай. Газар нутгийн хэмжээ нь 109,500 км². Аймгийн төв нь Улаанбаатар хотоос 450 км. Дорноговь аймаг Монгол орны зүйн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг.

Байгаль, цаг уур

Тус аймаг бүхэлдээ говийн бүсэд хамардаг, говь хээр хосолсон нутагтай. Говийн эмзэг байгалийг нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал. Гадаргын усны нөөц хомс тул гүний усыг татаж ахуй амьдрал болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ашигладаг.

Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог. Нутгийн дундуур зүүн хойшоо баруун урагшаа их хотгор газар үргэлжилнэ. Дорноговь аймгийн нутагт том гол мөрөн, нуур байхгүй, харин газар доорх усны их нөөц бий. Халзан уул, Бүсийн Чулууны, Толь булгийн зэрэг рашаан устай. Нутгийн ихэнхэд говийн бор хөрс тархсан бөгөөд элстэй, голдуу шимт бага үрт ургамалтай ба зарим газраар хайлаас, буйлс нутгийн баруун өмнөд хэсгээр заг ургадаг. Аймгийн нийт нутагт 46 овог, 181 төрөлд хамаарах 327 зүйл ургамал ургадаг. Амьтны аймгаар нэн баялаг бөгөөд үслэг амьтдаас мануул, чоно, үнэг, хярс, дорго, тарвага, өмхий хүрэн, туулай, туурайтнаас аргаль, янгир, цагаан зээр болон дэлхийд ховордож "Улаан ном"-нд бичигдсэн хулан адуу, хар сүүлтэй зээр сүрэглэн амьдардаг онцлогтой.

Хүн ам зүй

2016 оны эцсийн байдлаар 20229 өрхийн 66606 хүн ам оршин суудаг бөгөөд хүн амын 30.7%-ийг 0-14 насны хүүхэд, 63.7%-ийг 15-50 насны иргэд, 5.6%-ийг 60 дээш насны иргэд эзэлж байна. Суурин хүн амын 50% нь эрэгтэйчүүд, 50% нь эмэгтэйчүүд байдаг. Нийт хүн амын 62.4% нь хот (аймгийн төв) тосгонд, 14.2% нь сумын төвд, 23.4% нь хөдөөд амьдарч байна. Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны эцэст 1503, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 811 буюу 53.9%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийгэм, эдийн засаг

Дэд бүтцийн хувьд: Төмөр зам, авто зам, агаарын замтай.

Хөгжлийн түлгуур салбар: Ашигт малтмал, боловсруулах үйлдвэр, хүний хөгжил, хөдөө аж ахуй, аялал жуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Орон нутгийн төдийгүй, улс орны эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий орд газрууд Дорноговь аймагт байрладаг.

Нутгийн онцлог

Дорноговь аймаг нь өнөөгийн соёлт хүн төрөлхтний мөнхийн бүтээл болох ноён хутагт Данзанравжаагийн шашин, түүх бичиг, соёлын өв дурсгалыг хадгалж үлдсэн. Хилийн Замын-Үүд, Баянбулаг-Мандалын боомтууд нь Монгол Улсын эдийн засаг, бараа эргэлтийн үндсэн ачааг үүрч, өмнөд хөршийн харилцах үүд хаалга болж байна. 1954 онд жилдээ 50 мянган тонн нефт үйлдвэрлэх хүчин чадалтай Зүүнбаяны нефтийн үйлдвэр, 1956 онд Улаанбаатар-

Замын-Үүдийн 700 гаруй км төмөр зам ашиглалтад орсон, жонш олборлох уулын гурван үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн зэрэг нь тус аймгийн төдийгүй Монгол Улсын хөгжил дэвшилд түүхэн үүрэг гүйцэтгэх эдийн засгийн томоохон ололтууд болсон.

2. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Гэмт хэргийн нөхцөл байдал

Сүүлийн 5 жилийн байдлаар Дорноговь аймгийн хэмжээнд 19057 гомдол, мэдээлэл хүлээн авч 3651 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 3676 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн. Мөн Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны 102 тусгай дугаарын утсанд иргэд, ААН, байгууллагаас захиргааны зөрчлийн шинжтэй 11596 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан нөхцөл, хүчин зүйл

Дорноговь аймгийн хувьд төв суурин газарт өөр аймаг, сумаас шилжин ирэгсэд өсөж, хүн амын нягтшил ихсэж байгаатай холбоотойгоор ажилгүй иргэд, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо нэмэгдэж орон нутагт ядуурал, байнгын орлогын эх үүсвэргүй зарим иргэд хулгайлах гэмт хэрэг ихэвчлэн үйлдэж байна. Мөн нийгмийн сөрөг үзэгдлүүд, эдийн засгийн хямрал үүнээс шалтгаалаад үйл ажиллагаа явуулдаг зарим ААН-үүд зогсонги байдалд орсноос ажилгүйчүүдийн тоо нэмэгдэх зүйлүүд ихээр гарч байна.

Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан нь хөдөө орон нутагт ажлын байр хангалтгүйгээс ажилгүй залуучууд хямд хялбар аргаар мөнгөжих, хулгайлсан зүйл нь хурдан түргэн борлогдож бэлэн мөнгө ихээр орж ирдэг, мөн махны ченж гэж нэрлэгдэх хүмүүс ажилгүй залуучуудыг энэ төрлийн гэмт хэрэгт уруу татах, тэдэнтэй сүлжээ тогтоох хань хамсаатнаа болгох, малчид малаа хариуцлагагүй орхих зэргээс болж мал хулгайлах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна. Түүнчлэн, мал хулгайлах гэмт хэрэг нь 8-11 сард ихээр үйлдэгддэг болох нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь малын тарга тэвээрэг сайжирсан, баяр наадмын үеэр малчдын сонор сэрэмж хараа хяналт суларсан, идэшний цаг эхэлсэнтэй холбоотой.

Бусдын бие махбодид санаатай гэмтэл учруулах, танхайрах гэмт хэргийн шалтгаан нөхцөл:

Хөдөлмөрийн насны залуучууд ажиллах ажлын байргүйгээс, ажлын байр олдсон ч цалин бага, амьжиргаанд нь хүрэхгүй байх, хувь хүний ёс суртахуун зэрэг хүчин зүйлээс хамаарч хэсэг бүлгээрээ нийлж ахуйн хүрээнд, шөнийн цэнгээний газар архидах, ялимгүй зүйлээр шалтгаалан хоорондоо хэрүүл маргаан үүсгэж улмаар бусдын бие махбодод гэмтэл учруулж байна. Үүнийг дагаад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өсч байна. Аймгийн төвд архи согтууруулах ундаа худалддаг, борлуулдаг түүгээр үйлчилдэг 84 цэг үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна иргэд гар дээрээс архи согтууруулах ундааг зарж борлуулж байгаа нь дээрх төрлийн гэмт хэргүүд өсөх нэг шалтгаан нөхцөл болж байна.

Зам, тээврийн осол гарч буй шалтгаан нөхцөл байдал:

Дорноговь аймгийн хэмжээнд 2016 онд 353 зам тээврийн ослын дуудлага бүртгэгдсэн бөгөөд үүний 63 дуудлага, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 125 дуудлага мэдээллийг

эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал прокурорт шилжүүлэн, 165 дуудлагыг даатгалын байгууллагаар шийдвэрлүүлсэн.

Зам тээврийн осол гарсан хэргийг өмнөх онтой харьцуулвал:

Хүснэгт VIII.10.1.

	2015 он	2016 он	Өсөлт, бууралт
Гарсан хэрэг	72	63	-12.5
Нас барсан хүн	31	25	-19.4
Гэмтсэн хүн	36	35	-2.8
Осол	101	125	+19.2

Дорноговь аймагт 2016 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын дуудлага 353 байснаас:

Хүснэгт VIII.10.2.

Нас барсан	• Явган зорчигч 31 • Зорчигч 6 • Жолооч 12 • Дугуйтай хүн 13
Гэмтсэн	• Явган зорчигч 38 • Зорчигч 12 • Жолооч 17 • Дугуйтай хүн 7

Зам тээврийн осол гарч буй шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд:

- 347 осол буюу нийт ослын 98.3% нь жолоочийн буруутай үйлдлээс
- Үүний 145 буюу нийт осол гарсан шалтгааны 41.1%-ийг тээврийн хэрэгсэл хоорондын зай тохируулж яваагүйн улмаас гарсан осол эзэлж байна.

Зам тээврийн осол гарсан шалтгаан:

Хүснэгт VIII.10.3.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	26
Хурд хэтрүүлсэн	21
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	1
Анхаарал болгоомжгүй явсан	43
Зогсоох арга хэмжээ аваагүй	37
Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн	3
Хоорондын зай тохируулаагүй	145
Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн	1
Эсрэг урсгалд орсон	5
Эгнээ байр буруу эзэлсэн	2
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	1
Ухрах үйлдэл буруу хийсэн	57
Хэргийн газраас зугтаасан	5
Зорчигчийн буруугаас	-Явган ба дугуйтай хүний буруу 3 -Сургуулийн өмнөх насны хүүхэд 1

Зам тээврийн осол гаргасан хэлбэр:

Хүснэгт VIII.10.4.

Онхолдсон	Мөргөлдсөн	Явган хүн дайрсан	Үл хөдлөх эд зүйл мөргөсөн	Мал амьтан дайрсан	Дугуйтай хүн дайрсан
25	295	21	6	4	2

Тээврийн хэрэгслийн төрөл:

Хүснэгт VIII.10.5.

Суудлын	Ачааны	Мотоцикл	Микроавтобус
314	15	21	3

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бууруулахад анхаарах зүйл

1. Нууц далд аргаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхэд тасаг, албадын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах шаардлагатай.
2. Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх арга, хэлбэр улам нарийсч тухайлбал, халаас, орон байрнаас эд зүйл хулгайлах, автомашин, малын, түүх соёлын үнэт болон дурсгалт зүйлсийн зэрэг байдлаар дагнан тухайн гэмт хэргийн замаар олсон эд зүйлсийг мэдсээр байж авдаг, борлуулдаг сүлжээ, ченжүүд зохион байгуулалтад орж иргэн, ААН-д хохирол учруулсаар байгаад анхаарч орон нутгийн радио телевизээр санамж, зөвлөгөө, сэрэмжлүүлгийг явуулах. (гэмт хэрэг, захиргааны зөрчилд удаа дараа холбогдож байгаа хүмүүсийн талаарх мэдээллийг өгч байх)

3. ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Захиргааны зөрчлийн нөхцөл байдал

Түс аймгийн Цагдаагийн газар нь 2016 онд 12275 зөрчил илрүүлж, урьд оны мөн үетэй харьцуулахад 4826 буюу 28.2%-аар буурсан үзүүлэлттэй байна. 2015 онд 16028 иргэнийг 148.409.700 төгрөгөөр **торгох арга хэмжээ** ногдуулж байсан бол 2016 онд 11666 иргэнийг 543.251.600 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан нь 3.6 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь ЗХАБТХуулиар торгуулийн мөнгөн дүнгийн хэмжээ өндөр батлагдсантай холбоотой. 2015 онд 284 иргэнд **баривчлах** шийтгэл ногдуулж байсан бол 2016 онд 58 иргэн баривчлагдаж урьд оны мөн үетэй харьцуулахад 79.5%-аар буурсан үзүүлэлттэй байгаа нь ЗХАБТХ-ийн 27.3 дахь заалт хэрэгжихгүй, хүчингүй болсонтой холбоотойгоор баривчлагдсан иргэний тоо буурч мөн эрүүлжүүлэх байр албадан саатуулах байр болж журам өөрчлөгдсөнтэй холбоотойгоор баривчлагдсан хүний тоо буурсан гэж дүгнэж болно. Мөн 2016 онд 543 иргэн **тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан** нь 2015 онтой харьцуулахад 2.8%-аар буурсанг илтгэж байна. Харин 2015 онд 1538 иргэн **саатуулагдаж** байсан бол 2016 онд 1450 иргэн саатуулагдаж урьд онтой харьцуулахад 5.7%-аар буурсан нь эрүүлжүүлэх байр албадан саатуулах байр болж журам өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

3. ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дорноговь аймгийн ГХУСАЗСЗөвлөлөөс хуулийг чандлан сахиулах, гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс 2016 онд 4 бүлэг 27 зүйл заалт бүхий

ажлын төлөвлөгөөг Монгол Улсад ГХУСАЗЗөвлөлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараах чиглэлээр зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

Нийтлэг урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Сайншанд, Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай босоо тэнхлэгийн авто зам дээр тээврийн хэрэгсэл жолоодож байгаа жолооч нарт хурд хэтрүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцох, зам тээврийн осол гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох зорилгоор холбогдох байгууллагад санал хүргүүлсэн.
- Олон нийтийн цагдаагийн 14 ажилтныг чадваржуулах зорилгоор Цагдаагийн газрын нэгдсэн цугларалтаар 2 удаа сургалтад хамруулж, хууль эрх зүйг бие даан судлуулах зорилгоор гарын авлага бэлтгэн өгч мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан.
- Дорноговь аймгийн 5 сумын нийт 420 гаруй иргэнд "Иргэдээ сонсъё" уриан дор хууль сурталчлах, иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулахын зэрэгцээ тухайн сумдын ГХУСАЗСЗ, сургуулийн нийгмийн ажилтан, хэсгийн төлөөлөгчийн ажлыг 2016 оны эхний 4 сарын байдлаар шалгаж, холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн. ГХУСАЗСЗ, АА бүлгэм, хэсгийн төлөөлөгч нарын үйл ажиллагаатай танилцан, туслалцаа үзүүлж, ирэх оны ажил бусад чиглэлээр тэдний саналыг сонсох зэрэг ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн дараах 9 чиглэлээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулсан нь цаашид дээрх төрлийн гэмт хэргүүд үйлдэгдэхээс урьдчилан сэргийлсэн үр дүнтэй болсон байна. Үүнд:
  1. Архидан согтуурахтай тэмцэх;
  2. Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа этгээдүүдийн засран хүмүүжилд зохих нөлөө үзүүлэх;
  3. Сургалт сурталчилгаа;
  4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
  5. ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх;
  6. Хяналт шалгалт;
  7. Терроризм, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх;
  8. БХЖЭсрэг гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;
  9. Авлигатай тэмцэх чиглэл

5. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Дорноговь аймгийн хувьд зам тээврийн ослын талаар 2016 оны дүн мэдээнээс авч үзэхэд тус аймгийн нутаг дэвсгэр Улаанбаатараас Замын-Үүд явах босоо тэнхлэгийн улсын чанартай хатуу хучилттай авто замд хүн нас барсан зам тээврийн осол 15 буюу нийт хүн нас барсан ослын 71.4%, нас барсан хүний тоо 22 буюу нийт нас барсан хүний 70.9%-ийг эзэлж байгаа бүртгэл, судалгаатай байна. Ялангуяа тус аймгийн хатуу хучилттай зам дагуух сумын нутаг дэвсгэрт зам тээврийн осол харьцангуй их гарч хүн нас барж, гэмтэж бэртэн эд хөрөнгөөрөө хохирсон дүн мэдээ гарсан. Дээрх дүн мэдээнд үнэлэлт дүгнэлт өгч

шийдвэрлүүлэх дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

1. Одоогийн байгаа замын цагдаагийн орон тоо хүн, хүчээр зам тээврийн осол ихээр гарч байгаа хар цэгүүдийг бүрэн хяналтдаа авах боломжгүй байгаа учраас шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник хэрэгслийг ашиглаж хяналт тавих асуудлыг шийдвэрлүүлэх,
2. Төв суурин газар үйлдэгдэж байгаа хулгайлах, дээрэмдэх, хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг болон танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд хяналт тавихад орчны байдалтай харьцуулж "цахим зураглал хийх" (crime mapping) аргыг нэвтрүүлэх,
3. "Хөгжлийн төлөө хамтдаа" Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тэргүүлэх зорилтын 4.17-д босоо тэнхлэгийн 3 замын уулзварт байнгын пост барих, хяналтын телекамераар хангах заалт тусгагдаж аймгийн 2017 оны төсөвт пост барих 70 сая төгрөг, зөрчил илрүүлэгч камерыг төсвийн тодотголоор шийдвэрлүүлэхээр болсон ба энэ ажлуудын хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох газруудтай хамтарч ажиллан яаралтай дуусгах ажлыг зохион байгуулах ба 4 зохицуулагч, 4 цагдаа зохицуулагчийн орон тоог нэмэх,
4. Иргэдийг чирэгдүүлэхгүй байх, техникийн дэвшлийг орон нутагт нэвтрүүлэх зорилгоор бэлэн бус торгуулийн багажийг замын цагдаагийн алба хаагч бүрд олгож ашиглуулах асуудлыг шийдвэрлүүлэх,
5. Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг судлахад хурд хэтрүүлэн хөдөлгөөнд оролцсон гэсэн шалтгаантай осол 30%-ийг эзэлж байгаа учраас замын цагдаагийн алба хаагчдыг хурд хэмжигч багажаар хангах асуудлыг Аймгийн ГХУСАЗСЗ болон Замын цагдаагийн албанд тавьж шийдвэрлүүлэх,
6. Иргэд олон нийтэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, бусад холбогдох хууль, журам, стандартыг төрийн болон ТББ, хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран сурталчлах ажлыг зохион байгуулах,
7. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэргийн 53.3% нь гэр орон сууцанд, 29% нь гудамж талбайд үйлдэгдэж байгаа нь гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харагдаж байх тул архины хамааралтай хүмүүстэй ажиллахын тулд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгч буюу архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж, нэгдсэн эмнэлгийн наркологийн эмчийн хяналтад авч сэтгэл заслын нарийн мэргэжлийн эмчийн туслалцааг үзүүлэх, өрхийн эмнэлгээс энэ чиглэлийн үйлчилгээг өргөтгөх,
8. Орон нутагт хэрэгжиж байгаа АА буюу сайн дурын архины эмчилгээнд өргөнөөр хамруулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, ТББ-ыг төр, захиргааны байгууллагаас бодлогоор дэмжиж, хамтран ажиллах,
9. Цагдаагийн байгууллагын ажиллах боломжийг сайжруулах холбогдох техник хэрэгсэл маш их дутагдалтай байгаа нь судалгаанаас харагдаж байгаа тул гэрэлтүүлэг, гудамж талбайг камертай болгох асуудлыг цогцоор нь шийдэх арга хэмжээ авах
10. Мөн мал хулгайлах гэмт хэргийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог сайжруулж, малчид, мал бүхий айл, иргэдийн хүчийг нэгтгэсэн мал хамгаалах бүлэг, нөхөрлөлийг сум, баг бүрт байгуулж үйл ажиллагааг идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх, төр, захиргааны байгууллагууд бодлогоор дэмжих зэрэг тулгамдаж буй асуудал гарч байна.
11. Цаашлаад Дорноговь аймгийн хувьд хамгийн гол тулгамдаж буй асуудал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх төсвийг хангалттай хэмжээнд баталж өгөх асуудал юм. Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн үйл ажиллагаа явуулах төсөв нь олон нийтийн цагдаагийн урамшуулалд л зарцуулагдаад дуусах хэмжээний төсөв хуваарилагдаж байгаа тул энэ тал дээр анхаарах шаардлагатай байна.

ДУНДГОВЬ АЙМАГ



11. ДУНДГОВЬ АЙМАГ

1. НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, НУТАГ ОРОН, САЛБАРЫН ОНЦЛОГ.

Нутаг дэвсгэр, засаг захиргаа

Дундговь аймаг нь 1941 онд Өмнөговь аймгаас 8 сум, Дорноговь аймгаас 3 сум, Төв аймгаас 7 сум тус тус шилжүүлэн 18 сумтайгаар одоогийн Өлзийт сумын нутаг Ембүү дэрсэнэ ус гэдэг газар Шарангад аймаг нэртэйгээр байгуулагджээ. 1942 онд аймгийн нэрийг Дундговь хэмээн өөрчилж аймгийн төв одоогийн оршин байгаа Зоогийн Хар овооны энгэрт суурьшсан байна. Засаг захиргааны хувьд 15 сум, 66 багтай, 7469,0 мянган га нутаг дэвсгэртэй, газар нутгийн хэмжээгээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн 4,5%-ийг эзэлдэг, аймгийн төв нь Улаанбаатар хотоос 265 км зайд байрладаг, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг.

Байгаль, цаг уур

Тус аймгийн нийт газар нутаг нь тал хээр говийн бүсэд багтдаг. Тэгш тал газрын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 1530 м, хамгийн нам нь 980 м, хамгийн өндөр Дэлгэрхангайн уул далайн түвшнээс дээш 1913 м өндөр өргөгдсөн байдаг. Тус аймгийн нутагт уулын хөрс (хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн) маш бага хувийг эзэлж Адаацагийн хойд тал, Бага газрын чулуу, Угтаалын уул, Их газрын чулуу орчимд тархсан. Нутгийн төв, хойд хэсгээр ухаа толгод нам уулсын (хүрэн, цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, хээржүү цөлийн бор) хөрс, нутгийн төв, өмнөдхэсгээр тал хөндийн (цөлөрхөг хээрийн 20 төрлийн хөрс) хөрс тархсан.

Газар зүй

Монгол Улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөр, Дэлгэрхангай уул, Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Нутгийн хойд хэсэгт дээд палеозойн хурдас, өмнөд хэсгээр нь цэрдийн ба кайнозойн хурдас тархжээ.

Нийгэм, эдийн засаг

Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Цахилгаан хангамж бүрэн шийдэгдсэн. Холбоо харилцаа мен сайн хөгжсөн. Хоёр сумаас бусад нь шилэн кабельд холбогдоход бэлэн болсон байна. Даланзадгад болон Улаанбаатар хотуудтай хатуу хучилттай авто замаар шууд холбогдсон. Энэ замын дагуу Дэлгэрцогт, Сайнцагаан, Луус, Хулд сумд байрлах ба Дэрэн, Дэлгэрхангай сумдын төв цаашид холбогдоход хамгийн ойр. Одоо Мандалговь - Чойр чиглэлийн авто замыг барих нь эдийн засгийн чухал ач холбогдолтой. Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан, Гурвансайхан сумд аймгийн төв болон Улаанбаатартай холбогдоно.

Нутгийн онцлог

Чулуун нүүрс (Хүйтэнхонгор, Тэвш, Элгэн говь, Өвдөгхудаг, Сүүл-Өндөр), төмрийн хүдэр (Эрээн), гөлтгөнө (Таргат), Шохойн чулуу (Цахиурт), Шатдаг занар (Өвдөгхоолойн хошуу, Баянжаргалант), хайлуур жонш, барилгын материал зэрэг ашигт малтмал бий.

ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Гэмт хэргийн нөхцөл байдал

Дундговь аймагт 2010-2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг авч үзвэл дор дурдсан гэмт хэргүүд үйлдэгдсэн байна. Үүнд:

Хүснэгт VIII.11.1.

Хэргийн өнгө	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Хүнийг санаатай алах гэмт хэрэг		3	1	3		1	4
Хүчиндэх гэмт хэрэг	5	6	2	5	8	2	1
Дээрэмдэх гэмт хэрэг	1	1	2	1			1
Танхайрах гэмт хэрэг	20	17	12	12	12	10	4
Булаах гэмт хэрэг		4				1	1
Золгүй учрал	3	6		4	1	1	1
Бусдын бие махбодид гэмтэл учруулах	52	64	73	87	85	70	94
Мал хулгайлах	29	21	31	37	41	31	16
Иргэдийн өмчийг хулгайлах	90	42	49	86	53	61	46
ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг	5	19	9	29	33	35	22
Залилан мэхлэх гэмт хэрэг	6		5	5	5	7	10
Бусад гэмт хэрэг	20	23	17	15	22	23	21
Нийт гэмт хэрэг	231	206	201	284	260	242	221

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн үзүүлэлт:

Хүснэгт VIII.11.2.

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Гудамж талбайд үйлдсэн гэмт хэрэг	86	63	49	42	39	28	48	33	31	22
Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	90	79	57	68	67	64	89	86	66	66
Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг	80	65	43	55	13	25	27	31	25	14

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үзүүлэлт:

Хүснэгт VIII.11.3.

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (сая)	149.6	601.1	359.4	111.1	195.6	300.6	614.3	590.8	801.5	707.6
Нас барсан хүн	10	12	6	5	19	4	15	13	21	8
Гэмтсэн хүн	117	86	79	38	91	102	118	142	22	13

Гэмт хэргийн илрүүлэлт:

Хүснэгт VIII.11.4.

2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
46.7%	40.3%	72.7%	88.7%	78%	61.9%	47.7%	55.4%	53.8%	67.6%

Гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Дундговь аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар өссөн үзүүлэлттэй байгаа 3 төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж үзвэл дараах хүчин

зүйл буюу хүнийг санаатай алах гэмт хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг, залилан мэхлэх гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргүүд гарсан байна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан:

Хүн ам ихээр төвлөрсөн сум болон иргэдийн эрх зүйн мэдлэг муу сумдад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэл болон найз нөхөд, хамаатан садангийн таарамжгүй харилцаанаас үүдэж энэ гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл нь болж байгаа бөгөөд хүн амины гэмт хэрэг үйлдсэн этгээдийг судалж үзэхэд боловсрол, ажил эрхлэлт, амьжиргааны түвшин нь нөлөөлж байна. Мөн Дундговь аймгийн хувьд бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тодорхой арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг боловч энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг дутмаг зохион байгуулсантай холбож энэхүү гэмт хэрэг ихээр үйлдэгдэх болсон гэж үзэж болно.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн шалтгаан:

- Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг муу;
- Архидалт, ажилгүйдэл;
- Баяр ёслолыг архидаж тэмдэглэдэг;
- Олон нийтийн газарт биеэ зөв боловсон авч явах соёл дутмаг;
- Үйлчилгээний газарт үйлчлүүлэх соёлгүй зэргээс энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна.

Залилан мэхлэх гэмт хэргийн шалтгаан:

- Улс орны эдийн засгийн хямрал;
- Ажилгүйдэл, ядуурал;
- Иргэдийн амар хялбар аргаар мөнгөтэй болох сонирхол нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх шалтгаан нөхцөл болж байна.

Согтуугаар гэмт хэрэг үйлдэхийн шалтгаан, нөхцөл:

Хүн амын төвлөрөл, ажилгүйдэл, ядуурал, хүмүүсийн төлөвшилт, гэр бүлийн орчин, байгууллага хамт олон найз нөхдийн харилцаанаас шалтгаалан архидан согтуурах үзэгдэл улам бүр газар авч архины хэрэглээ ба түүнээс гарах сөрөг үр дагавар, хор уршиг нь жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байсаар байна. Үүнээс шалтгаалан согтуугаар гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдал болж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг нь дараах шалтгааны улмаас бий болж байна. Үүнд:

- Архидалт, ажилгүйдэл;
- Баяр ёслолыг архидаж тэмдэглэдэг;
- Олон нийтийн газар биеэ зөв боловсон авч явах соёл дутмаг;
- Үйлчилгээний газарт үйлчлүүлэх соёлгүй;
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцдог;
- Гэр бүлийн хүчирхийллийг согтуугаар үйлдэх;
- Насанд хүрээгүй хүмүүс архи, согтууруулах ундаа хэрэглэх;
- Гаргалт, үдэлтээр архидах;
- Аймгийн ойролцоо хөдөө архидах;
- Ажил бүтээх зорилгоор архидах;
- Бэлэг дурсгалын зүйлд ашиглан архидах зэрэг юм.

ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Захиргааны зөрчлийн нөхцөл байдал

Дундговь аймгийн хувьд 2015 он болон 2016 онд бүртгэгдсэн нийт захиргааны зөрчлийг харьцуулан авч үзвэл:

Хүснэгт VIII.11.5.

2015 он	2016 он
10242	8384

Дээрхээс дүгнэвэл 2016 онд 8384 зөрчлийг илрүүлсэн нь урьд оны мөн үеэс 1858 зөрчлөөр буюу 18.1%-иар буурсан үзүүлэлтэй байгааг харуулж байна.

Захиргааны зөрчилд арга хэмжээ авсан байдлын хувьд:

Хүснэгт VIII.11.6.

	2015 он	2016 он
Баривчлах	219	33
Эрх хасах	339	213
Журамласан тээврийн хэрэгсэл	765	528
Торгох	Торгуулийн хуудсаар-8694 Шийтгэвэрээр-990	Торгуулийн хуудсаар-7020 Шийтгэвэрээр-1118
Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хуулиар арга хэмжээ авагдсан хүн, төгрөг	9684 хүн 84,662 төгрөг	8138 хүн 285 төгрөг
Албадан саатуулах	471	513

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулсан үйл ажиллагаа

Дундговь аймаг нь 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дор дурдсан ажил үүргийг хийж гүйцэтгэсэн ба Үүнд:

- "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, албан тушаалтны хариуцлагыг нэмэгдүүлж, хяналт оролцоог хангах нь" сэдэвт мэдээлэл, хэлэлцүүлэг 2016 оны 2-р сард зохион байгуулсан;
- ГХУСАЗСЗ-ийн 04 дугаар тогтоолоор 2016 оны 1-р улиралд аймгийн Зөвлөлийн гишүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлахад мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, сургалт мэдээллийн ажилд ахиц гарсан;
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүн, бүлэг бөөгнөрөл, эмзэг цэг, сэтгэцийн эмгэгтэй, архаг архичин, биеэ үнэлж болзошгүй, захиргааны хяналтад байдаг этгээдүүдийн талаарх мэдээллийг судалгаа хяналтын нэгдсэн санд оруулж, хариуцсан нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй цэг /объект/-ийг Цагдаагийн хяналтад авч ажилласан;
- Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар "Архигүй Дундговь" хөтөлбөр батлан хэрэгжүүлсэн ба уг хөтөлбөрийн хүрээнд архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, идэвх санаачлагыг дэмжин хамтран ажилласан;
- Хүүхдийн гэмт хэрэг үйлдэх, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр хүүхдийн гэмт хэрэг үйлдэх, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх ажлыг Хүүхдийн

гэмт хэрэг, хэв журмын зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл, зам тээврийн болон ахуйн осол гэмтэл, цахим мэдээллийн сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх салбар дундын төлөвлөгөөг батлуулан, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг үүрэгжүүлэн ажилласан;

- 2016 оны 4, 5, 11-р сард Дундговь аймгийн сумдад мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулсан;
- Иргэдийн өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, гудамж талбай, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийг бууруулах, зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх ААН, байгууллагууд бүрэн камертай болгох, "Хөршийн холбоо"-г байгуулж, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, гудамж, байруудад ахлагч ажиллуулах, гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, айл өрхийн хашаа, орцыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгох, цонх хаалга, тагтны хамгаалалтыг сайжруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд 2016 оны 12 сарын байдлаар Дундговь аймгийн хэмжээнд 199 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа нь 2015 оноос 37 буюу 16%, танхайрах гэмт хэрэг 5 буюу 56%, хулгайлах гэмт хэрэг 41 буюу 45%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 13 буюу 38%, гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 10 буюу 34%, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 19 буюу 15%-аар буурсан байгаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлах, энэ талаар үйл ажиллагаа явуулах нь давуу талтай байгааг илтгэж байна.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ


Дундговь аймгийн хувьд архидан согтуурахтай тэмцэх талаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг цэгүүдийг гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлээр зохион байгуулж байгаа үйл ажиллагаандаа идэвхтэй оролцуулах нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдэх явдал багасахад хүргэх чухал арга зам болно гэж дүгнэж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулсан ч гэсэн тодорхой хэдэн гэмт хэргийн хувьд (мал хулгайлах, дээрэмдэх, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг) сургалт явуулсан нь хязгаарлагдмал бөгөөд цаашлаад энэхүү үйл ажиллагааныхаа хүрээг тэлэх нь гэмт хэрэг, зөрчлийн гарал үүслийг багасгахад чиглэгдэнэ. Жишээлбэл: тэмдэглэлт баяр ёслолыг зөв боловсон тэмдэглэн өнгөрүүлэх талаар иргэд, ААН, байгууллагад албан мэдэгдэл зөвлөмж хүргүүлж ажиллах тал дээр анхаарч ажиллавал согтуугаар үйлдэх гэмт хэргийн тоо багасахад хүрнэ.

Техник технологийн давуу байдлыг бий болгож камертай болгох, гэрэлтүүлэг хийх зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үүргийг гүйцэтгэж байгаа нь сайшаалтай ч иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах сургалт хөтөлбөрийг сумдад зохион байгуулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарах нөхцөлийг бууруулах тул энэ тал дээр анхаарч ажиллах;

Төв суурин газар үйлдэгдэж байгаа хулгайлах, дээрэмдэх, хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг болон танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд хяналт тавихад орчны байдалтай харьцуулж "цахим зураглал хийх" (crime mapping) аргыг нэвтрүүлэх;

Мөн шинээр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай хуулийг сурталчлах ажлыг хэрэгжүүлэх;

ЗАВХАН АЙМАГ



12. ЗАВХАН АЙМАГ

Завхан аймаг нь 1923 онд байгуулагдсан зэсаг захиргааны 24 сум, 115 багтай, Монгол Улсын баруун хэсэгт орших бөгөөд баруун талаараа Ховд, Увс, хойд талаараа ОХУ-ын Тува улс, зүүн талаараа Хөвсгөл, Архангай, урд талаараа Баянхонгор, Говь-Алтай аймгуудтай хиллэдэг. Нутаг дэвсгэр нь 82,5 мянган км², 21.1 мянган өрхийн 70852 хүн амтай (2016 оны байдлаар) Улаанбаатар хотоос 1104 км зайтай. Аймгийн дүнгээр 1 км² 0.85 хүн оногдож байгаа нь улсын дунджаас 0.9 хүн, баруун бүсийн дундажтай харьцуулахад 0.11 хүнээр сийрэг байна.

Хойд хэсгээрээ өвөлдөө зузаан цасан бүрхүүл тогтдог. Завхан, Идэр, Тэс, Мухар, Хүнгийн голууд, тэдгээрийн цутгалд Борх, Яруу, Ширээ, Чигэстэй, Буянт, Шар-Ус, Төмөрт, Зарт, Цэцүүх, Хос зайгал, Зүйл, Улиастай, Чулуут, их, бага Богд гэх мэт гол, мөрөн, Хар дөрөө, Тэлмэн, Бүст, Ар Бадархундага, Өвөр Бадархундага, Ойгон, Чандманы хар, Баян, Холбоо, Хөх нуур, Цагаан нуур зэрэг нууртай. Отгонтэнгэр уул нь мөнх цастай, Усны эрчим хүчний нөөц ихтэй бүс нутаг юм.

Өндөр уулын, тайгын, ойт хээр, хээрийн, хуурай цөлөрхөг хөрстэй, хээрийн олон хэв шинжийн ургамалтай. Хангай, Булнай, Тагнын нуруу, тэдгээрийн салбар уулсаар шинэс, Тарвагатайн нуруу нь хушин ойтой. Баавгай, зэрлэг гахай, бор гөрөөс, буга, аргаль, янгир, ирвэс, чоно, үнэг, хярс, мануул, дорго, шилүүс, туулай, чандага, тарвага, цагаан болон хар сүүлт зээр зэрэг ан амьтантай. Ойн болон өндөр уулын, тал хээрийн, нүүдлийн шувуу ирдэг. Хойлог, ятуу, хур сойр, хун, хотон, нислэг сар, тас, шонхор зэрэг ховордсон шувуу бий. Хар болон Баян нуурт загас маш элбэг байдаг.

Мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд илүү тохиромжтой, үржил хөрс бэлчээр сайтай голуудын хөндий тал хээр нутагт хүн ам нэлээд шигүү суудаг. Тосонцэнгэл сум нь хотжисон суурин юм. Баянзүрх, Зарт, Цэцүүх, Отгонтэнгэр, Улаан хаалга, Бор бургас, Даян зэрэг амралт сувиллын газартай. Таван хошуу малтай бөгөөд хонин сүргээрээ улсад дээгүүр байранд ордог. Тулман хөхт ямаа, Булнайн сарлаг, Тэсийн голын адуу, Сартуулын ууцан сүүлт хонь, ноолуурын хар ямаа, Талын улаан үхэр зэрэг нутгийн үүлдрийн шилмэл мал зонхилон өсдөг. Тэс, Идэр, Богдын голын хөндийд төмс, хүнсний ногоо чацаргана тариалдаг.

Улиастай хотод томоохон клиник эмнэлгүүдтэй, арван жилийн сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хөгжим бүжгийн коллеж, МУИСургуулийн харьяа Эдийн засгийн сургууль, Орхон их сургуулийн салбар, зохиогчдын болон урчуудын салбартай. Майхан уулын ам, Донойн хөндийд олон улсын чанартай нисэх онгоцны буудалтай. Түүх соёлын дурсгалаар арвин. Хөгжимт драмын театр, орон нутгийг судлах музей, номын сан, зэрэг ААН-тэй, аялал жуучлал хөгжүүлэх боломжтой аймгуудын нэг юм.

Хүн ам

График VIII.12.1.



2016 оны дүнгээр 19.9 мянган өрхийн 69.7 мянган хүн амтай болж өнгөрсөн оноос хүн амын тоо 1.1 мянган хүнээр буурсан нь нийслэл, аймаг руу 1,7 мянган хүн шилжиж явсантай холбоотой. Нийт хүн амын 49.9% нь эрэгтэй, 50.1% нь эмэгтэйчүүд, 31.4% нь 16 хүртэл насны хүүхэд, 33.7% нь 16-35 насны залуучууд, 25.7% нь 35-55 насны хүн ам, 9.2% нь 55-ээс дээш насны хүн ам эзэлж байна.

Аймгийн нийт хүн амын 22.2% нь Улиастай суманд, 12.3% нь Тосонцэнгэл суманд, 8.5% нь Их-Уул суманд 57.0% нь бусад сумдад оршин сууж байна. Нийт өрхийн 22.8% аймгийн төвд, 20.6% сумын төвд, 56.6% хөдөө оршиж сууж байна. Завхан аймгийн хувьд хүн амын дундаж наслалт 2012 онд 67,5 мянга байсан бол 2015 оны эцэст 69,7 мянга, 2016 онд 70852 хүн амтай .

Нийгэм, эдийн засаг

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 онд 137,2 тэрбум байсан бол 2015 онд 322,1 тэрбум болж 184,9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт ААН-ийн тоо 2012 оныхоос 749-өөр үйлдвэрлэл, эрхлэгч ААН, байгууллагын тоо 200-аар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2015 онд 2,1 саяас 4,6 сая болж тус тус нэмэгдсэн байна. Өнгөрсөн хугацаанд Завхан аймагт 63,2 км хатуу хучилттай зам баригджээ. Орон сууц 260-аар нэмэгдсэн.

Завхан аймгийн нийт үйлдвэрлэлийн хэмжээг 2012-2016 оны байдлаар авч үзвэл 2012 онд 11648.5 төгрөг, 2013 онд 10723.8 төгрөг, 2014 онд 11628.4 төгрөг, 2015 онд 10870.4 төгрөг, 2016 онд 10680.3 төгрөг байгаа нь 2014 оноос 2016 он хүртэл үйлдвэрлэлийн хэмжээ жил дараалан буурсан байна.


Мал тооллогын дүнгээр 2016 онд тус аймаг 3406.2 сая мал тоологдсон буюу өмнөх оны мал тооллогын дүнгээс 273200 толгойгоор таван төрөл дээр өссөн байна.

Тэмээ 0.2 мянга буюу 2.9%, адуу 23100 буюу 14.2%, үхэр 13500 буюу 8.5%, хонь 167600 буюу 10.7%, ямаа 68800 буюу 5.5%-аар тус тус өссөн байна.

Завхан аймаг дахь бүртгэлтэй ажилгүйчүүд:

Завхан аймагт 2012-2015 онд шинэ ажилд орсон иргэдийн тоо 5879 болж нэмэгдсэн дүн байгаа нь нэг жилд дунджаар 1469 иргэн шинэ ажилд орж байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог авч үзвэл, 2015 онд өмнөх оноос 289 хүнээр буурсан харин 2016 онд өмнөх оныхоос 121 хүнээс нэмэгдсэн байгаа нь тус аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ 2014 оноос хойш жил дараалан буурсантай холбоотой байна. Нэг жилд 1469 иргэн шинэ ажилд орж байхад бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо буурахгүй байна гэдэг нь Завхан аймаг бүртгэлтэй иргэдийг ажилтай болгох тал дээр хангалтгүй ажиллаж байна.

График VIII.12.2.



Энэ асуудал зөвхөн Завхан аймгийн бус нийт улсын хэмжээний асуудал бөгөөд учир нь дээрх боловсрол бүхий иргэдийг тухайн орон нутагт нь ажлын байраар хангах нь хүн амын төвлөрлийн үйл явцыг саармагжуулах чухал ач холбогдолтой.

Завхан аймаг дахь өргөн хэрэглээний барааны үнийг хил залгаа хилийн бүсийн аймгууд болох Хөвсгөл, Увс аймгуудын өргөн хэрэглээний барааны үнэтэй харьцуулан авч үзвэл:

Хүснэгт VIII.12.1.

№	Өргөн хэрэглээний бараа	Завхан аймаг (2017.05.17) УБ-Улиастай 1104 км	Хөвсгөл аймаг (2017.05.03) УБ-Мөрөн 648 км	Увс аймаг (2017.05.17) УБ-Улаангом 1379 км
1	Гурил 1кг	1000	1300	1000
2	Хонины мах 1кг	6500	5000	6500
3	Үхрийн мах 1кг	6000	5500	6000
4	Ямааны мах (ястай) 1кг	4500	4000	4500
5	Элсэн чихэр 1 кг	2400	2200	2400
6	Цагаан будаа 1кг	2433	2200	2433
7	Шингэн сүү 1л	1200	1800	1200
8	Дизелийн түлш 1л	1890	1840	1890
9	Бензин А-80 1л	1650	1570	1650
10	Бензин А-92 1л	1760	1780	1760

Өргөн хэрэглээний барааны үнэ ойролцоо байвч Улаанбаатар хотоос алслах зайтай холбон авч үзвэл, Улаанбаатар хотоос тээвэрлэн ирдэг барааны үнэ Завхан аймагт өндөр байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотоос 1104 км тээвэрлэн Улиастай хүргэх, 1379 км тээвэрлэн Улаангом хүргэсэн гурил, будаа, элсэн чихэр, дизель түлш, бензиний үнэ адил байна.


Завхан аймгийн нийт хүн амын 1/3 орчим буюу 27.5 мянган иргэн 2016 онд халамжийн сангаас халамж тэтгэмж авсан нь тухайн аймаг халамж, тэтгэврийн

сангаас ихээхэн хамааралтай нь дээр өргөн хэрэглээний бараа үнэтэй байгаа нь тухайн аймгийн иргэдэд нэлээдгүй хүндрэл учруулдаг.

ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улсын хэмжээнд 2016 онд 9222 гэмт хэрэг бүртгэгдсэний 259 гэмт хэрэг 2,8%-ийг Завхан аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд үүний 38.6%-ийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг, 37.1% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 5.8% нь ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, бусад гэмт хэрэг 18.5%-ийг эзэлж байна. Нийт 5621 зөрчил илрүүлж, 619 хүн эрүүлжүүлэх байранд хүргэгдэж, 55 хүн баривчлагдан, гэмт хэргийн улмаас 13 хүн нас барж, 90 хүн гэмтэж, 497.6 сая төгрөгийн хохирол учирчээ. Гэмт хэргийн тоо өнгөрсөн оноос 15.1%-аар, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 71.5%-аар тус тус өссөн байна.

График VIII.12.3. Гэмт хэргийн гаралтыг сумдаар авч үзвэл:



Улиастай сум 15756 хүн амтай 107 хэрэг бүртгэгдсэн, Тосонцэнгэл сум 9047 хүн амтай 52 гэмт хэрэг бүртгэгдсэн, Алдархаан сум 2816 хүн амтай 16 гэмт хэрэг бүртгэгдсэн, Их-Уул 6238 хүн амтай 13 гэмт хэрэг бүртгэгдсэнээр тус тус гэмт хэргийн гаралт бусад сумдтай харьцуулахад харьцангуй их байна. Мөн хүн амын нягтрал, хүн амын хөдөлгөөн гэмт хэргийн гаралтад нөлөөлөх хандлага ажиглагдаж байна.

Тухайлбал, Асгат сум 2 багтай 952 хүн амтай боловч тус суманд 3 гэмт хэрэг үйлдэгдсэн нь хамгийн бага газар нутагтай, хүн амын нягтрал их байгаатай холбоотой, Алдархаан сум газар нутаг том хүн ам тоо их биш (хүн амын тоо 2816) боловч тус сумын нутаг Донойн хөндийд нисэх онгоцны буудал байдагтай холбоотой хүн амын хөдөлгөөн ихтэй сум юм.

Завхан аймагт үйлдэгдсэн гэмт хэргийг сүүлийн таван жилийн байдлаар (2012-2016 он) аймгийн нийт үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үнэ өртөгтэй харьцуулах байдлаар дүгнэлт хийхэд:

Хүснэгт VIII.12.2.

Он	Гэмт хэрэг	Аймгийн нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ
2012	354	11648.5
2013	300	10723.8
2014	312	11628.4
2015	225	10870.4
2016	259	10680.3

Харьцуулалтад Завхан аймгийн нийт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үнэ 2014 оноос буурах болсон боловч бүртгэгдсэн гэмт хэрэг мөн адил буурсан байсан. 2016 онд өмнөх оны эцсээс 34 гэмт хэргээр нэмэгдэж 259 болсон ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ өндөр байсан 2014 оны бүртгэгдсэн гэмт хэргээс даруй 53 гэмт хэргээр бага байгаа нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах, эдийн засгийн уналт нь гэмт хэргийн гаралтын нэмэгдүүлдэг, эдийн засгийн уналтыг дагаад нийгэмд ядуурал бий болж гэмт хэрэг нэмэгддэг гэсэн ойлголт үгүйсгэгдэж нийгэм, эдийн засгийн харилцаа гэмт хэргийн үзүүлэлтэд нөлөөлөх зөвхөн нэг шалтгаан гэдэг нь улам бүр батлагдаж байна.

Захиргааны зөрчил 2014 онд 8553 бүртгэгдсэн, 2015 онд 9668 бүртгэгдэж өмнөх оноос 1115 буюу 13.0%-аар өссөн, 2016 онд 5624 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 41.9%-аар буюу 4047 зөрчлөөр буурсан байна.


ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ:

График VIII.12.4.



Гэмт хэргийн улмаас 2014 онд 288 иргэн, 2 байгууллага хохирсноос 13 хүн нас барж өмнөх оноос 18.8%, 107 хүн гэмтэж мөн өмнөх оноос 0.9%-аар өссөн. 2015 онд 257 иргэн хохирсноос 6 хүн нас барж өмнөх оноос 7 буюу 53.8%, 93 хүн гэмтэж мөн өмнөх оноос 14 буюу 13.1%-аар буурсан. 2016 онд 285 иргэн, 1 байгууллага хохирсноос 13 хүн нас барж өмнөх оноос 7 буюу 116% өссөн, 104 хүн гэмтэж мөн өмнөх оноос 3.2%-аар буурсан. Хохирлын хэмжээ мөнгөн дүнгээр 2014 онд 539.0 сая, 2015 онд 442.2 сая, 2016 онд 497.6 сая төгрөгийн хохирол тус тус бий болжээ.

График VIII.12.5. Гэмт хэрэгт холбогдогчийн нас:



Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн дунд 18-29 насны залуучууд 34-41.7%-ийг эзэлж байна. 2014 онд 283 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 96 буюу 34%, 2015 онд 237 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 99 буюу 41.7%, 2015 онд 264 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 108 буюу 40.9%-ийг 18-29 насны залуучууд эзэлж байна. Ялангуяа 2016 онд 108 хүн болон өмнөх оны гэмт хэрэгт холбогдогчоос 9%-аар өссөн нь харагдаж байгаа бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажиллагааг 18-29 насны иргэд рүү чиглүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа:

Хүснэгт VIII.12.3. Долоо хоногийн гарагийн байдлаар авч үзэхэд:


№	Гараг	2014 он	2015 он	2016 он
1	Даваа	56	32	31
2	Мягмар	58	40	
3	Лхагва	51	39	42
4	Пүрэв	44	33	35
5	Баасан	40	35	44
6	Бямба	28	24	40

7	Ням	35	22	30

Долоо хоногийн өдрүүдийн хувьд харилцан адилгүй 2014 болон 2015 онд гарагийн эхний өдрүүдэд, 2016 оны хувьд гарагийн сүүлийн өдрүүдэд гэмт хэрэг олон бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, хугацааг сүүлийн хоёр жилийн байдлаар үзэхэд шөнийн цаг буюу 22:00-06:00 цагийн хооронд хамгийн их 2015 онд 97 гэмт хэрэг, 2016 онд 117 гэмт хэрэг бүртгэгдсэн, харин 2015 онд 19:00-22:00 цагийн хооронд 89 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


График VIII.12.6.



ЗАВХАН АЙМАГТ ҮЙЛДЭГДСЭН ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ

Завхан аймгийн ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг хөдөө орон нутгийн нэг адил авто машин болон мотоцикл замын хөдөлгөөнд оролцохдоо гэмт хэрэг үйлдэгдэх явдал их байна. ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг тэр дундаа Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлд заасан гэмт хэргийн гаралт 2014 оноос жил дараалан буурсан байна.

График VIII.12.7.



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар тус аймаг дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

- Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, судалгаа, тооцоололд үндэслэсэн төлөвлөлтийг хийн, тодорхой хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг аймгийн ГХУСАЗСЗ-д тайлагнаж ажиллах бүхий орон тооны бус дэд зөвлөлийг байгуулж ажиллах талаар чиглэл өгсний дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар хамтран "Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус дэд зөвлөл"-ийг байгуулан ажиллаж байна.
- Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюулыг таслан зогсоох зорилгоор үүрэн холбооны үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллах талаар санал солилцлоо.
- Төрийн албан хаагчдыг архи согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзуулж, манлайллыг бүй болгох зорилгоор "Сүү өргөж хүндэтгэл үзүүлэх" уриалгыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргаж байгууллага ААН-үүд, сумдын удирдлагуудад албан бичгээр хүргүүлж хэрэгжилтийг хангуулж эхлээд байна.
- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газар, аймгийн Прокурорын газрын ажилтнууд 2017 оны 03-р сарын 17-ноос 19-ний өдрүүдэд Завхан аймгийн Дөрвөлжин суманд ажиллаж, сумын иргэд болон тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж бүй "Баян-Айраг Эксплорейшн" ХХК-ийн ажилтнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл хийлээ.
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажилтан 2, Цагдаагийн газрын олон нийт хариуцсан байцаагч, аймгийн ИТХ-ын орон нутаг, бодлого зохицуулалтын хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй Увс аймгийн төвд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, баруун аймгуудад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, алба хаагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор баруун бүсийн цагдаагийн хүрээний "Мал хулгайлах" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт зөвлөгөөнд мэдээлэл солилцуулж туршлага судлуулсан.

Дээрх тайланд тусгагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь сургалт, семинар, зөвлөгөөн, уриалгаар хязгаарлагдаж байгаа нь учир дутагдалтай байна. Тус аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралт сүүлийн хоёр жил дараалан буурах хандлагатай байгаад дүгнэлт судалгаа хийн ямар шалтгаан, нөхцөлийн улмаас гэмт хэргийн гаралт буурсныг судлан тогтоон, ирээдүйн хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний прогнозыг боловсруулах байдлаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сургалт, семинар явуулах тохиолдолд гэмт хэрэгт холбогдох магадлал бүхий зорилтод бүлэгт чиглэгдсэн байх ёстой. Тухайлбал, Завхан аймагт гэмт хэрэгт ихээр холбогддог 18-29 насны иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах, мөн тэдгээрийг урьдчилан сэргийлэх ажилд биечлэн оролцуулах шаардлагатай.

ОРХОН АЙМАГ



13. ОРХОН АЙМАГ

Эрдэнэт хот "Эрдэнэтийн овоо"-ны арын сайхан хөндийд 1973 онд шаваа тавьж, 1974 оноос Булган аймгийн Эрдэнэт хороо нэртэйгээр засаг захиргааны нэгжийн хувьд үүсгэн байгуулагдаж байжээ. Хурдан тэлж, хүн ам нь огцом өссөн тул хороог 1976 онд Эрдэнэт хот болгон зохион байгуулснаар Монгол Улсын гурав дахь хот болж хөгжсөн. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн өөрчлөлтөөр 1994 онд "Орхон аймаг" болгосон. Орхон аймаг нь Монгол Улсын төв хойд хэсэгт оршдог, Сэлэнгэ, Булган аймагтай хиллэдэг байна. Далайн түвшнээс дээш 1200 метрт өргөгдсөн, 84,4 мянган га газар нутагтай. Нийт нутаг дэвсгэрийн 50,2 мянган га нь ХАА-н эдэлбэр газар, 25,1 мянган га нь хот, тосгоны суурин газар, 24,7 мянган га нь ойн сан юм. ХАА-н эдэлбэр газрын 5300 га нь тариалангийн талбай, 33700 га нь бэлчээр юм. Эрс тэрс уур амьсгалтай. Өвөлдөө -20 хэм хүйтэрч, зундаа +30 хэм хүртэл халдаг. Жилийн дундаж хэм нь +0,8. Хур тунадас ихтэй, жилийн нийлбэр хэмжээ нь 371,8 мм. Дөрөв, тавдугаар сард хамгийн их салхитай, нэгдүгээр сард хамгийн хүйтэн, долдугаар сард хамгийн халуун байдаг. Орхон аймаг нь Баян-Өндөр, Жаргалант гэсэн 2 сумтай, тэдгээр нь 22 багтай.

Аймгийн төв Баян-Өндөр сум нь засаг захиргааны 21 нэгжтэй, нийт 87837 мянган хүн амтай, 41056 мянган толгой малтай. Хүн амын тоо, эдийн засгийн хүчин чадал, засаг захиргаа бүтцээрээ Монгол Улсын хамгийн том сум.

Жаргалант сум нь засаг захиргааны 4 нэгжтэй, нийт 3000 гаруй хүн, 850 өрхтэй. 80 мянга гаруй малтай, эрчимжсэн газар тариалан зонхилон эрхэлдэг сум юм.

Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэгч аймгийн Засаг дарга нь хотын захирагчийн үүргийг давхар гүйцэтгэдэг бөгөөд 5 хэлтэс бүхий аймгийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Цагдаа, Татвар, Статистик, Нийгмийн даатгал, Гааль, Хөдөлмөр халамж үйлчилгээ, Эрүүл мэнд, Боловсрол, Соёл, Биеийн тамирын газар зэрэг 20 гаруй агентлагаар дамжуулан төрийн үйлчилгээг иргэддээ хүргэдэг. Орхон аймагт нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлдэг аймгийн ИТХ нь 31 төлөөлөгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Эрдэнэт хот анх байгуулагдаж байх үедээ 7800 хүн амтай байсан бол өдгөө Орхон аймгийн 90 орчим мянга болж өсжээ. Энэ үзүүлэлтээрээ улсынхаа хэмжээнд Улаанбаатар хотын дараа хоёрдугаар байранд ордог. Хүн амын жилийн дундаж өсөлт 2,2 хувь бөгөөд нийт хүн амын 63,9%-ийг залуучууд эзэлдэг. Аймгийн хүн амын 64,0% нь хөдөлмөрийн насных бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүн амын 95,2% нь хөдөлмөр эрхэлж байна. Нийт иргэдийн 53,0 орчим хувь нь 6 бичил хороололд орон сууцанд, 47,0% нь гэр хороололд амьдардаг байна.

Орхон аймагт өнөөгийн байдлаар 37 цэцэрлэгт 7000 мянга гаруй хүүхэд, ерөнхий боловсролын 4 цогцолборын 20 сургуульд 20,0 орчим мянган хөвгүүд, охид суралцаж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1358 гаруй мэргэжилтэй ажилчин бэлтгэгддэг. Мөн МУИС, ШУТИС-ийн салбар сургуулиуд, Экологи, аялал жуулчлалын "Маргад" хувийн дээд сургуульд 3,0 гаруй оюутан суралцдаг байна.


Орхон аймгийн эдийн засгийн голлох салбар нь уул уурхайн олборлох үйлдвэр бөгөөд нийт 1700 шахам ААН-д 34,0 мянган хүн ажиллаж жилдээ 1,0 триллион төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээс 90 орчим хувийг нь жилдээ 25,0 сая тонн хүдэр олборлох хүчин чадалтай уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр дангаараа гаргадаг. Үлдсэн 10 орчим хувь нь цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, боловсруулах үйлдвэрт оногдож байна. Жилдээ 1,2 сая метр хивс үйлдвэрлэдэг "Эрдэнэт хивс" ХХК, 3600 тонн катодын зэс, зэс утас, цахилгааны утас үйлдвэрлэдэг Монгол-Америкийн хамтарсан "Эрдмин" үйлдвэр, барилгын үйлдвэрлэлийн "Очир төв" ХХК зэргийг дурдаж болно. Орхон аймаг дунджаар 270,0 орчим мянган малтай бөгөөд хувийн 8 мал эмнэлгийн газар үйл ажиллагаа явуулж

байна. Нийтдээ 50-аад ААН газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж жилд дунджаар 2000.0 гаруй тонн үр тариа, 5000 орчим тонн төмс, 4000 орчим тонн хүнсний ногоо хураан авч, 9000 орчим тонн хадлан бэлтгэдэг. Орхон аймаг нь дэлхийн болон эх орныхоо бүх цэгтэй холбогдсон холбооны сүлжээтэйгээс үүрэн утас хэрэглэгчдийн тоо 50.0 мянгад хүрдэг байна. Орхон аймаг зочид буудал, үсчин-гоо сайхан, зурагчин, гутал засвар, телевизор засвар, хими цэвэрлэгээ, нийтийн хоол зэрэг 770 гаруй цэгийг өөртөө нэгтгэсэн худалдаа үйлчилгээний цогц сүлжээтэй. Тус аймагт жилдээ 40,0 гаруй тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэдэг байна. Мөн нийслэл Улаанбаатар, Дархан-Уул аймагтай төмөр зам болон авто замаар, ОХУ, БНХАУ-тай төмөр замаар, нийслэл Улаанбаатар хоттой авто болон төмөр замаар холбогдсон нь аялагч, жуулчдын үндсэн нөхцөл болдог. Эрдэнэт хотод нийт 26 зочид буудал, 400 гаруй хүн хүлээж авах хүчин чадалтай 9 амралт, аялал жуулчлалын бааз үйл ажиллагаа явуулдаг. Мөн Орхон, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн нийт 25 жуулчны бааз, тур-операторуудыг хамарсан "Монгол өртөө" жуулчны сүлжээ үйл ажиллагаа явуулдаг байна.

ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Орхон аймгийн хэмжээнд 2016 онд эрүүгийн 575 хэрэгт шинээр дугаар олгон хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулан шалгасан. Үүнээс өмнөх онд үйлдэгдсэн хэрэг 16, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэрэг 7, өөр аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 2 хэрэг тус тус байсныг 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тооноос хасаж тооцжээ.

График VIII.13.1.



Тус аймагт 2015 онд 617 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байсан бол 2016 онд 550 болж 67 хэрэг буюу 10.8%-аар буурсан дүнтэй байна. 2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийг ангилж үзвэл 241 буюу 43.8% нь хөнгөн, 269 буюу 48.9% нь хүндэвтэр, 30 буюу 5,4% нь хүнд, 11 буюу 2% нь онц хүнд гэмт хэрэг тус тус эзэлж байна. Үүнийг дор графикт үзүүлбэл:

График VIII.13.2.



Үйлдэгдсэн гэмт хэргийн ангиллыг 2015 оныхтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 29-өөр буюу 10.7%, хүндэвтэр гэмт хэрэг 30-аар буюу 10%, хүнд гэмт хэрэг 4-өөр буюу 11.7%, онц хүнд гэмт хэрэг 3-аар буюу 21,4%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тус аймгийн нутаг дэвсгэрт зонхилон үйлдэгдэж байгаа хэргийн өсөлт бууралтыг 2015 оныхтой харьцуулан авч үзвэл, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 233 байсан бол 229 болж 4 буюу 1,7%-аар, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 58 байсан бол 24 болж 34-өөр буюу 58,6%-аар, залилан мэхлэх гэмт хэрэг 27 байсан бол 11 болж 16-аар буюу 60%-аар, албан тушаалын гэмт хэрэг 3 байсан бол 1 болж 2 буюу хувиар, булаах гэмт хэрэг 5 байсан бол 2 болж 3-аар буюу 60%-аар, танхайрах гэмт хэрэг 11 байсан бол 9 болж 2-оор буюу 18.1%-аар, хүчиндэх гэмт хэрэг 14 байсан бол 13 болж 1-ээр буюу 7.1%-аар тус тус буурсан үзүүлэлттэй гарсан. Харин бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 137 байсан бол 167 болж 30-аар буюу 21.8%, дээрэмдэх гэмт хэрэг 5 байсан бол 12 болж 7-оор буюу 2 дахин тус тус өссөн, хүнийг санаатай алах гэмт хэрэг 7 байсан бол өнгөрсөн онд 7 үйлдэгдэж ижил түвшинд байна.

Тухайн нутаг дэвсгэрт зонхилон үйлдэгдэж байгаа газар нутаг, гэмт хэргийн нийтлэг шалтгаан, нөхцөл нь:

- Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 56% нь гэр хорооллын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.
- Тухайлбал, хулгайлах гэмт хэргийн 118 буюу 70%, бусдын биед хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэргийн 124 буюу 72% нь гэр хороололд үйлдэгджээ.
- Гэмт хэргийн улмаас хохирсон 17 хүүхдээс 1 нь ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан, 8 хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон байна.
- ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг буурсан байгаа боловч 12 буюу 50% нь явган зорчигч автомашинд мөргүүлж осолдсон, мөн 3 буюу 12.5% нь явган хүний гарц дээр зам тээврийн осол гарсан тохиолдлууд тус тус эзэлж байна.
- Бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах 167 хэргээс 15 буюу 8.9% нь автомашин болон, автомашины эд ангийг тонох, автомашинд нэвтэрч эд зүйл хулгайлах арга хэлбэрээр үйлдэгдсэн хэргүүд байна.

Мөн хулгайлах гэмт хэргийн 117 буюу 70% нь орон байр, агуулах савand нэвтэрч үйлдэгдэж байгаа бөгөөд үүнээс 15 буюу 8.9% нь дэлгүүрт нэвтэрч, 102 буюу 61% гэр, орон сууц, гэр хорооллын байшинд нэвтэрч үйлдэгдсэн байна.


Тус аймагт 2016 онд мал хулгайлах гэмт хэрэг 9 үйлдэгдсэн ба энэ нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 5,3%-ийг эзэлж байна.

2016 онд хүний амь нас хохирсон талаарх 36 гомдол, мэдээлэлд Эрүүгийн хуулийн 95-р зүйлийн 95.1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан ба үүнээс 13 буюу 36% нь өөрийн амийг егүүтгэсэн, бусад 23 тохиолдол нь золгүй байдлаар хүний амь нас хохирсон болохыг мөрдөн байцаалтаар шалган тогтоожээ.

Мөн гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 337 буюу 62.5% нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд эзэлж байгаа нь архидан согтуурах, ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгэм эдийн засгийн сөрөг үзэгдэл, өмчлөх эрхийн эсрэг болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг өсөхөд нөлөөлсөн суурь шалтгаан, нөхцөл болж байна.

2016 онд бүртгэж, шалгасан гэмт хэргийн талаарх мэдээ, судалгаанд дүгнэлт хийхэд гэр хороололд амьдарч буй иргэд хулгайлах гэмт хэрэгт өртөх явдал зонхилон үйлдэгдэн гарсан нь хохирогчийн хэт салан задгай, өмч хөрөнгөндөө хайхрамжгүй хандах хандлага нөлөөлсөн байх боловч орон нутгийн зүгээс гэр хорооллын гудамж талбай, орон сууцанд камерын хяналтыг хүртээмжтэй байдлаар төвлөрүүлэн урьдчилан сэргийлэх ажлыг гэр хороололд төвлөрүүлэн ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

График VIII.13.3. Гэмт хэргийн илрүүлэлт ангилал, (хувиар)



Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 185 хэрэг бүртгэгдсэнээс 130 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон гэмт хэргийн илрүүлэлт 70.3%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. 2015 онд гэмт хэргийн илрүүлэлт 70,3%-тай байжээ.

Орхон аймаг дахь цагдаагийн газар нь 2016 оны байдлаар иргэд, ААН, байгууллагаас нийт 12442 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс 8,1%-аар өссөн байна.

Нийт гомдол, мэдээллийн 957 буюу 7,6%-ийг гэмт хэргийн шинжтэй, 6120 буюу 49,1%-ийг захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллүүд тус тус эзэлж байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 58,8%-ийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан бол 40,1%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорын байгууллагад хүргүүлсэн байна.

График VIII.13.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал




Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаас харахад дийлэнх хувийг согтуугаар үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна. Аймгийн хэмжээнд архидан согтуурах явдалтай тэмцэх, үүний эсрэг ухуулга сурталчилгаа явуулах, шөнийн цагаар архи, согтууруулах ундаа худалдан борлуулж буй иргэдийг хяналтад авах, уг үйлдлийг нь таслан зогсоох, олон нийтийн ажил зэргийг зохион байгуулах шаардлагатайг харуулж байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх нь харьцангуй буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүний батлагдах явцтай холбоотой бөгөөд цаашид ч энэ төрлийн гэмт явдал буурах хандлагатай байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 206 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 21 хэргээр буюу 9,3%, гэр бүл хүчирхийллийн улмаас бүртгэгдсэн гэмт хэрэг 46 бүртгэгдэж 14 хэргээр буюу


23,3%, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 80 бүртгэгдэж 23 хэргээр буюу 17,2%, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 103 бүртгэгдэж 6 хэргээр буюу 5,5%, хүүхэд оролцсон гэмт хэрэг 27 бүртгэгдэж 2 хэргээр буюу 6,9%-аар тус тус буурсан байна.

График VIII.13.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 5,2%, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 60,3%, олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 4,3%-аар тус тус буурсан бол гэр, сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 11,5%-аар өссөн байна. Хүнийг санаатай алах 7, бусдын эд хөрөнгийг булаах 2, хүчиндэх 14, бусдыг амиа хорлоход хүргэх 3, бусдын эд хөрөнгийг завшиж үрэгдүүлэх 17, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 12, ТХХАБАЖурам зөрчих 26, танхайрах 12, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах 13, бусдын бие махбодид гэмтэл учруулах 218, бусдын эд хөрөнгийг хулгайлах 167, орчиндоо аюул учруулах ан амьтныг зохих хамгаалалтгүй байлгах 7, албан тушаалын хэрэг 2, бусдыг болгоомжгүй алах 1, захиргааны журмын эсрэг 7, иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг 2, бусад төрлийн гэмт хэрэг 18 байна.

График VIII.13.6.



Нийт хэргийн хувьд авч үзвэл:

1. 218 буюу 41,2%-ийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэргүүд,
2. 167 буюу 31,6%-ийг хулгайлах,
3. 26 буюу 4,9%-ийг ТХХАБАЖЭсрэг хэргүүд,
4. 17 буюу 3,2%-ийг бусдын эд хөрөнгө завшиж үрэгдүүлэх хэргүүд,
5. 14 буюу 2,6%-ийг хүчиндэх,
6. 13 буюу 2,4%-ийг бусдын эд хөрөнгө залилан мэхлэх хэргүүд,
7. 12 буюу 2,2%-ийг дээрэмдэх,
8. 2 буюу 0,3%-ийг булаах,
9. 7 буюу 1,3%-ийг хүнийг санаатай алах, захиргааны журмын эсрэг, орчиндоо аюул учруулах амьтныг зохих хамгаалалтгүй байлгах хэргүүд,
10. 12 буюу 2,2%-ийг танхайрах,
11. 3 буюу 0,5%-ийг бусдыг амиа хорлоход хэргүүд тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад:

Өссөн гэмт хэргийн хувьд авч үзвэл:

1. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргүүд 218 бүртгэгдэж 12 гэмт хэрэг буюу 5,2%-аар,
2. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 3-аар буюу 40,0%-аар,
3. Булаах гэмт хэрэг 2-оор буюу 60,0%-аар,
4. Залилан мэхлэх гэмт хэрэг 14-өөр буюу 51,9%-аар,
5. Завшиж үрэгдүүлэх гэмт хэрэг 10-аар буюу 37,0%-аар,
6. Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд 2-оор буюу 50,0%-аар,
7. Орчиндоо аюул учруулах ань амьтныг зохих хамгаалалтгүй байлгах гэмт хэрэг 3-аар буюу 30,0%-аар,
8. Албан тушаалын гэмт хэрэг 1-ээр буюу 33,3%-аар тус тус буурсан.

Буурсан гэмт хэргийн хувьд авч үзвэл:

1. Хүний амь насыг санаатай хохироох гэм хэрэг 3 хэргээр буюу 75,0%-аар,
2. Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 30 хэргээр буюу 21,9%-аар,
3. Дээрэмдэх хэрэг 7 хэргээр буюу 7 дахин,
4. Танхайрах хэрэг 1 хэргээр буюу 9,1%-аар,
5. Захиргааны журмын эсрэг хэрэг 2 хэргээр буюу 40,0%-аар тус тус өссөн.

Харин бусдын амь насыг болгоомжгүй хөнөөх, хүчиндэх гэмт хэргүүд өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирлын хэмжээ

Гэмт хэргийн улмаас иргэд, ААН, байгууллагад 1.085.209.538 сая төгрөгийн хохирол учирсан байгаагийн 719,5 сая төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна. 2015 онд гэмт хэргийн хохирлын нөхөн төлөлт 65,8%-тай байжээ. Гэмт хэрэгт давхардсан тоогоор 539 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх 2015 оныхтой харьцуулахад 3,6%-аар буурсан.

- 80 буюу 14,8%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22,3%-

аар тус тус буурсан.

- 38 буюу 7,0%-ийг насанд хүрээгүй хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22,6%-аар, 337 буюу 62,5%-ийг эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 10,1%-аар тус тус өссөн байна.

Нийт гэмт хэргийн 41,2%-ийг бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргүүд, 31,6%-ийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргүүд дангаараа эзэлж байх тул аймгийн хэмжээнд зонхилон үйлдэгдэж буй эдгээр гэмт хэргүүдийн талаар дэлгэрэнгүй авч үзье:

Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн талаар:

Орхон аймагт жилд дунджаар 528 гэмт хэрэг бүртгэгдэж байгаагийн 167 буюу 31,6%-ийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргүүд эзэлдэг ба энэ гэмт хэргийн илрүүлэлт 69,0%-тай байдаг байна. Хулгайлах гэмт хэрэг 2013-2014 онд 27,7%-аар буурсан бол 2015-2016 онд 21,9%-аар өссөн үзүүлэлттэй байна. Хулгайлах гэмт хэргийн 91,0%-ийг хувийн өмчийг хулгайлах, 0,5%-ийг халааснаас эд зүйл хулгайлах, 5,9%-ийг мал хулгайлах, 2,9%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргүүд эзэлдэг.

Нийт хулгайлах гэмт хэргийн 51% нь 06-19 цагийн хооронд буюу өглөө өдрийн цагаар 49% нь 19-06 цагийн хооронд буюу шөнө оройн цагаар үйлдэгддэг байна.

Гэмт хэрэг үйлдэгдэж буй багаар нь авч үзвэл 36,7% нь төвийн орон сууцны хороололд, 48,1% нь гэр хорооллын багуудад үйлдэгдэж байгаа ба гэр хороололд үйлдэгдэж буй гэмт хэргийн 72% нь 06:00-19:00 цаг буюу өглөө-өдрийн цагаар иргэдийг ажил, сургуульдаа явсан, гэрээ эзгүй орхисон үеэр хаалга, цонхыг нь эвдэх, салхивчаар нь орох зэрэг аргаар орон байранд нэвтрэн орж үйлдэгддэг бол орон сууцны хороололд үйлдэгдэж буй гэмт хэргийн 53% нь 22:00-06:00 цагийн хооронд үйлдэгдэж тэдгээрийн дийлэнхийг нь дэлгүүр, худалдаа үйлчилгээний төв, сургууль гэх мэт ААН, байгууллагуудад цонх, салхивчаар нь орж компьютер, бэлэн хувцас, хүнс зэрэг эд зүйлс хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Гэр хорооллын багуудаас хамгийн их хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж буй багуудад Эрдэнэ, Яргуйт, Шанд, Цагаанчулуут багууд ордог бол төвийн орон сууцны хороололд хулгайлах гэмт хэрэг Уурхайчин, Хүрэнбулаг багуудад хамгийн их үйлдэгддэг байна. Мөн хулгайлах гэмт хэргийн 25,1% нь согтуугаар үйлдэгдэж байгаа бол 8,3%-д нь хүүхэд оролцдог байна.

Гэмт хэрэгт жилд дунджаар 539 хүн сэжиглэгдэн шалгагдаж байгаагийн 181 буюу 33,5% нь хулгайлах гэмт хэрэгт холбогддог байна. Эдгээр 181 хүний 22 буюу 12,1% нь насанд хүрээгүй хүүхдүүд, ихэнх буюу 50,0% нь 18-29 насны залуучууд, 157 буюу 86,7% нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байдаг байна. Мөн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа бүх эрхэлсэн тодорхой ажилгүй сэжигтнүүдийн 46,5% нь хулгайлах гэмт хэрэгт холбогддог байна.

Дээрхээс үзэхэд, амьдралын доогуур төвшин, ядуурал, ажилгүйдэл зэрэг үзүүлэлтүүдийн хулгайн хэрэгт эзлэх хувь өндөр хэвээр байгаагаас гадна иргэдийн өөрсдийн сонор сэрэмжгүй, анхаарал болгоомжгүй байдал уг хэргийн гаралтад нөлөөлөх гол шалтгаануудын нэг хэвээр байна. Мөн уг хэргийг 18-39 насны залуучууд үйлдэх явдал өссөн байгаа нь анхаарал татаж байна. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг аймгийн хэмжээнд жилд дунджаар 218 бүртгэгдэж байгаагаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг сард дунджаар 18 бүртгэгддэг. Уг хэргүүдийн дийлэнх буюу 53,6% нь согтуугаар, 2,2% нь хүүхэд оролцсон, 13,7% нь эмэгтэй хүн оролцож, 20,6% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдэж байна.

Бямба гаригт 17,4% үйлдэгдэж байгаа нь бусад өдрөөс илүү байгаа бол Ням гаригт 10,5% үйлдэгддэг нь бусад өдрөөс бага байна. *(Бусад өдрүүдэд жигд байдаг байна.)*

Эдгээр хэргийн 67,8% нь шөнө оройн цагаар үйлдэгддэг бол хэрэг гарч буй газрын хувьд 53,2% нь гэр орон сууцанд, 23,8% нь гудамж талбайд, 12,3% нь шөнийн цэнгээний газар, ресторан, зочид буудал зэрэг олон нийтийн газар үйлдэгдэж байгаа бөгөөд эдгээр

хэргүүд гэр орон сууцанд үйлдэгдэх явдал 2014-2015 онуудад өссөн бол 2016 онд буурсан, гудамж талбайд үйлдэгдэх явдал буурсан байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах 218 хэрэгт жилд дунджаар 227 хүн холбогдон шалгагдаж байгаагийн 54,6% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 69,1% нь суурь болон бүрэн дунд боловсролтой иргэд эзэлж байна. Мөн тэдгээрийн 3,5% нь насанд хүрээгүй хүн, 15,4% нь эмэгтэй хүн байгаа бөгөөд хүүхэд болон эмэгтэй хүн эзэлж байна. Тухайн гэмт хэрэгт холбогдож буй иргэдийн ихэнх буюу 39,2%-ийг 18-29 хүртэл насны залуучууд эзэлдэг байна. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн улмаас жилд дунджаар 222 орчим иргэн гэмтэж, 126.6 сая гаруй төгрөгийн хохирол учирсан байна. Тэдгээрийн 106,5 сая төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж хохирол нөхөн төлөлт 84,1%-тай байжээ.

Хохирогч иргэдийн 3%-ийг хүүхэд, 40,5%-ийг 18-29 насны залуучууд 46,6%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа бөгөөд эдгээр иргэдийн тоо 2012 оноос хойш өссөн байна. Хохирогч иргэдийн 53,3%-ийг ажилгүй, 66,5%-ийг суурь болон бүрэн дунд боловсролтой иргэд эзэлж байна. Уг хэргийн гаралт гудамж талбайд буурсан, Мөн уг хэрэгт бага насны хүүхэд, эмэгтэй хүн өртөж хохирох явдал өсөж байгааг эдгээр хэрэгт холбогдож буй иргэдийн ухамсартай холбоотой гэж үзэж болохоор байна.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 2012-2016 оныг дуустал сүүлийн 5 жилийн хугацаанд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр нийт 526 гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч хяналт тавин ажилласан байна.

ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

Бүртгэгдсэн нийт захиргааны зөрчил:

- Аймгийн хэмжээнд 15095 (давхардсан тоогоор) зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 676 зөрчлөөр буюу 4.2%-аар буурсан байна.
- Зөрчил гаргасан 13480 иргэн, 2 албан тушаалтан, 18 ААн, байгууллагад 830,7 сая төгрөг, үүнээс 1217 хүнийг 467.3 сая төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 378 хүнд баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл:

- 14688 буюу 97.4%-д цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч,
- 407 буюу 2.6%-д шүүгч шийтгэл оногдуулжээ.

Хүснэгт VIII.13.1. Захиргааны зөрчил/шийтгэл оногдуулсан хуулиар:

№	Шийтгэл оногдуулсан хууль тогтоомж	Зөрчлийн тоо
1	Захиргааны хариуцлагын тухай	5554
2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	9383
3	Тамхины хяналтын тухай	11
4	Архидан согтуурахтай тэмцэх тухай	18
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	1
6	Галт зэвсгийн тухай	1
7	Бусад хууль тогтоомж	2

Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэл оногдуулсан нийт зөрчлийн 5196 буюу 34.4%-ийг шийдвэрлэснээс танхайрах зөрчил 3928, худалдаа, үйлчилгээний журам зөрчих 332, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх,

цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх 695, бусдын эд хөрөнгө ашиглан шамшигдуулах 116, бусад төрлийн зөрчил 125 байна. 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль"-д заасан үндэслэлээр 2016 онд 9383 иргэнийг 795.7 сая төгрөгөөр торгох, 1217 иргэнд зөрчлийн шинж байдлыг нь харгалзан торгож, эрх хасах шийтгэлийг тус тус оногдуулсан байна.

ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ОСОЛ, ЗӨРЧИЛ

Хариуцсан нутаг дэвсгэр дээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэг ослыг хуулийн хүрээнд шалгаж шийдвэрлэх чиглэлээр ахлах зохицуулагч 1, зохицуулагч 3, гэрээт цагдаагийн хэлтэст зохицуулагч 1, цагдаа зохицуулагч 16, нийт 22 алба хаагч, шуурхай албаны автомашин 5, бэлэн бусаар торгуулийн арга хэмжээ оногдуулах багаж 16, согтуурал шалгах багаж 5, хурд хэмжигч 1, согтуурал тандагч багаж 15, гар станц 22, бусад техник тусгай хэрэгсэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллагаас 2016 онд иргэд, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн зам тээврийн ослын тухай 1043 дуудлага мэдээлэл ирснээс гэмт хэргийн шинжтэй 34 гомдол, мэдээллийг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шалгаж шийдвэрлэснээс хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тухай 26 мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 8 осолд холбогдох шалгалтыг явуулж, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал, материалыг прокурорт шилжүүлсний 6 буюу 75.0%-ийг хуулийн анхны хугацаа буюу 5 хоногт шийдвэрлэн, 867 дуудлагад ослын дүгнэлт гаргаж, буруутай этгээдээр хохирлыг төлүүлж, даатгалын байгууллагад тодорхойлолт гаргаж нөхөн олговрыг олгуулж ажилласан.

Нийт гэмт хэргийн 4 буюу 16.0%-ийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3, 2 буюу 8,0%-ийг Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийн 216.2, 6 буюу 24.0-%ийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.2, 1 буюу 7.6%-ийг Эрүүгийн хуулийн 223 дугаар зүйлийн 223.1, 13 буюу 50,0%-ийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.1-д заасан гэмт хэргүүд эзэлж байгаа бол 4 буюу 20.0%-ийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үеэс 14 буюу 2.8 дахин буурсан үзүүлэлттэй байна. Хот хоорондын замд хяналт шалгалтыг тогтмол явуулж ажилласнаар хот хоорондын улсын чанартай замд 2 хэрэг гарч бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 6 буюу 75.0%-аар буурсан.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх, иргэдийн ая тухтай аюулгүй зорчих нөхцөл бололцоог хангах зорилгоор 2016 онд хяналт шалгалтаар 21768 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 11950 хөдөлгөөнд оролцогчдод 802 сая 65.9 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1581 зөрчлийг илрүүлж ажиллан, 1256 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, захиргааны арга хэмжээ оногдуулжээ. 2016 онд илрүүлсэн зөрчил, шийдвэрлэлтийг урьд оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлтийг хүснэгтээр харуулвал:

Хүснэгт VIII.13.2.

№	Үзүүлэлт	2015 онд	2016 онд	Харьцуулалт/хувь/
1	Нийт зөрчил	26382	21768	-17.4
2	Согтуу	2184	1581	-27.6
3	Эрх хассан	1511	1256	-16.8
4	Баривчилсан	547	-	-
5	Торгосон хүн	11307	11950	+5.6

6	Торгосон төгрөг/м.төг/	273903.6	802065.9	2.9 дахин

Аймгийн хэмжээнд "Шинэ жил", "Сар шинэ-2016", "Согтуу", "Хууль бус тээвэрлэлт, жолоочийн хариуцлагын даатгал, хууль журмын хэрэгжилт", "Зогсолт зогсоол", "Явган гарц", "Мотоцикл", "Аюулгүй тээвэр-техникийн хяналт", "Осолгүй жолооч-Жаргалтай гэр бүл", "Оюутан тээвэр-1", "Хөдөлгөөнт эргүүл", "Оюутан тээвэр-2", "Хамгаалах бүс-Хамгаалалтын суудал", "Авто тээврийн хэрэгслийн стандарт", "Ургац-2016", "Тусгай дуут гэрэл дохио хэрэглэх журам", "Явган гарц", "Жолоодох эрх" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион явуулан үр дүнг тооцож, зөрчил гаргагчдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, үйл ажиллагааны явц үр дүнгийн талаар орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж ажилласан.

Зам тээврийн хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизүүдээр 61 удаа, нийт 197 удаагийн давтамжтайгаар мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэсэн.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Аймгийн ГХУСАЗСЗ, сум, баг, нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран гэмт хэргийг бууруулахад нөлөө үзүүлэхүйц сургалт, сурталчилгаа хийж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тал бүрээс нь судлан тогтоож, урьдчилан сэргийлэх ажилд ААН, байгууллага, иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэх, иргэд хамтран ажиллах нэн ялангуяа хөршийн холбоо байгуулах ажлыг бүхий л арга хэрэгслээр дэмжин ажиллах шаардлагатай.

Орхон аймагт сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгслийн тоо болон Хөвсгөл аймгийн зам ашиглалтад орсонтой холбогдуулж дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байгаагаас хөдөлгөөний нягтрал, замын ачаалал харьцангуй ихэсч байгаа бөгөөд замын цагдаагийн нэг зохицуулагчид оногдох тээврийн хэрэгслийн тоо стандартаас 4-5 дахин их байгаа тул хяналт тавихад хүндрэлтэй байна. Үүнтэй холбоотойгоор орон нутгийн замд хяналтын цэг (пост)-ийг шинээр нэмж байгуулах, энэхүү постод үүрэг гүйцэтгэх ажилтны орон тоог нэмэгдүүлэх шаардлага үүсч байна.

Шинэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хуулийн байгууллагын ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.

Орхон аймагт үйлдэгдэж буй гэмт хэргийн өсөлтөд хүн амын нягтрал, боловсролын түвшин шилжин суурьшигчдын хувийн жин, ажилгүйдлийн эзлэх хувь хэмжээ, иргэдийн ядуурал, эрх зүйн зөрчил гаргаж болзошгүй хүмүүсийн тоо, газар нутгийн байршил, архидан согтуурах явдал, гэр бүлийн хоорондох таарамжгүй харилцаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа бөгөөд эдгээр хүчин зүйлийг бууруулахын тулд нийгэм эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх ажилгүйдлийг багасгаж, шинээр ажлын байр бий болгох, архидан согтууралтай тэмцэх, тодорхой үр дүнтэй цогц бодлогыг авч хэрэгжүүлэх, гэмт хэрэг ихээр гардаг цэгүүдэд хяналтын камер суурилуулах, авто замуудыг бүрэн тэмдэг тэмдэглэгээтэй болгох, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж, хүүхдийн төлөө гэсэн уриатай төрийн болон ТББ-ын ажлын уялдаа холбоог сайжруулж хариуцлагыг өндөржүүлэх, төр захиргаа, хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж боловсронгуй болгох, хотын алслагдсан цэгүүдэд гэрэлтүүлэг хийх, зэрэг хүн хүч, хөрөнгө шаардсан ажлуудыг онцгой анхаарч хийх хэрэгтэй байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ



14. ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ 62.9 мянган км², хойноос урагшаа 385, зүүнээс баруун хил хүртэл 310 км, нийслэл Улаанбаатар хотоос 430 км зайд оршдог. Нутгийн хойд хэсэгт хангайн нурууны, өмнө хэсгээр нь Алтай нурууны салбар уулстай, аймгийн нийт нутгийн 23.0% нь хангайн, 28.2% нь тал хээрийн, 48.8% нь говийн бүсэд оршдог. Хүн амын нягтрал 2013 оны байдлаар 1 км²-д 1.62 хүн ногдож байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 19 сум, 109 багтай, 112.7 мянган хүн амтай, аймгийн төв Арвайхээр хотод 8.8 мянган айл, 33.2 мянган хүн оршин суудаг.

Өвөрхангай аймаг нь Орхоны хөндийн түүх, соёлын дурсгалт газрууд, үзэсгэлэнт Орхон гол, Улаан цутгалан, Хүйсийн Найман нуур, нутгийн сахиус тэнгэр болсон Баруун, Зүүн Хайрхан, Дөлгөөн, Батхаан, Ханхөгшин, Зүүн Богд Ханбаян, Хангайн овоо, Авзага, Хонгор хайрхан зэрэг хийморь түшсэн уул нурууд, эртний түүхт Хархорум, Монголын төв цэг, Өндөр гэгээн Занабазарыг хаан ширээнд залсан Ширээт цагаан нуур, номын баясгалант газар Төвхөн хийд зэрэг түүх, соёл, байгалийн үзэсгэлэнтэй газар олонтой. Өвөрхангай аймаг ХАА, түүний дотор мал аж ахуй зонхилсон эдийн засагтай 2015 онд 4.5 сая толгой мал тоолуулсан. Зах зээлийн нөхцөлд ХАА, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбаруудыг хөгжүүлж, орон нутгийн хөгжил дэвшилд хувийн хэвшлийн салбарын оролцоо дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн татварын албанд бүртгэлтэй ААН 1533, төсөвт байгууллага 208, ХК 11, ХХК 687, салбарууд 112, хоршоо 189, ЗБН 27, ББН 59, хадгаламж зээлийн хоршоо 9, шашны байгууллага 11 үйл ажиллагаа явуулж байна.

Хүн амын 62.6%-ийг хөдөлмөрийн насны иргэд эзэлж, тэдгээрийн 45.9% нь ХАА-н салбарт ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт бүсийн оношлогоо эмчилгээний төв 1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 1, сум дундын эмнэлэг 1, сумын эрүүл мэндийн төв 16, өрхийн 5 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Аймагт 4 сувилал, ортой хувийн эмнэлэг 4, үүдэн эмнэлэг 17 үйл ажиллагаагаа явуулж байна. 2016-2017 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллага 40, ерөнхий боловсролын 30 сургуульд нийт 29000 хүүхэд сурч хүмүүжиж, тэднийг 2365 багш, ажилтан, албан хаагчид сурган хүмүүжүүлж, багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамж 99%-д хүрчээ.

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 2 дугаар сард хүн амын цэвэр өсөлт 311 болж өмнөх оны мөн үеийнхээс 0.6%-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 3.7, нас баралт 1.0 байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нас баралт 0.1 пунктээр буурсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1989 болж өмнөх оны мөн үеийнхээс 480 хүнээр буюу 31.8%-аар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1076 буюу 54.1% нь 16-34 насны залуучууд байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 41 хүнээр өссөн бол ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо 2 дугаар сард 96 болж өмнөх оны мөн үеийнхээс 56 нэгжээр өссөн байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд жилд дунджаар 100 гаруй тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 1081.0 мянган төгрөгт хүрч өссөн. Өвөрхангай аймаг нь хүнс, ХАА түүний дотор МАА зонхилсон онцлогтой. Улсдаа олон малтай аймгийн хувьд улсын мал, мах, ноос, ноолуур, түүхий эд бэлтгэл, цөцгийн тос, гэрийн мод, тавилгын үйлдвэрлэлээрээ тэргүүлдэг.

ХАА-н түүхий эд, байгалийн нөөц баялагт түшиглэсэн, хүнсний жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, усалгаатай газар тариаланг түлхүү эрхлэх замаар газар тариаланг дэмжиж байна.

Аж үйлдвэр

Бүх сумд төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдож, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн нь иргэдэд өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхцөл бий болсон.

Аймгийн аж үйлдвэрийн салбарт нүүрсний олборлолт, уул уурхай, талх, нарийн боов, сүү, сүүн бүтээгдэхүүн, оёдол, барилгын төрөл бүрийн материалын үйлдвэрлэл үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн өсөн нэмэгдэж байна.

Барилгын материалын үйлдвэрлэл хурдацтай өсөн нэмэгдэж, бүтээн байгуулалтын ажил эрчимжсэн нь аймаг, орон нутгийн өнгө төрх өөрчлөгдөхөд үлэмж хувь нэмэр оруулжээ.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ажил үйлс, амжилт бүтээлээрээ хошуучилж, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ, нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон дэд бүтцийн давуу талаа ашиглан хөгжиж, иргэдийн ажиллаж амьдрах, сурч хөгжих ая тухтай орчныг бүрдүүлсээр байна.

Аялал жуулчлал

Монгол орондоо төдийгүй дэлхийн түүхэнд мөнхөрсөн XIII зууны Монголын эзэнт гүрний Нийслэл Хархорум хот, Эрдэнэ-Зуу хийд, ЮНЕСКО-ийн Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, Монголын бурхан шашны тэргүүн, Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар, түүний хосгүй бүтээл соёмбо үсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын анхны шав тавьсан газар нутаг зэрэг нь түүх, соёлын бахархал юм.

Улсын хэмжээний аялал жуулчлалын гурван том бүс нутгийн нэг Орхоны хөндийн сав газрыг түшиглэн аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байна. Тус аймаг нь 15 гаруй жуулчны баазад жилд дунджаар 25000 орчим жуулчин тогтмол хүлээн авч үйлчилж байгаа бөгөөд Монгол Улсад ирж буй нийт жуулчдын 25% буюу 90000 гаруй жуулчин манай аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байна.

Гадаад харилцаа

Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны хүрээнд хамтын үйл ажиллагааг бататгах, хөрөнгө оруулалт, түншийн харилцааг өргөжүүлэх, салбар хооронд шууд харилцаа тогтоон ажиллаж байна.

ОХУ-ын Алтай хязгаар Барнаваль муж, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орон, Нинши Хуйн өөртөө засах орон, Япон улсын Шёо-Оу-Чу, Гумма муж, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гүми Хот, Франц улсын Аллиер муж, Итали, Герман улсын эрүүл мэндийн салбар зэрэг муж, хот, салбартай байнгын харилцаагаа бэхжүүлэн орон нутгийн хөгжилд идэвхтэй харилцаа, хамтын үр ашигтай харилцааг хэрэгжүүлсээр байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн загварын дагуу Өвөрхангай аймаг нь хангай бүсийн аймгуудтай өөрөөр хэлбэл, Архангай, Баянхонгор, Орхон, Булган Хөвсгөл аймгуудтай бүсчлэн бэлчээрийн МАА, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах болон мод боловсруулах үйлдвэрийг түлхүү хөгжүүлэх стратегитай.

Нийтлэг стратеги дотроо тус аймаг нь түүх, соёл иргэншил, байгаль судлал, амралт сувиллаар тэргүүлэн хөгжиж, Хархорин хотыг Хангайн бүсийн тулгуур төвийн нэг болгон хөгжүүлэх эрхэм зорилттой байна.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

1. Бүртгэгдсэн гэмт хэрэг


Орон нутагт нийт 9222 гэмт хэрэг бүртгэгдсэний 508 буюу 5,5%-ийг Өвөрхангай аймагт бүртгэгдсэн хэрэг эзэлж байна. Бүртгэгдсэн хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 34 буюу 6.3%-аар, үүнээс аймгийн төв буюу Арвайхээр суманд 56 буюу 21.9%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

График VIII.14.1.



Гэмт хэргийн гаралт буурсан, өссөн үзүүлэлт (сумдаар):

График VIII.14.2.



Бүртгэгдсэн гэмт хэрэг (хэргийн ангиллаар):

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг ангиллаар нь урьд оны мөн үетэй харьцуулахад:

- Хөнгөн гэмт хэрэг 13.6%-аар өссөн;
- Хүндэвтэр гэмт хэрэг 17.9%-аар буурсан;
- Хүнд гэмт хэрэг 17.2%-аар буурсан;
- Онц хүнд гэмт хэрэг 40.0%-аар өссөн;


График VIII.14.3.



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц:

Хүнийг санаатай алах гэмт хэрэг 5, бусдын бие махбодид гэмтэл учруулах 159, хүчиндэх 5, танхайрах 12, хувийн өмчийг хулгайлах 144, мал хулгайлах 30, мотоцикл хулгайлах 30, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх 5, дээрэмдэх 3, булаах 2, хүн амын эрүүл мэндийн эсрэг 11, ТХХАБАЖЭсрэг 58, БХЖЭсрэг гэмт хэрэг 6, шүүн таслах ажиллагааны эсрэг 3, захиргааны журмын эсрэг 4, албан тушаалын 4 бусад төрлийн гэмт хэрэг 27 байна.

График VIII.14.4.



Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гариг:

График VIII.14.5.


(Бүртгэгдсэн хэргийн гариг, нийт хэрэгт эзлэх хувь)		
Даваа	76	14.9%
Мягмар	87	17.1%
Лхагва	76	14.9%
Пүрэв	78	15.3%
Баасан	68	13.3%
Бямба	66	12.9%
Ням	57	11.2%



ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

Гэмт хэргийн илрүүлэлт 66.5%-тай байгаа нь урьд оны мөн үеэс 0.3%-аар буурчээ.


График VIII.14.6.



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 248 хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 11 буюу 4.2%-аар буурсан, 165 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоон илрүүлсэн байна.


Гэмт хэрэгт холбогдсон хүн:

График VIII.14.7.



Нийт 506 хүн шалгагдсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 54 буюу 9.6%-аар буурсан. Үүнээс 47 буюу 9.2%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь урьд оны мөн үеэс 14.5 хувиар, 58 буюу 11,4%-ийг хүүхэд эзэлж байгаа нь урьд оны мөн үеэс 3.5%-аар тус тус өсжээ.

График VIII.14.8.



ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРЛЫН ХЭМЖЭЭ

Гэмт хэргийн улмаас 531 иргэн хохирсон нь урьд оны мөн үеэс 9.5%-аар буурч, үүнээс 33 хүн нас барж, 244 хүн гэмтжээ.

Гэмт хэргийн улмаас иргэн, ААН, байгууллагад 971.5 сая төгрөгийн хохирол учирснаас 63.3%-ийг нөхөн төлүүлж, 237.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

График VIII.14.9.



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 40,1%-ийг эзэлж байгаа бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 65,8%-ийг цонхоор орох буюу хаалгыг нь эвдэх аргаар, 83,6%-ийг шунахай сэдэлт ба амар хялбар аргаар ашиг олох зорилгоор, 38.3%-ийг иргэдийн эд зүйлээ ил задгай орхисон сонор сэрэмжгүй байдлыг ашиглаж үйлдсэн ба хулгайлах гэмт хэргийн 56,9%-ийг эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс үйлдсэн байна.

Бусдын биед санаатай гэмтэл учруулах хэргийн 79 буюу 50,0% нь хувийн таарамжгүй харьцаанаас, 40 буюу 25,1% нь архидан согтуурснаас, 23 буюу 14.4% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 3 хэрэг нь өс хонзонгоор, 6 буюу 3.7% нь ёс суртахууны доголдлоос

шалтгаалан үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил ихсэж байгаа шалтгаан нөхцөл нь иргэдийн дунд архи байнгын хэрэглээ болсон, архи хэтрүүлэн хэрэглэх, улмаар архинд донтох байдал газар авсантай холбоотой байна.

Хүн амын эрүүл мэндийн эсрэг 11 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 83,3%-аар өссөн нь иргэд орчиндоо аюул учруулж болох амьтан (нохой)-ыг зохих хамгаалалтгүй орхисноос зэргээс шалтгаалсан байна.

Цагдаагийн газарт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж 2017 онд "Архидалтгүй Өвөрхангай" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, нийгмийн сөрөг үзэгдэл болох архидан согтуурах явдалтай тэмцэх ажлыг сайжруулж архины хамааралтай иргэдтэй ажиллах "Мэргэжлийн баг", Аддиктологийн багийн гишүүдийг чадваржуулах, сайн дурын болон албадан эмчилгээнд архины хамааралтай иргэдийг хамруулах, АА-гийн бүлэгт элсүүлэх, 2016 онд өссөн тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛИЙН ТАЛААР

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2015 онд 9036, 2016 онд 8846, нийт 17882 захиргааны зөрчил бүртгэгджээ.


Торгуулийн арга хэмжээ авсан байдал:

Графикаас харахад 2016 онд урьд оны мөн үеэс 2,1%-аар буурсан үзүүлэлттэй байна. 2015 онд 8211 хүн 109,149,3 сая, 2016 онд 8297 хүн 372,439,1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авчээ.

График VIII.14.10.



График VIII.14.11.



Баривчилж, эрх хассан байдал:

Шүүхийн шийдвэрээр баривчлагдсан хүний тоо 2016 онд урьд оны мөн үеэс 218 буюу 50,3%-аар, торгож эрх хасагдсан хүн 56 буюу 14,3%-аар тус тус буурсан байна.

График VIII.14.12.



График VIII.14.13.



Зөрчигдсөн хууль тогтоомжоор үзвэл:

График VIII.14.14.




График VIII.14.15.



Захиргааны зөрчил гаргаж албадан саатуулагдсан хүн:

2015 онд 933 хүн, 2016 онд 1272 хүн саатуулагдсан нь урьд оны мөн үеэс 339 буюу 36,3%-аар өсжээ.

Зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл

Иргэд ахуйн хүрээнд архидан согтуурч улмаар хэрүүл маргаан үүсгэх, орчин тойрондоо түгшүүр төрүүлэх, архины зохистой хэрэглээ, архины хор хөнөөлийн талаарх мэдлэг, ёс суртахуун ухамсар хангалтгүй, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцэх, эрх чөлөөнд халдах, хууль тогтоомжид заасан шийтгэл болох баривчлах хоног, торгуулийн хэмжээ бага байгаагаас дахин давтан зөрчил гаргах зэрэг Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21, 30², 42 дахь зүйлд заасан зөрчил нийт зөрчлийн дийлэнх хэсгийг эзэлж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ТАЛААР

Зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлийн шинжтэй иргэд байгууллагаас ирүүлсэн 433 гомдол, мэдээллийг 2016 онд хүлээн авч, 56-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, 18-ыг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар Аймгийн прокурорын газарт шилжүүлэн шийдвэрлэж, тээврийн хэрэгсэлд бага хэмжээний хохиролтой 113 ослыг газар дээр нь шалгаж шийдвэрлэн,

холбогдох даатгалын байгууллагаар хохирлыг бүрэн төлүүлж барагдуулсан, зөрчил гаргасан 346 жолоочид Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу эрх хасах болон торгох захиргааны арга хэмжээ авч ажиллаа.

2016 онд ТХХАБАЖЭсрэг 58 гэмт хэрэг гарсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 6 буюу 10%-аар буурсан, дээрх гэмт хэргийн улмаас 22 хүн нас барсан нь 4 буюу 15%-аар буурсан, 45 хүн гэмтсэн нь 6 буюу 15%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд энэ онд 22 хүн нас барсан зам тээврийн томоохон ослууд нь замын цагдаагийн хяналт бүхий (Арвайхээр, Хархорин, Хужирт, Уянга, Нарийнтээл сум) газруудад хүний амь нас хохирсон 3 осол гарсан, бусад 18 осол хөдөө хээр малын бэлчээр, сумын төвөөс алслагдмал газар, хот хоорондын зам дээр үйлдэгджээ.

Зөрчил гаргасан иргэдийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн талаарх мэдлэг боловсрол хангалттүй, шинэ мэдээлэл авах талаар санаачлагүй ханддаг, хууль тогтоомж сахин биелүүлдэггүй, ёс суртахуун ухамсар хангалтгүйгээс санаатайгаар зөрчдөг, замын хөдөлгөөнд соёлгүй оролцдог, жолооч бэлтгэн гаргаж байгаа авто жолооны дамжааны сургалтын чанар муу байна. Мөн иргэд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох, хот хоорондын замд болон хөдөө хээр хурд хэтрүүлэх, хяналт шалгалтгүй газраар явах, анхаарал болгоомжгүйгээр хөдөлгөөнд оролцож замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлдэггүйгээс осол гаргаж бусдын амь нас, эд хөрөнгөнд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогджээ.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Нэг. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг буурсан статистик үзүүлэлттэй байгаа нь сайн талтай ч энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил сайн зохион байгуулагдсаны шууд үр дүн гэж үзэхэд учир дутагдалтай. Гэмт хэргийн статистик мэдээ бодит тоонд тайвширч болохгүй;

Хоёр. Гэмт хэргийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийгээд гэмт үзэгдлийн задлан шинжилгээг аймгийн болон бүсийн хэмжээнд огт хийхгүй байна.

Аливаа гэмт хэргийг задлан шинжилж урьдчилан сэргийлэх чиглэлүүдээ гаргана. Гэмт хэргийн задлан шинжилгээгээр дор дурдсан үзүүлэлтийг тогтооно.

1. Гэмт хэргийн үзүүлэлт, хөдөлгөөн, бүтэц, бүтцийн өөрчлөлт, түүний шалтгаан, ялангуяа аюултай буюу түгээмэл дэлгэрсэн гэмт хэргийн өөрчлөлт, хөдөлгөөн;
2. Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийн тархалтыг нутаг дэвсгэр, хүн амын суурьшил, үйлдвэржилт зэрэг нягтралаар харьцуулсан харьцаа;
3. Гэмт хэргийн хор аюулын шинж чанар;
4. Гэмт үйл ажиллагааны зорилго, сэдэлт, санааг тодорхойлох статистик үнэлэлт;
5. Дахин давтан ба бүлэг гэмт хэрэг;
6. Гэмт хэргийн илрүүлэлтийн (нуугдмал гэмт хэргийн) түвшин зэрэг үзүүлэлтийг бүрэн хэмжээгээр тогтоосноор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад тус болохуйц үнэ цэнтэй дүгнэлт гаргаж болно. Дээр задлан шинжилгээг криминологи чиглэлээр мэргэшсэн судалгааны нэгдсэн баг хийнэ. Одоогоор аймгийн хэмжээнд ийм задлан шинжилгээ байхгүй байна;

Гурав. Задлан шинжилгээг нарийвчлан гаргаснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологи прогноз буюу урьдчилан харалтын төлөвлөлтийг богино, дунд, урт хугацаагаар

гаргах өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтэй тэмцэх стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

Дөрөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эдийн засаг, нийгэм-соёл хүмүүжлийн, төр-хууль эрх зүйн дараах аргуудыг криминологи төлөвлөлтөд оруулж хэрэгжүүлэх;

Тав. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үүрэг хүлээсэн төрийн болон ТББ-уудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй байгааг засаж үйл ажиллагааг идэвхжүүлэх;

Зургаа. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын орон тоо дутагдалтай. Тухайлбал, Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор 5000 хүн тутамд 1 хэсгийн байцаагч ажиллах шаардлагатай боловч өнөөдрийн байдлаар Өвөрхангай аймгийн төвд 9000 хүн тутам 1 хэсгийн байцаагч оногдож байна. Иймд аймгийн төвд 5000 хүн тутамд 1 хэсгийн байцаагч ногдож ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй орчинд эргүүл хяналт шалгалт явуулах цагдаагийн алба хаагч болон Олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэх, гэмт хэрэг дахин үйлдэгдэхэд нөлөө үзүүлж болохуйц хүчин зүйлийг арилгаж гудамж, замын гэрэлтүүлэг, хяналтын камер байрлуулж байнгын хяналтад авах ажлыг зохион байгуулах;

Долоо. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон "Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийн хүрээнд иргэдийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулахад зайлшгүй шаардлагатай урамшууллын асуудлыг тодорхой шийдвэрлэсэн эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар иргэд, төрийн болон ТББ-уудыг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах ажлыг шинэлэг байдлаар зохион байгуулах. Тухайлбал, олон нийтийн эргүүлд ажилласан төрийн алба хаагч, ажилчдад цалинтай чөлөө олгох талаар эрх зүйн зохицуулалт бий болгох, иргэдэд олгох урамшууллыг нэмэх;

Найм. Нийгмийн хүчин зүйлээс шалтгаалсан иргэдийн ажилгүйдэл, ахуйн хүрээнд архидан согтуурал газар авсан, архины хор хөнөөлийн талаарх мэдлэг, ёс суртахуун ухамсар хангалтгүй байгаа нь гэмт хэрэг, зөрчил гарахад ихээр нөлөөлж байна;


Ес. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдах төсвийг нэмэх асуудлыг яаралтай шийдвэрлэх, торгуулийн орлогын 40%-ийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах;

Арав. Засгийн газрын 150 дугаар тогтоолыг хэрэгжүүлж хот хоорондын хатуу хучилттай зам дагуу 150 км тутамд хяналтын пост байгуулах, тэнд ажиллах алба хаагчдын орон тоог шийдвэрлэх, орон нутгийн гарах, орох чиглэлд зам, гүүрэнд хяналтын камер байрлуулах;

Арван нэг. Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг согтуурал хэмжигч багаж, бэлэн бус торгуулийн ухаалаг төхөөрөмж, авто машинаар бүрэн хангаж ажиллах нөхцөл байдлыг сайжруулах;

Арван хоёр. Гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шалтгаан нөхцөлд орчин үеийн шинжлэх ухааны арга, аргачлалын дагуу дүн шинжилгээг мэргэшсэн судалгааны байгууллагаар хийлгэж, үйл ажиллагаандаа ашиглах зэрэг ажлыг зохион байгуулж хийхийг зөвлөж байна.

ӨМНӨГОВЬ АЙМАГ



15. ӨМНӨГОВЬ АЙМАГ

Өмнөговь аймаг 1931 онд байгуулагдсан, засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 53 багтай, 2016 оны эцсийн байдлаар 63661 хүн амын 39% буюу 24072 хүн Даланзадгад суманд амьдардаг. Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудтай хөрш оршдог бөгөөд өмнө талаараа 700 км газраар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур, Альшаа аймгуудтай хиллэж, хилийн 2 боомтоор гадаад худалдаа эрхэлж байна. 2016 онд нийт мал 2313963 толгой болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 258.2 мянган толгойгоор таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс тэмээ 11909, адуу 11128, үхэр 3496, хонь 73897, ямаа 157768 толгойгоор тус тус өсжээ. Мөн тус аймгийн нэг онцлог сумууд нь аймгийн төвөөс 28-326 км зайд оршдог байна.

Өмнөговь аймаг 2016 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар орон нутгийн төсвийн орлого 64822,8 сая төгрөг болж, орлогын төлөвлөгөө 107.4%-тай биелсэн байна. Нийт орлогын 99.9%-ийг урсгал орлого, 0.1%-ийг хөрөнгө худалдсаны орлого тус тус эзэлж байна. Урсгал орлогын 94.6% нь татварын орлого, 5.4% нь татварын бус орлого байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Баяндалай, Баян-Овоо, Булган, Гурвантэс, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханбогд, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо, Даланзадгад сумууд 1,1-92,4%-аар давуулан биелүүлсэн байгаа нь тус аймаг уул уурхайн эдийн засгийн өсөлт төсвийн бүрдүүлэлтэд сайнаар нөлөөлсөн нь харагдаж байна.

Байгалийн тогтоц говь, уул нуруу үзэсгэлэнт газрууд болон түүх соёлын дурсгалууд нь аялал жуулчлал хөгжих бололцоотой. Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээн ашиглах бодлогыг зохистой авч хэрэгжүүлсний үр дүнд уул уурхайн үйлдвэрлэл, аялал жуучлалын эдийн засгийн бүс болон хөгжих бүрэн боломжтой аймаг юм.


Тус аймагт манай улсын томоохон уурхайнууд үйл ажиллагаа явуулдагтай холбоотой эдийн засаг хөгжихийн зэрэгцээ сүүлийн үед хүн амын төвлөрөл, шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн, үүнтэй холбоотойгоор уул уурхайн эрчимтэй хөгжсөн 2007 онд өмнөх онуудад бүртгэгдэж байсан гэмт хэргээс 100% нэмэгдсэн. Тухайлбал 2005 онд 209 гэмт хэрэг, 2006 онд 296 гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2007 онд 502 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Хүн ам, нийгмийн хамгаалал

Өмнөговь аймгийн хүн ам 2015 оны эцсийн хүн амын тооноос 3.4%-аар буюу 2121 хүнээр өслөө. Нийт хүн амын 50.2% буюу 31960 эрэгтэйчүүд, 49.8% буюу 31701 эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амын 39%-ийг Даланзадгад сумын төв, 21.4%-ийг Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын төвд суурьшиж байна. Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилбал 32%-ийг 0-15 насны хүүхэд, 62%-ийг 16-59 насны, 6%-ийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна. Өрхийн тоо 20669 болж өмнөх оноос 675 өрхөөр буюу 3.4%-аар өссөн дүнтэй байна.

Хүн ам, өрхийн өсөлтийн байдлыг сүүлийн таван жилээр авч үзвэл:


График VIII.15.1.



Хүн амын энэ өсөлтийг уул уурхай, олборлох үйлдвэрийн өсөлттэй авч үзвэл, 2015 онд 347260267.3 төгрөг байсан бол 2016 оны жилийн эцэст 705395482.6 төгрөг болон өссөн хүн амын тоо нэмэгдэх эдийн засгийн эерэг нөхцөл болсон байна.

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон ажилд орсон иргэдийн судалгаа:

График VIII.15.2



Эдийн засгийн өсөлт хүн амын өсөлт болон нийгэм эдийн засгийн таатай орчинг бүрдүүлсэн байтал ажил хайгч иргэдийн тоо жил дараалан өссөн харин нөгөө талд ажилд орсон иргэдийн тоо жил дараалан буурсан статистик байгаа нэлээд анхаарал татаж байна. Энэ үзүүлэлт хүн амын төвлөрөлтэй шууд холбоотой гэж дүгнэж болох боловч нутгийн иргэдийн оролцоо уул уурхай эдийн засгийн хөгжил оролцох оролцоо хангалтгүй байгаа нь харагдаж байна.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Тус аймгийн цагдаагийн газрын мэдээгээр он гарсаар 2017 оны 02 дугаар сарын нэг дэх долоо хоногийн статистик мэдээнд үндэслэн гэмт хэргийн нөхцөл байдлыг дүгнэвэл тус долоо хоногт хүлээн авсан гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл 54 хүлээн авсан нь өмнөх долоо хоногоос 7-оор буюу 13.5%-аар өссөн байна.

Гэмт хэргийн шинжтэй 20 гомдол, мэдээллийг бүтцээр нь ангилан авч үзвэл:

Хүснэгт VIII.15.1.


№	Гомдол мэдээлийн төрөл	Тоо
1	Бусдын өмчийг хулгайлах	4 буюу 20%
2	Бусдын бие махбодид санаатай гэмтэл учруулах	2 буюу 10%
3	ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг	8 буюу 40%
4	Хүчиндэх	1 буюу 5%
5	Золгүй байдлаар нас барсан	2 буюу 10%
6	Бусад	5 буюу 15%
	Дүн	20

Гэмт хэргийн нөхцөл байдлыг 2016 оны эцсийн байдлаар авч үзвэл гэмт хэрэг 409 гарсан нь өмнөх оны мөн үеэс 13 хэргээр буюу 3.3%-аар өссөн үзүүлэлттэй байна. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 71.7%-тай байгаа нь улсын дунджаас 7.7%-аар өндөр үзүүлэлттэй байна. Оны эхний 12 сарын байдлаар захиргааны зөрчлийн мэдээллээр саатуулагдсан хүний тоо 670 байгаа нь өмнөх оны мөн үеэс 542 хүнээр буюу 44.7%-аар, баривчлагдсан хүний тоо 49 байгаа нь өмнөх оны мөн үеэс 181 хүнээр буюу 78.7%-аар тус тус буурч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан жолооч 676 байгаа нь өмнөх оны мөн үеэс 233 хүнээр буюу 52.6%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх хоёр судалгаанд дүгнэлт хийхэд тус аймагт зам тээврийн ослын гаралт их байгааг харуулж байна

Өмнөговь аймгийн гэмт хэргийн гаралтын байдлыг ойролцоо аймгуудын гэмт хэргийн гаралтын байдалтай харьцуулан авч үзвэл:

График VIII.15.3.




Судалгаанд хилийн бүсийн болон говийн бүсэд хамаарах хүн амын тоо ойролцоо аймгуудтай гэмт хэргийн гаралтын байдлыг харьцуулахад Өмнөговь аймгийн гэмт хэргийн гаралт харьцангуй өндөр харагдаж байгаа бөгөөд ялангуяа 2007 оноос хойш гэмт хэргийн гаралт 100% нэмэгдсэн нь уул уурхай эдийн засгийн хөгжилтэй холбоотой өссөн үзүүлэлт.

Өмнөговь аймгийн энэ байдал Монгол Улсын криминологийн хөгжилд нэг томоохон сургамж болсон гэж дүгнэж болох бөгөөд уул уурхай, эдийн засгийн эрчимтэй хөгжиж байгаа бүс нутагт гэмт хэргийн гаралт огцом нэмэгддэг зүй тогтол ажиглагдаж байгаа тул урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Тус аймгийн гэмт хэргийн гаралтын байдлын нэг онцлог нь бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэргийн гаралт нэлээд өндөр байна.

Үүнийг графикаар харуулвал: (Гэмт хэргийг гаралтыг тоон дараалаар байрлуулсан болно)

График VIII.15.4.



Залилан мэхлэх гэмт хэргийн гаралтын байдлаар Өмнөговь аймаг бусад аймгийн хэмжээнд тавдугаар байранд байгаа бөгөөд 2005 онд 5 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2015 онд 15, 2016 онд 14 тус тус бүртгэгдсэн нь энэ төрлийн гэмт хэрэг өсөлттэй байгааг харуулж байна. Тус гэмт хэргийн өсөлтөд нийгэм эдийн засгийн олон хүчин нөлөөлсөн нь ойлгомжтой боловч яах аргагүй уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн хөгжил, эдийн засгийн өсөлттэй холбон үзэхээс өөр аргагүй юм.

Өмнөговь аймгийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн насыг ажил хайгч иргэдийн настай 2016 оны жилийн эцсийн байдлын харьцуулалт

Ажил хайгч иргэдийн нас хүйсийн байдал 2016 оны 12 сарын байдлаар

График VIII.15.5.





График VIII.15.6. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн насны байдал. 2016 оны 12 сарын байдлаар



Дээрх судалгаануудад ажилгүй иргэдийн нийтлэг нь гэмт хэрэгт холбогдсон этгээдийн олонхтой давхацсан байдал ажиглагдаж байна. Ажил хайж буй 845 хүний 503 буюу 60%-ийг 15-34 насныхан эзэлж байгаа бол гэмт хэрэгт холбогдсон 442 этгээдийн 238 буюу 54%-ийг 18-36 насныхан эзэлж байгаа нь энэ насны хүмүүс аймаг орон нутгийн эдийн өсөлт, ажлын байрны тэлэлтийн хаагуур өнгөрөөд байна гэх зүй ёсны асуулт гарч бодит тайлбар болон зохицуулалтыг шаардаж байна.

Гэмт хэргийн гаралтыг сумдаар авч үзэн орон нутгийн орлогын гүйцэтгэлтэй хийсэн харьцуулалт

Хүснэгт VIII.15.2.

№	Сумын нэр	2015 он	2016 он	Нийт	Орон нутгийн орлогын гүйцэтгэлтэй (сая төг)
1	Баяндалай	10	7	17	133717.1
2	Баян-Овоо	6	8	14	328446.0
3	Булган	13	7	20	121438.8
4	Гурван тэс	61	49	110	4100231.7
5	Мандал-Овоо	8	6	14	152402.3
6	Манлай	6	8	14	181701.1
7	Номгон	8	10	18	154821.3
8	Ноён	1	4	5	292054.4
9	Сэврэй	6	2	8	138487.0
10	Ханбогд	54	51	105	41483965.7
11	Ханхонгор	18	12	30	614250.9
12	Хүрмэн	8	13	21	232067.8
13	Цогц-Овоо	6	11	17	113238.3
14	Цогтцэций	68	66	134	7594611.9
15	Даланзадгад	123	155	278	947426.1

Сум тус бүрт гэмт хэргийн гаралтын байдал харилцан адилгүй байх бөгөөд гэмт хэргийн гаралт их байгаа сумдыг авч үзэл аймгийн төв Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумууд байна. Эдгээр сумдын онцлог нь хүн амын төвлөрөл ихтэй, орон нутгийн орлогын гүйцэтгэл сайтай байгаа ажиглагдаж байна.

Эдийн засгийн өсөлт нь ард иргэдийн амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх ёстой атал иргэд яагаад гэмт хэргийг ихээр үйлдээд байна, эрх зүйн зохицуулалт болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байгууллага цаг үетэйгээ нийлсэн арга хэмжээ авч чадахгүй

байна уу? эсвэл иргэдийн олсон орлого зөв зарцуулах эдийн засгийн мэдлэг хомс байна уу? гэсэн асуулт дагуулж байна гэсэн дүгнэлт хийж болох дүр зураг ажиглагдана.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ




Өмнөговь аймгийн авто замын нэг онцлог бол олон улсын чанартай авто зам байхгүй, улсын чанартай авто замын төгсгөл байдгаараа онцлог юм.

Харин БНХАУ-руу нүүрс тээвэрлэх авто замын харилцаа сүүлийн үед эрчимтэй хөгжиж байгаа боловч зам тээврийн ослын хэрэг ихээр үйлдэгдэж хүний амь нас хохирсоор байна. Ялангуяа Тавантолгойн ордоос Хятадын компани, хувь хүн Монгол жолооч нартай тохиролцон ямар нэг бүртгэлд хамруулалгүй хүнд даацын машинаа өгч, нүүрс тээвэрлүүлдэг, мөн Цагаанхаднаас Гашуунсухайт хүртэл нүүрс ачсан машинууд ихэвчлэн шороон замаар тээвэрлэлт хийдэг.

Учир нь хувиараа хөдөлмөр эрхэлж буй жолооч нар шороон замыг сонгон тээвэр хийдэг. Шороон зам нь тоос босон үзэгдэх орчинг хязгаарлах тул зам тээврийн осол гарах шалтгаан болдог байна.

Өмнөговь аймгийн ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн нөхцөл байдлыг ойролцоо аймгуудын гэмт хэргийн нөхцөлтэй харьцуулсан судалгаа

График VIII.15.7.



Харьцуулалтад хамрагдсан аймгуудад улсын чанартай авто замын сүлжээний төгсгөл бөгөөд уул уурхай салбар эрчимтэй хөгжиж байгаа мөн БНХАУ-руу нүүрс, газрын тосыг улсын хил дамнан тээвэрлэдэг зэрэг ойролцоо нөхцөл байдалтай хилийн бүсийн аймгууд юм. Хэдийгээр зам тээврийн харилцааны нөхцөл байдал ойролцоо боловч Өмнөговь аймгийн зам тээврийн ослын гаралтын байдлаар их байна.


ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус аймгийн цагдаагийн газрын криминологийн багаас гэмт хэргийн гаралт, шалтгаан, нөхцөлийн талаар долоо хоног, сар, улирлын мэдээ гарган тасаг, албадаа зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Тухайлбал, 2017 оны 02 дугаар сарын эхний долоо хоногийн гэмт хэрэг зөрчлийн судалгаа хийн зарим онцлог гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, криминологи шинжийг тодруулан зөвлөмж гаргасан байна. Тус зөвлөмжид согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргасан байршил, цаг хугацааг тодорхойлон тасаг албад тодорхой арга хэмжээ авах талаар тусгасан байна.

Дээрх үйл ажиллагааг явуулж байгаа боловч тус аймгийн гэмт хэргийн гаралтын байдал зарим гэмт хэргийн хувь бага зэргийн бууралт тухайлбал, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 2015 онд 72 бүртгэгдсэн бол 2016 онд 66 бүртгэгдсэн байдал ажиглагдаж байгаа боловч нийт гэмт хэргийн хувьд өсөлтийн байдал ажиглагдаж байна. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодитой, үр ашигтай, ялгамжтай авч хэрэгжүүлэх хэлбэрт шилжих зайлшгүй шаардлагатай байна.

Тус аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь аймгуудад байдаг нийтлэг жишгийн адил сургалт, семинар, зохион байгуулалтын үйл ажиллагааны хүрээнд явагдаж байна.

СҮХБААТАР АЙМАГ



16. СҮХБААТАР АЙМАГ

НЭГ. СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ ЗҮЙ, НУТАГ ДЭВСГЭР, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сүхбаатар аймаг хүн ам зүй, засаг захиргааны нэгжийн нөхцөл байдал

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр нь 1931 онд Халхын 4 аймгийг 13 аймаг болгон өөрчлөхөд Хэнтий, Дорнод аймагт харъяалагдаж, дараа нь 1940-1942 оны засаг захиргааны өөрчлөлтөөр 1942 онд Мандалын хийдийн сууринд "**Жавхлант шарга**" аймаг шинээр байгуулагджээ.

Энэ үед Дорнод аймгаас Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Дарханхаан, Жавхлант шарга, Зотол, Онгон, Урт, Халзан, Хонгор зэрэг 10 сум, Хэнтий аймгаас Баянтэрэм, Уулбаян, Өлзийт, Түвшинширээ зэрэг 4 сум бүгд 14 сум, 125 баг, 29,2 мянган хүн ам, 850 мянган толгой мал, өвс хадах морин станц 2, нүүрсний уурхай нэг, сүү тосны завод 3-тай төвлөрсөн. Улсын бага хурлын 1943 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор Жавхлант шарга аймгийг их жанжин Сүхбаатарын нэрэмжит болгож "**Сүхбаатар аймаг**", төвийг Баруун-Урт голын дэргэд шилжүүлэн суурьшуулж "Баруун-Урт" гэж нэрлэх болсон. Аймгийн төв Баруун Урт хот нь Улаанбаатар хотоос 560 км, Дорнод аймгаас 210 км, Хэнтий аймгаас 225 км, Дорноговь аймгаас 340 км зайд оршдог.

Хүн ам зүйн өнөөгийн байдал

Сүхбаатар аймаг хүн ам зүй, засаг захиргааны нэгжийн хувьд өнөөгийн байдлаар нийт **60 орчим мянган** хүн амтай, 13 сум, 66 багтай, хүн амын олонх нь Халх, Дарьганга ястан бөгөөд Үзэмчин, Барга, Хуучид, Өөлд, Цахар ястан цөөнх хувийг эзэлдэг.

Сүхбаатар аймаг нь 2016 оны жилийн эцсийн байдлаар **60032 хүн, үү**нээс эрэгтэй 30276, эмэгтэй 29756 хүнтэй байна. Нийт өрх 2016 онд 17561, шилжсэн өрх 672, шилжиж ирсэн өрх 961 байна. Хүн амын нягтаршилт: 1 кв километрт 0.71, аймаг, сумын төвд байдаг айлын тоо 9108, хөдөө сумдад 8453, байшин, орон сууцанд суудаг өрх 5693 буюу нийт өрхийн 33%, төвлөрсөн цахилгаанд холбогдсон 9885 өрх буюу нийт өрхийн 57.3%, тээврийн хэрэгсэлтэй өрхийн тоо 8645 буюу нийт өрхийн 50.1%, авто машинтай малчин өрх 2988 буюу нийт малчин өрхийн 43.6%, мотоциклтой өрх 3394 буюу нийт малчин өрхийн 49.5%, трактортой 46 өрх байна.

Хүснэгт VIII.16.1. Хүн амын тоо, бүтэц

№	Сумын нэр	Багийн тоо	Хүн амын тоо			Эр 2016	Эм 2016
			2008	2012	2016		
1	Асгат	4	1,775	1,752	1741	893	848
2	Баруун-Урт	9	15,549	17,463	20376	10037	10339
3	Баяндэлгэр	6	4,560	4,614	4891	2458	2433
4	Дарьганга	4	2,884	2,856	3024	1509	1515
5	Мөнххаан	5	4,335	4,269	4551	2316	2235
6	Наран	3	1,466	1,550	1595	813	782
7	Онгон	5	3,638	3,655	3757	1918	1839
8	Сүхбаатар	5	3,263	3,178	3167	1918	1839
9	Түвшинширээ	5	3,035	3,017	3302	1712	1590

10	Түмэнцогт	3	2,339	2,391	2468	1236	1232
11	Уулбаян	5	3,010	2,780	2876	1499	1377
12	Халзан	4	1,622	1,596	1666	847	819
13	Эрдэнэцагаан	8	6,309	6,527	6618	3383	2235
	Аймгийн дүн	66	53,785	55,648	60032	30276	29756

2012 оны мөн үетэй харьцуулвал хүн ам 4384 буюу 7.8%-аар өссөн. Нийт хүн амын 50.4%-ийг эрэгтэйчүүд, 49.6%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаагаас нийт хүн амын 17786 буюу 29.6%-ийг 0-15 насны хүүхэд, 38553 буюу 64.2%-ийг 16-59 насны хүмүүс, 3693 буюу 6.5%-ийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна.

Тайлант 2016 онд 17561 айлтай, шилжсэн айл 672, шилжиж ирсэн 961 айл тоологдсон нь өмнөх оноос 289 айлаар буюу 4.1%-аар өссөн үзүүлэлттэй байна. Нийт айлын хүн амын төвд 19827, хөдөө 39207 хүн сумын төвд байршиж байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 29600, ажилчдын тоо 26700, ажилгүй иргэдийн тоо 2884, бүртгэлтэй ажилгүйчүүд 432, үүнээс эмэгтэй 212, дээд боловсролтой 100, тусгай дунд 18, ерөнхий боловсролтой 23, мэргэжилгүй 291 хүн байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 68.7% байна.

Бүсийн хэмжээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар 208119 хүн амтай үүнээс Сүхбаатар аймаг 59034 (төвд 19827, хөдөө 39207), Дорнод аймаг 76476 (төвд 43506, хөдөөд 32970), Хэнтий аймаг 72609 (төвд 24736, хөдөөд 47873) хүн ам тоологдсон.

Сүхбаатар аймгийн хүн ам зүүн бүсийн хүн амд харьцуулж үзвэл 2016 онд 28%-ийг эзэлж байгаа бөгөөд 2010 онд 3.2%, 2011, 2012, 2014 онуудад 3.3%, 2013 онд 3.4%-аар өссөн нь, аймгийн хүн амын тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөөр байна.

Тус нутаг дэвсгэрт дараах эерэг хандлагууд тогтоогдож байна. Үүнд:

Хүн амын тоонд өсөх хандлага бий болж хүн амын тоо жилээс жилд нэмэгдсэн;

1. Шилжилт хөдөлгөөний урсгал саарч, шилжин ирэгсэд нэмэгдсэн;
2. Хүн амд хөдөлмөрийн насныхан зонхилж, цаашид өсөх хандлагатай байгаа;
3. Сүүлийн жилүүдэд төрөлтийн тоо тасралтгүй нэмэгдэж өсөх хандлага бий болсон;
4. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь эерэг үзүүлэлттэй гарч байгаа;
5. Хүйсийн харьцаа тэнцвэржсэн;
6. Өрхийн тоо нэмэгдсэн;
7. Дундаж наслалтын уртассан.

Дараах сөрөг хандлага тогтоогдож байна. Үүнд:

1. Хүн амд өсвөр ба залуу насны (0-29) иргэд зонхилох хувийг эзлэж байгаа боловч сүүлийн 3 жил дараалан цөөрөх хандлагатай;
2. Хүн ам зүйн ачаалал өсөх хандлагатай;
3. Шилжилт хөдөлгөөн бүрэн зогсоогүй;
4. Нас баралт тогтвортой буурахгүй байгаа;
5. Гэр бүл салалт тогтвортой буурахгүй байгаа зэрэг эерэг, сөрөг хандлага ажиглагдаж байгаа нь төрийн захиргааны ажилтнууд болон шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй хүмүүс, оюутнууд нийгэм, эдийн засгийн олон үр дүн, үйл явцтай холбон судлахад ашиглах боломжтой.

Нутаг дэвсгэр, байгаль, цаг уурын нөхцөл байдал

Аймгийн нутаг дэвсгэр Дорнод Монголын тэгш талын өмнөд хэсгийн үргэлжлэл[10] бүсэд багтах жижиг толгод, өргөн уудам хөндий, тэгш тал, элсэн говь зэрэг гадаргуутай бөгөөд газар нутгийн 19% нь тариалангийн талбай, 15,5%-ийг хадлан, 57,1%-ийг бэлчээр, 7,5%-ийг уул толгод эзэлнэ.

Нийт нутаг дэвсгэр 82,3 мян.км², тал хээрийн бүсэд багтдаг, хилийн нийт урт 1340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойт талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойт талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэдэг.

Байгалийн хачин сонирхолтой тогтоц бүхий газар нутаг элбэгтэй. Үүнд: Дарьганга суманд 200 гаруй сөнөсөн галт уул, Онгон, Дарьганга суманд 127-248 км² талбай эзлэх Онгон, Молцогийн их элс, Эрдэнэцагаан сумын нутагт байгалийн нөөц газар Лхачинвандад уул, Дарьганга, Наран сумын нутагт Баяндулаан, Талын агуйт, Мөнххаан сумын Баян-Уулын орчмын агуй. Лог, Будар, Зараа, Төрөнгө, Дэлгэрхаан, Харгилтай зэрэг үлэмж талбай бүхий чулуун тогтоцтой нуруу хөндий олон төдийгүй чулуужсан яс зэрэг амьтан, ургамлын олдвор Байшинт, Ходоодын говь, Хорголжингийн талаас олддог.

Байгалийн нөөц баялагийн нөхцөл байдал

Ан агнуурын ач холбогдол бүхий цагаан зээр, тарваганы нутагшил нилээд тархмал байдаг бөгөөд үнэг, чоно, үен, хярс, өмхий хүрэн, мануул, дорго, туулай, зурам, шилүүс, илбэнх, хар сүүлт зэрэг ан амьтан нутагшдаг. Эрдэнэцагаан сумын Лхачинвандад, баруун, зүүн Раатын уул, Далан тавын айрагт буга, гахай, Хар ямаат, Цав зэрэг газарт бор гөрөөс нутагшсан байдаг.

Эдийн засгийн нөөцийн нөхцөл байдал

Сүхбаатар аймгийн хэмжээнд төсвийн орлого 2016 онд 51809.1 сая, зарлага нь 51653.3 сая төгрөг. Сумдын төсвийн орлого 6803.8 сая, зарлага 33626.8 сая төгрөг байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 47095.5 сая төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл 99386.7 сая төгрөг, Бичигтийн боомтоор орсон хүн 46.3 мянга, гарсан хүн 46.5 мянгаар тоологдсон байна.

Ачаа эргэлтээр тээсэн ачаа 221.8 мянган тонн, зорчигч 52.6 мянган хүн, ачаа эргэлт 82.9 сая тонн байна.

Хөдөө аж ахуйн өнөөгийн байдал

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малтай өрх 9843 тоологдсоноос малчин өрх 7253, малчин өрхөд хамаарагдах нийт 14800 малчдын хариулга, маллагаанд нийт 5 төрлийн 3029.7 мянган мал тоологдсон байна.

Мал аж ахуй

Мал аж ахуй хувьд 2016 оны байдлаар нийт 3029.7 малтай, үүнээс бод 491.8 мянга, бог 2537.9 мянган мал тоологдсон байна.

Малын тоо өмнөх оныхоос хонин тоо толгой өссөн боловч нийт дүнгээрээ 41300 тоо толгой буюу 1,3%-аар буурсан, 21 аймгийн хэмжээнд малын тоогоор 12 дугаарт эрэмблэгдэж байна.

Сүхбаатар аймаг нь улсад адууны тоогоор 5, үхрийн тоогоор 9, тэмээний тоогоор 9,

10 Нутгийн ихэнх хэсэг нь далайн түвшнээс дээш 1000-1200 м өндөрт оршдог. Хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 1778 метрт өргөгдсөн Шилийн Богд уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 790 метрт өргөгдсөн Байшинт.

хонины тоо толгойгоор 8, ямаан тоо толгойгоор 14 дүгээрт ордог.

Хүснэгт VIII.16.2.

Он, малын төрөл	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
2015	259600	214500	8300	1511800	1076000
2016	274600	209300	7900	1541600	996300

Малын төрөл, тоо сумдаар:

Хүснэгт VIII.16.3.

№	Сумын нэр	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд
1	Баруун-Урт	37.9	27.8	0.5	178.8	113.5	358.5
2	Асгат	17.2	10.8	0.2	60.6	41.1	130.0
3	Баяндэлгэр	17.5	18.6	0.8	191.6	127.2	355.6
4	Дарьганга	19.6	17.3	0.2	92.3	54.8	184.3
5	Мөнххаан	33.7	24.2	0.6	190.5	129.6	378.7
6	Наран	8.9	10.0	0.2	61.0	35.6	115.7
7	Онгон	17.3	17.1	0.7	145.3	70.8	251.1
8	Сүхбаатар	23.1	15.4	1.0	129.4	67.2	236.1
9	Түвшинширээ	16.8	12.6	1.3	140.6	102.7	274.0
10	Түмэнцогт	14.0	11.0	0.3	46.2	36.4	107.8
11	Уулбаян	17.2	12.2	1.1	130.2	74.4	235.1
12	Халзан	13.7	9.5	0.3	75.5	40.3	139.3
13	Эрдэнэцагаан	37.9	22.6	0.7	99.7	102.7	263.6
	Дүн	274,6	209.3	7.9	1541.6	996.3	3029.7

Малтай айл болон малчин айл, малчдын тоо:

Малчдын насны хувьд 16-55 насны малчин нийт малчдын 94,5%, 55-аас дээш насны малчин 5.5%-ийг эзэлж байна. Нийт 14800 малчдын 6582 эмэгтэй малчин байдаг.

Хүснэгт VIII.16.4.

Он	Малтай айл	Малчин айл	Малчин
2012	9209	6530	14000
2013	9162	6466	13700
2014	9284	6552	13900
2015	9492	6858	14300
2016	**9843**	**7253**	14800

Аж үйлдвэр, үйлчилгээний өнөөгийн байдал

Сүхбаатар аймгийн эдийн засгийн хувьд голлох салбар нь бэлчээрийн мал аж ахуй, уул уурхайн салбар бөгөөд нутгийн шилмэл омгийн Баяндэлгэрийн улаан ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонь, Түмэнцогтын махны хэвшлийн үхэр, хурдан

удмын адуун сүрэг, уул уурхайн хувьд цайр, зэс молибден, хүрэн нүүрс, хайлуур жонш, гянтболд зэрэг орд газартай.

Сүхбаатар аймгийн гадаад харилцааны дэд бүтцийн хувьд Эрдэнэцагаан сумын нутаг дахь БНХАУ-тай хиллэдэг "Бичигт" боомт нь 2008 оноос эхлэн байнгын ажиллагаатай болж өргөжснөөр ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Зүүн Үзэмчин хошуутай гадаад хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 68.8 тэрбум төгрөг, үүнээс уул уухайн үйлдвэрлэл 57.7, эрчим хүч 8.7, аж үйлдвэр 2.4 тэрбум төгрөг. Аж үйлдвэрийн нийт борлуулсан бүтээгдэхүүн 120.3 тэрбум төгрөг. Үүнээс уул уурхай 108.7, цахилгаан эрчим хүч 8.9, аж үйлдвэр 2.7 тэрбум төгрөг байна. Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүн хүрэн нүүрс, цайрын баяжмал байдаг.

Нийт аж ахуйн нэгжийн тоо 2016 оны байдлаар 900, үүнээс үйл ажиллагаа эрхэлж байгаа 731, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 43734.8, аж үйлдвэрийн борлуулалт 152739.1, барилга угсралт 17394.5, нийт авто машин 7622, үүнээс суудлын 3800, ачааны 3373, автобус 295, мотоцикл 805 тоологдсон байна.

Уул уурхайн нөхцөл байдал

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын зөвшөөрөлтэй 147 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байна.

Сүхбаатар аймгийн Төмөртэйн цайр, Арын нуур, Нүхт даваа, Егүзэрийн ховор ба холимог металлын орд газрууд, Цагаанчулуут, Хөх-Өндөрийн алтны орд газар зэрэг ордыг түшиглэн олборлох болон орчин үеийн техник, технологи бүхий эцсийн бүтээгдэхүүн гаргадаг үйлдвэрүүдийг хөгжүүлэх нь зүүн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөөд зогсохгүй Монгол Улсын хөгжилд дорвитой хувь нэмэр үзүүлэх боломжтой.

Дээр дурдсан ашигт малтмалуудаас эхний ээлжинд газрын тос, цайр, гянтболд, жонш, ураны ордуудыг ашиглах, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, шохойн чулуунаас цемент, шохой, магнит гаргах ажлыг илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Аймгийн төвүүд, томоохон суурин газруудад мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалт бүхий экспортын чиглэлтэй жижиг, дунд үйлдвэрүүдийг шинээр байгуулах, хуучин үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх, технологийн өөрчлөлт хийх зорилгоор хөрөнгө оруулагчдыг татах эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Тээвэр, холбоо харилцаа, дэд бүтцийн өнөөгийн байдал

Сүхбаатар аймаг нь Улаанбаатар - Баруун-Урт хүртэл 560 км, Дорнод аймгийн Чойбалсан хоттой 400 км урттай цардмал засмал замаар холбогдсон бөгөөд олон улсын шилэн кабелийн дэд бүтэц бүхий бүс болон хөгжиж байна.

Аймаг, сумдын төвүүд эрчим хүчний систем болон мэдээлэл шуудан, харилцаа холбоо, авто замын нэгдсэн сүлжээнд бүрэн хамрагдсан.

Ачаа эргэлтээр тээсэн ачаа 221.8 мянган тонн, зорчигч 52.6 мянган хүн, ачаа эргэлт 82.9 сая тонн байна. Нийт авто машин 7622, үүнээс суудлынх 3800, ачааных 3373, автобус 295, мотоцикл 805 байна.

Цаашид орон нутгийн болон олон улсын чанартай төмөр зам, авто замын тээврийн салбарын дэд бүтэц хөгжих, Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг баталж[11],

11 Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих түсгай зөвшөөрлийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д олгосон.

төмөр замын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, томоохон уул уурхайн ордуудыг ашиглах, тус ордуудаас бүтээгдэхүүн экспортлох зорилгоор нийт 5600 км төмөр замын сүлжээг 2013-2022 оны хооронд хэд хэдэн үе шаттайгаар барьж байгуулахаар шийдвэрлэсэн.

Учир нь стратегийн чухал ордуудын нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд одоо ашиглаж байгаа төмөр замаар хангалттай хэмжээнд тээвэрлэлт хийж чадахгүй байгаа, Монгол Улс ойрын 20 жилд нэг тэрбум тонн хүртэл нүүрс, эрдэс баялаг түүхий эд, бүтээгдэхүүнийг Зүүн Өмнөд Азийн орнуудад нийлүүлэх гэрээ байгуулсан учраас төмөр замын тээврийн салбарыг шинэчлэх, шинэ гарцууд бий болгох зайлшгүй шаардлагын дагуу "Шинэ төмөр зам" төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд урд болон зүүн чиглэлд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 225 км, Тавантолгой-Хөөгт чиглэлийн 960 км, Хөөгт-Чойбалсан чиглэлийн 185 км, Чойбалсан-Эрээнцав чиглэлд 210 км, Хөөгт-Бичигт чиглэлийн 230 км нийт 1800 км урттай төмөр замын суурь бүтцийн барилгын ажил нэгэнт эхэлсэн төдийгүй цаашид энэ салбар тасралтгүй өргөжиж, ачаа эргэлт эрс өсөх, эрчимтэй хөгжих хандлага ажиглагдаж байна.

Боловсрол

Аймгийн хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилийн байдлаар сургуулийн өмнөх боловсролын 23 байгууллагад **4998**, ерөнхий боловсролын 16 сургуульд **10764**, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 1 төвд **389** суралцагч суралцаж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 162, ЕБС-д 549, МСҮТ-д 54 багш ажиллаж байна.

Иймд цаашид хүн амын өсөлттэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн дэд бүтцийг хөгжүүлэх, сургалтын тогтолцоог бэхжүүлэх, үүднээс сургалтын хөтөлбөр, сургагч багш, ажилтан нарын чадварыг хөгжүүлэх шаардлага бий болж байна.

ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Сүхбаатар аймгийн хөгжлийн хандлага нь "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"[12], "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр, "Төрөөс уул уурхай, эрдэс баялагын талаар баримтлах бодлого", "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого", "Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр", "Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр" зэрэг бодлогын баримт бичиг, хөтөлбөр батлагдсантай уялдан эрчимтэй хөгжих эрх зүйн орчин бүрдсэн.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны (2010 он хүртэлх) ерөнхий стратеги, бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль болон 1990-ээд оноос хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтийн үр дүн, залгамж чанар нь Монгол Улсын Зүүн бүсийн энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болов. Мөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшинг бүсүүдээр тодорхойлсон судалгааны материал нь тухайн бүсийн хэтийн хөгжлийн чиг хандлагыг гаргахад чухал үүрэг гүйцэтгэлээ.

Зүүн бүсэд Монгол Улсын нийт хүн амын 8.0% нь амьдарч, 2004 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний дөнгөж 4.8%-ийг үйлдвэрлэж байсан тоон үзүүлэлтээр хөгжлийн түвшингийн ерөнхий индексийг тооцож үзэхэд Зүүн бүс нь хөгжлийн хувьд улсын дундаж болон бусад бүсээс (Баруун бүсийг эс тооцвол) хоёр дахин хоцрогдсон байна.

12 Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 12.1.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын "Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай" 2005 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 202 дугаар тогтоол

Зүүн бүсийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 455.2 мян.төгрөг байгаа нь улсын дунджаас 40.2%-аар бага байна. Энэ бүс нутагт аж үйлдвэрийн салбар, түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ сул хөгжсөн байна. Үүний зэрэгцээ Зүүн бүсийн 3 аймагт урьд өмнө нь байгуулагдан ажиллаж байсан үйлдвэрийн газрууд хүчин чадлынхаа дөнгөж 20-30 хувийг ашиглаж байна.

Зүүн бүс нутаг нь харьцангуй сайн судлагдсан эрдэс түүхий эдийн орд илэрц газрууд ихтэй, тухайлбал тус бүсэд газрын тос, төмөр, хар тугалга, уран, цайр, цагаан тугалга, шохойн чулуу, занар, жонш, хоолны давс, гянтболдын улсын батлагдсан нөөцийн 58.5-90 гаруй хувь нь байна.

Түүний зэрэгцээ ОХУ-тай төмөр замаар, БНХАУ-тай авто замаар холбогдсоны дээр төвийн эрчим хүчний системтэй бүсийн дулааны станц, эрчим хүчний сүлжээгээр холбогдох эхлэл тавигдсан, шилэн кабелийн сүлжээгээр аймгууд нь хоорондоо холбогдсон зэрэг дэд бүтцийн хөгжлийн үндэс суурь тавигдсан нь бүсийн эдийн засгийн хөгжлийг хурдасгах таатай нөхцөл бүрдсэн байна.

Зүүн бүс нь ОХУ болон БНХАУ-тай хиллэдэг бөгөөд Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны Түмэн бүс хөтөлбөрийн интеграцид орж ажиллах гадаад хамтын ажиллагааны давуу талыг ашиглах боломжоороо бусад бүсээс илүү байна. Хөтөлбөрийн агуулга, шинэлэг тал нь дараах байдлаар илэрч байна. Тухайлбал, Нүүрсний орд, барилгын түүхий эдийн орд, авто зам болон төмөр замыг түшиглэн байгуулагдах Сүхбаатар, Сайншандын аж үйлдвэрлэлийн парк, аялал жуулчлалын цогцолбор зэрэг мега төслийг хэрэгжүүлсэний үр дүнд зүүн өмнөд бүсийн эрчимтэй хөгжлийн тогтолцоо бодит биелэл болсоноор дотоод болон гадаад ачаа эргэлт 3 орчим сая тонн болж өсөх, өөрийн аймгийн 60 орчим мянган иргэд, хил залгаа 3 аймгийн нийт 9 сумдын 12 орчим мянган иргэд, авто замаар дамжин өнгөрөх зорчигч эргэлт 100 мянга орчим нийт 170 орчим мянган хүн ам[13]-д, төрөл бүрийн үйлчилгээгээр бүрэн хангах шаардлага бий болж улмаар тухайн нөхцөлд тохирсон төрийн болон хувийн хэвшлийн ухаалаг тогтолцоо бүрдэх болно.

Иймд ирээдүйн хөгжлийн хандлагын үүднээс авч үзвэл, тухайн бодит нөхцөл байдалд тохирсон бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлага, аюулгүй байдлын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог "ирээдүйн судлалын ухаан"-ы үүднээс иж бүрэн тодорхойлох шаардлагатай байна.

Төр-захиргааны уламжлалт бодлого нь "захиргааны байгууллагаас тогтоосон захиргааны хэм хэмжээгээр" олон нийтийн хэрэгцээг хангахад чиглэж байсан бол өнөөгийн ардчилал, эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнт тогтолцоот нийгэм дэх бодлого нь зах зээлд "нэгдмэл (integrated), цогц (holistic), харилцан уялдаатай (relationship)", харилцааны маркетингийн бодлого, стратегийн чиглэлийг баримтлах шаардлагатай боллоо.

ХОЁР. СҮХБААТАР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Аюулгүй байдал, гамшгийн эрсдэлийн удирдлагын хэмжүүрийн гадаад илэрхийлэл нь нийгмийн амьдралтай холбоотой сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, зөрчлийн бүтэц, хөдөлгөөн, түвшингээр тодорхойлогдоно.

Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн шалтгаан нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай орчин нөхцөл бүрдээгүй, амьдралын зөв хэв маяг, сэтгэл зүйн эерэг хандлага дутагдалтай, түүнчлэн уул уурхай болон авто замын дотоод, гадаад сүлжээ бүхий нутаг дэвсгэртэй, байнгын оршин суугч иргэдээс гадна зорчигч эргэлтийн эрчим их, нөхцөл байдалд тохирсон эрх зүйн болон

13 УСХ-ны 2011-2016 оны хүн ам зүйн болон төмөр зам, авто замын тээврийн салбарын тоон мэдээлэлд үндэслэв.

бодитой аюулгүй байдал, эрсдлийн хяналт, хамгаалалтын удирдлагын тогтолцоо хангалттай бүрдээгүйтэй холбоотой.

Иймд иргэдийн сэтгэл зүйд эерэг нөлөөлөх, нийтээр амьдрах соёл, зөв хандлагатай, өөрийгөө ухамсартайгаар хариуцах ёс зүйтэй иргэн болгон гэгээрүүлэх, төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал

Хууль сахиулах байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдлыг сүүлийн 6 жилийн хугацаагаар судлан авч үзэхдээ хууль сахиулах байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэсэн гэмт хэрэг, ангилал, төрөл, илрүүлэлтийн тоо, хувийн жин зэрэг үзүүлэлтийг харьцуулан тоймлон дүгнэв. Үүнд:

1. Улсын хэмжээнд 2011-2016 онд бүртгэгдсэн гомдол, мэдээллийн дүн;
2. Улсын хэмжээнд 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;
3. Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдэж 2012-2016 онд бүртгэгдсэн гомдол, мэдээллийн дүн;
4. Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдэж 2012-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;
5. Сүхбаатар аймгийн хувьд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн дүнтэй харьцуулсан хувийн жинг харьцуулан шинжлэн дүгнэсэн болно.

Улсын хэмжээнд хууль сахиулах байгууллага (Цагдаагийн байгууллага) судалгаанд хамрагдсан 2011-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт 1851977 гомдол, мэдээлэл хүлээн авч үүнээс гэмт хэргийн шинжтэй нийт 486699 гомдол, мэдээллийг шалган 230361 тохиолдолд буюу 47,3%-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 310592 тохиолдолд буюу 63,8%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт 226674 буюу 42,4%, 6-19 хоногт 260054 буюу 57,6%-ийг шалгасан. (**Хүснэгт VIII.16.5**), (**Хүснэгт VIII.16.6**)

Сүхбаатар аймгийн Цагдаагийн байгууллага 2012-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт 15608 гомдол мэдээллийг хүлээн авч, үүнээс гэмт хэргийн шинжтэй 4511 гомдол, мэдээллийг шалган 1700 тохиолдол буюу 37,7%-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 2941 тохиолдолд буюу 65,2%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт 2887 буюу 64,0%, 6-19 хоногт 1824 буюу 40,4%-ийг шалгасан.

Гэмт хэрэг

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний болон сүүлийн жилийн байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг сонгон авч тоймлон дүгнэсэн болно.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2012 онд нийт гэмт хэргийн шинжтэй 656 гомдол, мэдээллийг шалгаад 259 (39,5%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 288 (43,9%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, 2016 онд нийт гэмт хэргийн шинжтэй 3617 гомдол мэдээллийг шалгаад 353 (9,75%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 515 (14,2%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь судалгаанд хамрагдсан эцсийн жил 2016 онд хүлээн

авсан гомдол, мэдээлэл нь судалгааны эхний жил 2012 оны дүнгээс +2961 нэгжээр өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл +491 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэсэн +94 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан +227 нэгжээр өссөн бөгөөд нийт дүнгээр нь шинжлэн үзвэл тоон ба чанарын бүх үзүүлэлт жил бүр тогтмол өссөн, цаашид эрчимтэй өсөх хандлагатай, иргэдийн эрх, эрх чөлөө, язгуур ашиг сонирхолыг зөрчсөн гэм буруутай үйлдэл ихсэх хандлагатай байна. **(Хүснэгт VIII.16.5.), (Хүснэгт VIII.16.6.)**

ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2012-2016 онд нийт 1477 (өсөлт 13,2%) гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 668 (илрүүлэлт 77,8%), хүндэвтэр 688 (илрүүлэлт 80,6%), хүнд 85 (илрүүлэлт 92,6%), онц хүнд 26 (илрүүлэлт 100%), илрээгүй хэрэг 82 боловч өмнөх оны хэрэг нэмэгдсэн үзүүлэлтээр авч үзвэл үүнээс хулгайлах гэмт хэрэг 484 нэгж, танхайрах гэмт хэрэг 122 нэгж, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 122 нэгж болж өссөн, эдгээр 3 төрлийн гэмт хэрэг нь нийт хэргийн ихэнх хувийг эзэлж байгаа дүн мэдээлэл (*ирүүлсэн зарим тоон мэдээлэл зөрүүтэй байгаа нь өмнөх оны илрээгүй хэргийн дүн нэмэгдсэн байх магадлалтайг анхаарах хэрэгтэй*) анхаарал татаж байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд судалгаанд хамрагдсан эхний 2012 онд нийт 207 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 74, илрүүлэлт 88,9%, хүндэвтэр гэмт хэрэг 117, илрүүлэлт 76,7%, хүнд гэмт хэрэг 14, онц хүнд гэмт хэрэг 2, харин гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 9 байгаагаас хулгайлах гэмт хэрэг 79, танхайрах гэмт хэрэг 26, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 18 байсан бол 2016 оны байдлаар нийт 309 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 187, илрүүлэлт 76,7%, хүндэвтэр гэмт хэрэг 100, илрүүлэлт 89,6%, хүнд гэмт хэрэг 13, илрүүлэлт 83,3%, онц хүнд гэмт хэрэг 9, гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 16, нийт гэмт хэргээс хулгайлах гэмт хэрэг 99, танхайрах гэмт хэрэг 14, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 24 (*ирүүлсэн зарим тоон мэдээлэл зөрүүтэй байгаа нь өмнөх оны илрээгүй хэргийн дүн нэмэгдсэн байх магадлалтайг анхаарах хэрэгтэй)* бүртгэгдсэн байна. (**Хүснэгт VIII.16.6.**)

Дүгнэлт: Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллийг улсын хэмжээний дүнтэй харьцуулбал нийт гомдол, мэдээллийн 0,84 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 0,92%, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн 0,73%, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 0,93%, шалгасан нийт хэргийн хувьд хөнгөн 0,96%, хүндэвтэр 1,03%, хүнд 0,82, онц хүнд 0,87%, илрээгүй хэрэг 0,3%, хулгайлах хэрэг 2,49%, танхайрах хэрэг 6,8% ТХХАБАЖЭГХ 1,0% тус тус эзэлж байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд хууль сахиулах, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд мөрдөн шалгасан нийт гэмт хэргийн 91,8% нь ил цагаан үйлдэлтэй хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг шалгасан төдийгөөр ихээхэн цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө зарцуулсан нь зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг бараг шалгаагүй[14], урьдчилан сэргийлсэн тоон мэдээлэл тодорхойгүй учир хангалтгүй ажилласан гэж дүгнэхэд хүрч байна.

Аймгийн байгаль, цаг уур, тээвэр, харилцаа холбоо, үйлдвэр, үйлчилгээний нөхцөл байдлын хувьд улсын нийт эдийн засаг, авто замын тээврийн ачаа, зорчигч тээврийн эргэлтийн хэмжээ эрс өссөн, гадаад, дотоод тээвэрлэлттэй холбоотой нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй, урьдчилан сэргийлсэн ажлын мэдээлэл байхгүй байна.

14 Эдийн засгийн салбар дахь гааль, татвар, банк санхүү, төсвийн хууль тогтоомж зөрчсөн хүнд, онц хүнд ангиллын зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж үзэх үндэслэлгүй тул цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэхэд хүргэж байна.

Мөн улсын хэмжээнд хүлээн авч шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, шалгасан гэмт хэрэгтэй харьцуулахад хүнд, онц хүнд ангиллын гэмт хэргийн илрүүлэлтийн хувь харьцангуй бага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх зохион байгуулалт, арга зүй, болон мэргэжлийн чадвар, сэтгэлгээ, хандлагыг эрс сайжруулах шаардлагатай байгааг илэрхийлнэ. (Хүснэгт VIII.16.7, VIII.16.8)

Хүснэгт VIII.16.5. Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

№	ХСБ	Хүлээн авсан нийт гомдол, мэдээлэл	Гэмт хэргийн шинжтэй	ЭХҮ	ЭХҮТ	ГХБ-гүй	Шийдвэрлэсэн хоног	
							0-5	6-19
2012 оны дүн								
1	Улсын	141276	62371	24273	36615	36167	31743	30628
2	Сүхбаатар	656	377	259	288	288	414	163
2013 оны дүн								
1	Улсын	171438	79983	93984	51139	50403	39533	40380
2	Сүхбаатар	3266	1036	351	673	672	681	355
2014 оны дүн								
1	Улсын	450967	93984	29940	63245	62439	45337	48647
2	Сүхбаатар	4126	1243	379	850	847	699	544
2015 оны дүн								
1	Улсын	471556	96661	30439	65885	64293	45568	51093
2	Сүхбаатар	3943	987	358	615	614	591	396
2016 оны дүн								
1	Улсын	488076	94324	28320	65709	64316	35730	58694
2	Сүхбаатар	3617	868	353	515	513	502	366
2011-2016 оны нийт дүн								
1	Улсын дүн	1851977	486699	230361	315949	310592	226674	260054
2	Сүхбаатар	15608	4511	1700	2941	2934	2887	1824
Улсын дүнтэй харьцуулсан хувь								
Хувь		0,84	0,92	0,73		0,93	1,27	0,71

Хүснэгт VIII.16.6 Бүртгэгдсэн гэмт хэрэг (ангилал, өндөр үзүүлэлттэй гэмт хэрэг)

№	ХСБ	Бүртгэсэн нийт гэмт хэрэг	Өсөлт, бууралт хувь	хөнгөн	Илрүүлэлт хувь	хүндэвтэр	Илрүүлэлт хувь	хүнд	Илрүүлэлт хувь	Онц хүнд	Илрүүлэлт хувь	Илрээгүй гэмт хэрэг	Хулгайлах гэмт хэрэг	Танхайрах гэмт хэрэг	ХАБ
2012 оны дүн															
1	Улс	22089	15,1	9637	53,8	10041	55,9	1914	64,3	497	77,1	3555	2444	189/13/	1999

2	СҮ	207	13.1	74	88.9	117	76.7	14	100	2	100	9	79	26	18			
2013 оны дүн																		
1	Улс	25362	14,8	11648	62,0	11514	54,7	1766	68,1	434	85,5	4528	3471	169	2148			
2	СҮ	312	50.7	147	64.9	137	67.5	19	100	9	100	26	106	26	25			
2014 оны дүн																		
1	Улс	27318	7,7	13057	60,9	11951	54,9	1781	67,2	529	88,0	5215	3674	/460/	2143			
2	СҮ	322	3.2	120	69.2	178	83.9	21	80.0	3	100	19	94	30	33			
2015 оны дүн																		
1	Улс	27757	1,6	13487	64,1	12127	58,9	1628	72,9	515	88	5278	3857	/498/	2010			
2	СҮ	317	-1.6	140	89.7	156	85,7	18	100	3	100	12	106	26	22			
2016 оны дүн																		
1	Улс	27167	-2,1	13519	68,5	11767	58,8	1393	76,4	488	91,9	5331	3917	/357/	1783			
2	СҮ	319	0.6	187	76,7	100	89.6	13	83.3	9	100	16	99	14	24			
2011–2016 оны нийт дүн																		
Дүн	Улс	148890	33,9	69325	61,2	66289	57,2	10305	70,1	2971	86,6	26412	19422	1786	11953			
	СҮ	1477	13.2	668	77.8	688	80.6	85	92.6	26	100	82	484	122	122			
Улсын дүнтэй харьцуулсан хувь																		
	Хувь	0,99		0,96		1,03		0,82		0,87		0,3	2,49	6,8	1,0			

Хүснэгт VIII.16.7. Гэмт хэргийн төрөл

№	ХСБ	79–90	Илрүүлэлт хувь	91–107	Илрүүлэлт хувь	145–155	Илрүүлэлт хувь	175	Илрүүлэлт хувь	177–191	Илрүүлэлт хувь	215–225	Илрүүлэлт хувь	263–273	Илрүүлэлт хувь
2012 оны дүн															
1	Улс	138	93,9	7155	74,6	9023	51,6	66	57,1	1749	65,4	1999	72,4	110	5,0
2	СҮ	-	-	56		93		3		26		18		1	
2013 оны дүн															
1	Улс	54	12,5	8156	85,0	11118	51,8	98	20,0	1894	77,4	2148	78,5	106	
2	СҮ	-	-	108		132		4		26		25		6	
2014 оны дүн															
1	Улс	45	21,4	8697	85,1	8424	49,4	69	22	1750	74,3	2143	84,8	135	
2	СҮ	-	-	106		128		3		30		33		1	
2015 оны дүн															

1	Улс	10		8468	89,0	13445	56,1	42		1630	79,8	2010	85,9	128	66
2	СУ	-	-	106		140		-		29		22		3	
2016 оны дүн															
1	Улс	36	50	8691	88,7	13336	56,8	40	100	1479	75,6	1783	87,8	111	
2	СУ	1	-	126		128		1		15		24		3	
2011-2016 оны нийт дүн															
Дүн	Улс	389		47629	84,4	62578	53,1	369	25,0	10375	74,5	11953	81,0	681	
	СУ	1	-	502		621		11		126		122		14	

Хүснэгт VIII.16.8. Прокурорын байгууллагаас гомдол, мэдээлэлийг хянан, шийдвэрлэсэн байдал

№	Хянасан нийт гэмт хэрэг	ЭХУ	ЭХҮТ	Эрүүгийн хэрэг үүссэн				Шүүхэд шилжүүлсэн	Хэр/гүй болгосон	Хэрэгсэхгүй болсон үндэс		
				Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Онц хүнд			Бүр/гүй	Эвлэрсэн	Бусад
Аймгийн Прокурорын хүлээн авсан, хянан, шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
1	4245	1496	2748	611	777	109	31	453	885	302	496	87
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		35.2	64,7	40.8	51.9	7.2	2.02	30.2	59.1	34.1	56.04	9.8
Улсын хэмжээнд хүлээн авсан, хянан, шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
2	367393	121128	244453	53667	68321	10395	3459	24379	85412	19640	38359	27413
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		32,9	66,5	44,3	56,4	8,5	2,8	20,1	70,5	23	44,9	32,1
Аймгийн прокурорын хувьд улсын хэмжээний дүнтэй харьцуулалтын хувь (2013-2016 он)												
3	1.25	1.2	1.12	1.23	1.13	1.04	0,89	1.85	1.03	1.53	1,29	0.31

Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн криминологи шинж

Тайлбар: Гэмт хэрэгт холбогдогсдын криминологи шинжийг үндэсний аюулгүй байдлын эсрэг, эрх, эрх чөлөөний эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, гаалийн хууль тогтоомж зөрчсөн, танхайрах, ТХХАБАЖЭсрэг, албан тушаалын гэсэн гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувийн жинтэй 6 төрлийн гэмт хэргийг сонгон авч шинжлэсэн болно. Судалгааг сүүлийн 6 жилээр авч үзлээ. (Хүснэгт VIII.16.9)

Гэмт хэрэгт холбогдогсдын хүйс, нас, боловсрол

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2012-2016 онуудад нийт 1578 хүн холбогдсоноос 134 эмэгтэй, бүлэглэсэн 351, согтуугаар 480, насанд хүрээгүй хүн 73, насны хувьд 18-34 насны 994, 35-дээш насны 511, ажил эрхлэлтийн хувьд төрийн албаны 107, хувийн салбарын 737, оюутан сурагч 73, ажилгүй 668, боловсролын хувьд бага 485, дунд 468, тусгай боловсролтой 36, дээд 189 байна.

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний 2012 он, сүүлийн 2016 оны байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж

байгаа хулгайлах, танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдлыг 2012 оныхтой харьцуулахад 2016 онд нийт 323 буюу 116 хүнээр өссөн нь харьцангуй өсөх хандлагатай, хүйсийн хувьд: 32 эмэгтэй буюу 22-р өссөн, насны хувьд: 11 хүүхэд буюу 6-аар өссөн, 18-34 насны 192 буюу 55-р өссөн, 35-70 насны 120 буюу 55-р өссөн, ажил байдлын хувьд: төрийн албан хаагч 22 буюу 2-р өссөн тогтвортой, хувийн секторын ажилтан 156 буюу 93-р өссөн, оюутан, сургачид 13 буюу 11-р өссөн тогтвортой, ажилгүй 132 буюу 40-р өссөн, оролцооны хувьд бүлэглэж 34 буюу 9-р буурсан боловч бусад онуудтай харьцуулахад харьцангуй өсөлттэй, боловсролын хувьд: бага 101-107 буюу харьцангуй тогтвортой өсөх, дунд 177 буюу 76-р өссөн, тусгай 6 буюу 23-р тогтвортой, дээд 39 буюу 7-р өссөн үүнээс согтуу 104 буюу 56-р өссөн байгаа нь харьцангуй тогтвортой мэт боловч тээврийн салбарын онцлогтой холбоотой үзүүлэлт тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. (Хүснэгт VIII.16.9.)

Дүгнэлт: Улсын хэмжээний дүнтэй харьцуулж үзэхэд төрийн болон хувийн салбарын дунд, дээд боловсролтой оролцогч нар, бүлэглэж үйлдэх гэмт хэрэг зэрэг онцлог үзүүлэлтээр 35-52% өсөх хандлагатай байгаа нь уул уурхай, авто замын тээврийн салбарын эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, үйлчилгээ, ачаа, зорчигч тээврийн эрчимтэй эргэлттэй холбоотойгоор дундаж настай, мэдлэг боловсролтой хүмүүс бүлэглэж гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байгааг илэрхийлнэ.

Хүснэгт VIII.16.9. Гэмт хэрэг үйлдэгсэд

№	ХСБ	Бүх хүн	эм	бүлэг	35-тай бүлэг	согтуу	Нас			Ажлын байдал				Боловсрол			
							НХХ	18-34	35-70	Төрийн	Хувийн	Оюутан сурагч	ажилгүй	бага	дунд	тусгай	дээд
2012 оны дүн																	
1	Улс	19734	2667	4030	23	4791	1248	12320	6166		1764	1316	10639	2808	8403	616	3305
2	СҮ	207	10	43	00	58	5	137	65	20	93	2	92	78	99	4	26
2013 оны дүн																	
1	Улс	22286	3137	4205	10	5695	1222	13766	7271	988	541	1575	11558	3084	14674	723	3816
2	СҮ	327	32	86	1	110	28	206	93	26	151	29	121	96	190	7	34
2014 оны дүн																	
1	Улс	23737	3618	2732	2	6686	1250	14481	8006		6900	1581	11966	3073	15250	876	4395
2	СҮ	356	29	98	-	117	9	238	109	12	176	11	157	107	203	7	39
2015 оны дүн																	
1	Улс	24857	3782	4624		5465	1402	15088	8363	1018	7178	644	12820	3251	1600	836	4755
2	СҮ	365	31	90	-	91	20	221	124	27	161	18	159	103	199	12	51

2016 оны дүн

1	Улс	23805	3592	3722	4	5507	1265	14422	8218	835	4927	1310	13143	2897	15494	834	4580
2	СУ	323	32	34	4	104	11	192	120	22	156	13	132	101	177	6	39
Нийт	Улс	132401	19099	21430	42	32456	7523	81434	43486	946	24052	7635		18012	64084	4433	23344
	СУ	1578	134	351	5	480	73	994	511	107	737	73	668	485	468	36	189

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ЦАГ ХУГАЦАА, ОРОН ЗАЙ

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний жил 2012 он, сүүлийн жил 2016 оны байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, түүнчлэн илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд нийт гэмт хэргийн ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Сүхбаатар аймгийн хэмжээнд **2012 онд** үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагын 1, 2, 4, 3 дахь өдрүүдэд, цагийн хувьд 19-22, 22-06 цагийн хооронд харин **2016 онд** үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагын 1, 2, 3, 4 дэх өдөр, цагийн хувьд 14-19, 19-22, 22-06 цагийн хооронд гэмт хэргийн түвшин өндөр хувьтай байгаа нь авто замын болон үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээ, төрөл, ажлын цагийн хуваарьтай шууд холбоотой боловч жилийн аль сарын хэд дэх 10 хоногт гэмт хэрэг үйлдэгдэж байгаа байдлаар гэмт хэргийн түвшин тодорхойлох мэдээлэл байхгүй байсан болно. (Хүснэгт VIII.16.10.)

Сүхбаатар аймгийн хэмжээнд гэмт хэрэг үйлдэгдэж байгаа орон зайн хувьд аймгийн онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээ, зам тээврийн салбарын онцлогтой холбоотой авто замын тээвэр, үйлчилгээний байгууллагуудын ажилчид, албан хаагчдын албан үүрэгт хамааралтай гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Хүснэгт VIII.16.10. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг

№	ХСБ	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2012 оны дүн												
1	Улс	3593	3342	3243	3212	3202	2714	2783	3814	5664	3956	8658
2	СУ	35	34	30	38	22	26	22	12	47	49	99
2013 оны дүн												
1	Улс	4067	3875	3765	3778	3707	3140	3030	4532	6405	4541	9884
2	СУ	31	49	46	45	56	49	26	30	74	54	154
2014 оны дүн												
1	Улс	4655	4178	4115	3937	4093	3192	3148	5758	7326	4434	9800
2	СУ	44	55	53	41	52	30	47	49	95	59	119
2015 оны дүн												
1	Улс	4655	4266	4159	4127	4028	3328	3194	6056	7948	4326	9427

2	СҮ	54	41	47	53	47	41	44	49	85	57	126
2016 оны дүн												
1	Улс	4280	4157	4018	4019	3979	3424	3280	5884	7782	4109	9392
2	СҮ	51	53	58	50	44	32	31	51	101	52	115
Дүн	Улс	24657	22633	22143	21892	21859	18015	17681	29295	40240	24920	54438
	СҮ	**215**	**232**	**234**	**227**	**221**	**168**	**170**	191	402	271	613

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ БОЛОН ХОХИРЛЫН БАЙДАЛ

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний жил 2012 он, сүүлийн жил 2016 оны байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт хохирсон болон хохирлын байдлыг 2012 оныхтой харьцуулахад 2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 345 хүн хохирсон буюу 148-р өссөн, эмэгтэй 109 буюу 47-р өссөн, хүүхэд 17 буюу 11-р өссөн, 18-34 насны 147 буюу 45-р өссөн, 35-70 насны 181 буюу 87-р өссөн, гэмт хэргийн улмаас нийт 674,5 орчим сая төгрөгийн хохирол буюу 381,1 сая төгрөгөөр өссөн үүнээс хөнгөн гэмт хэргийн улмаас 113,6 сая төгрөг буюу 100,8 сая төгрөгөөр өссөн, хүндэвтэр гэмт хэргийн улмаас 453,3 сая төгрөг буюу 271,4 сая төгрөгөөр өссөн, хүнд гэмт хэргийн улмаас 54,6 орчим сая төгрөг буюу -26,3 сая төгрөгөөр буурсан, онц хүнд гэмт хэргийн улмаас 53,0 сая төгрөг буюу 40,0 сая төгрөгөөр өссөн, үүнээс нөхөн төлүүлэлт хэрэг бүртгэлтийн явцад 100,0 сая буюу 74,7 сая төгрөгөөр өссөн, мөрдөн байцаалтын явцад 430,4 сая буюу 285,7 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь хохирол нөхөн төлүүлсэн үзүүлэлт мэт боловч ил үйлдэлтэй гэмт хэргийн хувьд цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг биелэлтэнд хангалттай биш.

Харин нийт хохирлоос нөхөн төлүүлэлт 78,63%-тай байсан нь нэг талаас сайн үзүүлэлт боловч нөгөө талаас хөнгөн, хүндэвтэр "ил цагаан" үйлдэлтэй гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт гэдгийг анхаарах ёстой.

Дүгнэлт: Эндээс харвал хохирогчийн тоо, хохирлын хэмжээ тогтвортой өссөн нь үйлчилгээний салбарын болон зам тээврийн хөгжилтэй холбоотой авто зам, үйлчилгээний эрчимтэй өсөлт, мөнгөний ханш, үнийн инфляцтай холбоотой байх магадлалтай, учир нь нөхөн төлүүлэлт харьцангуй сайн төдийгүй хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт ногдох хувь өндөр учир төлүүлэлт хялбар байх магадлалтай.

Энэ нь нэг талаас сайн үзүүлэлт мэт боловч нөгөө талаас зохион байгуулалттай, хүнд, онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудал байгааг илтгэнэ. Цаашид хохирлын хэмжээ эрс өсөх хандлагатай (Хүснэгт VIII.16.11.).

Хүснэгт VIII.16.11. Хохирогч, хохирлын байдал

№	ХСБ	Нийт хохирогч	Эм	НХХ	Хох-ийн нас		Хохирол Сая ₮	Хөнгөн. Сая ₮.	Хүн/тэр. Сая ₮	Хүнд	Онц хүнд Сая₮	Төлөлт. Сая₮	ХБ Сая₮	МБ Сая₮
					18-34	35-70								
2012 оны дүн														
1	Улс	21294	7977	1200	10540	9567	53263,2	6613,2	22223,1	14564,8	9862,2	25135,6	4409,6	20726,0
2	СУ	197	61	6	102	94	293.4	30.8	181.9	80.8	-	170.6	26.2	144.4
2013 оны дүн														
1	Улс	25015	9838	1426	12316	11273	159024,2	9433,2	87481,9	37049,2	25059,9		6582,2	
2	СУ	315	89	10	144	161	594.4	40.2	459.3	77.7	17.2	431.1	31.2	399.9
2014 оны дүн														
1	Улс	27475	10902	1576	13420	12479	148204,6	13800,7	34202,4	61890,7	38370,9	43652,5	9195,9	34456,6
2	СУ	362	129	15	165	182	731.4	54.1	564.6	101.8	10.9	552.8	37.1	514.9
2015 оны дүн														
1	Улс	27948	11207	1477	13528	12943	144341,4	15388,4	45783,3	38075,5	45094,2	48997,8	10224,2	38773,5
2	СУ	395	129	21	170	204	861.7	72.2	772.0	51.6	6.0	693.7	60.0	633.7
2016 оны дүн														
1	Улс	27689	11346	1340	13306	13043	162909,4	16585,8	40518,4	67975,0	37830,2	43964,0	11320,4	32643,5
2	СУ	345	109	17	147	181	674.5	113.6	453.3	54.6	53.0	530.4	100.0	430.4
Нийт	Улс	148013	58126	8197	72212	67603	150845,3	66047,7	250195,1	224268,2	163196,2	131242,5	44336,1	142486,2
	СУ	1614	517	69	728	822	3155.4	310.9	2431.1	366.5	87.1	2378.6	254.5	2123.3

СҮХБААТАР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхний жил **2012 он,** сүүлийн жил **2016 оны** байдлаар зөрчлийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа "танхайрах", "ТХХАБАЖЭсрэг"[15], "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" зэрэг төрөл сонгон авч тоймлон дүгнэсэн болно.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2012-2016 онд нийт 35687 зөрчилд 430801 хүн холбогдуулан бүртгэж 567,7 сая төгрөгөөр торгосон, үүнээс торгуулийн тасалбараар 23595 зөрчилд 198,7 сая төгрөгний торгуул ногдуулсан. Тус салбарт бүртгэгддэг зонхилох зөрчлөөс "танхайрах" зөрчил 6065-г бүртгэн 27,7 сая төгрөгний торгуул, "авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам" зөрчсөн 16306 зөрчил бүртгэж 275,9 сая төгрөгөөр торгож, "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" 214 зөрчилд 1,58 сая төгрөгний торгуул ногдуулсан байна. Энэ нь нийт зөрчлийн 66,2%, торгуулийн 35,0 орчим хувь эзэлж байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2016 онд зөрчлийн байдал, төрөл болон торгуулийн дүнг 2012-2015 оныхтой харьцуулахад 2016 онд бүртгэсэн нийт зөрчил 5138 буюу 2000-3000-р буурсан, холбогдсон хүн 4749 буюу 1000-2000-р буурсан, торгуулийн хэмжээ 312,5 сая төгрөг буюу 220,1-272,8 сая төгрөгөөр өссөн, торгуулийн тасалбараар 2684 зөрчилд буюу -3702-/-2033/ зөрчлөөр буурсан, тогруулийн хэмжээ 92,6 сая төгрөг буюу 62,0-69,0 сая төгрөгөөр өссөн үүнээс танхайрах зөрчил 428 буюу -2287-/-458/-р буурсан, торгуулийн хэмжээ 2,1 сая буюу 2,0-10,0 сая төгрөгөөр буурсан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын зөрчил 1762 буюу 1654-1000-р буурсан, торгуулийн хэмжээ 207,4 сая буюу 189,2-192,3 сая төгрөгөөр өссөн, цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй зөрчил 33 буюу 25-43-р буурсан, торгуулийн хэмжээ 0,165 сая төгрөг буюу 0,161 сая төгрөгөөр буурсан байна.

Дүгнэлт: Сүхбаатар аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, зам харилцааний хөгжлийн онцлогтой холбоотойгоор нутаг дэвсгэрийн нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг хэдий ч авто болон дамжин өнгөрдөг замын сүлжээний төвд байдаг учир жилд өөрийн аймгийн 60 орчим мянган иргэд, хил залгаа 3 аймгийн нийт 9 сумын 12 орчим мянган иргэд, авто зам замаар дамжин өнгөрөх зорчигч эргэлт 100 мянга орчим нийт 170 орчим мянган хүн ам орчим үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг баталгаатай хангаж ажиллаж байгаа. Гэтэл зөрчлийн бүртгэл жил бүр харилцан адилгүй хэдий ч цаашид зөрчлийн тоо буурах хандлага байгаа боловч торгуулийн хэмжээ өсөх дүн илэрхийлэгдэж байгаа нь хууль сахиулах үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, арга зүйг мэргэжлийн үүднээс зохион байгуулж хэрэгжүүлэх, үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бүрэн хянаж чадахгүй байгаагаас урьдчилан сэргийлэх ажлыг дүгнэхэд хангалттай үндэслэл байхгүй байна.

ГУРАВ. СҮХБААТАР АЙМГИЙН ГХУСАЗСЗӨВЛӨЛИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Сүхбаатар аймгийн ГХУСАЗСЗ-д Засгийн газрын 2012 оны 7 сарын 25-ны өдрийн 252 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр", Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2015 оны 06 сарын 22-ны өдрийн 257-дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Олон нийт

15 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэл, 2015 он, №28 дугаарт нийтлэгдсэн.

цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр"-үүдийг 2015 онд цагдаагийн газраас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг нь тооцон ажиллаж байна[16].

Сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нартай хөдөөгийн хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллах чиглэлээр "Гурвалсан гэрээ" байгуулан биелэлтийг нь хангуулан ажиллажээ. Сүхбаатар аймгийн хэмжээнд хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Хөршийн холбоо"-г баг бүрт байгуулах ажлыг багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай хамтран зохион байгуулж байгаа ба нийт 9 хөршийн холбоог байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлсэн.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 28 малчдын бүлэг холбоо байгуулан, сумдын хэсгийн төлөөлөгч нарт бүлэг холбоодын ажлыг сайжруулах, идэвхжүүлэх чиглэлээр Цагдаагийн газрын даргын зөвлөмжийг гарган хүргүүлж биелэлт үр дүнг нь тооцон ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу шүүх, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн орлогоос оруулсан орлогын 40%-ийг тусгай санд төвлөрүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, хэрэг, зөрчлийг бууруулахад зарцуулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн хэлтэст санал гаргаж Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт оршин сууж буй 40-с дээш насны иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх хөтөлбөрийн хүрээнд багийн Засаг дарга нартай хамтран 10 иргэнийг сонгон авч нэг сарын хугацаанд өдөр бүр тогтоосон маршрутын дагуу гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг буюу үйлдэгдэж болзошгүй цэгүүдээр эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж хүн нэг бүрийг 200000 төгрөгөөр цалинжуулан урамшуулж ажиллалаа.

Баруун-Урт сумын 5, 9 дүгээр багт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, Цагдаагийн байгууллага олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран "Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны өдөрлөг"-ийг зохион байгуулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн тасаг албад, төрийн болон ТББ-тай хамтран хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж Шинэ жил, Сонор сэрэмж, Ахуйн хүрээний архидалт, Сар шинэ, Шөнийн хяналт, Мэдэгдэл-1, Унаач хүүхэд, Захиргааны хяналт, Зочид буудал, Туслах уяач-малчин-унаач хүүхэд, Баруун-Урт сумын 1 шөнө, Сар шинэ тусгай зөвшөөрөл, нэг бүрчилсэн хяналтыг сайжруулья, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцье, Мансууруулах бодис, эмийн худалдаа, тамхины хяналт, Хээрийн түймрээс сэргийлье, Гэмт хэргээс урьдчилан сэргийлье, Мэдэгдэл, шаардлага, интернэт кафе, цахим тоглоом, Баяр наадам, Архидалттай тэмцье, Зочид буудал, "Баар", "Тамхины хяналт-2, Үер ус, аянга цахилгаан, Хичээлийн шинэ жил, Ломбард, РС цахим тоглоом, тусгай зөвшөөрөл хяналт, Гэрээт хамгаалалтын газар, 9 сарын 1-ны өдөр, архигүй өдөр, Хулгайтай тэмцье, Хүчирхийлэл ба хяналт, Нэгдсэн шалгалт-5, Оргодол, Саун массаж, Малын хулгай - 1, 2, Илрүүлэлт оргодол, Вакцин, Орон байрны хулгай, Илрүүлэлт, Хууль бус ан 2015, Хяналт шийдвэрлэлт, Алт судалгаа, Биеэ үнэлэгч, Эко - 2015, Ломбард, Илрүүлэлт шийдвэрлэлт, Хамгаалах бүс, хариуцлагын даатгал, Галын хор, Арал дугаар, Улсын дугаар, Мотоцикль, Хамгаалах малгай, Орон нутгийн зам, Хамгаалах бүс, Согтуу жолооч 1, 2, 3, Нийтийн тээвэр, хүн тээвэр, Авто машингүй өдөр, Техник, тэмдэг тэмдэглэгээ, Хяналт шалгалт, Гэрэл гэрлэн дохио, Оюутан тээвэр зэрэг 96 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж үр дүн биелэлтийг тооцож ажиллажээ.

Дүгнэлт: Сүхбаатар аймгийн ГХУСАЗСЗ-өөс аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс 12 багц ажлыг төлөвлөн, хариуцах эзэнтэй, зарцуулах төсөвтэйгээр үе шаттайгаар хэрэгжүүлсэн нь тодорхой

16 Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2015 оны тайлангаас авав.

үр дүнтэй ажил болсон гэдэг нь зөрчлийг хянан шийдвэрлэсэн тоон болон чанарын мэдээллээс харагдаж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулсан зарим сайн туршлагын шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дүгнэн, хөтөлбөр боловсруулах, улмаар бусад орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай байна. Цаашид гэмт хэрэг, зөрчилтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг, арга арга зүй, техник хэрэгсэл, ухаалаг технологийг үр бүтээлтэй ашиглах ажлыг зохион байгуулахаас гадна нутгийн өөрөө удирдах байгууллага болон бусад байгууллагтай хамтран тодорхой төсөвтэй, үйл ажиллагааны үнэлгээтэй зохион байгуулах шаардлагатай байна.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН БАЙДАЛ

Сүхбаатар аймгийн Цагдаагийн хэлтэс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран ажиллаж, багагүй хэмжээний хүн хүч, хөрөнгө мөнгө, техник хэрэгслийн дэмжлэгтэй ажиллаж байгаа боловч[17] үйл ажиллагаагаа шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой тодорхойлж зарим үр дүнгүй ажлыг хэрэгжүүлэхгүй, тайланд тусгахгүй байх шаардлагатай.

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг, арга зүйд үндэслэн оновчтой тодорхойлж, үйл ажиллагаагаа төлөвлөх (прогноз), хэрэгжүүлэхдээ цагдаагийн албан хаагчид урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдлэгтэй, ур чадвар, дадлага эзэмшин, криминологийн ололт, үр дүнг ашиглах шаардлагатай байгаа нь судалгаанаас илэрхий байх тул цагдаагийн байгууллагын нийтлэг чиг үүрэг гүйцэтгэх шинэ мэдлэг, арга зүй, техник технологи нэвтрүүлэх, сайн туршлагыг "нийгмийн гэрээний онол"-д тулгуурлаж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт VIII.16.12. Зөрчил, шийдвэрлэлтийн байдал

№	ХСБ	Нийт зөрчил	Хувь (+, -)	Иргэн	Торгууль Сая ₮	Торгуулийн тасалбар торгосон		Танхайрах нийт зөрчил		ХАБ журам нийт зөрчсөн		ХЁШаардлага эсэргүүцсэн	
						Тоо	Сая₮	тоо	Сая ₮	Тоо	Сая ₮	Тоо	Сая ₮
2012 оны дүн													
1	Улс	795923	21,8	751571	4654,413	627853	3043,012	126018	462,230	502438	238,823	10503	42,23
2	СУ	7312	6,2	6764	39,753	6386	29,256	2715	12,053	3449	16,145	76	0,365
2013 оны дүн													
1	Улс	777793	-2,3	726716	4853,349	655728	3029,8	137259	563,539	469677	2242,6	9565	42,684
2	СУ	8125	11,1	7417	61,401	5025	23,578	1604	7,318	3313	15,735	58	0,281
2014 оны дүн													
1	Улс	681222	-12,4	-	5253,6	538473	2973,76	131600	6032,7	369295	2192,42	12761	62,113

17 Сүхбаатар аймгийн ГХУСАЗСЗ-н 2016 оны үйл ажиллаганы тайлан

2	СУ	7463	-8,1	6801	61,586	4717	22,648	886	4,067	3770	18,279	15	0,75
2015 оны дүн														
1	Улс	1423088	2дах	1372058	17016,3	1279774	14300,4	117008	559,861	786338	5126,278	21720	107,24
2	СУ	7649	2,4	7050	92,447	4783	30,576	432	2,156	4012	18,285	5	0,025
2016 оны дүн														
1	Улс	1034585	-27,3	1001379	30617,3	927639	16749,2	107531	534,062	597524		30412	153,332
2	СУ	5138	-3,7	4749	312,515	2684	92,647	428	2,140	1762	207,489	33	0,165
Нийт дүн	Улс	4712611		3850345	62394,9	4029467	117472,1	619416	8152,4	2725272	9800,1	84961	407,59
	СУ	35687	2,9	30801	567,702	23595	198,705	6065	27,734	16306	275,933	214	1,586


ТАВ. САНАЛ

Сүхбаатар аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, зам харилцааны хөгжлийн онцлогтой холбоотойгоор нутаг дэвсгэрийн үйлчилгээ цогц байдлаар өргөжиж байгаатай уялдуулан аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагааг бодит байдалд тохирсон, үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс цагдаа, хууль сахиулах байгууллагуудыг мэргэжлийн албаны зохион байгуулалт, мэргэшсэн албаа хаагчдаар бэхжүүлэх, нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон тодорхой чиглэлээр үйл ажиллагааг мэргэшүүлэн гүйцэтгэх шаардлагтай (зам тээврийн, ачаа тээврийн, уул уурхай зэрэг эдийн засгийн салбарын гэмт хэрэгтэй тэмцэх) болсон байна.

Тайлбар: Хүнд, онц хүнд ангиллын гэмт хэрэг эдийн засаг, уул уурхай, үйлдвэрлэл, тээврийн салбарт үйлдэх магадлал өндөр бөгөөд үндэстэн дамнасан зохион байгуулалттай буюу НҮБ-ын тодорхойлсон 15 төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх магадлал их байна. Гэтэл Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн онцлогтой холбоотой үйлдэгддэж байгаа гэмт хэрэг шалгаж шийдвэрлэхгүй байгаа нь шинэ нөхцөл байдалд тохирсон сэтгэлгээ, сэтгэл зүй, арга барил, чадвар, туршлагыг шаардаж байна. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хүний нөөцийн удирдлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах, сэтгэлгээтэй, мэдлэгтэй, чадварлаг бүтэц бүхий хамт олныг бүрдүүлэх, хүний хүчин зүйлийг багасгах, ухаалаг технологид суурилсан урьдчилан сэргийлэх ажиллагааг (дүрс, дуу бичлэг, гэрэл зураг, зураг, радио, хэвлэлийн төрөл зүйлийг өргөн ашиглах) зохион байгуулах шаардлагатай болсон.

Тайлбар: Сүхбаатар аймгийн хэмжээнд ажилгүй болон бага насны хүүхэд зөрчилд холбогдох нь харьцангуй бага, ихэвчлэн эдийн засгийн боломжтой хүмүүс үйлчлүүлж байдаг, өнөөгийн шийдвэрлэсэн зөрчил нь ихэвчлэн нийтлэг зөрчил байна, салбарын өвөрмөц онцлогтой холбоотой зөрчил огт шийдвэрлэхгүй байгаатай холбоотой.

СЭЛЭНГЭ АЙМАГ



17. СЭЛЭНГЭ АЙМАГ

НЭГ. СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, НУТАГ ОРОН, САЛБАРЫН ОНЦЛОГ

Сэлэнгэ аймаг нь 17 сум, 56 багтай үүнээс тосгоны статустай 6 багтай Монгол орны нутгийн хойд хэсэгт Орхон, Сэлэнгийн сав газрын дунд зэргийн уулс бүхий 41,2 мянган дөрвөлжин км нутаг дэвсгэр эзлэн оршдог аймаг. Аймгийн төв нь Сүхбаатар хот, нийслэл Улаанбаатар хоттой төмөр зам болон асфальтан хучилттай замаар холбогддог ба нийслэлээс 321 км зайтай, Булган, Орхон, Хэнтий, Төв аймгуудтай хил залгаа оршдог ба дундаа Дархан-Уул аймгийг агуулдаг, эрс тэс уур амьсгалтай, газар юм.

Зураг VIII.17.1.



Сэлэнгэ аймаг 2016 оны жилийн эцэст суурин хүн амын тоо 106.677-д хүрсэн нь өмнөх оноос 1.9%-аар нэмэгдсэн байна. Хүн амын нас хүйсийн бүтцээр авч үзвэл нийт хүн амын хувьд авч үзвэл, эрэгтэйчүүд 50.6% эмэгтэйчүүд 49.4%, байгаа бол 0-14 насны хүүхэд 28.9%, 15-59 насны хүн 64.5%, 60-аас дээш насны хүмүүс 6.6%-ийг эзэлж байна.

Тайлант онд тус аймагт бусад аймаг хотоос бүгд 1639 хүн шилжин ирж, 2370 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирэгсдийн 40.2% нь Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгаас, шилжин явагсдын 76.9% нь Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймаг руу шилжин явжээ. Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 67.810 хүн зорчсон байна. Энэ онд аймгийн хэмжээгээр нийт 1826 эх төрж, 1836 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрөлт 6.1%-аар буурчээ. Нас барсан хүний тоо 570 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 43 хүнээр буюу 8.2%-аар өссөн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2016 онд 1016 болсон нь урьд оны мөн үеийнхээс 27.3%-аар өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 14.1%-ийг мэргэжилтэй ажилчид, 28.6%-ийг дээд боловсролтой, 50.4%-ийг ерөнхий боловсролтой, 0.6%-ийг тусгай дунд боловсролтой хүмүүс эзлэж байна. Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 115 хүн ажилд зуучлуулж, 352 хүн

идэвхгүй байдлын улмаас хасагдаж, 309 хүн шинээр бүртгэгдсэн байна. Он гарсаар 1470 хүн шинээр ажилд зуучлуулж орсон байна.

Сэлэнгэ аймаг нь газар тариалан голлон хөгжүүлсэн. Манай орны газар тариалангийн талбай нь үлэмж хэсэг Орхон Сэлэнгийн сав газарт төвлөрсөн байдаг. Улсын үр тарианы 45 орчим хувийг үйлдвэрлэдэг, 570 гаруй мянган малтай. Сэлэнгэ аймагт мод боловсруулах, гурилын, хүнсний, спирт бал бурмын үйлдвэр, вагон засварын газрууд байдаг. Сүхбаатар хот төмөр зам ба авто замын гол зангилаа нутаг бөгөөд хилийн байнгын чухал гарцын нэг юм.

Аймгийн хэмжээнд 2016 онд 147.3 мянган га талбайд үр тариа, 3.26 мянган га талбайд төмс, 2.6 мянган га талбайд хүнсний ногоо тус тус тариалжээ. Үүнийг 2015 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 6.2 мянган га буюу 4.0%-аар бага, хүнсний ногоо 0.31 мянган га буюу 13.8%-аар, төмс 0.37 мянган га буюу 12.9%-аар тус бүр илүү тариалсан байна.

Сэлэнгэ дахь Гаалийн газрын мэдээгээр 4129 суудлын вагон, 114734 ачааны вагон, 4326 зүтгүүрийн вагон, 171757 суудлын автомашин, 54192 ачааны автомашин, 5883 автобус, 1986 мотоцикл Алтанбулаг, Сүхбаатар боомтоор дамжин өнгөрсөн байна. Хилээр Монголын 1.178.733, гадаадын 152.829 иргэн зорчжээ. Урьд оны мөн үетэй харьцуулахад хилээр орсон гарсан ачааны автомашин 6.7%-аар, суудлын автомашин 4.2%-аар буурч, зүтгүүрийн вагон 6.5%-аар, ачааны вагон 3.0%-аар, Монгол иргэдийн тоо 40.8%-аар, гадаад иргэдийн тоо 29.8%-аар нэмэгдсэн байна. Энэ нь Алтанбулаг боомтын үйл ажиллагаа 24 цагаар ажилладаг болсонтой холбоотой.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд ашигт малтмалын 94, ашиглалтын 103 нийт 197 тусгай зөвшөөрөлтэй, эдгээр зөвшөөрөлтэй газрууд нь 13 сумын 221226.09 га газрыг хамарч, нийт газар нутгийн 5.4%-тай тэнцэж байна. Уул уурхайн хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 34 ААН байх ба нийт аймгийн татварын орлогын 33.1%-ийг бүрдүүлдэг байна.

Стратегийн томоохон ач холбогдолтой уул уурхайн газрууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- "Бороо-Гоулд" ХХК-ийн Бороогийн алтны уурхай;
- "Болд төмөр Ерөө гол" ХХК-ийн Баянголын уурхай;
- "Эрдэс Групп" ХХК-ийн Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай;
- "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Төмөртэйн уурхай;
- "Редхил Монголия" ХХК-ийн Улаан-Овоогийн нүүрсний уурхай тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймгийн хэмжээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч буюу нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон Мандал суманд 30 орчим нөхөрлөлийн 300-аад иргэд, Орхонтуул, Хүдэр суманд тус тус 1 нөхөрлөлийн 100-аад иргэд нийт 500 гаруй иргэд албан ёсоор гар аргаар ашигт малтмал олборлодог байна.

Зуны улиралд зөвшөөрөлгүй хууль бусаар гар аргаар алт олборлогч иргэд эрс нэмэгдэж харин өвлийн цагт багасдаг, аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийг нөхөрлөл хэлбэрээр хяналтад оруулах шаардлага байгаа хэдий ч өөр аймаг, сумдаас ирж ашигт малтмал олборлодог тул гэмт хэрэг гарах нэг шалтгаан болохоор байна.

Мөн нэг онцлог нь гэмт хэрэг, зөрчил нь цаг хугацааны хувьд байнгын болон улирлын шинжтэй байдаг. Тухайлбал, тус аймагт үйлдэгддэг БХЖЭсрэг гэмт хэрэг гэхэд л өвлийн цагт багасаж, хуурайшилтын ойн сан хаах үе буюу хавар 4-6 сар, намар 9-10 сард гэмт хэргийн гаралт гаралт ихсэн жишээтэй. Ялангуяа хууль бусаар мод бэлтгэх, зөөвөрлөх, тээвэрлэх асуудал 10-12 саруудад ихэсдэг байна. Харин өвлийн улиралд самар түүхээр очсон иргэдээс үйлдэх гэмт хэрэг ихсэх хандлагатай байдаг байна.

ХОЁР. СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Бүртгэгдсэн гэмт хэрэг:

Тус аймагт 2011-2016 онд нийт 4248 гэмт хэрэг бүртгэгдсэн ба жилд дунджаар 708 гэмт хэрэг бүртгэгддэг байна. 2011, 2013, 2016 онуудад гэмт хэргийн гаралт урьд оноос 27-172 хэргээр буурсан бол 2014, 2015 онуудад гэмт хэргийн гаралт 27-124 хэргээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

График VIII.17.1.



Тус аймгийн хэмжээнд бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгө хулгайлах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргүүд голчлон үйлдэгддэг байна.

Тухайлбал: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгдсэн хэргийн 35 гаруй хувийг эзэлдэг бөгөөд үүнээс бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 90 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 205, 2012 онд 228, 2013 онд 240, 2014 онд 249, 2015 онд 301, 2016 онд 233 хэрэг бүртгэгдсэн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 30 орчим хувийг эзэлдэг бөгөөд үүнээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 80 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 125, 2012 онд 149, 2013 онд 151, 2014 онд 192, 2015 онд 208, 2016 онд 161 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг тус аймагт бүртгэгдсэн хэргийн 15 гаруй хувийг эзэлдэг бөгөөд үүнээс ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 90 орчим хувийг эзэлдэг ба 2011 онд 70, 2012 онд 61, 2013 онд 56, 2014 онд 93, 2015 онд 65, 2016 онд 84 хэрэг бүртгэгдсэн байна.

Аймгийн прокурорын газрын статистик тоо үзүүлэлтээс үзэхэд Сэлэнгэ аймагт сүүлийн 3 жилд 1046 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлж, 1647 хэргийг хэрэгсэхгүй болгож, 149 хэргийг нэгтгэж, 127 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна.

Шүүхийн статистикаас үзэхэд Сэлэнгэ аймагт 2011-2013 онд 881 хүнд холбогдох 908 эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байсан бол 2014-2016 онд 1018 хүнд холбогдох 840 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх 3 жилтэй харьцуулахад 7.5%-аар буурсан үзүүлэлт гарчээ.

Шүүхээс 2011-2016 онд нийт 2286 хүн ял шийтгүүлснээс 159 буюу 7.0% нь албадан ажил хийлгэх ял, 287 буюу 12.6% нь баривчлах ял, 1733 буюу 75.8% нь хорих ял (үүнээс 503 буюу 29.0% нь биечлэн эдлэх, 1094 буюу 71.0% нь тэнсэн харгалзах ял)-аар шийтгүүлж, 21 буюу 0.9% нь өршөөлийн тухай хуулиар өршөөгдсөн байна.

Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар нь 2016 онд орон нутагт 9222 гэмт хэрэг бүртгэгдсэний 669 буюу 7.3%-ийг Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг 124 буюу 15.6%-аар буурсан байна.

2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг

Хүснэгт VIII.17.1.

Үзүүлэл	2015	2016	Өсөлт, бууралт	
			тоогоор	хувиар
Бүртгэгдсэн нийт хэрэг	27757	27167	-590	-2.1
Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэг	9779	9222	-557	-5.7
Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг	793	669	-124	-15.6

Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт бууралт (хувиар):

График VIII.17.2.



Бүртгэгдсэн хэргийн илрүүлэлт (хувиар):

Хүснэгт VIII.17.2.

	2015	2016	Өсөлт, бууралт /нэгжээр/
Улсын хэмжээнд	62.1	64.0	1.9
Орон нутгийн хэмжээнд	70.8	71.6	0.8
Сэлэнгэ аймгийн хэмжээнд	78.4	79.8	1.4

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (хэргийн төрлөөр):

График VIII.17.3.



Өмнөх онтой харьцуулахад: хүнийг санаатай алах гэмт хэрэг 68.8%, бусдын бие махбодод гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг тус бүр 22.6%, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 20.0%, бусад төрлийн гэмт хэрэг 15.3%-аар тус тус **буурсан.**

Хүчиндэх гэмт хэрэг 12.5%, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 28.6%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 29.2%-аар тус тус **өссөн.**

Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг тус бүр өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

Хүснэгт VIII.17.3.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	2015	2016	Нэгжээр	Өсөлт бууралт (хувиар)
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	55	52	-3	-5.4
Эмэгтэй хүн оролцсон	94	87	-7	-7.4
Хүүхэд оролцсон	48	26	-22	-45.8
Бүлэглэн гүйцэтгэсэн	77	49	-28	-36.4
Согтуугаар	295	250	-45	-15.2

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар:

Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 240 буюу 35.9% нь гэр орон сууцанд, 173 буюу 25.9% нь бусад газарт, 87 буюу 13.1% нь авто замд, 73 буюу 10.9% нь гудамж талбайд, 43 буюу 6.4% нь олон нийтийн газар, 33 буюу 4.9% нь ААН-д, 13 буюу 1.9 хувь нь төрийн байгууллагад, 4 буюу 0.6% нь ТББ-д, 3 буюу 0.4% нь нийтийн тээвэрт үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гараг, цаг :

Хүснэгт VIII.17. 4.

(Бүртгэгдсэн хэргийн гариг, нийт хэрэгт эзлэх хувь)		
Даваа	92	13.8 %
Мягмар	100	15.0 %
Лхагва	102	15.2 %
Пүрэв	99	14.8 %
Баасан	98	14.6 %
Бямба	91	13.6 %
Ням	87	13.0 %

График VIII.17.4.



Гэмт хэрэгт холбогдсон хүн 2016 он:

Нийт 701 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.6%-аар буурсан. 89 буюу 12.7%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11.0%-аар, 612 буюу 87.3% нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.9%-аар, 28 буюу 4.0%-ийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58.8%-аар тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:

График VIII.17.5.





График VIII.17.6.



Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

График VIII.17.7.



Гэмт хэргийн улмаас ААН, байгууллага 4, иргэн 701 хохирч, үүнээс: 56 хүн нас барж, 371 хүн гэмтсэн, 278 буюу 39.7% нь эмэгтэй хүн гэмт хэрэгт өртөж хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, ААн, байгууллагад учирсан 1465.3 сая төгрөгийн хохирлын 1001.9 сая төгрөг буюу 68.4%-ийг нөхөн төлүүлж, 414.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2016 онд урьд оны үлдэгдэл болон шинээр эрүүгийн хэрэг үүсгэн нийт 865 хэрэг шалгаснаас 38.8%-д хэрэг бүртгэлт, 61.2%-д мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт VIII.17.5.

Үзүүлэлт	2015	2016	Өсөлт, бууралт	
			тоогоор	хувиар
Шалгасан хэрэг	1121	865	-256	-22.8
Яллах дүгнэлт үйлдүүлэхээр	429	341	-88	-20.5
Хэрэгсэхгүй болгуулахаар	552	397	-155	-28.1
Нэгтгэсэн	52	57	5	9.6
Шийдсэн хэргийн хувь	92.1	91.9	-0.2	

Аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил буурсан хэдий ч согтуугаар болон гэр орон сууц, ахуйн хүрээнд танхайрах, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, зөрчлийн гаралт нийт хэрэг, зөрчилд эзлэх хувь нь төдийлөн буураагүй байна.

Тус аймагт хүчиндэх гэмт хэрэг 12.5%-аар, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 28.6%, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 29.2%-аар тус тус **өссөн** байгаад дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 34.8%-ийг эзэлж байгаа ба гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нь архидан согтуурхснаас болсон байна. Тус аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 62.9%-ийг тус гэмт хэрэг эзэлж байна.


Гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйл нь тус аймаг нь ашигт малтмалын томоохон орд газруудтай улмаас зуны улиралд хил залгаа болон бусад аймгуудаас зөвшөөрөлгүй хууль бусаар гар аргаар алт олборлогч иргэд эрс нэмэгддэг мөн Сэлэнгэ аймгийн Мандал суманд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чанга дэглэмтэй 0413, 0433-р ангиуд байдгаас хорихоос суллагдсан иргэд тэндээ оршин сууж, дахин гэмт хэрэг үйлддэг байна.

ГУРАВ. СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар иргэд, ААН, байгууллагаа гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 6228 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 99.2%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.

2011-2016 онд нийт 140265 захиргааны арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

График VIII.17.8.



Сэлэнгэ аймагт 2016 онд 15791 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6303 буюу 28.5%-аар буурч, зөрчил гаргасан 14679 иргэн, 65 ААН, байгууллагад 722.6 сая төгрөгөөр торгох, үүнээс 832 хүнийг 319.1 сая төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 215 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

График VIII.17.9.



Нийт бүртгэгдсэн захиргааны зөрчлийн 78.5%-ийг согтуугаар, зөрчлийн 8.6%-ийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 2501 хүн саатуулагдсанаас 152 буюу 6.1% нь эмэгтэй, 1 буюу 0.1% нь 18 хүртэлх на сны хүмүүс байна. 7 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

График VIII.17.10.



График VIII.17.11.



2011-2015 оны хугацаанд нийт 3992 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жилийн хугацаатай хасч захиргааны арга хэмжээ авсан бол "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль" 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээс хойш нийт 1071 жолоочийг торгож, эрхийг нь 6 сараас 2 жилийн хугацаатай хассан байна.

График VIII.17.12.



График VIII.17.13.



ДӨРӨВ. СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ


Сэлэнгэ аймагт ТХХАБАЖурам зөрчих гэмт хэрэг 2011-2016 онд нийт 475 хэрэг бүртгэгдэж, 143 буюу 30.1% согтуугаар үйлдэгдсэн байна.

График VIII.17.14.



Гэмт хэргийн ангилал (2011–2016 он):

График VIII.17.15.



Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа (2011–2016 он):

Хүснэгт VIII.17.6.

(Бүртгэгдсэн хэргийн гариг, нийт хэрэгт эзлэх хувь)		
Даваа	70	14.7 %
Мягмар	62	13.1 %
Лхагва	54	11.4 %
Пүрэв	67	14.1 %
Баасан	80	16.8 %
Бямба	74	15.6 %
Ням	68	14.3 %

График VIII.17.16.



Цаг хугацааны хувьд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг нь байнгын шинжтэй учир улирал харгалзахгүй үйлдэгддэг, ихэвчлэн 14-19, 22-06 цагийн хооронд үйлдэгдэх нь илүү байдаг байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар (2011-2016):

График VIII.17.17.



2011-2016 онд нийт 452 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 44 буюу 9.7% нь эмэгтэй, 408 буюу 90.3% нь эрэгтэй, тэдний 4 буюу 0.9% нь 16-17 насны хүүхэд, 279 буюу 61.7% нь 18-34 насны, 169 буюу 37.4% нь 35-аас дээш насны иргэд байна.


Гэмт хэрэгт холбогдогчдын 42 буюу 9.3% нь төрийн алба хаагч, 70 буюу 15.5% нь хувийн хэвшилд ажиллагч, 64 буюу 14.1% нь хувираа хөдөлмөр эрхлэгч, 229 буюу 50.7% нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд гэмт хэрэг үйлдсэнээс 121 буюу 26.8% нь согтуугаар, 20 буюу 4.4% нь урьд ял шийтгэгдсэн этгээд гэмт хэрэг үйлдсэн байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийг үйлдэж байгаа хүмүүс нь ихэвчлэн хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрмийг эс тоомсорлодог, хурд хэтрүүлдэг, хууль эрх зүйн мэдлэг дорой, бусдыг хүндэтгэх ёс суртахуун төлөвшөөгүй, хар амиа бодсон би л болж байвал бусад нь хамаагүй гэсэн аминчхан сэтгэлээр үйлдэл, эс үйлдэхүй болон хор уршигтаа хандсан онцлогтой.

Боловсролын хувьд судалж үзэхэд 55.7% нь бүрэн дунд боловсролтой, 12.8% нь бүрэн бус дунд боловсролтой, 27.4% нь тусгай дунд болон дээд боловсролтой, 4.0% нь боловсролгүй, бичиг үсэг мэддэггүй хүмүүс эзэлж байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол (2011-2016 он):

График VIII.17.18.



Гэмт хэргийн улмаас 581 иргэн хохирч, үүнээс 173 хүн нас барж, 344 хүн гэмтсэн (үүнээс: хөнгөн 54, хүндэвтэр 181, хүнд 109) байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 1462.9 сая төгрөгийн хохирлын 70.8%-ийг нөхөн төлүүлж, 572.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

2016 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 93 бүртгэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17 буюу 22.4%-аар өссөн байна.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэгт 2016 онд 89 иргэн холбогдон шалгагдсанаас 50 буюу 56.2% нь 18-34 насны иргэд эзэлж, 20 буюу 22.5% нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Мөн энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2016 онд 122 иргэн хохирч, 33 иргэн нас барж, 14 хүн хөнгөн, 42 хүн хүндэвтэр, 23 хүн хүнд гэмтэж, хэргийн улмаас 16 хүүхэд хохирч, 9 хүүхэд хүнд, хөнгөн гэмтэж, 4 хүүхэд нас барсан байна.

2016 онд бүртгэгдсэн нийт 86 буюу 92.5% нь аймаг, сумын төв болон улсын чанартай авто зам дээр голчлон үйлдэгдсэн байна.

ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, осол, хохирлын байдалд тээврийн хэрэгслийн өсөлт, замын хөдөлгөөний нягтрал, замын байгууламж болон түүний орчны байдал зохих хэмжээгээр нөлөөлж байна.

Тээврийн хэрэгслийн тоо жил бүр тогтмол өсөж, замын хөдөлгөөний нягтрал, ачаалал нэмэгдэхийн зэрэгцээ ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, ослоос хүний амь нас, эрүүл мэнд, төрийн болон ТББ, ААН, иргэдийн өмч хөрөнгөд хохирол учруулах явдал багасахгүй байна.

Замын хөдөлгөөнд оролцогчдоос Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх хөдөлгөөний соёл ихээхэн дутагдалтай замын хөдөлгөөнд оролцохдоо холбогдох журам, замын хөдөлгөөний дүрмийн заалтыг баримталдаггүй, энэ талаарх мэдлэг, сахилга хариуцлага сул, хурд хэтрүүлэх, урсгал сөрөх, явган хүний гарам руу ойртон ирэхдээ хурдаа хасдаггүй, гарцаар гарч яваа явган зорчигч нарт зам тавьж өгдөггүй, согтуугаар машин жолоодох зэрэг нөхцөл байдал нөлөөлсний гадна стандартын шаардлага хангаагүй эвдрэл гэмтэлтэй зам харгуй, замын тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй, жолооны курсуудын чанаргүй сургалт зэрэг нь гэмт хэргийн тоо өсөх үндсэн шалтгаан болж байна.

Хохирогчийн хэт хайхрамжгүй байдлаас мөн шалтгаалж байна. Хохирогч иргэдийн хувьд гарцгүй газраар гарах, хориглосон улаан гэрэл ассан үед дүрэм зөрчин гүйх, согтуугаар гуйвж дайван зам хөндлөн гарах зэргээр байнга хууль дүрэм зөрчиж байгаа бөгөөд тэдэнд замын цагдаа нар хариуцлага тооцдоггүй байдал нь нэг хэвшил бий болгосон байна.

Сэлэнгэ аймгийн хувьд орон нутгийн замууд нь нарийн, энхэл догол ихтэй, гэрэлтүүлэг байдаггүй, гэрлэн дохио байхгүй, байгаа зарим нь алдаг оног асдаг, явган хүний зам автомашины замтай зааваль давхацдаг зэрэг нь осол гарах нэг шалтгаан болж байна.

Гэмт хэрэг үйлдэгсдийн 20 гаруй хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох нь энэ төрлийн гэмт хэргийн бие даасан шалтгаан болж байна. Жолооч нар аймаг хооронд зорчихдоо хяналт шалгалт, цагдаа байхгүй гэж найдан уулын овоо бүр дээр шахам зогсож аян замаа мялааж байна гэсэн шалтаг тоочин архидан согтуурч улмаар хурд хэтрүүлэх, эсрэг урсгалд явах, гүйцэж түрүүлэх журам зөрчих нь осол болох нэг үндсэн шалтгаан болж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2011-2013 он хүртэл гэмт хэрэг бууралттай байж байгаад 2014 оноос өссөн байна. Энэ нь далд гэмт хэргийн өсөлттэй ч хамааралтай байх боломжтой.

ТАВ. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГХУСАЗСЗ-ИЙН 2016 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Сэлэнгэ аймгийн ГХУСАЗСЗ нь 2016 онд 3 удаа хуралдаан зохион байгуулж, аймгийн гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын салбаруудыг хамарсан 15 асуудал хэлэлцэж 4 зөвлөмж, 1 албан даалгавар гарган 2016 онд хийх ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн хууль сахиулах

байгууллагын хамтын ажиллагааны талаар 8, хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын талаар 9, хяналт шалгалтын ажлын талаар 6, зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын талаар 7 нийт 30 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 82.5%-тай байна.

Зөвлөлийн хуралдаанаар аймгийн хэмжээнд эрх зүйн сургалт сурталчилгааны цар хүрээ хүртээмжийг өргөжүүлэх сургалтын багийн бүрэлдэхүүн, ажиллах журам сумдын салбар зөвлөлүүдийн ажлыг шалган туслах удирдамж, аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн баталсан.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор Сүхбаатар сумын гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийн судалгааг шинэчлэн камержуулах ажлыг үргэлжлүүлэн нэгдсэн хяналтын системд холбох, сумдын хэсгийн төлөөлөгч нарыг мотоциклоор хангах асуудлыг 2016 оны төсөвт суулган батлуулсан.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр "Албан даалгавар" гарган хэрэгжүүлж ажилласнаар энэ төрлийн гэмт хэрэг 28.6%-аар буурсан байна.

Сумдын нутаг дэвсгэрийн байршил, хүн амын нягтрал, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсвийн тодорхой хэмжээний зардал хуваарилж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

ХЗДХЯ, Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэн, ЦЕГ-аас хамтран зохион байгуулсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадваржуулах" сургалтад хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг хамруулсан.

Энэ хугацаанд нийт 25 гэмт хэрэг, 3365 зөрчлийг илрүүлэн шийдвэрлэж, хулгайлах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох ажилд ахиц гарч хулгайлах болон танхайрах гэмт хэрэг 41.2%-аар буурсан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу аймгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий иргэний зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таны оролцоо" сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт Засаг дарга, хэсгийн дарга, болон иргэдийн төлөөллийг оролцуулан ажилласан.

Дээрх уулзалт хэлэлцүүлгээр сум, баг тус бүрийн хэв журмын нөхцөл байдлыг хэсгийн байцаагч, цагдаа нар танилцуулж "Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр яриа таниулга хийж, тэдний санал, хүсэлтийг нь хүлээн авч Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахаар тогтсон.

"Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье" сэдэвт 45 хоногийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх зорилгоор аймаг орон нутгийн онцлог байдлыг тусгасан шаардлагатай ажил арга, хэмжээний зураглалыг гарган хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж байна.

Хүүхдээс үйлдэж байгаа гэмт хэргийг бууруулах, хүүхдээс үйлдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэрэгт өртөж хохирч буй хүүхдүүд, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга гарган хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах "Ил захидал" гарган бүх сумдад хүргүүлж ажилласан.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 96 дугаар тогтоолоор "Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл хяналтын ажилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зохион байгуулан оролцуулах

тухай "School-Police" эргүүлийн ажиллах журмыг баталсан.

"Архигүй эрүүл орчин" аяны хүрээнд сумдын сургууль, цэцэрлэгийн багш ажилтан 882 хүнд сургалт явуулж, Хушаат суманд "Архи тамхигүй сум", Орхонтуул суманд "Архигүй Орхонтуулчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 12 удаагийн сургалтыг зохион байгуулж 3206 хүнд яриа таниулга хийсэн байна.

Замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёлыг дээшлүүлэх чиглэлээр "Хөдөлгөөний соёл" аян, "Ногоон гэрэл, цагаан шугам" уралдааныг аймгийн хэмжээнд зохион явуулж 14 сургууль 8 цэцэрлэгийн 500 гаруй хүүхдийг хамруулж, 5200 гаруй сурагчдад замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгосон

Олон нийтийн цагдаагийн ажилтнууд, иргэний зөвлөлийн гишүүд, сум багийн Засаг дарга нар, иргэдийн төлөөллийг оролцуулан "Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/134 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөө гарган Хүдэр суманд хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг таслан зогсоосон.

Ан агнуур, ашигт малтмалын хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хулгайн ан хийж болзошгүй газруудад хяналт шалгалтыг зохион байгуулж хулгайгаар ан агнасан 46 зөрчил илрүүлэн зохих байгууллагад нь шилжүүлэн ажилласан байна.

ЗУРГАА. СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/134 дугаартай захирамжийг хэрэгжүүлэх, БХЖэсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор "Бодис-2016", "Хяналт-Шалгалт-2016","Хүдэр-2016" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 25-наас 28-ны өдрийг хүртэлх хугацаанд цагдаагийн 24 алба хаагчдын бүрэлдэхүүнтэй явуулсан байна.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд 14 хоног, сар бүр дүн шинжилгээ хийж цагдаагийн газрын судалгаа, дүн шинжилгээний багаар хэлэлцүүлэн цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар хэлэлцэж сумдын ИТХ-лын дарга нар, аймгийн Засаг дарга, Шүүх, Прокурор, Статистикийн газарт хүргүүлэн хариуцсан нутаг дэвсгэрийнхээ нөхцөл байдлын талаар мэдээ мэдээллээр ханган үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ирснээр орон нутгийн дэмжлэг туслалцааг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд авч ажилласнаар бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах, хулгайлах, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл буурсан, ялангуяа худалдаа үйлчилгээний журам зөрчсөн зөрчил 148 бүртгэгдсэн нь өмнөх оны үеэс 58-аар буюу 28.2%-аар буурчээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарыг бүртгэл судалгаанд авч ажилласан ба гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж байгаа хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл 261 бүртгэгдсэн нь 130-аар буюу 99.2%-аар өсчээ.

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар орон нутгийн "Миний Монгол", "Мандал" телевизээс зохион байгуулсан "Иргэдээ сонсъё" "Эрх зүйн зөвлөгөө" шууд нэвтрүүлгээр хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар болон хар тамхи мансууруулах бодисонд донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тус тус мэдээлэл бэлтгэн явуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Хүүхэд бүр хүчирхийллээс ангид байх ёстой" сургалтыг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2, 3 дугаар сургуулийн сурагчдын

дунд 2 үе шаттай зохион байгуулж 8 бүлгийн 263 сурагч 18 багш хамрагдсан.

"Дотуур байр-Бидний гэр" тусгай арга хэмжээг зохион байгуулж арга хэмжээний хүрээнд техник мэргэжлийн сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдардаг нийт 327 сурагч, оюутнуудад "Хүний наймаа бол гэмт хэрэг" сэдвээр сургалт зохион байгуулж, "Хэн ч худалдаалагдах ёсгүй" зураг хуудас 400, "Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлье" санамж 350 ширхгийг тараасан.

Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас төмөр замын вокзал, худалдааны төв, зочид буудал, согтууруулах ундаагаар үйлчилдэг 82 цэгийн мэдээллийн самбарт болон хүний нүдэнд ил харагдах газруудад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 250 ширхэг сэрэмжлүүлэг, зураг хуудас байрлуулсан.

ДОЛОО. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэд, олон нийт, ТББ-уудын дэмжлэг туслалцаанд түшиглэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зүй ёсны шаардлага тулгарч байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил буурсан хэдий ч согтуугаар болон гэр орон сууц, ахуйн хүрээнд танхайрах, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, зөрчлийн гаралт нийт хэрэг, зөрчилд эзлэх хувь нь төдийлөн буурахгүй байгаа тул үүнд чиглэгдсэн зөв оновчтой, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлага байгаа нь харагдаж байна.

Гэмт хэргийг түргэн, шуурхай илрүүлснээр гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж таслан сэргийлэх арга хэмжээ авсанаар дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг нь таслан зогсоохоос гадна гэмт хэрэг үйлдвэл заавал хариуцлага хүлээдэг гэсэн эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг нийт иргэдэд ойлгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны талаар сурталчлах, соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын график төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй хөршийн хяналт, оюутан цагдаа, "School police" зэрэг хөтөлбөр арга хэмжээнд идэвхтэй оролцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгч буй санамж, зөвлөгөөг ахуй амьдралдаа мөрдлөг болгох.

Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг багасгах замаар ядуурлын түвшин, ажилгүйдлээс үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх уриалгыг гаргаж, ААН, байгууллагад дэмжлэг үзүүлснээр гэмт хэргийн гаралт буурна.

Нийгмийн эмзэг бүлэг, тэнэмэл амьдралтай, орон гэргүй, архаг архичин, мансуурах донтой, хорихоос суллагдсан хүмүүсийг эмчлэх, нийгэмшүүлэх, бусад хэлбэрээр туслалцаа үзүүлэх, хүч хэрэглэсэн гэмт хэргийн 60%-ийг согтуугаар үйлдэж, иргэдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа тул тухайн нутаг дэвсгэрт оршин суугчийн тоон үзүүлэлтийг харгалзан нийт нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчлэх ААн (цэг)-ийн дээд хязгаарыг зааж өгөх шаардлагатай байна. \

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаа, хууль сахиулах байгууллагаас явуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцох, бусад хэлбэрээр хамтран ажиллаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, судалгааны үр дүнг ашиглан ажил, арга хэмжээ зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзэж байна

ТӨВ АЙМАГ



18. ТӨВ АЙМАГ

НЭГ. ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭР, БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ, УУЛ УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА,

Төв - Монгол Улсын дорнод төв биед оршдог аймаг. Засаг захиргааны төв - Зуунмод хот. 74 мянган км² нутаг дэвсгэр, 88 мянган оршин суугчтай. 27 сум, 97 багтай.

Байрлал - Төв аймаг Монгол Улсын дорнод төв хэсэгт 74,042.37 км² газар эзлэн оршдог. Дундаа Улаанбаатар нийслэлийг хүрээлж, бусад талаараа Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ зургаан аймагтай хиллэнэ.

Газрын тогтоц - Далайн түвшинээс дээш дунджаар 1200-1500 м өргөгдсөн. Хэнтийннуруу, Заамарын нуруу, Зоргол хайрхан, Хустайн нуруу зэрэг уулархаг гадаргуутай. Асралт хайрхан (2800 м), Богд хан, Батхаан зэрэг уулс бий.

Нутаг дэвсгэрийн 16.4 хувийг ой мод, 36.5%-ийг хээрийн бүс эзэлдэг.

Газар зүйн байршлаар Хангай, Хэнтийн уулархаг, Дорно Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар байдаг.

Ус мөрөн - Хэрлэн, Туул зэрэг том жижиг 30 гаруй голтой. Жанчивлан, Цайдам, Цахир зэрэг бүрд нуурыудтай.

Амьтан ургамал - Аймгийн нутгийн өмнө ба баруун хэсгээр хээр талын хүрэн, цайвар хүрэн хөрстэй, зүүн хойд хэсгээр нь хөндийн бараан хөрс, уулын ой, нугын саарал хөрс тархжээ. Хангай, Хэнтийн салбар уулсад хуш, шинэс, улиас, бургас, нарс, яшил, яргай зэрэг янз бүрийн модтой, өрөл, мойл, үхрийн нүд, нохойн хошуу зэрэг жимс, сонгино, хөмөл, таана, мангир, халиар, гичгэнэ, мөөг зэрэг хүнсний ургамал, чихэр өвс, чацаргана мэтийн ховор болон дэгд, бадаана, таван салаа, тарваган шийр,алтан гагнуур зэрэг эмийн ургамал ургана.

Төв аймагт буга согоо, хандгай, аргаль угалз, хойлог, хүн зэрэг 16 зүйлийн дархан цаазат амьтдаас гадна хэрэм, тарвага, үнэг, хярс, гахай, баавгай, шилүүс зэрэг агнуурын ач холбогдолтой 30 гаруй төрлийн араатан, жигүүртэн бий.

Аж үйлдвэр – Чулуун нүүрс, төмрийн хүдэр, хар тугалга, гянтболд, усан ба утаат болор, жонш, оюу, номин, гялтгануур мана, цагаан тугалга зэрэг ашигт малтмалтай.

Уул уурхайн танилцуулга:

Төв аймагт алт, нүүрс, вольфром, төмөр, жонш, шохой, барилгын материал, элс, хайрагны ордын 455 тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН үйл ажиллагаа явуулж байна. Ашиглалтын 291 тусгай зөвшөөрөл бүхий 134173 га талбай, Хайгуулын 163 тусгай зөвшөөрөл бүхий 376068 га талбай олгогдсон байна[18].

18 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн тайлан мэдээ боловсруулсан. Хууль, Эрх Зүйн Хэлтсийн Дарга бөгөөд ГХУСЗ-ийн нарийн бичгийн дарга М.Мэндсүрэн 2017.01.16., 04/106 баримт бичгийн хавсралт 2 дахь хуудас.

ХОЁР. ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛСОН ТАНИЛЦУУЛГА

Тус аймгийн нутаг дэвсгэрийн онцлог: Нийслэл Улаанбаатар хотыг тойрсон байршилтай, нийт 74,8 мянган км² нутагтай, газар нутгийн 16.4%-ийг ойн бүс, 36.5%-ийг тал хээрийн бүс эзэлдэг. Засаг захиргааны 27 сум, 88 мянган хүн ам, 145 ААН, байгууллага, 28084 га талбай ашигт малтмалын газартай, 37 Ерөнхий боловсролын сургууль, 5 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв. 3 сая 572.980 мянган толгой мал, 14 мянган тээврийн хэрэгсэлтэй, хүн амын төвлөрөл, суурьшил ихтэй, Авто замын сүлжээ өргөн хөгжсөн, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган зэрэг аймгуудтай хил залгаа, Улаанбаатар хот руу дамжин өнгөрөх улсын чанартай хатуу хучилттай нийт 1500 орчим км зам дамжин өнгөрдөг. Аймгийн төвөөсөө хамгийн ойр сум нь 14 км, хамгийн хол бөгөөд алслагдсан сум нь 261 км зайтай байрладаг. Жилд дунджаар гэмт хэрэг, зөрчлийн газрын дуудлага мэдээллийг шалгах болон бусад ажилд нийт 115 сая төгрөгийн бензин шатахуун зарцуулдаг[19].

Тус аймаг нь газар нутгийн онцлог, хүн амын суурьшил, улсын чанартай авто зам, төмөр зам өргөн хөгжсөн, улсын чанартай бүтээн байгуулалтын ажил ихээр явагддаг үүнийгээ дагаад хүн амын төвлөрөл нэмэгддэг, отор нүүдэл ихтэй, зэрэг олон шалтгаан нөхцөлөөс шалтгаалан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал сүүлийн жилүүдэд хүндэрч ирсэн. Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, иргэдийн эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, ТХХАБАЖЭсрэг гэмт хэргүүд тодорхой хувийг эзэлж байдаг. Сүүлийн жилүүдэд БХЖЭсрэг гэмт хэрэг, ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргүүд нэмэгдэх хандлагатай байна.

ГУРАВ. ТӨВ АЙМГИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ (2007-2016)

Төв аймгийн эрүүгийн нөхцөл байдлыг 2007-2016 оны хоорондох 10 жилээр хэргийн төрлүүдээр нь судалж үзвэл хулгайлах гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдсэн гэмт хэрэг болж байна. Түүн дотроо бусдын эд хөрөнгө хулгайлах 6030 хэрэг үйлдэгдсэн бол 2009-2016 онд иргэдийн өмчийг хулгайлах 1588, мал хулгайлах 2083 гарчээ. Энэ нь сүүлийн найман жилийн хугацаанд жилд дунджаар 198 иргэдийн өмчийг хулгайлах, 260 мал хулгайлах гэмт хэрэг гарсан гэсэн үг. Судалгаанд хамруулсан хугацааны нийт дүнгээр эзлэх хувийг доорх графикт үзүүллээ[20].

Албан байгууллага, ААН, иргэдээс төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл Хүснэгт VIII.18.1

19 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн тайлан мэдээ боловсруулсан. Хууль, Эрх Зүйн Хэлтсийн Дарга бөгөөд ГХУСЗ-ийн нарийн бичгийн дарга М.Мэндсүрэн 2017.01.16., 04/106 баримт бичгийн хавсралт 2 дахь хуудас

20 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2007-2016 он

Он	Үүнээс														
	Өмнөх үлдэгдэл гомдол, мэдээлэл	Нийт шалгасан гомдол, мэдээлэл	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг			Өмчлөх эрхийн эсрэг						Танхайрсан	Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг	Байгаль хамгаалах журмын эсрэг	Бусад
			Хүний амь нас хохирсон	Бусдын бие махбодид гэмтэл учруулсан	Хүчиндсэн	Бусдын эд хөрөнгө хулгайлсан	Иргэдийн өмчийн хулгай	Малын хулгай	Булаасан	Дээрэмдсэн	Залилан мэхэлсэн				
2007		1663	14	300	22	629				10		40			238
2008		1900	77	408	24	642				11		31			243
2009		1839	11	475	25	571	185	222	1	5	45	25			304
2010		1784	117	416	24	547	276	223	5	6	57	35	286	14	277
2011	9	3148	118	388	23	453	233	186	2	7	26	238	966	92	835
2012	17	4557	141	377	18	559	130	292	2	5	64	63	1903	71	1354
2013	22	5465	105	379	22	704	110	367	4	4	60	70	2349	127	1641
2014	72	5637	62	360	12	522	120	250	1	3	52	100	2049	70	2406
2015	27	6527	100	378	20	708	185	312	2	5	84	84	2300	75	2771
2016	58	5901	142	453	28	695	349	231	3	9	93	911	1628	138	1801
Нийт	205	38421	887	3934	218	6030	1588	2083	20	65	481	1597	11481	587	11870

3.1. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

Үүнээс хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг сүүлийн 10 жилд 4821 гарснаас 3934 нь бусдын бие махбодид гэмтэл учруулсан, 887 нь хүний амь нас хохироосон гэмт хэрэг гарсан байна. Энэ мөн хугацаанд жилд дунджаар 89 орчим хүнийг санаатай алах хэрэг, 393 бусдын бие махбодид гэмтэл учруулсан хэрэг үйлдэгджээ. Үүнийг он тус бүрээр дараах графикт үзүүлэв. Нийт 10 жилийн хугацаанд хүний амь нас хохироосон хэрэг 91%, бусдын бие махбодид хохирол учруулсан хэрэг 51%-аар тус тус өссөн харагдаж байна[21].

График VIII.18.1. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (сүүлийн 10 жилийн байдлаар)



21 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2007-2016 он

Энэ гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар:

Сүүлийн жилүүдэд санаатай болон болгоомжгүй хүн амины гэмт хэргүүд гарах болсон.

1. Хүнийг санаатай алах гэмт хэрэг гарахад хүргэж байгаа шалтгааныг тодорхойлоход юуны өмнө энэ төрлийн гэмт хэргийн олонх нь яллагдагчийн зан суртахуун ба ууж согтуурах явдалтай шууд холбоотой гарч байгааг дурдах хэрэгтэй юм. Эдгээр хүчин зүйлүүдийн нийлбэр нь хувь хүний зан суртахуун бүрэлдэн тогтоход эсрэгээр нөлөөлж, нийгэмд харш үзэл санаа буй болж иргэдийн амь биеийн эсрэг ноцтой гэмт хэрэг, түүний дотор хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг. Энэ нь танхайн сэдэлтээр болон согтуугаар зодоон хийх, хэрүүл маргаан гаргах, мөн өш хонзонгийн улмаас гарсан хүн амины гэмт хэргүүд бүрэн хамаардаг.
2. Хүнийг санаатай алах гэмт хэрэг гарахад нөлөөлж байгаа нөхцөлүүдийн дотор зарим нэг этгээд үл зохицолдох байдал, зөрчил гаргаж буйг илтэд мэдсээр байгаад орчин тойрны хүмүүс "маргаанд оролцох хэрэггүй", "надад хамаагүй" гэх буюу айж эмээснээс болж ямар нэг хэмжээгээр түүнд нөлөөлж таслан зогсоох талаар арга хэмжээ авахгүй байгаа явдал гол байр эзэлдэг.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

3.2. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөл: Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг сүүлийн 15 жилийн дунджаар, аймгийн хэмжээнд үйлдэгддэг нийт хэрэгт 38-49%-ийн хэлбэлзэлтэй байдгийн 13 орчим хувь нь аймгийн төвд бүртгэгддэг байна. Гэмт хэрэг үүнээс хулгайлах гэмт хэрэг олноор үйлдэгдэж байгаа багуудын нутагт хүн ам, ААН, үйлчилгээний газруудын нягтрал, түр оршин суугчид болон дамжин өнгөрөгчдийн тоо нэмэгдсэн, газар нутгийн хувьд Улаанбаатар хоттой ойрхон, ажилгүйдэл их байгаа зэрэг олон шалтгаан нөхцөлтэйгээр дээрх төрлийн гэмт хэргийг гаралт их байна.

Бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргүүдэд судалгаа хийхэд гэмт этгээдүүд урьдчилан судалгаа хийгч, биечлэн гүйцэтгэгч, тээвэрлэгч, борлуулагч гэх мэтээр бүлэг зохион байгуулалтанд орсон нь зарим хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлаас харагдаж байна. Иргэд, ААН, байгууллагын ажилтнуудын сонор сэрэмжгүй болон хайхрамжгүй, хариуцлагагүй байдлууд ч гэмт хэрэг үйлдэгдэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

График VIII.18.2. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (сүүлийн 10 жилийн дүнгээр)



Иймд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ААН, байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах,
2. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын орон тоо, төсөв, цалин, хүч, хэрэгслийг нэмэгдүүлэх,
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, амьдарч буй орчноо амар тайван байлгахад идэвх санаачилга гаргасан (Ажлын байр, орон сууц бусад объектод гэрэлтүүлэг, дохиолол, камержуулалт) байгууллага, ААН, иргэдийг хөхүүлэн дэмжих,
4. Архи, согтууруулах ундааг худалддаг, үйлчилдэг дэлгүүр, цэнгээний газруудын тоог цөөрүүлэх, тусгай зөвшөөрөл олгохдоо тэдгээрийн байршил, хоорондын зайг зохистой байхаар зохицуулах,
5. Сум багийн нутагт оршин суугчид, шилжилт хөдөлгөөний бүртгэл хаягжуулалтыг тухай бүр байнга хийх,
6. Иргэний эрхийг зөрчихгүйгээр, гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон ял шийтгүүлсэн иргэдийн суурьшил хөдөлгөөнийг хяналтанд бүрэн оруулах, хорих газраас суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд ТББ-ын хүчийг ашиглах боломжийг судалж зохих арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Дээрх гэмт хэргүүдэд холбогдон шалгагдаж байгаа этгээдүүд нь ихэвчлэн малчид, тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж байна. Цаашид бусдын эд хөрөнгийг хулгайлах, тэр дундаа орон байр, авто тээврийн хэрэгсэл, мал хулгайлах, зам тээврийн осол, согтуугаар болон бүлэглэн үйлдсэн гэмт хэргүүд өсөх хандлагатай байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Иргэд, ААН, байгууллагууд өөрсдийн эзэмшлийн өмч хөрөнгөө хараа хяналтгүй орхидог, сонор сэрэмж муутай, ААН, байгууллагууд нь хяналтын камер, дохиололгүй, сахиул, манаачгүй байгаа зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан, нөхцөл болж байна.

Цаашид аливаа иргэд, ААН, байгууллагуудад анхааруулан сэрэмжлүүлэхэд аймаг, орон нутгуудад үйлдэгдэж байгаа хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрсдийнхөө өмч хөрөнгөндөө тавих хяналтыг сайжруулах, хөршийн холбоог бий болгох, байнгын тасралтгүй хараа хяналттай байлгах, хяналтын камер, дохиолол тавих, харуул, хамгаалалтаа сайжруулах гэх зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар өөрт оногдсон үүргээ биелүүлэх шаардлагатай.

3.3. Эдийн засгийн гэмт хэрэг

Тус аймагт тогтмол гарч, бүртгэгддэг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах (Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл), бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (Эрүүгийн хуулийн 150) гэмт хэргүүд нь 2002 оноос тодорхой хэмжээгээр буурч ирсэн боловч сүүлийн 2 жилд энэ төрлийн гэмт хэргийн нийгэмд учруулж байгаа хор хохирол хэдэн зуун тэрбум төгрөгөөр хэмжигдэж, шинэ тутам арга хэрэгслээр үйлдэгдэх болжээ.

Залилан мэхлэх, завших үрэгдүүлэх гэмт хэрэг нь цахим хэлбэрээр бусдыг хуурч мэхлэх, хуурамч гүйлгээ хийх, хуурамч байгууллага бий болгох, гэмт хэргээ далдлахын тулд санаатайгаар болон зохиомлоор дампуурах, сүлжээний бизнес, гоо сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж бусдыг их хэмжээгээр хохироох, бусдын дансыг ашиглах, албан тушаалын (сүүлийн үед банк санхүүгийн салбарт) давуу байдлаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэгдэж байна.

Эдийн засаг, банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд тавих хяналтын сул тал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зохицуулалт, эрх зүйн хэм хэмжээний хийдэл зэрэг нь эдгээр гэмт хэрэг үйлдэгдэх суурь шалтгаан (Хадгаламж зээлийн хоршоодын хэргийг шалгах явцад төрийн байгууллагын хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалт илт дутагдсан байдаг) болж байна. Зар сурталчилгаа, түүний хяналтгүй байдал, иргэдийн аж ахуй, үйлдвэрлэл эрхлэх боломж, эрх зүйн орчин байхгүй зэрэг нь хохирогчдыг энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж хохироход хүргэж байгаа төдийгүй цаашид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл болж байна.

График VIII.18.3.



3.4. Мал хулгайлах гэмт хэрэг

Цагдаагийн байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хуульд заасан үүргээ биелүүлж, энэ төрлийн гэмт хэргийг цаг алдалгүй, шуурхай шалгах үүрэгтэй. Харин нөгөө талаас иргэд, малчид өөрсдийн өмч хөрөнгө, малаа байнгын хараа хяналттай, хариулга маллагаатай байлгаж, урьдчилан сэргийлэх, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүдийн талаар цагдаагийн байгууллагад тухай бүр нь мэдээлэл өгч, хамтран ажиллах нь үүрэгтэй, энэ талаар мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад тодорхой тусгаж, хуульчилж өгсөн байдаг.

График VIII.18.4.




3.5 Хувь хүний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг

"Танхайрах гэмт хэрэг" нь гэмт этгээд олон нийтийг илтэд үл хүндэтгэн, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчихдөө нийгэмд тогтсон эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, уламжлагдан ирсэн зан заншлыг үл тоомсорлон, өөрийн ичгүүр сонжуургүй, догшин зан авир, бүдүүлэг үйлдлээ бусдын анхаарлын төвд байлгахыг эрмэлзэх, ямар ч шалтгаангүй, эсхүл ялимгүй зүйлээр шалтаглан хэрүүл маргаан өдөх, агсам тавих, элдвээр доромжлох, айлган сүрдүүлэх, басамжлах, дарамтлах, хүч хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэх зэрэг үйлдлээр илэрнэ. Харин тодорхой сэдэлттэй, тухайлбал, хувийн таарамжгүй харьцаа, эр эмийн хардлага, хохирогчийн зүй бус ажиллагаа зэргээс үүдэн өөр хоорондоо маргалдсан, зодолдсон, доромжилсон, бие махбодод нь гэмтэл учруулсан нь олон нийтийг илтэд хүндэтгэн үзээгүй буюу нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчөөгүй байвал хүний амь бие, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ[22].

"Хүчиндэх гэмт хэрэг" нь хүний амьдралын нарийн асуудал (интим) хамаарах учраас энэ гэмт хэргийг үүсгэх, хянан шалгахад байцаан шийтгэх ажиллагааны тусгай журам тогтоож, энэ тухай мэдээллийг задруулахгүй байх, хэргийг шүүх хурлаар хаалттай хэлэлцэнэ. Ийм хэргийг зөвхөн хохирогчийн гомдлоор үүсгэх ба талууд эвлэрсэн ч хэргийг хэрэгсэхгүй болгохгүй. Тус гэмт хэрэг нь эмэгтэй хүний хүсэл зоригоос гадуур хурьцал үйлдэх, энэ зорилгодоо хүрэхийн тулд хүч хэрэглэх, заналхийлэх буюу бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж үйлдсэн байдаг. Хурьцал үйлдэж эхэлснээр хүчиндэх үйлдлийг төгссөн хэрэг гэж үздэг. Тухайн гэмт хэргийн объектив талын зайлшгүй элемент нь хурьцал үйлдэх явдал бөгөөд физиологийн хувьд хурьцлыг дуусан, дуусаагүйгээс шалтгаалахгүй хүчиндсэнд тооцно. Ингэхдээ уг этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар хурьцал үйлдэж чадаагүй бол завдсан гэж үздэг[23].

График VIII.18.5. (Сүүлийн 10 жилийн үзүүлэлт)



22 Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, Зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар. Улсын дээд шүүхийн тогтоол. 2007. №41.

23 Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010. 333 дахь тал.

3.6 Нийтээр дагаж мөрдөх журмын эсрэг гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2010-2016 онд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 11487 болон байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 587 бүртгэгдсэн бөгөөд энэ нь жилд дунджаар 1149 болон 59 хэрэг үйлдэгддэг гэсэн дүн гарч байгаа бол жил тус бүрээр нарийвчилсан мэдээг дараах графикаас харна уу. Тус жилүүдэд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг 479, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 439%-аар тус тус нэмэгдсэн байна[24]

График VIII.18.6. (сүүлийн 7 жилийн үзүүлэлт)




Хүснэгт VIII.18.2. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

он	Согтуугаар үйлдэгдсэн	Мансуурсан үед үйлдэгдсэн	Галт зэвсгээр үйлдэгдсэн	Хүүхэд оролцсон	Эмэгтэй хүн оролцсон	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Эрүүгийн хуулийн 36.1				Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг	Аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг
							Бүлэглэн гүйцэтгэсэн	Урьдчилан үгсэж, тохиролцсон бүлэг үйлдсэн	Зохион байгуулалттай бүлэг үйлдсэн	Гэмт бүлэглэл үйлдсэн		
2007	165		5	6	29		142	19				
2008	147		4	2	10	20	138	13	4			
2009	161		7	15	31	13	77	4				
2010	162		6	12	48	5	112				89	
2011	93		5	5	18	1	156	1			76	57
2012	78		3	10	65	1	51	2			57	103
2013	95		1	5	65	4	58	1			65	141
2014	201	1	5	19	82	10	37	3			67	149
2015	181	2	6	28	99	48	52	2			45	129
2016	224	1	6	18	77	43	51	1			28	136
Нийт	1283	3	42	102	447	102	823	45	4		399	579

24 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2007-2016 он

Төв аймгийн эрүүгийн нөхцөл байдлыг 2007-2016 оны хоорондох 10 жилээр товчоолон гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг нь судалж үзвэл, согтуугаар гэмт хэрэг үйлдэх явдал хамгийн түгээмэл тохиолджээ. Нийт хугацаанд 1283 тохиолдолд согтуугаар гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэ нь жилд дунджаар 128 гэсэн үзүүлэлттэй байна. Он тус бүрээр нь авч үзвэл, 2007-2010 онуудад 160 орчим хэрэг согтуугаар үйлдэгдэж байсан бол 2011-2013 онд харьцангуй буурч 88 орчим болсон бөгөөд 2014 оноос эргээд огцом өсч 201 тохиолдол бүртгэгдсэн нь 2016 оны байдлаар 224 гэсэн үзүүлэлттэй байна. Нийт хугацаанд нь авч үзвэл, 2007 оны үеэс 2016 онд 36 орчим хувиар өссөн дүн гарчээ[25]. Судалгаанд хамруулсан хугацааны он тус бүрээр гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг нарийвчлан доорх графикт үзүүллээ.

График VIII.18.7. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (сүүлийн 10 жилийн үзүүлэлт)



Гэмт хэргийг үйлдэхэд:

Хар тамхи мансууруулах бодисын хууль бус наймаа, мөнгө угаах, мөрийтэй тоглоом, оюуны өмчийн хулгай, кибер болон эко терроризм, хүний наймаа, хууль бус цагаачлал, алан хядах ажиллагаа гээд эдгээр төрлийн гэмт хэргийн өсөлт хурдасч, дэлхий нийтийн улс орнуудыг бараг бүхэлд нь хамрах болсон энэ төрлийн гэмт хэрэг тус аймагт төдийлөн бүртгэгдээгүй байгаа хэдий ч дээрх төрлийн гэмт хэргийг гаргуулахгүй байх талаар анхааруулга санамж сэрэмжлүүлгийг тогтмол өгч, хүүхэд залууст энэ төрлийн гэмт хэрэгт өртөхгүй байх талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулахыг зохих шатны бүх төрийн байгууллага хийж байх хэрэгтэй байна.


Хүснэгт VIII.18.3. Гэмт хэрэг үйлдэгсэд (нас, хүйс) 2010-2016 он.

Он	Бүх хүн	Эмэгтэй	Нас												
			15 хүртэлх	16-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 ба түүнээс
2010	755	49	1	9	174	119	154	120	79	42	32	10	9	5	1
2011	634	50	1	10	154	141	113	70	67	39	19	5	9		6
2012	705	69	5	6	142	121	131	107	80	52	39	16	3	2	1
2013	773	65	13	17	145	159	128	106	88	60	41	10	4		2
2014	858	83	7	16	136	174	169	118	102	52	47	27	8	1	1
2015	884	98	17	16	144	191	149	118	119	72	33	14	5	3	3
2016	817	82	4	15	137	182	141	108	97	64	36	21	9	2	1
Нийт	5426	496	48	89	1032	1087	985	747	632	381	247	103	47	13	15

25 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2007-2016 он

Өөр нэг анхаарал татаж буй үзүүлэлт бол эмэгтэйчүүдийн гэмт хэрэг үйлдсэн байдал юм. Тухайлбал, 2010-2015 онуудад Төв аймагт гэмт хэрэг үйлдэгсдийн 10 орчим хувь буюу 496 тохиолдолд эмэгтэй хүн байжээ. Энэ нь уг 7 жилийн хугацаанд 67%-аар өссөн дүн болж байна[26]. Он тус бүрээр дараах графикаас үзнэ үү.


График VIII.18.8.



Гэмт хэрэг үйлдэгч эмэгтэй. (сүүлийн 7 жилийн дүнгээр)

Мөн төв аймгийн эрүүгийн нөхцөл байдлыг 2007-2016 оны хоорондох 10 жилээр товчоолон гэмт хэрэг үйлдэгчдийг насны байдлаар нь бүлэглэн авч үзвэл 18-34 насныхан хамгийн ихээр гэмт хэрэгт холбогдож хэрэг үйлдсэн болох нь анхаарал татахуйц байна. Тухайлбал, 25-29 насныхан 1084 буюу 20%, 18-24 насныхан 1032 буюу 19%, 30-34 насны залуус 985 буюу 18%-ийг тус тус хамгийн их үзүүлэлттэйгээр эхний гурван бүлгийг эзэлжээ. Тэгвэл мөн л дараагийн байруудыг идэр насны залуус буюу 35-39 насныхан 747 байна. Үүнийг он тус бүрээр дараах графикт үзүүлэв.

График VIII.18.9. Гэмт хэрэг үйлдэгчийн нас. (сүүлийн 7 жилийн үзүүлэлт)



26 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2010-2015 он.

Дээрх судалгаанаас хархад 18-34 насны залуучууд гэмт хэрэгт холбогдох нь харьцангуй өндөр байлаа. Тэгвэл 2016 оны 12 дугаар сард Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 974 болж, 2015 оны мөн үеэс 125 хүнээр, өмнөх сарынхаас 206 хүнээр тус тус өсчээ.

Ажилгүйчүүдийн 45.79% буюу 446 нь эмэгтэйчүүд байна. 12 дугаар сард аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 25.87% нь Зуунмод суманд; 9.65% нь Баянцогт суманд; 9.55% нь Угтаал суманд; 8.73% нь Баянжаргалан суманд бүртгэлтэй байна.

Тухайн сард бүртгүүлсэн 380 ажилгүй иргэний 23.16% нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 16.05% нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 12.63% нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 9.74% нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 6.84 хувь нь орон тооны цомхтголоор; 6.32% нь шилжин суурьшсан; 1.84% нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 1.58% нь цэргээс халагдсан; 0.79% нь байгууллага татан буугдсан; 0.79% нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0.53 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 19.74% нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд дунджаар 173 ажилгүйчүүд ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 24 хүнээр их байна. Ажилгүй иргэдийн тоо нэмэгдэж байгаа нь гэмт хэргийн гаралтанд нөлөөлж байгааг дараах судалгаа харуулж байна.


Хүснэгт VIII.18.4. Гэмт хэрэг үйлдэгсэд (нийгмийн байдал) 2010-2016 он.

Он	Нийгмийн байдал											
	Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувираа хөдөлмөр эрхлэгч	Ажилчин, малчин	Оюутан	Сурагч	Хугацаат цэргийн алба хаагч	Сургууль завсардсан хүүхэд	Тэнэмэл	Хоригдол	Ажилгүй
2010	30	40	8	68	134	6	14	1		2	4	448
2011	21	27	6	49	208	17	10				3	293
2012	47	32	21	101	173	6	4			4	10	307
2013	44	39	32	101	178	13	25	2		1	4	334
2014	41	32	21	113	156	10	18	1	1	2	5	458
2015	48	65	19	136	169	20	26		1	5	3	392
2016	32	52	26	149	142	22	12	1		8	1	372
Нийт	**263**	**287**	**133**	**717**	**1160**	**94**	**109**	**5**	**2**	**22**	**30**	2604

Улмаар төв аймгийн эрүүгийн нөхцөл байдлыг 2010-2016 оны хоорондох 10 жилээр товчоолон гэмт хэрэг үйлдэгсдийн нийгмийн байдлыг нь судлан үзвэл ажилгүй 2604, ажилчин, малчин 1160 тохиолдол бүртгүүлж тус тус хамгийн их үзүүлэлттэй байна. Тэгвэл хувираа хөдөлмөр эрхлэгч 717, төрийн албан хаагч 263, хувийн хэвшилд ажиллагч 287 гэх мэтээр тус тус дараагийн байруудыг эзэлж байна[27]. Судалгаанд хамруулсан хугацааны он тус бүрээр гэмт хэрэг үйлдэгсдийн нийгмийн байдлыг нарийвчлан доорх графикт үзүүллээ.

27 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2010-2016 он.

График VIII.18.10. Гэмт хэрэг үйлдэгчийн нийгмийн байдал. (сүүлийн 7 жилийн үзүүлэлт)



Ажилгүй иргэдийн гэмт хэрэг үйлдэж буй үзүүлэлт маш өндөр байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт болж байна. Хэдийгээр 2016 оны байдлаар 2010 оны үзүүлэлтээс 20 орчим хувиар буурсан боловч нийт судалгаанд хамрагдсан хугацаанд жилд дунджаар 372 ажилгүй иргэн гэмт хэрэг үйлдэж байгаа нь хамгийн ойрын үзүүлэлт бүхий нийгмийн бүлэг болох ажилчин малчдаас даруй 2.2 дахин их үзүүлэлт болж байна[28].

График VIII.18.11. Гэмт хэрэг үйлдэгчийн нийгмийн байдал. (сүүлийн 7 жилийн дүн)



28 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2010-2016 он

Гэмт хэрэг үйлдэгчдийн боловсролын байдлыг 2010-2016 оны нийт үзүүлэлтээр авч үзвэл хамгийн их нь 2210 буюу 37%-ийг бүрэн дунд, 1523 буюу 24%-ийг суурь боловсролтой иргэд үйлдсэн байна. Мөн бага боловсролтой 584 буюу 17%, боловсролгүй 269 буюу 9%, тусгай мэргэжлийн дунд 165 буюу 2%-ийг тус тус эзэлж байгаа бол анхаарал татаж буй нэг үзүүлэлт нь гэмт хэрэг үйлдэгсдийг 11% буюу 671 хүн дээд боловсролтой байгааг үзэж болно[29]. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэхэд тухайн гэмт хэрэгтний боловсролын түвшин төдийлөн шууд хамааралгүй нь эндээс ажиглагдаж байна.

График VIII.18.12. Гэмт хэрэг үйлдэгчийн боловсрол. (сүүлийн 7 жилийн дүн)




Төв аймгийн боловсролын нөхцөл байдлыг 2010 онтой харьцуулахад 2016 онд 44,2%-аар боловсролгүй иргэдийн буурсан үзүүлэлттэй байна. Мөн дээд боловсрол эзэмшсэн 2010 онд 83 иргэн байсан бол 2016 онд 117 болж өссөн байна.

Хүснэгт VIII.18.5. Гэмт хэрэг үйлдэгсэд (боловсрол) 2010-2016 он.

Он	Боловсрол						
	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
2010	70	124	180	282	2	14	83
2011	37	67	162	267	1	28	72
2012	24	62	250	259		20	90
2013	29	74	253	278		27	112
2014	39	84	233	379	1	30	92
2015	39	97	242	380		21	105
2016	31	76	203	365		25	117
Нийт	269	584	1523	2210	4	165	671

29 Цагдаагийн Ерөнхий Газрын гэмт хэргийн дүн мэдээ төв аймгийн үзүүлэлт 2010-2016 он

Зураг VIII.18.1. Нэг хүнд ноогдох гэмт хэргийн тоог газрын зургаар харуулвал



ДӨРӨВ. ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Шүүх байгууллагын мэдээгээр 2016 онд 400 эрүүгийн гэмт хэргээр 291 хүн ял шийтгүүлсний 17.59% нь хулгайлах, 16.83% нь зам тээврийн осол, 6.03% нь танхайрах, дээрэмдэх, 1.51% нь хүнд гэмтээх, 1.51% нь хүнийг санаатай алах, 55.28% нь бусад хэрэг эзлэв. Эдгээр таслан шийдвэрлүүлсэн бүх хүний 75.60% нь хорих, 23.02% нь хорихоос бусад ялаар шийтгүүлжээ. Гэмт хэргийн улмаас 27 хүн нас барж, 626.8 сая ₮-ийн хохирол учирсан нь тогтоогдлоо. Иргэний 1317 хэрэг шийдвэрлэв. Давж заалдах шатны шүүхээр эрүүгийн 50, иргэний 30, хяналтын шатны шүүхээр эрүүгийн 14, иргэний 8 хэргийг тус бүр хянан шийдвэрлэжээ[30].

30 Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2016/12 52 дэх тал.

Зураг VIII.18.2.



Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2016 онд өнгөрсөн онтой харьцуулвал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 129 тохиолдлоор буюу 47.6%-аар, ял шийтгүүлэгчдийн тоо 41 буюу 16.4%-аар тус тус өссөн дүнтэй байна.

Хүснэгт VIII.18.6. Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо[31]

Шүүх	Хэргийн тоо		Өсөлт бууралт		Ял шийтгүүлэгчдийн тоо		Өсөлт бууралт	
	2015 он	2016 он	Тоо	Хувь	2015 он	2016 он	Тоо	Хувь
Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	271	400	129	47.6	250	291	41	16.4
Улсын хэмжээнд нийт	6756	5762	994	-14.7	7696	6566	1130	-14.7

2002 оноос 2015 онуудад анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг дэлгэрэнгүй авч үзвэл доорх дүр зураг гарч байна.

Хүснэгт VIII.18.7. 2002- 2015 онуудад анхан шатны журмаар шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг (Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх)[32]

Шүүх	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо														
	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	Бүгд
Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	320	194	251	207	161	200	222	181	170	213	245	270	168	271	3073
Улсын хэмжээнд нийт	9183	5874	6272	6966	5558	5831	5812	5407	5460	5877	6161	6169	6375	6756	87701

Нийт эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2002 оноос 2015 онуудад шүүх хуралдаанаар нийт 87701 хэрэг хянан шийдвэрлэсэн бол Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 3073 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Орон нутгийн анхан шатны шүүхээр 2015 онд шийдвэрлэсэн хэргийг 2002 онтой харьцуулан үзвэл нийт аймгуудаар буурсан үзүүлэлттэй байна.

31 Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан. ШЕЗ, ШСМСХ . http://www.judinstitute.mn/
32 Эрүүгийн шүүн таслах ажиллагааны судалгаа 2002-2015. Монголын шүүх II. Улаанбаатар 2016.

Тухайлбал Архангай аймгийн шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 37 хэрэг буюу 21.1%, Баян-Өлгий аймаг 54 хэрэг буюу 40.3%, Баянхонгор аймаг 91 хэрэг буюу 35.0%, Булган аймаг 110 хэрэг буюу 44.7%, Говь-Алтай аймаг 90 хэрэг буюу 54.2% тус тус буурчээ.

Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 онд 49 хэрэг хянан шийдвэрлэсэн нь 2002 онтой харьцуулахад 15.3%-аар буурсан үзүүлэлт болж байна.

Хүснэгт VIII.18.8. Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн жилд дунджаар шийдвэрлэж байгаа эрүүгийн хэрэг

Шүүх	2002-2015 онд нийт шийдвэрлэсэн хэрэг	Нийт хэрэгт эзлэх хувь	жилд дунджаар
Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	3073	3.5	220
Улсын хэмжээнд нийт	87701	100	

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2002 оноос 2015 онуудад 21 аймгийн хэмжээнд шийдвэрлэсэн нийт 87701 хэргийн 49490 хэргийг буюу 56.4%-ийг шийдвэрлэжээ. Тухайн жилүүдэд орон нутгийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг нийт хэрэгт харьцуулан үзвэл:

- хамгийн их буюу 5.9- 4.7%-ийг Сэлэнгэ, Дархан-Уул;
- хамгийн бага буюу 0.9%-ийг Говьсүмбэр аймгийн шүүхүүд тус тус эзэлж байна.

Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх энэ хугацаанд 3073 хэрэг шийдвэрлэж байсан нь нийт улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэргийн 3.5%-ийг эзэлж байсан бөгөөд жилд дунджаар 220 хэрэг ногдож байна.

Дээрх үзүүлэлт нь Эрүүгийн хэрэг хамгийн өндөр гаралттай аймгуудын дотор Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь аймгуудын дараа дөрөвдүгээрт орох үзүүлэлт болж байна.

Хүснэгт VIII.18.9. 2002 оноос 2015 онуудад хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт холбогдсон ял шийтгүүлэгчдийг шүүх тус бүрээр нь үзүүлвэл:

	Шүүхээр ял шийтгүүлэгчдийн тоо														
	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	Бүгд
Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	427	254	383	293	242	295	305	232	215	291	341	343	184	250	4055
Улсын хэмжээнд	13007	9029	9473	10153	7792	8463	8495	7513	7292	8210	8324	8065	8178	7696	121690

Анхан шатны шүүхээр 2002 оноос 2015 онуудад гэмт хэрэгт холбогдож ял шийтгүүлсэн нийт 121960 хүний 52930 хүн буюу 43.5% нь нийслэлийн эрүүгийн хэргийн шүүх, 68760 хүн буюу 56.5% нь орон нутгийн эрүүгийн хэргийн шүүхээр тус тус ял шийтгүүлжээ.

Орон нутгийн анхан шатны шүүхээр 2015 онд ял шийтгүүлэгчдийн тоог 2002 онтой харьцуулан үзвэл нийт аймгуудаар буурсан байна.

Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2015 онд 250 хүн ял шийтгүүлсэн нь 2002 онтой харьцуулахад 177 ял шийтгүүлэгч буюу 41.4%-аар буурчээ.

2002 оноос 2015 онуудад Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийтгүүлсэн ял шийтгүүлэгчид нь нийт ял шийтгүүлэгчдийн 33%-ийг эзэлж байна.

Хүснэгт VIII.18.10. Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр ял шийтгүүлэгчдийн нийт улсын хэмжээний ял шийтгүүлэгчид эзлэх хувь

Шүүх	2002-2015 онд шийтгүүлсэн нийт ял шийтгүүлэгч	Нийт ял шийтгүүлэгчид эзлэх хувь	Жилд дунджаар
Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	4055	3.3	290
Улсын хэмжээнд нийт	121690	100	

Орон нутгийн анхан шатны шүүхээр ял шийтгүүлэгчдийг нийт ял шийтгүүлэгчдэд харьцуулан үзвэл:

- хамгийн их буюу 6.1- 5%-ийг Сэлэнгэ, Дархан-Уул;
- хамгийн бага буюу 0.8%-ийг Говьсүмбэр аймгийн шүүхээр ял шийтгүүлэгч тус тус эзэлж байна.

Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс энэ хугацаанд 4055 хүн ял шийтгүүлсэн нь нийт улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэргийн 3.3%-ийг эзэлж байсан бөгөөд жилд дунджаар 290 хүн ял шийтгүүлжээ.

Энэ нь 2002 оноос 2015 онуудад буюу сүүлийн 14 жилийн байдлаар ял шүийтгүүлэгчдийн тоогоор Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь, аймгуудын дараагаар дөрөвдүгээрт орох үзүүлэлтт болж байна.

ТАВ. ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛСОН ТАНИЛЦУУЛГА

Тус аймгийн нутаг дэвгэрийн онцлог:

Тус аймаг нь газар нутгийн онцлог, хүн амын суурьшил, улсын чанартай авто зам, төмөр зам өргөн хөгжсөн, улсын чанартай бүтээн байгууллалтын ажил ихээр явагддаг үүнийг дагаад хүн амын төвлөрөл нэмэгддэг, отор нүүдэл ихтэй, зэрэг олон шалтгаан нөхцөлөөс шалтгаалан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал сүүлийн жилүүдэд хүндэрч байна.

Төв аймгийн сумд нь Улаанбаатар хоттой хил залгаа оршдог бөгөөд Хэнтий, Дундговь, Булган, Сэлэнгэ, Увс, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Завхан, Хөвсгөл зэрэг аймгуудыг чиглэсэн төв зам дайран өнгөрдөг онцлог бүс нутаг юм.

Төв аймгийн хэмжээнд бүртгэгдсэн захиргааны зерчлийн шинжтэй мэдээллийн талаар: Төв аймаг дахь Цагдаагийн газарт 2016 онд нийт 5901 гомдол, мэдээлэл, захиргааны зөрчлийн шинжтэй дуудлага мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн.

Үүнээс 2703 буюу 45,8%-ийг зөрчлийн шинжтэй мэдээлэл эзэлж байгаа юм.

5.1. Буртгэгдсэн захиргааны зөрчил:

Тус аймагт 2016 онд нийт 28266 (давхардсан тоогоор) захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5233 буюу 22,7%-аар өссөн.

- Зөрчил гаргасан 27431 иргэн, 1 ААН, байгууллагад 1,075427,3 (нэг тэр бум далан таван сая дөрвөн зуун хорин долоон мянга гурван зуун) төгрөгөөр торгох;
- 733 хүнд торгож, тээврийн хэрэгсэл жолоодож эрхийг хассан;
- 101 хүнд баривчлах;
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 1060 хүн

саатуулагдсанаас тэдний 43 буюу 4.1% нь эмэгтэй, 4 буюу 0.4% нь 18 хүртэлх насны хүмүүс байна[33].

Хүснэгт VIII.18.11. Захиргааны зөрчил 2007-2016 он.

Он	Захиргааны зөрчил						
	Захиргааны эрх зүйн зөрчил	Иргэн	Албан тушаалтан	Байгууллага, аж ахуйн нэгж	Торгуулийн хэмжээ /мян.төг/	Тээврийн эрх жолоодох эрх	Баривчлах
2007	11552						
2008	7777	4771	16	2	12995.0		
2009	19635	19431	29	25	52514.4		
2010	8645	7845			35952.2		
2011							
2012	15333	22006	1		120929.8	657	323
2013	22987	23619	2	1	137693.9	821	392
2014	24835	23079		1	144547.4	693	290
2015	23033	21572	2	1	270963.7	745	432
2016	28266	27431		1	903280.7	733	101
нийт	**162063**	**126135**	**50**	**31**	**1678877.1**	**3649**	1568

2016 онд аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа зөрчлийн дийлэнх хувийг танхайрах (Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21-р зүйл) зөрчлөөр 2314 иргэнийг 11,594,0 сая төгрөгөөр, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн (Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30-2-1) 478 иргэнийг 2.477.0 төгрөгөөр, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлээгүй эсэргүүцсэн зөрчил, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн зөрчил, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг зөрчсөн зөрчлүүд тус тус эзэлж байна. Зөрчлийн гаралтыг бууруулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг тодорхой цаг хугацаанд шат дараатайгаар тус тус зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Зөрчлийн гаралтыг бууруулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг тодорхой цаг хугацаанд шат дараатайгаар тус тус зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан.

Хүснэгт VIII.18.12. Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Гараг	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2015	2016	
Даваа	3957	4021	1.6 % өссөн
Мягмар	3485	4363	20.1% өссөн
Лхагва	3456	4078	15.3 % өссөн
Пүрэв	3460	4325	20.0% өссөн
Баасан	2809	4311	34.8 % өссөн
Бямба	2333	3503	33.4 % өссөн
Ням	3533	3665	3,6 % өссөн

33 Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төв "Монгол улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал" 2017 он. 45 дахь тал

5.2. Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийн мэдээ

Цагдаагийн газарт ТХХАБАЖЭсрэг осол, хэргийн 453 гомдол, мэдээлэл хүлээн авч, 100 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 348 гомдол, мэдээллийг эрүүгийн үүсгэхээс татгалзах саналтай шийдвэрлэж прокурорын хяналтанд шилжүүлж ажилласан байна. Осол хэргийн улмаас нийт 55 хүн нас барж үүнээс явган зорчигч 5, зорчигч 32, жолооч 18 өртсөн байна. Нийт гэмтсэн хүн 292 үүнээс явган зорчигч 27, зорчигч 194, жолооч 70, унадаг дугуйтай хүн 1 тус тус хүнд болон хөнгөн гэмтэл авсан байна.

5.3. Зам тээврийн осол болсон шалтгаан:

Согтууруулах ундааны зүйл хэргэлсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 34 осол, орон нутагын замд хурд хэтрүүлсэн 59, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон 41, жолооч анхаарал болгоомжгүй 121, зогсоох арга хэмжээ аваагүй 129, уулзвар гарц нэвтрэх 9, эргэх үйлдэл хийх 2, гүйцэж түрүүлэх үйлдэл хийх 8, эсрэг урсгалд орох 15, хүн ба ачаа тээвэрлэх 2, ухрах үйлдэл 4, осол гаргаад хэргийн газраас зугтаасан 13 байна.

5.4. Замын нөхцөл байдлаас:

Замын эвдрэл гэмтлээс шалтгаалсан осол 43, халтиргаа гулгаанаас шалтгаалсан 26 осол, хэрэг бүртгэгдсэн байна.

5.5. Зам тээврийн хэрэг, ослын гарч байгаа хэлбэр:

Онхолдох 138, Мөргөлдөх 199, Явган зорчигч мөргөсөн 37, Дугуй болон морьтой хүн мөргөсөн 2, үл хөдлөх зүйл мөргөсөн 16, зорчигч унагасан 1, мал, амьтан дайрсан 60 бүртгэгдсэн байна.

5.6. Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл:

Суудлын автомашин 529, Ачааны автомашин 68, Автобус, микроавтобус 8, Механизм 3, Мотоцикль 29, Унадаг дугуй болон бусад 2 бүртгэгдсэн байна.

5.7. Зам тээврийн осол гарсан гараг:

Даваа 68, Мягмар 64, Лхагва 66, Пүрэв 66, Баасан 65, Бямба 61, Ням 64 тус тус осол шарсан байна.

5.8. Зам тээврийн осол гарсан цаг:

01 цагт 17, 02 цагт 17, 03 цагт 22, 04 цагт 19, 05 цагт 22, 06 цагт 21, 07 цагт 17, 08 цагт 24, 09 цагт 24, 10 цагт 20, 11 цагт 24, 12 цагт 24, 13 цагт 22, 14 цагт 17, 15 цагт 16, 16 цагт 19, 17 цагт 20, 18 цагт 16, 19 цагт 18, 20 цагт 16, 21 цагт 20, 22 цагт 18, 23 цагт 12,00 цагт 9 тус тус бүртгэгдсэн байна[34].

Дээрх осол, хэргийн нөхцөл байдал, шалтгаан, хүчин зүйлийг судалж үзэхэд орон нутгийн замд жолооч нар замын хөдөлгөөний дүрэмд заагдсан хурдыг хэтрүүлэн, анхаарал болгоомжгүй, хамгаалах бүс хэргэлдэггүй хөдөлгөөнд оролцож зам тээврийн осол, хэрэгт холбогдож байна.

34 Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийн мэдээ боловсруулсан. ХЭЗХ-н мэргэжилтэн Л.Цэрэнноров хянасан ХЭЗХ-н дарга М.Мэндсүрэн нарын 2016 оны тайлан.

ЗУРГАА. СУМДЫН ГХУСАЗСЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАН ТУСАЛСАН ДҮНГИЙН ТУХАЙ

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор 2016 оны 11 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд 27 сумын ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаанд шалган туслах ажлыг аймгийн зөвлөлийн гишүүдээр ахлуулсан 9 ажлын хэсэг хийж гүйцэтгэжээ.

Сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг 17 бүлэг үзүүлэлтээр дүгнэсэн. Шалгалтаар шаардлага бүрэн хангаж байгаа 3 сум буюу Эрдэнэ, Баянчандмань, Зуунмод сумд 90%-иас дээш буюу "А" үнэлгээ, шаардлага хангаж байгаа 5 сум буюу Аргалант, Архуст, Баянхангай, Мөнгөнморьт, Угтаалцайдам сумд "В" үнэлгээ, шаардлага дунд зэрэг хангаж байгаа 8 сум буюу Баян-Өнжүүл, Баянцогт, Бүрэн, Жаргалант, Лүн, Сүмбэр, Өндөрширээт, Эрдэнэсант сумд "С" үнэлгээ, шаардлага хангахгүй сум буюу Алтанбулаг, Батсүмбэр, Баянжаргалан, Борнуур сумд "О" үнэлгээ, "Р" үнэлгээтэй дүгнэгдсэн 7 сум буюу Баян, Баяндэлгэр, Баянцагаан, Дэлгэрхаан, Заамар, Сэргэлэн, Цээл сум байна. Сумдын дундаж үнэлгээний хувь 69.88%-тай дүгнэгдсэн байна.

6.1. Сумдын ГХУСАЗСЗ-үүдийн үйл ажиллагааны дүнг харьцуулсан байдал

Хүснэгт VIII.18.13. (2009-2016 он)

Сумдын нэр	2009 он үзлэгийн дүн	2010 оны үзлэгийн дүн	2011 оны үзлэгийн дүн	2012 оны үзлэгийн дүн	2013 оны үзлэгийн дүн	2015 оны үзлэгийн дүн	2016 оны үзлэгийн дүн
Алтанбулаг	73,3%	80%	80.3%	91%	90%	96.4%	68.29%
Аргалант	93%	92%	86%	95,45%	73%	95%	85.7%
Архуст	60%	90%	90%	60,97%	96%	84.4%	80.23%
Батсүмбэр	71,1%	72%	86.6%	70.23%	77%	64%	62.9%
Баян	73,3%	90%	78%	71,59%	48%	69%	35.2%
Баяндэлгэр	77,5%	80%	73%	82,45%	80%	83%	54.11%
Баянжаргалан	86,6%	88%	68%	64.18%	75%	83%	65.52%
Баянцагаан	71,1%	54%	84.4%	67,5%	79%	81%	49.7%
Баянхангай	76,2%	80%	76%	73,2%	67%	98%	85.58%
Баянөнжүүл	70%	66%	66%	70%	73%	80%	74.0%
Баянцогт	75,5%	88%	80%	61,82%	90%	65.92%	77.87%
Баянчандмань	75%	90%	88%	90,72%	98%	82.8%	92.64%
Борнуур	73,3%	74%	75.5%	71,1%	80%	86%	62.07%
Бүрэн	73,3%	80%	50.6%	38,1%	79%	84%	72.43%
Дэлгэрхаан	70%	82%	84.4%	70%	53%	81.6%	58.5%
Заамар	85,7%	62%	86%	80%	84%	84%	41.03%
Жаргалант	53,3%	97%	82%	74,29%	91%	40.8%	77.74%
Лүн	77,5%	72,4%	90%	75%	90%	81%	79.78%
Өндөрширээт	71,1%	78%	88%	70%	82%	70.96%	73.23%

Мөнгөнморьт	62,2%	50%	70.4%	77,71%	68%	83%	84.41%
Сэргэлэн	71,1%	70%	70%	93,6%	68%	43%	45.91%
Сүмбэр	51%	98%	86%	67,27%	91%	67%	74.58%
Угтаалцайдам	82,5%	81%	72%	72,22%	64%	84%	81.42%
Цээл	75,7%	79%	82%	84%	82%	74%	43.02%
Эрдэнэ	80%	86%	85.6%	91,54%	72%	90.5%	98.58%
Эрдэнэсант	93%	90%	97%	81%	86%	91.1%	71.54%
Зуунмод	91,1%	90%	96%	88,4%	88%	90%	90.9%
Нийт дүн	74.57%	79.97%	79%	75.30%	78.66%	79.03%	69.88%

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс сумдын зөвлөлийн үйл ажиллагааг тогтоосон үзүүлэлт удирдамжаар шалган дүгнэх замаар орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явц үр дүнд нь түвшин тогтоож ирсэн бөгөөд сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа дунджаар 2012 онд 75.30 хувьтай байсан бол 2016 оны 11 сард 69.88%-тай буюу 5.42 пунктээр буурсан байна.

Энэ нь орон нутагт зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа нь бүрэн тогтмолжоогүй энэ чиглэлд тавих хяналт суларсныг харуулж байна. Сумын зохицуулах зөвлөлийн ажил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, хяналт шалгалт төдийхнөөр хязгаарлагдаж байгаад цаашид онцгой анхаарах нь зүйтэй.

Сумдын ГХУСАЗСЗ дараах нийтлэг дутагдал, зөрчлүүд байна. Үүнд:

1. Сумдын ГХУСАЗЗ нь багийн Засаг дарга, дэд зөвлөлүүд, хэсгийн төлөөлөгч, төсвийн байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангах, үүрэг чиглэл өгөх, гишүүдийг ажил үүргийн хуваарь гаргах, жилийн ажлын төлөвлөгөөг эрчимжүүлэх, сайжруулах, бодит үр дүнтэй ажил зохион байгуулах, сумдын зөвлөл, дэд зөвлөл хурлаа тогтмол зохион байгуулж хэвших, багийн Засаг дарга, дэд зөвлөлд зөвлөгөө, зөвлөмж хүргэх, багийн иргэдэд уулзалт, сургалт, мэдээллийг олон талт хэлбэрээр хүргэж, иргэдийг мэдээллээр хангах ажиллах нь дутагдалтай байна. Үүнд:
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлын чанар, хүртээмжийг улам нэмэгдүүлэх, иргэдэд хуулийг тайлбарлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг сайжруулах, сургалт сурталчилгааны тасралтгүй байдлыг хангах;
3. Хэсгийн төлөөлөгчийг суманд нь тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг хангаж албаны хэрэгцээнд техник хэрэгслээр хангах;
4. ГХУС-х чиглэлээр ажиллаж буй олон нийтийн байгууллагуудын ажилд удирдлага арга зүй болон санхүүгийн, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
5. Сумын ГХУСАЗСЗ-н шийдвэр, энэ чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний болон аймаг, сумын дэд хөтөлбөрүүдэд хувийн хэрэг нээж, хэрэгжилтийг хангах, зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж үнэлэлт, дүгнэлт өгөх, дүгнэлтийг үндэслэн ажлын төлөвлөлтийг хийх, хувийн хэргийг тогтмол баяжуулах;
6. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулах, үр дүнг тооцох;
7. Сумын ГХУСАЗЗ-дээс сумын хэмжээнд үйлажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжүүдийн ажлыг тогтмол хянаж шалгах, зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн үүрэг чиглэл өгөх;
8. Дэд зөвлөлүүдийн ажлыг сайжруулах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, хулгайлах, ялангуяа мал хулгайлах, хар тамхи, мансууруулах бодис,

эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар онцгой анхаарч ажиллах, талаар сумдын дэд зөвлөлүүдийн ажлыг сайжруулах нь зүйтэй байна.

6.2. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2016 онд зохион байгуулсан үйл ажиллагаа

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2016 онд дараах тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн сумдын зохицуулах зөвлөлүүдийг чиглүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төр, захиргаа, хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн зохицуулах зөвлөл 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 бүлэг 43 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлан төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсвийг 39,928,000 (Гучин есөн сая есөн зуун хорин найман мянга)-н төгрөгөөр батлуулж төсвийг төлөвлөгдсөн арга хэмжээнд бүрэн зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн хуралдааныг 4 удаа хуралдуулж, 16 асуудлыг хэлэлцэж 13 тогтоол, 3 тэмдэглэл батлан холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж.

Хуралдаанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, сумдын зохицуулах зөвлөлийн 2015 оны ажил дүгнэсэн дүн, 2015 оны "Архи хэрэглэдэггүй байгууллага өрх", "Тэргүүний хуульч", "Тэргүүний малчдын бүлэг", "Гэмт хэрэг, хэв журмын зөрчилгүй сургууль шалгаруулах тухай", Иргэний зөвлөл, Баян сумын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны мэдээлэл, аймгийн хэмжээнд 2016 оны 1 дүгээр улиралд гарсан гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийн Цагдаагийн газрын техник, тусгай багаж хэрэгслийн тухай, "Зам" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай мэдээлэл, Хууль хяналтын байгууллагуудын өргөтгөсөн зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийг томилох, аймгийн Цагдаагийн газарт "Явуулын пост"-ын автомашинтай болох хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт өөрчлөлт оруулах тухай мэдээллийг хэлэлцэж тогтоол, шийдвэр гаргаж холбогдох сум, байгууллагад хүргүүлж хэрэгжилтийг нь хангуулж ажиллав.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс "Ахмадын хороо", "Оюунлаг өөрчлөлт", "Эмэгтэйчүүдийн зөвлөл" зэрэг ТББ-тай 2016 онд хамтран ажиллах гэрээ байгуулан, үйл ажиллагааг нь дэмжин 4,6 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.

ГХУСАЗСЗ-өөс сургалт сурталчилгааны ажлын тасралтгүй байдлыг хангаж, аймгийн төвд 3 удаагийн нэгдсэн сургалт, уралдаан тэмцээнийг үе шаттайгаар зохион байгууллаа. Тухайлбал:

Аймгийн Засаг даргын А/100 тоот захирамжаар "Авлигаас ангид Төв аймаг" аяныг 3 сарын хугацаатай төрийн бүх шатны байгууллагуудын дунд явуулж, авлигын хор хөнөөл, урьдчилан сэргийлэхэд орон нутгийн захиргаа, төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоо, сайжруулах зорилгоор зохион байгуулсны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо буурч, мэдээллийн ил тод байдал 10.5%-аар ахисан байна.

Авилгаас ангид - Төв аймаг аяныг угтаж аймгийн Засаг даргын А/138 тоот захирамжаар хүүхэд залуус, иргэдийн дунд Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор хөнөөлийг таниулах фото зураг, видео бичлэг, гар зураг"-ийн уралдааныг зарлаж, уралдаанд Алтанбулаг сумаас "Авлигын хор хөнөөл" сэдэвт видео бичлэг, шторк 1-р байр, Борнуур, Баянчандмань, Лүн, Дэлгэрхаан,

Заамар сумдын 7-9-р ангийн 11 хүүхдийн бүтээлээс 1-р байранд Дэлгэрхаан сум, 2-р байранд Баянчандмань сум, 3-р байранд Борнуур, тусгай байрт Лүн, Заамар сумын сурагчдын бүтээл тус тус байр эзэлж АТГ-аас ирүүлсэн ном товхимол, гарын авлага, материалын хамт өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулахад 205.0 төгрөгийг зарцуулсан.

ЕБС-ийн хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор тодорхой сэдвийн хүрээнд "Хуулиа дээдэлье" тэмцээнийг жил бүр зохион байгуулж ирсэн уламжлалтай.

Аймгийн Засаг даргын 2016 оны 11-р сарын 04-ны өдрийн А/614 тоот захирамжаар аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй цэг салбарт аттестатчилал явуулж 585 цэг салбарын 63.5%-ийг үзлэгт хамруулж, 36.41% нь хамрагдаагүй байна. */улирлын, ажиллаагүй, үйл ажиллагаагаа зогсоосон гэх/*

Мөн аймгийн ГХУСАЗЗ-ийн зардлаас 2 сая төгрөгний шатахууны асуудлыг шийдвэрлэн цагдаагийн байгууллагын "Бүс" нэгдсэн арга хэмжээг амжилттай зохион байгуулж үр дүнг тооцон ажиллав.

Тус зөвлөгөөнийг үгтаж цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай нисдэг камер-1 (6.5 сая төгрөг), аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй авто замуудад (хар цэгүүдэд) замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс 'Гэрэлт самбар" (1.6 сая төгрөг)-ыг байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн аймгийн зам засвар арчлалт эрхлэх ААН, байгууллагуудтай хамтран Зуунмод хотын замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохиог ажиллуулах болон замын тэмдэг тэмдэглэгээг шинээр 16-г байрлуулж, хуучирч муудсан 14 тэмдгийг сэргээж зассан зэрэг үр дүнтэй ажлуудыг зохион байгууллаа.

Тус зөвлөгөөний онцлог нь салбар 4 чиглэлээр буюу "Иргэдийн эрүүл мэнд эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн судалгаа, шалтгаан нөхцөл цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн" сэдэвт, "ТХХАБАЖЭсрэг гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал" сэдэвт, "Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг түүний шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт, цаашид анхаарах асуудал" сэдэвт, БХЖЭсрэг гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал" сэдэвт илтгэлүүдийг тавьж, шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн нөхцөл байдал, дүгнэлт, цаашид анхаарах асуудал" сэдвээр мэдээлэл, 27 сумаас 2 сум буюу Баянхангай, Батсүмбэр сумын ГХУСАЗЗ-ийн мэдээлэл, ЦЕГ-ын ЗЦ-ийн алба, МБГ-ын төлөөллийн мэдээлэл зэргийг тус тус танилцуулав.

Зөвлөгөөний 2-р үе шат буюу дээрх 4 чиглэлээр хэлэлцүүлгийг зохион байгуулж хэлэлцүүлгээс нийт 96 санал гарснаас 31 саналыг эрэмбэлэн гаргаж, зөвлөгөөнөөс гарах шийдвэрийн төсөл (Зөвлөмж, уриалга)-д оруулах саналыг нэг бүрчлэн танилцуулж оролцогчид тус бүр дэмжин, шийдвэрийг төслийг баталсан.

Энэхүү зөвлөгөөнийг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 17.400.0 (арван долоон сая дөрвөн зуун мянган) төгрөгийг зарцуулж, аймгийн хууль хяналтын байгууллага болон мэргэжлийн байгууллага бүр идэвх санаачилгатай оролцов.

Цаашид зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж, уриалгыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган үр дүнтэй ажлуудыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн болно.

6.3. Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Гэмт хэргээс урьдчилан ерөнхий арга хэмжээний хүрээнд

6.3.1. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс жил бүр сумдын зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, иргэний зөвлөлийн гишүүдэд зориулсан ээлжит мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулав.

6.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 03-р хуралдаанаар 'Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр" -90%. "Архидалтын эсрэг-Төв аймаг" хөтөлбөр-81.34%, "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр" 82.8%-тай тус тус хэрэгжилтийг гарган танилцуулж. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 06 дугаар тэмдэглэлээр үүрэг чиглэл өгснийг хэрэгжүүлэн ажилсан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Оюунлаг өөрчлөлт" ТББ-д 2016 оны зорилтот үйл ажиллагаанд нь зориулж 2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэв. "Архидалтын эсрэг Төв аймаг" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ГХУСАЗСЗ-тэй хамтын ажиллагааны гэрээний хүрээнд "Оюунлаг өөрчлөлт" ТББ-аас 14 сумын 280 иргэдэд "Архины хор түүнээс урьдчилан сэргийлэх тухай" цуврал ярилцлага, сургалт, түүнчлэн ЕБС-ийн нийт 1330 сурагчдад "Архигүй нийгмийн ирээдүй" сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, олон нийтэд гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг сурталчлан таниулах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран аймгийн төвд сурталчилгааны самбартай болгох ажлыг санаачлан аймгийн ГХУСАЗСЗ-ийн сангаас 629.0 төгрөгийг зарцуулж, 4 сурталчилгааны самбартай болгосон.

Аймгийн ИТХ-ын Ажлын алба, хурлын нутгийн удирдлага, хууль хяналт, гадаад харилцааны хороо, Зуунмод сумын ИТХ-ын Ажлын алба, хууль зүйн хэлтэстэй хамтран аймгийн төвд 03 сард аймгийн төвийн худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн дунд аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох шинэчилсэн журмын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгт 35 иргэн оролцож 5 иргэн 16 санал хэлсэн. 27 сумын хэлэлцүүлэг 03 дугаар сарын 02-ноос 04-ний өдрүүдэд болж хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 925 иргэн, худалдаа үйлчилгээ эрхлэгчид, төрийн байгууллагын албан хаагчид оролцов. Үүнээс хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан 266 иргэн санал, хүсэлт, дүгнэлтээ гаргаж журмын төсөлд тусгасан

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг 27 суманд ажиллаж, аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгосон нийт 585 цэг салбарын үйл ажиллагаанд "Аттестатчилал" явуулаа. Аттестатчиллын дүнгээр аттестатчилалд хамрагдсан 372 цэг салбараас стандартын шаардлага хангаж байгаа нь 8 буюу 1.3% нь 90%-аас дээш , 73 буюу 12.4% нь 80-89%-тай , 123 буюу 21.0% нь 70-79%-тай дүгнэгдэж, бусад 168 нь буюу 28.7% нь 69-оос доош хувьтай дүгнэгдсэн байгаа нь маш хангалтгүй үзүүлэлтийг харуулж байна.

СУМДЫН Г ХУСАЗСЗ-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ (2009-2016 ОН)

6.3.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

"Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг 2015 оны 12-р сарын 22-ны өдөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 92 дугаар тогтоолоор батлаж, 2016 оны А/113 дугаар захирамжаар мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 9 зорилт, 21 арга хэмжээг тусган Засаг даргын зөвлөлийн хурал болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 82.8%-тай хэрэгжсэн байна.

Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэрэг 12 сарын байдлаар 74 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 75 нэгжээр буюу 50,3%-аар буурсан. Мал хулгайлах гэмт хэргийн шинжтэй 213 гомдол мэдээлэл ирснийг зохих журмын дагуу хүлээн авч 34,7%-ийг

нь буюу 74 эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж бүртгэгдэх үедээ сэжигтэн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 64 хэргийн 29 хэргийг илрүүлэн мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 45.3%-тай урьд оны мөн үеэс 16,8%-аар буурсан.

ГХУСАЗСЗ-ийн 2-р хуралдаанаар Цагдаагийн газрын мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, зам тээврийн осол зөрчил, бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 12.5 сая төгрөгний төсөвт өртөгтэй явуулын пост ажиллуулах чиргүүлийн асуудлыг шийдвэрлэж өгсөн.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс жил бүр "Тэргүүний малчдын бүлэг"-ийг 2008 оноос эхлэн шалгаруулж байгаа бөгөөд 2015 онд Баянчандмань сумын Д.Хишгээ ахлагчтай "Сүүн далай" бүлэг, Баянжаргалан сумын Ц.Баянжав ахлагчтай "Хашаат" бүлэг, Аргалан тсумын "Их хангай" бүлэг тус тус шалгарч 1.5 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан 2016 онд 132 малчдын бүлэг ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэргийн гаралт ихтэй Аргалант, Баянчандмань, Баянхангай, Алтанбулаг, Эрдэнэсант зэрэг сумдын малчдын бүлгийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, 22 малчдын бүлгийн 150 гаруй малчин иргэд оролцоно. Мөн Аргалант сумын ЗДТГ-тай хамтран тус сумын улсын тэргүүний "Хашаат" малчдын бүлгийн гишүүдтэй уулзалт, өдөрлөг зохион байгуулж тэдгээрийн сайн туршлага арга барилыг **б**усад малчдын бүлгүүдэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулав. Архуст, Баянжаргалан, Баян суманд шинээр "Малчдын бүлэг, нөхөрлөлийг байгуулан сумын ГХУСАЗСЗ, хэсгийн төлөөлөгчтэй хамтран "Түншлэлийн гэрээ байгуулж, хаягас бүтэн жилээр дүгнэж, зөвлөгөө, зөвлөмж хүргэсэн.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016оны 01сард MYOHT-нийн Цагдаагийн дуудлага студид, Төв аймгийн TB5 телевизэд 15 минутынярилцлага мэдээ, Монголын Үндэсний Радиогийн "Эрэл сурал" нэвтрүүлэгт 15минутынсэрэмжлүүлэг яриа, нөхцөл байдлын мэдээ мэдээлэл, "Өнөөдөр" сонинд орон нутгийн TB5 телевизэд мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар мэдээлэл тогтмол хүргэв.

6.3.4. ТХХАБАЖЭсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг аймаг орон хэмжээнд хэрэгжүүлэх2016-2017 оны 16 заалт бүхий төлөвлөгөө гаргаж, Цагдаагийн зөвлөлийн хурлаар батлуулсан.2015 онд 90%-тай, 2016 онд 91.3 %-тай хэрэгжүүлсэн байна.

онд Зам тээврийн осол хэргийн улмаас 55 хүн нас барж, 292 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс буурсан байна, Нийт 157084 тээврийн хэрэгсэл шалгаж 80591 зөрчил илрүүлэн 337 хүнийг 762615400 төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 813 зөрчил илрүүлж 695жолоочийн эрхийг 6 сараас 2 жилийн хугацаагаар хасч эрхийн үнэмлэхгүй 118-ыг хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн төсвийн 130 сая төгрөгөөр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн Замын цагдаагийн тасагт Hundai Elentra маркийн автомашин-2, Hyundai Rio маркийн автомашин-1 нийт 3 машин, бэлэн бус торгуулийн 30 ширхэг багаж ("CAT" шалгах төхөөрөмж, M-3 ORANGE)-ийг тус тус авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2016 оны 19 дугаар тогтоолоор "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь" сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулахтай холбогдуулан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж "Нисдэг камер"-ыг 6.5 сая, осол, хэрэг гарч болзошгүй хар цэгт "Гэрэлт самбар"-ыг байрлуулав. Мөн Баянчандмань сум нь орон нутгийн төсвөөс 9 сая төгрөгийг ГХУС-х ажилд дэмжлэг үзүүлэн гэмт хэрэг гарч болзошгүй 11 цэгт хяналтын 11 камерыг байрлуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн төрийн байгууллага, зам засвар арчлалт эрхлэх ААН, байгууллагуудтай

хамтран замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, хайс хашлага, замын зорчих хэсгийг сайжруулах чиглэлээр замын тэмдэг тэмдэглэгээг шинээр 16 байрлуулж, хуучирч муудсан 14 тэмдгийг сэргээж, гэрэл дохио, чиглүүлэх хэрэгслийг MNS 4596-2014 стандартын дагуу тавьж, байрлууллаа.

Мөн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор Замын хөдөлгөөний цагаан толгой-2016 тэмцээнийг Зуунмод суманд зохион явуулахад Лүн сумын цэцэрлэг, Борнуур сумын цэцэрлэг, Заамар сумын "Шижир алт" цэцэрлэг, Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг, Сувилгаа чийрэгжүүлэлтийн цэцэрлэг, Бүжинхэн цогцолбор цэцэрлэг, Ирээдүй цэцэрлэг, Унагалдайн андууд цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг гээд нийт 9-н багийн 108 цэцэрлэгийн насны хүүхдүүд, 18 багш, 18 эцэг, эхийн зөвлөлийн гишүүд оролцож "Ногоон гэрэл цагаан шугам" тэмцээнд тэргүүн байранд 5-р сургууль, 2-р байранд "Хүмүүн" бага сургууль тус тус байр эзэлсэн. Мөн Дэлхийн дахинд "Зам тээврийн осолд өртсөн" иргэдэд хүндэтгэл үзүүлэх өдөрлөгийн үеэр аймгийн улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран анхны тусламж үзүүлэх хичээл сургалтыг иргэдийн дунд зохион байгуулсан.

Замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын мэдлэгийг дээшлүүлэх үзүүлэх сургалтыг аймгийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэнтэй хамтарч такси үйлчилгээнд явдаг нийт 110 жолооч нарт зохион байгууллаа.

Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас 2016 онд аймгийн нутаг дэвсгэр дээр орших улсын чанартай хатуу хучилттай зам дээр гарч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоо "Сар шинэ", "Хальтиргаа гулгаа-1, "Нийтийн тээвэр", "Замын хяналт", "Согтуу", "Согтуу-1", "Бүрэн бус техник-1 зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, "ХӨДӨЛГӨӨНИЙ СОЁЛ - БИДНИЙ ОРОЛЦОО", "ОСОЛГҮЙ ЖОЛООЧ-ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ" сэдэвт аян зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд www.stop.mn, tuv.police.gov.mn, "Төв аймаг дахь Замын цагдаагийн тасаг" цахим хуудсаар, аймгийн замын цагдаагийн тасаг, Баянчандмань замын цагдаагийн хэсэг, Лүн лүн гэсэн 3 facebook хаягаараа дамжуулан зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажил, цаг агаарын нөхцөл байдал, нутаг дэвсгэртээ зохион байгуулж байгаа арга хэмжээнүүдийг тогтмол танилцуулж "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль"-ийг иргэдэд сурталчлах зорилгоор Засаг даргын нөөц сангаас 300.0 төгрөгөөр 3 төрлийн видео шторкийг гарган, орон нутгийн "TBS" телевизээр 7 хоног бүр өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлэн, олон нийтэд сурталчлав.

6.3.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хүрээнд:

Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх 2016 оны төлөвлөгөөг 5 зорилт 19 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлан хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд 27 сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар, "Дэлхийн Зөн" Олон улсын байгууллагын Төв орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, ХЭҮК, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Хүүхдийн эрхийн үндэсний төв, "Монгол өрх" нийгэмлэг, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, "Хөөрхөн зүрх" ТББ, "Гэрэл төв" ТББ, ХБИ-ийн холбоо зэрэг төрийн болон ТББ-тай хамтран гэр бүл, хүүхдэд чиглэсэн нийт 16 удаагийн сургалт, 2 удаагийн сарын аян, 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 7000 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн.

Аймгийн Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 170 дуудлага

мэдээлэл хүлээн авсан. Үүнээс 109 иргэнийг саатуулах байранд эрүүлжүүлж, 35 иргэнийг 7- 30 хоногийн хугацаагаар баривчилна, 144 иргэнийг 1,668,350 төгрөгөөр торгосон. Гэмт хэргийн шинжтэй гэр бүлийн хүчирхийллийн нийт 26 гомдол, мэдээлэл хүлээн авч 21 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн дугаар авсан нь урьд оны мөн үеэс 3 нэгжээр буюу 24.0 хувиар өссөн, 5 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлэн шийдвэрлэсэн нь урьд онтой ижил хувьтай байна.

6.3.6. БХЖЭсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2016 онд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 20 бүртгэгдэж, илрүүлэлт 75%-тай байна. Уул уурхайн чиглэлээр сүүлийн 6 жилд 42 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа 247 ААН, 48 иргэд, иргэдийн нөхөрлөл хамрагдаж нийт 71 төрлийн 535 зөрчил илрүүлсэн. Нийт илэрсэн зөрчлийн 75 зөрчил буюу 14%-ийг газар дээр нь арилгуулж, 420 зөрчил буюу 78,5%-ийг улсын байцаагчийн актаар зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, хугацаатай үүрэг даалгавар өгөх зэрэг арга хэмжээ авч арилгуулж, 40 зөрчил буюу 7,5%-ийг тогтоосон хугацаанд арилгаагүйн улмаас 50,3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ, 9,4 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьж ажилласан байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан "Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам", байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх талаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран 1 удаа сургалт зохион байгуулж, сургалтанд цагдаагийн 75 алба хаагч хамрагдсан байна. Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 27 сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн TBS телевизээр БХЖЭсрэг гэмт хэрэг, ой, тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 28 удаагийн давтамжтайгаар сэрэмжлүүлэг мэдээг хүргэж, 280 ширхэг анхааруулга, санамжийг иргэдэд тарааж, 3 төрлийн зураг самбарыг гудамж талбай олон нийтийн газарт байрлуулсан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ой хээрийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг 78 ААН, амралтын газруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан мэдэгдэл хүргүүлж үр дүнг тооцон ажилласан. Заамар сум дахь сум дундын цагдаагийн хэлтсээс аймгийн Мэргэжлийн хяналтын газар, БОХУБ нартай хамтран уул чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 24 ААН, байгууллагад давхардсан тоогоор 46 хяналт шалгалтыг зохионбайгуулсан.

ДОЛОО. АЙМГИЙН ШҮҮХТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

"Иргэн ба эрх" хууль сурталчлах аяныг Төв аймгийн 27 сум, 97 багийн хэмжээнд зохион байгуулан 90926 иргэдэд шүүхийн шинэтгэлийг тайлбарлан таниулж, шинээр батлагдсан хууль тогтоомж сурталчлах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн чиглэлээр аймгийн ЗДТГ, Зуунмод сумын ЗДТГ, ГХУСАЗСЗ-тэй хамтран 2016 оны 5 сарын 4-нөөс 6 сарын 5-ныг хүртэл 1 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж, уг аяны үйл ажиллагааг дэмжин нутгийн захиргааны байгууллагаас 5 сая төгрөгийг шийдвэрлэв.

Энэхүү аяны үр дүнд шүүхийн шүүн таслах ажлын төрлөөр дагнаж, мэргэшсэн шүүгчтэй, нээлттэй шүүх болсныг олон нийтэд сурталчлан таниулж, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлснээрээ онцлогтой.

НАЙМ. ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР:

Аймгийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсны үр дүнд 2013 онд 922, 2014 онд 959, 2015 онд 863 гэмт хэрэг гарч өмнөх оныхоос 10%-gap буурсан. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар 786 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой (821) харьцуулахад 35 хэргээр буюу 4.39%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн илрүүлэлт 62.4% ба өмнөх оны мөн үеийн түвшинд байгаа нь жилийн эцсээр гэмт хэргийн гаралт буурч гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэх боломжтойг харуулж байна. Хөнгөн гэмт хэрэг 325, хүндэвтэр гэмт хэрэг 404, хүнд гэмт хэрэг 47, онц хүнд гэмт хэрэг 10 тус тус бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 27,1% буюу 214 хэрэг нь согтуугаар үйлдэгдсэн, 28.5% буюу 224 нь иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 15.3% буюу 120 нь зам тээврийн осол хэрэг, 2.54% буюу 20 нь БХЖЭсрэг гэмт хэрэг, 28,4% буюу 226 өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа ба үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 72 буюу бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 31.8%-ийг, орон байранд нэвтэрч эд зүйл хулгайлах гэмт хэрэг 98 буюу 43.3%-ийг, бусад төрлийн хулгайлах гэмт хэрэг 56 буюу 24.7%-ийг тус тус эзэлж байна.

Мал хулгайлах гэмт хэрэг 74 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 75 нэгжээр буюу 50.3%-аар буурч, илрүүлэлт 45.3%-тай байна. Өмчлөх эрхийн эсрэг хулгайлах гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

УВС АЙМАГ



19. УВС АЙМАГ

1. УВС АЙМГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХҮН АМ ЗҮЙН ОНЦЛОГ

Увс аймаг нь газар нутгийн хувьд 12457 км² газар нутагтай. Улаанбаатар хотоос 1417 км алслагдсан, хойт талаараа ОХУ-ын Тыва улстай 6

сумын нутгаар 575 км, дотооддоо Завхан аймагтай 340 км, Ховд аймагтай 152 км, Баян-Өлгий аймагтай 200 км газраар тус тус хиллэн оршдог.

Увс, Хяргас нуур, түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Хан-Хөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртлэх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан газар зүйн өвөрмөц тогтоцтой. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 758.9 метрт буй Увс нуурын ай савын дархан цаазат газар бөгөөд хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 4250 метрт өргөгдсөн Цагаан дэглий оргил юм.

Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Зун 7 сард +40-50 хэм халж, өвөл 01 сард -40, -50 хэм хүртэл хүйтэрдэг. Увс аймаг нь өндөр уул, ой тайга, өргөн тал, говь олон нуур, гол горхи зэрэг байгаль газар зүйн олон янзын онцлогт тохирсон төрөл бүрийн ургамал, ан амьтан элбэгтэй. Нутгийн 8.2%-ийг уулын ойт хээр, 14.5%-ийг өндөр уулын, 37.7%-ийг хээрийн, 39.6%-ийг говь, цөлийн бүс эзэлдэг. Тус аймаг нь нүүрс, алт, давс зэрэг эрдэс баялагийн нөөц ихтэй, Нүүрст хотгор, Худэн, Хар тарвагатайн чулуун нүүрсний ордууд нь нийт 167.26 сая тн нөөцтэй, жилд 150-200 мянган тн нүүрс олборлох боломжтой.

Улаангомоос Хандгайтын чиглэлд 120 км, Улаангом Наранбулаг Үзүүрийн булгийн чиглэлийн 300 орчим км, аймгийн төвд 29.3 гаруй км хатуу хучилттай замтай.

Харилцаа холбооны хувьд бүх сумуудад гар утасны сүлжээтэй бөгөөд аймгийн төв болон бүх сумууд Засгийн газрын хоорондын гэрээгээр ОХУ-аас татсан цахилгааны эрчим хүчний байнгын эх үүсвэрт бүрэн холбогдсон.

Аймгийн төв нь Улаангом, засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 93 багтай, 2016 оны жил эцсийн байдлаар 21.5 мянган өрх, **81.4** мянган хүн амтай. Хүн ам 2015 оноос хүн амын тоо 1.2 хувиар буюу 0.9 мянган хүнээр өссөн. Хүн амын 37.7% буюу 30.7 мянга нь аймгийн төвд, 20.3 хувь буюу 16.5 мянга нь сумын төвд, 41.9% буюу 34.1 мянга нь хөдөө амьдарч байна[35].

Аймгийн аж үйлдвэрийн голлох салбар нь МАА, газар тариалан бөгөөд хөнгөн, хүнс, худалдаа, үйлчилгээ, уул уурхайн үйлдвэрлэл зохих хэмжээнд хөгжиж байна. 2016 оны эцэст аймгийн хэмжээнд **2784.1** мянган толгой мал тоолуулж, үүний дотор 21.9 мянган тэмээ, 105.7 мянган адуу, 161.0 мянган үхэр, 1376.5 мянган хонь, 1119.0 мянган ямаатай болж, таван төрөлдөө өнгөрсөн оноос 55.0 мянга буюу 2.0%-аар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 57.9 мянган га-д газар тариалан эрхлэх тохиромжтой бөгөөд тариалангийн гол бүс нутаг Баруунтуруун суманд 40.0 мянга орчим га эргэлтийн талбайтай. Аймгийн хэмжээнд 2016 онд нийт 5195.3 га-д үр тариа, үүнээс 4694 га-д улаан буудай, 151 га-д арвай, 340.3 га-д овьёос,10 га-д хөх тариа, 248.6 га-д төмс, 273.2 га-д хүнсний ногоо, тосны ургамал 80 га-д, 1980 га-д тэжээлийн ургамал нийт 7.7 мянган га-д тариалалт хийж, аймгийн хэмжээнд 7930.4 тн үр тариа, 3191.5 тн төмс, 3404.7 тн хүнсний ногоо, 6131 тн тэжээлийн ургамал хураан авсан байна.[36]

35 http://www.uvs.nso.mn
36 http://www.uvs.nso.mn

Тус аймагт нүүрсний 3 орд, алтны 1 орд, барилгын материалын түүхий эдийн 3, давсны чиглэлээр 3 ААН үйл ажиллагаа явуулдагаас гадна хүнс, гурилын үйлдвэр, дулааны болон цахилгаан шугам сүлжээ, нийтийн аж ахуйн үйлчилгээ, худалдаа, хөнгөн үйлдвэрийн газрууд ажилладаг. Чацаргана нь Увс аймгийн брэнд бүтээгдэхүүн бөгөөд улсын хэмжээний нийт чацарганы 60% нь Увс аймагт ургадаг ба эрс тэс цаг агаарын нөхцөлд дасан зохицсон, хүний биед нэн хэрэгцээтэй витаминаар баялаг юм.

Увс аймгийн нутагт ашигт малтмалын 303 орд, илрэлийг тогтоогоод байгаагаас өнөөгийн байдлаар ашиглаж байгаа 9 төрлийн ашигт малтмалын 33 орд, цаашид нарийвчлан судлах 153 орд, илэрц газар байна.


2. УВС АЙМАГ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ

2.1. Гэмт хэргийн хөдөлгөөн

Гэмт хэргийн хөдөлгөөн гэдэг нь тодорхой цаг хугацаанд гэмт хэргийн мөн чанарт гарсан тооны ба чанарын өөрчлөлт. Гэмт хэргийн хөдөлгөөний үзүүлэлт нь гэмт хэргийн үнэмлэхүй өсөлт, бууралтын хэмжээ буюу түвшинг илэрхийлнэ. Увс аймгийн хэмжээнд 2007-2016 онд **3678** гэмт хэрэг бүртгэгдсэн ба жилд дунджаар 368 гэмт хэрэг бүртгэгджээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.59%-ийг эзэлж байна. 2008 онд гэмт хэргийн гаралт өмнөх оноос 27.5%-аар өссөн бол 2016 оны түвшинг 2008 оны түвшинтэй харьцуулахад жилд дунджаар 18 хэргээр буурч иржээ.

VIII.19.1. Увс аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг



Сүүлийн 10 жилд жилд дунджаар 5 хэргээр буурч ирсэн тооцоллоор үзвэл 2017 онд гэмт хэргийн гаралт 317, 2018 онд 313, 2020 онд 303 болж буурах урьдчилсан прогноз байна.

Хүснэгт VIII.19.1. Увс аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг	21268	20704	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167
Увс аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг	363	463	405	389	363	306	334	361	372	322
Эзлэх хувь %	1,71	2,24	1,99	1,96	1,89	1,39	1,32	1,32	1,34	1,19

2.2. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:

Увс аймаг дахь цагдаагийн газар иргэд, ААН, байгууллага гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй **3129** өргөдөл, гомдол, мэдээлэл, дуудлага хүлээн авч шалгаснаас 3108 буюу 99.3%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ. Тухайлвал,

Дээрх шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн 955 нь гэмт хэргийн шинжтэй (334-д эрүүгийн хэрэг үүсгэсэн, 621-д эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн), 1551 нь захиргааны зөрчлийн шинжтэй (228-д нь торгуулийн хуудсаар, 947-д нь шийтгэвэрээр, 38-д баривчлах, 321-д нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 17-г харьяаллын дагуу шилжүүлсэн) гомдол, мэдээлэл байжээ. Харин гомдол, мэдээллийн 26-г газар дээр нь зохицуулж шийдвэрлэсэн, 255-д нь зөвлөгөө өгсөн, 133-д нь саатуулах байранд шилжүүлсэн, 160 нь худал дуудлага, гомдол, мэдээлэл байсан байна.

График VIII.19.2. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт




2.3. Гэмт хэргийн тархалт:

Увс аймагт 2016 онд **322** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны түвшингээс 50 хэрэг буюу 13.4%-аар буурсан байна.

Увс аймагт 2016 онд 81377 хүн ам байгаагаас 16-аас дээш насны 52907 хүн байгаа бөгөөд бусад улс орон, хот, аймагтай жишиж үзэх үзүүлэлт болох 10.000 хүнд ногдох гэмт хэргийн гаралт мөн. Энэ тоо **61** байна.

Увс аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 47.5% нь Улаангом хотод, 6.8% нь Тэс, 5.3% нь Сагил суманд хамгийн ихээр гэмт хэрэг үйлдэгдсэн бол Завхан, Бөхмөрөн, Баруунтуруун сумдад хамгийн бага үйлдэгджээ.

График VIII.19.3. Сумдад бүртгэгдсэн гэмт хэрэг



Увс аймгийн Прокурорын байгууллага 2016 онд гэмт хэргийн талаарх 984 гомдол, мэдээлэл хүлээн авч, 355-д нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, 628-д нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байх ба 413 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ. Уг газраас тайланд хугацаанд 182 яллагдагчид хамаарах 97 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд 35 эрүүгийн хэрэг түдгэлзүүлсэн, 240 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Хүснэгт VIII.19.2. Прокурорын байгууллагын мэдээлэл

№	Үзүүлэлт	Он				
		2013	2014	2015	2016	Дундаж
1	Хүлээн авсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл	1095	1234	1234	984	**1137**
	Үүнээс:					
	Эрүүгийн хэрэг үүсгэсэн	376	405	412	355	**387**
	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	719	829	822	628	**750**
2	Хэрэг бүртгэлт, мөрдөж байцаалт явуулсан хэрэг	498	559	542	413	**503**
3	Шүүхэд шилжүүлсэн хэрэг	85	110	137	97	**107**
	Шүүхэд шилжүүлсэн хүн	125	158	195	182	**165**
4	Түдгэлзүүлсэн хэрэг	5	13	14	35	**17**
5	Хэрэгсэхгүй болгосон	239	288	308	240	269

Сүүлийн 4 жилийн хугацаанд жилд дунджаар гэмт хэргийн талаарх 1137 гомдол, мэдээлэл хүлээн авч, 387-д нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, 750-д нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байх ба 503 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 165 яллагдагчид хамаарах 107 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд 17 эрүүгийн хэрэг түдгэзүүлсэн, 269 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрөөр хэлбэл, Увс аймгийн прокурорын газраас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хэргийн 21.3%-ийг шүүхээд шилжүүлж, 3.4%-ийг түдгэлзүүлж, 53.5%-ийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

2016 онд **Увс аймгийн Анхан шатны шүүх** 201 хүнд холбогдох 108 эрүүгийн хэргийг хүлээн авч, шүүн таслах ажиллагаа явуулсанаас 22 хүнд холбогдох 10 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 15 хүнд холбогдох 10 хэргийг хэрэгсэхгүй болгож, 155 хүнд холбогдох 94 хэргийг шийдвэрлэжээ. Шүүхээс 4 иргэнд торгох, 12 хүнд албадан ажил хийлгэх, 25 хүнд баривчлах, 99 хүнд хорих ял оногдуулсанаас 16 хүний хорих ялыг биечлэн эдлүүлж, 86 хүний ялыг тэнсэн харгалзсан байна.

Увс аймгийн **Давж заалдах** шатны шүүхээр 11 хэргийг хянан шийдвэрлэсэн бол тус аймагт хамаарах 5 эрүүгийн хэргийг Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэжээ.

2.4. Гэмт хэргийн төрөл

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 43.2% нь бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 34.8% нь хулгайлах, 5.3% нь ТХХАБАЖЭсрэг, 1.9% нь хүчиндэх, 1.6% нь байгаль хамгаалах журмын эсрэг, 1.6% нь танхайрах, 1.6% нь залилан мэхлэж авах гэмт хэргүүд тус тус эзэлж байна.


График VIII.19.4. Гэмт хэргийн төрөл



2.5. Гэмт хэргийн ангилал:

Гэмт хэргийн нийгэм, хүн амд учруулж буй хор хохирлын хэмжээг илэрхийлэх үзүүлэлт бол гэмт хэргийн ангилал байдаг. Увс аймагт 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 57.5% нь хөнгөн, 36.0% нь хүндэвтэр гэмт хэрэг эзэлж байна.

График VIII.19.5. Гэмт хэргийн ангилал



2.6 Гэмт хэргийн илрүүлэлт

Цагдаагийн байгууллага гэмт хэргийн илрүүлэлтийг бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн нь хэргийн эзлэх хувийн жингээр тооцдог. Увс аймагт 2016 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 182 хэргээс 141 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн ба гэмт хэргийн илрүүлэлт **77.5%** байгаа нь өмнөх оны түвшингээс 3.1 пунктээр нэмэгджээ.

2.7 Гэмт хэрэгт холбогдогч

Увс аймагт бүртгэгдсэн 322 гэмт хэрэгт нийт 359 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8%-аар буурсан. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 7.2-%ийг эмэгтэй, 6.7%-ийг хүүхэд, 61.8%-ийг 18-34 насны залуучууд эзэлж байна.

Эдгээрийн 53.8%-ийг эрхэлсэн тодорхой ажилгүй, 18.7%-ийг малчин, 7.8%-ийг хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байна.

График VIII.19.6. Гэмт хэрэгт холбогдсдын нийгмийн байдал



2.8. Гэмт хэргийн хохирол, хохирогч

Гэмт хэргийн халдлагад 333 иргэн хохирч, үүнээс 7 хүн нас барж, 167 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал, нас барсан хүн 6 буюу 46.1%-аар, гэмтсэн хүн 27 буюу 13.9%-аар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, ААН, байгууллагад учирсан 512.0 сая төгрөгийн хохирлын 419.5 сая төгрөг буюу 81.9%-ийг нөхөн төлүүлж, 307.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

3. УВС АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Увс аймагт 2016 онд 7320 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2896 буюу 28.3%-аар буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 6953 иргэн, 2 албан тушаалтан, 3 ААН, байгууллагад 286.8 сая төгрөгөөр торгох, үүнээс 324 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 38 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл: 6996 буюу 95.6%-д цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, 324 буюу 4.4%-д шүүгч шийтгэл ногдуулсан байна. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 768 хүн саатуулагдсанаас 10 буюу 1.3% нь эмэгтэй хүмүүс байна. 2 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

4. УВС АЙМАГ ДАХЬ ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2016 онд аймгийн хэмжээнд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, ослын 41 дуудлага мэдээлэл хүлээн авсан ба эдгээрийн 17-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, 23-д нь эрүүгийн хэрэг үүсгэхээ татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар захиргааны арга хэмжээ авчээ.

График VIII.19.7. Увс аймагт гарсан ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 215-225)



Жилд дунджаар ТХХАБАЖЭсрэг 22 гэмт хэрэг гарчээ.


Сүүлийн 7 жилийн хугацаанд жилд дунджаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж, дүрэм, журам зөрсөн 5765 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 684 иргэнд 38.8 сая төгрөгөөр торгож, 351 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 254 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Хүснэгт VIII.19.3.

№	Он	Зөрчил	Иргэн	Торгосон			Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан	Баривчилсан
				Торгуулийн хэмжээ /сая. төг/	Албан тушаалтан	Хуулийн этгээд		
1	2010	4158	631	23,2			313	112
2	2011	5538	676	34,5			282	201

3	2012	5769	750	39,8		330	310
4	2013	6731	1108	53,3		451	386
5	2014	7709	962	58,3		488	353
6	2015	5562	461	36,2		269	163
7	2016	4887	199	26,3		324	-
	Дундаж	5765	684	38,8		351	254

График VIII.19.8. Увс аймагт гарсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил



Жолооч, иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн мэдлэг, хөдөлгөөнд оролцох соёл дутмаг байгаа байдал, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал хангагдаагүйгээс хөдөлгөөнд оролцсон, тээврийн хэрэгслийн хурдыг тохируулж яваагүйгээс, хөдөө орон нутагт мотоциклээр хөдөлгөөнд оролцохдоо зориулалтын хамгаалалтын малгай, хэрэгсэл хэрэглэдэггүй, согтууруулах ундаа хэрэглэсэн үелээ хөдөлгөөнд оролцсоны улмаас дээрх зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан нөхцөл нь болсон байна.

5. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн А/82 дугаар тогтоолоор "ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн"-ийг шинэчлэн батлаж, үйл ажиллагаагаа явуулж иржээ. Уг зөвлөлийн даргаар ИТХ-ын дарга, нарийн бичгийн даргаар хууль, эрх зүйн хэлтсийн дарга, гишүүдэд аймгийн Засаг дарга, ИТХ-ын мэргэжилтэн, Ерөнхий шүүгч, Аймгийн прокурор, Цагдаа, Тагнуул, Онцгой байдал, Мэргэжлийн хяналт, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Аудит, Боловсрол-соёл, Эрүүл мэндийн газрын дарга нар болон хүний эрх хариуцсан мэргэжилтэн, ТББ, хэвлэл мэдээллийн төлөөлөгчийг оролцуулан байгуулжээ.

Увс аймаг дахь ГХУСАЗСЗ-өөс 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд жигд явуулах, иргэд, олон нийтэд хүрч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах, гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хурдан шуурхай хүлээн авч, урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах, тайлбарлах зэргээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 онд "Гэр бүлийн хүчирхийлэлгүй амар тайван амьдарцгаая", "Мал сүргээ гэмт халдлагаас хамгаалья" гэсэн 2 төрлийн зурагт хуудас, "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах соёлыг хамтдаа бий болгоё" зурагт хуудас, гарын авлагыг 8000 хувь хэвлүүлэн олон нийтэд тараажээ.

Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр гарын авлага, сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх хуудсуудыг аймгийн 19 сумдад 1710 ширхэгийг хийж, тараасан байна.

Мал хулгайлах гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, Архидан согтуурахтай тэмцэх, БХЖЭсрэг тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр хуулийн байгууллага, хилийн цэргийн алба хаагчдын дунд урьдчилан сэргийлэх ажлыг явуулжээ.

Прокурор, цагдаагийн байгууллагаас Улаангом хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагын дарга, эрхлэгч, иргэдэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, журмыг сурталчилж, тэдний оролцооны талаар мэдээлэл хийсэн байна.

Орон нутгийн иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс салбар зөвлөлөөс "Сумдын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх тухай", "Малын хулгайтай тэмцэх тухай", "Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай", "Улсын хил хамгаалалтын үр дүн, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай", "Увс аймаг дахь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал", "Хууль бус үйлдэл, хил дамнасан малын хулгайтай тэмцэх тухай" зэрэг тогтоол, шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих замаар тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Архидан согтуурч удаа дараа саатуулах байранд саатуулагдсан, баривчлагдсан этгээдүүдийн судалгааг гарган, тэдэнд зориулан аймгийн Цагдаагийн газар нь Эрүүл мэндийн газартай хамтран архины хор хөнөөлийн талаар сургалт зохион байгуулжээ.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд техник технологийн дэвшлийг бүтээлчээр ашиглах, гэмт хэргийн илрүүлэлтийг шуурхай болгох, таслан зогсоох, бартаа саадтай газрыг богино хугацаанд тогтоох ач холбогдол бүхий "Нисдэг камер"-ыг ХУСАЗСЗ-өөс 4.1 сая төгрөгөөр худалдан авч, үйл ажиллагаандаа ашигладаг байна. Мөн гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор 1800-1505 тусгай дугаарыг нээн ажиллуулсан байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны А/55 дугаар тогтоолын хэрэгжилтийн мөрөөр 320 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн гадна, дотно орчныг хянах зорилгоор камержуулж, урьдчилан сэргийлэх ажилд ач холбогдолтой, үр нөлөөтэй ажил болсоор байна гэжээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор "Замын хөдөлгөөний цагаан толгой-2016" тэмцээнийг аймгийн төвийн цэцэрлэгүүдийн дунд, "Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцье уриатай-Дэвжээ", "Ногоон гэрэл, цагаан шугам-2016" тэмцээний ЕБС-ийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан байх ба сургуулийн орчимд хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр "School Police" арга хэмжээг улирал тутам тогтмол зохион байгуулжээ.

Монгол-Оросын Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээг хэрэгжүүлж ажилладаг ба талууд "Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комисс"-ын бүрэлдэхүүнийг хилийн зөрчлийн мөрөөр ОХУ-ын талд 3 удаагийн хамтарсан эрэлд оролцуулж, 2 толгой адууг олж хүлээн авч, эээнд нь буцаан өгчээ. 7 удаагийн 88 толгой адуу хил дамнан хулгайлагдсанаас 3 удаагийн 39 толгой адууг хил дээр саатуулж, 4 удаагийн 17 толгой адууг хамтарсан эрлээр олж, малыг эздэд нь хүлээлгэн өгсөн байна.

6. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахад зарцуулах зардал, төсөв хөрөнгийн дутагдалтай байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13, 19 дүгээр зүйлд заасан шагнал, урамшуулал тэтгэмж, зохион байгуулж байгаа арга хэмжээнд санхүүжүүлэх төсвийн хүрэлцээ дутагдалтай. Алслагдсан баг, айл өрхүүдэд хүрч ажиллахад унаа машин, бензин шатахууны хүндрэл учирдаг байна.

Иргэдийг шагнаж, урамшуулах, тус хуулийн 13 дугаар зүйл заалт хэрэгждэггүй учраас иргэд, олон нийтийн зүгээс нийгмийн ажилд идэвх оролцоо, санаачлагагүй байдал нь сөргөөр нөлөөлдөг байна.

Сумдын салбар зөвлөлүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцдоггүй, санаачлагагүй байдаг нь мөн тулгамдсан асуудал болж байна.

Аймаг, сумдын салбар зөвлөлөөс тухайн жилийнхээ хийсэн ажлын танилцуулга, тайланг чанартай, шаардлагын дагуу бэлтгэж ирүүлдэгээс нэгдсэн тайлан уялдаагүй, чанартай муутай гарч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг олон нийт, бүх шатанд танилцуулахад сөргөөр нөлөөлдөг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг жигд чанд мөрдүүлэх, иргэдийг урамшуулах, сургалт, сурталчилгаа, сэрэмжлүүлгийн чиглэлээр төлөвлөсөн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх төсвийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх хуулийн байгууллагууд, сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанаржуулах шаардлага байгаа нь судалгааны эх сурвалжуудаас ажиглагдав.

Түүнчлэн, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах, иргэний зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зэрэг үйл ажиллагааны үр дүн харагдахгүй байсан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зөвхөн цагдаагийн байгууллагын явуулсан үйл ажиллагааны үр дүнгээр салбар зөвлөлийн тайлан, үйл ажиллагаа үнэлэгддэг хандлага ажиглагдаж байв.

ДҮГНЭЛТ

Увс аймагт 2016 онд **322** гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, прокурорын байгууллагаас **413** эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, шүүхээс **94** эрүүгийн хэрэг хүлээн авч, шийдвэрлэжээ. 2016 онд гэмт хэргийн халдлагад **333** иргэн хохирч, үүнээс **7** хүн нас барж, **167** хүн эрүүл мэндээрээ хохирч, иргэн, ААН, байгууллагад учирсан **512.0** сая төгрөгийн хохирол учруулчээ.

Цаашид ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг оновчтой байдлаар шинэчлэн бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, салбар зөвлөлд орсон гишүүдийг идэвхжүүлж, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага байна.

ХОВД АЙМАГ



20. ХОВД АЙМАГ

Ховд аймаг нь 17 сум, 91 багтай, аймгийн харъяат хүн ам 2015 оны жилийн эцсийн байдлаар 83.5 мянга, 21.7 мянган өрхтэй жилдээ 352.1 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй нь нэг хүнд дунджаар 4.3 сая төгрөг ноогдож байна.

Аймгийн эдийн засгийн гол салбар болох ХАА-н салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 46.7% эзэлж Ховд аймаг 2015 оны жилийн эцсээр 2.9 сая мал тоолуулж, 7188 малчин өрх МАА-н үйлдвэрлэл эрхэлж 15232 малчид МАА-н салбарт ажиллаж байна. Нийт 923 ААН, иргэн үйлдвэрлэл эрхэлдэг ба Ховд-Улаанбаатар, Улаанбаатар-Ховдын чиглэлд нийт 40 тээврийн хэрэгсэл, хотын дотор нийтийн тээврийн 8 автобус, 250 такси зорчигчдыг тээвэрлэж, хүнд даацын 40 гаруй тээврийн хэрэгсэл улс, аймаг орон нутагт ачаа тээвэрлэж байна. Олон улсын нисэх буудал нь өдөр бүр нислэг үйлдэхийн зэрэгцээ, Ховд-Урэмчийн хооронд олон улсын нислэг хийдэг болтлоо хөгжлөө.

2015-2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 24 сургуулийн 694 бүлэгт 18341 хүүхэд суралцаж, Сургуулийн өмнөх боловсрол төрийн өмчийн 29, хувийн өмчит 14, хөдөөгийн багийн 3 нийт 46 цэцэрлэгт 6995 хүүхэд хамрагдаж байна. Ховд их сургууль, Хөгжил политехник коллежд нийт 300 гаруй багш ажиллаж, 4000 гаруй оюутан суралцаж байна.

Өнөөдөр Ховд аймагт Дөргөний УЦС, Хүүхэд залуучуудын ордон, Ховд Их сургууль, Политехник коллеж, Биеийн тамир спортын ордон, Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн, Усан спортын төв, Олон улсын нисэх буудал, Ахмадын өргөө, Өв соёлын хүрээлэн, Цементийн үйлдвэр, Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн, Ганданпунцагчойлин хийд, Барилга угсралт, барилгын үйлдвэрлэл гэсэн бүс нутгийн чанартай байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна

ХОВД АЙМГИЙН НУТАГ ДЭВСЭРТ 2016 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА

Хүснэгт VIII.20.1.

Асуулт		2015 он	2016 он	Өсөлт бууралт хувь
Нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл		6130	4816	-21.4%
Үүнээс	Гэмт хэргийн шинжтэй	1382	1140	-17.5%
	Захиргаанызөрчлийн шинжтэй	2527	1844	-27.0%
	Бусад	2221	1832	-17,5%
Бүртгэгдсэн гэмт хэрэг		498	398	-20,1%
Илрээгүй хэрэг		31	40	29,0%
Илрүүлэлтийн хувь		68,4	65,2	-3,2%
Хэргийн ангилал	Хөнгөн гэмт хэрэг	279	219	-21,5%
	Хялбаршуулсан хэрэг	160	125	-21,8%
	Хүндэвтэр гэмт хэрэг	202	173	-14,3%
	Хүнд гэмт хэрэг	14	5	-64,2%
	Онц хүнд хэрэг	3	1	-66,6%
Согтуугаар үйлдэгдсэн		132	118	-10,6%
Бүлэглэн үйлдэгдсэн		42	14	-66,6%
Галт зэвсгээр үйлдэгдсэн		2	3	50,0%

Хүүхэд оролцсон			18	19	5,5%
Гэр бүл хүчирхийллийн улмаас			28	33	17,8%
Хэргийн өнгө	Хүнийг санаатай алах		1	1	
	Танхайрах		16	5	-68,7%
	Залилан мэхлэх		18	13	-27,7%
	Хүчиндэх		3	7	2,3 д
	Бусдын бие махбодид гэмтэл учруулах		208	131	-37,0%
	Хулгайлах		125	124	-0,8%
	Үүнээс	Малын хулгайлах	34	29	-14,7%
		Хувийн өмчийг хулгайлах	83	89	7,2%
Дээрэмдэх			1	1	
ТХХАБАЖ эсрэг гэмт хэрэг			48	58	20,8%
Хүн амын эрүүл мэндийн эсрэг			4	2	-50,0%
Хүнийг болгоомжгүй алах			1		
Байгаль хамгаалах журмын эсрэг			3	6	100,0%
Албан тушаалын гэмт хэрэг			4	4	
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг				5	
Шүүн таслах ажиллагааны эсрэг			2	1	-50,0%
Бусдыг амиа хорлоход хүргэх			1	1	
Хүний эрх, эрх чөлөө,алдар хүнд нэр төрийн эсрэг			1	1	
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг			8	2	-75,0%
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг			5	3	-40,0%
Бусдын эд хөрөнгө завшиж үрэгдүүлэх			9	8	-11,1%
Бусад			40	25	37,5%
Хаана гарсан	Гудамж талбай		98	65	-33,6%
	Олон нийтийн газарт		37	31	-16,2%
	Төрийн байгууллагад		10	14	40,0%
	Төрийн бус байгууллагад		5	5	
	Аж ахуй нэгжид		18	18	
	Гэр орон сууцанд		160	122	-23,7%
	Авто зам		47	52	10,6%
	Нийтийн тээвэрт		6	1	-83,3%
	Бусад		117	90	-23,0%
Гариг	Даваа		81	66	-18,5%
	Мягмар		92	53	-42,3%
	Лхагва		64	66	3,1%
	Пүрэв		65	68	4,6%
	Баасан		69	51	-26,1%
	Бямба		51	52	1,9%
	Ням		76	42	-44,7%
Цаг хугацаа	06-14 цаг		115	92	-20,0%
	14-19 цаг		132	95	-28,0%
	19-22- цаг		81	69	-14,8%
	22-06-цаг		170	142	-16,4%

Нийт холбогдогч			562	386	-31,3%
Үүнээс	Эмэгтэй		69	43	-37,6%
	Хүүхэд оролцсон		29	26	-10,3%
Нас	17 нас хүртэл		29	26	-10,3%
	18-24 насны		105	76	-27,6%
	25-29 насны		121	77	-36,3%
	30-34 насны		92	73	-20,6%
	35-39 насны		74	46	-37,8%
	40-өөс дээш насны		141	88	-37,5%
Хохирол	Гэмт хэргийн улмаас	Нас барсан	19	22	15,7%
		Гэмтсэн	263	175	-33,4%
	Учирсан хохирол /сая төг/		856,9	1618,3	88,8%
	Нөхөн төлүүлсэн хохирол		586,1	1288,7	2,2 д
Захиргааны зөрчил	Нөхөн төлүүлэлтийн хувь		68,4	79,6	11,2%
	Илрүүлсэн бүх зөрчил		2478	1777	-28,2%
	Торгосон	Хүн	7190	5672	-21,1
		Төгрөг	84,931,9	335,238,6	3,9д
	Албадан саатуулсан хүн		2478	1777	-28,2%
	Эрх хассан		309	502	62,4%
	Захиргааны журмаар баривчлагдсан		245	29	-88,1

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар:

"Хууль сурталчлах", "Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдах үед иргэд, олон нийтэд албаны үйл ажиллагааг танилцуулан, сурталчилсан бөгөөд тус Цагдаагийн газрын цахим хуудсанд бүрэн байршуулсан.

Тухайлбал, "Нээлттэй хаалганы өдөр"-ийг тус аймгийн Цагдаагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу тасаг, албадууд хуваарийн дагуу 7 удаа зохион явуулсанаас Ховд их сургууль, 12 жилийн 1 дүгээр сургууль, Политехник коллежтэй хамтран 3 удаа зохион явуулсан.

ЦЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу "Амар тайван амьдралын төлөө хамтдаа" уриан дор "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулсан эдгээр арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 189 алба хаагч оролцож, 802 иргэн хамрагдсан ба 15 хүсэлт, 41 гомдол мэдээлэл ирсэнээс газар дээр нь 21 асуудлыг шийдвэрлэн, бусад асуудлыг Цагдаагийн газрын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнууд шалгаж шийдвэрлэн хариу мэдэгдсэн ба энэ үеэр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 200 иргэнээс санал асуулга авч нэгтгэн Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төвд хүргүүлсэн.

Тус аймгийн хэмжээнд хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараах ажлуудыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа. Тухайлбал, Орон нутгийн онцлогт тохируулан аймгийн хэмжээнд түдгэлзүүлсэн хэргийг илрүүлэх, шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Прокурорын газартай хамтран "Илрүүлэлт-шийдвэрлэлт-Ховд 2016" нэгдсэн арга хэмжээг 2 үе шаттай зохион байгуулж үр дүнг хэлэлцсэн. Орон сууцны гаднах зогсоолд болон гудамж, талбайд тавьсан иргэдийн автомашинуудын эд зүйл, малчдын мал бэлчээрээсээ алдагдах хэрэг гарч байгаатай холбогдуулан, гэмт этгээдүүдийн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, хулгайд алдагдсан мал, эд зүйлийг олж тогтоох, тэдгээрийг худалдан авдаг ченж нарыг илрүүлэх, хариуцлага тооцох зорилгоор "Судалгаа-хяналт" хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцож

ажилласнаар автомашины акумлятор хулгайлдаг 2, худалдан авдаг ченж 1 этгээдийг, мал хулгайлах гэмт хэрэг үйлддэг, үйлдэж болзошгүй 24 эдгээдийг шинээр бүртгэл судалгаанд хамруулж, мал хулгайлах 5 гэмт хэрэг илрүүлэн ажилласан байна.

Мөн аймгийн Цагдаагийн газрын даргын тушаалаар гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх зорилготой орон тооны бус "Криминологи судалгааны баг"-ийг шинэчлэн байгуулсан ба судалгааны багаас 7 хоног бүрийн Даваа гарагт тухайн 7 хоногт гарсан гэмт хэрэг, зөрчлийн талаарх дэлгэрэнгүй судалгааг Цагдаагийн газрын дарга, тасаг, албадын дарга нарт танилцуулж, цаашид ажиллах ажлын чиглэлээ тодорхойлж ажилласан.

Улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн мэдээлэл, аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын байдалд тулгуурлан, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах зорилгоор хууль хяналтын байгууллагуудаас санал авч 2016 онд хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллав.

Судалгааны багийн дүн мэдээнд үндэслэн Жаргалант сумын Магсаржав, Цамбагарав, Жаргалан, Наран, Баатархайрхан, Алагтолгой, Бугат багуудын нутаг дэвсгэрт оройн цагаар, Алагтолгой, Жаргалан багийн нутаг дэвсгэрт өдрийн цагаар явган эргүүл, Жаргалант сумын 12 багийн нутаг дэвсгэрт хөдөлгөөнт эргүүлийг 2 ээлжээр зохион байгуулж байгаа ба нөхцөл байдалтай уялдуулан баяр ёслол, нийтийг хамарсан арга хэмжээний үеэр шөнийн эргүүлд 2 офицер, 2 цагдааг хөдөлгөөнт эргүүлээр алслагдсан гэр хороолол, харанхуй гудамж, талбайд хяналт тавиулан ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор захиргааны арга хэмжээ авч мөнгөн торгууль ногдуулсаны 40 хүртэл хувийг тухайн орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд танилцуулан тухай бүр зарцуулж байна.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэх, иргэд, олон нийтэд ойлгон таниулах, малын хулгайн гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл цуглуулах, малчдын эрх ашгийг хамгаалах, иргэдийг хулгайн мал, мах, түүхий эд худалдан авахаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл өгөх зорилгоор "Мал хулгайлах гэмт хэргээс хамтдаа сэргийлье" сургалт, уулзалт ярилцлагыг аймгийн "Дэлхийд цорын ганц нүүдэлчин Монгол холбоо"-той хамтран зохион байгуулсан. Мөн мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилготой сумын нутгийн захиргааны байгууллага, иргэд, малчидтай хамтран малын хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгдэн гардаг зүүн таван сумын хэмжээнд "Морин эргүүл"-ийг гарган ажиллуулж байна. Морин эргүүл ажиллуулснаар тухайн нутаг дэвсгэрт мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэхгүй байх боломж бүрдсэн.

БХЖЭсрэг гэмт хэрэг, цахим гэмт хэрэг, мансууруулах бодис, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ХЗДХЯам, ЦЕГ-р, Эрүүгийн цагдаагийн газраас бэлтгэн ирүүлсэн видео бичлэг, нэвтрүүлгийг 2 телевизээр 16 удаа нэвтрүүлж, зураг хуудас, сэрэмжлүүлэг мэдээллийг хүн олноор цуглардаг газруудын мэдээллийн самбарт байрлуулсан.

Аймгийн Цагдаагийн газрын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн санал, бодлыг сонсох зорилгоор Khovd.police.gov.mn цахим хаяг болон Ховд Цагдаагийн газар фейсбүүк хуудас нээж байгууллагын үйл ажиллагааг сурталчлахаас гадна иргэдийн дунд зохион явуулсан уралдаан тэмцээн, сургалт, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол байршуулан олон нийтэд хүргэж байна.

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд насанд хүрээгүй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, тэднийг гэмт хэргэг, зөрчил, архидалт, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Гэр

бүл, залуучуудын хөгжлийн төв, "Дэлхийн зөн" ОУБ-ын Ховд ОНХХ, Залуучуудын хөгжлийн газар зэрэг төрийн болон ТББ-уудтай хамтран ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад 14 сэдвүүдээр 7 удаагийн сургалт орж, 980 гаруй хүүхэд хамрагдсан байна.

Боловсролын газартай хамтран 2016 оны 10 дугаар сард "School police" эргүүлийн үйл ажиллагааг чадавхжуулах сургалтыг ерөнхий боловсролын 7 сургууль дээр нийгмийн ажилтнуудыг хамруулан сургалтыг зохион байгуулсан.

Мөн аймгийн ЗДТГ, Залуучуудын хөгжлийн төв, "Эрүүл амьдралын түүчээ" ТББ-тай хамтран "Заавал эдлэх хайр" аяныг зохион явуулж "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 2016 онд 18 гэмт хэрэгт давхардсан тоогоор 24 хүүхэд холбогдон шалгагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хэргээр буюу 12.5%-аар өссөн, насанд хүрээгүй сэжигтэн 4%-аар буурсан.

Гэмт хэрэгт холбогдсон, хохирсон хүүхдүүдийг тухай бүр сэтгэл зүйчтэй уулзуулж сэтгэл зүйн заслын үйлчилгээ үзүүлэн "Амьдрах ухааны сургалт", "Өөрийгөө чадавхжуулах нь" сургалтуудад 20 хүүхдийг 3 удаа хамруулсан ба байцаан шийтгэх ажиллагаанд Гэр бүл залуучуудын газрын хүүхдийн эрхийн мэргэжилтэн, сурган хүмүүжүүлэгч, өмгөөлөгчдийг тухай бүр оролцуулж эрхийг нь хангасан.

2016 онд 98 иргэний эрсдлийн үнэлгээг гаргаж, гэр орондоо агсам согтуу тавьсан 27 иргэнийг Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногоор баривчлуулж, 28 иргэнд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 5 иргэний эрхийг хязгаарлах арга хэмжээ авч хяналт тавин Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Залуучуудын хөгжлийн төв, Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт"-ыг 2 өдөр зохион байгуулсан.

Хүүхдийг замын хөдөлгөөний болон бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ИТХ-аар сургуулийн орчим ажиллах эргүүлийн журмыг батлуулж, сургуулийн эргүүлийн хамт цагдаагийн алба хаагчид ажлын өдрүүдэд 07:30-08:20 цагийн хооронд сургуулиудын ойр орчмын 10 цэгт үүрэг гүйцэтгэж ажиллав.

Ахмадын зөвлөлөөс дрон буюу нисдэг камерыг тус Цагдаагийн газарт бэлэглэснээр хүн ихээр төвлөрсөн газруудад хяналт тавих ажлыг хэрэгжүүлж байна.

Тус аймгийн Цагдаагийн газар нь гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээ, бодлого чиглэл, нэгдсэн болон хэрэгчилсэн арга хэмжээ, Цагдаагийн газрын харъяа хэлтэс, тасгуудаас зохион байгуулсан сургалт, урлаг, спортын үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг, ярилцлага өгч, иргэдийн санал, хүсэлтийг 7043102 дугаараар хүлээн авч, эрх зүйн туслалцаа үзүүлж ажилласан.

2016 онд болсон тэмдэглэлт баяр, наадам, УИХ-ын болон орон нутгийн сонгууль, УИХ-ын дарга, Ерөнхий сайд болон бусад бүсийн чанартай уралдаан тэмцээний хамгаалалтыг давхардсан тоогоор 24 удаа батлагдсан зураглал, төлөвлөгөөний дагуу хэрэг зөрчилгүй зохион байгуулж, танилцуулгыг тухай бүр нь холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг дэвсгэрт орших Мянгат угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын тусгай хамгаалалттай бүсэд орших "Цагаан эрэг" гэх газарт иргэд хууль бусаар ашигт малтмал олборлосон, нөхөн сэргээлт хийх компаний үйл ажиллагааг тасалдуулсан иргэдийг тараах, хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор 4 удаа ажлын хэсэг томилж ажиллуулан, нөхцөл байдлын талаар холбогдох албадад тухай бүр нь танилцуулга хүргүүлж ажилласан.

Цэцэг сумын Хөшөөт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Мо Эн Ко" ХХК-ийн нүүрсний уурхайн тэсэлгээний ажлыг гэрээгээр хариуцан гүйцэтгэж байгаа "Мера" ХХК, Мөст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Бодонч Их Бүрд" ЗГБХН, Алтай сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Литологи" ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис хадгалах агуулах болон тэсэлгээний ажлын явц байдлыг 6 удаа шалгаж, хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд нутаг дэвсгэр хариуцсан хэсгийн төлөөлөгч нарт хяналт шалгалтыг эрчимжүүлэх тухай зөвөрчилга өгч, улирал бүр нөхцөл байдлын танилцуулга бичиж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.

Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хууль, Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/533 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 5 удаа зохион байгуулж, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 44 зөрчил ирүүлэн, 3 иргэн, 22 аж ахуй нэгжийг 562.000 төгрөгөөр торгож захиргааны шийтгэл ногдуулан, 13 литр спирт, 25 шил архи, 225 литр пиво хураан авч, Захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг үнэлэх, устгах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн байна.

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/533 дугаар захирамжийг удаа дараа зөрчин үйл ажиллагаа явуулсан 2 аж ахуйн нэгжийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг хүргүүлж, 2 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж шийдвэрлүүлсэн.

Тамхины хяналтын тухай хуулийг сурталчилах чиглэлээр 6 удаа сургалт зохион байгуулан, давхардсан тоогоор 135 хүнийг хамруулан, 13 санамж, 10 зөвлөмж, 12 анхааруулга, 9 сэрэмжлүүлэг хэвлүүлэн тарааж, хэвлэл мэдээллийн байгууллагад 11 удаа мэдээлэл өгч, 36 зөрчил илрүүлэн, 13 иргэн, 11 ААН-ийг 1.113.000 төгрөгөөр торгож захиргааны шийтгэл ногдуулсан байна.

Оюутан, сурагчдад архи, тамхи, мансууруулах бодисын хор холбогдлын талаар тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчилах зорилгоор Эрүүл мэндийн газартай хамтран "Архи, тамхигүй Ховд" аяныг зохион байгуулсан.

Галт зэвсгийн тухай хууль болон нэгдсэн арга хэмжээний талаар мэдээллийг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 3 телевизээр нийт 51 удаа, баруун бүсийн төв захын узелиэр хугацаанд нэвтрүүлж, Их буян, Цагаан морь зах, хот хоорондын болон сум хооронд зорчих тээврийн хэрэгслийн зогсоол, үзвэр үйлчилгээний газар, нисэх онгоцны буудал зэрэг хүн ам ихээр төвлөрсөн газруудад зарлан мэдээллийг байршуулсан.

Аймгийн хэмжээнд хууль бусаар галт зэвсэг, сум гар дээрээс борлуулж болзошгүй 5 этгээдийг хяналтанд авч, хууль бус үйлдлийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж, Галт зэвсгийн тухай хууль зөрчсөн нийт 3 зөрчил илрүүлэн, хууль худалдаалж байсан 31 ширхэг сум, 2 ширхэг галт зэвсгийн хураан авч, зөрчил гаргасан 3 этгээдэд Галт зэвсгийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн нийт 180.000 (Нэг зуун наян мянга) төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.

2016 онд зам тээврийн ослын 396 дуудлага мэдээлэл хүлээн авсанаас захиргааны зөрчлийн 344, гэмт хэргийн шинжтэй 52 мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн ба нийт 3732 зөрчил илрүүлсэнээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээтээврийн хэрэгсэл жолоодсон 502 жолоочийг илрүүлэн зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлж, 427 жолоочийн эрхийг 06 сараас 2 жилийн хугацаагаар хасч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 73 иргэнийг материалжуулан, бэлэн бус торгуулийн багажаар 1615 жолоочийг 70.897.200 төгрөгөөр торгож, шийтгэврийн хуудсаар 846 жолоочийг 198.434.000 төгрөгөөр, нийт 2461 жолоочид 269.331.200 төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажилласан.


ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх зорилгоор 10 мэдэгдэл бичиж хариуг нь авч, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн холбогдох заалтуудаар 6 төрлийн 1300 гаруй санамж, "Амссан бол жолоо бүү барь", "Аваа та битгий яараарай" гэсэн уриалгуудыг гарган иргэдэд тараасан.

Хөдөлгөөний ачаалал ихтэй 52 айлын 4 замын уулзварыг өргөтгөх ажлыг зам засвар үйлчилгээний "Кеналхан" ХХК хийж гүйцэтгэсэн ба асфальт тавих, гэрлэн дохио суурилуулах ажилд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ашиглалтад оруулснаар тухайн уулзварын ачаалал эрс багассан. Мөн Жаргалант сумын нутаг дэвсгэр дэх засмал замуудын эвдрэл гэмтлүүдийг "Ховд Азза" ХХК засварлах ажилд хяналт тавьж ажилласан.

ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн 9 арга хэмжээг, Жаргалант сумын цэцэрлэгүүдийн дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2016" тэмцээнийг зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд хийсэн ажлуудыг дүгнэн үзвэл мал хулгайлах гэмт хэрэг гардаг цөөн хэдэн сумдад анхаарал хандуулах, хил залгаа орших баруун аймгийн цагдаагийн газрууд болон ГХУСАЗСЗ-үүд сүлжээ байгуулан ажиллах талаар анхаарах хэрэгтэй байна. Түүнчлэн оюутан сурагчид, дотуур байрны нөхцөлд хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчил, өсвөр үеийнхний хооронд гарч болох дарамт, хүчирхийлэл зэрэг далд хэлбэрт байгаа гэмт явдалтай тэмцэх чиглэлээр гэмт хэргээс ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай

ХӨВСГӨЛ АЙМАГ



21. ХӨВСГӨЛ АЙМАГ

Хөвсгөл аймаг нь 1931 онд үүсэн байгуулагдсан. Булган, Архангай, Завхан аймагтай хиллэх ба улсын хилээр зааглагдаж ОХУ, түүний Тува, Буриад улсуудтай хаяа залгадаг. Аймгийн төв Мөрөн хот нь Нийслэл хотоос баруун хойш 671 км зайтай оршдог. Хөвсгөл аймаг 23 сум, 1 тосгон, 126 багтай.

Хөвсгөл аймаг нэг зуун мянга зургаан зуу гаруй (100,629) км² газар эзэлсэн Монгол Улсын 6 дахь том нутаг дэвсгэртэй аймаг. Үндсэндээ уулархаг, уул, ус, ой, хөвч, тайгаас бүрдэх ба ан амьтан, ургамал, ашигт малтмалаар баялаг, түүх, байгалийн дурсгалт газар арвинтай, онгон дагшин байгалийн өлгий болсон нутаг. 2011 оны байдлаар 126 мянган хүн оршин суух байсан ба хамгийн олон хүнтэй аймаг юм. Үндсэндээ Монгол үндэстэн, тэр дотроо халх, дархад, хотгойд, урианхай ястан зонхилдог. Мөн цаатан отгийн хүмүүс цөөн тоогоор бий.

Аймгийн нийт хүн амын 76,9%-ийг халх, 13,7% дархад, 5,2%-ийг хотгойдууд эзэлдгийн зэрэгцээ Буриад, Урианхай, Цаатан зэрэг ястан амьдардаг олон ястны өлгий нутаг юм. Тус аймгийн Баянзүрх, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагааннуур суманд ихэвчлэн Дархад, Цаатан, Тува, Чандмань-Өндөр суманд Урианхай, Цагаан-Үүр суманд Буриад, Шинэ-Идэр, Галт, Жаргалант суманд Халх, бусад суманд Хотгойд ястнууд голлон амьдардаг. Тус аймагт мөнх цаст сүрлэг уулс, ян сарьдаг, гүн цэнхэр нуурууд, хөвч тайга, гол мөрний өргөн хөндий зэрэг нь тэр аяараа Хөвсгөл нутгийн үзэсгэлэн гоо билээ. Шохойн ба гантиг чулуун тунадаснаас үүссэн Цагаан-Үүр сумын Даян дээрх зэрэг олон агуй, хонгил, сэнжит хад нь байгалийн биет үзмэр юм.

Аймгийн нутаг дэвсгэр нь Хангайн уулархаг хэсэгт орщдог. Уул нурууны гол хэсэг нь хангай нурууны салбар хэсэг Хөвсгөл Тагна. Саяны уулс багтана. Дэлгэрхаан уулын ноён оргил нь далайн түвшнээс дээш 3491 метр өндөрт орших ба аймгийн нийт нутаг дэвсгэр нь далайн түвшнээс 1650-2050 метр өргөгдсөн.

Хөвсгөл аймаг байгалийн баялаг, эрдэнэсийн сангаар нэн арвин, үйлдвэрийн зориулалтаар ашиглах боломжтой судалгаа хийсэн олон сая тонн нөөцтэй фосфорит, нүүрс, бал чулуу, алт, төмрийн хүдэр, хөнгөн цагаан, шороон будаг, боржин гэх зэрэг хөнгөн үйлдвэрлэлд чухал ач холбогдолтой баялаг элбэг. Мөн олон сая шоо метрээр тооцогдох ойн нөөцтэй. Аймгийн нийт нутгийн 35,4% буюу 35,5 мянган км квадрат талбайг ойн талбай эзэлнэ.

Тус аймагт вансэмбэрүү, алтан хундага зэрэг 80 орчим төрлийн эмийн ургамал ургана. Нэрс, үхрийн нүд, улаалзгана, бөөрөлзгөнө, хад, аньс, тошлой, гүзээлзгэнэ зэрэг жимс, самар, мэхээр, мөөг, сонгино гэх мэт хүнсний ургамлын арвин баялаг нөөцтэй.

Хөвсгөл аймагт 5 баг, 13 овог, 31 төрөлд хамрагдах 35 зүйлийн хөхтөн, тэр дундаа үнэг, чоно, хандгай, баавгай, хярс, хүдэр, зэрлэг гахай, буга, гөрөөс, булга, тарвага, ан амьтан, 2 зүйлийн 2 нутагтан, 4 зүйлийн хэвлээр явагч, 400 гаруй зүйлийн шавьж бүртгэгджээ.

Аймгийн эдийн засгийн гол салбар нь ХАА юм. Аймгийн нийт нутгийн 57.7%-г ХАА эдэлбэр газрын хэрэгцээнд ашигладаг байна. Тус аймгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон нутгийн шилмэл Дархад омгийн хонь, хогоргын улаан Монгол, эрчмийн харямаа, Тэсийн голын адуу зэргийг үржүүлэн ашиглаж байна. Тус аймгийн Цагааннуур суманд цаа бугыг өсгөн үржүүлдэг. Тус аймгийн Тариалан, Эрдэнэбулган, Рашаант суманд газар тариалан эрхэлж ирсэн ба 2000 оноос нийт эргэлтийн талбай 20,4 мянган га-д хүрч жилд дунджаар 10,4 мянган га-д үр, тариа, төмс, хүнсний ногоо тариалж байна.

Хөвсгөл аймагт 2015 оны жилийн эцсээр улсын нийт хүн амын 4.2%, Хангайн бүсийн хүн амын 22.2% буюу 128.2 мянган хүн оршин суудаг. 2015 оны байдлаар аймгийн нийт

өрхийн тоо 37773, үүнээс 31.3% нь аймгийн төвд, 21.2% нь сумын төвд, 47.5% нь хөдөөд амьдарч байна. Аймгийн төв Мөрөн сум 37.7 мянган оршин суугчтай.

Нийт хүн амын 41.7% нь 15-39 насныхан байгаа нь аймгийн хүн ам ерөнхийдөө залуу бүтэцтэйг харуулж байна. Хөвсгөл аймаг 0-18 насны 47718 хүүхэдтэй бөгөөд нийт хүн амын 37.2%-ийг эзэлж, үүнээс 24296 нь эрэгтэй, 23422 нь эмэгтэй хүүхэд байгаа бол нийт хүүхдийн 61.6% буюу 29410 нь сургуулийн насны хүүхэд байна.

ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН


Хөвсгөл аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх хувь нь иргэний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болох хулгайлах гэмт хэрэг, үүн дотроо орон байрнаас эд хөрөнгө хулгайлах болон мал хулгайлах гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдэж байна. Мөн бусдын бие махбодид гэмтэл учруулах (танхайрах) гэмт хэрэг зонхилдог ба ихэвчлэн согтуугаар үйлдэгддэг байна. Гэр бүлийн хүчирхийлэл аймаг, орон нутгийн хэмжээнд өсөх хандлагатай байгаа бөгөөд аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн дийлэнх хувь нь Мөрөн сум, түүнийг тойрсон сумдад үйлдэгдэж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийн хувьд, гэмт хэрэг жилээс жилд өссөөр ирсэн байдаг. Түүнд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл нь ажилгүйдэл түүнийг дагаж бий болж байгаа ядуурал. Мөн иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байдгаас гэмт хэрэг үйлдэх, түүнд холбогдох асуудал их байна. Нөгөө талаар гэмт хэргийн хохирогч болж байгаа иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх асуудал чухал байна. Иргэд өөрийн өмчийн зүйлдээ хараа хяналт сул байдгаас гэмт хэргийн хохирогч болох нь их. Нөгөө талаас гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн хувьд амар хялбар аргаар амьжиргаагаа залгуулах сэтгэлгээний ядуурал нөлөөлж байна.

Дээрх асуудлын хүрээнд архидалт нийгэмд нэмэгдэж аливаа гэмт хэргийн суурь шалтгаан нөхцөл болж байна.Цаашид хувь хүний хүмүүжил, төлөвшил, хандлагад эерэг байдлаар нөлөөлөх ажлуудыг үе шаттай зохион байгуулах шаардлага бий. Энэ ажлын хүрээнд хүүхэд, залуучуудыг зөв хүн байх, хүмүүжил, төлөвшилд эерэгээр нөлөөлөх сургалтуудыг аймгийн ИТХ-лын дэргэдэх ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулдаг байна.


2016 онд аймгийн хэмжээнд 755 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 48 хэргийг хэрэгсэхгүй болгож, статистик мэдээгээр нийт 707 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь урд оны мөн үетэй харьцуулахад 49 хэргээр буюу 6,5%-аар буурсан.

График VIII.21.1.




Нийт 666 хүн гэмт хэрэгт холбогдсон ба урьд оны мөн үетэй харьцуулахад 91 хүнээр буюу -12% буурсан. Насны хувьд ангилж авч үзвэл, насанд хүрээгүй буюу 15-17 насны хүмүүс 32 буюу 0,1%, 18-29 насны хүмүүс 46,0%, 30-34 насны хүмүүс 101 буюу 15,2%, 35-44 насны хүмүүс 140 буюу 21,02%, 45-59 насны хүмүүс 80 буюу 12,01%, 80-аас дээш насны хүмүүс 7 буюу 1,05%-ийг эзэлж байна. Үүнээс харахад, ид хийж бүтээх, сурч, боловсрох насны залуучууд ихээр гэмт хэрэгт холбогдож байгаа юм. Иймд тэдэнд чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн бүхий л хэлбэрээр түгээх нь зүйтэй.

График VIII.21.2.



Гэмт хэрэг үйлдэгсдийн 59 буюу 8,8%-д нь эмэгтэй хүн оролцсон. Ял шийтгэгдсэн 35 хүн дахин гэмт хэрэг үйлдсэн байна. Нийгмийн байдлаар нь авч үзвэл, төрийн алба хаагч - 36 буюу 5,4%, оюутан, сурагч - 35 буюу 5,2%, хувиараа хөдөлмөр эрхлэгч - 93, буюу 14,0%, малчин - 136 буюу 20,4%, ажил эрхэлдэггүй 324 буюу 47,2%-ийг эзэлж байна.

График VIII.21.3.



ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

Хөвсгөл аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа нийт зөрчлийн шалтгаан нөхцөлийн хувьд, архи согтууруулах ундаа хэрэглэж зөрчил гаргах нь их байдаг байна. Ажилгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгч зонхилон танхайрах болон ТХХАБАЖЭсрэг зөрчлийг ихэнхдээ үйлддэг байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд 11257 зөрчил бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,2%-аар, 1828 иргэн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 138 буюу 7,1%-аар тус тус буурсан байна.

График VIII.21.4.



ТХХАБАЖЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ОСОЛ, ЗӨРЧИЛ

Аймгийн хэмжээнд ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг сүүлийн үед нэмэгдэж байна. Шалтгаан, нөхцөлийн хувьд жолооч нарын замын хөдөлгөөний дүрмийн болон хууль, эрх зүйн мэдлэг хомс, жолоочийн соёл, мэргэжлийн бэлтгэл эзэмшүүлж байгаа байдал дутмаг зэргээс үүдэлтэй юм. Иргэд, жолооч нар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа аюулгүйн бүс хэрэглэхгүй байх, тамхи татах, утсаар ярих гэх мэт үйлдлүүд хийж анхаарлаа сарниулснаас энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гарах бас нэгэн шалтгаан болдог байна. Хөвсгөл аймаг Улаанбаатар хоттой шинэ засмал замаар холбогдсонтой холбогдуулан аялал жуулчлалын улирал болох 7, 8 сард замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нар тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцохдоо Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж хөдөлгөөнд оролцохгүй байх, хурд хэтрүүлэх, эргэлт бүхий газар хурдаа саарууллахгүй байх, урдаа яваа тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэх гэж байгаад авто осол ихээр гаргах хүчин зүйлүүд бий болж байна.

Тус аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-өөс олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд тухайлбал, аймаг, орон нутгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах, хууль сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, холбогдох хуулийн дагуу хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж зөрчлийг арилгах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд дэвшил гаргах зорилгоор зөвлөлийн гишүүдийг 3 багт хуваан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллажээ. Үүний дагуу зөвлөлийн дэргэд гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүгнэлт гаргах үүрэг бүхий аймгийн прокуророор ахлуулсан орон тооны бус мэргэжлийн зөвлөгөө өгөх "Криминологи шинжилгээний баг", хууль тогтоомж сурталчлах, соён гэгээрүүлэх, хүн, нийгмийн сэтгэл зүйн нөлөөллийн ажил зохион байгуулах үүрэгтэй "Нийгмийн гэгээрлийн ажлын баг"-ийг, мөн хяналт, шалгалтын хүрээнд ажиллаж илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгах зорилгоор "Хяналт, шалгалтын ажлын баг"-ийг тус тус ИТХ, ГХУСАЗСЗ-ийн даргын захирамжаар байгуулан ажилладаг байна.

2015 оноос эхлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх, шинэ санал, санаачлагыг дэмжих, төлөвлөгөөнд тусгах, хэрэгжүүлэх зорилгоор "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах нь" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар тогтсон байна. Өнгөрсөн онд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн оновчтой төлөвлөх вэ" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулжээ.

Иргэдэд хууль сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор "Хайрлаарай", "Зүрхийг тань дайлъя", "Ухаарахуй" сэдэвт лекцийг үнэ төлбөргүй зохион байгуулжээ. Мөн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой "Иргэний боловсрол" хөтөлбөрийг Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 11-р сарын 20-ны өдөр баталсан ба энэхүү "Иргэний боловсрол" хөтөлбөрийн хүрээнд аймгийн 23 сумын дотоод ажил, эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад сургалт явуулж бэйгаа бөгөөд сургалтаар эрх зүйн сургалт сурталчилгааны онцлог, арга зүй, анхаарах асуудал, Хүүхэд хамгаалах тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн агуулга, онцлог зэрэг хууль, эрх зүйн болон ажил хэргийн холбогдолтой бусад асуудлаар сургалт зохион явуулсан байна.

Аймгийн төв болох Мөрөн сумтай хил залгаа орших Алаг-Эрдэнэ, Хатгал тосгон, Бүрэнтогтох, Түнэл сумдын нийгмийн ажилтнуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэд, олон нийттэй хэрхэн ажиллах талаар сургалт явуулж, мэдээлэл өгч ажиллажээ. Тус аймгийн Арбулаг суманд 2015 онд гэмт хэргийн үзүүлэлт өндөр байсан бол 2016 онд гэмт хэргийн гаралт 80 гаруй хувиар буурсан мэдээтэй байна.

Аймгийн ИТХын Тэргүүлэгчдийн 2015 оны 10-р сарын 30-ны өдрийн 77 дугаар тогтоолоор Бүрэнтогтох сумыг 2016 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах "Жишиг сум" болгожээ. Бүрэнтогтох сумын хувьд 2015 онд аймгийн 23 сумын хэмжээнд гэмт хэргийн үзүүлэлтээр эхний хоёрт байсан бол 2016 оны эхний 11 сарын байдлаар Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38,1%-аар буурсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2016 онд 755 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 48 хэргийг хэрэгсэхгүй болгож статистик мэдээгээр нийт 707 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 49 хэргээр буюу 6.5%-аар буурсан байна.

Хөвсгөл аймагт үйлдэгдсэн гэмт хэргийн мэдээгээр аймгийн 23 сумаас Жаргалант, Төмөрбулаг, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Цагааннуур гэсэн 5 сум, Хатгал тосгонд гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад өссөн мэдээтэй байна. Үлдсэн 18 сумуудад нь гэмт хэргийн үзүүлэлт хэвийн, буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэг өссөн дээрх сумуудын ГХУСАЗСЗ-д тухайн нутаг дэвсгэртээ урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллах талаарх чиглэл өгч, биелэлтийг тухай бүр хянаж ажиллажээ.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ


1. Иргэдэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлан таниулах, орон нутагтаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлаа тогтмол мэдээлж байх,
2. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, хуульчилсан актууд болон шинэчлэн баталж байгаа хуулиудыг иргэдэд энгийн, ойлгомжтой байдлаар хэвлэл, мэдээллийн болон бусад хэрэгслээр сурталчлах ажлыг эрчимжүүлэх,
3. Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-ийн гишүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургаж, чадваржуулах мэргэжил, арга зүйн сургалтыг зохион байгуулах,
4. Бусад аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-үүдтэй ажлын туршлага солилцох болон гадаадын улс орны урьдчилан сэргийлэх ажлын туршлага судлах. Тохиромжтой арга хэмжээг авч туршилтаар хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах,
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын судалгааны ажлыг шинэ түвшинд гаргах;
6. Судалгаанд тулгуурлаж, шинжлэх ухааны үндэслэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулж, хөгжүүлэх,
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал, онол, практикийн хурлыг аймаг, бүс, улсын хэмжээнд зохион байгуулах. (Ингэснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллага, иргэдийн оролцоо нэмэгдэнэ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөж, судалгааны бүтээл нэмэгдэнэ, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх, шинэ санал, санаачлагыг дэмжих, төлөвлөгөөнд тусгах, хэрэгжүүлэх),

Нийгмийн сэтгэл зүй, иргэдийн ухамсарт чиглэсэн уламжлалт болон сэтгэл зүйн хосолсон аргыг хэрэглэн урьдчилан сэргийлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах, урьдчилан сэргийлэх ажилд мэргэжлийн сэтгэл зүйчидтэй хамтран ажиллах, төрийн байгууллага бүр сэтгэл зүйчтэй байх, нийгмийн гэгээрлийн ажлыг иргэдээс бус төрийн албан хаагчдаас эхлүүлэх нь зүйтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг шагнаж, урамшуулах" гэснийг нэг мөр хэрэгжүүлж ажиллах. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх, санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, байгууллага, хамт олныг шагнаж, урамшуулж, олон нийтэд сурталчлах. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг аймаг орон нутгийн онцлогт тулгуурлаж нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрт хамрагдах шаардлагатай байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах 19.1. "Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял оногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ"., гэсэн заалтыг өөрчлөн хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-ийн гишүүдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвх, санаачлагтай ажиллуулах, чадавхжуулах асуудал чухлаар тавигдаж байна. Мөн ХЗДХЯ-аас жил бүр тогтмол сургалт, семинарыг зохион байгуулж, арга зүйн заавар, зөвлөгөөг өгч байх нь орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр нөлөөг дээшлүүлэх чухал ач холбогдолтой. Хөдөө, орон нутагт зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд бодлогоор анхаарч ажиллах шаардлагатай байна.

ХЭНТИЙ АЙМАГ



22. ХЭНТИЙ АЙМАГ

1. ХЭНТИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, ЗАСАГ ЗАХИРГАА, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХҮН АМ ЗҮЙН ОНЦЛОГ

Хэнтий аймаг нь 200 гаруй жилийн түүхтэй ууган дөрвөн аймгийн нэг бөгөөд Сэцэн хан аймгийг 1923 оноос Хан Хэнтий уулын аймаг, 1930 оноос одоогийн Хэнтий аймаг болгон өөрчлөн зохион байгуулсан билээ. Хэнтий аймаг нь 1923 онд байгуулагдсан ба 80.3 мянган км² нутаг дэвсгэртэй, 76.0 мянган хүн амтай, 18 сум, 5 тосгонтой.

Аймгийн нутаг баруун хойд талаар далайн түвшнээс дээш 2451 м хүртэл өргөгдсөн Бага Хэнтий уул, Дэлгэрхаан уул, орших ба аймгийн нутгийн төв хэсгээр Баянхутаг уул, /1580/, зүүн талд нь Эрээн даваа /1438/ м тус тус байрлаж хойноосоо урагшлах тусам улам намсаж талархаг нутагт шилжинэ. Уул нурууд нь баруунаас зүүн тийш өргөрөгийн дагуу байрлалтай. Эдгээр уул нуруудын хооронд талархаг хээр, говь, цөөрөм бүхий өргөн уудам хөндийд үргэлжилнэ. Нутгийн ихэнхийг гүвээ, толгод, тал хээр эзэлдэг. Байгалийн бүс бүслүүрийн хувьд тайгын бүслүүр, уулын хээр, хээрийн бүс голлоно. Тус аймгийн газарзүйн байрлалын хувьд нутгийн 75% нь хойд талаасаа Сибирийн ой тайга уулсыг даган өмнө зүг түрсэн уулархаг нутаг, 25%-д өмнө талаасаа төв Азийн хээр тал хөндийг дамжин умардуу гүн нэвтэрч газар зүйн орчныг маш өвөрмөц завсрын шинжтэй болгосон юм. Хэнтий аймгийн нийт нутаг дэвсгэр хотгор гудгэрийн ялгаа ихтэй учраас өвөл зуны температурын хэлбэлзэл их байна.

Жилийн дундаж агаар температур 1000 м-ээс дээш өргөгдсөн газар нутагт -1.1-1.4 градус байхад 1000 м хүртэл өндөрт буюу тал хээрийн нутгийн дундаж агаарын температур -0.1 градус болж байна.

Жилийн хамгийн хүйтэн сар нь аль ч нутагтаа 1-р сард байх ба үнэмлэхүй бага температур -41.5-45.2 градус, зарим хүйтэн өвөл далайн мандалаас дээш 1302 м өргөгдсөн Хэрлэн голын хөндийн хүйтэн агаар тунан тогтох боломж ихтэйгээс аймгийн бусад газраас илүү хүйтэн болж агаарт -46.3 градус хүрч хүйтэрнэ. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сард байдаг бөгөөд агаарын дундаж температур +18.8 градус байна.

Ялангуяа хавар их салхитай байдаг. Хэнтий аймагт тэмдэглэгдсэн салхины хамгийн их хэмжээ 28-40 м/с хүрчээ. Аймгийн нийт нутгаар жилд дундажаар 1-20 өдөр шороон шуурга шуурна.

Манай аймгийн ой бүхий нутагт бор гөрөөс, зэрлэг гахай, шилүүс, халиун буга, хандгай, хүдэр, баавгай, чоно, үнэг тарвага, хярс, мануул, аргаль зэрэг ан амьтадтай.

Умард мөсөн далай, Номхон далайд цутгах төв Азийн усны хагалбарт орших Хэнтий нуруунаас эх авсан Онон, Хэрлэн, Туул, Балж, Бархан, Эг, Хурх, Улз зэрэг 70 гаруй том жижиг гол, Гурваннуур, Аварга тосон, Тарс, Онон, Хангал, Хөхнүүр зэрэг олон арван рашаан булагтай. Эдгээр цэнгэг уст голд тул зэвэг, хадран, гүрц булуу цагаан, мөнгөлөг хэлтэг, Амар мөрний сугас, Улаан живэр, Амар мөрний цурхай, Амар мөрний хилэм, гутаарь, Зантгар загас, Амар мөрний дэрэг цулбуурт загастай.

Хэнтий аймгийн ойд гүзээлзгэнэ, чацаргана, долоогоно, хад, нэрс, үхрийн нүд, мойл, өрөл, аньс, нохойн хошуу, зэрэг жимс, хуш модны самар, мангир, гоньд, таана, хөмөл, хүнхээл, уулын сонгино, мэхээр зэрэг хүнсний ургамалтай. Мөн сөд өвс, эмийн бамбай, халгай, тарваган шийр, чихэр өвс, царван, ганга, арц зэрэг эмийн ургамалтай баян нутаг юм. Тус аймгийн үзэсгэлэнт нутгаас баруун талын тахилгат Бурхан халдун уул, Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн, Онон, Туул болон тэлгээрт цутгадаг голуудын эх авсан, тайгын бүслүүрийн үндсэн хэв шинжийг агуулсан 12271 м² талбайд "Хан Хэнтийн дархан газар,

зүүн хойд талын 4157 км² нутгийг " Онон-Балжийн байгалийн цогцолборт газар" зүүн талын нутгаараа уулт хээрт шилжих 4700 км2 нутгийг "Тосон хулстайн" БНГазар, мөн Хар ямаат, Түмэнцогт зэрэг 506 км² нутгийн хамарсан "Хар ямаат"-ын БНГазар байдаг.

Манай аймаг нь түүх соёлын дурсгалт газраар баялаг нутаг юм. Үүнд эзэн Чингис хааны төрсөн газар Дэлүүн болдог, ундаалж өгсөн Хажуу булгийн рашаан, хаанд өргөмжилсөн Хар зүрхний хөх нуур, алдарт Монголын нууц товчоог туурвисан Хэрлэнгийн хөдөө арал болон Батширээт сумын нутагт буй ихсийн хориг, Баян-Адрага, Норовлин сумдын нутгийг дамнасан Чингисийн хэрмэн зам, Цэнхэрмандал сумын нутагт буй Чингисийн тулга зэрэг түүхийн дурсгалт зүйл олон. Мөн улсын тусгай хамгаалалтад орсон Батширээт сумын Зураг бичээстэй Рашаан хад Буган чулуу, Баян-Адрага сумын Дуурлиг нарсанд орших Хүннүгийн үеийн язгууртны булш, Баянхутаг сумын Баруун сэрвэн хаалга гэдэг газарт буй, Дэлгэрхаан сумын Аваргын рашааны арын дэнжид орших Аваргын балгас, Их хайлант, Шар хад, Ханангийн энгэрт байгаа олон төрлийн булш, чулуун, зэвсгийн үеийн бууц, Хэрлэн сумын Гэлэн хөшөө хүн чулуутай.

Орон нутгийн тусгай хамгаалалтад орсон Батширээт сумын Өглөгчийн хэрэм, Үзүүр цохионы зүүн талд буй сүг зурагтай хад, Эгийн живхээстэйд орших, сүг зурагтай хад, Дэлгэрхаан сумын Гүн бүрд, тооно ууланд орших хүн чулуу, хиргисүүр, булш, Цэнхэрийн голын хэрэм, Мөрөн сумын Салбарын уулын бичээс, Цэнхэрмандал сумын Бургастай гэдэг газарт буй сүг зурагтай хад болон ар халхын Утай гүмбэн гэж алдаршсан Өмнөдэлгэр сумын Балдан бэрээвэн хийд, Сэцэн хааны ордон цогцолбор зэрэг түүх соёлын дурсгалт зүйл олонтой.


Манай аймгийн нутагт ашигт малтмалын 62 орд, 259 илрэл, 360 эрдэсжсэн цэг илэрснээс чулуун нүүрсний 1, хүрэн нүүрсний 10, шатдаг занарын 3, эефтийн 3, битумын 3, төмрийн хүдрийн 20, кобальт никелийн 5, хар тугалганы 9, цайр, зэсийн 25, цайрын 11, цагаан тугалганы 51, вольфрамын 40, молибдений 20, алт, мөнгөний 92, ураны 6, радиогийн 1, газрын ховор элементийн 3 орд илрэл тус тус бүртгэгдээд байна.

Өнөөдрийн байдлаар "Бэрх-Уул" ХК нь Чандганы ордод нүүрс, "Бэрх Уул" ХК, "Адиулиор гео" ХХК Тохой булгийн ордод алт, "Дацан трейд" ХХК Баян уулын ордод алт, "Баян-Эрдэс" ХХК Салхитын ордод алт, "Бэрх-Уул" ХК Дэлгэрхааны гүний уурхай, "Бор-Өндөрийн" УБҮ Бор-Өндөрийн болон Адагийн жоншны ордод олборлолт явуулж байна. Баянхутаг сумын сондуультын 12 сая м³ шаврын ордоос тоосгоны шавар болон Өндөрхаан хотын ойр орших дулааны энгэрийн элсний карьераас элс, Хэрлэн голын эргийн хэсгээс хайрганы олборлолт явуулж байгаа бөгөөд бусад ААН-үүд үйл ажиллагаагаа эхлээгүй байна.

Өнөөдөр ашиглаагүй боловч ирээдүйтэй зарим ордуудыг дурдвал Гянтболдын нөөцөөрөө Монгол услдаа эхэнд орох Өндөрцагааны орд (175 мян.тн), Мөрөн сумын нутагт орших нүүрсний орд (2 тэрбум тн), Мөнгөн өндөрийн мөнгө-холимог металлын орд (31.3 сая.тн), Сондуультын тоосгоны шаврын орд (15 сая.м³) баялаг ордууд байдаг.

Аймгийн төв нь Чингисхаан хот, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум, 88 багтай, 2016 оны жил эцсийн байдлаар 23.8 мянган өрх, 73.6 мянган хүн амтай. 2016 оны жилийн эцсийн хүн амын бүртгэлээр манай аймгийн суурин хүн ам орон нутгийн засаг захиргааны бүртгэлээр нийт 73608 хүн байгаа нь 2015 онтой харьцуулахад 1269 хүнээр буюу 2.0 хувиар өссөн байна. Хүн амын 46.0% нь аймгийн төвд, 44.7% нь сум, хот тосгоны төвд, 35.0% нь хөдөө амьдарч байна .

График VIII.22.1. Хэнтий аймгийн хүн ам




2. ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ

2.1.Гэмт хэргийн хөдөлгөөн

Гэмт хэргийн хөдөлгөөн гэдэг нь тодорхой цаг хугацаанд гэмт хэргийн мөн чанарт гарсан тооны ба чанарын өөрчлөлт. Гэмт хэргийн хөдөлгөөний үзүүлэлт нь гэмт хэргийн үнэмлэхүй өсөлт, бууралтын хэмжээ буюу түвшинг илэрхийлнэ. Хэнтий аймгийн хэмжээнд 2007-2016 онд 6302 гэмт хэрэг бүртгэгдсэн ба жилд дунджаар 630 гэмт хэрэг бүртгэгджээ.

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.55 хувийг эзэлж байна. 2007 онд гэмт хэргийн гаралт 973 байсан бол 2016 онд 420 болж, 56.8%-аар 2.3 дахин буурсан байна.

График VIII.22.2. Хэнтий аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг



Сүүлийн 10 жилд жилд дунджаар 61 хэргээр буурч ирсэн тооцооллоор үзвэл 2017 онд гэмт хэргийн гаралт 359, 2018 онд 298 болж буурах урьдчилсан прогноз байна.

Хүснэгт VIII.22.1. Хэнтий аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг	21268	20704	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167
Хэнтий аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг	973	775	639	670	727	631	429	578	460	420
Эзлэх хувь %	4,57	3,74	3,14	3,38	3,79	2,86	1,69	2,12	1,66	1,55

2.2.Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 4346 өргөдөл, гомдол, мэдээлэл, дуудлага хүлээн авч шалгаснаас 4334 буюу 99.7-%ийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ. Тухайлбал,

Дээрх шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн 1116 нь гэмт хэргийн шинжтэй (407-д эрүүгийн хэрэг үүсгэсэн, 697-д эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн), 3100 нь захиргааны зөрчлийн шинжтэй (23-д нь торгуулийн хуудсаар, 2341-д нь шийтгэвэрээр тус тус торгож, 278-д баривчлах, 439-д нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 19-г зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр нэгтгэж шийдвэрлэсэн) гомдол, мэдээлэл байжээ.

График VIII.22.3. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт




2.3.Гэмт хэргийн тархалт:

Хэнтий аймагт 2016 онд 420 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны түвшингээс 40 хэрэг буюу 8.7%-аар буурсан байна.

Хэнтий аймагт 2016 онд 73608 хүн ам байгаагаас 16-аас дээш насны 50127 хүн байгаа бөгөөд бусад улс орон, хот, аймагтай жишиж үзэх үзүүлэлт болох 10.000 хүнд ногдох гэмт хэргийн гаралт мөн. Энэ тоо 84 байна.

Хэнтий аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 27.9% нь аймгийн төв буюу Хэрлэн суман, 13.8% нь Бор-Өндөр, 7.1% нь Бэрх, 5.7% тус бүр Мөрөн, Биндэр, Баянхутаг суманд хамгийн ихээр гэмт хэрэг үйлдэгдсэн бол Дадал, Батноров, Хүрх, Баянмөнх сумдад хамгийн бага үйлдэгджээ.

График VIII.22.4. Сумдад бүртгэгдсэн гэмт хэрэг



Хэнтий аймгийн Прокурорын байгууллага 2016 онд гэмт хэргийн талаарх 1148 гомдол, мэдээлэл хүлээн авч, 439-д нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, 696-д нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байх ба 543 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ. Уг газраас тайланд хугацаанд 196 яллагдагчид хамаарах 158 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд 52 эрүүгийн хэрэг түдгэзүүлсэн, 224 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Хүснэгт VIII.22.2. Прокурорын байгууллагын мэдээлэл

№	Үзүүлэлт	Он				
		2013	2014	2015	2016	Дундаж
1	Хүлээн авсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл	1985	1961	1073	1148	1542
	Үүнээс:					
	Эрүүгийн хэрэг үүсгэсэн	478	579	441	439	484
	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	1507	1382	630	696	1054
2	Хэрэг бүртгэлт, мөрдөж байцаалт явуулсан хэрэг	699	753	610	543	651
3	Шүүхэд шилжүүлсэн хэрэг	153	174	191	158	169
	Шүүхэд шилжүүлсэн хүн	233	261	288	196	245
4	Түдгэлзүүлсэн хэрэг	6	5	10	52	18
5	Хэрэгсэхгүй болгосон	348	373	255	224	300

Сүүлийн 4 жилийн хугацаанд жилд дунджаар гэмт хэргийн талаарх 1542 гомдол, мэдээлэл хүлээн авч, 484-д нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, 1054-д нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байх ба 651 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 245 яллагдагчид хамаарах 169 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд 18 эрүүгийн хэрэг түдгэзүүлсэн, 300 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрөөр хэлбэл, Хэнтий аймгийн прокурорын газраас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хэргийн 26.0 хувийг шүүхээд шилжүүлж, 2.8%-ийг түдгэлзүүлж, 46.1%-ийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

2016 онд Хэнтий аймгийн Анхан шатны шүүх 180 хүнд холбогдох 140 эрүүгийн хэргийг хүлээн авч, шүүн таслах ажиллагаа явуулсанаас 2 хүнд холбогдох 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 2 хүнд холбогдох хэргийг мөрдөн байцаалтад буцааж, 31 хүнд холбогдох 19 хэргийг хэрэгсэхгүй болгож, 136 хүнд холбогдох 131 хэргийг шийдвэрлэжээ. Шүүхээс 5 хүнд албадан ажил хийлгэх, 29 хүнд баривчлах, 102 хүнд хорих ял оногдуулсанаас 43 хүний хорих ялыг биечлэн эдлүүлж, 52 хүний ялыг тэнсэн харгалзсан байна.

Увс аймгийн Давж заалдах шатны шүүхээр 15 хэргийг хянан шийдвэрлэсэн бол тус аймагт хамаарах 13 эрүүгийн хэргийг Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэжээ.

2.4.Гэмт хэргийн төрөл

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 36.9% нь хулгайлах, 23.1% нь бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 9.3% нь танхайрах, 8.6% нь ТХХАБАЖЭсрэг, 3.3% нь залилан мэхлэж авах, 2.1% нь завших, үрэгдүүлэх гэмт хэргүүд ихэнх хувийг эзэлж байна.


График VIII.22.5. Гэмт хэргийн төрөл



2.5.Гэмт хэргийн ангилал:

Гэмт хэргийн нийгэм, хүн амд учруулж буй хор хохирлын хэмжээг илэрхийлэх үзүүлэлт бол гэмт хэргийн ангилал байдаг. Хэнтий аймагт 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 41.4% нь хөнгөн, 47.4% нь хүндэвтэр гэмт хэрэг эзэлж байна.

График VIII.22.6. Гэмт хэргийн ангилал



2.6.Гэмт хэргийн илрүүлэлт

Цагдаагийн байгууллага гэмт хэргийн илрүүлэлтийг бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн нь хэргийн эзлэх хувийн жингээр тооцдог. Хэнтий аймагт 2016 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 175 хэргээс 120 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн ба гэмт хэргийн илрүүлэлт 68.6% байгаа нь өмнөх оны түвшингээс 6.9 пунктээр нэмэгджээ.

2.7.Гэмт хэрэгт холбогдогч

Хэнтий аймагт бүртгэгдсэн 420 гэмт хэрэгт нийт 418 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.3%-аар буурсан. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 11.4%-ийг эмэгтэй, 10.5%-ийг хүүхэд, 41.1%-ийг 18-35 насны залуучууд эзэлж байна.

Эдгээрийн 50.7%-ийг тодорхой эрхэлсэн ажилгүй, 20.8%-ийг малчин, 8.4%-ийг хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байна.

График VIII.22.7. Гэмт хэрэгт холбогдсдын нийгмийн байдал



2.8.Гэмт хэргийн хохирол, хохирогч

Гэмт хэргийн халдлагад 446 иргэн хохирч, үүнээс 30 хүн нас барж, 160 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 2 буюу 6.3%-аар, гэмтсэн хүн 5 буюу 3.1%-аар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, ААН, байгууллагад учирсан 1.305.3 сая төгрөгийн хохирлын 905.2 сая төгрөг буюу 69.4%-ийг нөхөн төлүүлж, 306.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

3. ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хэнтий аймагт 2016 онд 7262 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6877 буюу 48.6%-аар буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 6503 иргэн, 3 албан тушаалтан, 7 ААН, байгууллагад 384.9 сая төгрөгөөр торгох, 296 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл, 2977 буюу 89,5%-д цагдаагийн эрх бүхий алба хаагч, 347 буюу 10,4%-д шүүгч, 85 буюу тус тус шийтгэл ногдуулжээ.

Шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан бүх зөрчлийг хянаж шийдвэрлэсэн хууль тогтоомжоор нь авч үзвэл, 2660 буюу 93.1%-ийг "Захиргааны хариуцлагын тухай", 133 буюу 3.5%-ийг "Архидан согтуурахтай тэмцэх тухай", 1 буюу 0.1%-ийг "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай", 8 буюу 0.2%-ийг "Галт зэвсгийн тухай" хуулиар, 45 буюу 1.2%-ийг Тамхины тухай хуулиар, 130 буюу 3.4%-ийг, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль 5 буюу 0.1%-ийг жолоочийн даатгалын хуулиар 5 буюу 0.1% бусад хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэсэн байна.

Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчлийг төрлөөр нь авч үзвэл, 2660 зөрчил бүртгэгдсэний дотор хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн, танхайрах 4275, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх 167, согтуурах 105, бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор хувьдаа ашиглах 63, худалдаа, үйлчилгээний журам зөрчих 9, төрийн байгууллагын ажилтны нэр барих 1, тамга тэмдгийн талаарх журам зөрчсөн 5, бусад 62 зөрчил тус тус бүртгэгджээ.


Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 1216 хүн албадан саатуулсан ба тэдгээрийн 70 буюу 5.5% нь эмэгтэй, 4 буюу 0.3% нь 18 хүртэлх насны хүн байна.

4. ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2016 онд аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослын 101 дуудлага мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оныхоос 1 хувиар буурч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 38 гэмт хэрэг бүртгэгдэж, хэргийн улмаас 23 хүн нас барж, 22 хүн гэмтжээ.

Ирсэн дуудлага мэдээллийн 53 даатгалаар шийдвэрлүүлж, 89 дуудлагад захиргааны арга хэмжээ авч, ослын улмаас 45.2 сая төгрөгийн хохирол учирсаныг нөхөн төлүүлсэн байна.

График VIII.22.8. ТХХАБАЖЭсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 215-225)




Жилд дунджаар ТХХАБАЖЭсрэг 40 гэмт хэрэг гарчээ.

Сүүлийн 7 жилийн хугацаанд жилд дунджаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж, дүрэм, журам зөрсөн 10106 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 1039 иргэнд 109.9 сая төгрөгөөр торгож, 528 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 204 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Хүснэгт VIII.22.3.

№	Он	Зөрчил	Торгосон		Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан	Баривчилсан
			Иргэн	Торгуулийн хэмжээ /сая.төг/		
1	2010	7347	792	42,8	355	75
2	2011	8379	767	47,7	479	162
3	2012	11814	1144	76,4	568	177
4	2013	12709	1649	87,4	728	336
5	2014	17440	1579	110,9	750	289
6	2015	9019	675	56,4	365	184
7	2016	4037	664	347,8	453	-
	Дундаж	10106	1039	109,9	528	204

График VIII.22.9. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж, дүрэм журам зөрчил



БНХАУ-ын замын компанийн тавьж улсын комисс хүлээн аваагүй байгаа Чингис-Чойбалсан чиглэлийн 50 км замд осол ихээр гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зам арчлалтын "Харгуй" ТӨХК-д цагдаагийн байгууллагаас мэдэгдэл хүргүүлж, тодорхой ажлуудыг хийлгэсэн байна. Жолооч, иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн мэдлэг, хөдөлгөөнд оролцох соёл дутмаг байгаа байдал, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал хангагдаагүйгээс хөдөлгөөнд оролцсон, тээврийн хэрэгслийн хурдыг тохируулж яваагүйгээс, хөдөө орон нутагт мотоциклээр хөдөлгөөнд оролцохдоо зориулалтын хамгаалалтын малгай, хэрэгсэл хэрэглэдэггүй, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хөдөлгөөнд оролцсоны улмаас дээрх зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан, нөхцөл нь болсон байна.

5. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 сарын 23 өдрийн 23 дугаар тогтоолоор 23 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэгдэн байгуулагдсан ГХУСАЗСЗ нь аймаг, орон нутгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулж, ажлын явц, үр дүнд хяналттай байх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Уг зөвлөлийн даргаар ИТХ-ын дарга, орлогч даргаар аймгийн Засаг дарга, нарийн бичгийн даргаар хууль, эрх зүйн хэлтсийн дарга, гишүүдэд аймгийн ЗДТГ-ын дарга, СТСХ-ийн дарга, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, ХААГазрын дарга, Шүүхийн Ерөнхий шүүгч, Аймгийн прокурор, Цагдаа, Тагнуул, Онцгой байдал, Мэргэжлийн хяналт, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Аудит, Боловсрол-соёл, Эрүүл мэндийн газрын дарга, Хэрлэн сумын ИТХ-ын дарга, Хэрлэн сумын засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч нар болон Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний тэргүүн, Аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн Хэнтий аймаг дахь салбарын тэргүүн, төлөөллийг оролцуулан байгуулжээ.

Хэнтий аймаг дахь ГХУСАЗСЗ-өөс 2016 онд харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэн, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж

хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулан ажиллаж байна.

ГХУСАЗСЗ нь 2016 онд 3 удаа хуралдаж гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын гүйцэтгэлийг тухай бүр хэлэлцэж ажиллажээ.

ГХУСАЗСЗ 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар 71.0 сая төгрөг төсөвлөж, үйл ажиллагаандаа зарцуулсан ба 22.0 сая төгрөгийг 18 сумдад хуваарилж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулжээ.

2016 онд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлуудад зориулж аймгийн цагдаагийн газарт 20.8 сая төгрөг, шүүхэд 2.0 сая төгрөг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 8.0 сая төгрөг, прокурорын газарт 2.0 сая төгрөг, тахарын албанд 1.2 сая төгрөг, мэргэжлийн хяналтын газарт 0.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус үзүүлж ажиллажээ.

- Аймгийн тодорхой сумдад өнгөт чулуу олборлох, худалдан авах асуудал онцгой анхаарал хандуулаад байсныг салбар зөвлөлийн хурлаар удаа дараа хэлэлцэн Батноров, Бор-өндөр, Дархан, Баянмөнх, Хэрлэн сумдуудад хууль бусаар өнгөт чулуу олборлож байгаль дэлхийд ноцтой хохирол учруулж байгаад дүн шинжилгээ хийж, хуулинд тодорхой заалтуудыг тусгуулах санал боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн байна.
- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргад иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Батширээт сумын Онон багийн нутаг гутайн даваанд ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулсан гэх нэг компаний үйл ажиллагаанд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газарт холбогдох албан бичгийг хүргүүлж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, хууль бус үйлдлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авсан.
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 36 дугаар тогтоолоор Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор батлагдсан "Мал, мах түүхий эдийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журам"-ын дагуу 2016 онд сумдад 34400 ширхэг гарал үүслийн гэрчилгээ олгосноос эргэн төлөлт 100 хувь хийгджээ. Мөн энэхүү журмын зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах санал иргэдээс ирж байгаатай холбогдуулан тус журамд өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
- Цагдаагийн газрын санаачилгаар аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Боловсрол соёл, урлагийн газар, "Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллагын Бор-Өндөр-2 хөгжлийн хөтөлбөр зэрэг байгууллагуудтай хамтран хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, сурагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг хөгжөөнт хэлбэрээр сурталчилан таниулах зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг "Хүүхэд хууль-2016" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг "Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" сэдвийн хүрээнд зохион байгуулсан байна. Тэмцээний 1 дүгээр шатанд Ерөнхий боловсролын 22 сургуулийн нийт 8000 орчим багш, сурагч, эцэг, эх хамрагдсан байна.
- "Хүүхэд хууль-2016" аймгийн аварга шалгаруулах тэмцээний 2 дугаар шатыг бүсийн хэмжээнд 2016 оны 11-р сарын 25-ны өдрөөс 12-р сарын 04-ний өдрүүдэд Галшар, Өмнөдэлгэр, Батширээт, Бэрх тосгон, Хэрлэн сумдад зохион байгуулагдаж тэмцээнд 22 нийгмийн ажилтан, 176 сурагч оролцож, 5 сумын 2000 орчим хүүхэд, залуучууд үзэж сонирхсон байна. Тус тэмцээний хүрээнд аймгийн нийтдээ 10.000 гаруй багш, сурагч, эцэг, эхийг хамруулан хууль сурталчлах ажил хийж ажилласан байна.
- Хүүхдүүдийн дунд "Ногоон гэрэл-Цагаан шугам" тэмцээнийг амжилттай зохион байгуулжээ.

- Салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" бүсчилсэн зөвлөгөөнийг 11-р сард аймгийн зүүн, урд, баруун, хойд гэсэн 4 бүсийн 15 сумдыг хамарч зохион байгуулж ажилласан. Мөн төвийн бүсийн зөвлөгөөнийг 12-р сард Хэрлэн суманд зохион байгуулж аймгийн 18 сум 5 тосгоныг хамруулсан байна. Орон нутгийн төрийн болон хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дээрх зөвлөгөөнийг энэ жил өндөр хэмжээнд ач холбогдол өгч зохион байгуулсан бөгөөд зөвлөгөөний үеэр гарсан санал, санаачлагыг нэгтгэн боловсруулж, сумдын ГХУСАЗСЗ-үүдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангах ажиллах талаар зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Тус зөвлөгөөнөөр:

- Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга Л.Батсайхан - Хэнтий аймаг ГХУСАЗСЗ-ийн ажлын чиг үүрэг сэдвээр,
- Цагдаагийн газрын дарга, хурандаа О.Ганбат - "Аймгийн хэмжээн дэх эрүүгийн нөхцөл байдал, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын оролцоо" сэдвээр,
- Аймгийн прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Д.Энхбаяр - "Гэмт хэргийн шалтгаан нөхцөл" сэдвээр,
- Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Мөнхтулга - "2016 онд Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хэлэлцэгдсэн хэрэг тэдгээрийн шийдвэрлэлт, гэмт хэргийн төрлийн зонхилох хувь хэмжээ" сэдвээр,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дэд дарга, дэд хурандаа Б.Баярсайхан - "Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал" сэдвээр тус тус мэдээлэл танилцуулсан.

Аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч Д.Оюунцэцэг нийт 32 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, Хэнтий аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Цэрэндулам нь иргэний хэргийн шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, шүүхийн танилцуулга, шүүхийн шинэтгэлийн үр дүн зэргийг сумдын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар болон иргэдэд танилцуулан, иргэний анхан шатны шүүхийн процесс ажиллагааг явуулж ажиллажээ. Мөн сумдын ГХУСАЗСЗ-өөс хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайлан, мэдээлэллийг сонссон байна.

6. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Нийгмийн хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж байгаа өнөө үед бүс нутгийн онцлог, хүн амын амьжиргааны баталгаажих түвшингээс хамаарч гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлд ч өөрчлөлт гарч, гэмт хэрэг үйлдэж байгаа арга, хэлбэр шинэ хэлбэрт шилжиж байна. Иймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахдаа тухайн хэргийн шалтгаан нөхцөл тус бүрийг анхааралтай, нарийн судлах шаардлага байгаа бөгөөд түүнд тохирсон урьдчилан сэргийлэх ажил хэрэгжүүлэх нь зүйтэй байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутгийн түвшинд явуулахад тулгамдаж буй асуудлууд бол хууль эрх зүйн орчны хангалтгүй байдал, хуулийн байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлын уялдаа холбоо, гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ажилд зарцуулах төсөв хөрөнгийг дутмаг байдал, ард иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг хангалтгүй байгаа байдал юм.

Түүнчлэн, кибер халдлага, шашин шүтэх, эс шүтэх, хар тамхи, мансууруулах бодис, насанд хүрээгүй хүүхдүүтэй холбоотой шинэ төрлийн гэмт хэргүүд үйлдэгдэж, улмаар шинээр мөрдөгдөж буй хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллах орчин нөхцөл бүрдээгүй зэрэг хүндрэл бэрхшээлүүд байна гэжээ.

Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хуулийн байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь уялдуулах, ард иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг явуулах шаардлагатай байна. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, байгууллага хооронд туршлага судлуулах, санал бодлыг солилцуулах, төр олон нийтийн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг хийх арга зүйн зөвлөмжийг сум, байгууллага, баг, иргэдэд өгөх, телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлгүүдийг түлхүү иргэд рүү чиглэн явуулах нь зүйтэй.

Цэнхэрмандал суманд замын цагдаагийн хяналтын иж бүрэн постын барилга барих Дадал суманд цагдаагийн хэсгийн кабон байр барих, цагдаагийн газрын албаконторын барилгыг шинэчлэх ажлыг 2017 онд эхлүүлэх, Цэнхэрмандал суманд Замын хяналтын төв барих, Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт хууль сахиулах байгууллагуудын сургалт, дадлагын төв байгуулах ажлыг эхлүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх саналыг цагдаагийн байгууллагаас гаргасан байна.

ДҮГНЭЛТ

Хэнтий аймагт 2016 онд 420 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, прокурорын байгууллагаас 543 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, шүүхээс 140 эрүүгийн хэрэг хүлээн авч, шийдвэрлэжээ. 2016 онд гэмт хэргийн халдлагад 446 иргэн хохирч, үүнээс 30 хүн нас барж, 160 хүн эрүүл мэндээрээ хохирч, иргэн, ААН, байгууллагад учирсан 1305.3 сая төгрөгийн хохирол учруулчээ.

Хэнтий аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил бусад аймагтай харьцуулахад үр дүнтэй явагдсан нь үйл ажиллагааны тайлан, гэмт хэргийн тоон үзүүлэлт буурсан байдал, интернэт сайт, холбогдох эх сурвалжуудаас ажиглагдаж байна. Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, олон нийтэд хүргэх ажлыг сайжруулах шаардлага харагдаж байв.

MIAT
MONGOLIAN AIRLINES

ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАР



23. ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАР

Манай орны хувьд иргэний агаарын тээврийн салбар нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэгч, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг хөгжүүлэгч томоохон хүчин зүйл мөн. Дэлхийн далайд гарцгүй орнууд дотор Монгол Улс газар нутгийн хэмжээгээрээ Казакстан улсын дараа ордог, тээврийн харилцааны хязгаарлагдмал байрлал бүхий бүсэд оршдог орон.

Манай улсын агаарын тээврийн салбар нь харьцангуй шинэ салбар боловч үндэсний болон олон улсын эрх зүйн хүрээнд баталгаажсан, олон улсын хамтын нийгэмлэгийн худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг хөгжүүлэгч гишүүний бүрэн эрхтэй хөгжиж байна[37].

ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монголын Иргэний Агаарын Тээвэр буюу "МИАТ", **(Mongolian Civil Air Transport)** нь Монголын үндэсний авиа компани ба төв байр нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана. Төв буудал нь Чингис хаан олон улсын нисэх буудлаас олон улсын 7 чиглэлд тогтмол нислэг үйлддэг, олон улсын агаарын хилээр гадаад улс орнуудтай шууд харилцдаг салбар болж хөгжиж байна.

Монгол Улсад анх 1925 онд агаарын ачаа тээврийн Y-13 онгоц оруулж ирсэн, түүнээс хойш 1946 онд тээврийн долоон онгоц, нэг По-2 онгоцтой болсноор Иргэний агаарын тээврийн тасаг байгуулагдаж Дундговь, Сүхбаатар, Сайншанд, Өндөрхаан чиглэлд дотоодын иргэний агаарын тээврээр үйлчилж эхэлсэн.

Монгол Улс 1958 оны байдлаар Ан-2 онгоц 14, Ил-14 онгоц 7, нийт 21 онгоцтой болж 1970 он гэхэд Монголын иргэний агаарын тээврийн "МИАТ" компани аймаг, сум, нэгдлийн төв зэрэг дотоодын нислэгийн 130 газарт буюу нийт нислэг үйлддэг газрынхаа 80%-д, 1987 оноос "МИАТ" компани ЗХУ-аас Ту-154 онгоц түрээслэн авч олон улсад нислэг үйлдэж үйлчилж, 1993 оноос "МИАТ" бие даасан, төрийн өмчийн иргэний агаарын тээврийн компани болсон түүхтэй.

Өрсөлдөөнт эдийн засгийн өнөө үед "МИАТ" компани 1993 онд Ан-24 онгоц 12, Ан-26 онгоц 3, Ми-8 нисдэг тэрэг 3, Ю-12 онгоц 5, Ан-2 онгоц 45, Боинг 727-800 онгоц 3, Ан-30 онгоц 1, нийт 71 онгоцтойгоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Иргэний агаарын тээврийн салбарын өнөөгийн байдал

ИНЕГ нь Засгийн газрын "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2014 оны 387 дугаар тогтоолын дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай үйл ажиллагаагаа явуулж, харьяа төв, орон нутгийн 28 салбар байгууллагатай, нийт 2235 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

"МИАТ" компани 1992 онд Хятад улсын Харбин Ю-12 онгоц 5 ширхгийг, Кореан Айр компаниас Боинг 727-200 онгоцноос нэгийг худалдан авч, Солонгосын Ханжин группээс бас нэгийг бэлгэнд авч, 1994 онд дахин нэгийг худалдан авснаар Боинг 727-200 төрлийн 3онгоц, 1998 онд "МИАТ" компани Эйрбас 310-300 онгоцыг түрээслэн авч эдгээр онгоцоор 2003-2008 он хүртэл нислэг үйлдсэн.

37 Иргэний агаарын тээврийн (*ИКАО, ICAO* International Civil Aviation Organization) олон улсын, бүс нутгийн гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн орсон

"МИАТ" компани 2011 оны эхээр China Eastern Airlines компанитай хоёр Боинг 767-300 ER онгоцыг 2013 хүртэл түрээслэх гэрээ байгуулан нислэгийн үйлчилгээнд ажилласан.

Монгол Улс гадаад зах зээлд нэвтрэх, хөрөнгө оруулагчдыг татах, жуулчдад үйлчлэх, эдийн засгийг дэмжих нэн чухал үүрэгтэй иргэний нисэхийн салбар болох "МИАТ" компани Япон улсын Токио хот руу өвлийн улиралд долоон хоногт 2 удаа, зуны улиралд долоон хоногт 6 удаагийн давтамжтайгаар, Сөүл хот руу өвлийн улиралд долоон хоногт 6 удаа, зуны улиралд долоон хоногт 10 удаагийн давтамжтайгаар, Бээжин хот руу өвлийн улиралд долоон хоногт 9 удаа, зуны улиралд 14 удаагийн давтамжтайгаар, Хонконг хот руу өвлийн улиралд долоон хоногт 3 удаа, зуны улиралд долоо хоногт 7 удаагийн давтамжтайгаар, Москва хот руу жилийн аль ч улиралд долоон хоногт 2 удаагийн давтамжтайгаар, Сингапур хот руу 5-р эрхтэйгээр буюу Бээжин хотоор дамжин долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар, Берлин хот руу өвлийн улиралд долоон хоногт 2 удаа, зуны улиралд долоон хоногт 4 удаагийн давтамжтайгаар, нийт олон улсын 7 чиглэлд хуваарьт нислэг үйлдэж байна.

Мөн Япон Улсын Осака хот руу улирлын чанартайгаар буюу зөвхөн зуны улиралд долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар, Ханой, Дубай, Бангкок, Чежү зэрэг хотууд руу захиалгат нислэгээр үйлчилдэг нийт замын урт 18000 гаруй км болсон.

"МИАТ" компани 2011 онд Америкийн Боинг компанитай онгоц худалдан авах гэрээ шинээр байгуулж, Боинг онгоцыг 2013 оны 05 сарын 15-ны өдөр түүхэндээ анх удаа, дараа нь 2015 онд хоёр дахь удаа 2 онгоц нь үйлдвэрээс нь шууд хүлээн авсан билээ. "МИАТ" компани 2018 оноос эхлэн АНУ руу шууд нислэг үйлдэх зорилттой ажиллаж байна.

Шинэчлэл

Иргэний агаарын тээврийн дотоод, гадаадын сүлжээг өргөтгөх, орон нутаг, олон улсын нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх, үнэ тарифыг бууруулах, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх шинэчлэлийн хүрээнд Пусан, Бангкок зэрэг шинэ чиглэл нэмэгдүүлэх, Австрали болон Зүүн Өмнөд Азийн 7 чиглэлд шинэ шугам нээхээр төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газраас 2020 он хүртэл иргэний агаарын тээврийн салбарт баримтлах төрийн бодлогыг баталсан ба энэхүү бодлогын хүрээнд одоогийн нийт нислэгийн цагийг 2 дахин ихэсгэх төлөвлөгөөтэй байна.

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал нь Монгол Улсын тэргүүлэх зэрэглэлийн нисэх онгоцны буудал учир үндэсний агаарын тээврийн компаниуд болох "Хүннү эйр", "МИАТ", "Изинис Эйрвэйз", "Аэро Монголиа" нь "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлыг ашигладаг[38].

Үндэсний агаарын тээвэрлэгч "МИАТ" компани Бүгд найрамдах Солонгос улсын нийслэл Сөүл хотын чиглэлд аялах нислэгээс гадна 2017 оны 6-р сарын 22-ноос эхлэн Бүгд найрамдах Солонгос улсын Бусан хот руу долоо хоногт хоёр удаа пүрэв, ням гараг бүр Боинг агаарын хөлгөөр шууд нислэг тогтмол үйлдэхээр болсон.

Үндэсний агаарын тээвэрлэгч "МИАТ" компани Боинг 737-800 гурван ширхэг, Боинг 767-300 бүр хоёр, нийт таван агаарын хөлөг мөн дээрхээс гадна Улаанбаатараас Бээжин, Хонконг, Сөүл, Токио, Москва, Берлин, Франкфурт хотуудад тогтмол нислэг үйлдэж, Хайнань, Чэжү арал, Японы Нагоя, Фүкүока, Бали арал зэрэг олон хотуудад захиалгат нислэг үйлдэж буй.

38 Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэргийг Эрхлэх Яамны сайдын 107 тоот тушаалаар1957 оны 2-р сарын 19-ний өдөр байгуулж, Улаанбаатараас Эрхүү, Бээжингийн чиглэлд олон улсын нислэг хийдэг болсноор 1958 онд Ил-14 онгоцоор "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал болсон. Монгол улсын Засгийн газрын 2005 оны 12-р сарын 21-ний өдөр 255 дугаар тогтоолоор Чингис хаан Олон Улсын нисэх буудал болгон өөрчилсөн.

Нисэх буудал

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос баруун урд зүгт 14.7 км-ийн зайд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр Буянт-Ухаад байрладаг нисэх онгоцны буудал. Баруунаас зүүн рүү бууж, зүүнээс баруун руу нисэх хатуу хучилттай нислэгийн нэг зурвастай.

ИНЕГ-ын харьяа Буянт-Ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал нь цагт 1000 хүнд үйлчлэх хүчин чадалтай олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, 24 цагийн үйл ажиллагаатай, зорчигч үйлчилгээний цогцолбор.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрсөн 82.6 мянган агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдалд үйлчилж, бүс нутгийн хэмжээнд хоёрдугаар байрт орж, улсын төсөвт 45.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн[39] байна.

Ачаа, зорчигч тээвэрлэлт

Монгол Улсын Иргэний нисэхийн салбар жил бүр эрчимтэй хөгжиж байгаа нь уул уурхайн үйлдвэрлэл, шуудан тээвэр, ложистик, аялал жуулчлалтай харилцан холбоотойгоор ачаа, зорчигч эргэлт өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг дагаад агаарын тээвэрлэгч компаниуд агаарын хөлгийн паркийн хүчин чадлаа нэмэгдүүлж, орон нутагт төдийгүй олон улсад өрсөлдөх чадвараа сайжруулсаар байна.

Иргэний агаарын тээврийн салбарын хэмжээнд нийт ачаа, зорчигч тээвэрлэлт 2011 оноос хойш жил бүр 23,1%-аар, тээсэн ачаа 4,7%-аар, шуудан тээвэр 17,2%-аар өссөн үзүүлэлттэй.

Монгол Улсын иргэний агаарын хөлгийн бүртгэлд 51 агаарын хөлөг бүртгэлтэйгээс 33 агаарын хөлөг нислэгт тэнцэх чадварын хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна. Дотоодын агаарын тээврийн 10 компани ("МИАТ" ТӨХК, "Аэромонголиа", "Изинес Эйрвэйз", "МАК", "Геосан", "Хүннү Эйрлайнес", "Блю скай авэйшн", "Тэнгэрийн улаач шинэ", "Томас эйр", "А-Жет авэйшн") үйл ажиллагаа гүйцэтгэдэг бөгөөд салбар дахь тоон мэдээлэл өдөр, сар, жилээр өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Олон улсын зорчигч тээвэрлэлтийг 2012 оны өмнөх онуудтай харьцуулж үзвэл 2011 оноос 14,8%-аар, 2010 оноос 19,5%-аар, 1993 оноос хойш жилд дунджаар 11,4%-аар тус тус өссөн.

Хүснэгт VIII.23.1. 2012-2016 оны нислэгийн чиглэлийн тоон үзүүлэлт

Чиглэл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 оны II
Олон улсын чиглэлд	9 а/тээвэрлэгч 13 чиглэлд	8 а/тээвэрлэгч 14 чиглэлд	7 а/тээвэрлэгч 17 чиглэлд	8 а/тээвэрлэгч 15 чиглэлд	8 а/тээвэрлэгч 15 чиглэлд
Орон нутгийн чиглэлд	3 а/тээвэрлэгч 18 чиглэлд	3 а/тээвэрлэгч 17 чиглэлд	4 а/тээвэрлэгч 16 чиглэлд	3 а/тээвэрлэгч 14 чиглэлд	3 а/тээвэрлэгч 11 чиглэлд

Иргэний агаарын тээврийн салбар 2016 оны эхний 10 сард дотоод зорчигч 193,9 (33,9%) мянга буюу өмнөх оноос 31,2 (19,2%) мянга, гадаад зорчигч 378,5 (66,1%) мянга болж 9,2 (2,5%) мянгаар өссөн байна. Агаарын тээврийн салбарын орлого 2016 оны эхний 10 сард 242,7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 21,3 (9,6%) тэрбум төгрөгөөр өссөн.

39 Манай улс өөрийн нутаг дэвсгэр дээгүүр өнгөрч буй агаарын 90 орчим мянган хөлгүүдийн 80 гаруй хувийг харж, удирдах боломжтой болсон. 2016 он

ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улс болон хоёр хөрш улсын хил дагуу нийт агаарын хаалга 15 тогтоогдсон байдаг бөгөөд ОХУ-тай 9 нь, БНХАУ-тай хиллэдэг хилийн дагуу 6 нь тус тус байрладаг.

2012 оны байдлаар Монгол Улсын агаарын зайгаар өнгөрөлтийн нийт 82627 нислэг, 6354 олон улсын буулт, хөөрөлт үйлдэгдсэн ба энэхүү үзүүлэлтийг 2011 онтой харьцуулахад дамжин өнгөрөлт 6%-аар, олон улсын хөөрөлт, буулт 4,1%-аар жил бүр тасралтгүй өссөн үзүүлэлттэй.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын суурьшил сийрэг, далайд гарцгүй манай орны хувьд иргэний нисэхийн салбар нь гадаад ертөнцөд гарах гол гарц төдийгүй үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйл гэж үзэж, агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин хөгжүүлэхээр тогтож, "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичиг"[40] батлан гаргасан.

Монгол Улс ашигт малтмалын томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж эхэлснээр эдийн засгийн өсөлт түргэсэх, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг дагаж машин, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний барааны импорт, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, ачаа эргэлт эрс өсөх хандлагатай байна.

Агаарын тээврийн хөгжлийн хандлага нь "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр, "Төрөөс иргэний агаарын тээврийн талаар баримтлах бодлого" зэрэг өмнө нь батлагдан гарсан бодлогын бичиг баримт, хөтөлбөрүүдтэй уялдуулан гаргасантай холбоотой.

Манай агаарын тээврийн салбар нь ХБНГУ, Бельги, Голланд, Европын холбоо, АНУ, Канад, Австрали, Япон, БНСУ, Сингапур, ОХУ, БНХАУ, Сингапур зэрэг салбарын хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч улсуудын иргэний нисэхийн салбарын талаар судалгаа хийж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний олон улсын байгууллага (CANSO), Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо (IATA) зэрэг салбарын хөгжилд нөлөө бүхий олон улсын байгууллага, холбоодоос гаргасан заавар, зөвлөмж, стандартыг ашиглаж хурдтай хөгжих хандлагатай.

Тухайлбал, "МИАТ" ТӨХК-д 2014 онд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараараа агаарын тээврийн "3" одны болзол хангасан, нийт нислэгийн тоо 2014 онд анх удаа 100 мянга давсан, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлэгчдийн тоо 1.1 саяд хүрсэн.

Хүснэгт VIII.23.2.

Он	Зорчигчид	Өмнөх оноос (%)	Нислэгийн тоо	Ачаа (тонн)
2007	599,555	□+9.6%	9,297	3,299
2008	596,765	□-0.5%	9,552	3,500
2009	532,861	□-10.7%	8,330	2,970
2010	665,055	□+24.8%	11,678	3,922
2011	885,885	□+33.2%	14,940	5,452
2012	1,098,865	□+24.0%	17,465	5,709
2013	1,106,704	□+0.7%	16,468	5,825

40Монгол Улсын Их Хурлаас 2013 оны хоёрдугаар сарын 7-ны өдөр "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичиг" батлагдсан.

Шинэ нисэх буудал

Хөшигийн хөндийн нисэх буудал (англи. *New Ulaanbaatar International Airport* буюу *NUBIA.*) нь Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл нэртэйгээр баригдаж буй шинэ нисэх онгоцны буудал. Улаанбаатар хотоос 52 км зайд Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт баригдаж байгаа бөгөөд 2017 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй.

Энэхүү бүтээн байгуулалтын үр дүнд тус буудал нь жилд 3 сая зорчигчид үйлчлэх хүчин чадалтайгаар төлөвлөгдсөн, үүний зэрэгцээ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, "Богд хан" төмөр замын төсөлтэй уялдуулснаар их хот урд зүгтээ тэлэн хөгжих асуудал бодит ажил хэрэг болон олон мянган иргэд шинээр ажлын байраар хангагдах нөхцөл бүрдэж Хөшигийн хөндийд шинэ дагуул хот[41] бий болно. Шинээр баригдаж буй Олон улсын нисэх буудлыг Хойд Азийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа болгон тус нисэх буудлын нутаг дэвсгэрийг оролцуулан эдийн засгийн чөлөөт бүс[42] байгуулна.

Шинэ нисэх буудлын цогцолбор нь жилд гурван сая хүртэл зорчигч хүлээн авах хүчин чадалтай орчин үеийн шаардлагад бүрэн нийцсэн зорчигч үйлчилгээний барилга, цаг агаарын тааламжгүй байдал, салхины чиглэлээс үл хамааран 24 цагийн турш агаарын хөлөг хүлээн авах хоёр талын оролт, гаралттай зурвас, орчин үеийн техник хэрэгсэл, төхөөрөмжөөр тоноглогдсон нислэгийн хөдөлгөөнийг удирдах цамхаг болон бие даасан дулаан, ус хангамж, цэвэрлэх байгууламж зэрэг 30 гаруй барилга байгууламжуудаас бүрдсэн иж бүрэн цогцолбортой.

Цаашдаа зорчигч үйлчилгээний барилгыг 20 хүртэл хүзүүвчтэй болгон жилдээ 22 мянган агаарын хөлөг хүлээн авч, 12 сая хүртэл зорчигчид үйлчлүүлэх боломжтой өргөтгөлийг тооцсоноос гадна дахин нэмэлт зурвас барих зай талбайг төлөвлөсөн[43].

Аюулгүй байдал ба гэмт хэрэг, зөрчил

Өнөө үед олон улсын нисэх буудал нь террорист халдлага, хил дамнаж үйлдэгддэг гэмт хэргүүдийн гол цэг болж байгаа учир Хөшигийн хөндийн нисэх буудал нь аюулгүй байдлыг дээд зэргээр хангахаар зохион байгуулагдсан гэж тодорхойлж байна.

Монгол Улсын агаарын тээвэр жил ирэх тутам өргөжиж байгаа тул хил дамнасан гэмт хэргүүдийг илүү нарийн технологи ба зохион байгуулалтаар илрүүлж аюулгүй болгох нь гол зорилго тулгарах нь ойлгомжтой[44].

Хөшигийн нисэх буудал нь жилд 22000 агаарын хөлөг хүлээн авч 3 сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай зорчигч үйлчилгээний барилга 6 хүзүүвчтэй, нийт 37000 м^2 талбайтай ашиглагдах учир гэмт хэрэг, зөрчлийг илүү нарийн зохион байгуулалттайгаар илрүүлж дотоодын аюулгүй байдлыг сахих нь буудлын зохион байгуулалтын чухал бүрдэл хэсэг болж байна.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган шийдвэрлэх, гэмт хэргийг мөрдөн шалгахдаа хуульд тогтоосон харьяаллыг баримталдаг.

Иргэний агаарын тээврийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1991 оны 8 сарын хуралдаанаар хэлэлцэн аяллын замд зорчигчдын ая тух алдагдуулах, амь нас, эрүүл мэнд, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй эрчимтэй тэмцэх ажлын зохион байгуулалтын хүрээнд 1992 онд онгоцны нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдалтай

41 Төсөл хэрэгжиж 2017 онд шинэ нисэх буудал ашиглалтад орсноор 100 мянган хүн ам оршин суух дагуул хот шинээр үүсэх нөхцөл бүрэлдэнэ.

42 "Чөлөөт бүсийн тухай хууль", УБ., 2015.02.12.

43 Ирээдүй судлалын ухааны үндэслэлтэйгээр тооцсон

44 Эд өлгийн зүйлс, хууль бус сэргээш, палеонтологийн олдвор, хар тамхи, үнэт металл зэргийг нэвтрүүлэх хэргүүд байнга гарч байна. Ноцтой гэмт хэрэг нь 2010 онд Өмнөд Солонгосын 13 жуулчин 15кг алтыг Монгол улсаас хууль бусаар шилжүүн гэдсэндээ хийж авч гарах гэж байгаад баригдсан гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн.

холбоотойгоос бусад гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах харьяаллыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад шилжүүлсэн нь өнөөг хүртэл мөрдөгдсөөр байна.

ХОЁР. ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭРТ ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Иргэний агаарын тээвэрт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал

Гэмт хэргийн нөхцөл байдлыг судалгаанд хамрагдсан 6 жилийн хугацаанд хууль сахиулах байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэсэн гэмт хэрэг, ангилал, төрөл, илрүүлэлтийн тоо, хувийн жин зэрэг үзүүлэлтийг харьцуулан тоймлон дүгнэв. Үүнд:

Улсын хэмжээнд 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;

Иргэний агаарын тээврийн салбарт үйлдэгдэж 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;

Иргэний агаарын тээврийн салбарын хувьд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн дүнтэй харьцуулсан хувийн жинг шинжлэн дүгнэсэн болно.

Улсын хэмжээнд хууль сахиулах байгууллага (Цагдаагийн байгууллага) судалгаанд хамрагдсан 2011-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт 1851977 гомдол, мэдээлэл хүлээн авч үүнээс гэмт хэргийн шинжтэй нийт 486699 гомдол, мэдээллийг шалган 230361 тохиолдолд буюу 47,3%-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 310592 тохиолдолд буюу 63,8%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт 226674 буюу 42,4%, 6-19 хоногт 260054 буюу 57,6%-ийг шалгасан. (Хүснэгт VIII.23.3), (Хүснэгт VIII.23.4)

Иргэний агаарын тээврийн салбарт (Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэс) 2011 онд гэмт хэргийн шинжтэй **29** гомдол, мэдээллийг шалгаад **6** тохиолдолд буюу 20,6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн, **23** тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, 2016 онд **54** гомдол, мэдээллийг шалгаад **14** тохиолдолд буюу 25,9%-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, **40** тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь судалгаанд хамрагдсан эцсийн жил 2016 онд хүлээн авсан гомдол, мэдээлэл нь судалгааны эхний жил 2011 оны дүнгээс +314 нэгжээр өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл +50 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэсэн +25 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан +17 нэгжээр өссөн бөгөөд нийт дүнгээр нь шинжлэн үзвэл бүх үзүүлэлт жил бүр огцом өсөх хандлагатай байна.

Харин 2013-2015 онд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тохиолдол **23-54** нэгж болж өссөн нь гэмт хэргийн шинжтэй тохиолдлууд өссөн байх магадлалтай анхаарах асуудал болно. (Хүснэгт VIII.23.3), (Хүснэгт VIII.23.4)

Гэмт хэргийн илрүүлэлтийн нөхцөл байдал:

Иргэний агаарын тээврийн салбарт 2011-2016 онд нийт 77 (өсөлт 5 дахин) гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 53 (илрүүлэлт 86,5%), хүндэвтэр 72, хүнд 12, онц хүнд 4, илрээгүй хэрэг 9 үүнээс хулгайлах гэмт хэрэг 4, 5 нэгж танхайрах зэрэг гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байгаа дүн мэдээлэл гарсан байна.

Иргэний агаарын тээврийн салбарт 2011 онд нийт 11 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 4, илрүүлэлт 100%, хүндэвтэр гэмт хэрэг 5, илрүүлэлт 100%, хүнд гэмт хэрэг 1,

онц хүнд гэмт хэрэг 1, гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 1, нийт гэмт хэргээс хулгайлах гэмт хэрэг 2, танхайрах гэмт хэрэг 1 байсан бол 2016 оны байдлаар нийт 10 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 6, илрүүлэлт 100%, хүндэвтэр гэмт хэрэг 4, илрүүлэлт 100% бүртгэгдсэн бөгөөд хүнд, онц хүнд ангиллын хэрэг бүртгээгүй байна. (Хүснэгт VIII.23.4.)

ДҮГНЭЛТ

Иргэний агаарын тээврийн салбарт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллийг Улсын хэмжээний дүнтэй харьцуулбал нийт гомдол, мэдээллийн 0,05%, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 0,08%, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн 0,03%, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 0,09%, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн хувьд хөнгөн 0,07%, хүндэвтэр 0,1%, хүнд 0,11%, онц хүнд 0,13%, илрээгүй хэрэг 0,03%, хулгайлах хэрэг 0,02%, танхайрах хэрэг 0,27% тус тус эзэлж байна.

Улс орны эдийн засаг, агаарын тээврийн ачаа болон зорчигч эргэлтийн эрс өсөлт болон улсын хэмжээнд хүлээн авч шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, мөрдөн шалгасан гэмт хэрэгтэй харьцуулахад хүнд, онц хүнд ангиллын гэмт хэргийн илрүүлэлтийн хувь харьцангуй бага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх бүтэц, зохион байгуулалт, удирдлага, арга зүй, сэтгэлгээний болон мэргэжлийн чадвар, хандлага дутагдалтай байна гэж үзэх үндэслэлтэй.

Иргэний агаарын тээврийн салбарт хууль сахиулах, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд мөрдөн шалгасан нийт гэмт хэргийн **91,2-94,8%** нь ил цагаан үйлдэлтэй хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг шалгаж, ихээхэн цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө зарцуулсан харин зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгдэх гэмт хэрэгтэй тэмцэх[45], урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй гэж дүгнэхэд хүрч байна.

Ачаа болон зорчигч тээврийн эргэлт, эдийн засгийн эрчим өндөртэй, цаашид эрчимтэй хөгжих зорилготой бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл дуусаж байгаа энэ салбарт хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа нь зөвхөн гомдол, мэдээллийг хүлээн авах төдийгөөр бус илүү өргөн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй мэргэшсэн албаны бүтэц, зохион байгуулалттайгаар, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан алсын хараа, стратеги, төлөвлөлттэй ажиллах шаардлагатайг илэрхийлнэ. (Хүснэгт VIII.23.5, VIII.23.6.)

Дүгнэлт

Бүртгэсэн гэмт хэргийн 91,2-94,8% нь хөнгөн, хүндэвтэр ангилалын, үйлдэл нь илэрхий гэмт хэргүүд мөрдөн шалгасан нь цаг хугацаа, хүн хүч, төсвийн зардлын хувьд ч үрэлгэн ажилласан байх ба хуулиар тогтоосон үүргийн хувьд ч туйлын хангалтгүй байна.

Энэ салбарт эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой далд үйлдэлтэй, албан тушаал, гаалийн хууль тогтоомж болон татварын хууль тогтоомж, банк, санхүүгийн, аж ахуйн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдсэн байна. (**Хүснэгт VIII.23.5.**)

Иймд гэмт хэрэгтэй тэмцэх салбарын тогтолцоог эрс өөрчлөх, чиг үүргийг тодорхой болгох, улмаар мэргэшсэн алба, мэргэжлийн алба хаагч ажиллах орчныг бий болгох гэмт хэрэгтэй тэмцэх, Криминологийн шинжлэх ухааны үр дүнг ашиглан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрс шинэчлэх, тогтолцоо, бүтэц, бодлогыг шинэ нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх шаардлага байна.

45 Эдийн засгийн салбар дахь гааль, татвар, агаарын тээвэр, банк санхүү, төсвийн хууль тогтоомж зөрчсөн хүнд, онц хүнд ангиллын зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж үзэх үндэслэлгүй тул Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэхэд хүргэж байна.

Хүснэгт VIII.23.3. Хүлээн авсан нийт гомдол, мэдээлэл

№	ХСБ-га	Хүлээн авсан нийт гомдол, мэдээлэл	Гэмт хэргийн шинжтэй	Эрүүгийн хэрэг үүсгэсэн	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	Гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй	Шийдвэрлэсэн хоног	
							0-5	6-19
2011 оны дүн								
1	Улсын дүн	128664	59376	23405	33356	32974	28763	30612
2	ИАТ	41	29	6	23	23	22	7
2012 оны дүн								
1	Улсын дүн	141276	62371	24273	36615	36167	31743	30628
2	ИАТ	71	54	15	39	38	32	19
2013 оны дүн								
1	Улсын дүн	171438	79983	93984	51139	50403	39533	40380
2	ИАТ	105	93	21	72	69	51	42
2014 оны дүн								
1	Улсын дүн	450967	93984	29940	63245	62439	45337	48647
2	ИАТ	85	82	10	70	67	47	35
2015 оны дүн								
1	Улсын дүн	471556	96661	30439	65885	64293	45568	51093
2	ИАТ	340	63	11	52	49	28	44
2016 оны дүн								
1	Улсын дүн	488076	94324	28320	65709	64316	35730	58694
2	ИАТ	355	54	14	40	37	25	29
Нийт дүн	Улсын дүн	1851977	486699	230361	315949	310592	226674	260054
	ИАТ	997	375	77	296	283	205	176

Хүснэгт VIII.23.4 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

№	ХСБ-га	Бүртгэсэн нийт гэмт хэрэг	Өсөлт, бууралт хувь	Хөнгөн	Илрүүлэлт хувь	Хүндэвтэр	Илрүүлэлт хувь	Хүнд	Илрүүлэлт хувь	Онц хүнд	Илрүүлэлт хувь	Илрээгүй гэмт хэрэг	Хулгайлах гэмт хэрэг	Танхайрах гэмт хэрэг
2011 оны дүн														
1	Улс	19197	-3,2	7977	58,0	8889	60,1	1823	72,2	508	89,3	2505	2059	113
2	ИАТ	11	-21,4	4	100	5	100	1		1		1	2	1
2012 оны дүн														
1	Улс	22089	15,1	9637	53,8	10041	55,9	1914	64,3	497	77,1	3555	2444	189/13/
2	ИАТ	13	18,2	7	50,0	2		3		1		2		1/1/
2013 оны дүн														

1	Улс	25362	14,8	11648	62,0	11514	54,7	1766	68,1	434	85,5	4528	3471	169
2	ИАТ	82	6 да	25	63,6	52		4		1		6	2	/4/
2014 оны дүн														
1	Улс	27318	7,7	13057	60,9	11951	54,9	1781	67,2	529	88,0	5215	3674	/460/
2	ИАТ	11	-86,6	4	100	7								
2015 оны дүн														
1	Улс	27757	1,6	13487	64,1	12127	58,9	1628	72,9	515	88	5278	3857	/498/
2	ИАТ	10	-9,1	7	100	2	100			1				
2016 оны дүн														
1	Улс	27167	-2,1	13519	68,5	11767	58,8	1393	76,4	488	91,9	5331	3917	/357/
2	ИАТ	10		6	100	4	100							
Нийт дүн	Улс	148890	33,9	69325	61,2	66289	57,2	10305	70,1	2971	86,6	26412	19422	1786
	ИАТ	137	5дах	53	85,6	72		12		4		9	4	5

Хүснэгт VIII.23.5. Гэмт хэргийн төрөл

№	ХСБ-га	79-90	Илрүүлэлт хувь	91-107	Илрүүлэлт хувь	145-155	Илрүүлэлт хувь	175	Илрүүлэлт хувь	177-191	Илрүүлэлт хувь	215-225	Илрүүлэлт хувь	263-273	Илрүүлэлт хувь
2011 оны дүн															
1	Улс	96		6462		7232		54		1873		1870		101	
2	ИАТ			4		5				2					
2012 оны дүн															
1	Улс	138	93,9	7155	74,6	9023	51,6	66	57,1	1749	65,4	1999	72,4	110	5,0
2	ИАТ			4		6	50	1		2					
2013 оны дүн															
1	Улс	54	12,5	8156	85,0	11118	51,8	98	20,0	1894	77,4	2148	78,5	106	
2	ИАТ	35		4		11	60,0	6				2	100		
2014 оны дүн															
1	Улс	45	21,4	8697	85,1	8424	49,4	69	22	1750	74,3	2143	84,8	135	
2	ИАТ					2	100	3							
2015 оны дүн															
1	Улс	10		8468	89,0	13445	56,1	42		1630	79,8	2010	85,9	128	66
2	ИАТ			2		7	100			1					
2016 оны дүн															
1	Улс	36	50	8691	88,7	13336	56,8	40	100	1479	75,6	1783	87,8	111	
2	ИАТ			2		3	100	1				1			
Нийт дүн	Улс	389		47629	84,4	62578	53,1	369	25,0	10375	74,5	11953	81,0	681	
	ИАТ	35		16		34		11		5	80,0	3			

Хүснэгт VIII.23.6. Тээврийн прокурорын газраас гомдол, мэдээллийг хянан, шийдвэрлэсэн байдал

д/д	Хянасан нийт гомдол мэдээлэл	ЭХУ	ЭХУТ	Эрүүгийн хэрэг үүссэн				Шүхэд ш/сэн	Хэр/гүй болгосон	Хэрэгсэхгүй болсон үндэс		
				Хөнгөн	Хүн/тэр	Хүнд	Онц хүнд			Бүрэлдэхүүнгүй	Эвлэрсэн	Бусад
Тээврийн Прокурорын хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
1	22287	4960	17235	2452	2752	60	9	1443	3571	938	2357	218
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		22,2	77,3	49,4	55,5	1,2	0,2	29,1	72	26,2	66	6,1
Улсын хэмжээнд хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
2	367393	121128	244453	53667	68321	10395	3459	24379	85412	19640	38359	27413
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		32,9	66,5	44,3	56,4	8,5	2,8	20,1	70,5	23	44,9	32,1
Тээврийн прокурорын хувьд улсын хэмжээний дүнтэй харьцуулалтын хувь /2013-2016 он/												
	6,06	4,09	7,05	4,56	4,02	0,57	0,26	5,91	4,18	4,77	6,14	0,79

ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ ШИНЖ

Тайлбар: Гэмт хэрэгт холбогдогчдын криминологи шинжийг үндэсний аюулгүй байдлын эсрэг, эрх, эрх чөлөөний эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, гаалийн хууль тогтоомж зөрчсөн, танхайрах, ТХХАБАЖЭсрэг, албан тушаалын эсрэг гэсэн гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувийн жинтэй 6 төрлийн гэмт хэргийг сонгон авч шинжилсэн болно. Судалгааг сүүлийн **6** жилээр авч үзлээ. **(Хүснэгт VIII.23.7.)**

Гэмт хэрэгт холбогдогчдын хүйс, нас, боловсрол

Улсын хэмжээнд 2011-2016 онуудаднийт 132401 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 19099 эмэгтэй, бүлэглэсэн 21430, зохион байгуулалттай бүлэг 42, согтуугаар 32456, насны хувьд насанд хүрээгүй хүн 7523, 18-34 насны 81434, 35-дээш насны 43486, ажлын хувьд төрийн албан хаагч 946, хувийн салбарынхан 24052, оюутан сурагчид 7635, ажилгүй[45], боловсролын хувьд бага 18012, дунд 64084, тусгай 4433, дээд 23344 байна.

Иргэний агаарын тээврийн салбарт 2011-2016 онуудад нийт 105 хүн холбогдсоноос 38 эмэгтэй, 21 бүлэглэсэн, согтуугаар 7, насанд хүрээгүй хүн 00, насны хувьд 18-34 насны 66, 35-дээш насны 48, ажил эрхлэлтийн хувьд төрийн албаны 10, хувийн салбарын 27, оюутан сурагч 5, ажилгүй 35, боловсролын хувьд бага 8, дунд 44, тусгай боловсролтой 12, дээд 47 байна.

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл жилээр гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

46 Тоон мэдээлэл тодорхой гараагүй

Иргэний агаарын тээврийн салбарын хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдлыг 2011 оныхтой харьцуулахад 2016 онд нийт 12 хүн холбогдсон буюу 7 хүнээр өссөн, хүйсийн хувьд: 3 эмэгтэй буюу 2 хүнээр өссөн, насны хувьд: 1265 хүүхэд буюу 00, 18-34 насны 7 буюу 2 хүнээр өссөн, 35-70 насны 00, ажил байдлын хувьд: Төрийн албан хаагч 1 буюу 1-ээр өссөн, хувийн секторын ажилтан 3 буюу 2-аар өссөн, оюутан, сурагчид 1 буюу 1-ээр өссөн, ажилгүй 4 буюу 2-оор өссөн, оролцооны хувьд: бүлэглэж 00, боловсролын хувьд: бага 00, дунд 5 буюу 2-ээр өссөн, тусгай 1 буюу 1-ээр өссөн, дээд 6 буюу 5-аар байгаа нь харьцангуй тогтвортой мэт боловч агаарын тээврийн салбарын онцлогтой холбоотой үзүүлэлт тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. (**Хүснэгт VIII.23.7.**)

Дүгнэлт

Улсын хэмжээний дүнтэй харьцуулж үзэхэд төрийн болон хувийн салбарт ажилладаг, дунд, дээд боловсролтой хүмүүс, гэмт хэрэг бүлэглэж үйлдэх зэрэг онцлог үзүүлэлтээр 50-аас дээш хувь өсөх хандлагатай байгаа нь агаарын тээврийн салбарын эдийн засгийн өсөлт, ачаа, зорчигч тээврийн эрчимтэй эргэлттэй холбоотой.

Иймд тодорхой ажил, албан тушаалтай, дундаж настай, мэдлэг боловсролтой хүмүүс гэмт хэрэг бүлэглэж үйлдэх магадлалтай их байгааг илэрхийлнэ.

Хүснэгт VIII.23.7. Гэмт хэрэг үйлдэгсэд

№	ХСБ-га	Бүх хүн	Нас		Ажлын байдал				Боловсрол		
			18-34	35-70	Төрийн	Хувийн	Оюутан сурагч	ажилгүй	бага	дунд	тусгай	дээд
2011 оны дүн												
1	Улс	17982	11357	5462	664	2742	1209	10088	2899	8663	548	2493
2	ИАТ	5	5			1		2		3		1
2012 оны дүн												
1	Улс	19734	12320	6166		1764	1316		2808	8403	616	3305
2	ИАТ	9		9	1	2		3	2	3		4
2013 оны дүн												
1	Улс	22286	13766	7271	988	541	1575		3084	14674	723	3816
2	ИАТ	56	32	24	4	5	3	27	4	25	4	23
2014 оны дүн												
1	Улс	23737	14481	8006		6900	1581	11658	3073	15250	876	4395
2	ИАТ	11	5	6	2	8		1	1	2	1	7
2015 оны дүн												
1	Улс	24857	15088	8363	1018	7178	644		3251	1600	836	4755

№	ХСБ-га	Бүх хүн	эм	бүлэг	3Б-тай бүлэг	сотгуу	НХХ
2011 оны дүн							
1	Улс	17982	2303	2117	3	4312	1136
2	ИАТ	5	1	4		3	
2012 оны дүн							
1	Улс	19734	2667	4030	23	4791	1248
2	ИАТ	9	2	1	1	1	
2013 оны дүн							
1	Улс	22286	3137	4205	10	5695	1222
2	ИАТ	56	26	6		1	
2014 оны дүн							
1	Улс	23737	3618	2732	2	6686	1250
2	ИАТ	11	4	2		1	
2015 оны дүн							
1	Улс	24857	3782	4624		5465	1402

2	ИАТ	12	2	4				7	7	2	8	1	1	1	6			6
2016 оны дүн																		
1	Улс	23805	3592	3722	4	5507	1265	14422	8218	835	4927	1310		2897	15494	834		4580
2	ИАТ	12	3	4		1		7		1	3	1	4		5	1		6
Нийт дүн	Улс	132401	19099	21430	42	32456	7523	81434	43486	946	24052	7635		18012	64084	4433		23344
	ИАТ	105	38	21	1	7		66	48	10	27	5	35	8	44	12		47

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, орон зай

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Иргэний агаарын тээврийн салбарын хэмжээнд 2011 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагийн 2, 4 дахь өдрүүдэд, цагийн хувьд 14-19, 22-06 цагийн хооронд ихэвчлэн үйлдэгддэг, гэмт хэргийн түвшин өндөр хувьтай байгаа нь нислэгийн хуваарьтай шууд холбоотой, 2016 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагийн 4 дэх өдөр, цагийн хувьд 22-06 цагийн хооронд ихэвчлэн үйлдэгддэг, гэмт хэргийн түвшин өндөр хувьтай нь нислэгийн хуваарь болон нисэх буудлын үйлчилгээ өргөжсөнтэй холбоотой. Харин жилийн аль сарын хэд дэх 10 хоногт гэмт хэрэг үйлдэгдэж байгаа байдлаар гэмт хэргийн түвшин тодорхойлох мэдээлэл байхгүй байсан болно. (**Хүснэгт VIII.23.8.**)

Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа орон зайн хувьд салбарын онцлогтой холбоотой нисэх онгоцны аяллын үед онгоц дотор, нисэх буудлын орчин, хил, гаалийн бүсийн галт тэрэг дотор, ачаа тээврийн онгоцны ачаа, тээвэрлэлтийн үеийн болон иргэний агаарын тээврийн байгууллагууд, албан хаагчдын албан үүрэгт хамааралтай гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Хүснэгт VIII.23.8. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг

д/д	ХСБ-га	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2011 оны дүн												
1	Улс	3407	2815	2843	2819	2850	2217	2246	3251	5115	3554	7277
2	ИАТ	1	4		4		2		2	4	2	3
2012 оны дүн												
1	Улс	3593	3342	3243	3212	3202	2714	2783	3814	5664	3956	8658
2	ИАТ	3	5	1	1	2		1	3	4		6
2013 оны дүн												
1	Улс	4067	3875	3765	3778	3707	3140	3030	4532	6405	4541	9884
2	ИАТ	20	15	9	5	14	8	11	11	13	1	57
2014 оны дүн												
1	Улс	4655	4178	4115	3937	4093	3192	3148	5758	7326	4434	9800
2	ИАТ	1	2	3	2	3			5	2	1	3
2015 оны дүн												
1	Улс	4655	4266	4159	4127	4028	3328	3194	6056	7948	4326	9427

2	ИАТ	3	1	1	1	1	1	2	6	3		1
2016 оны дүн												
1	Улс	4280	4157	4018	4019	3979	3424	3280	5884	7782	4109	9392
2	ИАТ	3	1		4			2	3	3	1	3
	Улс	24657	22633	22143	21892	21859	18015	17681	29295	40240	24920	54438
	ИАТ	31	28	14	17	20	11	16	30	29	5	73

Гэмт хэргийн хохирогч болон хохирлын байдал

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Иргэний агаарын тээврийн салбарын хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт хохирсон болон хохирлын байдлыг 2011 оныхтой харьцуулахад 2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 8 хүн хохирсон буюу 4-өөр өссөн, 3 эмэгтэй буюу 2-оор өссөн, 18-34 насны 5 буюу 2-оор өссөн, 35-70 насны 3 буюу 2-оор өссөн, гэмт хэргийн улмаас нийт 10 орчим сая төгрөг буюу 6,5 сая төгрөгөөр өссөн, нийт хохирлоос хөнгөн гэмт хэргийн улмаас 10,8 сая буюу 7,3 сая төгрөгөөр өссөн, хүндэвтэр 4,3 орчим сая төгрөг буюу 5,7 сая төгрөгөөр буурсан (2014 онд 23,2 сая төгрөг байсан), үүнээс хэрэг бүртгэлтийн явцад 4,5 сая, мөрдөн байцаалтын явцад 0,5 сая төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн нь бүх үзүүлэлт өсөх хандлагатай байна.

Харин нийт хохирлоос нөхөн төлөлт 50%-тай хувьтай байсан нь нэг талаас сайн үзүүлэлт боловч нөгөө талаас хөнгөн, хүндэвтэр "ил цагаан" үйлдэлтэй гэмт хэргийн нөхөн төлөлт гэдгийг анхаарах ёстой[47].

Эндээс харвал хохирогч, хохирлын хэмжээ тогтвортой өссөн нь зорчигчийн эргэлтийн эрс өсөлт, мөнгөний ханш, инфляцтай холбоотой байх магадлал өндөр байна.

Учир нь нөхөн төлөлт тээврийн салбарын хувьд харьцангуй сайн төдийгүй хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт ногдох хувь өндөр учир төлөлт хялбар байна.

Энэ нь нэг талаас сайн үзүүлэлт мэт боловч нөгөө талаас зохион байгуулалттай, хүнд, онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудал байгааг илтгэнэ.

Цаашид салбарын шинэчлэл, хөгжилтэй холбоотойгоор хохирогч, хохирлын хэмжээ эрс өсөх хандлагатай. (**Хүснэгт VIII.23.8.**)

Хүснэгт VIII.23.9 Хохирогч, хохирлын байдал

№	ХСБ-га	Нийт хохирогч	Эм	НХХ	18-34	35-70	Хохирол Сая ₮	Хөнгөн гх	Хүн/тэр гх	Хүнд гх	ОХүнд гх	Төлөлт	ХБ	МБ
2011 оны дүн														
1	Улс	18592	6856	1178	9116	8298	35904,1	4226,4	19986,0	4713,0	6978,8	18490,4	2603,8	15886,6
2	ИАТ	4	1		3	1	14,2	3,5	10,8			2,3	2,3	
2012 оны дүн														

47 Хүснэгт №7 2012 онд 17,2 сая төгрөг, 2013 онд 426,6 сая төгрөгийн хохиролтой гэмт хэрэг мөрдсөн.

1	Улс	21294	7977	1200	10540	9567	53263,2	6613,2	22223,1	14564,8	9862,2	25135,6	4409,6	20726,0							
2	ИАТ	11	2		6	9	26,3	4,8	4,0	17,2		9,0	3,0	6,0							
2013 оны дүн																					
1	Улс	25015	9838	1426	12316	11273	159024,2	9433,2	87481,9	37049,2	25059,9		6582,2								
2	ИАТ	22	9		9	13	483,4	9,7	47,2	426,6		432,8	4,3	428,5							
2014 оны дүн																					
1	Улс	27475	10902	1576	13420	12479	148204,6	13800,7	34202,4	61890,7	38370,9	43652,5	9195,9	34456,6							
2	ИАТ	9	4		1	8	556,7	553,6	23,2			553,1	533,6	19,6							
2015 оны дүн																					
1	Улс	27948	11207	1477	13528	12943	144341,4	15388,4	45783,3	38075,5	45094,2	48997,8	10224,2	38773,5							
2	ИАТ	11	4		7	4	148,6	11,1	2,1		135,5	4,6	2,7	2,0							
2016 оны дүн																					
1	Улс	27689	11346	1340	13306	13043	162909,4	16585,8	40518,4	67975,0	37830,2	43964,0	11320,4	32643,5							
2	ИАТ	8	3		5	3	10,8	6,5	4,3			5,0	4,5	0,5							
Нийт дүн	Улс	148013	58126	8197	72212	67603	150845,3	66047,7	250195,1	224268,2	163196,2	131242,5	44336,1	142486,2							
	ИАТ	59	23		31	41	1240,0	589,2	91,6	443,8		1006,8	550,4	456,6							

Иргэний агаарын тээвэрт үйлдэгдэж байгаа зөрчлийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар зөрчлийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа "танхайрах", "авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал"[48], "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" зэрэг төрөл сонгон авч тоймлон дүгнэсэн болно.

48 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015 оны 7 сарын 5-ны өдөр

Иргэний агаарын тээврийн салбарын хэмжээнд 2012-2016 онд нийт 11875 зөрчилд 11865 хүн холбогдуулан бүртгэж 130,02 сая төгрөгөөр торгосон бөгөөд үүнээс торгуулийн тасалбараар 11609 зөрчилд 120,96 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

Тус салбарт бүртгэгддэг зонхилох зөрчлөөс танхайрах зөрчил 1088-ыг бүртгэн 5,07 сая төгрөгийн торгууль, хөдөлгөөний аюулгүй байдлын 8422 зөрчил бүртгэж 96,65 сая төгрөгөөр торгож, цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй 1362 зөрчилд 6,6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Энэ нь нийт зөрчлийн 91,5%, торгуулийн 83,3% эзэлж байна.

Хүснэгт VIII.23.10. Зөрчил, шийдвэрлэлтийн байдал

№	ХСБ-га	Нийт зөрчил	Хувь (+, -)	Иргэн	Торгууль Сая ₮	Торгуулийн тасалбар торгосон		Танхайрах нийт зөрчил		ХАБ журам нийт зөрчсөн		ХЁШаардлага эсэргүүцсэн	
						Тоо	Сая₮	тоо	Сая ₮	Тоо	Сая ₮	Тоо	Сая ₮
2011 оны дүн													
1	Улс	68226	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	ИАТ	3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2012 оны дүн													
1	Улс	795923	21,8	751571	4654,413	627853	3043,012	126018	462,230	502438	238,823	10503	42,23
2	ИАТ	1778	69,5	1778	8,977	1767	8,834	76	0,380	1653	8,264	-	-
2013 оны дүн													
1	Улс	777793	-2,3	726716	4853,349	655728	3029,8	137259	563,539	469677	2242,6	9565	42,684
2	ИАТ	2537	42,7	2536	14,54	2456	11,042	188	0,824	2135	9,647	96	0,401
2014 оны дүн													
1	Улс	681222	-12,4	-	5253,6	538473	2973,76	131600	6032,7	369295	2192,42	12761	62,113
2	ИАТ	512	-	510	2,969	472	1,959	277	1,159	-	-	149	0,631
2015 оны дүн													
1	Улс	1423088	2дах	1372058	17016,3	1279774	14300,4	117008	559,861	786338	5126,278	21720	107,24
2	ИАТ	2504	5дах	2499	23,718	2425	21,542	295	1,45	1365	7,281	210	1,051
2016 оны дүн													

1	Улс	-	-27,3	-	30617,3	927639	16749,2	107531	534,062	597524	-	30412	153,332		
2	ИАТ	4544	81,5	4542	79,82	4489	77,583	252	1,26	3269	71,462	907	4,535		
Нийт дүн	Улс	4712611	-	3850345	62394,9	4029467	117472,1	619416	8152,4	2725272	9800,1	84961	407,59		
	ИАТ	11875	-	11865	130,024	11609	120,96	1088	5,073	8422	96,654	1362	6,618		

Иргэний агаарын тээврийн салбарын хэмжээнд 2016 онд зөрчлийн байдал, төрөл болон торгуулийн дүнг 2012-2015 оныхтой харьцуулахад 2016 онд нийт зөрчил 4544 буюу 4030-9982-оор өссөн, холбогдсон хүн 4542 буюу 2764-2006-аар өссөн, торгуулийн хэмжээ 79,82 сая төгрөг буюу 70,8-56,1 сая төгрөгөөр өссөн, торгуулийн тасалбараар 4439хүн буюу 2672-1983 хүнээр өссөн, торгуулийн хэмжээ 77,583 сая төгрөг буюу 68,749-56,041 сая төгрөгөөр өссөн үүнээс танхайрах зөрчил 252 буюу 176-64-өөр өссөн, торгуулийн хэмжээ 1,26 сая буюу 0,88-0,19 сая төгрөгөөр өссөн, хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил 3269 буюу 1616-1134-өөр өссөн, торгуулийн хэмжээ 71,462 сая буюу 63,198-61,815 сая төгрөгөөр өссөн, цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй зөрчил 907 буюу 811-697-оор өссөн, торгуулийн хэмжээ **4,535** сая төгрөг буюу 4,134-3,484 сая төгрөгөөр өссөн байна.

ДҮГНЭЛТ

Иргэний агаарын тээврийн онцлогтой холбоотойгоор нисэх онгоцны нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах[49, 50] зорилготой Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн байгууллага нь иргэний нисэх, иргэний агаарын тээврийн онгоцны хөдөлгөөнтэй холбоотой зөрчлийг харьяалдаг[51] хэдий ч жилд 250 мянга орчим зорчигч, 3 сая орчим үйлчлүүлэгчийн ая тухыг баталгаатай хангах, 100-200 гаруй мянган тонн ачааны бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажиллаж ирсэн байна.

Гэтэл зөрчлийн бүртгэл жил бүр харилцан адилгүй, зарим жилийн мэдээлэл зөрөөтэй гарч байгаа нь хууль сахиулах үйл ажиллагааг мэргэжлийн үүднээс хэрэгжүүлээгүй, гэмт хэрэг, зөрчлийг бүрэн хянаж чадаагүй, өөрийн үйл ажиллагааг дүгнэн, эрсдлийн төлөвлөгөө гаргаж ажил зохион байгуулаагүй зэрэг нь иргэдийн цагдаа, хууль сахиулах байгууллагад итгэх итгэл хангагдаагүй байсан гэж дүгнэх үндэслэлтэй.

ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН БАЙДАЛ

Иргэний агаарын тээвэр дахь Цагдаагийн хэлтэс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулж иргэний агаарын тээврийн албадаас багагүй хэмжээний хөрөнгө мөнгө жил бүр авдаг боловч шинжлэх ухааны үндэслэл бүхий оновчтой үйл ажиллагаанд зарцуулахгүй,

49 Иргэний нисэхийн тухай хууль, 1999 оны 01 сарын 21-ны өдөр,

50 АНУ-ын Чикаго Олон улсын нисэхийн ICAO хэлэлцээр 1944.12.07., Манай Улс Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцод 1989 онд нэгдэн орсноор ICAO-ийн гишүүн болсон.

51 Иргэний агаарын тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1991 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаан, Цагдаагийн ерөнхий газрын даргын 1992 оны 12-р сарын 28-ны 412 тоот тушаалаар аяллын үед зорчигчдын ая тух алдагдуулах, эрүүл мэнд, эд хөрөнгийн эрхийг зөрчих зөрчил их байгаатай холбоотойгоор нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотойгоос бусад зөрчлийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хариуцуулсан.

зөвхөн зураг хуудас хэвлүүлсэн, тодорхой хүмүүст яриа, таниулга хийсэн зэрэг үр нөлөө багатай ажилд зарцуулсан байна.

Энэ байдал нь цагдаагийн албан хаагчид урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдлэг хомс, ур чадвар, дадлага хангалтгүй, үйл ажиллагаандаа криминологийн болон бусад шинжлэх ухааны үр дүнг ашиглахгүй байгаа нь судалгаанаас илэрхий байна.

Мөн албан хаагчийн харилцааны соёл хангалтгүй байгаатай холбоотой "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" гэх зөрчил улсын хэмжээний дүнтэй харьцуулахад 11,4%, торгууль 10,2%"ийг эзэлж буй нь харьцангуй өндөр үзүүлэлт[52] гарч байгаа тул цагдаагийн байгууллагын нийтлэг чиг үүрэг гүйцэтгэх шинэ арга зүй, туршлагыг "нийгмийн гэрээний онол"-д тулгуурлаж хэрэгжүүлэх шаардлагатай.

Нэгдсэн дүгнэлт

Иргэний агаарын тээврийн салбарын үйлчилгээ цогц байдлаар өргөжиж байгаатай уялдуулан аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд суурилсан, бодит байдалд тохирсон, үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс мэргэжлийн албаны зохион байгуулалт, мэргэшсэн алба хаагчид, тодорхой чиг үүрэгтэй гүйцэтгэх шаардлагатай (хил, гааль, мөнгө угаах, хүн худалдаалах зэрэг эдийн засгийн салбарын гэмт хэрэгтэй тэмцэх) болсон байна. Гэтэл тээврийн салбарын онцлогтой холбоотой гэмт хэрэг шалгаж шийдвэрлэхгүй байгаа нь шинэ нөхцөл байдалд тохирсон бүтэц, зохион байгуулалт, удирдлага, арга зүй, сэтгэлгээ, сэтгэл зүй, арга барил, чадвар, туршлагыг шаардаж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр офицер бүрэлдэхүүнийг өргөжүүлж, нийтийн хэв журмын орон тоо, хүний хүчин зүйлийг багасгаж ухаалаг технологид суурилсан цомхон орон тоогоор урьдчилан сэргийлэх ажиллагааг (дүрс, дуу бичлэг, гэрэл зураг, зураг, радио, хэвлэлийн төрөл зүйлийг өргөн ашиглах) шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулан үйл ажиллагааг төлөвлөгөөтэй хэрэгжүүлж хэвших ажлыг зохион байгуулах шаардлагатай болсон.

Тайлбар, Хүнд, онц хүнд ангиллын гэмт хэрэг тээврийн салбарт үйлдэх магадлал өндөр бөгөөд үндэстэн дамнасан зохион байгуулалттай буюу НҮБ-ын тодорхойлсон 15 төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх магадлал их байгаа тул дараахь санал илэрхийлж байна.

Нэгдсэн санал

Бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн чиглэлээр

Энэ салбарт ажилгүй болон бага насны хүүхэд зөрчилд холбогдох нь харьцангуй бага, ихэвчлэн эдийн засгийн боломжтой хүмүүс үйлчлүүлдэг учир ихэвчлэн нийтлэг зөрчил үйлдэж байгааг анхаарах, эрүү, зөрчлийн хуулиуд шинээр батлагдан, мөрдөгдөх болон салбарын өөрмөц онцлогтой холбоотой огт шийдвэрлэгддэггүй зөрчилтэй тэмцэхэд мэргэшсэн албаны эрэлт шаардлагатай холбоотой санал хүргэж байна.

- Төмөр замын тээврийн салбар дахь Цагдаагийн газрын бүтцэд "Шинэ төмөр зам"-ын салбарын болон Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийг нэгтгэн нэг бүтэцтэй болгох,
- Мэргэжлийн албаны зохион байгуулалттайгаар, мэргэшсэн албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой тоглолцоо, эрх зүйн үндэс бий болгох,
- Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл нь "эдийн засгийн салбарт үйлдэгдэх зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх" хүрээнд офицерын бүрэлдэхүүнийг өргөтгөж,

52 Нийтийн тээвэр, Олон улсын тээвэрт харьцангуй соёлтой иргэд зорчдог бөгөөд зүй бус шаардлагыг үл биелүүлэх, тайлбар тавих явдал их байдаг байна.

хэв журмын чиг үүргийг ухаалаг технологид суурилсан цомхон бүрэлдэхүүнээр зохион байгуулах,

Статистик, мэдээллийн чиглэлээр

- Хэргийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг мэдээнд нарийвчлан гаргах,
- Түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон хэргийн үндэслэлийг мэдээнд нарийн гаргах,
- Илрээгүй хэргийн хохирол, шалтгааныг мэдээнд нарийн гаргах,
- Олон үйлдэлтэй хэргийн үйлдлийн тоо, хэргийн төрлөөр нь гаргах,
- Хохирлын нийт хэмжээ ба нөхөн төлүүлсэн дүнг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд нэгтгэн гаргах,
- Гэмт хэрэгт холбогдогчийн "нутгийн харьяалал"-ыг нэмж нэгтгэн гаргах,
- Зөрчлийн төрөл (нийтлэг буюу торгуулийн хуудас, бүртгэх буюу баримт бүрдүүлж шийдвэрлэх), ангиллаар мэдээнд нарийн гаргах,
- Зөрчил үйлдэгчийг насны болон бусад үзүүлэлтээр мэдээ гаргах,
- Сарын эхний 10, дунд 10, эцсийн 10 хоногоор мэдээ гаргах,
- Цагийг 06-12, 12-18, 18-24, 24-06 цагт гэж ангилж мэдээ гаргах,

Урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Салбарын онцлогтой холбоотой үзүүлэлтээр мэдээ гаргах,
- Ухаалаг технологид суурилсан үйл ажиллагааны мэдээ гаргах,
- Зөрчил үйлдсэн цаг, газар орныг онцлогтой холбоотойгоор мэдээ гарах.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАР



24. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАР

Нийгэмшлийн шинэ орчин дахь сөрөг үзэгдлийн зүй тогтол, бүтэц, хандлагын талаар нийгэм судлаачид, гэмт үзэгдэл судлаачид шинжлэх ухааны үндэслэлээр тодорхой онол, таамаглалыг боловсруулж, "нийгэмшлийн энэхүү сөрөг өөрчлөлт, хандлага нь сүүлийн жилүүдийн гэмт хэрэг, зөрчлийн тоо баримт, бүтэц, хэлбэр, хөдөлгөөн, түвшин, нөхцөл байдлаар илэрхийлэгдэнэ" гэж тодорхойлсон.

Бодитой байгаа энэхүү сөрөг үзэгдлийг тухайн салбарын бүтэц, зохион байгуулалт, гадаад дотоод бодлого, үйл ажиллагаатай уялдуулан тодорхой баримтаар, шинжлэх ухааны үндэслэлтэй судлахгүйгээр бодитой, үнэн зөв тодорхойлох, түүнтэй тэмцэх бодлого, арга зүй, нөөцийг зохион байгуулах боломжгүй.

Иймд Төмөр замын тээврийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг төр-засгийн бүтэц, тогтолцоо, гадаад дотоод бодлого, эдийн засаг, хүн ам зүйн нөхцөл байдлыг хамруулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр иж бүрэн судлах, шинжилж дүгнэн, цаашдын хандлагыг бодитой, үнэн зөв тодорхойлох[53] улмаар төрөөс баримтлах бодлого, арга зүй, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох эрх зүйн үндсийг шинэчлэх[54]шаардлагатай болсон.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллага болох НҮБ[55]-д 1961 онд элссэнээр[56] хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлагатай зэрэгцэн хөгжих эрх зүйн үндэслэл бүрэн хангагдаж улмаар НҮБ-ын суурь конвенц, гэрээнүүдэд нэгдэн орсон төдийгүй НҮБ-ын гишүүн 181 улстай дипломат харилцаа тогтоон, гэрээ байгуулснаар үндэснийхээ язгуур эрх, ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг баталгаажуулсан.

Энэ нь Үндсэн хуулийн "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"[57] гэсэн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үндэсний болон олон улсын эрх зүйн үндэслэл бүрдсэн.

Тухайлбал, Манай орны хувьд төмөр зам, агаарын тээвэр, авто замын тээврийн салбар нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэгч, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг хөгжүүлэгч томоохон хүчин зүйл мөн.

Манай улсын төмөр замын тээврийн салбар нь харьцангуй шинэ салбар боловч үндэсний болон олон улсын эрх зүйн хүрээнд баталгаажсан, олон улсын хамтын нийгэмлэгийн худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг хөгжүүлэгч гишүүний бүрэн эрхтэй эрчимтэй хөгжиж байгаа салбар[58].

---

53 "Дэлхийн ирээдүй судлалын ухааны хүрээлэн"-ийн Ерөнхийлөгч Эдвард Корниш "ирээдүй судлалын зорилго нь ирээдүйг үгтан таамаглах, зөвхөн тоон мэдээ гаргах бус судалгааны бодит мэдээлэлд уялдуулан ирээдүйг илүү боломжтой, үр дүнтэй болгож өөрчлөхөд оршино"

54 "Бодитой байгаа зүйлийн хүрээнд, эрсдэлд орох магадлалыг өмнөх эрсдэлийн тоон үзүүлэлттэй харьцуулан судлах"-даа хууль зүйн салбараас гадна сэтгэл судлал, математик, логик, философи, социологи зэрэг салбар ухаантай харьцуулан нарийвчлан үндэслэлтэйгээр судлах арга. Тухайлбал: Карл Marbe (Парис 1869-1953) Германы Франкфурт хотын Нийгмийн болон арилжааны шинжлэх ухааны академийн сэтгэл судлалын тэнхимийн сэтгэл судлаач, тээвэр ложистик, зар сурталчилгаа, шүүх эрх мэдлийн чиглэлээр сэтгэл зүйн шинжлэх ухааны мэдлэгийн хөтөлбөр боловсруулсан "Марбен буюу дахин гарах хууль"

55 НҮБ-ийн гишүүн 193 орны 181 оронтой дипломат харилцаа тогтоосон, 2016 оны 12 дугаар сарын байдлаар

56 НҮБ-д 1961 оны 10 сарын 27-ны өдөр элссэн

57 Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он 19 дүгээр зүйл 1 дэх хэсэг

58 Төмөр замын (транссибирын тээврийн хэлэлцээр) болон олон улсын, бүс нутгийн гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн орсон

Төмөр замын тээврийн салбарын өнөөгийн байдал

Төмөр замын тээврийн **(Mongolian railway Transport)** салбарын үүслийн хувьд Монголд анх удаа 1938 онд Налайх-Улаанбаатарын 48 км урттай, нарийн царигийн төмөр зам ашиглалтад орж байсан бол үүний дараа БНМАУ болон ЗСБНХУ-ын хооронд байгуулсан хамтын ажиллагааны тухай гэрээний дагуу ЗХУ-ын Наушки өртөөнөөс БНМАУ-ын нийслэл Улаанбаатар хот хүртэл 400 км урттай төмөр замын шугамыг тавих төмөр замын барилгын ажил 1947 онд эхэлж 1949 онд ашиглалтад орсон түүхтэй.

Харин Улаанбаатар-Замын-Үүд хүртэлх 700 км урттай төмөр замыг 1955 онд ашиглалтад оруулснаар Евро-Азийн төмөр замын сүлжээний хамгийн дөт бүрэлдэхүүн хэсэг болж төмөр замын шууд харилцаа нээгдсэн.

Монгол Улсын эдийн засаг, үйлдвэр, худалдааны хөгжлийн дагуу 1965 оноос хойш Дархан-Шарын гол, Салхит-Эрдэнэт, Багахангай-Багануур, Айраг-Бор-Өндөр, Сайншанд-Зүүнбаян, Эрээнцав-Баянтүмэн, Болд-Төмөр ерөө зэрэг салаа зам ашиглалтад орсон.

"Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн төмөр замын тээврийн хэмжээнд нийт 1910 гаруй км урттай төмөр зам, 88 орчим өртөө, зөрлөг, 16 мянга гаруй ажиллагсадтайгаас гадна Евро-Азийн сүлжээний хэсэг болох гол зам 1111 км урттай, хойд хилээр ОХУ болон Европын улсууд, урд хилээр БНХАУ болон Зүүн хойд Азийн улсууд, дорнод хилээр БНХАУ болон ОХУ-тай төмөр замын тээврийн хилээр гадаадад нэвтрэх боломжтой, ачаа тээх, нэвтрүүлэх суурь хүчин чадал жилд 24 орчим сая тонн ачаа буюу ачаа эргэлтийн 96,8%, 4 орчим сая зорчигч буюу зорчигч эргэлтийн 47,4%-ийн тээврийн эргэлт бүхий салбар болон эрчимтэй хөгжиж байна.

Тухайлбал: Төмөр замын тээврээр 2016 оны эхний 10 сард нийт 16112,0 мянган тонн ачаа, 2211,8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 635,6 мянган (4,1%) тонноор өссөн, зорчигч 180,2 (7,5%) мянгаар буурсан. Төмөр замын тээврийн салбарын орлого 2016 оны эхний 10 сард 355,5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 36,7 (11,5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсад хөдөө аж ахуй, уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор төмөр замаар тээвэрлэгдэх ачаа эргэлтийн хэмжээ 9-15%-аар жил бүр тасралтгүй өсөх хандлага ажиглагдаж байна[59].

Эрэлт нийлүүлэлтийн хэрэгцээтэй уялдуулан төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг батлан[60] мөрдүүлж, төмөр замын ачаа тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг эрс нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлт хийх, өргөтгөх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулснаар 2016-2018 онд 34 сая тонн, 2020 онд 48 сая тонн, 2030 онд 76 сая тонн болгох бодлого, төлөвлөгөө боловсруулсан.

Төмөр замыг шинэчлэн, ачаа тээх, нэвтрүүлэх суурь хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого, төлөвлөгөөндөө Евро-Азийн хуурай замын "Эдийн засгийн коридор"-ын нэг хэсэг болгох хөрш орнуудын стратеги бодлоготой нийцүүлэх өмнөд бүс нутагтаа уул уурхайг хөгжүүлж, эрдэс, түүхий эдийн бүтээгдэхүүнээ Зүүн Өмнөд Азийн орнуудад нийлүүлэх талаар тусган ажиллаж байна.

Цаашид дотоодын ачаа тээврийн эргэлтээс гадна олон улсын транзит тээвэр, ложистик тээвэр, аялал жуулчлалын тээвэр гэх мэт салбараар тасралтгүй хөгжих, тээврийн эргэлт эрс өсөлттэй байх хандлага ажиглагдаж байна[61].

59 Төмөр замаар 2012 онд тээвэрлэсэн ачааны хэмжээ 20,4 сая тонн, зорчигч 4,0 сая гаруй болсон.

60 УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоол., "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай".

61 Нийт 19 орчим сая тонн ачаа тээврийн 50.6 хувийг дотоодын ачаа тээвэр, 41 хувийг олон улсын тээвэр, үлдсэн 9 орчим хувийг дамжин өнгөрүүлсэн тээвэр эзэлж, гадаадад зорчигч 200 гаруй мянга, дотоодод зорчигч 3,7 сая болж Төмөр замын тээврийн орлого 500-700 тэрбум орчим болсон үзүүлэлттэй байна. 2015 оны тоон үзүүлэлт.

Төмөр замын тээврийн салбарын хөгжлийн чиг хандлага

Монгол Улсад хөдөө аж ахуй, уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа төдийгүй хөрш орнуудын эдийн засгийн хөгжлийн хандлага, стратеги бодлоготой нийцүүлэх өмнөд бүс нутагтаа уул уурхайг хөгжүүлж, эрдэс, түүхий эдийн бүтээгдэхүүнээ Зүүн Өмнөд Азийн орнуудад нийлүүлэх, улмаар бүс нутгийг хөгжүүлэх цаг үеийн бодит байдалтай уялдуулж бүсийн хэмжээнд тээврийн харилцааны салбарыг хурдтай хөгжүүлэх шаардлагатай болсон.

Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг баталж[62], төмөр замын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, томоохон уул уурхайн ордуудыг ашиглах, тус ордуудаас бүтээгдэхүүн экспортлох зорилгоор нийт 5600 км төмөр замын сүлжээг 2013-2022 оны хооронд хэд хэдэн үе шаттайгаар барьж байгуулахаар шийдвэрлэсэн.

Учир нь стратегийн чухал ордуудын нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд одоо ашиглаж байгаа төмөр замаар хангалттай хэмжээнд тээвэрлэлт хийж чадахгүй байгаа, иймд Монгол Улс ойрын 20 жилд нэг тэрбум тонн хүртэл нүүрс, эрдэс баялаг түүхий эд, бүтээгдэхүүнийг Зүүн Өмнөд Азийн орнуудад нийлүүлэх гэрээ байгуулсан учраас төмөр замын тээврийн салбарыг шинэчлэх, шинэ гарцууд бий болгох зайлшгүй шаардлага урган гарсан.

Энэ хүрээнд шинэчлэлийн эхний 1, 2 дугаар үе шатанд Тавантолгойн нүүрсний ордоос өмнөд болон зүүн зүгийн зургаан чиглэлд 1800 км урттай төмөр замын сүлжээ барих **"Шинэ төмөр зам"** төслийг хэрэгжүүлэхээр болсон билээ.

Үүний дагуу "Шинэ төмөр зам" төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд урд болон зүүн чиглэлд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 225 км, Тавантолгой-Хөөгт чиглэлийн 960 км, Хөөгт-Чойбалсан чиглэлийн 185 км, Чойбалсан-Эрээнцав чиглэлд 210 км, Хөөгт-Бичигт чиглэлийн 230 км нийт 1800 км урттай төмөр замын суурь бүтцийн барилгын ажил нэгэнт эхэлсэн төдийгүй цаашид энэ салбар тасралтгүй өргөжиж, ачаа эргэлт эрс өсөх, эрчимтэй хөгжих хандлага ажиглагдаж байна.

Төмөр замын тээврийн аюулгүй байдал

Төмөр замын тээврийн салбар нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг. Төмөр замын тээврийн өсөн нэмэгдэж буй энэ цаг үед хууль сахиулах байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаас гадна терроризм, төмөр замын тээвэрт оролцогчдын ашиг сонирхлыг хангах, төмөр замын салбарт дахь хил, гааль, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, гэмт хэрэг, зөрчилтэй үр дүнтэй тэмцэх нэг хүчин зүйл нь оновчтой тогтолцоо бүхий мэргэшсэн алба, мэргэжилтэн бий болгох эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай.

ХОЁР. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Иргэдийн аюулгүй байдлын хэмжүүрийн гадаад илэрхийлэл нь нийгмийн шинжтэй сөрөг үзэгдлүүдийн нэг хэсэг болох гэмт хэрэг, зөрчлийн бүтэц, хөдөлгөөн, түвшингээр тодорхойлогдоно.

Төмөр замын тээврийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн шалтгаан нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эдийн засаг, эрх зүй, соёлын таатай орчин бүрдээгүй, нийтээр амьдрах соёл, харилцааны зөв хэв маяг, сэтгэл зүйн эерэг хандлага дутагдалтай байгаатай холбоотой.

62 Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д олгосон.

Энэ нь УИХ-аас гарах шийдвэр, баримт бичиг нь үндэсний уламжлал, орчин үеийн хэрэгцээ шаардлага, хүн төрөлхтний хөгжлийн түгээмэл чиг хандлагад нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй биш, "сэтгэл хөдлөл", "хүч түрэх" байдлаар батлагдан гарч иргэдийг "НАМ"[63], "БҮЛЭГ", "НУТАГ УС" зэрэг байдлаар талцуулж, ирээдүйдээ итгэх итгэл алдарч улмаар "зүй ёс"-ыг биш "зүй бус ёс"-ыг бий болгох сэтгэл зүйг бий болгож байна.

Иймд иргэдийн сэтгэл зүйд эерэг нөлөөлөх, нийтээр амьдрах соёл, зөв хандлагатай, өөрийгөө ухамсартайгаар хариуцах ёс зүйтэй иргэн болгон гэгээрүүлэх, төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төмөр замын тээвэрт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, хүчин зүйл

Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал

Гэмт хэргийн нөхцөл байдлыг судалгаанд хамрагдсан 6 жилийн хугацаанд хууль сахиулах байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэсэн гэмт хэрэг, ангилал, төрөл, илрүүлэлтийн тоо, хувийн жин зэрэг үзүүлэлтийг харьцуулан тоймлон дүгнэв. **Үүнд:**

- Улсын хэмжээнд 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;
- Төмөр замын тээврийн салбарт үйлдэгдэж 2011-2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн;
- Төмөр замын тээврийн салбарын хувьд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн дүнтэй харьцуулсан хувийн жинг шинжлэн дүгнэсэн болно.

Төмөр Зам дахь Цагдаагийн байгууллага 2011-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт 4931 гомдол мэдээллийг хүлээн авч үүнээс гэмт хэргийн шинжтэй 2021 гомдол, мэдээллийг шалган 739 тохиолдол буюу 36,5%-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 1217 тохиолдолд буюу 60,2%-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт 1004 буюу 47,1%, 6-19 хоногт 1069 буюу 52,9%-ийг шалгасан.

Гэмт хэрэг

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Төмөр замын тээврийн салбарт 2011 онд нийт гэмт хэргийн шинжтэй 285 гомдол, мэдээллийг шалгаад 157 (55%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 102 тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, 2016 онд нийт гэмт хэргийн шинжтэй 335 гомдол мэдээллийг шалгаад 112 (33,4%) тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 223 тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь судалгаанд хамрагдсан эцсийн жил 2016 онд хүлээн авсан гомдол, мэдээлэл нь судалгааны эхний жил 2011 оны дүнгээс +210 нэгжээр өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл +50 нэгжээр өссөн, эрүүгийн хэрэг үүсгэсэн -40 нэгжээр буурсан, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан +119 нэгжээр өссөн бөгөөд нийт дүнгээр нь шинжлэн үзвэл бүх үзүүлэлт жил бүр тогтмол өсөх хандлагатай байна.

63 "Ам Чам Монгол" байгууллагаас 2015 оны 1 дүгээр сард "Монгол Улсын бизнесийн орчны талаарх үндэсний хэмжээний судалгаа"-нд Улс төрийн нам хүчин, удирдагчдын гаргасан шийдвэр бизнесийн орчинд хамгийн их нөлөөтэй" гэсэн дүн гарсан.

Харин 2013-2015 онд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тохиолдол 244-285 болж өссөн нь гэмт хэргийн шинжтэй тохиолдлууд өссөн байх магадлалтай анхаарах асуудал болно. **(Хүснэгт VIII.24.1.), (Хүснэгт VIII.24.2.)**

Гэмт хэргийн илрүүлэлтийн нөхцөл байдал

Төмөр замын тээврийн салбарт 2011-2016 онд нийт 590 (бууралт -36%) гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 350 (илрүүлэлт 68,0%), хүндэвтэр 212 (илрүүлэлт 60,4%), хүнд 21 (илрүүлэлт 93,7%), онц хүнд **7**, илрээгүй хэрэг 54 үүнээс хулгайлах гэмт хэрэг 81, 20 нэгж танхайрах зэрэг гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байгаа дүн мэдээлэл (ирүүлсэн зарим тоон мэдээлэл зөрөөтэй байгааг анхаарах хэрэгтэй) гарсан байна.

Төмөр замын тээврийн салбарт 2011 онд нийт 122 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 61, илрүүлэлт 76,2%, хүндэвтэр гэмт хэрэг 57, илрүүлэлт 46,2%, хүнд гэмт хэрэг 2, онц хүнд гэмт хэрэг 2, гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 12, нийт гэмт хэргээс хулгайлах гэмт хэрэг 42, танхайрах гэмт хэрэг 5 байсан бол 2016 оны байдлаар нийт 92 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хөнгөн гэмт хэрэг 73, илрүүлэлт 84,6%, хүндэвтэр гэмт хэрэг 14, илрүүлэлт 50%, хүнд гэмт хэрэг 4, илрүүлэлт 100%, онц хүнд гэмт хэрэг 1, гэмт хэрэг үйлдсэн хүн нь олдоогүй 9, нийт гэмт хэргээс хулгайлах гэмт хэрэг 8, танхайрах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн байна. (**Хүснэгт VIII.24.2.**)

Дүгнэлт

Төмөр замын тээврийн салбарт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллийг Улсын хэмжээний дүнтэй харьцуулбал нийт гомдол, мэдээллийн 0,26%, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 0,4%, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн 0,39%, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 0,39%, шалгасан нийт хэргийн хувьд хөнгөн 0,5%, хүндэвтэр 0,3%, хүнд 0,2%, онц хүнд 0,2%, илрээгүй хэрэг 0,2%, хулгайлах хэрэг 0,5%, танхайрах хэрэг 1,11% тус тус эзэлж байна.

Улс орны эдийн засаг, ачаа болон зорчигч тээврийн эргэлтийн өсөлт болон улсын хэмжээнд хүлээн авч шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, шалгасан гэмт хэрэгтэй харьцуулахад хүнд, онц хүнд ангиллын гэмт хэргийн илрүүлэлтийн хувь харьцангуй бага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх зохион байгуулалт, арга зүй, сэтгэлгээний болон мэргэжлийн чадвар, хандлага дутагдалтай байна гэж үзэх үндэслэлтэй.

Төмөр замын тээврийн салбарт хууль сахиулах, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд мөрдөн шалгасан нийт гэмт хэргийн 96,7-94,6% нь ил цагаан үйлдэлтэй хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг шалгасан төдийгөөр ихээхэн цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө зарцуулсан, харин зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгдсэн гэх гэмт хэрэг бараг шалгаагүй[64], урьдчилан сэргийлсэн тоон мэдээлэл тодорхойгүй учир хангалтгүй ажилласан гэж дүгнэхэд хүрч байна.

Ачаа болон зорчигч тээврийн эргэлт, эдийн засгийн эрчим өндөртэй, цаашид эрчимтэй хөгжих зорилготой бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл дуусаж дотоодын эдийн засгийн 50 илүү хувь, ачаа эргэлтийн 96 гаруй хувийг эзлэх энэ салбарт хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа нь зөвхөн гомдол, мэдээллийг хүлээн авах байдлаар хязгаарлагдах бус илүү өргөн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй мэргэшсэн албаны бүтцээр ажиллах шаардлагатайг илэрхийлнэ. (Хүснэгт VIII.24.3. VIII.24.4.)

64 Эдийн засгийн салбар дахь гааль, татвар, төмөр замын тээвэр, банк санхүү, төсвийн хууль тогтоомж зөрчсөн хүнд, онц хүнд ангиллын зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж үзэх үндэслэлгүй тул Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэхэд хүргэж байна.

Хүснэгт VIII.24.1. Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

д/д	ХСБ-га	Хүлээн авсан нийт гомдол, мэдээлэл	Гэмт хэргийн шинжтэй	ЭХҮ	ЭХҮТ	ГХБ-гүй	Шийдвэрлэсэн хоног	
							0-5	6-19
2011 оны дүн								
1	Улс	128664	59376	23405	33356	32974	8763	30612
2	Төмөр зам	460	285	157	102	102	170	115
2012 оны дүн								
1	Улсын дүн	141276	62371	24273	36615	36167	31743	30628
2	Төмөр зам	617	269	119	138	138	114	155
2013 оны дүн								
1	Улсын дүн	171438	79983	93984	51139	50403	39533	40380
2	Төмөр зам	1259	367	116	245	243	165	202
2014 оны дүн								
1	Улсын дүн	450967	93984	29940	63245	62439	45337	48647
2	Төмөр зам	1132	373	129	244	237	169	256
2015 оны дүн								
1	Улсын дүн	471556	96661	30439	65885	64293	45568	51093
2	Төмөр зам	793	392	106	285	281	204	188
2016 оны дүн								
1	Улсын дүн	488076	94324	28320	65709	64316	35730	58694
2	Төмөр зам	670	335	112	223	216	182	153
2011-2016 оны нийт дүн								
Улсын дүн		1851977	486699	230361	315949	310592	226674	260054
Төмөр Зам		4931	2021	739	1237	1217	1004	1069

Хүснэгт VIII.24.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

№	СБ-га	Бүртгэсэн нийт гэмт хэрэг	Өсөлт, бууралт хувь	хөнгөн	Илрүүлэлт хувь	хүндэвтэр	Илрүүлэлт хувь	хүнд	Илрүүлэлт хувь	Онц хүнд	Илрүүлэлт хувь	Илрээгүй гэмт хэрэг	Хулгайлах гэмт хэрэг	Танхайрах гэмт хэрэг
2011 оны дүн														
1	Улс	19197	-3,2	7977	58,0	8889	60,1	1823	72,2	508	89,3	2505	2059	113
2	ТЗам	122	-15,3	61	76,2	57	46,2	2		2		12	42	5
2012 оны дүн														
1	Улс	22089	15,1	9637	53,8	10041	55,9	1914	64,3	497	77,1	3555	2444	189/13/
2	ТЗам	99	-18,9	42	83,3	50	68,4	7	75,0		100	9	6	1/2/
2013 оны дүн														
1	Улс	25362	14,8	11648	62,0	11514	54,7	1766	68,1	434	85,5	4528	3471	169
2	ТЗам	89	-10,1	57	64,3	28	80	2		2		8	5	/3/
2014 оны дүн														

1	Улс	27318	7,7	13057	60,9	11951	54,9	1781	67,2	529	88,0	5215	3674	/460/
2	ТЗам	98	10,1	62	92	30	58,3	4	100	2	50	8	3	/5/
2015 оны дүн														
1	Улс	27757	1,6	13487	64,1	12127	58,9	1628	72,9	515	88	5278	3857	/498/
2	ТЗам	90	-4,3	55	91,3	33	60	2	100			8	7	/1/
2016 оны дүн														
1	Улс	27167	-2,1	13519	68,5	11767	58,8	1393	76,4	488	91,9	5331	3917	/357/
2	ТЗам	92	2,2	73	84,6	14	50	4	100	1		9	8	/1/
2011-2016 оны нийт дүн														
Дүн	Улс	148890	33,9	69325	61,2	66289	57,2	10305	70,1	2971	86,6	26412	19422	1786
	ТЗам	590	-36	350	68,0	212	60,4	21	93,7	7		54	81	20

Хүснэгт VIII.24.3. Гэмт хэргийн төрөл

д/д	ХСБ-га	79-90	Илрүүлэлт хувь	91-107	Илрүүлэлт хувь	145-155	Илрүүлэлт хувь	175	Илрүүлэлт хувь	177-191	Илрүүлэлт хувь	215-225	Илрүүлэлт хувь	263-273	Илрүүлэлт хувь
2011 оны дүн															
1	Улс	96		6462		7232		54		1873		1870		101	
2	ТЗам			40		57		5		5		10			
2012 оны дүн															
1	Улс	138	93,9	7155	74,6	9023	51,6	66	57,1	1749	65,4	1999	72,4	110	5,0
2	ТЗам			19	100	55	77,8	14	33,3	4	50	2		1	
2013 оны дүн															
1	Улс	54	12,5	8156	85,0	11118	51,8	98	20,0	1894	77,4	2148	78,5	106	
2	ТЗам			27	50	49	66,7	5		1	50	3			
2014 оны дүн															
1	Улс	45	21,4	8697	85,1	8424	49,4	69	22	1750	74,3	2143	84,8	135	
2	ТЗам			23	50	31	85,7	10		1	100	3			
2015 оны дүн															
1	Улс	10		8468	89,0	13445	56,1	42		1630	79,8	2010	85,9	128	66
2	ТЗам			21	100	49	73,3	2		3	100	4	100		
2016 оны дүн															
1	Улс	36	50	8691	88,7	13336	56,8	40	100	1479	75,6	1783	87,8	111	
2	ТЗам			22	100	60	77,5	1		5	100				
2011-2016 оны нийт дүн															
	Улс	389		47629	84,4	62578	53,1	369	25,0	10375	74,5	11953	81,0	681	
	ТЗам	00		152		301		37		19		22		1	

Хүснэгт VIII.24.4. Тээврийн прокурорын байгууллагаас гомдол, мэдээлэлийг хянан, шийдвэрлэсэн байдал

Д/д	Хянасан нийт г/м	Эрүүгийн хэрэг үүссэн						Шүүхэд ш/сэн	Хэр/гүй болгосон	Хэрэгсэхгүй болсон үндэс		
		ЭХУ	ЭХУТ	Хөнгөн	Хүн/тэр	Хүнд	Онц хүнд			Бүр/гүй	эвлэрсэн	Бусад
Тээврийн Прокурорын газрын хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
1	22287	4960	17235	2452	2752	60	9	1443	3571	938	2357	218
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		22,2	77,3	49,4	55,5	1,2	0,2	29,1	72	26,2	66	6,1
Улсын хэмжээнд хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн 2013-2016 оны дүн												
2	367393	121128	244453	53667	68321	10395	3459	24379	85412	19640	38359	27413
Шийдвэрлэсэн дүнд эзлэх хувь		32,9	66,5	44,3	56,4	8,5	2,8	20,1	70,5	23	44,9	2,1
Тээврийн прокурорын газрын улсын хэмжээний дүнтэй харьцуулалтын хувь /2013-2016 он/												
3	6,06	4,09	7,05	4,56	4,02	0,57	0,26	5,91	4,18	4,77	6,14	0,79

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ ШИНЖ

Тайлбар: Гэмт хэрэгт холбогдогчдын криминологи шинжийг үндэсний аюулгүй байдлын эсрэг, эрх, эрх чөлөөний эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, гаалийн хууль тогтоомж зөрчсөн, танхайрах, ТХХАБАЖЭсрэг, албан тушаалын эсрэг гэсэн гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувийн жинтэй 6 төрлийн гэмт хэргийг сонгон авч шинжилсэн болно. Судалгааг сүүлийн 6 жилээр авч үзлээ. (Хүснэгт VIII.24.5.)

Гэмт хэрэгт холбогдогчдын хүйс, нас, боловсрол

Улсын хэмжээнд 2011-2016 онуудад нийт 132401 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 19099 эмэгтэй, бүлэглэсэн 21430, зохион байгуулалттай бүлэг 42, согтуугаар 32456, насны хувьд насанд хүрээгүй хүн 7523, 18-34 насны 81434, 35-аас дээш насны 43486, ажлын хувьд төрийн албан хаагч 946, хувийн салбарынхан 24052, оюутан сурагчид 7635, ажилгүй[65], боловсролын хувьд бага 18012, дунд 64084, тусгай 4433, дээд 23344 байна.

Төмөр замын тээврийн салбарт 2011-2016 онуудад нийт 557 хүн холбогдсоноос 151 эмэгтэй, 183 бүлэглэсэн, согтуугаар 126, насанд хүрээгүй хүн 53, насны хувьд18-34 насны 336, 35-дээш насны 296, ажил эрхлэлтийн хувьд төрийн албаны 31, хувийн салбарын 243, оюутан сурагч 55, ажилгүй 282, боловсролын хувьд бага 28, дунд 409, тусгай боловсролтой 48, дээд 146 байна.

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Төмөр замын тээврийн хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдлыг 2011 оныхтой харьцуулахад 2016 онд нийт 98 буюу 33 хүнээр буурсан боловч харьцангуй тогтвортой, **хүйсийн хувьд**: 26 эмэгтэй буюу 2-оор буурсан, **насны хувьд**: 2 хүүхэд буюу 5-аар буурсан ч 2012, 2014, 2015 онуудад харьцангуй өссөн, 18-34 насны

65 Тоон мэдээлэл тодорхой гараагүй

52 буюу 18-аар буурсан ч тогтвортой, 35-70 насны 44 буюу 10-аар буурсан ч 2013 онд өссөн, **ажил байдлын хувьд**: Төрийн албан хаагч 4 буюу тогтвортой, хувийн секторын ажилтан 37 буюу 8-аар өссөн, оюутан, сурагчид 4 буюу 2-оор буурсан, ажилгүй 53 буюу 6-аар буурсан, **оролцооны хувьд:** бүлэглэж 22 буюу 8-аар өссөн, **боловсролын хувьд**: бага 2, дунд 65 буюу 29-өөр өссөн, тусгай 4 буюу 4-өөр буурсан, дээд 27 буюу 8-аар өссөн үүнээс согтуу 23 буюу 7-оор өссөн байгаа нь харьцангуй тогтвортой мэт боловч тээврийн салбарын онцлогтой холбоотой үзүүлэлт тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. (**Хүснэгт VIII.24.5.**)

ДҮГНЭЛТ

Улсын хэмжээний дүнтэй харьцуулж үзэхэд төрийн болон хувийн салбарт харъяалалтай дунд, дээд боловсролтой хүмүүс гэмт хэрэг бүлэглэж үйлдэх зэрэг онцлог үзүүлэлтээр 20-40% өсөх хандлагатай байгаа нь төмөр замын тээврийн салбарын эдийн засгийн өсөлт, ачаа, зорчигч тээврийн эргэлтийн эрчимтэй холбоотой ажил эрхэлдэг, мэдлэг боловсролтой, дундаж настай хүмүүс гэмт хэрэг бүлэглэж үйлдэх магадлал өндөр байгааг илэрхийлнэ.

Хүснэгт VIII.24.5. Гэмт хэрэг үйлдэгсэд

№	ХСБ-га	Бүх хүн	эм	бүлэг	ЗБ-тай бүлэг	согтуу	Нас			Ажлын байдал				Боловсрол			
							НХХ	18-34	35-70	Төрийн	Хувийн	Оюутан сурагч	ажилгүй	бага	дунд	тусгай	дээд
2011 оны дүн																	
1	Улс	17982	2303	2117	3	4312	1136	11357	5462	664	2742	1209	10088	2899	8663	548	2493
2	ТЗам	131	28	14		15	7	70	54	4	21	6	59		94	8	19
2012 оны дүн																	
1	Улс	19734	2667	4030	23	4791	1248	12320	6166		1764	1316		2808	8403	616	3305
2	ТЗам	120	30	58		26	22	58	40	3	51	20	43	18	49	6	21
2013 оны дүн																	
1	Улс	22286	3137	4205	10	5695	1222	13766	7271	988	541	1575		3084	14674	723	3816
2	ТЗам	111	19	42		16	1	47	71	6	41	3	43	3	71	11	26
2014 оны дүн																	
1	Улс	23737	3618	2732	2	6686	1250	14481	8006		6900	1581	11658	3073	15250	876	4395
2	ТЗам	103	33	7		16	11	48	44	6	46	14	33	4	61	12	26
2015 оны дүн																	

1	Улс	24857	3782	4624		5465	1402	15088	8363	1018	7178	644		3251	1600	836	4755
2	ТЗам	114	35	40		30	10	61	43	8	47	8	51	1	79	7	27
2016 оны дүн																	
1	Улс	23805	3592	3722	4	5507	1265	14422	8218	835	4927	1310		2897	15494	834	4580
2	ТЗам	98	26	22		23	2	52	44	4	37	4	53	2	65	4	27
Нийт	Улс	132401	19099	21430	42	32456	7523	81434	43486	946	24052	7635		18012	64084	4433	23344
	ТЗам	557	151	183		126	53	336	296	31	243	55	282	28	409	48	146

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, орон зай

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Төмөр замын тээврийн салбарын хэмжээнд 2011 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагийн 1, 4 дахь өдрүүдэд, цагийн хувьд 06-14, 22-06 цагийн хооронд харин **2016 онд** үйлдэгдсэн нийт гэмт хэрэг гарагийн 2, 3, 5 дэх өдөр, цагийн хувьд 14-19, 22-06 цагийн хооронд гэмт хэргийн түвшин өндөр хувьтай байгаа нь галт тэрэгний цагийн хуваарь, ачаалал, галт тэрэгний буудлын үйлчилгээний хүрээ, төрөл, хуваарьтай шууд холбоотой байсан боловч жилийн аль сарын хэд дэх 10 хоногт гэмт хэрэг үйлдэгдэж байгаа байдлаар гэмт хэргийн түвшин тодорхойлох мэдээлэл байхгүй байсан болно. (**Хүснэгт VIII.24.6.**)

Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа орон зайн хувьд салбарын онцлогтой холбоотой суудлын галт тэрэгний аяллын үед галт тэрэг дотор, галт тэрэгний буудлын орчин, хил, гаалийн бүсийн галт тэрэг дотор, ачаа тээврийн галт тэрэгний ачаа, тээвэрлэлтийн үеийн болон төмөр замын байгууллагууд, албан хаагчид албан үүрэгт хамааралтай гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Хүснэгт VIII.24.6. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг

Д/Д	ХСБ-га	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2011 оны дүн												
1	Улс	3407	2815	2843	2819	2850	2217	2246	3251	5115	3554	7277
2	ТЗам	23	14	17	22	13	17	16	47	20	16	39
2012 оны дүн												
1	Улс	3593	3342	3243	3212	3202	2714	2783	3814	5664	3956	8658
2	ТЗам	9	12	14	13	23	12	16	36	18	14	31

2013 оны дүн														
1	Улс	4067	3875	3765	3778	3707	3140	3030	4532	6405	4541	9884		
2	ТЗам	11	13	20	13	10	11	11	34	14	15	26		
2014 оны дүн														
1	Улс	4655	4178	4115	3937	4093	3192	3148	5758	7326	4434	9800		
2	ТЗам	12	11	13	10	19	16	17	33	28	19	18		
2015 оны дүн														
1	Улс	4655	4266	4159	4127	4028	3328	3194	6056	7948	4326	9427		
2	ТЗам	10	8	18	12	16	9	17	20	25	15	30		
2016 оны дүн														
1	Улс	4280	4157	4018	4019	3979	3424	3280	5884	7782	4109	9392		
2	ТЗам	13	15	15	14	19	8	8	22	29	10	31		
Нийт дүн	Улс	24657	22633	22143	21892	21859	18015	17681	29295	40240	24920	54438		
	ТЗам	78	86	97	84	100	61	85	192	134	89	175		

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ БОЛОН ХОХИРЛЫН БАЙДАЛ

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Төмөр замын тээврийн салбарын хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт хохирсон болон хохирлын байдлыг 2011 оныхтой харьцуулахад **2016 онд** үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 94 хүн хохирсон буюу 6-аар буурсан, эмэгтэй 47 буюу 7-оор өссөн, хүүхэд 5 буюу 3-аар өссөн, 18-34 насны 51 буюу 10-аар өссөн, 35-70 насны 43 буюу 14-өөр буурсан, гэмт хэргийн улмаас нийт 792,6 орчим сая төгрөгийн хохирол буюу 553,0 сая төгрөгөөр өссөн үүнээс хөнгөн гэмт хэргийн улмаас 75,6 сая төгрөг буюу 48,6 сая төгрөгөөр өссөн, хүндэвтэр 44,5 орчим сая төгрөг буюу 3,5 сая төгрөгөөр буурсан, хүнд 672,6 сая төгрөг буюу 538,0 сая төгрөгөөр өссөн, үүнээс хэрэг бүртгэлтийн явцад 58,1 сая буюу 39,2 сая төгрөгөөр өссөн, мөрдөн байцаалтын явцад 699,2 сая буюу 506,6 сая төгрөгөөр өссөн дүнтэй хохирол нөхөн төлүүлсэн нь бүх үзүүлэлт эрс өссөн.

Харин нийт хохирлоос нөхөн төлөлт 95,5%-тай байсан нь нэг талаас сайн үзүүлэлт боловч нөгөө талаас хөнгөн, хүндэвтэр "ил цагаан" үйлдэлтэй гэмт хэргийн нөхөн төлөлт гэдгийг анхаарах ёстой.

ДҮГНЭЛТ

Эндээс харвал хохирогчийн тоо, хохирлын хэмжээ тогтвортой өссөн нь ачаа, зорчигчийн эргэлтийн эрчимтэй өсөлт, мөнгөний ханш, үнийн инфляцтай холбоотой байх магадлалтай учир нь хохирол нөхөн төлөлт тээврийн салбарын хувьд харьцангуй сайн байгаа нь хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт ногдох хувь өндөр учир төлөлт хялбар байна.

Энэ нь нэг талаас сайн үзүүлэлт мэт боловч нөгөө талаас зохион байгуулалттай, хүнд, онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудал байгааг илтгэнэ. Цаашид хохирлын хэмжээ эрс өсөх хандлагатай. (**Хүснэгт VIII.24.7.**)

Хүснэгт VIII.24.7. Хохирогч, хохирлын байдал

№	ХСБ-га	Нийт хохирогч	Эм	НХХ	18-34	35-70	Хохиро Сая ₮	Хөнгөн.гх Сая ₮.	Хүн/тэр. гх Сая ₮	Хүнд гх	ОХүнд.гх Сая₮	Төлөлт. Сая₮	ХБ Сая₮	МБ Сая₮
2011 оны дүн														
1	Улс	18592	6856	1178	9116	8298	35904,1	4226,4	19986,0	4713,0	6978,8	18490,4	2603,8	15886,6
2	ТЗам	100	40	2	41	57	239,6	27,0	48,0	134,6	30,0	211,4	18,9	192,6
2012 оны дүн														
1	Улс	21294	7977	1200	10540	9567	53263,2	6613,2	22223,1	14564,8	9862,2	25135,6	4409,6	20726,0
2	ТЗам	87	38	5	43	39	189,8	54,4	132,4	3,0		136,8	49,0	87,8
2013 оны дүн														
1	Улс	25015	9838	1426	12316	11273	159024,2	9433,2	87481,9	37049,2	25059,9		6582,2	
2	ТЗам	80	39	1	55	42	2952,4	37,3	2915,1			2001,0	32,1	1968,9
2014 оны дүн														
1	Улс	27475	10902	1576	13420	12479	148204,6	13800,7	34202,4	61890,7	38370,9	43652,5	9195,9	34456,6
2	ТЗам	90	56	3	34	53	758,3	39,3	48,6	35,4	635,0	110,0	31,0	79,0
2015 оны дүн														
1	Улс	27948	11207	1477	13528	12943	144341,4	15388,4	45783,3	38075,5	45094,2	48997,8	10224,2	38773,5
2	ТЗам	92	51	2	48	42	707,2	71,8	633,9	1,5		592,9	54,0	538,9
2016 оны дүн														

1		27689	11346	1340	13306	13043	162909,4	16585,8	40518,4	67975,0	37830,2	43964,0	11320,4	32643,5
2	ТЗам	94	47	5	51	43	792,1	75,6	44,5	672,0		757,3	58,1	699,2
Нийт	Улс	148013	58126	8197	72212	67603	150845,3	66047,7	250195,1	224268,2	163196,2	131242,5	44336,1	142486,2
	ТЗам	543	271	18	272	276		305,4	3822,5	846,5	665,0	3809,4	735,4	3566,4

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

Тайлбар: Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар зөрчлийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа "танхайрах", "авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал"[66], "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" зэрэг төрөл сонгон авч тоймлон дүгнэсэн болно.

Төмөр замын тээврийн салбарын хэмжээнд 2012-2016 онд нийт 81081 зөрчилд 80701 хүн холбогдуулан бүртгэж 783,4 сая төгрөгөөр торгосон, үүнээс торгуулийн тасалбараар 77376 зөрчилд 712,3 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Тус салбарт бүртгэгддэг зонхилох зөрчлөөс "танхайрах" зөрчил 25263-ыг бүртгэн 12302,7 сая төгрөгний торгууль, "авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам" зөрчсөн 25811 зөрчил бүртгэж 352,1 сая төгрөгөөр торгож, "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" 9683 зөрчилд 41,57 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Энэ нь нийт зөрчлийн 74,9%, торгуулийн 95 орчим хувь эзэлж байна.

Төмөр замын тээврийн салбарын хэмжээнд 2016 онд зөрчлийн байдал, төрөл болон торгуулийн дүнг **2012-2015** оныхтой харьцуулахад **2016 онд** нийт зөрчил 20178 буюу 4030-9982-оор өссөн, холбогдсон хүн 20171 буюу 4108-10030-аар өссөн, торгуулийн хэмжээ 321,6 сая төгрөг буюу 259,6-81,7 сая төгрөгөөр өссөн, торгуулийн тасалбараар 19834 хүн буюу 10380-4798 хүнээр өссөн, торгуулийн хэмжээ 307,427 сая төгрөг буюу 256,1-75,0 сая төгрөгөөр өссөн үүнээс танхайрах зөрчил 6652 буюу 3939-870-аар өссөн, торгуулийн хэмжээ 33,26 сая буюу 9,8-4,35 сая төгрөгөөр өссөн, хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил 8091 буюу 7744-2011-ээр өссөн, торгуулийн хэмжээ 241,96 сая буюу 240,2-187,3 сая төгрөгөөр өссөн, Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй зөрчил 9683 буюу 9283-6914-өөр өссөн, торгуулийн хэмжээ 41,57 сая төгрөг буюу 39,6-27,7 сая төгрөгөөр өссөн байна.

Дүгнэлт

Төмөр замын тээврийн салбарын онцлогтой холбоотойгоор галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах[67] зорилгоор Төмөр зам дахь цагдаагийн байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой зөрчлийг харьяалан[68] жилд 4 сая орчим зорчигч, 30-40

66 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015 оны 7 сарын 5-ны өдөр

67 Төмөр замын тээврийн тухай хууль 2007 оны 07 дугаар сарын 5-ны өдөр

68 Төмөр замын тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1991 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаан, Цагдаагийн ерөнхий газрын даргын 1992 оны 12-р сарын 28-ны 412 тоот тушаалаар аялын вагон эвдэх, тонох,

сая орчим үйлчлүүлэгчийн ая тухыг баталгаатай хангах, 30 орчим сая тонн ачаа эргэлтийн хэвийн байдлыг ханган ажиллаж ирсэн.

Гэтэл зөрчлийн бүртгэл жил бүр харилцан адилгүй байгаа нь хууль сахиулах үйл ажиллагааг мэргэжлийн үүднээс зохион байгуулж хэрэгжүүлэх, үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бүрэн хянаж чадахгүй байгаагаас урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байх үндэслэлтэй.

ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН БАЙДАЛ

Төмөр зам дахь Цагдаагийн хэлтэс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулж төмөр замын албадаас багагүй хэмжээний хөрөнгө мөнгө, техник хэрэгслийг жил бүр авдаг боловч шинжлэх ухааны үндэслэлээр тодорхойлсон оновчтой үйл ажиллагаанд зарцуулахгүй зөвхөн 400-600 хүнд яриа хийсэн, станц, камер авсан зэрэг үр нөлөө багатай ажилд зарцуулсан байна.

Цагдаагийн албан хаагчид урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдлэг хомс, ур чадвар, дадлага хангалтгүй, үйл ажиллагаандаа криминологийн шинжлэх ухааны үр дүнг ашиглахгүй байгаа нь судалгаанаас илэрхий байна.

Мөн алба хаагчийн харилцааны соёл хангалтгүй байгаатай холбоотой "Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй" гэх зөрчил улсын хэмжээний дүнтэй харьцуулахад 11,4%, торгууль 10,2%-ийг эзэлж буй нь харьцангуй өндөр үзүүлэлт[69] гарч байгаа тул цагдаагийн байгууллагын нийтлэг чиг үүрэг гүйцэтгэх шинэ арга зүй, туршлагыг "нийгмийн гэрээний онол"-д тулгуурлаж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт VIII.24.8. Зөрчил, шийдвэрлэлтийн байдал

№	ХСБ-га	Нийт зөрчил	Хувь (+, -)	Ирген	Торгууль Сая ₮	Торгуулийн тасалбар торгосон		Танхайрах нийт зөрчил		ХАБ журам нийт зөрчсөн		ХЁШаардлага эсэргүүцсэн	
						Тоо	СаяТ	Тоо	Сая ₮	Тоо	Сая ₮	Тоо	Сая ₮
2011 оны дүн													
1	Улс	68226	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	ТЗам	123	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2012 оны дүн													
1	Улс	795923	21,8	751571	4654,413	627853	3043,012	126018	462,230	502438	238,823	10503	42,23
2	ТЗам	12572	128,2	12509	65009,0	11607	55,182	2713	12190,0[1]	6080	29,746	400	1,972
2013 оны дүн													
1	Улс	777793	-2,3	726716	4853,349	655728	3029,8	137259	563,539	469677	2242,6	9565	42,684

зөрчигчдын ая тух алдагдуулах, эрүүл мэнд, эд хөрөнгийн эрхийг зөрчих зөрчил их байгаатай холбоотойгоор галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотойгоос бусад зөрчлийг нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллагад хариуцуулсан.

69 Орон нутгийн нийтийн тээвэр, Олон улсын тээвэрээр боловсролтой, харьцангуй соёлтой иргэд зорчдог бөгөөд зүй бус аливаа шаардлагыг үл биелүүлэх, зүй ёсны тайлбар тавих, хууль ёс шаардах явдал их байдаг байна.

		Нийт дүн													
		Улс	ТЗам	Улс	ТЗам	Улс	ТЗам	Улс	ТЗам	Улс	ТЗам	Улс	ТЗам	Улс	ТЗам
2	ТЗам	16148	28,4	16063	94,9	15036	75,117	4684	23,413	4811	24,055	1432	7,160		
2014 оны дүн															
1	Улс	681222	-12,4	-	5253,6	538473	2973,76	131600	6032,7	369295	2192,42	12761	62,113		
2	ТЗам	10196		10141	61,989	9454	42,27	5782	28,910	347	1,735	1647	8,235		
2015 оны дүн															
1	Улс	1423088	2дах	1372058	17016,3	1279774	14300,4	117008	559,861	786338	5126,278	21720	107,24		
2	ТЗам	21864	2,1дах	21817	239,93	21445	232,362	5432	27,16	6482	54,639	2073	10,365		
2016 оны дүн															
1	Улс	1034585	-27,3		30617,3	927639	16749,2	107531	534,062	597524		30412	153,332		
2	ТЗам	20178	-7,7	20171	321,6	19834	307,427	6652	33,26	8091	241,961	2769	13,845		
Нийт дүн	Улс	4712611		3850345	62394,9	4029467	117472,1	619416	8152,4	2725272	9800,1	84961	407,59		
	ТЗам	81081		80701	783,4	77376	712,3	25263	12302,7	25811	352,13	9683	41,57		

ДҮГНЭЛТ

Төмөр замын тээврийн салбарын үйлчилгээ цогц байдлаар өргөжиж байгаатай уялдуулан аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагааг бодит байдалд тохирсон, үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс мэргэжлийн албаны зохион байгуулалт, мэргэшсэн алба хаагчид, тодорхой чиг үүрэгтэй гүйцэтгэх шаардлагатай (хил, гааль, мөнгө угаах, хүн худалдаалах зэрэг эдийн засгийн салбарын гэмт хэрэгтэй тэмцэх) болсон байна.

Салбарын онцлогтой холбоотой гэмт хэрэг шалгаж шийдвэрлэхгүй байгаа нь шинэ нөхцөл байдалд тохирсон бүтэц, зохион байгуулалт, удирдлага, арга зүй, арга барил, сэтгэл зүй, сэтгэлгээ, чадвар, туршлагыг шаардаж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр офицер бүрэлдэхүүнийг өргөжүүлж, нийтийн хэв журмын орон тоо, хүний хүчин зүйлийг багасгаж ухаалаг технологид суурилсан цомхон орон тоогоор урьдчилан сэргийлэх ажиллагааг (дүрс, дуу бичлэг, гэрэл зураг, зурагт, радио, хэвлэлийн төрөл зүйлийг өргөн ашиглах) шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулан үйл ажиллагааг төлөвлөгөөтэй хэрэгжүүлж хэвших ажлыг зохион байгуулах шаардлагатай болсон.

Тайлбар, Тээврийн салбарт үндэстэн дамнасан зохион байгуулалттай буюу НҮБ-ын тодорхойлсон 15 төрлийн хүнд ангиллын гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байгаа тул дараахь санал илэрхийлж байна.

Санал

Энэ салбарт ажилгүй болон бага насны хүүхэд зөрчилд холбогдох нь харьцангуй бага, ихэвчлэн эдийн засгийн боломжтой хүмүүс үйлчлүүлдэг учир ихэвчлэн нийтлэг зөрчил үйлдэж байгааг анхаарах, эрүү, зөрчлийн хуулиуд шинээр батлагдан, мөрдөгдөх болон салбарын өвөрмөц онцлогтой холбоотой огт шийдвэрлэгддэггүй зөрчилтэй тэмцэхэд мэргэшсэн албаны эрэлт шаардлагатай холбоотой санал хүргэж байна.

Төмөр зам дахь Цагдаагийн газрын бүтцэд "Шинэ төмөр зам"-ын салбар болон Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийг нэгтгэн нэг бүтэцтэй болгох, Мэргэжлийн албаны зохион байгуулалттайгаар, мэргэшсэн албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой тогтолцоо, эрх зүйн үндэс бий болгох, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл нь "эдийн засгийн салбарт үйлдэгдэх зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх" хүрээнд офицерын бүрэлдэхүүнийг өргөтгөж, хэв журмын чиг үүргийг ухаалаг технологид суурилсан цомхон бүрэлдэхүүнээр зохион байгуулах нь зүйтэй.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү тайланд орсон судалгааны ажлын үр дүнгүүд, статистикийн мэдээлэлд үндэслэн Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг дараах байдлаар тоймлон дүгнэж байна. Үүнд:

1. Монгол Улсад гэмт хэргийн гаралт 1968 оноос 2016 он хүртэл **7.9 дахин өсчээ.** Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас өрсөлдөөнт зах зээлийн шинэ нийгэмд шилжсэн үе болох 1992 он 12467 гарч байсан бол сүүлийн 25 жилийн хугацаанд 2016 он 27167 болж, 2.2 дахин өссөн байна.
2. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад 231060, жилд дунджаар **23106 гэмт хэрэг** бүртгэгдсэн статистик мэдээ байна.
3. Гэмт хэргийн түвшин 2007 оноос 2011 он хүртэл 9.7%-аар буурч, харин 2011 оноос 2016 он хүртэл 41.5%-аар өссөн байна. Сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн гэмт хэргийн үзүүлэлтээр чиг хандлагыг математик статистикийн аргыг ашиглан тодорхойлоход цаашид жилд дунджаар **655 хэргээр өсөн нэмэгдэх прогноз** байна.
4. 2016 оны байдлаар хүн амд ногдох гэмт хэргийг тооцоолоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 100 000 хүнд 1153, 100 000 хүнд 1219 гэмт хэрэг тус тус оногдож байна. Цаашид энэ тоон үзүүлэлтэд үндэслэн Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулах боломж бүрдэх юм.
5. Сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн 41.3% нь орон нутагт, 58.7% нь нийслэлд үйлдэгдсэн байна. **Харин гэмт хэргийн 2007 онд 49.4% нь Улаанбаатар хотод үйлдэгдэж байсан бол 2016 онд 65.9%** болж, цаашид ч улам өсөх хандлагатай байна.
6. Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн **33.4%-ийг хулгайлах, 30.4% нь бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 7.9% нь залилан мэхэлж авах, 6.6% нь ТХХАБАЖЭсрэг, 5.3% нь танхайрах,** 1.7% нь дээрэмдэх, 1.2% нь завших, үрэгдүүлэх, 1.1% нь хүчиндэх бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.
7. Улсын хэмжээнд 2016 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 27689 хүн эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа, 84 байгууллага, аж ахуйн нэгж, нийт 162.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгөөрөө хохирчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн 41.0% нь эмэгтэй, 4.8% нь насанд хүрээгүй байгаа ба гэмт хэргийн улмаас 880 хүн нас барж, 11257 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн байна. **Хоногт хүний гэм бурyутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас 2-3 хүн нас барж, 31 хүн эрүүл мэндээрээ хохирчээ.**
8. Монгол Улсын Нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдлыг 2012-2016 оны мэдээлэлд үндэслэн таамаглан тусгай коэффициентын аргачлалаар тооцоолж үзэхэд 2016 онд 27167 гэмт хэрэг бүртгэгдсэн байсан бол түүний нуугмал байх түвшин нь өнгөрсөн 5 жилийн дунджаар **5705 (коэффицент 0.21) гэмт хэрэг нуугдмал байх магадлалтай** байна. Цаашид гэмт хэрэгт хохирох эрсдэлийг тодорхойлох

чанарын судалгааг улсын хэмжээнд явуулах замаар нуугдмал гэмт хэргийн түвшнийг тодорхойлох нь зүйтэй.

9. Сүүлийн 3 жилийн байдлаар Монгол Улсын шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн тоо жил тутам тогтмол 9.9-12.7%-аар өссөн байна.

   Анхан шатны шүүхүүд 2016 онд нийт **10120 хүнд холбогдох 7025 эрүүгийн хэрэг хүлээн авснаас** 1368 хүнд холбогдох 730 хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, 42 хүнд холбогдох 22 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1148 хүнд холбогдох 782 хэргийг хэрэгсэхгүй болгож, **нийт 5762 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 6566 хүнийг** гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан байна.

   Анхан шатны шүүхээр **2016 онд торгох ялаар нийт 216, албадан ажил хийлгэх ялаар 376, баривчлах ялаар 733, хорих ялаар 5114 хүн шийтгүүлсэн** байна. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс биечлэн эдлүүлсэн 1823, тэнссэн 2866 хүн, насанд хүрээгүй этгээд 217, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 86 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна.

   2016 онд **баривчлах, цагдан хорих талаар нийт 9746 шүүгчийн захирамж гарсан** байна. Эдгээр сэжигтэн, яллагдагчаар баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүст холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж байгаа талаарх мэдээллийг шүүн таслах ажиллагааны тайлан мэдээнээс гаргах боломжгүй байгаа нь учир дутагдалтайг дурдах нь зүйтэй.

   Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 2016 онд нийт 1961 хэрэг хүлээн авч, **1822 хэргийг хянан шийдвэрлэж**, 66 хэргийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 73 хэрэгт давж заалдах гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан байна.

   УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхим 2016 онд нийт **454 хэрэг хүлээн авч, 337 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 22 хэрэгт** Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж, албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд 88 хэргийг хянан буцааж, 6 хэргийн үлдэгдэлтэй байна. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 337 хэрэгээс 320 хэргийг гомдлын дагуу, 5 хэргийг прокурорын эсэргүүцлээр, 12 хэргийг прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэжээ.

   Монгол Улсын шүүхээр сүүлийн 5 жилд дунджаар 5961 гэмт хэрэг шийдвэрлэгджээ. Цагдаа, авлигатай тэмцэх зэрэг хуулийн байгууллагад жилд дунджаар 23106 гэмт хэрэг бүртгэгдсэн байдаг бол үүний **25.7% нь буюу 1/4 нь шүүхээр шийдвэрлэгджээ**. Олон улс дахь "гэмт хэргийн юүлүүр тогтолцоо" буюу "criminal funel system" талаас үзвэл цагдаагийн байгууллага болон авлигатай тэмцэх газар зэрэг хуулийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 25% нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг. Үлдсэн 75% нь цагдаа, авлигатай тэмцэх зэрэг хууль сахиулах байгууллагаас шалгах явцад болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэгддэг гэж болно.

10. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх үйл ажилагааны хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэх, төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар баримтлах бодлогын баримт бичиг гаргаж мөрдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлийг бодитой тогтоож, түүнд үндэслэн урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, нэгдсэн зохион байгуулалттайгаар, тодорхой төсөв хөрөнгө төсөвлөн зарцуулж хэрэгжүүлэх нь үр дүнд хүрэх боломжтой.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

"Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016" сэдэвт суурь судалгааны ажлын тайланд дурьдагдсанаас гадна дараах санал, зөвлөмжийг дэвшүүлэв. Үүнд:

1. Орчин үеийн криминологийн чиг хандлага, эрүүгийн болон зөрчлийн багц хуулиудад нийцүүлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулах;
2. Дээрх эрх зүйн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Монгол Улсын төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулан мөрдүүлж, хэрэгжүүлэх;
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулж буй үндсэн болон салбар, дэд зөвлөлүүдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, тэдний үйл ажиллагааг тогтмолжуулж, уялдуулах, ажиллах хүний нөөцийг мэргэшүүлж, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бий болгох;
4. Монгол Улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үзүүлэлт, хүснэгттэй болж, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн нэгдмэл бодлогыг хангуулах;
5. Улсын хэмжээнд болон аймаг, нийслэл, тодорхой салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг боловсруулах, батлуулах, зарцуулах үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг хувь хэмжээг тодорхой болгож, нэг мөр мөрдүүлэх;
6. "Гэмт хэргийн цагаан ном"-ыг жил бүр боловсруулан гаргаж, хууль сахиулах байгууллагууд, иргэд, олон нийт ашиглах нөхцөл боломжийг бүрэлдүүлж байх, шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр иргэд, эрдэмтэн, судлаач, практикийн ажилтан хэн боловч ашиглах боломжтой болгох.

ХАВСРАЛТ

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

(хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын статистикийн мэдээллийн үзүүлэлт)

№	Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
	Цагдаагийн байгууллага						
1	Цагдаагийн байгуулагын хүлээн авсан гомдол, мэдээлэл	130416	144543	174079	455265	475434	492375
2	Шалгасан захиргааны зөрчил	653619	795923	777793	681222	1423088	1038050
3	Бүртгэгдсэн гэмт хэрэг	19197	22089	25362	27318	27757	27167
4	Бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл						
	4.1.Бусдын бие махбодид гэмтэл учруулах (ЭХ-ийн 96-100)	5838	6546	7564	8132	8064	8248
	4.2.Бусдын эд хөрөнгийг хулгайлах (ЭХ-ийн 145)	5276	6266	7884	8424	9169	9065
	4.3.Бусдын эд хөрөнгийг залилах (ЭХ-ийн 148)	688	1098	1231	1843	2067	2165
	4.4.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (ЭХ-ийн 215-225)	1870	1999	2148	2143	2010	1783
	4.5.Танхайрах (ЭХ-ийн 181)	1824	1687	1839	1681	1582	1449
	4.6.Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (ЭХ-ийн 147)	536	552	620	686	537	474
	4.7.Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (ЭХ-ийн 150)	202	269	326	297	333	322
	4.8.Хүчиндэх (ЭХ-ийн 126)	367	305	344	300	279	290
	4.9.Хүнийг санаатай алах (ЭХ-ийн 91)	262	231	204	211	204	174
	4.10.Бусдын эд хөрөнгийг булаах (ЭХ-ийн 146)	137	179	227	245	216	176
	4.11.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөх бодистой холбоотой гэмт хэрэг Бусдын эд хөрөнгийг булаах (ЭХ-ийн 192)	12	75	29	51	71	94
5	Гэмт халдлагад өртөж хохирсон иргэн	18592	21294	25015	27475	27948	27689
6	Нийт учирсан хохирол	35.9	53.3	159.0	148.3	144.3	162.9
	6.1.Үүнээс нөхөн төлүүлсэн хохирол	18.5	25.1	111.3	43.7	49.0	44.0
	6.2.Хохирол нөхөн төлүүлэлтийн хувь	51.5	47.1	70.0	29.5	34.0	27.0
7	Гэмт хэргийн улмаас хүн нас барсан тоо	922	901	949	1078	847	880
8	Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо	8100	8436	9797	11281	11287	11257
9	Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн	17982	19734	22286	23737	24857	23805
	Үүнээс:						
	9.1.Эмэгтэй	2303	2667	3137	3618	3782	3592
	9.2.Хүүхэд	1163	1248	1222	1250	1402	1165

	9.3.Тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс	10088	10398	11310	11658	12532	12838
	9.4.Согтуугаар	4608	4791	5695	6003	5465	5507
	9.5.Урьд ял шийтгэгдсэн	994	900	909	1101	1455	1608
	Прокурорын байгууллага						
10	Хүлээн авсан гомдол, мэдээлэл, үүнээс	63036	67215	81025	93961	97656	94751
	10.1.Эрүүгийн хэрэг үүсгэсэн	23086	25752	28964	31271	31589	29304
	10.2.Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	34530	37122	52053	62672	66041	63687
11	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг	31349	34697	42850	46575	48677	41525
12	Яллагдагчийн тоо			23530	26782	27238	24213
13	Хохирол /сая төгрөг/	16829.3	43917.4	1236276.6	3992692.1	3062407.6	1054505.4
14	Шүүхэд шилжүүлсэн						
	хэрэг	6389	6584	6068	6085	6385	5907
	Хүн			8481	8735	8806	8110
15	Түдгэлзүүлсэн хэрэг	2845	3587	832	1280	2084	5317
16	Хэрэгсэхгүй болгосон хэрэг	15895	17614	18749	19925	25050	21701
	Он	2011	2012	2013	2014	2015	2016
	Шүүх						
17	Хүлээн авсан						
	Хэрэг	6776	7065	7248	7603	7998	7025
	Хүн	10517	10672	10901	11430	11603	10120
18	Мөрдөн байцаалтад буцаасан						
	Хэрэг	440	465	495	694	694	693
	Хүн	812	844	1004	1411	1278	1329
19	Хэрэг бүртгэлтэд буцаасан						
	Хэрэг	8	7	10	18	42	37
	Хүн	13	7	10	19	48	39
20	Харьяаллын дагуу шилжүүлсэн						
	Хэрэг	13	12	12	23	23	22
	Хүн	23	20	27	41	45	42
21	Хэрэгсэхгүй болгосон						
	Хэрэг	242	258	368	468	1042	782
	Хүн	453	522	667	747	1520	1148
22	Шүүхээр шийдвэрлэсэн						
	Хэрэг	5877	6161	6169	6375	6756	5762
	Хүн	8210	8324	8065	8178	7696	6566

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ-ийн мэдээлэл

СУДЛААЧИД:

Б.Батзориг (Ph.D) /VII.14/
Ж.Бумнанжид /VI.1/
Ц.Гантулгабат /VI.2/
С.Гантулга (Ph.D) /VII.10, VIII.2/
Э.Ганцэцэг /VI.4/
Г.Золбоо /VII.15, VIII.8, VIII.17/
Т.Золбоо /VII.11/
Ж.Мөнхболд (Ph.D) /VII.4/
Б.Мөнхдорж /Бүлэг II, VII.6, VIII.19, VIII.22/
Б.Мөнхсэргэлэн /VIII.7, VIII.16/
О.Мөнхцэцэг /Бүлэг I/
Ж.Нямдулам (Ph.D) /VII.7/
Ч.Нямсүрэн (Ph.D) /Бүлэг V, VIII.18/
Г.Оюунболд /Бүлэг III, VI.3, VI.5, VI.6, VII.5, VII.18, VIII.3, VIII.20/
С.Пүрэврагчаа /VII.3, VII.17, VIII.5, VIII.9/
Д.Сумъяацэрэн /VII.8, VIII.13, VIII.21/
Ж.Төгс-Очир, С.Энхчимэг /VII.12/
Г.Туяа /VIII.12, VIII.15/
Л.Цогтбаяр /VIII.23, VIII.24/
Ц.Цэлмэг (Ph.D) /VII.13, VIII.4, VIII.6/
Б.Энхболд (Ph.D) /Бүлэг IV, VII.1, VIII.1/
М.Эрдэнэбаяр (Ph.D) /VII.9, VIII.14/
Ж.Эрдэнэбулган (Ph.D) /VII.16, VIII.10, VIII.11/
Ц.Эрдэнэчимэг /VII.2/

ДАА 340
ННА 67
М-695

СУДАЛГААНЫ УР ДҮНГ НЭГТГЭСЭН:

Б.Мөнхдорж
Ц.Гантулгабат

ТЕХНИК РЕДАКТОР:

Б.Мөнхдорж
Ц.Гантулгабат
Б.Мөнхсэргэлэн
Л.Цогтбаяр
Г.Оюунболд

ХЯНАН РЕДАКТОРЛАСАН:

Н.Жанцан *Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор (Ph.D), профессор*
Г.Эрдэнэбат

ДИЗАЙНЕР:

Д.Энхнаран

Цаасны хэмжээ: 210-297
Хэвлэлийн хуудас: 83.25 хх

МӨНХИЙН ҮСЭГ ХХК-д хэвлэв.

ISBN 978-99978-2-281-9